






С.Л. Кузьмин

# НУУЦ ТҮВД ОРОН

## Тусгаар тогтнол ба эзэгнэлийн түүх

# Нууц Төвд Орон

С. Л. Кузьмин

# Нууц Түвд Орон

## *Тусгаар Тогтнол ба Эзэгнэлийн Түүх*

**“Түвдийг хадгалж үлдье” сан**

**Улаанбаатар**

**2011**

Хариуцлагатай редактор — А. Терентьев

Орчуулагч — Б. Сандагдорж

Түвд бол олон нууц хадгалж үлдсэн газар. Энэ нууц шашин хийгээд агийн ёсонд байгаа төдийгүй түүхийн олон зүйл ч нууцлаг хэвээр үлджээ. Энэхүү номонд балар эрт үеэс өнөөдрийг хүртэлх түвдийн соёл иргэншлийн түүхийг мөшгөж, «энх тайван чөлөөлөлт» буюу Түвдийг БНХАУ-ын бүрэлдэхүүнд хүчээр оруулахаас өмнө болон түүнээс хойшхи түвдчүүдийн амьдралын тухай өгүүлнэ. Номыг зохиогч Түвд урьд өмнө бусад улсын нэг хэсэг байгаагүй гэсэн дүгнэлтэд хүрчээ. Хятад газар монголын Юань гүрэн болон Манж чин улсын бүрэлдэхүүнд орж байсан тэр үед Түвд бие даасан байдлаа хадгалж үлдсэн бөгөөд Түвд бол Хятадын нэг хэсэг байсан хэмээх санаа нь дэлхий нийтийг хамран захирах гэсэн эртний хятадын эзэн хааны үзэл санаанаас л үүдэн гарч байгаа юм. Тиймээс Түвдийг БНХАУ-ын бүрэлдэхүүнд оруулсан нь хууль ёсны үйлдэл биш, Түвд бол эзлэгдсэн орон хэвээр байгаа юм.

Түвдийн түүхийн сүүлийн үетэй холбогдсон олон гэрэл зураг, мэдээлэл анх удаа нийтлэгдэж байна.

©2010 С. Л. Кузъмин
ISBN 978-0-9669571-4-3

“Түвдийг хадгалж үлдье” сан

www.savetibet.ru
russia@savetibet.ru

# Агуулга


Оршил үг — Тэло Тулку Ринбүүчи . . . . . i
Өмнөтгөл . . . . . 1
1. Түвдчүүдийн газар зүй ба гарал үүсэл . . . . . 4
2. Эртний ба дундад зууны үе . . . . . 12
3. Чин гүрний үе . . . . . 47
4. Тусгаар тогтнолын сүүлчийн жилүүд . . . . . 94
5. Шашин ба соёл . . . . . 125
6. Төр, нийгмийн байгуулалт, эдийн засаг . . . . . 150
7. «Энх тайван чөлөөлөлт» ба түүний уршиг дагавар . . . . . 181
8. Ардын бослогоос соёлын хувьсгал хүртэл . . . . . 235
9. Аугаа их пролетарийн соёлын хувьсгал. Маогийн үеийн үр дүн . . . . 323
10. Сэргээн босголт ба шинэчлэл . . . . . 390
Түвдийн ард түмний тэмцэл, Далай лам ба түвдийн дүрвэгчид . . . . 397
Шашин . . . . . 435
Өөртөө засах эрх ба хүн ам зүй . . . . . 464
Хэл, боловсрол, соёл . . . . . 475
Байгаль орчны байдал . . . . . 481
Эдийн засаг . . . . . 486
Цэрэгжилт . . . . . 493
Амьдралын түвшин ба эрүүлийг хамгаалалт . . . . . 495
11. Түвд орон хятадын салшгүй хэсэг мөн үү? . . . . . 499
Олон улсын эрх зүй болон хятадын уламжлал дахь төрт ёс . . . . . 499
Хятад ба “хятадын эзэнт улсуудын” тухай . . . . . 512
Хятадад үндэсний асуудлыг шийдвэрлэсэн нь . . . . . 532
Түвдийн статус: түүхэн өнгөрсөн үе . . . . . 544
12. Түвд-монголын соёл иргэншил бөхөж байгаа юу? . . . . . 572
Тайлбар . . . . . 581
Ашигласан ном зохиол . . . . . 625

# Оршил үг

Эрхэм уншигчид танаа!

Би, С.Л. Кузьмины урьд орос хэлээр хэвлэгдсэн, удахгүй англи хэл дээр орчуулагдан гарах гэж байгаа «Нууц Түвд Орон» номыг өнөөдөр монгол хэл дээр хэвлэгдэж буйг толилуулан танилцуулж байгаадаа тун их баяртай байна.

Монгол, Түвд хоёр оронг эртний үеэс түүх, улс төрийн болон шажны нягт харилцаа холбодог. Бид энэ номыг хэн нэгэн хүний улс төр, түүхийн мэдлэг төсөөллийг өөрчлөх гэж хэвлэж байгаа бус, олон түмэн ардад жинхэнэ үнэн баримтыг нээх гэж хичээн өргөн барьж байгаа юм.

Доктор С.Л. Кузьмин гарамгай их гүнзгий судалгааг явуулан гүйцэтгэсэн байна.Тэр энэ номонд түвдийн болон монголын ард түмэнд, юуны өмнө эрх чөлөө, үнэн шударга байдалд хандах өөрийн гүн сэтгэлийг илэрхийлжээ.

Энэхүү ном монгол хэл дээр хэвлэгдэн гарч байгаа нь бас нэг эрхэм зүйл бөгөөд түүний зарим нэг бүлэг бие даасан тусгаар Монгол ба Түвд улсуудын хоорондох харилцаанд зориулагдсан нь маш чухал юм.

Хорьдугаар зуунд хоёр улс – хэв заншил болон тогтсон улс төрийн төдийгүй шашин соёлын суурийг эвдлүүлсэн адилхан гашуун зовлонд нэрвэгдсэн билээ. Хоёр орны хувь тавиланд аймшигт зовлон оногдсон тул би өөрийн амьдралын өдөр тутам дарангуйлан захирагч дэглэмийн доор гашуун бэрх бүхнийг дахин амсан туулахгүй байхын төлөө залбиран мөргөдөг юм.

Түвд, Монголын ард түмэнд бие биедээ тухайн цаг үеийн үйл явдлаас дурсан харилцан ярилцах олон зүйл бий гэж надад санагдана. Үүний тулд бие биеийг тус бүртээ харилцан сонсож, суралцахын зэрэгцээ эрдэм мэдлэгийг эзэмших хэрэгтэй буюу. Эрдмийн хамгийн гол үндэс нь ном байдаг. Уг номыг уншигч абугай бүр улс төрийн хувиралтын эргүүлэгт шурган орохоос гадна өөрийн биеэр монгол ба түвдийн ард түмний гүн сэтгэхүйн арга маяг, амьдрал ахуйн төлөвтэй танилцах буй за.

Тавдугаар Далай ламын үед Түвдийн амьдралд монголын ард түмэн оролцоогүй бол түвдийн төр улс байгаагүй гэдэг болон түвдчүүдийн оролцоо нэмэргүйгээр Монголд бурханы шашин дэлгэрэнгүй хөгжлийг олоогүй байх гэдэг нь одоо тов тодорхой мэдэгдэж байгаа билээ.

Тус хоёр улс нь – ихэр ах дүү ард түмэн билээ. Тэдгээр нь амьдралын ижил гашуун бэрхийг даван туулсан бөгөөд одоо манай монголчуудад өөрсдийн онцлог туршлага дээр тулгуурлан түвдийн ард олонд эрх чөлөө, ардчилалын замыг заах өвөрмөц үүрэг оногдож байгаа цаг ирлээ. Гэвч үүнийг гүйцэтгэж чадахын тулд түүхийг, эхлээд энэхүү «Нууц Түвд Орон» гайхамшигт номын тусламжтайгаар эргэн судлах аялал хийвэл зүгээр болов уу.

Тэло Тулку Ринбүүчи
Монголд Дилав хутагт алдартай
халимаг ардын Шаджин лам
«Түвдийг хадгалж үлдье» сангийн Шажны дарга

# Өмнөтгөл

Түвд бол өнөөг хүртэл манай гаригийн хамгийн нууцлагдмал газар нутгийн нэг хэвээр байна. Түвдчүүдийн түүх, шашин, зан заншилд өөр соёл иргэншлийн хүнд амархан ойлгогдохооргүй тийм олон зүйл бий. Тус орны олон зуун жилийн тусгаарлагдмал байдал, түүний улс төрийн систем, олон улсын харилцааны өвөрмөц онцлогоос болж, харин сүүлийн хэдэн арван жилд бас хятадын суртал нэвтрүүлгийн улмаас түвдийн түүхийн зарим талуудын тухай олон зүйл тодорхой бус байна. Хэрэв Түвд ямагт Хятадын салшгүй хэсэг байсан юм бол яагаад одоо Хятад шиг болоогүй юм бэ? Түвдчүүдийн байнгын тэмцэл хөдөлгөөн юу вэ – салан тусгаарлах үзэл үү, аль эсвэл үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн үү?

Манай оронд Октябрын хувьсгалаас хойш Түвдийн сүүлийн хагас зуун жилийн үйл явдлуудыг мэдээлэх явдал хэд хэдэн үе шат дамжиж иржээ. Эхлээд тэнд Хятадын Коммунист Намын хийж буй ажлыг ямар ч эргэлзээгүй магтан дуулж, түүнийг эсэргүүцэгчдийн бүх үйлдлийг империализмын өдөөн хатгалага хэмээн тайлбарлаж байлаа.[1] Дараа нь Н.С. Хрущевийн үед БНХАУ-тай харилцаа муудсанаас хойш шүүмжлэлийн үе эхэлсэн билээ. Маогийнхан «марксизмыг мушгин гуйвуулж» байгаад гол үндсэн анхаарал хандуулах болов. Гэхдээ зарим бүтээл түүхийн үнэт мэдээллийн эх сурвалж болсон юм.[2]

ЗСБНХУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болох үед олон ургалч үзэл бий болов. Орост Мао Зедун болон хятадын шинэчлэгчдийг бишрэн магтахаас эхлээд хүний эрх хамгаалах үзэл бодлын үүднээс тэднийг няцаах хүртэлх янз бүрийн үзэл бодол гарч ирэв. Сүүлийн үед энэ чиг хандлага хүчээ авч, алагчлахгүй үзэх хандлага улам бага болж байна. «Зогсонги» үеийн нийтлэл ч ховор үзэгдэл болжээ. Энэ нь цаг үеийн хувьд Түвдийн

тухай суртал нэвтрүүлгийг ялангуяа хилийн чанадад хүчтэй болгохоор БНХАУ-д шийдвэрлэсэнтэй давхцаж байгаа юм.[3] Тусгайлан сонгож авсан Хятадын түвдчүүд болон Түвд судлаачдын элдэв төрлийн аялал, гадаадын сэтгүүлчдийн Түвдэд хийлгэх аялал, үзэсгэлэн, нийтлэл, Интернет-сайт зэргийг зохион байгуулж байна. Хятадын эрх баригчдын байр суурийг ул үндэстэй болгох зорилготой баримт сэлтийг нийтлэх болж, харин энэхүү байр суурьт харшилсан баримт бичгүүдийн талаар таг дуугүй суух болов. Зүүний чиг хандлагатай гадаадын суртал нэвтрүүлэгчдийн идэвхи дээшлэв.[4]

Хятадын эрх баригчид болон түвдийн цагаач иргэд бараг 50 жилийн турш англи, орос зэрэг гадаад хэлээр олон материал хэвлэн гаргаж байна. Тэд иим аргаар хамгийн хүчтэй хэмээн үзсэн учир шалтгаануудаа амилуулж байгаа нь тодорхой билээ. Хоёр талын гаргаж ирж буй мэдээллүүдийн аль нь үнэн зөв болохыг тэр болгон шалган тогтоож болохгүй байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй юм. Бие даасан шинжээчдийн комиссийн тусламжтайгаар л нарийн зөв шалгалт хийх боломжтой ч хятадын эрх баригчид тэднийг одоохондоо улс орондоо оруулахгүй байна.

Түвдийн түүхийн тухайд бол түүнийг нэг бус удаа дүрслэн бичиж байсан бөгөөд чанартай сайн олон тойм, баримт бичиг, судалгааны ажлын нийтлэл гарч тэдгээрт түвдийн түүхийн асуудлаар нарийвчилсан дүн шинжилгээ хийгдсээр байна. Тэдгээрээс гол, гол бүтээлийг энэхүү номын төгсгөлд хавсаргасан ном, зохиолын жагсаалтад оруулав. Эдгээрийг энд давтах нь илүүц хэмээн үзлээ. Түвд гэж юу вэ? Бие даасан орон байсан уу, аль эсвэл бусад орны салшгүй хэсэг байсан уу? Түвдийн асуудлаар орчин үеийн хятадын баримталж буй байр суурийн үндэс хаана байна вэ? Түвдийг БНХАУ-ын бүрэлдэхүүнд оруулсан нь хэр зэрэг маргашгүй зүйл вэ, хятадын шинэтгэл түвдийн ард түмэнд юу авчирсан бэ? Энэ тухай түвдчүүд юу боддог вэ? зэрэг улиглал мэт санагдаж болох асуултуудад хариулахын тулд дээр дурдсан мэдээллүүдийг харьцуулан үзэж, нэгтгэж дүгнэх нь сонирхолтой байх биз ээ. Энэхүү номонд янз бүрийн, тэр дундаа эсрэг тэсрэг үзэл бодлыг харьцуулах замаар эдгээр асуултад хариулах зорилт тавьлаа. Бүлэг 1–10-т түүхэн баримтууд оруулж, бүлэг 11-д тэдгээрт янз бүрийн үеийн олон улсын харилцааны хүрээнд дүн шинжилгээ хийлээ.

Хятад, Түвд хэлээр гарсан түүхэн баримтуудад нарийвчилсан дүн шинжилгээ хийх биш, харин орчин үеийн шатан дахь янз бүрийн салбарын шинжилгээ судалгааг нэгтгэн дүгнэх явдал энэхүү номын зорилго юм.Үүнтэй уялдан гол төлөв олон тооны мэдээллийн эх булагуудыг нэг бүрчилэн тоочиж, дүн шинжилгээ хийсэн тойм хэлбэрийн нийтлэлүүдийг

ашигласан болно. Түүний зэрэгцээ номонд тийм ч их тодорхой биш бөгөөд өнөөг хүртэл нийтлэгдэж байгаагүй мэдээллүүдийг ашиглалаа. Ишлэлийг хашилтад (“ “) авч, нэг өгүүлбэрийн хүрээнд зарим үг алгасаж явсныг олон цэгээр, нэг буюу хэд хэдэн өгүүлбэр буюу бүтэн утга санаа алгассан бол хэдэн өгүүлбэр буюу бүтэн утга санаа алгассанаас үл шалтгаалан <…> ээр тэмдэглэлээ.

Энэ номыг гадны санхүүгийн дэмжлэггүйгээр, зохиогчийн хувийн санаачлагаар бичсэн болно. Гэрэл болон гар зураг, мэдээлэл, зөвлөлгөө өгч энэ ажилд тусласан, энэхүү номыг хэлэлцэхэд оролцсон бүх хүнд зохиогч чин сэтгэлээс талархал илэрхийлж байна.

Бүлэг 1

# Түвдчүүдийн газар зүй ба гарал үүсэл

Азийн төвд орших түвдийн өндөрлөг бол дэлхийн хамгийн том бөгөөд өндөр өндөрлөгүүдийн нэг мөн. Түүний талбай 2 сая 200 мянган ам дөрвөлжин километр. Түүний үлэмж хэсэг далайн түвшнээс 3–4 мянган метрийн өндөрт байна. Уулсынх нь өндөр 5–7 мянган метрт хүрнэ. Өндөр уулсын оргил цас, мөсөн голоор хучигджээ. Тиймээс Түвдийг ихэвчлэн цаст уулсын Орон хэмээн нэрлэдэг билээ. Энд, Түвд, Балбын хил дээр дэлхийн хамгийн өндөр уул – Жомолунгма (Эверест) байх агаад түүний өндөр 8848 метр. Түвд, Балба болон энэтхэгийн Сикким муж улсын хил дээр өөр нэг өндөр уул Канченжанга – 8598 метр байна. Түвдийг Кайлас, Цари, Ярлха Шамбо, Чомо Кэнрег, Канкар Шаме, Ньянчен Тангла, Мачен Помра (Амне Мачен) зэрэг олон өндөр уулс сувдан сондор мэт хүрээлэн оршино. Мөсөн голууд 105 мянган ам дөрвөлжин километр асар уудам талбайг бүрхжээ.

Инд, Брахмапутра, Меконг, Сатлеж, Салуин, Шар мөрөн, Хөх мөрөн зэрэг Азийн аугаа их гол мөрд Түвдээс эх аван урсана. Түвдээс эх аван урсдаг гол мөрдийн сав газрын нийт талбай 5477700 ам дөрвөлжин километрт хүрэх бөгөөд зөвхөн Хятадын цэнгэг усны 30 хувь түвдээс эх аван урсдаг гол мөрдөд оногдоно.[5] Түвд баруун талаас Каракорумын, хойд талаас Куньлуны, Наньшаны өндөр уулсын систем, өмнө талаас Гималайн уулс, Баян харын нуруунууд ба Сычуаны Альп хэмээх нуруугаар тус тус хүрээлэгджээ. Өргөрөгийн чиглэлд түвдийн тэгш өндөрлөгийг Кайлас, Ньенчен-Танглхын уулс хөндлөн огтолж байгаа юм. Түвдийн тэгш өндөрлөгийн барагцаалбал гуравны хоёрыг гол төлөв 5 мянган метрийн өндөрт байрлах Чантангийн өндөрлөг газар эзэлдэг байна. Энэ бол гол төлөв хатуу ширүүн уур амьсгалтай чулуурхаг цөл газар юм. Зүүн хойд

талаас Хөх нуурын өндөрлөг газар түрэн орж ирнэ. Эд бүгд нийлж Хөх нуур – Төвдийн өндөрлөг газрыг бүрдүүлдэг байна. Төвдийн умард нутаг уулын нугаар хучигджээ. Энд малын сайн бэлчээртэй, олон гол, нууртай, эх газрын хатуу ширүүн уур амьсгалтай. Өмнө зүгт уур амьсгал аядуу болж, хур тундас их унана. Энд шигүү ой мод ургаж, үржил шимт газруудыг боловсруулж, жимс, жимсгэний мод тарьж ургуулдаг байна.

Төвдийг хэд хэдэн мужид хувааж ирсэн түүхтэй билээ. Түүний төв хэсэг буюу Бод (bod: Төвд аялгаар “Пё” гэж дуудагдана”) муж Кайлас уулын дэргэдэх Манасаровар нуур, Тисе голоос эхэлж, Цангпо (Брахмапутра) голын дагуу үргэлжилнэ. Төвдчүүд эх орноо Бод, өөрсдийгөө бодпа хэмээн нэрлэнэ.Эдгээр нэр хэзээ, хэрхэн үүссэн нь тодорхой бус ажээ. Зарим судлаач “Бод” гэдэг нь “эх орон” буюу” үүссэн газар” гэсэн үг хэмээн үздэг.

Төвд гэдэг нэр анх удаа Монгол улсын Орхон голын хөндийн эртний түрэгийн бичээснээс олджээ. Монголд оршин сууж байсан эртний ард түмнүүдээс бусад хэл, тухайлбал тай хэлэнд “Тибет”, араб хэлэнд “Туббат” болж орсон бололтой юм. Орчин цагийн монгол хэлэнд “Төвд” хэмээн дуудагдана. Энэ нэр Туфа хэмээх от гоос үүсч гарсан байж болох талтай бөгөөд энэ отгоос Ярлунгийн эзэнт улсын хаадын нэг гарсан ажээ. Хятадын эртний “Туфа” гэдэг нэрийг ч энэ отогтой холбон үздэг юм байна. Одоогийн Төвд хэл сино-төвдийн (буюу одоо БНХАУ-д бичдэгээр хан-төвдийн) хэлний бүлгийн төвд-бирмийн салбарт хамаарна. Сино-төвдийн хэлний бүлэгт Төвд хэл Умард Энэтхэг болон Зүүн Өмнөд Азийн зарим ард түмний хэлтэй хамт ангилагддаг бол хятад хэл бие даасан ангилал болдог ажээ.[6] Төвдийн янз бүрийн омог янз бүрийн аялгаар ярина. Бичиг үсэгтэй болсноос хойш тэрхүү бичгийн хэл төвдийн бүх овог аймгийн хувьд нэгдмэл хэл болж, цомтгох чухал үүрэг гүйцэтгэжээ.

Газар зүйн Бод муж У ба Цанг гэсэн хоёр хэсэгт хуваагдана. Төвдчүүд энэ хоёрыг У-Цанг хэмээх нэг хязгаарт нэгтгэн авч үздэг. Тус хязгаар баруун зүгт Нгари – Корсумаас Согла Кьяо хүртэл үргэлжилнэ.[7] Цанг баруун хэсгийг эзэлдэг байна. Энд Шигазе, Гьянзе зэрэг томоохон хотууд оршино. У нь зүүн хэсэгт оршино. Энд Кийчу голын цутгалан Цангпогийн эрэгт Лхас хот байна. Эндхийн уур амьсгал харьцангуй аядуу учир газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой. Төвдчүүдийн хамгийн дуртай хөдөө аж ахуйн ургамал бол бусад ургамал тариалахад бэрхшээлтэй нилээд өндөрлөг газарт ч (4 мянган метр хүртэлх) сайн ургац өгдөг арвай ажээ. Арвай нь төмөр ихтэй учир цус багадах, хавагнах болон уушигны элдэв өвчнөөс сэргийлнэ. Энэ бүхэн нь хүчилтөрөгч багатай, нэг янзын хоол хүнстэй өндөр уулын

нөхцөлд чухал ач холбогдолтой юм. Арвайгаар түвдийн уламжлалт хоол цампуг хийдэг бөгөөд энэ бол арвайн гурилыг халуун ус буюу сүүнд тос хийж зуураад хайрсан нэгэн төрлийн бин юм.Өндөр уулын нөхцөлд сарлаг өсгөж, түүний мах, сүү, хөөвөр, савагийг ашиглана. Сарлаг маш тэсвэртэй, тэжээл их шаардахгүй, уулын нөхцөл, өвлийн хүйтнийг сайн тэсвэрлэнэ. Сарлагийг мөн уналга, ачилгад ашиглана.

Түвдийн зүүн хэсэг бол түүхэн муж Кам, зүүн хойд хэсэг нь Амдо муж. Кам муж Согла Кьяогоос Мачу голын эргэлт (Хуанхэ мөрний дээд бие) хүртэл үргэлжилнэ. Энэ эргэлтээс Цагаан суварга хүртэл Амдо муж оршино. Энэ бол Түвдийн зүүн – хойд хил мөн. Энэ хоёр муж малын сайхан бэлчээртэй, тал хөндийд нь газар тариалан хөгжсөн, уулсын хажуу ой модоор хучигджээ. Баруун өмнөд хэсэгт Ладак муж (Ба түвд) оршино. Түүний үлэмж хэсэг жижгэвтэр уулс, ой модоор хучигджээ.

Одоо түүхэн Түвдийг авч үзье. Энэ бол зөвхөн өндөр уулс, амьдралгүй шахам тэгш өндөрлөг биш билээ. Түүний нийт талбай түвдийн тэгш өндөрлөгийнхөөс хавьгүй их – 3 сая 800 мянган ам дөрвөлжин километр. Шилдэг шашин У-Цангад, шилдэг хүмүүс Камд, шилдэг адуу Амдод гэж түвдчүүд ярьдаг.[8] У-Цангийн оршин суугчид маш их сүсэг бишрэлтэй, Камынхан сайн дайчид, Амдод сайн үйлдвэр худалдаа эрхлэгчид байдаг учраас иймхүү хэлэлцдэг ажээ. Түүхэн гурван муж: У-Цанг (Нгарийг оролцуулж), Кам, Амдог түвдчүүд мөн Гурван Муж хэмээн нэрлэдэг ажээ. Өөрөөр энэ нутаг дэвсгэрийг Их Түвд хэмээн нэрлэдэг байна. Энэ нутаг дэвсгэрийг бүхэлд нь БНХАУ-д нэгтгэжээ. Өнөөгийн байдлаар БНХАУ-д түвдийн нутаг дэвсгэрийн засаг захиргааны дараахь хувиарлалт хүчин төгөлдөр үйлчилж байна. У-Цангийг үндсэнд нь Түвдийн өөртөө засах орон болгожээ. Камыг Түвдийн өөртөө засах орон, хятадын Сычуань, Юньнань, Хөх нуур (Цинхай) мужуудад, Амдог Хөх нуур, Ганьсу мужуудад тус тус хуваажээ. Хятадын мужуудад түвдийн дараах өөртөө засах нэгжүүд байна. Хөх нуур муж: Монгол-түвдийн Хайси (түвдээр Цонуб) тойрог, түвдийн Юйшу, Хайнань (Цолхо), Хайбэй (Цожанг), Хуанань (Малхо), Голо (Голок) тойрог, Ганьсу муж: түвдийн Тяньжу (Пари) гацаа, Ганьнань тойрог, Сычуань муж: Түвд-цяны Аба тойрог, түвдийн Ганьзы (Карзе) тойрог, Мули (Мили) гацаа, Юньнань муж: түвдийн Дацин (Дэчин) тойрог зэрэг болно.

Түвдчүүд гарал үүслийнхээ тухай янз бүрийн домог хүүрнэх ажээ. Тэд бусад олонхи ард түмний нэгэн адил гарал үүслээ янз бүрээр ойлгогддог элэнц өвөгтэйгээ холбон үздэг байна.[9] Эртний түвдийн бон шашны түүхэн бичвэрүүдэд эртний сав ертөнц, түүнд байх ахуйн орон зай – өндөгнөөс гарч




Түвд (http://perso.wanadoo.fr/tibetmap/tibet21.jpg, өөрчлөлтийн хамт):
1 – түүхэн хил: 2 – 1914, 1950 оны хоорондын хил: 3 – өнөөгийн засаг захиргааны хил.
Бичмэл үсгээр БНХАУ-ын орчин үеийн мужуудыг үзүүлэв




Түвдийн өнөөгийн засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарилалт

ирсэн амьтнаас үүссэн тухай хүүрнэл өргөн дэлгэрсэн байна.[10] Ертөнцийн гарал үүслийн тухай сургаальд анх түрүүчийн элементүүд үүсч, тэдгээрээс ертөнц болон эх болсон зургаан зүйл хамаг амьтны эхлэлийг тавьсан "анхдагч өндөг"үүсч гарсан хэмээн өгүүлдэг байна. Эртний түвдийн төсөөллөөр бол ертөнц нь тэнгэр (Нам), дэлхий (Бар),буюу "дунд"(Са), "доод"газар доорхи (Ог) тив хэмээн хуваагдана. Эдгээр хүрээг Лха, Лу, Цэн (буюу Ньен) бурхад хариуцдаг ажээ.[11]

Бон (бөмбөгийн) шашны хүлээн зөвшөөрсөн бөгөөд нарийвчлан боловсруулсан төсөөллөөр бол хүмүүс Ньен овогоос үүсчээ.[12] Эртний боны нэгэн шастирт арван найман мөгөөрсөн өндөгнөөс арван найман орон зайн том муж, тэнд оршин байх амьтан, тэр дундаас нэгэн дун – өндөгнөөс Шангшунг ба Түвд орны хүмүүсийн элэнцийн элэнц өвөг Менпэй Миво Лумлум үүсч гарсан хэмээн өгүүлжээ.

Шангшунг орон Баруун болон Умард Түвдэд байжээ. Түүний төв Тисе (Кайлас) уул, Мапам (Манасаровар) нуурын хавьд байсан хэмээн үздэг юм байна. Элэнцийн элэнцээс хойш хүмүүсийн олон төрөл гарч, тэдний халааг Дон, Дра, Дру ба Га хэмээх дөрвөн их (буюу Го төрөлтэй хамт таван) төрөл, түүнчилэн Вал, Да хэмээх хоёр төрөл авсан байна. Тэдгээрийг нийлүүлэн хүний зургаан (буюу долоон) омог гэж үздэг байна. Эдгээр омог бол түвдийн бүх овогийн элэнц ажээ. Дон болон Сен омогийн удмынхан аажимдаа өөр хоорондоо холилдон шангшунг – түвдийн угсааг үүсгэжээ.

Өөр нэг домгоор бол түвдчүүдийн гарал үүслийг бичтэй холбон үздэг нь Ч. Дарвины онолтой нийцэж байгаа ажээ. Энэ домогт өгүүлснээр эрт дээр цагт Түвдэд шулам, шулмас эмс л амьдарч байжээ.[13] Газар оронд хүмүүс суулгаж, тэднийг Буддагын сургаалийн түшиг тулгуур болгохын тулд бодьсад Жанрайсэгийн хувилгаан (өөр нэг хувилбараар бол түүний шавь сармагчин) дүрд хувилж, нэгэн шулам эмтэй нөхцжээ. Энэ гэр бүлээс түвдчүүд гарсан ажээ. Энэ бүхэн У-Цанг мужийн төвд орших Цетангаас холгүй газарт болсон байна.[14] Энэ домог нилээд эртний хууч ярианы буддын боловсруулалт байж болох талтай юм. Түвдчүүдийн хаан Ньяти Замба тэнгэрээс бууж ирсэн хэмээх домог ч бий ажээ.

Эдгээр домогийг Түвд орон бол дэлхийн төв хэмээх түвдийн уламжлалт төсөөллүүдтэй хамтатган авч үзвэл түвдчүүд бол Түвдийн өндөрлөгт гаднаас ирсэн биш, харин тэндхийн уугуул ард түмэн гэдэг үзлийг нотлон харуулж байна. Шинжлэх ухааны мэдээллүүд ч үүнийг нотолно. Гарвал зүйн (генетикийн) баримт мэдээллээр бол түвдчүүдийн өвөг дээдэс умард азийн ба сибирь гаралтай бөгөөд 18–22 мянган жилийн өмнө Түвдийн тэгш

өндөрлөгт хүн амьдарч байсан ул мөр олдсон тухай мэдээлэл ч бий.[15] Шинэ чулуун зэвсгийн зуун буюу неолитын эриний үеийн хүний амьдарч байсан газрууд хэдэн арваараа олджээ. Үүнээс нилээд эртний буюу эртний чулуун зэвсгийн үеийн (палеолит) ул мөрүүд ч олдсон байна.[16] Далайн түвшнээс 4 мянга гаруй метрийн өндөрт байрлах өндөр уулын районд ч хүн амьдарч байсан зарим ул мөр олджээ. Гурваас таван мянган жилийн тэртээ орчин үеийн Чамдо, Лхас хотуудын районд шинэ чулуун зэвсгийн үеийн өндөр хөгжсөн соёл байсан бөгөөд түүний түвшинг Хятадын энэ үеийн зарим соёлын түвшинтэй харьцуулан үзэж болох ажээ. Түвдийн оршин суугчид манай эриний 1-р зуунд төмөр хайлж сурчээ. Эдгээр соёлын төлөөлөгчид бол Түвдийн өндөрлөгт үүсч, хөгжсөн түвдийн ард түмний өвөг дээдэс мөн бололтой юм.

Манай ард түмэн энэтхэг үндэс язгууртай гэж түвдийн зарим эрдэмтэн үздэг.[17] Ямар нэгэн Рупати гэдэг нэртэй хаан буюу цэргийн жанжин энэтхэгийн “Махабхарат” туульд дүрслэн бичсэн Пандав, Каурав нарын хооронд болсон аугаа их дайнд оролцсон гэж дээрх эрдэмтэд үздэг. Тэр хаан буюу цэргийн жанжин Кауравчуудын талд тулалдаж, тэднийг ялагдсаны дараа өөрийнхөө талыг баримтлагчдын хамт Түвдэд зугатаж очжээ. Түвд хүмүүс иранчуудаас гарсан гэж үзэх эрдэмтэд ч байна. Хүн судлалын баримт мэдээллүүд үүнийг няцааж байгаа юм. Түвдчүүд монгол, япон, солонгос, хан үндэстнүүдтэй (хятад) хамт монголжуу (монголоид) арьстны зүүн азийн төрөлд хамаардаг байна.[18] Түвдчүүд болон хан үндэстнүүдийг нийтлэг өвөг дээдсээс нь салган авч үзэх явдал маш эртнээс, 5–6 мянган жилийн тэртээ үүссэн тухай мэдээлэл ч байдаг. Түвд хүмүүс монголчуудтай генетикийн нийтлэг үндэстэй гэж зарим судлаач үздэг ч бусад хүчтэй нөлөө,[19] магадгүй энэтхэгийн нөлөө байсан нь тодорхой билээ.

Түвдчүүд өндөр уулын нөхцөлд дасан зохицсон хосгүй чадвартай бөгөөд хүчилтөрөгч багатай ийм нөхцөлд дасаагүй хүмүүс уулын өвчинд нэрвэгдэх аюул байсан зэрэг нь хятадууд, түвдчүүд маш эрт дээр үеэс бие биеэсээ тусгаарлагдсаныг гэрчлэн харуулж байгаа юм. Энэхүү дасан зохицсон чадвар түвдчүүдэд өндөр уулын нөхцөлд суурьшин амьдрах давуу байдал олгожээ. Түвдчүүдийн цусны хүчилтөрөгчийн хангамж, жишээлэхэд хятадуудынхаас илүү өндөр байдгийг генетикийн үүднээс батлан тогтоожээ.[20] Түвдчүүд ойр ойрхон амьсгалдаг, тэдний биеийн эрхтнүүдэд хүчилтөрөгч хүргэдэг артерийн болон хялгасан судаснууд илүү өргөн байдаг нь уулын өвчнөөс сэргийлэх боломж бүрдүүлжээ.[21] Тэдний амьсгалаад гаргаж буй агаарт азотын ислийн агууламж илүү их

байдаг нь энэ бодис организмд эрчимтэй задардагтай холбоотой юм. Үүний дүнд өндөр уулын нөхцөлд уушигны судасууд өргөсөж, тэндхийн цусны эргэлт сайжирч, уушигны судасны даралтыг багасгаж, цусан бөөмлүүрийн (гемоглобин) исэлдэх чадварыг хүчтэй болгодог байна.[22] Энэ бүхэн нь бие организмыг хүчилтөрөгчөөр баяжуулж, уушигны үйл ажиллагааг сайжруулахад тус дөхөм үзүүлнэ.

Түвдчүүдийн организм өндөр уулын нөхцлийг тэндхийн уур амьсгалд дассан хятадуудынхаас илүү сайн тэсвэрлэдэг байна. Тухайлбал Түвдийн өндөрлөгт зүрхний цохилтын цахилгаан зургийн (ЗЦЗ) гажилтын давтамж шилжин суурьшсан хядадуудад (бага залуу насандаа тийшээ очиж суурьшсан хүмүүс ч ялгаагүй) Түвд оршин суугчдынхаас их байна.[23] Оршин суух газар өндөрсөхийн хэрээр хятад эрчүүдэд энэ үндэсний эмэгтэйчүүдийг бодоход цусан бөөмлүүрийн(гемоглобин) төвлөрөл илүү хүчтэй нэмэгддэг бол түвдчүүдэд ийм зүйл гарахгүй.[24] Дөнгөж төрсөн хятад хүүхэд түвдчүүдийг бодоход уулын өвчин тусах нь амархан байдаг.[25] Нас баралтын хувьд ч мөн иймэрхүү ялгаа гарна. Өндөр уулын нөхцөлтэй холбоотой амьсгалуурын шинж чанараар бол Түвд бүсгүйгээс төрсөн хятад эцгийн үр удам цэвэр хятадууд болон түвдчүүдийн дунд завсрын байрлал эзэлдэг байна.[26] Ингэхлээр тэрхүү үр удам өндөр уулын нөхцөлд хятадуудаас илүү, харин түвдчүүдээс дутуу дасан зохицсон байдаг ажээ. Гэвч хятад эр, Түвд бүсгүйн холимог гэр бүл тун ховор юм.

Энэ онцлог байдал бол хятадууд (хан үндэстнүүд) Түвдийн өндөр уулын нутгийг амжилттай колончилж чаддаггүй бол намхавтар газар байдаг түвдийн нутгуудад олноороо ирж суурьшсаны нэг шалтгаан мөн.

Энэ бүхэн нь түвдчүүд эрт дээр үеэс бүрэн тусгаарлагдмал байдалд аж төрж иржээ гэсэн үг бишээ. Хуучны судлалын баримт мэдээгээр бол зүүн умард зүгээс Түвдэд ирж суурьшсан хамгийн эртний хүмүүс бол цянууд буюу Түвд – бирмийн бүлгийн ард түмэн ажээ.[27] Түвдчүүдийн өвөг дээдэс байж болох бусад ард түмэн бол монууд (Энэтхэг хятадын хойгийн эртний ард түмнүүдийн нэг бүлэг), түүнчилэн энэтхэг – европ гаралтай омгууд юм.[28] Цянуудад ч хамаатуулж болох монголорхуу аймгууд ч тодорхой нөлөө үзүүлсэн байж болох билээ.Монууд түвдчүүд болон хятадуудад уусчээ. Цянууд наад зах нь гэхэд манай эриний өмнөх хоёрдахь мянган жилээс эртний хятадын Шан-Инь улстай хөрш зэргэлдээ оршиж байсан тухай мэдээ бий. Цянууд иньчүүдтэй худалдааны хэлхээ холбоо тогтоож, өөр хоорондоо төрөл садан болж, бас дайтаж байжээ. Тэд иньчүүдэд алба гувчуур төлдөг байв. Иньчүүд цян нараар овоо, туг тахиж, Шан-Иньд олон

тооны цян – боол байжээ. Нөгөө талаас хоёр ард түмний дээд ангийнхан хоорондоо ураг барилдаж, Эртний хятадын дээд зиндааны овогийнхны нэг Зянууд цян гаралтай ажээ.

Цянууд болон түвдчүүд генетикийн (гарвал зүйн) холбоотойг тодруулж чадаагүй байна. Нэг хэсэг судлаач цянуудыг түвдчүүдийн өвөг хэмээн үздэг бол бусад зарим нь эсрэгээр тайлбарладаг ажээ. Ямар ч байсан энэ л үед хятадын бичмэл түүхэнд Түвд–бирмийн ард түмний өвөг дээдэс хятадуудын өвөг дээдэстэй анхны хэлхээ холбоо тогтоож байсан тухай мэдээлэл орж эхэлсэн байна. Цянууд таван мянган жилийн өмнө сарлагийг гэрийн тэжээмэл амьтан болгож, сарлаг тэдний хувьд сэтэртэй мал болж, сарлагтай холбоотой олон домог, мухар сүсгийн яриа байдаг ажээ.[29]

Манай эриний эхний зуунуудад цянууд Хөх нуур орчмын монголчуудын өвөг дээдэс байх магадлалтай нүүдэлчин аймаг буюу сянби нарын мэдэлд оржээ.[30] Энэ бол түвдчүүд болон монголчуудын өвөг дээдсийн хамгийн эртний хэлхээ холбооны нэг байсан бөгөөд хожим нь энэ холбооноос улбаалан нийтлэг нэг соёл иргэншил үүссэн байна.

Тийнхүү угсаатны зүйн хувьд түвд, хятадууд маш эрт цагт тусгаарлагдсан ажээ. Эхний үед тэд ураг төрөл болж байсан хэдий ч тэдний цаашдын хөгжил янз бүрийн нөхцөлд үргэлжилж, соёлынх нь орчин ч өөр өөр байжээ.[31] Тэр үеэс Түвд, Хятад улс хоёр өөр соёл иргэншлийн хувьд хөгжиж, хэн нь ч нөгөөгийнхөө нэг хэсэг болоогүй ажээ.

Бүлэг 2

# Эртний ба дундад зууны үе

Бусад олон ард түмний нэгэн адил түвдчүүд ихэс дээдсийнхээ төр улсыг тэнгэр бурхантай зүйрлэн үзэж иржээ. Эртний Ча (шувуу) омгийг Тэнгэртэй холбон үзжээ.[32] Тэр омгийн өргөө – Юмбулаган шилтгээнийг Ярлун болон Дарпо голууд нийлдэг Ярлунгийн хөндийд босгожээ. Энэ газар Лхасаас зүүн урагш байна. Энд бодьсад болон эм шуламын гэр бүлээс түвдчүүдийн өвөг гарсан хэмээх домог бий.

Ча-гийн угсаа тасарсны дараа хүмүүсийг захирах гэж газарт бууж ирсэн Лха тэнгэрийн хүү хэмээгддэг Ньяти Замба хаан Ярлунгийн засгийн эрхэнд гарчээ. Тэрээр Ярлунгийн хаант улсыг (хятад зохиогчид энэ улсыг Тубо буюу түвдийн хэмээн нэрлэдэг) үндэслэжээ. Ньяти Замба тэнгэрээс шатаар бууж ирсэн гэдэг домог байдаг ажээ. Тэрээр жирийн хүмүүсээс эрс ялгаатай: аньсага нь шувууных шиг хаагддаг, оюу хөмсөгтэй, сахал нь барынх шиг, шүд нь дун цагаан, хөл, гарынх нь хуруу усны шувууных шиг сарьсан хальсаар холбогджээ. Түвдэд бурханы шашин хөгжих үед үүссэн өөр нэг уламжлалаар бол энэ орны эртний хаад өнөөгийн энэтхэгийн Бихар муж улсын нутаг дэвсгэрт аж төрөн сууж байсан хүмүүсээс гарвалтай ажээ.[33]

Тэр хаан тэнгэрийн их хүчтэй байсан бөгөөд түүнийг бон шашны лам нар хамгаалж байсан хэмээн үздэг ажээ.[34] Хааныг ширээндээ залрахад түүний баруун талд бон шашны лам, зүүн талд төрийн сайд сууна. Тэр хоёр хүн төр удирдахад оролцоно. Газар дэлхийд хааны гүйцэтгэх гол зорилго хүмүүсийг үймээн самуун, гадныг дайснаас хамгаалах явдал ажээ. Хааны тэнгэр гарал нь газрын хүч болон үхэгсдийн ертөнцийг мэдэлдээ оруулж, амьд бүхнийг түүнээс хамгаалах боломж олгожээ. Эндээс түвдийн хааны «тулку лха-цэнпо»буюу»амилсан бурхан-хаан» хэмээх цол үүдэн гарчээ. Эхлээд засгийн эрх бага хүүд, дараа нь том хүүд нь шилжсэн, том хүүгээ насанд хүрэхэд хаан жанч халах ёстой гэсэн мэдээ ч байдаг ажээ. Хаан

өвдсөн нөхцөлд ч мөн ингэх ёстой гэнэ. Эхний хаад тун залуудаа насан өөд болжээ. Нас барсан хааны шарилыг зэс саванд хийж, голын усанд хаях бөгөөд тэрхүү цогцос Лу тэнгэрийн ивээлд орж, эргэж төрөх ёстой ажээ. Хожим нь энэ ёслолыг шарил занданшуулж, дараа нь оршуулах (нас барснаас хойшхи гуравдахь жилд) тун ярвигтай үйлдлээр сольсон байна. Эрт цагт бусад олон ард түмний нэгэн адил түвдчүүд ч хааныг нас барахад түүний агт морьд, эхний үед шадар түшмэд, хожим нь гвардийнхан болон боолуудыг хороож, хамт оршуулдаг байв.

Дараа нь хүнээр тахилга үйлдэхийг хоригложээ. Боолууд болон гвардийнхан хааны бунханы хавьд үлдэн амьдарч, түүнийг хамгаалж, эвдэрч гэмтсэн хэсгийг засч янзалдаг байна. Гэхдээ тэдэнд бусад хүнтэй хэлхээ холбоо тогтоохыг хориглож, тэднийг «амьд хүүр» хэмээн нэрлэдэг байв.

Ярлунгийн хаант улс барагцаалбал манай эриний өмнөх 95 оноос манай эриний 846 он хүртэл түвдийн өндөрлөгийн зүүн өмнөд хэсэгт Ярлунг, Ньянгпо, Конгпо, Пово мужуудыг захирахад нийт 42 хаан ээлж дараалан суужээ.[35] Тэдгээрийн намтарт ер бусын шинж чанаруудын (Тэнгэртэй харьцдаг байсан, ер бусын байдлаар төрж мэндэлсэн гэх мэт) тухай олон мэдээлэл байдаг юм. Эдгээр мэдээллийн зарим нь дундад зууны үеийн монголын хаад, вангуудын намтрын зарим үйл явдлуудтай төстэй байгаа нь хожим түвд-монголын соёл иргэншлийг төлөвшүүлэн бий болгосон ард түмнүүдийн зан заншил адил төстэй байснаас болсон бизээ. Европт Ярлунгийн эзэнт гүрний тухай анхны мэдээлэл Клавдий Птолемейн “Газар зүй” хэмээх бүтээлд орсон байна. Энэ орныг уг номонд “Батаи” (бод гэсэн Түвд үгээс) гэж тэмдэглэсэн байна.

Ярлунгийн эзэнт гүрний нилээд эртний түүх гол төлөв эртний түвдийн домог яриагаар л илэрхийлэгдэж ирсэн бөгөөд тэнд олон төрлийн домог яригддаг. Дээр дурдсан хаадын хэн нь бодит хүн, хэн нь домог байсан тухай асуудлыг өнөөдөр ч эрдэмтдийн хүрээнд шүүн хэлэлцэж байна. Гэсэн хэдий ч хүрэл болон төмөр зэвсгийн үеэс гарвал үүсэлтэй Ярлунгийн хаант улс түвдийн ард түмнийг төлөвшүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой билээ. Ньяти Замба болон түүний дараачийн зургаан хаан насан өөд болохдоо “тэнгэрийн дүүжин шатаар” тэнгэртээ буцсан учир тэдний шарил хаана оршуулагдсан нь тодорхой бус байдаг хэмээх домог ч бий ажээ.[36] Найм дахь хааны шарил У-Цангийн Конгпод бий. Тэрээр “тэнгэрийн дүүжин шатыг” санамсаргүй огтолсон учир тэнгэртээ буцаж чадаагүй гэсэн домог байдаг. Энэ хааныг Дигум Замба гэдэг байжээ.



1



2



3

Юмбулаган цайз:
1 – 1938 – 1939 онд (Bundesarchiv, Bild 135-KB-06-088/Foto: Ernst Krause / License CC-BY-SA 3.0); 2 – Соёлын хувьсгалын үед эвдэрч сүйдсэний дараа (DIIR Archive, Central Tibetan Administration); 3 – 2005 онд (photo: Kyra/Creative Commons License)

Монголын түүхч Саган Цэцэн монголын аугаа их хаадын угсаа Ярлунгийн эзэнт улсаас гарвалтай хэмээн бичжээ. Жати Замба хааны бага хүү эцгийгээ нэгэн сайддаа алагдсаны дараа Байгал нуур болон Бурхан Халдун уулаас холгүй орших беде ард түмний нутагт зугтаж очжээ гэж тэрээр бичсэн байна.

Ярлунгийн эзэнт улсын үед өндөр хөгжсөн соёл иргэншил цэцэглэж, газар тариалан ба мал аж ахуй түүний гол үндэс болж байв.[37]

Хүн ам нь газар тариалан эрхлэгчид болон хотын оршин суугчид (тонде), нүүдэлчин малчид болон хагас нүүдэлчид (гонде) гэсэн хоёр үндсэн бүлэгт хуваагджээ. Тус улсын нутаг дэвсгэр өргөжиж байв. Цари Тагри Нинсан, Намри Соронзон (570–620) нар түвдчүүдийг нэгдмэл улсад нэгтгэхийн төлөө тэмцжээ. Намри Соронзоны нэг зуун мянган хүнтэй арми умар зүгт түрэгүүдийн эзэмшил газар, өмнө зүгт Төв Энэтхэг хүрчээ. Түүнийг засаг барьж байх үед бослого хөдөлгөөн ч гарч байв. Намри Соронзон нийслэл хотоо Ярлунгийн хөндийгөөс Кийчугийн хөндийд байх Раса (Хүрээлэгдсэн газар) хэмээх нэртэй сууринд шилжүүлэн аваачжээ. Дараачийн хаадын үед энд, Марпори уулан дээр хааны шилтгээн байгуулж, суурин Лхас (Бурхадын газар) хэмээн өөрчилж нэрлэсэн байна.

Манай эриний VII зуунд Түвд улс дэлхийн тавцанд гарч, богино хугацаанд Төв азийн нэг гол хүч болж байв. 613 онд (буюу 617) Намри Соронзонгийн хүү аугаа их Соронзон Гомбо хаан төрөв. Тэрээр 618 онд эзэн хаан Ли Юаний (засаглалын уриалал – У-дэ) байгуулсан хятадын Тан улс үүсэхээс өмнөхөн төржээ.[38] Энэ үед Түвд улс умар зүгт Танглагийн нуруу, өмнө зүгт гималайн уулс, өрнө зүгт Кайлас уул, дорно зүгт Дричу гол (Хөх мөрний дээд бие) хүртэлх газар нутгийг эзлэн оршиж байлаа.[39] Соронзон Гомбо төрт ёсоо бэхжүүлэхийг гол зорилтоо болгов. Түүний үед газар эзэмших, газар ашиглах систем боловсруулж, нутаг бүрт улсын мэдлийн газрын сан байгуулж, улс орныг зургаан мужид хувааж, мужийн удирдагчаар амбан захирагч нарыг томилж, газрыг зааглах арга хэмжээ авч, шинэ хууль тогтоомж боловсруулж, шинэ арми байгуулав.

Соронзон Гомбо хааны үед түвдэд бичиг үсэг бий болгов. Түвдэд бичиг үсэг бий болгох гэсэн таван удаагийн оролдлого үйлдсэн тухай Ю.Н. Рерих бичсэн байдаг.[40] Гэвч Тонми Самбхотагийн боловсруулсан систем нийтийн хүртээл болсон байна. 632 онд Соронзон Гомбо түүнийг Кашмир руу явуулав. Түвдийн ирээдүйн сайд энэ хүн энэтхэгийн эрдэмтдээр бичиг үсэг, хэл зүй заалгажээ. Тонми Самбхота Түвдэд буцаж ирээд энэтхэгийн тавин үсгийг түвдийн гучин гийгүүлэгч, дөрвөн эгшиг үсэг болгон засан



Соронзон Гомбо хаан (Chandra, 1999)

боловсруулжээ. Энэтхэгийн брахма, гупта бичгийг Түвд цагаан толгойн,[41] санскрит бичгийн тийн ялгалын системийг Түвд хэлний тийн ялгалын системийн[42] үндэс болгосон байна. Шангшунгийн орны системээс үүссэн бөгөөд урьд өмнө Түвдэд ашиглаж байсан хэлний зүйн системд хэрэглэхэд тохиромж муутай олон сул үг, өгүүлбэрийн бүрэлдэхүүн хэсгүүд байжээ. Тонми тэдгээрийн тоог эрс цөөрүүлж, хэлний зүйг илүү тохиромжтой болгосон байна. Түүний боловсруулсан бичгийн хэл, ярианы хэлний омгийн аялгийн ялгаанаас үл шалтгаалан бүх Түвд хүний хувьд нэгдмэл хэл болжээ.

Соронзон Гомбо дотоодод төр улсаа бэхжүүлэхийн зэрэгцээ Түвд болон түвд-бирм омгуудыг интеграцчилах, өөрөөр хэлбэл тэднийг үндэснийхээ уламжлалт хил хязгаарын хүрээнд нэгтгэхэд чиглэсэн идэвхтэй гадаад бодлого баримтлан явуулжээ. Мачу голын хөндий болон түүнээс урагш орших докпа нар (өнөөгийн голокуудын өвөг), Хөх нуурын ойролцоо (Амдо муж), Цайдамын зүүн хэсэгт орших панак омог, Танглагийн нуруунаас умар зүгт орших хорпа нарыг цэргийн хүчээр эрхэндээ оруулсан байна.[43] VII зууны эхний хагаст цян, сумпа, аша болон зүүн хойт түвдийн бусад аймгийг нэгтгэх ажил эхлэв.

634 онд түвдчүүд анх удаа монголчуудын өвөг гэгддэг сяньби аймгийн[44] улс болох Тугухуны хараат байсан тангадуудын өвөг дансян аймагт халджээ.[45] Энэ улс хятадын одоогийн Ганьсу, Хөх нуур, Сычуань муж, Шинжаан-Уйгурын өөртөө засах орны нутаг дэвсгэрийн үлэмж хэсгийг эзлэн оршиж байв.Үүнээс долоон жилийн өмнө хятадын Тан (618 он) улсын элч нар хилийнхээ мужуудыг халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор Тугухуньд ирсэн байна. Гэвч Тугухуны хаан хятадуудад итгэл үзүүлээгүй ажээ. Тэрээр “хэ цинь” – “найрамдал, ураг төрлийн тухай” гэрээ байгуулж, тан улсын гүнжийг хүүд нь эхнэр болгон явуулах санал тавьжээ.Түвдчүүд дансянуудад халдах жил Тан улс руу мөн элч илгээжээ. Үүний хариуд Фэн Дэця тэргүүтэй хятадын элч нар Лхаст ирэв. Түвдчүүд

Тугухунь болон Тан улсын харилцааны тухай мэдэж байсан учир хаандаа тан улсын гүнжийг хатан болгон авч өгөх хүсэлт тавьсан байна. Гэвч хятадууд түвдчүүдтэй биш сяньби, түрэгүүдтэй байлдаж байсан учир найрамдлын гэрээ байгуулах шалтгаангүй байв. Тиймээс Түвд рүү биш, харин Тугухунь болон түрэгүүдэд гүнж нараа илгээсэн байна. "Улаан түүх" хэмээх он дараалын бичигт тэмдэглэснээр бол түвдийн хаан арми явуулан гүнжийг хүчээр авч, Тан улсыг булаан эзлэхээ амалжээ. 638 оны есдүгээр сарын 12-нд түвдийн цэрэг дансян нарын суудаг Суйжоу (одоогийн Сычунь муж) тойрогт цөмрөн орж, Тан улсын нийслэл – Чанъань хотод түвдийн элч ирж, хятад газарт халдана хэмээн сүрдүүлжээ.

Ийнхүү гэрээ байгуулах шалтгаан үүссэн байна. 640 оны арван хоёрдугаар сард түвдийн сайд Тонцэн Юлсун 5 мянган лан мөнгө, хэдэн зуун алтан эдлэл барин Чанъаньд иржээ. Тэрээр дараа жилийнх нь гуравдугаар сард хятад гүнж Вэньчэнийг дагалдан Лхас орохоор хөдөлсөн байна. Лхас хүрэх аялал хэдэн жил үргэлжилж Вэньчэн гүнж 646 онд л Соронзон Гомбын хатан болжээ. Соронзон Гомбо бараг таван жил төр бариагүй бөгөөд энэ жилүүдэд Соронзон Гомбын Түвд эхнэр Монса Тичамаас төрсөн хүү (хаанд өөр хүү байгаагүй) Гүнсэн Гунцай төрийн хэрэг хөтлөн явуулсан байна.

Уламжлал ёсоор тэр 13 нас хүрч байж хаан ширээнд заларсан боловч 18-тайдаа насан өөд болсон учир Соронзон Гомбо дахин хаан ширээндээ заларсан байна. Соронзон Гомбо нөлөө бүхий зөвлөхтэйгээ тэмцэлдэх явцад эрх мэдлээ түр хугацаагаар алдсан боловч түүнийг ялж гарсан гэж судлаачид үздэг юм байна.

Вэньчэн гүнж цутгамал Будда бурхан, 10 мянга гаруй хуй хоргой, олон хайрцаг хятадын сонгодог ном зохиол, янз бүрийн технологийн ном, мөн янз бүрийн эд хэрэглэл авчирч, Юйтянь болон бусад газрын бурханы шашны лам нарыг Түвдэд авчирч, бурханы шашны сүм хийд байгуулах, ном судар орчуулахад тусалжээ.[46] Гэхдээ хааны анхны хатан Бхрикути гэдэг балба гүнж байжээ. Тэр бүсгүй Майдар бурхан Дарь эхийн зурмал хөрөг, цутгамал найман настай Будда бурхан авч ирсэн байна.[47] Соронзон Гомбо хаан Ляонигий зүүн хэсэгт ялалт байгуулсан Тан улсын эзэн хаан Ли Шиминьд (засаглалын уриалал – Чжэнь-гуан) баяр хүргэв. Тэрээр тухайн үеийнхээ ёс журмыг баримтлан Тан улсын эзэн хаан Дундад Иргэн Улсын бүх талыг байлдан эзэлснийг тэмдэглээд түүний эсрэг гаргасан бослого хөдөлгөөнийг бусадтай хамтран даран сөнөөх хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Хоёр хаан холбоотны харилцаатай байсныг энэ илгээлт гэрчлэн харуулна. Гэтэл зарим түүхч үүнээс: "Соронзон Гомбо Түвдийг Тан улсын орон нутгийн

засаг захиргааны мэдэлд орсон гэж үзэж байсныг эдгээр баримт гэрчлэн харуулна" гэсэн хачин дүгнэлт хийдэг юм.[48].

Түвдийн хаан хятад болон балба гүнж нарыг хатан болгож авч байсан нь улс төрийн чухал алхам байв. Гэхдээ хамгийн гол нь энэ хоёр гүнж түвдэд бурханы шашин хөгжүүлэхэд оюун ухааны хувь нэмэр оруулсан нь маргаангүй үнэн билээ. Түүнээс гадна энэ нь дээр дурдсан хоёр оронтой Түвдийн харилцааг үлэмж бэхжүүлсэн юм. Эндээс Түвд орон Хятад буюу Балбад захирагдах болсон хэмээх дүгнэлт хийж болохгүй. Гэхдээ түвдчүүд хятадын буянаар цаас, бэхтэй, магадгүй тээрмийн чулуу болон бусад зарим урлалтай танилцаж, хятадын засаг захиргааны системийн зарим шинж чанаруудыг уламжлан авчээ. Хятадын зохиогчдын адилаар түвдийн газар тариалан эрхлэлтийн үүслийг үүнтэй холбож үзэх нь буруу билээ.[49]

Тэр жилүүдэд түвдчүүд дээд Бирмийн зарим хэсэг, 640 онд Балбыг байлдан эзэлж тэнд хэдэн жил суусан байна.[50] Балбад томоос том шон босгож түүн дээр түвдийн хаанд алба гувчуур төлөх болсон тухай бичээс сийлжээ. Балбын цанг, лама, шерпа, таманг аймаг тус улсад ирж суурьшсан Түвд иргэдээс үүссэн юм.

643 онд шангшунгийн хаан Түвдэд дагаар оров. 645 онд хятадын эзэн хаан Умард энэтхэгийн нэг улсын хааны ордон руу элч илгээжээ. Элчийг очих үед хаан нас барьж, бурханы шашинд хүлцэлгүй сайд Арджуна хааны сэнтийд заларсан байв. Түүний тушаалаар хятад элч нарыг цаазалжээ. Төлөөлөгчдийн тэргүүн хэдхэн хүний хамт амь тэмцэн гарч Балбад очиж, Соронзон Гомбоос тусламж хүсэхэд хаан балба, түвдчүүдээс бүрдсэн цэргийг энэтхэг рүү явуулсан байна. Хятадын эзэн хаан Соронзон Гомбод маш их баярласан учир нас барсныхаа дараа шарилынхаа дэргэд түвдийн хааны цутгамал дүрийг тавиулна гэж амалжээ. Энэ бол хүндэтгэл үзүүлж буй хэрэг боловч далд санаа агуулж байгаа бөгөөд хаадын бунхны хажууд гол төлөв түүний түшмэд, сайд нарын хөшөө сэлтийг тавьдаг билээ.

649 онд Соронзон Гомбо хаан халуун хумхаа хэмээх халдварт өвчнөөр таалал төгсөв.[51] Тэрээр Лхас хот дахь бурханы шашны гол дугана-Жоканд байрлуулсан бодьсад Жанрайсэгийн цутгамал дүр дотор балбаас авчирч хийсэн жижигхэн модон Будда бурхан дотор шингэж уусcан хэмээх домог бий.

Соронзон Гомбыг таалал төгссөний дараа түүний ач хүү Мансонг Манцанг хаан ширээнд суув. Гэхдээ засгийн эрх мөн чанартаа эртний Гар омогийн төлөөлөгч болох Тонцэн Юлсуны гарт байв. Энэ омог 698 он хүртэл засгийн эрх барив. Соронзон Гомбыг 655 онд насан өөд болсны дараа

Тонцэн Юлсун түвдийн эртний хил орчмын газар нутаг болох Тугухунь улсад өнгөлзөж буй тухайгаа мэдэгдсэн байна. Тугухунынхан Тан улсын эзэн хаанаас тусламж хүссэн боловч татгалзсан хариу авчээ.[52] Тугухуны эрх баригч бүлгийнхний төрөл садангийн хүн болох түшмэл Тохэгүй Түвд рүү зугтан гарч, энэ тухай ярьжээ. 663 онд түвдчүүд тугухунийг эзлэн авч, энэ орны армийг бутниргэв. 667–670 онд түвдчүүд зимүүд буюу Тан улсын бүрэлдэхүүнд ороогүй ч тус улсын албат болж явсан тойрог, гацаануудыг устгаж эхэлсэн байна. Эдгээр тойрог, гацааг хятадууд өөрийн хараат болсон цянуудын газарт байгуулсан ажээ. 670 онд түвдчүүд түрэгүүдтэй холбоо тогтоож Тарим голын хөндийд цөмрөн оров. Үүний хариуд 670 оны наймдугаар сард Сюэ Жэньгуйн командалсан хятадын нэг зуун мянган хүнтэй арми Хөх нуур хавийн нутагт цөмөрч оржээ. Тидин Гарагийн командалсан түвдийн арми Бухайн голын хавьд хятадуудыг бутниргэжээ.

Түвдчүүд мөн баруун зүгт ч давшилт хийж байв. 656 онд тэд Ваханыг эзэлж, Болорыг хяналтандаа оруулж, 670 он гэхэд Хотан, Кашгарыг хятадуудаас булаан авч, 670-аад оны сүүлчээр Тарим голын бараг бүх сав газар, түүнээс баруун урагш орших уулархаг нутгийг мэдэлдээ оруулав.

Хятадууд Дорнод Туркестан дахь түшиц газруудаа алджээ. Ийм учир тэд Түвд рүү анхаарлаа хандуулах болсон байна. Гэвч 678 оны зун түвдчүүд Хөх нуурт хятадын армийг бут цохив. Үүнээс хойш хоёр орны эрх баригчид нас барж, дотооддоо үймээн самуунтай болсон учир Түвд болон Тан улсын хоорондын дайн түр зогсов.

687 онд түвдчүүд Куча хотод (өнөөгийн Шинжаан дахь) довтлов. Хятадууд хараат иргэддээ туслахаар арми илгээсэн боловч түвдчүүд түүнийг 689 оны зун бутниргэжээ. 692 онд Ван Сяозийн удирдсан тан улсын шинэ арми эмхлэн байгуулагдав. Удалгүй түвдчүүд Кашгараас гарч явсан байна. Энэ нь хятадуудын ялалтаас болсон уу, аль эсвэл түвдийн хаан Дуйсонг Мангже цэрэг гаргахыг тушаасан уу гэдэг нь тодорхой биш байдаг юм.[53] Гадна талд байгуулсан ялалтын дүнд засгийн эрх барьж байсан Гар отогийнхонтой тэмцэхэд түвдийн хаанд цэрэг хэрэгтэй болсон байж болох билээ. Хаан дайнд ялагдсаны гэм бурууг Гар отогийнхонд оногдуулжээ. Дараачийн хоёр жилд түвдчүүд зүүн хойд болон баруун хил дээр хятадуудаас дараа дараалан ялагдал хүлээсэн бөгөөд энд түрэгүүд хятадын холбоотон болсон байна.

Гэвч 695 онд түвдчүүд Ланьжоугийн чиглэлд хятадуудад томоохон цохилт өгч, найрамдал тогтоохыг санал болгоод эс зөвшөөрвөөс баруун хязгаартай тогтоох холбоог тасална гэж сүрдүүлсэн байна.Түвдэд дотоод

улс төрийн тэмцэлтэй байгааг мэдсэн хятадууд өөрсөдтэй нь маш амжилттай байлдсан Гар отогийнхон унана хэмээн найдаж хэлэлцээг сунжруулж байв. Үнэхээр ч Дуйсонг Мангдже 698 онд Гар отогийнхонд халдаж, хоёр мянга шахам хүн олзлон авч цаазалжээ. Тидин Цэндо Гар эсэргүүцэх гэж оролдсон боловч бутцохигдон, дараа нь амиа егүүтгэж, түүний дүү болон хөвгүүд хятад руу зугатжээ. Гэвч хааны бодит эрхийг сэргээн тогтоосон явдал Түвдийн гадаад бодлогыг өөрчилж чадаагүй юм. Түвдчүүд 700, 701 онд Ланьжоугийн ойролцоо болон зүүн хойд зүгт байлдааны ажиллагааг сэргээжээ. Дараачийн хэдэн жилд байлдааны ажиллагаа, хэлэлцээ ээлж дараалан явагдаж байв. 703 онд Балба, Энэтхэгт түвдчүүдийг эсэргүүцсэн бослого эхлэв.Эдгээр бослогыг дарах үед 704 онд Дуйсонг Мангже алагдаж, удалгүй тан улсын хатан хаан У-Хоу нас нөгчив. Энэ хүн хятадыг харьцангуй олон жил удирдсан байна.

706 оны шинэ хэлэлцээ “Шэнь-лун хаанчлалын уриан дор байгуулах тангарагийн холбоо” төслөөр дуусч, энэ төслөөр Түвдийн хаант улс, Тан гүрэн гэсэн хоёр улс хил зааглагдсан байна. 707 онд хятадууд энэ бол “хэ цинь” буюу “найрамдал ба ураг төрлийн” гэрээ байсныг хүлээн зөвшөөрч, 710 онд Циньчэн гүнжийг Түвд рүү явуулав.[54] Тан улсын эзэн хаан Гүнжийг замын нэг хэсэгт биечлэн дагалджээ. Хөх нуурын эргээс зүүн тийш, Шар мөрний дээд биеийн хоёр эргийн дагуу орших Хэси-Цюцюй гэдэг нэртэй газрыг Түвдийн хаанд инж болгож барьсан байна.

713 онд Циньчэн буурал толгойт хэмээх хочтой Тидэ Цугтэ хааны хатан болов.

714 онд түвдчүүд Линьтао–Ланьжоуд, 716 ба 717 онуудад одоогийн Сычуань, Ганьсу муж дахь Тан улсын хилд халдан орох оролдлого хийсэн байна. Тэд баруун зүгт араб жанжин Кутейба ибн-Муслимтэй холбоотон болж байлдав. Кутейбийн цэргүүд Дундад азид исламын шашинг тулган хүлээлгэж, тэндхийн “тэрс үзэлт шашны” соёлыг зэрлэг балмадаар устган сөнөөжээ. Гэвч түвдчүүд арабчуудын түрэмгийлэн эзлэх бодлогын аюулыг дутуу ойлгожээ. Тэд арабчуудыг ханилж ч болох, хаяж ч болох сул дорой ард түмнүүдийн л нэг хэмээн үзэж байв. Ингээд ч түвдчүүдийн дэмжлэг нэг их амжилтад хүрээгүй бөгөөд 715 онд баруун түрэгүүдээс эмхлэн байгуулсан тан улсын цэрэг Ферганд арабчуудыг бутцохисон байна. Хожим нь 736–737 онд түвдчүүд түрэгүүдтэй (Тюргеш хаганат) нийлж, хуучин холбоотон байсан боловч Ташкент, Ферганыг булаан эзлэхийг эрмэлзсэн арабуудтай байлдав. Ийнхүү арабууд хятадуудтай хэлхээ холбоо тогтоохыг эрмэлзсэн боловч хятадууд гэрээ байгуулахаас татгалзжээ.

Тидэ Цугтэн байлдааны ажиллагаа явуулахын зэрэгцээ 716, 718, 719 онуудад Тан улстай найрамдлын гэрээ байгуулахыг эрмэлзсэн боловч бүтээгүй ажээ. 724 онд дахин байлдаж энэ дайн 729 он хүртэл үргэлжилжээ. Ялалт, ялагдал ээлжилж байсан нь “ялалт, ялагдалд харьцангуй тэнцвэртэй байдал үүссэн юм”[55] гэж хятад түшмэл Жан Юэгийн дүрсэлж бичсэн тэрхүү нөхцөл байдалд хүргэжээ. Хоёр тал хилийн дарга нарын түрэмгий ажиллагааг зэмлэн буруушааж, найрамдлын гэрээ байгуулахыг эрмэлзэж байгаагаа батлан илэрхийлж байв. 60 жилийн дайны дараа 730 онд Тан улс болон Төвдийн хооронд найрамдлын гэрээ байгууллаа.Үүнд хятад хэл сайн мэддэг төвдийн элчин сайд, төвдийн хааны хятад эхнэр их үүрэг гүйцэтгэжээ. Талууд Чилиний нуруу (Сининээс зүүн тийш Улаан-шар даваа, одоогийн Хөх нуур муж ), Ганьсунлиний нурууг (Сычуань мужийн Сунпань гацаа) хоёр улсын хил хэмээн хүлээн зөвшөөрсөн байна. Долоон жилийн дараа дахин дайтаж эхэлсэн учир хилийн шон босгох ажлыг дуусгаж чадаагүй ажээ.

736 онд төвдчүүд Кашмирын Гилгитэд халдав. 737 онд хятадууд Хөх нуурын районд Төвд рүү халдав. Үүний дараа тулгаралт улам өргөжиж, Чилиний нуруунд босгосон хилийн шонгуудыг устгасан байна. 741 онд Циньчэн хатан таалал төгсөв. Төвдчүүд Тан улсын хилийн нутгуудад халдаж, хятадуудын ургуулсан тариа будааг дээрэмдэн авч явах болов. Тэд мөн хятадын Шипу хотыг булаан авч 748 он хүртэл тэнд эзэгнэн суужээ.[56] 747–750 онуудад хятадууд баруун зүгт томоохон арми явуулж, төвдийн Гилгит, Шипу хот болон Тарим голын сав газрын ванлигуудыг эзэлж авсан боловч 751 онд Талас голын дэргэд арабчуудад ялагдсан байна.[57]

751–752 онд төвдчүүд зүүн өмнө тийш орших Наньжао (одоогийн Юньнань муж) улсыг эрхэндээ оруулав. Тэд 750 онд тай нартай гэрээ байгуулав. Тэрхүү гэрээнд тайн захирагчийг төвдийн хааны «дүү» хэмээн нэрлэсэн байна.

Удалгүй Тидэ Цугтэн нас барж, хятадад Ань Лушаны бослого гарав. Төвдийн шинэ хаан Тисон Дэцэн хөрш зэргэлдээх улсууд суларсныг ашиглан орчин үеийн хятадын Ганьсу, Сычуань мужуудын өргөн уудам нутаг дэвсгэрийг булаан эзэлжээ. Тэр хаан Баруун хязгаарт Төвдийн нөлөөг сэргээн тогтоожээ. Төвд, уйгурууд хамтарч хятадад гарсан бослогыг дарж өгөхийг санал болгоод хариуд нь «найрамдал, ураг төрлийн» тухай гэрээ байгуулахыг шаарджээ. Хятадууд төвдийн бус, харин уйгурын шаардлагыг хангах зөвшөөрөл өгсөн байна. Төвдийн хаан үүнийг Тан улстай дайн хийх шалтаг болгон ашиглажээ. Шанчим Гьелцэг Шултэнг, Тактра Луконг гэсэн



Тисон Дэцэн

хоёр командлагчтай цэргийг хятадын нийслэл рүү илгээжээ. Ширүүн тулалдаан болж Тан улсын цэрэг бутцохигдож, эзэн хаан нь зугтажээ. 763 оны арваннэгдүгээр сарын18-нд түвдийн цэрэг Тан улсын нийслэл Чанъань хотыг эзлэв. Түвдчүүд хятадын хаан ширээнд Ли Жигийн жич хүү Ли Чэнхуныг суулгав. Ли Чэнхун шинэ уриалал – Да-шугийн дор өөрийн засаглалыг явуулав. Түвдийн хаан дээрх цэргийн хоёр жанжинг эзэн хаанаасаа урвахаас бусад ямар ч үйлдлийн төлөө эрүүгийн шийтгэл (цаазаар авахыг оролцуулан) оноохоос чөлөөлөх болгож шагнав.

Ялалтад зориулж чулуун багана босгож, түүн дээр Тисон Дэцэн тан улсын олон цайзыг эзлэн авч, тан улсын эзэн хаан болон түүний албатууд 50 мянган хуй торгоор алба гувчуур төлж байхыг зөвшөөрнө үү хэмээн түвдийн хаанаас хүссэн бөгөөд харин дараачийн эзэн хаан алба төлөхөөс татгалзсан тул түвдчүүд дахин армийг явуулж, хятадуудыг бутцохиход эзэн хаан нь нийслэлээсээ зугтав хэмээн сийлжээ.[58]

15 хоногийн дараа түвдийн цэрэг Тан улсын нийслэлийг орхив, гэвч дараачийн жилүүдэд цэргийн ялалт байгуулжээ. 781 он гэхэд Хами, Дуньхуаны район, Ланьжоу, Ганьжоу, Сучжоу хотууд түвдчүүдийн гарт орсон байлаа. Тан улс баруун зүгт гарах чухал замаа алджээ. 783 онд Түвд, Тан улсын хооронд Циншуй хотноо найрамдлын гэрээ байгуулав. Энэхүү гэрээнд хоёр орны шинэ хилийг маш тодорхой зааж өгсөн бөгөөд хятадууд энд нутаг дэвсгэрийн томоохон буулт хийсэн байна. Орчин үеийн хятадын дүгнэлтээр бол «Шар мөрнөөс хойш орших Хэланьшань район завсрын газар болж үлдсэн юм. Хилийн шугам Шар мөрнөөс урагш Люпаньшаны уулсаар дамжин Миньзян гол, Дадухэ голын дагуу явж Лунъю, одоогийн Лизян район, Юньнань муж хүрнэ. Энэхүү шугамаас зүүн тийшхи бүх нутаг Тан улсад, баруун тийшхи бүх нутаг Түвдэд очжээ».[59]

Тийнхүү Хэлуны район түвдчүүдийн мэдэлд очсоныг Тан улс хүлээн зөвшөөрч Баруун хязгаарт тавих хяналтаа алдсан байна.

Гэрээ байгуулснаар түвдчүүд түшмэл Жу Цыгийн өдөөсөн үймээнийг дарахад хятадуудад туслав. Хятадууд үүний төлөө Аньси, Бэйтин районуудыг захирах эрхийг түвдэд өгнө гэж амласан боловч хэлсэндээ хүрээгүйн хариуд түвдчүүд Ордос дахь тан улсын бэхлэлтэд халдаж, 787 онд Чанъанид дөхөж очив. Дараачийн жилүүдэд түвдчүүд уйгур, арабуудтай байлдав. Үүний дүнд 791 он гэхэд тэд Дорнод Туркестаны үлэмж хэсгийг эзэлж авсан байлаа.

XIII зууны сүүлч, IX зууны эхэн үе Түвдийн хаант улсын сүр хүчний оргил үе байв. Кабулын шаг (шах) түвдчүүдэд дагаар орж, тэд Памир, Кашмирын хагас хэсгийг хяналтандаа авсан байна.[60] Түвдийн арми умар зүгт Амударья мөрөн хүрчээ.[61] Энэ үед түвдийн баримт бичгүүдэд Бод Ченпо («Аугаа их Түвд») гэсэн нэр гарч иржээ. Тан улсын «Цю Тан шу» гэдэг түүхийн он тооллын бичгийн бүлэг 196В-д: «Түвдчүүд олон жилийн өмнө манай баруун хилд хаант улсаа үндэслэн байгуулсан юм: тэд нутаг дэвсгэрээ өргөжүүлэхийн тулд торгоны хүр хорхой мэт зэрлэг балмад хөршүүдийнхээ эзэмшлийг хэмлэн орж ирж байв. Гао-зуны үед түвдчүүдийн нутаг дэвсгэр 10 мянган ли-д хүрч, бидэнтэй өрсөлдөж байсан бөгөөд сүүлийн шинэ үед тэднээс хүчтэй хэн ч байгаагүй юм»[62] гэж бичсэн байна.

Харин XIII зууны сүүлчээр Түвд улсын сүр хүчинд ан цав гарч эхлэв. 794 онд Наньжао улсын эзэн Түвдэд захирагдахаас татгалзаж, Тан улсын эзэн хааны хараат болов. Умар зүгт Уйгур улс түвдчүүдийг шахаж эхэлсэн бөгөөд Тан улстай «найрамдал, ураг төрлийн» тухай гэрээ байгуулжээ. Тисон Дэцэнийг нас барснаас хойш түүний хоёр дахь хүү Мунэ Замба ширээнд залрав. Тэрээр албат иргэд нь тэгш биш, тариачид нь ядуу байгааг олж хараад баян, хоосон хэмээн ялгаварлахыг устгахаар шийдсэн байна. Ингэхийн тулд газрыг тэгш эдлэх тухай зарлиг гаргав. Хаан хэсэг хугацааны дараа шинэтгэлийн үр шимийг сонирхжээ. Ядуу хүмүүс улам ядуурч, баячууд улам баяжсаныг тэр олж мэджээ. Машид их гайхаж ундуусан хаан бурханы шашны номлогч Бадмаажунайгаас зөвөлгөө авахад тэрээр баян, ядуугийн тэгш биш байдлыг хаан хүн хүчээр арилгаж чадахгүй гэж хэлсэн байна.[63] Мунэ Замба ганцхан жил хаан ширээнд суугаад хорлогдож нас барсан ажээ. Тусгаар тогтносон түвдийн түүхэнд баялгийг тэнцвэртэй хуваарилах гэсэн цорын ганц удаагийн оролдлого ингэж төгссөн ажээ.

Улс төрийн тогтворгүй байдал Ти Ралбаачанг хааны үед Түвд улс Тан гүрэнтэй хэлэлцээ хийхэд хүргэжээ. 821 онд Чанъаны дэргэд, Лхас хотын хавьд гэрээнд гарын үсэг зурсан байна. Гэрээний эх бичгийг дөрвөн баганан дээр сийлж, Лхас, Чанъань хотод нэг нэгийг, хилийн хоёр талд нэг нэгийг



Ти Ралпачэн

босгожээ.[64] Гэрээний хятад бичвэрт хоёр хааныг жу («хаан») хэмээн нэрлэж, хятадын хааныг ах (цю – эхийн талын буюу нагац ах), түвдийнхийг дүү (шэн – зээ буюу дүүгийн хүүхэд) гэж нэрлэсэн байна.

Хоёр улсыг гэрээнд тусгаар тогтносон, тэгш эрхт хэмээн нэрлэж: «Түвдийн аугаа их хаан, тэнгэрээс заяагдсан Замба, Хятадын аугаа их хаан Хуанди, Зээ ба Нагац ах. Эзэмшил нутгуудынхаа хооронд холбоо тогтоохоор зөвлөлдөж, аугаа их гэрээ байгуулж, хэлэлцээрт гарын үсэг зурав... Түвд ч, Хятад ч одоогийнхоо хилийн хүрээнд улс орноо авч явах болно. Зүүн тийш орших бүх муж – Аугаа их Хятад, баруун тийш орших бүх муж – Аугаа их Түвд орон, энэ хилийн хоёр талд цэрэг дайны бэлтгэл, дайсагнасан халдлага хийж, нутаг дэвсгэр булаан эзлэхгүй... Одоо энэ эзэмшлүүд төрөл болж, найрамдлын тухай аугаа их гэрээ байгуулсан учир харилцаа холбоог Зээ болон Нагац ахын хооронд тааламжтай бичиг захидал явуулан хэрэгжүүлэх хэрэгтэй, хоёр талын элч нар эрт дээр цагт тавигдсан замаар явах ёстой... Зээ болон Нагац ахын хооронд тогтсон дотно, найрсаг харилцааны дагуу эрхэмлэн хүндэтгэж, найрсаг хандах явдлыг мөрдлөг болговол зохино. Хоёр улсын хооронд ямар ч утаа тортог, тоос шороо гарах ёсгүй.[65] Гэнэтийн түгшүүр буюу дайсагналын үг ч хэлэхээс цээрлэж, хил хамгаалж байгаа хүмүүсээс эхлээд дээш дээшхи бүх хүн ямарваа ажиг сэжиг болон айдас хүйдэсгүй аж төрөх ёстой, тэдний газар тэднийх, тэдний ор хөнжил тэднийх л байг... Түвдчүүд Түвддээ аз жаргалтай, хятадууд Хятаддаа аз жаргалтай байх аугаа их эрин үеийг тогтоож буй энэхүү хэлэлцээрийг хэзээ ч өөрчлөхгүй байхын тулд Ихсийн бие, Нар ба сар, од ба гариг энэ Гурван Эрдэнийг гэрч болгон дуудаж байна»[66] гэж өгүүлжээ. БНХАУ-ын гадаад явдлын яамны Интернет-Сайтад энэ тухай: «Холбоонд оролцогч хоёр тал түүхийн явцад бүрэлдэн тогтсон ураг төрлийн хэлхээ холбооныхоо тухай ёслол төгөлдөр мэдэгдэж, ирээдүйд тэд өөрсдийгөө нэг орны харьяатууд хэмээн үзэхээр тохиролцов»[67] гэж бичсэн байна.

Бурханы шашныг үндсээр нь устгах гэсэн Дарма хааны оролдлогын улмаас түр зуурын хугацаагаар тасарсан энэ шашны байр суурь Түвдэд дээрх гэрээг байгуулсны дараах жилүүдэд улам бэхжив.(5-р бүлэгт тодорхой

үзмүү). Түүнийг 842 онд алагдсаны дараа хан хүү Нагдаг Юмтэн, Нагдаг Одсун нар засгийн эрхийн төлөө тэмцэлдэж эхэлжээ. Юмтэн Ярлунгд, Одсун Лхаст бэхжив. Одсуны гуч Баруун Түвдийн Пуранд очиж, Нгарийн эзэнт гүрнийг үндэслэн байгуулж, мөн Одсуны хоёрдугаар ач Цангд бэхжсэн байна. Цэргийн жанжнууд болон томоохон түшмэд аль нэгэн хааны талд орох эсэхүл бие даасан байдлаа зарлацгаана. 851 онд хятад гаралтай Түвд түшмэл Дунхуан Түвдээс салж, тан улсын иргэн болжээ. Энэ бол үнэхээр ёс төдий алхам байлаа. Үнэн хэрэгтээ бол Дуньхуан монголчуудын үед л Бээжингийн мэдэлд буцаж ирсэн байна. 860 онд Сычуаны Түвд цэргийн командлагч Тан улсын харьяат болсон байна. Түвдийн өөр нэг цэргийн жанжин төрөл ард түмэн болох тангад нарын хаанд олзлогдон очиход хаан түүний толгойг авч, Тан улсын нийслэлд хүргүүлсэн байна. Түвдийн гадна үлдсэн Түвд цэргүүдийн зарим нь байсан газраа уусч, нөгөө зарим нь бие даасан чигжүү эзэмшил газар бий болгожээ. Тухайлбал X зууны сүүлчээр Ланьжоу хотод төвтэй түвдийн томоохон эзэмшил, XI зуунд Хөх нуурын районд түвдийн улс, мөн Шар мөрний дээд биеэр хэд хэдэн жижиг эзэмшлүүд байжээ.[68]

Аугаа их Түвд улсыг задрахад дотоодын хэрүүл, тэмцлийн шалтгаан болсон бурханы шашин нөлөөлсөн гэж зарим зохиогч үздэг:овогт хаадын буян хишгийг бага зэрэг түрэгдэж байсан бон шашин гийгүүлнэ, харин бурханы шашин түүний байрыг арай эзлээгүй байжээ. Үүнийг нотлох шууд нотолгоо үгүй юм. Энд янз бүрийн бүлгүүд аль нэгэн шашныг улс төрийн зорилгодоо ашиглаж байжээ. Цэргийн их зардал, өргөн уудам нутаг дэвсгэрийг хянах хөрөнгө мөнгө хүрэлцээгүй байсан явдал улс орны задралд их нөлөө үзүүлжээ.

Түвдийн умард нутагт байсан жижиг эзэмшлүүд хятадуудтай нэгдэн Тангад (хятадаар Си Ся) улстай дайтаж, мөн өөр хоорондоо дайсагналцаж байв. Түвдийн эдгээр нутаг дэвсгэр аажмаар Хятадын, дараа нь Тангад нарын эрх мэдэлд орсон байна. Түвдчүүд Тангадын эзэнт улсад чухал байр эзэлж байв. Түвд хэлийг бурханы шашны хэл хэмээн хүлээн зөвшөөрч, түвдчүүд өөрийн гэсэн буддын нийгэмлэгтэй, Түвд хүмүүс тангад, хятад, уйгуруудтай хамт энэхүү эзэнт гүрний үндсэн ард түмнүүдийн нэг болж байлаа.

X зуунд Түвдэд шашин, төрийн эрх мэдэл нийлэх үйл явц эхэлжээ. Гэхдээ улс төрийн амьдрал тайван үргэлжилж, улс орныг нэгтгэсэн бурханы шашин хөгжиж байв. Үүний дүнд түвдийн ард түмэн бүрэн төлөвшин тогтжээ. Тан улсаас хойш улс төрийн тавцанд гарч ирсэн хятадын улсуудтай



Сахьяа бандид Гунгаажалцан
(Chandra, 1999)

харилцах харилцаа сул байв. Төвдийн болон хятадын засгийн газруудын хооронд бараг харилцаа байгаагүй юм. 907–960 оны Таван гүрэн, 960–1279 оны Сунгийн хоёр улсын үед Төвд, Хятадын харилцаа хилийн жижиг мөргөлдөөн гарах, худалдаа хийх, бэлэг сэлт илгээх, хариу бэлэг болон цол хэргэм хүлээж авах зэрэг ёс төдий элэгсэг байдлаар хязгаарлагдаж байв.

Төвдийг хятадын төв засагт захирагдаж байсан гэх буюу Хятадын бүрэлдэхүүнд орсон зэрэгээр хятадын тал заримдаа буруу тайлбарладаг юм.

1206 он гэхэд Чингис хаан монгол аймгуудыг нэгтгэж, байлдан дагуулах идэвхтэй бодлого баримтлав. Төвдчүүдтэй эртнээс наашсайн харилцаатай явж ирсэн уйгур, түрэгүүд түүний харьяанд орлоо. Монголын эзэнт гүрэн түргэн хугацаанд өргөжин тэлэв. 1206 буюу 1207 онд төвдчүүд төр, шашны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй элч нарыг Чингис хаанд илгээж, тэр элч нар их хаанд тансаг бэлэг сэлт өргөж, сүсэглэн дагаж явахаа илэрхийлсэн байна.[69] Эзлэгдсэн бусад ард түмний нэгэн адил төвдчүүд алба гувчуур төлдөг болсон юм. Энэ нь төвдийг монголын халдлагаас ангижруулсан хэмээн түүхчид үздэг. 1227 онд монголчууд тангадын эзэнт улсыг мөхөөж, хааныг нь цаазлав. Тангад улсын нийслэлийг эзлэх үед Чингис хаан тэнгэрт халив. Үүнээс хойш төвдчүүд алба гувчуур төлөхөө байж, монголчуудтай харилцах харилцаа ч түгшүүртэй болж ирсэн байна.[70]

1240 онд Леже, Дордай дархан нарын командалсан монголын 30 мянган хүнтэй корпус Төв Төвдэд халдаж оров. Энэ корпусыг Өгөөдэй хааны хоёрдугаар хөвгүүн, Чингис хааны ач хан хүү Годан явуулсан байна. Монголын цэрэг Лхас хотоос хойш орших Пханьюл хүрчээ. Тулалдаан болж, хоёр хийд шатаж, 500 лам тэргүүтэн алагдсан байна.[71] Монголчууд цааш яваагүй ч Годан хаан Төвдийг мартаагүй ажээ. Тэрээр буддын Шагжаа чиглэлийн (сургуулийн) тэргүүн Гунгаажалцанд урилга явуулжээ. Тэрээр их эрдэм мэдлэгтэй лам тул түүнд Сахьяа бандид хэмээх эрдмийн зэрэг олгосон юм байна. Ийнхүү урих болсон хэд хэдэн шалтгаан бий гэсэн таамаглал байдаг. Годан төвдтэй хил залгаа орнуудтай байлдаж явахдаа

олж мэдсэн бурханы шашны өндөр зиндааны лам хүнээс адис хүртэж энэ шашинд орохыг хүссэн гэдэг бол хамгийн үнэнд ойрхон бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрсөн таамаглал мөн. Чухамдаа шашны энэ урсгалыг сонгож авсны шалтгаан дараах байдлаар илрэн гардаг ажээ.[72] Монголын нийгэм болон бурханы шашны өмнөх итгэл үнэмшил түвдийнхтэй төстэй байсан бөгөөд очирт хөлгөний буддизм монголчуудын сонирхлыг илүү их татсан бөгөөд Сажа урсгал буддын хуучин уламжлалыг баримталдаг, лам нар нь төрийн эрх баригчидтай идэвхтэй хэлхээ холбоо тогтоож байв. Энэ бол төлөвшин тогтож буй Түвд-монголын соёл иргэншлийн гол шинж чанарууд байжээ.

Годан:[73] "Хамгийн хүчирхэг, цэцэглэн хөгжиж буй хан хүү Годан би миний мунхаг харанхуй хүмүүсийг ёс суртахуунтай, оюун ухаантай болгон сургаж өгөх тийм лам хүн хэрэгтэй байгааг Сахьяа бандид Гунгаажалцан танд мэдээлж байна.

Миний хязгааргүй хайрлан хүндэтгэдэг талийгаач эцэг эхийн минь сайн сайхны төлөө мөргөл үйлдэж өгөх хүн ч надад хэрэгтэй байна. Би олон удаа эргэцүүлэн бодсоны эцэст энэ зорилгод тохирох цорын ганц хүн бол Таныг хэмээн шийдлээ. Та бол миний сонгож авсан цорын ганц лам хүн учираас насны байдал, аялах замын бэрхшээл зэрэг ямар ч тайлбарыг би хүлээж авахгүй.

Ариун гэгээн Будда эх болсон зургаан зүйл хамаг амьтаны тусын төлөө бүх насаа зориулсан билээ. Тиймээс Таны хувьд үүргээ биелүүлэхээс зайлсхийх гэсэн оролдлого итгэл үнэмшлээсээ ухарсан хэрэг болохгүй гэж үү? Миний хувьд бол Таныг бидэнд авчируулахын тулд цэргийн том отряд явуулах нь тийм хэцүү ажил биш боловч гэм зэмгүй олон хүнийг гамшиг зовлонд оруулж болох юм. Бурханы шашны итгэл үнэмшлийн төлөө, эх болсон зургаан зүйл хамаг амьтаны тусын тулд нэн даруй хүрэлцэн ирэхийг Танд санал болгож байна. Би бээр Танд талархсанаа илэрхийлж наран шингэх зүгт аж төрөн суугаа лам нарыг ивээлдээ авьяа.

Би танд таван мөнгөн гулдмай, зургаан мянга хоёр зуун сувд эрдэнээр чимсэн торгон жанч (нөмрөг), торгон хувцас, гутал, таван янзын өнгө бүхий хорин хуй торго илгээж байна. Энэ бүгдийг миний элч Дхо Сегон, Ун жо Карма нар Танд хүргэж өгнө. Луу жилийн (1224 он) наймдугаар сарын 30-ны өдөр" гэж бичжээ.

Гунгаажалцан арван настай Лодойжалцан, зургаан настай Чагнаа хэмээх хоёр зээгийн (дүүгийн хүүхдүүд) хамт Годаных руу хөдөлсөн байна. Тэд Годан хан хүүгийн өргөөнд 1245 онд хүрэлцэж ирсэн боловч ханхүү Их

Хуралдайд оролцохоор Монгол руу явсан байв. 1247 онд Ланьжоу хотын хавьд энэ хоёр их хүн уулзсан байна. Годан сахьяа бандидад зориулж Тулпэдэ хийд байгуулжээ (өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн). Гунгаажалцан монголын хан хүүг ямар нэгэн өвчнөөс анагаажээ. Годан бандид лам Гунгаажалцанд бүх Түвдийг захирах эрх шийтгэн шагнажээ.

Энэ нь Түвд аймгууд Монголын эзэнт гүрэнд нэгдэн орж, тус улсын засаг захиргааны бүх хууль заавaрт захирагдах ёстой болсон хэрэг биш юм. Годанаас эрх мэдэл авсан Гунгаажалцан эх орондоо тус болохын тулд бурханы шашныг Түвдийн хилийн чанадад дэлгэрүүлэхийг гол зорилгоо хэмээн үзэж буйгаа түвдийн эрх баригчдад тайлбарласан[74] илгээлт явуулсан байна. Тэрээр монголын хан хүү шашны хэрэгт түвдчүүд туслана хэмээн найдаж байгаа бөгөөд монголчууд төрийн хэрэгт бидэнд туслах болно гэж Гунгаажалцан бичжээ.

Түвдийн шашин-төрийн эрх баригчид болон монголын, дараа нь манжийн хаадын "номын багш – төрийн ивээн тэтгэгч" зарчимд тулгуурласан харилцааны үндэс суурь ийнхүү тавигджээ. Энэхүү зарчим ("лам – өглөг өгөгч") Эртний Энэтхэгээс гаралтай бөгөөд тэнд бурханы шашны лам нар өглөг барьцаар амьдарч байсан бөгөөд лам нарыг хүндэтгэж, хоол хүнсээр хангах явдлыг энгийн иргэдийн оюун санааны их гавьяа хэмээн үздэг байжээ. Харин Түвдэд IX зууны дунд үеэс XIII зууны эхэн хүртэл энэ томьёоллыг сүм хийд болон орон нутгийн Түвд хүн амын харилцаанд хэрэглэж байв.[75]

Годан монголчуудын их хааны талын хүн учир 1251 онд Мөнх хаан төрийн тэргүүн болохдоо хүн амын тооллогыг шалгуулахын тулд Түвд рүү түшмэл нар илгээж, орон нутгийн төр, шашны эрх баригчдын эзэмшлийг баталжээ.[76] Гэхдээ Түвд рүү эзэнт гүрний засаг захиргааны төлөөлөгчдийг ч, цэргийн анги нэгтгэлийг ч явуулаагүй байна.

1251 онд Гунгаажалцан нас барж, удалгүй Годан хан хүү ч өөд болжээ. Тэр жил монголын их хаан Мөнхийн тушаалаар Чингис хааны ач хүү Хувилай Өмнөд Хятадын эсрэг кампанийг тэргүүлжээ. Гунгаажалцангийн том зээ дүү Пагва лам 1253 онд Хувилайн анхаарлыг бурханы шашинд хандуулав. Ямар нөхцөл болзлоор ингэсэн тухай янз бүрээр бичдэг юм.[77] Хувилай Түвдийн асуудлаар Пагва ламтай зөвлөлдөх, харин Пагва Монгол улсын хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх болзлоор Пагва лам Хувилайд бурханы шашны сахил хүртээсэн гэж зарим судлаачид үздэг. Түүнээс гадна Хувилай сүсэгтэн олны дэргэд биш, хурал номын үеэр л багшдаа мөргөл үйлдэж байхыг зөвшөөрсөн байна. Хувилай бясалгал үйлдэх,

хурал хурах, сахил хүртэх үед Пагва ламаас доогуур суудалд суух, төрийн хэрэг шийдэх үед нэг түвшингийн суудалд суухыг зөвшөөрсөн хэмээх өөр мэдээлэл ч байдаг ажээ. Үүний дараа Хувилай болон түүний бараа бологчдын 25 гишүүн Пагва ламаас Сажагийн чиглэлийн хамгийн чухал очирт хөлгөний буюу Хөвазар очирт хөлгөний сахил хүртсэн байна.[78]



Пагва лам

1254 онд Хувилай Түвдийг удирдах дээд эрхийн тухай баримт бичгийг Пагва ламд гардуулжээ.[79] Энэ баримт бичигт: “Алтан нар лугаа аливаа харанхуйг гийгүүлэгч ертөнцийн ялагдашгүй, бүхнийг ивээн тэтгэгч аугаа их гэгээнтэн Буддаг чин сэтгэлээс шүтэн бишрэгч би бээр Танай орны лам нар хийгээд сүм хийдийн тухайд ямагт онцгой анхаарал хандуулж ирсэн билээ. Будда бурханд итгэсэн миний бие Таны нагац ах Сахьяа бандидаас сургааль ном хүртэж, усан үхэр жил (1253 он) Танаас ном хүртсэн билээ.

Танаас ном хүртсэнээс хойш сэтгэл ариусан бадарсан би бээр Танай лам нар болон сүм хийдийг ивээн тэтгэсэн хэвээр байсан бөгөөд Таны надад өгсөн тэр их мэдлэгийн төлөө талархсаны тэмдэг болгож би Танд бэлэг барих ёстой билээ. Энэ баримт бичиг Танд барих миний бэлэг юм. Би Танд бүх Түвдийг захирах эрх мэдэл бэлэглэж байгаа бөгөөд Та сүм хийд хийгээд Танай ард түмий итгэл үнэмшлийг хамгаалж, мөн Ариун Буддагийн сургаалийг дэлгэрүүлж яваарай. <...>

Түвдийн лам нар, ард түмэн өөрсдийнх нь төлөө миний хийж буй зүйлийг мэдэж байх ёстой. Тэд Танаас өөр ямар нэгэн удирдагчийг эрэхгүй байх гэдэгт би итгэлтэй байна. Өөрт нь эрх мэдэл олгосон энэхүү баримт бичгийг эзэмшигч хүн ямарваа хэлбэрээр ард түмнээ дарлан мөлжих ёсгүй. Лам нар өөр хоорондоо маргалдаж хэрэлдэх, хүчирхийлэл үйлдэхээс түдгэлзэх ёстой. Тэд тайван, амгалан аж төрөх ёстой. Ариун Буддагийн сургаалийг мэддэг хэн бүхэн түүнийг цуцалтгүй дэлгэрүүлэх ёстой. Уг сургаалийг мэддэггүй хэн бүхэн чадах бүхнээ судлахыг эрмэлзэх ёстой <...> Би Таныг ивээн тэтгэгч болж байгаа учир Та Ариун Буддагийн сургаалийг мөрдөн явах үүргээ биелүүлэх ёстой билээ. Энэхүү баримт бичиг миний

бие Танай бурхан шашныг ивээн тэтгэх үүрэг хүлээж буйг баталгаажуулж байгаа юм. Модон бар жилийн (1254 он) дунд сарын 9-ний өдөр” гэж өгүүлсэн байна.

Хувилай энэ баримт бичгээр “номын багш – төрийн ивээн тэтгэгч” зарчимд тулгуурласан харилцааг бататгажээ. Түүний зэрэгцээ Хувилай уламжлалынх нь дагуу бусад бүх чиглэлийн шашинд ч буддын сургааль судлахыг зөвшөөрч: Пагва лам тэдгээр шашны урсгалуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байжээ. Энэ тухай заримдаа: “XIII зуунд эзэн хаан Хувилай Ромын пап лам бусад епископыг захирдгийн нэгэн адил бусад бүх лам нарыг даргалах ёстой анхны Аугаа их Ламыг бий болгосон юм”[80] гэж бичдэг нь инээдтэй хэрэг билээ. Бас: “XIII зуунд Чингис хааны ач хүү Хувилай түвдийн нэрт бурханы шашинтнуудын нэгэнд эзэн хааны багш буюу Далай лам цол олгож, түвдийн газар нутгийг удирдахыг түүнд даалгав”[81] гэсэн нь бүр ч инээдтэй юм.

1258 онд Мөнх хааны зарлигаар Хувилайн ордонд бурханы болон даос шашинтнуудын хооронд ном хаялцаан болж даосынхан ялагджээ. Энэ нь Монголын эзэнт гүрэнд бурханы шашны байр суурийг бэхжүүлэв. 1259 оны наймдугаар сард Мөнх хаан амь үрэгдсэн байна. Их хааны суудалд Чингисийн удмын хэд хэдэн хүн: төрсөн ах дүү Хүлэг, Хувилай, Ариг Бух нар өрсөлдөв. Гэхдээ сүүлчийн хоёр хүн бодит өрсөгдөгчид болж: Хүлэг Ойрхи Дорнодод эрх мэдлээ бэхжүүлсэн, Хувилай хараахан бүрэн эзлэгдээгүй Хятадад байв. Ингээд Ариг Бух Монголын их хаанаар сонгогдов.

Хувилай вангуудын их хуралдайг хийлгэж, Ариг Бухыг их хаанаар зарлан тунхаглажээ. Үүний дараа болсон иргэний дайнд Хувилайг ялахад Пагва лам түүнийг мэргэн ухааны бодьсад Манзушрын хойд дүр хэмээн зарласан байна. Хувилай үнэхээр маш авьяаслаг хүн байв. Түүнийг бага залуу байхад нь “цэцэн” хэмээн нэрлэдэг байжээ.[82] Хожим нь монголын он дараалльн бичгүүдэд Хувилай цэцэн хаан гэж цоллон нэрлэж иржээ.

Пагва лам эх орноосоо гарч явснаас хойш анх удаа 1265 онд Түвдэд эргэж ирсэн байна. 1267 онд тэрээр хааны ордонд хүрэлцэн ирнэ үү гэсэн урилга бүхий илгээлтийг Хувилайгаас хүлээн авчээ. Пагва ламыг монгол газарт хааны хатан болон ахмад хөвгүүн угтан авч нийслэл хүртэл дагалдан явжээ. 1268 онд Пагва лам хааны нийслэл Ханбалык хотод ирмэгцээ Түвд бичгийг үндэслэн монголчуудад зориулан боловсруулсан цагаан толгойг (дөрвөлжин бичиг) Хувилайд хэлэлцүүлэхээр өргөн барьжээ. Энэ бичиг монгол, хятад хэлний авиаг илэрхийлэн гаргах боломж олгожээ. Хувилай хаан ч сэтгэл хангалуун байлаа. Угсаатны зүйн бие даасан байдлыг

хадгалан үлдэхэд хэл бичиг чухал үүрэгтэйг тэр ойлгож байлаа. Хувилай хаан Пагва ламд: "Энэтхэг бурхадын жонон, тэнгэрийн доорхи, газар дээрх гайхамшигт их Эзэн, бичиг үсэг бүтээгч, Орчлонгийн энх тайвны мэдээч, таван дээд ухааны мастер, эзэн хааны багш Пагва"[83] хэмээх цол шагнан олгов.

1271 онд Хувилай хаан хятад заншлаар эзэнт гүрэн буюу Юаны үеийг зарлан тунхаглаж, эзэнт гүрнээ ч ийнхүү нэрлэв. Хятад (Өмнөд Сун улс) тэр үед бүрэн эзлэгдээгүй байв. Пагва лам Хувилайд Чакравартин (номын хүрд эргүүлэгч, өөрөөр хэлбэл бурханы шашинд туслагч бүх дэлхийн гайхамшигт удирдагч), Номун хаан (итгэл үнэмшлийн хаан) цол, түүний өвөг эцэг Чингис хаанд Чакравартина цол бэлэглэв. Пагва лам төрийн багш цол, Түвдийн эзэн захирагч, эзэнт гүрний бурханы шашны эзэн захирагчийн хаш тамга хүлээж авсан байна. Тийнхүү "багш – ивээн тэтгэгчийн" хуучин харилцааг бататгажээ. Пагва ламд нэг мянган мөнгөн гулдмай, 59 мянган хуй торго бэлэг болгож өгсөн байна. Пагва лам 1274 онд Түвд буцахаар шийджээ. Их хаан багшдаа хүндэтгэл үзүүлэн Амдо муж дахь Мачу (Шар мөрний дээд бие) голын тохой хүртэл хэдэн сарын замд дагалдан үджээ. Пагва лам 1276 онд монгол цэргийн отрядаар хамгаалуулан Сажад буцаж очжээ.

Монголчууд 1279 онд хятадыг бүрэн эзлэж авахад Пагва лам их хаанд бэлэг, баяр хүргэсэн захидал илгээсэн байна. 1280 онд тэрээр 46 насандаа ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ. Шадар туслахууд нь түүнийг хордуулсан гэж ярьдаг ажээ.[84]

Хувилай хаан энэ хэргийг мөрдөн шалгуулахаар цэргийн хоёр жанжинг тусгай отрядаар хамгаалуулан явуулсан байна. Тэд Пагва ламыг хордуулсан хэрэгт сэжиглэгдсэн Гунгаа Самбуу гэдэг хүнийг цаазалжээ. Гэвч түүнийг жинхэнэ хордуулагч этгээд гүтгэсэн гэж хүмүүс ярьдаг. Хувилай хаан шудрага бус ялын тухай олж мэдээд цэргийн хоёр жанжинг цаазалсан байна. Пагва ламыг түүний зээ дүү Дхармапала залгамжилсан байна. Тэрээр таван жилийн дараа Ханбалыкаас Түвд орох замдаа насан эцэслэжээ. Үүнээс болж үүссэн үймээнийг монголчууд дарав. Үүнээс хойш юань улсын эзэн хаан бүр өөрийн гэсэн лам багштай байжээ.[85] Түүнээс гадна Сажагийн дээд тушаалтнуудад монголчууд «байлан ван» цол олгож, гүнж нараа эхнэр болгон өгч байжээ.[86]

Барагцаалбал 1286 онд Хувилай хаан түвдээр дамжин Энэтхэг, Балбад халдах гэж байсан хэмээх мэдээ байдаг юм.[87] Энэтхэгт байсан түвдийн йогч Ургьен Сенге хаанд шашны сэдэвтэй урт найраглал илгээж, аян дайнаасаа

татгалзахыг уриалсан байна. Энэ захидал нөлөөлсөн эсэх нь тодорхой бус боловч Хувилай хаан Энэтхэг, Балбад дайнаар очоогүй ажээ.

Тийнхүү Хятад дэлхийн түүхэнд байсан хамгийн том орон болох Аугаа их Монголын эзэнт гүрний нэг хэсэг болох Юань улсын салшгүй хэсэг болжээ. Монголын эзэнт гүрэн Номхон дөлгөөн далайгаас Европ хүртэлх өргөн уудам нутаг дэвсгэрийг эзлэн оршиж байлаа. Түвд, байлдан эзлэгдсэн буюу хараат улсын тангараг өргөсөн орнуудын адил Их Монгол гүрний нэг хэсэг байгаагүй юм. Юань гүрний нутаг дэвсгэрийн албан ёсны жагсаалтад ч Түвд үгүй ажээ.[88] Ингэхлээр Юань улсад хэрэглэж байсан засаг захиргаа – нутаг дэвсгэрийн систем Түвдэд хамааралгүй юм.

Юань улсын эзэн хаадын шашинд хандах хандлага хятадын хаадынхаас өөр байсан нь ойлгомжтой. Тийм харилцааны (хандлагын) хамгийн шилдэг хувилбарыг монголын «Магтаал даах арван хууль» хэмээх он тооллын бичигт дүрслэн харуулжээ. Тэнд төрийн «хоёр журмын» онолыг дурдсан нь Пагва ламын төрийн эрх мэдэлд хандах үзэл бодлыг тусгасан бололтой.[89] Дэлхийн бүх бодгаль төрийн болон шашны авралд хүрэхийг эрмэлздэг. Шашны буюу оюун ухааны аврал нь зовлонгоос бүрэн чөлөөлөгдөхөд, төрийн аврал нь сайн сайхан байдалд оршдог ажээ. Энэ хоёр нь шашны ба төрийн хэмээх хоёр журмаас хамаарна. Шашны журам судар номонд, төрийн журам энх, амгалан байдалд тулгуурлана. Шашны журмыг лам, төрийн журмыг эрх баригч хэрэгжүүлнэ. Тийнхүү шашин ба төр бие биеэс хамаарна. Шашин, төрийн тэргүүн нар адил тэнцүү боловч өөр өөрийн тусгай үүрэгтэй. Лам нар Будда бурханд, Эрх баригчид Номун хаанд сүсэглэнэ.

Тийм чанар чансаа түүхийн үе бүрт нэг л удаа гарч ирнэ. XIII зуунд энэ бол Пагва лам, Хувилай хаан хоёр байв. Энэ журмыг яв цав мөрдөж байгаагүй ч юань гүрний эзэн хаад түүнийг мөрдөх гэж эрмэлзжээ.

Пагва ламын боловсруулсан онолоор бол монголын эзэн хаадыг ямар нэгэн хятадын овогт хаадын бус, бүх дэлхийн буддын эзэн хаадын залгамжлагчид хэмээн үзэж байв. Чингис хааныг ч, Хувилай хааныг ч Энэтхэгийн Чакравартин, түвдийн ариун гэгээн хаадтай адилтган авч үзсэн байна. Үүний зэрэгцээ хятадын эрдэмтэд Хувилай хаан болон түүний удмынхныг Хятадыг захирч байсан хуульт ёсны овогт хаадын жагсаалтад оруулах боломж олгосон өөр нэг бүдүүвч хувилбар боловсруулсан байна (тодорхой үзмүү: 11-р бүлэг).

Хувилайн үед засаг захиргааны удирдлагын систем боловсруулсан бөгөөд энэ систем Юань гүрний сүүлчийн өдөр хүртэл бараг өөрчлөгдөөгүй

ажээ.[90] Эзэн улс буюу Монголыг удирдах засаг захиргааны байгууллагуудыг илүү сайн боловсруулсан бол бусад нутаг дэвсгэрийн байгууллагууд үр нөлөө багатай, тэдгээрийн үүргийг гол төлөв өөр бусад байгууллага хавсран гүйцэтгэдэг байв. Эзэнт гүрний удирдлага төвлөрөл багатай байсан учир монголчууд алслагдсан нутгийн орон нутгийн байгууллагуудыг «илэрсэн баримтын дагуу» л хянадаг байжээ.[91] Эзэнт гүрний шүтлэгийн Товчоо шашны хэргийг эрхлэн удирдаж байв. Шүтлэгийн олонхи байгууллага энэхүү товчооны мэдэлд байв. Таван мужид түүний тамгын газрууд ажиллана. Төвдийн тухайд зуньжиюань хэмээх тусгай газар байгуулж, анхных нь тэргүүнээр Пагва ламыг томилжээ.[92] 1284 онд энэ газрыг буддын хэрэг эрхлэх товчоо хэмээн өөрчлөн нэрлэх болсон байна. Энэ товчоог иргэний хэрэг эрхлэх газар, арми, хянах засаглал зэрэг эзэнт гүрний төрийн эрх барих дээд байгууллагуудтай нэгэн зиндаанд аваачиж тавьсан байна. Энэхүү товчооны бүрэн эрхт төлөөлөгчдийн тэн хагасыг түшмэл нар, нөгөө хагасыг лам нар эзэлж байв. Төвдэд зориулсан байгууллага болон Өмнөд Хятадын бурханы шашны хэрэг эрхэлсэн комисс гэсэн хоёр өөр байгууллагыг 1329 онд нэгтгэсний дагуу Төвд болон бурханы шашны хэрэг эрхэлсэн товчоо бий болсон байна.[93]

Хувилайн үед Юань гүрнийг засаг захиргааны хувьд хуваан авч үзэх ажил эхэлсэн байна. Энэ ажил нилээд хожуу буюу 1321 онд дуусчээ. «Юань гүрний шинэ түүх» хэмээх он дараалын бичигт эзэнт гүрнийг 12 мужид хуваав.[94] Хятад болон Чин улсын нутаг дэвсгэрээс гадна Монгол (хоёр мужид), Тангад улс, Амдо, Өмнөд Сибирийн зарим хэсэг, түүнчилэн Солонгосыг бүхэлд нь дээрх 12 мужид нэгтгэн оруулсан байна.

Төвдийг эдгээр мужид нэгтгэн оруулаагүй ч түүнийг нилээд өмнө хэд хэдэн «зам» (муж) болгож хуваасан ажээ. Эдгээр мужийн дээд эрх Сажагийн тэргүүний мэдэлд байв. Түүний дэргэд иргэний болон цэргийн хэрэг эрхлэх түшмэл байх ажээ. Энэ түшмэл ч Монголын илбэн тохинуулах товчооны хяналтад байжээ. Төвдийн баримт мэдээллээс үзвэл «тэрээр ламын тушаалаар, эзэн хааны мандатаар удирдах ажлаа эрхлэн явуулна. Тэрээр хоёр хуулийг (шашин ба иргэний) хамгаалах бөгөөд улс орны амгалан тайван байдал, шашны цэцэглэл хөгжлийн төлөө хариуцлага хүлээнэ»[95] хэмээн заажээ.

1264 онд Кам ба Амдог (монголчууд олноор суурьшдаг нутаг) Төв Төвдийн Засаг захиргааны удирдлагаас гаргасан байна.[96] Эдгээр нутаг хяналт багатай, дуулгавар муутай аймгуудыг үе үе «илбэн тохинуулахад» хүрдэг байжээ. Монголчууд л энэ ажлыг хамгийн их үр нөлөөтэй хийж

чаддаг ажээ. Тэд 1256-аас 1355 оныг дуустлах хугацаанд тийш нь 21 удаа цэрэг явуулсан байна. У, Цанг ба Нгари-Корсум Пагва ламын шууд харьяанд үлджээ. Тэдгээрт монголчууд нилээд доод түвшингийн удирдлагын газрууд бий болгож, эдгээр газар хэдий чинээ засаг захиргааны шигээ, төдий чинээ хяналтын үүрэг гүйцэтгэж байв.[97] Сажагийн эзэмшил газар 13 районд хуваагдсан бөгөөд эдгээрт сүм хийд гол нөлөөтэй байв. Гэсэн хэдий ч «багш – ивээн тэтгэгчийн» харилцааны хүрээнд Сажагийн тэргүүний эрх мэдлийг бүх түвдчүүд хүлээн зөвшөөрдөг байв.

Хувилай хаан Түвдэд өөрийн «сюзеренитет» буюу «төвийн захиргааг» тогтоосон хэмээх зарим судлаачийн таамаглал ул үндэсгүй юм. Илбэн тохинуулах товчоогоор дамжуулан монголчуудын хэрэгжүүлж байсан хяналт улс оронд амгалан тайван байдал сахиулахад туслахад л оршиж байв. Түвд бол Монголын эзэнт гүрнээс хараат орон байснаас биш хятадаас хэзээ ч хараат байгаагүй юм. Нутаг дэвсгэрийг хамгаалах, туслах үүрэг бүхий түшмэд илгээх, хууль тогтоомж боловсруулах, өртөө улааны алба залгуулах зэрэг нь багш хэмээн хүндэлж буй Түвд ламд ивээн тэтгэгчийн хувьд хандаж буй монголын эзэн хааны хүлээх үүрэг хариуцлага байснаас биш хятадын засаглалын удирдлага огт биш юм.

1267 онд монголчууд түвдийн хүн амын тооллого хийсэн байна (Юаны үед 1287, 1334 онд хоёр удаа ийм тооллого хийжээ). Ийнхүү тооллого зохион байгуулахын тулд алтан пайз буюу «мандат» бүхий тусгай элч төлөөлөгчид явуулсан байна. Тооллогын дүнд татвар төлөгч хүмүүсийг буддын сүм хийдийн болон түвдийн феодалуудын албат хэмээн хуваасан байна. Татварын систем болон 10 мянга, нэг мянган айлын цэрэг-засаг захиргааны хувиарлалт тогтоов. Эзэнт гүрний нэгэн адил одоогийн Ганьсу мужаас түвдийн Сажа муж хүртэлх өртөө улааны систем бий болгов.

Энэ нь тухайн үедээ дэлхийн хамгийн тэргүүний шуудангийн систем байлаа. Улаач нэг өртөөнөөс нөгөөг хүртэл мориор довтолгож, тэнд морио солин дараачийн өртөө хүртэл явдаг ажээ. Өртөөнийхөн элчээр явж буй түвд, монголын түшмэл нарыг морь уналгаар хангана. Алс хол газар шуудан хүргэх нөхцөлд нэг улаач тухайн өртөөн дээр ирж өөр улаачид шилжүүлэх замаар уг шууданг цаг алдалгүй довтолгох ажээ. Тээврийн энэхүү систем Түвдэд 1956 он хүртэл хүчин төгөлдөр үйлчилсэн байна.[98] Лам нар албаны адууг дур зоргоор хэрэглэдэг байсан нь энэхүү албыг монголчууд хэр зэрэг сул хянадаг байсныг гэрчлэн харуулна.[99] 1311 онд үүнийг хориглосон хаант төрийн тушаал шийдвэр хүртэл гарч байжээ.

Эзэнт гүрний эрх баригчид XIV зууны эхэн үеэс түвдийн бурханы

шашны баяруудыг тохиолдуулан хоригдлуудыг суллах болсон бөгөөд энэ заншил удалгүй хятадын Шинэ жилд ч хамаарах болсон байна. Ийнхүү өршөөл үзүүлэх явдал хэтэрхий их болсон учир хэсэг хугацааны дараа эрх баригчид дахиад л хөндлөнгөөс оролцох хэрэгтэй болжээ. Түвдийн бурханы шашны лам нар түвддээ төдийгүй тус улсын хилийн чанадад ч хятад санваартнуудаас илүү эрх дарх эдэлж байсан тухай мэдээ бий билээ. Нөгөө талаас хятадын бурханы шашныг ч хөхүүлэн дэмжих болсон байна. Тухайлбал, Хятадын Сун улсын үед төрийн албан хаагчдад шилжүүлэн өгсөн шашны зан үйлийн олон барилга байшинг тус улсыг мөхсөний дараа лам нарт эргүүлэн өгчээ.

Монгол хэлэнд улам олон Түвд үг орж ирсэн нь хоёр ард түмнийг мөн тийм хэмжээгээр ойртуулсан байна. Монголчууд шинэ төрсөн хүүхэддээ түвд, тэрч байтугай энэтхэг нэр, тэр дундаа шашны агуулгатай нэр өгөх болов. Бурханы шашны адис хүртээсэн Түвд лам нар тийм нэр хайрлаж байсан нь тодорхой билээ. Монголчуудын зарим их хаад ч (Аюрбарибада, Судхибала, Госала, Ринчинбал, Аюширидара) тийм нэртэй байжээ. Цаашид монголын ард түмнүүдийн дунд бурханы шашин дэлгэрэхийн хэрээр тийнхүү нэр зээлдэн хэрэглэх явдал улам өргөжсөн байна. Одоо ч монголжсон Түвд нэр цэвэр монгол нэрнээс бараг цөөнгүй бизээ. Долоо хоногийн өдөр гаригийн нэр, зарим тооны нэр, уламжлалт цаг тооны бичиг зэргийн нэрийг Түвд хэлнээс авчээ.

Нөгөө талаар олон монгол үг, юуны өмнө феодалуудын цол хэргэм, албан тушаалтай холбоотой үгнүүд Түвд хэлэнд нэвтэрч орсон байна.

1327 онд Сажагийн тэргүүн Даньи Санпопэл нас барав. Түүний долоон эхнэрээс гарсан хөвгүүдийн хооронд эрх мэдлийн төлөө тэмцэл эхэлжээ. Энэ нь Ханбалыкын дотоодын тэмцэлтэй давхацсан байна.

Тэнд Хайсаны засаглалаас (1308 он) Тогоон төмөр хаан (1333 он) хүртэл найман хаан солигдсоны дотор 1328–1333 онд зургаан хаан бие биенээ халсан байна.[100]

Ийнхүү хаад ойр ойрхон солигдсон явдал Юань улсыг сулруулав. Юань гүрэн оршин тогтносон сүүлчийн жилүүдэд их хаан засаг төрийн хэргээс бүрэн тусгаарлагдаж, хаан ширээ нь ноёд, түшмэл нар болон хааны төрлийн олон хүний ширүүн тэмцлийн талбар болсон байна.

Хан хүү Тогоон Төмөр 1331 онд Гарма-Кагью сургуулийн тэргүүн III Ранжун Доржыг урьжээ. Тэрээр Юань гүрний сүүлчийн эзэн хаан болсон Тогоонтөмөрийг хаан ширээнд суулгах ёслолыг удирдан хийлгэсэн бөгөөд их хаан Тогоонтөмөр Бээжинд сууж төр удирдсэн түүхтэй билээ. Энэ үед

Түвдэд Сажа болон Кагьюгийн чиглэлийг баримтлагчдын хооронд засгийн эрхийн төлөө тэмцэл өрнөжээ. 1354 онд бурханы шашны Кагьюгийн чиглэлийг (сургууль) баримтлагч Жанчив Жалцан засгийн эрх булааж авсан байна. Юань гүрний эзэн хаан 1357 онд түүний статусыг хүлээн зөвшөөрчээ. Жанчив эзэмших газрын хязгаар тогтоож, газрын татварыг ургацын зургааны нэгтэй тэнцэх хэмжээгээр бодсон нэгдмэл систем бий болгож, зам, гүүр байгуулж, цагдаагийн эргүүлийн алба бий болгож, лам нарын сахилга батыг чангатгажээ.

Уналтад орсон Монголын эзэнт гүрэн Түвдэд нөлөөлж чадахгүй болжээ. 1351 онд хятадад улаан алчуууртнуудын бослого буюу монголын эзэгнэлийг эсэргүүцсэн тариачны өргөн хөдөлгөөн эхлэв. Энэ хөдөлгөөн өргөжиж, мөн янз бүрийн бүлэглэлийн удирдагчид үе үе өөр хоорондоо дайсагналцаж, мөн үүний нэгэн адил бие биендээ дайсагнасан монгол цэргийн жанжнуудтай сүлбэлдэх болов. Энэ тэмцлээс хятад лам жу Юаньжан ялагч болон гарч иржээ. 1368 онд Тогоонтөмөр хаан Бээжингээс зугтаж гарав. Бээжинг орхиж явахдаа түүний уйлан хайлж хэлсэн үг хадгалагдан үлджээ.[101]

Мин улсын анхны эзэн хаан жу Юаньжан урьд өмнө Тан улсад түвдчүүд халдаж байсан тухай санаж явуулсан илгээлтдээ Хятадад засаг солигдсон тухай зарлан мэдээлсэн байна.[102] Тэрээр Шэньси мужийн захирагчийг Түвд рүү илгээж, Юань гүрний үед тамгын газруудад ажиллаж байсан хүмүүсийг хятадын нийслэлд ирж, эзэлж буй албан тушаалаа баталгаажуулахыг анхааруулсан байна гэж “Мин ши” он дараалын бичигт өгүүлжээ.

1374 оны наймдугаар сарын 23-нд түшмэл Вэй Жэнийг Хэйжоугийн гвардын командлагчаас районы цэргийн комиссарын албан тушаалд дэвшүүлсэн бөгөөд тэрээр Хэйжоугийн хамгийн өндөр тушаалын түшмэл болж, Хэйжоу, До-Кам, У-Цанг, өөрөөр хэлбэл бүх Түвдийг удирдлагадаа авчээ гэж[103] “Мин-Ши” бичигт өгүүлсэн байна. Гэтэл энэ түшмэлийн нэр түвдийн түүхийн ном зохиолуудад байдаггүй бөгөөд удирдлагын тамгын газрууд Түвдэд биш, харин Хэйжоу болон Сининий ойролцоох хил хавийн районуудад байжээ. Энэ хоёр нутаг Түвдэд улс төрийн бодит бүтэц болж байгаагүй ажээ. Түвдэд Мин улсын улс төрийн эрх хэзээ ч байгаагүй, хятадын хууль, татварын систем ч байгаагүй юм. Энэ нь Түвд энэ үед ч бие даасан улс байсныг гэрчлэн харуулна.[104]

Мин улсын анхны эзэн хаад Хятадын Тан улсыг дотоод, гадаад бодлогын загвар болгон ашиглаж байсан бололтой юм.[105] Түүний зэрэгцээ тэр хаад бурханы шашинтнууд байсан бөгөөд хятадын болон түвдийн бурханы шашныг тэгш эрхтэй хэмээн үзэж байжээ. Бээжинд бурханы

шашны цутгамал бурхад бүтээж, буддын “Ганжуур” судар хэвлэн гаргаж байв.[106] Гарма Кагьюгийн талыг баримтлагчид Бээжинд амьдарч байв. 1407 онд тэдгээрийн удирдагч Кармапа IV Дешин Шегпаг Нанжин хотод урин ирүүлж, тэрээр эзэн хаан Жу Ди-гийн эцэг, эхийн дурсгалд зориулсан ёслол үйлдсэн байна. Хятадын эзэн хаан болон түүний хатан IV Кармапад шавь орсон байна. Жу Ди түүнд “Шашны үнэт эрдэнэ, Баруун зүгээс ирсэн аугаа их өрөвч сэтгэлтэн, дэлхийн хүчирхэг Будда” хэмээх цол шагнажээ.[107] Эзэн хаан түүнд түвдийг захирах эрх, Хятадын бурханы шашны дээд суудал санал болгожээ. Кармапа түвдийн бурханы шашны бусад чиглэлийг дарах хүсэлгүй байна гэдгээр шалтаглан тэр саналыг хүлээж аваагүй байна.

Жу Ди мөн Гэлуг сургуулийг үндэслэгч Цонкапыг (Зонхов) урьсан боловч тэрээр энэ саналыг хүлээж аваагүй ажээ. Хэрэв Түвд нь Мин улсын нэг хэсэг байсан бол Зонхов ингэж чадахгүй байсан бизээ. Хоёр дахь урилга ирсний дараа Зонхов өөрийн төлөөлөгч буюу шавь Шагжаа Ишийг явуулжээ. Тэр хүн эзэн хааны хувийн лам болсон байна. Түүнд: “Бүхнийг мэдэгч, Орчлонгийн уужим сэтгэлт, сонор соргог илбэн тохинуулагч, аугаа их нигүүлсэнгүй үзэлт, бүхэнд хүндлэгдсэн, Баруун зүгийн ариун явдалт, бат бэх хаант улсын аугаа их хан хүү, лам, эзэн хааны аугаа их лам Жамчин Цорж”[108] цол шагнан олгожээ.Тэр лам их бэлэг сэлт ачиж Түвдэд буцаж ирсэн байна. “Мин-ши” он дараалын бичигт энэ тухай бичихдээ тэр үеэс хойш баруун зүгийн орнууд түүнд захирагдах болсноо хүлээн зөвшөөрсөн юм хэмээжээ.[109] Бодит байдалд бол энэ лам улс төрийн ямар ч эрх мэдэл аваагүй ажээ. Мин улсын эрх баригчдаас түвдчүүдэд олгож байсан цол хэргэм нь эрх мэдэл олгодоггүй, зөвхөн нэр төрийн төдий зүйл байжээ.

Түвдийн шашны удирдагчид Мин улсын бусад эзэн хаадтай «багш – ивээн тэтгэгчийн» харилцаанд орж байсан тухай мэдээлэл байдаггүй. Хятад, Түвд улсууд улс хоорондын ямар нэгэн гэрээ байгуулаагүй юм байна. Энх тайвнаар зэрэгцэн орших явдал хоёр оронд аль алинд нь ашигтай байжээ. Түвд дотоодын асуудал буюу засгийн эрхийн төлөө омгуудын хоорондын тэмцэл, Мин улс монголчуудтай хийх сунжирсан дайнаас болоод гэрээ хэлэлцээр байгуулах зав зай ч үгүй байжээ. XIV зууны хоёрдугаар хагаст хятадын эрх баригчид Мин улс болон Түвдийн хооронд хилийн харуулын шугам тогтоожээ. Хил дээр хятад цайг Түвд адуугаар (монголчуудтай байлдахад хэрэглэх зорилгоор) сольж арилжих зах зээлүүд бий болов. 1407, 1414 онд эзэн хаан Жу Ди Түвдтэй шуудангийнхаа харилцааг сэргээх хүсэлтээ илэрхийлсэн байна.

Хоёр орны хооронд элч нар солилцож, түвдчүүд худалдаа наймаа

хийх, цол гуншин, хөлс цалин авахаар Мин улс руу дуртайяа явдаг байв. Мин улсын хууль тогтоомж худалдааны үйл ажиллагааг нарийвчлан заан тогтоож, тухайлбал, хятад цайг Түвд адуугаар солих үйлдлийг зааж өгсөн байв.[110] Түвдийн хилээр дамжуулан цай дамлан наймаалсан хятадууд хатуу цээрлэл, түүний дотор дөрвөн мөчөө тас цавчуулах ял хүлээдэг байжээ. Түвдчүүдэд цай худалдахын тулд хил орчмын нутгуудад нууцаар очиж суурьшсан хүмүүсийг баривчлан цөлдөг байв. Тийнхүү түвдчүүдтэй хийх худалдааг өөр оронтой хийх худалдаа хэмээн үздэг байсан нь тодорхой болж байгаа юм. Мин улсын эрх баригчдаас олгож байсан наймаа арилжаа эрхлэх эрхийн алтан пайзыг түвдчүүд олонтоо «гээдэг» байсан нь тэд ийм арилжаа эрхлэх хүмүүсийн тоог өргөжүүлэх хүслээр бусдад худалддаг байсан бололтой юм.

XV зууны дунд үед жил бүр 3–4 мянган хүн түвдээс Бээжинд «бэлэг барьцтай» ирдэг байв.[111] Түвдчүүд адуу, ноосон даавуу, эсгий болон орон нутгийн бараа таваар бэлэг болгон авчирч, хятадын хааны ордныхон үүний хариуд ихээхэн өгөөмөр сэтгэл гаргадаг байжээ. Мин улсын эзэн хаад Түвдтэй бусад тусгаар тогтносон улсуудын нэгэн адил түвшинд харилцдаг байсан юм.[112] Дээр дурдсан солилцоо орон нутгийн засаг захиргаадын хувьд яршиг түвэгтэй болж ирсэн бололтой юм. Тийнхүү 1569 онд алба гувчуур, өглөг барьцын хэлбэрээр элдэв бараа сэлт баригсад жилд гурван удаа л орж ирж байх тухай эзэн хааны хууль гарч, тэдгээрийн тоог хязгаарлаж, явах замынх нь зургийг ч нарийвчлан тогтоожээ.[113]

XV–XVI зууны сүүлчээр Түвдэд шашны үзэл бодлын үүднээс л дотоодын тэмцэл хөдөлгөөн гарч байжээ. Шашны аль нэгэн чиглэлийнхэн (сургуулийнхан) ялахад ялагдсан талынхан «малгайгаа солих», өөрөөр хэлбэл нөгөө талынхны шашинд орох ёстой болдог байжээ. Гэлуг сургуулийнхан зонхилох байр суурь эзэлдэг У мужийн цэрэг, Кагьюгийнхан давамгайлдаг Цангийн цэрэгтэй байлдах жишээтэй юм.

Юань гүрэн нуран унаж байсан хэдий ч монголчууд хүчирхэг хэвээр байв. Түвдчүүд хүчирхэг хөршүүдийн дотроос соёл иргэншлийн хувьд хятадуудыг бодоход монголчууд өөрсдөд нь илүү ойр дөтийг ойлгож байсан нь маргаангүй билээ. Хөх нуурын районд илүү идэвхтэй хэлхээ холбоо хөгжиж байсан бөгөөд тэнд тасралтгүй дайн тулаан болж байсны улмаас Түвд-Монгол – түрэг овог аймгийн холимог хүн амын бүтэц байнга өөрчлөгдөж байв. Хөх нуурын ард түмнүүд, ялангуяа монгол, түвдчүүдийн дунд бурханы шашин умард зүгийн монгол аймгуудынхыг бодоход илүү түргэн дэлгэрсэн байна. Түвдийн бурханы шашны янз бүрийн чиглэлийн

(сургуулийн) лам нар монголчууд дээр үргэлж ирцгээнэ.

1543 онд Лхасаас холгүй орших Толунгд ирээдүйн гуравдугаар далай лам Содномжамц мэндэлжээ.[114] Түүнийг Дрепун хийдийн түрүүчийн тэргүүн хамба Гэндэнжамцын хойд дүр хэмээн хүлээн зөвшөөрчээ.Тэр баньд энэ хийдэд шавилан суух болж удалгүй багш, эрдэмтний гайхашигт авьяас чадвараа илрүүлэн гаргажээ. Тэрээр Дрепун хийдийн хамба болж, алдар нэр нь түгэн тархав. Түүнийг зуучийн үүрэг гүйцэтгэж өгнө үү хэмээн олонтоо хүсдэг байж. Энэ хүн, цус асгарах явдал болон хүчирхийллийг олон удаа сэрэмжлэн зайлуулж чадсан байна. Жишээ нь, тэрээр 1559 онд Кагью, Гэлуг чиглэлийн талынхны хооронд гарч болох мөргөлдөөнийг сэрэмжилжээ. 1562 онд Кийчу гол хамгаалалтын даланг сэт татан Лхас хот усанд автав. Содномжамц өөрийнхөө талын хүмүүстэй хамт үерт нэрвэгдэгсдэд ихээхэн тусламж үзүүлж, даланг засч сэргээхэд тусласан байна.

XVI зууны 30-аад онд баруун монголчууд буюу ойрдууд Хамийн районд хийсэн дайнд ялагдал хүлээж, тэдний зарим нь Хөх нуур руу зугтажээ. 1550 онд Алтан хаан хэмээх цол авсан түмэдийн захирагч Анда (1507–1582) Хөх нуурт очсон байна. Тэр үед түмэд аймаг ойрдуудын бүрэлдэхүүнд орж байв. Алтан хаан «бага хаан» хэмээх цолтой байжээ. Тэрээр бурханы шашинд орохдоо эрх мэдлээ бататгаж, энэхүү итгэл үнэмшлийг дэлгэрүүлнэ хэмээн найджээ. Түүний нүдэнд Годан болон Хувилай хааны дүр төрх харагдсан нь маргаангүй юм. 1576 онд Алтан хааны талынхан түүнд хандаж: «Цас мөсний оронд <...> Бүхнийг харагч, Нигүүлсэл сэтгэлтний жинхэнэ хойд дүр амьдран суудаг хэмээлдэх юм. <...>

Түүнийг урин залж, Хувилай цэцэн хаан, гэгээн Пагва лам нарын үеийнх шиг шашин, төрийн холбоо тогтоовол гайхалтай байхсан бусуу» хэмээжээ. [115]

Ойрдууд Содномжамцад урилга гардуулах өргөн бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид явуулав. Тийнхүү Содномжамц 1577 онд Дрепун хийдээс хөдөлсөн байна.[116] Түүнийг угтаж авахын тулд Хөх нуурын Цабчаал хэмээх газарт тусгай сүм барьжээ. 1578 онд Содномжамц бараа бологчдынхоо хамт Монголд хүрэлцэн иржээ. Түүнийг Алтан хааны элч нар тосож авсан байна. Хэдэн өдрийн дараа хаан өөрөө нэг мянган морьт цэргийн хамт хүрэлцэн ирж Содномжамцыг угтан мэндчилсэн байна. Дараа нь тэд Алтан хааны нийслэл Хөх хотод очив. Алтан хаан болон түүний хүмүүс бурханы шашинд орж, Содномжамц тэдэнд адис хүртээсэн байна.Содномжамц хаанд хандаж урьд насандаа та Хувилай хаан, харин би Пагва лам байжээ хэмээн хэлжээ.


Гуравдугаар Далай лам Содномжамц

Шашны ёслол үйлдэж, баяр хүргэсний дараа Алтан хаан тунхаг гаргав. Түүнд:[117] «Тэнгэрийн заяат гаралтай монголчууд бид сүр хүчтэй, аугаа их Чингис хаан эзэнт гүрнээ Хятад, Түвд хүртэл өргөтгөн байгуулсан билээ. Бид Сахья Бандидыг ивээлдээ авсан эрт дээр цагт бурханы шашин анх удаа бидэнд ирсэн юм. Хожим нь Төмөр хааны засаглалын үед манай ард түмэн шашин шүтлэггүй болж, манай орон уналтад орж, цусан далай манай газар нутгийг бүрхэх мэт болсон билээ. Таны энэ удаагийн айлчлал бурханы шашнаа сэргээхэд бидэнд тусалж байна. «Ивээн тэтгэгч – лам»-ын уриан доорхи бидний харилцааг Нар, Сарны харилцаатай зүйрлэж болно. Цусан далай Сүүн далайгаар солигдлоо. Эдүгээ энэ оронд аж төрөн сууж буй түвд, хятад, монголчууд Ариун Буддагын сургаалийн арван зарчмыг баримтлах ёстой юм» хэмээн өгүүлжээ. Алтан хаан энэхүү тунхагт «монголын нийт ард түмний» даган мөрдөх дүрмийг тогтоосон бөгөөд энэ дүрмээр нас барсан хүний эхнэр, албат зарц нар, аргамаг хүлэг болон мал адгуусаар овоо тахих, онгон шүтээн дуудах зэрэг бөөгийн шашинтнуудын үед мөрдөж байсан зан заншлыг халсан байна. Энэхүү онгон шүтээнийг устгаж, түүний оронд айл гэр бүрт Махгал бурхан залж шүтэж байхыг тунхагт зарлиг болгожээ. Хүн хороож овоо, сүлд тахисан этгээдийг цаазлах, мал хороож тахивал түүнийг арав нугалж төлүүлэх торгууль оноох, онгон шүтээн хадгалсан айлын гэрийг шатаах зарлиг буулгав. Хөршүүдээ хүндэтгэж, тэдний мал хөрөнгийг хулгайлахгүй байх зарлиг буулгажээ.

Алтан хаан Содномжамцад Далай лам цол хүртээсэн байна. Алтан хаан «жамц» хэмээх Түвд үгийн орчуулгыг харгалзан үзээд ийм цол бэлэглэсэн бөгөөд энэ үгийг орчуулахад мөн л «далай» хэмээх утга илэрхийлэгдэх ажээ. Содномжамцын өмнөх хоёр төрөлд энэ цолыг нэхэн олгосон учир Содномжамц III Далай лам болжээ.

Тэрээр «Очир Баригч, Далай лам» гэсэн бичигтэй тамга хүлээж авсан байна. Хариуд нь Содномжамц Алтан хаанд «Шашны хаан, Брахма-бурхадын тэргүүн» хэмээх цол бэлэглэж, түүний залгамжлагчид 80 жилийн турш бүх Монгол хийгээд Хятадыг захирах болно гэж лүндэн буулгажээ.[118]

Интернетэд энэ үйл явдлын тухай инээдтэй тайлбар тарааж байна: «Хятадын эзэн хаан хожим нь өөртөө Далай лам, бүх Түвдийг захирагч хэмээх цол олгосон албан тушаалд дуртай 25 настай залуу буюу Аугаа их ламыг дэмжихээр Түвд рүү арми илгээсэн юм. Үүнд л түүхэн тавилан оршиж байгаа бөгөөд анхны Далай ламыг хятадын арми дэвшүүлэн тавьсан юм»[119] гэж энэхүү тайлбарт өгүүлжээ. Уншигч авгай нар энэхүү тавилан гэгчийг өөрсдөө дүгнэн үзэж чадах билээ. Тэгэхдээ энэ бол түүхэн биш, харин суртал нэвтрүүлэг – боловсруулалтын чанартай «хувь тавилан» гээч мөн бизээ.

Алтан хааныхаас гарч буцах замдаа Далай лам Мин улсын мэдэлд байсан Ланьжоу хотоор оржээ. Хятадууд түүнийг хүндэтгэн угтаж, Алтан хаанд нөлөөтэй хүн болсныхоо хувьд манай орон руу чиглэсэн монголчуудын халдлагыг сулруулж өгнө үү хэмээн хүссэн байна. БНХАУ-д энэ тухай: «Мин улсын төв засгийн газар түүнд [Далай ламд – зохиолч] алба гувчуур төлөхийг зөвшөөрснөөрөө онцгой эрх дарх олгосон юм»[120] гэж бичиж байна. Хятадын эрх баригчид цэргийн яамны орлогч сайдынхаа хэлснээр Алтан хааны авч хэрэгжүүлсэн алхамуудыг дараах байдлаар сайшаан дэмжсэн байна:[121] «Түвдийн лам нар зэрлэг ард түмэнтэй эвийг нь олон харьцаж, тэднийг ёс журамтай хүмүүс болгоход амжилтад хүрч л байг. <...> Алтан хаан руу ирүүлж буй лам бүрт бурханы шашны хэрэг эрхлэх ерөнхий газраас тодорхой албан тушаалын цол олгож, <...> зэрлэгүүдийн санаанд нийцүүлэхийн тулд тэдгээр лам нарт тусгай хувцас гаргаж өгч байх нь чухал юм <...> ингэсэн цагт алба гувчуурын тухай хэлэлцээр хавьгүй сайн мөрдөгдөх бөгөөд хил дээр ч ямагт амгалан тайван байх болно» гэжээ. Юань болон Мин улсуудын хооронд залгамж шинж чанар байгаагүйг энэ бичвэр дахин нотолж байна.

Алтан хааныг таалал төгсөхөд Содномжамц 1582 онд монголчуудын хааны өргөөнд дахин морилон ирлээ. Зургаан жилийн дараа Лхас орохоор гарсан боловч зам зууртаа насан эцэслэжээ. Тэрээр Монголд Алтан хааны гуч болж дахин төржээ. Тийнхүү монгол хүн Ёндонжамц нэрээр IV Далай лам (1589–1617) болсон түүхтэй юм. Хүүгийн эцэг, эх түүнийг дэндүү балчир байна хэмээн шалтаглаж Түвдийн төлөөлөгчдөд өгч явуулахаас татгалзсан байна.Тиймээс Түвд лам нар хүүг эхний үед Монголд номд сургажээ.[122]

Ингээд 1601 онд түүнийг монголчууд дагалдан хамгаалж Лхаст хүргэж, Далай ламын сэнтийд залсан бөгөөд тэндээ амьдран сууж, ном эрдэмд боловсорсон байна. Залуу хөвгүүнийг Дрепун хийдэд эрдэм номтой

болгожээ. Түүний багш Дашлхүмбэ хийдийн Лувсан Чойжалцан гэдэг хүн байв. Ёндонжамц багшдаа Банчин лам – “Цэцэн багш” цол олгосон байна. Дашлхүмбэ хийдээс зээлдэж авсан хятад уламжлалаар бол Лувсан Чойжалцанг IV Банчин лам гэж үздэг бөгөөд учир нь түүний өмнөх дүрүүдэд энэ цолыг нэхэн олгож байсан гэж үздэг ажээ. Гэтэл түвдчүүдийн бусад нь түүнийг I Банчин лам хэмээн үздэг бөгөөд үүнээс болж хятадын болон түвдийн олонхи эх бичгүүдэд Банчин ламын дэс дарааллын асуудлаар санал зөрөлдөөн гарсаар иржээ.

1615 онд хятадын эзэн хаан Жу Изюнь (засаглалын уриалал – Вань-ли) Далай ламд элч илгээж, Нанжин хотод байгуулсан бурханы шашны сүмийг аравнайлуулахаар түүнийг урьсан байна. Далай лам энэ урилгаас татгалзсан боловч өөрийнхөө хийдээс уг сүмийг адислах зөвшөөрөл өгч, үүнийхээ ч дагуу хятад улсын зүг харан сууж ном уншаад будаа цацаж ёслол үйлджээ.[123] 1617 онд IV Далай лам 28 насандаа Дрепун хийдэд ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн байна. Түүний цогцосыг чандарлаж, чандарын хагасыг тусгай бортогонд хийж Түвдэд байрлуулж, нөгөө хэсгийг Монголд авчирч, түүний эцэг болон Түмэдийн тайж цолтой ивээн тэтгэгч төрийн түшмэл (тайж) хоёрт хувааж өгсөн байна.

Түүний хойд дүрийг 1619 онд Төв Түвдээс олсон боловч дараах шалтгаануудын улмаас хэсэг хугацаанд нууцалсан байна. Цанг мужийн захирагч Пунцаг Намжил (Гарма Кагью чиглэлийг баримтлагч) тухайн үедээ IV Далай ламд бараалхах гэхэд шадар туслахууд нь зөвшөөрөөгүйд дургүй нь хүрч явдаг байжээ.[124] Пунцаг Намжил 1618 онд өөрийнхөө талын хүмүүсийг цуглуулж монголчууд руу халдан Лхас хотыг эзэлж авчээ. Дрепун болон Сэр хийдийн лам нар, энгийн иргэд зэрэг олон хүн амь эрсдэж, Гэлугийн чиглэлийн хэд хэдэн хийд Гарма Кагьюгийнх болж, Гэлуг сургуулийнханд орон нутгийн хязгаарлалтууд тавьжээ. Дараа жил нь Түвдэд монголчуудын отряд ирсэн байна. IV Далай ламыг дагалдан хамгаалж ирсэн хүмүүс буцаж, үлдсэн хэсэг нь Цанг мужид халдсан боловч хоёр талын алин нь ч ялалт байгуулж чадаагүй байна. Монголчууд Лхас хотын дэргэд хуарагнан буужээ. Банчин лам найрамдлын хэлэлцээн дээр зуучлагчаар оролцов. Лхас хотыг хэнд нь ч өгөхгүй, булаан авсан сүм хийдүүдийг Гэлуг сургуульд буцааж өгөхөөр тохиролцсон байна.[125] 1621 онд Пунцаг Намжилыг нас барснаас хойш Гарма Кагью болон Гэлугийн талынхны тэмцэл далд байдалд оржээ.

1635 онд ойрд аймгуудын холбоо баруун монголд Зүүнгарын хаант улс байгуулснаа зарлан тунхаглав. 1634–1635 онд Хөх нуурт Гарма Кагьюгийн



Тавдугаар Далай лам
Агваан Лувсанжамц

талыг баримтлагч халх монголчуудын Цогт тайж гарч ирсэн байна. Тэрээр хүүгийнхээ хамт Гэлуг чиглэлийнхнийг устгахаар шийджээ. Халх монголчууд ойрдууд буюу Зүүнгарынхантай байлдах гэж буйг мэдсэн Гэлуг сургуулийн элч нар ойрдуудаас дэмжлэг хүсэхээр очжээ. Ингээд Гүш хаан болон баатар Хунтайж тэргүүтэй хошуут аймгийн ойрдуудын аян замын корпус Түвд рүү хөдөлсөн байна. Гэвч Цогт тайжийн хүү Арслангаар удирдуулсан 10 мянган хүнтэй корпус Түвдэд түрүүлж оржээ. Гүш хаан, Арслан нар хэлэлцээ хийсний дүнд Арслан их цэргээ Тэнгэр нуурын дэргэд үлдээж, зөвхөн бие хамгаалагч нарынхаа хамт Цангд ирсэн байна. Үүнийг мэдсэн Кармапа Лхас хотоос зугатаж явжээ. Арслан мөргөлчний дүрээр Лхаст ирж, V Далай лам Лувсанжамцад бараалхаж, адис хүртсэний дараа Дрепун хийдэд очиж Гэлугийн сургааль сонсож, эцгийнхээ захиасыг үл огоорон Гэлугийн сургаальд үнэнч явах ам тангараг өгсөн байна. Цангийн захирагч ийнхүү Арслангийн «урвасан» тухай Цогт тайжид мэдээлж, өөрөө цэргээ удирдан Лхаст орсон байна. Далай лам өрсөлдөгч талуудыг эвлэрүүлж чаджээ. Хожим нь эцгийнхээ үгэнд ороогүй Арсланг алсан байна.

Гүш хаан ч мөн мөргөлчний дүрээр Лхаст ирсэн байна.Тэнд Гүш хаан V Далай лам болон IV Банчин лам нартай уулзав. Тэдний боловсруулсан төлөвлөгөө ёсоор бол Гүш хааны цэрэг эхэлж Хөх нуур хүрч Цогт тайжыг бутцохиод, дараа нь Беригээс тэндхийн захирагч Донье Доржийг (буддистуудыг мөрдөн хавчдаг бон шашны талыг баримтлагч) хөөж гаргахын тулд Кам руу, дараа нь У-Цанг руу орох ёстой байлаа. Зүүнгарынхан энэ төлөвлөгөөг биелүүлж, Цогт тайжын цэргийг бутцохин түүнийг хөнөөсөн байна. Үүний дараа Баатар хунтайж Зүүнгарт эргэн ирж, харин Гүш хаан Хөх нуурын захирагч болж Түвд рүү явсан байна.

1638 онд Гүш хаан дахин Лхаст очиж мөргөсөн байна. Далай лам түүнд адис хүртээж, «Шашны хаан, буддын итгэл үнэмшлийг хадгалагч» хэмээх цол, тамга шийтгэн олгож, харин Гүш хаан Далай ламын түшмэл нарт засаг ноён, тайж, да лам, даян хаан[126] цол олгосон байна. Энэ үед Гүш хааны гарт нэгэн захидал орсон бөгөөд тэнд Цанг, Кам мужууд Гэлуг чиглэлийн

шашинг устгаж, боныг оролцуулан бусад итгэл үнэмшлийг эрх чөлөөтэй болгохын тулд өөр хоорондоо нэгдэхээр шийдсэн тухай өгүүлжээ. Гүш хаан Кам руу дайнаар очихоор шийдэж, Далай ламын зөвшөөрлийг авсан байна. Амдо мужийн түвдчүүд ч хошуутын монголчуудтай хамтран Кам руу оров. Цус асгаруулсан тулалдааны эцэст Кам эзлэгдэв. Энэ зуурт Гүш хаан Цангийг авахаар шийдэв.

Далай лам, Банчин лам нар зуучилсан боловч энэ шийдвэрийг өөрчилж чадаагүй бөгөөд санаачлага монголчуудын талд байсан юм. 1642 онд монголчууд Далай ламын цэрэгтэй хамт амжилтад хүрч, Далай лам Шигазе руу явсан байна.

Хотоос гарснаас хойш хоёр хоногийн замд түүнийг Гүш хаан, Төв Түвдийг эзлэн авахад монголчуудад тусласан Далай ламын түшмэл Содном Чойжил нар өөрийнхөө хүмүүсийн хамт углаж, томоохон ёслол үйлдсэн байна.[127] Шигазегийн ойролцоо тэднийг 600 орчим монгол морьт цэрэг, То, У, Цанг мужийн өндөр албан тушаалын түшмэд уган авч, гудамжны хоёр талаар лам нар эгнэн зогсож, энгийн иргэд үндэсний бүжгийг бүжиглэж байв. 1642 онд Далай ламыг сэнтийд нь ёс төртэй залж суулгасан байна. Далай лам сэнтийдээ заларч, түүний хоёр талаар Гүш хаан, Содном Чойжил нар эгнэн суусан байна. Гүш хаан V Далай ламд бэлэг өргөн барьж, зүүн зүгийн Дарцедогоос баруун зүгийн Ладак хүртэлх бүх Түвдийн бүрэн эрх түүнд шилжин очиж байгааг зарлан тунхаглав. Улс төрийн удирдлага Содном Чойжилд үлдсэн байна. Түүнд дэси буюу тэргүүн сайдын цол шийтгэн олгов. Далай лам засгийн газраа эмхлэн байгуулаад Лхаст эргэж ирсэн байна. Тэрээр Дрепун хийдэд олны өмнө үг хэлэхдээ Лхасыг Түвдийн нийслэл хэмээн албан ёсоор зарлан тунхаглажээ. Тэрээр дагаж мөрдөх хууль тогтоомжуудыг заан нэрлэж, тойргуудын захирагч, засгийн газрын сайд нарыг томилов. Тийнхүү Далай лам анх удаа Түвдийн шашин, төрийн удирдагч болсон байна. V Далай лам болон түүний талынхан хошуут монголчуудыг улс төрийн хэрэгт хөндлөнгөөс оролцдоггүй цэргийнхний явцуу хүрээ болгон Түвдэд үлдээх сонирхолтой байв.[128]

Гарма Кагьюгийн талыг баримтлагч зарим хүмүүс шинэ засгийн эсрэг боссон ч ялагджээ. Дараачийн жилүүдэд Түвд дэх Далай ламын эрх мэдлийг Балба, Сикким хүлээн зөвшөөрч, харин түвдчүүд монгол цэргийнхний дэмжлэгтэйгээр Гималайн нурууны өмнөд этгээдэд байдаг түвдийн Бутан улсын хэрэгт хөндлөнгөөс оролцох гэсэн боловч амжилтад хүрээгүй ажээ. Дараа жил нь түвд, бутанчууд найрамдлын гэрээ байгуулж, хоёр талын харилцааг мөргөлдөөн гарахаас өмнөх байдалд оруулсан байна.

Гэвч дараа жил нь дахин дайн гарав. Түвдчүүд Паро-г эзэлсэн боловч бутанчууд тэднийг цөм цохижээ.

1645 онд Гүш хаан Банчин ламд Банчин богд цол олгосон байна. Тэр жил Лхас хот дахь 638 оны хааны ордны балгас байсан газарт Будалын ордонг барьж эхэлжээ. V Далай лам улс орноо төвлөрүүлэх бодлого баримталж бурханы шашны Гэлуг чиглэлийг засаг захиргааны арга хэмжээгээр бусад чиглэлээс дээгүүрт тавьж чадсан байна.

Тухайлбал, тэрээр Жонанг чиглэлийн шашинг хориглож,[129] түүний сүм хийд, Кагьюгийн хэд хэдэн хийдийг Гэлугийнхэнд шилжүүлэн өгчээ. Камын хүн ам Лхаст төвтэй засгийн газарт татвар төлөх болжээ.

❁

Эртний болон дундад зууны үед Түвд хэзээ ч бусад улсын нэг хэсэг байгаагүй билээ. Харин түвдчүүд оршин суудаг зарим нутаг дэвсгэр дундад зууны хятад болон монгол улсуудын бүрэлдэхүүнд орж байжээ. Түвдтэй өрсөлдөж, заримдаа тус улстай тэгш эрхт харилцаатай, заримдаа цэрэг дайны ялагдал хүлээж байсан боловч хэзээ ч түүнийг эрхэндээ оруулж байгаагүй хятадын Тан гүрэнтэй Түвд нягт хэлхээ холбоотой явж иржээ. Түвдтэй Мин улсын холбоо зөвхөн түүний дээд эрх баригчид түвдийн зарим лам нартай хувийн харилцаа тогтоох, цол зэрэг олгож, бэлэг солилцох, хилийн худалдаа хийх зэргээр хязгаарлагдаж байлаа. Хятадын бусад улстай бараг хэлхээ холбоогүй байжээ. Түүнээс гадна монголын улсуудыг бодвол дундад зууны хятадын улсууд түвдчүүдийн хувьд "сэтгэл татах төв" болж чадаагүй ажээ.

Нөгөө талаас түвд, монголчууд соёл иргэншлийн нэгдмэл чанарт цомтгогдох болов. Угсаатны холбоо, ертөнцийн ойлгоцын адил төстэй байдал төдийгүй аль ч шажныг хүлцэх чанар үүнд ихээхэн хэмжээгээр нөлөөлжээ. Жишээ нь, Мөнх хаан: "Бурхан бидний гарт янз бүрийн хуруу хайрласны нэгэн адил хүмүүст ч янз бүрийн зам заяажээ"[130] хэмээн хэлсэн байна. Зарим нэг ёс жаягийн ялгаатай ч түвдийн бон, монголын бөөгийн мөргөл дэлхийн хамгийн хүлцэнгүй шашин – буддизмыг бишрэн шүтэх болсноос хойш ч хадгалагдан үлджээ. Бурханы шашин шүтэгч Энэтхэгийн алдарт Ашока хаан (манай эриний III зуун) нэгэн зарлигтаа (лүндэн).[131] "Аливаа өөр итгэл үнэмшлийг хүндэтгэх ёстой <...> өөрийнхөө итгэл үнэмшлийг хүндэтгэж, итгэл үнэмшилдээ үнэнч байгаагийн шинж тэмдэг болгон бусдынхыг үгүйсгэдэг хэн бүхэн <...> итгэл үнэмшилдээ тун их хор хүргэж байгаа юм. Тиймээс ч эв найрамдал зөвхөн хүмүүс нэгний болон

нөгөөгийн хуулийг сонсож, түүнийг дагах дуртай байвал л ашигтай" хэмээн бичжээ. XVII зуунд католик шашны лам нар номлол айлдах зорилгоор Түвдэд ирж байжээ.

Тэдний үйл ажиллагаа амжилттай төгсөөгүй ч түвдийн эрх баригчид Энэтхэг рүү амар тайван буцахад нь туслан шаардлагатай бүхнээр хангаж, хамгаалалтын хүмүүс хүртэл гаргаж өгдөг байжээ. Тэр үед Европт буюу арабын дорно дахинд... аливаа шашныг хүлцэх иймэрхүү хандлага гаргана гэдэгт итгэхэд бэрх билээ.

Монголчууд улс орноо нэгдмэл удирдлагын дор нэгтгэхэд түвдийн ард түмэнд нэг бус удаа туслаж байв. Тэдний энэхүү үйл ажиллагаа Түвдийг төвлөрүүлэхэд төдийгүй Сажа, дараа нь Гэлуг чиглэлийн шашны байр суурийг дээшлүүлэхэд, цаашлаад Түвд-Монголын соёл иргэншлийг хөгжүүлэхэд тус дөхөм болжээ. Гэсэн хэдий ч зарим зохиогчид өнөөдөр ч:[132] «XIII зуунд Хувилай хаан Түвдийг хятадад нэгтгэсэн... Хятадын эзэн хаан Түвдэд бэхжихийг хүсэж сүм хийдийн тэргүүн нарын дунд түшиг тулгуур олохыг эрмэлзэж байсан. Тийм хүмүүс хожим нь далай лам хэмээх цол авч байсан» гэж бичиж байна. Энэ бүхэн худал билээ. Түвд орон тухайн үедээ хятадын биш, харин монголын улс байсан Юань гүрний нэг хэсэг ч байгаагүй юм.

XVII зууны эхний хагаст Түвдэд болсон үйл явдлыг заримдаа шашны дайн, бурханы шашны үл тэвчих шинж чанарын жишээ болгон гаргадаг.[133] Гэвч энэ бүгдийг үнэн хэмээн үзэж болохгүй юм. Төв Түвдийн засгийн эрхийн төлөө өрсөлдөгч янз бүрийн хүчний хооронд дайн гарч байсан боловч харин энд шашин нь үзэл суртлын зөвтгөх шалтгаан байсан юм. Эдгээр дайнд «ялагдсан шашны» талынхныг хүйс тэмтрэн устгах явдал гарч байгаагүй юм. «Ялагдсан» итгэл үнэмшлийн талыг баримтлагч энгийн иргэдийг үзэл суртлын үүднээс устган хөнөөж, гэсгээн цээрлүүлдэггүй байжээ. Хэрэв Түвдэд шашны бус шалтгаанаар дайн гарсан бол л цус асгаруулах явдал гарах байсан бизээ.

Өр нимгэн сэтгэлтэй бодьсад удирдагчийн (өөрөөр хэлбэл Далай лам – Арьяабалын хувилгаан) үзэл баримтлал л Түвдийг нэгтгэх цорын ганц боломжтой хувилбар байсан нь тодорхой юм.[134] Монголчуудын тухайд ч ийм байсан хэмээн хэлж болно. Бурханы шашинд орсноос хойшхи энэ хоёр орны улс төрийн амьдралд чухамдаа эргэн төрж байсан өндөр зиндааны лам нар л улам өсөн нэмэгдэх үүрэг гүйцэтгэж иржээ. XX зууны эхэнд эдгээр лам нарын нэг болох Жавзандамба хутагтын нэр хүнд шинэ Монгол улсын төрт ёс төлөвшин тогтох нөхцөл бүрдүүлжээ.

Бүлэг 3

# Чин гүрний үе

XVII зуунд Төв Азид шинэ аугаа их гүрэн – Манж чин улс бий болов. Манжийн эзэн хаад эхний үед бөөгийн мөргөлтнүүд байсан ч бусад бүх шашинд хүлцэнгүй хандаж байв. Манжийн хаадын ордонд лам нар амьдардаг байж. 1639 онд манжийн хаан Түвдээс: Далай лам, Банчин лам, Гүш хаан, Цанпа хаанаас захидал авчээ.[135] Тэд Манж чин улстай сайн харилцаа тогтоох хүсэлтээ илэрхийлжээ. Манжийн эзэн хаан "түвдийн хаан, дээд ламд" хариу илгээлт явуулж бурханы шашин дэлгэрүүлэхийг хүсч буйгаа батлан илэрхийлээд энэ бол түвдийн хааны хувьд сюзерен буюу давуу эрх болно гэдгийг егөөдсөн утгаар хэлжээ. 1642 онд түвдчүүд Ялгуусан хутагт тэргүүтэй элч төлөөлөгчдийг Мүгдэн хот руу явуулсан байна. Үүний хариуд манжийн эзэн хаан Түвдэд чухам хэн ялсан тухайд ойлгомж муутай байгаагаа бичээд бурханы шашны бүх чиглэлийнхнийг (сургуулийнхныг) ивээлдээ авах хүсэлтээ илэрхийлсэн байна. Манжийн Абахай хаанаас түвдийн дээд эрх баригчдад явуулсан захидлууд хадгалагдан үлджээ.[136] Эдгээр захидалд ямар нэгэн ёс төдий харилцаа тогтоосон баримт ч тусгагдаагүй бөгөөд харин эзэн хаан бурханы шашныг ивээлдээ авах хүсэлтээ илэрхийлсэн байна.

1644 онд манж нар Бээжинг эзэлж, нийслэлээ тийш нь шилжүүлжээ. Гүш хаан манжийн эзэн хаан Фулиньд[137] захидал илгээж, V Далай ламыг хүлээн авч уулзахыг хүссэн нь Далай лам болон эзэн хааны хооронд "багш – ивээн тэтгэгчийн" харилцаа тогтоож магадгүй хэмээн найдсан хэрэг байв.[138] 1647 онд Далай лам, Банчин лам нар ялалт байгуулсанд баяр хүргэсэн захидалыг Будда бурханы алтан цутгамал дүрийн хамт Бээжин

рүү явуулсан байна. Түвдийн дээдчүүлийн санаачлага таг чиг өнгөрөөгүй бөгөөд эзэн хааны илгээсэн Шарав гэдэг лам түвдэд хүрэлцэн ирж, Далай лам, Банчин лам нарыг Бээжинд хүрэлцэн ирэхийг урьжээ. Тэд айлчлалаар очоогүй боловч 1649-өөс 1651 оны хооронд Фулинь хаан V Далай ламд хэд хэдэн удаа тусгай даалгаварт элч явуулж, тэр тоолонд урилга хүргүүлсэн байна.[139]

Ингээд V Далай лам 3 мянган хүний хамт Бээжин рүү хөдлөв.[140] Түүнийг нэг өдрийн турш Гүш хаан болон тэргүүн сайд дагалдаж, бүх замын турш Далай ламыг түвд, монгол хүмүүс хүндэтгэн угтаж, Сининээс эхлэн аялагчдын талаар манж нар анхаарал тавьж эхэлсэн байна. Түвдийн тэргүүн хүнийг эзэнт гүрнийхээ хил дээр залуу хаанаараа угтуулахыг манж нар хүссэн ажээ.

Гэвч хятад түшмэд жононгуудын хэн нэгнийг бэлэг авч хил рүү явуулах нь зүйтэй хэмээн хаандаа зөвлөсөн байна. Үгээрээ тэд Юань улсын үед байсан тэр харилцаа дахин сэргэхгүйг харуулах гэж хүсчээ.

Хил дээр Далай ламыг хааны ордны нэгэн сайд угтаж, цааших замд Далай лам шар өнгийн жууз тэргээр явсан нь Манж чин улсын дээд хүндэтгэл ажээ. V Далай ламын намтраас үзвэл манжийн эзэн хаан түүнийг ан хийж яваад санамсаргүй угтжээ.[141] Өөр нэг хувилбараар бол Далай ламыг замд явж байх зуур хятад сайд ирж, удахгүй манжийн эзэн хаан түүнийг угтана хэмээн мэдээлсэн байна. Удалгүй 300 морьт цэрэг командалсан эзэн хааны цэргийн жанжин хүрэлцэн иржээ. Эзэн хаан маргааш өдөр ирнэ хэмээн тэр хэлж, угтах ёслолын бэлтгэл сургуулилт хийж эхэлжээ. Энэхүү уулзалт Котор хотод болсон байна. Тэндхийн ордонд эзэн хаан Далай ламтай гар золгон мэндчилсний дараа найрсаг яриа өрнөсөн байна. Ямар ч байсан эзэн хааны түшмэд нарийвчлан бэлтгэсэн нь энэ уулзалтыг урьдаас төлөвлөсөн байсныг гэрчлэн харуулна.

Бээжинд Далай ламд зориулан Хуансы хийд байгуулжээ. Хааны ордны дэргэдэх күнзийн түүх судлаачид энэ үйл явдлыг үл тоомсорлосон нь анхаарал татдаг билээ.[142] Далай ламыг өдөр бүр янз бүрийн түвшний түшмэл эргэдэг байв. Манжийн сайд нар Далай ламд алт, мөнгөн шоо, луун хээтэй пайз зэрэг эзэн хааны тансаг бэлэг авч ирэх ажээ.[143] 1653 оны хавар энэ хийдэд Далай лам түвдийн шинэ жилд зориулсан хүлээн авалт хийжээ. Тэрээр зуны халуунаар шалтаглан удахгүй нутаг буцах хүсэлтээ илэрхийлсэн боловч цаад тал эвтэйхэн байдлаар татгалзсан хариу өгчээ. Манж нар монголчуудыг захиргаандаа илүү сайн оруулахын тулд монголын вангуудын их хуралд түүнийг оролцуулна хэмээн найдлага тавьсан юм

байна.

Албан ёсны хүлээн авалт дээр Далай лам эзэн хааны баруун гар талд зассан сэнтийд заларчээ.[144] Эзэн хаан түүнд “Очир баригч Далай лам” хэмээх үгийг манж, түвд, хятад хэлээр сийлсэн алтан таваг бэлэглэсэн байна. Далай лам эзэн хаанд алтан таваг, “Тэнгэрийн бодьсад Манзушри, Аугаа их эзэн” хэмээх цол бэлэглэв. Хожим нь энэ цол түвд, монголчууд манжийн эзэн хаадад хүндэтгэн хандахын нэг шалтгаан болсон байна.

Түвдчүүд манжийн эзэн хаанд бодьсад Манзушрийн адилаар хандаж байсан нь улс төрийн учир шалтгаантай байсан нь тодорхой бөгөөд тухайн үедээ оросын хатан хаад, эзэн хаадыг Цагаан дарь эх, Чингис хаан, түүний удмынхныг Очирваань, хатан хаан Викторияг Янжинлхамын хувилсан дүр хэмээн зарладаг байсантай төстэй юм.[145]

Түвд ойлголтоор бол бодьсад Жанрайсэг, Манзушри ба Очирваань нь Түвд, Манж, Монголыг өмгөөлөн тэтгэгч нар мөн учир эдгээр орны хууль ёсны хаад нь эдгээр бурхадын хойд дүрүүд байх ёстой ажээ. Гадаадын бусад орны хаадын тухайд ч нөхцөл байдал үүнтэй төстэй байсан бизээ. Гэвч бурханы шашны очирт хөлгөний (тантрын) номын зан үйлд эдгээр хаадын дүрийг ашигладаггүй байв.

Манжийн хаан Фулинь Гүш хаанд “Үйлс нь ариун, үүрэгтээ үнэнч, гэгээрсэн мэргэн Гүш хаан”[146] хэмээх цол шагнажээ.Цолны хамт Гүш хаанд гардуулсан дипломонд: “ Чин сэтгэлээс хандаж, үнэнч байхыг улам их эрмэлзэгтүн, алдар суу, эрхэм сургаалиар өргөн дэлгэрүүлэгтүн (манай эзэнт гүрний нөлөөг), хязгаар нутагт ч, эзэнт гүрэнд ч энх амгалан байдал бататган тогтоохын тулд миний туслах, хаалт хамгаалагч (хил дээр) бологтүн”[147] гэж бичжээ. Эзэн хаан ингэхдээ тэр үед Түвд ч, Хөх нуур ч өөрөөс нь хараат ч биш байсан баримтыг үл огоорчээ. Иймд Түвд, Хөх нуурыг түүний улсын “хил” хэмээн үзэж болохгүй. Түвдийн хошуут монголчууд өөрсдөд нь өгсөн цол, дипломыг инвеститур биш (эзэн хүн хараат хүндээ цол, эдлэн газар бэлэглэж өөрийн мэдэлд оруулах акт), зүгээр л дипломатын ёсорхуу зан хэмээн үзэж байжээ.

1653 оны хавар V Далай лам монгол ван, ноёдын их хуралдайд оролцолгүйгээр Бээжингээс явсан байна. Эзэн хаан үдэлтийн ёслол дээр түүнд “Ариун Буддагын сургаалийг Залгамжлагч, Баруун зүгт Энхийг бүтээгч, буддын итгэл үнэмшлийг тэнгэрийн дор Нэгтгэгч Далай лам,Очир баригч”[148] цол шагнажээ. Энэ цолыг шийтгэн олгосон дипломын үгийг күнзийн арга барилаар зохиосон бөгөөд тэнд лам ба эзэн хааны харилцаа тогтоосон тухай, түүний шинж чанарын тухай огт дурдаагүй ажээ.[149] Хожим

нь ордны күнзийн сургаальт эрдэмтэн Нин Ваньво Далай ламын буусан Хуансы хийдэд эзэн хааны тушаалаар бичээс зохиож хадсан бөгөөд түүний орчуулгыг янз бүрээр тайлбарладаг ажээ. Тухайлбал, тэнд Далай лам "төр улсдаа энх амгалан байдал, ард түмэндээ буян хишиг хуруулахаар ирсэн" гэсэн мөрүүд байдаг юм. Гэтэл эрхэм хүндэт цол бие биендээ олгосон явдал лам ба эзэн хааны хооронд "багш – ивээн тэтгэгчийн" харилцаа тогтсоныг албан ёсоор бататгасан хэрэг болжээ.

1655 онд Гүш хаан насан эцэслэв. Үүний дараа Хөх нуур болон Төв Түвд дэхь хошуут монголчуудыг Гүш хааны хөвгүүд удирджээ. Түвдийн удирдлагуудаас манж чин улсын эзэн хаантай тогтоосон харилцааг нэр төдий эзэн, албатын харилцаа байсан хэмээн үздэг.[150]

Гэвч түвдийн дээд эрх Далай ламд оногдож байжээ. Далай ламын эрх мэдлийн төвлөрөл ч улам хүчтэй болж байв. Алс холын Бенгалийн эрх баригч Шах Шоджак ч түүнд элч илгээж байв. Түвд улс Бутанд цэрэг илгээж, тэндхийн хүчнүүдийн хооронд гарсан зөрчил тэмцэлдээнийг зохицуулж байв. 1659 онд Далай лам Монгол улс руу төлөөлөгчөө явуулж, өөр хоорондынхоо тэмцлийг зогсоож, улс орныхоо эв нэгдлийг сахин хамгаалж үлдэхийг монголын ноёд, вангуудад хандаж хүссэн байна.[151] Үүний хариуд монгол ноёд түүнд ингэх тухай ам тангараг өгсөн захидал бичиж, өөр өөрсдийн тамгыг даран баталгаажуулжээ. Далай лам мөн монголчууд болон манж нарын хооронд гарсан хэд хэдэн удаагийн маргалдааныг зохицуулжээ.

Энэ зуурт манж нар хятадыг эзэнт гүрэндээ нэгтгэж дууссан байна. Манж нарыг Мин улсад урьж иргүүлэхийг санаачлагчдын нэг хятад генерал У Саньгуй 1658–1659 онд Жу овгийнхны эзэн хаад эрх барьсан хэвээр байсан одоогийн Сычуань, Юньнань мужуудын зарим нутаг дэвсгэрийг эзэлж байв. У Саньгуй 1662 онд Мин улсын сүүлчийн эзэн хааныг хүүгийнх нь хамт цаазалсан байна. Тэр жил Фулинь ч нас баржээ. Юанье манжийн эзэн хаан болов. Түүний эмэг эх Чингис хааны удмаас гарвалтай ажээ.[152] Сюанье 1673 онд өмнөдийн гурван мужийн захирагч нарын мэдэлд байсан цэргийг тараах тухай зарлиг гаргасан байна. 1678 онд тэрээр Ханжоуд өөрийгөө эзэн хаанаар зарлан тунхаглаж, бие даасан хятад улсыг сэргээжээ. Тэрээр ийнхүү хаан байх хугацаандаа Далай ламтай холбоотой байжээ. Хэрэв У Саньгуй дэндүү шургуу зан гаргавал Чин улсын эзэн хаанд хандаж хятад генералтай энхийн гэрээ байгуулж, түүний эзэмшил газрыг хэвээр үлдээхийг хүснэ гэдгээ Далай лам илэрхийлж байжээ.[153] Энэ нөхцөлд Юньнаны хоёр жижиг хот түвдийн цэргийн мэдэлд байв. Эдгээр хот урьд өмнө ч түвдийнх байсан бөгөөд Гарма Кагьюгийн талынхан удирдаж байсан

ажээ. Сюанье манжид гарсан үймээнийг дарахад оролцохыг түвдчүүдээс хүссэн боловч тэд Юньнаний халуун уур амьсгал түвд, монголчуудын хувьд хүндрэлтэй, хүмүүс болон агт морьд өл хоол муутай байна гэдгээр шалтаглаж эвтэйхэн татгалзсан хариу авчээ.. Түвд улс манжийн удирдлага, тэрч байтугай түүний ашиг сонирхлын хүрээний гадна байсан учир Сюанье тус улсын эрх баригчдад тулган шаардаж чадаагүй ажээ.

1663 онд эзэн хаан Сюанье түвдийн Амдо мужийн шашны тэргүүнийг Бээжинд урин ирүүлж, Жанжаа хутагт цол шагнасан байна.[154] Хожим нь манжийн, дараа нь хятадын эрх баригчид хөх нуурын монголчуудад ноёрхлоо тогтоохын тулд Жанжаа хутагтын дэмжлэгийг авах гэж эрмэлзсэн байна.

1680 онд Түвд, Ладакын хооронд маргаан үүсэв. Ладак тэр үед Түвдийн заналхийлж байсан Бутанд туслахаар шийдсэн байна. Тэгэхэд Түвд-Монголын цэрэг Ладак болон баруун түвдийн Гуге, Пуран, Руток эзэмшлүүдийг булаан эзлэв. 1684 онд Түвд, Ладакийн хооронд байгуулсан гэрээгээр энэ гурван нутаг дэвсгэр Түвдийн мэдэлд очив. Эцгийгээ нас барсны дараа манж нарын эсрэг тэмцлийг тэргүүлсэн У Саньгуйн хүү У Шифаны цэргийг 1681 онд манж нар бутцохиж Гуйжоу, Юньнанийг булаан эзэлсэн байна.[155] Хятадуудын эсэргүүцлийн сүүлчийн голомтыг 1683 онд даран сөнөөжээ. Ийнхүү бие даасан хятад улс 10-хан жил болоод дуусчээ.

Хийж бүтээсэн үйлсийнхээ төлөө “Аугаа их тавдугаар” хэмээн нэрлэгдсэн V Далай лам 1682 онд 68 насандаа тэнгэрт хальжээ. Түвдийн засгийн газрын тэргүүн Сангижамц Далай лам нас барсныг нууцалж, түүнийг тодорхой бус хугацаагаар гүнзгий бясалгал үйлдэхээр бүхнээс тусгаарлагдан суусан хэмээн зарлажээ. Далай ламтай уулзахаас өөр аргагүй хүмүүстэй түүнийг орлох төстэй хүнийг уулзуулж, бараг бүх нүүрээ халхалсан том малгай духдуулан тавьсан тэр хүн бүх асуултад хариу өгөн явуулдаг байжээ. Сангижамц эрх мэдлийг зөвхөн өөрийнхөө гарт төвлөрүүлийг эрмэлзсэн хэмээх яриа байдаг билээ. Гэвч илүү үнэний хувьтай байж болох өөр тайлбар бий бөгөөд Сангижамц хожим нь түүнийг Банчин ламд ярьжээ. Энэ яриагаар бол Амьдралынх нь үйл хэрэг балран унахаас эмээсэн Аугаа их тавдугаар Далай лам өөрөө ийнхүү нууцлахыг тушаасан юм байна. Сангижамц нас залуу (тэр үед 30-тай байв), шинэ дүр тодруулахад санал зөрөлдөөн гарч болох, шинээр тодрох хүүхэд хэний гарт (ивээлд) очих нь тодорхой бус, банчин лам бага настай, монголчуудын дунд хэрүүл маргаантай, бослого гаргасан хятад генералыг номхотгож өгөөгүй Түвдэд эзэн хаан Сюанье дургүй байсан зэрэг нь Далай ламыг ийм алхам

хийлгэх болсон шалтгаан байж болох юм.[156] Гэхдээ манжийн эзэн хаан ч V Далай лам нас барсан тухай мэдсэн боловч дуугүй суусан байх магадлал ч бий юм. Монголчуудтай харилцах харилцаанд Далай ламын нэр хүндийг ашиглахын тулд ийнхүү нууцалсан байж ч болох билээ.

Бодит байдалд бол Сюанье өөр хоорондын дайнд автсан монголчуудыг эрх мэдэлдээ оруулахын тулд энэхүү дипломат бодлогыг ашиглажээ. Тэрээр V Далай ламд бичсэн захидлууддаа зүүнгарынхныг төв болон умард монголын оршин суугчид болох халхчуудтай эвлэрүүлэхийг хүсч байжээ. Үүнээс болж хэлэлцээ хийсэн боловч үр дүнд хүрсэнгүй. Зүүнгарынхан халхад довтолсон хэвээр байв. Зүүнгарын Галдан хаан дорно зүгт хийсэн түрэмгийллээ монголчуудыг нэгтгэх, Хятадыг эргүүлж авах, монголчуудад эзлэгдэж байсан зүрчид аймгаас гаралтай Чин улсыг газрын хөрснөөс арчих гэсэн хүсэл гэдгээр тайлбарлаж байв.[157]

Зүүнгарынхныг түрэмгийлэл үйлдсэн хэмээн буруутгахад хэцүү, яагаад гэвэл манж нар булаан эзлэх бодлого баримталсан юм. Тэд эрт орой хэзээ нэгэн цагт Зүүнгарын хаант улстай мөргөлдөх нь тодорхой байсан билээ.

Гэсэн хэдий ч халхчууд манж нарыг Зүүнгарынхнаас хамгаална хэмээн найдаж байжээ. 1691онд Долон нуурын хавьд халхын ноёдын хуралдай болж манжийн хааныг хүлээн зөвшөөрөв. Сюанье энэ тухай V Далай ламд (өөрөөр хэлбэл Сангижамцад) мэдээлж, Галдан хааныг Түвд рүү явуулахыг хүссэн байна. Тэрээр мөн Галдан хаанд хандаж, Түвдээс ямар сураг ажиг дуулдаж байгаа тухай сонирхож байжээ.

1694 ионд Сюанье Галдан бошигт хааныг бутцохиж, V Далай лам насан өөд болсон тухай зарлаж, Банчин ламыг засгийн эрхэнд гаргахыг шаардсан байна.1695 оны хавар Сангижамц Галдангийн хаан цолыг хэвээр үлдээхийг Сюаньиас хүсэхийн зэрэгцээ Түвдтэй залгаа Хөх нуурын хилээс чин улсын цэргийг нэн даруй татан гаргахыг шаарджээ Далай лам нас барсныг хэдийнээ мэдэж буй тухайгаа Түвдийн эрх баригчдад мэдээлж байсан Сюанье дээрх шаардлагын хариуд Сангижамц бол Чин улсын албат боол учир цэрэг гаргахыг шаардах эрхгүй хэмээн мэдэгдсэн байна.[158] Эзэн хаан мөн Далай лам, Банчин лам, Сангижамц нарт захидал явуулсан байна. Тэрээр Банчин ламд явуулсан захидалдаа Сангижамц Зүүнгарын хаанд тусласан, Банчин ламыг ятгаж Бээжин явуулаагүй хэмээн зэмлэн буруушаасан байна. 1696 онд Сангижамц V Далай лам тэнгэрт хальсан тухай, түүний хойд дүрээр 13 настай хөвүүн тодорсон тухай зарлав. Сангижамц мөн энэ тухай Бээжингийнхэнд албан ёсоор мэдээлэхэд хүрчээ. 1697 онд тэнд очсон элчийг ордны гадна хаалганы дэргэд эзэн хаан биечлэн угтсан байна.[159] Тэр

жил Галдан хаан амиа хорлож, Цэвээнравдан Зүүнгарын шинэ удирдагч болов.

Манжийн эзэн хаад бүр эхнээсээ монголчуудыг “илбэн тохинуулахад” түвдийн бурханы шашныг ашиглахыг эрмэлзэж байсан хэмээн европын зохиогчид бичдэг юм. Энэ бол үнэмлэхүй үнэн гэхэд бас хэцүү юм. Чин улсын эзэн хаад хятадыг эрхшээлдээ оруулсны дараа бусад шашныг хүндэтгэж, күнзийн ёс зүйг баримталсан хэвээр байсан ч бурханы шашинд оржээ. Тэд бурханы шашны дээд эрх баригчидтай “багш – ивээн тэтгэгчийн” харилцаагаа үргэлжлүүлж, энэ харилцааны үед түвдийн бурханы шашны “алтан зуун” эхэлсэн билээ.[160] 1882 он гэхэд Төв Түвдэд л 2500 гаруй хийдэд 760 мянган лам шавилан сууж байжээ.[161] Бусад газарт мөн олон мянган хийд байв. Манжийн нэг эзэн хаан Жэхэ муж дахь зуны нийслэлдээ Будалын ордны жижиг биш хуулбарыг бариулж,

Бээжин дэхь Юнхэгун ордноо бурханы шашны сүм болгож хувиргасан бөгөөд тэрхүү ордны хагасыг түүний өмнөх хаан түвдчүүдэд хийд болгож өгсөн байжээ. XVIII зууны сүүлч үеэс манжийн эзэн хаад энэ хийдэд жил бүр эцэг өвгөдөө дурсах ёслол үйлдэх болсон байна.

Манж нар эзэнт гүрнээ өргөжүүлэхийг эрмэлзжээ. Нэг хэсэг нутаг дэвсгэр манж гүрний салшгүй хэсэг(жишээ нь, хятад) болж, өөр бусад нутаг их, бага ямар нэгэн хэмжээгээр түүний хараат (жишээ нь, Монгол, Түвд) газар болж байв. Түвдчүүд Лифаньюань буюу гадаад харилцааны хэрэг эрхэлсэн Танхимын харьяанд байжээ. Манжуур болон хятадын хувьд “гадаад” гэгдэх ард түмнүүд буюу монгол, түвдчүүд, Дорнод Туркестаны оршин суугчид болон оросууд энэ танхимын мэдэлд байжээ. Гадаад харилцааны хэрэг эрхлэх танхим Түвдийн тухайд алба гувчуурын төлөлтийг хянах, орон нутгийн дээд ангийнхныг цол хэргэмд нэр дэвшүүлэх, тэд үүний төлөө хичнээн хэмжээний төлбөр өгөхийг тодорхойлох, түвдчүүдийг эзэн хаанд бараалхуулах ажил зохион байгуулах, Түвдтэй хийж буй худалдаа арилжааны талаар анхаарал тавих зэрэг үүрэг гүйцэтгэж байв.[162] Манж нар бурханы шашныг бусад ард түмнийг эршхээлдээ оруулах хэрэглүүрийн хувьд биш, харин шашны зорилгоор хөгжүүлжээ. Түүний зэрэгцээ бас эзэн хааны засаглалыг бэхжүүлэхийн тулд сүм хийдтэй хамтран ажиллахыг эрмэлзсэн нь ойлгомжтой бөгөөд орост үнэн алдартны шашин болон хамжлагат ёс мөн ийнхүү бие биенээ дэмжиж байсан билээ.

Сюанье 1697, 1698 онд Банчин ламд урилга явуулсан байна.Түүний илгээсэн захидлуудад бурханы шашин болон хятад, түвдийн ард түмний найрамдлыг бэхжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэжээ. Банчин лам эдгээр

урилгад татгалзсан хариу өгсөн байна. Түвдийн эрх баригчдыг цээрлүүлнэ хэмээн сүрдүүлсэн удаа ч бий ажээ. VI Далай лам Цаянжамц нас залуу байсан учир урилга хүлээж аваагүй юм. Тэрээр шашны хичээлд тийм ч дуртай биш байсан тухай хэлэлцдэг байжээ. Жишээ нь, ном хаялцахад оролцох дургүй, ерөөс лам болох ч дургүй хэмээн мэдэгддэг байжээ. 1701 онд Сюанье, монголын эрх баригч Цэвээнравдан, Лувсан хан (Гүш хааны ач) нар Цаянжамцыг V Далай ламын хойд дүр хэмээн хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа түүнд мэдэгджээ. 1702 онд Цаянжамц гэлэн сахил хүртэх ёстой байсан ч мөн л татгалзав. Үүний оронд тэрээр Дашлхүмбэ хийдэд очиж, урьд өмнө хүртсэн гэцэл сахилаа буцааж өгсөн байна.[163] Тэрээр нум сум харвах дасгал хийдэг, эмс охидтой уулзаж учирдаг, дуу зохиодог байсан бөгөөд хожим нь түүний зохиосон дуунуудыг нэгтгэн “Сонсохуйяа тааламжтай дуунууд” хэмээх нэрд гарсан дууны түүвэр зохиогджээ. Ийм л амьдралаа үргэлжлүүлэхийн тулд тэрээр сахил санваар хүртэх дургүй байсан бизээ.

Энэ зуурт Цаянжамцыг жинхэнэ Далай лам хэмээн хүлээн зөвшөөрөөгүй түвдийн хошуут монголчуудын эрх баригч Лувсан ханы зүгээс Сангижамцад дайсагнан хандах явдал улам хүчтэй болов.Сангижамц Лувсан ханыг баривчилан хорьж чадсан боловч Банчин лам энэ хэрэгт оролцож түвдийн зарим дээд тушаалын түшмэд болон Далай лам, Банчин лам нар оролцсон хэлэлцээ зохион байгуулав. Лувсан хан Хөх нуур явахаар амласан боловч Нагчу хүрмэгцээ хошуутын отрядууд цуглуулж эхэлжээ.Сангижамц түүний эсрэг боссон боловч бутцохигдож, удалгүй баривчлагдан цаазлуулжээ. Түвдийн зарим түшмэл нарын дэмжлэгийг хүлээсэн хошуутын отрядууд Лхаст оров. “Хуурамч” Далай ламыг баривчилж, Бээжинд хүргүүлэх тухай зарлиг Бээжинд гарчээ. Гэвч түвдийн дээд эрх баригчид Цаянжамцыг “хуурамч” VI Далай лам хэмээн үзэхээс татгалзсан байна. Гэхдээ тэд шинэ Далай ламын гэгээрэл бага байгааг хүлээн зөвшөөрч, түүнийг Бээжин рүү явуулахыг эсэргүүцсэн саналыг дэмжжээ.[164]

Лувсан хан 1706 оны зургадугаар сарын 11-нд Цаянжамцыг дуудан ирүүлж түүнд үйлдсэн үйлдэл, нүгэл хилэнцийг нь тоочин хэлсний дараа түүнийг Лхас хотын ойролцоох монгол цэргийн хуаранд аваачихыг тушаажээ. Зургадугаар сарын 27-нд Цаянжамцын цол хэргэмийг хураахж, цөллөгөнд явуулах тухай зарлав.[165] Үүнээс болж ард олны тэмцэл хөдөлгөөн өрнөсөн байна. Дрепун хийдийн лам нар Далай ламыг авч явсан ардуудад халдаж, түүнийг хийддээ авч ирсэн байна. Далай ламын шинэ дүр үнэн болохыг зөнч мэргэн нотолж хэлэхдээ энэ хүн ад зэтгэрийн нөлөөнд автсан байна гэж айлджээ. Гэсэн хэдий ч хошуут иргэд хийдийг бүсэлж Цаянжамц

ч цус асгаруулахаас зайлсхийхийн тулд бууж өгөв. Гэсэн хэдий ч Лувсан хан Дрепун хийдийг эзлэн авч зарим хэсгийг нь эвдлэн сүйтгэжээ. Цаянжамцыг Сангижамцын эхнэр, хүүхдүүдийн хамт цөллөгөд явуулав. Цөллөгийн газар хүрэх замд Цаянжамц 24 насандаа Хөх нуурын ойролцоо насан өөд (алагдсан байж болзошгүй) болжээ. Сюанье түүнийг ёс төртэй оршуулахыг хориглосон тушаал гаргасан байна. Түүнийг хэрхэн оршуулсан тухай үнэн магадтай мэдээлэлгүй байсан явдал Цаянжамц ер бусын байдлаар мөнх бусыг үзүүлэн тэнгэрт одсон тухай цуу үг тарахад хүргэжээ. VI Далай лам өндөр зиндааны йогч байсан, түүний шүлгүүд далд утгатай, тэдгээрийн зарим нь очирт хөлгөний сургаалийн гүн гүнзгий танин мэдэхүйн үндэстэй гэж төвдчүүд ярьдаг ажээ.[166] Цаянжамцаас ангижирмагцаа Лувсан хан Банчин ламтай харилцаагаа зохицуулж, түүний тусламжтайгаар Лхас хотоос Далай ламын “шинэ дүрийг” тодруулсан байна. Агваан Ишжамц хэмээх нэрийг авсан шинэ VI Далай ламыг Банчин лам, Лувсан хан болон манжийн засгийн газар хүлээн зөвшөөрөв.[167]

Төвдэд нөлөөгөө бэхжүүлэхийг эрмэлзсэн манж нар 1710 онд “Төвдийн хэрэг эрхлэгчийг” Лхас руу явуулсан боловч тэрээр дараа жил нь буцаж ирсэн байна. 1713 онд V Банчин лам манжийн эзэн хаанаас “Банчин эрдэнэ” цол алтан тамга, диплом хүлээж авсан байна. “Эрдэнэ” гэдэг нь “Ринбүчи” хэмээх Төвд үгийн монгол орчуулга бөгөөд шашныхаа ажлыг үргэлжлүүлэх гэж байнга эргэж төрдөг лам хүнд олгодог цол ажээ. БНХАУ-ын Гадаад Явдлын Яамны интернет-сайтад энэ цолыг “Далай ламын шашны хэрэг эрхэлсэн орлогч” хэмээн орчуулсан нь инээдтэй хэрэг юм.[168]

Ишжамц төвдчүүдийн ч, монголчуудын ч дэмжлэгийг хүлээж чадаагүй байна. Хэсэг лам нар Литан нутгаас VI Далай ламын өөр нэг шинэ дүр-Галсанжамц хэмээх хөвгүүнийг олж тодруулав. Шинэ олдвор үнэн зөв болох нь зөнч мэргэдийн таавар, Цаянжамцын амьд сэрүүндээ ярьж байсан үг зэргээр нотлогдсон байна.[169] 1715 онд манж нар түүнийг Далай лам хэмээн хүлээн зөвшөөрч, дараа жил нь түүнийг Амдо мужийн Гүмбэн хийдэд залж суулгасан байна. Яагаад ингэв гэвэл Лувсан ханы хүлээн зөвшөөрсөн Далай лам Лхаст сууж байв.

Манжийн хааныхан дайсагнасан хандлагатай байгааг олж харсан Лувсан хан Зүүнгарынхнаас дэмжлэг хайх болов.[170] Түүний хүү Цэвээнравдангийн охинд сүй тавихаар явав. Гэтэл Цэвээнравдан түүнийг нууцаар цаазлан хороосон байна. Лувсан ханы хөвгүүн болон түүний эхнэрийг Төвд хүртэл дагалдан хамгаалах нэрийдлээр Зүүнгарын 6–7 мянган хүнтэй цэрэг тийш хөдлөв. Лувсан ханыг Бээжингийн тавиул этгээд гэж үзсэн Цэвээнравдан

түүнийг эрх мэдэлгүй болгохыг нууцаар тушаажээ. Лувсан хан ч үүнийг мэдэж, хоёр талын хооронд дайн эхэлжээ.Зүүнгарынхан нутгийн Түвд эрх баригчдын тусламжтайгаар Лхас хотыг эзэлж, Лувсан хан амь үрэгдэв. Зүүнгарын жанжин Цэрэндондов (Цэвээнравдангийн дүү) түвдийн засгийн газрыг өөрчилж, Ишжамцыг баривчлав. Түүнийг манж чин улс руу явуулсан бөгөөд 1725 онд тэндээ насан өөд болсон бололтой байдаг.

Лувсан ханы хөвгүүдийн нэг Зүүнгарынханд олзлогдож, түүний эхнэр Хөх нуурт зугатан очиж, Түвдийг Зүүнгарынхнаас чөлөөлж өгөхийг Сюаньегээс хүссэн байна. Цэргийн тусламж үзүүлэх тухай хүсэлтийг биелүүлж, 1718 онд Ерэнтэй хэмээх манж хүнээр удирдуулсан чин улсын арми Түвдэд оржээ. Зүүнгар – түвдийн цэрэг энэ армийг бутниргэв.Чин улсын бараг бүх цэрэг, дарга нар алагдсан байна.

Түвд дэхь хошууд монголчуудын нөлөө Зүүнгарынхаар солигдов. Гэвч Зүүнгарынхан Түвдэд олж авсан нэр хүндээ ашиглаж чадаагүй бөгөөд тэд эрх мэдлээ тогтоомогц Ньингма чиглэлийн дөрвөн том ламыг цаазалж, энэ сургуулийн шилдэг хоёр хийдийг цөлбөн дээрэмдсэн байна.[171]

Зүүнгарынхан түвдчүүдийн хүсэлтээр Галсанжамцыг Түвдэд ирүүлнэ үү гэж манж нарт ятгасан боловч үр дүнд хүрсэнгүй. Зүүнгарынхан ийнхүү улам нэр хүндгүй болжээ. Тэргүүн сайд болон түвдийн бас гурван түшмэл Галсанжамцыг VII Далай лам хүлээн зөвшөөрсөн тухай өгүүлсэн захидлыг Гүмбум рүү нууцаар явуулсан байна. Үүний хариуд 1719 онд чин улсын цэргийг дахин Түвд рүү явуулав. Энэ цэргийн жанжнуудын нэг эзэн хааны хүү Юнди зам зуураас эх орондоо буцаж, Ян Синьд командлалаа шилжүүлэн өгчээ. Ингэх болсны шалтгаан бол VII Далай ламыг Лхас хүргэх явдал байжээ. Тэнд Зүүнгарынхны эсрэг бослого эхэлсэн байлаа. Зүүнгарынхан ялалт байгуулж чадахгүй болсноо ойлгож Лхас хотыг тонон дээрэмдэж, баруун хойт зүг явжээ.

Чин улсын генерал Ян Синь VII Далай ламыг Лхаст хүргэж иржээ. 1720 оны дөрөвдүгээр сарын 27-нд эзэн хааны том хүү шинэ Далай ламд диплом болон “Жинхэнэ бүхний удирдагч, сургааль ухаан дэлгэрүүлэгч Далай лам”[172] гэсэн бичээс бүхий алтан тамга гардуулан өгчээ. Энэ бичээсийг манж, монгол,түвд хэлээр үйлдсэн (хятад орчуулгагүй) байна. Манжийн эзэн хаан Цаянжамцыг ч, Ишжамцыг ч Далай лам хэмээн хүлээн зөвшөөрөөгүй юм. Сюанье шинэ Далай лам болон түүний талынханд захидал бичиж, тэр өөрөө болон Гүш хааны удмынхан Далай ламын ивээн тэтгэгчид бөгөөд гурван жилийн турш Далай ламын туслахууд болон лам нарын бүх зардлыг даана, Сюанье миний бие эв нэгдлээ хадгалж, эзэн хаанд үнэнч байхыг Хөх

нуурын монголчуудад итгүүлэн үнэмшүүлэхийг Далай ламаас хүснэ гэж мэдэгдсэн байна.[173]

VII Далай ламыг 1720 онд Будалын ордонд сэнтийд нь залжээ. Чин улсын цэргийн даргын удирдлага дор түр засгийн газар эмхлэн байгуулж, түүний бүрэлдэхүүнд хоёр Түвд хүн, дөрвөн монгол ван, түүний дотор халхын хоёр, хошууд монголын хоёр ван тус тус орсон байна.[174] 1721 оны хавар гурван сайдын бүрэлдэхүүнтэй шинэ засгийн газар байгуулав. Баруун түвдийн захирагч Кангченэйг тэргүүн сайдаар томилж, дайчин баатар цол шагнасан байна. Лхасын эргэн тойрон босгосон хэрмийг буулгаж, тус хотод Цэвээнноров хэмээх монгол хүнээр командлуулсан чин улсын гарнизон байгуулсан бөгөөд монгол командлагч нь генерал Ян Синьд захирагдах болсон байна. Мөн Литан, Чамдо хотуудад чин улсын цэрэг байрлуулав. Литан, Батангаас зүүн тийш орших түвдийн нутгийг түвдээс салган авч чин улсын Сычуань мужийн бүрэлдэхүүнд оруулжээ.

1723 онд Сюанье нас нөгчив. Инь жэнь шинэ эзэн хаан болов. Тэрээр Лхас хотоос чин улсын цэргийг гаргаж, тийш нь Орай гэдэг түшмэл явуулсан байна.[175] Зүүнгарын хаант улстай олон жил дайтсаны улмаас хөрөнгө мөнгөний хомсдолд орсон нь Лхасаас цэрэг гаргах шалтгаан болсон байна.[176] Түшмэл Орай чин улсын гадаад харилцааны хэрэг эрхэлсэн танхимыг төлөөлж байв.

1722–1725 онд Хөх нуурт манжийн эсрэг хошуут монголчуудын бослого гарч түүнд 200 мянган тангадууд нэгдсэн байна.[177] VII Далай ламыг сэнтийд залах үед чин улсын түшмэлүүд ариун зулын галаас тамхи асаах зэргээр зохисгүй авирласан нь ийнхүү бослого гарахын шалтгаан болжээ. Хятад оршин суугчдад зориулсан газар таслан авч, Наньшань уулнаас зяюйгуань хүртэлх газрыг Чин улсын мэдэлд авсны тэмдэг болгож хилийн багана байрлуулсан явдал бослого гарахын шалтгаан болсон хэмээх мэдээлэл ч байдаг ажээ.[178] Үүнээс болж хятад оршин суугчдыг харгислаж, орон нутгийн эрх мэдлийг сэргээн тогтоосон байна. Үүнээс болж Ин Жэнь залхаан цээрлүүлэх арми болон түшмэл нарыг явуулж, чин улсын цэрэг 100 мянган хүн олзлон авч, хэд хэдэн хийд,түүний дотор гурван том хийд, 7 мянган айлын гэр байшин, 17 тосгон галдан шатаажээ. Хөх нуурыг Чин улсын мэдэлд оруулав. Амдо, Камын хооронд юань улсын үед татсан хилийг дахин сэргээсэн байна.[179] Бослогын удирдагч Зүүнгар руу оргож гарсан бөгөөд тэрээр түвдийн засгийн газрын сайд нарын нэгний хамаатны хүн байв. Манж нар Түвдэд үймээн самуун гарахаас болгоомжилж Хөх нуураас 2 мянган хүнтэй отрядыг Түвдэд оруулсан байна. Бослогын удирдагчийг

Зүүнгараас хөөж гаргасны дараа чин улсын цэргийг Түвдээс гаргажээ.

Түвдийн засгийн газрын сайд нарын хооронд хагаралтай байсан нь иргэний дайн гарахад хүргэжээ. Ингээд манж нарын дэмжлэгийг хүлээсэн сайд Миванг Полонай засгийн эрхийг булааж авсан байна.Манж нар Түвд рүү 11 мянган хүнтэй цэрэг явуулав. Энэ цэргийг Лхаст орж ирэхэд манж нар Полонайн дайснуудын хэргийг шүүх ажиллагаа зохион байгуулав. Түүнд дайсагнан хандсан гурван сайдад зоосны нүхээр цувуулж алах ял оноож гүйцэтгэсэн байна.[180] VII Далай лам болон түүний эцгийг Литангийн ойролцоох Гартар хийд рүү явуулжээ.

Кам мужийн үлэмж хэсэг буюу Литан, Батангаас зүүн тийшхи нутаг дэвсгэрийг Сычуань муж, Гьялтангийг Юньнань мужийн бүрэлдэхүүнд оруулж, түвдийн умард нутгийн нүүдэлчдийн 40 бүлгийг Сининий захирагчийн мэдэлд шилжүүлжээ.[181] 1724 онд гол төлөв түвд, монголчууд оршин суудаг Амдо муж (Хөх нуур буюу Цинхай) Сининий мэдэлд очсон байна. Кам мужаас тасалж авсан нутаг дэвсгэрт 27 тойрог байгуулжээ.

Манжийн хааныхан Цанг, Нгарийг Банчин ламд бэлэглэж, зөвхөн У, Чамдо муж л түвдийн засгийн газрын шууд мэдэлд үлдсэн байна. Манж нар түвдийн газар нутгийн зарим хэсгийг хүчээр хавсарган нэгтгэсэн хэдий ч түвдийн эрх баригчдын эрхэм дээд нэр хүнд тэнд хадгалагдан үлджээ.

Түвд рүү манж амбан томилон явуулсан байна. Түвдийн эрх баригчидтай хэлхээ холбоотой байж, тэнд Бээжингийн нөлөөг хэрэгжүүлэх явдал тэрхүү амбан сайдын үүрэг байв. Эхний үед хятад биш хүмүүс буюу манж нарыг, цөөн тохиолдолд монголчуудыг амбан сайдаар томилон явуулдаг байсан бол XIX зууны сүүлчээр л[182] хятад амбанууд бий болсон байна. Хэрэв амбан нарыг томилдог болохоос өмнө манж чин улсын засгийн газар Лхас руу тодорхой хэрэг хэлэлцэн шийдэх үүрэг бүхий түшмэл нарыг нэг бус удаа явуулдаг байсан бол сүүлдээ ийнхүү эзэнт гүрний байнгын оролцоо бий болжээ. 1727–1750 онд Түвдэд амбан сайд байнга суух болж, амбаны газрын тогтолцоо бий болсон байна. Амбан сайд нар улс орны ерөнхий нөхцөл байдал, түвдийн засгийн газар болон Далай ламын үйл ажиллагаанд хяналт тавих, түвдийн батлан хамгаалалтыг зохион байгуулах үүрэгтэй байжээ. [183]

1728 онд Лхаст 1500 хүнтэй чин улсын гарнизон оруулж амбан сайдын мэдэлд шилжүүлэв. Кам мужийн 14 тойргийг Лхасын захиргаанд шилжүүлж, 13 тойргийг Сычуань мужид үлдээсэн байна. Хожим нь Лхасын мэдэлд шилжсэн Кам мужийн нутаг дэвсгэрийн хил хязгаар байнга өөрчлөгдөж байв. Булаагдсан нутаг дэвсгэрийн хотуудад хамгаалалтын

алба гүйцэтгэдэг чин улсын жижиг гарнизонууд байрлуулсан байна. Бээжин рүү байнга бэлэг сэлт явуулдаг журам тогтоожээ. Түвд рүү явуулсан эзэн хааны зарлигуудыг тэндхийн түшмэд биелүүлэх ёстой байв. Чин улсын албан ёсны түүхийн ном зохиолууд хятад уламжлалыг дагаж байсан бөгөөд Эзэн хаан бол бүхнээс дээгүүрт тавигдах ёстой, тийм учир амбан нар болон Далай ламын үүргийг гадаад харилцааны хэрэг эрхэлсэн танхимаас “түвдийн хэргийг удирдах батламж бичиг”[184] авсан түвдийн дээд тушаалын түшмэдийн хамтарсан “захирамж” хэмээн тодорхойлж, эзэн хаанд явуулах бэлгийг “алба гувчуурын” хэмжээнд авч үзэж байжээ.

Түвдэд энх амгалан байдал тогтов. Шинэ засгийн газар бурханы шашинд дэмжлэг үзүүлэв. Үүнийг чин улсын эрх баригчид бүрэн ойлгож байлаа. Жил бүр бээжингээс түвдийн сүм хийдүүдэд 5 мянган лан мөнгө явуулж, түвдийн засгийн газрын дарга Полонайн санаачлагаар бурханы шашны олон боть “Ганжуур” судар хэвлэх модон бар сийлсэн байна.

Амбан сайд нарыг томилон явуулж, чин улсын гарнизон байрласан хэвээр байсан ч Түвд орон өөрийнхөө засгийн газраар удирдуулж, чин улсын зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд үл хамаарагдах өөрийн гэсэн армитай байжээ. 1730–1731 онд Түвд улс Бутанд гарсан дотоодын тэмцэл хөдөлгөөнийг зохицуулахад дахин хөндлөнгөөс оролцсон байна. Ингээд хоёр талын хооронд байгуулсан гэрээгээр Бутаны тал өөрийнхөө төлөөлөгчөөр түвдийн засгийн газарт алба гувчуур хүргүүлж байх үүрэг хүлээсэн байна. Энэ заншил 1950 он хүртэл мөрдөгджээ. Түвдийн засгийн газрын эрх мэдлийг 1732 онд Ладак хүлээн зөвшөөрөв.

1734 онд манжийн эзэн хаан Гартарын хийдэд сууж байсан Далай ламыг эргүүлэхээр дүү хархүүгээ явуулж,[185] хилийн ойролцоо хийд байгуулах ажлыг санхүүжүүлж, хийдийн үйл ажиллагааны зардлыг дааж байхыг санал болгож, бүх Түвдийн хийдүүдэд хэрэглэх шахмал цайны төлбөрийг хийх хөрөнгө мөнгө гаргаж өгсөн байна. 1735 онд Далай ламд Лхаст буцаж очих зөвшөөрөл олгосон байна. Тэр үед Лхас хот Полонайн бүрэн хяналтад байжээ. Далай лам есдүгээр сард тийшээ очсон бөгөөд аравдугаар сард Инь Жэнь нас барав. Хунли манжийн эзэн хаан болов.

1740 онд бутанчууд Сиккимд цөмрөн оров. Сиккимийн захирагч насанд хүрээгүй хүүхэд байсан учир түүний нэгэн албат Лхаст очиж, улс орныг удирдахад туслах хэн нэгэн хүн явуулахыг Полонайгээс хүсчээ. Түвдээс Сикким рүү төлөөний хүн томилон явуулсан байна. Сиккимийн эрх баригчийг насанд хүрэхэд түвдээс явуулсан түшмэлийг байлцуулан түүнийг хаан ширээнд суулгажээ. Хунли хаан 1740 онд Полонайд чин

гүрний дээд цолнуудын нэг болох жун ван цол хүртээжээ. Полонай 1747 онд өвчний улмаас нас баржээ. Түүний засаг барьсан он жилүүд түвдчүүдийн ой дурдатгалд тайван амгалан үе, тэр өөрөө хүчтэй удирдагч болон үлджээ. Гэхдээ тэрээр манж нартай хамтран ажилласан явдал тэдний хувьд Түвдийн засгийн эрхэнд санаархах шалтгаан болж үлдсэн байна.

Лхаст амьдарч байсан, жунь вангийн цол өвлөж авсан Полонайн бага хүү Далай баатар Гьюме Намгьял манжийн цэргийг түвдээс хөөж гаргахаар шийджээ. Тэрээр түвдийн гарнизон манжийнхаас дутахгүйгээр албаа гүйцэтгэх чадвартай, хэрэв ингэвэл эмс охид, агт морьд хулгайлах явдал зогсох ашиг тустай юм хэмээсэн захидалыг Бээжин рүү явуулсан байна.[186] Манж амбан нар түвдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож байгааг захидалын төгсгөлд тэмдэглэжээ. Хунли үүнийг зөвшөөрч, амбан сайдыг хамгаалж байсан лхасын гарнизоныг 100 хүн хүртэл хорогдуулж, амбан сайд түвдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглосон боловч Лхаст түвдийн гарнизон байрлуулахыг зөвшөөрсөн байна.

Гьюмэ Намгьял Зүүнгар руу захидал илгээж, Зүүнгарынхныг түвдэд орж ирэхийг урьжээ. Энэ нь цаг хугацааны хувьд Хунли Зүүнгарын хаант улстай хийх томоохон дайнд бэлтгэж байсан үетэй давхацсан байна. Уг захидлыг амбан нараас хахууль авсан хүмүүс замаас нь олзолж авчээ. 1750 оны арван нэгдүгээр сард амбан нар эзэн хааны бэлэг гардуулах нэрийдлээр Гьюмэ Намгьялыг шилтгээндээ урин ирүүлж, бараа болж ирсэн түвдчүүдийнх нь хамт түүнийг хороожээ. Нэг лам л зугатаж амжсан ажээ. Тэрээр түвдчүүдийг цуглуулан амбан сайд нарын шилтгээнд халдаж, амбан сайд нарыг цаазлан хороож, тэнд байсан хятадууд болон манж нарын олонхийг нэвширтэл зоджээ. Тэднээс цөөн тооны хүн Будалын ордонд очиж, Далай ламын дэргэд амь хоргодож үлдсэн байна. Сычуаниас яаралтай татан ирүүлсэн манжийн цэрэг 1751 оны нэгдүгээр сард бослогыг дарж, түүний удирдагч долоон хүнд хамгийн харгис ял буюу зоосны нүхээр цувуулж цаазлах ял, олзлогдсон бусад хүнд хамгийн хөнгөн буюу толгойг нь цавчих буюу дүүжлэх ял оноож, зарим зэрэг хэргэмтэй хүмүүст амиа хорлохыг зөвшөөрч, үлдсэн хүмүүсийг шоронд хорьсон байна. Манжийн эзэн хаан "чадвартай, сайн хүмүүсийг" сонгон авч, дөрвөн сайдад эрх мэдлийг дахин хувиарлаж өгөхийг манжийн гарнизоны командлагчид даалгажээ.[187] Энэ сайд нар амбан нар болон Далай ламын зааврыг биелүүлэх ёстой байв. Лхаст дахин манж чин улсын гарнизон оруулжээ.

Түүний зэрэгцээ мөн түвдийн арми байгуулах асуудлыг авч үзсэн байна. Цэрэг татлага болоход газар эзэмшдэг айл өрх бүр нэг хүн гаргаж

өгөх ёстой болжээ.У мужид нэг мянга, Цангад хоёр мянган хүнтэй Түвд цэргийн гарнизон байрлуулав. Эрх мэдлийн хүрээнд дахин өөрчлөлт хийсэн байна. Кашаг буюу сайд нарын зөвлөлийг засгийн газар хэмээн үзэх болов. Хятад эх сурвалжаар бол VII Далай лам болон адил эрх мэдэлтэй хэмээн тооцогдож байсан хоёр амбан засгийн газрыг тэргүүлэх болсон байна.[188] 1752 оны “Түвдийн хуульд” цэрэг оруулах, удирдлагын шинж чанарыг өөрчлөх тухай заажээ.[189] Энэхүү “Хууль” ёсоор Далай лам Түвдийн шашин, төрийн тэргүүн болсон байна. Амбан нарын нөлөө өргөжиж: чин улсын гарнизон тэдэнд захирагдах болж, Чэнду, Лхасын хоорондох шуудангийн албаны аюулгүй байдлыг ч амбан нар хариуцаж, улс орныг удирдахад засгийн газрын зөвлөхийн хувьд оролцох эрх олж авсан байна.[190]

Түвд эх сурвалжаар бол Далай ламд улс орондоо үнэнч зүтгэх тангараг өргөсөн сайд нар улс орныг удирдаж, Далай лам шашин, төрийн бүрэн эрхийг өөртөө авсан байна.[191]Сайд нарт эрх үүргийн нарийн хувиар байгаагүй ажээ.

Тийм учраас нилээд доод түвшингийн түшмэд хариуцлага хүлээхээс зайлсхийхдээ тухайн хэргийг сайд нарт хэлэлцүүлэхээр оруулж болдог байв.

Энэ нь янз бүрийн будлиан гарах, аливаа хэргийг хэлэлцэн шийдвэрлэх ажил сунжрах, санаачлага гаргах хүсэлгүй болох зэрэгт хүргэж байлаа. 200 жил оршин тогтносон тийм систем улс орны дэвшил хөгжилд саад тушаа болсон байна.

Манжийн засгийн газар монголчууд өөр хоорондоо болон түвдчүүдтэй нэгдэхээс болгоомжилж байлаа. Ялангуяа Манж чин улсыг сөрөн зогсох хүчний төв болж байсан Зүүнгарын хаант улс манж нарын сэтгэлийг онцгой их түгшээж байсан юм. Эзэнт гүрний эрх баригчид Түвдийг энэ улстай хэлхээ холбоотой байхыг хоригложээ. Зүүнгарынхан Түвдэд орох нөхцөлд авах арга хэмжээг ч төлөвлөсөн байв. 1754–1757 онд Зүүнгарын хаант улсыг манж нар байлдан эзлэв. Хунли энэ орон эзлэгдэж, бутцохигдох дөхөж байгаа тухай Далай лам, Банчин лам нарт мэдээлэв.

1755 оны аравдугаар сард Хунли:[192] “Зүүнгарын янз бүрийн аймгийн хүмүүс бие биенээ хөнөөж байна. Энэ орны ард түмэн амгалан тайван байдлаа алджээ. Би бээр бүх Дундад иргэн улсыг нэгтгэхдээ үүнийг зүгээр хараад сууж чадахгүй. Тиймийн учир Зүүнгарыг байлдан дагуулах томоохон хүчийг хоёр чиглэлээр явуулна” гэж мэдэгджээ. Эзэн хааны бүх дэлхийг захирах эрх мэдлийн тухай онолыг иш үндэс болгосон манж чин улсын удирдлага Зүүнгарын болон Яркендын хаант улсуудыг өөрийн хууль ёсны

эзэмшил нутаг, тэдгээрийн удирдагчдыг өөрсдийн хараат боолууд хэмээн үзэж байв. Дээр дурдсан удирдагчид өөрсдийгөө Тэнгэрийн хөвгүүний албат хэмээн хүлээн зөвшөөрөх хүсэлгүй байсан учир чин улсын эрх баригчид тэднийг харанхуй бүдүүлэг, "тэнгэрийн хууль" хийгээд манжийн эзэн хаанд захирагдаж, түүний заалврын дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг хариуцлагаа ойлгодоггүй хүмүүс хэмээн зэмлэн буруушааж байв.Эдгээр орны оршин суугчдын манжийн эсрэг тэмцэл хөдөлгөөнийг эзэн хаан дээрэм, тонуулын ажиллагаа, харин чин улсын түрэмгийллийг аргагүйн эрхэнд авсан залхаан цээрлүүлэх арга хэмжээ гэж үзэж байв.

Тийнхүү Зүүнгарын хаант улсын хүн амын аравны долоон хувь нь чин улсын цэргийн ирт зэвсэг, халдварт өвчнөөс болж үрэгдсэн байна.[193] Нийтдээ хэдэн зуун мянгаас нэг сая хүртэлх хүн амь үрэгдэж, хэдхэн арван мянган хүн амьд үлдсэнээс нилээд олон нь Орос руу зугатан гарчээ.

Зүүнгарынхныг толгой дараалан хүйс тэмтэрч, тэдний газар нутгийг чин гүрэнд нэгтгэх тухай Хунли хааны тушаал тийнхүү биелжээ.Орчин үеийн ойлголтоор бол энэ нь аймаглан устгах явдал, цэргийн гэмт хэрэг байв.

Гэтэл "дагаар ордоггүй зэрлэгүүд" гэгчийн тухай хуучны ойлголтоор бол өөр дүгнэлт гарна. Мин болон чин улсын эриний заагт амьдарч байсан их хан үндэстний дээрэнгүй үзлийн үзэл сурталч Ван Чуаньшан энэ үзэл бодлыг илэрхийлж бичихдээ: "Зэрлэгүүдтэй хийх аливаа тэмцлийг Дундад иргэн улс дайн хэмээн нэрлэх ёсгүй, яагаад гэвэл тэднийг устгах нь харгис явдал биш, тэднийг хууран мэхлэх нь итгэл эвдсэн хэрэг биш, тэдгээрийн нутаг дэвсгэрийг эзэлж, өмч хөрөнгий нь хураах явдал шударга бус явдал биш юм" гэжээ.[194]

"Зэрлэгүүдийг" бутниргэхэд цэргийн жанжнуудын авьяас чадвар тэгтлээ их шаардагдаагүй ажээ. Нэгэн цагт цэргийнхээ сүр хүчээр алдаршиж байсан Зүүнгарын хаант улс энэ үед өөр хоорондынхоо тэмцэлд идэгдэж, бараг л задран унаж байв. Зүүнгарынхныг бодоход манж нар цахиур буу, үхэр буу зэрэг олон галт зэвсэгтэй байв. Манж нар бусдын нутаг дэвсгэр булаан эзэлж, "амьдрах орон зайгаа" дахин хүчтэй өргөжүүлжээ. 1760 онд Дорнод Туркестан болон Зүүнгараас Шинжаан (шинэ хязгаар) хэмээх чин гүрний нэг муж байгуулжээ. Зүүнгарын "чөлөөлөгдсөн" нутгуудад бусад ард түмнүүд ирж суурьших болж, уугуул хүн ам бараг устжээ. 2000 онд Шинжааны монголчууд хүн амын нэг хүрэхгүй хувь байсан бол хятадууд 30 гаруй хувь буюу 6 сая гаруй хүн байлаа.

Түвд улс хуучин уламжлалаар монголчуудад найдан хандаж болохгүй

болжээ. Ингээд Чин гүрэнтэй харилцаа тогтооход хүрсэн нь манж чин улс бурханы шашныг дэмжиж, түвдийн бурханы шашны дээд эрх баригчидтай “багш – ивээн тэтгэгчийн” харилцаа тогтоохоос татгалзаагүйтэй холбоотой байсан юм. Эзэн хаан Хунли Жанжаа Ролбий Дорж, Банчин Балдан Иш гэсэн түвдийн хоёр ламаар судар ном заалгаж, чамгүй эрдэм сурч, Бээжин хотод 500 лам ном хурах хийд, өөрийнхөө ордноос холгүй газарт Будалын болон Дашлхүмбэ ордныг дуурайлгасан гурваас дөрвөн давхар хэд хэдэн сүм бариулж, “Ганжуур” сударыг манж хэлээр, “Данжуур”-ыг монгол хэлээр орчуулан хэвлэх ажил зохион байгуулжээ.[195]

VII Далай лам 1757 оны гуравдугаар сард насан өөд болсон байна. VIII Далай ламыг бага настай байхад улс орныг түүний төлөөний хүн болох Дэми хутагт удирджээ. Манж чин улсын эзэн хаан ивээн тэтгэгчийнхээ үүрэг хариуцлагыг биелүүлж Далай ламыг ширээнд залах тухай, өсвөр насны түүнийг зохих ёсны боловсролтой болгох талаар анхаарал тавих тухай зарлиг гаргаж байв.[196] Энэ үед Бутан, Бенгалийн хооронд мөргөлдөөн үүсэв. Бутаны бурханы шашны сүм хийдийн тэргүүн зуучийн үүрэг гүйцэтгэж өгөхийг Банчин ламаас хүссэн байна.

Бутаны элчийн хамт Дашлхүмбэ хийдэд Энэтхэг дэхь Британийн засаг захиргааны төлөөлөгч Ж.Богль Түвдтэй худалдааны гэрээнд гарын үсэг зурахаар хүрэлцэн иржээ. Богль дөрвөн сарын дараа ямар ч үр дүнд хүрэлгүй Энэтхэгт буцаж очсон байна.

1778 онд Амдо мужийн хэсэг дээрэмчин түвдийн засгийн газрын цай ачсан жингийн цуваа болон хэд хэдэн тосгон дээрэмдсэн байна.[197] Тэнд дэг журам тогтоох зорилгоор Түвдийн нэгэн сайдын удирдсан отряд, Сычуаниас чин улсын цэрэг иржээ. Чин улсын генерал байлдааны даалгавараа биелүүлсний дараа Хунли хаанаас: “Та Далай ламын цайны жингийн цувааг дээрэмдсэн хүмүүсийг цээрлүүлэн шийтгэжээ. Даалгавар биелсэн учир цэрэг гэртээ буцаж ирэх ёстой. Хэрэв та тэнд удвал Далай ламын харьяатуудад түвэг учруулах болно” гэсэн тушаал авсан байна. Хунли хааны урилгыг авсан VI Банчин лам 1779 онд манжийн эзэн хаадын зуны өргөө болох Чэндэ (Жэхэ муж) ордон руу хөдөлсөн байна. Эзэн хаан түүнд ярианы Түвд хэл сурч байгаа бөгөөд манай өвөг дээдэс V Далай ламыг хэрхэн угтаж байсан шиг тийм л уулзалт зохион байгуулах бодолтой байна гэж мэдээлжээ. Эзэн хаан Банчин ламд хөрөг зурагаа явуулахдаа Амьд Будда хөрөг зурганд мөргөх ёсгүйг цохон тэмдэглэжээ. Банчин ламыг 1780 оны зун Жэхэд хүрэлцэн ирэхэд Хунли хаан өргөөнийхөө үүдэнд түүнийг угтаж авсан байна.Эзэн хаан өвдөгөө сөхөрч мэндчилэхгүй байхыг ламд

анхааруулаад төвдөөр яриагаа эхэлжээ. Энэхүү айлчлал бурханы шашныг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж тэрээр батлан хэлсэн байна. Дараа нь Банчин лам Бээжин орж, тэндхийн Хуансы хийдийг түүнд гаргаж өгсөн байна. Гэвч тэр жилийнхээ намар Банчин лам цагаан бурхан өвчнөөр насан өөд болж, түүний шарилыг Дашлхүмбэ хийдэд хүргүүлжээ.

1783 онд английн шинэ элч С.Тернер Энэтхэгээс Төвдэд ирж, худалдааны гэрээнд гарын үсэг зурахыг дахин оролдсон[198] боловч дахиад л үр дүнд хүрсэнгүй. Төвдийн засгийн эрхийг VIII Далай лам авсан боловч шинэ төлөөний түшмэл Агваан Цүлтэм Далай лам болон амбан сайд нарын эрх мэдлийг хязгаарлав. Ингээд түүнийг Бээжинд дуудан ирүүлж, Лхаст амбан сайд нарын нөлөөг сэргээн тогтоолгох зорилгоор саатуулан хорьжээ.

Үүнээс өмнөхөн Балбыг нэгтгэсэн гурхүүд 1775 онд Сиккимд цөмөрч оров. Төвдчүүд Сиккимд хоол хүнсээр тусласан явдал гурхүүдийн дургүйцлийг төрүүлсэн байна.[199] Удалгүй Төвдтэй дайтах шалтаг гарч ирэв. Гарма Кагьюгийн чиглэлийн том лам нарын нэг Шамар Тулку Балбад дүрвэн гарчээ. Тэрээр Дашлхүмбэ хийд дэх Банчин ламын эд хогшлыг авах гэсэн хүслээ биелүүлэхэд гурхүүдийг ашиглана хэмээн найджээ. Гурхүүд ч энэ шалтагийг алдахгүйг хичээсэн байна. Балбад төвдийн цалин цагаан мөнгөөр Төвдийн хэрэгцээнд зориулж мөнгөн зоос цутгадаг байжээ.

Яваандаа уг зоосонд улам их зэс нэмэх болсон бол дахин цэвэр мөнгөн зоос гаргаж, хуучны холимог зоосыг эргэлтээс гаргахыг шаардаж эхэлсэн байна. Энэ нь төвдчүүдэд хохиролтой болж, балбынханд нэмэлт орлого өгөх болжээ. Түүнээс гадна гурхүүд илүү сайн чанартай давс нийлүүлэхийг төвдчүүдээс шаардав. Төвдийн сайд нарын зөвлөл хоёр төрлийн зоос цутгах ажлаа үргэлжлүүлэхийг балбын талд санал болгож, харин давсны чанарт гаалийн хэсгүүдэд төвд, балбын байцаагч нар хяналт тавих журам тогтоохоор болсон байна.

Гурхүүд энэ саналд татгалзсан хариу өгч, 1788 онд Төвдэд халдав. Тэд Ньянанг, Роншар, Кьиронг, Цонкаг эзэлж авсан байна. Төвдэд сууж байсан амбан нар энэ халдлагын тухай нэн даруй эзэн хаандаа мэдээлж, чин улсын цэрэг Төвд рүү хөдлөв. Энэ цэргийн эхний хэсэг ирж, тэдэнтэй төвдчүүд нэгджээ. Төвдчүүдийн ятгалагыг үл харгалзан чин улсын жанжин тулалдаанд орох гэж нэг их яарсангүй.[200] Ингээд чин улсын цэрэг гурхүүд рүү хөдөлж, тэднийг шахан хөөсөөр Шекарт өвөлжсөн байна. Төвдийн отряд гурхүүдийг Сиккимээс хөөн гаргав. Кьиронгэд гурван этгээдийн хэлэлцээ эхлэв. Төвдчүүд энэхүү хэлэлцээн дээр буулт хийхэд хүрэв. Тэд төвдийн дотоодын хууль журамд захирагдахгүй байх балбчуудын эрхийг

хүлээн зөвшөөрч, тэдэнд жил бүр дайны төлбөр өгч, балбын төлөөлөгчдийг Шигазе, Гьянзед ирүүлэхийг зөвшөөрөх үүрэг хүлээсэн байна. Балбын тал эхний төлбөр авсны дараа эзлэгдсэн нутгуудыг чөлөөлөх үүрэг хүлээсэн байна. Хуучин зоосны өртгийг бууруулж, харин тутрага (цагаан будаа), давсны өртгийг зах зээлийн ханшаар тогтоож, давсны чанарыг сайжруулахаар тогтов. Түвдийн худалдаачид Балбад очихыг хориглож, харин балба наймаачмд Түвдэд чөлөөтэй ирж, зочид буудал болон түлш шатахуун сонгож авах эрх эдлэхээр болсон байна.

Тийнхүү чин улсын цэргийн жанжин байлдааны ялалт байгуулах хүсэлгүй байснаас болж балбын тал өөртөө ашигтай гэрээ байгуулж чадсан байна. Гурхүүд болон хятадуудын хооронд маш бага ялгаа бий: гурхүүд дайсан болж ирсэн учир алж, талсан, хятадууд анд нөхдийн хувьд ирсэн учир мөн л алж, талсан хэмээн түвдчүүд ярьдаг байжээ.[201] Чин улсын цэргийн жанжны чадварлаг биш ажиллагаа түүний засгийн газрын дургүйцлийг төрүүлсэн үү, яасан, ямар ч байсан тэрээр нутаг буцаж очсоныхоо дараа амиа хорлосон юм билээ.Чин улсын түшмэл нарын шаардлагаар түвд, балбчууд манж чин улсын эзэн хаанд талархал илэрхийлжээ.

Балбачууд 1789 онд эхнийхээ татварыг авмагц Түвдээс гарч явсан байна. Балбын удирдагч манжийн эзэн хаанаас ван цол хүртэв.

Түвдчүүд дайны төлбөрийг багасгаж, дараа нь ерөөс төлөхгүй байхаар шийдэв.Улс төрийнх нь туршлага Далай лам болон сайд нарын зөвлөлд туйлын чухал хэрэгтэй болсон Агваан Цүлтэм Бээжингээс Лхаст эргэж ирсэн явдал дээрх бүх арга хэмжээний шалтгаан болсон байна.[202] Төлөөний түшмэл гурхүүдэд ашигтайгаар хятадуудтай нэгдэх гэсэн Кашаг буюу сайд нарын зөвлөлийг зэмлэн буруушааж, ашиггүй гэрээнд гарын үсэг зурсан хүмүүсийг иш татаж нэрлэсэн байна. Тэрээр 1791 онд зүрхний өвчнөөр нас баржээ. Тэр жил балбачуудтай хэлэлцээ хийх хоёр хэсэг төлөөлөгчид явуулсан боловч төлөөлөгчдийн гишүүдийн нэг хэсгийг хөнөөж, заримыг нь баривчлан хорьсон байна. Үүний дараа гурхүүд Түвдэд халдаж, Шигазег эзлэв. Лхаст эмх замбараагүй байдал үүсэв. Манж амбан Далай лам, Банчин лам хоёрыг Кам муж руу явахыг хүсэх болов. Гэвч Далай лам болон “томоохон сүм хийдийн” хамба нар хүмүүст үймж самуурахгүй байхыг итгүүлэн үнэмшүүлэхийг эрмэлзжээ.Түвдийн арми Шигазе дахь гурхүүд рүү давшиж, тэдэнд хангамж нийлүүлдэг замыг тасалсан байна. Гурхүүдийн дунд халдварт өвчин гарч, дараа жилийнх нь хавар Хунли хааны төрлийн нэг хүнээр командлуулсан чин улсын 13 мянган хүнтэй арми Түвдэд орсон байна. Гурхүүд бутцохигдож, түвдийн болон чин улсын

цэрэг Балбад цөмрөн орж, тус улсын нийслэл Катманду хүрэв.[203] Шамар Тулку амиа хорлов. Байлдааны ажиллагаа болсны хариуцлагыг түүнд оногдуулсан байна: тэрээр төвдийн дотоод асуудлыг шийдвэрлэхэд гурхууд тусална хэмээн найдаж Балба руу оргож, дайны үед яриа хэлэлцээ хийхэд балбын талыг баримталж, түүний нэгэн зарц гурхуудийн цэргийг Төвдэд авчирч Ньянанг, Роншар, Кьиронгийг эзлүүлж байжээ.[204]

Энэ удаад Балба улс булааж авсан эд хөрөнгийг эргүүлэн өгч, манжийн эзэн хаанд таван жилд нэг удаа "алба гувчуур" илгээж, төвдийн бүх олзлогдогчийг суллаж, Шамар Тулкугийн талынхныг шилжүүлэн өгөх үүрэг хүлээсэн байна. Энэ ялалтын дурсгалд зориулж Будалын ордны дэргэд төвд, манж, хятад хэлээр үйлдсэн бичээс бүхий багана босгожээ.[205] Түүний зэрэгцээ Лхас хотын хүн ам чин улсын цэргийг хэн ч урьж залаагүй, төвдчүүд өөрсдөө гурхуудийн учрыг олж чадах байсан, амбан сайд нар төвдийн хэрэгт хөндлөнгөөс оролцож байна гэсэн үг бүхий зурагт хуудас тараах эхэлжээ. Үүний дүнд Төвдэд байсан хоёр амбанг Бээжинд дуудан авч явсан байна. Шамар Тулкугийн талынхныг суллав. Харин түүний хийдийг засгийн газар хураан авч, түүний хойд дүр тодруулахыг хориглов. XX зууны сүүлчээр л XIV Далай лам түүний хойд дүр тодруулахыг дахин зөвшөөрчээ.

Балбын эсрэг ялалт байгуулахад чин улсын цэрэг чухал үүрэг гүйцэтгэсэн нь Төвдэд манжийн эзэн хааны байр суурийг хүчтэй болгов. Балбын мөргөлдөөнтэй холбоотой тэр үеийн хятадын баримт бичгүүдэд Төвд бол хятадын нэг хэсэг, Тэнгэрийн эзэнт гүрэнд захирагдаж байсан хэмээх томьёолол тааралддаг юм.[206] Гэтэл манжийн цэргийн командлагчаас Далай ламтай хийсэн хэлэлцээн дээр: "Эзэн хаан Аугаа их генерал Надад бүх зүйлийг дэс дараатай авч хэлэлцэх нарийвчилсан зааварчлага өгсөн билээ... Далай лам эзэн хаанд талархлаа илэрхийлэн сайтар бодож боловсруулсан энэ бүх саналыг авч үзнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Гэхдээ хэрэв эртнийхээ уламжлалыг баримтлах гэвэл эзэн хаан цэрэг гаргасны дараа амбан сайд болон гарнизоныг татахад бэлэн байна. Түүнээс гадна хэрэв хойшид иймэрхүү мөргөлдөөн гарвал эзэн хаан юугаар ч тусалж чадахгүй. Тиймээс төвдчүүд өөрсдөө таалаараа бүх асуудлыг шийдвэрлэх болно, хэрэв чадахгүй бол, хэрэв хүнд байдал тохиолдвол, хэрэв амархан гэж үзвэл өөрсдөө л сонголтоо хийх болно"[207] хэмээн тушаал биш, санал маягийн зүйл хэлсэн байдаг. Энэ нь Далай лам болон эзэн хааны хооронд "багш – ивээн тэтгэгчийн" харилцаатай байсныг тусган харуулж байгаа юм.

1792 онд "Төвд хуулийн" хэм хэмжээг бэлтгэсэн бөгөөд хожим нь

эдгээр хэм хэмжээ 1818 оны гадаад харилцааны хэрэг эрхэлсэн танхимын энэхүү хуулийн “Түвдийн тухай тогтоолын” бүрэлдэхүүнд оржээ. Эдгээр “тогтоолын” зүйл ангиудын үндсэн заалтууд дараах байдлаар илрэн гарч байна.[208] Ээлж ээлжээр солигдож байдаг хоёр амбанг Түвдэд томилж явуулна: тэдний бүрэн эрх, статус Далай лам, Банчин ламынхтай адил: иргэний болон цэргийн бүх түшмэл тэдэнд захирагдана: Балбын ванлигуудтай харилцах харилцаа тэдний эрх мэдэлд багтана: элчин төлөөлөгчдийн бүх гишүүнийг нэр заасан жагсаалтаар хилээр гаргана, амбан сайд нартай уулзсаны дараа л Далай ламд бараалхана: амбан нар Түвдийн санхүүг эмх журамд оруулна: Далай лам, Банчин лам нарын төрөл төрөгсөд татвараас зайлсхийж байгаа эсэх, эрх тушаалаа урвуулан ашиглахаас зайлсхийх зорилгоор тэд түшмэлийн албан тушаал эзэлж байгаа эсэхэд хяналт тавина: түвдийн армийн зардлыг нэмэгдүүлэхийн тулд Далай лам, Банчин ламын зардлыг хасах:гэмт хэрэгтнүүдийн эд хөрөнгийг сангийн санд шилжүүлж байгаа эсэхэд хяналт тавих эрх эдлэнэ: Лхас, Шигазе, Чамдо, Гьянзе, Тингригийн гарнизоныг эрх мэдэлдээ байлгах, шуудангийн албыг эрхлэн явуулах, хятадаас үр тариа тээвэрлэж, гарнизонуудыг үр тарианы бүтээгдэхүүнээр хангахын төлөө хариуцлага хүлээнэ хэмээн заасан байна.Эдгээр заалт Түвдийн ажил хэргийг дэг журамд оруулахад тус дөхөм үзүүлэх ёстой байлаа. Янз бүрийн үед хараат орнуудад суугаа гадаадын элчин сайдын яамд болон зөвлөх нар иймэрхүү үүрэг гүйцэтгэж байжээ.

Түүнээс гадна гадаад харилцааны хэрэг эрхлэх танхимаас гаргасан “хууль” амбан сайд нарын эрх мэдлийг үнэмлэхүй хэлбэрээр төлөөлөн гаргажээ. Үнэн хэрэгтээ бол амбан нар уламжлалт нөхцөл байдал болон орон нутгийн ёс заншлыг өөрчлөх чадваргүй байв.[209] Энэхүү хуулийн 29 заалтын зарим хэсгийг л түвдчүүд хүлээн зөвшөөрсөн байна.[210]

1793 онд Хунли хаан Лхас руу Алтан бумба явуулсан бөгөөд Далай лам, Банчин лам, Жавзандамба хутагтын хойд дүрийг тодруулах үед түүн дотор хийсэн нэрнээс сугалж шодох ёстой байв. Энэ дүрмийг хаая, тухайлбал дүр тодруулах үед маргаан үүссэн нөхцөлд л хэрэглэжээ.[211] Алтан бумба бол шарын шашны сургааль, өөрөөр хэлбэл Гэлугийн чиглэлийн сургаалийг эзэн хаан ивээн тэтгэж буйн билэг тэмдэг юм[212] гэж 1792 оны “түвдийн хуулинд” өгүүлсэн байна. Чин улсын эрх баригчдын зүгээс энэ ажлыг ямар нэгэн хэлбэрээр “удирдах” тухай ямар ч заалт байхгүй бөгөөд тэрхүү “хуулинд” нэгэнт тодруулсан дүрийг батлах тухай л өгүүлсэн байна.

Тэрхүү бумбыг Түвдийн гол сүм – Жокангийн сүмд байрлуулжээ. Шодолт хийх үед бумбыг Будалын ордонд манж чин улсын эзэн хааны

хөргийн өмнө байрлуулж, чин улсын амбан бумбанд хийсэн нэрнээс нэгийг савхаар татаж гаргах ажээ. Энэ бол хойд дүр тодруулах ажиллагааны сүүлчийн шат юм байна. Үүний өмнө эрэл хайгуулын удаан үйл явц үргэлжлэх ажээ. Энэ үйл явц шашны дүрэм, уламжлалаар тодорхойлогдох бөгөөд түүнд чин улсын төлөөлөгчид оролцох боломжгүй байв. Зан үйлийн ажиллагаанд зөнч мэргэдийн таавар, зөн билгийн элдэв зүүд зэргийг тайлах үйл, насан өөд болсон түрүүчийн хүний эдлэж хэрэглэж байсан зүйлсийг нэр дэвшигчид таних явдал зэрэг олон үйлдэл ордог байна. Яваандаа алтан бумбанаас шодолт хийх үйлдлийг цөөхөн тохиолдолд хийх болжээ. Гадаад харилцааны хэрэг эрхлэх танхимын архивын баримт мэдээллээр бол 1903 он хүртэлх 100 жилийн дотор У ба Цанг мужийн 39 хутагтыг алтан бумбанаас шодож тодорхойлсон байна.[213] Бурханы шашны бүх түүхэнд есөн удаагийн Далай лам, Банчин ламын тавыг тодруулахад (1822, 1841, 1857, 1858, 1887 он) тийм шодолт хийсэн байна. Зургаа дахь удаад 1995 онд Банчин ламыг "сонгоход" энэ аргыг хэрэглэжээ. IX Далай лам, XIV Далай лам болон IX Жавзандамба хутагт болон бусад өндөр тушаалын лам хуврагуудыг шодолт хийлгүйгээр тодруулсан байна.

Лхаст амбан нарын байр суурь хүчтэй болж байв. Далай лам, Банчин лам болон сайд нарын зөвлөл буюу Кашаг өргөх бичгээ шууд эзэн хаанд биш амбан нараар дамжуулан барьдаг болов. Лхас, Шигазе, Тингрид чин улсын гарнизон суулгав. Эдгээр гарнизон түвдийн армийн хамт амбан нарын мэдэлд очив.

Түвд цэргүүд чин улсын эзэн хаанаас бага хэмжээний мөнгөн тэтгэлэг, түвдийн засгийн газраас арвайн хувь хишиг авах ажээ.

Батлан хамгаалалт, хилийн хяналт болон гадаадынхан түвдэд очих зөвшөөрөл, санхүү, шүүхийн чухал чухал асуудал амбан нарын эрх мэдэлд орсон байна.

Түвдэд үзүүлэх манж нарын нөлөө түүхийн дээд цэгт хүрэв. Эзэнт гүрний улс төрийн нөхцөл байдал, амбан сайдуудын хувийн зан байдлаас хамааран тэдний нөлөө нэг үе өсч, нэг үе буурч байв. Харин бодит эрх мэдлийг урьдын адил түвдийн удирдлага хэрэгжүүлж иржээ. Төр, шашны өндөр албан тушаалд хэн нэгнийг томилохдоо чин улсын түшмэд болон эзэн хаантай олонхи тохиолдолд зөвлөлдөж байсан ч энэ нь засаг захиргааны удирдлага биш, "багш – ивээн тэтгэгчийн" харилцааны хүрээнд Түвдэд ирэх тусламж төдий зүйл байлаа. Өндөр албан тушаалуудыг урьдын адил түвдчүүд эзэлж, тэдгээрт хэн томилогдох нь Түвдийн дотоод улс төрийн нөхцөл байдлаар тодорхойлогдож ирсэн байна.

Түвдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох манж нарын боломж тун хязгаарлагдмал байлаа. Жишээ нь, 1796 онд гурхүүдтэй хийсэн дайнд тусласны төлөө чин улсын цэргийн жанжин талархал илэрхийлэн намайг татвараас чөлөөлсөн юм гэж түвдийн нэгэн тариачин мэдэгджээ.[214]Кашаг буюу сайд нарын зөвлөл манжийн генерал бол зөвхөн манай холбоотон учраас хүнийг татвараас чөлөөлөх эрхгүй хэмээн хариу мэдэгдэж, тэрхүү тариачинд татварынхаа дутууг нөхөж төлөхийг үүрэг болгожээ.

Барагцаалбал тэр жилүүдэд Лхас хотын хүмүүс манж, хятадуудыг эсэргүүцэн шоглосон элдэв төрлийн зурагт хуудас тарааж, тэд нартай хамсан ажилласан Түвд түшмэдийг зэмлэн буруушааж байлаа.[215] Амбан сайд нар болон манжийн гарнизоныг татан буулгаж явуулахыг шаардаж байв.Кам муж болон Төв Түвдийн хооронд зорчих чин улсын түшмэд халдлагад өртөх болов. Манжийн шинэ эзэн хаан Юньянь нөхцөл байдалтай танилцуулахаар тусгай даалгаварт хоёр төлөөлөгчийг Лхас руу явуулжээ. Ингээд чин улсын хэд хэдэн түшмэлийг эгүүлэн татаж, гарнизоныг 250-аад хүнтэй болгож багасгасан байна. Үүнд хариу алхам болгож түвдийн засгийн газар эсэргүүцлийн ажиллагаа санаачлан гаргагчдыг баривчлав. Гэвч эсэргүүцлийн хөдөлгөөн зогссонгүй. Хэрэгцээ гарвал гурхүүдэд хандсан нь дээр гэсэн үг яриа ч гарч байв. Манжийн элч нар юу хийхээ ч мэдэхгүй байв. Энэ бүхний дүнд 1805 онд өөр хоёр түшмэлийг Түвдэд ирүүлсэн байна. Тэдний мөрдөн шалгах ажлын дүнд нэг амбаныг гавлан хятад руу явуулж, өөр нэгийг Өрөмч (Шинжааны нийслэл) рүү явуулсан байна. Түшмэдүүд нь мэдлэг боловсролгүй, амбан сайдууд нь чадвар муутайн улмаас манж нар Түвдийн бодлогод нөлөөлөх чадвараа алдаж эхэлсэн байна.

1808 онд Далай ламын шинэ дүрийг тодруулав. Түвдийн албаны хүмүүс алтан бумбанаас шодолт хийхээс татгалзаж, өөр замаар сонгосон байна.[216] Тэдний зохион байгуулсан ёслолын ажиллагаанд Манж чин улс, Монгол, Балба, Бутаны төлөөлөгчид иржээ. Шинэ Далай лам удалгүй уушигны хатгалгаа өвчнөөр нас барав.Гурван шинэ нэр дэвшигчийг тодруулж, тэдгээрийн нэгийг шинэ Далай ламаар хүлээн зөвшөөрөв. Гэвч амбан сайд нар алтан бумбанаас шодуулахын тулд бүхнийг хийсэн байна. Энэ үед засаг баригч нас барж, шинээр томилогдсон засаг баригч түрүүн тодруулсан нэр дэвшигчийг X Далай ламаар баталсан тухай зарлав. Гэхдээ тэрээр Далай ламыг алтан бумбанаас шодож сонгосон хэмээн зарлажээ. Тэрээр иймхүү амбан сайдын үгийг дагажээ.

Чин улсын засгийн газрын шийдвэрээр Түвдээс тасалж авсан нутаг

дэвсгэрүүд янз бүрийн статустай байв. Манжийн эрх баригчид Дорнод Камад Монголын нэгэн адил орон нутгийн ванлигуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцдоггүй боловч тэдгээрийг аажмаар жижиглэн хуваах бодлого баримталжээ. Кам болон Амдогийн нутаг дэвсгэрүүдийг чин улсын болон түвдийн эрх баригчдад захируулах явдал нэр төрийн төдий, хяналт ч маш сул байв. Ванлигуудыг үе дамжин удирдах эрхийг Бээжинд баталсан төдий болдог байжээ. Үнэн хэрэгтээ бол вангууд буюу овог аймгийн удирдагчид бараг бүрэн бие даасан эрхтэй байв. Амдо муж дахь түвдийн голок аймгийн “мянгатын” олон дарга нараас зөвхөн нэг хүн л манж чин улсаас олгосон тамга барьж байсан бөгөөд гэхдээ л 1814 оноос өмнөх үйл явдал бишээ.[217] Тэнд байсхийгээд л тэмцэл хөдөлгөөн гарах боловч Лхас, Бээжингийн алин нь ч түүнийг сонирхдоггүй өнгөрдөг байв. 1807 онд голокуудын хоёр удирдагч бослого гаргахад[218] түвд, чин улсын цэрэг очиж дарсан байна.Тайван биш мужуудад дээрэмчдээс хамгаалах цөөн тооны дагалдах хүмүүсийн хамт тусгай төлөөлөгчид явуулдаг байв. Эдгээр түшмэдийн зохиосон баримт бичгүүд Данаг Косум, Цоломой, Шанди, Гормогийн хоорондох хил орчмын нутгуудад түвдийн хууль тогтоомж үйлчилж, түвдийн засгийн газар хяналт тавьдаг байсныг гэрчлэн харуулж байгаа юм. 1832 онд Хөх нуурын районд түвд, монголчуудын хооронд газар булаацалдсанаас үүдсэн мөргөлдөөн гарав. Тэнд түвдийн цэрэг очиж, 1834 онд үймээнийг дарсан байна. Жилийн дараа түвдийн засгийн газар зэвсэг хэрэглэх замаар Кама мужийн баруун хойд хэсгийн Пово тойргийн хүн амаар Лхаст татвар төлж, түвдийн хууль тогтоомжийг сахин мөрдүүлдэг болгожээ.

XIX зууны эхний хагаст Түвд орон гадаадынхны хувьд бараг бүрэн хаалттай нутаг болов. Түвдийн сайд нарын зөвлөл буюу Кашаг орон нутгийн эрх баригчдад гадаадынхан улс оронд орж ирэхэд бүхий л арга хэрэгслээр саад хийхийг үүрэг болгосон захирамж гаргасан байна.

Манжийн эрх баригчдын нөлөөн дор ийм шийдвэр гарсан гэж олонхи судлаач үздэг юм.[219] Бодит байдалд бол энд манж, түвдийн эрх баригч бүлгийнхний ашиг сонирхол давхацжээ. Манж нар өрнөдийнхий худалдааны өрсөлдөөн, улс төрийн түрэмгийлэн эзлэх бодлогоос, түвдчүүд шашны болон улс төрийн түрэмгийллээс тус тус болгоомжилжээ. Энэтхэг улс газар зүйн хувьд ойрхон оршдогийн улмаас түвд, манж нарт илүү сайн танигдсан Британийн колончлогчдын түрэмгий бодлого ийнхүү болгоомжлоход чухал нөлөө үзүүлжээ. Британчууд хэд хэдэн удаагийн дайн хийж, хавсарган нэгтгэх бодлого баримталж, элдэв төрлийн гэрээ хэлэлцээр

байгуулах замаар гималайн бүх орныг аажим аажмаар эрх мэдэлдээ оруулж авчээ.[220] Эдгээр орны олонхи нь Лхастай холбоотой байсан юм.

Их Британий түрэмгийлэл Манж чин гүрэн уналтад ороход түлхэц нөлөө үзүүлэв. XIX зууны эхний хагаст британийн Ост-Индийн компани төр улсынхаа ивээл дор үйл ажиллагаа явуулж, Хятадад хар тамхи эрчимтэй оруулж ирэх болсон байна. Хар тамхины арилжаа ч өсөв. Англичуудын хажуугаар америкчууд гарч ирэв. Хүн амаа хар тамхинаас хамгаалах гэсэн манжийн засгийн газрын бүхий л хүчин чармайлт талаар өнгөрөв. Ингээд 1839 онд эзэн хаан бүрэн эрхт төлөөлөгч томилж, гаднаас хар тамхи орж ирэхийг таслан зогсоох үүрэг өгснийг тэрээр биелүүлсэн байна. Их Британи улс худалдаачдынх нь эрх зөрчигдлөө хэмээн нэн даруй зарлан мэдээлж, цэргийн түрэмгийлэл хийж эхлэв. Техникийн хувьд үлэмж давуу талтай байсан британчууд ялалт байгуулж, зам зууртаа хятадын зарим хотыг эзлэн авч, тонон дээрэмджээ. Дайны дүнд чин улсын засгийн газар эрх тэгш бус гэрээнд гарын үсэг зурахад хүрсэн байна. Энэ гэрээгээр Их Британи улс худалдааны хөнгөлөлт, Сянганыг (Гонконг) мөнх эзэмших эрх болон британийн иргэд давуу эрхтэй байх боломж олж авсан байна. Манж чин улсын засгийн газар британчуудад төдийгүй америкчуудад дайны төлбөр төлөх ёстой болжээ.

Чин гүрэн сул дорой болж байгааг ашиглан цэргийн жанжин Зоравар Сингх догров аймгийн таван мянган хүнтэй арми командлан эзлэгдсэн Ладак мужаас 1841 онд Баруун Түвдэд халдав. Тэрээр Руток, Гарток, Цапаран, Пураныг эзэлж авав. Гэвч түвдчүүд догров аймгийнхныг ялж, Зоравар Сингх тулалдааны үеэр амь үрэгдсэн байна. Догр аймгийнхан галт зэвсэг сайтай, харин түвдчүүд гол төлөв сэлэм,жад, нум сум, цөөн тооныбүдүүлэг цахиур буугаар зэвсэглэсэн байв.[221] Цас ихтэй, хахир хатуу өвөл болсон нь ялалтад нөлөөлжээ. Түвдчүүд амь үрэгдсэн дайсандаа хүндэтгэлтэй хандаж.

Зоравар Сингхийн шарил дээр ариун гэгээн хүмүүсийн дурсгалд зориулан босгодог уур суварга хэлбэрийн сүрлэг том улаан хөшөө босгожээ.[222] Түвдчүүд Ладакт орж, тэнд хуарагнан буужээ. 1842 онд Ладакт догруудын нэмэлт хүч орж ирж, түвдчүүд ялагдаж, түвдийн цэргийн жанжнууд олзлогдсон байна. Олзны хүмүүсийг Ладакийн нийслэл Лех хотод хүргэж ирэхэд тэднийг түвдийн засгийн газрын төлөөлөгч хүлээж авсан байна. Дараа нь найрамдлын гэрээнд гарын үсэг зурж, энэ гэрээгээр хоёр тал бие биендээ халдан довтлохгүй байх үүрэг хүлээжээ. Хожим нь Ладактай байгуулсан гэрээгээр мөнхийн найрамдал тогтоосныг баталж, Төв Түвд

болон Ладакийн хилийг Лхари голоор татаж, Ладакаас Далай ламд тогтмол бэлэг явуулж байх, түвдийн худалдаачдыг Ладакт үнэ төлбөргүй орон байр, хоол хүнсээр хангаж байх болсон байна. Хоёр талын олзлогдогчидыг суллав. Олзлогдсон догр аймгийнхан болон ладакчуудын гуравны нэг нь өмнөд Түвдэд үлдэхээр шийджээ. Тэд нутгийн Түвд бүсгүйчүүдтэй гэр бүл болж, алим, лийр, усан үзмийн тариалан эрхлэх болжээ. Манж амбан догруудтай хийсэн дайны тухай, мөн гэрээ байгуулсан тухай Бээжин рүү мэдээлсэн боловч Англитай дайтаж байсан чин улсын засгийн газар үүнд нэг их анхаарал тавилгүй өнгөрчээ.

1844 онд Ци Шань амбан Лхаст ирэв. Тэрээр түвдийн засаг баригчийг хэд хэдэн хууль бус үйлдэлд буруушаан баривчилж, 28 зүйл бүхий меморандумыг Бээжинд илгээж, өөрт нь Далай лам, Банчин лам нартай адил эрх мэдэл олгохыг шаарджээ.[223] Үүний хариуд Сэра хийдийн лам нар босч, засаг баригчийг суллав. Манж амбан нуугдаж амжсан байна. Дараа өдөр нь Босогчид бууж өгч, засаг баригчийг дахин баривчилж, Бээжинд хүргүүлэхээр явуулсан боловч европын гүрнүүдийн түрэмгийлэл болон тайпиний бослого манж чин улсын засгийн газарт түвдийн асуудалд зохих ёсны анхаарал тавих боломж олгоогүй ажээ. 1847 онд Ци Шань цэргийн болон санхүүгийн асуудлыг шийдвэрлэх эрхийг түвдийн засаг захиргаанд шилжүүлэв.

Балба улс 1814, 1840, 1842, 1846 онд англичуудын түрэмгийлэн эзлэх бодлогын эсрэг тусламж үзүүлэхийг хүсч манж чин улсын засгийн газарт хандсан боловч үр дүнд хүрсэнгүй, яагаад гэвэл хүчний тэнцвэр дэндүү нөгөө талд байжээ. 1852 онд балбын шинэ төлөөлөгчид Бээжинд ирэв. Төлөөлөгчид 1853 оноос өмнө тэнд очсон байна. Балбачууд өрнөдийн гүрнүүдийн түрэмгийлэл болон эрх тэгш биш гэрээ хэлэлцээрийн улмаас чин гүрэн дотооддоо тогтворгүй болсныг олж мэджээ. Тэд үүнийг далимдуулан 1855 онд түвдэд халдаж, Ньянанг, Роншар, Цонка, Пуран тойргуудыг эзэлж авав. Дараа жил нь Балба, Түвдийн хооронд байгуулсан найрамдлын гэрээгээр балбачууд худалдааны эрх чөлөө, түвдийн хууль дүрэмд захирагдахгүй байх эрх олж авч: нутаг нэгтнүүдийнхээ хэргийг удирдах балбын төлөөлөгч Лхаст ирж, Түвдийн тал дайны төлбөр төлөх үүрэг хүлээжээ.

Балбын тал булааж авсан дөрвөн тойрог, бүх сарлаг, зэр зэвсгийг Түвдэд эргүүлж өгөхөөр болсон байна. Хойшид маргаантай асуудлыг хамтран шийдвэрлэж байхаар тохиролцов. Гэрээний хоёрдугаар зүйлд балбачууд (гуркхи) болон Түвд улс аугаа их эзэн хаанд хүндэтгэлтэй хандаж буйгаа

нотолж, гурхүүдийн засгийн газар гадаад орны цэрэг халдсан тохиолдолд Түвдэд чадахын хэрээр тусалж байхаар тохирлоо хэмээн өгүүлсэн байна.[224] Энэ гэрээ Балбад ашигтай болсон ч үүнээс өмнө чин улсын гүйцэтгэж байсан хамгаалагчийн үүрэг тус улсад оногджээ.

Насан өөд болсон Далай ламын хойд дүрийг 1858 онд тодруулжээ. Алтан саванд гурван хөвгүүний нэрийг бичиж хийгээд сугалж шодсон байна. Дөрвөн жилийн дараа засаг баригч болон нэг сайдын хооронд маргаан үүсэв. Ингээд засаг баригчийг огцруулсны дараа том толгой түшмэдүүд, Гандан болон Дрепун хийдийн лам нарын Ассамблей хуралдаж алтан савнаас хийсэн шодолтыг баталсан боловч засаг баригчийг манжийн эзэн хаанд үйлчлэхийн тулд л шодолт зохион байгуулсан хэмээн буруушаажээ.[225] Засаг баригч хятад руу зугатаж, түүний хөрөнгийг хураав. Тэрээр эрх мэдлийг нь эргүүлж өгөхөд туслахыг эзэн хаанаас хүссэн боловч эзэн хаан засаг баригч асны эд хөрөнгийг эргүүлэн өгч, түүнийг түвдэд эргэж очих зөвшөөрөл олгохыг хүссэнээр энэ тусламж хязгаарлагджээ. Харин Ассамблей энэ хүсэлтийг биелүүлэхгүй байх нь зүйтэй хэмээн үзсэн байна. Засаг баригч Лхас орох замдаа нас баржээ.

1861 оны арван нэгдүгээр сард Бээжинд ордны эргэлт гарч хааны бэлэвсэн эхнэр асан Цысигийн бүлэг засгийн эрхэнд гарчээ.Хувийн эрх ямбаа хадгалах гол үндсэн авьяастай хуучин нууц амраг энэ эмэгтэй харгис хэрцгий, бас завхай зайдан явдлаараа нэрд гарсан нэгэн ажээ.[226] Тэрээр 1898 онд японы Мэйдзи сэргээн засварлалтын хэлбэрийн шинэтгэл хийж улс гүрнээ аврах гэсэн эзэн хаан зайтяны эхлэл санаачлагыг тасалдуулж чаджээ. Ийнхүү нэг сайхан боломжийг алджээ. Эрх мэдэлд шунасан Цыси эзэн хаан зайтяныг (дашрамд дурдахад зээ дүү буюу өргөмөл хүү) “албан тушаалдаа тохирохгүй хүн” хэмээн хууль бусаар зарлаж, насан эцэслэтэл нь гэрийн хориond суулгаж, хар тамхинд оруулсан байна. Цысийг нас барахаас өмнөхөн түүний тушаалаар эзэн хааныг хүнцэл хэмээх хороор хордуулжээ.[227] Муу удирдлага улс оронд гарсан хямралыг гүнзгийрүүлж байх зуурт хааны ордныхны муу ёс суртахуун эзэнт гүрний нэр хүндийг хүн амын нүдэн дээр улам унагажээ. Цыси болон түүний бүлгийнхнээр удирдуулсан эзэнт гүрэн мөхөл рүүгээ гулсаж орсон байна.

1862 – оос 1871 он хүртэл Түвдийн төр засгийн бодит эрх Гандан болон Дрепун хийдийн Ассамблейд, харин 1871-ээс 1873 он дуустлах хугацаанд Үндэсний ассамблейн гарт байв. Шинэ XII Далай ламыг хүүхэд ахуй цагт янз бүрийн бүлгийн дотоодын тэмцэл байн байн засаг төр солигдохын шалтгаан болжээ. Далай лам засгийн эрх авснаас хойш хоёрхон жил

болоод 1875 онд насан өөд болов. Түүнийг хүч хэрэглэн үхүүлсэн тухай цуу яриа нилээд хүчтэй гарч байжээ. XIX зууны дунд үед төвдийн хэрэг явдлыг нүдээр үзсэн европын шажин номлогч Э.Р. Гюк амбан сайд нар ямар ч бодит эрх мэдэлгүй байсан, сайд нар (калон) төвдийн дотоод хэрэгт манж нар аливаа хэлбэрээр хөндлөнгөөс оролцохыг тэвчдэггүй байсан гэж мэдээлсэн байна.[228]

Төвдтэй хил залгаа Дорнод Туркестанд Чин улсаас тасарсан исламын хэд хэдэн улс байгуулагджээ. 1863–1877 онд төвдийн засгийн газар Чин улс болон Кам мужийн дотоодын эмх замбараагүй байдлыг ашиглан дорно зүгт Хөх мөрөн хүртэл эрх мэдлээ тэлсэн байна. Төвдийн Дергэ болон Хор ванлигууд төвдийн төв засгийн газрын мэдэлд оров. XIX зууны сүүлч гэхэд Камын хойд нутгийн эзэмшлүүд Лхасын эрх мэдэлд байсан бол өмнөд Камын Ба тойрог, Литан муж Сычуаны тавиул төлөөлөгчийн нэр төдий хяналтад байжээ.[229] Лхасын цэрэг Дергэ ванлигаас гарч явсны дараа энэ ванлиг үнэн хэрэгтээ Лхас болон Бээжингээс хараат биш болов.[230] Тэр үед Төвдэд манжийн эзэн хааны үзүүлэх нөлөө эрс сулрав.Амбаны үйл ажиллагаа нь элдэв төрлийн ёслолын ажиллагаанд, түүнчилэн төвдийн засгийн газарт хийж буй шинэ томилгооны тухай эзэн хаанд явуулах илтгэлийг хэлэлцэхэд оролцох төдийгөөр хязгаарлагдах болов. Чин улсын гарнизон хэдхэн зуун цэрэгтэй болсны олонхи нь хятад цэрэг, Төвд бүсгүйчүүдийн холимог гэр бүлээс төрсөн хүүрхдүүд ажээ. Эдгээр цэрэг маш ядуу учир шинэ жилийн баярын үеэр айл айл хэсч арслан, барс, луу тэргүүтнийг дүрсэлсэн бүжиг дэглэн үзүүлж хэд гурван зоос олдог байжээ.[231]

Стратегийн чухал байрлалтай Төвд орон Их Британи улсын сонирхлыг гойд их татаж байлаа.Британчууд өөрийн колони Энэтхэгээс нутагшсан төвдчүүд болон энэтхэгчүүд зэрэг туршуулуудыг Төвд рүү явуулдаг байв. Англичууд энэтхэгийн умард нутагт тэр туршуулуудыг бэлтгэх тусгай сургууль байгуулсан байна.[232] Тэнд бэлтгэгдсэн тагнуулууд зураг зүйн болон байршлын шинж чанартай бөгөөд цэрэг дайны ач холбогдол бүхий мэдээлэл цуглуулах ажээ. Тэдний явуулсан мэдээллийг Галигдаа хотод боловсруулан нууцалдаг байв. 1887 онд төвдчүүд британчуудад зориулсан чухал мэдээлэл цуглуулж байсан Төвд судлаач томоохон эрдэмтэн С.Ч. Дасыг Төвдэд тодорхой хугацаагаар оршин суухад нууцаар тусласан Банчин ламын төлөөний хүн болох Сенчен ламыг цаазалжээ.

Сикким 1860-аад онд Британийн эзэнт гүрний хараат болж, Бутан улс нутаг дэвсгэрийнхээ зарим хэсгийг Британид шилжүүлэн өгөхөд хүрсэн байна. Британчууд Даржилинг муж болон өөр зургаан тойргийг эзэнт

гүрнийхээ бүрэлдэхүүнд оруулав.[233] Тэр үед Сикким ч, Бутан ч түвдээс хараат байсан ажээ. Тийм учраас Манж чин гүрэн энэ хоёр улсад голлох эрх мэдэлтэй байх гэж эрмэлзсэн байна. Гэвч британийн түрэмгийлэлд ямар ч хариу үйлдэл үзүүлээгүй нь энэ хоёр "боол" манж нарт захирагдаж байгаагүйн нотолгоо мөн. Түвдчүүд Сиккимийн вантай тохиролцсоны үндсэн дээр тийш нь нэг мянган хүнтэй цэргийн отряд явуулж, түвдийн хилээс урагш 20 километрийн зайтай орших Линту тосгоны хавьд бэхлэлт байгуулжээ. Гэвч английн отряд энэ бэхлэлтийг эзэлсэн боловч түвдчүүд тэрхүү отрядыг отон тулалдаж байсан учир англичууд арга буюу энэтхэг рүү буцжээ.

1876 онд англичууд Чифуд чин улсын амбан сайд Ли Хунжанаар конвенцид гарын үсэг зуруулсан бөгөөд Түвд рүү төлөөлөгчдөө явуулж байхыг англичуудад зөвшөөрсөн заалт уг конвенцид оржээ. Энэ конвенцид орсон түвдийн тухай зүйл анги үндсэн баримт бичигтэй холбоогүй байв.[234] Түвдэд очих англичууд тусгай паспорттой байх ёстой гэж энэхүү зүйл ангид өгүүлжээ. Ингэхлээр Британи улс ч, манж нар ч түвдийг өөр өөрсдийн эзэнт улсын нэг хэсэг хэмээн үздэггүй байсан учраас л 1858 оны Тянжиний гэрээнд заасны дагуу британчууд манжийн эзэмшил газруудаар орон нутгийн эрх баригчдын гарын үсэг зурсан паспортоор зорчиж байх үүрэг хүлээжээ. Гэтэл Түвд Их Британий төлөөлөгчдийг хүлээж авахаас татгалзсан байна. Түвдийн үндэсний ассамблейн гишүүд манжийн эзэн хаан англичуудыг түвдэд зорчуулахыг зөвшөөрөх эрхгүй хэмээсэн шийдвэр гаргасан байна.[235] Манж нар түвдийн үндэсний ассамблейн гишүүдийн шийдвэрийг өөрчлүүлж чадаагүй учир үүнийхээ нөхөн төлөөс болгож англичууд Бирмыг хавсарган нэгтгэхийг хүлээн зөвшөөрсөн байна.

1890 онд Галигдаа хотод "Сикким, Түвдийн тухай конвенцид" гарын үсэг зурав. Манж чин улсын засгийн газар Сиккимийг Их Британий хараат нутаг болохыг хүлээн зөвшөөрөв. Түвд-Сиккимийн хилийг тодорхойлж, Түвдэд худалдаа хийх тухай асуудлаар англичуудтай хэлэлцээ хийхээр төлөвлөжээ. Конвенцид британийн талаас Энэтхэгийн дэд ван, чин улсын талаас лхасын нэг амбан гарын үсэг зурсан байна. Түвдчүүд энэ конвенцийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, хил дээр байрлуулсан шонгуудыг авч хаясан байна.[236]

1893 онд манж,британийн төлөөлөгчид "худалдаа, зам харилцаа, бэлчээрийн тухай нэмэлт дүрэмд" гарын үсэг зуржээ. Энэ хоёр хэлэлцээрт түвдийг оролцуулалгүйгээр гарын үсэг зурсан учир тус улс тэдгээрийг мөн хүлээн зөвшөөрөөгүй юм. Түвдийн эрх баригчид англичуудтай худалдаа


Арван гуравдугаар Далай лам Түвдэнжамц

хийхээр төлөвлөсөн Ятунги хавьд нутаглахыг түвдчүүдэд хориглож, Парид цэргийн харуул тавьжээ. Хятадууд Түвдэд ямар ч эрх мэдэлгүй, Хятад улс нь Түвдийн нэр төдий л сюзерен (эзэн улс) юм гэж Сиккимд сууж байсан британийн төлөөлөгч К.Уайт дурсан бичжээ.[237] "Түвдийг захирах хятадын сюзеренитет эрхийн" тухай ойлголтыг англичууд гаргасан бөгөөд тэд манжийн эзэнт гүрнийг хятад хэмээн үзэж, 1720 оноос хойшхи эзэн хаан болон түвдийн харилцааг буруу ойлгон тайлбарлажээ.[238]

1895 онд XIII Далай лам Түвдэнжамц (1876–1933) түвдийн засгийн эрхэнд гарав. Тэрээр эрч хүчтэй, авьяаслаг улс төрч байв. Энэ хүн манжийн төлөөний түшмэл болох Дэмо хутагтыг баривчилж, бүх эрх мэдлийг гартаа авч чадсан байна. Үүний дараа тэрээр манж амбан нарыг улс орныг удирдах хэргээс зайлуулав.[239] Манж амбан нар энэ тухай Бээжинд мэдээлж, төлөөний түшмэлийн эрх мэдлийг сэргээх тухай эзэн хааны зарлигийг хүлээж авсан байна. Гэвч төлөөний түшмэл шоронд нас барж, шинэ амбан хааны зарлигийг нийтэд зарлаж зүрхлээгүй ажээ.

Энэ зуурт Их Британи улс түвдийн талаар баримтлах бодлогоо боловсруулж байлаа. Британийн энэтхэгийн дэд ван лорд Ж.Н. Керзоны төлөвлөгөө Түвдийг ганцаардуулахыг зогсоож, тэнд англичуудад давуу эрх олж авах, Түвд дэхь манж гүрний "сюзеренитетийг тэмдэглэхэд" чиглэжээ.[240] Их Британийн эрх баригчид Орос улсыг Төв Ази дахь гол өрсөлдөгчөө хэмээн үзэж байв.[241] Британчууд хятадыг худалдааны чухал түнш, Азид Оросыг тогтоон барих гол цайз хэмээн үзэж байлаа.[242] Англичууд урт хугацааны уршиг дагаварын тухай эрэгцүүлэн бодолгүйгээр түвдийг оростой хийх өрсөлдөөнд задгай мөнгө болгон ашиглахаар шийдсэн байна.

Орос улс XIX–XX зуунд Түвд, Монголтой хэлхээ холбоогоо өргөжүүлэхийг эрмэлзжээ. Тус улсын газар зүйн бодлого, түүхэн уламжлал, угсаатны зүйн бүрэлдэхүүнээс ийм эрмэлзэл урган гарч байгаа юм. Орос улс евразийн нийтлэг байдлын салшгүй хэсэг болж, төв азийн улсуудтай

харьцангуй урт хилээр зэрэгцэн оршдогийн хувьд эрт дээр үеэс түвд-монголын соёл иргэншилтэй хэлхээ холбоотой явж иржээ. Юун түрүүн түвдийн бурханы шашин бол түвд, монголчууд төдийгүй мөн тэдэнтэй төрөл ард түмэн болох буриад, халимагуудын уламжлалт шашин мөн учир дээр дурдсан хэлхээ холбоо ямагт.

Оросын эзэнт улсын амьдралын салшгүй хэсэг болж иржээ. Монгол ард түмнүүд Оросын эзэнт улсын бүрэлдэхүүнд орсон явдал бол байлдан дагуулалтын үр дүн байгаагүй, оросууд ч тэднийг дорд үзэж ирээгүй ажээ. Энэ явдал Орос улсыг ямагт Их Британаас ялгаруулж иржээ. “Оросууд төв азийг байлдан дагуулсан явдал бол дорно зүгийн нэг ард түмэн нөгөөгөө байлдан дагуулсан хэрэг мөн бөгөөд зан үйлийн төстэй байдал нэгдэн нийлэх явдлыг илүү хөнгөн болгодог юм байна. Гэтэл английн түшмэд өөрсдийг нь индус (энэтхэг) овог аймгийнхнаас зааглаж буй тэрхүү саад тотгорыг зөөлрүүлэх гэж хэзээ ч эрмэлзэж байгаагүй билээ”[243] гэж англичууд тэмдэглэн бичиж байв.

Хаант оросын захиргаа тодорхой хязгаарлалт тавьж байсан хэдий ч “жижиг ард түмнүүдийн” нийгмийн амьдралд хөндлөнгөөс оролцохгүй байхыг эрмэлзэж, тэдгээрийг дарлал мөлжлөг, уусч устах аюулаас хамгаалахыг хичээж (хэдийгээр “орон нутагт” элдэв зөрчлүүд гарч байсан ч) ирсэн байна. Хаант оросын засгийн газар Төв азийн нилээд сул дорой улсуудын тухайд ч мөн ийм бодлого баримталж,олон улсын тавцанд тэдгээрийг ивээл хамгаалалтандаа авч ирсэн байна. Оросын хаадыг Алтан Ордны улсын залгамжлагчид хэмээн үзэж, тэр хаад бурханы шашинд хүндэтгэлтэй хандаж байсан явдал ч зохих ёсны үүрэг гүйцэтгэсэн бизээ. Тиймээс монголын үндэстэн ястнууд цагаан хааныг хүндэтгэж, Орос улсад итгэл хүлээлгэн ханддаг байв. Түвдүүд ч үүнийг мэддэг байсан нь маргаангүй хэрэг билээ.

XIX зууны сүүлчээр оросын эзэнт улс түвдтэй улс төрийн хэлхээ холбоо тогтоож эхэлсэн байна. Орос дахь Далай ламын төлөөлөгч болсон буриадын цанид хамба Агваан Доржиев (1854–1938) үүнд онцгой үүрэг гүйцэтгэжээ.[244] Тэрээр нилээд хэдэн жил XIII Далай ламын багш нарын нэг байсан хэмээх яриа ч бий. Ямар ч байсан тэрээр буддын боловсролын нэг чухал хэсэг болох гүн ухааны мэтгэлцээнд (ном хаялцахыг хэлж байна) Далай ламын түнш байжээ. “Тэрхүү хүч (Орос-зохиогч) хол байсан хэдий ч түүний нэр хүнд бусад аль ч орныхыг бодоход Түвд, Монголд нилээд дээгүүр байсан юм”[245] гэж англичууд хүлээн зөвшөөрчээ. Энэ байдал Их Британий эрх баригчдын дургүйг хүргэсэн байна. Төв Азитай түүхийн

болон угсаатны зүйн хувьд холбоотой биш байсан Их Британи улс Оросыг дэлхийн эн бүс нутагт явуулах түрэмгийлэн эзлэх бодлогынхоо зам дахь гол саад тотгор хэмээн үзэж байв. 1900–1901онд II Николай хаан А. Доржиев болон Далай ламын бусад төлөөлөгчийг хүлээн авч уулзсан тухай мэдээ англичуудын сэтгэлийг ихэд түгшээсэн байна. 1902 онд оросын эсрэг чиглэлтэй англи-японы хэлэлцээрт гарын үсэг зурав.

1902 онд английн хэвлэл Орос улс Түвд болон хятадтай нууц гэрээ байгуулсан тухай нэг бус удаа мэдээлсэн байна.[246] Тухайлбал 1902 оны дөрөвдүгээр сард Бээжинд сууж байсан “Ройтерс” агентлагийн сурвалжлагч мэдээлэхдээ оросын элч төлөөлөгч П.М. Лессар Түвдэд тусгаар тогтнол бэлэглэхийг манжийн эзэн хаанд санал болгосон байна гэжээ. Түвдийг оросын ивээлд оруулах тухай, бээжингийнхэн Түвд дэхь ашиг сонирхлоо Орост шилжүүлж өгөх тухай нууц гэрээ хэлэлцээрүүд байгуулсан тухай мэдээлж байлаа.

Тийм гэрээ хэлэлцээр байгаагүйг оросын гадаад бодлогын архивын материалууд гэрчлэн харуулж байна.[247] Манж чин улстай Оросын хийж байсан хэлэлцээ ингэхийн шалтгаан болсон нь тодорхой юм. Британийн засгийн газар, цэргийн яамны төлөөлөгчид болон энэтхэгийн хэвлэлийнхний хувьд Түвдэд учирах “оросын аюул”-аас болгоомжлох шалтгаан байгаагүй нь ойлгомжтой билээ. Нөгөө талаас тийм аюул гэгч нь британийн хамгийн дайнч бүлгийнхний төлөвлөгөөг зөвтгөж, британийн цэргийн халдлагын нэг шалтаг болж байв. Англичууд Түвд рүү төлөөлөгчид явуулснаа Керзоны гурван захидлыг задлаж үзэлгүйгээр буцаасан, 1890 онд Чин улстай байгуулах хэлэлцээрийг түвдийн эрх баригчид хүлээж авахаас татгалзсан зэрэг түвдийн засгийн газрын ажиллагаанд өгч буй зүй ёсны хариу хэмээн тайлбарлажээ.[248] Гэтэл бодит байдалд бол урьдаас бодож төлөвлөсөн эдгээр ажиллагааны цаана түрэмгийлэл үйлдэх гэсэн санаа нуугдаж байсан юм.

1903 оны хоёрдугаар сарын 2-нд Лондонд суугаа оросын элчин сайдын яам Их Британий гадаад явдлын яаманд явуулсан меморандумдаа оросын засгийн газар Түвдэд англичууд цэргийн ажиллагаа явуулах гэж байгаа тухай найдвартай эх булагаас мэдэж байгаа бөгөөд хэрэв тийм ажиллагаа үйлдвэл орос улс тухайн бүс нутагт ашиг сонирхлоо хамгаалах арга хэмжээ авахад хүрнэ гэдгээ анхааруулж байна гэж тэмдэглэжээ.[249] Лондонд орос, британийн тал энэ сэдвийг хэд хэдэн удаа авч хэлэлцсэн байна. Оросын гадаад явдлын яам Түвдийн бурханы шашны удирдагчидтай хэлхээ холбоо тогтоох, Далай лам болон бээжингийн эрх баригчдын харилцаанд байнгын ажиглалт тавих зорилгоор Дарцедо (Кандин)-д тусгай элч явуулахаар

шийдсэн байна. Түүнээс гадна энэ нь Орос улсад Өмнөд хятад дахь Англи, Францийн үйлдлийг ажиглах, Түвд рүү явж буй оросын мөргөлчдөд ажиглалт тавих, Манж чин гүрэнтэй эдийн засгийн харилцаа хөгжүүлэх боломж олгох ёстой байлаа. Доржиев тийм төлөөлөгчийг мөргөлчний дүрээр Дарцедогийн нэгэн хийд рүү явуулахыг санал болгожээ. Ингээд Б. Рабданов ийм төлөөлөгч болсон байна. Тэрээр 1903 оны сүүлчээр Дарцедод очжээ. 1903 оны арваннэгдүгээр сарын 6-нд английн эрх баригчид түвдтэй залгаа хилийг давж орохыг өөрийнхөө отрядад тушаасан бөгөөд арваннэгдүгээр сарын 8-нд оросын гадаад явдлын яам энэ тухай мэдээлэл ирүүлэхийг.

Рабдановоос хүсчээ.1904 оны эхээр Рабданов түвдэд дайнд бэлтгэж байна, түвдчүүд бүх европчуудаас оросуудыг л талархан үзэж байна гэж мэдээлжээ. Рабданов Лхаст байсан Доржиевээс мэдээлэл авдаг байжээ. Рабданов 1905 буюу 1906 онд Орост буцаж ирсэн байна

1903 оны гуравдугаар сарын 20-нд Оросын гадаад явдлын яамнаас Лондонд суугаа элчин сайддаа явуулсан захидалд орос улс Түвдэд статус-квогоо хадгалан үлдэх сонирхолтой байна, хэрэв англи улс түүнийг зөрчвөл Оросын засгийн газар Түвдэд биш, харин Азийн бусад нутагт зохих ёсны арга хэмжээ авна хэмээн өгүүлжээ.[250] Үүний дараа хэлэлцээ болов. Хэлэлцээнд оролцогч талууд Түвдийн статус-квог зөрчихгүй байхаар тохиролцож, Англи улс түвдийн нутаг дэвсгэрийг хавсарган нэгтгэхгүй байхаа амласан байна. Британийн онцгой ашиг сонирхол болон газар зүйн шалтгаанаас болж Түвдэд бий болсон “орон нутгийн давуу байдлыг” Орос улс хүлээн зөвшөөрөв.

1903 оны арваннэгдүгээр сарын 6-нд Их Британий засгийн газар Түвдэд цөмрөн орох тушаал өгөв. “Бөглүү орныг” үзэх гэсэн зүгээр нэг сонирхол биш, харин улс төр-шашны аугаа их төвд ноёлох байр суурьтай байхыг хүссэн Орос улсын далд явуулагын дүнд нилээд ноцтой мэт бидэнд санагдсан түвдчүүдийн дайсагнасан дээрэлхүү хандлага л 1903 оны арванхоёрдугаар сард британийн зэвсэгт бүлгийг Түвд рүү хөдөлгөх шалтгаан болсон юм”[251] Лондонд суугаа оросын элчин сайд А.К. Бенкендорфт британийн харьяатуудын талаар түвдчүүд “харгис зан авир” гаргасан нь халдлага үйлдэх шалтгаан болсон тухай мэдээлсэн байна. Лондонд суугаа оросын элчин сайд 1903 оны арваннэгдүгээр сард VII Эдуард вантай уулзав. Тэд бусад асуудлын зэрэгцээ Түвд, Манж, Персийн (Иран) байдлыг хэлэлцжээ. Орос, Их Британий зөрчлийг “илүү сайн ойлгох” явдал англичуудын зорилго байсан бөгөөд Их Британи улс Германтай дайтахад бэлтгэхдээ ирээдүйнхээ холбоотонтой санал зөрөлдөөнөө урьдаас зохицуулахыг эрмэлзсэн байна.



Их Британы отряд Лхас хот дахь Будалын ордны хавьд

1903 оны арванхоёрдугаар сард генерал Д.Р.Л. Макдональд, хурандаа Ф.Э. Янгхасбенд нарын командалсан английн цэргийн отряд энэтхэгээс Түвдэд оров. Энэ отряд 1904 оны зун гэхэд түвдийн төв хэсэгт орсон байв. Англичууд Гуругийн районд түвдчүүдтэй хэлэлцээ хийж байх зуурт английн отряд түвдийн хуаран руу гал нээсний уршгаар 500 хүн амь үрэгдэж, 300 гаруй хүн олзлогдож, англичууд бүх зэвсгийг булааж авсан байна. Английн отряд цааш давшиж Дзамтен, Соугхан, Нейин, Гьянзед түвдчүүдийн эсэргүүцлийг даржээ. Гьянзегийн зонг цайз их буугаар галласны дараа эзлэгдэв. Олон Түвд хүн алагдав. зонг цайзын командлагч зугатаж гараад нэмэлт хүч цуглуулан эргэж ирэн английн лагерийг авах гэж бас хоёр өдөр тулалдсан боловч олон хүнээ алджээ.

Энэ үед манж амбаны төлөөлөгч Гьянзед ирж, амбан маань биеэр хүрэлцэн ирэхэд бэлэн байгаа боловч түвдийн засгийн газар тээврийн хэрэгсэл гаргаж өгөхгүй байгаа учир ирж чадсангүй гэж британчуудад мэдээлсэн байна.[252] Англичууд Гьянзегээс Лхас руу хөдөлж, түвдчүүдийн эсэргүүцлийг даван урагшилсаар байв. Англичууд Каро-лагийн хавцалд

хоёр урвагч малчны тусламжтайгаар түвдийн бэхлэлтийг тойрон гарч, өндөрлөг газраас давшжээ.

Британчуудтай хийсэн тулалдаанд түвдийн армийн бараг гуравны нэг нь амь үрэгдэв. "Түвдчүүдийн эрэлхэг зориг үнэхээр маргашгүй юм" хэмээн англичууд хүлээн зөвшөөрсөн байна.[253] Тэгвэл БНХАУ-д: "Түвдчүүд британийн хүчийг баатарлагаар эсэргүүцэж, империализмын эсрэг хятадын ард түмний тэмцлийн түүхэнд яруу алдарт хуудас үлдээв"[254] гэж бичиж байв. Хятадууд энэ дайнд оролцоогүй нь үнээн. Гэхдээ англичууд дээрэм тонуул хийгээгүй, эвдлэн бусниулахаас зайлсхийхийг эрмэлзэж, шархадсан түвдчүүдэд тусламж үзүүлж, тэрч байтугай хүнс болон бусад материалыг худалдан авч байжээ.

Британийн цэргийн давших замд чин улсын төлөөлөгчид Англи, үвд улсууд дайн хийж байгаа, харин хятад улс хоёр орны аль алиных нь найз юм гэсэн үг бүхий ухуулах хуудас газар сайгүй нааж байжээ.[255] Ингэсэн нь Түвд болон Манж чин улс бол бие даасан улсууд мөнийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болжээ. 1904 оны наймдугаар сарын 4-нд британчууд Лхаст оров. Тэднийг орж ирсэн эхний өдөр манж амбан Ю Тай английн цэргийн хурандаа Янгхасбендтай уулзав. Амбан англичуудыг хоол хүнсээр хангаж, бүрэн эрхт чин улсын засаг захиргааны төлөөлөгчийн хувьд бүх талын дэмжлэг үзүүлэхээ амласан байна.[256] Түвдчүүд бол харанхуй бүдүүлэг, онгироо сагсуу зэрлэгүүд гэж тэр амбан британчуудад итгүүлсэн байна. Тэрээр булзаж бултсан тактик баримталж: эхлээд Хятадаас ирэх хугацаагаа элдэв аргаар хойшлуулж, ирсэн хойноо Лхасаас гарахгүй сууж байжээ. Түвдэд хуучин байр сууриа сэргээн тогтоохын тулд британи, түвдийн хүчийг адилхан сулруулахыг хятадууд хичээсэн хэмээх сэтгэгдэл англичуудад төржээ.

Хожим нь төлөөний сайд болон түвдийн түшмэд англичуудтай хэлэлцээ хийж эхлэв. Энэ үед нэгэн Түвд лам английн лагерьт сэм орж ирж, английн хоёр офицерын амь насыг хөнөөсөн байна. Тэр лам ямар хийдэд шавилан суудагийг хэлүүлж чадаагүй ажээ. Ламыг нийтийн өмнө цаазлан хороов. Англичууд үймээн самуун гарахаас зайлсхийхийн тулд "том хийд" бүрээс нэг нэг лам барьцаа болгож авсан байна.

Эдгээр үйл явдлаас өмнөхөн долдугаар сарын 30-нд XIII Далай лам нийслэлээс гарч, хойд зүг рүү явжээ. Тэрээр өөрийнхөө эзгүй хойгуур засгийн эрх бариулахаар Гандан хийдийн Ти Ринбүүчи Лувсан Жалцан Ломашарыг төр баригчаар томилжээ.[257] Британчуудтай учир начираа олохыг түүнд даалгасан байна. Далай лам Монгол руу ийнхүү хөдөлжээ. Тэрээр 1904 оны арваннэгдүгээр сарын 27-нд тэр үед манж чин улсад



Түвд лам VIII Богд гэгээн – Монголын сүүлчийн эзэн хаан. Төмөр дээр пааландаж хийсэн бурхан. (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)

хараат байсан Гадаад Монголын нийслэл Өргөө (одоогийн Улаанбаатар) хотод ирсэн байна. Тэнд Гадаад Монголын шашны удирдагч буюу умард зүгийн бурханы шашны дээд удирдагчдын нэг VIII Богд гэгээн Жавзандамба хутагтын өргөө байсан юм. Далай ламыг монголын эрх баригчид, олон тооны мөргөлчид, түүний дотор Халимаг, өвөр байгалаас ирсэн мөргөлчид ёс төртэй угтан авчээ. Монголд Далай лам II Николай хааны төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж эхлэв. Тэдний нэг, нэрд гарсан жуулчин П.К. Козлов энэ хэлэлцээний тухай нэг бүрчлэн бичиж үлдээсэн байна.[258] Далай лам оросын дэмжлэг авна хэмээн найдаж Монголд бараг бүтэн жил суусан байна. Тэрээр сүм хийд, лам нартай маш найрсаг харьцаж байв.[259] Далай лам шашны ном хаялцаанд их цаг зав гаргаж, гүн ухааны нарийн ээдрээтэй асуудлуудыг лам нар тайлбарлаж өгөх ажээ. Тэрээр монгол хэл сурч, насан эцэстэлээ монгол хувцас өмсөх дуртай байжээ.

“Хувааж ав, захир” хэмээх зарчмын дагуу ажиллаж байсан манжийн эрх баригчдын өдөөн хатгалагын уршгаар Далай лам, Богд гэгээн хоёр эв түнжингүй мэт тийм байдал үүсгэжээ.[260] Бодит байдалд бол энэ хоёр их хүн хэвийн харилцаатай байсан боловч үүнийгээ нуухад хүрсэн байна. Тэд хэд хэдэн удаа уулзжээ.[261] Эдгээр уулзалтын агуулга тодорхой бус хэвээр үлджээ.Далай лам болон монголын нөлөө бүхий хутагт, гэгээнтнүүд болон тайж нар “цус урсгахаас зайлсхийхийн тулд Орос улсын ивээл, дэмжлэгийн дор хятадаас тусгаарлаж, бие даасан холбооны улс байгуулахаар эргэлт буцалтгүй шийдсэн юм” гэж Хиагтад сууж байсан оросын хилийн комиссар А.Д. Хитрово гэрчлэн бичиж үлдээжээ.[262] Далай лам болон Богд гэгээний уулзалтын үеэр энэ шийдвэрийг гаргасан байж ч болзошгүй билээ. Манж чин улсын удирдлага Монгол, Түвдтэй тохиролцсон гэрээ хэлэлцээрийг зөрчиж, бие даасан эдгээр орныг ердийн нэг муж болгох чиг шугам баримталж эхэлсэнтэй холбогдуулан ийм шийдвэр гаргасан байж болох талтай билээ. Монгол, түвдийг хятадын колони болгох явдал дээрх чиг шугамын хамгийн чухал зорилго байв. Ингэснээр бээжингийн эрх баригчид

өрнөдийн гүрнүүд түрэмгийлэл үйлдэхээр зэхэж буй үед Манж чин улсыг бэхжүүлнэ хэмээн найджээ.

Англичууд Лхасыг эзлэн авсныхаа дараа түвдчүүдтэй хэлэлцээ хийж эхлэв. Есдүгээр сарын эх гэхэд хэлэлцээрийн эх бичиг боловсруулав. Британчууд энэ хэлэлцээрт Түвдийн бүрэн эрхт удирдагч Далай ламаар гарын үсэг зуруулахыг хүссэн байна. Манж амбан болон түвдийн төлөөлөгчид Далай ламд захидал бичиж Лхаст хүрэлцэн ирэхийг хүсчээ.[263] Далай лам эргэж ирэхгүй нь нэгэнт тодорхой болмогц манж амбан (магадгүй англи хурандаагийн нөлөөн дор) “Далай ламын цолыг түр хугацаагаар хурааж”, түүний оронд Банчин ламыг томилохыг чин улсын эзэн хаанд зөвлөсөн байна. Ингэх нь буддын сургаальд харшлах байлаа. Гэсэн ч утгагүй зарлиг гардгаараа гарсан байна. Энэ шийдвэрт эзэн хаан зайтянь биш, харин Цыси зөвшөөрөл өгсөн нь маргаангүй, яагаад гэвэл тэр үед эзэн хаан юу ч шийдвэрлэж чадахаа больсон байв.

Хятадууд Лхас хотод Далай ламыг “тушаал бууруулсан” эзэн хааны зарлиг гарсан тухай зарлал нааж, түвдчүүд түүнийг хуулж хаяж байжээ.[264] Гэсэн ч зарлиг гарсны дараа 1904 оны есдүгээр сарын 7-нд Лхаст англичуудтай хэлэлцээр байгуулав. Энэ хэлэлцээрийг Лхасын конвенц хэмээн нэрлэдэг юм. Хэлэлцээрийн дагуу түвдийн засгийн газар 1890 оны англи-хятадын гэрээ, 1893 оны Дүрмүүдээр тогтоосон Сикким, Түвдийн хилийг хүлээн зөвшөөрч, Түвдийн гурван хотод худалдааны зах нээж, Их Британид 500 мянган стерлингийн фунтын дайны төлбөр төлж, түвдийн хэрэгт гадаадын гүрнүүдийг хөндлөнгөөс оролцуулахгүй байх үүрэг хүлээсэн байна.[265] Дээрх хэлэлцээрийн 9-р зүйлд зааснаар түвдийн засгийн газар британийн засгийн газрын зөвшөөрөлгүйгээр “нутаг дэвсгэрийнхээ ямар ч хэсгийг гадаадын гүрэнд тавьж өгөхгүй, худалдахгүй, түрээсээр эзэмшүүлэхгүй, дэнчин болгож тавихгүй, өөр ямар нэгэн замаар эзэгнэлд өгөхгүй байх” үүрэг хүлээжээ.[266] Хэлэлцээрийн 5-р зүйлд зааснаар түвдийн засгийн газар төсвийн хөрөнгийг (бараа буюу мөнгө) аливаа үндэслэлээр ямар нэгэн гүрэн буюу түүний төлөөлөгчид олгохгүй байх үүрэг хүлээв.

Энэ зүйлд заасны дагуу гадаадын гүрэн гэсэн ойлголтод Манж чин гүрэн ч багтаж байгаа бөгөөд энэ нь 1906 оны англи-чин улсын хэлэлцээрийн 3-р зүйл, 1914 оны Симлагийн хэлэлцээрийн 6-р зүйлээр нотлогдож байгаа юм.[267] Манж амбан, Бутан, Балбын төлөөлөгчид энэхүү хэлэлцээр байгуулахад гэрчийн этгээдээр оролцсон байна. Манж амбан гарын үсэг зурах ёслолыг өөрийнхөө өргөөнд хийхийг санал болгосон ч Янгхасбенд (английн хурандаа) болон түвдийн төр баригч хоёр Будалын ордны ёслолын



Арван гуравдугаар Далай ламын “цолыг хураасан” тухай Чин улсын зарлиг. Энэхүү зарлигийг Лхас хотын оршин суугчид урж хаяжээ (Уоддель, 1906)

танхимыг санал болгосныг хүлээн зөвшөөрсөн байна. Гарын үсэг зурах үеэр танхимд 200 англи цэрэг байсан бөгөөд ордныг цэрэг болон их буугаар бүслэн хүрээлсэн байжээ. Энэ хэлэлцээрт Түвдийг тусгаар улс хэмээн үзсэн байна.

Энэ баримт бичгийг Орос, Герман улсууд, мэдээжийн хэрэг манж чин улсын эрх баригчид сөрөгөөр хүлээж авсан юм. Чин улсын эрх баригчид Түвдийг захирах өөрсдийнх нь эрх мэдлийг хүлээн зөвшөөрөөгүй уг хэлэлцээрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан байна.

Английн эзэмшлийн цэрэг 1904 оны есдүгээр сарын 23-нд Лхас хотоос гарч явсан ч дайны бүх төлбөрийг төлөх хүртэл Чумбигийн хөндийд үлдэх ёстой байв. Мөн оны арван нэгдүгээр сарын 11-нд энэтхэгийн амбан захирагч хэлэлцээрийг батлахдаа дайны төлбөрийн хэмжээ болон төлөх хугацааг багасгасан байна.

Түвдийн тухай асуудал Их Британтай Орос улсын хийсэн хэлэлцээн дээр чухал байр эзэлсэн байна. Лондон, Петербургт хийсэн хоёр орны дипломат төлөөлөгчдийн хэлэлцээ Янгхасбендын отряд Түвд рүү явж байх үед ч үргэлжилсэн хэвээр байв. 1904 оны дөрөвдүгээр сард буюу

орос – японы дайны үед VII Эдуард оросын элч А.П. Извольскийтэй (ирээдүйн гадаад явдлын яамны сайд) хэлэлцээ хийхдээ Оростой найрсаг харилцаа тогтоох хүсэлтээ илэрхийлжээ.[268] Орос улсын түвдийн бодлогод эсрэг тэсрэг хоёр чиг шугам байсан нь: Түвдийг британчуудын эзэгнэлд оруулахгүй байх эрмэлзэл, францийн зуучлалтайгаар их Британтай ойртох анхны алхам болгон Түвдийн асуудлаар найрамдлын хэлэлцээр байгуулж, улмаар шинэ Антантад (1904–1907 онд Англи, Франц, Оросын хооронд байгуулсан холбоо) хүрэх эрмэлзэл байв.[269] Оросын гадаад явдлын яам Лондон, Бээжинг харж хүлээзнэсэн, тухайн нөхцөл байдалд зохицсон байр суурь баримталж байв. Гэхдээ европ талаа илүү баримталжээ. Нөгөө талаас оросын II Николай хаан, цэргийн удирдлага, олон нийт Түвдэд английн хийсэн түрэмгийллийн тухай мэдээг сэтгэл түгшин хүлээж авсан байна. Хаан бурханы шашинт хэсэг халимаг хүнийг нууцаар тийш нь явуулжээ. 1905 онд тэд Лхаст очиж, түвдийн эрх баригчид, шашны томчууд болон амбан сайдтай уулзсан байна.

Шүүмжлэлийн даралт шахалтад орсон Британи улс Манж чин гүрэнтэй онцгой хэлэлцээр байгуулав. 1906 оны дөрөвдүгээр сарын 27-нд Бээжин хотноо Лхасын хэлэлцээрийн нэмэлт хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Энэ нь Түвдийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг чин улсын засгийн газарт шилжүүлсэн хэрэг болсон бөгөөд энд Чин гүрнийг "гадаадын гүрнүүдийн" нэрсийн жагсаалтаас хасчээ. Ийнхүү манжийн эзэн хаан Түвдийн бүрэн бүтэн байдлын төлөө британийн засгийн газраас илүү их хариуцлага хүлээх болсон байна.[270] Түвдийн засгийн газар энэ хэлэлцээрийг Далай лам, эзэн хааны хооронд байгуулсан "багш – ивээн тэтгэгчийн" харилцааг зөрчсөн хэмээн үзэж хүлээн зөвшөөрөөгүй юм.

"Энэ гэрээг хэн нэгэн этгээд заавал биелүүлэх зүйл хэмээн үзэж болохгүй юм" гэж Түвдийн засгийн газрын дүгнэлтэд өгүүлсэн байна. [271]

1907 оны наймдугаар сарын 31-нд Петербург хотод "Перс, Афганистан, Түвдийн хэргээр Орос, Их Британий хооронд байгуулсан Конвенцид" гарын үсэг зурав. Энэ конвенциэр Ираныг (Перс) нөлөөний хүрээнд хувааж, Афганистаныг завсрын улс хэмээн хүлээн зөвшөөрч, харин Түвдийн хэрэгт хоёр гүрэн оролцохгүй байх үүрэг хүлээсэн байна. Орос, Их Британи улсууд мөн Түвдийн талаархи Бээжингийн "сюзеренитет" эрхийг хүлээн зөвшөөрч, зөвхөн бээжингээр дамжин түвдтэй харилцаж байх үүрэг хүлээжээ. Тийнхүү орос улс Перс, Афганистанаас ашиг олох гэсэн хоосон мөрөөдлөөсөө болж соёл иргэншлийн болон газар зүйн бодлогын хувьд өөрт нь чухал ач холбогдолтой оронтой ойртохоос татгалзжээ. Гэхдээ хоёр

гүрэн Түвдийн хувь заяаг түүний өмнөөс, түүнийг оролцуулалгүйгээр шийджээ.

Британчууд Түвдэд цөмрөн орсон явдал чин улсын эрх баригчдыг айлгажээ. Тэд англи, орос, францчууд задран унаж буй эзэнт гүрэнд шинэ баазтай болохоос айжээ.[272] Түвдийн эрх баригчид хүсэлт гаргаагүй ч Манжийн засгийн газар Түвдийн өмнөөс англичуудад дайны төлбөр хийв. Манжийн засгийн газар түрэмгийллийг няцаахад ямар ч тусламж үзүүлээгүй хэрнээ ийнхүү Түвдийг "эзэмших" ажилд орсон байна.[273]

Бүр 1903 оны арванхоёрдугаар сард Сычуань мужийн захирагч бусад хэд хэдэн хүнтэй хамт эзэн хаанд меморандум явуулж, "Сычуаны хил орчмын нутаг", өөрөөр хэлбэл Камыг хөгжүүлэх санал тавьсан байна.[274] "Хөгжүүлэх" арга хэмжээ гэгч нь газар тариалан, уул уурхайн хэрэг нэвтрүүлж, хятад нүүн суурьшигчдыг ирүүлэх явдал болох ёстой ажээ. XX зууны эхэн хүртэл Түвдэд хятадаас ирж суурьшигчид тийм ч олон байгаагүй билээ.[275] "Зэрлэгүүдийн (өөрөөр хэлбэл нутгийн нүүдэлчин түвдүүд) зөрүүд занг" зэвсгийн хүчээр номхотгохыг санал болгожээ.[276] 1904 оны эхээр Сычуаний уурхайн товчооны хоёр ажилтан Батангад ирж, тэндхийн газар үржил шимтэйг олж мэдээд тэр нутгийг "хөгжүүлэх" хэтийн төлөвийг авч хэлэлцэх болсон байна. Барагцаалбал энэ үед Чамдо руу явж байсан Фэн Чуань амбаны орлогч Батангад бууж, дээрх хүмүүстэй уулзжээ. Ингээд тэд "хөгжлийг" эхлүүлэхээр шийдэж, жижгэвтэр талбай гаргасан байна. Тэр талбайг хятадууд боловсруулах болов.

Янгхасбендын отряд Лхаст орсонтой холбогдуулан чин улсын эзэн хааны ордныхон Түвдийн засгийн газарт захирагддаг Ньяронгийн районд эрх мэдлээ тогтоохоор шийдэв. Энэ тухай захирамж Лхаст суугаа амбан, Батангад суугаа түүний орлогч нарт ирсэн байна. Нөхцөл байдал улам хурцдаж: амбаны орлогчийн байгуулсан отрядууд урьд өмнө байгаагүй гадаадын системээр байлдааны бэлтгэл хийж, хятадууд улам их газар хагалж, Батангад францийн католиг шашны төлөөлөгчийн газар нээгдэж, бүх Түвд түшмэдийг өөр тийш нь явуулах юм гэнэ гэсэн цуу яриа дэгдэв.

1905 оны хавар бослого гарав. Энэ бослого хятад, өрнөдийн зэрэг гадаадын түрэмгийллийг эсэргүүцсэн байна. Бослогын голомт сүм хийдүүд байсан ч айл өрх бүрт хэн нэг нь лам байсан учир энэ бослого түвдийн хүн амын бүх давхарагыг хамрах болов. Фэн Чуань болон бусад хэд хэдэн хүн алагдаж, католиг шашны төлөөлөгчийн газрыг хоосортол нь дээрэмдсэн байна.[277] Үүнийг далимдуулан 1905 оны зун Сычуаниас ислам сүсэгт генерал Ма Вэйчийн удирдсан арми Батангад оров. Хоёр сарын дараа

хятад генерал Жао Эрфэний 7500 цэрэг Ма-гийн армитай нэгдэв. 322 лам цаазлуулав.[278] Ма Сычуаньд эргэж ирж, Жао тэндээ буюу Камд үлдсэн байна.Тэрээр зөвхөн Батан, Литангад хяналт тавьж байв. Хүн ам халдан түрэмгийлэгчдэд дайсагнан хандаж, бослого ч өргөжив. Жао бослогыг нухчин дарахын тулд залхаан цээрлүүлэх ажиллагаа үйлдсэн байна. Энэ ажиллагааны явцад бүхнийг эвдлэн сүйтгэж, тонон дээрэмдэж, хүмүүсийг үйл олноор нь гэсгээн цээрлүүлж, түвдчүүдийг цаазлан хороожээ.[279] Лам нар голдуу 1317 хүн алагдаж, зургаан хийд бүрэн буюу заримдаг байдлаар сүйдэж, шашны зан үйлийн металл эдлэлүүдийг хайлж зоос болгожээ. Түвдчүүд энэ генералыг харгис үйлдлийнх нь төлөө “жао-яргачин” хэмээн нэрлэх болжээ.[280]

Жао Эрфэн Камд хятадууд суурьшуулахыг өөгшүүлэн дэмжээд зогсолгүй түвдчүүдийг ч хятадчилахыг эрмэлзжээ. Түвдийн суурин газруудын нэрийг хятад болгож өөрчлөв.[281] 1906 онд тэр генерал Батангийн 43 дүрэм гэгчийг зарлав. Оршин суугчдад хятад хувцас өмсөж, хятадаар ярих, күнзийн сургаалийг даган мөрдөх, хятад ёс заншлын дагуу аж төрөх, хятад овог авах, үс гэзгээ хятад маягаар засуулах, эцэг эхээ хятад заншлаар оршуулж байхыг тушаасан байна.[282] Сычуаны хятадуудыг Дорнод Түвдийн “зэлүүд” нутагт ирж суурьшихыг уриалах болов.[283] 1907 онд Жао Эрфэний цэрэг өмнөд Камын түвдчүүдээс их хэмжээний үр тариа (арвай ) хурааж авсан байна. 1907 оны сүүлч, 1908 оны эхэн үе гэхэд эзлэгдсэн нутаг дэвсгэрийн Түвд захиргаадыг хятадын цэргийн эрх баригчдаар сольжээ.[284] Камын засаг захиргааны хуучин системийг устгав. “Гадаад” орнуудыг колони болгон хувиргах чин улсын шинэ бодлогын үр шим гэвэл энэ байна.

1906 оны Хэлэлцээрийн үргэлжлэл болгон 1908 оны дөрөвдүгээр сард Галигдаа хотод “Түвдтэй худалдаа хийх дүрэм” гэгчид гарын үсэг зурсан бөгөөд энэ дүрмийн дагуу захууд болон худалдааны замууд дахь цагдаагийн албыг Бээжин хариуцах болсон байна. Оросын элчин сайдын яамны ажилтан Я.И. Кростовецоос Гадаад явдлын яамандаа ирүүлсэн мэдээллээр бол үүний дараа бээжингийн засаг захиргаа Түвдэд ээнт гүрний удирдлага тогтоох арга замыг эрж хайх болсон байна.[285] Бээжингийн эрх баригчид түвдийн засгийн эрхийг хувааж, Далай ламд зөвхөн шашны хэргийг даатгаж, засаг захиргааны бусад бүх асуудлыг манж нарт хариуцуулахаар шийдсэн байна.[286] Түвдийн тухай дипломатын бүх асуудлыг бээжингийн засгийн газартай ярилцан шийдвэрлэх хэрэгтэй, бээжингийн оролцоогүй байгуулсан бүх гэрээ, хэлэлцээр хүчингүй байх болно гэж Бээжинд суугаа гадаадын төлөөлөгчдөд мэдээлжээ. Мөн онд (1908) Жао Эрфэнийг хилийн

хэрэг эрхэлсэн дээд комиссар, Лхасын хоёрдугаар амбанаар томилов. Тэр генерал Чамдод бүс нутгийн засгийн газар байгуулж, Түвдийн нийслэл рүү дайнаар мордох гэж шийджээ.[287] Манжийн засгийн газар үүнийг замуудад цагдаагийн хамгаалалт тавих шаардлага гэгчээр тайлбарлаж, Энэтхэгээр дамжуулан цэргээ оруулахыг англичуудаас хүссэн боловч татгалзсан хариу авсан байна.[288] Далай лам Их Британи, Орос, Франц, Япон, Балбаас яаралтай тусламж хүсэв. Их Британи улс Бээжингийн эрх баригчдад эсэргүүцэл илэрхийлсэн төдийгөөр өнгөрсөн нь дээрх хүсэлтийн цорын ганц үр дүн болжээ.

II Николай хаан, цэргийнхэн болон оросын олон нийт түвдийг дэмжсэн сэтгэлээ илэрхийлсэн нь Далай ламыг орост ирүүлэх буюу түвдэд цэргийн тусламж үзүүлэхэд төдийгүй түвдийн шашны тэргүүнийг хамгаалуулах казакуудын отрят явуулахад ч хангалтгүй зүйл болоод өнгөрчээ. Энэ бүхэнд оросын гадаад явдлын яам саад тавьжээ.[289] Тус яам түвдийн тусгаар тогтнолын дайснуудтай дипломатын нарийн ээдрээтэй тоглоомд хутгалдаж орсон байна. Лондон, Бээжингийн уур хилэнг хүргэхгүй байх гэсэн тус яамны хүсэл Төв Азид Орос улсын олж авах ашгаас илүү хүчтэй болсон байна. Ийнхүү манжийн засгийн газар санасандаа хүрч, XIII Далай лам Монголоос хятадаар дамжин нутаг буцахад хүрчээ. 1906 онд тэрээр Халхаас Хөх нуур хүрч, дараа нь Сианиар дамжин Бээжин явжээ.

Төмөр замын буудалд түүнийг дотоод, гадаад явдлын яамны сайд нар, түүнчилэн Бээжин хотын дарга угтаж авсан байна.[290]

Далай лам Хуансы хийдэд буув. 1908 оны есдүгээр сарын 27-нд Далай ламд зориулж ёслолын хүлээн авалт зохион байгуулсан боловч тэрээр урьд өмнөхөөсөө нэг л өөр шинжтэй байжээ. Цыси өөрийнх нь дэргэд Далай ламын өвдөгнөөс адис авах ёслол үйлдэхийг зөвшөөрсөн байна.[291]

Дараа нь Цысигийн төрсөн өдөр ордны заншлаар тэндхийн бүх дээдчүүл болон Далай лам түүнд хүндэтгэл үйлдэн баяр хүргэжээ. Далай ламд зориулж Бээжин хотод тансаг дайллага зохион байгуулахад бурханы ном уншиж цамын бүжиг харайсан нь Цысид гойд их таалагджээ.[292] Далай ламд "Аугаа их, Буян хишигт, Мөнхөд орших Будда" цолыг "эргүүлэн" олгосон боловч "Үнэнч, Дуулгаварт" хэмээх үг нэмжээ.[293] Хоёр талын хэлэлцээн дээр Далай лам чин улсын цэрэг болон түшмэдийг Камаас гаргахыг шаардаж, Түвдтэй харилцах Чин улсын харилцаа ямагт шашны ивээл болон харилцан туслах явдалд үндэслэж ирснийг онцлон тэмдэглэжээ. Цыси түрүүчийн харилцаа хэвээр үргэлжлэхийг батлан илэрхийлсэн боловч Далай лам дан ганц шашны харилцааг эрхэмлэдэгт гадаад явдлын яамны сайд дургүйцэл

илэрхийлсэн байна.[294] Ингээд хоёр тал Камд байгаа чин улсын цэрэг болон түшмэдийн тоог цөөрүүлэхээр тохиролцжээ.

Эдгээр үйл явдал нууц амраг явсан энэ эмэгтэй болон түүний ордныхны нэг л сонин онцлог байдлыг гэрчилж харуулсан бөгөөд тэндхийн хэт их сүсэг бишрэлтэй байдал бурханы шашин болон күнзийн сургаальтай огт үл нийцсэн шинжтэй байжээ. Цыси өөрийгөө байнга Нигүүлслийн охин тэнгэр Гуаньиньтэй харьцуулан үзэх ажээ. Ингэхдээ тэр бэлэвсэн эхнэр ордныхон нь түүнийг "Буддад хүндлэгдсэн хатан" гэх мэтээр дуудахад дуртай ажээ.[295] Энэ бүхэн Далай ламын "цолыг хурааж", Банчин ламыг "томилж", доромжлолын шинж чанартай ёслолын ажиллагаа зохион байгуулж "цол эргүүлж өгөх", бурханы шашны гол үндсэн сургааль номлолыг бүдүүлгээр зөрчихөд саад болоогүй ажээ. Энэ үед манж чин улсын хууль ёсны эзэн хаан хэрэг дээр гэрийн хорионд сууж байв.

Арван нэгдүгээр сарын 15-нд Цыси нас барав. Өмнөх өдөр нь тэрээр эзэн хаан зайтянд хор өгч хөнөөсөн юм.[296] Далай лам бээжингийн Юнхэгун хийдэд нас барсан дээрх хоёр хүний сүнсийг залах ном уншиж, дараа нь манжийн сүүлчийн эзэн хаан Пуи-г хаан ширээнд залах ёслолд оролцсон байна.[297] Далай лам Бээжинд Их Британи, Франц, Герман, АНУ, Японы төлөөлөгчидтэй харилцаа тогтоох гэж эрмэлзсэн боловч хятад түшмэд дипломат ёсоо ч умартан үүнд саад болохын тулд чадах бүхнээ хийжээ.

1908 оны сүүлчээр Далай лам Амдогийн Гүмбэн хийдэд шилжиж очив. Арваннэг-арван хоёрдугаар сард тэрээр Лхасдаа буцаж ирэхийг хүссэн захидлыг төвдийн эрх баригчдаас авсан байна. 1909 онд чин улсын шинэ арми 1908 оны "дүрмэнд" заасан худалдааны төвүүдийг хамгаалах зорилгоор Чамдогоос Төвдрүү хөдлөв.[298]

Цэргүүдэд хоол хүнс гэж гаргаж өгөөгүй учир тэд барагцаалбал 15 бээр газар яваад л орон нутгийн оршин суугчдыг дээрэмдэж байжээ. Тэр оны есдүгээр сард манж амбан Лянь Юй Төвд орон 200 гаруй жил чин улсын колони байсан тухай тунхаг бичиг нийтлүүлсэн байна. Жао Эрфэн арван нэгдүгээр сард бээжингийн эрх баригчдад хандаж Төвдийг аль болох түргэн хугацаанд ердийн муж болгохыг зөвлөв.[299] 1910 онд тэрээр Дазяньлугаас (Дарцедо) Конгпо Гьемда (Лхасаас зүүн тийш 120 бээр) хүртэлх нутаг дэвсгэрийг чин улсын шинэ муж, хэрэг дээр бол хятадын колони болгохыг санал болгожээ. Энэ шийдвэрийг хэрэгжүүлэхэд Синхайн хувьсгал саад болсон ч хорин таван жилийн дараа энэ нутгийг нэгтгэн Сикан ("баруун кам") муж байгуулав.

1909 оны арван хоёрдугаар сард Далай лам Лхаст буцаж ирэв. Жао

Эрфэн халдах аюултай холбогдуулан манж амбантай хэлэлцээ хийж эхэлсэн байна. Амбаны орлогч түүнд жаогийн цэрэг худалдааны төвүүдийг хамгаалах зорилгоор газар газарт хувиарлагдсан тул Түвдийн дотоод хэрэгт оролцохгүй гэж батлан хэлжээ. Энэ цэргийн нийт тоо 1 мянгаас давах ёсгүй байв.[300] 1910 оны хоёрдугаар сард 2700 хүний бүрэлдэхүүнтэй чин улсын тэргүүн шугамын цэрэг Лхаст орж ирэв. Далай лам дахиад л, энэ удаад бол Энэтхэг рүү зугатав. Лянь Юй амбан энэ тухай мэдэж, хойноос нь цэрэг явуулж, шашны тэргүүний толгойг өөрт нь авч ирэхийг тушаасан байна. Гэвч түвдчүүд хятад цэргүүдийг саатуулж чадсан бөгөөд Далай лам ч Энэтхэг рүү гарч явжээ. Хятад цэргүүд хэд хэдэн хүн буудан хороож, Жокан болон Будалын ордныг буудаж,[301] Будалын ордон болон Норовлинд байсан Далай ламын өмч болон Түвдийн засгийн газрын сан хөмрөгийг хурааж авчээ. Лхас хотын зэвсгийн агуулах, зоос болон сум хэрэгслийн фабрикийг эзэлж авав. Далай ламтай хамт зугадсан сайд нарын гэр оронд үе үе хулгай ордог болов.

1910 оны хоёрдугаар сарын 25-нд чин улсын эзэн хааны нэрийн өмнөөс гаргасан зарлигаар Лхасаас зугтан гарч, эзэн хаанд талархалгүй хандаж, түүнд захирагдаагүй, түвдчүүдийг эсэргүүцлийн хөдөлгөөнд өдөөн тухирсаны төлөө Далай ламын цолыг хоёрдахь удаагаа “хасах”-аар болсон байна.[302] Чин улсын цэргийг энх амгалан байдал тогтоож, худалдаанд нээлттэй газруудыг хамгаалах

зорилгоор Түвд рүү илгээсэн гэж энэхүү зарлигт тэмдэглээд онцгой гайхамшигт шинж чанар бүхий хэд хэдэн жаал хөвгүүнийг аль болох түргэн хугацаанд эрэн сурвалжилж олоод Алтан савнаас (бумба) шодолт хийж, сонгож авсан хүүхдэд бурханы шашин дэлгэрүүлэх зөвшөөрөл олгох тухай хүсэлт бүхий илтгэл оруулахыг амбанд тушаал болгосон байна. Энэ зарлиг Цысигийн үед гаргаж байсан бусад баримт бичгүүдийн нэгэн адил Далай лам болон манж гүрний хооронд байгуулсан “багш – ивээн тэтгэгчийн” харилцааг зөрчсөн бөгөөд шашны уламжлалыг гутаан доромжилсон баримт бичиг болсон нь тод харагдаж байна. Гэвч түүнийг эзэн хааны санаа бодол хэмээн үзэж болохгүй, яагаад гэвэл жаахан хүү эзэн хаан Пуи ямар ч шийдвэр гаргаж чадахгүй байсан хэрэг билээ.

Зарлиг нийтлэгдсэний дараахан Бээжинд сууж байсан оросын элчин зөвлөх чин улсын засгийн газарт саналаа илэрхийлсэн захидал явуулж, бурханы шашин, Далай лам, Оросын буддистуудын шашны тэргүүний талаар яаруу алхам хийхээс түдгэлзэхийг уриалсан байна.[303] Үүний хариуд чин улсын гадаад явдлын яам “тушаал бууруулж”,”цол хэргэм хасах” явдал

зөвхөн Далай ламд холбоотой, бурханы шашин болон оросын бурханы шашинтнуудад хамаагүй юм гэж мэдээлсэн байна.

IX Банчин лам Лхаст ирэв. Тэрээр Далай ламын зарим үүргийг биелүүлэх болсон ч Түвдийн төр баригч болно уу хэмээсэн хууль бус саналаас татгалзав. Лхасын бүх эрх мэдлийг чин улсын генералууд булааж авчээ.Энэ нөхцөлд бээжингийн засгийн газар Балба, Бутаныг эзэнт улсынхаа хараат газрууд хэмээн зарлаж, харин Түвдэд сюзеренитетийн үе дууссан хэмээх шалтгаар өөрийнхөө бүрэн эрхийг тулгасан байна.[304] Далай лам болон түүний сайд нар энэхүү өнгөлзлөгийг няцаав. Их Британи, Балба, Сикким манж чин улсын засгийн газарт эсэргүүцлийн бичиг явуулав.

Түвдчүүд чин улсын жанжин сайдад захирагдахаа болив. Тэд Лхас руу биш, харин Далай ламын байсан Даржилинг хийд рүү татвараа явуулах болсон байна. Тэр үед чин улсын харуулууд хилийн дагуу байрлаж, энэтхэг рүү явж буй бүх хүнийг нэгжих болсон байна. Түвдийн зүүн болон өмнөд нутагт эсэргүүцлийн хөдөлгөөн өсөв. Ингээд чин улсын эрх баригчид хэлэлцээ эхлүүлэхэд хүрсэн байна. Тэд Далай ламд нутаг орондоо эргэж ирж, шашныхаа удирдлагыг хүлээж авахыг санал болгосон ч татгалзсан хариу авсан байна.[305] Далай лам манжийн засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ло Дитайд захидал бичиж, энэтхэг явах болсон шалтгаанаа тайлбарлан бичихдээ: “Эзэн хаан Түвд бол бие даасан улс болохыг анхааралдаа авалгүйгээр, манай орнуудын хоорондын шашны харилцааг харгалзан үзэлгүйгээр Лхаст суугаа манж амбаны үгээр бүхнийг хийсэн

болохоор миний бие хятадтай цаашид шууд хэлэлцээ хийх нь утгагүй зүйл болсныг ойлгов. Би хятадад итгэх итгэлээ алдаж, энэ оронтой зөвлөлдөх замаар ямар ч шийдвэр гаргаж чадахгүйг ойлгосон <...> Үүнээс хойш Түвд,Хятад улсууд урьдын адил харилцаж чадахгүй болжээ” гэж тайлбарласан байна.[306]

1910 онд XIII Далай лам 1904 оны Лхасын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг хариуцлагыг нь Их Британид сануулахын тулд Даржилингээс Галигдаа руу явав.[307] Британийн эрх баригчдын зүгээс саад тотгор учруулж байсан ч Оростой хэлхээ холбоо тогтоохыг оролдсон хэвээр байсан бөгөөд тус улсаас дэмжлэг авна хэмээн найджээ. Тэрээр 1910 онд оросын дорно дахиныг судлагч Ф.И. Щербатской, 1912 онд Галигдаад сууж байсан оросын ерөнхий консул Б.К. Арсеньев нартай тус тус уулзсан байна. Арсеньев ерөнхийлдсөн байдлаар бичсэн хоёрдугаар Николай хааны захидлыг Далай ламд уламжилжээ.[308] Хаан тухайлбал Орос, Их Британийн хооронд түвдийн асуудлаар тохиролцсон тухай бичсэн байна. Түүнээс гадна, тус хоёр орон

бээжингийн эрх баригчид Далай ламын "тушаалыг бууруулсан" явдлыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь захидлаас тодорхой харагдаж байна.

Гэвч "цагаан хаан" түвдчүүдэд талархан ханддагаа илэрхийлээд ч, Доржиев Петербургт хөөцөлдөж гүйгээд ч урьдын адил хангалттай үр дүнд хүрсэнгүй. 1906–1910 онд англид талтай хандагч А.П. Извольский оросын гадаад явдлын яамны сайдаар ажиллажээ. Дараа нь түүний оронд мөн л английг талархагч С.Д. Сазонов иржээ. Бодит холбоотон болох Германтай санал зөрөлдөөн улам их болсон нь Орос улсыг бодит өрсөлдөгч болох Их Британтай холбоо сүлбээнд татан оруулж байв. Газар зүйн бодлогын үүднээс авч үзвэл энэ холбоо Орос, Германд биш, харин Британид ашигтай байв. Эх газрын хоёр гүрний мөргөлдөөн тэдгээрийн байр суурийг сулруулж, Их Британи, АНУ зэрэг арлын гүрнүүдийг хүчтэй болгов. Орост өөрт нь улс орныг дотроос нь бусниулсан хувьсгалт хөдөлгөөн хүчтэй болж байлаа. Тийнхүү Далай лам Оросоос дэмжлэг авч ч, европ руу хэлэлцээ хийхээр явж ч чадсангүй үлдэв.

❁

Манжийн эзэнт гүрний засаглалын үед Түвдийн дээд тушаалын лам нар улс орноо нэг ёсоор интеграцчилжээ. "Багш – ивээн тэтгэгчийн" зарчмаар манжийн эзэн хаадтай тогтоосон тэдний харилцаа Түвдийг чин улсын муж болгон хувиргахад саад болсон байна. Их Британи улс XIX зууны хоёрдугаар хагас, XX зууны эхэнд манж чин улс суларч эхэлснийг ашиглан түвдийг цэрэг зэвсгийн замаар "нээж", Бээжингийнхний булаан эзлэх хорхойг хүргэжээ. Түвдэд 1903–1904 онд үйлдсэн английн түрэмгийллийн үед бээжингийнхэн "хөндлөнгөөс оролцоогүй нь" чин гүрэн сул байсантай холбоотой юм. Их Британи улс түвдийн статусыг европын нэр томьёонд буруу тайлбарласан гэрээ хэлэлцээрийг Түвдийн ар хударгаар гуравдагч орнуудтай байгуулснаараа энэ орны бүрэн эрхт байдал руу чиглэсэн хятадын дараа дараачийн өнгөлзлөгийн үндэс суурийг тавьж өгчээ. "Бид Түвдэд орж, дараа нь тэндээс дахин гарч байснаараа түвдчүүдийг дайран унагаж, гаднаас ирсэн эхний этгээд л өшиглөөд байх тийм байдалд үлдээсэн билээ" гэж Ч. Белл шудрагаар тэмдэглэн хэлсэн байна.[309] Ингээд манж нар эхэлж иржээ. Гэвч Түвдийн хууль ёсны эрх баригчид тэдний сюзеренитетийг хүлээн зөвшөөрөөгүй юм. Оросын дэмжлэгийг авна гэсэн тэдний найдлага талаар болов. Гадаад явдлынх нь яаманд С.Д. Сазонов ирснээс хойш Орос улс Их Британтай байгуулсан хуучин гэрээ хэлэлцээрээс ухарсан нь Түвдэд үйл ажиллагаа явуулах эрх чөлөөг британчуудын гарт шилжүүлэх

сонирхолтой холбоотой байв.[310] Оросын гадаад явдлын яамны газар зүйн бодлогын алдаанаас болж Оросын эзэнт гүрэн болон Түвдийн хэлхээ холбоо дан ганц шашны асуудлаар хязгаарлагдаж байв.

Чин улс нурж унахаас өмнөхөн тус улсын засгийн газрын бодлого өөрчлөгдөв. Мөхөж буй эзэнт гүрэн европчуудын түрэмгийллийг сөрөн зогсох гэхдээ хуучин хараат орнуудыг Хятадын “хил хавийн” мужууд болгохоор шийджээ. Хараат ард түмнүүдийг (түвд, монголчууд зэрэг) ердийн харьятууд, тэдгээрийн газар нутгийг хятадын колони болгон хувиргаж эхэлсэн байна. Энэ нь манжийн хаант засаг дампуурч, хувьсгал гарч, эзэнт гүрэн задрах үйл явцыг хурдасгав. Түвдэд чин улсын цэрэг харгис хэрцгий авирлаж, тус улсын нутаг дэвсгэрийн зарим хэсгийг хавсарган нэгтгэж, Далай ламыг “огцруулж” бас “томилох” гэсэн оролдлого үйлдэж байсан нь “багш – ивээн тэтгэгчийн” харилцааг зогсооход хүргэв. Үүнийг жинхэнэ эзэн хаад биш (тэр үед эрх мэдэлгүй байсан) бэлэвсэрсэн хатан Цыси зэрэг хүмүүс хийжээ. Энэ явдал Чин гүрэн болон Түвдийн урьдын харилцаа бүрэн тасрахад хүргэжээ.

Бүлэг 4

# Тусгаар тогтнолын сүүлчийн жилүүд

1911 онд Манж чин гүрэн унаж, Бүгд Найрамдах Хятад улсыг зарлан тунхаглахад хүргэсэн Синьхайн хувьсгал эхлэв. Түвдэд байсан хятад цэргүүд хуваагдав. Тэдний нэг хэсэг нь хаант засгийг, нөгөө нь бүгд найрамдах улсыг дэмжих болов.[311] Лхаст байсан хятад цэргүүд "Гэ лао хуэй" хэмээх нууц нийгэмлэгийн гишүүд байв.[312] Тэд хувьсгалын тухай олж мэдмэгцээ эмх замбараагаа алдаж, дээрмийн бүлгийнхэн болж хувирав. Хожим нь монголд мөн ийм үйл явдал болсон билээ. Тэд 1911 оны арван нэгдүгээр сард манж амбан Лянь Юйг барьцаалан авч, өөр нэг манж хүн болох генерал жун Инийг шинэ амбанаар сонгов. жун Ин цэргүүдэд 250 мянган рупийн цалин тарааж тэднээр төвийг сахисан байр суурь баримтлуулж чадсан байна. Тэр онд жао Эрфэн Сычуань мужийн амбан захирагчаар дэвшиж, Ньяронгийг булаан эзэлжээ. Дараа жил нь тэрээр хувьсгалчдын нэгний гарт амь үрэгдсэн байна. 1912 онд Камын түвдчүүд болон Чамдогийн лам нар хотоо хятад гарнизоноос чөлөөлөх гэсэн боловч ялагдал хүлээв. Мөн онд хятадууд 1436–1444 онд байгуулагдсан Чамдо мужийн Калден жамбалин хийдийг эвдлэн сүйтгэжээ. Ингээд түвдчүүд 1917 онд Чамдог эргүүлж авахдаа уг хийдийг шинээр барьжээ.

Түвдийн бусад гарнизоноос эмх замбараагаа алдсан хятад цэргүүд Лхас руу цугларч, хувьсгалчид тэдэнд эх орондоо эргэж очихыг санал болгосон байна. Партизаны хөдөлгөөн өргөжив. Гьянзе, Шигазед байсан хуучин чин улсын гарнизонууд Энэтхэг рүү явсан байна. Түвдийн эрх баригч бүлгийнхэн хятад цэргүүдэд хандах хандлагаараа хуваагдаж эхлэв.[313] Гандан болон Сэр хийдийн лам нар хятадын эсрэг тэмцэлд

идэвхтэй оролцсон бол Дрепун хийдийн лам нар, түвдийн засгийн газрын гишүүдийн зарим хэсэг хятадын эрх баригчдаас хэлхээ холбоогоо таслахыг хүссэнгүй. Сэр хийдийн лам нар тэргүүн сайд, түүний хөвгүүд, түшмэл нарыг хороосон байна. Тэр үед сычуаны цэргүүд тус хийдийг бүслэсэн байжээ. Лам нар бүслэлтийг сэтэлж, Лхас хотын зүг хөдлөв. Тэднийг зэвсэглэсэн ард түмэн дэмжсэн байна. 1912 оны хоёрдугаар сарын 8-наас зургадугаар сарын 19-ныг дуустал Лхас хотод гудамжны тулалдаан болжээ. Дараа нь балбын төлөөлөгчийн зуучлалаар хэлэлцээр байгуулж, түүний дагуу хятадууд зэвсэг болон цэргийн хэрэгслүүдээ түвдчүүдэд өгч, хариуд нь Энэтхэгээр дамжиж Хятад руу явах уналга болон хоол хүнс авах ёстой болсон байна. Хятадын төлөөний түшмэл болон түүний хамгаалалтын 20 хүн Лхаст үлдсэн байна.

1912 оны наймдугаар сарын 4-нд дараах гол үндсэн заалт бүхий хэлэлцээрт гарын үсэг зурав:[314] 1. Амбан цөөн тооны бараа бологчдын хамт Лхаст үлдэнэ. 2. Тэрээр бие хамгаалагч 200 хятад цэрэг авч үлдэнэ. 3. Үлдсэн хятад цэргүүд зэвсэг болон цэргийн хэрэгслүүдээ хураалгаж, хятад руу буцна. 4. Зэвсэг болон цэргийн хэрэгсэлийг лацдан Лхаст үлдээнэ. 5. Хятадын талд байсан түвдчүүдэд өршөөл амалж байна. Генерал Жун тэргүүтэй 500 орчим хятад цэрэг зэвсгээ хураалган Энэтхэгээр дамжиж хятад руу буцна.

Энэ зуурт Хятадын ерөнхийлөгч жун Инийг “Түвд дэхь албаны ахлах офицерээр” томилжээ.[315] Дараа нь Бээжингээс ирүүлсэн нууц зааврын улмаас цэрэг гаргах ажил саатсан байна. Ингээд арван хоёрдугаар сарын 4-нд л балбачуудын зуучлалаар бас нэг хэлэлцээр байгуулж, хятад цэрэг гаргах тодорхой өдрийг арван хоёрдугаар сарын 16 гэж тогтоов. Хятадууд Түвдэд байх ёсгүй болсон бөгөөд зэвсэг болон цэргийн хэрэгслийг балбачуудын хяналт дор Лхаст үлдээжээ. 1913 оны нэгдүгээр сарын 6-нд гурхүүдээр (балбачууд) хамгаалуулсан жун Ин тэргүүтэй хятад цэргүүд Лхас хотоос гарч явсан байна. 1913 онд хятадын засгийн газар амбаны газрыг татан буулгав. 1914 онд жун Иныг Түвдэд бүтэлгүй үйл ажиллагаа явуулсан хэмээн үзэж Бээжинд цаазалжээ.

1912 оны түвдийн хэрэг явдлууд энэ улс руу чиглэсэн өнгөлзлөгөө хуульчлах гэсэн хятадын оролдлогын дэвсгэр дээр болж өнгөрсөн юм. 1912 оны дөрөвдүгээр сарын 8-нд хятадын түр ерөнхийлөгч Юань Шихай хараат нутаг дэвсгэр хэмээх Монгол, Түвд, Дорнод Туркестаны статусыг өөрчилж, тэдгээрийг хятадын ердийн муж болгох тухай хууль гаргав.[316]

“Таван ястан нэгдмэл бүгд найрамдах улсыг бүрэлдүүлж буй өнөө

үед Монгол, Түвд, Туркестан нийтлэг үндэслэлээр Бүгд найрамдах Хятад Улсын нутаг дэвсгэрийг бүрдүүлж, тэдгээрт оршин сууж буй ястнууд: монголчууд, түвдчүүд болон ислам сүсэгтнүүд Бүгд Найрамдах Хятад Улсын иргэд хэмээн тооцогдох ёстой бөгөөд үүний учир цаашид тэдний тухайд хаант байгууллын үед хэрэглэж байсан колонийн, хараат эзэмшил зэрэг нэр томьёо хэрэглэх ёсгүй. Үүнээс хойш Монгол, Түвд, Туркестаныг удирдах тухайд төр улсын дотоодын удирдлага болон тэнд оршин сууж буй бүх ястанг нэгтгэхэд тус дөхөм болох тийм журам боловсруулах ёстой юм. Бүгд найрамдах улсын засгийн газар колониудын удирдлагатай холбогдсон хэргүүдийг хариуцах тусгай яам байгуулах гээгүй нь Монгол, Түвд, Туркестаныг хятадын өөрийнх нь мужуудтай адилтган авч үзэж буй хэрэг мөн бөгөөд иймийн учир хойшид нэр дурдсан бүх газар нутгийн удирдлага дотоодын удирдлагын хэмжээнд тавигдах болно <...> Дотоодын удирдлагатай холбоотой нийтлэг дүрмийг одоохондоо боловсруулаагүй байна, Монгол, Түвд, Туркестантай холбоотой хэргийг өмнөх хууль зааврын үндсэн дээр шийдвэрлэх ёстой болно” гэж дээрх хуулинд дурдсан байна.

Тийнхүү Юань Шихай чин улсын эрх баригчдын хуучин гэрээ хэлэлцээрүүдийг зөрчсөний улмаас монгол, түвдчүүдийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн эхэлсэн байна. Түүнээс гадна ерөнхийлөгчийн дээрх шийдвэр хууль бус байв. Хятад бол чин гүрний нэг хэсэг л юм. Энэ хэсэг нь бусад хэсгээсээ дээр гарахыг эрмэлзэж, бүгд найрамдах улсын эрх баригчид хааны феодалын эрхийг “залгамжлан авах” гэж зүтгэсэн хэрэг болж байна. Юань Шихай Сычуань, Юньнаны цэрэгт Лхасын хятад гарнизонд туслахаар явах тушаал өгснөөрөө дээрх баримт бичгээ бататгажээ. Их Британи улс Түвдийг захирах бүрэн эрх биш, харин хятадын сюзеренитет эрхийг хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэв.[317] Тус улс цэргийн энэ аян зогсох хүртэл Бүгд найрамдах хятад улсыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан байна. Энэ нөхцөлд Юань Шихай цэргийн хөдөлгөөнийг зогсоох тушаал өгсөн байна. Түүний зэрэгцээ ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Далай ламд цахилгаан утас цохиж, хятадын цэргүүдийн дэглэм журамгүй үйлдлийн төлөө хүлцэл өчиж, Далай ламын бүх цол, хэргэм, албан тушаалыг “сэргээсэн” тухай мэдээлсэн байна.[318]

Би Түвдэд эрх мэдлээ хэрэгжүүлэх бодолтой байгаа учир танаас ийм шийдвэр гаргахыг хүсээгүй билээ хэмээн Далай лам хариулсан байна. Шар феодалын өөр нэг хаан – Богд гэгээн VIII Жавзандамба хутагт мөн иймэрхүү хариулт өгсөн байна. Түүнийг 1911 оны арван хоёрдугаар сарын 29-нд Монголын Богд хааны ширээнд залах ёслол энэ орны тусгаар тогтнолыг

зарлан тунхаглах үйл явдал болсон байна. Энэ нөхцөлд Юань Шихай хятадтай харилцаа холбоогоо сэргээхийг Богд хаанд уриалав. Үүнд хутагт монголчууд манж чин улсад үнэнч байхаа тангарагласан билээ, хувьсгал гарснаар энэ холбоо тасарч, Монгол, Хятад гэсэн хоёр улс бий болсон, энэ хоёр улс бие биендээ өнгөлзөж болохгүй юм. “Та хятадын ард түмний толгойд, би монголын ард түмний толгойд гарсан нь асуудлын хамгийн зөв шийдэл болсон бөгөөд энэ нь харилцан дайсагнал үүсгэх үндэс болохгүй мэт санагдаж байна”[319] гэсэн тун ч тохирсон хариу өгсөн байна. Тийнхүү Монгол, Түвдийн байдал адил төстэй байдлаар өрнөж иржээ.

1913 оны нэгдүгээр сарын 11-нд Гадаад Монголын нийслэл Өргөө хотод гарын үсэг зурсан монгол-түвдийн гэрээнд “Манжийн эзэнт гүрнээс чөлөөлөгдсөн Монггол, Түвд хоёр улс хятадаас тусгаарлаж бие даасан улсаа байгууллаа, энэ хоёр улс эрт дээр цагаас нэг шашин шүтэж ирснийг иш үндэс болгон хоёр талын түүхэн Найрамдлаа бэхжүүлэхийн тулд <...> энэхүү гэрээг байгуулав” хэмээн өгүүлжээ.[320]

Гэрээнд хоёр улс, хоёр удирдагч – Далай лам, Жавзандамба хутагт бие биенээ хүлээн зөвшөөрөв. Хоёр улс бурханы шашны сайн сайхан байдлын төлөө анхаарал тавьж, аялал жуулчлалын хүмүүст туслаж, харилцан ашигтай худалдаа хийж, үйлдвэрийн газрууд нээж, бие биендээ зээл тусламж үзүүлж, бүрэн эрхт төлөөлөгчид солилцож байх үүрэг хүлээсэн байна. Гэрээ байгуулахын өмнө Далай ламын төлөөлөгч А. Доржиев Монгол улсын гадаад явдлын яамны сайдын үүрэг гүйцэтгэгч Равдантай хэлэлцээ хийжээ. Доржиев гэрээнд гарын үсэг зурсны дараа Өргөөгөөс Петербург рүү явсан байна.[321] Тэнд очсоныхоо дараа засгийн газартаа Далай ламын хоёр захидал, “Түвдийн байдлын тухай санамж бичиг” дамжуулан өгчээ. Далай лам эх орных нь тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхийг Орос, Их Британи улсуудаас хүсч, дипломат төлөөлөгчдөө Лхас руу явуулахыг санал болгожээ. Энэ хүсэлтийг биелүүлсэнгүй. Европт дайн нүүрлэсэн нөхцөлд хоёр эзэнт гүрэн өөр хоорондоо ч, хятадтай ч сөргөлдөхийг хүсээгүй юм. Тийнхүү Түвд орон их гүрнүүдийн “том тоглоомд” “задгай мөнгө” болон үлджээ.

XIII Далай лам 1913 оны нэгдүгээр сарын 23-нд Лхаст буцаж ирэв. Тэр цагаас насан эцэслэх хүртлээ тэрээр Түвдийн бүх эрх мэдлийг хэрэгжүүлжээ. Түүний гаргасан тунхаглалд:[322]

“Буддын итгэл үнэмшлийг дээдийн дээдээр сүсэглэн хамгаалагч Далай лам би бээр яруу алдарт Энэтхэгээс гаралтай Ариун Буддагийн шийтгэн олгосон цолыг авч яваагийн хувьд та бүхэнд дараахь зүйлийг мэдэгдэж

байна.

Би түвдийн ард түмний бүх давхаргынханд хандаж байна. Бодьсад Жанрайсэгийн хойд дүр болох эртний хаадаас орчин үеийн удирдагчид хүртэлхТүвдийн удирдагчид улс орноо ивээлдээ авч явна хэмээн яруу алдарт Энэтхэгээс гаралтай Ариун Будда лүндэн буулгасан билээ. Чингис хаан, Алтан хааны үед, Хятадад Мин улс, Манж чин улс эрх барьж байх үед Түвд, Хятад хоёр улс "ивээн тэтгэгч – ламын" харилцааны үндсэн дээр хамтран ажиллаж ирсэн билээ. Хэдэн жилийн өмнө Сычуань, Юньнаний хятад эрх баригчид манай нутаг дэвсгэрийг колончлох гэсэн оролдлого үйлдэв. Тэд худалдааны төвүүдийг хамгаалах нэрийдлээр Төв Түвдэд их цэрэг оруулсан юм. Тиймээс миний бие Түвд, хятадын харилцаа бол "ивээн тэтгэгч – ламын" зарчимд тулгуурласан харилцаа мөн бөгөөд нэг тал нь нөгөөдөө захирагдах зарчимд хэзээ ч үндэслэж байгаагүйг цахилгаан холбооны тусламжтайгаар манжийн эзэн хаанд тайлбарлана хэмээн найдаж Лхас хотоос гарч энэтхэг – түвдийн хил рүү сайд нарынхаа хамт явсан билээ. Надад улс орноосоо гарч явахаас өөр сонголт байгаагүй, яагаад гэвэл хятад цэргүүд амьд, үхсэн аль нэг байдлаар барьж авахын тулд намайг мөрдөн мөшгөж байсан юм.

Би Энэтхэгт ирмэгцээ эзэн хаанд хэд хэдэн удаа цахилгаан утас цохсон боловч Бээжингийн авилгалд автсан түшмэлүүд миний шаардлагад өгөх хариуг саатуулсан юм. Хэсэг хугацааны дараа Манжийн эзэнт гүрэн оршин тогтнохоо болив. Түвдчүүд хятадуудыг Төв Түвдээс хөөж гаргах оролдлогууд үйлдсэн билээ. Би ч ариун дагшин эх орондоо эсэн мэнд эргэж ирлээ, одоо хятадын цэргийн үлдэгдлийг зүүн Түвдийн До Камаас үлдэн хөөх болно. Өнөөдөр "ивээн тэтгэгч – лам"-ын харилцаагаар халхавчлан Түвдийг колонио болгох гэсэн хятадуудын санаархал тэнгэрийн солонго арилах лугаа үеэ өнгөрөөжээ. Бид бүхний хувьд аз жаргалтай, энх тунх амьдралын босгон дээр дахин ирсэн би бээр дараах үүрэг хариуцлагуудыг чанд хатуу хэрэгжүүлэх нь чухал байгааг та бүгдэд хариуцуулж байна:

(1) Буддын итгэл үнэмшлийг хадгалснаар л энэ ертөнцөд аз жаргал, амар амгаланг ханган тогтоож болно. Тийм бөгөөс Лхасын жокан, Рамоче, Өмнөд Түвдийн Самье, Тадук сүм, гурван аугаа их хийд зэрэг буддын бүх сүм, хийдийг Түвдэд хадгалан авч үлдэх нь маш чухал байна.

(2) Түвдийн буддын янз бүрийн сургууль (чиглэл) өвөрмөц шинж чанар болон уламжлалынхаа цэвэр байдлыг сахин хадгалж үлдэх ёстой. Буддын сургаалийг зохих хэлбэрээр эзэмшиж, судлаж, хэрэглэх ёстой. Тусгай хүмүүсийг эс оролцуулан сүм хийдийн засаг захиргаад худалдаа,

мөнгө хүүлэх үйл ажиллагаа явуулах, гэрийн мал адгуулах буюу бусдын харьятуудыг захирахыг хориглоно.

(3) Түвдийн засгийн газрын энгийн болон цэргийн түшмэд татвар хураах буюу өөрсдийн захиргаанд буй иргэдтэй бусад ажил хэрэг биелүүлэхдээ иргэдэд хор хохирол учруулах биш, харин засгийн газарт ашиг тус хүргэхийн тулд үүрэг хариуцлагаа шудрага, үнэнч биелүүлэх ёстой. Баруун Түвдийн Нгари Корсум, Зүүн Түвдийн До Камд байгаа төв засгийн газрын зарим түшмэл харьяат иргэдээрээ өндөр үнээр бараа таваар худалдан авахуулж, засгийн газраас тогтоосон хэм хэмжээнээс дээгүүр тээврийн татвар тогтоосон байна. Хараат иргэдийнхээ гэр орон, эд хөрөнгө, эзэмшил газрыг хууль зөрчсөн нэрийдлээр хурааж авсан байна. Түүгээр ч барахгүй иргэдийг шийтгэх хэлбэр болгон тэдний гар хөлийг тайрах арга хэрэглэжээ. Хойшид шийтгэлийн иймэрхүү харгис хатуу хэлбэрийг хориглож байна.

(4) Түвд бол байгалийн нөөцөөр баян орон боловч тэнд шинжлэх ухаан бусад орных шиг хүчтэй хөгжиж чадаагүй байна. Бид бол жижиг, сүсэг бишрэлтэй, бие даасан үндэстэн мөн. Бид бусад улс оронтой эн тэнцүү оршин тогтнохын тулд эх орноо хамгаалах ёстой. Бидэнд тохиолдсон гадаадын халдлагуудын улмаас манай хүмүүс тодорхой бэрхшээлүүдтэй тулгарах бизээ, гэхдээ бид түүнээс айх ёсгүй юм. Эх орныхоо тусгаар тогтнолыг сахин хамгаалахын тулд бүгд нэг хүн мэт ухамсартай бөгөөд нөр их хөдөлмөрлөх ёстой. Хилийн хавьд оршин амьдарч буй манай иргэд сонор сэрэмжтэй байж, аливаа сэжигтэй үйл явдлуудын тухай засгийн газарт уламжилж байх ёстой. Манай иргэд үл ялиг шалтагаар хоёр үндэстний хооронд мөргөлдөөн тухирах ёсгүй.

(5) Түвд бол хүн ам сийрэг суудаг, том нутаг дэвсгэртэй орон билээ. Орон нутгийн зарим түшмэл, газар эзэмшигчид өөрсдөө хийж дийлэхгүй хэрнээ эзэнгүй газар эзэмшихийг хүссэн хүмүүст харам сэтгэлийн үүднээс саад учруулж байна. Тийм байр суурь баримталж буй хүмүүс бол төр улсын, манай дэвшил хөгжлийн дайснууд мөн. Одооноос эхлэн, хойшид хэн ч эзэнгүй байгаа аливаа газар эзэмшихэд хэнд ч саад учруулах ёсгүй. Тийм нөхцөлд гурван жилийн турш газрын татвар авах ёсгүй. Үүний дараа газар боловсруулагч (тариачин) жил бүр засгийн газар болон газар эзэмшигчид газрын ренттэй хувь тэнцүү татвар төлнө. Газар нь газар боловсруулагчийн мэдэлд байна.

Та энд миний хэлсэн бүхнийг хэрэгжүүлбэл засгийн газар, ард түмний өмнө таны хүлээсэн үүрэг хариуцлага биелэх болно. Энэ тунхаглалыг Түвдийн район бүрт илгээж, зарлан мэдээлэх бөгөөд тойрог бүрийн засгийн

газрын байгууллагуудад энэхүү баримт бичгийн нэг хувь байх ёстой" хэмээн өгүүлсэн байна.

Тийнхүү Түвд тусгаар тогтнолоо албан ёсоор нотолсон байна. Тэр үеэс 1951 он хүртэл түвдийн засгийн газар эх орныхоо дотоод, гадаад хэрэгт бүрэн хяналт тавьж иржээ.[323] Гэтэл 1913 оны тавдугаар сарын 15-нд Түвдээс хятадын анхны парламентад сонгогдсон гишүүдийн нэрсийн жагсаалт нийтэлжээ.[324] Мэдээжийн хэрэг Түвдийн нийт ард түмнийг төлөөлж чадахгүй бөгөөд хятадын дотоодын районуудаас гаралтай түвдчүүд парламентын гишүүн болжээ. Мөн онд Далай лам сайд жамба Тэндарыг Камын захирагчаар томилж, найман генералын хамт тийш нь явуулсан байна.

Британийн засгийн газар түвдийн асуудлыг хэлэлцээ хийх замаар, гэхдээ түвдчүүдийг оролцуулан шийдвэрлэхийг Юань Шихайд санал болгосоор байв.[325] Энэ зорилгоор Юань Шихай 1913 оны гуравдугаар сард Чамдо руу хоёр төлөөлөгч томилон явуулсан байна. Хэлэлцээ хийж эхэлсэн боловч тасарч, дараа нь 1913 оны аравдугаар сарын 3-нд Энэтхэгийн Симла хотод түвд, хятад, британийн төлөөлөгчдийн оролцоотойгоор сэргэв. Бага хурлын нээлт дээр түвдийн төлөөлөгч улс орныхоо байр суурийг, тухайлбал, Чин гүрэнтэй тус улсын тогтоосон харилцааны суурь зарчим болох "багш – ивээн тэтгэгчийн" үзэл баримтлалыг тайлбарласан байна. Хятадууд Түвдийг өөрийнхөө орны салшгүй хэсэг мөн гэж батлах учир шалтгааны урт жагсаалт гаргаж тавьсан байна;[326] түвдийг Чингис хаан байлдан эзэлж байсан: V Далай ламын цолыг манжийн эзэн хаан өгсөн; гурхүүд (балбачууд) болон Зүүнгарынхнаас хамгаалахад хятадын арми тусалсан; эзэн хаан Сюаньегийн үед Лхаст амбан сайд болон цэрэг байлгахыг түвдчүүд хүссэн; Жао Эрфэн мөрдөн байцаалт явуулахаар Кам руу явсан: английн халдлагын дараа Бээжин түвдийн дайны төлбөрийг барагдуулсан: Их Британи болон Манж чин улсын тухайд Түвдийн статусыг 1908 оны байдлаар сэргээн тогтоох зэрэг санал гаргасан байна. Эдгээр үндэслэлүүдийн ихэнхэд албан ёсны нэг ч баримт бичиг гаргаж үзүүлээгүй ажээ.

Түвдийн төлөөлөгч хятадын талын үндэслэлүүдийг нэг нэгээр нь няцааж байв. Бага хурал санал зөрөлдөөнөөс болж нилээд сунжрав. Их Британий төлөөлөгч Г. Макмагон Түвдийг монголын нэгэн адил "Гадаад Түвд", Дотоод Түвд" хэмээх хоёр бүс болгон хуваахыг санал болгов. "Дотоод" хэсэг нь хятадын мэдэлд орж, харин "гадаад" нь бүрэн өөртөө засах эрх олж авчээ. Хэдийгээр Түвд Гадаад, Дотоод хэмээн хуваагдсан ч газар зүй, улс төрийн хувьд нэгдмэл улс хэмээн хүлээн зөвшөөрөгдөж

байв.[327] Хятад улс Гадаад Түвдэд нэр төдий сюзеренитет эрхтэй, харин Дотоод түвдэд их эрх дарх олж авсан нь хэлэлцээрт британчуудын оруулсан сюзеренитет хэмээх ойлголттой муу авцалдсаны баримт мөн.

Маргааныг шийдвэрлэхийн тулд түвдийн засгийн газрын тэргүүн сайд Л. Шэтра Түвд дэх хятадын сюзеренитетийг дурдсан хэлэлцээрт гарын үсэг зурах Г. Макмагоны саналыг зөвшөөрсөн байна.[328] Хэлэлцээрт түвд – энэтхэгийн хилийг тодруулжээ. Энэ хил түүхэнд “Макмагоны шугам” нэртэйгээр оржээ. 1914 оны гуравдугаар сарын 24, 25-нд түвд, британийн талуудын хооронд нот бичиг солилцож энэхүү тохиролцоог бататгав. 1914 оны дөрөвдүгээр сарын 27-нд түвд, хятад, британийн төлөөлөгчид британчуудын санал болгосон Конвенцийн төслийг үзэглэжээ (урьдчилан гарын үсэг зурах). Энэхүү конвенцийн 2-р зүйлд: “Их Британи, хятадын засгийн газрууд Түвд нь хятадын сюзеренитетэн дор байгааг хүлээн зөвшөөрч, Гадаад Түвдийн өөртөө засах эрхийг хүлээн зөвшөөрч тус орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэж, Лхаст төвтэй түвдийн засгийн газрын мэдэлд үлдэх ёстой Гадаад Түвдийн (Далай ламыг сонгох, албан тушаалд оруулах зэрэг) удирдлагад хөндлөнгөөс оролцохоос түдгэлзэх үүрэг хүлээж байна. Хятадын засгийн газар Түвдийг хятадын муж болгохгүй байх үүрэг хүлээж байна. Их Британий засгийн газар Түвд буюу түүний ямар нэгэн хэсгийг хавсарган нэгтгэхгүй байх үүрэг хүлээж байна” гэж өгүүлжээ.[329] Хятадын тал 300-гаас илүүгүй хүний бүрэлдэхүүн бүхий хамгаалалттай түшмэлээ Лхас руу томилон явуулж байх боломжтой болов.

Гьянзе дэх британийн худалдааны төлөөлөгч түвдийн засгийн газартай зөвлөлдөхөөр Лхас орж байх болов. Конвенцийн 9-р зүйлд Энэтхэгтэй залгаа Түвдийн хил, Гадаад, Дотоод Түвдийн хоорондын “зааг” (өөрөөр хэлбэл хятадын Сычуань, Юньнань мужтай залгаа түвдийн хил) газрын зурагт тэмдэглэгдсэнээр дайрч өнгөрнө гэж заасан байна.

Гэвч хятадын төлөөлөгч Бээжингээс ирсэн заавар гэгчээр шалтаглан Конвенцид гарын үсэг зурахаас татгалзав: хятадын удирдлага энэ хилийг маргаантай хэмээн үзжээ. Англичууд Түвдийн тусгаар тогтнолын төлөө нөхөн төлөөс болгож түвд – энэтхэгийн хилийн дагуух 90 мянган шоо дөрвөлжин километр “хятадын” нутаг дэвсгэрийг салгаж авах гэсэн юм гэж БНХАУ-д нотлож байгаа юм.[330] Хэрэв хятад улс Конвенцид гарын үсэг зурахгүй бол британийн төлөөлөгч гарынхаа үсгийг тавих бүрэн эрхгүй байв. Тийм учир Конвенц гарын үсэг зурагдалгүй үлдсэн байна.

Гэхдээ Макмагон, Шэтра нар 1914 оны долдугаар сарын 3-ны хоёр

этгээдийн тунхаглалд гарын үсэг зуржээ. Түүнд: "Их Британи, Түвдийн бүрэн эрхт төлөөлөгчид бид урьдчилан гарын үсэг зурсан Конвенцийг Их Британи, Түвдийн засгийн газрын хувьд заавал биелүүлэх баримт бичиг хэмээн хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэхийн тулд энэхүү Тунхаглалыг боловсруулаа: бид мөн Хятадын засгийн газар энэхүү конвенцид гарын үсэг зурах хүртэл тус засгийн газар Конвенциэс үүдэн гарах эрх дархыг эдэлж болохгүй хэмээх тохиролцоонд хүрлээ" гэж өгүүлсэн байна.[331] Түвдийн талаас Тунхаглалд тэргүүн сайдын гарын үсэг, тамгаас гадна Үндэсний Ассамблей, Далай лам, Дрепун, Сэр, Гандан зэрэг "аугаа их хийдүүдийн" тамгыг хавсаргасан байна.

Хятадын гарын үсэг байгаагүй учир Их Британи улс Монголын төлөө Орос улсын хийсэн тэр зүйл буюу бие даасан байдлыг нь хүлээн зөвшөөрч, тусгаар тогтнолоо бэхжүүлэх нөхцөл бүрдүүлсэн үйл ажиллагааг Түвдийн тухайд хийж чадаагүй юм. 1914 оны Симлагийн Конвенцид гурав биш (хятадыг оролцуулан) хоёр тал (Түвд, Их Британи) гарын үсэг зурсан болохоор тэр баримт бичиг хүчин төгөлдөр болж чадаагүй юм. Ингэснээрээ Бүгд Найрамдах Хятад улс зөвхөн "Макмагоны шугамыг" хүлээн зөвшөөрөөгүй өнгөрсөн хэрэг бишээ. Хятад улс дээр дурдсан Конвенцийг Түвдийг захирах сюзеренитет эрхийг нь нотолсон олон улсын эрх зүйн баримт бичиг хэмээн иш татан маргаж суух боломжоо алдсан юм. Түвд "Макмагоны шугамыг" хүлээн зөвшөөрсөн "ганцхан багцаар л" хятадын сюзеренитет эрхийг хүлээн зөвшөөрчээ. Эрх зүйн хувьд гарсан гаж явдал гэвэл Түвд Англитай байгуулсан тунхаглалаар өөрийг нь захирах хятадын сюзеренитет эрхийг хүлээн зөвшөөрсөн бол хятад өөрөө энэ баримт бичигт гарын үсэг зураагүйгээрээ Түвдийн хүлээн зөвшөөрөлтийг өөрөөсөө түлхжээ.

Оросын гадаад явдлын яамны сайд С.Д. Сазонов тухайн үедээ Симлагийн Конвенцийн зарим заалт 1907 оны Конвенцийн үндэслэлүүдтэй харшилж буйг олж харжээ. Тэрээр "Түвдийг Афганистанаар" гэсэн дипломатын хэлцэл байгуулахыг эрмэлзэхдээ л Их Британтай ээлжит арилжаа хийсэн ажээ.[332] Англичууд Түвдийг яах нь надад огт хамаагүй хэрэг, гэхдээ хэрэв үүний төлөө ямар нэгэн нөхөн төлөөс байхгүй бол Оросын олон нийт намайг зэмлэх болно гэж тэрээр хэлэлцээн дэр хэлж байжээ. Наймаа удаан бас үр дүнгүй үргэлжлэв. Дараа нь дэлхийн нэгдүгээр дайн эхэлж, Орос улс Түвдтэй манатай болсон байна.

Ойрмогхон өөрийгөө хятадын эзэн хаан хэмээн зарласан Юань Шикай 1916 оны зургадугаар сарын 6-нд нас барав. Хятад, Манж улс

милитаристуудын өөр хоорондын тэмцэлд олон жил автжээ. Төв засгийн газар хятадын зах хязгаар нутгууд болон мэдэлдээ авах гэж шунаж байсан нутаг дэвсгэрүүдэд хангалттай анхаарал тавьж чадахаа болив. 1917 онд сычуаны генерал Бэн Зошэн түвдийн отрядуудыг Зүүн түвдээс шахан гаргах гэж оролдов.[333] Тэр үед идэвхи зүтгэлтэй Дасанг Додул Царонг (1886–1959) түвдийн армийн ерөнхий командлагч байсан бөгөөд тэр хүн армийг бэхжүүлэх зорилготой шинэтгэл хийжээ. Түвдийн армийг Жао Эрфэний түрэмгийллийн үеийг бодоход илүү сайн зэвсэглэж, бэлтгэжээ. Түвдчүүд англи зэвсэгтэй болж, английн сургагч нар түвдийн армийг сурган бэлтгэсэн байна. Зэвсгийн наймааг ил шууд, өргөн хүрээтэй эрхэлж байсан хятадын цэргийнхнээс ч багагүй зэвсэг, цэргийн хэрэгсэл худалдаж авчээ.[334]

Түвдийн цэрэг 1917 оны есдүгээр сард сөрөг давшилтад орж, Чамдог бүсэлж, 1918 оны дөрөвдүгээр сарын 16-нд түүнийг эзэлж авсан байна. Түвдийн арми амжилттай тулалдаж 1918 оны зун гэхэд Дарцедо, Юньнань мужийн хил хүртэлх бүх Камыг эзлэв. 1918 оны наймдугаар сарын 19-нд жамба Тэндар, сычуаны генерал Лю заньтин нар Дарцедод суугаа британийн консул Э. Тейхманаар зуучлуулан Чамдод энх найрамдлын хэлэлцээрт гарын үсэг зурав. Энэ хэлэлцээрийн дагуу Хөх мөрний дээд биеэр түр зааглах шугам татсан байна. Дергэ, Пхаюл болон Лю заньтиний хяналтад байсан түвдийн нутгуудын бүх хийд түвдийн засгийн газрын мэдэлд шилжив. Хятадууд түвдийн бурханы шашны амьдралд хөндлөнгөөс оролцохгүй байх, түвдчүүд хятад түшмэдийн орон нутгийн эрх мэдэлд хутгалдахгүй байх үүрэг хүлээв. 1918 оны аравдугаар сарын 10-нд байлдааны ажиллагааг зогсоож, аравдугаар сарын 31 гэхэд хоёр талын цэргийг гэдрэг татах тухай нэмэлт хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хятадын төв засгийн газрын даалгавараар Ганьсу мужийн захирагчийн илгээсэн хятадын төлөөлөгчид 1919 оны наймдугаар сард Лхаст ирэв. Хэлэлцээ хийх төлөөлөгчдийг Бээжин рүү явуулахыг түвдчүүдэд санал болгожээ. Гэвч түвдчүүд Лхас буюу Чамдод Түвд, Хятад, Их Британийг оролцуулсан хэлэлцээ хийх санал тавьсан байна. Хятадын төлөөлөгчид ийнхүү үр дүнд хүрэлгүй 1920 оны дөрөвдүгээр сард Лхасаас гарч явжээ.

Хэлэлцээ идэвхжсэн нь монголын хэрэг явдалтай холбоотой байсан гэх үндэслэл нилээд магадлалтай юм. 1919 оны зун генерал Сюй Шужэний командалсан хятад цэрэг 1915 оны монгол-орос-хятадын Хиагтын хэлэлцээрийг зөрчиж Гадаад Монголд цөмрөн оров. Мөн оны арван нэгдүгээр сард хятадууд Монголын автономит эрхийг хүчингүй болгов. Тэд үүнийгээ гадаад талын аюул (нармай монголчууд болон цагаан гвардийнхны зүгээс

ирэх) болон эзлэгдсэн Өргөө хотод монгол ноёдын тавьсан “хүсэлтээр” – тайлбарласан байна. Хятадууд түвдэд ч ийм байдал үүснэ хэмээн найдаж байсан бизээ. Тэр үед хятадууд Бээжинд түвдийн асуудлаар англичуудтай хийж байсан зөвлөлдөөнөө зогсоогоод байсан билээ.[335]

1920 онд барон Р.Ф. фон Унгерн-Штернбергийн цагаан гвардийн отряд Гадаад Монголд орж ирэв. Унгерн дипломатын маргаан үүснэ гэдгийг үл тоомсорлон хятад цэргийг бутниргэж, монгол улсын тусгаар тогтнол, VIII Богд гэгээний төр, шашны хэмжээгүй эрхийг сэргээн тогтоов. Тэрээр Манжийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд Монгол, Түвд, Шинжааны хүчирхэг холбоо байгуулж, манжийн хаант засгийг сэргээх бодолтой байв. Энэхүү холбоо хан үндэстний хятадыг сөрөн зогсож, тус холбоонд нэгдсэн орнуудын бодит бие даасан байдлын баталгаа болох ёстой байв. Унгерн болон монголын засгийн газар Далай ламтай захидлаар харилцаж, түвдэд хятадын эсрэг тэмцэл идэвхжиж байв. Унгерн большевикуудад ялагдсаны дараа Түвд рүү явах хүсэлтэй байсан боловч амжаагүй ажээ. Улаантнууд монголыг чөлөөлөв.

Оросын большевикуудаас санхүүжиж байсан коминтерн (коммунист интернационал) 1920 онд коммунист хөдөлгөөн зохион байгуулах зорилгоор хятад руу төлөөлөгчид явуулав.[336] Бээжин, Шанхай болон бусад хотод коммунист дугуйлан, бүлгүүд байгуулагдав. 1921 оны хоёрдугаар сард Францад хятадын социалист залуучуудын эвлэл байгуулагдав. Энэ эвлэлээс Жоу Эньлай, Дэн Сяопин зэрэг гарамгай коммунистууд гарсан байна. Хятадад байгуулагдсан бүлгэм дугуйлангуудын үндсэн дээр 1921 оны зургаа – долдугаар сард коммунист намын анхдугаар их хурлыг зарлан хуралдуулсан байна. 1922 онд болсон энэ намын 2-р их хурлаас батлан гаргасан тунхагт бусад гол гол зорилтуудын дотор “Монгол, Түвд, Шинжааныг чөлөөлөх замаар жинхэнэ бүгд найрамдах улс байгуулах” зорилт дэвшүүлэн тавьжээ.[337]

Москвагаас хятад руу мөнгө ус мөрөн мэт урсана. Хятадын Коммунист нам (ХКН) Москвагаас бараг бүрэн санхүүжиж байлаа.[338] Хятад нөхдийн хүсэлт большевик ивээн тэтгэгчдийн эгдүүцлийг төрүүлэх үе ч гарч байв. Гэвч Орос улсад мөнгө хөрөнгө багатай, эвдрэл сүйрэл гарсан ч Москвагийнхан харамгүй сэтгэлээр ханджээ. Гадаадын тусламж ХКН төлөвшин тогтох чухал хүчин зүйл болжээ. Хятадын коммунистуудын мэдээлэлд түшиглэсэн зөвлөлтийн тагнуулын газар хятадад идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлэв.

Түвдийн удирдлагад тийм ивээн тэтгэгч олдоогүй ажээ. Цор ганц

дотоодынхоо нөөц боломжид түшиглэсэн XIII Далай лам тусгаар тогтнолоо бэхжүүлж, улс орноо шинэчлэсээр байв. Арми болон төв засгийн газраа бэхжүүлэх явдал хамгийн чухал зорилт болж байв. Энэ ажил түвдчүүдийн зарим хэсгийн эсэргүүцэлтэй тулгарч байв. Янз бүрийн бүлгийнхний хооронд, засгийн газар болон орон нутгийн эрх баригчдын хооронд санал зөрөлдөөн гарч, хөрөнгө хүч хүрэлцэхгүй байлаа. Сажа (баруун Цанг), Лха Гьяри (Төв Түвд), Банчин ламын эзэмшил (Дашлхүмбэ) зэрэг зарим нутаг дэвсгэр хагас бие даасан байдалтай байв. Кам, Амдогийн нүүдэлчин аймгууд Далай ламын нэр хүндийг хүлээн зөвшөөрөх боловч өөрийнхөөрөө амьдрах ажээ.Энэ тухайд Амдо мужийн нэгэн нүүдэлчин өвгөний яриа сонирхол татах бизээ.[339] Түүний хувьд өөрийн гэсэн омог бий, хөрш зэргэлдээ омгууд ч бий, Лабран хийд бий, гэтэл хүүхдээ хааш нь лам болгохоор явуулж болох вэ, Лхас хот хол, тэгээд ч шашны төв...

Татвараас үүдсэн санал зөрөлдөөн IX Банчин лам 1923 онд Түвдээс гарч явах шалтгаан болсон гэж судлаачид үздэг юм. Өөр мэдээллээр бол тэрээр бүх зүйлийг хуучин байдалд нь оруулахын тулд хятадын дэмжлэгийг авах гэж хүссэн боловч хятадууд түүнийг буцааж явуулалгүй барьж, Лхастай хийх хэлэлцээнд тамга хөзөр болгон ашиглах болсон байна.[340] Банчин лам мөн санал зөрөлдөөнөө англичуудын тусламжтайгаар зохицуулахыг оролджээ. Англичууд зуучлахаас татгалзахад тэрээр Өвөр Монгол руу явж, 1925 онд Бээжинд иржээ. Тэрээр хятад цэргээр хамгаалуулан Түвдэд буцаж очих гэсэн боловч түвдчүүд зөвшөөрсөнгүй.

Хятадууд Түвд рүү төлөөлөгчөө илгээхийг олон удаа оролдсон ч татгалзсан хариу авсан байна.[341] Лхасын засгийн газарт У-Цанг муж төдийгүй түвдийн армийн чөлөөлсөн хойд зүгийн нутаг дэвсгэрүүд захирагдах ажээ. Тэнд байсан Түвд генералууд хятадын шинэ халдлагыг сэргийлж чадсан байна. Хилийн хяналт армийн гол зорилго байв. Тухайлбал, 1927 оны намар түвдчүүд Лхас орохоор явж байсан Н.К. Рерихийн шинжилгээний ангийг Нагчуд саатуулжээ. Рерих бол “Улаан оросуудын” туршуул юм гэж Сиккимд сууж байсан английн төлөөлөгч Ф.М. Бейли түвдчүүдэд мэдээлсэн учир ийм явдал болсон байна.

Н.К. Рерих өөрийгөө V Далай ламын хойд дүр, ирээдүйн “Шамбалын хаан” хэмээн үзэж, өөрийгөө өрнөдийн Далай лам гэж тунхаглахаар шийдэж, ЗСБНХУ-ын ивээл дор азийн бурханы шашинтнуудыг нэгтгэхийг хүсч, буддизм, коммунизмын холбоо байгуулахыг уриалж, өөрийнхөө бодол төлөвлөгөөг зөвлөлтийн албаны хүмүүстэй хэлэлцэж байжээ.[342] Энэ шинжилгээний анги (экспедици) уулын хүйтэн жаварт даавуу майханд

олон хоносны эцэст ямар ч үр дүнд хүрэлгүй буцжээ. Энэ ангийн гишүүд Түвдийн тухай тааламжтай биш сэтгэгдэлтэй буцсан гэдэгт гайхахын хэрэггүй бизээ.

1920-иод онд Түвд олон улсынхаа харилцааг өргөжүүлэв. 1921 онд британчууд Түвдийн өөртөө засах эрхийг хүлээн зөвшөөрөхийг хятадад тулган шаардаж, эс тэгвээс Түвдтэй хоёр этгээдийн хэлэлцээ хийж эхэлнэ хэмээн сүрдүүлэв.[343] Бээжингийн эрх баригчид үүнд хариу өгөөгүй учир британчууд Лхастай хэлхээ холбоо тогтоов. Гэвч удалгүй Ч. Белл засгийн газрын түшмэл байхаа больж, Түвдэд сайд Шэтра нас барав. Хоёр талын харилцаа ч нэр төрийн төдий зүйл болж эхэлсэн байна. 1924 онд Түвдэд ирсэн хошууч Ф.М. Бейли тус орны бие даасан байдалд итгэжээ. Москвагаас нууц төлөөлөгчид хэд хэдэн удаа ирж, Лхасаас ч Москва руу явсан байна. Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсад энэ асуудлыг Г.В. Чичерин тэргүүтэй гадаад хэргийн ардын комиссарын газар хариуцаж байв. А. Доржиев идэвхтэй хөөцөлдсөний дүнд 10 – 20 Түвд хүнийг Орос руу сургалтанд явуулах ажлыг зохион байгуулж чадсан байна. Тэдэнд зориулж “дарины хэрэг” судлах тусгай анги хүртэл байгуулжээ. 1925 онд Чичерин Түвдэд Оросын байнгын дипломат төлөөлөгчийн газар, харин 1926 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дипломат төлөөлөгчийн газар зохион байгуулах гэжээ. Гэвч XIII Далай лам энэ саналыг хүлээж аваагүй байна. Тэрээр Их Британитай харилцаа хурцдахаас болгоомжилсон байна. Түүнээс гадна тэрээр Орос, Монголын улаантнууд бурханы шашныг мөрдөн хавчиж байгааг мэдэж байжээ. Энэ тухай тэрээр Доржиев болон VIII Богд гэгээнээс олж мэдсэн байна. Хятад, цаашлаад Азийн бүх оронд хувьсгалыг экспортлох гол түшиц газар хэмээн Коминтерны үзэж байсан Монголыг зөвлөлтжүүлэх туршлагыг Москвагийн хэн нэгэн зүтгэлтэн Түвдэд ашиглахыг хүссэн байж ч болох талтай билээ. Магадгүй, ЗСБНХУ-д бурханы шашны эсрэг олныг хамарсан гэсгээн цээрлүүлэлт явуулснаас болж 1930-аад онд зөвлөлт – түвдийн яриа хэлэлцээ зогссон байж болох юм.[344]

Далай лам зөвхөн британчууд болон оросуудтай хэлхээ холбоо тогтоосон биш билээ. Түвдэд японцууд ирж, тэдний нэг нь түвдийн армид сургагчаар хүртэл ажиллажээ.

Гэхдээ хамгийн чухал нь мэдээжийн хэрэг хятадтай харилцах харилцаа байв. 1928 онд Өмнөд Хятадын гоминьданы засгийн газрын үед Нанжин хотод генерал Янь Сишанаар удирдуулсан Монгол, Түвдийн хэрэг эрхлэх хороо байгуулав. Энэ хороог 1914 оноос үйл ажиллагааг явуулсан Монгол, Түвдийн хэрэг эрхлэх танхимын үндсэн дээр байгуулжээ. Тус хорооны

бүрэлдэхүүнд хятадад эзлэгдсэн нутаг дэвсгэрт оршин сууж байсан түвдчүүд, түүний дотор XIII Далай ламд сөрөг ханддаг байсан хүмүүс орсон байна. Нанжины засгийн газар Далай ламыг Монгол, Түвдэд мужийн удирдлага бий болгоход нэг ёсны зэвсэг болгон ашиглахыг хүсчээ.[345] Түүнээс гадна, энэ Хороогоор дамжуулан Далай ламтай хэлэлцээ хийхээр төлөвлөсөн байна. Чан Кайши 1928, 1930 онд Далай ламд хоёр захидал, 1933 онд нэг цахилгаан утас [346] явуулсан байна. Гэсэн ч албан ёсны хэлэлцээ болоогүй, яагаад гэвэл Далай лам Түвдийг хятадад нэгтгэж, IX Банчин ламыг хятад цэргээр хамгаалуулан Түвдэд эргэж ирэхийг зөвшөөрөөгүй ажээ. Нанжингийн засгийн газар Банчин ламд “Улс үндэстнээ хамгаалагч, соёлыг түгээгч Аугаа их сэцэн лам”, “Баруун нутгуудын соёлын асуудал эрхэлсэн тусгай комиссар” цол шагнав.[347]

Далай лам нанжины засгийн газартай цаашдаа Бээжин дэх түвдийн Юнхэгун хийдийн хамба ламаар дамжуулан харьцдаг байжээ. Энэ нь үнэн хэрэгтээ улс хоорондын хэлхээ холбоо байсан ч үүнийг Хятадад дагаар орох гэсний шинж тэмдэг хэмээн өнөөгийн үед заримдаа тайлбарлах болжээ. Далай лам хятадтай хийх түүний хэлэлцээнд зуучлагчаар оролцох гэсэн Британийн оролдлогыг няцаав.[348] Түвдийн шашны тэргүүн хоёр гүрний аль алинд тал алдахгүй байж шууд хэлэлцээ хийх замаар хоёр этгээдийн харилцааг шийдвэрлэх нь зүйтэй хэмээн үзжээ.

1930 онд түвдийн цэрэг Камд лам нарын дэмжлэгтэйгээр орж, Амдо мужийн хил хүртэл давшсан байна. Сычуаны Лю Вэньхуэй, Хөх нуурын (Цинхай) Ма Буфэн хэмээх хоёр милитарист хятад генерал 1932 онд сөрөг давшилтад оров. Түвдчүүд урьдыг бодвол илүү сайн зэвсэглэжээ. Тэд англи, мөн цөөн тооны орос винтовтой байв. Хятадын гадаад явдлын яам Энэтхэгээс түвдэд зэвсэг нийлүүлж байгаатай холбогдуулан Их Британий засгийн газарт эсэргүүцэл илэрхийлэв. Хожим нь хятадын коммунистууд “лхасын милитаристуудын (дайнчдын) ард английн эрх баригч бүлгийнхэн байсан” гэж ярьсан байдаг юм.[349] Англичууд Түвдийг хавсарган нэгтгэхийг хүсч байсныг үгүйсгэх аргагүй билээ.

Түвдийн талын санаачлагаар түр эвлэрэх гэрээ байгуулав. Хөх мөрний дээд бие дахин хил болсон байна. Энэ нөхцөлд Түвдийн үндэсний ассамблей Их Британий засгийн газарт хандаж, 1914 онд Симлад үзэглэсэн Конвенцийг нэн даруй батлахыг хүсэв.

XIII Далай лам насан өөд болохоосоо нэг жилийн өмнө буюу 1932 онд бодлогынхоо гол үндсэн зарчмуудыг түшмэдүүддээ илэрхийлэн хэлж эдгээр зарчмыг цаашид баримтлахыг хүсчээ. Энэ бол түүний улс төрийн

гэрээс болжээ.[350] Түвдийн шашны тэргүүн Британийн Энэтхэг болон Хятадын хүрээлэлд Түвдийн тусгаар тогтнолыг хадгалан авч үлдэх тухайд сэтгэл түгшиж явсан байна. Түвдийн нутаг дэвсгэрийг булаан эзлэгчдэд өдлөг болгох зорилгоор Камтай залгаа хил рүү цэрэг илгээсэн тухай, Гадаад монголын коммунистууд сүм хийдийг эвдлэн нурааж, Богд гэгээний хойд дүр тодруулах явдлыг хориглож, лам нараар цэргийн алба хаалгаж байгаа тухай тэр ярьсан байна. Коммунизм хэзээ нэгэн цагт гаднаас буюу дотроос Түвдэд ирнэ. Одоо л зохих ёсны арга хэмжээ авбал коммунизмыг сэрэмжлэн зайлуулах боломжтой, эс тэгвээс улс орон бүхлээрээ энэ системийн боол болно. Түвдийг хүчтэй болгох нь чухал байна. Энэ хэрэгт хүн бүр оролцох ёстой гэж Далай лам урьдчилан айлджээ. Далай лам Түвдийг хятадын эрх мэдлээс бүрэн төгс чөлөөлөхөөр шийдсэн бөгөөд олонхи түвд хүн энэ тэмцэлд түүнтэй эв санааны нэгдэлтэй байсан юм гэж XIII Далай ламыг сайн мэддэг Ч. Белл тэмдэглэжээ.

Түвдчүүд 1933 оны зургадугаар сарын 15-нд Ма Буфэнтэй найрамдлын хэлэлцээр байгуулав. Мөн оныхоо зун тэд Юньнаний чиглэлээр давшилтад орж, энэ нутгийн умард хэсгийн Жундянь хот, дараа нь Батангийг эзэлж, Хөх мөрний дээд биед 10 мянга хүртэлх цэрэг төвлөрүүлэв.[351] Мао Зэдун Шанхай хотод болсон дайн, империализмын эсрэг олон улсын бага хуралд оролцогчдод: "Баруун хятадад британийн империалистууд манай Сикан, Сычуань мужуудыг эзэлж авахын тулд түвдийн цэргийг ашиглаж, Баруун хятадыг британийн колони болгохоор бэлтгэж байна"[352] гэсэн үгтэй цахилгаан утас илгээжээ. Гэтэл Их Британи улс "Түвдийг эрх чөлөөтэй болгохыг л" хүсчээ.[353] Тус улсад шинэ колони биш, харин Энэтхэг, Хятадын хооронд орших завсрын бүс хэрэгтэй байв.

Мао төдийгүй Гоминьдан түвдийг хятадын нэг хэсэг хэмээн үзсэн хэвээр байв. 1933 онд Чан Кайши шууд хэлэлцээ хийхийг санал болгож Далай ламд дахин цахилгаан утас илгээв. "Хэдэн зууны туршид Хятад, Түвд хоёр нэг гэр бүлийнхэн мэт хамт явж ирсэн билээ. Хятад одоо бүгд найрамдах улс болсон учир бидний хооронд аливаа асуудлыг чөлөөтэй хэлэлцэх бүх боломж байна"[354] гэж хятадын ерөнхийлөгч нотолжээ. 1933 оны арван хоёрдугаар сарын 16-нд Монгол, Түвдийн хэрэг эрхлэх хороо байлдааны ажиллагааг зогсоохыг Далай ламаас шаардав. Гэвч 1933 оны арван хоёрдугаар сарын 17-нд XIII Далай лам насан эцэслэжээ. Хятадын засгийн газар эмгэнэл илэрхийлж, Лхас руу төлөөлөгчид явуулсан байна. Далай ламд цол хэргэмийг нь нэхэн олгосон байна.

Энэхүү батламж бичгийг БНХАУ-д Далай ламыг Хятадын засгийн

газрууд “баталж байсны нэг нотолгоо” болгон ашиглаж байгаа юм.

Камд болж байсан байлдааны ажиллагаа түр зогсов. Энэ үед түвдчүүд ирээдүйн Сикан мужийн гуравны хоёрыг эргүүлэн авчээ.[355] Хятадын эрх баригчид Камын нутаг дэвсгэрээс энэ мужийг байгуулахаар төлөвлөжээ. Түвдчүүд 1934 оны гуравдугаар сард Дергэг эзлэв. Тэд тавдугаар сард генерал Лю Вэньхуйтэй түр эвлэрэл байгуулсан байна.

1934 оны наймдугаар сарын 25-нд Гоминьданы өндөр албан тушаалын ажилтан генерал Хуан Мусун Лхаст ирэв. Тэрээр нэгэн сүмд очиж бүрлээч Далай ламд хүндэтгэлийн ёслол үйлдэж, түвдчүүдтэй хэлэлцээ хийсэн байна. Хуан: Түвд хятадын нэг хэсэг болох ёстой: хятад улс түвдийн батлан хамгаалалтыг хариуцна: Лхаст амбаны газрыг сэргээнэ гэсэн болзол тавьжээ.[356] Түвдчүүд зөвхөн дараах болзлуудыг хүлээн авахад бэлэн байв: Түвд бусад оронтой чухал асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулахдаа хятадын төлөөлөгчийг байлцуулна, гадаад түрэмгийллийн үед батлан хамгаалалтын асуудлаар Нанжинтай зөвлөлдөнө, түвдчүүд өндөр албан тушаалын хүмүүсийг сонгосон, томилсон тухай Хятадад мэдээлж байна, Лхаст 25 хүний бүрэлдэхүүнтэй бараа бологчид бүхий хятадын төлөөний сайд суух бөгөөд тэрээр орон нутгийн эрх баригчдад захирагдана, хятадууд Дергэ, Ньяронг, Хоркок болон Кам, Амдогийн бусад зарим нутаг дэвсгэрийг эргүүлэн өгч, өөрийн засгийн газрын эсрэг боссон нэг ч Түвд хүнд орогнол олгохгүй байна. Түвдчүүд мөн Британийн Энэтхэгтэй хийх хэлэлцээнд оролцуулж байхыг шаардахдаа ингэх нь өөрсдөд нь олон улсын баталгаа болно хэмээн үзсэн боловч хятадууд татгалзсан хариу өгсөн байна.

Тийнхүү лхассын засгийн газар Түвд орон хятадын нэг хэсэг биш, харин бие даасан улс байхыг зөвшөөрөхөд бэлэн байв. Юуны өмнө тус засгийн газар хилийн тухай асуудлыг зохицуулах гэж эрмэлзжээ.[357] Гэвч Хуан Мусун чухал асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулах бүрэн эрхгүй байжээ. Тэрээр радиодамжуулагч аппарат байрлахтай холбогдуулан хятадын хоёр офицерийг Лхаст үлдээх тухай асуудлаар л тохиролцож чадсан байна. Тэр хоёр офицер үлдэж, Нанжин хоттой байнгын холбоо тогтоож, Хуан Монгол,Түвдийн хэрэг эрхлэх хятадын хороог тэргүүлэх болов. 1940-өөд онд Лхаст хятадын, британийн төлөөлөгчид сууж байв. Лхаст ийнхүү төлөөлөгчид байх явдал түвдийн бие даасан байдлыг батлалсан хэрэг болно хэмээн хятадын засгийн газар үзжээ.

1937 оны гуравдугаар сард IX Банчин лам 20 хятад түшмэл, 500 цэрэг дагалдуулан Зүүн Түвдийн жекундод ирэв.Мөн оны наймдугаар сард нанжины засгийн газар хятадын эсрэг японы түрэмгийлэл эхэлсэнтэй

холбогдуулан Банчин ламыг дагалдан очсон хүмүүсийг буцаан татжээ.

Мөн оны арван хоёрдугаар сард Банчин лам жекундод нас барав.Түвдийг ямагт хятадын нэг хэсэг байсан гэж нотлоход зориулсан хятадын баримт бичгүүдийн эмхэтгэлд түүний гэрээс гэгчийг оруулжээ. Монгол, Түвдийн хэрэг эрхлэх хорооны даргад хаягласан энэхүү “гэрээс”-т өгүүлснээр бол тэрээр хятадын төв засгийн газарт, бурханы шашны хөгжилд, хятадын таван үндэстний эв нэгдэл, найрамдалд насан туршдаа тааламжтай хандаж ирсэн бөгөөд түвдийн ард түмэн, засгийн газар Хятадын таван үндэстний бүгд найрамдах улсын төв засгийн газрыг хүлээн зөвшөөрөх ёстой ажээ. Түвдийн цагаачлалд буй засгийн газар энэ баримт бичиг жинхэнэ эхээрээ гэдэгт ихээхэн эргэлздэгээ илэрхийлж байна.[358] Түвдийн уламжлалаар бол насан өөд болж буй хүн өөрөө дуудаж өөр хүнээр бичүүлэх буюу өөрийн гараар бичсэнийг сүүлчийн хүсэл ба гэрээс хэмээн нэрлэдэг ажээ. Түүнээс гадна захидлын зарим хэсгийг IX Банчин ламыг нас барсны дараа л бичсэн байж болох талтай ажээ.Эцэст нь “баруун хилийн районд бурханы шашин дэлгэрүүлэх газрын нарийн бичгийн дарга нарын газар” гэрээсийг илгээв гэсэн байна.

Хятадын удирдлага Түвдийн эрх баригч бүлгийнхний дотор гарсан хэрүүл маргаан болон тус улсын төв засаг суларсан явдлыг ашиглажээ. 1935 оны зургадугаар сард Сикан мужийг зохион байгуулах асуудал эрхэлсэн хороо байгуулав. Тухайн үедээ манжийн эзэнт улс Камын нутгуудаас энэ мужийг байгуулж амжаагүй ажээ.Одоо энэ үзэл санааг бүгд найрамдах улсын талыг баримтлагч хан үндэстнүүд буюу хятадууд сэхээн амьдруулжээ. 1936 оны наймдугаар сард энэ хороог Дарцедод шилжүүлэн байрлуулж, Сикан мужийн засаг захиргааны байгууллага хэмээн зарлав.[359] Энэ хот шинэ мужийн нийслэл болох ёстой байв. Камын гацаа суурин бүрт анх удаа ердийн (шашны бус) сургууль байгуулав. Амдог Хөх нуур (Цинхай),Ганьсу мужуудад хувааж нэгтгэв. Тэнд Хөх нуур, Ганьсуг хятадын бусад мужтай нэг ижил болгох зорилготой шинэтгэл хийж эхлэв. Сикан мужийг 1939 оны нэгдүгээр сарын 1-нд Дарцедо хотод зарлан тунхагласан байна.

XIII Далай лам тэнгэрт хальсан явдал дээд давхаргынхны өрсөлдөгч бүлгүүдийн тэмцлийг хурцатгав. Түүний шадар хүмүүсийн дотроос хамгийн их жин, нөлөөтэй нь тариачны гэр бүлээс гаралтай Тубтен Кунпэл байв.1931 онд энэ лам Лхасын ойролцоох Драпчи хотын цахилгаан машины газрын тэргүүнээр томилогдож, 1931-1932 онд нийслэлийг хамгаалах нэг мянган цэрэгтэй шилмэл хороо эмхлэн байгуулжээ. Тус хороог хамжлагууд болон язгууртнууд биш, харин хотын дундчуудын төлөөлөгчдөөс эмхлэн

байгуулжээ. Хороонд үймээн гарсны дараа түүнийг татан буулгав. Кунпэлийг баривчлан цөллөгт явууллаа. Кунпэл болон зөнч мэргэн Нэчун нарыг XIII Далай ламын эмчилгээг буруу зохион байгуулсан хэмээн буруутгажээ.

Кунпэлийн талыг баримтлагчдын нэг Камд бослого гаргах гэсэн боловч ялагдав. Бослогчдыг гэр бүл болон эд хөрөнгийнх нь хамт хятадуудаар хамгаалуулан Батан руу явуулсан байна.

Үндэсний ассамблей 24 настай Райдан хутагтыг засаг баригчаар сонгожээ. Ийнхүү тэргүүн сайд болон засаг баригчийн албан тушаалд туршлагагүй залуу хүмүүс очсон байна.[360] Тэр үед Далай ламын шадар байсан хүмүүсийн нэг Луншар Дорж Цогьял улс орны удирдлагын системийг шинэтгэх санал дэвшүүлэв. Сайд нарыг Далай лам бүх насаар нь томилох биш, харин Үндэсний хурлаас дөрвөн жилийн хугацаагаар сонгох бөгөөд тэд ажлаа үндэсний хуралд тайлагнадаг байх ёстой гэж тэр үзжээ. Луншар шашин, төрийн түшмэдүүдийн хурлыг хоёр удаа хийлгэсэн бөгөөд тэр хоёр хуралд түшмэдүүдийн тавны нэгээс дөрөвний нэг хүртэлх хувь нь оролцсон байна. Хоёр хурлын дүнгээр сайд нарын зөвлөлд өргөх бичиг бэлтгэжээ. Гэтэл өргөх бичгийг танилцуулахаас нэг өдрийн өмнө Луншар болон түүний талынхныг засгийн газраа түлхэн унагаж, удирдлагын большевик систем тогтоох гэсэн хэмээн баривчилж, Луншарын хоёр нүдийг сохолж, түүнийг дэмжигчдийг цөлсөн байна. Түвдэд засаглалын шинэтгэл хийх гэсэн ээлжит оролдлого ингэж төгсчээ.

Шинэ засаг баригчийн талынхан хятадууд хөндлөнгөөс оролцохгүй байх болзлын дор хятадтай харилцаагаа бэхжүүлэхийн төлөө тэмцлийг Лхаст өрнүүлэв. Гэтэл хятадын засгийн газар түвдийн гадаад бодлого, батлан хамгаалалт, зам харилцаа, дээд албан тушаалтнуудын томилолт зэрэг асуудлыг мэдэлдээ авах шаардлага тавьжээ. Түвдэд Нанжин хотоос томилогдох бүрэн эрхт төлөөлөгчийн удирдлагад байх өөртөө засах эрх (автономи) олгохыг амласан байна.[361]

Луншарыг зайлуулсны дараа Түвдийн төр, шашны эрх баригчид XIII Далай ламын хойд дүр болох хөвгүүний эрэлд гарсан байна. Зохих ёсны зан үйл гүйцэтгэж, зөнч мэргэдийн таавар явуулсны эцэст эрлийн бүлэг Амдо мужийн Гүмбум хийдэд иржээ. Хөрш зэргэлдээх тосгонд нь шинэ Далай лам тодорсон бөгөөд 1935 оны долдугаар сарын 6-нд төрсөн тэр хөвгүүнийг Лхам Дондов гэдэг ажээ. Гол төлөв түвд, монгол, түрэг хүмүүс оршин суудаг Амдо мужыг хятадууд хянадаг байв. Түвдийн элч нар жаал хүүг авч явахын тулд хятад эрх баригчдад их мөнгө төлөхөөр тохиролцов. Гэвч тэд энэ бол түвдчүүдийн яриад байгаагаас илүү эрхэм хүний хойд дүр

байх хэмээн таамаглаж нэмж мөнгө өгөхийг шаарджээ. Ингээд Лхасаас мөнгө ирүүлж, хүүг гэр бүлийнх нь хамт авч явжээ.

Түвдийн үндэсний хурал Лхас орох замд шинэ дүр тодорсныг баталсан байна. Засаг баригч Райдан XIII Далай ламын зарлан тунхагласан түвдийн тусгаар тогтнолын бодлогыг зөрчин хятадуудтай харилцаагаа сайжруулах гэхдээ Алтан савнаас Далай ламыг тодруулах ёслолын ажиллагаанд хятадуудыг урьж, дараа нь энэ ёслолыг өөрчлөхийг хүсч, тэдэнтэй захидлаар харилцаж байжээ.[362] Хойд дүр тодруулах, түүнийг сэнтийд залах ажиллагаа хятадуудаас үл шалтгаалан хийгдэж дууссан ч гоминьданыхан Далай ламыг "баталсан" тухай, Алтан савнаас шодох үйлдлийг халах тухай, 400 мянган юань төсөвлөн гаргаж байгаа тухай зарлиг гаргасан байна. Райдан 1941 оны эхээр огцорч, 1947 онд нас барав.[363] XIV Далай ламыг сэнтийд залах ёслол 1940 оны хоёрдугаар сарын 22-нд Будалын ордонд болов. Монгол, түвдийн хэрэг эрхлэх хорооны төлөөлөгч Лхаст үлдсэн байна.

Хятадын засгийн газар өөрийн элч У Жосиний тусламжтайгаар XIV Далай ламыг сонгон шалгаруулж, хүлээн зөвшөөрөхөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж хожим нь тус засгийн газар мэдэгдсэн байна. Гэтэл ёслолын ажиллагаан дээр түүний гүйцэтгэсэн үүрэг гадаадын бусад төлөөлөгчдийнхөөс ялгараагүй ажээ. Бүх хятадын ардын төлөөлөгчдийн хурлын (БХАТХ) байнгын хорооны (БХ) орлогч дарга Агваан Жигмэд энэ асуудлыг хятадын архивын материалаар тусгайлан судалжээ. 1989 онд тэрээр энэ түүхийг гоминьданыхан хэрхэн мушгин гуйвалсан баримтууд олсноо нэг бүрчлэн бичиж үлдээжээ.[364] Хятадын элчийн хуурамч тайлан, "Чайниз Ньюс Рипорт" сонинд гарсан Далай лам, У жосин нарын гэрэл зургийг ашигласан бөгөөд тэр гэрэл зургийн доод талд үүнийг Далай ламыг сэнтийд залах үед татуулав хэмээн бичсэн байжээ. Үнэн хэрэгтээ, энэ гэрэл зургийг сэнтийд залах ёслолоос хойш хэд хоногийн дараа буюу У Жосан Далай ламд бараалхаж адис хүртэх үеэр татуулсан байна гэж Жигмэд нотолсон байна.[365] Ингэхлээр Далай ламын хойд дүрийг гоминьданы засгийн газар баталсан гэх нотолгоо худал болж байгаа ажээ.[366]

Хятадад Гоминьдан болон ХКН-ын хооронд иргэний дайн болж байлаа. 1934–1936 онд Хятадын улаан армийн аугаа их аян болсон нь Гоминьданы шахалтаар гол хүчнээсээ салж баруун хойд зүгт ухарсан явдал мөн бөгөөд араас нэхсэн дайсантай хийсэн тулалдаануудад энэ армийн дайчдын 60 хүртэлх хувь нь амь үрэгдсэн байна.

Энэ үед мөн Коминтернээс ХКН-д тогтмол ирүүлж байсан мөнгөн тэтгэлэг зогсжээ. Ийнхүү зөвлөлтийн томоохон тусламжийн тухай

асуудал босч ирсэн байна. Маод Сычуань – Сиканы хилийн районд "үндэсний цөөнхийн" улс байгуулах санаа төржээ. Энэ улсад түшиглэсэн коммунистуудын гол хүч Хөх нуур буюу Ганьсугаар дамжин Шинжаан хүрч, тэндээс ЗСБНХУ-тай холбоо тогтоож, тус улсаас бүх талын тусламж авах ёстой байв.[367]

Энэ төлөвлөгөө биелэж чадаагүй ч 1936 онд ХКН Москва дахь Коминтерны төлөөлөгчдөөс 3 сая доллар, нисэх онгоц, хүнд зэвсэглэл, зенитын пулемёт, сум, винтов буу, цэргийн хэрэгсэл хүсчээ. Большевикууд дээрх зэр зэвсгийг нийлүүлэх төлөвлөгөө боловсруулж, 2 сая хүртэлх америк доллар өгөхөөр амласан байна.[368] 1940 онд Мао: "Зөвлөлт Холбоот Улсын тусламжаас татгалзана гэдэг бол хувьсгалаа ялагдалд хүргэнэ гэсэн үг байлаа" гэж хэлсэн байдаг.[369]

Харин Түвдэд ирэх гадаадын тусламж тун багавтар (гол төлөв буу, цэргийн хэрэгслээр хязгаарлагдана), засгийн эрх мэдэл болон үзэл сурталд үзүүлэх гадаадын нөлөө ерөөс мэдэгдээгүй өнгөрчээ.

1935 оны зургадугаар сард хятадын улаан армийн ангиуд Юньнань мужаар дамжин өмнө зүгээс Сиканд оров. Тэдний зам Дергэ, Литан, Ньярон, Хорков, Ба тойргуудаар дайрсан байна.[370] Улаан цэргийн командлал зам зууртаа тойрог, гацааны зөвлөлт "засгийн газрууд" байгуулж явжээ. Засгийн газрын бүрэлдэхүүнд ядуу гэр бүлээс гаралтай залуучуудаас бүрдсэн бөгөөд газрын эзэдтэй тэмцэх тусгай отрядууд орж байв. Баячуудын газрыг хураан авч, газаргүй болон бага газартай тариачдад шилжүүлэн өгчээ. Үүнийг эсэргүүцсэн хөдөлгөөн ч гарч байв.[371] "Хавчигдсан цөөнхийг" өөрийн талд татаж, империализм, гоминьданы эсрэг хувьсгалыг эрчимжүүлэх хэрэглүүр болгох явдал хятадын зөвлөлүүдийн нэг гол зорилт болж байлаа".[372]

Улаантнууд хоол хүнсээр дутагдаж байв. Ийм учир тэд эдгээр"хавчигдсан цөөнхийг" дээрэмдэж, тэдний мал, үр тариа, хүнсний ногоо, тутрага, цөцгийн тосыг булаан авч байв.[373] Энэ зорилгоор "эмэгтэйчүүдийн хороо", "хүүхдийн отряд" хүртэл байгуулжээ. Коммунистууд дээрэм тонуул хийж, сүм хийд эвдлэн нураадгийг түвдчүүд анх удаа үзсэн байна.[374] Улаантнууд хангалттай хэмжээний үр тариа нөөцөлсний эцэст есдүгээр сарын багцаанд хоёр хэсэг болон хуваагдаж умар зүг хөдлөв. Тэдний удирдагчид санал зөрөлдөөнтэй байв. Мао Зэдун тэргүүтэй нэг бүлэг ихээхэн хохирол амсан байж Ганьсугаар дамжин Шэньси мужид оров. Энд онцгой район Яньань коммунистуудын гол түшиц газар болжээ. Өөр нэг бүлэг нь 1936 онд Гоминьданд ялагдаж Сиканд буцаж ирээд 30-40 мянган ам дөрвөлжин километр нутаг дэвсгэр эзэлж авсан байна.[375] Улаан цэргийн командлал

зөвлөлт “засгийн газрын “оронд түвдийнхийг байгуулж эхэлсэн байна. Эдгээр засгийн газарт Түвд үндэстний “дээд давхаргын эх орончдыг”, гэхдээ эхний ээлжинд ядуучуудыг оруулж байв.

1936 оны тавдугаар сард Карзед Даофу, Лухо, Карзе болон бусад нутгийн ардын төлөөлөгчдийн анхдугаар их хурал болов. Их хурлыг хятадын улаан армийн командлагч Жу Дэ даргалсан байна. Их хурлаас “Хятадын зөвлөлт бүгд найрамдах улсын Түвдийн өөртөө засах засгийн газар” байгуулж, даргаар нь Геда ламыг сонгосон байна. Ядуу гаралтай зарим Түвд хүн ХКН болон улаан армид элсэн оров.[376] 1949 онд ХКН хятадын засгийн эрхийг авахад дээрх хүмүүс зохих албан тушаалд очжээ.Үүнийг суртал нэвтрүүлгийн хэрэгслээр өргөн сурталчилсан байна.

Сиканд улаантнуудын 4-р корпусынхны тоо 40–50 мянгад хүрчээ.[377] Удалгүй энэ корпуст хятадын улаан армийн 2 ба 6-р бүлэг нэгдэв. Тэдгээр бүлэг хамтдаа Сиканаас Ганьсугийн зүг урагшилж эхэлсэн байна. Улаан армийнхныг ирэхийн өмнө нутгийн хүн ам хэрэгтэй бүхнээ аван зугатжээ. Цэргүүд нүдэнд харагдсан бүхнээ авч, ууланд яваа мал адгуусыг агнуулахаар цэргийн отряд явуулж байв. Нутгийн оршин суугчид гоминьданыханд ч, коммунистуудад ч нэгэн адил дайсагнан хандаж байсан юм. Тэд зарим нэг цэрэг болон жижгэвтэр бүлгүүд рүү халдаж байв. Алагдсан, осгосон, өлсөж үхсэн хүний тоо өсч байлаа. Зам харгуй муу байсан явдал урагшлах хөдөлгөөнийг туйлын их хүндрүүлж байлаа. Ухарч яваа цэргүүд өлсөхийн эрхэнд өвс ногоо, модны навч, зарим нь бүр нас барсан нөхөдийнхөө хүүрийг ч иддэг байсан гэж энэ бүхнийг нүдээр үзсэн хүмүүс ярьдаг байсан юм гэж цэргийн зөвлөх О. Браун дурсан бичжээ.[378] Хятадын улаан армийг явсны дараа дээр дурдсан “засгийн газрууд” таржээ.

Түвдэд хувьсгал экспортлох гэсэн анхны оролдлого ийнхүү дампуурчээ. Энэ бол зүйн хэрэг, яагаад гэвэл уламжлалт нийгэм л түвдчүүдийн сэтгэлд нийцэж байжээ. Тэд Сиканд улаантнуудын гаргасан зан авирыг нүдээр харсан. Түүнээс гадна тэд БНМАУ-д юу болж байгааг олж мэдсэн, энэ тухай сонссон. Яг энэ үед монголд хүмүүсийг олноор нь баривчилж, лам нар болон феодалуудыг буудан хороож, сүм хийдүүдийг эвдлэн сүйтгэж, хамтралжуулж, “олон нийтийг гэгээрүүлэх” ажил өрнөж байлаа.

1937 онд эхэлсэн хятад-японы дайны үед Гоминьдан болон хятадын коммунист намын хоорондын дайн түр зогссон боловч хоёр хувьсгалт намын сөрөг төвлөрөл хэвээр үргэлжилжээ. “ЗСБНХУ-ын зүгээс тусламж, тэрч байтугай цэргийн шууд дэмжлэг ирнэ хэмээн тооцоолсон Мао Зэдуны голчлон өдөөсөн Гоминьдан болон ХКН-ын цэргүүдийн зэвсэгт

мөргөлдөөнийг зөвлөлтийн засгийн газар л унтрааж байлаа" гэж Ледовский бичжээ.[379]

Түвдийн хууль ёсны эрх баригчдын эсрэг хилийн чанадаас явуулах хорлон сүйтгэхүйл ажиллагаа ч зогсохгүй байв. 1939 онд энэтхэгийн умард нутгийн Калимпонг хотод хятадын талыг баримталсан – Баруун түвдийн шинэтгэлийн нам байгуулагдав. Түүнийг Кам мужийн хамгийн баян нэг гэр бүлийн гишүүн байгуулсан бөгөөд түвдийн цөлөгдсөн оргодлууд болон цагаач иргэд энэ намын гишүүн болсон байна. Хятадын бүрэлдэхүүнд өөртөө засах бүгд найрамдах Түвд улс байгуулах явдал энэ намын гол үзэл санаа ажээ. Түүний удирдагчдын нэг 1930-аад оноос 1940-өөд оны эхэн хүртэл Хятадад байж, хэсэг хугацаанд Монгол, Түвдийн хэрэг эрхлэх хороонд ажиллаж байжээ. Тэрээр Гоминьданаас мөнгө авч, Түвдэд Синьхайнхтай адил хувьсгал хийх гэж хүсч байжээ.[380] 1945 оны зургадугаар сард тэрээр английн колонийн эрх баригчдад баривчлагдаж, Түвд рүү хүргэгдсэн байна. Түүнийг тэнд элдвээр тамласны эцэст шоронд хийжээ. Тус намын Энэтхэгт байдаг бусад гишүүдийн гэрт нэгжлэг хийжээ. Энэ үеэр олдсон баримт бичгүүд тус намынхан эргэлт гаргаж, Түвдийг хятадад нэгтгэх бодолтой байсныг гэрчлэн харуулсан байна. Хувьсгал хийх гэсэн бас нэг оролдлого ийнхүү төгсжээ.

Германы засгийн эрхэнд гарсан үндсэрхэх социалистууд Түвдийг сонирхож эхэлсэн байна. Тэд ЗСБНХУ-аар дамжуулан тийш нь экспедиц явуулах гэсэн боловч бүтсэнгүй.[381] Тэр үеэс хойш нацистууд болон түвдийн хэлхээ холбооны тухай асуудал олны сонирхлыг татаж иржээ. "Түвдэд СС-ийнхний ул мөр" бий тухай олон тооны дам яриа ихэнх тохиолдолд бодит байдлаас зөрдөг билээ. "Хувь заяаны жад" хэмээх номондоо Т. Равенскрофтын мэдээлсэн "Шамбалын одон", "Агарти" хэмээх газар дорхи нийгэмлэгийн гишүүдтэй хэлхээ холбоо тогтоох зорилгоор Түвд рүү германы экспедиц (шинжилгээний анги) явуулж байсан тухай мэдээлэл бол дэндүү санаанаас зохиосон зүйл[382] юм. Дээр дурдсан ном болон Л. Повель, Ж. Бержье нарын зохиосон "Ид шидэтний өглөө" хэмээх бас ч үгүй нэрд гарсан нэгэн бүтээлд дурдсан нацист герман дахь "түвд оршин суугчдын" тухай мэдээлэл ч мөн тийм домог төдий зүйл ажээ. XX зууны эхний хагаст Германд Төв Азийг судлагч германы эрдэмтэн А. Тафелийн орчуулагч Бугьял гэдэг нэртэй ганцхан Түвд хүн сууж байжээ. Энэ хүн 1920 онд Тафелийн тогооч герман бүсгүйтэй гэрлэж, түүний овгийг авсан юм байжээ. 1940-өөд оны эхээр тэр хүн Штутгартын ойролцоо байсан тухай мэдээ бий билээ. Герман хувцастай "түвдчүүдийн" шарил Берлин хотоос олдсон тухайд бол

1942–1943 онд герман руу гарч явсан халимагууд байсныг үгүйсгэхийн аргагүй бөгөөд тэр халимаг хүмүүс биеийнхээ байцаалтад төрсөн газраа Лхас гэж тэмдэглүүлдэг байжээ. Гэхдээ дайны сүүлчийн өдрүүдэд Берлинд халимагууд бараг байгаагүй ажээ.[383]

Өнөөгийн хятадын суртал нэвтрүүлэгт Түвдийн дээд эрх баригчид нацистуудтай холбоотой байсны “нотолгоо” болгож хэн бүхэнд тодорхой дараах баримтыг иш татан дурддаг юм. 1945 онд германы армийн олзлогдсон хоёр офицер – австри үндэстэн Г. Харрер, П. Ауфшнайтер нар Энэтхэгийн Дерадун дахь эрх чөлөө нь хасагдсан хүмүүст зориулсан британийн лагериас оргожээ. Тэднийг уулын экспедициэс Пакистан руу буцаж явах замд нь олзолсон байна. Г. Харрер СС-ийн офицер, нацист намын гишүүн байжээ. Энэ хоёр хүн Түвдэд ирж тэнд орогнох зөвшөөрөл авчээ, учир нь Түвд төвийг сахисан орон хэвээр байсан юм. Тэд Түвдэд 7 жил болохдоо тэндхийн эрх баригчид болон британийн төлөөлөгчидтэй сайн харилцаатай болсон байна. Британчууд тэдэнд боломжийнхоо хэрээр, тухайлбал эх орон руугаа захидал явуулахад нь тусладаг байжээ. Харрер тэр үед түвдчүүдийн хувьд үл мэдэх, ер бусын санагдах өрнөдийн орнуудын тухай Далай ламд олон удаа ярьж өгсөн байна. Хожим нь Харрер “Түвдэд долоон жил” хэмээх ном бичсэн нь олны сонирхлыг татсан байна.[384] Гэвч Харрер ч, германы рейхийн өөр хэн нэгэн ч Түвдийн засгийн газрын зөвлөх байгаагүй, тус улсын бодлогод ямар ч хэлбэрээр нөлөөлөөгүй ажээ. Дэлхийн хоёрдугаар дайн дуусах үед дөнгөж арван настай байсан Далай лам нацистуудын тухай юу ч мэддэггүй байсан гэж ярьжээ.[385]

Нилээд өмнөх үеийн нэг тохиолдол чухал ач холбогдолтой юм. Англи – энэтхэгийн эрх баригчид эсэргүүцэж байсан хэдий ч 1939 оны эхээр Э. Шефферийн удирдсан германы экспедиц ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр Түвд хүрч, тэнд хоёр сар шахам болсон байна. Энэ хугацаанд экспедицийн гишүүд түвдийн засгийн газрын сайд нар, засаг баригч Ретинг нартай хэлхээ холбоо тогтоож, түвдийн язгууртнуудын олон гэр бүлтэй найрсаг харилцаатай болжээ. Түвдийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхийг сонирхдог засаг баригч герман Шефферийн зөвлөснөөр тэр үеийн германы засгийн газрын тэргүүн А. Гитлерт захидал бичсэн байна. “Түвдэд ирсэн анхны германчууд болох “Шеффер болон түүний отрядад улс орондоо орох зөвшөөрөл олгож, шаардлагатай тусламж үзүүлсэн тухай энэ захидалд мэдээлээд Түвд, Германы хооронд найрсаг харилцаа тогтоох хүсэлтээ илэрхийлжээ.

Засаг баригчийн захидал Түвдийн хувьд уламжлал болсон албан ёсны бичиг

захидлын хэлбэрээр, тухайлбал "элэгсэг байдлаар, юуг ч үүрэг болгоогүй" тийм хэлбэрээр бичигдсэн боловч энэ захидал янз бүрийн гуйвуулга хийхийн нэг шалтаг болжээ. Өнөөдөр ч энэ захидлыг Түвдчүүд нацистын германд найрсаг байдлаар хандаж байсны "нотолгоо" болгох гэж байн байн иш татаж байна. Нэгэн сонирхолтой баримт дурдахад ЗСБНХУ тэр үед Герман улстай допломат харилцаатай байсан бөгөөд мөнөөх 1939 онд тус улстай "үл довтлох тухай гэрээ" байгуулсан байсан шүү дээ.



Дасан Додул Царон 1939 он (Bundesarchiv, Bild 135-S-13-06-35/foto: Ernst Schaefer/ License CC-BY-SA 3.0)

Номхон далайд дайн эхэлснээс хойш буюу 1941 оны арван хоёрдугаар сард Түвдэд дайтаж буй талуудын аль нэгний ялалтын төлөө биш, харин амар амгалан байдал тогтохын төлөө мөргөл үйлдсэн байна.[386] 1942 оны сүүлчээр АНУ-ын стратегийн албаны (тагнуулын) Товчооны ажилтан дэд хурандаа И. Толстой, ахмад Д. Брук нар Лхаст албан ёсоор хүрэлцэн ирсэн байна.[387] Тэд ерөнхийлөгч Рузвельтын албан ёсны төлөөлөгчид бөгөөд ерөнхийлөгч Далай ламд бичсэн захидлаа тэр хүмүүсээр дайж явуулсан байна. Америк офицерууд Энэтхэгээс хятадын төв нутаг руу зам тавихтай холбогдсон мэдээлэл цуглуулах гол зорилготой ирсэн байна.[388] Японы эсрэг дайны фронтод ачаа бараа тээвэрлэн хүргэхэд энэ зам чухал үүрэгтэй байжээ. Цэргийн тусламж тээвэрлэхийг хориглосон байв. Гэвч Түвдийн сайд нарын зөвлөл (Кашаг) энэ хоёр офицерт түвдийн нутаг дэвсгэрээр дамжин хятад руу явах зөвшөөрөл олгож, АНУ, Түвдийн найрсаг харилцаа тогтоох нь гадаадын бусад улсад сонин үзэгдэл болно хэмээн үзэх хэрэгтэйг зарласан байна.[389] 1942 онд Түвд Энэтхэгээс японы фронтод ачаа бараа тээвэрлэн хүргэх зам тавих тухай Хятадын гоминьданы засгийн газрын саналд татгалзсан хариу өгсөн байна. Харин англичууд тусгай зам тавилгүйгээр цэргийн биш бараа тээвэрлэх тухай асуудлаар тохиролцож чадсан байна. Үүгээрээ Түвд тусгаар тогтносон улс болохоо, Хятадтай харилцаагаа





Түвдийн арми 1939 онд (Bundesarchiv, Bild 135-S-13-06-35/foto: Ernst Schaefer License CC-BY-SA 3.0)

өргөжүүлэх бодолгүйгээ бас дахин нотолжээ.

1943 онд Британийн эрх баригчид зөвхөн Симлагийн хэлэлцээрийн үндсэн дээр Түвдийг захирах хятадын сюзеренитет эрхийг хүлээн зөвшөөрөх асуудлыг сэргээн тавьжээ.[390] Чан Кайши Энэтхэгээс тээвэрлэлт хийхтэй холбогдсон нөхцөл байдлыг мухардлаас гаргахын тулд 1943 онд Сикан, Сычуань, Юньнань мужийн цэрэгт Түвдийн хилд дөхөж очих тушаал өгсөн байна.[391] Түвдчүүд армиа хөдөлгөв. Гэвч талууд дайнд бэлэн биш байв. Ингээд ачаа тээвэрлэх ажлыг хувь хүмүүсээр хийлгэх болжээ. Зүүн хойд Энэтхэгийг Сычуань мужтай холбодог агаарын коридор Түвдийг дайран өнгөрдөг байсан юм. Нисэх онгоцны ослоор амь үрэгдсэн америк нисэгчдийн шарил саяхан Төв Түвдээс олдсон байна.[392] Япон улс мөн Түвдийн дээд давхаргынхантай хэлхээ холбоо тогтоож, Түвдэд тагнуулын ажил зохион байгуулахыг эрмэлзсэн[393] боловч үр дүнд хүрсэнгүй.

Гитлерийн эвсэл ялагдсан тухай мэдээг Түвдэд талархлын үг хэлж, шашны ёслол үйлдэж баяр ёслолын байдалтай тэмдэглэжээ.[394]Тийнхүү дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд Түвд төвийг сахисан байр суурь баримталжээ.

Үүгээр тус улс эвсэлд үл нэгдэх, бие даах гадаад бодлого баримтлах чадвартайгаа нотлон харуулсан юм.[395] Түвдийн эрх баригчид төвийг сахисан бодлого баримтлахдаа нууцлагдмал байдлаа хадгалж, хувьсгалт донсолгоо, гадаадын түрэмгийллээс сэрэмжлэхийг эрмэлзжээ. Түвдчүүд замын сүлжээгүй, өндөр уулс зэрэг байгалийн саад бэрхшээлтэйдээ найдлага тавьсан бололтой юм. Бүх улсын хэрэг эрхлэх газар буюу бүр 1909 онд байгуулсан Гадаад хэргийн товчоог 1942 онд Лхаст сэргээв.[396] Хятадын төлөөлөгч түүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзав. 1961 онд түүнийг хаах хүртэл үндсэндээ англичууд л энэ товчоотой холбоотой байжээ. 1945 онд Түвдэд очсон Р. Форд энэ бол өөрийн гэсэн зан заншил, хууль дүрмээ баримталдаг бие даасан орон байсан юм гэж гэрчлэн бичжээ.[397]

1946 онд гоминьданы засгийн газрын элч Лхаст иржээ. Тэрээр дэлхийн хоёрдугаар дайнд холбоотнууд ялсныг тохиолдуулан Энэтхэгээр дамжуулан "сайн санааны төлөөлөгчдийг" Нанжин хот руу явуулах тухай асуудлаар Түвдийн эрх баригчидтай тохиролцжээ.[398] Түвдийн эрх баригчид төлөөлөгчдөөрөө албан ёсны илгээлт явуулсан байна. Түвд бол Далай ламаар удирдуулсан, хятадтай "багш – ивээн тэтгэгчийн" зарчмаар тайван харилцаа тогтоохыг хүсдэг бие даасан орон билээ гэж энэхүү илгээлтэд өгүүлсэн байна. Түвдчүүд мөн Кам, Амдог эргүүлж өгөхийг шаарджээ. Төлөөлөгчдийг хүрэлцэн ирмэгц Нанжин хотын хэвлэл "японы




Янз бүрийн орны тамга дарсан В.Д. Шакабпын паспорт

түрэмгийллийн эсрэг дайны үед түвдийг удирдаж байсны төлөө ерөнхийлөгч Чан Кайшид түвдчүүдээр хүндэтгэл үзүүлэхийн тулд" түвдийн төлөөлөгчид Үндэсний Ассамблейд очих ёстой хэмээн зарласан байна.

Нанжинд очсон төлөөлөгчид Ассамблей болон улс төрийн хэлэлцүүлэгт

оролцож болохгүй гэж британчууд Түвдийн засгийн газарт урьдчилан анхааруулж байжээ. Тэдний тооцоолсноор Нанжинд очсон төлөөлөгчид хэрэг дээр барьцаанд орсон байна.[399] Түвдийн засгийн газар төлөөлөгчдийг буцааж явуулахыг шаардсан боловч хожимджээ. Хятадууд төлөөлөгчдийн буцах бэлтгэлийг хангахаас татгалзаж, Лхасаас ирсэн илгээлтэд Чан Кайшийн өгөх хариуг хүлээ хэмээн үлдээсэн байна.Төлөөлөгчдийн гишүүд бол Бүгд Найрамдах Хятад улсын үндэсний Хурал дахь Түвдийн төлөөлөгчид юм гэж хятадын үндсэн хуулийн хурал 1946 оны арван нэгдүгээр сард зарлажээ.[400] "Төлөөлөгчид нь энэхүү Ассамблейд оролцож буй орнуудын бүх ард түмэн бол Хятадын гоминьданы засгийн газрын харьятууд мөн"[401] хэмээсэн хурлын тогтоолын материалууд хэвлэлд гарч ирэв.

Түвдийн төлөөлөгчид энэ тухай сайд нарынхаа зөвлөлд мэдээлсэн байна. Түүний хариуд тогтоолыг хүлээн зөвшөөрч болохгүй, баяр хүргэх зорилгоор л төлөөлөгчид явуулсан, хоёр этгээдийн харилцааны асуудлыг л шийдвэрлэж болно, хэрэв үг хэлэх зөвшөөрөл олголгүйгээр тогтоол батлахад хүрвэл хуралдааны танхимыг орхиж гарахаас өөр зам байхгүй гэсэн цахилгаан утас иржээ. Түвдчүүд хятадын үндсэн хуулийн төслийг оролцуулан ямар нэгэн тогтоолд гарын үсэг зурахаас татгалзаж байна, бид хуралдаанд оролцохоос өөр ямар нэгэн алхам хийх эрхгүй гэж нийтийн өмнө мэдэгдсэн байна. Түвдийн статусыг ч, Лхасаас ирсэн захидлыг ч ерөөс хэлэлцэлгүй өнгөрчээ.[402] Гэвч хятадын хэвлэл Түвдийн төлөөлөгчид Ассамблейд ирснийг онцлон дурдаж, тэр төлөөлөгчид Ассамблейн ажилд оролцсон хэмээх сэтгэгдэл төрүүлэхийг эрмэлзжээ.

Төлөөлөгчид Лхаст буцаж ирэв. Нанжины засгийн газар шинэ төлөөлөгчид ирүүлэхийг шаардав. Гашуун туршлагаасаа суралцсан түвдийн эрх баригчид татгалзсан хариу явуулжээ. Гэтэл 1947 онд хятадын үндэсний хурлаас батлан гаргасан үндсэн хуульд Түвдийн төлөөлөгчдийн гишүүд энэ хуульд гарын үсэг зураагүй, түүнийг хүлээн зөвшөөрөөгүй ч Түвдийн өөртөө засах эрхийг баталгаажуулж байна гэж өгүүлжээ. Хятадын суртал нэвтрүүлэгчид одоо ч Түвд орон Хятадад захирагддагийн "нотолгоо" болгон ашиглаж байна.

Энэ зуурт Түвдийн байдал хурцдав. Шинэ засаг баригч Тактра хийдийн Агваан Сунраб зарим шинэтгэл хийхийг эрмэлзэж: сүм хийдийн тариачдаас татварын дутууг цуглуулж, Лхас хотод англи хэл үзэх төрийн сургууль нээв. Засаг баригчийн амь насанд хоёр ч удаа халдсан байна. Хоёр хийдийн лам нар босов. Бослогыг дарж, 200 гаруй лам алагдав.[403] Бослогод бэлтгэж байсан хуучин засаг баригч Ретинг мөн баривчлагдав. Одоогийн

засаг баригчийн амь насыг хөнөөх гэсэн, хятад захиргаа тогтоосны хариуд цэргийн тусламж үзүүлэхийг хүссэн захидлыг Чан Кайшид илгээсэн гэж түүнийг буруутгажээ. Ретинг шоронд нас барсныг нэг бол амиа хорлосон, үгүй бол түүнийг хордуулсан хэмээн үздэг юм байна. Бусад бослогчийг эрүүдэн шүүж, заримыг шоронд хорьж, нөгөө хэсгийг язгууртнуудын эдлэн газруудад албадан ажиллуулахаар явуулж, мөн заримд нь өршөөл үзүүлжээ. Хятадтай хамтран ажилласан гэж зарим хүнийг буруутгасан нь үндэстэй бөгөөд Түвдээс 200 гаруй хүн гоминьданы хяналтад байдаг нутаг дэвсгэрүүд рүү зугатсан байна.

Шинэ засаг баригч Тактра тэргүүтэй Түвдийн засгийн газар тусгаар тогтнолоо бататгахын тулд бүхнийг хийж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхийг эрмэлзжээ. 1947 оны хавар Энэтхэгийн үндэсний конгресс нам Дели хотноо Азийн бага хурал зохион байгуулав. Тус бага хуралд бие даасан улсын хувьд Түвдийн төлөөлөгчдийг урьжээ. Гуравдугаар сарын 23-нд бага хурлын нээлт дээр түвдийн далбааг босгож, хананд өлгөсөн газрын зураг дээр Түвдийг тусгаар тогтносон улс хэмээн тэмдэглэсэн байв.[404] Үүнд Хятадын гадаад явдлын яам эсэргүүцэл илэрхийлэв. Тэгэхэд далбааг авч, газрын зурагт Түвдийг Хятадад “оруулан зурж”, түвдийн төлөөлөгчдөд бага хурлын ажилд оролцох зөвшөөрөл олгосноор асуудлыг нэг тийш болгон намжаасан байна.[405] Гэхдээ түвдчүүд ч, хятадууд ч сэтгэл дундуур үлджээ.

1947 оны наймдугаар сарын 15-нд Энэтхэг тусгаар тогтнолоо тунхаглав.Тус улсад Түвдтэй байгуулсан хэлэлцээрийн дагуу Их Британид оногдож байсан бүх эрх, үүрэг, хариуцлага шилжиж ирэв.[406] Лхас дахь төлөөлөгчийн газар, Гьянзе, Гарток, Ятун дахь худалдааны төлөөлөгчийн газар Энэтхэгийнх болов. Түвдийн эрх баригчид эхний үед түвдчүүд оршин суудаг Ладак, Дарджилинг, Сиккимийн тухайд маргаан үүсгэсэн боловч дараа нь энэ асуудлыг ирээдүйд шийдвэрлэхээр хойш тавьсан байна. Энэтхэг улс эхний үед түвдийг Энэтхэг болон хятадын хооронд завсрын орон хэвээр байлгахыг сонирхож байсан боловч хятадыг сөрөн зогсох хангалттай хүч бий билүү гэсэн асуулт байсан юм гэж түүхч Ц. Шакья үзсэн байна. Яагаад гэвэл Энэтхэг тухайн үед Их Британиас сул байв. Түүнээс гадна Энэтхэгийн удирдагчид эдийн засгаа өөд татаж, өөр хоорондынхоо тэмцлийг зогсоож, Пакистантай холбоотой асуудлыг шийдвэрлэх явдал тэргүүн зэргийн зорилт хэмээн үзжээ.

1947 оны аравдугаар сард Түвд санхүүгийн асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга В.Д. Шакабпа тэргүүтэй албан ёсны төлөөлөгчдийг Энэтхэг, Хятад, Англи, Франц, Итали, АНУ-руу илгээв. Төлөөлөгчдийн гол зорилт

бол эдгээр оронтой харилцаа тогтоох явдал байв. Түүнээс гадна, Энэтхэгээс английн өрийг рупигээр биш, доллар буюу фунт стерлингээр авч, зоос цутгах цалин цагаан мөнгө олж ирэхийг Шакабпад даалгажээ.

Төлөөлөгчдийг дээд удирдагчид: Делид – М.К. Ганди, Ж. Неру, Нанжинд – Чан Кайши, Вашингтонд – Ж. Маршалл, Их Британд – хаан VI Георг, ерөнхий сайд К.Р. Эттли нар хүлээн авч уулзсан байна. Төлөөлөгчдийг Нанжинд байх үеэр Үндэсний Ассамблей Хятадын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг сонгохоор хуралджээ. Төлөөлөгчид Ассамблейн хуралдаанд оролцоогүй боловч зарим судлаач эсрэгээр нотолдог юм.[407]

Төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан Энэтхэг, АНУ-д хятадын эрх баригчид эсэргүүцэл илэрхийлсэн байна. АНУ-ын төрийн департамент (ГЯЯ) хэрэг дээр хятадын засгийн газар Түвдийг удирддаггүй хэдий ч эрх зүйн хувьд Түвдийг захирах Хятад улсын эрхийг хүлээн зөвшөөрч байна хэмээн тайлбар хийх нь зүйтэй гэж үзжээ. Америкчууд ерөнхийлөгчийн хүлээн авалтад түвдийн төлөөлөгчдийг дагалдан хүрэлцэж ирэхийг хятадын элчин сайдад зөвшөөрөхөд хүрсэн бөгөөд түвдчүүд хүлээн авалтад оролцохоос татгалзжээ. Тэд ерөнхийлөгчийн оронд төрийн нарийн бичгийн даргатай (ГЯЯ-ны сайд) уулзсан байна. Төлөөлөгчид улс төрийн зарим амжилтад хүрсэн боловч тусгаар тогтнолоо албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж чадаагүй ажээ. Түвдчүүд Энэтхэгтэй худалдааны хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Төлөөлөгчдийн гишүүд Түвд паспорт, хил нэвтрэх бусад баримт бичигтэй байсан бөгөөд тэдний очсон бүх орон эдгээр баримт бичгийг хүлээн зөвшөөрчээ.

БНХАУ байгуулагдахаас нэг жилийн өмнө буюу 1948 онд түвдийн оршин суугчид сүүлт од олж харжээ. Үүнийг муу ёрын шинж тэмдэг гэж үзсэн бөгөөд 1910 онд Галлейн сүүлт од харагдсаны дараа хятадын цэрэг халдан орж ирсэн гэж хүмүүс ярьж байжээ.[408] Лхаст ирэх аюулаас ангижруулахыг хүсч мөргөл үйлдэж эхэлжээ.

❁

Түвд, Монгол улсууд Синьхайн хувьсгалын өмнөхөн тусгаар тогтнолоо зарлажээ. Монгол улсын хувьд энэ нь хятадуудыг улс оронд нь суурьшуулах гэсэн бодлоготой, Түвдийн хувьд – бас л колончлох эцсийн зорилго бүхий чин улсын түрэмгийллэлтэй холбоотой байв. Энэ бол монголчууд манжийн хааны сюзеренитет эрхийг хүлээн зөвшөөрч, харин түвдчүүд өөрийнхөө бүрэн эрхийг хязгаарлан манжийн ивээлийг ашиглахад гол үндэс болгосон тэдгээр зарчмыг зөрчсөн хэрэг болсон байна. Чин гүрэнд гарсан хувьсгал

болон түүний уналт бас нэг хууль ёсны үндэслэл бий болгосон нь: Чин гүрэнтэй монгол, түвдчүүдийн зохиосон харилцаа манжийн Айсинь Гиоро улстай харилцаж байсан харилцаанд үндэслэж байсан бөгөөд Айсинь Гиорог мөхөхөд дээр дурдсан харилцаа зогссон юм. Хятад нь чин гүрний бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд бусад хэсгүүдэд, тэр дундаа чин улсын нэг хэсэг байгаагүй тэдгээр оронд өнгөлзөх ямар ч эрхгүй юм. Засгийн эрхэнд гарсан үндсэрхэх үзэлт бүгд найрамдахчууд өрнөдийн ардчилалыг эзэнт гүрний "зэрлэгүүдийг" захирах эртний уламжлалтай хамтатган авч үзжээ. Гэвч Түвд хятадын мэдэлд байдаг хуурамч нэр зүүж, гоминьданы засгийн газар түүнийг "эргүүлж авах" гэж эрмэлзсэн ч Бүгд Найрамдах Хятад улсаас хараат биш хэвээр үлджээ.

Бүлэг 5

# Шашин ба соёл

Түвдийн ард түмний эртний шашин бол бон шашин бөгөөд энэ нь "гиншиж ярих" гэсэн хуучин Түвд үйл үгнээс гаралтай ажээ.[409] Энэ үгийн гарал үүслийн тухай өөр таамаглал ч байдаг юм. Боныг бөөгийн шашин[410] болон Ираны зороастрист шашинтай (дорнод болон дундад азийн эртний шашин)[411] холбоотой хэмээн үздэг байна. Энэхүү сүсэг бишрэл эртний хятадын итгэл үнэмшил бус, харин монгол угсаатнуудын буддын өмнөх үеийн бөөгийн итгэл үнэмшилтэй илүү төстэй юм.[412] Түвдийн хаант улсын амьдралд бон шашны үүрэг эртний монгол, түрэг, зүрчид улсуудад бөөгийн шашны гүйцэтгэж байсан үүрэгтэй адил төстэй байсан ажээ.[413]

Зарим мэдээгээр бол энэ шашин манай эриний эхээр, Соронзон Гомбо хааны үед Түвдэд бий болж, хөгжлийн хэд хэдэн шат дамжжээ. Домогт хэмээн хэлж болох бие хүн буюу Шангшунг орны Шэнраб Мивочиг энэ шашныг үндэслэгч гэж үздэг байна. Гэвч энэ нь Намхай Норов ринбүүчийн үзсэнээр бол алдаатай дүгнэлт бөгөөд Шэнраб Мивочигийн сургаалийг бон шашны бүх ном сударт Юндрун бон гэж нэрлэдэг, түүнээс өмнө боны олон уламжлал байжээ.[414] Энэ шашинд янз бүрийн үед үүсч бий болсон хэд хэдэн "давхарга" байдаг ажээ. Энэ шашныг баримтлагчдын нэг хэсэг Шэнраб Мивочиг Буддагийн үеийн хүн, нөгөө хэсэг нь Будда бол түүний хойд дүр, гуравдахь хүмүүс түүнийг хожим нь буддизмыг эсэргүүцэгч болсон бурханы шашны нэгэн атаач бандидын хойд дүр хэмээн үздэг ажээ.[415]

Түвдэд Бурхны шашинд орохоос өмнө тодорхой ёс жаяг үйлдэх, тодорхой ном судар унших, өөрөөр хэлбэл ёслолын үйлдэл хийхэд "бон" гэдэг нэр томьёо хэрэглэдэг байжээ. Тийм учраас бон шашин үүссэн цорын



Шэнраб Мивочи (Chandra, 1999)

ганц уг сурвалжийг олж тогтоох боломжгүй гэсэн үзэл бодол ч байдаг юм. Эртний Ярлунгийн хаант улсын үед мэдлэгийн арван хоёр салбарын бон шашин цэцэглэн хөгжиж байв.[416]

Түвдэд буддизм орж ирснээс хойш энэ шашин бонтой өрсөлдөж, давамгайлах болсон байна. Гэвч бон шашин буддизмын хэд хэдэн элемент, ялангуяа зан үйлийн тухайд нилээд баяжсан ажээ. Шэнраб Мивочийн намтрын нилээд сүүлч үеийн хувилбарууд Буддагийнхыг санагдуулдаг ажээ. Нацистууд бон шашнаас хас тэмдэг зээлдэж авсан гэж ч зарим судлаач үздэг юм байна.[417]

Энэ бол магадлал багатай, яагаад гэвэл хас тэмдэг нь янз бүрийн оронд тархсан эртний энэтхэг – арийн билэг тэмдэг юм. Жишээ нь, 1919 онд гаргасан зөвлөлтийн мөнгөн тэмдэгт дээр ч энэ тэмдэг бий. [418]

Түвдийн хааны шашны статус бон уламжлалаас үндэстэй юм. Бон шашны хуврагууд төрийн ёслолын ажиллагаа болон амьтанаар тахилга үйлдэхэд оролцохын зэрэгцээ төр удирдахад нөлөөлдөг байжээ. Хаан жил бүр сармагчин, хонь болон нохойгоор бага тахилга үйлдэх бөгөөд гурван жилд нэг удаа хүн,адуу, үхэр,илжиг тэргүүтнээр их тахилга тахидаг байжээ. Мал амьтаны хөлийг хугалж, гэдэсийг нь хагалж, дотор эрхтнийг нь гаргаж тавих үед бон шашны хуврагууд: “гэмт хэрэгтнүүд ийм болог” хэмээн хэлдэг байжээ.[419] Тийм уламжлал бон шашны эртний чиглэлүүдэд байжээ. Шенраб Мивочи цус урсгасан аймшигт тахилгыг халж, үүний оронд гурил, цагаан будаа болон юти (исгэсэн барашки) хэрэглэдэг болсон байна.[420]

Түвдчүүд бурханы шашинд орсон нь тэдний зан үйл болон ёс суртахуун цаашид зөөлрөхөд тус дөхөм болжээ.Амьд бүхэнд хор учруулахгүй байх явдал энэ шашны нэг гол зарчим болжээ. “Түвд хүн бүрээс гэрэлтсэн шашны ёс үнэхээр сэтгэл хөдөлгөх ажээ. Би энэ оронд хэсэг хугацаагаар байсны дараа юу ч бодолгүйгээр ялаа алж чадахаа больсон бөгөөд хэзээ ч нутгийн оршин суугчдын дэргэд хорхой шавьж дэвсэж чаддаггүй болсон. Тийм нөхцөлд нутгийн оршин суугчдын зан ааль үнэхээр уян наалинхай байна. Хэрэв хээр зугаалж наргих үед хэн нэгний өмссөн хувцасан дээр

шоргоолж авирч гарсан байвал түүнийг болгоомжтой нь аргагүй авч, газарт тавина, хэрэв аягатай цайнд ялаа орвол яаж ийгээд л үхүүлэхгүй гаргахыг эрмэлзэх бөгөөд тэр ялаа өөд болсон эмэг эхийн нь сүнс явж байж ч мэдэх юм гэж түвдчүүд үздэг ажээ. Хүмүүс өвөл цөөрмийн загас хөлдөж үхэхээс болгоомжилж тэндхийн мөсийг хагалдаг, хэрэв зун цөөрмийн ус хатаж ширгэвэл тэндхийн загас жараахайг устай саванд хийж цөөрмийн ус эргэж дүүрэхийн цагт буцааж усанд нь тавьдаг юм. Ингэснээр аврагчид маань сүнс, сүлдээ баярлуулдаг ажээ. Аливаа хүн амьтаны амь аварч л байвал өөрийгөө төдийчинээн аз жаргалтайд тооцдог ажээ”[421] гэж Г. Харрер дурсан бичжээ.

Лхатотори Ньенцэн хааны (манай эриний IV зуун) үед Түвдэд бурханы шашин дэлгэрч эхэлсэн байна. Буддын уламжлал ёсоор бол энэ хааны үед түүний Юмбулаган шилтгээний дээвэр дээр тэнгэрээс ариун номын хуудсууд, алтан уур (уур нүдүүрийн), “ум ма ни бад ми хум” хэмээх маанийн зургаан үсэг унажээ. Эдгээр эд зүйлсийн утга учир Лхатоторигоос хойшхи тав дахь хаанд тодорхой болно гэсэн үгс тэнгэрээс сонсогдсон байна.

Лхатотори хаан бон шашны лам хуврагуудаас асуугаад ч энэ үгийн утгыг ухаж ойлгож чадаагүй ажээ. Ингээд тэрээр эдгээр эд зүйлсийг газар ухаж булахыг тушаасан бөгөөд түүний албат нар тэдгээрийг хуучин эд зүйлсийн хамт замбараагүй шидлэн газарт булжээ. Үүний дараа улс оронд өвс ургамал ургахаа больж, мал олноороо үхэж үрэгдэн өлсгөлөн зовлон, өвчин эмгэг нүүрлэсэн байна.[422] Тэгэхэд “ариун үйлст таван сайхан эр гарч ирж” дээр дурдсан эд зүйлсэд хүндэтгэлгүй хандсан явдал гай барцадын учир шалтгаан болсон байна хэмээн хэлжээ. Ингээд тэр таван залуу эр алга болжээ. Хаан дээр дурдсан эд зүйлсийг бүх хүнд үзэгдэхээр газарт тавих тушаал буулгажээ. Ард олон тэдгээр эд зүйлст хүндэтгэлтэй хандсаны дараа зовлон гамшиг зогсчээ.

Лхатотори Ньенцэнээс хойшхи тав дахь хаан бол Соронзон Гомбо байв. Тэрээр мөн эдгээр эд зүйлсийн зориулалтын тухай бон шашны лам хуврагуудаас олж мэдэж чадсангүй. Ингээд тэр хаан түвдчүүдийг Энэтхэг рүү явуулсан байна. Энэ нь түвдэд бурханы шашин дэлгэрэх эхлэл тавьсан байна. Энэ хэрэгт Соронзон Гомбо хааны хоёр хатан бурханы шашинт Бхрикути, Вэньчэн нар буюу балба, хятад гүнж нар чухал үүрэг гүйцэтгэжээ. Бурханы шашинтнууд Бхрикутийг Ногоон дарь эх, Вэньчэнийг Цагаан дарь эхийн хойд дүр хэмээн үзэж хүндэтгэх ажээ. Энэ хоёр гүнж бурханы шашны нандин шүтээн болох эд зүйлсийг Түвдэд авч иржээ. Ийнхүү авч ирсэн ариун шүтээнүүдэд зориулж Рамоче Цуглаканг, Тинланг сүмүүдийг



Бадамжунай (Chandra, 1999)

барьсан бөгөөд хожим нь Жокан нэрээр алдаршсан байна. Соронзон Гомбо хааны үед болон түүнээс хойшхи бараг нэг зуун жилд бурханы шашин Түвдэд сүрхий их үүрэг гүйцэтгээгүй гэж өрнөдийн болон хятадын зарим зохиогч үздэг байна. Нилээд хожуу үеийн түвдийн эх сурвалжуудад өөр санаа бодол илрэн гардаг юм. Бурханы шашныг оруулсан явдал энэ хааны гол гавьяа хэмээн дээрх эх сурвалжуудад тэмдэглэсэн байдаг. Соронзон Гомбо, Тисон Дэцэн, Ралпачэн нарыг “шашны хаад” хэмээн нэрлэдэг нь жирийн хэрэг бишээ. Соронзон гомбо хааныг насан өөд болсноос хойш IX зуун хүртэл бон болон бурханы шашны туган дор Түвдийн эрх барих бүлгийнхний хооронд өрсөлдөөн үргэлжилжээ.

Тисон Дэцэний үед Түвд аугаа их гүрнүүдийн нэг болсон байлаа. Түүний үед Шантаракшита, Бадамжунай зэрэг буддын гарамгай багш гэгээнтнүүдийг урьж ирүүлсэн байна. Лхасаас 137 километрийн зайтай газарт Самье хийд байгуулав. Тэр хийдэд түвдийн Бурхны шашны анхны лам нар шавилан суужээ.

Хаан буддын сударыг Түвд хэлэнд орчуулан гаргахыг тушаасан байна. Түвдэд мөн Хятад, Хотаны бурханы шашин номлогчид байжээ. 781 онд буддизмыг Түвдийн төрийн шашин болгож зарлав. Хааны зарлигийн бичвэрийг чулуун баганан дээр сийлж, Самье хийдэд байрлуулав. Бон шашин мөрдлөг хавчилгад хэлмэгдэж, тус шашны олон ном бүтээлийг устгав. 791–794 онд энэтхэгийн бурханы шашныг номлогч Камалашила, хятадын чань-буддийн шашны номлогч алдарт Хэшан нарын хооронд түүхэнд нэрд гарсан ном хаялцаан болсон байна. Хэшан гэдэг бол хүний нэр биш, харин шашны цол бөгөөд түүнийг орчуулахад “лам” хэмээх үг ажээ. Түүний лам нэр нь Махаянадэва юм. Энэ ном хаялцааны тухай зөрчилтэй мэдээлэл байдаг юм. Нилээд хожуу үеийн түвдийн дурсгал бичгүүдэд Камалашилаг ялсан гэж тэмдэглэн үлдээжээ. Ямар ч байсан Хэшаныг нутаг буцаах шийдвэр гарсан байна. Ийнхүү түвдэд бурханы шашны энэтхэг чиглэл хөгжжээ.

Тисон Дэцэний залгамжлагчдын үед бурханы шашин байр сууриа бэхжүүлэв. Бон шашныг ашиглаж хаан болохыг эрмэлзсэн хан хүү

Дармаагийн үед энэ шашны байр суурь сулрав. Хан хүү лам-сайд нарын нэгийг, дараа нь хааныг өөрийг нь хөнөөх хуйвалдаан зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.[423] Дарма хаан болмогцоо бурханы шашны сургаал, номын зан үйлийг хориглож, сүм хийдийг хааж, бурхны шашинтнуудыг цаазаар аваачна хэмээн сүрдүүлж, итгэл үнэмшлээсээ татгалзахыг лам нарт тулган шаардав. Тэрээр Төв Түвдэд бурханы шашныг устгаж чадсан боловч бусад нутагт түүний оролдлого амжилтад хүрч чадаагүй ажээ.[424] Ард олон хийгээд шашинтай харьцах хааны хандлага хүмүүсийн санаанд нийцсэнгүй. Тиймээс түүнийг Ландарам (“мал Дарма”) хэмээн дуудах болсон байна. Тэрээр энэ нэрээр түүхэнд орсон байна. Дарма хаан 842 онд Лхалун Пэлги Доржийг хөнөөв. Тэрээр лам хүн биш байсан гэж түүхчид бичдэг юм. Үнэн хэрэгтээ тэр ваар гэлэн гэцлийн сахил хүртсэн, даянчлан агуйд бясалгал үйлддэг байжээ.

Дараачийн хоёр зуун жилд Түвдийн төр улс уналтад орж, харин бурханы шашны нөлөө хүчтэй болов. X зуунд Сакьяд төрийн эрх мэдэл шашныхтай нийлэх үйл явц эхлэв. Эрх баригч бүлгийн гишүүд бурханы шашны багш нар болж, сүм хийд байгуулж эхэлсэн байна. X–XII зуунд Түвдэд бурханы шашны хэд хэдэн сургууль (чиглэл) төлөвшин тогтов. Эдгээрийг одоо ч гол төлөв “сектүүд” хэмээн нэрлэж байна. Орос хэлтэй ард түмнүүдийн утга зохиолд хэрэглэдэг тодорхойлолтоор бол сект гэдэг нь үндсэн сургаалиас тасарч гарсан шашны бүлэг мөн. Гэвч үнэн хэрэгтээ эдгээр сургууль буддын шашнаас тасарч гаралгүйгээр түвдийн бурханы шашныг бүрэлдүүлжээ. Монголын Бурхны шашны нэр томьёонд эдгээр 4 төрлийн сургуулиудыг Нимава буюу Улааны ёс, Сажаа, Гаржүд, Гэлүгийн дөрвөн ёс хэмээн нэрлэдэг. Түвдийн Бурхны шашны эдгээр 4 том урсгалын их мэргэд гэгээнтнүүд энэхүү 4 ёсны үндсэн үзэл тааллыг нэг хэмээн үздэг юм.

Эдгээр сургуулийн хамгийн ахмад нь хожим Ньингма (хуучин орчуулгын “сургууль” гэсэн үг) нэр авсан бөгөөд бадамжунайд хамаарна. Сүүлд гарч ирсэн бүх сургуулийг Сарма (шинэ орчуулгын “сургууль” гэсэн үг) хэмээн нэрлэгдсэн байна. XI зууны 30-аад онд Түвдийн баруун зүгийн Нгари орны захирагчийн урилгаар Энэтхэгийн их мэргэн, бурханы шашны алдарт номлогч Жовужи Балдан Адиша Түвдэд морилсон ажээ. Атиша болон түүний шавь Домтонпа нар Түвдэд үлдсэн амьдралаа өнгөрүүлэхдээ Гаадамба ёсны сургуулийн (чиглэлийн) үндсийг тавьсан байна. Атишын сургаалийг Түвдийн бүх сургуульд хүндэтгэн үздэг байна.

Энэтхэгт алдарт багш Наропа, Майтрипа нараас шашны сургааль



Атиша (Chandra, 1999)



Марпа (Chandra, 1999)

хүртсэн Марпа (1012–1097) Гарма сургуулийг үндэслэгч гэж үздэг билээ. 1155 онд кагью чиглэлийн гол хийд Цурпху хийдийг үндэслэгч Дуйсум Кэнпагийн шавь нар Кагью сургуулийн гол салбар болох Гармагаржид ёсыг үүсгэжээ.[425]

1073 онд Гончигжалцан Төв Түвдийн баруун хэсэгт Сажа хийд байгуулсан бөгөөд Түвдийн бурханы шашны бие дааж гарсан анхны сургуулийн нэгийг энэ нэрээр нэрлэсэн байна. Тэрээр Энэтхэгээр аялан явж, тэнд янз бүрийн багш нараас сургааль хүртсэн Дрогми Шагжаа Ишийн шавь юм. Сажа ёсны лам Кунпан Тукдже Цондру 1294 онд жомонан гэдэг газарт мөн ийм нэртэй хийд байгуулсан бөгөөд жонан сургуулийн нэр ч үүнээс гарчээ. Хожим нь Шигазе хотоос баруун тийш орших Тактен Пунцоглин хийд энэ сургуулийн гол хийд болсон байна. Жонан сургуулиас шашны хэд хэдэн гарамгай сэтгэгч, эрдэмтэн төрж гарсан байна. Энэ бол Долбоогийн Шаравжалцан, Жавзан дараната (Жецун Таранатха) болон бусад хүмүүс юм. даранатийн хойд дүр Жавзандамба хутагт I Занабазар Гадаад (ар) монголын Бурхны шашны тэргүүн болжээ. Тэр үеэс хойш Монголд шарын шашны засаглал тогтсон байна.

Монголын эзэнт гүрний үед Түвдэд Сажийн ёсны дээд лам нарын засаглал бүрэлдэн тогтов. Монголын эзэнт гүрний төгсгөл үед Түвдийн засгийн эрх Жанчивжалцан болон түүний залгамжлагчдын Гарма ёсны сургуулийнханд шилжжээ. XIV зууны эхээр Түвдийн алдарт түүхч, шашны зүтгэлтэн Будон Ринчендуб түвдийн бурханы шашны сургаалийг цэгцэлж, “Түвд, Энэтхэгийн бурханы шашны түүх” хэмээх бүтээл туурвижээ.[426] 1346 онд Гунгаадорж “Улаан түүх” хэмээх ном бичсэн нь түвдийн түүхийн чухал

эх сурвалжуудын нэг болсон байна. XIV зууны эхээр түвдийн түүх, шашны асуудлаар бусад хэд хэдэн чухал бүтээл гарсан байна.


Гончигжалцан (Chandra, 1999)


Зонхов (Chandra, 1999)

Бурханы шашны томоохон зүтгэлтнүүдийн нэг бол Зонхов (Цонкапа) Лувсандагва (1357–1419) юм. Монголчууд Зонхабаг “Богд лам” хэмээн хүндэтгэн нэрлэдэг юм. Богд лам Түвдийн Амдо нутгийн Зонхаба буюу Мангирт гэдэг газар мэндэлжээ. Чойже Дондов Ринчен долоон настай жаал хүү Зонховд өөрийнхөө агуйд очирт хөлгөний авшиг хүртээсэн байна. Дараа нь Дондов Ринчин тэр хүүг 1349 онд өөрийн үндэслэн байгуулсан хийддээ авч иржээ. Зонхов эхний шатны сахил хүртэж, уг хийдэд 16 нас хүртлээ шавилан суусан байна.

Тэрээр бага залуу насандаа авшиг хүртэж, оюун ухааныхаа мэдлэгийг өргөжүүлэхийг эрмэлзэхдээ ариун гэгээн газруудаар аялан явж, янз бүрийн хийдэд эрдэм номын хишиг хүртжээ. Гайхамшигтай ой тогтоомжтой залуу лам Зонхаба том том судар номыг алдалгүй цээжээр уншдаг байв. Зонхов 25 насандаа ламын бүтэн авшиг хүртэв. Тэрээр гүн ухаан төдийгүй йог, бясалгалаар шургуу хичээллэж, бусдыг ч ном эрдэмд сургасан бөгөөд түүний шавь нарын тоо нэг мянга гаруй болжээ. Зонхов богд бурханы шашны асуудлаар хэд хэдэн тулгуур бүтээл туурьвижээ. Тэдгээрээс хамгийн алдартай нь “их бодь мөрийн зэрэг” (“Ламрим Ченмо”) хэмээх бүтээл юм.[427] Энэ бол хэрэг дээр хэрэгжүүлж буйгаа улам боловсронгуй болгох журмаар илэрхийлсэн буддизмын нэг ёсны тайлбар мөн билээ.[428]

Зонхов түвдийн бурханы шашны шинэ сургууль (чиглэл) болох Гэлугвагийн ёсыг үндэслэжээ. Бурханы шашны дэг жаягийг илүү хатуу



Сэра хийд: 1 – 1938 онд (Bundesarchiv, Bild 135-S-13-06-35/foto: Ernst Schaefer License CC-BY-SA 3.0)



2 – “Урт наслалтын гурван бурхны” – Жүгдэрнамжил, Цагаан Дарь эх, Аюуш – баримал; тэдний дээд талд түвдийн бурханы шашны 108 боть “Ганжуур” сударыг мөн төдий тооны хүрд болгон тавьсан нь харагдаж байна



3 – Хийдийн хашаан дотор байгаа эвдэрсэн цутгамал бурхад, 1991 онд (Norbulingka Institute Archive, Dharamsala/NgodupTsoknyid)

сахин мөрдөхөд чиглэсэн шинэтгэл хийх явдал энэхүү чиглэлийн гол зорилго байв. Гэлугийн сургаальд бусад чиглэлийн сургуулиудын олон дээд ололтуудыг багтаасан байна. Гэлугва сургуулийн талыг баримтлагчид Түвдийн хэд хэдэн том сүм хийдүүдийг үндэслэн байгуулсан нь: 1409 онд Гандан, 1416 онд Дрепун, 1418 онд Сэра, 1447 онд Дашлхүмбэ хийд тус тус боссон байна. Эдгээр хийд улам өргөжиж, нэг хийдийн лам нарын тоо гэхэд л хэдэн мянга болсон байв. 1432 онд Гандан хийдийг Кхедуб Чже тэргүүлж байсан бөгөөд ирээдүйд түүнийг I Банчин лам хэмээн үзэх болсон байна. Түүний үед Гандан хийдэд тусгай павильон (үзмэрийн танхим) байгуулж, Зонховын н чандар бүхий бортого байрлуулжээ. Зонховын шавь Гэдундуб 1447 онд Дашлхүмбэ хийдийг үндэслэсэн байна.

Гэлугва сургуулийн лам Содномжамц монголын Алтан хаанаас Далай лам хэмээх цол авсны дараа түүний түрүүчийн хоёр дүр: Гэндэнжамц (1475–1542), Гэндэндүб (1391–1447) нарт энэ цолыг нэхэн олгосон байна. Содномжамц бол III Далай лам юм. Далай лам нар нь бодьсад Жанрайсэгийн газарт хувилж ирсэн дүрүүд мөн ажээ. Тэрээр ийнхүү Далай ламд илрэн гарч байгааг нарны дүрс усны дусалд харагдаж байгаатай зүйрлэн үзэж

болох билээ. Гэхдээ Далай лам бүр нь шууд Жанрайсэгийн биш, харин өмнөх хүнийхээ хойд дүр нь болж байдаг ажээ. Дахин төрөх энэ ёс маш эрт дээр үеэс уламжлалтай ажээ. 1582 онд Содномжамц монголын хааны өргөө рүү явах замдаа Зонховын төрсөн газарт Гүмбум хийдийн суурийг тавьсан байна. Энэ хийд Гэлугва ёсны сургуулийн гол хийдүүдийн нэг болжээ.

IV Далай лам Ёндонжамцыг Монголд Чингис хааны алтан ургийнхнаас тодруулж, Түвд рүү явуулсан тухай дээр дурдсан билээ. Түүний багш Дашлхүмбэ хийдийн лам Лувсан Чойжин Банчин лам хэмээх цол авсан байна. Банчин лам нар бол Бодьсад Арьяабалын номын "эцэг" Амитабхи бурханы замбуутивд төрсөн хойд дүрүүд ажээ. Гэхдээ энэ нь Банчин лам бол Далай ламаас "илүү чухал" гэсэн үг биш юм. Уламжлал ёсоор бол тэдний ахмад нь залуугийнхаа багш гэж тооцогддог байжээ. Зонховын шавь Кедуб Пэлсанг (1385–1438) ламыг I Банчин лам гэж зарлажээ. Соном Чоглан (1439–1504), Лувсан Дондов (1505–1566) нарыг хоёр, гуравдахь хойд дүрүүд хэмээн хүлээн зөвшөөрсөн байна. Ингэхлээр Лувсан Чойжин бол IV Банчин лам болж байгаа юм. Энэ нөхцөлд дээр тэмдэглэснээр хойд дүрүүдийг тодруулж хүлээн зөвшөөрдөг Түвд уламжлалаар бол Лувсан Чойжингаас л Банчин ламуудыг тоолж эхэлж байгаа юм. Шигазе хотын ойролцоох Дашлхүмбэ хийдийг Банчин ламын суух гол хийд хэмээн үзэх болсон байна.

Дундад зууны үеийн Түвдэд гарч байсан өөр хоорондын тэмцэл заримдаа шашны өнгө аястай болж байсан тухай дээр өгүүлсэн (2-р бүлгийг үзмүү) билээ. Үүнийг гол төлөв түвдийн Бурхны шашны янз бүрийн "сектийн" хоорондын тэмцэл гэж үздэг юм. Бодит байдалд бол отог омог хоорондын энэ тэмцлийн гол зорилго феодалын тархай бутархай үеийн элдэв үйл явдлуудтай л холбоотой юм. Энд дундад зууны үеийн европын шашин хоорондын дайнтай гадаад талаараа адил төстэй зүйлүүд ажиглагдах бөгөөд энэ нь хүмүүс өөрсдийгөө хамгийн энх амгалан шашны талыг баримтлагчид хэмээн үзэж хомхой сувьдаг санаа, хүчээр түрэмгийлэх үзэл бодлоо зөвтгөх гэж эрмэлзэж байсныг илтгэн харуулж байгаа юм.

Бурханы шашин Түвдээс умард зүгийн Монголд дэлгэрэв. 1587 онд Халхын томоохон хийд Эрдэнэ зууг аравнайлсан байна. Ингээд бурханы шашны сүм, хийдийн тоо улам өсөв. XVII зуунд ойрдууд бурханы шашинд оров. XVII зууны дунд үед Түвдэд боловсрол эзэмшсэн Зая бандидын соён гэгээрүүлэх үйл ажиллагаа эхэлсэн байна. Гэлугвагийн ёс Орост амьдарч байсан халимаг, буриад, тува зэрэг монгол угсаатны дунд ч дэлгэрэв. Бусад аливаа шашны нэгэн адил Орост дэлгэрсэн бурханы шашин хэдэн зуун

жилийн дотор орон нутгийн шинж чанартай болсон ч үзэл баримтлалын хувьд өөрчлөгдөөгүй ажээ: Монгол ба Орос улсын уламжлалт буддизм бол ямар нэгэн орон нутгийн чиглэл биш, чухамдаа түвдийн бурханы шашин мөн билээ.

Түвдийн бурханы шашны сургаалийг илэрхийлэх явдал энэ номын гол зорилго биш билээ. Гэхдээ л энэ шашны зарим нэг чухал шинж чанаруудыг тэмдэглэх хэрэгтэй юм. Бодит баримтууд бол хамгийн шилдэг эх сурвалж болдог билээ. Иймд би XIV Далай ламын өргөн олонд нэрд гарсан номуудаас иш татаж байна.[429]

Бүх шашныг бурхан бол ертөнцийг Бүтээгч гэж нотолдог теист, үүнийг нотолдоггүй теист биш гэсэн хоёр бүлэгт хуваан авч үздэг байна. Эхний бүлэгт жишээ нь, христосын, исламын, иудийн, индуизмын, хоёрдугаар бүлэгт буддын ба жайнизмын шашин орно. Бурханы шашны бусдаас ялгарах шинж чанар бол нэгдмэл бөгөөд үл өөрчлөгдөх сүнс байдаггүй хэмээн нотолдогт оршино.

Буддагийн сургааль гэдэг бол шаштир, очирт хөлгөн буюу монголоор сударын ёсон болон нууц тарний ёсыг хослуулсан үзэл баримтлал мөн. (Бурхны сургаал бол ёс зүй, оюуны төвлөрөл, билиг барамид гэсэн үлэмж дээд гурван суртахуунаа дагаад “винай- дэг журам”,” “судар-буддын яриа шаштир”,” абхидхарм буюу илт ном- метафизик онол” гэсэн 3 том хэсэгт хуваагддаг болой). Гэгээрэлд хүрсэн Будда гурван том цуврал сургааль бүтээжээ. Үүнийг Номын хүрдний гурван ай сав хэмээн нэрлэдэг бөгөөд эхний үед Будда Дөрвөн ариун үнэний тухай номлолыг илэрхийлж Номын хүрд эргүүлсэн байна: дунд үед бүх үзэгдлийн өөрөө оршин байх ахуй үл оршихуйн тухай номлол, сүүлчийн үед жинхэнэ ба жинхэнэ биш оршихуйг зааглах тухай номлолыг айлджээ

Будда мөн очирдарын дүрд (очирт хөлгөний дүр) хувилж, гэгээрлийн замаар аль болох түргэн дэвших нөхцлийг бүрдүүлсэн аргуудын систем болох Агийн ёсны сургааль айлдаж байжээ. Түвдийн уламжлалд дээд хөлгөн гэж үздэг Очирт хөлгөн буюу Важраяна нь Их хөлгөнд багтдаг ажээ. Буддагийн шавь нарын бичиж авсан Бурхан багшийн айлдварууд бүгд шаштирын эхлэлийг тавьжээ. Эдгээр шаштирын Түвд орчуулга бол олон боть “Ганжуур” судрыг бий болгосон байна. Түвдийн буддизм бол анхны энэтхэг сургаалийн цэвэр хувилбар мөн бөгөөд бурханы шашны хоёр гол чиглэл – Их хөлгөн, Бага хөлгөний уламжлалыг өөртөө шингээжээ. Буддизмын дотор онол,практикийн 2 үндсэн тогтолцоо байдаг бөгөөд нэг нь Бодгалийн хөлгөн буюу Хинаяана (Бага хөлгөн), нөгөө нь Бүх нийтийн

хөлгөн буюу Махаяна (Их хөлгөн) юм. Энэ хоёр чиглэлийн нэг болох Махаянагийн (их хөлгөн) онцлог шинж бол өөрийнхөө төлөө биш, харин хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэхийн тулд гэгээрэлд хүрэх эрмэлзэл юм. "Би үгүй"-г ухаарах үзлийг илэрхийлдэг онол үйлдлийн тогтолцоог Махаяна Их хөлгөн гэнэ.

Бүх амьд бодгаль аливаа үзэгдлийн жинхэнэ мөн чанарын тухай сургаалийн ачаар л аливаа зовлонгоос ангижирна. Юуг хүлээж авах вэ, юуг няцаах вэ гэдэгт сургаж байж л бодгалийг зовлонгоос ангижруулж болно. Гэхдээ бусдыг сургахын тулд юуны өмнө өөрөө үүнийг мэдэж, ойлгосон байх ёстой, зөвхөн Будда л ингэж чадна. Тийм учраас зорилгодоо хүрэх буюу хамаг амьтны сайн сайхан байдалд хүрэх нэг гол болзол бол Бурхан болох явдал мөн.

Буддагийн сургасан дөрвөн ариун үнэн бол зовлон, түүний учир шалтгаан, зовлонг арилгах нь, зовлонг гэтлэн давах ариун зам зэрэг болно. Ухамсар гэдэг бол үхэлд ч тасрахгүй тийм урсгал мөн.

Тийм учраас хүмүүс дахин төрдөг ажээ. Буруу муу үйлдлүүд ухаан задраагүйгээс болж хуримтлагдан ухамсрын урсгалд энэ буюу өөр ертөнцөд дахин төрөх далд боломж бий болгодог байна. Зовлонгийн эх үүсвэр хоёр байдаг: гутрал ба гутранги үйлдэл. Гол зургаан гутрал байна: хэт татагдах явдал, дайсагнал, ихэрхэх зан, харалган байдал, эргэлзээ тээнэгэлзэл, буруу үзэл зэрэг болно. Гутралын эдгээр шинж чанар хий үзэгдлийн шалтгаан болдог байна. Хамтын чанартай ийм хий үзэгдэл ухамсар дахин төрөх сансрын нэг ертөнц,[430] тэнгэрийн орон,[431] асур, хүмүүс, өлсгөлөн сүнс, амьтад, тамын орнуудыг бүрдүүлнэ. Энд сансрын зургаан (заримдаа тав) ертөнц, гутралын (харанхуйн, үзэн ядалтын, шунал тачаалын) гурван гол ертөнц, үл хамаарах гарвалын арванхоёр үе (өөрөөр хэлбэл сансарт оршихуйн учир шалтгаан-үр дагаварын хүчин зүйлүүдийн) ба сансрын хил хязгаараас халих замыг тус тус дүрслэн харуулжээ.

Гутралыг арилгаснаар эрх чөлөө буюу Нирваан дүрд хүрч, дараа нь Бурхан болдог байна. Нирваан дүр гэдэг бол эс оршихуй биш билээ. XIV Далай лам:[432] "Нирваан дүр гэдэг бол шууд утгаараа зовлонгийн хил хязгаарын гадна талд орших байдал мөн бөгөөд оршихуйн эргэх тойргоос чөлөөтэй байх явдалд хамаарна" гэж цохон тэмдэглэжээ. Түүнийг дүрслэн бичих аргагүй, яагаад гэвэл аливаа ойлголт болон илрэхийлэлд гагцхүү сансарт оршино.

Үйл ба үйлийн үр (санскрит: карма) дагавар ашиг тустай ба ашиг тусгүй гэж байна. үйлийн үрийн хууль гэдэг бол учир шалтгаан, үр дагаварын

хууль мөн. Хэрэв гутралын ертөнцийг (санскрит: скандха) үгүй болговол түүнтэй холбоотой зовлон гамшиг арилж, ангижралт хэрэгжинэ.

Шашин номын үйлгүйгээр ухамсараа цэвэр ариун болгож, дахин төрөх давтамжийг зогсоох боломжгүй юм. Бурхад нэгэн цагт бусадын л адил бодгалиуд байв. Шагжмун бурхан бол тэдний нэг билээ.

Гол өмөг түшиг, хамгаалагч бол Бурхан, Ном[433], Хуврагийн чуулган буюу гурван эрдэнэ билээ. (хамтын оюун ухаан мөн). Гутралын оронгүйгээр гэгээрлийн зам гэж үгүй. Гэгээрэлд хүрэхийн тулд бие хүнийг бүрэлдүүлж буй бие – сэтгэцийн үйл ажиллагааны зарчмаар нэгдсэн элементүүд буюу гутралынхаа урсгалд Бурханы сургааль оруулж өгөх хэрэгтэй юм. Ингэхийн тулд биеийн болон үг хэлний бүх үйлдлийг номд урвуулах хэрэгтэй. Гэгээрэлд хүрэхийн тулд ахуй амьдралыг орхиж магад гарахуй сэтгэлийг үүсгэх хэрэгтэй. Ингэхгүйгээр хэн нэгэн хүн хичнээн ч бясалгал үйлдээд, хичнээн ч ном судар уншаад, сүм хийдэд хичнээн ч жил суугаад нэмэр болохгүй. Практикт чухамдаа оюун ухаан л чухал хэрэгтэй. Ёс бус амьдралын хэвшил шашны практиктай үл нийцнэ. Бүх зүйл учир шалтгаан, нөхцөл байдлаас үүсдэг болохоор ухамсарынхаа урсгалд Бурханы сургаалийн үнэт зүйлстэй ураг төрөл болох учир шалтгааныг оруулж ирэх хэрэгтэй юм.

Үүний тулд дээд ёс суртахуун, дээд бясалгалын төвлөрөл, дээд мэргэн ухаан хэмээсэн Гурван практикийг нэгтгэсэн замаар урагшлах хэрэгтэй. Ёс суртахууны үндсэнд амьтны амь хөнөөх, хулгай хийх, завхайрах, худал хэлэх, хараал зүхэл тавих, бүдүүлэг авир гаргах, хоосон чалчих, атаархах, хорон муу санаа өвөрлөх, буруу үзэл бодолтой байх зэрэг 10 хар нүглийг тэвчих үйл оршино. Эдгээр 10 хар нүглийн эсрэг 10 цагаан буян байна. Эдгээр буянт сайн үйлийг мөрдөх явдлыг ёс суртахуунт явдал хэмээн нэрлэдэг байна.

Эхний үед бясалгах төвлөрөл гэдэг бол аливаа нэгэн зүйлд нэг чиглэлээр төвлөрөх чадварыг эзэмших явдал мөн. Хэрэв ингэхийн зэрэгцээ буддийн шашны Орон зайг хүлээн авч чадвал буддийн шашны практик болж байгаа юм. Дээр дурдсан аливаа зүйлс гэдэгт Бурхан багш буюу бусад гэгээрсэн бодгалиудын хөргийг ашиглаж болно. Мөргөл үйлдэх болон ухаан төвлөрөх үед дээр дурдсан хөрөг дүрүүд нь тэдгээрийн цаад утга болж буй бодгалиудад ухамсараа чиглүүлэн төвлөрүүлэх боломж олгож байгаа юм.

Важраяны (тантар ) практик бол бусадтай харьцуулахад сансраас ангижирахын илүү хурдан зам мөн. Энэ нь бясалгал, йогийн тусгай аргын тусламжтайгаар ухамсар болон биеийн янз бүрийн эрчим хүчийг Сэрэхүйд



Цамын бүжгийн хэсгээс, 1938 он Лхас хот (Bundesarchiv, Bild 135-S-13-06-35/foto: Ernst Schaefer License CC-BY-SA 3.0)

хүрэхэд үндэслэнэ.

Хоосон чанар болон бодь сэтгэлийг ухааран авахын үүднээс хэрэглэдэг бясалгалын аргуудаас гадна бие махбодийн янз бүрийн цогц хэсгүүдийг бясалгалд ашигладаг илүү боловсронгуй арга барилыг Очир хөлгөнд хэрэглэдэг. Ур чадварын өндөр түвшинд гагцхүү иогийн нарийн дасгалуудыг хийж хүрэх бөгөөд эдгээр дасгалууд нь биеийн амин эрчмийн төвүүд буюу хүрдэнд (чакра) зориуд нэвтэрч билиг оюун, бие хоёрыг

нарийн зохицуулснаар мунхагийн үндсийг танин барих явцыг түргэсгэж, төгс гэгээрэлд хүрдэг онцлог нь зөвхөн Очир хөлгөнд байдаг.

Агийн ёсны бичвэрүүд болон бурханы зурагийн урлагт түрэмгий шинж чанарыг дүрслэн үзүүлдэг нь шашны нилээд эртний хэлбэрүүдийн буддийн шашинд эрэгцүүллийн аргаар гаргаж ирсэн сэдвүүд мөн. очирт хөлгөний шашны бурхадын янз бүрийн дүрслэлүүд бол бохирдсон элементүүд болон үндэслэлүүдийг ариутган цэвэрлэх аргуудыг тусган харуулсан дүрүүд юм. Бурхадын амгалан тайван болон уур хилэнтэй дүр,нүүр царай болон гар хөлийн тоо, гол болон дагалдах дүрүүдийн тоо, дур сонирхол,авьяас чадвар, сэтгэлгээний хэлбэр болон суралцагчдын чадварын ялгаанд нийцдэг байна. Энэ бол "хүмүүс шүтэж биширэн мөргөдөг чөтгөр шуламууд" бишээ. Амьтаны амь тасалж, үхсэн биеийг тас татан идэж буй зурагууд бол Ангижралд хүрэх зам дахь саад тотгоруудыг ялан дийлж, ухамсарыг ариусгагч оюун санааны хүчийг илэрхийлэн гаргаж буй хэрэг мөн. Оюун санааны хүч гэдэг бол ухамсарыг бүрхэгтүүлэн харлуулах дотоодын дайснууд руу хийх дайралтыг илэрхийлэн гаргаж байгаа бөгөөд дотоод сэтгэлийн дайсан гэдэгт сэтгэлийн харанхуй байдал, үзэн ядалт, дур тачаалыг оруулж болно. Үүнийг дотоодын (оюун санааны) биш, харин гадаад (биеийн) ертөнцөд явуулах үйл ажиллагааны удирдлага хэмээн үзэх нь буддийн шашныг бүдүүлэг байдлаар тайлбарлах явдал төдийгүй энэ шашныг огт эсрэгээр ойлгож буй явдал мөн юм. Буддийн шашныг цус урсгасан ёслол үйлддэг мэтээр сэжиглэх нь шавь нартаа Иисус Христийн санал болгосон талх, дарсыг бие ба цус хэмээн адилтгаж үзэх үндсэн дээр христийн шашинг зэрлэг балмад гэж сэжиглэхээс ч дутуугүй инээдтэй хэрэг мөн.

Важраяны урлагт сексийн хэд хэдэн дүр бий. Энэ бол уур хилэнт бурхадын нэгэн адил билэг тэмдгийн төдий л зүйл юм. Эдгээр дүр ангижралд хүрэхийн тулд мэргэн ухаан, арга хоёрыг нэгтгэх явдал чухал болохыг илэрхийлэн харуулж байгаа юм. Түвдэд байдаг "сексийн йог" гэгчийн тухайд бол хий хоосныг гэтлэн давахад чиглэдэг биеийн далд эрчим хүчийг идэвхжүүлэх олон аргуудын л нэг юм. Энэ практикт олон жилийн бясалгалын дараах өндөр хөгжсөн йогуудыг л хэрэглэж болдог байна. Хоёр түнш авшиг буюу сахил хүртэх үед олж авсан ёс жаягийг сахин мөрдөж, хоёулаа йогийн практикаас оюун ухааны ашиг тус олж авахын тулд йогийн хөгжлийн харьцангуй адил түвшинд байх ёстой юм. Мэдээжийн хэрэг агийн ёсонд хүмүүний аливаа нийгэмд байдгийн нэгэн адил явцуу зорилгын үүднээс шашны сургаалийг ашиглан халхавчилдаг хүмүүс тааралддаг ажээ. Тийм учираас Интернет болон нууц ном зохиолуудад тааралддаг "агийн

ёсны сексийн" тухай бүх мэдээлэл бол буддийн шашинд огт үл хамаарах садар самууны элдэв үйлдэлд мөнгө гаргуулах гэсэн л оролдлого юм.

Буддийн шашны зарим нууцлаг шинжүүд шинжлэх ухааны аргаар судлагдаагүй боловч практик амьдралаар нотлогджээ. Жишээ нь, нэчун чойжингийн дүрд "хувилдаг" Түвдийн гол зөнч мэргэний урьдчилан хэлсэн зүйлс нотлогддог байсныг XIV Далай лам болон бусад олон хүн нотолжээ. Бас нэг жишээ бол йогууд байна. Тэднийг өөрөө өөрийгөө мэдэхгүй тийм байдалд оруулахад уулан дундуур өдөрт 70 километр гүйж чаддаг ажээ.[434] Жишээ нь, энэ бол тумо йог бөгөөд түүний тусламжтайгаар. очирт хөлгөний сургаалийн ололтуудын тухай ямар нэгэн утгаар танин мэдэж болно.[435] Буддийн шашны зарим практик үзэгдлүүдийг шинжлэх ухааны аргаар судлаж тогтоосон байна. Туршилтад орсон лам нар цасан дээр нүцгэн биеэрээ суухад тэдний биен дээр тавьсан нойтон даавуу хатаж байсан бөгөөд энэ нөхцөлд агаарын температур тэгээс доош байжээ.

Өөр нэг гайхамшигтай үзэгдэл бол зарим лам нарын бие махбодь насан өөд болсон хойноо ч үхжээгүй хэвээр оршин байдаг ажээ. Үүний нэг жишээ бол оршуулснаас нь хойш 75 жилийн дараа 2002 онд гаргаж ирсэн буриадын хамба лам Д.Д. Итгэлтийн бие юм. Шинжээчид шинжилгээ судалгаа хийсний дараа түүний биеийн эд эс нас барсан хүнийх биш байсныг тогтоожээ.[436]

Түвдэд соёлын хувьсгалын үеэр Итгэлтийнх шиг тийм байдалтай байсан хэд хэдэн ламын биеийг олсон тухай XIV Далай лам хэлсэн байдаг. Саяхан Энэтхэгт Лувсанням гэдэг нэгэн эрдэмтэй ламыг нас барснаас нь хойш 18 хоногийн дараа шинжилж үзэхэд бясалгал үйлдэж байсан тэр л байдалдаа байсныг тогтоосон байна.[437] Бурханы шашны сургаалиар бол өөрийгөө захирах өндөр түвшинд хүрсэн хүн маш удаан хугацаагаар самадхийн байдалд орох чадвартай болдог ажээ. Самадхи гэдэг нь ухамсарын бясалгалын байдлыг хэлдэг бөгөөд энэ байдлыг удаан хугацаагаар үргэлжлүүлэхэд өөрийн ухамсараас өөр ямар нэгэн учир шалтгаан шаарддаггүй ажээ. Зарим лам нар нас барахаасаа өмнө ийм байдалд орж удаан хугацаагаар түүнийгээ хадгалдаг байна.

Сохроор итгэх биш, бүхнийг эрэгцүүлэн дүгнэх хэрэгтэй байдаг ажээ. Одоогийн Далай лам ийнхүү сургасан байна. Тэрээр эдгээр үзэгдлийг шинжлэх ухааны аргаар судлан үзэхийг дэмждэг хүн юм. "Нууцлаг" гаж үзэгдлүүдийг судлах салбарт олон улсын эрдэм шинжилгээний төслүүд хэрэгжиж байна. "Оюун ухаан ба амьдрал" хэмээх олон улсын хүрээлэн байгуулагдсан бөгөөд энэ хүрээлэн бодит байдлын мөн чанарыг ойлгох,

хүмүүсийн сайн сайхан байдалд туслахын тулд орчин үеийн шинжлэх ухаан болон бурханы шашны хооронд ажил төрлийн хамтын ажиллагаа,шинжилгээ судалгааны түншлэл тогтоох зорилготой билээ.[438] Эдгээр шинжилгээнд анагаах ухаан, нейрологи,сэтгэл судлал, физик, боловсролын асуудлууд хамрагдаж байна. Тус хүрээлэн олон улсын бага хурал зохион байгуулж, ном сэтгүүл хэвлэн гаргаж, хамтарсан төслүүдэд оролцож байна.

Буддын сургаалиар бол мэргэн ухааны практик гэдэг нь болзолт буюу нэрлэсэн мэдлэг, үнэмлэхүй мэдлэгийн практик мөн ажээ. Болзолт мэдлэг – энэ бол хүмүүсийн хүртэж хүлээж авч буй эд юмсын тухай мэдлэг юм. Харин үнэмлэхүй мэдлэг бол ахуйн мөн чанарын тухай мэдлэг ажээ. Бүх юмс, үзэгдлийн эцсийн мөн чанар бол хоосон чанар болохыг эрэгцүүллийн замаар тогтоодог байна. Гэхдээ энэ нь битүү сав, хоосон ахуй биш, харин бие даан оршин тогтнохуйн хоосон чанар, өөрөөр хэлбэл өөрөө оршихуй мөн юм. “Би” хэмээх хуурамч үзэл баримтлал эд юмсын мөн чанарын тухай мэдлэг дутагдсанаас үүсэн гардаг: сансар дахь бүх зүйлс учир шалтгаанд гарал үүслийн хүчээр л оршин тогтдог, аяндаа оршин тогтдог юм гэж үгүй ажээ. Энэ бол ертөнц өөрөө хоосон чанар гэсэн үг бас бишээ. Ертөнц оршин байгаа, гэхдээ учир шалтгаан,гарал үүслийн хүчинд л иймхүү оршдог байна. Тийм учраас ертөнц өөрөө хоосон чанартай адил юм. Ертөнцийг үзэх “Би” төвт буюу амин хувиа хичээсэн үзлийг даван туулахад түвдийн бурханы шашны оюун ухааны практикийн үндэс болох бусдын тухай анхаарал халамж тавих, тэднийг хайрлан хүндэтгэх дадлыг олох нь үлэмж тустай байдаг. Ингэхгүйгээр сансраас чөлөөлөгдөж чадахгүй.

Түвд лам нар буддизмыг өөрчлөөгүй, түүнийг өөр ямар нэгэн шашинтай хослуулан хэрэглээгүй юм. Түвд ном судруудад шашны сургаалийг товч байдлаар тайлбарласны дараа ч Бурхан багшийн буюу энэтхэгийн өөр ямар нэгэн ламын үг зэрэг эх сурвалжийг заавал иш татаж, зөвхөн энэ үндсэн дээр шашны дүрэм журам бүрийг баталгаажуулдаг юм хэмээн XIV Далай лам онцлон тэмдэглэжээ. Буддын сургаалийн үндэслэлүүд ойлгоход хүндэвтэр байх нөхцөлд ч олон зуун жилийн өмнө хийсэн Түвд орчуулгуудад тэдгээр үндэслэлийн утга санаа илүү тод гарсан байдаг гэж буддын болон буддын биш гүн ухааны салбарт ажиллаж буй орчин үеийн энэтхэгийн эрдэмтэд тэмдэглэсэн байдаг юм. Санскрит хэлтэй харьцуулахад Түвд орчуулгууд ойлгоход илүү хялбар байдаг гэж энэтхэгийн зарим судлаач үзэж байна. Түүнээс гадна Энэтхэгт олдохоо больсон бурханы шашны олон бичвэр зөвхөн Түвд орчуулгад хадгалагдан үлджээ. Бусад шашны нэгэн адил түвдийн болон энэтхэгийн буддизмын хооронд орон нутгийн ялгаа, цаг

хугацааны буюу гадаад талын нөхцлөөс шалтгаалсан үл ялиг ялгаа бий. Түвдийн бурханы шашны янз бүрийн сургууль (чиглэл) уг үндсийн хувьд нэгдмэл, харин багшлах аргаас үүдсэн зарим нэг ялгаа байдаг ажээ.

Түвдийн Бурхны шашин бол хятадынхаас эрс ялгаатай бөгөөд хожуу үеийн энэтхэгийн Махаянын буддизмын Түвд хэлээр яг оноож орчуулсан хувилбар мөн.[439] Махаянын түвд, хятад салаа мөчрүүд тус тусдаа бие дааж хөгжсөн, харин түвд, хятад хэлүүд Махаянын буддизмын дамжуулж авсан хамгийн чухал энэтхэг биш хэл болсон байна. Хятад хэлт уламжлалаас зүүн азийн бурханы шашны олон янз төрлүүд үүсч гарсан бол Түвд хэлээр илэрхийлэгдсэн хувилбар Монгол болон Гималайг дамнасан бүс нутгийн бурханы шашны үндэс болжээ.

Тийм учраас түвдийн буддизмыг ямар нэгэн өөрчлөгдсөн хувилбар буюу тэр дундаа буддизм, бөөгийн шашны хольц хэмээн үзэх нь буруу юм. Энэ л зорилгоор европчууд “ламаизм” буюу ламын шашин хэмээх нэр томьёо гаргаж иржээ. Энэ үгнээс татгалзах хэрэгтэй, яагаад гэвэл энэхүү нэр томьёо өөрөө ч, түүнд шингээсэн утга агуулга ч буруу юм. Энэ тухай олон судлаач бичиж байжээ. Оросын томоохон эрдэмтэн Е.А. Торчиновын бичсэнийг иш татья:[440]”Түвдийн буддизмын тухай ярихдаа Махаяны энэ чиглэлийг илэрхийлэхийн тулд “ламаизм” хэмээх нэр томьёо хэрэглэх явдал буруу болохыг шууд цохон тэмдэглэх нь зүйтэй. Түвдүүд өөрсдөө энэ үгийг мэдэхгүй, тэдний хувьд Дхарма, Буддагийн Дхарма буюу Махаяна хэмээх ойлголт байдаг юм. Энэ үгийг европынхон XIX зуунд шашны номын багш-”сайн нөхөр” буюу лам (ла-р “өндөр” ба ма – “үгүй”, өөрөөр хэлбэл “үүнээс өндөр үгүй” хэмээх Түвд үгнээс гаралтай) – ыг тахин шүтэж байсныг онцлон тэмдэглэхийн тулд л гаргаж иржээ. Тийнхүү түвдийн буддизм онцгой маягийн шашинлаг шинжтэй болж хувирсан гэдэг бол буруу үзэл бөгөөд яагаад гэвэл түвдийн сүм хийдийн уламжлал нь сүүлч үеийн энэтхэгийн бурханы шашны уламжлалыг тэр хэвээр нь маш нарийн дэгтэйгээр хадгалан сэргээсэн байна. Энэ тухайд хятадын уламжлалт соёлын нөлөөгөөр хүчтэй өөрчлөгдсөн хятадын буддизмын онцгой хувиргалыг маш үндэстэйгээр тэмдэглэн хэлж болох билээ. Ламыг тахин шүтэхийн тухайд бол багшийг хүндэтгэх йогийн ухаан нь түвдийн ямар нэгэн өвөрмөц шинжгүй бүрнээ энэтхэг үзэгдэл мөн юм. Үнэн хэрэгтээ бол Паловын эриний энэтхэгийн буддизмээс түвдийн буддизмын ялгарах бүх онцлог ард олны болон ахуйн чанартай шашин шүтлэгийн түвшинд л байхаас биш жинхэнэ “их уламжлалыг” хөндөлгүй үлдээсэн байна.

XX зууны 60-аад онд “ламаизмын” (ламын шашны) тухай асуудал

улс төрийн хэмжүүртэй болж: Түвдэд гарсан хятадын эсрэг бослогыг нухчин дарж, XIV Далай лам Энэтхэг рүү дүрвэн гарснаас хойш (ялангуяа 1966–1976 оны гунигт “аугаа их пролетарийн соёлын хувьсгалын” үед) БНХАУ-ын эрх баригчид түвдийн санваартнуудын эсрэг, мөн тус орны нийт бурханы шашны уламжлал болон үндэсний соёлын эсрэг хэд хэдэн залхаан цээрлүүлэх ажиллагаа явуулахдаа түвдийн “ламаизм” бол бурханы шашин биш гэх буюу буддизмын гажуудсан хэлбэр төдий л зүйл юм, тийм болохоор энэхүү “ламын шашин” гэгчийг нийт хятадын соёлын өвийн нэг хэсэг хэмээн хадгалан хөгжүүлэх хэрэггүй юм хэмээн нотолж байв. Чухам тэр үед л Далай лам “ламаизм” хэмээх үг хэрэглэхээсээ татгалзахыг бүх дэлхийн эрдэмтдэд хандаж уриалсан юм. Бид ч дан ганц шинжлэх ухааны шинжтэй шалтгааны улмаас энэ үгийг хэрэглэхгүй байя” гэж тэр бичжээ.

Гэсэн хэдий ч хятадын суртал нэвтрүүлгийн материалуудад одоо ч “түвдчүүд ламаизм хэмээх өөрийн гэсэн Түвд шашинтай”[441], энэ бол хятадын буддизмын нэгэн салаа мөчир, Банчин лам бол “хятадын бурханы шашны итгэл үнэмшлийн багш” мөн[442] гэсэн нотолгоо тааралдсан хэвээр байна. Гэхдээ байдал өөрчлөгдөх бизээ. 2008 оны түвдийн соёлын тухай хятадын “Цагаан ном”-ын англи орчуулгад “ламаизм” бус, харин “түвдийн буддизм” хэмээх нэр томьёо хэрэглэжээ.[443]

Түвдэд бон, бурханы шашин баримтлагчдаас гадна цөөн тооны ислам болон христосын католик шашинтнууд байна. Хятадын эзэгнэлд орохоос өмнө индуистууд ч байсан юм.[444] Тэнд бусад шашны төлөөлөгчдөд бүрэн хүлцэнгүй ханддаг билээ. Шашин, төрийг хослон баригчид дээр дурдсан шашны төлөөлөгчдийг өөрийнхөө итгэл үнэмшилд оруулах гэж хэзээ ч эрмэлзэж байгаагүй ажээ. Ислам болон бусад шашны төлөөлөгчид ч энэ тухай мэдээлж байжээ.[445] Тийм болохоор “хуучин Түвдэд толгой дараалан сүсэг бишрэлтэй байсан нь гажуудсан хэлбэртэй болсон нийгмийн шашин, төрийг хослуулах байгууллын нөхцөлд хэрэг дээр хүний эрхийг зөрчсөн хэрэг байсан хэмээн батлах нь буруу юм. Учир нь хуучин цагт хүмүүс таалларaa шүтэж бишрэх эрхийн тухай ярих нь битгий хэл хувь заяагаа ч шийдвэрлэж чадахгүй байсан билээ”.[446]

Түвдийн Бурхны шашинд олон сонирхолтой зүйл байдгийг бид мэднэ. Гэхдээ энэ бүхэн хүмүүсийг төөрөгдөлд оруулах нь цөөнгүй байдаг билээ. “Буддын ойролцоох” үзэл баримтлал, жишээлэхэд теософ онол буюу хүмүүний сэтгэл санаа бурхантай хамт байдаг хэмээх онолыг авч үзэхээ больё. Шашин хоорондын үзэн ядалт дэвэргэхэд чиглэсэн суртал нэвтрүүлгийг ч авч үзэхээ больё, яагаад гэвэл эдгээрийн хариултыг

интернетээс олж үзэж болно.[447] Харин байнга хэлэлцдэг зарим нэг жишээн дээр тогтож ярьяа. Эхнийх нь бурханы шашин дахь “хүнээр тахил өргөх”, “хүний амь хөнөөж ёслол үйлдэх” тухай асуудал юм.

Оросын худалдаачин А.В. Бурдуков XX зууны эхээр монголчуудад “хүнээр тахил өргөх” ёслол байсан: Жа лам олзлогдсон 10 хятад хүнээр туг тахисан, нэгэн казах хүний арьсыг хуулсан: Чойжин лам цагаан гвардийн нэг цэргийн зүрхийг суга татаж гаргаад идсэн: цэргийн зарим жанжин цаазлуулсан хятадууд болон цагаан гвардийнхны зүрхний цусаар байлдааныхаа тугийг будсан (тахисан) тухай бичсэн байна. 2008 онд Бээжинд гаргасан “Түвдийн өнөөдөр ба өнгөрсөн үе” үзэсгэлэнд хүний арьс, “хамжлагуудын” гавлын болон шаантны ясаар хийсэн эдлэл зэргийг тавьсан байжээ. 1959 оны бослогыг нухчин дарснаас хойш Дрепун, Лхас, Сэра, Гьянзе, Лхока болон бусад газарт суртал нэвтрүүлгийн чанартай иймэрхүү үзэсгэлэн зохион байгуулжээ.[448] Эдгээр үзэсгэлэнг үзэхээр ирсэн хүмүүст дээр дурдсан эд зүйлсийг хийхийн тулд хүний амь хороож байсан мэтээр үнэмшүүлэхийг эрмэлзэж байв. 1948 онд лам нар хятадын халдлагыг сэрэмжлэн зайлуулах гэхдээ 21 хүний амийг хөнөөж, дараа нь хүмүүсийн биеийн муудаагүй хэсгүүдийг жил бүр ашиглаж байсан мэтээр[449] ярьж байжээ.

Зөвлөлтийн сэтгүүлч Вс. Овчинников нэгэн сүмийг сэргээх үед өөрийг нь амьдаар булах гэсэн тухай хувраг байсан нэг хүний яриаг иш татсан байдаг. Зарим хуврагуудыг ухсан нүхэнд албадан оруулж, хийдийн чулуун шалан дор амьдаар нь оршуулдаг байсан бөгөөд тэр хүмүүсийн шарил телепатийн мэдээ дамжуулахад радиодолгионы үүрэг гүйцэтгэдэг мэтээр ярьсан яриа ч байдаг ажээ.[450] Нэг бодьгалийн кармаг нөгөөд шилжүүлэн суулгаж болохгүй.[451]

Энэ бүхэн бурханы шашны үзэл баримтлалд харшилж байгаа юм. Амьтны амь хөнөөх явдал энэ шашинд хамгийн муу үйлдлийн нэг билээ. Буддагийн зарим сургаалийг авч үзье.[452] “Амьтны амь хөнөөж, ийнхүү хөнөөхийг тулгаж ч болохгүй, <...> Өөртөө аз жаргал эрэхдээ мөн түүнийг хүсч буй амьтанг хөнөөвөл үхсний дараа аз жаргал олж авахгүй, <...> Аливаа хүн хорт муу үйлдэл хийвэл өөрийгөө доромжлон гутааж буй хэрэг мөн. Хорон муу үйлдэл хийхгүй бол өөрөө өөрийгөө цэвэрлэж байгаа нь тэрээ. Сайн, муу үйлдлүүд тухайн хүнтэй холбоотой. Нэг хүн нөгөө хүнийг цэвэр ариун болгож чадахгүй”

Бодит байдалд бол Жа лам шашныхаа сургаалийг бүдүүлгээр зөрчиж, лам нарыг тамлан зовоож, монголын сүм хийдийн тэргүүнд захирагдаагүй

ажээ. Тийм учир VIII Богд гэгээн түүний цол хэргэм, эд хөрөнгий нь хурааж, баривчлах тушаал өгсөн байна. Түрүүн дурдсан Бээжингийн үзэсгэлэнд хэн, хэзээ авсан нь үл мэдэгдэх, ямар нэгэн баримтгүй зүгээр л хуучин музейн гэрэл зургууд тавьсан байжээ. Түвдэд зориулсан бээжингийнхний суртал нэвтрүүлгийн тухай ном зохиогч[453] Ж. Пауэрс дээр дурдсан зүйлсийг нотолсон байна. Хуучин Түвдийг идэвхтэй шүүмжлэгчдийн нэг А.Т. Грюнфельд хүртэл алслагдсан нутгуудад л маш ховор тохиолдолд хүний амь хөнөөж тахилга үйлддэг байсан байж болох юм гэж онцлон тэмдэглэсэн байна.[454]

Хүний яс, заримдаа бусад эд эсийг авч хэрэглэдэг байсан нь үнээн. Үүнийг эрдэмтэд ч, хятадын суртал нэвтрүүлэг ч хүлээн зөвшөөрдөг.[455] Ингэхэд хүний амь хөнөөх хэрэггүй, ингэх ч шаардлагагүй: Түвдэд эрт балар цагаас “тэнгэрт оршуулах” ёс буюу талийгаачдыг мөчлөн эвдэж, тас шувуу хооллодог байжээ. Хувьсгалын өмнөх Монголд иймэрхүү заншил байсан юм. Ер нь бол нас барагчдын шарилаас авах материал хангалттай байсан хэмээн хэлж болно. Түвдийн өндөр уулын нөхцөлд газар булж оршуулах газар тийм ч элбэг биш, бас түүдэг гал асаах түлээ мод ч ховор ажээ. Түүнээс гадна, энэ заншил шашнаар зөвтгөгдөж байгаа бөгөөд бусдын төлөө анхаарал халамж тавих явдал бурханы шашны хамгийн чухал зарчим, ингэхлээр энэхүү зарчмын логик төгсгөл өөрийгөө золиослох явдал бөгөөд шарилаа (хүүр) раа амьтан хооллох явдал энэ практикийн нэг хэлбэр болж байгаа юм. Нас барагчдыг ийм байдлаар оршуулахыг хориглоход хүмүүс тийм ч сэтгэл хангалуун биш байжээ. Ер нь бол нас барагсдын хүүрний зарим хэсгийг зөвхөн бурханы шашны ёс заншлаар өргөн хэрэглэдэг төдийгүй бусад шашин, жишээлэхэд христос шашинтнууд ч хэрэглэдэг байжээ.[456]

Бусад орны нэгэн адил Монгол, Түвд, Хятадад эрүү шүүлт болон харгис хэрцгий аллагын аль алин нь байжээ. Харин хэн нэгэн этгээд үүнийг шашнаар халхавчилсан байж болох талтай. Бодит байдалд бол энэ нь бусдыг тарчилган зовоож таашаал авах явдал буюу буддын шашнаас өмнөх уламжлалын хоцрогдол байж болох юм. Жишээ нь, алдарт жуулчин С.Гедин дурсамжиндаа хятад бүсгүйчүүд хүүхдээ тэжээж чадахгүйд хүрэхээрээ гол төлөв амийг нь хороочихдог байсан тухай бичсэн байна.[457] Түвд болон Монголд тийм явдал тохиолдож байгаагүй. Гэхдээ хятадуудын нэгэн адил алагдсан хүний зүрхийг идэхэд түүний эр зориг шилжиж ирдэг хэмээх бурханы шашны өмнөх мухар сүсэг хадгалагдан үлджээ. Жишээ нь, түвдчүүд баатарлагаар амь үрэгдсэн дайсан Зоравар Сингхийн зүрхийг иджээ.[458] XIX

зуунд хятад цэргүүд Исламын шашинтнуудын бослогыг дарсныхаа дараа алагдсан хүмүүсийн элэг, зүрхээр хоол хийж идэж байжээ.[459] 1909 онд Манжуурт цаазлагдсан хунхуузын (хятад жинчдийг замд нь дээрэмддэг хүмүүс) зүрхийг уг ялыг гүйцэтгэгч этгээд нэг хазаж үмхээд цугларсан олон руу шидэхэд тэд түүнийг тас тас татан идэж дуусгаж байжээ.[460] 1914 онд хятадууд хэд хэдэн монгол хүн цаазалж, зүрхийг нь гарган авч байжээ.[461] Иймэрхүү зэрлэг хэрцгий явдал БНХАУ-д ч Соёлын хувьсгалын үед гарч байсан юм.[462] Түвдэд Маогийн шинэтгэлээс болж эхэлсэн их өлсгөлөнгийн үед ийм явдал гарч байв.

Миний бие тахилга үйлдэх журмаар хүний амь хөнөөдөг, мөн хүмүүсийг сүм хийдийн сууринд амьдаар нь булж оршуулдаг байсан тухай түвдэд байхдаа ч, түвдийн дүрвэгчдээс ч асууж сураглаж байсан билээ. Гэтэл надтай уулзсан бүх хүн ийм явдал болж байгаагүй гэж хэлж байсан юм. Түвдэд ховорт тооцогддог газарт булж оршуулах тохиолдлууд дээрх ярианы үндэс болсон байхыг үгүйсгэх аргагүй юм. Жишээ нь, У-Цангд нас барсан хүүхдийг хаа нэгтээ газарт булж оршуулдаг байжээ.[463] Алагдсан хүмүүсийг ч ингэж оршуулдаг байж. Шашны ёслолд ясыг нь хэрэглэхийн тулд алагдсан хүмүүсийн хүүрийг тодорхой заасан өдөр ухаж гаргаж авдаг эрх бүхий тусгай хүмүүс ч байсан ажээ.[464]

Заримдаа нас барсан хүмүүсийг байшингийн хананд оршуулдаг байж.[465] Хятадын "тайван чөлөөлөлтийн" дараа л бага насны хүүхдийг газар ухаж булдаг болсон тухай яриа гарч иржээ. Энэхүү суртал нэвтрүүлгийг зориуд зохион байгуулан явуулж байгаа юм гэж Түвд өвгөчүүл надад ярьсан билээ. Тэр үед л Овчинниковын ярьсан зүйлийг санаанаас зохиосон нь илэрхий байна. 1965 онд Лхас хотод Хувьсгалын музей нээгджээ. Уг музейд нэгэн байшингийн хоёр хананы уулзварын өнцөг дор оршуулсан гэх дөрвөн жаал хүүгийн нэгний араг яс тавьсан байжээ.[466] Өөр нэг жаал хүү уг музейн танхимуудаар явж, ингэж оршуулагдахаас арай ядан зугатаж гарсан тухайгаа хүмүүст ярьж явах ажээ. Шавар дүрсний тусгай үзэсгэлэн "феодализмын аймшигуудын" нэг болох энэ үйл явдлыг [467] "нүдэнд харагдтал өгүүлэх" ажээ. Хожим нь энэ үзэсгэлэнг гадаадынханд зориулсан тусгай үзмэрээс хассан байна, тэндхийн үзмэрүүдийг харсан гадаадынхан үл итгэж, инээд ханиад болох нь их байсан ажээ.

Европ, Ази, Африк, Америкийн олон орны шинэ үеийн түүхэнд хүний амь хөнөөж элдэв ёслол үйлдэх явдал гарч л байжээ. Түвд эдгээрийн нэг болох нь ойлгомжтой. Нилээд хожуу үед ч хүний амь хөнөөж тахилга үйлдэх бурханы шашны өмнөх тохиолдлууд Түвдэд гарч байсан тухай

мэдээлэл бий.[468] Гэвч бурханы шашинд ийм практик байгаагүй, байхгүй, байж ч болохгүй юм.

Нилээд баргардуу үйл явдлын тухай товч ярья. Сүүлийн хэдэн арван жилд Орос улсын номын дэлгүүрүүдийн лангуун дээр хуурамч шинжлэх ухааны, хуурамч шашны бизнес-төслийн бүтээгдэхүүн дүүрэн чихээстэй харагдах болжээ. Олон тоогоор хэвлэгдсэн,”эрэг шурагий нь нилээд сайн чангалсан”номууд гарах болж, хүн ам ч худалдан авах ажээ. А.Т. Фоменко болон бусад хүний бичсэн “Шинэ он дарааллын бичиг” хэмээх ном мэдээжийн хэрэг тэргүүн эгнээнд тавигдах бизээ. Энд түүнийг шүүн хэлэлцэх нь утгагүй хэрэг: тэр номонцор Түвд хүрээгүй ч Монгол, Хятадаар аль хэдийнэ шургалаад амжжээ. Марко Поло хятадын цагаан хэрмийн тухай бичээгүй болохоор энэ байгууламж тэр үед босоогүй байсан хэрэг болохнээ. Ингэхлээр саяхан түүнийг байгуулсан болж таарна. XVIII зуунд бас нэг итали эр мөн ийм зүйл бичжээ. Тэр үед нэгэн уншигч: Марко Пологийн аялалын маршрут нэг бүрчлэн тодорхой биш байдаг юм билээ. Магадгүй тэрээр Бээжингээс хойш хөл тавиагүй учир цагаан хэрмийг олж хараагүй юм байлгүй[469] хэмээн хэлж зохиогчийг мад тавьсан юм гэдэг. “Шинэ он дарааллын бичгүүдийн” энэ мэт санаанаас зохиосон зүйлүүдийг дээрх зарчмаар няцааж болох билээ.

Теософ (хүмүүний сэтгэл санаа өөр ертөнцтэй буюу бурхан тэнгэртэй шууд харьцаж болох тухай онол) онол болон түвдийн сүсэг бишрэлийн асуудлаар бичсэн төслүүд гэгч ч бий. Жишээ нь, Э.Р. Мулдашевын бичсэн “бурхадын хот”, нууц агуйнууд, Шамбалын орон, Кайлас уул, Манасаровар нуурын тухай, түвдчүүд атлантуудаас (тэнгэрийн хаяаг тулж зогсох ял шийтгүүлсэн аварга биетнүүдийн тухай домог) гаралтай тухай номуудыг энд нэрлэж болно. Үнэн хэрэгтээ бол түүний хийсэн аялал ямар ч “гэнэтийн үр дүн” өгсөнгүй. Ямар ч нууцлаг зүйлийг уншигчид олж үзсэнгүй. Экспедицийн (ямар учираас “эрдэм шинжилгээний” гэж хэлсэн нь ойлгомжгүй байна) тухай дүрслэлүүд Е.П. Блаватскаягийн теософ үзэл, хэнд ч хэрэггүй элдэв хүмүүсийн яриа, санаанаас зохиосон зүйлүүдтэй хутгалджээ. Жишээлэхэд бурханы шашны эд зүйлс болон сүм дуганан дээр зураастай байдаг “үсний эргүүлэг” болон нүдний хэлбэр нь ийм үс, нүдтэй хүмүүс дээр дурдсан атлантуудаас гаралтайг, загас мэт нүдээ анидаггүй амьтадын шинж тэмдэг болох юм гэнээ. Гайхалтай: нүдний эмч хүн л загасны төрлийн гэхээр нүдээ анидаггүй организмуудын дасан зохицох үйлийн тухай, жишээлэхэд “гуравдагч аньсаганы” (гуравдахь нүдтэй андууравзай) тухай бичсэн эрдэм шинжилгээний бүтээлийг уншиж үзэх

бизээ. Мулдашев гуай зөөлнөөр хэлэхэд бурханы шашныг тааруухан мэддэг бололтой. Хэрэв тийм бишсэн бол энд яригдаж буй нүдний хэлбэр бол бясалгалыг илэрхийлж буйг, харин хөмсөгнүүдийн хооронд ("хамар байх газар" биш шүү) байх эргүүлэг үсийг бурхан Буддагийн 32 шинжийн нэг хэмээн үздэгийг эрхбиш мэдэх бизээ. Мулдашевт ярилцлага өгсөн хүмүүс энэ тухай түүнд яриагүй бололтой юм <...> харин тэд өөр олон зүйлийн тухай бурж өгчээ хөөрхий. Жишээ нь, "автомашины ослоор нас барсан"[470] Марпа багшийнхаа хүүтэй учир ургуулсан түвдийн йогч "Минерапу"-ын тухай "зохиолд гардаг" л үйл явдлуудыг хуучилж өгчээ. Энэхүү "зохиол" гэгчийг нь харахгүй өнгөрвөл юу болохсон бол? Наад захын жишээ болгож "Википедия"-г аваад үзье. Энэ зохиолыг сөхөөд үзэхэд тэрхүү йогч эрийг Миларепа гэдэг бөгөөд 1052–1135 онд, харин түүний багш Марпа 1012–1097 онд амьдарч байсныг мэдэж болох ажээ. Тэр үед эртний атлантчуудад (аварга биетнүүдэд) автомашин байсан эсэхийг ёстой бурхан мэдтүгэй. Бидний энд авч ярьж буй зохиогч маань атлантчуудын тухай Лобсанг Рампын[471] номноос олж мэдсэн бололтой юм. Энэхүү "сэтэртэй" зохиогч[472] Түвдийн агийн ёс, далд хүчний тухай олон ном бичжээ. Эдгээр номыг ч мөн л баруун солгойгүй зарж борлуулж байгаа аж. Хүмүүс ч номуудыг уншиж, өөр хоорондоо хэлэлцэж байгаа гэсээн. Гэхдээ энэ хүмүүсийн ихэнх нь Түвд нэрний цаана британийн ус түгээгчийн хүү Сирил Генри Хоскин гэгч нуугдаж буйг тэр болгон мэддэггүй ажээ.

Одоо санаанаас зохиосон зүйлс, алдаатай дүгнэлтүүдийг жишээ болгож татахаа больёо, цаас, завны гарз биз. Энэ бүх номонцорууд нь фэнтези гэгчийн төрөл жанраар бичигдсэн марзан зүйлээс хэтрэхгүй юм.

2005 онд Далай лам оросын сэтгүүлчдэд: "Та бүхэн Энэтхэгт хэд хонох бол? Дөрвөн өдөр болно гэнээ? Энэхүү нууц мэдлэгийг эрж хайгаарай. Хэрэв та нар түүнийг олж чадвал надад мэдэгдэхийг хичээгээрэй. Би л лав үүний тухай олж мэдээгүй юм байна.<...> Түвдийг гайхамшгийн орон болгож хувиргасан Лобсанг Рампын номууд гарсан байна билээ"[473] хэмээн хэлсэн билээ.

❁

Түвдийн ард түмний амьдралыг Бурхны шашнаас салгаж үзэхийн аргагүй билээ. Магадгүй, энэ бол дэлхийн хамгийн сүсэг бишрэлтай ард түмэн бөгөөд бараг бүх Түвд хүн шашин шүтдэг бизээ. Энэ оронд очсон хэн боловч үүнийг олж харна. Бон болон түвдийн буддизм хятад гэхээсээ Энэтхэг, Монголын ийм төрлийн сургаалиудтай олон талаар төстэй. Түвдийн

буддизм – энэ бол энэтхэг сургааль тэр чигээрээ байна. Түвдийн буддизм нь хятад бурханы шашны нэг хэлбэр ч биш, буддизмыг гуйвуулсан хувилбар ч биш, бөөгийн шашинтай нийлсэн түүний хольц ч биш, аллага таллага, харгис хэрцгий явдлыг практикт хэрэгжүүлдэг ямар нэгэн шашин ч бишээ. “Ламаизм” хэмээх нэр томьёоноос татгалзах хэрэгтэй, яагаад гэвэл энэ нь шинжлэх ухааны болон шашны үзэл бодолд үл нийцнэ.

Бурханы шашин нь түвдийн ард түмний сэтгэл зүй, ертөнцийг хүлээж авах мэдрэмжид хамгийн шилдэг хэлбэрээр нийцжээ. Бурхны шашинд орсон явдал Түвд хүний амьдралыг энэрэнгүй аястай болгоход тус дөхөм үзүүлж, Түвд-Монголын соёл иргэншлийг төлөвшүүлэн тогтоох чухал хүчин зүйл болсон байна. Буддизм бол (түвд хэлбэрээр) Монголын ба Оросын уламжлалт шашны нэг мөн. Бурхны шашны гол утга санаа бол ид шидийн гайхамшиг биш, харин хамаг амьтны тусын тулд сэтгэл санаагаа боловсронгуй болгож, төгс гэгээрэлд хүрэх явдал мөн. “Шашны зан үйлийн зорилго бол ид шидийн чадвартай болоход биш, харин дотоод ертөнцөө ариусгахад оршино”[474] хэмээн Далай лам айлджээ.

Бүлэг 6

# Төр, нийгмийн байгуулалт, эдийн засаг

Эртний болон дундад зууны эхэн үед Түвдийг хаад (цэнпо) захирч байжээ. Тэдэнд төрийн хэргийг хэлэлцэн шийдвэрлэдэг зөвлөлийн гишүүд тусалдаг байж. Анхны хаадын үед хоёрдмол засаглалтай, төрийн удирдагчид (эхний үед үе залгамжилсан биш) болон бон шашны лам хуврагуудын хооронд зөрчилтэй байжээ.

Соронзон Гомбо хааны (VII зуун) засаглалын үед улс орны удирдлагад өөрчлөлт хийв. Гурван бүлэгт хуваагдах сайд нар удирдлагыг хэрэгжүүлж байв. Төрийн их канцлер, төрийн канцлер (командлагчийн орлогч), дотоод хэргийн сайд, засаг захиргааны канцлер, харгалзагч – байцаагч, гадаад хэргийн сайд, орлого, татварын хэрэг эрхэлсэн сайд, цэргийн сайд, шүүхийн сайд хэмээх бүтэцтэй[475] төв засгийн газар улс орныг удирдаж байв. Сайд нар болон хааны шадар түшмэд төрийн зөвлөлийг бүрдүүлэх бөгөөд энэ зөвлөлийн гишүүд дотоод, гадаад хэргийн асуудал эрхэлсэн зөвлөхүүд, жирийн зөвлөхүүд хэмээн хуваагдах ажээ. Мөн орон нутгийн засаг захиргааны бүтэц бий болгожээ. Хаанд ордны түшмэлүүд үйлчилнэ. Түвд улс мужууд болон арай жижиг нэгжүүдээс бүрдэнэ. Гадаад талын нутаг дэвсгэрүүдийг эзэлж авсаны дараа тэнд амбан захирагчийн газрууд байгуулав. Тусгай томилогдсон түшмэд газар нутгийг тэндхийн оршин суугчдын дунд хувиарлан өгсөн байна. Мянгатын дарга тэргүүтэй мянган өрх засаг захиргааны гол үндсэн нэгж болов. Үе залгамжилсан биш баячуудад газрыг тариачдынх нь хамт олгожээ. Муж бүр өөрийн гэсэн дүрэмт хувцас, туг далбаа, нэг зүсний агт морьд бүхий цэрэгтэй байв. Цэргийн гол үндсэн нэгж нь мөн мянгат цэрэг байжээ. Арми нь арван

мянгатын зарчмаар байгуулагджээ. Дайчид нь харваач, сэлэм жадтай цэрэг хэмээх хоёролын зарчимд үндэслэжээ.

Түвдэд өөрийн гэсэн эрх зүйн систем байв. Түвдчүүд түрэг, уйгур нараас анхныхаа хуулиудыг зээлдэж авсан хэмээх мэдээлэл байдаг. Шүүх системтэй байв. Нэг зуун жилийн дотор Түвд хэлэнд шүүх эрх зүйн тов тодорхой нэр томьёо боловсрогдсон байлаа. Түвдийн эрх зүйн систем үнэмлэхүй бие даасан шинжтэй байсан бөгөөд хэдийгээр зарим тохиолдолд хуучин монголын эрх зүй болон Юань, Чин улсын эрх зүйн хэм хэмжээг ашигласан боловч бүхэлдээ бол төв азийн эрх зүйн[476] үнэхээр бие даасан бүлэг болон хөгжжээ. XX зууны дунд үе хүртэл хадгалагдан үлдсэн түвдийн эрх зүйн онцлог шинж чанар бол шашны дүрэм (лам нарт зориулсан), хууль зүйн хэм хэмжээ (энгийн иргэдэд зориулсан) гэсэн хоёр хэсэгт хуваан авч үзэж байсан явдал мөн.[477] Түвдэд бие хүний эсрэг үйлдсэн гэмт хэргийн төлөө нөхөн төлөөс өгөх тухай заасан эрүүгийн шийтгэлийн систем үйлчилж байв.

Нөхөн төлөөсийн хэмжээ үйлдсэн гэмт хэргийн хүнд хөнгөнөөс, гэм буруутан болон хохирогчийн нийгмийн зэрэг дэвээс шалтгаалах ажээ. Эртний бусад олон улс орны нэгэн адил Эртний Түвдэд гэм буруутайг тогтоохдоо эрүү шүүлт ашиглаж байжээ. Булингартай ус, сүү, буцалж буй сүү буюу буцалж буй тосноос цагаан буюу хар чулуу гаргаж ирэх ёстой байв. Хар, цагаан чулуугаар сэжигтэний буруутай, буруугүйг тогтоодог ажээ[478].

VII–X зуунд Түвдэд тариалан эрхэлдэг газрыг улсын, хааны мөн түвдийн отог омгийн тэргүүлсэн гэр бүлийн гэж хуваан авч үзэж байжээ.[479] Эр талын нэг өвөг дээдсийн удмынхан отог болон нэгддэг байжээ. Дээд тушаалын сайд, түшмэд нар бол хаантай ураг төрлийн холбоотой омгуудаас гаралтай хүмүүс ажээ. Нийгмийг язгууртнууд, энгийн хүмүүс хэмээн хуваан авч үзэх бөгөөд энгийн хүмүүс нь бас эрх чөлөөтэй, чөлөөгүй гэж хуваагдана. Тэд хааны газар боловсруулж, газрын татвар төлөх ажээ. Газар эзэмшигч эрх чөлөөт иргэн бүр улаан хуудас авдаг ба энэ хуудаст газар эзэмшсэний төлөө, түүнээс үр тариагаар авах татварын хэмжээг тогтоосон байдаг ажээ. Түвдийн түүхийн бүх үед газар эзэмшигчдэд тариачидтай зүй бусаар харьцахыг хуулиар болон уламжлалаар тас хориглодог байжээ. Соронзон Гомбо хааны үеэс эхлэн түвдийн олон эрх баригч Дхармын арван цагаан буян[480], өөрөөр хэлбэл буддын ёс суртахууны номын зан үйлд үндэслэсэн хууль гаргажээ. Энэхүү номын зан үйл нь эрх баригчид өөрийн харьяат хүмүүсийг өмгөөлөн хамгаалах ёстой хэмээн шаарддаг ажээ. VIII

зууны дунд үеэс татвар төлөгчдийн нэрсийн жагсаалт гаргаж эхлэв. Энэхүү жагсаалтыг Хятадынх шиг цаасан дээр бичдэг байж. Газар эзэмшигч эрх чөлөөт иргэдэд газрын татвараас гадна албан журмын хөдөлмөр эрхлэх, нэмэлт татвар төлөх үүрэг оногддог байв. Хувийн эрх чөлөөгүй иргэдийн дотор газар боловсруулагчид төдийгүй малчид, гар урчууд, зарц ядуус орж байв.

V Далай лам бурханы шашны янз бүрийн чиглэлийн (Гарма Кагьюгаас бусад) сүм хийдийн эзэмших газрын хэмжээг нэмэгдүүлж, засаг захиргааны шинэтгэл хийж, нилээд эрт үеийн хууль тогтоомжид үндэслэсэн “13 хууль”,”16 хууль” хэмээх бүгд хууль (багц) батлан гаргажээ. Түвдийн нийгмийн дээд давхаргыг язгууртнууд,тэдний үе удам, том толгой түшмэд, сүм хийдийн дээд бүлэг; дунд давхаргыг худалдаачид, лам нар, доод тушаалын түшмэд; доод давхаргыг тариачид, түүнчилэн нядалгаатай ямар нэгэн хэмжээгээр холбоотой хүмүүс буюу ярганы ажилчид, арьс шир боловсруулагчид болон

төмрөөр (алт, мөнгө ч орох байх) эд юмс хийгчид тус тус бүрдүүлж байв. 1792 онд түвдийн анхны мөнгө бий болов.[481] Балбын мөнгөн зоосыг загвар болгон авч, түүн дээр өөрийнхөө үсгээр тэмдэглэгээ тавьжээ. Хожим нь янз бүрийн өртөг бүхий зоос цутгах болсон байна. Түвдийн мөнгөний систем Чин гүрний валюттай холбоогүй бөгөөд бие даасан шинж чанартай байв.

Шүүх, шийтгэлийн систем урьдын адил эрүү шүүлт, дэнсийг өөртөө багтаажээ.[482] Том хэмжээний хулгайн хэргээс хүний амь хөнөөх хүртэлх хэд хэдэн гэмт хэрэгт цаазлах ял оноох ажээ. Зарим тохиолдолд их хэмжээний нөхөн төлөөсөөр цаазын ялыг сольж болдог байв. Энэ ялыг гол төлөв хулгайн хэрэгт хэрэглэнэ. Шашны эсрэг үйлдсэн гэмт хэргийн төлөө хатуу ял оноох ажээ. Эхнэр, нөхөрийн аль нэгний санаачлагаар гэр бүл салах тохиолдолд торгууль оногдуулж, хүү хүүхдийг эцэгт нь, охин хүүхдийг эхэд нь үлдээдэг байв.Эхнэр, нөхөрөөс гадуур явалдсан тохиолдолд торгууль оногдуулах ажээ.

Тан гүрний түүхийн сурвалж бичгүүдээс үзвэл VII зуунд түвдийн хүн ам 10 сая байжээ.[483] Юань болон Манж чин улсын үед янз бүрийн мэдээгээр энэ хүн ам 850 мянгаас 3,5 сая байжээ.[484] Энэ бол гайхах зүйл биш, тэр үед Түвд их хэмжээний нутаг дэвсгэрээ алдсан байв.

Түүхийн явцад түвдийн нийгмийн байгуулал болон эдийн засаг маш удаан өөрчлөгдсөн байна. Энэ нь зарим талаар байгаль цаг уурын хахир хатуу нөхцөлтэй холбоотой юм. Хөдөө аж ахуй бол Түвдийн эдийн засгийн

үндэс мөн. Бүдүүлэг аж ахуй давамгайлж, тавaарын үйлдзвэрлэл удаан хөгжиж байв. Байгальтай зохицон амьдарч, байгаль орчны хямрал ба өлсгөлөнгөөс зайлсхийх боломж олгосон үр ашиг муутай хөдөө аж ахуйн систем төвдчүүдэд төлөвшин бий болжээ. Энэхүү уламжлалт систем нь хүрээлэн буй орчинд ариг гамтай хандах номын зан үйлийг хөгжүүлэхэд хүргэжээ.[485] Төвдчүүдийн мөрддөг зөв амьдралын тухай буддын сургааль ёсоор бол хэт их хэрэглээнээс, байгалийн нөөцийг хэт их ашиглахаас татгалзаж, "аядуу хэрэглээг" эрхэмлэх явдал чухал бөгөөд эс тэгвээс амьд амьтад болон хүрээлэн буй орчинд хор хохирол учруулна хэмээн үздэг ажээ.

Төвдчүүд хүн, байгаль хоёрыг сөргүүлэн тавихыг хэзээ ч үл зөвшөөрнө. Хятадууд болон прагматик үзэлтэй өрнөдийнхөн төвдийн соёл иргэншлийн үнэт зүйлсийг ойлгодоггүй билээ.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг арилжаанд оруулах хүсэлгүй байх явдлыг "хоцрогдол хэмээн нэрлэж байна. "Хүн амын өсөлт зогсонги байдалд орж, байгалийн сүйрэл байнга тохиолдож, зуд турхан болон байгалын бусад гамшгийн улмаас хүмүүс болон мал амьтан олноор үхэж үрэгдэх шалтгааны улмаас билчээрийн ашиглалт тааруухан байсан юм"[486] гэж хятадын албан ёсны мэдээлэлд өгүүлжээ. Энэ бол худал дүгнэлт мөн. Нүүдлийн мал аж ахуй шим тэжээл багатай өндөр уулын билчээрт эрт дээр цагаас зохицож ирсэн байна. Олон зууны туршид мал аж ахуй эрхлэх тодорхой соёл боловсрогдсон бөгөөд билчээр нутгийн ашиглалтыг байнга бүртгэж, энэхүү билчээрийг байгаль орчны хувьд хэвээр хадгалж байхын төлөө тал талдаа хариуцлага хүлээж, сарлаг, хонь, ямаан сүргийг системтэйгээр ээлжлүүлэн нутаглуулж ирсэн байна.[487] Нүүдэлчид ихэнхи билчээр нутагт янз бүрийн төрлийн мал амьтны сүрэг адгуулан үржүүлж иржээ. Энэ янз бүрийн мал амьтан янз бүрийн төрлийн ургамал хэрэглэдэг нь билчээрийн даацыг илүү тэнцвэртай байлгах нөхцлийг бүрдүүлж өгдөг байна. Түүнээс гадна билчээрийн төрөл, далайн түвшнээс дээш ямар өндөрт байгаагаас, мөн хүрээлэн буй орчны тодорхой нөхцлөөс шалтгаалан мал маллах янз бүрийн систем хэрэглэдэг байна.

Хүрээлэн буй орчны экологийн багтаамжийн тухай орчин үеийн үзэл баримтлалыг төвдчүүд мэддэггүй ч байгаль ашиглалтынх нь үр дүн адилхан байдаг. Төвдчүүд байгалыг "байлдан дагуулахын" оронд амьдралын хэвшил, аж ахуйгаа байгальтай зохицуулжээ. Энх тайвнаар зэрэгцэн орших энэ хэвшил бурханы шашны нөлөөтэй үлэмж хэмжээгээр холбоотой билээ. Бүр 1642 онд V Далай лам "Байгаль, амьтан хамгаалах тухай зарлиг" гаргажээ. Жилийн тодорхой саруудад мал гаргахыг хориглож, ан ав хийхийг хатуу

зохицуулсан хуулиуд гаргаж байв.[488] Нүүдэлчид хоол хүнсний зорилгоор л хааяа нэг ан авд морддог байжээ. Жишээ нь, түвдчүүдэд айл гэрийн ойролцоо гөлөглөсөн чоно алахыг хориглосон заншил байжээ. Эх чоно үүрнийхээ хавь ойр амьтан барьдаггүйг харгалзан ийм журам баримталдаг байжээ (монголд ч чоно үүрэндээ өлзийтэй хэмээх зүйр үг байдаг). Хэрэв чоны бэлтрэгийг албал эх чоно тэр хавийн малыг барьж эхэлдэг ажээ.

Түвд, монголчууд ялангуяа ариун дагшин газар нутгийн амьтанд гар хүрдэггүй заншил одоо ч мөрдөгдсөн хэвээр байна. Жишээ нь, Түвдийн гандан хийдийн ойролцоох зэрлэг бор ятуу шувуунд хүмүүс гурван метрийн зайтай дөхөж очиход нисдэггүйг миний бие нүдээр харсан бөгөөд Монгол улсын Амарбаясгалантын хийд хавийн нутаг болон Богд хан уулын амьтны аймаг бусад газрынхтай харьцуулахад мэдэгдэхүйц олон төрөл бас тоо толгой нь ч олон юм билээ.

Суурин амьдралын нөхцөлд үйлдвэрлэлийн бааз сул хөгжилтэй, эдлэхүүний (натурал) аж ахуй эрхэлдэг, лам нарын тоо олон, олон нөхөртэй байдаг зэрэг уламжлалт аргаар хүн амын өсөлтийг хязгаарладаг нь байгаль орчинд үзүүлэх ачааллыг бууруулахад тус дөхөм болдог байна. Түвдэд олон нөхөртэй байх явдал ердийн үзэгдэл[489] бөгөөд энэ нь нэг гэр бүлд удмаа хадгалж, хүн амын өсөлтийг хязгаарлахад хэрэгтэй ажээ. Тийм гэр бүлүүдэд эмэгтэй хүн гол байр суурь эзэлж, тэдний нөлөө улам өсдөг байна. Насны хувьд хол зөрөөгүй хэд хэдэн ах дүү нар нэг эхнэртэй байдаг ажээ. Хадам эцэг бэртэйгээ сууж болдог, хэрэв бэлбэсэн авгай нөхөрт гарвал түүний охид хойт эцгийн эхнэр болдог тухай Вс. Овчинников бичжээ. Онцгой тохиолдолд л тийм хувилбарууд гардаг ажээ. Хэрэв эмэгтэй хүн хэд хэдэн нөхөр элээсэн ч хүүхэд гаргаагүй бол түүнийг бүх төрлийн алба, гучуураас чөлөөлдөг байна. Маш цөөн тохиолдолд олон эхнэртэй байх нь тааралддаг ажээ. Гэрлэлтийн эдгээр хэлбэр материаллаг байдал болон бусад тодорхой нөхцөл байдлаар тодорхойлогдоно.

Ардчилсан шинэтгэлээс өмнө түвдэд язгуууртны төр улс ноёрхож байв. Засгийн дээд эрх Далай ламд оногдоно. Бараг бүх түвшингийн засаг захиргаанд сүм хийдийн төлөөлөгчид орсон байдаг учир шар феодалын засаглал илрэн гарч байв. Далай ламын эрх мэдэл үнэмлэхүйд тооцогдож байсан ч тэрээр зөвлөлдөөний үндсэн дээр эрх мэдлээ хэрэгжүүлж ирсэн байна.[490] Далай ламыг байхгүй хойгуур буюу түүнийг бага настай байхад Үндэсний ассамблей засгийн эрхийг хэрэгжүүлж, засаг баригчийг томилно. Засаг баригчийн албан тушаал өрсөлдөгч бүлгүүдийн хооронд хэрүүл тэмцэл үүсэх шалтгаан болох нь цөөнгүй байжээ.



Төв түвдийн тариачид (Уоддель, 1906)

Засгийн газарт энгийн болон лам хүнээс бүрдэх хоёр шадар сайдын албан тушаал байна. Сайд нарын зөвлөл (Кашаг) иргэний удирдлагыг хэрэгжүүлнэ. Тус зөвлөл төрийн болон хувь хүний чанартай бүх асуудлыг хариуцах ажээ. Сайд нарын зөвлөлд гурван хар түшмэл болон нэг лам хүн орно. Сайд нарын зөвлөлийн харьяанд улс төрийн, цэргийн, эдийн засгийн, хуулийн, гадаад хэргийн, сангийн болон боловсролын газруудаас бүрдсэн удирдлагын байгууллага байна.[491] Бойдаа болон дөрвөн лам хүнээс бүрдсэн Зөвлөл шашны бүх хэргийг удирдана. Энэ байгууллага шадар сайдын захиргаагаар дамжуулан шашны асуудлаар байр сууриа Далай ламд танилцуулна. Бойдаа нь Далай ламын хувийн эрдэнэсийг хадгалагч байдаг бөгөөд ойн газрыг тэргүүлнэ.

Төрийн дээд албан тушаалд гол төлөв Далай ламын төрөл төрөгсөд, эртний овгийн, ялангуяа хаад болон тэдний сайд нарын овгийн төлөөлөгчид

ажиллана. Тийм гэр бүл ердөө 197 байв. Тэдгээрээс 25 нь хамгийн их нөлөөтэй байжээ. Язгууртнууд албан тушаал, эрх ямбын тухайд давуу эрх эдлэнэ.[492] Удам дамжсан язгууртнуудын нэг хүүхэд лам биш түшмэлүүдэд зориулсан албан тушаалд ажилладаг байна.[493] Гэхдээ энэ нь энгийн иргэдийн албан тушаал ахих үйл явцад саад тотгор болдоггүй ажээ. Түвдийн түүхэнд анги бүлгүүдийн доторхи хөдөлгөөн маш доогуур байсан хэмээх А.Т. Грюнфельдын[494] нотолгоо үндэслэл муутай юм.

Нэгдүгээрт, тариачдын бараг гэр бүл бүр наад зах нь гэхэд нэг хүүхдээ хийдэд суулгаж, өөр ангийн төлөөлөгч болгож байв. Санваартнуудын ихэнхи хэсэг тариачдын гэр бүлээс гаралтай хүмүүс ажээ. Хоёрдугаарт, хамгийн дээд тушаалын том лам нарын хойд дүр жирийн хүмүүсийн гэр бүлээс тодордог байв. Энэ систем нь нийгмийн бүтцийг нилээд харьцангуй болгох нөхцөл бүрдүүлжээ. Эцэст нь “доод” гаралтай хүн лам болох замдаа эрдмийн оргилд хүрч, төрийн дээд албан тушаалд очих явдал ч гардаг ажээ. Жишээ нь, XIX зууны дунд үед түвдийн засгийн газрын тэргүүн шадар сайдын албан тушаал хүртэл дэвшсэн Пишипаг нэрлэж болно.[495] Эрэлхэг зориг гаргасан жирийн цэрэг удам дамжсан цол хэргэм, газар авах явдал ч гарч байв.[496] Гэхдээ аливаа түшмэл Далай лам буюу ерөнхий сайд нарын дургүйг хүргэвэл албан тушаалаа амархан алдах ажээ. Ноцтой алдаа дутагдал гаргасан түшмэдэд хатуу шийтгэл оногдуулдаг байжээ. Тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд ч цээрлэл үзүүлдэг байв.[497]

Түвдийн бүх газар нутаг Далай ламын мэдэлд байдаг гэх боловч[498] засгийн газар, феодалууд болон сүм хийдийнхэн газар эзэмшин захирах гол үүрэг гүйцэтгэнэ. Тариачдад Далай ламын нэрийн өмнөөс газар эзэмшүүлнэ. Үүний төлөө тэд алба гувчуур төлж, хариуцлага хүлээнэ. Язгууртнуудын гэр бүлүүд өмнөх үеэс шагнуулсан их хэмжээний газар эзэмших бөгөөд үүнийхээ төлөө гэр бүлийн гишүүдээс нэг эр хүн төрд зүтгэх ёстой байв. Эдгээр гэр бүлийн зарим нь улсад мөнгө төлдөг бөгөөд энэ мөнгөний үлдсэн хэсгээр дээр дурдсан төрийн албан хаагчийн цалинг бүрдүүлнэ.[499] Хэрэв Далай лам хэн нэгэн хүнд буюу сүм хийдэд газар бэлэглэвэл түүнийг эзэмшигч этгээд олсон орлогыг бүрэн буюу заримдаг байдлаар эзэмшинэ.[500] Ийм газар эзэмшигч нь хувийн өмчтөн болж чаддаггүй, яагаад гэвэл тэрээр энэ газрыг худалдах буюу барьцаанд тавьж болохгүй. Түвд түшмэл албан тушаал хаших хугацаандаа газар эзэмших эрх эдлэнэ.

Засгийн газрын эдэлбэр газрыг дайчлагдсан тариачид болон хөлсний ажилчид боловсруулна. Энэ газраас олсон орлого улсын мэдэлд шилжинэ. Улсын газар боловсруулах үүрэг хүлээсэн хүмүүс нь тариачдын тэн хагас

хүрэхтэй үгүйтэй хувийг эзлэнэ.[501] Тэдэнд өөрийн гэсэн газар буюу мал байна. Орон нутгийн түшмэдийн олонхи нь эдгээр гэр бүлээс гардаг байна. Ажилтнуудын олонхи нь хөдөө орон нутагт буюу хот газар ямар ажил үйлчилгээ эрхлэхээ чөлөөтэй сонгох эрх эдлэнэ. Тариачдын гэр бүлүүд өөр хоорондоо нэгдэж, ахлагч нарыг сонгоно. Энэхүү ахлагч нар алба гувчуур, татвар төлөлтийн байдалд хяналт тавина. Түүнээс гадна энэ хүмүүс өөр бусад хүнийг ч шүүн таслах эрхтэй ажээ. Өөр хоорондоо нэгдсэн тариачдын амьдралын асуудлуудыг хурлаараа шийдвэрлэн зохицуулна.

Хятадын суртал нэвтрүүлэгчид өнөөг хүртэл түвдийн тариачдыг “хамжлагууд болон боолууд” хэмээн үзсээр байгаа бөгөөд энэ хүмүүс нийт хүн амын 95 гаруй хувийг эзлэх ажээ.[502] Эсвэл тэдгээр суртал нэвтрүүлэгчид: “ардчилсан шинэтгэл хийхээс өмнө Түвдэд боолууд, хамжлагын тариачид хэмээх хоёр бүлэг хүмүүс л байсан”[503] гэж бичиж байна. Үнэн хэрэгтээ бол байдал эрс өөр юм.

“Хамжлагууд” хүн амын хэдэн хувийг эзэлж байсан тухай бодитой тоо баримт үгүй юм. А.Т. Грюнфельд[504] 1959 оны хятад тоо баримтад тулгуурлан язгууртнууд хүн амын 5 %, лам хуврагууд 15%, нүүдэлчид 20%, “хамжлагынхан” 60 %-ыг эзэлж байна хэмээх тоо баримт дурджээ. Гэтэл “хамжлагынхан” гэгчид хамаатуулж болох хүмүүс 30 орчим хувийг л[505] эзэлж болох магадлалтай ажээ. Мөн түүнчилэн тариачид гэгдэх хүмүүс зарчмын хувьд эрх чөлөөтэй иргэд байсан бөгөөд жинхэнэ европ үгийнхээ утгаар бол хамжлагынхан гэж Түвдэд огт байгаагүй юм. Түвдийн “хамжлагын тариачид” гэдэг бол үнэн хэрэгтээ бие хүнийх нь эрх шүүхээр тогтоогдсон, эдгээр эрхийг баталгаажуулсан баримт бичигтэй, хууль ёсны шүүхэд хандах боломжтой фермерүүд[506] байсан юм. “Хамжлагын тариачдын” хэд хэдэн бүлэг байжээ.[507] Тариалангийн талбай боловсруулдаг хүмүүс эдэлбэр газартаа албан татвараар биш, харин ажил хөдөлмөрөөрөө холбогдсон хүмүүс байв. Хөдөөгийн “хамжлагууд” гол төлөв татвар төлөх үүрэгтэй, өртөө улаа нэхэх үүрэг хүлээсэн хүмүүс байв. Тэдгээрийн тэн хагас нь хувийнхаа эрх чөлөөг худалдаж авсан хүмүүс ажээ. Бүх “хамжлагууд” бол үндсэндээ түрээслэгчид байсан нь тэднийг хамжлагынхан хэмээн үзэх хууль ёсны үндэслэл байхгүй байснаар тодорхойлогдоно.

“Боолууд” гэгчид нь үнэн хэрэгтээ гэрийн зарч нар болон тухайн айлын ажил хэргийг хариуцан явуулагчид ажээ. Хэзээ нэгэн цагт авсан зээлээ төлж чадаагүй хүмүүс “боол” гэгчийн зэрэглэлд ордог ажээ. Тэд феодалуудын хувийн аж ахуйг эрхлэн явуулах ёстой хүмүүс. Зарцын статус үе дамжин залгамжлагдах ажээ. Тэд ихэнхи тохиолдолд эздийнхээ итгэмжлэгдсэн

хүмүүс байдаг учираас тариачдыг бодоход илүү өндөр статустай байв. У-Цангад боолчлол байгаагүй ч хил орчмын нутгуудад энэ байдал эрт дээр үеэс хадгалагдан үлдсэн байж болох талтай. Тариачид болон зарц нар бие даасан бүлгүүд байгаагүй юм.Тариачид зарц болох, зарц нар тариачдын эгнээнд шилжих явдал байлаа. XIII Далай ламын хийсэн шинэтгэлээс хойш гурван жилээс илүү хугацаагаар эзэмшил газартаа ажиллаагүй аливаа “хамжлагууд” ердийн хүний, өөрөөр хэлбэл төрийн “хамжлагын” статустай болж, харин 1944 онд түвдийн засгийн газар татвар төлөх чадваргүй ядуучуудыг өрөөс чөлөөлсөн захирамж гаргасан байна.[508]

Тариачдын олонхи нь өөрийн гэсэн эдэлбэр газартай байв. Гэхдээ тариачин хүн газрын эзэнд түүнийхээ өртгийг төлж чадаагүй, энэ эдэлбэр газрыг боловсруулах хүнийг олж чадаагүй бол тэрхүү газрыг орхиж явах эрхгүй байв. Эдэлбэр газрыг бусдад хувааж эдлүүлэхгүй, түүнийг бүх эрх, үүргийнх нь хамт том хүүдээ өв болгон шилжүүлэх ажээ. Бусад хөвгүүд нь гэрээсээ явах ёстой бөгөөд тэдний олонхи нь сүм хийдэд шавилан суудаг байв. Эцэг эхчүүд хүүхдээ өөрийнхөө болон бусад ах дүү нарынхаа амьдрал, ахуйг харж үздэг хүндтэй бөгөөд эрх дархтай тийм хүн болгохыг хүсч сүм хийдэд явуулдаг байжээ. Хэрэв “хамжлагын хүн” лам болвол түүний “эзэн” ямар ч нөхцөлд татгалзах ёсгүй юм. Тариачны хүү өөр газрын эзэнд очихдоо түрээслэгч буюу барлаг болж, хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж чадвал хэзээ ч өөр тийш явар эрхтэй юм. Энэ системийн дунд эзэмшил газруудыг үр, ач нартаа хувааж өгөх явдал гараагүй байна. Ингэснээр гэр бүлүүдийг тэжээхэд хүрэлцэхүйц хэмжээний хангалттай томоохон эдэлбэр газруудыг хадгалан авч үлдэж чадсан байна.[509] Бүх газар төрийн мэдэлд байна гэх боловч улсын мэдлийн тариачид үнэн хэрэгтээ газар эзэмшигчид болж, тэд ч газрыг худалдах биш, харин өв болгон үлдээхийг эрмэлзэх болжээ.[510]

Газар эзэмшигчээс өв дамжуулан түрээслэх эрхээр газар авсан тариачид түүнийг дэнчинд тавих, түрээслүүлэх, хөлсний хөдөлмөр ашиглах эрх эдлэнэ. Хэрэв ажилтан үнэнчээр зүтгэж өөрт олдсон газрынхаа хөлсийг төлсөн бол түүнд олгогдсон газрыг буцааж авахгүй байх боломж бүрдэнэ. Татвараа төлөөгүй буюу хөдөлмөрийнхөө үүргийг биелүүлж чадаагүй ажилтны газрыг л хурааж авдаг байв.[511] Тийнхүү түрээслүүлэгч газар олгож, харин тариачны хөдөлмөр түрээсийн төлбөр болдог байв. Тийм учир “хамжлагын тариачин” бүх насаараа эзний газарт хадагдаж, түүнээс төлбөр авдаггүй байсан хэмээн үзэх нь буруу юм.[512]

Эдэлбэр газартаа хэзээ юу ургуулах, ямар мал маллахаа тариачин хүн өөрөө шийддэг байжээ. Зарим хүний бичдэгээр энэ бүхнийг газрын эзэн



1



2

Амдогийн Лаврандашчил хийдийн Гонтан суварга: 1 – 1900-гаад он (Оросын газар зүйн нийгэмлэгийн архив, сан 18, данс 7); 2 – Соёлын хувьсгалын үед эвдэрсэн суварганы хуучин байран дээр шинээр босгосон нь (D. Croner авсан гэрэл зураг)



Дранангийн хөндий дахь Түвдийн хамгийн том Жамбалын суварга, 1938 он, эвдэрч сүйдэхээс өмнөх үеийн гэрэл зураг (Bundesarchiv, Bild 135-S-13-06-35/ foto: Ernst Schaefer License CC-BY-SA 3.0)

шийддэггүй байжээ.[513] Газрын эзэн шаардлагатай гэж үзвэл "хамжлагын" тариачинд мал болон тариалалтын материал өгдөг байв. Орон сууцны байшин эзэмших нөхцөлд ч татвар, алба гувчуурын систем үйлчилнэ. Тариачид түүний хүрээнд ажлаа хэрхэн хуваарьлахыг өөрсдөө шийднэ. Байшингийн эзэн татвар, алба гувчууртай холбоотой асуудлыг л хариуцахаас биш бусад тохиолдолд тариачдын амьдралд оролцохгүй.[514] Бүх үүрэг хариуцлага биеэлсний дараа сууц эзэмшлийн бүх гишүүн эрх чөлөөтэй болж, юу дуртайгаа хийх, жишээлэхэд эргэл мөргөл хийх зорилгоор өөр газар руу явах буюу төрөл төрөгсдөө эргэж тойрохоор явах эрхтэй болдог байна.

Тариачид ид ажлын үед хоногт 18 цаг ажиллана. Энэ бол "хамжлагын тариачдын" хөдөлмөрийг мөлжиж буй хэрэг биш юм. Цаг агаар хүйтэрсний улмаас ургацаа алдахгүй гэсэндээ л тэд ийнхүү уртасгасан өдрөөр ажилладаг ажээ. Харин ургацаа хураасны дараа тэдэнд цаг зав их гарах бөгөөд зарим гадаадынхан түвдчүүдийг залхуу амьтад хэмээн нэрлэдэг байжээ. Тийнхүү зун цагт ажиллах хүн хүрэлцэхгүй шахам болж, харин өвөл ажил бага болдог ажээ. Түвдчүүд, ялангуяа өвлийн цагт ийш тийш их явна. Энэ үеийг түвдэд одоо ч эргэл мөргөл хийхэд өргөн ашиглаж байна.[515]

Шаардлага гарсан үед газрын эзэн тариачныхаа хөдөлмөрийг өөр хүнээр түрээслүүлэн хийлгэнэ. Үүнийг зүүний суртал нэвтрүүлэгт "хамжлагын тариачныг худалдах" явдал[516] хэмээн нэрлэдэг ажээ. Зарим өндөр тушаалын түшмэд нилээд том хэмжээний газартай байв. Жишээ нь, нэгэн засаг баригчийн эдэлбэр газарт 5 мянган тариачны аж ахуй байжээ. Зарим язгууртан 10–20 мянган хараат тариачин ажиллуулж байв.[517]

Уламжлалт удирдагчид болон газрын эзэд ихэнхдээ дарлан мөлжигчид биш. Тэд сүсэг бишрэлийн үрээр, мөн тариачдын хөдөлмөрөөс хараат байсныхаа улмаас "хамжлагууд" болон "боолуудтай" дэндүү харгис харьцаж чаддаггүй байв. Түвдийн ихэс дээдэс баян чинээлэг, харин энгийн


Суурин амьдралтай түвдчүүдийн байшин (С.Л. Кузьмины авсан гэрэл зураг)

хүмүүс гуйланч ядуу байсан тухай бичдэг хүн олон бий. Гэтэл тэндхийн амьдралыг нүдээр үзсэн хүмүүс түвдийн янз бүрийн давхаргынхны орлогын ялгаа тийм ч их бишийг тэмдэглэдэг билээ. Энэ ялгаа, жишээлэхэд Орос, Европын орнууд буюу хятадынхаас харин ч бага юм. Түвдийн тариачид дунджаар хятадын тариачдыг бодвол баян юм байна гэж 1940-өөд оны үеийн жуулчид тэмдэглэсэн байдаг. Олон улсын хуульчдын холбооны дүгнэлтээр бол хуучин Түвд дэхь олонхи хүний амьдралын хангамж европын зарим орныхтой ойролцоо байжээ.[518] "Хамжлагынхан" заавал ядуу хүмүүс байгаагүй. Олон ийм хүн хөрөнгө чинээтэй, зарц үйлчлэгчтэй[519] байжээ. Нөгөө талаас баян худалдаачдын идэж хэрэглэдэг хоол хүнс үндсэндээ тариачдынхтай адил: мах, шар тос,бяслаг, цай ажээ. Бусад олон орноос ялгаатай нь гэвэл түвдэд дээд давхаргынхан доодчуулаас хэт их хөндийрөөгүй, эдгээрийн харилцаа ихэнхдээ эв найрамдал, нөхөрлөл болон хувирдаг ажээ.[520] Доод давхаргын төлөөлөгчид болох ярганыхан (мал нядлагчид) хүртэл язгууртнуудтай найз нөхөд байх нь олонтаа тохиолдоно. 1959 онд хятадууд Самьегийн язгууртнуудыг баривчлан хориход тэдний зарц байсан хүмүүс нууцаар хоол унд авчирж өгч байжээ. "Тэрхүү газрын эзэн харгис хэрцгий, дураараа авирласан ноёнтон биш, харин эцгийн талыг баримталсан байшингийн эзэн л хүн юм билээ" гэж учир явдлыг нүдээр харсан хүн нотлон бичжээ.[521]

Түвдийн тариачид энэтхэгчүүдийнхээс нилээд тохилог чулуун байшингуудад суудаг юм билээ гэж дээр дурдсан хүн хэлжээ.[522] Түвдийн төв нутагт эрт дээр үеэс чулуун байшин барьж иржээ. Ийм байшинг нэгдмэл схем бүхий өвөрмөц шийдлээр барьдаг бөгөөд нүүрэн талыг нь ихэвчлэн урагш харуулдаг нь наранд илүү сайн халаах зорилготой ажээ.Барилгын гол материал бол тоосго, чулуу. Нэгдүгээр давхарын талаас хоёр давхар болгож өндөрсгөнө.[523] Хаалга, цонхны рамыг хар цементээр хийх буюу хар өнгөөр буддаг нь цонхоор нарны гэрэл их оруулах зорилготой ажээ. Байшингийн дээврийг хавтгай байлгадаг нь тэнд уламжлал ёсоор түлээгээ хурааж, янз бүрийн мөргөлийн дарцаг байрлуулдагтай холбоотой юм. Сүмийн барилгын янз төрх Балба, Энэтхэг, Хятад уламжлалын нөлөөн дор бий болсон байна.



Нүүдэлчин түвдчүүдийн майхан (Пржевальский, 1883)

Нүүдэлчид сарлагийн хөөвөр савгаар том, жижиг янз бүрийн хэмжээтэй майхан (палатка) хийнэ. Зарим иим сууцыг хэд хэдэн өрөө тасалгаатай хийх бөгөөд 100–200 хүний багтаамжтай байна. Нүүдэлчдийн лагерийн эргэн тойронд янз бүрийн мөргөлийн дарцаг хийсгэнэ.

Ямар ч ажилтан өөрийн гэсэн байшин барих эрхтэй. Жишээ нь, гэр бүл нь түвдийн хамгийн ядуу давхаргад хамаардаг Тондуп Чойдон "чөлөөлөлтөөс" өмнөх амьдралаа ийнхүү дүрслэн ярьж байна.[524] "Би бол түвд хүн. Хамжлагынхан хэмээн хятадуудын нэрлээд байгаа тэр бүлэгт хамаарна. Манайх ам бүл зургуул, хоёр давхар байшинтай, гадуураа хэрмэн хашаатай байв. Бид нэгдүгээр давхартаа 4 сарлаг, хонь, ямаа нийлсэн 27 бог, хоёр илжиг оруулдаг, 0,37 га газартай байлаа. Бидэнд амь зуулгаа хангахтай холбогдсон бэрхшээл хэзээ ч тулгарч байгаагүй. Манай мужид нэг ч гуйлан

ч ядуу хүн байгаагүй". Ингэхлээр "энх тайван чөлөөлөлтөөс" өмнө түвдийн нэг сая хүн амын 900 мянга нь орон гэргүй байсан хэмээх нотолгоо хачин сонсогдож байгаа биз.[525] Хэрэв түвдчүүдийн 90 хувь нь толгой хоргодох оронгүй байсан бол энэ ард түмэн аль хэдийнэ мөхөх байсан бизээ. Феодалуудын "хамжлагат" иргэдийн амьдрал муу байсан тухай олон тооны яриа тэднийг коммунист хятад улс "чөлөөлснөөс" хойш л бий болжээ.

Хамгийн ядуу зарц нар болон "хамжлагууд"-ын талаар хэзээ ч шашин шүтлэгийн болон шилжин суурьших боломжийн тухайд хязгаарлалт тавьж байгаагүй ажээ.[526] Харин түр хугацаагаар өөр тийш явах хэрэг гарвал хариуцсан хүнээс тусгай зөвшөөрөл авдаг байжээ.[527] Тариачин хүн мөн бүрмөсөн өөр тийш явахыг хүсч байгаа тухайгаа газрын эзэндээ мэдэгдсэн бичиг барьж болдог байв.[528] Ийнхүү явах болсон тохиолдолд тодорхой хэмжээний төлбөр өгөх хэрэгтэй болдог байжээ. "Хамжлагынхан" тохиролцолгүй, дур мэдэн явсан нөхцөлд тэднийг эрж олоод хуучин ажиллаж байсан газарт нь буцааж тавьдаг байжээ. Гэхдээ ийм явдал тун цөөн гардаг байв. Ажлаа хүнд хэцүү байна гэж үзсэн "хамжлагын" тариачин түүнийг хөнгөвчилж өгөхийг хүссэн хүсэлтээ эзэндээ бичгээр илэрхийлэх бөгөөд түүний үр дүн олон хүчин зүйлээс шалтгаалах ажээ. Хэрэв эзэн зөвшөөрөхгүй бол "хамжлагын" тариачин Түвдийн алслагдсан нутаг буюу Энэтхэг рүү оргож явах нь олонтаа ажээ.[529] Яагаад гэвэл тэр үед үр нөлөөтэй цагдаагийн алба гэж байгаагүй юм.

Түвдчүүдийн олонхи нь газар тариалан, цөөнх нь мал аж ахуй эрхлэн амьдарна. Малчид, тариачид бараа таваараа солилцоно.[530] Нэг овог аймгийн хүмүүсийн зарим нь мал маллаадаг, нөгөө хэсэг нь тариа тарьж амьдрах явдал ч цөөнгүй байжээ. Нүүдэлчдийн хувьд малын билчээр нийт овог аймгийн өмч байдаг бол мал нь гэр бүлийн өмч байх жишээтэй. Түүнчилэн феодалуудын малыг төлбөр төлж түрээслэн малладаг практик ч байсан ажээ. Түрээслэгчид чөлөөтэй нүүдэл суудал хийж, өөр газарт шилжин суурьших эрх үл эдлэнэ. Өөрийн гэсэн малтай иргэд л чөлөөтэй нүүж явдаг байв. Зоотехникийн ажил сул дорой хөгжилтэй байсны улмаас малын үхэл хорогдол их буюу 80 хувьд хүрэх явдал ч байсан, хятадын суртал нэвтрүүлэгчид ганц ч толгой мал үлдэлгүй хорогдсон тухай мэдээлж байжээ.[531] Малын тоо толгой хэлбэрэлтгүй хорогдож байсан биш, хэлбэлзсэн үзүүлэлттэй байсан нь ойлгомжтой, эс тэгвээс ганц ч толгой малгүй болох байсан бизээ.

Түвдийн татвар оногдуулалтын үндсийг натурал татвар бүрдүүлж, мөнгөн татвар хоёрдугаар зэргийн үүрэг гүйцэтгэж ирсэн байна.[532] Энэ

зорилгоор хүн амын тооллого байнга хийж, газрын кадастрын зураг гаргадаг байв. Сүм хийдийн газруудыг татвараас чөлөөлж, бас олон сүм хийд засгийн газраас гол төлөв хоол хүнсний хэлбэрээр тэтгэлэг авч байлаа. Газрын татварыг арван нэгдүгээр, арван хоёрдугээр, нэгдүгээр сардуудад гурав хуваан төлж болох ажээ. Малын тоо толгойноос хамааран татвар ногдуулна. XIX зуунд 10 хонины нэгийг өгдөг байсан бол 1914 оноос засгийн газар давс, малын арьс шир, үс ноос, ноолуур, хятадаас оруулж ирдэг цайнаас татвар авдаг болсон байна.[533] Эхнэр авах, хүүхэд төрөх, хүн нас барах, мод тарих, амьтан тэжээх, өөр тосгонд очиход “татвар” авдаг байсан тухай мэдээ ч бий.[534] Бодит байдалд бол энэ нь татвар биш, харин тодорхой, тодорхой төрлийн хураамж байсан ажээ. Жишээ нь, тариачин хүн “өөр эзэнд хамаарах хамжлага бүсгүйтэй” гэрлэхэд хүрвэл тэр эзэнд хураамж өгөх хэрэгтэй болох ажээ. Мөн өөр тохиолдолд тэр “эзэн” хамжлага эмэгтэйн оронд сүйт залуугийнхнаас нэгэн бүсгүй авах жишээтэй ажээ. Үүнийг “хүний солилцоо” хэмээн нэрлэж байсан бөгөөд хот айл бүр дэх тариачдын тоог тогтвортой байлгах нөхцөл бүрдүүлжээ. Хэрэв “хамжлага” бүсгүйчүүд хуучин эзэндээ үлдэж, хүү төрүүлбэл тэрээр ноён нөхрийн “хамжлага”, охин төрүүлбэл тэр нь хатан эхийн “хамжлага” болох жишээтэй. “Хамжлагуудын” хүүхдүүдийг төрмөгц нь тусгай бүртгэлд оруулах ажээ.

XIX зууны сүүлч XX зууны эхээр Түвдэд очиж байсан европчуудын мэдээлснээр бол газар тариалан эрхлэгчид ургацынхаа гуравны нэгийг, малчид мал аж ахуйн бүтээгдэхүүнийхээ 60 хүртэлх хувийг рентийн хэлбэрээр (түрээс) өгдөг байжээ.[535] Татварын хэмжээг ургацын байдлаас шалтгаалан жил бүр тогтоодог. Иймийн учир татвар нь тариачдын хувьд тийм ч дааж давшгүй зүйл биш байлаа. Район бүрээс авах татварын хэмжээг засгийн газар тодорхойлох бөгөөд харин орон нутагт тухайн нөхцөл байдалд тохирсон өөрийн гэсэн татвар ноогдуулдана. XIV Далай лам засгийн газар, шинэтгэлийн асуудал эрхэлсэн хороотой зөвлөлдсөний дүнд энэ системийг өөрчилсөн байна. Одоо гацаа, тосгоны удирдагчид улсын санд зориулсан, тогтоосон хэмжээний мөнгө цуглуулж өгөх ёстой бөгөөд засгийн газар үүний хариуд тэдэнд цалин пүнлүү тогтоож өгсөн байна.[536]

Татвараас гадна улсын чанартай албан журмын хөдөлмөр байсан бөгөөд өртөө улаанд тариачин хүн жилд хэд хэдэн удаа уналга, ачааны мал болон малын тэжээл нийлүүлдэг (энэ албанаас зөвхөн сүм хийдүүд чөлөөлөгдөнө), хадлан хадах, нэхмэлийн бүтээгдэхүүн гаргах, мод түлээ бэлтгэх, далан хаалт барих, засварлах зэрэг боловсруулалтын ажил хийх,

бүтээгдэхүүн, нэхмэл эдлэл, цаас зэргээр илэрхийлэгдэх тусгай татвар өгөх ёстой байв. XIII Далай лам өртөө улааг халж, тээврээр үйлчлүүлсний тогтоосон хэмжээний төлбөр бий болгосон нь жирийн хүмүүсийн орлогыг нэмэгдүүлжээ. XIV Далай лам энэ төлбөрийг улам нэмсэн байна.

Гудамжинд гуйлга гуйдаг хүмүүст ч татвар оногдуулдаг байсан гэж М. Паренти бичжээ. Үнэн хэрэгтээ бол гуйлгачид өөрийн гэсэн толгойлогчтой нэг ёсны "бүлэг" бүрдүүлж байсан бөгөөд тэр толгойлогч нь гуйлгачин нараас татвар авдаг байжээ. Гудамжны энэ гуйлгачид ч мөн удам дамжсан шинж чанартай байв. Гуйлгачид, ялангуяа ийм хөгшчүүдэд нилээд энэрэнгүй байдлаар хандаж, гуйлга гуйх явдлыг нэг ёсны мэргэжил хэмээн үздэг байжээ.[537] Түвдэд одоо ч ийм хүмүүс цөөнгүй байна.

Татварын журмаар авсан бүтээгдэхүүнийг хадгалах систем үйлчилж байв.[538] Илүүдэл бүтээгдэхүүн, ялангуяа үр тариаг хувийн болон улсын агуулахуудад хадгална. Ургац алдах буюу мал сүрэг хорогдсон тохиолдолд нөөцөлсөн бүтээгдэхүүн гурван жилд хүрэлцэх ажээ. Хүн амын тоо цөөн, том хотууд бий болоогүй, хэрэглээний түвшин харьцангуй бага байсан явдал тийм хуримтлалыг оновчтой ашиглах боломж бүрдүүлжээ. Түүхэн эх сурвалжуудаас үзвэл дээрх бүхний дүнд Түвдэд өлсгөлөн гэж тохиолдож байгаагүй ажээ. Тус улс зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүн гаднаас авахаас биш хүнсний гол гол эх үүсвэрээр өөрийгөө бараг бүрэн хангажээ.

Албан журмын хөдөлмөр эрхлэлт нь цөөнгүй тохиолдолд албан тушаалаа урвуулан хэрэглэхэд хүргэж, энэ нь жирийн ард түмэнд хүнд дарамт болж байв. Жишээ нь, янз бүрийн түшмэд улсын бэлтгэл гэгчийн нэрээр тариачдыг өөрсдийн газарт ажиллуулж, албан ёсныхоо хүмүүсийн тоог нэмэгдүүлэхэд хүргэж байв. Ийм тохиолдолд дээрх буруу үйлдлийг таслан зогсоох гэсэн чин улсын амбан сайд нар нэг ёсны "хяналтын шат дамжлагын" үүрэг гүйцэтгэх болжээ.[539] Гэвч амбан сайд нар ч өөрсдөө амин хувийн ашиг хонжоо харах явдал гарах болсон байна. Түвдэд манж амбан нар суухаа больсоноос хойш XIII Далай лам 1913 онд гаргасан зарлигтаа орон нутагт дэг журам тогтооход онцгой анхаарал хандуулжээ.[540]

"Түвдийн засгийн газрын иргэний болон цэргийн түшмэл нар татвар хураах буюу өөрсдийн мэдэлд буй иргэдтэй харьцахдаа харьяаныхаа хүмүүст хор хохирол учруулах биш, харин засгийн газарт ашигтай байдал бий болгохын тулд үүрэг хариуцлагаа шудрагаар биелүүлэх ёстой <...> Үүнээс хойш хэн ч сул чөлөөтэй байгаа газар эзэмшихэд нь хэнд ч саад тотгор учруулах ёсгүй. Энэ тохиолдолд гурван жилийн хугацаанд газрын татвар авахгүй. Үүний дараа газар боловсруулагч нь жил бүр засгийн газар

болон газрын эзэнд хувь тэнцүү татвар төлөх ёстой болно. Боловсруулж буй газар нь газар эзэмшигчийн мэдэлд байна” гэж энэхүү зарлигт өгүүлсэн байна.

XIII Далай лам нас өндөр болсон зарц үйлчлэгч нарыг ажлаас халахыг, нас өндөр болсон эцэг эхээ хөөж явуулахыг тус тус хоригложээ. Түүний үед мөнгө хүүлэгчдийн зээлийн хүүг хязгаарласан байна. Мөнгө хүүлэгчид тариачдад жилийн 20 хувийн хүүтэй үр өгөх болсонтой холбогдуулан ийм арга хэмжээ авсан байна.[541] Малчдын тэн хагас гаруй нь худалдаачид болон дамын наймаачдаас бүтээгдэхүүн авч байсан нь тэдэнд багагүй дарамт учруулж байсан юм гэж хятадын талын мэдээнд өгүүлсэн байна. БНХАУ-ын халдлагаас өмнөхөн XIV Далай лам язгууртнуудын томоохон эдлэн газруудын зарим хэсгийг төрийн мэдэлд эргүүлэн авч, тэдэнд нөхөн төлөөс олгох, газрыг тариачдад хуваарилан өгч, төрийн бүх албан хаагчдыг зөвхөн цалингаар амьдардаг болгох шийдэр гаргажээ.[542]

Сүм хийдүүд томоохон газар эзэмшигчид болсон байв. Төв Түвдэд 1950 он гэхэд хагалсан бүх газрын 36,8 хувь нь сүм хийдийн мэдэлд байв.[543] Зарим хийд олон зуун жилийн хугацаанд үлэмж их баялаг хуримтлуулжээ. Гэхдээ хийд бүр их хэмжээний өмчтэй байсан хэрэг бас биш юм. Зарим хийд лам нарынхаа хэрэгцээг хангах ч хөрөнгөгүй болсон байв. Тийм хийдүүд амиа аргацаахын тулд наймаа арилжаа эрхлэхэд хүрч байв. Онцгой эрх дархтай лам нар ийм ажил эрхэлж байжээ.[544] 1913 онд XIII Далай лам итгэл үнэмшлийнхээ цэвэр ариун байдлыг сахин мөрдөх захирамж гаргажээ. “Түвдийн бурханы шашны янз бүрийн чиглэл (сургууль) өөрсдийн өвөрмөц байдал болон ёс уламжлалынхаа цэвэр ариун байдлыг хадгалах ёстой <...> Зарим нэг тусгай хүмүүсээс бусад бүх сүм хийдийн захиргаа наймаа арилжаа, мөнгө хүүлэх үйл ажиллагаа эрхлэх, мал өсгөх буюу бусдын харьяатуудыг захирахыг хориглоно” гэж энэхүү захирамжид өгүүлжээ.[545]

Сүм хийдийн газрыг хийдийн болон хувийн гэж авч үзэж байв. Хувийн газар гэдэг нь том толгой лам нарын хойд дүрүүдэд оногдох бөгөөд энэ газрыг өв залгамжлан эдлэхгүй, ийм лам нарын хойд дүр янз бүрийн гэр бүлд тодордог байна. Лам нарын олонхи нь тариачны гэр бүлээс гаралтай ажээ. Тэд эд материалын дэмжлэг байнга авч байсан гэр бүлийнхэнтэйгээ бат бэх холбоогоо хадгалдаг ажээ. Түвдчүүд лам нарын тоо олон болж байгааг хүнд ачаа хэмээн үздэггүй ажээ. Лам нар бол юу ч хийхгүй гар хумхин суугчид биш, нийгмийн сайн сайхан байдал, ёс суртахууны эрүүл саруул, тогтвортой байдлыг идэвхтэй бүтээгчид гэж түвдчүүд үздэг юм. Үүний эцсийн үр дүн бол гэгээрсэн багш нар мөн бөгөөд тэдний цэцэн мэргэн ухаан, ард түмний

удирдагчийн практик заавар зөвлөлгөө улс оронд үнэхээр чухал хэрэгтэй ажээ. Монголд ч тийм байсан билээ. Гэвч коммунист ба ашиг хонжоо харсан хөрөнгөтний уламжлалаар хүмүүжсэн хүмүүс үүнийг ойлгодоггүй ажээ. Эндээс л "паразитлагч лам нарын тухай", лам нарыг устгаж, тэдний тоог цөөрүүлэх шаардлагын тухай үзэл баримтлал гарч ирж байгаа билээ. Коммунистууд засгийн эрхийг булаан эзэлснийхээ дараа олон түвд, монгол хүнд тийм үзэл бодол суулгаж чаджээ.

Түүнээс гадна лам нарын тоо олон байсны дүнд төрөлт буурсан, Түвдийн хөдөө аж ахуй ашиг шим багатай учраас хүн амын тоо их байх шаардлагагүй билээ. Эцэст нь, нас өндөр болсон лам нарыг хийд нь тэжээдэг учир тэд гэр бүлийнхэндээ дарамт ачаа болдоггүй байна. Нийт нийгэм нь сүм хийдэд мөнгө цуглуулж өгдөг учир өвгөн лам нарыг ийнхүү тэжээдэг нь нэг ёсны өндөр насны тэтгэвэр болж байгаа юм.[546]

Лам нар төрөлхийн авьяас, сонирхлоосоо шалтгаалан гурван чиглэлээр "мэргэждэг" байжээ. Оюун ухааны хичээлд үнэхээр дур сонирхолтой хүмүүс нь эрдэм ухаанд хүчээ сорьж, бусад нь шашны зан үйл, ёслолын талын ажиллагаанд илүү дур сонирхолтой болдог байна. Дээр дурдсан хичээл, сонирхолд дур муутайхан хүмүүс нь хийдийнхээ дотор янз бүрийн албан тушаалд томилогдож, аж ахуйн ажил эрхлэн хөтлөх ажээ.[547] "Тариачдын хүүхдүүдийг насан туршын албанд татаж, үйлчлэгч – зарц, бүжигч эмс, цэрэг болгодог байсан" хэмээх нотолгоо хачирхалтай сонсогдох бизээ.[548]

Түвдчүүд заавал үйлдэх зан үйлийг биелүүлэхийг чин сэтгэлээсээ хичээж, шашны боловсрол эзэмшихэд их анхаарал тавьж иржээ. [549] Зоологч, угсаатны зүйн судлаач Ч.Стонор маш гярхай ажиглалт хийжээ:[550] "Шерпүүдийн оронд би санваартны өрөө, бурхан тахилаа тавих тавцан, эдлэл хэрэглэл, ханын зураг бүхий мөргөлийн газар шиг тансаг бөгөөд гоё сайхан зүйл үзээгүй билээ. Хэрэв энэ бүхнийг мөнгөнд шилжүүлбэл хэд хэдэн мянган рупийн тоо гарах нь магадтай бөгөөд ийм хэмжээний мөнгийг гэр бүлийн хадгаламжаас гаргана гэдэг бол багагүй өглөг болох бизээ <...> Чин сэтгэлээс гарах сүсэг бишрэлийн итгэл үнэмшил л шерпүүдийг мөргөлийн газар байгуулахад хүргэдэг ажээ".

Түвд уламжлалаар бол ухаалаг бөгөөд ёс төртэй амьдрал эд агуурс хуримтлуулахаас хамаагүй чухалд тооцогдох бөгөөд энэ бол шашны онол биш, харин өдөр дутмын практик ажил үйлс ажээ.[551] Түвдчүүд "мөнгө хийх" ажлыг идэвхтэй эрхэлж буй өнөө үед ч тэд орон нутгийн сүм хийд, сургууль, эмнэлгүүдэд орлогынхоо үлэмж хэсгийг зориулж байна.[552] Алдар нэрд гарсан түвдчүүд олон зууны туршид өглөгийн үйл ажиллагаа явуулж

иржээ. Заримдаа, жишээлэхэд баян чинээлэг хүн нас барахад түүний гэр бүлийнхэн ийм өглөгийн үйл ажиллагааг үлэмж хэмжээгээр явуулж, хаад болон ихэс дээдэс сүм хийдэд их хэмжээний бэлэг сэлт өгдөг байжээ. Зарим хүн өөрсдийнхөө сүсэглэдэг сүм хийдэд байнга эд материалын тусламж үзүүлж, тэднийг ч эдгээр сүм хийдийн ивээн тэтгэгчид хэмээн үздэг байв. Баян хүмүүс ядуу тариачдад ч өглөгийн гар сунгах ажээ. Баян түвдчүүд маш олон хүн хамарсан дайллага цайллага зохион байгуулдаг тухай тэр үеийн хүмүүсийн дурсамжид тэмдэглэн үлдээжээ.[553] Тийнхүү өглөгийн үйл ажиллагаа явуулах нь зүгээр нэг уламжлал төдий зүйл бишээ. Энэ бол Гэгээрэлд хүрэх зам дахь зургаан гайхамшгийн нэг, бурханы шашны сургаалийн нэг үндэс мөн.

Түвдэд экспорт, импортын валютын зохицуулалт, хязгаарлалт гэж байсангүй.[554] Эдийн засаг нь бүрэн хэмжээгээр зах зээлийнх байв. Түвдийн засгийн газар 1914 оноос хуучин байсан алт, мөнгөн зоосон дээр нэмж зэс зоос цутгаж эхэлсэн байна.[555] Эдгээрийн зэрэгцээ энэтхэгийн, чин улсын мөнгөн тэмдэгт, мөнгөн ембүү гүйлгээнд явж байв. 1890 оноос 5, 10, 15, 25, 50 мянган сангкийн цаасан мөнгө үйлдвэрлэн гаргах болсон байна. Цаасан мөнгө гаргах технологи судлуулахаар Галигдаа хот руу явуулсан хоёр Түвд хүний тусламжтайгаар ийнхүү мөнгө хэвлэх болжээ. Энэхүү цаасан мөнгө засгийн газрын алтны нөөцөөр баталгаажжээ.[556] Түвдийн тусгаар тогтнолыг батлан харуулахын тулд ийнхүү цаасан мөнгө, шуудангийн марк хэвлэн гаргажээ.[557]

Түвдийн засгийн газар хилийн ойролцоох худалдааны төвүүдэд хүргэж ирсэн бараа таваараас худалдан авах зорилгоор жингийн цуваа явуулж байлаа. Худалдаачдаас зарим төрлийн татвар авдаг хийдүүдийн ойролцоо Хятад, Балба, Ладакийн бараа таваарын арилжаа зохион байгуулах ажээ. Малын үс ноосыг Энэтхэг рүү, тэрч байтугай Хятадаар дамжуулан Нью-Йорк руу гаргаж байв. Түвдийн хуульд үл захирагдах эрх эдэлж байсан балбын худалдаачид Энэтхэгтэй хийх худалдааг хяналтандаа барьж байв. Түвдчүүд мөн Японтой худалдаа хийж байв. ислам сүсэгт худалдаачид Кашмираас хэдэн зууны тэртээгээс Түвдэд ирж, тэнд аж төрөн сууж, маш баян чинээлэг амьдарч байжээ. Лхаст мөн Бутаны гар урчууд сууж байв. Гэхдээ XIX–XX зуунд Манж чин, дараа нь Хятад улс Түвдийн худалдааны гол түнш болж байв. Сарлагийн хөөвөр, саваг (АНУ-д Санта-Клаусын сахал хийх гэж худалдаж авдаг), тунсаа (төмөр гагнахад хэрэглэдэг бүтээгдэхүүн) болон давс экспортын үндсэн бүтээгдэхүүн болно.[558] Мөн арьс шир, зaарь (хүдрийн), үнэртэн танартан, эмийн ургамал, байвгайн доньд (хатаасан

цөс), бугын цусан эвэр их биш хэмээгээр гаргадаг байв. Мөн адуу, илжиг, луус, хонь, ямаа ч арилжаанд орно. Энэтхэгээс ноосон даавуу, хөвөн цаасан даавуун эдлэл, торго, хөвөн, керосин, шил, гар урлалын бүтээгдэхүүн, төмөр, зэс, тутрага (цагаан будаа), жимс жимсгэнэ, эм худалдаж авна. Хятадаас цай, торго, шаазан эдлэл, пааландсан (сиян) сав суулга, хадаг, Балбаас тутрага, зэс эдлэл тус тус худалдан авах ажээ. Лхаст оруулж ирсэн даавуун эдлэлийн тавны хоёр хувийг төвдийн бусад нутаг руу зөөж аваачна.[559] Тийнхүү төвдийн нийгмийн хөрсөнд энгийн таваарын үйлдвэрлэл болон таваар-мөнгөний харилцаа өсч, мөнгөн рент үүсч бий болов.

XIII Далай лам Сиккимд сууж байсан английн төлөөлөгч Ч. Беллтэй шинэчлэлийн асуудлаар зөвлөлдөж, Лхаст бүтэн жил байхыг түүнд зөвшөөрсөн байна. Англи улс тусламж үзүүлнэ хэмээн Белл амлажээ. Юуны өмнө XX зуун гэхэд байлдах чадвар нь доод хэмжээнд байсан төвдийн армийг шинэтгэх хэрэгтэй байлаа. Хилийн алба гүйцэтгэх, зам харилцааг дээрэмчдээс хамгаалах явдал армийн үндсэн үүрэг байв. Энэхүү арми хэв журам сахиулж, оргодол босуул “хамжлагуудыг”[560] баривчлахын тулд л газрын эздийн эрх ашигт нийцүүлэн цагдаагийн үүрэг гүйцэтгэж байсан хэмээх нотолгоо ч үнэнд үл нийцнэ.

Англичууд төвдэд пулемёт, уулын их буу болон сум хэрэгсэл өгнө гэж амласан боловч эдгээр зэвсгийг хятадын эсрэг хэрэглэхгүй байх болзол тавьсан байна. Англичууд мөн Гьянзце, Лхасын хооронд цахилгаан холбоо тавих, ашигт малтмалын хайгуулын ажил хийхэд туслахаа амлажээ.[561] Цахилгаан техник, уул уурхайн ажил болон цэргийн хэрэг, цахилгаан холбооны ажил судлах дөрвөн Төвд хүнийг Англи руу явуулав. Орос, Герман, АНУ-д төвдчүүдийг сурган бэлтгэх ажил зохион байгуулах гэсэн боловч бүтсэнгүй. Энэтхэг болон Гьянзед английн сургагч нар төвдчүүдийг цэргийн хэрэгт сурган бэлтгэв. Төвдийн армид оросын сургагч нар (төвдээр ярьдаг буриадууд), японы цэргийн зөвлөх нууцаар ажиллаж байв. 1913 онд Далай лам жирийн ард түмний дундаас гарсан Цэрэнг армийн ерөнхий командлагчаар томилов. Далай лам армийн цэргийн тоог 15 мянган хүн хүртэл нэмэгдүүлэхийг санал болгов. Засгийн газар 1914 онд англичуудаас таван мянган винтов буу, таван зуун мянган сум худалдаж авсан байна.[562] Гэвч түүний энэ үйлдэлийг гурван “аугаа их хийд” дэмжсэнгүй. Тэр гурван хийдийн тэргүүн хамба нар татвар тогтоосны улмаас лам нарын тоо цөөрөхөөс болгоомжилжээ.[563] Гэсэн хэдий ч тэд хятадын аюулыг ойлгож байлаа. Эцсийн дүнд засгийн газар армийг аажим аажмаар өргөжүүлж, лам нарыг цэрэг татлагаас чөлөөлөх тухай зааж тодорхой



Хоёр түвд зоос (С.Л. Кузьмины авсан гэрэл зураг)

хэмжээгээр буулт хийсэн хувилбар баталсан байна. Манай ард түмэн, ялангуяа лам нар үнэхээр хуучныг баримталсан үзэлтэй учир армийг шинэчлэх ажил эсэргүүцэлтэй тулгарч байна гэж Далай лам тэр үед Их Британийн элч төлөөлөгч Д. Макдональдад ярьж байжээ.[564]

XIII Далай ламын үед Түвдэд цахилгаан болон телефон холбоо, шуудан, авто тээвэр бий болжээ. Энэтхэгээс авчирсан хэд хэдэн машиныг туршилтын журмаар ашиглаж үзэв. Зам муутайн улмаас эдгээр машиныг задалж, 1928 онд үхэр тэргээр Лхаст тээвэрлэж хүргэсэн байна.[565] 1930 онд Британийн худалдааны төлөөлөгч Пари, Гьянзегийн хооронд жип машин явах зам тавьсан боловч хэдэн долоо хоногийн дараа түүнийг хаах болсон байна. Нутгийн оршин суугчид үхэр болон морин (илжиг, луус) тэргээр мөнгө олж чадахгүй болсон учир энэ зам биднийг амьдрах хөрөнгөгүй болголоо хэмээн гомдол гаргасан юм байна. 1930-аад онд Лхас хотод 120 кВт-ын хүчин чадалтай цахилгаан станц байгуулав.[566] Дараа нь Энэтхэгийн умард нутагтай нисэх онгоцны харилцаа тогтоох бодолтой байжээ.[567] Шуудангийн шинэ алба, цагдаагийн газар, Түвд эмнэлэгийн сургалтын төв, банк шинээр байгуулав. Банк байгуулснаар бүх мөнгөн эргэлт хэвийн байдалд оржээ. Хөдөө тойргууд руу эмч нар илгээв. Төрөх эмэгтэйчүүд болон өвчтэй малд эмнэлэгийн болон мал эмнэлэгийн тусламж үзүүлэх



Хоёр түвд цаасан мөнгө (С.Л. Кузьмины авсан гэрэл зураг). Зүүн гар талд 100-тын, баруун гар талд 10-тын санг.



Түвд марк (http://www.rangzen.net)

боломж бүрдэв.[568] Лхаст эмчилгээний хоёр газар нээв.

XIII Далай лам гол төлөв сүм хийдийн шинж чанартай байсан боловсролын системийг шинэчлэх гэж хүссэн байна. Тийм шинэчлэгдсэн боловсрол бичиг үсэгтэй хүмүүс болон лам нар бэлтгэн гаргах боломж олгоод зогсохгүй аль ч давхаргаас гаралтай хүмүүсийн өмнө буддын логик, гүн ухаан, урлаг, анагаах ухааны оргилд хүрэх зам нээж өгсөн билээ. Гэхдээ л эдийн засаг, гадаад улс төрийн харилцаа хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг өгч чадаагүй юм. Далай лам үүнийг ойлгож байлаа. Тэрээр Английн Регбигийн сургуульд түвдчүүдийг суралцуулахаар явуулж, 1923 онд Их Британий сурган хүмүүжүүлэх ухааны онолч Ф.Лудглоуг түвдийн засгийн газар Гьянзе, Шигазед англи системийн сургууль үндэслэн байгуулж өгөхийг хүсч урьсан байна.[569] Гьянзед шашны биш, энгийн сургууль байгуулж, тэнд англи багш сургалтын үйл явцыг хэвшүүлж эхэлжээ. 1944 онд Лхаст тиймэрхүү сургууль байгуулагдаж, дараа нь улсын сургуулиудын тоо өсөв.

Гэвч гурван “аугаа их хийдийн”тэргүүн хамба нар англи боловсрол бол түвдийн соёл, урлагт заналхийлж байна хэмээн үзэв. Энгийн иргэд болон



Түвд цэргүүдийн дундад зууны үеийн зэвсэглэл, Шинэ жилд зориулсан парад, 1938 он (Bundesarchiv, Bild 135-S-13-06-35/foto: Ernst Schaefer License CC-BY-SA 3.0)



Түвдийн бүжгийн хамтлаг, 1938 он (Bundesarchiv, Bild 135-S-13-06-35/foto: Ernst Schaefer License CC-BY-SA 3.0)

язгууртнуудын дургүйцэл улам өсөв. 1925 онд халуун хумхаа өвчин гарсан явдал байдлыг улам хурцатгав. 1920-оод онд Лхаст хэд хэдэн удаа тэмцэл хөдөлгөөн гарч, армид хагарал гарав. Далай лам өөрийнхөө талын хүн болох Цэрэнг армийн ерөнхий командлагчийн албан тушаалаас огцруулахад хүрэв. Гэтэл хятадын одоогийн түүхчид үүнд Цэрэнг өөрийг нь буруутгаж, тэрээр Далай ламыг түлхэн унагаж, англичуудын санаанд нийцсэн иргэний засгийн газар байгуулахыг хүсч буй английн талыг баримтлагч офицеруудын хуйвалдаан зохион байгуулсан гэж батлахыг оролддог юм.[570]

Үнэн хэрэгтээ бол Цэрэнг хэд хэдэн нөхцөл байдалтай холбогдуулан огцруулжээ. Язгууртнууд болон сүм хийдийнхэн Цэрэнд тааламжтай биш ханддагийг Далай лам харгалзан үзэхгүй байж чадаагүй, өөрөө ч Цэрэнгийн байр суурь хэтэрхий их хүчтэй болохоос болгоомжилсон, Хятад улс түвдчүүдэд урьдын адил айдас төрүүлэх нь багасч, армийг бэхжүүлэх шаардлага ч нэг их биш болсон, Банчин ламыг Түвдээс явсантай холбогдуулан сүм хийдийнхэн болон түшмэдүүдийг тайвшруулах хэрэгтэй болсон зэрэг шалтгаан гарсан нь армийн ерөнхий командлагчийг огцруулах нөхцөл бүрдүүлжээ.[571] Цэрэнг эсэргүүцэгчид түүнийг баривчлах шургуу хүсэлт гаргасан ч Далай лам ерөнхий командлагч болон түүний офицеруудыг баривчлах тушаал өгөөгүй юм. Тэрээр армийг өргөжүүлэх ажил болон лхасын цагдаагийн газрын үйл ажиллагааг түр зогсоож, 1926 онд Гьянзегийн иргэний сургуулийг хаасан байна.

Түвдийн засгийн газар 1920 онд Кам муж дахь хяналтынхаа хүрээг аажмаар өргөжүүлж, Монголоос Түвд орох тэмээн жингийн замыг хамгаалах эргүүлийн цэргүүд тавьсан байна. Үүнтэй холбогдон гарч ирсэн элдэв төрлийн татвар, шинэ цэрэг татлага нүүдэлчдийн дургүйцлийг төрүүлэв. Үүнээс болж бослого хөдөлгөөн гарч, орон нутгийн эрх баригчдыг огцруулан түшмэд болон цэргүүдийн амь насыг хөнөөсөн байна. Тийнхүү Түвдийн шинэтгэл холын уршиг дагавар бүхий ноцтой бэрхшээлүүдтэй тулгарав.

Түвдийн нийгэм олон бүлгээс бүрджээ. Тэнд “хамжлагынхан”, “боолууд”, феодал ангийнхан, лам нар төдийгүй эрдэмтэн, зураач, худалдаачин, гар урчууд, төмөрийн дархан, завь хийдэг мужаан зэрэг төрөл бүрийн хүмүүс байлаа. Ан ав, загас агнуур, гар урлал болон наймаа худалдаа эрхэлдэг өрхүүд ч байх ажээ. Өмнөд нутагт жимсний, умардад мал аж ахуй эрхлэх, Гьянзед хивс, Шигазед сав суулга, мөнгөн гоёл чимэглэлийн зүйлс үйлдвэрлэх гээд бүс нутаг тус бүрт аж ахуй эрхлэх тодорхой хувиарлалт тогтсон байлаа.[572] Хотуудын гар урчууд цехүүдэд нэгджээ. Хятадын талын

баримт мэдээллээр бол мэргэжлийн гар урчуудын давхарга хүн амын 1,5-2 хувийг эзэлж байв.[573]

Умард болон дорнод төвдийн олон овог аймаг өөрсдийгөө чөлөөт иргэн хэмээн үзэх ажээ.Бээжингийн удирдлагад байдаг хэмээгдэх Камд бодит байдалд бол нутгийн эрх баригчдад бүх эрх мэдэлд төвлөрч байв. Гэсэн хэдий ч эндхийн, мөн Амдогийн Төвд хүн ам ямар нэгэн хэмжээгээр Далай лам болон сүм хийдийнхний нэр төрийг хүлээн зөвшөөрөх ажээ. Төвдийн ихэнхи хэсэг шууд удирдлагатай байгаагүй ч төвдчүүд Лхасыг соёлынхоо төв хэмээн үздэг байжээ. Кам, Амдогийн бүх хийд У-Цангад төвтэй өөр өөрсдийн чиглэлийн (сургуулийн) гол гол хийдүүдийн удирдлагад байв.[574] Лам нар тухайн нутгийн оршин суугчдын хүсэлтээр тэдний маргааныг шийдвэрлэж, элдэв мөргөлдөөнийг зохицуулах явдал ердийн л нэг практик болсон байв. Өөрсдийгөө Төвдийг захирагчид хэмээн үзэж байсан бээжингийн төлөөлөгчдийн эрх мэдэл сайндаа л гэхэд нэр төрийн төдий зүйл байв.[575] Жишээлбэл, Бээжингийн эрх баригчдын зөвшөөрлөөр тусгай паспорт олгосон ч төвдчүүд 1880 онд Н.М. Пржевальскийн шинжилгээний ангийг Лхаст оруулалгүй буцаасан байна.[576] Үнэн хэрэгтээ бол бээжингийн эрх баригчид төвдчүүдээс орлого олж байгаагүй орон нутгийн түшмэд л халаасаа түнтийлгэж байжээ.

Амдо, Камд дээрэмчдийн хяналтад орсон бүхэл бүтэн районууд байв. Төвдийн зарим суурин болон нүүдэлчдийн хот айлууд дээрэм хийж амьдарч байсан юм.[577] Нэг овог аймгийн бие даасан бүлгүүд ч өөр хоорондоо дайсагналцах ажээ. Голок аймагт “бүлгийн сэтгэлгээ” өнөөг хүртэл арилаагүй байна.

Ингэхийн зэрэгцээ тэд Монгол болон хятадаас Лхас орохоор явж буй жингийн цуваг дээрэмдэж, хөрш – монголчууд руу халдах явдал энүүхэнд ажээ. Ийм байнгын халдлагаас болж төвдийн монгол хүн ам ойр ойрхон нүүдэллэн явж, жингийн цуваанууд олноороо нэгдэж, зэвсэгт хүмүүсээр хамгаалуулдаг болов.[578] Дээрэмчид хүнийхээ тоогоор цөөн ч сайн зэвсэглэсэн нүүдэлчидтэй таарлдвал гол төлөв ялагдал хүлээнэ. Жишээлбэл, Н.М. Пржевальский, П.К. Козлов нарын шинжилгээний анги хавьгүй олон хүнтэй дээрэмчдийн халдлагыг няцааж байжээ. Төвдийн янз бүрийн бүлгүүдийн мөргөлдөөн хоёр талаас хэд хэдэн хүн алагдсаны дараа зогсоно. Ийм нөхцөлд зуучлагчид болон төвдийн түшмэд мөргөлдөөнийг зохицуулахыг эрмэлзэнэ. Энэ хүчин чармайлт ч үр дүнд хүрч, алагдсан хүмүүсийн төлөө торгууль төлнө. Хүндрүүлж авч үзэх нөхцөлд шоронд хорих, тодорхой тоогоор ташуурдах, хөл гарынх нь аль нэгийг хугалах

буюу тайрч хаях зэрэг ял оноонo.

Бусад олонхи түвдчүүдийн нэгэн адил дээр дурдсан дээрэмчид ч бээжингийнхний эрх мэдлийг үл хүлээн зөвшөөрнө. Дээрэмдүүлсэн хүмүүс ч эрх баригчдад хандаж гомдол гаргаад нэмэргүйг ойлгодог ажээ. Дээрэмчдэд шийтгэл хүлээлгэж, тэдний дээрэмдсэн эд зүйлсийг хурааж авсан ч эздэд нь буцааж өгдөггүй ажээ. Хятад түшмэд өөрсдөө хахууль авдаг учир дээрэм тонуулыг харсан ч хараагүй царайлна.[579] Өөр нэг зүйл гэвэл төвөөс томилогдсон комиссийн гишүүд нутгийн түвдчүүдийн зардлаар аль болох олон хоног тансаглах гэхдээ мөрдөн шалгах ажлыг сунжруулна.[580] Хятадын төлөөлөгчидтэй харилцах харилцаа зөвхөн "алба гувчуур" хүргэж өгөх, цол хэргэм хүртэх төдийгөөр хязгаарлагддаг бол бодит эрх мэдэл түвдчүүдийн гарт байх ажээ.[581] 1874 онд Лхасаас Бээжин рүү буцаж явсан хятадын төлөөний сайдын жингийн цуваанд голок, еграи омгийн 800 Түвд хүн халджээ.[582] Тэд хамгаалалтын цэргүүдийн заримыг устгаж, үлдсэн хэсгийг үлдэн хөөж, 300 орчим пүү (нэг пүү – 16,3 кг) алт болон бусад үнэт эдлэл дээрэмдэн авч, эсэргүүцэл үзүүлсний цээрлэл болгож төлөөний сайдыг суулган авч явсан жууз хэлбэрийн суудлыг эвдэж хаясан учир сайд цааш морь унаж явахад хүрсэн бөгөөд энэ нь түүний хувьд багагүй хүнд шийтгэл болсон байна.

Феодалын Түвдэд шийтгэлийн систем харгис хатуу байв. Бүр XIX зуунд хэрэг хийсэн хүнийг сарлагийн нойтон ширэнд чанга ороож тавихад уг шир хатахдаа дотор нь байгаа хүнийг амьсгал авч чадахгүй болтол нь барьдаг бөгөөд ингэсний дараа тэр ширлүүлсэн хүнийг голын усанд хаядаг байжээ. Хөл, гарын гав, дөнгө, хүзүүний дөнгө, хөл, гарын хурууг хавчих, нүд сохлох төхөөрөмж хэрэглэнэ. Хөл, гар хугалах, тас цавчих, хөлийн шөрмөс таслах, хилэнцэт хорхойтой нүхэнд суулгах, өвдөгний тойг, хамар, чих буюу хэл огтолж хаях шийтгэл оноонo. Хэрэг хүлээлгэхийн тулд ташуурдах, хүйтэн усанд суулгах, биен дээр нь халуун тос асгах, хөл, гарынх нь хумсны цаагуур нимгэн хулс шаах зэрэг арга хэрэглэнэ. XIX зуун гэхэд манж нар энэ практикийг улам харгис шийтгэлээр "баяжуулж": хүзүүний дөнгөтэй удаан хугацаагаар байлгах, зоосны нүхээр цувуулж алах зэрэг эрүү шүүлт тулгах болсон байна.

Аливааг харьцуулалтын аргаар л мэдэж болдог билээ. Манж чин улсын хууль тогтоомжид 2759 гэмт хэрэг тодорхойлогдож, тэдгээрийн нэг мянга гаруйд нь цаазаар авах ял оноож байжээ.[583] Цаазын зарим төрлийг гэмт хэрэгтэн олон цагаар тарчилж үхэх тийм байдлаар зохиожээ. Чин улсад зоосны нүхээр цувуулж алахаас эхлэн зүгээр л толгойг нь цавчих хүртэлх

хүнд, дунд зэргийн, хөнгөн гэсэн гурван төрлийн цаазын ял байжээ. Толгойг нь цавчих ял бараг л өдөр дутмын шинжтэй болж түүнийг олон хүн цуглардаг газруудад олонтоо хэрэглэх ажээ. Манж улсад жуулчилж яваа хүмүүс тэндхийн эрүү шүүлтийн тухай сонирхож асуухад орон нутгийн эрх баригчид тэдгээр эрүү шүүлтийг баривчлагдсан хүмүүс дээр туршиж үзүүлэхийг санал болгодог байжээ. Тийнхүү Түвдийн шийтгэл XX зуун хүртэл манж – хятадынхыг бодоход тийм ч их харгис биш байжээ. Түвдэд дээрэм тонуул хийж, их хэмжээний эд зүйлс хулгайлсан зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд л хөл, гарын хурууг тас цавчих ял оноож байжээ. Түүнчилэн улс төрийн томоохон гэмт хэрэг үйлдсэн хүнд нүдийг нь сохлох ял оноодог байж. “Орон нутагт” дөрвөн мөч гэмтээхтэй холбогдсон ялыг амбан захирагч нар л шийтгэн оноодог байжээ. 1913 оны нэгдүгээр сард XIII Далай лам дээр дурдсан ял шийтгэлүүдийг бүрмөсөн халах зарлиг гаргаж, засгийн газрын эсрэг хуйвалдаан зохион байгуулсан хүмүүст л цаазаар авах, хөл, гарыг нь тас цавчих ял оноож байхаар болсон байна.[584] Гэхдээ эдгээр шийтгэлийг маш цөөн тохиолдолд хэрэглэнэ. Хамгийн сүүлд XX зууны эхээр сайд Луншарын нүдийг сохолсон бололтой юм. Тусгай бэлтгэгдсэн хүмүүс сарлагийн тойгны ясаар хүний нүдийг сохолдог байжээ. Энэ технологийг мэддэг хүн олно гэдэг ч тийм амар зүйл биш байж.

Феодалууд ийм аргаар “хамжлагынхныг” шийтгэдэг байсан гэж хятадын суртал нэвтрүүлэгчид нотолдог нь үнэнд үл нийцнэ. Газрын эзэд тариачидтай зүй бусаар харьцаж, нухчин дарахыг хууль болон нийгмийн гэрээгээр хориглодог байв. Хэрэв газрын эзэн албат зарцаа бэрттэл нь зодвол тэрээр эмч дуудаж тусламж үзүүлэх ёстой байжээ.Феодалууд тариачдын амь насыг хөнөөх явдал гарч байсан нь мэдээжийн хэрэг билээ.[585]Тийм шийтгэл байнга хэрэглэдэг байсан тухай мэдээлэл үлдээгүй ажээ. 1909 онд XIII Далай ламын гаргасан зарлигт ёс бусаар харьцсан эзнийхээ талаар шууд Далай ламд гомдол гаргаж байх эрхийг тариачдад олгосон байна. Тийм гомдлыг мужийн захирагч нараар дамжуулан уламжилж ч болох ажээ.[586]

“Орон нутагт” хөл, гар тайрах шийтгэлийг нилээд хожим ч хууль зөрчин оноож байсан байж болох талтай юм. Г. Харрер Кам мужид гар, хөлийг нь тас цавчих шийтгэл хүлээдэг дээрэмчдийн үйлдлийг дараах байдлаар дүрслэн бичжээ:[587] “Дээрмийн бүлгийнхэн гол төлөв гурав – дөрвөн гэрт цугларч байрлана. Ингээд дараах байдлаар халдлага үйлдэнэ:винтов үүрч, сэлэм барьсан дээрэмчид нүүдэлчин айлын гэрт дайран орж, дээд зэрэглэлээр дайлж хүндлэхийг шаардана. Үнхэлцгээ хагартал айж балмагдсан нүүдэлчид байгаа бүхнээ л гаргаж тавина. Дээрэмчид гэдсээ цадтал идэж

ууж аваад малынх нь хагасыг тууж ор сураггүй алга болно. Дараа өдөр нь тэд өөр айлд дайран орох зэргээр тэр хавийн нутгийн айлуудыг мулзалж дуустал дээрмийнхээ үйлдлийг үргэлжлүүлэх ажээ. Дараа нь тэд өөр газарт шилжин очиж, бузар ажлаа үргэлжлүүлнэ. Гартаа зэвсэггүй нүүдэлчид хувь заяандаа захирагдаж, харин засгийн газар тэр хол нутагт очиж нүүдэлчдийг хамгаалах чадваргүй ажээ. Гэхдээ орон нутгийн ямар нэгэн түшмэл иймэрхүү хязгаар нутагт очвол гар хоосон үлдэхгүй, яагаад гэвэл тэрээр дээрэмчдийн бүх олзыг булааж авдаг байна. Баригдсан дээрэмчдэд хатуу цээрлэл буюу хоёр гараа тайруулах ял оногдоно. Гэвч ингэлээ гээд тэд зогсдоггүй ажээ. Тэдний харгис үйлдлийн тухай олон янзын яриа байдаг билээ. Заримдаа тэд мөргөлчид, бадарчин лам нарын амь насыг ч хөнөөдөг ажээ. <...> Дээрэмчид үйлдэл дээрээ цагдаа нарт баригдвал хоёр гарынх нь сарвуу, хөлийнх нь өлмийг тас цавчина. Тас цавчуулсан гар, хөлийн шархыг хэрхэн ариутгаж халдваргүйжүүлж буй аймшигт үйлдлийг миний бие нүдээр харсан билээ: тас цавчуулсан гар, хөлийн шархтай хэсгийг буцалж буй тосонд дүрж нилээд удаан байлгах юм билээ. Ийм аймшигт шийтгэлүүд ч хууль зөрчигчдийг зогсоодоггүй ажээ. Нэг мужийн захирагч надад цагдаа нарт баригдахдаа өөрсдөө гараа өгч тайруулснаасаа хойш хэдэн долоо хоногийн дараа дахиад л дээрмийнхээ ажилд гардаг хүмүүсийн тухай ярьж өгч билээ" гэжээ. Шийтгэгдсэн хүмүүсийн хүзүүнд түүний үйлдсэн ялыг бичсэн хүснэг өлгөж, тэр хүн гутамшгийн баганын дэргэд хэдэн өдөр зогсох бөгөөд сайн санаат хүмүүс түүнд хоол, унд авчирч өгөх ажээ.[588]

XX зууны дунд үе гэхэд Түвдэд ташуурдахыг эс оролцуулбал бие махбодийн шийтгэлийг маш цөөн тохиолдолд хэрэглэжээ. Гэтэл тэр үед энэ шийтгэл "соёл иргэншилтэй" орнуудад ердийн үзэгдэл байлаа. Их Британий сургуулиудад ороолгох шийтгэлийг дөнгөж 2003 онд хориглосон бол хятадад хорьдугаар зуун энэ талаар улам харгис үе байжээ.

Түвд орон даяар Лхасын, Шолагийн гэсэн хоёрхон шорон байжээ. Бидний ажигласнаар хятадууд орж ирэхээс өмнө энэ хоёр шорон тус бүрт 5–10 хүн л хоригдож байсан гэж өвгөчүүд надад ярьсан билээ. 13 насанд хүрээгүй хүүхэд хулгайн хэрэгт холбогдоход тэднийг шийтгэдэггүй, харин эцэг, эхийг нь зэмлээд өнгөрдөг байжээ.[589] Жирэмсэн эмэгтэйчүүд болон өвчтэй хүмүүсийн тухайд бие махбодийн шийтгэл ерөөс оноодоггүй байж. Эдлэн газруудад байцаах, ташуурын амт үзүүлэх тусгай өрөө тасалгаа байжээ. Үүнийг л суртал нэвтрүүлэгчид "хамжлагын" эзэн бүрт байсан аймшигт шорон гяндангууд гэж нэрлэсэн бололтой юм билээ.

Европын эрүүлийг хамгаалах систем XX зууны эхээр л Түвдэд нэвтэрч

эхэлсэн байна. Гэхдээ л олон мянган жилийн өмнөхийн нэгэн адил түвдийн анагаах ухаан энэхүү системийн үндэс хэвээр байв. Гол төлөв лам хуврагууд Түвд эмнэлэгийн үндэс суурийг бүрдүүлнэ. Олон зуун жилийн дотор түвдийн анагаах ухаан маш өндөр түвшинд хүрсэн учир одоо ч түүнийг дэлхийн шинжлэх ухаан өндөр үнэлж байна. Хуучин Түвдэд халдварт өвчнөөс үүдсэн нас баралтын түвшин өндөр байсан нь тэндхийн тариачид эмнэлгийн дүрэм болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг биелүүлдэггүй байсантай холбоотой юм. Түүний зэрэгцээ түвдчүүдийн 90 хувь нь элдэв өвчний халдвартай, энэ нь нас баралт өндөр түвшинд байдаг, эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх нь багассаны шалтгаан болсон[590] хэмээх мэдэгдлүүд ч зүүний чиглэлийн буруу суртал нэвтрүүлэг мөн. Түвдэд хүн амын дундад наслалт 35,5 жил, шинэ төрсөн болон бага насны хүүхдийн нас баралт 43 хувьд хүрч байна[591] гэж хятадын суртал нэвтрүүлэг нотолж байна. Эдгээр дүгнэлт үнэн зөв эсэх нь эргэлзээтэй ч Түвдийн хүн амын дундаж наслалт европын орнуудынхаас бага бөгөөд энэ нь хүүхдийн нас баралт их байгаатай холбоотой билээ. Харин хүн амын тоо удаан ч гэсэн нэмэгдэж иржээ. Янз бүрийн мэдээллээр бол XIX зууны сүүлч, XX зууны эхээр тус улсын хүн амын тоо 1-ээс 15,4 сая болжээ.[592] Харин Ч. Белл, П.К. Козлов нарын[593] гаргаж ирсэн тоо үнэнд хамгийн их ойр бөгөөд XX зууны эхний хэдэн арван жилийн байдлаар түвдчүүдийн тоо 4–5 сая болжээ.

❁

Хуучин Түвд – Жеймс Хилтоны дуульд гардаг Шангрилын уран зөгнөлт орон бишээ. Утга зохиолын шүүмжлэгчид яагаад ч юм бэ Түвдийг энэ оронтой харьцуулдаг бол түвдчүүд өөрсдөө тийм орон байдаг тухай мэддэггүй юм билээ. Хуучин Түвд бол хоцрогдсон орон учир түүнийг шинэчлэх нь зүйтэй гэж олонтоо бичдэг. Мэдээжийн хэрэг аль ч орноос ямар нэгэн тааруухан зүйл олж болох билээ. Гэхдээ бүхнийг харьцуулалтаас л тодруулж болдог.

Түвдийн “хамжлагууд” гэдэг бол үнэн хэрэгтээ түрээслэгчид, харин “боолууд” гэгчид нь гэрийн зарц үйлчлэгч нар мөн. Европ болон Манж чин улсаас ялгаатай нь гэвэл Түвдэд ангийн мэдэгдэхүйц антагонист зөрчил байсангүй. Ингэхлээр феодал – шарын шашны байгуулал ард түмний санаа сэтгэлд нийцэж байжээ. Харин энэ байгуулал гадаадынхны санаанд нийцээгүй боловч тэднийг хэн ч Түвдэд оч гэж дуудаагүй билээ. Энэ орон шинжлэх ухаан – техникийн хувьд Хятадаас хоцорсоон. Гэхдээ ялгаа үлэмж их биш бөгөөд чин улсын үед түвдчүүд төр улсаа амжилттай хамгаалж чадаж байлаа. Хоцрогдол нилээд хожим сөрөг нөлөө үзүүлсэн юм. Түвдийн

удирдлага шинэтгэл хийх гэж эрмэлзсэн боловч нийгмийн эсэргүүцэлтэй тулгарчээ. Хүмүүнлэгийн болон нийгмийн хувьд хуучин Түвд, Чин гүрэн болон өрнөдийн улсуудаас дор байгаагүй. Чин гүрнийг унаснаас хойш дундад зууны үеийн эрүү шүүлт болон цаазыг Түвдэд тун цөөхөн удаа хэрэглэжээ. БНХАУ-д гаргадаг эрүү шүүлтийн элдэв хэрэгслүүдийн тухай үзэсгэлэнд хятадуудыг ирэх үед огт хэрэглэдэггүй байсан тэр зүйлсийг л дэлгэж үзүүлсэн байдаг юм.

Шашин – гүн ухааны тухайд бол түвдийн хоцрогдлын тухай ярих нь илүүц бизээ. Түвдийн бурханы шашин сэтгэлгээний давж гарахын аргагүй өндөрлөгт хүрчээ. Тэдгээр сэтгэлгээний заримыг (харьцангуйн үзэл, ертөнцийн олон янз байдал) орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтуудаар нэгэнт нотолжээ. Феодалын Түвдэд боловсруулсан гүн ухааны (философийн) үзэл баримтлалууд нь Өрнө, Дорнын бусад орныхоос давна уу гэхээс биш дутахгүй ажээ.

Тийнхүү феодал – шарын шашны Түвдэд маш удаан ч гэсэн шинэтгэл үргэлжилжээ. Энэхүү үйл явц XIII, XIV Далай ламуудын үед хурдассан боловч тэр хүмүүс энэ шинэтгэлийг эцэст нь хүргэж чадаагүй, яагаад гавал Түвд орон БНХАУ-д эзлэгдсэн юм. Ямар ч шинэтгэл Түвдийг хориодхон жилийн дотор Зөвлөлт Холбоот Улсын дэмжлэгтэй олон сая хүн амтай Хятадын интервенцийг ганцаараа няцааж чадах тийм хүчирхэг улс болгож чадахгүй бизээ.

Бүлэг 7

## «Энх тайван чөлөөлөлт» ба түүний уршиг дагавар

Гоминьданы буюу коммунистуудын мэдэлд байх нь хамаагүй өрнөдийн эсрэг бодлого баримталсан нэгдмэл хятад улс И.В. Сталинд чухал хэрэгтэй байв.[594] Ази дахь Орос, Хятадын холбоо ялагдашгүй хүч болж чадна гэж тэрээр төсөөлж байлаа. Гэвч хятадын тал ЗСБНХУ-ын холбоотон болсонгүй. Сталин 1940-өөд оны дунд үеэс Хятадын Коммунист Нам (ХКН)-д найдлага тавьсан байна. Зөвлөлтийн удирдлага 1945 онд Манж-го улсыг Японоос чөлөөлснийхөө дараа түүнийг Хятадад өгөв. Өвөр Монголд байсан япончуудыг зөвлөлт, монголын цэрэг бутниргэсний дараа өвөр монголчууд хятадаас чөлөөлөгдөж, БНМАУ-тай дахин нэгдэхийг хүсч байсан ч Сталин Өвөр монголыг бас л Хятадад өгөв.[595] 1949 онд Бүгд Найрамдах Дорнод Туркестан улсын бүх удирдлага Алма – Ата хотоос Бээжин орж хэлэлцээ хийхээр явах замдаа нисэх онгоцны ослоор сэжиг бүхий амь үрэгдсэний дараа Дорнод Туркестаныг БНХАУ-д нэгтгэжээ.[596]

Манж-го улсыг японы цэргээс чөлөөлсний дараа зөвлөлтийн тал цаг хожиж, ХКН-ынхныг оруулах аль болох таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд тийш нь Хятадын (гоминьданы) засгийн газрын цэрэг оруулахад саад хийж эхэлсэн байна.[597] Түүнээс гадна манжуур руу хийх засгийн газрын цэргийн давшилтад Умард хятадад байсан ХКН-ын гол хүч болох наймдугаар арми маш хүчтэй саад хийж байв. ЗСБНХУ-ын засгийн газар Хятадын коммунист намын цэргийг тээвэрлэхэд дорнод хятадын төмөр замыг (ДХТЗ) ашиглах зөвшөөрөл өгөв. Зөвлөлтийн командлал Манжуурт цэрэг, цагдаагийн хүч байгуулахыг эрмэлзсэн гоминьданыхныг баривчилж, харин хятадын коммунистуудад энэ бүхнийг хийх зөвшөөрөл олгожээ. Тэнд хүрэлцэн очсон коммунистуудад зэр зэвсэг өгч, цэрэг элсүүлэх замаар цэргийн ангиуд бий болгохыг зөвшөөрөв. Хятадын умард нутгаас ирсэн

ХКН-ын 8-р, мөн шинэ 4-р армийн. Отрядуудаас 100 хүртэлх мянган хүнтэй арми эмхлэн байгуулсан бөгөөд хожим нь энэ армийн цэргийн тоо бараг 1 саяд хүрчээ. Японыг бууж өгсний дараахан Манжуурт байгуулагдаж буй Нэгдсэн ардчилсан арми, түүний намын байгууллага, ХКН-ын Төв Хорооны Зүүн – хойт товчоог удирдуулахаар хятадын хэсэг коммунист удирдагчийг Яньаниас зөвлөлтийн цэргийн нисэх онгоцоор Манжуурт хүргэсэн байна.[598] Гоминьдан нийт Манжуурт эрх мэдлээ тогтоож чадаагүй бөгөөд манжуураас зөвлөлтийн цэргийг гаргасны дараа тэндхийн хэд хэдэн район хятадын коммунистуудын хяналтад орсон байлаа.

Ардын ардчилсан районуудын эрх баригчид байгуулагдсан анхныхаа өдрөөс эхлэн ЗСБНХУ-ын бүх талын тусламж, дэмжлэг авч эхэлсэн байна.[599] Хятадын коммунистууд Зөвлөлт Холбоот улсад зочлон очиж, зөвлөлтийн төлөөлөгчид Манжуурт очиж байв. ЗСБНХУ Нэгдсэн ардчилсан армийг бэхжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ. Зөвлөлтийн командлал энэ армийг японы Квантуны армиас олзолж авсан шилдэг сайн зэвсгээр хангажээ. Японоос олзолж авсан зэвсэглэлийн үндсэн хэсэг буюу 327877 винтов буу, 5207 пулемёт, 5219 их буу, мина харвагч, 743 танк, хуягт машин, 612 нисэх онгоц, 1224 автомашин, трактор болон чирэгчийг 1945 оны ес – арван нэгдүгээр сард Нэгдсэн ардчилсан армид шилжүүлэн өгчээ.[600]

Нэгдсэн ардчилсан арми ийм их хэмжээний зэвсэг хүлээж авснаар ХКН-ын хамгийн хүчирхэг арми, Манжуур нь засгийн эрхийн төлөө тэмцэл дэх энэ намын гол түшиг тулгуур, Хятадын иргэний дайны гол фронт болж хувирсан байна.[601] Хэрэв коммунистуудад зөвлөлтийн тусламж очоогүй бол Хятадын засгийн газар ХКН болон түүний зэвсэгт хүчнийг амархаан дарж чадах байсан билээ. Түүнээс гадна: "Хятадын Коммунист Нам засгийн эрхийг зэвсгийн хүчээр авах өөрийн гэсэн боломжгүй, Зөвлөлт Холбоот Улсад л түшиглэж байсан үед Гоминьдан АНУ-ын тусламжгүйгээр бие даан эрх мэдлээ хамгаалж чадах байсан юм".[602] Москвагийн эрх баригчид хятадын засгийн газарт аливаа тусламж үзүүлэхээ зогсоохыг АНУ-аас шаардаж, харин өөрсдөө энэ засгийн газарт хүчтэй шахалт үзүүлж, коммунистуудын эсрэг, хүч хэрэглэхгүй байхыг шаардахын зэрэгцээ коммунистуудыг эрчимтэй зэвсэглэж байлаа. 1949 онд БНХАУ байгуулагдах үед хятадын ардын чөлөөлөх армид зөвлөлтийн 1012 мэргэжилтэн болон зөвлөгчид ажиллаж байжээ.[603]

ХКН болон Гоминьданы хооронд өргөн хэмжээний иргэний дайн эхэлсний дараахан буюу 1946 оны арван хоёрдугаар сараас Манжуурын ардын ардчилсан районуудад зөвлөлтийн ачаа барааг их хэмжээгээр

нийлүүлж эхлэв.[604] Хүнсний бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн бараа таваар, нефтийн бүтээгдэхүүн, цаас, эм, сургууль, эмнэлэгийн тоног төхөөрөмж нийлүүлж эхэлсэн байна.[605] Энэ тусламжийн тухай бүрэн мэдээлэл өнөөг хүртэл нууц хэвээр байна. Ил хэвлэлд нийтлэгдсэн тоо баримт гэхэд л дээр дурдсан тусламж урьд өмнө байгаагүй цар хүрээтэй байсныг гэрчлэн харуулна. Зөвлөлтийн байгууллагууд Манжуурын ардын ардчилсан байгууллагуудад дотоодын худалдаа, санхүүгээ зохион байгуулахад нь тусалжээ. ЗСБНХУ дайны үед эвдэрч сүйдсэн зам харилцааг сэргээхэд тусалж: Урал, Сибирийн заводуудад ДХТЗ-ын ажиллагаагүй болсон хөдлөх бүрэлдэхүүнийг засварлаж, Сибирь, Алс Дорнодод хятадын ардын чөлөөлөх армийн төмөр замын цэрэг бэлтгэх ажил өрнөж: 1948 оны зуны саруудад л янз бүрийн чиглэлийн 4600 гаруй мэргэжилтэн бэлтгэжээ.[606]

Манжуурын засаг захиргааны хорооны дэргэдэх Эдийн засгийн хороо ЗСБНХУ-аас нийлүүлэх барааны захиалгыг нэмэгдүүлэх асуудлыг хэд хэдэн удаа авч хэлэлцжээ. Жишээ нь, хөвөн цаасан даавууг 20 сая метр хүртэл, хөвөнг 30 мянган тонн, автомашины тосыг (масло) 7400 тонн хүртэл нэмэх санал тавьжээ.[607] 1946 оны арван хоёрдугаар сараас 1947 оны нэгдүгээр сарыг дуустлах хугацаанд ЗСБНХУ-аас Манжуур дахь хятадын коммунистуудад 151 сая рублийн, 1948 онд 335,4 сая рублийн, 1949 онд 420,6 сая рублийн тоног төхөөрөмж, стратегийн материал, аж үйлдвэрийн бараа таваар нийлүүлсэн байна.

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хятадын засгийн газар (гоминьданы) ядахдаа ХКН-тай хийх яриа хэлэлцээнд дэмжлэг үзүүлэх тухай асуудлаар ЗСБНХУ-тай тохиролцох гэж олон удаа оролдсон боловч үр дүнд хүрээгүй юм. 1946 онд Зян Зинго, эцэг Чан Кайшийн даалгавараар Москвад И.В. Сталинтай хэлэлцээ хийв. Энэ хэлэлцээ үр дүнгүй дуусч: Сталин өөрт нь Чан Кайшийн амласан асар их ашигтай нөхцлийг үл харгалзан ХКН-тай харилцаагаа зохицуулахад нь туслахаас татгалзав.[608]

Иргэний дайн өргөжихийн хэрээр ХКН-д үзүүлэх ЗСБНХУ-ын тусламж ч өссөн байна. Зөвлөлтийн үйлдвэр, байгууллагуудыг машин, трактор, тослох материал, аж үйлдвэрийн бусад материалаар хангах хангалтыг багасган хятадад дээрх материалуудыг их хэмжээгээр нийлүүлж байсан явдал зөвлөлтийн хүмүүсийг эн тэргүүний хэрэгцээт бараа таваарар хангахад гарсан дайны дараах бэрхшээлийг улам гүнзгийрүүлжээ.[609] ХКН-д нийлүүлэх зарим төрлийн машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэхийн тулд хилийн чанадаас жинхэнэ каучук зэрэг бараа бүтээгдэхүүнийг валютаар худалдаж авахад хүрч байсан бөгөөд тэр үед валютын нөөц маш бага байлаа.

Зүүн хойт армийн цэргийн икомандлагч Линь Бяо 1948 оны есдүгээр сарын 8-нд И.В. Сталинд бичихдээ: “Манай эдийн засгийг бүх талаас нь судалж, аж үйлдвэрийн хамгийн гол салбаруудыг сэргээн босгож, ашиглах нэгдмэл төлөвлөгөө хамтран боловсруулах мэргэжилтнүүдийг хэсэг явуулахыг бид Танаас хүсч байна” гэжээ.[610] Энд хятадын зүүн-умард нутгийн тухай яригдаж буй юм. Мао 1949 оны нэгдүгээр сарын 8-нд Сталинд бичсэн захидалдаа зээлийн журмаар тоног төхөөрөмж, материал, уурын тэрэг нийлүүлэхэд тусламж үзүүлэхийг түүнээс хүсээд “аль болох түргэн хугацаанд ачаалж, бидэнд илгээнэ үү”[611] хэмээжээ.

1949 оны арван хоёрдугаар сарын 10-нд Бүх Оросын Коммунист (большевик) Намын Төв хороонд А.Я. Орловын явуулсан нууц илтгэлээс товч дүгнэлт хийж болно. Тэр илтгэлд: “ХКН-ын 28 жилийн ойг тохиолдуулж явуулсан баярын цахилгаан утасны хариуд тэрээр (Мао Зэдун) “Хэрэв ЗСБНХУ байгаагүй бол Хятадын Коммунист Нам байхгүй байхсан” гэж тов тодорхой хэлжээ. Одоо Мао Зэдун бүх итгэл найдвараа ЗСБНХУ, Бүх Оросын Коммунист(б) Нам, ялангуяа нөхөр Сталинд тавьж байгаа юм байна”[612] гэж бичжээ. “ЗСБНХУ-ын засгийн газар ХКН-д эд материалын, түүний дотор цэрэг-техникийн тусламж үзүүлэхдээ 1945 оны наймдугаар сарын 14-ний Зөвлөлт-Хятадын гэрээ, НҮБ-ын Дүрэм, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг зөрчсөний төлөө улс орноо олон улсын ноцтой хориг арга хэмжээнд оруулах томоохон эрсдэлтэй алхам хийсэн юм”[613] гэж хятадад ажиллаж байсан зөвлөлтийн нэрт дипломатч А.М. Ледовский тэмдэглэсэн байдаг.

А.И. Микоян 1949 оны эхээр Мао Зэдунд үндэсний цөөнхөд тусгаар тогтнолын оронд өөртөө засах эрх олгох хэрэгтэй гэсэн И.В. Сталины зөвлөлгөөг уламжилжээ.[614] Энэ нь марксизм-ленинизмын зарчимд (үндэстний өөртөө засан тохинох эрхийг тунхагласан) харшилсан боловч Маогийн төлөвлөгөөнд нийцжээ. Ерөөс Мао 1949 оны эхээр болон түүнээс хойш ч Жоу Эньлай, Лю Шаоци нарын хамт хятадын хувьсгалын бүх асуудлаар Сталин болон зөвлөлтийн удирдлагын зөвлөлгөө, зааврыг авах гэж хичээнгүйлэн зүтгэжээ.[615] Жишээ нь, 1949 оны зургаа-наймдугаар сард ХКН-ын төв хорооны төлөөлөгчдөөс БОК(б)Н-ын Төв Хорооны улс төрийн товчоонд танилцуулсан илтгэлд: “Хэрэв ХКН, БОК(б)Н-ын хооронд зарим асуудлаар санал зөрөлдөөн гарвал ХКН байр сууриа илэрхийлээд БОК(б)Н-ын шийдвэрт захирагдаж, түүнийг эрс шийдвэртэй биелүүлэх болно” хэмээн өгүүлсэн байна. Сталин тэр илтгэлийн хажуугийн зайд: “Үгүй” хэмээн бичжээ. Тэрээр энэ санаагаа хоёр талын хэлэлцээний үеэр

дипломат хэлбэрээр илэрхийлсэн юм. Гэтэл Мао бүр Коминтерны үеэс Москвагийн зөвлөлгөөг "хятадын хувьсгалд саад болсон зохистой бус, буруу зүйл" хэмээн үзэж байсан нь Сталиныг нас барсны дараа тодорхой болжээ. ЗСБНХУ-ын тусламжтайгаар хятадын засгийн эрхийг булаан авч, Манжуур, Өвөр Монгол, Шинжаан, Түвдийг өөртөө нэгтгэхийн тулд Сталины итгэлийг ашиглах явдал Маогийн гол зорилго байжээ.

Мао өөрөө зөвлөлтийн тусламж авч байсан хэрнээ олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хятадын гоминьданы засгийн газарт үзүүлсэн америкийн тусламжийг хятадын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон хэрэг гэж тодорхойлоод зогсоогүй америкийн империалистууд гоминьданыхны тусламжтайгаар нутаг дэвсгэр, усан хил (нутаг дэвсгэрийн ус), агаарын уудмаа эзэмших Хятад улсын эрх, хөлөг онгоц зорчуулах эрх, худалдаан дахь давуу эрх, тэрч байтугай хүн алах давуу эрхийг булааж авсан юм гэж бичжээ.[616] Хожим нь тэрээр иймэрхүү тайлбарыг Түвдийн тухайд дахин ашиглажээ.

Лхасын эрх баригчид коммунистууд ялалт байгуулж байгааг хараад тэндхийн гоминьданы төлөөлөгчийн газар хятадын түшиц газар болно хэмээн болгоомжлох болжээ.[617] 1949 онд хятадын худалдаачид болон Лхас дахь төлөөлөгчийн газрын гишүүд зоогийн газар (ресторан) нээж, тэнд коммунист суртал нэвтрүүлэг явуулах болсон байна.[618] Тийм учир коммунистуудыг дэмжигчид болон тагнуул этгээдүүдийн нэрсийн жагсаалтыг ашиглан дээрхи төлөөлөгчийн газрынхныг 1949 оны долдугаар сард хөөж явуулсан байна. Тэдэнтэй хамт бүх хятад иргэдийг хөөж, хятад сургууль болон радиостанцийг хаажээ. Энэ үйл явдлыг хятадад "хан үндэстнүүдийг цөлсөн будлиан" хэмээн нэрлэж ирсэн байна. Үүнийг коммунистууд ч, гоминданыхан ч эсэргүүцжээ. Тэд Лхас хотод сууж байсан Энэтхэгийн төлөөлөгчийн газар, тухайлбал тэндхийн ажилтан Х. Ричардсоныг дээрх хэрэг явдлын гол гэм буруутан хэмээн үзжээ. Гэтэл Ричардсон хятадын төлөөлөгчийн газар аюул учруулж болохыг байнга сануулдаг байсан ч тэднийг хөөж явуулах санал дэвшүүлснээ үгүйсгэжээ.

Хятадын төлөөлөгчийн газрыг Лхасаас явуулснаас хойш тэнд хятадын нөлөө үлдээгүй юм. Коммунистуудад тааламжтай ханддаг гэж сэжиглэгдэж байсан түвдчүүдийг ч хятадуудтай хамт хөөж явуулсан байна. Тэдний нэг бол Түвдийн анхны коммунист Пунцог Ванжил байжээ. Хүмүүс дээр дурдсан хэрэг явдлыг гадаадын төлөөлөгчдийг хөөж явуулсан ажиллагаа хэмээн үздэг байсан гэж Түвд өвгөчүүл дурсан ярьдаг юм. Гэтэл коммунистуудын хувьд Лхас хотоос хятадуудыг гаргаж явуулсан явдал Түвдэд гадаадын

хүчин орж ирээд бидний эсрэг үйл ажиллагаа явуулж байна хэмээн үзэх шалтаг болсон байна.

Мөн оны наймаас аравдугаар сар дуустлах хугацаанд америкийн иргэн Л.Томас радиогийн сурвалжлагчийн (тайлбарлагч) дүрээр Лхаст байжээ. Тэрээр Түвдэд Америкийн цэргийн тусламж үзүүлэх тухай асуудлаар хэлэлцээ хийсэн байна. Барагцаалбал энэ үеэр АНУ-ын ерөнхий консулын орлогч Д.С. Маккирнам, Ф. Бессаг, Оросын цагаан гвардад алба хааж байсан гурван орос офицер, коммунистуудад эзлэгдсэн Шинжаанаас Түвд рүү оргожээ. Түвдийн засгийн газар ийм хүмүүс ирж магадгүй гэж хилийнхээ эргүүлүүдэд мэдээлсэн байна. Гэтэл тэр хүмүүсийн очсон хилийн боомт дээрх мэдээг хараахан хүлээж аваагүй учир дэд консул болон Оросын цагаан цэргийн гурван офицерыг буудан хороожээ. Ингээд Лхасын эрх баригчид гадаадынхны нүдэн дээр гэм буруутай этгээдийг нэвширтэл нь ташуурдаж шийтгэсэн байна.

Иргэний дайнд ХКН-ынхан гоминьданыг ялсан нь 1949 оны зун нэгэнт тодорхой болов. “Хотуудыг тосгодоор бүслэх” явдал Маогийн хамгийн дуртай байлдааны тактик байжээ. Өмнө нь энэ тактикийг гадаадын булаан эзлэгчид хэрэглэж байсан бол энэ удаад маогийнхан хуулбарлан дууражжээ. Ямар нэгэн хотыг цэргийн хүчээр бүсэлж, дайсны цэрэг өлсөхийн эрхэнд бууж өгөх хүртэл суух явдал энэ тактикийн гол утга санаа юм. Хотоос гарч чадахгүй хоригдож, хотууд болон байлдаж буй талуудын хоорондох завсрын бүсэд олон мянгаараа өлсгөлөнгөөр нас барсан энгийн иргэд л гол хохирогчид болж байсан нь тодорхой.[619]

ЗСБНХУ-ын сайд нарын зөвлөлийн 1949 оны есдүгээр сарын 5-ны өдрийн тогтоолоор зөвлөлтийн худалдааны яам хятадын коммунист эрх баригчдад 33,3 сая рублийн 500 километр төмөр замын рельс зээлийн журмаар олгож: есдүгээр сарын 19-ны өдрийн тогтоолоор хятадын ардын чөлөөлөх армид 125,8 сая рублийн байлдааны, сургуулийн, тээврийн нисэх онгоц, нисэх онгоцны хөдөлгүүр, зенитийн их буу, пулемёт: арван нэгдүгээр сарын 4-ний өдрийн тогтоолоор 28 сая рублийн сургуулийн нисэх онгоц, нисэхийн техникийн тоног төхөөрөмж, автомашин нийлүүлэх шийдвэр гаргажээ.[620]

Эдгээр тогтоол тун цагаа олсон зүйл байв. Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг зарлан тунхаглахаас өмнө, 1949 оны есдүгээр сарын 2-нд Синьхуа хорооны (мэдээллийн агентлаг) мэдээ[621] дамжуулжээ: “Хятадын ардын чөлөөлөх арми Түвд, Сикан болон Хайнань, Тайвань арлуудыг оролцуулан хятадын бүх нутаг дэвсгэрийг чөлөөлнө. Тус арми хятадын сөөм газрыг

ч БНХАУ-ын гадна үлдээхгүй" гэж энэ мэдээнд өгүүлсэн байна. Тийнхүү гадны улс-Түвдийг "чөлөөлөх" болсон ажээ. Хятадын нутаг дэвсгэрүүдээс Гоминьданы хяналтад байсан (Хайнань, Тайвань) газруудыг л "чөлөөлөх"-өөр шийдсэн байна. Эрх тэгш бус гэрээний үндсэн дээр өрнөдийн империалистуудын эзэмшиж байсан колониуд буюу жинхэнэ хятадын газар нутаг болох Аомынь (Макао), Сянган (Гонконг)-ыг огт дурдалгүй өнгөрчээ.

Түвдэд өнгөлзөх явдал шинэ ардчилсан хувьсгалчид Манж чин улсын бүх "өвүүдийг" авах гэж эрмэлзсэнтэй холбоотой төдий зүйл бишээ. Энэ бол БНХАУ-ын "олон улсын нэр хүндийн" асуудал байв.[622] Түүнээс гадна Мао Зэдун: "Түвд хүн амын нягтрал багатай ч том орон зай эзэлж байна. Тэндхийн хүн амыг хоёр буюу гурван саяас тав буюу зургаан сая, цаашдаа арван сая хүртэл нэмэгдүүлэх ёстой юм" гэж хэлжээ.[623] Түвдийн стратегийн байрлал болон байгалийн баялаг өөр нэг шалтгаан болсон байна. Хятадын ерөнхий сайд Жоу Эньлай Түвдийг нэгтгэсний дараа: "Хятадууд асар олон, тэд эдийн засаг, соёлын талаар хангалттай сайн хөгжсөн, харин тэдний оршин сууж буй бүс нутгуудад ах дүү ард түмнүүдийнхтэй харьцуулахад хагалах газар болон байгалийн нөөц баялаг бага үлджээ" гэж хэлсэн байна.[624] Тийнхүү "ах дүү ард түмнүүдийн" газар нутгийг сонгодог утгаар колони болгон хувиргахыг эрмэлзжээ.

1949 оны аравдугаар сарын 1-нд Бээжин хотноо БНХАУ-ыг тунхаглав. Гоминьданыханд АНУ-ын үзүүлсэн тусламж хятадын коммунистуудад ЗСБНХУ-ын үзүүлсэн тусламжаас үр нөлөө багатай байв. ЗСБНХУ-ын тусламжтайгаар унасан Гоминьдан нам АНУ-ын хүчинд Тайваньд эрх мэдлээ хадгалж үлдсэн байна. Энэ арлыг Мао Зэдун "чөлөөлж" чадаагүй юм. Саяханыг хүртэл дэлхийн олонхи орон Бээжингийн биш, харин Тайбэйн засгийн газрыг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрч байлаа. Дараа нь байдал бээжингийн талд ашигтайгаар өөрчлөгдсөн юм. Одоо Тайбэйн засгийн газрыг дөнгөж 23 орон хүлээн зөвшөөрч байна. Үнэн хэрэгтээ бол энэ асуудал аяндаа шийдвэрлэгдэх ёстой билээ. Яагаад гэвэл Гоминьдан намыг хятадын хувьсгалчдын нэг Сунь Ятсен үндэслэн байгуулж, тэдгээр хувьсгалчид Чин улсын хууль ёсны засгийн газрыг түлхэн унагаж, Сунь Ятсен өрнөдөд-империалист Францад цагаачлан сууж байхдаа Бүгд Найрамдах Хятад Улсыг тунхаглажээ. Хувьсгалт эрх баригчдаас ялгаатай нь гэвэл Далай ламын засгийн газар маргаангүй хууль ёсны шинж чанартай байсан юм.

Хятадын шинэ далбаа улаан өнгөтэй болов. Зөвлөлт Холбоот Улсынх шиг гэж гайхмаар. Харин Бүгд найрамдах хятад улсын анхны далбаа

(1912–1928 он) үндэстнийхээ тоогоор таван өнгөтэй байв. Хан үндэстийг илэрхийлсэн улаан, манж нарын шар, монголчуудын хөх, хуй үндэстний цагаан, түвдчүүдийн хар өнгийн адил тэнцүү хэмжээтэй зурвасуудыг дээрээс доош хөндлөн байрлуулжээ. Энэ далбааг Гоминьдан өөрчилжээ. Дараа нь коммунистууд хятадын далбааг дахин өөрчлөх нь тэр. Нэг өнгө буюу улаан өнгө үлдсэн бөгөөд түүн дээр нэг том таван хошууг тойруулан дөрвөн жижиг таван хошуу (дахиад л тав) байрлуулжээ. Үүнээс үндэсний шинжтэй далд санаа эрэхээ больёо. Албан ёсны тайлбараар бол таван таван хошуу нь хувьсгалын өнгөний дэвсгэр дээр коммунизмын байгуулалтад Намаа тойрон нягтарсан дөрвөн анги буюу ажилчин, тариачин, дунд анги, үйлдвэр худалдаа эрхлэгчдийг илэрхийлж байгаа ажээ. Өөр нэг таамаглалаар бол зөвхөн нэг өнгө, нэг том таван хошуу байгаа ажээ.

Тийнхүү эх газрын хятадад ганцхан засаглал ХКН үлджээ. Одоо Түвд рүү хандсан түүний өнгөлзлөг амьдралд хэрэгжих болов. Хувьсгал ялснаас хойш нэг сарын дараа тэр үед дөнгөж 10 настай байсан X Банчин лам Хөх нуур мужаас Мао Зэдун, Жу Дэ нарт баяр хүргэсэн илгээлт явуулж: "Ойрын өдрүүдэд Түвдийг ч чөлөөлнө хэмээн найдья"[625] гэжээ. Хятадын мужуудад нэгтгэсэн бусад районуудаас ч хэд хэдэн өндөр албан тушаалын түвдчүүд иймэрхүү утгатай захидал илгээжээ. Эдгээр илгээлтийг яаж тайлбарлахаас үл шалтгаалан тэдгээрийг хууль ёсны хэмээн үзэх үндэсгүй, яагаад гэвэл тэр үед засаг төрийн бүрэн эрх мэдэл түвдийн засгийн газарт байсан билээ. Энэ засгийн газар хятадын өнгөлзлөгт өөрийн гэсэн хариу өгсөн байна. Арван нэгдүгээр сарын 2-нд Түвдийн гадаад явдлын яам Мао Зэдунд илгээлт явуулав. Түвд бол эрт дээр цагаас тусгаар тогтносон орон байсан тухай энэхүү илгээлтэд өгүүлжээ. Хятадын түрүүчийн засгийн газруудын хавсарган нэгтгэсэн Түвдийн газар нутгуудыг буцааж авах тухай асуудлаар хэлэлцээ хийхийг уг илгээлтэд уриалсан байна.[626] Түвд, Бээжингийн харилцаа "багш – ивээн тэтгэгчийн" зарчимд үндэслэж байсан, Түвд хэзээ ч хятадын нэг хэсэг байгаагүй, гадаадын ямар ч гүрэн түвдийг захирахгүйг мэдэгджээ.[627] ХКН-ын удирдагч түвдчүүдийн саналыг үл тоомсорлов. 1949 оны арван нэгдүгээр сарын 4-нд Түвдийн засаг баригч Тактра тусламж үзүүлэхийг хүсч бүх улс оронд хандсан боловч тусыг эс олов.

XIII Далай ламын урьдчилж хэлсэн зүйл хэрэгжиж эхлэв.[628] "Манай Түвдэд шашин шүтлэг болон засгийн газрыг дотроос ч, гаднаас ч довтолж болох юм. Хэрэв бид улс орноо хамгаалахгүй бол эцэг, хүү болох Далай лам, Банчин лам, түүнчилэн итгэл үнэмшлийг хамгаалах бүх эрхэмүүд үгүй болж, мартагдах явдал гарч магадгүй байна. Лам хуврагууд болон

сүм хийдүүд устаж үгүй болно. Хуулийн хүч суларч байна. Засгийн газрын гишүүдийн эд хөрөнгө, эзэмшил газар булаагдана. Тэднийг дайснуудад нь албадан үйлчлүүлэх буюу гуйланчлан тэнэхэд хүргэнэ. Бүгд гамшиг зовлон, айдас хүйдэст автана, зовлон гамшгаар дүүрсэн өдөр, хоногуудыг өнгөрөөнө гэдэг хэцүү болно" гэж Далай лам айлджээ.

Үнэхээр ч Хятадууд халдан орж ирэх үед Түвдэд англиар сайн ярьдаг цөөхөн тооны түшмэд байсан бөгөөд орчин үеийн дипломатын ёс, олон улсын харилцааны асуудал гадарладаг хэн ч үгүй, арми нь чадваргүй шахам болсон байлаа.[629] "Хуучинсаг үзэлт лам нар болон шашны зүтгэлтнүүд Түвдийн бурханы шашны эрхэм нандин үнэт зүйлс болон үзэл суртлыг өрнөдийнхөн бузарлах аюулаас хамгаалах гэхдээ зүсэн бүрийн болзол бий болгосон нь шашин мөргөлийн тэрхүү үнэт зүйлсийг хамгаалж, хадгалан үлдэх засгийн газрын боломжийг ч хаажээ" гэж М.К. Гольдштейн тэмдэглэн бичжээ.Тэрээр түвдийн уламжлалт анд нөхөд, хөршүүд дипломатын болон цэргийн үр нөлөөтэй тусламж үзүүлэхээс татгалзсаныг "ламын шашны улс" мөхөх болсны гадаад талын шалтгаан гэж цохон тэмдэглэсэн байна. Гадаад талын энэ шалтгаан мэдээжийн хэрэг маш их нөлөөлжээ.

1949 оны арван нэгдүгээр сарын 23-нд Мао Зэдун Түвдэд ХКН-ын арми баруун хойт талаас орох төлөвлөгөөний талаар маршал Пэн Дэхуйд ханджээ.[630] Энэ захидалд "Түвд" гэсэн нэр томьёог Лхасын хяналтад буй нутаг дэвсгэрийг илэрхийлэхэд ашигласан байна. Кам, Амдо мужууд хятадын мэдэлд аль хэдийнэ орсон байлаа. Арван хоёрдугаар сарын 30-нд Пэн хариу захидалдаа Хөх нуур, Шинжаанаас Түвдэд цэрэг оруулах маш хэцүү: тэнд хангалттай тооны цэрэг, хоол хүнс цуглуулж, зам барихад бэрхшээлтэй, тиймээс хээрийн хоёрдугаар армийн хүчээр баруун өмнө зүгээс орох нь илүү тохиромжтой гэж бичжээ. Энэ армийн зарим ангиуд бүр 1949 оны сүүлчээр Түвдийн хилд (У-Цангийн умард хилийг хэлж байна) тулж очсон[631] бөгөөд хятадууд хил зөрчих явдал гарч байсан билээ.[632]

Мао Зэдун Москвад байхдаа Пэн Дэхуйгаас цахилгаан утас авсан байна. Тэрээр албан ёсны айлчлал хийхээр 1949 оны арван хоёрдугаар сарын 16-нд Москвад очжээ. Мао 1950 оны нэгдүгээр сарын 2-нд ХКН-ын төв хорооны баруун өмнөд товчоо, баруун өмнөдийн цэргийн тойргийн удирдагч Дэн Сяопин, Лю Бочэн, Хэ Лун нарт цахилгаан утас явуулав. Дарга Мао энэ цахилгаан утсандаа олон улсын тавцан дахь Түвдийн байдал маш чухал байна, түвдийг "чөлөөлж", түвдийн ард түмний ардчилал болгон хувиргах хэрэгтэй байна, 1950 оны дөрөвдүгээр сард Түвдэд орж, аравдугаар сар гэхэд "чөлөөлсөн" байхыг хичээх хэрэгтэй байна гэж тэмдэглэжээ.[633]

Сиканаас Түвд хүртэл зам тавьж, түвдийн арми том биш болохоор тийш нь армийн нэг корпус буюу 40 орчим мянган хүнтэй дөрвөн дивиз явуулахыг Мао санал болгожээ. Түүнээс гадна тэрээр Түвд боловсон хүчин бэлтгэхийг санал болгосон байна.

Нэгдүгээр сарын 7-нд Мао нааштай хариу хүлээн авч, 10-нд бас нэг цахилгаан утас илгээжээ.[634] Дарга Мао Их Британи, Энэтхэг, Пакистан улсууд БНХАУ-ыг хүлээн зөвшөөрсөн нь тааламжтай нөхцөл бүрдүүлж байна гэж цахилгаан утасныхаа эхэнд тэмдэглээд Түвдийг удирдахын тулд нэн даруй төлөвлөгөө боловсруулж, түүнийг хэрэгжүүлж эхлэх ёстой намын хороо байгуулахыг санал болгов. Энэ байгууллагын тэргүүн зэргийн зорилт бол боловсон хүчин болон цэргийн албан хаагчдыг сургах, зам тавих, Түвдтэй залгаа Сиканы хил рүү цэрэг хөдөлгөх явдал мөнийг тэрээр онцлон тэмдэглээд цахилгаан утсанд бичсэнээр “Сиканы ард түмний дунд гарч буй дотоодын хуваагдлыг хөхүүлэн дэмжихийн тулд” тавдугаар сарын дунд үе гэхэд хил хавийн нутгуудыг эзэлж авахыг санал болгожээ. 1950 оны нэгдүгээр сард ХКН-ын Төв хороо, түүний Цэргийн зөвлөл Түвд рүү хийх аян дайныг эхлүүлэх тухай удирдамжийг ХКН-ын Төв Хорооны баруун өмнөдийн товчоонд явуулжээ. Энэ зорилгод хээрийн 2-р армийг ашиглахаар төлөвлөсөн байна. Энэ армийн гол хүчийг 18-р корпус бүрдүүлжээ.[635]

Гэхдээ Бээжингээс Мао Зэдунд Түвдэд хийх интервенцийн төлөвлөгөөний тухай цахилгаан утас явуулаад зогссонгүй. Мао даргыг Москвад байх хугацааны туршид Гириний томоохон цахилгаан станцийг сэргээх, БНХАУ-ын агаарын цэргийн хүчин байгуулахын тулд хятадын нисэгчид бэлтгэх тухай, 93 мянган тонн бензин болон тослох материал яаралтай явуулах тухай зэрэг ЗСБНХУ-д хандсан олон тооны хүсэлт бүхий ХКН-ын төв хорооны цахилгаан утсууд ар араасаа ирж байлаа.[636] Энэ бүх хүсэлтийг нэн даруй биелүүлж байсан нь дайны дараах аж ахуйгаа сэргээн босгож хараахан чадаагүй байсан Зөвлөлт холбоот улсад асар их дарамт болжээ.

1950 оны нэгдүгээр сарын 22-нд болсон хэлэлцээний төгсгөлд Сталин өөр ямар нэгэн асуудал хэлэлцэх хүсэлтэй байна уу гэж Маогаас асуужээ. Маогоос ээлжит хүсэлт тавьж: “Таны явуулсан нисэх хүчний хороо бидэнд маш их тус болсныг тэмдэглэн хэлэхийг би хүсч байна. Энэ хороо 140 мянга шахам хүн тээвэрлэсэн билээ. Энэ тусламжийн төлөө нөхөр Сталин танд баяр хүргэхийн ялдамд түвдэд давшиж орохоор бэлтгэж буй Лю Бочэний цэргүүдэд хоол хүнс тээвэрлэн хүргэхэд тусламж үзүүлэхийн тулд нисэх хүчний энэ хороог хятадад хэсэг хугацаагаар байлгахыг Танаас хүсэх

гэсэн юм" гэж хэлсэн байна. Сталин: "Та бүхэн давшилтад бэлтгэж байгаа тань сайн хэрэг. Түвдчүүдийг гартаа оруулж авах хэрэгтэй. Нисэх хүчний хорооны тухайд бол цэргийнхэнтэйгээ ярилцаж байгаад Танд хариу өгье" гэж хариулсан байна. Сталин ч "ярилцаад" зөвшөөрсөн хариу өгчээ.[637] Гоминьданы цэргийн эсрэг байлдааны хамгийн хүнд ажиллагаа явуулахад, ялангуяа ХАЧА-ийн ангиудыг Шинжаан руу тээвэрлэхэд туслахын тулд ХКН-ын Төв хорооны хүсэлтээр явуулсан зөвлөлтийн нисэх хүчний хороо Хятадад байсан юм байна.

А.М.Ледовский:[638] "Нэгдүгээрт, нисэх хүчний хороо зөвлөлтийн байлдааны нисэх онгоцноос төдийгүй бүхэлдээ зөвлөлтийн цэргийн нисэгчдээс бүрдсэн бөгөөд энэ тусламж хууль бус байсан учир нисэгчид болон зөвлөлтийн нисэх буудлын ажилтнууд хятад хувцас өмсдөг байсан, хоёрдугаарт,ардын чөлөөлөх армийн цэргүүдийг түвдэд хүргэх, өөртөө засах энэ орныг түрэмгийлэн эзлэхийн тулд зөвлөлт засгийн газар хүнд ачаа ачиж, их өндөрт нисч чадах зөвлөлтийн хамгийн том, хүчирхэг дөрвөн мотортой нисэх онгоцуудаа гаргаж өгсөн, яагаад гэвэл түвдэд энэхүү байлдааны ажиллагааг явуулахын тулд хамгийн өндөр өндөр уулын оргил дээгүүр нисэх хэрэгтэй байсан, тэр үед өөр нисэх онгоцууд ийм өндөрийг давч чадахгүй байсан юм" гэж дурсан бичжээ.

Хятадын төлөөлөгчдийг Зөвлөлт Холбоот Улсаас буцахын өмнөхөн. 1950 оны хоёрдугаар сард "ЗСБНХУ, БНХАУ-ын найрамдал, холбоо, харилцан туслах тухай гэрээнд" гарын үсэг зурав. Энэхүү гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд цаашдаа тав таван жилээр аяндаа сунгагдаж байх ёстой (хожим нь хятадын удирдлага эхний хугацаа дуусмагц түүнийг цуцалжээ) байв. Хоёр тал хэлэлцээний дүнд сэтгэл хангалуун үлдсэн байна. Мао цөмийн зэвсэг өгөхөөс татгалзсан Сталины байр суурьт сэтгэл дундуур үлдсэн хэмээх санал зөрөлдөөнтэй таамаглалууд үнэнд үл нийцнэ. Бодит байдалд бол энэ хэлэлцээн дээр цөмийн зэвсгийн тухай асуудал ерөөс хөндөгдөөгүй (нилээд хожим, 1958 онд Н.С. Хрущев болон Мао Зэдун нарын хэлэлцээний үеэр энэ тухай яригдсан ажээ) юм.[639]

Гэвч хүсэлт зогссонгүй. "Мао Зэдуныг Бээжинд буцаж ирсний дараа хамгийн ноцтой бэрхшээлүүдийг даван туулахад ХКН-ын удирдлагад өргөн цар хүрээтэй, яаралтай тусламж үзүүлэхийг хүссэн хүсэлтүүд ар араасаа улам их цуварсан билээ" гэж А.М. Ледовский бичжээ.[640] Японы түрэмгийлэл, ХКН Гоминьдан хэмээх хоёр хувьсгалт намын хоорондын иргэний дайны дараа улс орон эвдрэл сүйрэлд орсон болохоор арга ч үгүй юм.

Хятад руу гадаадын тусламж өмнөхөөс улам их хэмжээгээр очих болов. Зөвлөлтийн цэрэг БНХАУ-ын хотуудад хийсэн гоминьданы нисэх хүчний халдлагыг няцааж байлаа, зөвлөлтийн цэргийн техник хятадын ардын чөлөөлөх армийн зэвсэглэлийг дүүргэж байлаа, богино хугацааны дотор ЗСБНХУ-ын тусламжтайгаар 250 шахам үйлдвэрийн газар байгуулж, хайгуул шинжилгээний ажил хийсэн байлаа.[641] ЗСБНХУ Порт-Артурын цэргийн бааз, түүнчилэн Дорнод хятадын төмөр замыг бүх дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийх нь хамт БНХАУ-д үнэ төлбөргүй шилжүүлэн өгөв. МиГ-15 маркийн олон сөнөөгч нисэх онгоцыг БНХАУ-д нийлүүлэв. Хятадын армийг солонгосын дайнд ороход зөвлөлтийн 64-р сөнөөгч нисэх онгоцны корпус түүнийг халхавчилж байв.

Хятадын тал бараг уран зөгнөлийн мэт санагдах хөнгөхөн буюу 1%-ын хүүтэй 1200 сая рублийн (300 сая доллар) зээл авчээ.[642] Тэр үед ЗСБНХУ-ын валютын нөөц маш бага байсан үед шүү. Үүгээр бүх асуудал дууссан хэрэг бишээ. ЗСБНХУ хоёр жилийн дотор 943 мянган тонн хар төмөрлөг, 1,5 сая тонн нефтийн бүтээгдэхүүн, түүний дотор 506 мянган тонн бензин, 477 мянган тонн керосин хятадад нийлүүлсэн байна.[643] Хятадын тал ЗСБНХУ-аас тэргүүний технологийг улам улам их хэмжээгээр авчээ. Тухайлбал, ЗСБНХУ 1950–1953 онд барилга, машины үйлдвэр, технологийн үйл явцын асуудлаар боловсруулсан шинжлэх ухаан-техникийн 599 иж бүрдэл баримт бичиг, 1954–1957 онд 6447 иж бүрдэл шинжлэх ухаан-техникийн баримт бичиг (зөвхөн хувилж олшруулсан зардал авсан), 1958-1960 онд гол төлөв хүнд аж үйлдвэрийн 7307 иж бүрдэл баримт бичиг үнэ төлбөргүй өгсөн байна.[644] ЗСБНХУ 1966 он хүртэл зөвхөн иргэний зориулалттай обьектууд барих, шинэчлэн засварлахад туслах нийт 8089 мэргэжилтнээ эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-д томилолтоор явуулжээ.[645] Зөвлөлтийн цэргийн технологийн үндсэн дээр БНХАУ-д дунд тусгалын “Дунфэн-1” пуужин, бөмбөгдөгч Н-6 нисэх онгоц, сөнөөгч-бөмбөгдөгч Q-5 нисэх онгоц зохион бүтээжээ.[646]

Тийнхүү ХКН гадаадын тусламжын ачаар засгийн эрхэнд гараад зогсоогүй цаашид ч тийм тусламжийг их хэмжээгээр авсан ажээ. Тэр жилүүдэд Мао Зэдун үүнийг нуугаагүй бөгөөд: “Империализм оршин тогтож байгаа эрин үед аливаа оронд олон улсын хувьсгалт хүчний зүйл бүрийн тусламжгүйгээр жинхэнэ ардын хувьсгал ялалтад хүрч чадахгүй юм <...> Энэ нь бидэнд өнгөрсөн үед тусламж хэрэгтэй байсан, одоо ч ийм тусламж хэрэгтэй байна, ирээдүйд ч хэрэгтэй байх болно” гэсэн үг юм гэж хэлжээ.[647] Тэр үед Зөвлөлт холбоот Улс маогийнхны нүдэнд “хөрөнгөтний

диктатурын бурангуй фашист улс" болон хувираагүй байжээ.[648]

Түвдэд гадаадын ийм өгөөмөр ивээн тэтгэгч байсангүй. Энэтхэг улс магадгүй Симлагийн хэлэлцээрийн үндсэн дээр түвдийг захирах хятадын сюзеренитетийг хүлээн зөвшөөрөхөөр бэлтгэж байснаа тайрбарласан юм. Их Британи улс мөн л иймэрхүү үзэл бодолтой байж, харин АНУ-ын эрх баригчид Их Британи, Энэтхэгийг дагах нь зүйтэй хэмээн үзжээ. Тус улс Лхаст хийх гэж байсан төлөөлөгчдийнхөө айлчлалыг болиулж, Түвдийн тусгаар тогтнолыг дэмжихгүй байх шийдвэр гаргасан байна.[649] Энэтхэг улсын байр суурь нь Ж. Неру улс орон нь хятадтай найрамдалтай байх явдлыг шинэ Ази тивийн хувьд, өрнөдийн биш ертөнцийн ёс суртахууны шинэ дэг журмын хувьд маш чухал зүйл хэмээн үзэж, тусгаар тогтносон Түвд улс энэ төлөвлөгөөнд аюул учруулна гэж төсөөлсөнтэй холбоотой юм.[650] Неру тэр үед маогийнхан удалгүй Энэтхэгт нутаг дэвсгэрийн өнгөлзлөг хийж, тэр өөрөө ч хятадуудын нүдэнд "империалистуудын эрх ашигтай нягт холбогдсон энэтхэгийн томоохон газрын эздууд, харгис бүлгийнхний төлөөлөгч" болон хувирахаа мэдээгүй бизээ.[651]

1950 оны нэгдүгээр сард Лхас хотын радио түвд, хятад, англи хэлээр нэвтрүүлэг явуулж эхлэв. Хятадын суртал нэвтрүүлгийг сөрөн эсэргүүцэх явдал энэ радиогийн гол зорилт байв. Нэгдүгээр сарын 31-нд энэ радиогоор Түвд 1912 онд манжийн гарнизоныг хөөж гаргаснаас хойш тусгаар тогтносон улс байсан юм хэмээн зарласан байна.[652] Түвдийн сайд нарын зөвлөл НҮБ-д түвдийг элсүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Их Британи, АНУ, Энэтхэгт уриалжээ. Энэ хүсэлтэд: одоо яагаад ч нэмэргүй, ЗСБНХУ, Хятад улс Аюулгүйн Зөвлөлд хориг тавих эрхээ эдлэнэ гэсэн хариу өгчээ. Ингээд түвдчүүд коммунистуудтай хэлэлцээ хийхийн тулд Москва, Гонконг, Сингапурт төлөөлөгчдөө явуулахаар шийдсэн байна.[653] Нэг ийм төлөөлөгчдийг В.Д. Шакабпа, Ц.Т. Гьелпо нар тэргүүлсэн байна. Тэдэнд Түвдийн засгийн газраас өгсөн итгэмжлэх жуух бичгэнд:[654]

"Цас мөсний орон Түвд бол шашин шүтлэгтээ үнэнч тусгаар тогтносон, энхийг сахигч орон мөн. Хятадад болж буй иргэний дайны явцад ялагдал хүлээсэн хятадын цэргүүд түвдийн нутаг дэвсгэрт орж ирэх боломжтой байгаагаас үүдэн манай орны амгалан тайван амьдрал эвдэгдэж, аюулд учраад байна, Түвдийн засгийн газрын гадаад хэрэг эрхлэх газар үхэр жилийн есдүгээр сарын арванхоёрны өдөр коммунист хятадын дарга Мао Зэдунд хятадын цэргийг Түвдийн нутаг дэвсгэр дээгүүр явуулахыг зогсоохын тулд эрх мэдлээ хэрэглэхийг хүсч захидал явуулсан боловч хятадын тал энэ хүсэлтэд хариу өгөөгүй юм. Үүний оронд Синин, Бээжингээс явуулж буй

радио мэдээллүүдэд Түвдийг хятадын нэг хэсэг хэмээн зарлаж, тус улсыг чөлөөлөхийг ард түмэндээ уриалжээ. Түвдийн хэргийг хариуцах бүрэн эрх бүхий төлөөлөгчид:

1) Түвдийн гадаад хэрэг эрхлэх газраас Мао даргад явуулж хариу аваагүй захидлын асуудлаар:

2) Синин, Бээжингээс явуулсан зүй бус мэдэгдлийн асуудлаар:

3) Түвдийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг зөрчихгүй байх баталгааны асуудлаар:

4) Түвдийн ард түмэн, засгийн газар Далай ламууд Түвдийг удирдахад хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрөхгүй, тусгаар тогтнолоо хамгаалахад бэлэн байгаа тухай Хятадын засгийн газрын мэдэглийн тухай асуудлаар хийх хэлэлцээнд оролцох ёстой.

Төлөөлөгчдөд хил орчмын ямар нэгэн районд хятадын төлөөлөгчтэй энэ бүх асуудлаар хэлэлцээ хийх заавар өгсөн болно" гэж өгүүлсэн байна.

Энэтхэгт суугаа хятадын элчин сайд Дели хотод хүрэлцэн очсон түвдийн төлөөлөгчдөөс түвдийг хятадын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрч, үндэснийхээ батлан хамгаалалтыг хятадын мэдэлд шилжүүлэхийг зөвшөөрч, гадаад орнуудтай хятадаар дамжуулан улс төрийн болон худалдааны харилцаатай байхыг шаарджээ.[655] Түвдийн засгийн газар энэ төлөөлөгчдөд дээрх бүх саналыг няцаах заавар өгсөн байна.

"БНХАУ-ын үндэсний цөөнхийн" олон нийтийн байгууллагууд болон төлөөлөгчид "Түвдийн район дахь империалистуудын өдөөн хатгалагыг" эсэргүүцсэн жагсаал хийх болов.[656] Хөх нуур мужийн лам нар түвдийг "чөлөөлж", харгис элементүүдийг устгаж, империалистуудыг хөөн зайлуулахыг шаардсан "хүсэлтийг" Бээжин рүү явуулсан байна. Сиканы Түвд хүн амын төлөөлөгчид Бээжинд очиж мөн иймэрхүү шаардлага гардуулав. Энэ төлөөлөгчдийн гишүүн Ван зя түвдийн ард түмний өмнөөс түвдийг "чөлөөлүүлэхийн" тулд хятадын ардын чөлөөлөх армийнхныг урьсан байна.

Энэ зуурт баруун өмнөд нутгийн цэрэг-захиргааны комисийн дарга Лю Бочэн аян дайн хийх цэргийг Сычуанд бүрдүүлж эхэлжээ. Лю Бочэн болон Дэн Сяопин (тэр үед ХАЧА-ийн баруун өмнөд цэргийн тойргийн улс төрийн комиссар байсан) нар аян замын цэрэг бүрдүүлэх ажлыг залуу дарга Жан Гохуад даалгахаар шийджээ. Олон цэрэг, дарга нар янз бүрийн шалтгаанаар Түвд рүү явахаас айж байлаа.[657] Энэ нөхцөлд тэр хүүмүүсийг цуглаанд оролцуулж, "түүхэн ариун зорилтуудыг" тайлбарлан таниулжээ. Энэ хийх гэж буй аян дайны нөхцөл Гоминьдантай хийсэн дайны үеийнхээс

хамаагүй хөнгөн болохыг онцлон тэмдэглэж байлаа.

1950 оны гуравдугаар сарын 18-нд 18-р корпусын цэрэг Сычуаниас Кам руу хөдөлж, Дарцедог (Кандин) эзлэв. Гуравдугаар сарын 28-нд 30 мянган хүнтэй тэргүүн шугамын ангиуд Карзе хүрсэн байна.[658] Эхний үед цэргийн хангалтын ажил маш хүнд, заримдаа хангалтын материалыг нисэх онгоцноос хаяж өгөх явдал ч гарч байв. Карзед зам, нисэх онгоцны буудал байгуулах ажил эрчимтэй өрнөж байв. Гүүр барих материал ачсан америк, зөвлөлтийн ачааны машины цуваа уртын урт үргэлжилж байсныг нүдээр харсан хүмүүс хожим дурсаж ярьсан байдаг. Автомашины зам тавьж байх зуурт Сиканд түвдчүүдийг барилгын ажилд, мянган сарлагыг тээврийн хэрэгсэл болгон ашиглаж байв. Үүнийг хийхэд хүнд биш байсан, яагаад гэвэл ажлын хөлсийг Гоминьданы үеийн хятадын цалин цагаан мөнгөн доллараар төлж байсан юм[659] гэж түвдийн нэг коммунист хэлсэн байдаг. Зарим хүн армид орох өргөдөл өгөх ажээ. Түвдчүүд хятадын цэрэгт “чадах ядахаараа дэмжлэг үзүүлж байгаа” тухай, жишээлэхэд дархан, мужаан хүмүүс армийнханд өдөр, шөнөгүй ажиллаж, малчид сарлагаа тууж ирж, эрэгтэй, эмэгтэйчүүд зэвсэг, сум хэрэгсэл зөөх бригадууд байгуулж, зам тавьж, хэлмэрч болон газарчаар ажиллаж байгаа тухай өргөн мэдээлж байлаа.[660]

Түвдчүүдийг зам, тээврийн ажилд тэдний хүсэлтийг үл харгалзан дайчилж байсан боловч таарсан хөлс шанг нь өгөх ажээ.[661] Орон нутгийн дээд бүлгийнхэн шинэ албан тушаалд очиж, өндөр цалин хөлс авах болов. Тийнхүү хүн ам “эх орноо чөлөөлөхийн төлөө” биш харин мөнгөний төлөө, бас айж эмээсэндээ ажиллаж байжээ. Нөгөө талаас түвдчүүд өөрийнхөөрөө л амьдарч сурсан бөгөөд Бээжин, Лхасын харилцааг нэг их анхаарч үзэхгүй ажээ. Түүнээс гадна эхний үед журам дүрэм зөрчих явдал бараг гардаггүй байв. Орон нутгийн оршин суугчид, тэдний зан заншил, шашинд хүндэтгэлтэй хандахыг армийнханд тушаажээ. Хятад улсад ажлын хүч, найдвартай ар тал л хэрэгтэй ажээ. Янз бүрийн газраас ирсэн хүмүүс У. Смитэд “хятадууд түвдчүүдэд туслахаар түвдэд орж ирсэн, Түвд орон “сайжирч”, өөрийгөө удирдах чадвартай болсон цагт гарч явна гэж бидэнд ярьсан” хэмээх нэг л зүйлийг хэлдэг байжээ.

1950 оны тавдугаар сарын 10-нд хятадын отряд стратегийн хувьд чухал ач холбогдолтой Денго пунктыг эзлэв.[662] Энд радиодамжуулагч ажиллаж байсан юм. Тэндхийн амбан захирагч Цэвэгдорж шууд энэ тухай сайд нарын зөвлөлд мэдээлж,өөрийнхөө хүчээр сөрөг давшилтад орох санал тавьсан байна. Зөвхөн Денгог буцааж авахыг түүнд зөвшөөрчээ. Генерал

Муджийн командалсан отряд энэ даалгаврыг биелүүлсэн байна.

1950 оны зургадугаар сард Солонгост дайн эхэлсэн, Гоминьдантай хийсэн мөргөлдөөн удаан үргэлжилсэн, эдгээр үйл явдалд АНУ нөлөөтэй оролцсон зэрэг нь Бээжингийнхнийг нилээд яарах байдалд хүргэсэн байна. Чунциний үйлдвэрийн газрууд хятадын армийг хувцас, сум хэрэгслээр хангах, Сычуань, Юньнаны үйлдвэрүүд хоол хүнсээр хангахын тулд илүү цагаар ажиллаж байлаа.[663]

Хятадууд "энхийн чөлөөлөлтийг" Лхасын засгийн газраар хүлээн зөвшөөрүүлэх гэж эрмэлзэв.[664] Зургадугаар сард Сининээс худалдаачдын дүрээр хэсэг хүн ирсэн бөгөөд тэд засаг баригч Тактра болон Түвдийн засгийн газарт хаягласан хоёр захидал авч ирсэн байна. Энэ хоёр захидалд хэлэлцээ эхлүүлэхийн тулд Бээжин рүү төлөөлөгчдөө илгээхийг санал болгожээ. Барагцаалбал энэ үед хятадуудыг радиодамжуулагчийн хамт дагалдсан өөр нэг төлөөлөгчдийг Амдогоос явуулсан байна. Тэр хэсэг хүн 3 сар шахам явж, Чамдог унасны дараа ирсэн боловч хятадуудыг Лхаст оруулсангүй. Долдугаар сард хятадууд Карзегээс Гед ламыг Лхас руу илгээв. Тэр лам 1936 оноос хойш хятадуудтай хамтран ажиллажээ. Түүнийг Чамдод баривчлан саатуулав. Гед удалгүй тодорхой бус нөхцөл байдалд нас барсан байна. Шууд нотолгоо байхгүй ч хятадын суртал нэвтрүүлэгчид түүнийг хорлосон гэж нотолдог юм. Гед ламын үхлийг Лхасынхан хэлэлцээ хийхээс дургүй байсан явдлаар тайлбарладаг юм.

Дели хотод Шакабпа хятадын элчин сайдтай холбоо барьж байжээ. Гэвч Түвдийн сайд нарын зөвлөлийн заавраар хэлэлцээ сунжирсан байна. Солонгосын дайн хятадуудын анхаарлыг улс орноос нь холдуулна хэмээн түвдчүүд найдсан байж болох билээ.

Баруун өмнөдийн цэрэг-засаг захиргааны комиссийн гол зорилт бол "түвдийг чөлөөлөх" явдал мөн бөгөөд Хятадын ардын чөлөөлөх арми "давшилтад орох ёстой" хэмээсэн генерал Лю Бочэний үгийг долдугаар сарын 29-нд бээжингийн радиогоор нэвтрүүлсэн байна. Гэвч хятадууд давшилтад ороход хараахан бэлэн биш байв. Энэ нь амбан захирагч Лхалу болон түүний офицеруудад Чамдогийн батлан хамгаалалтыг хэвийн байдалд оруулах боломж олгосон байна. Хятадууд 1950 оны наймдугаар сард л Дарцедогоос Карзе хүртэлх замыг барьж дуусгажээ.[665] Тийнхүү ХАЧА-ийн анги нэгтгэлүүд Амдод орж, Жекундод бааз байгуулж, Чамдогийн зүгт автозам тавьж эхэлсэн юм. Камд орсон ХАЧА-ийн ангиудад сычуаны милитарист (дайнч) Лю Вэньхуйн цэргүүд, Амдод Ма Буфэний дунганы отрядууд нэгдэж орсон байна.

Европын зэвсэгтэй болж, шинэтгэл хийсэн хэдий ч түвдийн армийн байлдах чадвар муу байлаа. Тус армийн зэвсэг гол төлөв хуучирсан, дэлхийн нэгдүгээр дайны үеийнх байв. Засгийн газар цэргийн бэлтгэл биш, хүний тоог л сонирхож байсан юм гэж Г. Харрер дурсан бичжээ.[666] Энэтхэгт бэлтгэгдсэн цэргийн сургагч нар орчин үеийн зэвсэг яаж хэрэглэхийг мэдэх ажээ. Түвд, урду, англи үг хольсон хэлээр цэргүүдэд команд өгнө. Үүнээс хойш бүх тушаалыг зөвхөн Түвд хэлээр өгч байх болно гэж батлан хамгаалалтын шинэ сайдын тушаалд өгүүлжээ. Түвдийн үндэсний сүлд дууллыг зохиож, түүнийг парадын үеэр эгшигшүүлэх ажээ. Офицер хүн цолноосоо шалтгаалсан тооны алтан өлзий хувцасан дээрээ хадсанаараа цэргээс ялгарах ажээ. Дүрэмт хувцас хүрэлцээгүй үлдсэн хүн олон байна. Цэргүүд цол, шагналын оронд цалингаа нэмүүлнэ. Ялалт байгуулсан нөхцөлд дайны олзноос цэргүүдэд өгнө. Энэ систем орчин үеийн дайнд биш, харгис дээрэмчидтэй тэмцэхэд үр нөлөөтэй байжээ. Түвдийн засгийн газар энэтхэгээс зэвсэг худалдаж авна. Хайрцагтай сум, гранат ачсан 500-2 мянган луус явж байсан тухай нэг ажиглагч бичжээ.[667] Түвдийн армид 8500 цэрэг,офицер, 50 их буу, 250 миномёт,200 шахам пулемёт,[668] 30 мянга орчим [669] винтов буу байв.

Хятадууд амьд хүч болон зэвсэглэлийн хувьд үлэмж давуу байжээ. Камд халдаж орох үед хятадын цэргийн тоо 40 мянга байв.[670] БНХАУ солонгосын дайнд орохоор товлосон хугацаанаас (бодит байдалд бол солонгост хийх хятадын давшилт аравдугаар сарын 25-нд эхэлсэн байна) зургаан өдрийн өмнө Төв Түвд рүү бөөн хүчээр давшив.

Хятадууд 1950 оны аравдугаар сарын 7-нд умард, төв, өмнөд гэсэн гурван чиглэлээр Дричу голыг (Хөх мөрний дээд бие) гатласан байна. 54-р хороо Денгогоос дээхнүүр Дричу голыг гаталж, Жекундогийн зүг давшив. Тэндээс өмнө зүг эргэж, түвдийн армийг бүслэн Лхас руу ухрах замыг хаахаар төлөвлөжээ. ХАЧА-ийн 157-р хороо Дричуг гаталж түвдийн цэргийн умард зүг ухрах замыг хаахын тулд Маркхам руу хөдөлсөн байна. Хятадууд нийтдээ Цакалогоос Денго хүртэл зургаан газраар давшилтад оржээ.

Чамдогийн умард хэсэгт гол тулалдаанууд болов.Түвдчүүд эрэлхэгээр тулалдав. “Цанго Дора... хятадын давшиж буй цэрэг рүү дайралт хийсэн боловч зэвсэглэсэн түвдчүүдийн жижигхэн бүлэг зохих ёсны эсэргүүцэл үзүүлж чадалгүй зөвхөн урт сэлмээр зэвсэглэсэн Цанго гардан тулалдаанд орж <...> Тэрээр олон хятад цэрэг устгаж эцэж цуцсан учир хэсэг амрахаар гүүрэн дор суужээ. Гүүрэн дээрээс дуссан цус түүний сахиусан дээр бууж

эзнээ хамгаалах хүчийг нь үгүй болгосон юм. Үүний дараа тэрээр гүүрэн дор хажууханд нь тэсэрсэн сумны хэлтэрхийд оногдож амь үрэгдсэн юм" гэж тэр тулалдааныг нүдээр харсан хүн тэмдэглэн үлдээжээ.[671]

Денгогийн гарнизон дайсныг тогтоон барьж, генерал Муджейн командалсан цэрэг хятадын ардын чөлөөлөх армийн цэргүүдийг голын цаана гартал нь нэхэн хөөсөн байна.[672] Гэвч умард талаасаа бүслэгдсэн генерал Ривочег алдахгүйн тулд ухрахад хүрчээ. Хятадууд хүн хүчний давуу байдлаа ашиглан "давалгааны араас давалгаа" хэмээх тактикаа хэрэглэсэн байна. Хоёр тал үлэмж хохирол хүлээв. Хятадуудыг ялалт байгуулах хүртэл Түвдийн тал хэд хоног тогтоон байлджээ. Рангсум, Маркхам, Денго, Жекундо, Ривоче, Гартокийг ээлж дараалан алдав. Тийнхүү Чамдо бараг хамгаалалтгүй үлдсэн бөгөөд тулалдаанд ороогүй, бас хятадуудаас муу зэвсэгтэй 3 мянга орчим хүн л байв.[673]

Аравдугаар сарын 11-нд Чамдогийнхан халдлага эхэлсэн тухай мэдсэн боловч хүмүүс тэгтлээ их сандралд ороогүй ажээ. Оршин суугчид дайснаас чөлөөлөгдөхийн төлөө мөргөл үйлдэхээр хийд рүү цувж эхэлжээ. Тэр үед Агваан Жигмэд Чамдогийн захирагч байв. Үүнээс өмнө тэрээр Камд алба хааж, авьяас чадвар нь ч гоц ялгарч гараагүй юм. Чамдод тэр хүн үдэшлэг цэнгээнд оролцох дуртай, эр зоригтой тулалдаж явснаа, ХАЧА чадварлаг болохыг ярих дуртай нэгэн байв. Лхас хотынхон "чөлөөлөлт" эхэлсэн тухай мэдээг аравдугаар сарын 10-нд л олж мэджээ. Жигмэд сайд нарын зөвлөлөөс ямар захирамж гаргах гэж байгааг асууж сонирхсон боловч хариу ирсэнгүй. Ингээд Жигмэд ухрахаар шийджээ.[674]Тэрээр аравдугаар сарын 17-нд Чамдогоос гарахдаа тэнд орхисон зэвсэг болон бусад хэрэгслийн агуулахыг устгахыг хоёр Түвд офицерт тушаасан байна.[675] Дараа нь тэрээр генерал Муджед бууж өгөхийг тушаасан байна.[676] Аравдугаар сарын 18-нд ХАЧА-ийн умардын бүлэг Түвдийн цэргийн баруун зүгт ухрах замыг тасалсан байна. Аравдугаар сарын 19-нд хятадууд Чамдо хотыг эзлэв. Тэнд хятадын цэрэг радио дамжуулах станцийг англи холбоочны хамт эзэлж авсан байна. Тэр өдөр Чамдогийн захирагч Агваан Жигмэд бууж өгөхөө хятадуудад мэдээлж, маргааш нь ийнхүү бууж өгчээ. Түвдчүүд түүнийг урвасан гэж үздэг ажээ.

Бууж өгсөн офицерууд болон Жигмэдийг Чамдод аваачиж, цэргүүдэд социализмын тухай лекц уншсаныхаа дараа цалин цагаан мөнгө болон хоол хүнс өгч тавьж явуулсан байна.[677] Хятадын цэрэг аравдугаар сарын 22-нд Лхо Зонг, 27-нд Шопандог эзэлжээ.[678] Чамдод түвдчүүдийн тусламжтайгаар ялалт байгуулсан, тэд хоол хүнс, түүнчилэн ачаа бараа тээвэрлэх сарлаг авч

ирж байсан гэж хятадын талын мэдээнд өгүүлсэн байдаг юм.[679] ХАЧА-д тээврийн тусламж үзүүлэхэд 150 мянган Түвд хүн оролцож, 100 мянган сарлагаа ачлага уналгад хэрэглүүлжээ. Олон хүн ХАЧА-ийн эсрэг тулалдаж, зарим хүн тэр армийн талд орж, бас олон Түвд цэрэг Чамдог унахаас бүр өмнө бууж өгсөн байна.[680]

Хятадын талын мэдээгээр бол алагдаж, шархдаж, олзлогдсон түвдчүүдийн тоо 5738, үүнээс алагдсан хүн 180 болсон байна.[681] Хятадын баримт мэдээг иш татан уламжилсан Түвдийн мэдээгээр бол 1950 оны аравдугаар сарын 7–25-ны хооронд хятадын ардын чөлөөлөх арми түвдийн 5700 гаруй цэрэг "үгүй хийж", 2 мянга гаруй хүнийг Дорнод Түвдийн янз бүрийн мужийн шоронгуудад хорьжээ.[682]

"Гурван сая Түвд хүнийг империалист дарлал мөлжлөгөөс чөлөөлж, хятадын баруун хилд үндэсний батлан хамгаалалтыг бэхжүүлэхийн тулд Түвдийн нутгийн гүн рүү орохыг ардын армийн анги, нэгтгэлүүдэд тушаасан"[683] тухай БНХАУ-ын мэдэгдэл 1950 оны аравдугаар сарын 25-нд л нийтэд тодорхой болсон байна. Үүний хариуд "Түвдийн удирдагчдын тунхаг" хэвлэгдэж гарсан бөгөөд түүнд "түвдийг чөлөөлөх" хэмээх үг бол яахын аргагүй доромжлол, яагаад гэвэл эрх чөлөөт хүмүүсийн орныг чөлөөлөлт нэрийдлээр булаан эзэллээ гэж өгүүлсэн байна. Радиогоор нэвтрүүлсэн мэдээллүүдэд Түвдэд империалистууд гэж байхгүй, Түвд орон хэзээ ч хятадын нэг хэсэг байгаагүй, харин хятад улс түвдэд халдсан юм гэж өгүүлжээ.[684]

Энэтхэг улс аравдугаар сарын 26-нд БНХАУ-ын үйлдлийг буруушаав. Энд нилээд болгоомжилсон томьёолол хэрэглэсэн байна. Харин түүний хариулт шууд утгатай байсан бөгөөд хятад улс түвдийн ард түмэнд түрэмгийллээс чөлөөтэй байж, бүс нутгийнхаа өөртөө засах эрх, шашныхаа эрх чөлөөг эдлэх боломж олгохын тулд "түвдийн ард түмнийг чөлөөлөх <...> гадаадын хүчнийг хөөн гаргаж, түүний нөлөөг устгах бүрэн эрх болон "ариун үүргээ" биелүүлсэн юм гэжээ.[685] Энэ хандлага хятадын ардын чөлөөлөх армийн 1950 оны арваннэгдүгээр сарын 11-ний өдрийн тунхагт тусгагджээ.[686]

"Ардын төв засгийн газрын дарга Мао Зэдун, ХАЧА-ийн ерөнхий командлагч Жу Дэ нар түвдийн ард түмнийг Их Британи, Америкийн империалистууд болон Чан Кайшийн харгис засгийн газар удаан хугацаагаар дарлан мөлжиж байгаад гүнээ сэтгэл түгшиж, түвдийн ард түмнийг энэ дарлалаас үүрд чөлөөлөхийн тулд түвдэд орохыг манай армид тушаасан билээ. Манай түвдийн шашны бүх байгууллага, ард түмэн ХАЧА-д аль

болох бүх талын тусламж үзүүлж, империалист нөлөөг ховх цохин хаяж, түвдийн өөртөө засах эрхийг хэрэгжүүлэхийн тулд, улс орныхоо бусад үндэстэнтэй найрамдал, харилцан туслах ах дүүгийн харилцаа тогтоохын тулд, тэдгээрийн тусламжтайгаар шинэ Хятадын бүрэлдэхүүнд шинэ Түвд улсыг цогцлон байгуулахын тулд нэн даруй нэгдэн нягтрах ёстой юм.

ХАЧА Түвдэд ормогцоо шашны бүх байгууллага, ард түмний амьдрал, эд хөрөнгийг хамгаалах, түвдийн бүх ард түмний шашин шүтэн эрх чөлөө,сүм, хийдүүдийг хамгаалж, ард түмний амьдралыг сайжруулахын тулд боловсрол, хөдөө аж ахуй, мал аж ахуй, аж үйлдвэр, худалдааг нь хөгжүүлэхэд түвдийн ард түмэнд туслах болно. Түвдийн одоогийн улс төр, цэргийн систем өөрчлөгдөхгүй. Түвдийн одоогийн цэргийн хүчин БНХАУ-ын батлан хамгаалах хүчний нэг хэсэг болно. Бүх түвшингийн шашны байгууллагын гишүүд, засгийн газрын түшмэд болон удирдагчид үүрэг хариуцлагаа урьдын адил биелүүлэх болно. Түвдэд хийх шинэтгэлтэй холбоотой бүх зүйлийг түвдийн ард түмний хүсэл эрмэлзэлийг бүрэн харгалзан үзэх үндсэн дээр, түвдийн ард түмэн, удирдагчидтай зөвлөлдөх замаар хэрэгжүүлнэ. Урьд өмнө империализмын талыг, гоминьданы талыг баримталж байсан засгийн газрын түшмэд ажил цалгардуулж, эсэргүүцэл үзүүлэхгүй бол албан тушаалдаа хэвээр үлдэх бөгөөд тэдний өнгөрсөн үйл ажиллагаатай холбогдсон ямар нэгэн хавчлага явуулахгүй" гэж энэхүү тунхагт өгүүлжээ. Энэ үед Түвд болон түүний хилийн чанадад гарч буй дургүйцлийн давалгааг багасгаж, тус оронд бүрэн хяналт тогтоох цаг хугацаа хожихын тулд аядуу хандлага баримтлах шаардлагатай байв.

1950 оны арваннэгдүгээр сарын 1-нд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Түвдэд БНХАУ-ын явуулж буй үйлдлийг "Азид цаашид коммунистуудын явуулах түрэмгийлэл" хэмээн тодорхойлсон байна.[687] Арваннэгдүгээр сарын 6-нд Их Британи улс хятадын үйлдлийг зэмлэн буруушааж, Түвдээс цэргээ гаргахыг Хятад улсаас шаардав. Английн парламентын зарим гишүүн Түвдэд агаараар цэрэг оруулахын тулд Британийн хамтын нөхөрлөлийн улсуудтай хэлхээ холбоо тогтоохыг санал болгов. Тэр үед Их Британи улс Түвдтэй гэрээгээр хүлээсэн бүх үүрэг, хариуцлагаа Энэтхэгт шилжүүлжээ. Түвд арван нэгдүгээр сарын 7-нд НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргад илгээлт явуулж, хятадын түрэмгийллийг зогсооход туслахыг уриалсан байна. Түвдийн засгийн газар энэхүү илгээлтдээ: "Түвдийг коммунист хятадын бүрэлдэхүүнд гагцхүү хүч хэрэглэн нэгтгэх зорилгоор эзэлж авсан нь яахын ч аргагүй түрэмгийллийн илрэл мөн. Түвдийн ард түмэн хүсэл, сэтгэлээрээ биш бусдын хүчээр

Хятадын нэг хэсэг болж байгаа цагт түвдийг булаан эзэлсэн явдал хүчтэй нь хүчгүйгээ эзэгнэхийн аймшигт жишээ болсон хэвээр байх болно.

Тийм учраас бид Танаар дамжуулан бидний талд зогсож, хятадын түрэмгийллийг зогсооход туслахыг дэлхийн ард түмнүүдэд хандан уриалж байна" гэж албан ёсоор мэдэгджээ.[688]

Үүнээс хоёр хоногийн өмнө НҮБ хятадын цэрэг Солонгост орсон тухай нотолгоо хүлээж авсан бөгөөд энэ асуудал ч хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд тавигдсан байлаа.[689] Сальвадорын төлөөлөгч НҮБ-ын Ерөнхий Ассамблейд түвдийн тусгаар тогтнолын тухай асуудлыг дэвшүүлэн тавьсан байна. Тэрээр "Түвдэд өөр улсын хүчин цөмөрч оров" хэмээх нэртэй баримт бичиг танилцуулжээ. Зөвлөлтийн төлөөлөгч ерөөс түвдийн асуудлыг хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнөөс хасахыг уриалжээ. Энэтхэг улс асуудлыг НҮБ-ын оролцоогүйгээр эв зүйгээр шийдвэрлэх арга олохыг санал болгожээ. Түвдийн асуудлыг авч хэлэлцэх нь Солонгосын мөргөлдөөнийг шийдвэрлэх талаар энэтхэг улсын тавьж буй зуучийн хүчин чармайлтад саад болно гэж энэтхэгийн төлөөлөгч болгоомжилсон байна. Тухайн үедээ Түвдийг мэдэлдээ оруулах гэсэн Бээжингийнхний үйлдлийг өдөөн тухирч (дэмжиж) байсан Их Британи улс түвдтэй ойр дотно харилцаатай байсан хагас зуун жилийн дараа Манай засгийн газар түвдийн статусыг тодорхой бус хэмээн үзэж, энэ асуудлыг хойш тавихыг санал болгож байна гэж мэдэгджээ.[690] Тус улс Энэтхэгийн саналыг дэмжиж, дараахан нь АНУ ч мөн дэмжсэн байна.[691] Ийнхүү Түвдийн асуудал хэлэлцэхийг хойшлуулжээ. "Холбоотнуудынхаа" тийм зан авирт урам хугарсан Түвд улс мөрдөн шалгах комисс явуулахыг хүссэн илгээлтийг НҮБ-д явуулав. Үүний хариуд ямар ч үйлдэл хийсэнгүй.

1950 оны арван нэгдүгээр сарын 16-нд Энэтхэг дэхь Канадын дээд комиссар Түвдийн статус эрхийг маш товчоор базаж тодорхойлсон илгээлтийг Оттава хот руу явуулсан байна.[692] Тэрээр "чөлөөлөлт" гэгчийн тухайд хятадуудын гаргаж ирж буй шалтаг шалтгаанууд зүйд нийцэхгүйг цохон заажээ. Нэгдүгээрт, Хятадын эрх баригчид тус улсын сюзеренитет түвдийн өөртөө засах эрхтэй зохицсон хэлэлцээрийг хэзээ ч баталж байгаагүй. Цаашлаад сюзеренитет гэдэг нь бүрэн эрх, ялангуяа өөртөө засах эрхийг (автономи) ямар нэгэн хэлэлцээрийн нэг хэсэг хэмээн үзэж буй нөхцөлд ийм бүрэн эрх болж чадахгүй бизээ. Хэрэв хятад улс Түвдийг эзэмшиж байсан бол хоёр этгээдийн харилцааг зохицуулахын тулд арми илгээх үндэслэл байхгүй байсан юм гэж тэрээр онцлон тэмдэглэжээ.

1950 оны арваннэгдүгээр сарын 21-нд гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн нарийн бичгийн дарга Вашингтонд суугаа канадын элчин сайдын

яаманд түвдийн асуудлыг НҮБ-д хэлэлцүүлэхээр оруулах боломжтой холбогдуулан гаргасан эрх зүйн хэлтсийн меморандум явуулсан байна. Түвдийг эзэмших хятадын сюзеренитет эрх 1911 он хүртэл ёс төдий байсан ч гэсэн дараа нь тэрхүү эрх хоосон зүйл болж хувирсан юм. Үнэн хэрэгтээ бол Түвд сүүлийн 40 жилд дотоод, гадаад хэргээ өөрөө хянаж иржээ. Ийм нөхцөлд түвдийг олон улсын эрх зүйн үүднээс бол бие даасан улс хэмээн үзэх ёстой билээ гэж тэр меморандумд өгүүлсэн байна. Канадын засгийн газар дээр дурдсан баримт бичгүүдийг 2009 онд л ил болгож тавьсан байна.

1950 оны арваннэгдүгээр сарын 17-нд түвдийн Үндэсний Ассамблей иргэний болон шашны бүх эрхийг тэр үед 15 настай байсан XIV Далай ламд шилжүүлж өгчээ. Түүний гадаад хэрэг эрхэлсэн нарийн бичгийн дарга:[693]"Түвд орон засгийн бүх эрхийг авсан Далай ламаа тойрон нэг хүн мэт нэгдэж байгаа бөгөөд Түвдэд үйл ажиллагаа явуулж буй гадны хүчинд ямар ч боломж байхгүй. Бид өдөж авчираагүй энэ түрэмгийлллийг няцаахад энхийн тусламж үзүүлэхийг хүсч дэлхийн улс орнуудад хандлаа. Хэрэв ийм тусламж ирэхгүй бол бид тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэхээр шийдсэн билээ. Шаардлагатай гэж үзвэл бид тэмцлээ үргэлжлүүлэхийн тулд засгийн газар болон Далай ламыг өөр мужуудад шилжүүлэн нүүлгэхэд ч бэлэн байна. Түвд бол газар зүйн тогтоцын хувьд өргөн уудам бөгөөд бэрхшээл бартаатай орон, хэрэв бидэнд хүн хүч, зэвсэг хэрэгсэл олдвол байлдааны ажиллагааг эцэс төгсгөлгүй үргэлжлүүлж чадна" гэж мэдэгдсэн байна.

Хятадууд 1950 оны арваннэгдүгээр сарын 24-нд Камд Сикан мужийн анхны түвдийн өөртөө засах район байгуулж, Дерцедо (Кандин) хот түүний төв болсон байна. Энэ район баруун талд Хөх мөрнөөс зүүн тийш Дадухэ гол хүртэл[694] үргэлжлэн тогтжээ. Мөн оны тавдугаар сард Ганьсу мужид Тяньжугийн (Пари) өөртөө засах гацаа байгуулав.

БНХАУ суртал нэвтрүүлгийн хумхаа өвчинд автжээ. Түвдийг "чөлөөлөхийн" төлөө олон хүн оролцсон цуглаан зохион байгуулах болов. Тосгоноосоо өөр юу ч үзээгүй шахам "хоцрогдсон" түвдчүүд гэнэт улс төрийн боловсролын гайхамшиг үзүүлж эхэлжээ. Тэд газар сайгүй зохион байгуулдаг ийм цуглаан дээр төв засгийн газрыг "бүрэн дэмжиж", америкийн империализмыг гутаан доромжилж, Түвд оронг бүхэлд нь "тайван замаар чөлөөлөхийг" шаардаж байлаа.[695] Түүнээс гадна тэд Солонгос дахь америкийн түрэмгийлэл, Алс Дорнод дахь америкийн империализмын төлөвлөгөө, японыг дахин цэрэгжүүлэх явдлыг эсэргүүцэж, таван их гүрэн энх тайвны гэрээнд гарын үсэг зурахыг уриалж байв.

Нэгэн хэв шинжит жишээ дурдая.[696] Нэгэн өндөр албан тушаалын

хятад түшмэл шинэ дэглэмийн тухай та юу бодож байна вэ? гэж Түвд тариачнаас асуухад маш баяртай байна хэмээн хариулаад: "Шинэ татвар гэж нэг зүйлгүй бол ч" гэж хэлэхэд, – "ямар шинэ татвар? "хэмээн хятад түшмэлийг асуухад – "Алга таших татвар. Бидэнд хятад хүн ирэх бүрт л бид нэгэн дуугаар цугларч, алга таших ёстой болдог юм" гэж тэр тариачин эр хэлсэн гэдэг.

Балбад ч хятадын суртал нэвтрүүлгийн хэлбэрүүд үүсч бий болов. Жишээ нь, олон тооны гэрэл зургаас бүрдэх хятад-түвдийн долоо хоног дутмын сэтгүүлд "чөлөөлөгдсөн" түвдийн ард түмэн хятадуудтай танилцаж: баяр хөөрийн инээмсэглэл тодорсон зулуу бүсгүйчүүд хятад дарга нарын машиныг арчиж, туг далбаа барьсан залуус удирдагчдад баяр хүргэж байгааг дүрслэн харуулжээ. "Энэ сэтгүүл "материализм" хэмээх нэртэй аварга биетэн танай гэрийн босгоны дэргэд тулж ирснийг улиглан сануулах ажээ"[697].

Хэний ч үгэнд орох дургүй голок омгийн зарим удирдагч 1951 онд хятадын эрх баригчидтай өвөр түрийдээ орох болжээ.[698]1952 оноос тэр удирдагчдын зөвшөөрлөөр "ажилчдын бүлгүүд" ирж, бүхэл бүтэн сүлжээ үүсгэсэн байна. "Ардын засгийн газрууд" байгуулж, сургууль, эмнэлэг, мал эмнэлэгийн станц, шуудан барьж эхэлсэн байна. Гэвч голокууд хятадуудын улам өсөн нэмэгдэх нөлөөнөөс болгоомжлох болж, зургаан жилийн дараа бослого гаргасан байна.

1952 оны арванхоёрдугаар сарын 19-нд Далай лам шадар хүмүүсийнхээ санаачлагаар Цэрэнгийн командалсан хэдэн зуун цэргээр хамгаалуулан Лхасаас гарч, Энэтхэгийн хилийн дэргэд байх Дромод 1951 оны нэгдүгээр сарын 5-нд очсон байна. Энд Түвдийн засгийн газар байрлав. Далай лам Донкар хийдийг албан өргөөгөө болгожээ. Лхасаас нунтаг алт болон мөнгөн гулдмайныхаа зарим хэсгийг Сиккимтэй залгаа хил рүү авч ирсэн нь есөн жилийн дараа тун их хэрэг болжээ.[699] Далай лам Лхасаас гарч явснаас болж тэндхийн хүмүүс сандралд орж[700], чинээлэг хүмүүс хөрөнгө зоорио илжиг, луусанд ачиж, аюулгүй газар бараадав. Лхаст эсэргүүцлийн үзэл санаа унтарсан байлаа гэж тэнд сууж байсан энэтхэгийн төлөөлөгч мэдээлсэн байдаг.

Энэ зуурт Агваан Жигмэд болон олзлогдсон түвдийн бусад түшмэл Чамдод "дахин хүмүүжигджээ".Тэнд хятадын цэргүүд бүрнээ дэг журамтай байгааг тэд харсан байна. Цэргүүд зөвхөн майханд байна, сүм хийдүүд болон түвдчүүдийн. гэрт хэзээ ч суудаггүй, тэднээс "сэтэрхий тэвнэ" ч авдаггүй, боломж л гарвал тусалдаг, эмнэлгийн тусламж үзүүлнэ[701] гэж

Агваан Жигмэд дурсан бичжээ. Ингээд олзлогдсон захирагч Лхас руу хоёр ч удаа захидал бичиж, цэргийн халдлагаас зайлсхийхийн тулд хэлэлцээ хийж эхлэхийг уриалжээ. Гэсэн ч тэрээр бас нэг нууц захидал явуулж чаджээ. Тэрээр энэ захидалдаа бие даасан үйлдэл хийж чадахгүй байна, хятад цэргийнхэнтэй зохицож байхаас өөр арга алга, түвдийн засгийн газар миний тухайд, олзлогдсон бусад түшмэлийн тухайд сэтгэл зоволгүйгээр хэрэгтэй гэж үзсэн тэр л алхамаа хийх ёстой гэж мэдээлжээ.[702] Түвдийн Засгийн газар удаан хэлэлцсэний эцэст Агваан Жигмэдийг оролцуулан 3 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг хэлэлцээ хийлгэхээр Чамдо руу явуулахаар томилсон байна.

Далай лам болон сайд нарын зөвлөл хэлэлцээ хийх бүрэн эрхийг түүнд олгов.[703] Түүнд явуулсан захидалд Түвдийн тусгаар тогтнолыг хамгаалж, тэнд ХАЧА-ийн ангиуд оруулахаас татгалзахыг анхааруулсан байна. Түүнд мөн хэлэлцүүлгийг эхлүүлэх таван зүйлт мэдэгдлийг гардуулж өгчээ; 1. Түвдэд империалистуудын нөлөө байхгүй; XIII Далай лам энэтхэгт очсоны дүнд британчуудтай бага зэргийн хэлхээ холбоо л тогтсон; АНУ-тай харилцах харилцаа зөвхөн арилжааны шинж чанартай; 2. хэрэв Түвдэд империалист гадаадын нөлөө үүсвэл тус улс Хятадаас тусламж хүснэ; 3. Камд байрлуулсан хятадын цэргийг гаргах ёстой; 4. Банчин лам болон засаг баригч Райдангийн бүлэг хятадын засгийн газарт нөлөөлөх ёсгүй; 6. манжийн үеийн хятад, гоминьдан болон шинэ хятадад эзлэгдсэн нутаг дэвсгэрүүдийг түвдэд буцааж өгөх ёстой.

Агваан Жигмэдийг хятадуудад энэ таван зүйлт мэдэглийг танилцуулахад тэд дөрөвдэхээс бусад бүх заалтыг эсэргүүцэж, Түвдэд районы өөртөө засах эрх санал болгосон байна. Хоёр талын байр суурийг ойртуулж чадаагүй учир Жигмэд Лхас буюу Бээжинд хэлэлцээ хийхийг Түвдийн засгийн газарт санал болгожээ.

Далай лам хилийн чанадад гарах хэрэгтэй юу, эсвэл Бээжинд хэлэлцээ хийж эхлэх нь зөв үү гэсэн асуудлыг түвдийн засгийн газрын хүрээнд хэлэлцэв. Сүүлчийн санал давамгайлж, 1951 оны нэгдүгээр сард Далай лам Шакабпагийн төлөөлөгчдийг Энэтхэгээс буцаж ирэхийг дуудав. Хоёрдугаар сард хоёр хэсгээс бүрдсэн төлөөлөгчдийг Бээжинд хэлэлцээ хийлгэхээр явуулсан бөгөөд нэг төлөөлөгчид Түвдээс, нөгөө нь Энэтхэгээс очих болсон байна. Төлөөлөгчдийг Агваан Жигмэд тэргүүлэх болов. Түүнээс гадна төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Түвд улсын зэвсэгт хүчний командлагч, Далай ламын гарын нарийн бичгийн дарга болон түшмэд, сүм хийдийн төлөөлөгчид зэрэг өөр 18 хүн орсон бөгөөд Амдо мужаас Банчин

лам мөн Бээжин орохоор морджээ.[704]

Жигмэд тэргүүтэй төлөөлөгчдөд оролцогчдын нэрсийн жагсаалт бүхий баримт өгсөн байна. Түвдийг захирах Бээжингийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч болохгүй, бүх чухал асуудлаар Дромо руу холбогдон зөвлөлгөө авах хэрэгтэй, Бээжин, Дромогийн хооронд радио холбоо тогтоох нь зүйтэй гэсэн заавар өгчээ.[705] Агваан Жигмэд төлөөлөгчдийн ахлагчаар томилогдсон ч сайд нарын зөвлөл болон Далай ламтай зөвлөлдөлгүйгээр шийдвэр гаргах эрхгүй байв. Энэтхэгээр дамжиж ирсэн нөгөө төлөөлөгчдийн гишүүд сайд нарын зөвлөлөөс шинэ заавар авсан байна. Энэ төлөөлөгчид эхний үед түвдийн тусгаар тогтнолыг хамгаалах, хэрэв хэлэлцээ мухардмал байдалд орвол дараах болзлоор Түвд улс хятадын нэг хэсэг болохыг зөвшөөрөх ёстой байв: 1) Түвд дотоодын бүрэн тусгаар тогтнолтой байх ёстой; 2) Тэнд хятадын цэрэг байх ёсгүй, 3) Батлан хамгаалалтын төлөө түвдийн арми хариуцлага хүлээх ёстой; 4) Лхаст байх хятадын төлөөлөгч, түүний ажилтнууд болон хамгаалалтынхны тоо 100 хүнээс давах ёсгүй; 5) Хятадын төлөөлөгч бурханы шашинтан байх ёстой зэрэг болно.

Хятадууд энэ болзлыг хүлээж авахгүй гэж Жигмэд Дромо руу цахилгаан утсаар мэдээлсэн байна. Хятадын цэргийг Түвдэд байрлуулж болохгүй, харин түвдийн армийг батлан хамгаалалтын зорилгоор хятадын армийн бүрэлдэхүүнд оруулж болох юм гэсэн хариуг түүнд явуулжээ. Гуравдугаар сарын 26-нд Жигмэд тэргүүтэй төлөөлөгчдийн нэг хэсэг Чамдо руу хөдлөв. Дэн Сяопин болон бусад коммунистууд замын туршид төлөөлөгчдөд “хүмүүжлийн хичээл”[706] заасан байна. Энэ ажилд Пунцаг Ванжил ч хятад туслахынхаа хамт оролцжээ. Пунцаг Ванжил бол Түвдийн коммунист намыг үндэслэгч хэмээн алдаршсан хүн юм. Тэрээр 1940-өөд оны дундуур Агваан Кесангтай хамт Нанжинд жижигхэн бүлэг байгуулж, түүнийгээ Түвдийн коммунист хувьсгалт бүлэг хэмээн нэрлэсэн бөгөөд дараа нь түүнийг 1949 онд ХКН-ын бүрэлдэхүүнд орсон түвдийн коммунист нам болгожээ.[707] Энэ хүн 1950-аад онд Түвдэд орсон хятадын зэвсэгт хүчний голлох газарч, хангамж хариуцсан (үр тариа, малаар) мэргэжилтэн болж, Чамдо, Маркхам дахь Түвдийн командлалыг дайсны талд оруулах гэж элдвээр оролдож байжээ.[708] Түүнээс гадна, хятадын 18-р корпусын олон нийтийн харилцааны асуудал хариуцсан хүн байв. Төлөөлөгчдийн гишүүд, түүний дотор олзлогдсон Агваан Жигмэдийг бодоход хятадуудтай сайн дураар хамтран ажиллажээ. Тэрээр түвдийн засгийн газрыг үр нөлөө муутай хэмээн үзэж байсан учир хятадуудын тусламжтайгаар эх орноо “хоцрогдлоос чөлөөлөхийг” хүсчээ. Хэлэлцээн дээр хятадуудад орчуулагчаар ажилласан

байна. Энэ ажил хятадуудын хувьд маш чухал байсан, учир нь түвдчүүд (төлөөлөгчид) бараг бүгдээрээ хятадаар ярьдаггүй байв. Хожим нь Ванжил ардчилсан шинэтгэл хийх арга буруу байсан учир бослого гарсанд харамсаж, бас төв засгийн газар Түвд, Камын харилцааг ойлгохыг хүсээгүй явдалд харамсаж байгаагаа илэрхийлжээ.[709] Үүнээсээ болж тэрээр баривчлагдан 18 жил шоронд суусан ч марксист үзэл бодлоо орхиогүй ажээ. Нилээд хожуу БНХАУ-д түүний дурсамжын номууд гарсан байна.

Чамдогоос гарсан төлөөлөгчдийн зарим хэсэг дөрөвдүгээр сарын 22-нд Бээжинд ирэв. Дромогоос ирэх ёстой нөгөө хэсэг төлөөлөгчид дөрөвдүгээр сарын 26-нд мөн тэнд очсон байна. Төмөр замын буудалд төлөөлөгчдийг гадаадын зочдын нэгэн адил ёс төртэй угтав.

Хоёр талын хэлэлцээнд зориулж хятадуудын бэлтгэсэн 10 зүйлт баримт бичгийг дөрөвдүгээр сарын 28-нд түвдчүүдэд тарааж өгсөн байна.[710] Өмнө нь хятадын талын мэдэгдэж байсан санаанууд энэхүү баримт бичгийн үндэс болжээ. Дараа өдөр нь хэлэлцээ эхлэв. Түвдчүүд хятадын баримт бичгийг няцааж, таван зүйлээс бүрдсэн өөрсдийнх нь баримт бичгийг авч хэлэлцэхийг санал болгосон байна. Хятадууд татгалзав. Ингээд хэлэлцээ тавдугаар сарын 2-нд сэргэв. Түвдийг эзэмших хятадын бүрэн эрх бол хэлэлцэх асуудал биш, бидний санал болгосон 10 зүйлт баримт бичгийг л хэлэлцэж болох юм. Түвдэд ХАЧА орсон явдал түвдийн ард түмэн болон нийт БНХАУ-д таатай нөлөө үзүүлсэн бөгөөд "үндэсний цөөнхийг чөлөөлөх", империалистуудын түрэмгийллийг сөрөн эсэргүүцэх зорилгоор л ийнхүү арми оруулсан, энэ бол БНХАУ-ын дотоод хэрэг, төв засгийн газрын шийдвэр юм. Далай лам энэтхэг рүү явах аваас түүнийг "албан тушаалаас нь зайлуулна" гэж хятадууд мэдэгдсэн байна.

Түвдчүүд байр суурьтаа зогссон хэвээр байсан учир хятадуудын мэдэгдэл улам их сүрдүүлсэн шинж чанартай болж байлаа.[711] 10 зүйлт баримт бичиг бол БНХАУ-ыг байгуулах үед гаргасан Намын санал нэгтэй шийдвэр мөн гэж тавдугаар сарын 2-нд түвдчүүдэд мэдэгджээ. Тавдугаар сарын 7-нд үг хэлэх зөвшөөрөл ч олголгүй хятадуудын сүр далайлгасан нэг хэвийн үгийг албадан сонсгожээ. Түвдэд улс төр, цэргийн дээд байгууллага болох цэрэг-засаг захиргааны комисс байгуулах тухай Бээжингийн шийдвэрийг тавдугаар сарын 10-нд түвдчүүдэд танилцуулав.Өөрсдөд нь санал болгосныг хүлээн зөвшөөрөхгүй бол "чөлөөлөлтөөс" өмнө буюу түүний дараа хэзээ ч буцаж болохыг түвдчүүдэд дуулгажээ. Хятадын цэрэг түвдэд орсон байгаа, тэднийг ажиллагаанд оруулахад Бээжингээс ганцхан цахилгаан утас явуулахад л хангалттай гэж мөн хэлсэн байна. Энхийн болон

зэвсэгт "чөлөөлөлтийн" алиныг сонгож авахаа шийдэхийг төлөөлөгчдөд тулган хүлээлгэв.

Хятадууд хэлэлцээний явцад хэлэлцээрт гарын үсэг зурах бүрэн эрхтэй эсэхийг нь Жигмэдээс хэд хэдэн удаа асуужээ. Тэрээр эрхтэй хэмээн хариулж байлаа.[712] Хэрэв тэрээр татгалзсан хариу өгсөн бол хэлэлцээг тэр дор нь зогсоож болох байсан юм. Тэрээр ямар учраас ийм хариу өгч байсан нь тодорхойгүй үлджээ, яагаад гэвэл Жигмэд сайд нарын зөвлөл болон Далай ламтай зөвлөлдсөний эцэст л ямар нэгэн баримт бичигт гарын үсэг зурж чадах байснаа хожим ярьсан байдаг юм.

Түвдчүүдийг Бээжинд ирснээс хойш гурван долоо хоногийн туршид тэдэнд засгийн газартайгаа холбоо барих боломж олгоогүй бөгөөд үүнийгээ хэлэлцээ маш ээдрээтэй байна, ийм холбоо барих нь хэлэлцээний нууцыг задруулах аюултай гэж тайлбарлажээ.[713] Үүнээс болоод төлөөлөгчид Далай лам Түвдэд байгаа юу, аль эсвэл тэндээс гарч явсан уу гэдгийн алиныг ч мэдэж чадахгүй байв.

Хэрэв хятадын болзлыг хүлээж авахгүй бол ХАЧА тэр дариудаа л Түвд рүү хөдлөх нь тавдугаар сарын 15-ны уулзалтын үеэр тодорхой болсон байна. Түвдчүүд хятадын талын шаардлагыг урьдчилсан байдлаар хүлээж авахаас өөр аргагүй болжээ. Түвдчүүд мөн хэрэв түвдийн засгийн газар болон Далай лам Хэлэлцээрийг хүлээж авахгүй бол, хэрэв Далай лам Түвдээс гарч яваад 4-5 жилийн дотор эргэж ирвэл түүний эрх мэдэл болон албан тушаалыг сэргээх баталгаа бидэнд хэрэгтэй байна хэмээсэн болзол тавьсан байна. Энэ хэсгийг тусгай нууц хэлэлцээрээр баталгаажуулахыг хятадууд санал болгожээ. Хятадууд мөн Түвдийн засгийн газар болон Банчин ламын үзэл бодол нийцэхгүй байгааг Хэлэлцээрт тусгах шинэ санал оруулав. Үүний хариуд Жигмэд энэ бол Түвдийн дотоод хэрэг, би хэлэлцээг тасалж, түвдийн төлөөлөгчид нутаг буцаж болох юм хэмээн мэдэгджээ. Дараачийн өдрүүдэд хятадууд Пунцаг Ванжилаар дамжуулан Банчин ламын статусын тухай асуудлаар түвдийн төлөөлөгчидтэй тохиролцож чадсан байна.

Тавдугаар сарын 21-нд хятадын тал шинэ Хэлэлцээр болон 7 зүйлт нууц баримт бичгийн эх ноорогийг бэлэн болгов.[714] Энэхүү хэлэлцээр төлөөлөгчдөд анх танилцуулсан 10 зүйлт баримт бичигтэй бараг адилхан байжээ. Түвдийн төлөөлөгчдийн мэдэгдлээс үзвэл нууц баримт бичгийн зарим заалт дараах байдлаар тусгагджээ:хэрэв Далай лам Түвдээс гарч явж,4-5 жилийн дараа эргэж ирнэ гэвэл түүний эрх мэдэл болон албан тушаалыг хэвээр хадгална: энэ хугацаанд түвдийн засгийн газар түүнийг бүх зүйлээр хангана: ХАЧА-ийн 20 мянган цэргийг түвдийн хил дээр байрлуулна: Түвдэд

байх ХАЧА-ийн цэрэгт командлагчийн орлогчийн эрх бүхий 1–2 Түвд сайд байна: түвдийн засгийн газрын мэдэлд Далай ламын бие хамгаалагч 500 хүн, түвдийн янз бүрийн хэсэгт 1 мянган хүнтэй аюулаас хамгаалах хүчин байна: Түвдийн гадаад явдлын яам БНХАУ-ын Гадаад явдлын яамны Түвд дэхь салбартай адил эрхтэй байна. Эдгээр болзол эцсийн бөгөөд тулган шаардах бичигтэй адил утгатай болохыг хятадууд ойлгуулжээ.

1951 оны тавдугаар сарын 23-нд "Түвдийг энх тайвнаар чөлөөлөх талаар авах арга хэмжээний тухай Хятадын Ардын Төв засгийн газар болон түвдийн орон нутгийн засгийн газрын хооронд байгуулсан Хэлэлцээрт" Бээжин хотноо гарын үсэг зуржээ. Түүнийг, "17 зүйлт хэлэлцээр" хэмээн нэрлэх болсон байна. Энэхүү хэлэлцээрт:[715]

"[Оршил] Түвдчүүд бол Хятад улсын хил хязгаарт орших урт удаан хугацааны түүхтэй үндэстнүүдийн нэг билээ. Хятадын нутаг дэвсгэрт оршин суух бусад үндэстнүүдийн нэгэн адил түвдчүүд аугаа их Эх орныхоо төлөвшил, хөгжлийн туршид яруу алдарт хувь нэмэрээ оруулсан юм. Гэтэл сүүлийн 100 гаруй жилд империалист хүчин Хятадад цөмрөн орж, Түвдийн районд цөмрөн орж, зүсэн зүйлээр хууран мэхлэж, өдөөн хатгах ажиллагаа тухирав. Гоминьданы харгис засгийн газрын тухайд бол энэ нь Түвдийн түрүүчийн харгис засгийн газрын нэгэн адил үндэстнийг дарлан мөлжиж, үндэсний нэгдэл нягтралыг эвдэн сүйтгэх чиг шугам баримталсан юм. Үүний уршгаар Түвд үндэстэн дотроо хагарч, эв нэгдэлгүй болов. Түвдийн орон нутгийн засгийн газар империалистуудын хууран мэхэлж, өдөөн тухирах бодлогын талаар хариу арга хэмжээ огт аваагүй бөгөөд аугаа их эх орныхоо тухайд эх оронч бус байр суурь баримталж иржээ. Энэ бүхэн Түвд үндэстэн, түвдийн ард түмнийг боолчлол, ядуурлын байдалд оруулжээ.

1949 онд нийт Хятадын хэмжээнд ХАЧА-ийн явуулсан Чөлөөлөх дайнд үндсэндээ ялалт байгуулсан билээ. Хятадын бүх ард түмний дотоодын нийтийн дайсан-гоминьданы харгис засгийн газрыг бут ниргэж, Түвдээс гадаадын нийтийн дайсан-империалистуудын харгис хүчнийг хөөн гаргалаа. Энэ үндсэн дээр БНХАУ, Ардын төв засгийн газрыг зарлан тунхаглав. Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн[716] батлан гаргасан нийтлэг программын үндсэн дээр Төв засгийн газар үндэстэн бүрийн дотоодод байсан империалистууд болон нийтийн дайснуудыг эсэргүүцэж, БНХАУ-д аж төрөн суудаг бүх ард түмний тэгш эрх, тэдгээрийн нэгдэл нягтрал, харилцан туслах үйл ажиллагааг зарлан тунхагласан юм. Тийнхүү БНХАУ найрамдал, хамтын ажиллагаагаар нэгдсэн бүх үндэстний их гэр бүл болсон юм. Энэ их гэр бүлд үндэсний цөөнх бүрт тэдний оршин

суугаа газар нутгийн хүрээнд үндэсний орон нутгийн өөрөө удирдах эрх олгож; үндэсний цөөнх бүр хэл, бичиг үсгээ хөгжүүлэх эрх,амьдралынхаа хэв маяг, зан заншил, түүнчилэн шашин шүтлэгээ хэвээр хадгалах буюу өөрчлөх эрхтэй болсон билээ. Ардын төв засгийн газар улс төр, эдийн засаг, соёл, боловсролоо хөгжүүлэхэд нь үндэсний бүх цөөнхөд туслах үүрэг хүлээв. Үүний дараа Түвд болон Тайваны районоос бусад үндэсний бүх цөөнхийг чөлөөлөх ажил эхэлсэн юм. Ардын төв засгийн газрын нэгдмэл удирдлага, орон нутгийн бүх шатны ардын засгийн газруудын шууд удирдлагаар Хятадын үндэсний бүх цөөнх үндэсний адил тэгш эрх эдлэх болсон бөгөөд үндэсний орон нутгийн өөрөө удирдах эрхийг аль хэдийнэ хэрэгжүүлж эхэлсэн буюу хэрэгжүүлж байна.

Түвд дэхь империалист нөлөөнөөс амжилттай ангижирч, БНХАУ-ын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн нэгдмэл байдлыг хэрэгжүүлж, хил хязгаарын батлан хамгаалалтыг хангахын тулд, Түвд үндэстэн, түвдийн ард түмэн чөлөөлөгдөж, БНХАУ-ын аугаа их гэр бүлд эргэн ирж, улс төр, эдийн засаг, соёл, боловсролоо хөгжүүлэн хятадын бусад үндэстнүүдтэй хамт тэгш эрх эдэлдэг болгохын тулд Ардын төв засгийн газар Түвдийн нутагт орсон ХАЧА-ийн анги нэгтгэлүүдэд Ардын төв засгийн газартай Түвдийн энх тайван чөлөөлөлтийн тухай Хэлэлцээр байгуулахтай холбогдсон хэлэлцээ хийх хүмүүсээ Төв рүү явуулахыг түвдийн орон нутгийн засгийн газарт уламжлахыг тушаасан юм. Түвдийн орон нутгийн засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид найрсаг санаа бодол өвөрлөн 1951 оны дөрөвдүгээр сарын сүүлчээр Бээжинд хүрэлцэн иржээ. Хоёр тал хэлэлцээний дүнд хэлэлцээр байгуулж, түүнийг хэрэгжүүлэх нөхцлийг хангахаар тохиролцлоо.

Ардын төв засгийн газар, түвдийн орон нутгийн засгийн газрын хооронд байгуулсан 17 зүйлт хэлэлцээр:

1. Түвдийн ард түмэн нэгдэж, империалист түрэмгий хүчнийг түвдээс хөөн гаргана: түвдийн ард түмэн Эх орон-БНХАУ-ын ард түмнүүдийн аугаа их гэр бүлд эргэж орно.

2. Түвдийн орон нутгийн засгийн газар Түвдэд давшилтаа үргэлжлүүлж, үндэсний батлан хамгаалалтыг бэхжүүлэхэд нь Ардын чөлөөлөх Армид идэвхтэй туслах болно.

3. Түвдийн ард түмэн Хятадын Ардын Улс төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн ерөнхий программд илэрхийлсэн үндэсний бодлогын дагуу Ардын төв засгийн газрын удирдлагаар үндэсний орон нутгийн өөрөө удирдах эрх авч байна.

4. Төвийн эрх баригчид Түвдэд хэрэгжиж буй улс төрийн системийг

өөрчлөхгүй: мөн Далай ламын одоо байгаа статус, үүргийг өөрчлөхгүй. Янз бүрийн түвшний албаны хүмүүс урьдын тушаалдаа хэвээр үлдэнэ.

5. Банчин эрдэнийн статус (эрх), үүргийг хэвээр үлдээнэ.

6. Далай лам, Банчин эрдэнийн одоо байгаа эрх, үүрэг гэдэгт XIII Далай лам болон IX Банчин эрдэнийн хооронд найрсаг харилцаатай байсан үеийн тэдний статус, үүргийг ойлгоно.

7. Хятадын Ардын Улс төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн Ерөнхий программд илэрхийлсэн шашны итгэл үнэмшлийн эрх чөлөөний бодлогыг хэрэгжүүлнэ. Түвдийн ард түмний шашны итгэл үнэмшил, зан заншлыг хүндэтгэх бөгөөд шарын шашны сүм хийдийг хамгаална. Төвийн эрх баригчид дээр дурдсан хийдүүдийн орлогод өөрчлөлт оруулахгүй.

8. Түвдийн цэрэг ХАЧА-ийн ангиудад аажмаар өөрчлөн байгуулагдаж, БНХАУ-ын үндэсний батлан хамгаалалтын нэг хэсэг болно.

9. Түвдийн бодит нөхцөл байдлын дагуу Түвд хэл, бичиг үсэг, сургуулийн боловсролыг хөгжүүлнэ.

10. Түвдийн бодит нөхцөл байдлын дагуу Түвдийн газар тариалан, мал аж ахуй, аж үйлдвэр, худалдааг аажмаар хөгжүүлж, ард түмний сайн сайхан байдлыг дээшлүүлнэ.

11. Төвийн эрх баригчид Түвдэд шинэтгэл хийхтэй холбогдсон асуудлаар албадлагын арга хэмжээ авахгүй. Түвдийн орон нутгийн засгийн газар шинэтгэлийг сайн дураар хийх ёстой. Хүн амын зүгээс дэвшүүлж буй шинэлгэл хийх шаардлагын тухайд түвдийн удирдагчидтай зөвлөлдөх арга хэрэглэх хэрэгтэй юм.

12. Урьд өмнө империалист үзэл бодолтой буюу гоминьданыхантай холбоо сүлбээтэй байсан албан тушаалтнуудын тухайд бол хэрэв тэд империалистууд, гоминьданыхнаас холбоо харилцаагаа эрс шийдвэртэй тасалж, хорлон сүйтгэх ажиллагаанд оролцохгүй, шинэ засагт эсэргүүцэл үзүүлэхгүй байгаа бол хуучин явдлыг нь хэрэгсэхгүй болгож болно. Тийм хүмүүс хуучин албан тушаалаа үргэлжлүүлэн хашч болно.

13. Түвдэд орсон ХАЧА-ийн ангиуд улс төрийн бүх заавры мөрдөж, шудрага наймаа арилжаа хийж, хүн амаас сэтэрхий тэвнэ, сэмэрхий хадаг ч авахгүй.

14. Ардын төв засгийн газар гадаад улс төрийн бүх хэргийг нэгдмэл удирдлагаар хангахдаа хөрш зэргэлдээ орнуудтай тэгш эрхтэй, харилцан ашигтай байх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх үндсэн дээр энх тайвнаар зэрэгцэн оршиж, тэдгээр оронтой худалдааны шудрага харилцаа тогтоон хөгжүүлнэ.

15. Ардын төв засгийн газар энэхүү хэлэлцээрийн биелэлтийг баталгаатай болгохын тулд Түвдэд цэрэг-засаг захиргааны хороо, цэргийн тойргийн штаб байгуулах бөгөөд тэдгээрийн орон тоонд Ардын төв засгийн газраас томилогдсон хүмүүсээс гадна түвдийн орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчдийг дээд зэргээр татан ажиллуулна.

16. Түвдэд Цэрэг-засаг захиргааны хороо, Цэргийн тойргийн штаб, ХАЧА-ийн ангиудыг байлгахад шаардагдах мөнгөн хөрөнгийг Ардын төв засгийн газар хангана. Түвдийн орон нутгийн засгийн газар ХАЧА-ийн ангиудад хоол хүнс, ахуйн бусад бараа таваар худалдан авч, тээвэрлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

17. Энэхүү хэлэлцээр түүнд гарын үсэг зурж, тамга дарсны дараа хүчин төгөлдөр болно" гэжээ".

Хэлэлцээрт: БНХАУ-ын Ардын төв засгийн газраас-үндэстний хэрэг эрхлэх комиссийн дарга Ли Вэйхань (төлөөлөгчдийн тэргүүн), Жан Зиньу, Жан Гохуа, Сунь Зиюань, түвдийн төлөөлөгчдийн өмнөөс-Агваан Жигмэд (төлөөлөгчдийн тэргүүн), Кемэй Соном Вангдуй, Түвдэн Тэнтар, Түвдэн Лэгмон, Сампо Тензин Дондов нар гарын үсэг зурсан байна. Гарын үсэг зурах ёслолд БНХАУ-ын засгийн газрын орлогч дарга Жу Дэ, Ли Зишэнь, төрийн зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Чэнь Юнь, Дун Биу, Го Можо нар болон Банчин ламын дэргэдэх Каньбугийн зөвлөлийн төлөөлөгчид оролцжээ.

Түвд улс гэрээ байгуулахад хэрэглэх албан ёсны засгийн газрын тамга түвдийн төлөөлөгчдөд байсангүй. Тэр үед би төрийн тамгуудыг Дромод барьж байсан гэж XIV Далай лам хэлжээ.[717] Агваан Жигмэдэд л Дорнод Түвдийн захирагчийн тамга байсан боловч тэрээр энэ тамгыг ашиглаагүй ажээ. Төлөөлөгчдийн гишүүд хувийн тамгатай байсан ч хятадуудад энэ тухай хэлээгүй юм байна. Ингээд хятадууд төлөөлөгчдийн нэр бүхий модон тамга сийлж, Хэлэлцээрт даруулсан байна.[718] Түвдийн сайд нарын зөвлөлийн баримт мэдээгээр бол Хэлэлцээрт дарсан тамгуудыг Бээжинд хийсэн байна.[719] Энэ бол хууран мэхэлсэн хэрэг: жинхэнэ тамганы оронд орлуулагч ашиглажээ. Түүнээс гадна: хятадууд Түвд үсэг мэдэхгүй учир нэгэн төлөөлөгчийн нэрийг шинэ тамган дээр үсгийн алдаатай сийлсэн байна.[720] Түвдчүүд Хэлэлцээрт бид өөрийнхөө өмнөөс л гарын үсэг зурж байна, Далай ламын болон сайд нарын зөвлөлийн өмнөөс хэлэлцээр байгуулах бүрэн эрхгүй гэдгээ хятадуудад анхааруулж байжээ.[721] Ингэхлээр тэд эрх мэдлээ хэтрүүлэн Хэлэлцээрт гарын үсэг зуржээ.

Хэлэлцээрийн оршилд бодит байдалд үл нийцсэн үзэл суртлын чанартай




Түвдийн төлөөлөгчдийн тамга дарсан “17 зүйлт хэлэлцээрийн” түвд хэлээр орчуулсан хуудасны хуулбар (Facts about the 17-point “Agreement”, 2007, p. 129). Энд дарсан тамганууд албан ёсных биш ажээ. Эдгээр тамгыг хятадууд Бээжин хотод хийсэн бөгөөд тэнд зөвхөн төлөөлөгчдийн нэрийг л сийлжээ. Сүүлчийн тамгыг алдаатай хийсэн бөгөөд тэнд Самбо Тензин Дондуп гэсэн нэрэн дээр хэмээх үсэг нэмж бичсэн нь алдаа болжээ

хэвшмэл хэллэгүүд оржээ. Түвд тэр үед тусгаар тогтносон улс байсан. Тийм болохоор Хятадын “төв” засгийн газар болон Түвдийн “орон нутгийн” засгийн газрын хооронд хэн нь хэндээ захирагдах тухай асуудал байх ёсгүй юм. Тэх тусмаа Бээжин, Тайбэйд байсан Хятадын хоёр төв засгийн газар хэн нь хууль ёсных вэ гэдэг тухайд маргалдаж байсан цаг билээ.

Цаашилбал Түвд дэхь империалистуудын үүрэг гэгчийг илэрхий өсгөн мэдээлж байв. Гадаадын империалистуудаас Түвдийг “чөлөөлөх” үзэл санаа хятадын хувьсгалын хэтийн төлөвийн тухай И.В. Сталины хэлсэн үгэнд (1926 он) агуулагдсан байж болох талтай юм. Хятад дахь гадаадын империалистуудын интервенц гэдэг бол заавал тэдгээрийн цэрэг орж ирэх явдал биш, энэ бол орон нутгийн хувьсгалын эсэргүүчүүдийг дэмжих явдал байж болох юм[722] гэж Сталин хэлсэн байна. “Империалист хүчин” гэж юу болох, ямар учраас, хэнийг хөөж гаргах гээд байгааг түвдийн төлөөлөгчид ойлгосон болов уу даа. Тэр дундаа хэлэлцээрийн оршилд эдгээр хүчнийг Түвдээс аль хэдийнэ хөөж гаргасан гэж бичсэн байжээ. Гэхдээ л хятадууд шахаж шаардаад байсан болохоор түвдийн төлөөлөгчид: “Хэрэв империалистууд тэнд байгаа юм бол та нар хөөгөөд өг л дөө” хэмээн зөвшөөрсөн бизээ.[723]

Өөр нэг зүйл бол Түвдийг хятадад нэгтгэхийг эрмэлзэгчид түвдийн ард түмэнд хагарал гэгчийг оруулах гэж эрмэлзжээ. Коммунист төв засгийн газар “үндэстэн бүрийн дотор байгаа нийтийн дайсныг” эсэргүүцэж ирсэн тухай өгүүлбэр үүнийг дам хэлбэрээр нотлон харуулж байна. Нөгөө талаар түвдийн засгийн газрын “эх оронч биш байр суурь” зүй ёсны хэрэг байсан, яагаад гэвэл түвдчүүд бусад (хятад) биш, өөрийнхөө улсын (түвдийн) эх оронччид байсан билээ. “Түвд үндэстэн, түвдийн ард түмэн” БНХАУ-ын аугаа их гэр бүлд эргэж ирэх” ёстой хэмээх өгүүлбэр үүнийг бас л дам хэлбэрээр хүлээн зөвшөөрчээ. Хэрэв түвдчүүд энэ гэр бүлийн нэг хэсэг байсан юм бол түүнд буцаж очих хэрэг юу байхсан бол оо?

“Чөлөөлөлт” эхэлснээс өмнөх улс төр, эдийн засаг, соёл, гэгээрлийнх нь хөгжилд “үндэсний бүх цөөнхөд” ардын төв засгийн газраас үзүүлсэн тусламж чухам юунд оршиж байсан нь ойлгомжгүй байна. Цааш нь, энэ засгийн газар түвдэд орсон ХАЧА-ийн ангиудад хэлэлцээнд оролцох хүмүүсээ Төв рүү явуулахыг “орон нутгийн” засгийн газарт мэдээлэхийг тушаажээ. Цэргийн аюулын дор Хэлэлцээрт гарын үсэг зурсныг тохиролцож буй талууд түүний оршилд дам хүлээн зөвшөөрсөн болж таарч байна.

2-р зүйл нь: “түвдийн засгийн газар бусад улсын армийг нутаг дэвсгэр дээгүүрээ явуулахад туслана хэмээн “сайн дурын” хэлэлцээрт заасан тухай

оршлын нэгэн өгүүлбэртэй дуу дуугаа авалцсан мэт адил сонсогдож байна. Гэхдээ Түвд улс бие даасан төрт ёсны чухал шинж тэмдэг болох өөрийн гэсэн цэрэгтэй байхыг хүлээн зөвшөөрсөн (8-р зүйл) байна. Зүйл 15 нь зүйл 4-тэй зөрчилдөж байна, яагаад гэвэл хятадын засгийн газар цэрэг-засаг захиргааны хороо, тойргийн штаб байгуулах нь цэргийн төдийгүй улс төрийн шинж чанартай ажиллагаа болсон байна.

Хэлэлцээрийг хэд хэдэн зүйл нь хоёрдмол утгатай, хятадууд болон түвдчүүд янз янзаар тайлбарлаж болохоор зохиожээ. Юуны өмнө энэ хэлэлцээрт хамрагдах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг заасангүй. Хятадуудаас ялгаатай нь гэвэл түвдчүүдийн олонхи нь “Түвд” хэмээх нэрийн дор 1951 онд Лхаст захирагдаж байсан нутаг төдийгүй Хятадын мужуудын бүрэлдэхүүнд оруулсан түвдийн газар нутгийг хамруулан ойлгож байлаа. Энэ нь хятадуудад Их Түвдийн бараг тэн хагаст өөрсдийгөө энэхүү Хэлэлцээрээс ангид чөлөөтэй хэмээн үзэх боломж олгожээ. Түүнээс гадна Чамдо муж болон урьд өмнө Банчин ламын мэдэлд байсан нутгууд түвдийн засгийн газрын эрх мэдлээс хасагдсан байв.[724] Хятадууд болон түвдчүүд “түвд үндэстэн ба түвдийн ард түмэн” буюу “түвд үндэстэн, ард түмэн” гэж ялган авч үзэхдээ ямар утга агуулсан нь тодорхой биш байна. “Үндэсний районы (орон нутгийн) өөрөө удирдах эрх” хэмээх нэр томьёог ч яг таг тодорхойлсонгүй.

Хэлэлцээрт Түвдийг Хятадын нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрчээ. Гэтэл түвдчүүд хятадыг эх орноо хэмээн үзэж ирээгүй билээ. Тиймээс тэд хэлэлцээрийн 1-р зүйлийг биелүүлж чадаагүй юм. Тэд хөрш зэргэлдээх улсуудаасаа хараат биш байхад л дасан зохицжээ. Ихэс дээдсийн олон төлөөлөгч хүртэл тусгаар тогтнол гэдэг бол олон улсын эрх зүйн стаусын ухагдахуун биш, харин амьдрах хэлбэр ба соёл хэмээн үзэж иржээ.[725] Түвдчүүд энэхүү Хэлэлцээрийг ёс уламжлалыг нь хамгаалах зам гэж үзсэн бол хятадууд энэ бол Түвдийг эзэгнэх мандат хэмээн үзсэн байна.

Хэлэлцээрт буулт хийсэн заалтууд орсон ч хятадуудад ашигтай болсон юм. Эртний хятадын “Интоорыг аврахын тулд чавгыг золиосонд гарга” хэмээх мэргэн хэллэгт: “хэрэв алдагдалгүй өнгөрч болохооргүй нөхцөл байдал тохиолдвол хүчтэй байр сууриа илүү их бэхжүүлэхийн тулд сулыг нь золионд гаргах хэрэгтэй” гэж сургажээ.[726] Түвдчүүдэд хийсэн бүх буулт түр зуурын бөгөөд зарим нэг талуудад л хамаарсан байна. Хамгийн гол нь Түвдийг анх удаа хятадын бүрэлдэхүүн гэж зарлаж, өөрчлөн байгуулалтад оруулах болжээ. Ингэхдээ Хэлэлцээрт коммунизмын тухай ч, социализмын тухай ч шууд зааж хэлээгүй байна. БНХАУ Түвдэд бэхжих хүртэл тийм

шинэтгэлүүдийг ирээдүйн асуудал болгон хойш тавьжээ. Санаа бодлоо илэрхийлэх хэлбэр, хүч хэрэглэх аргууд нь коммунистуудын арга барил мөн ажээ. Хэлэлцээрийн эцсийн хувилбарыг коммунистуудын засвараар хийсэн нь маргаангүй билээ.

Хэлэлцээрт гарын үсэг зурсны маргааш өдөр Мао Зэдун түвдчүүдэд хайртай дуртайгаа илэрхийлсэн урт үг хэлжээ. Тэрээр шаардлага гарсан нөхцөлд орон нутгийн хятад түшмэдүүдийн талаарх гомдол саналаа Бээжин рүү шууд “өөрт” нь уламжлахыг уриалаад: энэхүү хэлэлцээр бол түвдчүүд болон хятадуудын хувьд бахархах үйл явдал мөн, түвдчүүд БНХАУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдож, Бээжинг хяналтандаа авах боломжоор хангагдаж байна гэж мэдэгдэв. Түвдчүүд Жоу Эньлайд хандаж, бүх Түвдийг нэгтгэх, өөрөөр хэлбэл хятадын мужуудын бүрэлдэхүүнд оруулсан түвдийн нутаг дэвсгэрүүдийг Лхасын мэдэлд эргүүлж өгөхийг хүсэв. Гэвч тэд одоо ингэх тохиромжтой үе биш, харин хэдэн жилийн дараа хоёр талын хооронд яриа хэлэлцээ хийх замаар үүнийг хийж болох юм гэж шалтаглан татгалзсан хариу авсан байна.[727] Мэдээжийн хэрэг хятадын удирдагчид ямар ч “яриа хэлэлцээ” хийх бодолгүй байсан нь ойлгомжтой. 2000 онд тэд ямар ч Их Түвд гэж хэзээ ч байгаагүй юм хэмээн мэдэгджээ.

Ер нь бол энэ Хэлэлцээр “Хятадын Коммунист Нам, дарга Мао Зэдуны гайхамшигт амжилт” болжээ.[728]

Коммунистууд Хэлэлцээрт гарын үсэг зурах гэж яаравчилсан бөгөөд тэдэнд “энх тайван чөлөөлөлтийн” тухай дэлхий дахинд аль болох түргэн хугацаанд мэдээлэх явдал чухал байлаа. Түвдийн төлөөлөгчид Дромо руу хэлэлцээрт гарын үсэг зурсан тухай цахилгаан утас явуулав.[729] 1951 оны тавдугаар сарын 27-нд Бээжингийн радио Хэлэлцээрийг бүрнээр нь нэвтрүүлэв. Тэгэхэд л Далай лам болон түүний засгийн газар хэлэлцээрийн агуулгыг олж мэдсэн байна.[730] Бид балмагдаж, сэтгэл түгшиж эхэлсэн билээ гэж Далай лам дурсчээ. Гэсэн ч тэрээр гэрээний бүрэн эхийг авч үзэхээс нааш энэ баримт бичгээс татгалзаж буйгаа нийтэд мэдээлэхийг хойшлуулахаар шийдсэн байна. Түвдийн сайд нарын зөвлөл Хэлэлцээр болон түүний нууц хавсралтын бүрэн эхийг нэн даруй илгээхийг хүсч төлөөлөгчдөд цахилгаан утас явуулжээ.[731] Төлөөлөгчид зааварчлага авах хүртэл Бээжинд хүлээж суух ёстой болжээ. Хятадууд засгийнхаа газарт биеэр хүрэлцэн очиж, баримт бичгүүдээ гардуулан өгөхийг түвдийн төлөөлөгчдад санал болгожээ.[732]. Ийнхүү Жигмэд гарын үсэг зурсан Хэлэлцээр нууц хавсралттай учир радио долгионоор хариу өгч болохгүй байна,хэрэв сайд нарын зөвлөл Хэлэлцээрт сэтгэл дундуур байгаа бол Бээжин рүү шинэ төлөөлөгчид явуулахаас өөр

аргагүй болно гэсэн хариуг Дромо руу явуулав.[733] Түвдийн төлөөлөгчид хоёр бүлэг болж нутаг буцав. Жигмэд хятадууд өөрийнх нь аюулгүй байдлын тухайд санаа зовж байна гэж хэлсэн болохоор Чамдогоор дайрч явахаар болов. Үнэн чанартаа бол хятадууд түүнийг Энэтхэгт үлдчихэж магадгүй хэмээн болгоомжилжээ.

1951 оны есдүгээр сарын 9-нд Энэтхэгт суугаа Канадын дээд комиссар тус улсын гадаад хэрэг эрхэлсэн төрийн нарийн бичгийн даргын орлогчид нууц захидал явуулав.Түвдийн төлөөлөгчид хэлэлцээрт гарын үсэг зурсныхаа дараа эргэж ирээд Далай ламаас урьдчилж зөвшөөрөл авалгүйгээр түүнд гарын үсэг зурах хүсэлгүй байсан тухайгаа ярьсан юм гэж дээд комиссар захидалдаа тэмдэглэжээ.[734] Ирээдүйд энэ нь Хэлэлцээрийг эрх зүйн хувьд хүчингүйд тооцоход хүргэж болох юм, яагаад гэвэл энэ баримт бичигт шахалтаар гарын үсэг зуржээ хэмээн тэр үзсэн байна. Гонконгод сууж байсан Канадын засгийн газрын худалдааны комиссар өөрийнхөө орны гадаад хэргийн департаментад 1959 оны зургадугаар сарын 23-ны өдөр явуулсан илгээлтдээ мөн иймэрхүү дүгнэлт хийж: 17 зүйлт хэлэлцээр – энэ бол өрнөдийн орнууд Манж Чин улсад тулган хүлээлгэж байсан гэрээ хэлэлцээрүүдтэй адилхан тийм л тэгш бус гэрээ болсон байна гэжээ. Жигмэд нилээд хожим энэ бол БНХАУ-ын “дотоодын” хэлэлцээр, түүнд найрсаг уур амьсгалд сайн дураар гарын үсэг зурсан учир хууль ёсных байх ёстой хэмээн мэдэгдэж байжээ.[735] Тэрээр БНХАУ-д хариуцлагатай албан тушаалд ажиллаж байхдаа үүний эсрэг утгатай үг хэлж чадаа гэж үү?

1951 оны наймдугаар сарын 8-нд хятадын засгийн газрын төлөөлөгч Жан Зиньу Лхаст хүрэлцэн очжээ. Тэрээр үүний өмнө Хэлэлцээрийг сайшаан дэмжсэн цахилгаан утас Бээжин рүү явуулахыг түвдийн сайд нар болон Далай ламд хичээнгүйлэн ятгаж байжээ.[736] Энэ удаад тэрээр Түвдийн хоёр тэргүүн сайдтай уулзах санал тавьсан боловч сайд нарын зөвлөл тэдний оронд бага тушаалын хоёр түшмэл явуулсан бөгөөд тэд Түвд улс өөрийгөө хятадын нэг хэсэг гэж үзэхгүй байгааг илэрхийлсэн байна. Генерал тэргүүн сайд нартай уулзсан боловч тусыг эс олов.

Наймдугаар сарын 17-нд Далай лам Лхаст буцаж ирж, харин есдүгээр сарын 9-нд ХАЧА-ийн 3 мянган хүнтэй тэргүүн шугамын ангиуд тус хотод орж ирэв. Хятад цэрэг бүрээ, бөмбөр дэлдэн уртын урт цуваагаар алхаж, цуваан дээгүүр Мао Зэдун, Жу Дэ нарын хөрөг бүхий улаан туг, далбаа тэнгэсийн давалгаа мэт намилзан харагдах ажээ.[737] Тэдэнтэй хамт Агваан Жигмэд, Пунцаг Ванжил нар ирсэн байна. Хятадуудын гол хүч тулж ирэв. Энэ удаад түвдчүүд ямар нэгэн нэмэлт болзол авч хэлэлцэж чадаагүй,



ХАЧА Лхаст орж ирж байна

харин хятадууд ингэх ч дургүй байлаа. Түвдийн удирдлага эрх мэдлээ алдав. Тус удирдлага энэ удаад нөгөө талын тулгасныг л хүлээн зөвшөөрч, Хэлэлцээрээс болж илүү муу юм болох вий гэж залбирахаас хэтэрсэнгүй.

Үндэсний Ассамблей түвдийн төлөөлөгчдийг сонсоод дараах болзлоор хэлэлцээрийг хүлээн авахыг сайд нарын зөвлөлд санал болгожээ:[738] "Түвдэд байрлуулах ХАЧА-ийн цэргийн тооны дээд хязгаар байх ёстой; цэргүүд Лхаст ирэлгүй, шууд хил рүү явах ёстой; Түвдийн засгийн газар Хэлэлцээрийг биелүүлэх явцад хүлээн авч болохооргүй хэмээн үзсэн асуудлуудыг хятад түшмэд нарт дэвшүүлэн тавих эрх эдлэх ёстой; Цэрэг-засаг захиргааны комиссийн эрх мэдэл ХАЧА-д сахилга бат сахиулах явдлаар хязгаарлагдана; хөгжилтэй (жишээ нь уулын ажил) холбоотой асуудлууд, хилийн аюулгүй байдлыг Түвдийн дүрэм журмын дагуу шийдвэрлэх ёстой; хятадын засгийн

газар Хэлэлцээрийн аливаа заалтыг зөрчсөн тохиолдолд түвдийн засгийн газар хөндлөнгөөс оролцох эрхтэй байх ёстой" зэрэг болно.

Эдгээр зөвлөмжийн үндсэн дээр түвдийн сайд нарын зөвлөл "цэрэг-засаг захиргааны комиссийн эрх мэдэл, үүрэг нь Далай ламын эрх мэдэл, үүргээр хязгаарлагдах ёстой; ХАЧА-ийн хязгаарлагдмал тооны цэрэг л Түвдэд байрлаж болно; чухал чухал хилийн аюулгүй байдлын төлөө хүлээх хариуцлагыг түвдийн армид итгэн хүлээлгэх ёстой; түвдчүүд оршин суудаг бүх мужийг түвдийн засгийн газрын эрх мэдэлд нэгтгэж, Чамдо болон Камын бусад мужийг Түвдийн засгийн газарт эргүүлж өгөх ёстой" гэсэн гурван үндэслэлийг Хятад улс зөвшөөрсөн нөхцөлд Хэлэлцээрийг хүлээн авсан тухай радиогоор мэдээлж болно гэж Жан Зиньуд мэдэгдсэн байна.[739] Жан Зиньу эхний хоёр үндэслэлийг эсэргүүцэж, гуравдугаар үндэслэлийн тухайд энэ асуудлыг хожим, Сычуань, Ганьсу, Юннань ба Хөх нуур мужийн түвдчүүдийн дунд санал асуулт явуулах замаар шийдвэрлэх ёстой юм байна гэж хэлжээ.[740] Мэдээжийн хэрэг "хожим" ямар ч санал асуулт болоогүй билээ.

Аравдугаар сарын 24-нд Жан Зиньу Хэлэлцээрийг дэмжсэн тухай цахилгаан утасыг Далай ламын нэрийн өмнөөс Мао Зэдунд илгээв.[741] Агваан Жигмэд хятад генералтай уулзаж, Түвдийн засгийн газар аравдугаар сарын 24-нд цахилгаан утас явуулахыг зөвшөөрлөө хэмээн хэлсэн хэмээх мэдээ байдаг юм.[742] Энэ баримт бичиг болон түүний хятад орчуулга Интернетэд бий.[743] Хоёр баримт бичигт Далай ламын тамга дарагдаагүй бөгөөд тэр үед Түвдэд нэг ч баримт бичиг хөдөө бөглүү нутагт ч тамгагүй л бол хүчингүйд тооцогддог байжээ. Энэ цахилгаан утасны эх ноорогийг түвдээр бичиж бээжингийнхний нэг түшмэл орчуулжээ.[744] Гэвч Жан Зиньу зарим нэр томьёо (жишээ нь "Хятад ба Түвд", учир нь энэ бол "нэг орон") хэрэглэхээс татгалзсан байна. Тэрээр цахилгаан утасыг илгээхээс өмнө түүнийг томьёолоход идэвхтэй оролцсон бололтой юм.

Энэ бүхнийг баримт бичиг батлах хууль ёсны ажиллагаа хэмээн үзэж болохгүй юм. Тэр дундаа Далай лам санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олдмогц хэлэлцээрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан байна.

Хятад цэргийн давшилт үргэлжилж байлаа. Аравдугаар сарын 26-нд гол хүч тулж ирэв.[745] Аравдугаар сарын 29-нд генерал Жан Гохуа, Тань Гуаньсэн нарын отрядууд Лхаст оров.[746] Түвдчүүд хятад цэргийг харахаар бөөн бөөнөөрөө гудамжинд гарч иржээ. Сурвалжлагчид үүнийг "ард олны баяр хөөр" мэтээр уламжилж байв. 1951 оны арван нэгдүгээр сарын 1-нд Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн бүх хятадын хороо Далай

лам, Банчин лам, Агваан Жигмэд нарыг гишүүнээрээ элсүүлэв. Арван нэгдүгээр сарын 15-нд ХАЧА Гьянзе, Шигазе-д оров. Хятадын цэрэг мөн Руток, Гарток зэрэг чухал хотуудыг эзлэв. Ийнхүү Сычуань, Юньнань, Шинжаанаас ирсэн отрядууд Төвдийн нутаг дэвсгэрийг бүрэн хянах болов. Лхаст орсон цэргийн дарга нар өөрсдийнх нь санаанд таарсан байшингуудыг албаны мэдэлд авч, Далай ламын зуны өргөөний (лавиран) зэргэлдээх цэргийн лагерьт зориулж том талбайтай газар авч, хоол хүнс, элдэв багаж хэрэгсэл гаргаж өгөхийг шаардах болсон байна.[747] Хятад цэргүүд маш ядуу байсан гэж тэр үеийн үйл явдлыг нүдээр үзсэн нэг хүн ярьдаг. Зам харгуй муу байснаас болж цэргийн хангамжийн асуудалд бэрхшээл учирч байлаа. Хоол хүнс үл хүрэлцэнэ. Гэсэн ч цэргийн сахилга бат сайн байв. Төвдчүүдээс ямар нэгэн зүйл дураар авахыг цэргүүдэд хоригложээ.

Тэр үед Лхас хотын хүн ам 30 мянга орчим байжээ. Есөн сараас арван хоёрдугаар сарын эхэн хүртэлх гурван сарын хугацаанд найман мянган цэрэг нэмж ирсэн явдал хэдийгээр цэргүүд майханд байрласан ч бэрхшээл үүсгэжээ.[748] Хэд хэдэн хотод ийнхүү цэрэг оруулсан байна. Зам харгуй муу учир хятадаас хангалттай хэмжээний хоол хүнс хүргэж ирэх боломж муу учир түүнийг орон нутгаас хайх хэрэгтэй болов.

Хангалтын ажилд тасалдал гарч эхэлсэн бөгөөд цэргүүд гол зогсоох төдий байна. Хэдийгээр хятадууд авсан бүхнийхээ хөлсийг төлдөг ч хангамж тогтмол биш байв. Төвдчүүд хятад мөнгө авдаггүй, яагаад гэвэл тэдний очиж худалдаа хийдэг Энэтхэг улсад энэ мөнгийг сольж болдоггүй ажээ.[749] Ийм болохоор хятадууд гоминьданы үеийн мөнгөн доллараар наймаа хийх ажээ. Энэ доллар нь ч бас хүрэлцээ муутай. Ингээд хятадад мөнгөөр хийсэн гоёл чимэглэлийн болон шашны эд зүйлсийг цуглуулж, түүнийгээ хайлуулан мөнгөн зоос цутгах болов. Энэ зорилгоор Чэндуд тусгай төв байгуулав. Энэ зоосыг зөвхөн Төвдэд зориулан цутгаж байв.

Ирээдүйн Төвдийн Өөртөө засах Оронд хятадын цэргийг богино хугацаанд үр тариагаар хангах нөөцтэйг тооцоо харуулсан бөгөөд үр тарианы хомсдолыг зориудаар бий болгожээ.[750] Эзлэн түрэмгийлэгчдийг тэжээх хүсэлгүй байсан явдал үүний ганц шалтгаан бишээ (олон язгууртан үр тариа худалдаж багагүй орлого олсон юм). Төвдийн хөдөө аж ахуй үр ашиг багатай байв. Ургац алдах, байгалийн гамшиг тохиолдох нөхцөлд үр тарианы нөөцтэй байх шаардлага тэргүүн эгнээнд тавигджээ. Засгийн газар үр тарианы нөөцийг хамаа намаагүй зарцуулахыг зөвшөөрөх боломжгүй байсан юм.

Хятад цэргийн командлал 2 мянган тонн арвай болон бусад хүнсний

бүтээгдэхүүн гаргахыг шаардав. Мөнгөн зоос их хэмжээгээр орж ирсэн явдал, хүнсний хомсдол хоёр нь мөнгөний ханш буурахад хүргэв. Үр тарианы үнэ 10 дахин, цөцгийн тосны үнэ 9, бусад бараа таваарынх 2–3 дахин өсөв.Түвдчүүд болон хятадуудын хооронд түгшүүртэй байдал улам өсөв. Хятад цэргийг гаргахыг шаардсан ухуулах хуудас гаргав. Хятад түшмэд болон цэргийн дарга нар үүнийг "харгис үйл ажиллагаа" гэж зарлалаа. Тэд хийдийн хамба болон том толгой лам нартай хамт цуглаан хийхийн тулд сүм хийдээр явах болов.[751] Түүний зэрэгцээ ард түмний талархлыг хүлээхийн тулд заримдаа сүм хийдүүдэд бэлэг сэлт барих болжээ.

Цэргийн хангамжтай холбогдсон асуудлууд Түвдэд хятадуудын байдал тогтворгүй байгааг илтгэн харуулав. Хятадууд үр тарианыхаа хэрэгцээний зарим хэсгийг хангахын тулд Лхасын ойролцоо бага хэмжээний газар хагалж, Энэтхэгээс тутрага авах ажил зохион байгуулав. Энэ тутрагыг маш үнэтэй авсан байна. 1951–1954 онд Чамдогоор дамжуулан ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд 71 сая фунт (1 фунт 409,5 граммтай тэнцэнэ) бараа оруулж иржээ.[752] Энэ ажилд 69900 ачлага, уналгын мал, 15600 хүн дайчилжээ. Бусад нутаг, түүний дотор Энэтхэг, Амдогоос ачаа бараа тээвэрлэхэд ч мөн ийм шаардлага гарсан байна. Хятадууд эхний үед ажлын хөлс төлж байсан боловч дараа нь энэ төлбөрөө багасгав. Түвд хүмүүсийн дунд хөлс хүчгүй бараа таваар тээвэрлэх явдал ч гарч байв. Үүнээс болж олон айл ядуурав. Хятадууд Хэлэлцээрийн 16-р зүйлийг ингэж л биелүүлсэн байна.

1952 оны нэгдүгээр сард Чамдо районы ардын чөлөөлөх хороо байгуулагдав. Энэ хороо бээжингийн засгийн газарт захирагдах орон нутгийн засгийн газрын үүрэг гүйцэтгэх болжээ. 1952 оны хоёрдугаар сарын 10-нд ХАЧА-ийн түвдийн цэргийн тойрог байгуулав. Түвдийн ангиудыг хятадын армийн бүрэлдэхүүнд оруулах болов. 1952–1958 онд Түвдийн арми хоёр тугтай байсны нэг нь Түвдийн (цаст уулын цагаан арслантай), нөгөө нь БНХАУ-ынх ажээ.[753] Тойргийн командлагчаар хятад генерал Жан Гохуаг, түүний орлогчоор хоёр түвд, нэг хятад хүнийг томилсон байна. Улс төрийн комиссарын тушаалд мөн л хятад хүн томилсон байна. Хоёрдугаар сарын 23-нд Бээжинд Далай ламын төлөөлөгчийн газар, Лхаст БНХАУ-ын төв засгийн газрын төлөөлөгчийн газар байгуулав. 1952 оны зургадугаар сарын 23-нд Банчин лам Дашлхүмбэ хийдэд буцаж ирэв. Түүний дэргэд Каньбугийн зөвлөл зохион байгуулж, 100 мянга орчим хүн амтай Цангийн нутагууд энэ зөвлөлийн удирдлагад орсон байна.[754] Энэ зөвлөл хэрэг дээр бээжингийн эрх баригчдын мэдэлд оржээ. Хэлэлцээрийн 5-р зүйл иймхүү

зөрчигдөв.

Хятадын удирдлага үндэсний районы өөртөө засах эрхийн төлөвлөгөөг Түвдэд хэрэгжүүлж эхэлсэн юм. Хэрэв коммунистууд засгийн эрхэнд гарахаасаа өмнө Хятад Холбооны улс байхыг зөвшөөрч байсан бол тэр үзэл баримтлал өөрчлөгдөв.[755] Мао болон түүний талынхан нэгдмэл улс байгуулах болсон байна. 1949 оны есдүгээр сард батлагдсан Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх Зөвлөлийн хөтөлбөрт үндэстнүүдийн тэгш эрх, найрамдал, хамтын ажиллагаа, их гүрний (хятадын) болон явцуу (бага ард түмнүүдийн) үндсэрхэх үзлийг даван туулах зорилт, яс үндсээр ялгаварлан гадуурхах хандлага болон дарлал мөлжлөг, үндэсний нэгдэл нягтралд хагарал гаргахад чиглэсэн үйл ажиллагааг хориглох зорилтуудыг зарлан тунхаглажээ.[756] "Үндэсний цөөнх" бөөнөөр оршин суудаг нутгуудад өөрөө удирдах байгууллага, хэл, бичиг үсэг, сүсэг бишрэлийн эрх чөлөө бүхий районы үндэсний өөртөө засах эрхийг тунхаглав. 1952 онд "Районы үндэсний өөртөө засах эрхийг хэрэгжүүлэх үндсэн зарчмуудыг" батлан гаргав.

Үүнээс хоёр жилийн өмнө буюу гоминьданыхан ХКН-д ялагдсаны дараа Сикан мужийг Хөх мөрнөөр хил зааглан хуваасан юм. Баруун хэсэг нь Чамдогийн нутаг дэвсгэр болж, зүүн хэсэг нь Сиканаараа үлджээ. 1955 онд Сикан мужийг татан буулгаж, Сычуаньд нэгтгэсэн байна. Түүний Түвдийн өөртөө засах районыг Сычуань мужийн Ганьзыйн өөртөө засах тойрог болгон өөрчилж нэрлэв. Түвдийн өөртөө засах дараахь нэгжүүд байгуулагдав. Хөх нуур мужид: Юйшу тойрог (1951 оны арванхоёрдугаар сар), Хайнань, Хайбэй, Хуанань тойргууд (1953 оны арван хоёрдугаар исар), Голок тойрог (1954 оны нэгдүгээр сар), Сычуань мужид: Аба тойрог (1953 оны нэгдүгээр сар), Ганьсу мужид: Ганьнань тойрог (1953 оны аравдугаар сар), Мули гацаа (1953 оны тавдугаар сар), Юньнань мужид: Дацин тойрог (1957 онд) зэрэг болно. 1954 оны БНХАУ-ын үндсэн хууль ХКН-ын удирдлагаар боловсруулсан үндэсний бодлогын үндсэн зурчмуудыг нотолсон байна. Өөртөө засах эрх гурван зэрэглэлтэй бөгөөд энэ нь район буюу орон (мужийн эрхтэй), тойрог, гацаа (мужид захирагдана) зэрэг болно. Өөртөө засах эрхийн зэрэглэлийг дээшлүүлэх буюу түүнийг нэгтгэх оролдлогыг тэр үеэс хойш хятадын эрх баригчид ямагт таслан зогсоож иржээ.[757] Тийм систем БНХАУ-ын эв нэгдлийг хангаж, хэдийгээр албан ёсоор тунхаглаагүй ч бусад ард түмнээс ялгарах давуу байдлыг хан үндэстэнд олгож иржээ. "Өөртөө засах гацаа хэлбэрийн бичил автономи байгуулах явдал ард түмнүүдийг задлан холдуулж, тэднийг дахин нэгтгэх үйл явц гаргуулахгүй

байх”[758] гэсэн Мао Зэдуны бүлгийн их гүрний санаархалд нийцэж ирсэн байна. Маогийнхан “үндэсний цөөнхийн” дотор хагарал гаргахдаа тэднийг БНХАУ-ын бусад ард түмэн, юуны өмнө хятадуудтай нэгтгэх талаар ямагт анхаарал тавьж иржээ. Энэ нь үндэсний өөрийн ухамсрыг нухчин дарж, том үндэстэнд уусах нөхцлийг бүрдүүлж ирсэн байна. “Төр улсын нэгдмэл байдал, ард түмний нягтрал, улс орны бүх үндэстний нягтрал – энэ бол бидний үйл хэрэг маргаангүй ялахын гол баталгаа мөн” гэж Мао Зэдун цохон тэмдэглэжээ.[759] Гэсэн ч өөртөө засах нэгжүүдэд хуваагдаж бутарсан түвдчүүд өөрсдийгөө нэгдмэл ард түмэн гэж үзсэн хэвээр байна.

Хятадын удирдлага бүр эхнээсээ “үндэсний цөөнхийн” элит давхаргынхныг өөрсдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд ашиглах гэж эрмэлзэж иржээ. Үүнд “нэгдмэл фронтын” бодлого үйлчилсэн билээ. Түүний мөн чанар нь “үндэсний цөөнхийн” нөлөө бүхий төлөөлөгчдийг удирдлагын байгууллагуудад оруулах явдал мөн. Харин эдгээр байгууллага намын хятад удирдлагын мөрийн хөтөлбөрийг биелүүлдэг хятад коммунистуудын хяналтад ямагт явж иржээ. Ийм нөхцөлд өөрөө удирдах ёс гэгч нь хоосон зүйл болон хувирч байгаа юм. Ингэснээрээ хятадын эрх баригчид Хэлэлцээрийн 3 ба 4-р зүйлийг зөрчжээ.

1952 оны гуравдугаар сарын 31-нд гол төлөв Лхас хотын эргэн тойронд ардын холбоотнууд (Миманг Цонду) байгуулав.[760] Эдгээр холбоонд тариачид болон хятадын армид цомтгон нэгтгэсэн түвдийн армийн цэргүүд орсон байна. Энэ бол Түвдийн түүхэнд анх удаа ард түмний олон нийтийн байгууллагууд болжээ. 1952 оны хавар ардын холбоотнууд жагсаал, цуглаан зохион байгуулж, хятад цэрэг гаргахыг шаардсан өргөх бичиг өгчээ. 1952 оны гуравдугаар сарын 31-нд Чушул тосгоны ардын төлөөлөгчид Лхас хотод хүрэлцэн ирж, Түвдийн сайд нарын зөвлөл болон хятад генерал Жан Гохуад өргөх бичиг барьжээ. Нэг мянга гаруй түвд хүмүүс генералын байшинг бүслэж, хятад цэрэг гаргахыг шаардав. Дөрөвдүгээр сарын 1-нд түвд, хятад цэргийн хооронд зэвсэг хэрэглэсэн мөргөлдөөн гарсан байна.

1952 оны дөрөвдүгээр сарын 6-нд түвдийн асуудлаар ХКН-ын Төв Хорооны удирдамж гарав. Түвдэд хан үндэстэн маш цөөн байна, тийм учраас нийгмийг аажмаар хувьсган өөрчилж, ард олны дэмжлэгийг авах хэрэгтэй байна гэж уг удирдамжид тэмдэглэжээ.[761] Түвдийн армийг өөрчлөн байгуулахгүй, цэргийн дэд тойрог, цэрэг- засаг захиргааны хороо байгуулахгүй байж, орон нутгийн хүн амын амьжиргааны түвшинг бууруулахгүйн тулд ХАЧА-ийн хангамжийг Хятад, Энэтхэгээс хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна. Цаг үе төвийн эрх баригчдын талд

ашигтай байгаа болохоор тэдний байр суурь бэхжиж, түвдийн эрх баригч ангийн байр суурь сул болж байна гэж удирдамжид өгүүлжээ.[762]

Гэвч Жан Гохуа тэмцэл хөдөлгөөнийг зохион байгуулагчидтай холбоотой байсан түвдийн засгийн газрын хоёр тэргүүн сайд Лхагва болон Лувсандаш нарыг огцруулах шаардлага тавьсан байна. Гэтэл тэр хоёр сайдын нэг Лхагва түвдийн ард түмэн 17 зүйлт Хэлэлцээрийг ерөөс хүлээж аваагүй[763] юм гэж Жан Зиньуд ил шууд мэдэгдсэн байна. Энэ хоёр тэргүүн сайд түвдийн ард түмэнд маш их нэр хүндтэй байв. Хятадууд тэр хоёрыг зэмлэн буруушаах тусам тэд улам их нэр хүндтэй болжээ. Гэвч түвдийн сайд нарын зөвлөл хоёр тэргүүн сайдыг огцруулж, Лхасыг чөлөөлөх бүлгийг тарааж, түүний удирдагч зургаан хүнийг түр хугацаагаар баривчлахаас өөр аргагүйд хүрчээ. Лхас хот дахь Хятадын цэргийн эрх баригчид 1952 оны дөрөвдүгээр сарын 11-ний өдрийн тушаалдаа: “гуравдугаар сарын 31-нээс империалист булаан эзлэгчид, гоминьданы тагнуулууд болон түвдийн дээд ангийнхны цөөнх харгис “ардын холбоотнууд”-ыг зохион байгуулсан түвдийн армийн цэргүүд, хулигаанууд, худалдаачид, лам нартай хамтран “Лхасыг чөлөөлөх бүлэг” байгуулсан юм гэж дүгнэжээ.[764]

Лхагва албан тушаалаасаа халагдсаны дараа Энэтхэг рүү (Калимпонг) оргож, харин лам Лувсандаш шашныхаа ажилд эргэж орсон байна. Тэднийг ийнхүү огцруулсаныг Мао болон ХКН-ын төв хороо сайшаасан байна. Гэвч цэрэг-засаг захиргааны хороо байгуулахаар төлөвлөсөн нь бүтээгүй ажээ.

Түвдэд марксизм-ленинизм судлах сургууль болон ангиуд нээгдэв. ХКН, Хятадын залуучуудын шинэ ардчилсан эвлэлийн (хожим нь хятадын коммунист залуучуудын эвлэл болсон) үүрүүд бий болов. Лхас хотын эх орончи залуучуудын соёлын холбоо, Эх оронч эмэгтэйчүүдийн холбоо (1953 онд), Гьянзегийн орон нутгийн эрх баригчдын төлөөлөгчдөд зориулсан сургалтын хороо (1956 он) байгуулав.[765] Дараа нь Түвдийн бусад хотод ч “эх оронч холбоод” бий болсон байна.Сургуулиудын шилдэг сурагчдыг залуу пионеруудад оруулах болов. Язгууртны хүүхдүүд пионерт дуртайяа элсэх болов.[766] ХАЧА-д алба хааж буй түвдчүүдэд зориулж 1952 оны нэгдүгээр сард байгуулсан боловсон хүчний сургууль - анхны сургууль болжээ.[767] Армид алба хааж буй түвдчүүдээс кадр ажилтан бэлтгэхээр төлөвлөжээ. Энэ сургуульд мөн хятад цэргүүдэд Түвд хэл заана. Тэнд нийтдээ 800 хүн суралцаж байв.

1953 оны нэгдүгээр сард хятадууд түвдийн цэргийн тойргийн намын анхны бага хурал зарлан хийлгэсэн байна.[768] Энэ бол Түвдэд коммунист нам байгуулах анхны алхам байсан юм. Энэ бага хуралд хятад кадр ажилтнууд

оролцсон бөгөөд түвдчүүдээс Кам, Амдод коммунист намд элссэн хүмүүс байв. Тэд хожим нь Түвдийн Өөртөө засах Оронд хэлмэрчээр ажиллажээ. Бага хурлаар өнгөрсөн хоёр жилд гарсан Түвдийн ололт амжилтуудыг хэлэлцэж, Бээжингийн үндэсний бодлогыг дэмжсэн байна.

Лхас дахь хятадын төлөөлөгчид бүр 1952 оны зун хүмүүс шинэ засгийн удирдлага дор хэрхэн аж төрөн амьдарч буйг нүдээр үзүүлэхийн тулд Түвд түшмэд болон бусад хүмүүсийн төлөөлөгчдийг Хятад руу явуулахыг санал болгож байжээ. Төлөөлөгчид хятадын хэд хэдэн хот, Өвөр Монголд очсон байна. Хятадын суртал ухуулгын товхимолууд бол худал зүйл гэж төлөөлөгчдийн санал хуваагдсан байна. Нөгөө хэсэг нь Хятадад очиж, техникийн "гайхамшгийг" үзээд энэ орныг "газрын диваажин" хэмээн үзэх болсон байна. Зарим нь бүр Маогийн дүрийг гэртээ тахих болжээ.[770] Эрх баригчид худалдаачид, санваартнууд болон залуучуудын шинэ шинэ бүлгийг хятад руу явуулах болжээ. 1950-аад оны дунд үе гэхэд нэг мянга гаруй хүн хятадад явж ирсэн байлаа. Олон Түвд залуусыг Бээжин, Чунцин болон хятадын бусад хотын сургуулиудад явуулав.

1959 онд Бээжингийн үндэстний төв сургуульд (дээд) гэхэд л 900 Түвд оюутан суралцаж байв.[771] Түвдчүүдийн олонхи нь залуучуудыг хятад руу явуулах дургүй байсан юм.[772] Гэвч 1952–1956 онд энэ дээд сургуульд элсэн орсон залуучуудыг маш сайхан хүлээж авсан байна.[773] Тэдэнд өдөрт гурван удаа хятад хоол (нэг удаа дөрвөн янзын хоол) өгч, мөргөл үйлдэх сүм гаргаж өгч, түвдээс үндэснийх нь хоолыг зөөж ирж, сайн стипенд цалин өгч байлаа. Тэрч байтугай хоёр давхар орыг нэг дан болгосон нь түвдчүүдийн хүзүүндээ зүүдэг сахиусыг хүндэлж буйн илрэл ажээ. Хичээл заах гол хэл бол "хамгийн хувьсгалч" хятад хэл байв. Маог "зуун цэцэг дэлгэрэг" хэмээх кампанит ажил зарласны дараа буюу 1956 оны тав-зургадугаар сард Бээжингийн үндэстний дээд сургуулийн Түвд оюутнууд 17 зүйлт Хэлэлцээрийг буруушаасан зурагт хуудас хадаж, хятад багш нар Түвд орон ямагт хятадын нэг хэсэг байсан гэж ярихдаа түүхийг мушгин гуйвуулж байна гэж хэлдэг болжээ.[774] 1957 оны дунд үе гэхэд "зуун цэцгийн" кампанит ажлыг эрс хязгаарласан бөгөөд энэ ажил нэг ёсны занганы үүрэг гүйцэтгэжээ. "Буруутсан" оюутнуудыг урт сандалд хоёр цаг суулгаж, "орон нутгийн үндсэрхэх үзэл" гэсэн бичээс бүхий цаасан малгай өмсгөн шүүмжилдэг байжээ.

Коммунист нам улс орны шашны амьдралыг хяналтандаа авахыг эрмэлзэв. 1952 оны аравдугаар сарын 8-нд Мао хэлэхдээ ХКН "шашныг хамгаалах" бодлого баримтлах боллоо хэмээн тэмдэглэжээ.[775] 1953

оны зургадугаар сард Бээжин хотноо Хятадын бурханы шашны холбоо байгуулж, түүний зөвлөлд 29 Түвд хүн оруулав. Далай лам, Банчин лам хоёрыг хүндэт дарга болгожээ. 1956 оны аравдугаар сард энэ холбооны түвдийн салбарыг Лхаст байгуулав. Тэргүүн сайд нарыг огцруулсны дараа тэдгээрийн албан тушаалыг устгав. Ингэснээр Далай ламыг дээд шүүгчийн үүрэггүй болгож, түүнийг "орон нутгийн засгийн газрын" ердийн даргын зиндаанд аваачжээ.[776] Ийнхүү Хэлэлцээрийн 4, 6, 11-р зүйлийг зөрчсөн байна.

1954 оны есдүгээр сард бүх хятадын ардын төлөөлөгчдийн хурлын анхдугаар чуулган Бээжин хотод болов. Есдүгээр сарын 20-нд чуулганаас БНХАУ-ын үндсэн хуулийг санал нэгтэй батлав. Чуулганд Далай лам, түүний гэр бүлийн гишүүд, түүний хоёр багш, гурван сайд, томоохон хийдүүдийн төлөөлөгчид болон Банчин лам оролцсон байна.[777]

Далай лам хожим нь Маогийн урилгыг хүлээж авахгүй байж чадаагүй билээ: дэлхийн нэг ч орон Түвдийн тусгаар тогтнолыг дэмжээгүй, коммунистуудын гар тайлагдсан байлаа[778] гэж дурсан бичжээ. Бээжингийн эрх баригчидтай хамтран ажиллах явдал ард түмнийх нь хувь тавиланг хөнгөвчилнө гэж тэрээр найджээ. Гэтэл 1954 оны үндсэн хууль зөвхөн "районы өөртөө засах эрхийг" зөвшөөрчээ. Далай лам энэ үндсэн хуулийг боловсруулахад оролцож чадаагүй, учир нь хэлэлцүүлгийг хятад хэлээр явуулжээ.[779]

Гэхдээ түвдийн төлөөлөгчид чуулганы хуралдаануудад, Үндсэн хууль батлах ажилллагаанд оролцжээ. Далай лам Бүх хятадын ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хорооны орлогч даргаар, Банчин лам түүний гишүүнээр сонгогдсон байна. Бээжинд Далай лам Мао Зэдун, Жу Дэ, Жоу Эньлай, түүнчилэн зөвлөлтийн удирдагч Н.С. Хрущев, Н.А. Булганин, Энэтхэгийн ерөнхий сайд Ж. Неру нартай уулзжээ.[780] Хятадын удирдагчид түвдчүүд, тэдний итгэл үнэмшил, зан заншилд хүндэтгэн ханддагаа онцлон тэмдэглэж, тэдний эрх ашгийг бүх талаар харгалзан үзэж байхаа амалжээ. Түвдчүүдийг маш өндөр түвшинд хүлээж авсан байна.Дээд зиндааны лам нар, язгууртнуудад тус тусад нь тээврийн хэрэгсэл гаргаж өгч, бусад төлөөлөгчдийг хамтад нь хөнгөн тэрэг болон автобусаар зөөж, халаасны мөнгө өгч, дээд зэрэглэлээр хооллож, улс орноороо аялуулсан байна. Далай ламыг аялалд яваад ирсний дараа Мао БНХАУ-ын зүүн хойт нутгийг сэргээн босгоход ЗСБНХУ-ын үзүүлсэн тусламж танд ямар сэтгэгдэл төрүүлэв хэмээн онцгой сонирхож байжээ. 1955 оны нэгдүгээр сарын 19-нд Бээжин хотноо Далай лам, Банчин лам нар хоёр талын хоорондын

маргаантай асуудлыг зохицуулах тухай: татвар хуваарилах тухай, албан журмын хөдөлмөрийн тухай, армийн зардлын тухай хэлэлцээрт гарын үзсэг зуржээ.[781]

Далай лам буцах болов. Түүнийг буцахын өмнө Мао Зэдун: "Би таныг маш сайн ойлгож байна, гэхдээ шашин бол айхтар хор. Түүнд хоёр дутагдал байна – нэгдүгээрт, шашин хүн амын өсөлтөд саад болно, хоёрдугаарт, улс орны хөгжлийг саатуулна. Түвд, Монгол хоёр түүнд хордсон юм" гэж хэлжээ.[782] Түүний хэлсэн үгэнд цорын ганц тайлбар хийж болох бөгөөд тэрээр шинжлэх ухаан, дэвшил хөгжилд хандах Далай ламын сонирхлыг буруу ойлгожээ.[783] Маогийн хэлсэн зүйл бол "Шашин бол ард түмний хар тамхи мөн" (түвдэд хар тамхи бараг байгаагүй) хэмээх К. Марксын үгийг л давтжээ. Гэсэн хэдий ч хятадад хийсэн аялал Далай ламын сэтгэлд нийцжээ. Тэрээр социализмын нааштай талууд, шашинтай төстэй шинж чанаруудыг тэмдэглэсэн байдаг билээ.[784] Далай лам 1955 оны зургадугаар сарын 29-нд Лхаст буцаж ирсэн байна. Түвдийн хүн ам түүнийг элэгсэг дотно угтав. Лам хуврагууд мөргөлийнхөө дарцагийг барьж, урт эгнээ болон зогсож, түвдийн арми парад зохион байгуулжээ.[785]

Түвд дэхь хятадын засгийн газрын төлөөлөгч 1955 оны гуравдугаар сарын 9-нд БНХАУ-ын төрийн зөвлөлийн 7-р бүгд хуралдаан дээр үг хэлэхдээ Маогийн зааврын дагуу Түвдэд гарч буй өөрчлөлттэй холбогдуулан авч үзвэл цэрэг-засаг захиргааны хороо хэмээх бүтэц тэнд хэрэггүй болжээ.[786] Түүний оронд түвдийн өөртөө засах орон байгуулах асуудал эрхэлсэн бэлтгэл хороо байгуулах хэрэгтэй байна. Энэ хороонд түвдийн орон нутгийн засгийн газар, Банчин ламын дэргэдэх каньбугийн Зөвлөл, Чамдо мужийн ардын чөлөөлөх хороог нэгтгэвэл зохино гэжээ. Ингээд ч Бээжинд тэрхүү бэлтгэл хороог байгуулав. Энэ хорооны ажлын дүнгээр1954 оны арван хоёрдугаар сарын 30-нд хятадын засгийн газарт тайлан явуулжээ.

"Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороо байгуулах тухай тогтоол"-ыг БНХАУ-ын төрийн зөвлөл 1956 оны гуравдугаар сарын 9-нд батлан гаргажээ. Энэ хороо Түвдийн өөртөө засах орон байгуулах хүртэлх хугацаанд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж, БНХАУ-ын төрийн зөвлөлд шууд захирагдана гэж тогтоолд заасан байна.[787] Энэ бол түвдийн эрх мэдлийн бүтцийг өөрчлөх чухал алхам байлаа. Гэтэл энэ засаглал 17 зүйлт хэлэлцээрийн дагуу бол өөрчлөгдөхгүй хэвээр үлдэх ёстой байв.

Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороо байгуулсныг 1956 оны тавдугаар сарын 1-нд зарлан тунхаглажээ. Энэ тухай Мао Зэдунд явуулсан

цахилгаан утсанд: “Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороо байгуулсан нь түвдийн ард түмэн районы өөртөө засах эрхийг хэрэгжүүлэх үйл хэрэг, социализмд хүрэх зам дахь чухал алхам болж байгаа юм <...> Бүх ард түмний баяр хөөрийн энэ өдөр бид гагцхүү Коммунист нам, Ардын төв засгийн газар, хайрт удирдагч Мао Зэдуны мэргэн удирдлагаар Түвдийн ард түмэн цэцэглэн хөгжиж болохыг улам гүнзгий ухамсарлан ойлгож байна”[788] гэж өгүүлсэн байна. Камд энэхүү “мэргэн удирдлагын” эсрэг ард түмний бослого хөдөлгөөн өргөжиж байсан үед энэхүү цахилгаан утсыг илгээсэн байна. Энэ тухай дараачийн бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ.

БНХАУ-ын төрийн зөвлөлд захирагдах Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороо тэр үед хятадын мужуудад ороогүй байсан түвдийн нутгуудыг нэгтгэв. Хорооны даргаар Далай лам, түүний орлогчоор Банчин лам, Жан Гохуа, хариуцлагатай нарийн бичгийн даргаар Агваан Жигмэд нар ажиллахаар болсон байна. Тус хорооны анхдугаар хуралдаан дээр Маогийн төлөөлөгч-маршал Чэнь И үг хэлж, түвдчүүдийг”тэргүүний” хятад үндэстний түвшинд хүргэхийн тулд “хоцрогдлын” эсрэг шинэтгэл хийх нь чухал байгааг зарлан тунхаглав.[789] Түвд орныг хөгжүүлж, түвд,хятадын ард түмний найрамдлыг бэхжүүлэхийн тулд түвдийн угсаатны бүх мужийг Түвдийн өөртөө засах оронтой нэгтгэвэл сайн гэж Чэнь И мэдэгджээ.[790] Өөрөөр хэлбэл үүнээс хэдэн жилийн өмнө Жоу Эньлайгийн хэлсэн тэр л санааг илэрхийлжээ. Мэдээжийн хэрэг ямар ч нэгдэл хэрэгжээгүй билээ.

Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороо байгуулагдсан нь түвдийн дээд давхаргынхны төдийгүй нийт түвдчүүдийн дургүйцлийг төрүүлэв. Эсэргүүцлийн жагсаал, цуглаанаас тогтоол гаргаж, тэдгээрийг Түвдийн сайд нарын зөвлөл (Кашаг) болон хятад түшмэдэд гардуулж байв. Бэлтгэл хорооны бүрэлдэхүүнийг түвдийн ард түмэнтэй тохиролцож байж тогтоох хэрэгтэй, Далай лам түүний ажилд биечлэн оролцох буюу хятадуудын хийлгэж буй хурал цуглаанд очоод байх үүрэггүй юм гэж дээр дурдсан тогтоолуудад өгүүлжээ.[791] Өөр нэг онцлог шаардлага бол Түвд валютын гүйлгээг зогсоохгүй байх явдал ажээ. Хятадуудын шахалтаар Далай лам болон түүний засгийн газар жагсаал цуглаан хийхийг хориглож, Түвд, хятадын харилцааг муутгаж болох бүхнээс түдгэлзэхийг хүссэн тунхаг бичиг гаргав.

1956 оны есдүгээр сарын 26-нд Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хороо “Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хорооны тухай түр дүрэм” батлав. Энэ дүрмээр Түвдийн засгийн газрын эрхийг хязгаарласан хэд хэдэн ноцтой өөрчлөлтийг “Тогтоолд” оруулсан байна.[792]

Тухайлбал, Түвдийн удирдлагыг Далай ламын дэргэдэх түвдийн засгийн газар (Лхаст), Шигазед Банчин ламын дэргэдэхь Каньбугийн Зөвлөл, Чамдо тойргийн ардын чөлөөлөх хороо гэсэн гурван хэсэгт хуваажээ. Энэ хуваарьлалт Түвдийн засгийн газрыг сулруулж, Бээжингийн тусгай даалгаварт элч нарын үүргийг хүчтэй болгосон байна. Түвдийн бараг бүх дээд тушаалын түшмэд энэ хороонд албан тушаалтай болов.

Энэ хороо түвдчүүдийг төлөөлөх байгууллагын нүүрэн тал болж, харин засгийн бодит эрх хятадуудад үлдэв.[793] Би хорооны дарга хэдий ч юу ч хийж чаддаггүй байсан гэж XIV Далай лам тэмдэглэн хэлжээ. Ингэхлээр Хэлэлцээрийн 4 ба 6-р зүйлд бататгасан түүний бүрэн эрхийг зөрчжээ. Чухал асуудлуудыг бэлтгэл хорооны өмнөөс дан хятадуудаас бүрдсэн ХКН-ын орон нутгийн хороо шийдвэрлэнэ. Бэлтгэл хорооны хүрээ хязгаар аажмаар өргөжихийн хэрээр түвдийн “орон нутгийн” засгийн газрын эрх мэдэл багасав. 1956 оны есдүгээр сарын сүүлч үед Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороонд 14 хэлтэс, комисстой болсон байлаа.[794] Бүх тойрог, гацаанд тус хорооны тамгын газар байгуулах зорилт ч дэвшин гарч ирэв. 1957 оны наймдугаар сар гэхэд түвдийн 50 гацаа, 8 онцгой тойрогт тийм тамгын газар байгуулжээ.[795] Үнэн хэрэгтээ эрх мэдлийн босоо засаг тогтолцоо бий болсон байлаа. Ингэснээр Хэлэлцээрийн 4-р зүйл зөрчигджээ.

Олон улсын түвшинд Түвдэд хяналт тавьж, түүний хангамжийг сайжруулахын тулд 1954 оны дөрөвдүгээр сарын 29-нд Бээжин хотноо Түвдийн район болон Энэтхэгийн хооронд энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр худалдаа, харилцаа тогтоох тухай хэлэлцээр байгуулав. Ятунг, Гьянзед байсан энэтхэгийн худалдааны агентлагийг хэвээр үлдээж, Гартокт шинээр бий болгов. Дели, Галигдаа, Калимпонгт хятадын худалдааны агентлагууд нээгджээ. Энэтхэг, Түвдийн хоорондын эргэл мөргөл үйлдэгчдийн хөдөлгөөн болон худалдааны дүрмийг тохиролцов. Тэр жил Энэтхэг улс Түвдэд үлдсэн цэргийн ангиудаа гаргасан байна. Түвдэд энэтхэгийн мэдэлд байсан шуудан, цахилгаан харилцаа, утсан харилцааны бүх албыг хятадад шилжүүлэн өгчээ.

1956 оны есдүгээр сард Балбын гадаад явдлын яамны сайд болон энэ оронд суугаа хятадын элчин сайд нар ноот бичиг солилцов. Хоёр тал энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр харилцаагаа хөгжүүлэхийг хүсч буйгаа илэрхийлж, худалдаа, харилцааны тухай хэлэлцээр байгуулав. Дараа жил нь балбын зэвсэгт хамгаалалтын ангиудыг Түвдээс гаргасан байна. Түүхэнд анх удаа Түвдэд зөвхөн хятад цэрэг үлджээ.



Будалын ордны эсрэг талд босгосон энэ хөшөө түвдчүүд хятадуудтай гар гараа барилцан шилдэг сайхан ирээдүйгээ цогцлон байгуулж буйг харуулж байна (Ray Kreisel авсан гэрэл зураг)

БНХАУ-ын эрх баригчид У-Цангийн оршин суугчдын эсэргүүцлээс зайлсхийхийн тулд бүр 1951 онд тийш нь хүнсний бүтээгдэхүүн ачсан жингийн цуваа явуулжээ. ХАЧА-ийн ангиуд төмөр хүрз, зээтүү, борной, сүх, анжис хийхэд нь орон нутгийн тариачдад тусалдаг байв.[796] Тэд слесарийн, оёдлын газар, хөллөгөөний малын тоног, ноос ээрэх артель зэрэг сурталчилгааны дөрвөн үйлдвэр байгуулав. Лхасын ойролцоо нүүрс олборлож, агротехникийн станц байгуулав.Энэ станцийн туршилтын талбайд хятад цэргүүд улаан буудай, төмс, шар буурцаг, өргөст хэмх, чинжүү, хөвөн, цай, тосны ургамал, хаш ургуулах болсон байна. Усжуулалт хийх, мод тарих ажил эхэлсэн байна. 1951–1954 онд хятадын засгийн газар түвдийн тариачдад ажлын багаж, үр, бусад бараа худалдаж авахад нь зориулж 1,7 сая юаний, малчдад 0,1 сая юаний зээл олгожээ. Хятад улсын тусламжтайгаар түвдийн тариачид 1954 он гэхэд 3300 гектар тариалангийн талбай шинээр эзэмшсэн байна. 1953 онд Лхас хотод агрономч, зоотехникч бэлтгэх түр сургуулиуд нээгдэв.[797] Мал эмнэлэгийн арга хэмжээний ачаар 1953 онд л 90 мянга гаруй толгой малд урьдчилан сэргийлэх тарилга хийж, эмчилсэн байна. Хятадуудад хөлслөгдөн ажилладаг түвд хүмүүст мөнгөн зоосоор цалин пүнлүү олгож байсан нь бас л хүн амын сонирхлыг татжээ.[798] Хоол хүнсний дутагдлыг хөнгөвчлөхийн тулд хятадууд үр тариа нийлүүлэлтийн асуудал эрхэлсэн товчоо байгуулав.[799] Эрчимтэй байгуулж эхэлсэн автомашины замууд ажлын амжилтад маш их нөлөө үзүүлж байв.

Лхас болон Сажад зарим хүн Хятад улсад нааштай хандах болсон байна. Хүмүүс цэргийнхний малгайд хадсан улаан таван хошууг хараад: “Энэ цэргүүд чинь бодьсад нар юм шиг байна. Тэдний толгойноос улаан өнгө цацарч байна шүү” гэлцдэг байсан тухай хятадын хэвлэлд бичжээ.[800]

Суртал нэвтрүүлэг үүгээр хязгаарлагдаагүй нь ойлгомжтой билээ. Бүр 1951 оны арван хоёрдугаар сард армийн 18-р корпусын улс төрийн хэлтэс “Цэргийн давшилтын удирдамж” гаргасан байна.[801] Энэ удирдамжид

түвдчүүдийн зан заншил, шашин шүтлэгийг хүндэтгэх нь чухал болохыг онцлон тэмдэглэжээ. Тэднээс мөнгө авах, албадлагын ажил хийлгэхийг хориглосон байна. Намын хорооны зөвшөөрлөөр л суртал нэвтрүүлэг хийж болох бөгөөд ангийн тэмцэл, газрын шинэтгэлийн тухай ярих, "мухар сүсгийн" эсрэг ухуулга хийхийг хоригложээ. Хийдүүдийн хавь орчимд шүлсээ хаях, загас барих, ан ав хийхийг мөн хориглов.

Суртал ухуулгыг дараах байдлаар хийж байжээ.[802.] Хятадын суртал нэвтрүүлэгчид ямар нэгэн буу зэвсэггүйгээр суурин газруудад очиж, жүжиг үзүүлнэ хэмээн тэндхийн оршин суугчдыг задгай талбайд цуглуулах ажээ. Дараа нь хэнгэрэг цан, янчир хөгжмийн аян дор ХАЧА-ийн дүрэмт хувцас өмссөн бүжигчид хятадын армийн цэргүүд ядуучуудад хэрхэн тусалж байгааг буюу хорон санаат газрын эзний савраас залуухан бүсгүйг яаж салгаж авч байгааг үзүүлэх ажээ. Дараа нь хятад офицер индэр маягаар зассан модон хайрцаган дээр гарч, Мао дарга биднийг Түвдэд туслуулахаар явуулсан, энэ ажлыг дуусмагц бид хятад руугаа буцаж явна гэсэн дэлгэрэнгүй үгийг цугларсан олонд хэлнэ. Коммунизмын тухай огт дурсахгүй ажээ. Цэргүүд тосгодоор явж, олон хүн цуглуулан гоминьдан болон японччуудын эсрэг ХАЧА-ийн дайчид ялалт байгуулсан тухай кино үзүүлнэ. Японччууд яагаад ямагт ялагдал хүлээдэг юм бол гэж зарим хүн асуух ажээ. Тэр жилүүдэд хүмүүс бидэнд газар өгөх гэхийн хэрэггүй, ямар байсан тэр хэвээрээ л үлдэх минь гэсэн утгатай дуу зохиож байсан тухай ахмад настай түвдчүүд надад ярьж байсан юм.

Тэр үед хятадууд "тариачдын ангийн ухамсрыг" дээшлүүлэх гэж эрмэлзээгүй юм.[803] Эгэл жирийн хүмүүс ангийнхаа эрх ашгийг тэргүүн эгнээнд тавьж, ирээдүйд коммунист намыг дэмжинэ гэж хятадууд найджээ. Тийм учир Түвдийн уламжлалт засгаар дамжуулан өөрсдийнхөө шийдвэрийг хэрэгжүүлэх гэж эрмэлзжээ. 1950–1959 онд жирийн Түвд иргэдийг барилгын ажилд ашигладаг байсан боловч тэдэнд ямар нэгэн үзэл санаа тулган хүлээлгэх гэж эрмэлзээгүй юм гэж Сажа мужийн нэгэн иргэн ярьсан байна.[804] Язгууртнууд болон худалдаачид зэрэг элит бүлгийнхэнд л Маогийн үзэл санааг тулган хүлээлгэхийг эрмэлзсэн байна. Тэр хүмүүсийг хувьсгалын манлай хүчин болгоход бичиг үсэггүй олон нийт тэдний араас дагана хэмээн маогийнхан тооцоолсон байна.

Түвдийн намын удирдлагын зарим хэсгийнхэнд гол удирдах хүмүүс болох Далай лам, Банчин лам нарын хооронд хагарал гаргах[805] санаа төрсөн байна. Банчин ламыг тойрон хүрээлэгчид шинэтгэлийг дэмжиж байгаа, харин Далай лам харгис хүчнийхнээр хүрээлүүлсэн гэж намын удирдлага

үзсэн байна. Тиймээс Банчин ламын мэдэлд байдаг нутаг дэвсгэрүүдэд ардчилсан шинэтгэлийг эрчимжүүлж, тэрч байтугай эдгээр нутаг дэвсгэрийг болж өгвөл засаг захиргааны хувьд тусгаарлах хэрэгтэй, харин Далай ламын нутаг дэвсгэрийн тариачид мөн тийм шинэтгэл хийхийг шаардаж байгаа ч энэ хандлага Маогийн дэмжлэгийг хүлээсэнгүй.

“Ардчилсан шинэтгэл хийх тухай тогтоол санал болгож, өнгөрсөн онд (1956) болсон бэлтгэл хорооны хуралдаанаас дэмжсэний дараа дээд давхаргынхнаас цөөн тооны хүн түүнийг дэмжиж, харин олонхи хүнд янз бүрийн эргэлзээ төрж, хэрэг дээр түүнийг эсэргүүцэж байхад олон түмний цөөнх шинэтгэлийг талархан шаардаж, олон түмний ихэнхид тийм оргилуун хүсэл байхгүйг бодит баримтууд нотлон харуулж байна. Ийм болохоор одоо шинэтгэл хийх нөхцөл бүрдээгүй байна”[806] гэж Мао хэлжээ. Тиймээс ХКН-ын төв хороо дараачийн таван жилд (1958–1962) шинэчлэлт явуулахгүй байж, ирээдүйд нөхцөл байдал ямраар эргэхийг харахаар шийджээ.

Хятадын эрх баригчид 1, 2-р таван жилийн Төлөвлөгөөний (1953–1957, 1958–1962) явцад Хөх нуур, Юньнань, Гуанси, Фузянь, Өвөр Монгол, Нинся, Ганьсу[807] зэрэг дайсагнасан ажиллагаа явуулж болох, бас газар зүйн бодлогын хувьд чухал ач холбогдолтой бүс нутгуудад төмөр замын байгуулалтыг түлхүү хөгжүүлжээ. Төмөр замыг гол төлөв хятад ажилчид тавьж, түвдчүүдийг туслах чанарын ажилд ашиглажээ.

1954 оны арван нэгдүгээр сарын 27 гэхэд Сикан-түвдийн засмал зам, Хөх нуур-Түвдийн засмал замын хөдөлгөөн нээгдэв. Хөх нуур-Түвдийн засмал замыг түвдчүүд “Амьдралын зам”[808] хэмээн нэрлэдэг байж билээ гэж зөвлөлтийн нэг сурвалжлагч бичсэн байна. Тэр сурвалжлагч Түвдийг бүслэгдсэн Ленинградтай андуурсан бололтой юм.

1955 онд Лхас–Шигазейн, Шигазе–Гьянзейн, Гьянзе–Ятунгийн замууд нээгдэв. Эхний жилүүдэд эдгээр замаар хятадаас машин, тоног төхөөрөмж, аж үйлдвэрийн бараа таваар зэрэг олон арван мянган тонн ачаа тээвэрлэжээ. 1955 оны гуравдугаар сард болсон БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн хуралдаан дээр эдгээр замын гол ач холбогдол бол Түвдийг хятадын төв нутгуудтай холбосонд оршино гэж тэмдэглэсэн байна.[809] Учир юу вэ гэвэл зам харилцаа гэдэг бол нутаг дэвсгэр, тэр дундаа уулархаг нутаг дэвсгэрт хяналт тавих хамгийн чухал нөхцөл мөн. Цаашид ч шинэ шинэ зам тавихаар төлөвлөжээ. Эдгээр замыг ХАЧА байгуулахдаа улс төрийн хоригдол хятадууд, түвд хар ажилчдын хөдөлмөрийг дайчлан ашиглажээ.[810] Техникийн ажилтнууд, засварын бригадууд болон техник хэрэгслийг БНХАУ-аас нийлүүлжээ. Хятадууд цалин хөлсөөр түвдчүүдийг татаж,

тэдэнд уралдаантай ажиллах санаа бодол төрүүлж, янз бүрийн цуглаан зохион байгуулж, түүнд оролцогчдыг дайлж цайлж, сайн ажилласан хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүдийг хөхүүлэн урамшуулж байлаа.[811] Зарим хүнд Маогийн дүр бүхий энгэрийн тэмдэг, бүлэг хүмүүст шилжин явах улаан туг гардуулах ажээ.

1952 онд Лхас, Шигазег хятадын Чунцин хоттой холбосон шуудан-цахилгаан холбооны шугам тавьж, 1953 онд Лхас, Бээжингийн хооронд утсан харилцаа тогтоож, 1955 онд Лхас, Шигазе, Чамдогийн радио станцийг ашиглалтад оруулж, 1956 онд Лхасын ойролцоо усан цахилган станц байгуулав. 1959 онд Лхас, Цетангийн хооронд хөлөг онгоц зорчих болсон байна. Түвдэд анх удаа домен зуух, тоосго шатаах зуух, цементийн фабрик, авто засварын газар, хөрөө раам бий болов. 1956 онд анхны нисэх онгоцны буудал-Дамшунгийг ашиглалтад оруулав.[812]

Хятадын улсын худалдааны компани Түвдээс малын ноос, үс, эмийн ургамал их хэмжээгээр зөөж эхлэв 1954–1955 онд гэхэд л энэхүү тээвэрлэлтийн хэмжээ хоёр дахин нэмэгдэж, 1 сая юаньд хүрчээ. Энэ компани төв хятадтай хийх түвдийн худалдаанд монополи эрх эдлэх болсон байна. Үүнээс болж худалдаа эрхлэгч Түвд түшмэд, худалдаачид болон сүм хийдийн эрх ашиг хөндөгдөв.[813] Түүний зэрэгцээ төр гаднаас оруулж ирж буй цайны үнийг бууруулж, түвдчүүдээс худалдан авч буй малын ноос, үсний үнийг нэмсэн байна. Ингэхдээ зөвхөн дээд зэргийнх биш бүх үс, ноосыг худалдаж авдаг болжээ. Гэтэл Түвд наймаачид зөвхөн дээд зэргийн ноос авдаг байсан ажээ. Энэ нь Түвд наймаачдын байдлыг улам муутгав. Хэлэлцээрийн 7, 10-р зүйлийг ийнхүү зөрчив. Агваан Жигмэд "зарим кадр ажилтан, офицерууд болон ХАЧА-ийн хүмүүс зарим талын дутагдал гаргаж, худалдаа, тээврийн салбарт жижиг гэмт хэрэг үйлдсэн боловч дутагдлыг нэн даруй арилгаж, алдааг зассан юм" гэж 1955 оны гуравдугаар сард тэмдэглэсэн байна.[814]

Лхас, Шигазе, Чамдо, Гьянзед эмнэлгийн улам олон шинэ байгууллага бий болов.[815] 1953–1955 онд 400 гаруй хятад эмч, эмнэлгийн сувилагч Түвд рүү явуулж, түвдийн 170 эмч бэлтгэжээ. 1958 оны сүүлч үе гэхэд Түвдэд шинэ үеийн эмнэлэгийн 18 байгууллага байсан бөгөөд улс орон даяар явуулын бригадууд ажиллаж байлаа. Хятадын удирдлага Түвдэд иргэний сургуулиуд зохион байгуулав. Түвд хүүхдүүдийг хятад сургуульд татан оруулахын тулд эхний үед уулзалт зугаалга зохион байгуулж, мөнгөн зоос өгч, ядуу айлын хүүхдүүдэд хувцас тарааж байв.[816] Гэсэн ч олонхи хүн Түвд сургуульд орохыг эрмэлзжээ. 1957 онд Түвд 78 бага, нэг дунд сургуультай

болжээ. Түвд багш нар цөөхөн байв. Тийм учир лам байсан хүмүүсээр хичээл заалгажээ. Хичээл эхлэхийн өмнө мөргөл үйлдэнэ. Лам нар шашны үндэс хэмээх хичээл заах ажээ.[817]

1951 онд хятад улс түвдийг булаан эзэлснийг "чөлөөлөлт" хэмээн нэрлэдэг. Хэнээс чөлөөлсөн хэрэг вэ? Энэ бол оньсого. "Империалистууд" болон "хамжлагын эздээс" гэж ярьдаг. Түвд дэхь "империалистууд" гэвэл 6 хүн байсан: британийн гурав, австрийн хоёр, нэг орос хүн.[818] Үүний өмнө Түвдэд гадаадынхан ирдэг, явдаг л байжээ. Улс орныг тэд биш, хилийн чанадаас ирсэн хэн ч биш, Лхасын хууль ёсны засгийн газар л хянаж иржээ. Хятадаас өөр гадаадаас ирсэн хэн ч Түвдэд санаархаж байгаагүй. Засгийн эрхэнд гадаадын (ЗСБНХУ) тусламжаар гарч, тэр тусламжийг их хэмжээгээр авсан хэвээр байгаа ХКН-ыг бодоход Түвдэд үзүүлсэн гадаадын (Их Британи, АНУ-аас) тусламж үл ялигхан байсан. Түвдэд хилийн чанадаас бие даасан оронд хэмээх хууль ёсны үндсэн дээр тусламж үзүүлж иржээ. Өөр дэмжлэггүй байгаа нөхцөлд Түвдийн засгийн газар өрнөдийн орнуудад найдлага тавих нь зүйн хэрэг билээ. Энэ нь Түвд улсын өмнө БНХАУ-д улс төрийн шахалт үзүүлэх боломж нээж өгчээ.

Ингэхлээр энд "чөлөөлөлтийн" тухай ярих нь шууд утгаараа байж боломгүй зүйл юм. Харин ард түмнийг өөрийнх нь "хамжлагын эздээс" "чөлөөлөх" ажлыг гадаадынхан буюу хятадууд л хийжээ. Тэр дундаа ард түмэн нь үүнийг хүсч байгаа үгүйг асуулгүйгээр шүү.

Түвдчүүд олон зуун жил хаалттай нийгэмд амьдарч, улс орноо нэн хожуу, дэндүү тууштай биш байдлаар дэлхийн тавцанд гаргаж иржээ. XX зууны дунд үеийн дипломатын болон газар зүйн бодлого, олон улсын харилцааны мэдлэг дутмаг түвдийн удирдагчид "энх тайван чөлөөлөлтийн" тухай хэлэлцээрт гарын үсэг зурахдаа түүнээс үүдэх үр дагаварын тухай таамаглаж чадаагүй бизээ. Тэд өөртөө засах эрхийг хуучин Манж чин улстай хэрэгжүүлж ирсэн харилцааны л багцаанд ойлгохдоо хэлэлцээнд оролцогч түншүүд улс орныг нь хавсарган нэгтгэж, уламжлалт нийгмийнх нь байгууллыг бүрмөсөн эвдэнэ чинээ бодоогүй бизээ.

БНХАУ-ын бусад "чөлөөлөгдсөн" нутаг дэвсгэрүүдтэй иймэрхүү хэлэлцээрт гарын үсэг зураагүй ажээ. Гарын үсэг зурсан баримт гэхэд л түвдийг өөртөө засан тохинох эрхээс нь хүчээр татгалзуулсныг гэрчлэн харуулна. Мао Зэдун "салшгүй хэсгийг нь" хятадад "сайн дураар" буцааж оруулж (өөрөөр хэлбэл интервенцийг хууль ёсны болгох) байгааг дэлхий

дахинд нотлон харуулахын зэрэгцээ зам харгүй муутай хүрэхэд бэрх өндөр уулын нөхцөлд цэргийн ажиллагаа явуулах зардал үрдлээс зайлсхийхийг хүссэн нь илэрхий юм. Түүнээс гадна Чамдог авсны дараа хятадын цэрэгт түр амсхийх шаардлага гарсан юм.

Мао мөн нутаг дэвсгэрийг барьж байхад нэг Хэлэлцээр болон тодорхой тооны цэрэг хангалтгүйг ч ойлгож байсан. Ингэхийн тулд хангамж, холбоо харилцаа, дэд бүтэц, орон нутгийн төвийг сахисан боловсон хүчний аппарат чухал шаардлагатай юм. Тийм систем бий болгоход цаг хугацаа шаардагдсан бизээ. 1954 оны хоёрдугаар сарын 10-нд ХКН-ын төв хороонд Түвдийн асуудлаар хийлгэсэн Ажлын бага хурлын илтгэлд: “Түвд аугаа их эх орны нэг хэсэг боллоо. Манай намын байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, цэрэг оруулсны дүнд сүүлийн хоёр жилд түвдчүүдийн эх оронч хүчин нэмэгдлээ. Эдгээр хүчин түвдийн бодлогод улам чухал, тэрч байтугай шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Гэхдээ зам хараахан тавигдаагүй, бид өөрийнхөө бүтээгдэхүүнээр хангагдаж чадаагүй, түвдийн дээд ангийнхан бидний тухайд ихээхэн сэтгэл түгшиж, түвдчүүд болон хан үндэстнүүдийн хоорондын зааг ялгаа маш их хэвээр байна. Тиймээс бид түвдэд баттай байр суурьтай болж чадаагүй байна. Бид хэнд ч дийлдэхээргүй тийм байдалд хүрч чадаагүй байна” гэж өгүүлжээ.[819]

Намын удирдлагын хүлээзнэсэн байр суурь, “нэгдмэл фронтын” бодлого, Төв Түвд дэхь ардчилсан шинэтгэлийн удаашрал үүгээр л тайлбарлагдана. Энэхүү шинэтгэл гэгч чухам юу болохыг түвдчүүд мэдээгүй. Тэд ирээдүйг төсөөлөлгүйгээр урьдынхаа л байдлаар амьдарч иржээ. “Өдөр бүр нүдэнд харагддаг зүйл сэжиг таавар төрүүлдэггүй. Цэлмэг сайхан өдөр харанхуй шөнөөс ч илүү нууцалдаг. Бүхнийг илчилнэ гэдэг бол бүхнийг нууцална гэсэн үг мөн”. “Хааныг хуурч тэнгэс гатална”[820] хэмээх эртний хятадын хэллэгийг ийнхүү тайлж болно. “Дайсныхаа итгэлийг ол, түүний сэтгэлийг тайван болго: ийм үед л нууц төлөвлөгөөгөө хэрэгжүүл. Бүх бэлтгэлээ хангасны дараа ямар ч эргэлзээгүй довтол, дайсанд сэхээрэх зав бүү олго” гэсэн өөр нэг хэллэг байна.

Хятадын эрх баригчид түвдчүүдийн итгэлийг хүлээх гэж эрмэлзэхдээ тэдний нийгмийг дотроос нь шинэчлэн өөрчилж чадахгүйгээ ойлгожээ. Лхасын мэдэлд байдаг газар нутгуудад хувьсгалт эргэлт, өөрөөр хэлбэл ардчилсан шинэтгэл гарах ёстой байлаа. Их Түвдийн бусад хэсэг, тухайлбал коммунистууд “баттай байр суурьтай болсон” Кам, Амдод энэ өөрчлөлт нэгэнт эхэлжээ.

Бүлэг 8

# Ардын бослогоос соёлын хувьсгал хүртэл

Хятадын эрх баригчид түвдийн хүн амыг өөрийнхөө талд татахыг эрмэлзсэн тухай дээр хэлсэн билээ. Тэд сайн сайхан байдал амалж, эхний үед цалин пүнлүү ч сайн өгч байв. Гэвч Кам, Амдогийн түвдчүүд эрх чөлөөтэй амьдралд дасчээ. ХАЧА-ын ангиуд орсны дараахан буюу 1949 оноос зарим нэг мөргөлдөөн гарч эхлэв.[1048] Тэр үед түвдийн худалдаачдын авч ирсэн "гадаадын империалистуудын" бараа таваарыг хураан авч, хүмүүсийг баривчлах тохиолдлууд гарч байв.[1049] Зам тавих ажил ч олны дургүйцлыг төрүүлэв.[1050] Хүмүүс хятадаас бие даан аж төрөн амьдрахыг хүсч байна хэмээн ярих болов. 1950-1954 онд Гьелтанд (Литанаас өмнө тийш) Аку Лемарын, Хормукха, Нанрад (Амдо) Чойжил, Ванчин нарын удирдлагаар бослого гарав.[1051] Хэдэн мянган хүн зэвсэг барин босчээ. Хэд хэдэн газарт тулалдаан болов. Түвдийн талын мэдээгээр бол хэд хэдэн удаагийн тулалдаанд 631 Түвд хүн, 1140 хятад хүн алагдаж шархаджээ. Түвд эмэгтэйчүүд алагдсан нөхөрийнхөө өмнөөс тулалдаж байжээ. 1951 онд 70 мянга шахам хятад цэрэг ирж, хэд хэдэн удаагийн тулалдааны дараа Хормукха, Нангруг эзлэв.

Босогчид ууланд гарав. Хятадууд гурван жилийн турш партизануудын халдлагад няцаалт өгч, дахин дахин хүн амын тооллого хийж, хавь орчмын нутаг дэвсгэрийг судлаж байв.[1052] Нэмэлт цэргийн хүч ирэв. Партизанууд цохигдож, 300 хүнээ алдсаны дараа тарж бутарсан байна. Хятадууд 500 шахам хүнээ алджээ.[1053] Олон партизан бууж өгөв. "Тэмцлийн цуглаан" гэгчийг зохион байгуулж, дараа нь арав шахам хүн буудан алдаг болов. Нанграгаас цөөн хэдэн хүн Энэтхэг хүрсэн болович оргосон хүмүүсийн

олонхи нь замдаа алагдаж, зарим нь баривчлагдсан байна. Тосгон суурингуудад сохор, доголон, өвгөд хөгшид, хүүхэд голдуу цөөн хүн үлджээ. 1954 онд Чойжил, Ванчин нарыг гэрийн хорионд суулгав. Тэр цагаас хойш энэ хүмүүсийн сураг тасарчээ.

Эхний үед сүм хийдийнхэн, омгийн удирдагчид болон феодалууд сэтгэл түгшиж байсан бол "доод" давхаргын төлөөлөгчид зам тавих ажилд сайн дураар оролцжээ. 1953 онд коммунистууд Амдогийн сүм хийдүүдээс буулгаж эхэлсэн байна.[1054] Тэр жилээс эхлэн түвдчүүдэд зам тавих ажилд оролцож, ХАЧА-ын барилгын ангиудад уналга, хөллөгөөнд хэрэглэх илжиг луус, сарлаг гаргаж өгөхийг, замын ойролцоох тосгодын оршин суугчдад замын барилгачдыг хоол хүнсээр хангахыг шаардах болов.[1055] Сүм хийдүүдэд ч ийм үүрэг өгөх болсон байна.

Хятадад ардчилсан шинэтгэл ба социаласт өөрчлөлт гэсэн хоёр шатаар социализмд шилжих ажил өрнөжээ. Энэ шинэтгэлийн мөн чанар газрыг дахин хуваарилах, газрын эзэд болон хувьсгалын эсэргүүчүүдийг нухчин дарах, ангийн хувиарлалт хийж, ангийн тэмцэл өрнүүлэхэд оршиж байлаа.[1056] 1950 оны дунд үе гэхэд Хятад улс энэхүү шилжилтийн эхний шатыг үндсэнд нь дуусгасан байв.1955–1956 онд Маогийн зарлан тунхагласан эрчимтэй хамтралжуулах ажил эхэлжээ. "Үндэсний цөөнх" хятадуудаас хоцрохгүйн тулд тэдний замаар замнах, өөрөөр хэлбэл бүрэн хэмжээний ардчилсан шинэтгэл хийх ёстой юм гэж Мао үзжээ. Лхасын хяналтад байсан нутаг дэвсгэрүүдийн тухайд бол түр зуурын өөр хандлага баримталсан байна.Хятад мужуудад орсон түвдийн нутаг дэвсгэрүүдийн "түүхэн нөхцөл байдал" гэгч нь огт өөр зүйл бөгөөд тэндхийн хүн ам шинэтгэл хийх хүсэлт гаргажээ.

Гэхдээ жинхэнэ шалтгаан үүнд биш, харин хятадын засгийн газрын үр нөлөөтэй хяналтад байсан юм. "Чамдогийн чөлөөлөлтийн хорооны" нутаг дэвсгэрүүдэд бас л шинэтгэл хэрэгжүүлж эхэлсэн байна. 1956 онд энэ нутаг дэвсгэрийг ирээдүйн Түвдийн өөртөө засах Оронд нэгтгэж, 1957 оны наймдугаар сард Чамдод шинэтгэл хийхгүй хэмээн зарлав. Гэсэн ч тэр үед тус тойрогт бослого хөдөлгөөн гарч эхэлсэн байлаа.

Ардчилсан шинэтгэлийг түвдчүүд сайшааж уггсангүй.[1057] "Түвдчүүд түүнийг юуны өмнө үнэт зүйлсийнх нь системд хийсэн дайралт хэмээн үзжээ. Баян буюу ядуу байх нь хамаагүй, тэд бурханы шашинд хандсан итгэл үнэмшлээрээ, шашны байгууллагуудыг дэмжих үйлсээрээ нэгдмэл бөгөөд ертөнцийг үзэх үзлийнх нь төв болж байсан эдгээр шашны байгууллагуудыг эцэс болгох ямар нэгэн шинэтгэл гэгчийг төсөөлж ч чадахгүй байсан юм".[1058]

Зарим нутагт лам хуврагууд хүн амын 11–20 хувийг эзэлж байв. Түвдийн тариачид ч нэгэнт тогтсон ёс уламжлалыг эвдэж болох аливаа сургаальд сэжигтэй хандаж байсан юм гэж Канадын засгийн газрын үндэсний батлан хамгаалалтын газрын 1950 оны аравдугаар сарын 6-ны өдрийн нууц илтгэлд өгүүлсэн байна.[1059] "Олон зуун жилийн туршид гараас гар дамжиж ирсэн тэдний соёлын өв маш үнэтэй юм. Хувь тавилантайгаа тэмцэж, шашныхаа ёс үйлдэлд бие сэтгэлээрээ татагдан орсон, уламжлалт амралт цэнгээнээс таашаал авсан энгэл жирийн хүмүүс уул, хөндий хосолсон нутаг оронд минь орхиж үзээч хэмээн наминчлэн хүсдэг юм билээ".[1060]

Энэ байдал коммунистуудын сэтгэлд нийцсэнгүй. Бүр 1950 онд Дэн Сяопин "үндэсний цөөнхийн" нутгуудад эдгээр "цөөнхийн" элементүүд л шинэтгэлийг хэрэгжүүлэх ёстой юм гэж онцлон тэмдэглэжээ.[1061] Шинэтгэл хийхгүйгээр "ядуурал, хоцрогдлоос" ангижирч чадахгүй болохоор түүнийг заавал хийх хэрэгтэй юм. Гэхдээ нөхцөл боломж бүрдээгүй цагт шинэтгэл хийж болохгүй. Тийм учир эхэлж орон нутгийн кадр ажилтан, "хүн амын эх орон ч сэтгэлгээтэй" давхарга бий болгох хэрэгтэй гэж тэрээр цохон тэмдэглэжээ.[1062]

ХКН-ын анхны Түвд гишүүд 1950-аад оны эхний хагаст У-Цангд бий болсон байна. Түвдэд 5 мянга гаруй түвдийн хувьсгалт кадр ажилтан, коммунист намын 1 мянган гишүүн, комсомолын (коммунист залуучуудын эвлэл) гишүүн 2 мянга гаруй хүн, залуучуудын эх оронч соёлын холбооны гишүүн 6 мянга гаруй хүн, Эмэгтэйчүүдийн эх оронч холбооны 1 мянга гаруй гишүүн байна гэж 1957 оны аравдугаар сарын 5-нд мэдээлжээ.[1063] Өөр эх сурвалжаас авсан хятадын статистик мэдээгээр бол 1952 онд ирээдүйн Түвдийн Өөртөө Засах Оронд 877 коммунист, 1965 онд (соёлын хувьсгалын өмнөхөн) 14830 коммунист байсны 7153 нь "үндэсний цөөнхийнх" (түүний дотор түвдчүүд), 1989 онд энэ тоо 70 мянга, 56 мянга болсон байна.[1064] Дорнод Түвдэд цөөн тооны коммунист байсан, энэ тоо баримт ХКН-ын Сычуаны салбарын архивт байж болох юм: эхний үед түвдийн бүх коммунист Дорнод Түвдээс гаралтай байв. Албан ёсны тоо баримтаар бол 1954 оны аравдугаар сард Хөх нуурын нийт коммунист Түвд иргэдийн тоо 1500 гаруй байсан юм гэж Ц. Шакья үзжээ.[1065]

Эх орных нь олонхи оршин суугч хятадуудын эрх мэдлийн эсрэг, цөөн тооны хүн л тэдэнтэй хамтарч ажиллдадаг байсан тухай Түвд өвгөчүүл надад ярьсан билээ. Түвдчүүдийн олонхи сүсэг бишрэлтэй учир маогийнхныг зэвсэг барин орж ирсэн бурхан шүтээнгүй амьтад хэмээн хүлээж авчээ. Тэд гадаадынхан байхгүй хаалттай нийгэмд амьдарч сурсан, цаашид ч ингэхийг

хүсчээ. Тэд бараг бүгдээрээ дээд бүлгийнхэндээ итгэж иржээ. Жижиг сажиг зүйлийн тухайд дургүйцэх явдал гардаг л биз. Тэр жилүүдэд түвдчүүд Түвд феодалуудын тухай биш, хятад эрх баригчдыг элэглэж шоолсон дуу зохиодог байсан юм. Энэ бол ард олны сэтгэл хөдлөлийн илэрхийлэл мөн.

Тийм болохоор “Түвдийн эсэргүүцлийн хөдөлгөөнийхөнд маш явцуухан түшиг тулгуур байсан юм” гэж зүүнийхэн үзсэн нь алдаа болсон бизээ.[1066] Бодит байдалд бол коммунист намд л түшиг тулгуур явцуухан байсан юм.

XIV Далай лам 1955 оны хавар Бээжингээс буцах замдаа Амдо хот дахь төрөлх Такцер тосгоноороо орсон байна. Энд ардчилсан шинэтгэл нэгэнт эхэлсэн байв. Түүнийг хүмүүстэй ярилцаж эхлэхэд бүгд л Мао болон коммунист намын удирдлага дор аз жаргалтай сайхан байна хэмээн ярьж гарчээ.[1067] Гэвч тэрээр ийнхүү албан бус байдлаар хөөрөлдөж суухдаа хятадууд газар тариалан хамтран эрхлэх журам оруулж ирж, харин тариачид үүнийг нь зад эсэргүүцэж байгаа юм байна гэдгийг ойлгож авчээ. Хүмүүсийн түгшүүр улам их болж, хятадууд улам шахаж шаардсан, сэжиг бүхий шинжтэй болж, хүн амын санаа бодлыг үл тоомсорлож эхэлжээ. XIV Далай лам Дорнод Түвдийн хил орчмын районуудаар явах замынхаа турш Түвд хүмүүс хятадуудыг үзэн ядах явдал улам өсч, хятадууд ч улам их харгис хэрцгий болж байгааг олж харсан байна.

Тэнд бослого хөдөлгөөн эхлээгүй ч бусад нутагт ширүүн өрнөж байв. 1955 оны сүүлч, 1956 онд Камын бүх нутаг бослого хөдөлгөөнд хамрагдав.Тийш нь цэргийн нэмэлт хүч явуулав.[1068] Ширүүн тулалдаан эхлэв. Хятадууд түвдчүүдийг айлгахын тулд суурин газрууд болон сүм хийдүүдийг их буугаар галлаж, агаараас бөмбөгдөж, хүмүүсийг үй олноор нь гэсгээн цээрлүүлж эхэлсэн байна. Түвдчүүд хятад цэргүүдийг”тендра” буюу “итгэл үнэмшлийн дайсан”, харин партизануудыг “тэнсунг” буюу итгэл үнэмшлийг хамгаалагчид хэмээн нэрлэж байжээ.[1069]

Литан муж бослогын томоохон голомт болов. Коммунистууд 1950 онд тэнд очжээ.[1070] Үүнээс хойш тэд ардчилсан шинэтгэл хэрэгтэй гэж хүн амд ятган үнэмшүүлэхийн тулд таван жилийн турш аядуу зан ааш гаргасан байна. 1952 онд эрчимтэй суртал нэвтрүүлэг эхлэв. Хураалгах ёстой эд хогшлын жагсаалтыг оршин суугчдад уншиж танилцуулах болов. Дараа нь хятадуудын толгой дээр америкчууд атомын бөмбөг хаяхгүй байлгахын тулд хандив өг гэж шаардаж эхэлсэн байна. Мөнгөгүй хүмүүс 25 толгой мал өгөх ёстой байв. 1954–1955 онд хятадууд ядуу хүмүүсийг цуглуулж, тэдэнд хоол унд, хувцас, мөнгө тараах болов. Дараа нь энэ ядуус газар

сайгүй явж, санваартнууд ард түмнийг дарлан мөлжиж байгаа тухай ярих ажээ.Мөн баячуудыг хараaж зүхнэ. Ингээд хятадууд суртал нэвтрүүлэг үр дүнгүйг ойлгомогцоо: "Цагаан зам бол коммунизмд хүрэх зам, харин хар зам нь та бүхэнд байгаа бүх зүйл: аж амьдрал, эд хөрөнгө, шашин шүтлэг, нийгмийн бүтцийг эвдэж сүйтгэнэ. Хүссэн замаа сонгож авагтун" гэж мэдэгдэв. Олон хүн тэрхүү "хар зам" гэгчийг нь сонгожээ.


Залуу удирдагч юнру пон Соном Ванжил (Norbu J. March winds . . .)

Хятадуудтай хийсэн мөргөлдөөнд оролцож байсан тосгодын оршин суугчид 1956 оны хоёрдугаар сард нэгэн томоохон хийдэд нуугджээ. Гэтэл агаарт нисэх онгоц гарч ирж бууж өгөхийг уриалсан хуудаснууд шидсэн байна. Хүмүүс энэ хуудсанд хариу өгсөнгүй, гэтэл уг нисэх онгоц 3 мянга шахам хүн нуугдсан хийдийг бөмбөгдсөний улмаас олон зуун хүн амь үрэгдэв.[1071] Үлдсэн хүмүүсийн зарим хэсэг нь хятадуудад бууж өгч, бусад нь зугтажээ.

Энэ тухай олж мэдсэн түвдчүүд Литангийн гол хийдийг хамгаалахаар явсан байна.[1072] Гандан Дэгчинлэн Чойкорлинг гэдэг энэ хийдийг XVI зуунд III Далай лам үндэслэн байгуулжээ. Тэр хийдэд хэд хэдэн мянган Түвд хүн цугласан байв. Ингэсэн нь зөвхөн бослоготой холбоотой биш, Түвдийн шинэ жилийн баяр тэмдэглэж байсантай холбоотой бөгөөд энэ үеэр мөргөлчид сүм, хийдүүдэд олноороо очдог ажээ. Хятадууд хуурай замын цэргийн дайралт болон агаараас буудаж бөмбөгдөх замаар уг хийдийг эзэлж авах гэж эрмэлзэн түүнийг олон хоног бүслэлтэд байлгажээ. Үүний хариуд эсэргүүцэн босогчид хятадын цэргийн хуарангуудад хэд хэдэн удаа халджээ. Хятадууд агаараас бөмбөгдөв. Хийдэд нуугдсан хүмүүст бууж өгөхийг шаардав. Хийдэд бүслэгдсэн хүмүүсийг Юнру омгийн залуу удирдагч Соном Ванжил толгойлжээ. Тэрээр хятад цэргийн даргыг цэргүүдийнх нь нүдэн дээр буудан хороож, өөрөө баатарлагаар амь үрэгджээ.[1073] Энэ явдал түвдийн Шинэ жилийн хоёрдахь өдөр болсон байна. Сычуаны Чэндугийн нисэх хүчний баазаас хөөрсөн нисэх онгоцуудаас дээрхи хийдийг зад бөмбөгдсөн байна. Энэ бол ЗСБНХУ-аас нийлүүлсэн

хоёр моторт фронтын бөмбөгдөгч Ил-28 нисэх онгоц байсан хэмээх мэдээ байдаг юм.[1074] Нэг мэдээгээр бол хэдэн зуун хүн алагдаж шархадсан гэдэг бол өөр мэдээллээр хэд хэдэн мянга гэсэн тоо байдаг юм.

Залхаан цээрлүүлэгчид айлган сүрдүүлэх ажиллагаа явуулжээ. Нэг ламыг буудан хороожээ.[1075] Хийдийн хамбын хөл, гарыг урт модонд (шургааг) холбон хүлж, хоолойг нь хэд хэд ороосон гинжийг мөн тэр модноос өлгөжээ. Өөр нэг ламыг нүцгэлж, хоёр хуруу зузаан улайсгасан төмрөөр гуя, цээж, сугыг нь түлж эхэлсэн байна. Энэ эрүү шүүлтийг гурван өдөр дараалан хийж, “завсарлагаанаар” түлэгдсэн шарханд нь тос түрхэх ажээ. Хүмүүсийг цуглуулж, хийдийн хамба байсан хоёр хүнийг авчирч бай болгон буудуулахдаа амин газарт онохгүй байх үүрэг өгчээ. Дараа нь тэр хоёр хүний нэгний дээр буцламгай халуун ус асгаж, нөгөө рүү нь чулуу нүүлгэж, дараа нь сүхээр толгой, мөрнийх нь тус газраар цавчжээ. Цугларсан хүмүүст тэр хоёрыг дарлан мөлжигчид хэмээн тайлбарлажээ.

Энэ хоёр хийд төдийгүй бусад зарим хийдийг ч агаараас бөмбөгдсөн тухай мэдээ байдаг юм.[1076] Энэхүү бөмбөгдөлт бослого хөдөлгөөнийг улам хүчтэй болгов. Босогчдын эгнээ өргөжив. Эмэгтэйчүүд босогчдын эгнээнд орж, тэдний зарим нь бүлгийн удирдагч болжээ. Алагдсан эхийнхээ оронд охин нь тулалдах тохиолдол ч гарч байжээ. Бусад газруудын нэгэн адил энд ч ХАЧА-ийнхан “давалгаа” хэмээх давшилт ашиглаж, амь үрэгдсэн цэргүүдийн оронд шинэ шинэ хүч нэмэгдэн орж ирэх ажээ.[1077] Үүнээс болж хятадуудын хохирол үлэмж их болж байлаа. Сэрта, Далак Тэнгчэн, Техор Танко, Ба Чхоти, Маркхам Ло хийдүүдийг эвдлэн сүйтгэжээ.[1078]

Оршин суугчдыг гэсгээн цээрлүүлж байлаа. Үүнээс болж Литангийн хүн амын тэн хагас амь үрэгдсэн юм гэж түвдчүүд ярьдаг байв. 13 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүд л үлджээ. Залхаан цээрлүүлэгчид партизануудыг эрэх нэрийдлээр айлуудын байшинд дайран орж, нохой, заримдаа бага насны хүүхдүүдийг ч буудан хөнөөж байжээ. Хоол хүнсийг нь булаан авч, партизануудад ашиглуулахгүйн тулд үр тарианых нь нөөцийг устгах ажээ. Хүмүүс өлсөж эхлэв. Зарим эмэгтэйчүүд зовлон гамшгийг тэсвэрлэж чадахаа больж хүүхдээ тэврэн гол руу үсрэн орж амиа хөнөөж байжээ.

Төв Түвдэд гаднаас хүмүүс орж ирэх болов. Эхний үед тэд өөрсдийгөө “мөргөлчид” хэмээн нэрлэж байсан ч үнэн хэрэгтээ зарим нь дүрвэгчид, нөгөө хэсэг нь партизанууд[1079] байсан юм гэж энэ үйл явдлыг нүдээр үзсэн нэгэн хүн ярьжээ. Яриа илэн далангүй болохын цагт тэр хүмүүс эд хогшлоо зарж цалин цагаан мөнгө болгоод хожимдоогүй дээрээ Энэтхэг рүү явахыг

нутгийн түвдчүүдэд зөвлөдөг байв. Эхний үед нутгийн оршин суугчид Камд хятадуудын үйлдэж буй хэрэг явдлуудын тухай дүрвэгчдийн үгэнд итгэдэггүй байв.

Түвдийн төв нутгийн хүн ам шинэтгэлийг сонирхдоггүй байв. 1956 оны хоёрдугаар сард Монламын баярын үеэр Лхас хотод Түвдээс гарч явахыг хятадуудад шаардсан ухуулах хуудсууд гарч, эрх баригчдад өргөх бичиг барьжээ. 1952 онд хятадуудын хүчээр тараасан байгууллага болох ардын холбоотнуудын нэрийн өмнөөс эдгээр ухуулах хуудас, өргөх бичигт гарын үсэг зуржээ.[1080]

Энэ байгууллагад худалдаачид болон бага тушаалын түшмэд орж байв. Томоохон худалдаачин Цэрэндорж болон өөр хоёр түшмэл энэхүү холбоог тэргүүлжээ. Затула ринбүүчи хэмээх том ламын дэмжлэгтэй Ванчин Гэлэг гэдэг сайд дээрх байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэв. Энэ байгууллага Далай ламд бэлэг барих ёслолын ажиллагааг санхүүжүүлж, хятадын оролцооны эсрэг, Далай ламын эрх мэдэл, түвдийн валют болон армийг сэргээхийн төлөө тэмцжээ. Хожим нь ардын холбоо “Ядуучуудын хангамж” хэмээх байгууллага бий болгосон бөгөөд энэ байгууллага дүрвэгчид төдийгүй үнийн өсөлтөөс болж хэлмэгдсэн Лхасын ядуучуудад тусалж эхэлжээ. Энэ байгууллага ядуучуудад туслаж, эм тан тарааж, арвайн гурил хийхдээ усан тээрэм үнэ төлбөргүй ашиглахыг ядуучуудад зөвшөөрөхийг засгийн газраас шаардаж байлаа. Тус байгууллага мөн үйл ажиллагааныхаа хүрээг Лхасаар хязгаарлалгүй Шигазе, Гьянзе хүртэл өргөжүүлэв.

Мао Зэдун энэ үйл ажиллагааг дутуу үнэлсэн ажээ. Тэрээр Бээжинд Лхалу тэргүүтэй түвдийн төлөөлөгчидтэй уулзахдаа дээрх үйл ажиллагаа эдийн засгийн бэрхшээлтэй холбоотой бизээ, энэ бэрхшээл арилахын цагт хүмүүсийн дургүйцэл аяндаа зогсоно хэмээн мэдэгдсэн байна. Гэсэн хэдий ч хятадын эрх баригчид ардын холбооны үйл ажиллагааг зогсоохыг Түвдийн сайд нарын зөвлөлөөс шаардаж: цэргийн ажиллагаа явуулна хэмээн сүрдүүлж, дээр дурдсан гурван удирдагчийг баривчлуулав. Хятадууд тэр гуравт Гоминьдан болон Америктай холбоотой байсан гэгч ял тулгажээ. Нотолгоо олдоогүй боловч тэр гурвын нэг нь шоронд нас барсан байна. Үүнээс болж ард олны хөдөлгөөн маш хүчтэй болсон учир хятадууд 1956 оны наймдугаар сарын 25-нд дахин суртал ухуулга явуулахгүй байх болзлоор нөгөө хоёр хүнийг суллахаар шийджээ.[1081]

Харин хятадууд Кам, Амдод ардчилсан шинэтгэл үргэлжлүүлэв. Тэд бослого гарч буй нутгууд руу 40 мянган хүний бүрэлдэхүүнтэй цэрэг

явуулав.[1082] 1956 оны дөрөвдүгээр сард баруун Камын удирдагчдыг Чамдод цуглуулж "шинэтгэл хийх шаардлага" дэвшүүлэхийг тэдэнд ухуулжээ.[1083]

Гэтэл тэдний олонхи нь ийм шинэтгэлийг хойшлуулах буюу ерөөс явуулахгүй байх санал өгчээ.Удирдагчдыг гэр гэрт нь явуулав. Харин дөрөв буюу тавдугаар сард тэдний зарим хэсгийг Чамдогийн зүүн хойт нутгийн Жомдад цуглуулж, ХАЧА-ийн цэргүүдээр бүслэж, шинэтгэлийг нэн даруй эхлүүлнэ гэж зарласан байна. Удирдагчид ч зөвшөөрсөн мэдэгдэл хийж. Гэвч хамгаалалтынхан сонор сэрэмж алдах үеэр тэр удирдагчид оргон гарч босогчидтой нэгдсэн байна. Ньяронгод гарсан бослогыг тэр үед Дарцедод хуралдаанд оролцож байсан орон нутгийн удирдагчийн эхнэр Дорж Юндэн удирджээ. Хэсэг эмэгтэйчүүд болон мөн тэр хуралдаанд оролцож байсан өөр нэг түшмэлийн хүүхдүүд алагдсаны дараа Ньяронгод ийнхүү бослого гарчээ.

Хятадын эрх баригчид "хамжлагын эзэд", "боол эзэмшигчдийг" буруушаан цээрлүүлж, их хэмжээний эзэмшил газар хураан авч, өөрсдийнхөө үзэмжээр газар дахин хуваарилаж, зарим газрын эздийг цаазалжээ.[1084] Байшин, газар, мал, түүнчилэн сүм хийдийн эд хогшилд шинээр татвар оногдуулав.[1085] Хятадууд У-Цангийн цэргийн хэрэгцээнд хөрөнгө мөнгө хэрэгтэй байна гэсэн шалтаг зааж хүн амаас цалин цагаан мөнгө гаргаж өгөхийг шаардах болсон юм гэж дүрвэгчид ярьсан байна.[1086] У-Цангийн оршин суугчдад төлбөр хийхэд нь эрх баригчдад мөнгөн зоос хэрэгтэй болжээ. Кам, Амдогийн мөнгөгүй хүмүүс мал болон нөөц үр тариагаа худалдахад хүрсэн байна. Татвараа төлөхийн тулд өмсөх хувцасаа, тэрч байтугай цай уудаг аягаа хүртэл худалдахад хүрч байлаа.[1087] Нүүдэлч малчдыг хомроголон баривчилж эхлэв: нүүдэллэн амьдрана гэдэг бол балмад явдал гэж коммунистууд үзэж байв.

Хятадын эрх баригчид газар сайгүй хурал цуглаан хийж, төв засгийн газрын бодлогыг тайлбарлан таниулж, чинээлэг тариачид, газрын эзэд, лам нарыг дайсан этгээд хэмээн зарлаж, тэднийг "доодчуулын" зүгээс "шүүмжлүүлэхийг" эрмэлзэж байв. Хүмүүсийг элдвээр сүрдүүлэн цуглаанд оролцуулдаг байсан гэж түвдийн цагаач иргэд ярьжээ. Шинэтгэлийг хэрэгжүүлэхэд цөөхөн тооны ядуучууд ХКН-тай хамтран ажилласан бөгөөд харин олонхи хүмүүсийг энэ ажилд хүчээр албадан оролцуулсан ажээ.[1088]

Хүн амыг нэг талаас "боол эзэмшигчид", "хамжлагын эзэд", нөгөө талаас "хамжлагынхан", "боолууд" хэмээн хуваажээ.[1089] Хэрэв "хамжлагынхан" болон "боолууд" шинэтгэлд оролцохоос татгалзвал хятадын эрх баригчид тэднийг энэ хэрэгт хүчээр оролцуулахыг эрмэлзэж,

ихэнх тохиолдолд өөрсдөө уг шинэтгэлийг хэрэгжүүлж байв. Зарим үед тариачдад эд материалын тусламж болон цалин пүнлүү санал болгох ажээ.

Янз бүрийн төрлийн сургууль, хүмүүжлийн төв, бусад нэгдлүүдэд аль болох олон Түвд залуучууд бүртгэж авахыг эрмэлзэж байв.[1090] 1950-аад онд хятад руу явуулахаар түвдчүүдийн хүүхдийг хүчээр шахам элсүүлэн авч байсан тухай мэдээллийг орон нутгаас (голдуу Амдо-гоос, цөөнх тохиолдолд Түвдийн төв нутгаас) Олон улсын хуульчдын Комисс цуглуулан авчээ. Ийнхүү хүүхдээ явуулахыг эцэг эхэд нь элдвээр ятгах, мөнгө өгөх, албадах аргаар тулган хүлээлгэдэг байв. Олон мянган айлын хүүхдүүдийг албадан Хятад руу аваачиж, тэнд өөрийнх нь уламжлал, эх орных нь эрх чөлөөтэй хэрхэн тэмцэх үзэл санаагаар тэднийг хүмүүжүүлжээ. Энэ хүүхдүүд хятадад зохих ёсны хэвийн боловсрол олж аваагүй ажээ. Энэ нь гэр бүлүүд болон нийгэмд хагарал үүсгэжээ. Олон хүүхэд ерөөс эргэж ирээгүй, эцэг эх нь тэдний тухай ямар ч мэдээлэл олж чадалгүй үлджээ. Эрх баригчид хятад залуучуудыг Түвд бүсгүйчүүдтэй гэр бүл болгох ажлыг ч эрхлэн хийж байсан тухай мэдээ бий.[1091]

Олон улсын хуульчдын Комисс мөн 1950-иад оны хоёрдугаар хагаст коммунистууд түвдийн сүм хийдүүдийг хааж байсан тухай олон арван гэрчийн мэдээлэл цуглуулжээ.[1092] Янз бүрийн суварга, сүм дуганыг эвдлэн сүйтгэж, сүм дуганыг хятад цэргийн хуаран болон албан контор болгон ашиглаж, том толгой лам нарыг баривчлах, лам нарыг автомашины зам, цэргийн хуаран барих ажилд албадан дайчилж, тэднийг гэрлүүлэх буюу эмэгтэйчүүдтэй нэг гэрт хамтран амьдрахыг албадах, тэдний хөрөнгө хогшлыг хураах, сүм хийдээс хөөгдсөн өвгөчүүл хоосорч ядуурах явдал ердийн үзэгдэл болжээ.

Чинээлэг хүмүүс, түүний дотор тариачдыг гэр орноос нь, лам хуврагуудыг сүм хийдээс нь хөөн гаргаж, эд хогшлыг нь хураан авч, айлын байшин, сүм хийдийн хаалган дээр: “Намын шийдвэрээр хураагдсан. Орж болохгүй” гэсэн бичиг хаддаг байсан тухай энэ үйл явдлыг нүдээр харсан хүмүүс дурсан ярьжээ.[1093]

1954 онд Пунцоглин хийдэд эмэгтэйчүүдийг хөөж оруулан лам нарт тэднээс сонгож авахыг тушаажээ.[1094] Лам нар татгалзав. Тэгтэл хятадуудад баригдсан нэг эмэгтэй тэнд байсан нэг хөгшин ламыг өөртэй нь эр эмийн холбоотой байсан хэмээн буруушаажээ. Тэр ламаас та энэ хүүхэнтэй гэрлэх, цаазлуулах хоёрын аль нэгийг сонгож ав хэмээн тулгаж, чулуун хайрган дээр өвдгөөр нь суулгаж 15 минут болгосны дараа өргөстэй харганан дээр нэг цаг хэртээ суулгасны эцэст хятадууд тэр эмэгтэйн хамт өнөө ламыг зодож,

сэлэмний үзүүрээр хатгаж, чихийг нь тас цавчиж, гавлажээ. Маргааш өдөр нь бас хоёр цаг хэртээ зодсоны эцэст лам нас барсан байна. 1955 онд Шива хийдэд зэвсэглэсэн хятадууд ирж, нэгэн сүмд эмэгтэйчүүдийг хэсэг адууны хамт хөөж оруулан тэдгээр хүүхнүүдийг гаргаж авахыг лам нарт шаардахад тэд татгалзжээ. Шашны ном сударыг гудсан завсар чихэж, ариун цэвэрийн цаас болгож эхлэхэд нэгэн лам эсэргүүцэл илэрхийлжээ. Тэр ламын хоёр гарыг тохойноос нь дээхнүүр тас цавчиж, Бурхан чамд хоёр гарыг чинь эргүүлж өгөх юм байгаа биз хэмээн хэлсэн байна. Хятадууд шашин ямар ч хэрэггүй, яагаад гэвэл түүнээс болж хүмүүс ажил хийхгүй байна гэж лам нарт тайлбарлажээ. 1955 оны гуравдугаар сард хятадууд Ньяронгийн (Амдо) лам нарт эхнэр авахыг шаарджээ.[1095] Татгалзсан хүмүүсийг шоронд хорьж: 12 ламыг загалмай модонд төмөр хадаасаар хаджээ. Шашны эсрэг суртал ухуулга явуулахаас татгалзсан өөр нэг ламын ташаан тус газар хуруу зузаан төмөр шааж алсан байна. Олон лам болон тариачид зугтажээ.

Лам нарыг гол төлөв хятадууд эрүүдэн тамлах бөгөөд түвдийн улаан идэвхтнүүд хүртэл ингэхээс татгалзаж байжээ.[1096] Энэ бол шашны эсрэг суртал нэвтрүүлэг байсан бөгөөд үүгээр бурхан тэнгэрийн их хүчинд итгэхийн хэрэггүйг нотлох гэж эрмэлзэж байжээ. Жишээ нь зарим лам нарыг морины сүүлнээс зүүж тавихад тэд моринд чирэгдэж яваад нас бардаг ажээ.[1097] Лам нарыг хоол ундгүй хорьж, та нар өөрсдөө ид шидийн хүчээр хоол ирүүл хэмээн шаардах ажээ. Мэдээжийн хэрэг хоол өөрөө гарч ирэхгүй бөгөөд үүнийг шашны эсрэг суртал нэвтрүүлэг “зөв үнэн” болохын нотолгоо гэнэ.[1098] Коммунистууд марксист ном, өгүүлэл орчуулж, тараахыг лам нарт хүчээр тулгана. Олон лам хятадын жижиг суурингуудад цөлөгджээ. Хэд хэдэн хийдийн зурмал, цутгамал бурхан бүрт татвар ногдуулжээ.[1099] Энэ бүхний хажуугаар суртал ухуулга явуулж, феодалын зан суртахууны оронд коммунист ёс суртахуун суулгахыг эрмэлзэх ажээ. Сүмд янхан хүүхнүүдийг оруулж, тэнгэр бурхадад бэлэг болгох хэлбэрээр хадгалж байсан эртний сэлэм, хутга тэргүүтнийг хулгай хийлгэнэ.[1100]

Нилээд тохиолдолд гуйланч ядуу түвдчүүд эд хөрөнгий нь авах зорилгоор баячууд болон дунд ангийн хүмүүсийг залхаан цээрлүүлэхийг зөвшөөрдөг байв. Амдод зарим хурал цуглаан дээр “хамжлагын эзэн” байсан хүмүүсийг илчилж, заримыг нь шууд дагзанд нь буудан хороож байв. Бодит байдалд бол энэ хүмүүсийн нилээд нь зарц буюу хөлсний ажилчидтай байсан бөгөөд цалинг нь ч зохих ёсоор нь төлдөг байжээ. Амдогийн Дои тойрогт хятадууд нэг зуу орчин чинээлэг хүмүүсийг цаазлан хороохын тулд ард олныг хүчээр цуглуулжээ.[1101] Тэнд болсон цуглааны үеэр хятадуудаас

мөнгө харамж авсан ядуу Түвд хүмүүс цугларсан хүмүүсийн дундуур явж, баячуудыг цаазлахыг зөвшөөрөхгүй бол өөрсдийг тань буудан хороох болно шүү гэж тайлбарлаж явах ажээ. Тиймээс асуудлыг тэр дор нь шийдэж, гуйланч байсан нэг Түвд хүн тойргийг тэргүүлэх болсон байна.

Орон нутгийн удирдагч, Дарцедогийн хамгийн баян нэг хүний бүх эд хөрөнгийг нь хурааж, эхнэр, хүүхдүүдийнх нь хамт торны цаана суулгажээ.[1102] Түүний гэр бүлийн арван дөрвөн гишүүнийг голын усанд үйж алсан байна. Миньягийн иргэн Ванток гэгчийг шинэтгэлийн эсрэг үйл ажиллагаа явуулсан гэж зэмлэж, ардчилагчид түүнээс алт гаргаж өг хэмээн шаардахад түүнд тийм алт байгаагүй ажээ. Ингээд нутгийн оршин суугчдыг гудамжинд хүчээр цуглуулан харгис эрүү шүүлтийг тэдэнд үзүүлэв. Эхлээд “гэмтэн этгээдийг” банз шаахайгаар балбаж, толгой дээр нь буцламгай халуун ус асгаж, хоёр гарынх нь эрхий хуруунаас дүүжилж, духанд нь хоёроос-гурван см-ийн урт улайссан хадаас шааж машины тэвшин дээр шидэж авч явжээ.

1956 оны наймдугаар сард Амдогийн Түвд хүн амын дунд бослого хөдөлгөөн өрнөв. “Тэд манай газар нутгийг авах гэсэн юм. Бидэнд тэмцэхээс өөр зам байгаагүй. Амдогийн бусад омгийнхны хувьд ч мөн ийм явдал болсон билээ. Энэ тэмцэл хөдөлгөөний дараа Амдог ёстой л хоосруулсан даа <...> Манай бүлэгт анхны боломж гармагц л Чөлөөлөх армийн дайчид руу халдсан дөчөөд хүн байсан юм. Баригдах л юм бол буудуулна гэдгээ мэдэж байсан учир бид яахаас ч буцахгүй болсон байлаа. Амдод бидэнтэй адил бодол санаатай болсон голчлон нүүдэлчид, залуу эмэгтэйчүүдээс бүрдсэн бусад бүлэг ч байсан юм. Би ташаан тус газраа шархдаж, сум гэдэсний хөндийгөөр гарч томоос том нүх үлдээжээ. Манай дайчид гэдсэн тус газраа шархадвал амь гарч болох юм хэмээн бодож голдуу л хоол идэхгүй шахам тулалдана. Миний дотор эрхтэн шархны нүхээр цувж эхэлсэн тул би тэлээгээ чангалж, гарч ирсэн гэдэс дотрыг цааш нь чихэж, тогтоохыг эрмэлзэж байв <...> Тэгтэл ч “миний ах”, миний лам найз морьтойгоо давхиж ирээд хэрэггүй гэсэн боловч намайг эмээлийнхээ араар хөндлөн хаяад л тулалдааны талбараас авч гарсан юм” гэж нэгэн нүүдэлчин эр дурсан ярьжээ.[1103]

Эрчүүд нь партизануудтай нийлэхээр явсан айлын эмэгтэйчүүд, хүүхдүүдийг, пулемётоор буудан хороонo.[1104] Эмэгтэйчүүдийг хүчиндэх бол энүүхэнд.

Коммунист эрүү шүүлт болон цааз феодалын үеийнхээс хамаагүй харгис хэрцгий байв. Олон улсын хуульчдын комисс энэ сэдвээр олон

тооны гэрчийн мэдүүлэг цуглуулжээ. Буудан хороож, дүүжлэхээс гадна түвдчүүдийн толгойг нь авч, үхтэл нь зодох, хөл, гарыг нь тас цавчих, усанд живүүлж алах, улайсгасан төмрөөр түлэх, биеийг нь хэдэн хэсэг болгож тасчин хуваах, амьдаар нь газарт булах, өлсгөлөнгөөр цааш харуулах, боймлон хороох, дүүжлэх (заримдаа толгойг нь доош харуулж ), гэдэс дотрыг нь хага татан гаргах, морины сүүлнээс чирж алах, өлсөж гуринхатсан нохдод хаяж өгөх зэрэг харгис эрүү шүүлт тулгаж байв.[1105]

Хүмүүсийн амийг нийтийн өмнө хөнөөнө. Банз, шаахай хэрэглэн зодох, цаазлах ялыг гэр бүлийнх нь гишүүдэд харуулж, бага насны хүүхдүүдээр эцэг эхийг нь буудуулдаг байжээ.[1106] Хүмүүсийг зөвхөн сэжиглэсэн төдийгөөр, мөнгөний төлөө, нийгмийн байдлаа дээшлүүлэх зорилгоор л ямар ч шүүхийн ажиллагаа явуулалгүйгээр хороодог байв. Лам нарыг онцгой аргаар алж хөнөөнө. Ялангуяа нас өндөр болсон буюу хамгийн хүндтэй лам нарыг эрүү шүүлтийн өмнө нэр төрийг нь гутаах гэж эрмэлзэнэ. Тэднийг анжисанд хөллөж, хоёр мөрөн дээр нь сууж морь унасан мэт давхиулах, ташуураар зодох зэргээр тамлана. 1959 оны зургадугаар сард Камд 250 сүм хийд эвдлэн нурааж, том толгой лам нарыг бараг бүгдийг нь баривчилж, цаазалсан тухай мэдээ байдаг юм.

Хэрэв Хөх нуурт үйлдсэн зэрлэг балмад явдлын тухай кино зураг авсансан бол үзэгчдийн сэтгэлийг шимшрүүлэх байсан бизээ[1107] гэж X Банчин лам бичжээ.Жишээ нь, Голокт олон хүнийг нэвширтэл нь нүдэж амийг нь хөнөөгөөд өндөр уулан дээрээс хүүрийг нь хадны ангал руу шидэж байжээ. Хятад цэргүүд тэдний гэр бүлийн гишүүд болон төрөл төрөгсдийг цуглуулан “самуун дэгдээгчдийг” даран сөнөөсөн баяр тэмдэглэхийг тулган шаардаж байжээ. Тэр ч бүү хэл алагдсан хүмүүсийн шарил дээр бүжиглэхийг шаарджээ. Ингэсний дараа тэр хүмүүсийг пулемётоор буудан хороож, тэнд газар ухаж булж байжээ. Амдо, Камд хүмүүсийг 10–15-аар нь жагсааж байгаад л бууддаг ажээ. Энэ бүхнээс болж тэндхийн хүн ам эрс цөөрсөн байна.

Хөх нуурын хот, тосгодод 3–4 мянган Түвд хүн байсан бол тэдгээрийн 800–1000-ыг баривчилсан бөгөөд барагцаалбал тэдний тэн хагас нь хориондоо байхдаа нас барсан юм. Тэдний олонхи нь гэм буруугүй байсан. Бослого хөдөлгөөнд нилээд их хамрагдсан нутгуудад хүүхэд, эмэгтэйчүүд, өвгөд хөгшид л үлдсэн бол залуучууд, дунд насны болон нэр хүндтэй хүмүүсээс тун цөөхөн үлдсэн гэж Банчин лам хэлсэн байна.[1108] ХАЧА голокуудын эсрэг Чэндуд байсан зөвлөлтийн 28 МиГ-15 с нисэх онгоцыг сөнөөгч-бөмбөгдөгч болгон ашиглажээ.[1109] ХАЧА эдгээр нисэх онгоцыг Түвдийн бусад нутагт ч



Лхас хот дахь хятадын агаарын цэргийн хүчний МиГ-15 сөнөөгч нисэх онгоц, 2004 оны дөрөвдүгээр сар (Creative Common License/uploaded on 7 May 2008 by nathanialfreitas)

ашигласан байна.

Голокийн хүн ам 1956 онд 130 мянга байсан бол 1963 онд 60 мянга болтлоо хорогджээ.[1110] 1986 онд Банчин лам Хөх нуурт бослогод оролцож байгаад үлдсэн хэдхэн тооны хүнтэй олж уулзсан ажээ. Залхаан цээрлүүлэгч байсан зарим хүн хожим түвдийн цэргийн тойрог, Чэндугийн цэргийн тойрогт ажиллаж байсан юм. Тэд хийх ёсгүй л зүйл хийснээ Банчин ламд хүлээн зөвшөөрчээ.[1111]

Гэвч тэр жилүүдэд боссон ард түмнийг бүрмөсөн устгах гэсэн хүн ч байсан. Хятад хурандаа надад: "Бид энэ хүмүүсийг бүгдий нь, тэрч бүү хэл эмэгтэйчүүд, хүүхдүүдийг <...> үндсээр нь устгах хэрэгтэй. Хэрэв хуурсыг бүгдий нь устгавал бөөс гэж байхгүй болно шүү дээ" хэмээн тайлбарлаж байсан юм гэж маогийнхантай хамтран ажиллаж байгаад гадагш цагаачлан гарсан нэгэн Түвд хүн ярьжээ.[1112] Хятадын шоронгоос оргож чадсан, хятад хэлтэй нэгэн Түвд хүн хятад цэргүүд хоёр Түвд хүн үлдэхэд л үймээн самуун дэгдээж, их эвдрэл сүйтгэлд хүргэнэ хэмээн хэлж түвдчүүдийг бүрмөсөн устгана гэж байнга тангарагладаг байсан тухай[1113] ярьжээ.

Хөх нуур мужийн намын хорооны хөдөөгийн хэлтсийн дарга Лю Цэси хэлэхдээ Амдогийн ард түмэн ангийн тэмцлийг хүсээгүй, түүнийг коммунистууд л дэвэргэсэн юм гэж санамсаргүй хүлээн зөвшөөрсөн байдаг: "Энэхүү харгис хэрцгий ангийн тэмцэлд, суртал нэвтрүүлэг, хүмүүжлийн кампанит ажил явуулсны дараа, нийгмийн шинэ ба хуучныг сөргүүлэн тавих болсны дараа хөдөлмөрчин малчдын олонхид тэр дороо л ангийн ухамсар сэргэв. Дарлан мөлжигч феодал ангийн харгис мөн чанарыг ухамсарлангуутаа л тэд үнэхээр гайхшралд орсон билээ. Тэд бузар муухай

гэмт хэрэг үйлдсэн дарлан мөлжигч ангийг зэмлэн буруушааж боссон юм. Тэд сайн дураараа хувьсгалын эсэргүүчүүд болон муу элементүүдийг баривчлан засгийн газарт шилжүүлэн өгч, тэдэнд зохих ёсны шийтгэл оногдуулахыг хүссэн юм"[1114] гэж тэр хүн тэмдэглэсэн байна.

Гэсгээн цээрлүүлэлт нь сөрөг үр дүн үзүүлсэн нь маргаангүй. "Доодчууд"-ын олонхи "дээдчүүлтэй" эв санааны нэгдэлтэйгээ илэрхийлэх болсон бөгөөд учир нь энэ бол түвдийн нийгмийн хамгийн их хүндэтгэл хүлээсэн хүмүүс ажээ.[1115]

Марксист ягширмал үзлээс зөрөөтэй нь гэвэл ард түмнийг хагалан бутаргахад чиглэсэн коммунистуудын үйлдэл ангийн тэмцэл биш, харин "дарлан мөлжигчид" болон "дарлагдсан олныг" нэгтгэхэд хүргэжээ. Гэхдээ коммунист нам болон ард түмний хоорондын зааг ялгаа нэмэгдэв. Үүнийг өнөө хүртэл маогийн суртал нэвтрүүлгийг давтаж буй хүмүүс ойлгохгүй байна: "Түвдийн газрын эзэд болон лам нар гаднаас ирсэн хятадууд коммунистууд байсан явдалд л дургүйцсэн билээ.

Тэд цаг хугацаа өнгөрөх тусам коммунистууд Түвдийн шашин, төрийг хослуулан баригч өндөр эрх дарх бүхий ангийнханд тэгшитгэх, хамтач үзлийн шийдвэрүүдээ тулган хүлээлгэнэ гэж болгоомжилсон юм".[1116.]

Түвдийн мужуудад хятад кадр ажилтнуудын явуулж буй ажлын арга барилыг Бээжинд шүүмжлэх явдал ч гарч байв. Газрын шинэтгэл, сүм хийдэд оногдуулж буй татвар хураалт, тэндхийн газар болон малын хэмжээнд тэгш биш байдал гарч байна, шашны бодлого нэгдмэл биш байна, их хан үндэстний дээрэнгүй үзлийн илрэл ажиглагдаж, түвдийн кадр ажилтнуудын боловсрол мэдлэг муу байна гэсэн хэл яриа гарч байв.[1117] Зарим түшмэдийг шийтгэсэн байна. Гэсэн ч ард түмэн шинэтгэлийг хүсээгүй юм. Тийм учраас л түүнийг хэрэгжүүлэх гол хэрэглүүр нь гэсгээн цээрлүүлэлт болж үлджээ.

Тийм хандлага Мао Зэдуны үзэл санаанд харшлаагүй ажээ. "Юуны өмнө "ард түмэн" гэж юу вэ, "дайсан" гэж юу вэ гэдгийг ялгаж мэдэх хэрэгтэй. Өнөөгийн шатанд буюу социализмын байгуулалтын үед социалист байгуулалтын үйл хэргийг сайшааж, түүнийг дэмжиж, энэ үйл хэрэгт оролцож буй бүх анги, давхарга, нийгмийн бүлгүүд ард түмэн хэмээх ойлголтод хамаарна: социалист хувьсгалыг эсэргүүцэж, социализмын байгуулалтад дайсагнан хандаж, түүнд хор хүргэж буй нийгмийн бүх бүлэг, хүчин ард түмний дайсан мөн <...> Бид болон бидний дайснуудын зөрчлөөс үүдсэн тэмцэл нь хувьсгалын эсэргүүчүүдийг үндсээр нь устгах үндэс суурь мөн"[1118] Ингэхлээр социализмыг үл хүсэгч хэн бүхэн бол ард түмэн биш. Ард түмэн гэдэг бол Маогийн төлөө явж буй тэр хүмүүс л мөн билээ.

Иймийн учир маогийнхны эсрэг бослого бол ард түмнийх байж чадахгүй. Энэ бол “ард түмний дайснуудын” үйлдэл мөн бөгөөд тэднийг үндсээр нь устгах хэрэгтэй.

Түвдийн төв нутагт ч социалист шинэтгэлийг эржимжүүлэх төлөвлөгөө гарав. 1956 оны долдугаар сарын 1-нд ХКН-ын Жан Зиньи, Жан Гохуа тэргүүтэй түвдийн асуудал эрхэлсэн ажлын хороо 1956 оны өвөл-1957 оны хавар эхлээд хэд хэдэн газарт, дараа нь нийт Түвд даяар шинэтгэл хийж эхлэхийг ХКН-ын төв хороонд санал болгов.[1119] 4–6 мянган хүний бүрэлдэхүүнтэй аюулаас хамгаалах олон нийтийн цагдаагийн хүч байгуулж, ардын цагдаа, эдийн засгийн цагдаагийн хүчийг 2400 хүртэл хүнтэй болгож нэмэгдүүлж, Түвд кадр ажилтнуудын тоог 40–60 мянга болгох, 20–30 мянган Түвд хүнийг ХКН-д, 30–50 мянган хүнийг комсомолд элсүүлж, бас 6 мянган хятад кадр ажилтанг Түвд рүү нэмж явуулахыг санал болгов.

Түвдэд гарсан бослого Далай лам болон түвдийн засгийн газрыг хүнд байдалд оруулав. Тэд босогчдыг дэмжиж байсан боловч хятадуудын хүч дэндүү давуу байсан учир зэвсгээ хураалгаж, гэр орондоо эргэж очихыг тэдэнд зөвлөхөд хүрсэн байна. Босогчид тэмцлээ цаашид үргэлжлүүлэхэд бэлтгэхдээ Лхаст байдаг нутаг нэгтнүүдийнхээ тусламжийг авсан байна. Хятадын эрх баригчид бодит байдлыг харгалзан үзэхээс өөр аргагүй болжээ. Тэд Түвдийн төв нутагт үйл явдлыг яаравчлахгүй байх нь зөв гэж үзсэн байна.

1956 оны есдүгээр сарын 20-нд Жан Гохуа ХКН-ын ҮШ их хурал дээр үг хэлж, ирээдүйн Түвдийн өөртөө засах Оронд хятадын засаглалыг хэрэгжүүлсэн таван жилийн ажлын дүнгийн тухай мэдээлсэн байна. Түвд “феодал-хамжлагийн” байгуулалтай, хөдөлмөрчид хүнд нөхцөлд аж төрж, эдийн засаг хоцрогдмол байгааг генерал тэмдэглэжээ. Шинэтгэлийг амжилтад хүргэхийн тулд: “1) хөдөлмөрчид өөрчлөн байгуулалт хийхийг шаардаж, харин дээд давхаргын төлөөлөгчид тэднийг чин сэтгэлээс дэмжих; 2) түвдийн нийгэм-эдийн засгийн байдалд хийсэн шинжлэх ухааны судалгаанд үндэслэсэн, хүн амын бүх давхаргын төлөөлөгчидтэй тохиролцсон өөрчлөн байгуулалтын арга боловсруулж; 3) тодорхой тооны үндэсний боловсон хүчинтэй байх явдал хэрэгтэй байна гэж тэр хэлжээ.[1120]

Үүнд их хугацаа хэрэгтэй гэж генерал үзжээ. Энэ ажилд түвдийн нийгмийн дээд давхаргынхныг татан оролцуулж, итгэл үнэмшлийн эрх чөлөөг хангаж, шашинг хамгаалах хэрэгтэйг тэр онцлон тэмдэглэжээ.

Түүний санал маш үнэтэй юм. Хөдөлмөрчид өөрчлөн байгуулалт хийхийг шаардаагүй, түүнийг дээд давхаргынхан дэмжээгүй, шинэтгэл

хийх арга боловсруулаагүй, ард түмэнтэй тохиролцоогүйг энэ санал нотлон харуулж байна. Ард түмэн маш эв нэгдэлтэй байсан учир ХКН-ыг дэмжигч орон нутгийнхны тоо маш цөөн байжээ.

Партизануудын хувьд бол үйл ажиллагаагаа зохицуулах явдал бодит шаардлага болж байв. Литангийн наймаачин Гомбодаш (1905–1964) ингэх гэж эрмэлзжээ. Тэрээр зоримог бөгөөд авьяаслаг зохион байгуулагч, цэргийн жанжин болохоо харуулсан билээ. Хожим нь тэрээр Энэтхэг рүү гарч чадсан боловч Дрегун Машунийн дэргэд болсон тулалдаанд шархадсанаасаа болж нас барсан ажээ. Гомбодаш 1956 оны арван хоёрдугаар сард зүүн өмнөд түвдийн партизануудад дараах утгатай илгээлт явуулжээ: “Хүмүүс та бүхэн нилээд хугацааны турш улаан хятадуудын эсрэг бослого гаргаж байна. Одоо та нарын бүх эрэлхэг зүтгэлийг нэгтгэж, та нарын аймшиггүй чин зоригийг шалгах цаг ирээд байна. Та нар Түвд орноо хамгаалахын тулд амь насаараа дэнчин тавьж, бүх хүчин чармайлтаа дайчлан гаргахад бэлэн байгааг би мэднэ. Та нарын өмнөө дэвшүүлэн тавьсан асар том зорилт бол ариун үйл хэрэг бөгөөд дайсан этгээдийн үйлдэж буй аймшигт зэрлэг ажиллагаанаас үл шалтгаалан та бүхэн зорьсон үйл хэргээсээ татгалзахгүйг ч би мэдэж байна. Аюулын харанга дэлдсэн энэ цаг мөчид би засгийн газрын албан хаагчдыг оролцуулан эрх чөлөөгөө, шашнаа хүндэтгэдэг бүх хүнд хандаж хятадуудын эсрэг нийтийн тэмцэлд нэгдэхийг уриалж байна. Түвдчүүдэд өнөөдөр хятадуудын эсрэг зэвсэг барин босохоос өөр зам байхгүй болсныг тайлбарлаж ойлгуулахын тулд Түвдийн бусад хэсэг, хөрш зэргэлдээх орнууд, жишээлэхэд Энэтхэгт аж төрөн суудаг хүмүүст мэдээлэл явуулж байна”.[1121] Үүний дараа босогчдын тархай бутархай отрядууд нэгдэж эхэлсэн байна. 1956 оны сүүлчээр коммунист Пунцаг Ванжил Лхас хотод Камын худалдаачдын цуглаан зохион байгуулав.[1122] Тэрээр цуглаан дээр үг хэлэхдээ оршин суугчид хятадын бодлогыг мэдэхгүй байгаа явдал дайны шалтгаан болж байна: хэрэв тэд гэртээ харивал хятадын засгийн газар бизнесээ сэргээхэд тань туслахад бэлэн байгаа юм гэж мэдэгджээ. Ванжил мөн Камын байдлын талаар лам нарыг төөрөгдөлд оруулахыг эрмэлзсэн байна. Харин Гомбодаш түүний үгийг няцаагаад хятадууд 17 зүйлт Хэлэлцээрийг зөрчсөн тухай сануулсан юм.

Буддагийн нирваан дүр олсны 2500 жилийн ойд зориулсан баяр ёслол 1956 оны арван нэгдүгээр сард Энэтхэгт болов. Энэтхэгийн засгийн газрын урилгаар Далай лам тэргүүтэй, Банчин лам тэргүүтэй Түвдийн хоёр хэсэг төлөөлөгчид Энэтхэгт очсон байна. Энэ хоёр хүний сууж очсон нисэх онгоц хятадын далбаагүй, харин Энэтхэгийн болон өөрсдийнх нь хувийн

далбаагаар чимэглэгдсэн байсан гэж тэр үед Энэтхэгийн Галигдаа хотод сууж байсан америкийн консулын газрын төлөөлөгч мэдээлжээ. Энэтхэгт Далай лам хятадуудын өгсөн зааврыг үл тоомсорлон ёслолын ажиллагаан дээр үг хэлж, тусгаар тогтносон жижиг ард түмнүүдийг том, хүчтэйнүүд нь устгаж байна гэж мэдэгджээ.[1123]

Тэр жилийн сүүлчээр ХАЧА-ын ангиуд Босогчид руу давшиж эхлэв. Энэ тухай олж мэдсэн Далай лам төвдийн асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх хүртэл Энэтхэгт үлдэхийг хүсчээ. Мао Зэдун 1956 оны арваннэгдүгээр сарын 15-нд ХКН-ын Төв Хорооны бүгд хурал дээр үүнтэй холбогдуулж үг хэлэхдээ: “Төвд дэхь манай ажлын хороо болон цэргүүд бэлтгэлээ базааж, бэхлэлт хаалт байгуулж, аль болох их хоол хүнс, ус бэлтгэх ёстой... Эхлээд тэд халдвал ч халдаг, тэгсэн цагт бид сөрөг давшилтад орж, дайсныг толгой дараалан устгана. Ганц Далай лам явлаа гэхэд надад харамсаад байх юу билээ? Түүн дээр бас есийг нэмье л дээ, хамаагүй арван Далай яваг, надад харамсаад байх юм алга” гэж онцлон тэмдэглэжээ.[1124] Гэвч 17 зүйлт Хэлэлцээрийг мөрдөх нь зүйтэй гэсэн Ж.Неругийн зөвлөгөө болон Мао Зэдуны хэлсэн үгийг иш татаж шинэтгэл хэрэгжүүлэх ажлыг хойшлуулна, төвдчүүдийн хүсэлтээр л түүнийг хийнэ гэсэн Жоу Эньлайн баталгааны дараа Далай лам нутаг буцахаар шийджээ.[1125]

Мао Зэдун 1957 оны хоёрдугаар сарын 27-нд: “Төв засгийн газар болон Төвдийн орон нутгийн засгийн газрын хооронд байгуулсан 17 зүйлт хэлэлцээрийн дагуу нийгмийн байгууллын шинэтгэл тэнд гарцаагүй хэрэгжинэ, гэхдээ шинэтгэл хэрэгжүүлэх хугацааны тухай шийдвэрийг төвдийн ард түмний олонхи хэсэг болон тэдгээрийн удирдагчид үүнийг боломжтой хэмээн үзсэн цагт л гаргаж болох юм: энэ талаар яаравчилсан алхам хийж болохгүй” гэж мэдэгджээ.[1126] Энэ мэдэгдэл Далай лам буцаж ирэх бас нэг шалтаг болсон болов уу. Тэрээр 1957 оны дөрөвдүгээр сарын 1-нд Лхаст эргэж ирсэн байна. 1957 оны зун Төвдийн өөртөө засах Орны Бэлтгэл хорооны хуралдаан болов. Хуралдаанд оролцогчид төвдчүүдийн төлөөллийг 90 хувь хүртэл өргөжүүлж, хэд хэдэн хороо (түүний дотор эдийн засгийн, нийгмийн аюулгүй байдлын ба шүүх цаазын хороог), орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг тарааж, ХАЧА-ийн хүчийг хорогдуулахыг шаардав.[1127] Тийнхүү Төвдийг хятадад засаг захиргааны хувьд интеграцчилах төлөвлөгөө нуржээ.

Энэ хооронд Кам, Амдогийн томоохон худалдаачид Далай ламд урт наслаж, удаан жаргахыг ерөөж Төвдийг өмгөөлөн хамгаалагч бурхадад өргөл өргөх ёслолын ажиллагаанд зориулж мөнгө хуримтлуулжээ. Гэвч энэ





Үндэсний батлан хамгаалах сайн дурын армийн гишүүд (DIIR Archive, Central Tibetan Administration)



Чуши Гандругийн партизанууд (DIIR Archive, Central Tibetan Administration)

үйл ажиллагааны өөр нэг зорилго бол хожим нь партизаны өргөн хөдөлгөөн зохион байгуулсан Чуши Гандругийн холбоо байгуулах явдал байжээ.[1128]

Чуши Гандруг гэдэг нь түвдээр “Дөрвөн гол, уулсын зургаан систем” гэсэн үг ажээ. Энэ бол Кам, Амдогийн уламжлалт нэр юм байна. Энэ холбоог зохион байгуулагч нь Гомбодаш байв. Түүнтэй хамт нууц бэлтгэл ажилд Дорнод Түвдийн янз бүрийн мужийн удирдагчид оролцжээ.[1129]

Тэд дүйнхорын авшиг хүртээхийг Далай ламаас хүсч зөвшөөрсөн хариу авсан байна. Үүнээс өмнө Амдогийн түвдчүүдээс мөн ийм хүсэлт ирсэн учир энэ хоёр хэсэг хүмүүс нэгджээ. Мөн Лхасын оршин суугчид ч тэдэнтэй нэгдсэн байна. Авшиг хүртээх ёслол 1957 оны долдугаар сарын 4-нд болов. Энэ ёслол XIV Далай ламыг Их Түвдийн эрх баригчийн хувьд сэнтийд нь залж, дээд тэнгэрээс заяат бодгалийнх нь хувьд түүнд итгэн үнэмшиж буйг батлан илэрхийлсэн билэгдэл болжээ. Ийм ёслолыг жил бүр явуулж, энэ үеэр Далай лам сэнтийдээ заларч, ард түмэндээ сургааль хайрлаж, бусад цагт сэнтий Будалын ордонд хадгалагдаж байх болжээ.

Хятадын эрх баригчид 1958 оны эхээр Төв Түвдэд нилээд хэдэн жил оршин суусан 1500 хятад иргэнийг тэндээс хятад руу шилжүүлэн нүүлгэв.[1130] Коммунизмын эсрэг бодол санаатай, түвдчүүдэд мэдээлэл дамжуулсан гэж тэр хүмүүсийг сэжиглэжээ. Тэдэнтэй хамт хэдэн зуун нүүдэлчдийг хөөж явуулав. Хүн ам үүнийг эрх баригчид шинэтгэлийг эрчимжүүлэх бодолтой байгаагийн шинж тэмдэг гэж үзсэн байна. Үүнээс хойш удалгүй Гомбодаш партизаны 23 бүлгийн зөвлөлгөөн хийлгэв.



Түвдийн партизанууд олзолсон хятад зэвсэг туршин үзэж байгаа нь (Andrugtsang, 1973)

Тийнхүү Чуши Гандруг хэмээх бүс нутгийн эсэргүүцлийн хөдөлгөөн нь Тенсунг Дангланг Магар буюу нийт түвдийн Шашны сургаалийг хамгаалах сайн дурын хүчин болж өөрчлөгдөв. Зэвсэг, агт морьд цуглуулж эхэлсэн бөгөөд түвдийн армийн хоёр офицер болон лам нартай холбоо тогтоов. Ийнхүү нүүдэлчид хуучны үеийн өөр хоорондынхоо тэмцэл, дайсагналыг умартаж, булаан эзлэгчдийн эсрэг нэгдэж эхэлсэн байна. Дээрх нэрийн гарал үүсэл тодорхойгүй байгаа юм. Энэ талаар хэд хэдэн таамаглал байдаг ажээ.[1131] Сайн дурын арми – энэ бол Чуши Гандруг (дөрвөн гол, уулсын зургаан систем), Миманг Цондугийн (Ардын холбоо) холбоо гэж Аведон үздэг. Тэгвэл Гомбодаш үүнийг Эрх чөлөөний төлөө сайн дурын тэмцэгчид хэмээх өөрчлөн байгуулагдсан хөдөлгөөн гэж нэрлэхдээ дээр дурдсан армийн нэрээс иш татаж авсан бололтой юм. Ж. Норовын үзэж буйгаар бол энэ нэр Чуши Гандругийг орлосон, яагаад гэвэл Камын олонхи партизан энэ хөдөлгөөнд нэгдсэн юм байна.

Зарим хятад иргэд засгийн газрынхаа үйл ажиллагааг дэмжээгүй юм. Тухайлбал, их бууны ангийн хурандаа Чэн Хочин түвдийн Хаданг Дашийн дивизид шилжиж иржээ.[1132] Тэрээр зарим төрлийн буу, сум авч ирсэн байна. Түвд нэртэй болсон энэ офицер партизануудын талд есөн сар тулалдаж,

дараа нь түүнийг Энэтхэгийн Массури хот руу гаргажээ.

Цанпо голоос урагш Лхока тойрогт олон тооны партизан цугласан байв. 1957 онд 150 мянган хүний бүрэлдэхүүнтэй хятад цэрэг дээр дурдсан партизануудыг Лхока тойрог хүртэл хөөсөн юм. Тэр партизануудын хувьд дүрвэж гарах буюу хангамж авах зорилгоор Энэтхэг рүү гарахад хялбар байжээ. 1958 оны зургадугаар сарын 16-нд Лодам Дама зонг гэдэг газарт партизануудын хурал болж, хэр хүчтэй, хэр зэргийн зэвсэгтэйгээ тоолж үзсэн байна.[1133] Туршлагатай дөрвөн хүнийг дээд тушаалын дарга нараар, таван хүнийг холбооны офицероор, бас таван хүнийг бэлтгэгчээр тус тус сонгов. Нарийн бичгийн дарга нарын газар, санхүүгийн хэлтэс байгуулав. Нийтдээ хээрийн 18 командлагчтай, 10 партизан бүрт нэг даргатай болгов. Биелүүлэх даалгавар, тагнуулын хэсгүүдийг хуваарилан өгч, гадна тийш хэлхээ холбоо барих, тусламж авахад ашиглах сүм хийд, эдлэн газар, мужийн хэмжээний цайзуудыг тодорхойлон заасан байна.[1134] 27 зүйлт сахилга батын дүрэм баталсан бөгөөд хожим нь түүнийг өргөтгөжээ.

Энэхүү дүрмийн нэг чухал заалт бол хүн амыг хулгайч, дээрэмчдээс хамгаалах явдал байлаа. Партизанууд дээрэм тонуул хийдэг, бас өөр хоорондоо хэрүүл тэмцэлтэй байсан гэж хятадын суртал нэвтрүүлэгчид тэмдэглэдэг юм.[1135] Бодит байдалд бол тэд улс орноо хамгаалах нэрийдлээр хүн амыг дээрэмддэг бүлгүүдийг илрүүлэх гэж эрмэлзэж иржээ. Гомбодаш тийм дээрэмчид байдаг нутагууд руу 50–100 партизаны бүрэлдэхүүнтэй отрядууд явуулж, дээрэмчдийг баривчлах буюу устгах тушаал өгдөг ажээ. Камд 120 орчим партизан өөрийнхөө зоргоор явахаар отрядуудаа хаяж явжээ.[1136] Тэдний олонхи нь хоёр бүлэг болон. хуваагдаж, дээрэм хийх болжээ. Гомбодаш тэдний эсрэг тус бүр 100 хүнтэй дөрвөн отряд явуулж, дээрэмчдийн толгойлогч нарыг цаазалж, дээрмийн бүлгийнхний зэвсгийг хураaж, дээрэмдсэн эд зүйлсийг эздэд нь буцааж өгсөн байна.

Хятад эрх баригчид түвдчүүдийн дунд хагарал гаргахын тулд дээрэмчдийг ашиглах гэж эрмэлзэж байв. Эрх чөлөөний төлөө тэмцэгчдийн дүрээр халдлага үйлдэж, хүн амыг дээрэмдэж, бас хажуугаар нь партизануудын тухай мэдээлэл цуглуулахыг тэднээс шаардах ажээ. Гэвч энэ үйл ажиллагааг бүр эхнээс нь тас цохисон байна. Ингээд хятадууд энэ төлөвлөгөөнөөсөө татгалзахад хүрэв. Гэвч зарим газарт хүн амын дунд хагаралтай хэвээр байв. Жишээ нь, Дорнод Түвдийн Пала тойрогт нүүдэлчдийн нэг хэсэг босогчидтой нэгдсэн бол бусад нь нийлэхээс татгалзав.[1137] Ингээд Босогчид дээрмийн халдлага хийх болжээ. Цэрэг ирж, Босогчид ялагдав. Үүний дараа шинэтгэл хийж эхэлсэн боловч энэ ажлыг

аажим аажмаар хэрэгжүүлж: газрыг хураан авч, дахин хуваарилах болсон бөгөөд харин коммун байгуулах ажлыг хойшлуулжээ.

Хятадуудын шахалтаар түвдийн засгийн газар Лхока тойргийн партизануудад байлдааны ажиллагаа явуулахаа зогсоохыг хүссэн захидал бичиж, дараа нь мөн энэ зорилгоор тусгай төлөөлөгч явуулсан байна.[1138] Партизанууд татгалзсан хариу өгөв. Түвд түшмэлийн хүсэлтээр тэд ийнхүү татгалзсан шалтгааныхаа тухай сайд нарын зөвлөлд бичиж,элч ч Лхаст буцаж очжээ.

1958 оны наймдугаар сард Ньемо Дукхак Самдо тосгоны дэргэд түвд, хятадуудын хооронд анхны мөргөлдөөн болов.[1139] Хятадууд замын хажууд нуувч ухан отож, партизануудыг хүрч ирэхэд их буу, пулемёт, винтов буугаар галласан байна.Түвдчүүд арав арван хүнтэй хэсгүүд болон хуваагдаж ухрахдаа уулын оройд болон голын цаана стратегийн байрлал эзэлсэн байна. Буудалцаан хоёр хоног гаруй үргэлжлэв. Сум дуусмагц түвдчүүд сэлмээ сугалан гардан байлдаанд оржээ. Хятадуудаас 200 хүн алагдаж, нилээд олон хүн шархадсан байна. Түвдийн талаас 40 хүн алагдаж, 68 хүн, 50 морь, луус шархаджээ. Ийнхүү зам чөлөөлөгдсөн байна.

Түвдийн засгийн газар 17 зүйлт Хэлэлцээрийг биелүүлж эсэргүүцлийн хөдөлгөөнд тусламж үзүүлнэ үү гэсэн албан ёсны хүсэлт явуулах тухай АНУ-ын тагнуулын төв газрын эрэлт хүсэлтийг хайхралтгүй өнгөрөөв. Тийм учир Гомбодаш түвдийн засгийн газрын мэдлийн зэвсэг, хэрэгслийн агуулах байдаг Шанг Гаден Чокхорт отрядынхаа хамт очжээ.[1140] Хятадын цэргийн хөдөлгөөнийг тагнах зорилгоор 50–100 хүний бүрэлдэхүүнтэй бүлгүүдийг ойр хавийн газруудад хуваарилан явуулав. Агуулах хамгаалж байсан хүмүүс нилээд удаан хэлэлцсэний эцэст түүнийг партизануудад өгснийг Гомбодаш хожим нь дурсаж ярьсан байдаг юм. Тэдэнд түвдийн засгийн газар партизануудад зэвсэг өгч болохгүй гэсэн тушаал буулгасан боловч партизануудад сэтгэл гаргасан нь энэ ажээ.

Партизанууд гол төлөв хөнгөн зэвсэгтэй байв.[1141] Тэд дэлхийн хоёрдугаар дайны үеийн англи, герман, чехословак, орос винтов буугаар зэвсэглэжээ. Нэг хэсэг зэвсгийг тэд хятадуудаас булааж авсан, нөгөө хэсгийг дээр дурдсан агуулах руу дайрах үед авсан, заримыг нь өөрсдийнхөө мөнгөөр худалдаж авчээ. АНУ-ын тагнуулын төв газар Түвдэд нисэх онгоцоор зэвсэг болон мөнгө хаяж өгдөг байв. Үүнийг мэдэгдэхгүйн тулд америк биш зэвсэг өгнө. Америк зэвсгийн оронд нисэх онгоцноос Энэтхэг, Пакистанд хэрэглэж байсан бага зэрэг хуучирсан англи буу хаяж өгөх ажээ. Нисэх онгоцноос хаяж өгсөн буу зэвсэг эвдэрч хэмхрэх нь их, голдуу хэрэгцээгүй болно.

Харин хятад улс гадаадын сайн зэвсэгтэй, тоо хэмжээ нь ч их. Америкийн лагерьт түвдчүүдэд партизаны дайн хийх сургалт явуулжээ.

Партизанууд болон ХАЧА-ын цэргүүдийн хооронд хэд хэдэн шинэ тулалдаан болов. Хамгийн ширүүн тулалдаан Уюг, Ньемо, Ньемо Шол, Ньемо Каркханг, мөн Кангсюнгийн нисэх онгоцны буудал, Кьогчегийн даваанд, Дикхунг, Дугонгийн хийдийн дэргэд, жан Мойшун, Равдан Гон, Чунпо Тенчен, По Тамод болсон байна.[1142] Хятадуудын барьсан По Тамо хотын дэргэд 15 хоног үргэлжилсэн томоохон тулалдаан болжээ. 550 гаруй цэрэг алагдаж, партизануудаас 20 гаруй хүн алагдаж, есөн хүн шархаджээ. Өөр гурван тулалдаанд хятадууд 176, 700, 200 хүнээ алдсан бол түвдчүүдийн хохирол бага байв. Түвдчүүд зэвсэг, цэргийн хэрэгсэл, эд хогшил, хоол хүнс, эм тан олзолж авсан байна. Жолоодож чадахгүй учир хятад цэргийн автомашиныг шатаажээ.

Энэ бүхний дүнд Лхока муж хятадуудаас чөлөөлөгдөж, газар доорхи хонгилын сүлжээ бүхий 2 мянган хүний гарнизон байрласан Цетан л үлдсэн байна.[1143] Өмнө зүг явах зам хятадын армийн хяналтад орсон учир партизаны отрядууд хойд болон зүүн хойд зүгт тулалдан ухрахад хүрчээ. Агаараас буудах, бөмбөгдөх явдал партизануудад их хохирол учруулжээ. Хятадууд партизаны отрядуудын хүч болон байрлалын тухай сайн мэдээлэлтэй байжээ.[1144] Хятадууд мөн Кам, Амдод амжилттай ажиллагаа явуулсан байна.

Энэ зуурт У-Цангийн дүрвэгчдийн тоо эрс өсөв. 1957 оны сүүлч гэхэд Камаас У-Цангд 15 мянган айл дүрвэж очсон тухай мэдээ бий билээ.[1145] ХКН 1957 оны зунаас эхлэн "барууны хөрөнгөтний элементүүдийн эсрэг хийх тэмцэлд нийт улс орны хэмжээнд ард олныг" дайчилсан явдалд хэргийн учир оршиж байгаа юм.[1146] 1958 онд БНХАУ-д Их үсрэлтийн чиг шугам зарлав. Энэ чиг шугам (үр дүнд хүрэлгүй дампуурсан) гэгч нь түргэн хугацаанд коммунизм байгуулахын тулд амьдралын бүх хүрээнд эрс шинэтгэл хийнэ гэсэн үг юм. Техникийн болон соёлын хувьсгалыг Их үсрэлтийн бодлогын хамгийн чухал угтвар нөхцөл хэмээн зарлаж, бичиг үсэг үл мэдэх явдлыг устгаж, соёл–олон түмний ажилд анхаарал тавихыг уриалах болсон билээ.[1147] Бас яасан гээ: аж үйлдвэрийн гол үндсэн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр 15 жилийн дотор Английг гүйцэж, түрүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд ХКН үүнийг илүү түргэн хугацаанд хийхийг уриалж: "Хэдхэн жил шургуу хөдөлмөрлөхөд 10 мянган жилийн аз жаргалыг бүтээнэ!" гэжээ. Кам, Амдогийн ардчилсан шинэтгэлийг илүү эрс байдлаар явуулах болов.

Орчин үеийн зэвсэглэлийг нүдээрээ ч харж үзээгүй олонхи түвдчүүдийг хятадууд айлган сүрдүүлдэг байв. Жишээ нь: “1958 оны хавар Хятадын баруун нутагт тогтвортой биш байлаа <...> Синин хотын хавьд зарим дээд тушаалын лам нар – амьд Будда гэгдэх лам нар болон ариун удирдагч зэрэг хүмүүс урьд үзэгдээгүй хүчтэй дайралт хийх гэж байгаа тухай бид олж мэдсэн билээ. Нэг удаа тэнд байрласан ХАЧА-ийн нэгтгэл барагцаалбал, нэг зуугаад тийм лам нар болон удирдагчдыг бүслэн баривчилж, цэргийн ачааны машинд суулган Сининий нисэх онгоцны буудалд авч ирэв. Тэнд энэ хүмүүст агаарын шоу үзүүлэх гэсэн хэрэг л дээ <...> Тэр өдөр бид нисэх буух зурвасны өмнөд цэгээс барагцаалбал, 50 метрийн зайтай газарт дүүрэн бензинтэй 50 поошигийг 10-аад метрийн радиустай бай болгон өрж тавив. Түвдийн жолоодогч нарыг ирэхэд “тулалдаан үзүүлэхийн” тулд тэднийг нисэх буудлын төвд суулгав. Агаарын цэргийн хүчний 26-р дивизийн “Лавочкин Ла-11с” маркийн хоёр нисэх онгоц хөөрч, мянгаад метр ниссэний дараа агаарт эргэлт хийж нислэгийн зурвасаас 2 мянга орчим метрт дөхөж ирэх үед нисэх онгоцноос бензинтэй поошиг руу пулемётоор галлаж эхлэв.Пулемётын амнаас гал улалзахыг бүгд харсан бөгөөд дараа нь поошигнууд асар хүчтэй дуу чимээ гарган дэлбэрэх нь тэр <...> “Ла-11с” онгоц бүр нисэх онгоцны буудлыг тойрон нисч тэр хавийн газрыг суман мөндөр буулгаж “усласны” дараа бөмбөгдөгч нисэх онгоцуудад зам тавьж өгөхийн тулд газардав” гэж ХАЧА-ийн цэргийн нисэгч байсан хүн дурсан ярьжээ.[1148] Бөмбөгдөгч онгоцууд ч 250 килограммын бөмбөгөөр байг маш мэргэн оножустгажээ. Энэ явдал хэзээ ч иймэрхүү зүйл харж байгаагүй түвдчүүдийг маш их айлгасан тул тэд тэр дороо л ХАЧА-д итгэж байгаагаа мэдэгдэж, зарим нь маогийн лоозон хашгирч байжээ.

Хятадын нууц баримт мэдээгээр бол 1952–1958 оныг дуусах хугацаанд армийнхан Ганьсу мужийн Канлхо тойрогт гэхэд л 996 бослого дарах үед 10 мянган партизан устгажээ.[1149]

1958 оны наймдугаар сард янз бүрийн үндэстний тариачид болон малчид Канлход “ангийнхаа ухамсрыг түргэн хугацаанд дээшлүүлжээ”.[1150] Тэд “шашны манцуйд өлгийдүүлсэн хувьсгалын эсэргүүчүүд, харгис этгээдүүд, шашны янз бүрийн бүлгийн заналт элементүүд, феодал ангийнхан, сүм хийдийн дарлан мөлжигчид болон зүсэн бүрийн хууль бус үйл ажиллагаатай гал халуун тэмцэл явуулж” эхэлжээ. Энэ тэмцэл хуучны, тэрч байтугай байгаль хамгаалах уламжлал, жишээлэхэд ариун дагшин ууланд уурхай ухах, өвс ургамал түүхийг хориглосон уламжлалыг бүрмөсөн эвдэж хаяхад чиглэжээ. Дээд ангийн хүмүүсийг “гэмт хэрэгт” холбогдуулан буруушааж,

“амьд Будда гэгчдийн тухай аймшигт үнэнийг илчлэх” олон нийтийг хамарсан”тэмцлийн цуглаан” зохион байгуулж байв. “Хүзүүнд нь зүүсэн гинжийг тас татаж хаясан” илчлэгчид Мао бол бидний “гайхамшигтай, шудрага эцэг” мөн билээ хэмээн тангараглан хэлэх ажээ. 1958 оны арван нэгдүгээр сар гэхэд Канлход шинэтгэлийг бүрэн хийж дуусчээ.[1151] Газар бүрт малчдын ардын коммунууд байгуулав. Тэнд “үндэсний цөөнхийн” 1500 кадр ажилтан, 1200 коммунист, 2200 комсомолын гишүүн, намын анхан шатны 26 байгууллагатай болсон байлаа. Тэд хуучирсан уламжлалтай тэмцэх хөдөлгөгч хүч болж байв. Арван нэгдүгээр сар гэхэд Амдогийн бараг бүх малчин хүмүүсийг коммунд хөөж оруулжээ.

1958 оны сүүлч гэхэд Сычуаньд ч бүрэн шинэтгэл хийжээ. 1958 оны намар гэхэд энэ шинэтгэл Сычуаний Түвд хүн амын 90 хувьд ялалтаар дууcч, Карзе тойрогт оны эцэс гэхэд шинэтгэлийг дуусгахаар төлөвлөсөн билээ гэж тус мужийн амбан захирагчийн орлогч тэмдэглэн бичжээ.[1152] Шинэтгэл хийхгүйгээр нийгмийг ангийн шинж чанараар хуваан авч үзэх боломжгүй, шинэтгэл бол “хүчээр хийх, хурц бөгөөд хамгийн нарийн ээдрээтэй ангийн тэмцэл юм”. Түвд, хуэй (дунган) зэрэг “хоцрогдсон” ард түмний хувьд хувьсгал онцгой чухал юм. Тэд дараачийн, социалист шинэтгэлийг түргэн хугацаанд хийж дуусгавал боолчлолоос шууд социализмд орж болно гэж амбан захирагчийн орлогч үзсэн байна.

Сычуань, Хөх нуураас гадна Ганьсу мужийн өмнөд нутгийн өмнөд хэсгийн нүүдэлчдийн дунд бослого хөдөлгөөн эхлэв. Амдогийн тал нутагт хийх залхаан цээрлүүлэх давшилтад ХАЧА-ийн морин цэргийг өргөн ашиглажээ. Зарим нутагт эр хүн бараг үлдээгүй ажээ.[1153] Мачу голоос зүүн тийш орших Сокпо хэмээх монголчууд голдуу суудаг нутгийн хүн амын олонхи үрэгдсэн юм гэж тэр үеийн үйл явдлыг нүдээр үзсэн нэгэн хүн ярьжээ. Шашныг эхний ээлжинд устгажээ. Лам нарыг хийдийнх нь хашаанд цуглуулж зогсоогоод пулемётоор галласан явдал ч гарч байжээ. Аугаа их Лабран хийдийнхэн бослогод оролцоогүй ч хаагдаж, юу ч үгүй хоосон сав болон хувирчээ. Тэндхийн гурван мянган ламын хоёр мянгыг баривчилж, тэдний 600-г Шинжааны бөөнөөр хорих лагерьт явуулсан байна.

Хятадууд 1958 онд Нансан (Ба) хийдийн лам нарт эхнэр авахыг шаарджээ.[1154] Лам нарын нэг хэсэг нь оргож, зарим нь алагдсан байна. Тус хийдээс холгүй газарт нэгэн даянч ганцаар амьдарч, жаазтай бурхадынхаа өмнө мөргөл үйлдэж суудаг байжээ. Гэтэл хятадууд хүрч ирээд мөргөл үйлдэхээ зогсож, эхнэр авч, ажил хийхийг түүнд шаардахад тэр лам татгалзжээ. Ингээд хятадууд тэр ламын зэс гуулиар хийсэн шашны бүх

эдлэлийг хураан авч, шавар цутгамал бурхадыг эвдэлж, судар номууды нь шатааж, ламыг олны өмнө пулемётоор буудан хороожээ.

Карзегийн Цогчин болон Шечен хийдэд хятадууд ирж, тэндхийн хамба ламыг барьцаанд авч, цуглаан хийлгэжээ.[1155] Шашны зэрэг цолоо хураалгаж, гэр бүлтэй болохыг лам нарт шаардав. Үүний дараа 2 сар шахам албадлагын ажил хийлгэж, бие биенээ "шүүмжлэхийг" шаардсан байна. Бурхадын зургийг газарт шидлэж, буу тулган дээр нь гишгүүлжээ. Эцэст нь хийдийн хамба болон том толгой лам нарын эсрэг "тэмцэх цуглаанд" оролцохыг шаардав. Үүнээс үүдэн бослого гарч, хятадууд бүгд, лам нараас тавиад хүн амь үрэгдсэн байна. Амьд үлдсэнгүүд нь партизануудтай нийлжээ. Ньингма чиглэлийн зургаан том хийдийн нэг болох Цогчин хийд (1675 онд үндэслэн байгуулагдсан) эвдрэн сүйджээ.

Хятадууд хэвлэл мэдээллээр хэрээс хэтэрсэн суртал ухуулга хийж байв. 1958 оны арван нэгдүгээр сард Карзе, Дарцедо, Сининд Түвд хэлээр гардаг сонинуудад шашин шүтлэгийг бүдүүлгээр дайран давшилсан материалууд гарч, Буддаг харгис этгээд хэмээн зарлажээ.[1156] Жишээ нь Карзегийн өдөр дутмын ("Карзе Ниларэ Саргьюсэр") сонинд 1958 оны арван нэгдүгээр сарын 18-нд: "Хийдүүд ямагт феодалууд болон тосны үйлдвэрийн эзэдтэй, тэрч байтугай империалистууд болон гоминьданы харгис хүчинтэй хуйвалдаж ирсэн. Хийдүүд эх орноо хувааж авахын тулд мужийн засгийн газар байгуулахыг оролдож ирсэн юм <...> Карзе гацаанд 390 хийд хууль бус үйлдэл, эсэргүүцлийн ажиллагаанд оролцож байна. Бүх хийд бол шашны баг өмссөн харгис хүчнүүд мөн. Хийдүүд бол дарлал мөлжлөгийн хэрэглүүр, язгууртан-феодалуудын түшиг тулгуур мөн, тэд бол шинэтгэлийн эсрэг бослогын төв мөн. Хэрэв тэднийг бүрмөсөн устгавал язгууртан-феодалын дарлал мөлжлөгийг устгана" гэж бичжээ.[1157]

Арван нэгдүгээр сарын 22-нд тэнд "Шашны эрх баригч бүлгийнхэнд хамаарах харгис хууран мэхлэгчдийн хар санааг тэвчихийн аргагүй" хэмээх гарчигтай том өгүүлэл нийтлэгджээ. Тэр өгүүллийн эхний өгүүлбэр л түүний санааг илтгэн харуулах бөгөөд: "Санваартны хувцас өмссөн эдгээр харгис лам нар хорт могойноос ч илүү үхлийн хортой, зэрлэг араатнаас ч илүү хэрцгий догшин амьтад" гэж бичжээ. Цаашаа маогийн уламжлалаар түүх рүү эргэж орсон аялал эхэлж: эцэг Буддагийн үед хөрш зэргэлдээх орнуудын эсрэг түрэмгий дайн хийж байсан, Буддагийн хаанчлалын үед албат иргэд нь түүний эсрэг босч байсан бөгөөд тэрээр ялагдал хүлээснийхээ дараа аглаг ойд гарч, хүмүүсийн эрэлхэг зоригийг мохоож, эрх мэдлээ сэргээхийн тулд гутрангуй үзэл сурталдах болсон юм гэх мэтээр бичсэн байна.[1158] Маогийн

суртал нэвтрүүлгийнхэн сурсан зангаараа худал гүтгэлэгийг “түүхэнд тов тодорхой тэмдэглэгдсэн баримт” хэмээн зарлах ажээ. Дараа нь сүм хийдийг баяжиж хөлжсөн дарлан мөлжигчид, мухар сүсэгтнүүд гэх зэргээр элдвээр зэмлэн буруушаана. “Миний итгэдэг бурхан бол коммунизм” хэмээх төгсгөлийн өгүүлбэр худал гүтгэлэгийн эх сурвалжийг илтгэн харуулах ажээ.

Гэсэн хэдий ч 1958 оны сүүлч гэхэд 80 мянган хүнтэй партизаны арми өмнөд түвдийн бүх тойрог, Зүүн түвдийн зарим хэсгийг хяналтандаа авсан байлаа. Дригутангт сайн дурынхан цугларч эхлэв.[1159] Тэд Кам, Баруун ба Умард Түвдэд ХАЧА-д өргөн фронтоор халдах ажиллагаа зохион байгуулж чаджээ. Хятадууд ялагдсан тухай мэдээг ухуулах хуудас хэлбэрээр Лхас хотын гудамжуудад наасан байв. Хятад эрх баригчид бослогыг цэргийн хүчээр дарахыг түвдийн сайд нарын зөвлөлөөс шаардав. Гэвч түвдийн засгийн газар хагаралтай байсан учир шийдвэр гаргаж чадсангүй.[1160] Засгийн газрын түшмэд бие биенийхээ эсрэг санал бодлоо илэрхийлэхээс эмээжээ. Түвд кадр ажилтнууд ардын коммун судлахаар Хятад руу явах гэж байгаа тухай 1959 оны нэгдүгээр сард зарлав. Энэ бол ардчилсан шинэтгэлийн бэлтгэл байлаа.

Кам, Амдогийн олон тооны “охин” хийдүүдийн эсрэг үйлдсэн гэсгээн цээрлүүлэлтэд “аугаа их хийдүүд” сэтгэл дундуур байв.[1161] Хоёрдугаар сарын 16-нд нүүдэлчдийн нэг удирдагч бослого хөдөлгөөнийг дэмжин ажиллахыг Далай лам болон сайд нарын зөвлөлөөс шаарджээ. Гэвч хангалттай тооны цэргийн хүчгүй, бас бээжингийн эрх баригчидтай сөргөлдөх сонирхолгүй түвдийн засгийн газар энэ шаардлагыг няцааж, бослогчдыг дэмжихгүй байхыг түвдийн армиас шаардсан байна. Дорнод түвдийн олон хүн үүнд дургүйцэв.[1162] Гэхдээ Лхасын эрх баригчид Бээжингийнхэнд туслах ямар ч бодит алхам хийгээгүй юм.[1163]

Улам олон Түвд хүн бослого гаргагчидтэй нийлэв. 1959 оны эхээр нүүдэлчдийн отрядууд Лхасаас өмнө тийш 200 км-ийн зайтай орших Цетан дахь 3 мянган хүнтэй хятад гарнизонд халдаж, тус хотыг эзэлж авсан байна.[1164] 1959 оны хоёрдугаар сарын сүүлчээр Лхокийн партизанууд Лхас руу явахаар шийдсэн байна.[1165] Хоол хүнс, эд хогшил, цэргийн хэрэгслээ авсан 500 хүнтэй цуваа нийслэлийг чиглэн хөдөлжээ. Удаан ч явсан байна. Тэд Лхас орох замдаа Энэтхэгийн радиогийн мэдээнээс тус хотод бослого гарсан тухай олж мэджээ. Гэхдээ тэд Далай ламыг Энэтхэгт очсоны дараа буюу дөрөвдүгээр сард л түүний оргож гарсан тухай олж мэдсэн ажээ.

Мао Зэдун 1959 оны нэгдүгээр сарын 22-нд дараах зааврыг өгсөн

байна: “Түвдийн районд дайсны тал ба манай тал хэдэн жилийн турш олон түмний дэмжлэг авахын төлөө уралдаж, зэвсэгт хүчнийхээ бэлэн байдлыг шалгах болж байна, дараа жишээ нь, 3-аас 4 жил, 5-аас 6 жил буюу 7-гоос 8 жилийн дараа гарцаагүй шийдвэрлэх тулалдаан болно. Тэр үед л асуудлыг бүрэн шийдвэрлэнэ. Эхний үед түвдчүүдийн цэргийн хүч маш сул байсан бол одоо тэд босогчдын 10 мянган хүнтэй хүч командалж байна, босогчдын санаа сэтгэл ч өндөр байна. Энэ бол бидний хувьд аюултай дайсан мөн. Гэхдээ энэ бол заавал муугаар эргэх зүйл бишээ: харин ч сайн талтай байж болох юм, яагаад гэвэл энэ нь асуудлыг дайн хийж шийдвэрлэх боломж олгох билээ”.[1166]

Мао бослого хөдөлгөөн хэрхэн өсөн нэмэгдэж байгааг ажиглаж, үүнийг нэг л байдлаар тайлбарлаж байв. Жишээ нь: “Иймэрхүү маягийн бослогууд бидэнд туйлын таатай нөлөө үзүүлнэ, яагаад гэвэл манай отрядуудыг дасгалжуулж, манай хүмүүсийг дасгалжуулахад туслаж, бослогыг даран сөнөөж, ирээдүйд бүх нийтийг хамарсан шинэтгэл хийх хангалттай боломж олгохоороо бидэнд ашиг тустай байх юм” гэж дүгнэсэн байна.[1167]

1959 оны гуравдугаар сард Дорнод Түвдэд партизаны 23 отряд, Өмнөд Түвдэд 16 отряд байсан бөгөөд партизануудын нийт тоо 100–200 мянгад хүрсэн байж болох ажээ.[1168] Гоминьданы баримт мэдээгээр бол нүүдэлчдийн отрядуудтай хийсэн тулалдаанд ХАЧА-ийн хүлээсэн хохиролыг алагдсан шархадсан хүнээр тооцож гаргахад 65–75 мянга болжээ.[1169]

1959 оны гуравдугаар сарын эхээр болсон Монламын баярын үед Лхаст байсан олон арван мянган дүрвэгчид дээр олон тооны мөргөлчид, түүний зэрэгцээ зэвсэглэсэн босогчдын бүлгүүд нэмэгджээ. Зарим мэдээгээр бол 100 мянга хүртэлх хүн цуглажээ. Байдал улам түгшүүртэй болж байлаа. Зарим байшингийн дээвэр дээр хятад цэргийн ажиглагч нар үзэгдэх болов. Дөрөвдүгээр сард нээгдэх Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Хурлын чуулганд оролцуулахаар Далай ламыг хүчээр авч явах юм гэнэ гэсэн цуу үг түвдчүүдийн дунд тарсан байв. Далай лам зөвшөөрөл өгөөгүй ч түүнийг Бээжинд очих болсон тухай гуравдугаар сард зарласан нь энэхүү цуу үгийг бүр ч ортой болгожээ.[1170] Тэгтэл ч хятадууд гуравдугаар сарын 10-нд цэргийн тойргийн штабт болох театрын үзүүлбэрт гэнэт урьжээ. Шашны тэргүүн дагалдах хүмүүсгүйгээр ирэх ёстой гэж хамгаалалтынх нь албаны даргад мэдээлсэн байна.[1171] Ингэсэн нь тогтсон протоколыг зөрчиж, Далай ламыг баривчлах төлөвлөгөөтэй байгааг илтгэн харуулав. Далай лам ийнхүү урьсан тухай гуравдугаар сарын 9-н хүртэл огт мэдээгүй байсан гэж хожим нь түвдийн олонхи кадр ажилтан нотолж байсан болович хятадын

эх сурвалжууд Далай ламд гуравдугаар сарын 7-нд энэ тухай мэдэгдсэн хэмээн нотолдог ажээ.[1172] Энэ урилга бослого гаргахад хүргэхийг Лхас дахь ХКН-ын түшмэд ч, ХАЧА-ийн дарга нар ч мэдээгүй юм гэж эдгээр эх сурвалжуудад өгүүлжээ.

Гэтэл тэр өдрүүдэд Норовлин хийдэд байсан төвдийн засгийн газрын түшмэл Тенпа Сопа надтай уулзахдаа хүмүүс энэ урилгыг дэндүү тулгасан зүйл хэмээн үзэж байсан юм, ер нь бол тийм урилгыг гол төлөв ядаж нэг сарын өмнө явуулдаг шүү дээ хэмээн ярьсан билээ. Хятадын командлагчид шашны удирдагчдыг ямар нэгэн баяр ёслолын ажиллагаанд урьдаг, харин тэр хүмүүс дараа нь сураггүй болдог тохиолдлууд гарч байсан болохоор хүмүүс ийнхүү сэжиглэсэн байж болох юм. Амдогийн том тушаалын лам Шаравжамц, Гончиг Лхүндэв нар тийм байдлаар алагдаж, Камд нэрд гарсан лам: Бандида Ши Чен алагдаж, өөр нэг Каток Ситу гэдэг лам баривчлагдсан ажээ.[1173] Урьд өмнө гарсан хоёр үйл явдал олны сэжигийг улам ч хүчтэй болгожээ. 1958 онд Далай ламтай уулзах гэсэн нэг хятад иргэнээс тэсрэх бөмбөг олж хурааж авчээ. 1959 оны нэгдүгээр сард гар буу нууцаар өвөртөлж явсан өөр нэг хятад хүнийг баривчилсан байна.

Далай ламыг хүчээр авч явахад саад хийхийн тулд гуравдугаар сарын 9-нд Норовлин ордны дэргэд төвдчүүд цуглаж эхлэв. Нэг мэдээллээр бол 10 мянга орчим[1174], өөр нэг мэдээллээр 30 мянган хүн цугласан ажээ.[1175] Хүмүүс гол төлөв бэрээ мод, хутгаар зэвсэглэсэн, заримд нь галт зэвсэг байжээ.[1176] Зарим партизан пулемёт, миномёт хүртэл авч иржээ. Төвд цэргийн хороо хятад цэргийн дүрэмт хувцасаа төвдийнхээр сольжээ. Тэр цэргүүд Далай лам, эх орныхоо талд байгаагаа мэдэгдсэн байна. Цугларагсад төвдийн тусгаар тогтнолын төлөө, хятадуудыг хөөж явуулахыг уриалсан ухуулах хуудас барьжээ.[1177] Гурван “аугаа их хийдийн” төлөөлөгчид ордноосоо гарахгүй, Төвдийн тусгаар ттогтнолыг тунхагласан өдөр ч хятадуудтай хамт хурал, цуглаанд оролцохгүй байж, янз бүрийн асуудал авч хэлэлцэх шашны болон иргэний засаг захиргааны төлөөлөгчид, “аугаа их хийдүүд”, арми, ард түмний төлөөлөгчид сонгохыг Далай ламд уриалав.[1178] Босогчид Энэтхэгийн Калимпонгт суугаа эх орон нэгтнүүддээ хоёр удаа цахилгаан утас явуулжээ. Эдгээр цахилгаан утсанд “хан үндэстний улаан коммунист намын” эсрэг бослого гаргасан тухай, Төвдийн тусгаар тогтнолыг сэргээх тухай өгүүлсэн байна. Босогчид Энэтхэгийн зүгээс дэмжлэг үзүүлж, НҮБ-ын ажиглагчид явуулахыг хүсэв. Энэтхэгт аж төрөн суугаа төвдчүүд эх орных нь хэрэгт хөндлөнгөөс оролцохыг энэтхэгийн эрх баригчдад ятгахыг эрмэлзжээ. Энэтхэгийн сониудад төвдийн бослогын тухай өргөн мэдээлэл



1959 оны гуравдугаар сарын 10-нд Норовлин ордны дэргэд цугласан түвдчүүд (DIIR Archive, Central Tibetan Administration)

тавьсан нь хамгийн хурдан илэрч гарсан үр дүн болсон байна.

Гуравдугаар сарын 10-ны өглөө Далай ламын гэр бүлийн зарим гишүүн, түүний хоёр багш, сайд нар, шашны зарим удирдагч, язгууртнууд штабт уригдаж ирсэн байна.[1179] Тэд мөргөлдөөнийг эв зүйгээр зохицуулж, Далай лам "боловсролгүй олон түмний" жагсаалаас болж хүрэлцэн ирж чадаагүйг тайлбарлах гэж эрмэлзжээ. Хятадууд ч түвдийн язгууртнуудын нэгэн адил Лхас хотод гарсан бослогод бэлэн биш байсан ажээ.[1180] Түвдийн язгууртнуудад зориулан штабт тансаг хүлээн авалт зохион байгуулсан байна. Энэ үед Норовлин ордны эргэн тойрон цугларсан олон ардын төлөөлөгчдийг сонгож, 70 хүний бүрэлдэхүүнтэй эрх чөлөөний хороо байгуулав. Тэднийг гурван "аугаа их хийдийн" тэргүүн нар, доод зиндааны

олон арван түшмэл, Далай ламын хамгаалалтын албаны офицерууд, түвдийн цэргийн зарим хэсэг дэмжжээ. 17 зүйлт хэлэлцээрт "урвагч Агваан Жигмэд" гарын үсэг зурсан, бас түүнийг хятадууд зөрчиж байгаа учир тэрхүү хэлэлцээр хүчингүй гэж дээр дурдсан хороо зарлав.[1181] Энэ хороо мөн түвдээс нэн даруй гарч явахыг хятадуудаас шаардсан тунхаглал бэлтгэсэн байна. Гуравдугаар сарын 10-нд түвдийн нэг сайд Норовлин ордны дэргэд цугларсан олонд зодуулж, цэргийн эмнэлэгт хэд хоног хэвтжээ.

Сайд нар гуравдугаар сарын 12-нд хятад цэргийн штабаас Норовлин ордонд очиж, босогчидтой хийсэн зөвлөлгөөнд оролцов. Тэд жагсаал цуглаанаа зогсоохыг босогчдын удирдагчдад ятгасан боловч бүтээгүй бөгөөд харин ч сайд нар гэрийн хорионд орсон байна.

Лхас хотын хятад гарнизон босогчдын хүчнээс дутуу буюу 1 мянга шахам хүнтэй байв. Гэхдээ энэ гарнизоны ард ХАЧА байсан, бас зэвсэг сайтай байсан юм. Тиймээс хоёр тал хүлээзнэсэн байр суурь баримталжээ. Хятадын засгийн газрын төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч генерал Тань Гуаньсэнь болон Далай лам гуравдугаар сарын 10–16-нд захидал солилцжээ. Эдгээр захидлын агуулгаас үзвэл генерал түвдийн удирдлагаар бослогчдыг дэмжүүлэх биш, төвийг сахисан байр суурь баримтлуулахыг, харин Далай лам нөхцөл байдлыг эв зүйгээр зохицуулахыг эрмэлзсэн байна.[1182]

Бослогчдоос эмээж болгоомжилсон 600–800 Түвд хүн Түвдийн Өөртөө Засах Орны Бэлтгэл хороо болон Лхас дахь ХАЧА-ийн байрлалуудад нуугджээ.[1183] Тэд дээрх хоёр байгууллагыг хамгаалахад хятадуудад туслав. Хятадын талын эх сурвалжаас үзвэл дээд давхаргын төлөөлөгчид болох хэд хэдэн Түвд хүн хятадуудыг дэмжжээ. Ингэхлээр бүх "дарлан мөлжигчид" боссон хэмээн хэлж болохгүй юм. Түвдийн нийгэм ангийн шинж чанараар хуваагдаагүй ажээ.

Энэ үед Мао Зэдун Бээжинд байгаагүй юм. Тэрээр Уханьд байцаан шалгах ажлаар явж байв. Хямралыг шийдвэрлэхийн төлөө гол хариуцлагыг Лю Шаоци хүлээж байсан юм.Тэрээр гуравдугаар сарын 11-ний орой болсон Жоу Эньлай, Дэн Сяопин, Пэн Жэн, Пэн Дэхуэй, Чэнь И, Ян Шанькунь, Сю Бинь зэрэг ХКН-ын удирдагчдын хурлыг даргалав.[1184] Тэд энэхүү хямралыг тийм ч их аюул биш, харин харгис элементүүдийг илрүүлж, шинэтгэл хийх нөхцөл бололцоо бүрдүүлэх боломж хэмээн үзсэн байна. Хятадын талын баримт мэдээллээр бол энэ хүмүүс ХАЧА залхаан цээрлүүлэх ажиллагаа явуулах биш, харин хяналт болон байлдааны бэлэн байдлаа дээшлүүлэнэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлжээ.

Далай ламын энхийг сахиулах хүчин чармайлт үр дүнд хүрсэнгүй.

Түвдийн засгийн газар нөхцөл байдалд хяналт тавьж чадсангүй. Лхас хотод дэлгүүр хоршоо дээрэмдэх явдал гарч байлаа. Босогчид Түвдийн бусад нутагт жагсаал, цуглаан зохион байгуулж, тэндээс тусламж авахыг эрмэлзэж, Лхас хот болон нисэх онгоцны буудлын хоорондох замд бэхлэлт байгуулав. Тэд Энэтхэг, Балбын төлөөлөгчдөд хандаж Түвдэд болж буй үйл явдлуудын тухай дэлхий дахинд мэдээлэх хүсэлт тавьсан байна.[1185] Гуравдугаар сарын 12-нд Лхас хотод олон мянган эмэгтэйчүүд оролцсон жагсаал болов. Хожим нь жагсаалд оролцогчдыг удирдсан хоёр эмэгтэйг хятадууд шоронд байхад нь цаазалсан байна.[1186]

1959 оны гуравдугаар сарын 12-нд Бээжин хотод ХКН-ын удирдагчдын хоёр дахь хурал болов.[1187] Хуралд оролцогчид мөн л ХАЧА хамгаалалтын байр суурь баримталж, түрүүлж гал нээхгүй байх ёстой гэж дахин мэдэгдэв. Нэмэлт хүч татахаар шийдвэрлэв. Мао энэ шийдвэрийг сайшаагаад Далай ламыг Лхаст саатуулаад байх хэрэггүй, энэтхэг рүү гарах боломж олгох нь зүйтэй гэж цохон тэмдэглэжээ. Хятадууд богино хугацаанд Лхас хотын эргэн тойронд үлэмж хэмжээний хүч, тухайлбал танк, их бууны ангиуд төвлөрүүлж чадсан байна. Гуравдугаар сарын 14-ний өглөө пулемёт ачсан цэргийн ачааны машины цуваа, араас нь танк орж ирэв.[1188] Энэ цуваа Норовлин ордноос зүүн тийш байх хятадын цэргийн хуаран руу явжээ. Лам нар нь сайн дурын журамт цэргийн отрят байгуулсан хийдүүд рүү хятадын туршуулууд явуулжээ. Лхас хотын оршин суугчид хятад цэргийн лагерийг эзэлж авсан бөгөөд лам нар хийдүүддээ үлдэх хэрэгтэй болсон юм байна гэж тэр туршуулууд ярьжээ.[1189]

Түвдийн төрийн үзмэрч улс орноосоо гарч явахыг Далай ламд зөвлөв.1959 оны гуравдугаар сарын 17-ны шөнө Далай лам, түүний эх, эрэгтэй дүү, охин дүү, багш нар, дөрвөн сайд, түшмэд болон бие хамгаалагчид Лхасаас нууцаар гарч, цөөн цөөнөөрөө хэсэг бүлэг болон Энэтхэгийн зүгт явжээ. Цангпогийн өмнөд эрэг хүрмэгцээ Далай лам болон түүнийг дагалдан яваа хүмүүс партизануудын хамгаалалтад орсон байна.[1190] Далай лам ийнхүү дүрвэсэн явдалтай холбогдуулан янз бүрийн цуу үг таржээ: Америкийн тагнуулын төв газар төрийн үзмэрчид түвдээс зугатаж гарах замыг нарийвчилж тодорхойлсон заавсрыг маш яаралтай хүргүүлсэн юм гэж нэг тийм таавварт өгүүлсэн байна. Гэхдээ бодит нөхцөл байдал ердийнхөөрөө л өрнөж: Тагнуулын төв газрын лагерьт ойр зуурын юм заалгасан хоёр Түвд хүнд радио дамжуулагч аппарат байсан ажээ. Гэсэн хэдий ч тагнуулын төв газар намайг оргуулах ажиллагаанд шууд оролцоогүй, үзмэрч ч энэ байгууллагатай холбоотой байгаагүй юм гэж Далай лам өөрөө

ярьжээ. Далай лам оргосон тухай мэдээг тагнуулын төв газар гуравдугаар сарын 19-нд Калькутта дахь төлөөлөгчийнхөө газраар дамжуулж мэджээ авсан байна. Тэр хоёр Түвд хүн хоёр өдрийн турш дүрвэгсдийг шамдуулан явуулсны дараа л тагнуулын төв газар руу өдөр бүр мэдээ дамжуулжээ.[1191]

ХКН-ын улс төрийн товчооны хуралдаан гуравдугаар сарын 17-нд Бээжинд болов. Түвдийн нийгмийн дээд хэсгийнхэн бослогод оролцсон болохоор шинэтгэл хийж эхлэхээс өөр сонголт байхгүй, бослогыг дарахад бэлэн байх хэрэгтэй юм гэж Лю Шаоци, Дэн Сяопин нар онцлон тэмдэглэжээ.[1192] Тэр өдөр хятадууд улс төрийн товчооны албан ёсны зааврыг зөрчин тус ордныг бууджээ. Норовлин ордноос хойш орших тээврийн станцад байсан ХАЧА-ийн нэгэн доод тушаалын офицер тэсвэр алдаж тус станц руу довтолсон босогчид руу галлах тушаал өгсөн ажээ.

Энэ зуурт Лхас хотын Босогчид 18-60 хүртэлх насны эрчүүдийг дайчлан татав.[1193] Босогчид: "Коммунист нам манай шашин, манай үндэстнийг устгах гэж хүсч байгаа болохоор арвайн гурилынхаа замбайг идэж, маань мэгзэмээ уншдаг [1194] манай цас мөсний хязгаар нутгийн бүх хүн нэгдэн нягтарч, шашин, үндэстнээ хамгаалахын тулд тусгаар тогтнолынхоо төлөө зэвсэг барин тэмцэх ёстой билээ" хэмээсэн уриалга гаргав.[1195]

300 шахам хүний бүрэлдэхүүнтэй Цонгдугийн (ардын холбоотнуудын) ассамблей бослогыг зохицуулж байсан боловч удалгүй лам-түшмэл Лувсан Цэвээн, түвдийн шинэ армийн анхны командлагч, тэр үед өвгөн буурал болсон Дасан Цэрэн нарт бослогын бодит удирдлага шилжжээ.[1196] Цэрэн үүнээс хэдэн сарын өмнө Далай ламыг хамгаалахаар Лхаст ирсэн байжээ. Бослого дарагдсаны дараа тэрээр олзлогдож, Лхасын шоронд насан эцэслэсэн байна.

Босогчид түвдийн армиас үлдсэн цөөн тооны нэгтгэлүүдийг Лхас хотын стратегийн байрлалуудад хувиарлажээ.[1197] Норовлин, Шол, Будалын ордон, Чакпори, Жоканг, Лубу, Рамочегийн районуудад бие даасан отрядууд оруулсан байна. Хятад эх сурвалжуудын мэдээлснээр бол Босогчид гуравдугаар сарын 19-ний шөнө Лхас дахь хятадын штаб[1198], Түвдийн Өөртөө Засах Орны Бэлтгэл хорооны ажлын комисс болон бусад байгууллагад халдсан боловч цохигдон ухарчээ. Хятадууд Далай лам алга болсныг мэдмэгцээ гуравдугаар сарын 20-ны шөнийн 2 цагт Норовлин ордныг их буугаар галлаж эхэлсэн байна.[1199] Тэнд байсан түвдчүүд ердийн буугаар хариу гал нээжээ.[1200] Хятадууд гуравдугаар сарын 20-ны үүрээр хагас эвдэрч сүйдсэн ордны цогцолборт дайран орж, Далай лам байгаа эсэхийг танихаар алагдсан хүмүүсийн хүүрийг шалгаж эхэлжээ. Тэнд амьд

үлдсэн 2–3 зуу орчим Түвд хүн олзлогджээ.

Гуравдугаар сарын 20-ны өглөө ХКН-ын удирдлага түвдийн асуудлаар ээлжит хуралдаан хийж, тийш нь нэмэлт хүч явуулахаар шийдвэрлэв. Өглөөний 9 цаг 30 минутад ХКН-ын цэргийн төв комисс Лхас хот дахь ХАЧА-ийн дарга нарт цахилгаан утас явуулав. Тийнхүү тус комисс бослогыг бүрмөсөн даран устгах “ногоон гэрэл” өгсөн байна.[1201] Стратегийн бүх чухал газруудыг хяналтандаа авч, дайсны умар болон өмнө зүгт ухрах замыг таслан хааж, нэмэлт хүч очсоны дараа бослогчдыг бүрмөсөн устгахын тулд тэдний гол хүчийг Лхаст үлдээхийн тулд бүх арга хэмжээ авахыг ХАЧА-ийн ангиудад үүрэг болгожээ. Хятадуудын тушаалаар Агваан Жигмэд Лхас хотын оршин суугчдад хандаж бууж өгөхийг уриалаад эс тэгвээс нийслэл хот чулуун овоо болж хувирна хэмээн анхааруулжээ.[1202]

Нийслэлийг их буугаар буудсан хэвээр байлаа. Хот, түүний сүмүүд, ойролцоох хийдүүдийг галлах ажээ. Будалын ордон тэр чигээрээ утаа, шорооны цаана орон харагдахаа больж, түүнийг бүхэлд нь бөмбөгджээ гэсэн сэтгэгдэл төрөхөөр байв. Үнэндээ ч Сэра хийдийн зарим байшин, Чакпорын эмнэлэгийн сургууль эвдрэн сүйдэж, Жокан сүмийн алтан ганжир цоо буудагдаж, Будалын ордны баруун жигүүр нилээд их гэмтжээ. Дрепун хийдийг их буугаар галласны дараа тэнд үлдсэн бүх ламыг баривчилжээ.[1203] Норовлин ордны өмнүүр урсдаг голыг гатлах үед олон Түвд хүн амь үрэгджээ.[1204]

Дараа өдөр нь Лю Шаоци Бээжинд намын удирдлагын бас нэг хурал хийлгэв. Энэ хурлын дүнгээр “түвдэд гарсан бослогыг дарах замаар ардчилсан шинэтгэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон улс төрийн зарим асуудлаар гаргах шийдвэр” баталсан байна.[1205] Энэ баримт бичиг ёсоор бол бослогыг дарахтай нэгэн зэрэг шинэтгэл хийх ёстой ажээ. Гуравдугаар сарын 22-нд Лхас хотод зэвсгээ хураалгахыг чанга яригчаар уриалж эхлэв. Бууж өгсөн хүмүүст өршөөл үзүүлнэ хэмээн амлав. Жокан сүмийг хамгаалж байсан түвдчүүдэд:хэрэв бууж өгөхгүй бол уг сүмийг эвдлэн сүйтгэнэ гэж сүрдүүлэв.[1206] Хятадууд давшилтад орж, гуравдугаар сарын 23 гэхэд Лхас хотыг бүхэлд нь эзлэв. “Би хятад цэргээр дүүрсэн гудамжуудаар явж байлаа: цэргүүд орилолдож, харсан зүг ирүүгээ галлах ажээ. Будалын ордон руу их буугаар буудна. Энэ ордон удахгүй газрын хөрснөөс арчигдах нь дээ гэж надад бодогдож байсан... Хятадууд хоёр цагийн турш галласан хэвээр байлаа. Үүний дараа Будалын ордны лам нар уулан дээрээс хар хурдаараа бууж ирж байгаа нь хятадын пулемётын галын бай болох нь дээ хэмээх сэтгэгдэл төрүүлэх ажээ. Хоёр эмэгтэй, нэг эр хүн хотын төв рүү орох

гудамжаар бууж өгч буйн тэмдэг болгож цагаан алчуур даллан алхаж явтал дөрөв, таван удаа буудах шиг болсон бөгөөд тэр гурван хүн гартаа цагаан алчуураа барьсан хэвээр зам дээр хэвтэж үлдсэн юм. Будалын орднoос холгүй орших нэгэн хийдэд гараа дээш өргөсөн гуч орчим Түвд хүнийг буу шагайн тууж яваа хятадуудыг би харсан юм. Цэргүүд тэр лам нарыг нэгжсэн боловч буу зэвсэг олоогүй. Би энэ хүмүүсийг суллаж явуулах нь дээ гэж бодсон маань эндүүрэл болж: тэр хүмүүсийг зогсож байсан газарт нь нэгийг ч үлдээлгүй буудан хороохыг нүдээрээ харсан билээ" гэж Лхас хот дахь энэтхэгийн консулын газрын ажилтан дурсан бичжээ.[1207]

Түүхэнд анх удаа Будалын ордон дээр хятадын далбаа хатгав. 1959 оны гуравдугаар сарын 30-нд мэдээллийн Синьхуа агентлаг Лхас хотоос: "Гэрэл гэгээ, аз жаргалын билэг тэмдэг болсон Хятадын үндэсний далбаа Лхас хот дээр намиран хийсч, эртний энэ хот сэргэн мандаж буй үйл явдалд баяр хүргэж байна" гэж мэдээлжээ.[1208]

Гэвч тэрхэн үедээ энэ хотын гудамжууд алагдсан эр, эм хүмүүс, жаахан хүүхдүүдийн хүүрээр дүүрсэн байлаа. Гудамжинд хэд хоносон зарим тийм шарилыг золбин ноход болон тас шувуу зулгаах ажээ. Хүмүүс цагаан даавуу барин гудамжинд гарч, төрөл төрөгсөд болон танил хүмүүсээ таньж олохын тулд тэдгээр шарил дундуур явах ажээ. Зарим хүн Рамоче сүмд гарсан галыг унтраах гэж эрмэлзэнэ. Хятадууд "самуун дэгдээгчдийг" эрэх ажээ. 4–5 цэргээс бүрдсэн хэсгүүд заримдаа хэлмэрч дагуулан айл айл хэсэн нэгжинэ.

Босогчдын олонхи нь цэргийн хэрэгт суралцаагүй, бас туршлагатай дарга наргүй учир их хохирол хүлээжээ.[1209] Түвдийн талын гаргасан мэдээгээр бол 10–15 мянган Түвд хүн алагдаж, 20 мянган хүн олзлогджээ. Лхаст олонхи эрчүүд, бас олон эмэгтэй хүн баривчилсан гэж хүмүүс ярьж байв.[1210] Тэднээр хэрэг "хүлээлгэх" гэж эрмэлзэж байлаа. Далай ламын бие хамгаалагч байсан хүмүүс болон гэрээс нь зэвсэг олдсон түвдчүүдийг олны өмнө цаазлан хороов. Хятадын талын мэдээгээр бол гуравдугаар сарын 23-н хүртэлх хугацаанд дөрвөн мянган бослогч, 8 мянга гаруй винтов, 81 хөнгөн ба хүнд пулемёт, 27 миномёт, 6 уулын их буу, 10 сая сум олзолж авчээ.[1211] Хурдан хугацаанд ялалт байгуулж, их хэмжээний зэр зэвсэг, олон тооны хүн олзолж авснаас үзвэл хятадууд түвдийн засгийн газрын зэвсгийн агуулахыг мэдэлдээ оруулсан нь тодорхой байгаа юм.[1212] Түвдчүүд тулалдаанд үнэхээр цөөн, муу зэвсэгтэй байжээ. Түвдийн талын (босогчдын олонхид галт зэвсэг ч байгаагүй) болон хятадын (Лхаст 7 мянга шахам бослогч, ХАЧА-ийн нэг мянган цэрэг байсан) талын мэдээ үүнийг гэрчлэн харуулж байгаа юм.[1213]

Гуравдугаар сарын 25-нд Шанхайд улс төрийн товчооны өргөтгөсөн

хуралдаан болов. Лхаст бослого гарснаас хойш анх удаа ХКН-ын бүх удирдагч хамт цуглажээ. Өнгөрсөн 8 жилд төв засгийн газар болон ХАЧА түвдэд 17 зүйлт Хэлэлцээрийг сайн санааны үүднээс мөрдөж ирсэн, харин түвдийн дээд давхаргынхны бүлэглэл "Хэлэлцээрийг тас татаж, эх орноосоо урваж, төв засгийн газрыг эсэргүүцэхийн тулд хүч хэрэглэж, ХАЧА-д халдсан юм" гэж Дэн Сяопин мэдэгджээ.[1214] "Одоо манай лоозон бол ардчилал, социализмын шинэ Түвд орныг цогцлон байгуулах явдал мөн" гэж Дэн мэдэгджээ.

Хятадууд давшилтаа үргэлжлүүлэн гуравдугаар сарын 28 гэхэд Нгари, Гьянзе, Паро, Ятун, Нетон, Линьжи, Чамдо, Чаюемийг эзлэв. Энэ өдөр БНХАУ-ын төрийн зөвлөл Далай ламыг Босогчид хүч хэрэглэн авч явсан юм гэж мэдэгдсэн байна. Банчин ламыг бэлтгэл хорооны даргын үүрэг гүйцэтгэгчээр томилов. Хятадууд Далай ламын хойноос нэхүүл явуулсан боловч түвдчүүд тэднийг саатуулж чадсан байна. Хүмүүс газар сайгүй Далай ламынханд туслаж, шар тос, арвайн гурил болон бусад хүнсний бүтээгдэхүүн өгч байлаа. Далай лам ийнхүү гадагш гарах гэж байгаа явдалд хүмүүс үнэн сэтгэлээсээ гашуудаж байв. Хожим нь энэ хүмүүсийн олонхийг эсэргүүцлийн хөдөлгөөнийг дэмжсэн хэмээн буруутгажээ.Үнэн чанартаа бол энэ нь шашны шинж чанартай тусламж-хүндэтгэлээ илэрхийлсэн бэлэг ажээ.[1215]

Бослого зохион байгуулах, Далай ламыг оргуулахад америкийн тагнуулын төв газар ч, Калимпонг дахь түвдийн цагаач иргэд ч оролцоогүй юм.[1216] Тэд ч, партизаны отрядууд ч Лхаст болсон хэрэг явдалд бэлэн биш байжээ. Тийнхүү хятадууд (ачааны 300 машин цэрэг) нийслэл рүү явж байсан партизануудын цуваанд халдаж[1217], партизанууд ялагдсан байна. Партизануудын хяналтын хүрээ багасав. Дөрөвдүгээр сарын 12-нд партизануудын гол түшиц газруудын нэг болох Цона хотын хохирол онцгой хүнд тусчээ. Хятад эх сурвалжуудаас үзвэл ХАЧА түвдчүүдийн бослогыг дарж байх үед ЗСБНХУ партизануудын шилжилт хөдөлгөөний тухай тагнуулын чухал мэдээллээр БНХАУ-ыг хангаж байжээ.[1218] 1959 оны гуравдугаар сард хятадын эрх баригчид бослогыг дарж буй явцын тухай зөвлөлтийн удирдлагад мэдээлж байжээ.

Зарим хийд, байгууллага, багтаамж ихтэй том байшингууд болон Норовлин ордон хүмүүсийг түр хугацаагаар хорих шорон болж хувирчээ. Түвдийн засгийн газрын баривчлагдсан гишүүд болон сүм хийдийн тэргүүн нарын олонхийг хятадын цэргийн штабт байрлуулав.[1219] Хожим нь тэдний олонхийг Ганьсу мужид төмөр зам тавих ажилд явуулж, үлдсэн хэсгийг янз

бүрийн шорон,хорих лагеруудад тараажээ.

Гуравдугаар сарын 28-нд ерөнхий сайд Жоу Эньлай Түвдэд гарсан бослоготой холбогдуулан гаргах Төрийн Зөвлөлийн зарлигт гарын үсэг зурав.[1220] Уг зарлигт: “ Түвдийн орон нутгийн засгийн газрын олонхи сайд, Түвдийн эрх баригч харгис бүлгийнхэн империалистуудтай хуйвалдаж, самуун дэгдээгч дээрэмчдийг цуглуулан үймээн самуун дэгдээж, ард түмэнд хохирол учруулан Далай ламыг авч явж, Түвдийг энх тайвнаар чөлөөлөх арга хэмжээний тухай 17 зүйлт Хэлэлцээрийг тасалдуулж, гуравдугаар сарын 19-ний шөнө Лхас хот дахь ХАЧА-ийн ангиуд руу орон нутгийн Түвд цэргүүд болон самуун дэгдээгчдийн хийсэн өргөн давшилтыг тэргүүлсэн юм” гэж өгүүлжээ.[1221] Энэ зарлигаар “түвдийн орон нутгийн засгийн газрыг” тарааж, 18 Түвд хүнийг Түвдийн өөртөө засах орны Бэлтгэл хорооноос хасч, тэднийг “эх орноосоо урвагчид” хэмээн үзэж шийтгэхийг тушааж, 16 хүнийг (тэдний тав нь хятад) Бэлтгэл хорооны бүрэлдэхүүнд оруулжээ.Намын удирдагчид “үймээн самууныг хамгийн түргэн хугацаанд дарж, төр улсын батлан хамгаалалтыг бэхжүүлж, нийгмийн хэв журам сахиулахад” ХАЧА-д туслахыг Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороо, “түүний удирдлагад байх Түвдийн санваартнууд болон энгийн хүн амд” уриалсан байна. “Шинэ, ардчилсан, социалист Түвд улс байгуулахын төлөө тэмцэхийг” зарлигийн төгсгөлд түвдчүүдэд хандаж уриалжээ.

Мөн өдөр мэдээллийн Синьхуа агентлаг Бээжингийн эрх баригчдын үзэл бодлыг тайлбарласан Түвдийн “бослогын” тухай мэдээлэл дамжуулжээ.[1222] Түвдийн сайд нараас хоёр “эх оронч” байсан бөгөөд тэдний нэгийг “самуун дэгдээгчид” шархдуулсан юм. Үлдсэн дөрвөн сайдын нэг нь 1957 онд Калимпонг руу оргож, нөгөө гурав нь “эх орноосоо урвасан юм” гэж уг мэдээнд өгүүлжээ. Энэ “урвагчид” бослогоос өмнө Лхаст харгис хүчнийг нэгтгэж, бослогод тус болж байсан гэж хятадууд үзсэн байна. Мөн 1958 оны тав-зургадугаар сард Босогчид түвдийн “орон нутгийн засгийн газар болон харгис үзэлт дээд бүлгийнхний” зааврааар Нагчу, Лхокийн районд дэг журам зөрчих болсон юм гэж мөн хятадын талын мэдээнд өгүүлжээ. Төв засгийн газар самуун дэгдээгчдэд шийтгэл оногдуулахыг “орон нутгийн засгийн газарт” хэд хэдэн удаа уриалсан боловч ийм арга хэмжээ аваагүй юм. Ингээд самуун дэгдээгчид “Лхаст хүчээ төвлөрүүлэн гуравдугаар сарын 10-нд 17 зүйлт Хэлэлцээрийг зөрчсөн юм гэж мөн мэдээнд өгүүлсэн байна. Түвдийн засгийн газар болон Далай ламыг одоо ч ийнхүү зэмлэн буруушаасан хэвээр байна.[1223]

Энэ бол ул үндэсгүй зэмлэл юм. Далай лам болон сайд нарын зөвлөлийн

зүгээс бослогчдод тусламж үзүүлээгүйг Гомбодаш дурдатгал номондоо тэмдэглэсэн байна. Үнэндээ бол бослогыг санаачлагч хэмээн хятадуудын зарласан түвдийн гурван сайд дайсагнагч талуудын хооронд эвлэрэл тогтоохыг эрмэлзэж байсан бол дөрөвдэхь сайд хилийн чанадад байсан учир засгийн газрын үүргийг биелүүлж чадаагүй ажээ. “Түвдийн районы удирдагчид зарим нэг тохиолдлыг эс тооцвол Дорнод Түвд дэхь хятадын эсрэг ажиллагааны гадна талд үлдсэн юм. ...Бослогыг түвдийн армийн хүчээр дарах тухай түвдийн засгийн газарт дэвшүүлсэн хятадуудын шаардлага ерөөс хэрэгжих боломжгүй байсан, яагаад гэвэл армид хятадын эсрэг санаа бодол их байсан юм.....Түвдийн “орон нутгийн засгийн газар” бослогыг голлон санаачлагчдын нэг мөн гэдэгт эргэлзэх нилээд жинтэй үндэслэл бий билээ. ...Далай лам бослогыг санаачлагч биш төдийгүй харин ч хамгийн идэвхтэй эвлэрүүлэгчдийн нэг байсан юм... Орон нутгийн засгийн газрын сайд нар яагаад ч бослогыг санаачлагч, удирдагч байж чадаагүй ажээ.”[1224]

Тийнхүү ХКН-ын удирдлага ардчилсан шинэтгэл гэгчийн хортой нөлөөг ч, “харгис дээд бүлгийнхэн” биш, харин ард түмэн боссон тэр баримтыг ч хүлээн зөвшөөрөөгүй юм. Ингэхийн оронд намын удирдлага 17 зүйлт Хэлэлцээрийг тасалдууллаа гэж түвдийн засгийн газрыг ул үндэсгүй буруутгаснаараа энэхүү хэлэлцээрээс өөрсдөө татгалзаж буйгаа хуульчлахыг эрмэлзжээ. “Түвдийн орон нутгийн засгийн газрыг” тараав. Түүний үүргийг Түвдийн Өөртөө засах орны бэлтгэл хороонд шилжүүлжээ. Өөрөөр хэлбэл түвдийн засгийг солих гэсэн санаа бодлоо гүйцэлдүүлж, ардчилсан шинэтгэл гэгчийг хэрэгжүүлэх эрх чөлөөтэй болж авчээ.

Ямар ч байсан 1959 оны гуравдугаар сарын 28-нд БНХАУ-ын эрх баригчид өөрсдийнхөө тулган хүлээлгэсэн Хэлэлцээрийг иш татдаг байсан боломжоо алдаж: энэ өдрөөс эхлэн уг хэлэлцээр хятадуудын санаачлагаар хүчингүй болжээ. Ингэхлээр нөхцөл байдал хэлэлцээрийн өмнөх үед,өөрөөр хэлбэл түвдийн бие даасан байдалд эргэж оржээ гэсэн үг юм. Ингэхлээр 2009 оноос гуравдугаар сарын 28-нд гэж товлосон “хамжлагын боолчлолоос чөлөөлөгдсөн өдөр” үнэхээр хоёрдмол утга агуулгатай болж байгаа юм.

17 зүйлт Хэлэлцээр хүчингүй болсныг хятадын дараах баримт бичгүүдэд тусгажээ. 1959 оны дөрөвдүгээр сарын 8-нд “гуравдугаар сарын 28-ны өдрийн Төрийн зөвлөлийн тушаалыг хэлбэрэлтгүй биелүүлэх тухай Түвдийн өөртөө засах Орны бэлтгэл хорооны шийдвэр” гарав. Энэ тушаалыг эрс шийдлвэртэй, бүрэн дүүрэн биелүүлэх ёстойг уг баримт бичигт онцлон тэмдэглэжээ. Цэргийн эрх баригчдад очиж бүртгүүлэн зохих байгууллагаас ирэх шийдвэрийг хүлээж суухыг түвдийн хуучин засгийн газрын засаг



Арван дөрөвдүгээр Далай лам Данзанжамц, түүний дүү Данзанчойжил нар бараа бологчдынхаа хамт Энэтхэг рүү дүрвэн гарч байгаа нь (DIIR Archive, Central Tibetan Administration)

захиргааны байгууллагуудын бүх ажилтанд тушаасан байна. Бүх оршин суугчдад ХКН, төв засгийн газрын удирдлага дор нэгдэн нягтарч, ХАЧА-ийг дэмжиж, “ардчилсан, социалист шинэ Түвд улс байгуулахын төлөө тэмцэхийг” дахин үүрэг болгожээ.[1225] Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн Хурлын анхдугаар чуулганы 1959 оны дөрөвдүгээр сарын 28-ны өдрийн тогтоолд “бослогыг” дарж, “түвдийн орон нутгийн засгийн газрыг” тараасны дараа Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хорооны удирдлагаар орон нутгийн засаг захиргааны байгууллагууд бий болгож, “шинэтгэлийг хэрэгжүүлэх тухай түвдийн ард түмний өргөн олны шаардлагыг амжилттай хэрэгжүүлэх” боломж бүрдсэн юм гэж цохон тэмдэглэжээ.[1226] Орон нутгийн засгийн эрх барих байгууллагуудыг татан буулгаж, түүний оронд хятадын цэргийн хяналтын хороодыг газар сайгүй байгуулж эхлэв. Эдгээр хороо засаг захиргааны шинэ бүтэц байгуулах ажилд орсон байна. ХАЧА-ийн цэргийн албан хаагчид, “орон нутгийн эх оронч үзэл санаатай оршин суугчдыг” эдгээр хороодод оруулахаар шийдвэрлэсэн байна.[1227]

Арван дөрөвдүгээр Далай лам болон түүний бараа бологчид БНХАУ-ын Төрийн зөвлөлийн тушаалын тухай гуравдугаар сарын 29-нд олж мэдмэгцээ

шууд шинэ засгийн газар байгуулав.[1228] Албан ёсны тангараг өргөх ёслол хийв. Далай лам болон түүнийг дагалдан яваа хүмүүс гуравдугаар сарын 31-нд Энэтхэгт очжээ. Тэнд Далай лам хэвлэлийн бага хурал хийлгэж: "Би хаана байх нь хамаагүй миний засгийн газрыг дагалдсан түвдийн ард түмэн биднийг түвдийн засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрч байгаа юм" гэж мэдэгджээ.[1229] Тийнхүү түвдийн засгийн газрыг татан буулгасан тухай БНХАУ-ын Төрийн зөвлөл зарласны маргааш өдөр Түвдийн загийн эрх барих хууль ёсны дээд байгууллага дахин бий болжээ.

1959 оны дөрөвдүгээр сарын 8-нд ХАЧА-ийн ангиуд Цангпо голыг гаталж, гурван цуваагаар өмнө зүгт давшив. Энд хэд хэдэн тулалдаан болж, түвдчүүд ялагдал хүлээв. Хятадын талын мэдээгээр бол 10 өдөр байлдахад 2 мянга шахам "үймээн дэгдээгч" этгээд алагдаж, шархадсан буюу олзлогджээ.[1230] Партизануудын гарт орсон ХАЧА-ийн нууц илтгэлээс үзвэл 1959 оны гуравдугаар сараас аравдугаар сар дуустлах хугацаанд Лхас хот болон түүний ойролцоох газруудад 87 мянган Түвд хүн устгажээ.[1231] Бас 25 мянган хүн баривчлагдсан байна.[1232] Нийтдээ 20 мянган "үймээн дэгдээгч" байсан гэж Синьхуа хороо мэдэгджээ.[1233] 87 мянган хүн алагдсан тухай too баримтыг хятад судлаач зарим мэрэгжилтэн тайлбарлахдаа үгчлэн орчуулахад "устгах, газрын хөрснөөс арчих" хэмээх санаа илэрхийлдэг "сяомэ" гэдэг хятад үг энд "баривчлагдсан","устгагдсан" хэмээх санаа илэрхийлж байна гэж үздэг ажээ. Энэ тайлбар ойлгомжгүй байна. Тэгэхдээ тулбал "алах" гэдэг үгийг ч шилжсэн утгаар ойлгож болох ажээ:цэргийн тайлангийн хэл тов тодорхой бөгөөд нэг л утгаар ойлгогдох ёстой билээ.[1234] Хятадын талын баримт мэдээгээр бол 1959–1961 онд ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд 93 мянган бослогч, өөр нэг мэдээгээр бол 1959–1960 онд 81 мянган хүн алагдаж, шархдаж олзлогджээ.[1235]

1959 оны гуравдугаар сараас хойшхи нэг жилийн дотор 80 мянган Түвд хүн Балба, Бутан, ялангуяа Энэтхэгт дүрвэж очсон байна.[1236] Түвдийн түүхэнд ийм явдал болж байгаагүй ажээ.1959 оны дөрөвдүгээр сарын 18-нд Далай лам Энэтхэгийн Тезпурт мэдэгдэл нийтлүүлж, Энэтхэгт дүрвэж ирсэн шалтгааныхаа тухай тайлбарлажээ.[1237] 17 зүйлт хэлэлцээрт шахалтаар гарын үсэг зурсан, яагаад гэвэл түвдчүүдэд үүнээс өөр зам байгаагүй юм. Хятадууд энэхүү хэлэлцээрийг байнга зөрчиж ирсэн. Түвдийн засгийн газарт өчүүхэн төдий ч бие даасан эрх байгаагүй. Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хороо эрх мэдэл багатай, бүх чухал шийдвэрийг хятад түшмэд гаргадаг байсан юм. Хятад цэргүүд бослого дарах үед аллага үйлдэж, энд тэндгүй эвдлэн сүйтгэсэн. Далай ламын анхаарал тавих гол үндсэн асуудал бол

ард түмнийхээ сайн сайхан байдлыг хангаж, шашнаа мөнхөд цэцэглүүлэн хөгжүүлж, эх орноо эрх чөлөөтэй байлгах явдал мөн гэж тэрхүү мэдэгдэлд өгүүлсэн байна. Тэр үеэс хойш Далай лам энэхүү Хэлэлцээрийг хууль бус хэмээн үзэх хэрэгтэй бөгөөд Түвдийн тусгаар толгтнолыг сэргээн тогтоохын төлөө би тэмцэх болно гэж мэдэгдэж иржээ.[1238] Зургадугаар сарын 20-нд Далай лам хэвлэлийн бага хурал хийлгэж, би болон манай засгийн газар 1950 он хүртэл Түвд улсын бие даан эдэлж байсан бүх эрх,бүрэн эрхийг хангах нөхцөлд л асуудлыг энх тайвнаар зохицуулах алхам хийхэд бэлэн байна гэж мэдэгджээ.[1239] Түвдчүүд НҮБ-д хандахаар шийдлээ гэж тэрээр есдүгээр сарын 5-нд мэдэгджээ.

Үүнээс хойш удалгүй Малай, Ирланд улсууд түвдийн асуудлыг НҮБ-ын 14-р чуулганы хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулж чаджээ. Социалист эвслийн гишүүн орнуудын төлөөлөгчид энэ асуудлыг хэлэлцэхэд саад тавьсан байна. Хятадын төлөөлөгч (энэ бол тайбэйн засгийн газрын төлөөлөгч байв) “түвд бол Хятадын нэг хэсэг мөн” гэж мэдэгдсэн боловч тэнд коммунистууд хүний эрх зөрчиж байгаа тухай асуудлыг авч хэлэлцэх санал оруулжээ.[1240] НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1959 оны аравдугаар сарын 21-нд 1353-р тогтоол гаргав. Энэ тогтоолд Ерөнхий Ассамблей: “1) НҮБ-ын Харти болон хүний эрхийн түгээмэл тунхаглалд илэрхийлсэн зарчмуудыг хүндэтгэх явдал хууль ёсонд үндэслэсэн энх тайван байдал тогтоохын үндэс мөн хэмээн итгэл төгс байдгаа нотлож; 2) түвдийн ард түмний үндсэн эрх, түүнчилэн энэ ард түмний соёл,шашныг хүндэтгэхийг уриалж байна” гэж өгүүлжээ.[1241] Тогтоолыг батлахад 42 улс дэмжиж, 9 улс (соц.орнууд) эсэргүүцэж, 26 улс түдгэлзсэн байна.

Хятадын эрх баригчид олон хүн Энэтхэг рүү дүрвэн гарч байгаатай холбогдуулан энд тэндгүй цуглаан зохион байгуулж, хүмүүсийг халуун орны уур амьсгал, халуун хумхаа өвчин,капиталист байгууллаар айлган сүрдүүлж эхэлжээ.[1242] Хятад улс хөрш зэргэлдээх орнуудыг “чөлөөлөх” явдал ойрхон байгаа явдал ч ингэх шалтаг болжээ. Гэвч тус болсонгүй. Эхний үед буддын болон бон шашныг баримтлагчид хилийн чанад руу гарч байсан бол жилийн дараа аллага хядлагыг тэсч чадахаа больсон ислам сүсэгтнүүд ч ийнхүү дүрвэж эхэлжээ.[1243] Хятад түшмэд эд хөрөнгөө л түвдэд үлдээж байвал исламын аль ч оронд цагаачлан гарахыг тэдэнд санал болгож байв. Эд хөрөнгөө авахыг шаардсан хүмүүст эсэргүүцэл зарлаж, тэдэнд хоол хүнс худалдахыг хоригложээ. Үүнээс болж ислам сүсэгт өвгөд хөгшид болон бага насны хүүхдүүд өлсөж үхэх явдал гарч байв. Зарим хүн Кашмир рүү явахыг эрмэлзэхдээ Энэтхэгт очино. Нөгөө хэсэг нь Саудын

Арави, Турк, Балба руу тэмүүлнэ. Гадагш гарч чадаагүй зарим Түвд хүн зэвсэг хэрэглэх буюу голын ус руу үсрэх зэргээр амиа хорлох ажээ.

Хүний эрхэнд ороогүй үлдсэн хүн бас олон байлаа. Амдо муж, тэр ч байтугай Баруун Түвдийн зарим хэсэг жил шахамын турш партизануудын хяналтад байв. Энэтхэг, Балбатай залгаа түвдийн хил дээр 1960 он гэхэд 4 мянга орчим партизан төвлөрсөн байлаа.[1244] 1961–1962 онд 100–200 хүний бүрэлдэхүүнтэй бүлгүүд Түвдэд 100 хүртэлх км-ийн гүнд нэвтрэн орж, булаан эзлэгчдэд халдаж, зэр зэвсэг олзлон авч байв.

1960 оны гуравдугаар сард Тайваны ерөнхийлөгч Чан Кайшигээс партизануудад явуулсан илгээлт бичигт: "Жу Дэ, Мао Зэдуны коммунист дээрэмчдийн тоглоомын засгийн газар коммунизм, харгис хүчнийг эсэргүүцсэн танай хөдөлгөөнийг аллага хядлага, харгислалын хүч хэрэглэсэн харгис аргаар нухчин дарж, хяналтандаа оруулахыг эрмэлзэж байна. Коммунист дээрэмчдийн араатны цэргийн хүч танай сүм хийдүүдийг эвдлэн нурааж, танай хот тосгодыг тонон дээрэмдэж чадах боловч та нарын хувьсгалт зориг эрмэлзэл, шашны итгэл үнэмшлийг хэзээ ч эвдэж чадахгүй гэдэгт би итгэл төгс байна" гэж өгүүлжээ.[1245]

Хятадын талын баримт мэдээгээр бол 1960 оны сүүлч гэхэд босогчдын томоохон отрядууд үндсэндээ ялагдаж, 1962 оны гуравдугаар сар гэхэд Түвдэд бослого хөдөлгөөн зогсчээ. Дээрх мэдээллээр бол босогчдын 70 хувь олзлогдсон буюу бууж өгч, цөөн тооны хүн шархдаж, нилээд хэдэн хүн алагдаж, харин ХАЧА-ийн хохирол гэвэл 1551 хүн алагдаж, 1987 хүн шархаджээ.[1246]

Гэвч түвдчүүдийн хохирол илүү байх ёстой,яагаад гэвэл тэд зэвсэг муутай, Босогчид Энэтхэг рүү гарах гэж явсан болохоор гэр бүлийн гишүүдтэйгээ хамт байсан юм. Хятадууд хэт давуу хүчтэй байв. Түвдчүүд тархай бутархай, энд нэг, тэнд нэг замбараа муутай бослого гаргах ажээ. Х Банчин лам:[1247] "Эхний үед түвдийн нутагт гарсан бослогын олонхи нь нутгийн омог аймгуул болон хөдөө тосгодын үймээн самуун төдий л байсан юм. Гол баазуудад халдлага үйлдээгүй юм. Түүнээс гадна тэр бослогчдод цэргийн хэтийн төлөв гэж байгаагүй, яагаад гэвэл тэдэнд ерөнхий удирдлага буюу командлал гэж байхгүй, тэдний зохион байгуулалт болон зэвсэг хэрэгсэл тун янз бүр, бие биенээ дэмждэггүй, өөр хоорондоо холбоогүй, тэдэнд бас дотоодын шинжтэй олон зөрчил байсан, бас тархай бутархай, ...тэдэнд мөн стратеги гэж байгаагүй юм" гэж бичсэн байна.

Тагнуулын төв газар партизануудад үр нөлөө багатай тусламж үзүүлжээ. Английн нэгэн адил АНУ-д Түвдийн улс биш, харин БНХАУ-д

шахалт үзүүлэх зэвсэг л хэрэгтэй байжээ. Америкийн тагнуулын төв газар партизануудыг номхон далайн Сайпан аралд, дараа нь Колорадо муж улсын Хадан уулан дахь Хейлийн хуаранд сургаж байжээ.[1248] 3 мянга орчим хүнийг хорлон сүйтгэх ажиллагаанд сургасан байна. Энэхүү сургалтын дараа түвдчүүдийг шөнө дөлийн цагаар америкийн нисэх онгоцоор эх оронд нь буулгажээ. Тэд үндэснийхээ хувцастай, винтов, миномёт буутай, баригдсан нөхцөлд хэрэглэх цианит калийн уусмал, богино долгионы бага гарын дамжуулагчтай байжээ. Тэдэнд орон нутгийн эсэргүүцлийн хөдөлгөөнүүдтэй холбоо тогтооход тун их бэрхшээлтэй байв. Тэднээс амьд үлдсэн хүн цөөхөн юм.

1960 онд зүүн хойт Чантангийн Сог, Бачэн болон бусад районы нүүдэлчид Норовцэрэнгийн удирдлагаар 5–7 мянган хүнтэй босогчдын хүч байгуулав.[1249] Хятадууд тэр Босогчидтой тэмцэхийн тулд морин цэрэг, хуягт тээвэрлэгч, танк, сөнөөгч нисэх онгоцоор хүч нэмэгдүүлсэн явган цэргийн хоёр дивиз явуулав. Сөнөөгч нисэх онгоцууд Лхас хотоос умар зүгт орших Дамшунт байрлаж байв. Тагнуулын төв газарт сургасан найман Түвд шүхэрчинг бослогчдод туслуулахаар явуулж, дараа нь нисэх онгоцноос зэвсэг хаяж өгсөн байна.

АНУ-ын тагнуулын төв газар америкийн лагерьт бэлтгэл сургуулалт хийсэн түвдчүүдийн дөрвөн бүлгийг 1959 оны сүүлч, 1960 оны эхээр шүхэрээр буулгажээ. Тэр үеийн үйл явдлуудад оролцож явсан хүмүүсээс олж мэдсэн зарим зүйлийг энд дурдая.[1250] Бүлэг бүр утасгүй дамжуулагч аппараттай, хувийн зэвсэгтэй, бүлгийн гишүүн бүрт олзлогдох нөхцөлд хэрэглэх цианит калийн уусмалтай байжээ. Эхний бүлгийг 1959 оны есдүгээр сард Лхас хотоос хойш орших Намцо нуурын хавьд буулгажээ. Түвдчүүд газарт буумагцаа холбоо тогтоох ёстой байсан партизануудыг хятадууд бутниргэснийг олж мэдсэн байна. Ингээд тэд Балбаар дамжин Энэтхэг рүү гарсан байна. Барагцаалбал мөн энэ үед 18 хүний бүрэлдэхүүнтэй өөр нэг бүлгийг Лхасаас зүүн хойш тусгаар тогтнолын төлөө тэмцэгчид гэр бүл, мал ахуйнхаа хамт бөөгнөрсөн Чагра Пембар гэдэг газрын хавьд буулгажээ. Удалгүй тагнуулын төв газар шүхрээр зэвсэг буулгасан байна. Өмнөх зэвсгээс ялгаатай нь гэвэл энэ удаад америк зэвсэг, гол төлөв М-1 винтов буу, миномет, гэдэргээ тийрдэггүй хөнгөн их буу, пулемёт, гар бөмбөг зэрэг зэвсэг байв. Урьдаас гаргасан төлөвлөгөө ёсоор америкийн лагеруудад сургалтад хамрагдсан таван Түвд хүн Нира Цонго мужийн тусгаар тогтнолын төлөө орон нутгийн тэмцэгчидтэй нийлэхээр умар зүгт явжээ. Энэ бол мал бүхий гэр бүлүүдээс бүрдсэн хэсэг хүмүүс байв. Энэ нь аян дайн хийж

яваа партизаны лагерь гэхээсээ дундад зууны үеийн нэг иймэрхүү лагерийг санагдуулах ажээ. Партизанууд рацийн холбоо барьж, тусламж үзүүлэхийг хүссэн юм байна. Үүний хариуд Нира Цонго, Чагра Пембарт бас гурван бүлэг (нийт 16 хүн), зэвсэг буулгажээ. Эдгээр бүлэг өөрсөдтэй нь нийлсэн дүрвэгсэдийн гэр бүлийн гишүүдээр олонтоо өсөн тэлж байв. Америкийн тагнуулын төв газар янз бүрийн отрядын удирдагчдад жижиг бүлгүүд болон хуваагдаж, нэг газарт том цохилт авахгүйн тулд таран байрлахыг итгүүлэн үнэмшүүлэх хэрэгтэй гэж өөрсдийнхөө хүмүүст анхааруулж байсан боловч ийм явдал болсонгүй.

Чагра Пембарын нэг тэмцэгч: “Нэг удаа хятадууд биднийг бүслэв. Өглөөгүүр хятадын нисэх онгоцууд дөхөж ирж америкийн империалистуудын үгэнд орохгүй байхын тулд түргэхэн бууж өгөхийг зөвлөж, эс тэгвээс сайн зүйл огт болохгүй гэж ятгасан ухуулах хуудсууд хаяв. Үүнээс хойш эдгээр нисэх онгоц өдөр бүр ирэх болсон юм. Тав таван нисэх онгоцноос бүрдсэн бүлэг болон нисч ирнэ. Өдөрт 3–4 цаг зарцуулан байж иймэрхүү ухуулга хийнэ. Нисэх онгоц бүрт 15–20 бөмбөг байсан юм гэнэлээ. Бид далайн түвшнээс дээш нилээд их өргөгдсөн тал газарт байрласан учир нуугдах газаргүй. Таван нисэх онгоц маш түргэн тойролт хийж хүмүүс болон мал амьтныг устгана. Маш олон хүн амь үрэгдсэн дээ” гэж дурсан ярьжээ.[1251] Чагра Пембар, Нира Цонгод агаараас бөмбөгдөж, дараа нь их буугаар галласнаас болж олон мянган хүн, бага насны хүүхэд амь үрэгдсэн байна. Шүхрээр буусан хүмүүсээс таван хүн л Энэтхэг рүү гарч амжжээ.

1960 оны нэгдүгээр сард Маркхамд десант буулгав.[1252] Партизанууд давуу хүчтэй хятадуудтай бүтэн өдөржин тулалдах бөгөөд нэг өдөр бүслэгдсэнээ ойлгожээ. Гэсэн ч партизанууд эцсээ хүртэл тулалдахаар бэлтгэжээ. Тэндээс амьд үлдсэн цорын ганц хүн: “Биднийг эргэн тойрон хүрээлсэн уулсын оройд хятадууд бүрхэн байрлажээ. Бид тэр хүмүүстэй есөн удаа тулалдаанд орж, тэр өдөр манайхны олонхи нь амь үрэгдсэн. Хятадууд: “бууж өгцгөө” хэмээн хашгирах бөгөөд бид: “Хог новш зажилцгаа. Та нар манай орныг эзэлж авчихаад юун бууж өгөх тухай яриад байгаа юм бэ?” гэж хариу хашгирна. Бид буудалцаж, тулалдаж байсан бөгөөд энэ нь хятадуудад зүүд мэт, байж боломгүй зүйл мэт санагдсан юм. Дараа нь би арван цагийн алдад эргэн тойрноо харахад манай бүлгийн хоёр хүн цианиттай капсул залгиж нас барсныг олж харав. Дахиж боломж олдохгүй учир би амандаа капсул зууж билээ” хэмээн дарсаж ярьсан байна. Гэвч тэр хүн хороо залгиж амжилгүй цохилтод өртөн ухаан алдсан бөгөөд

олзлогдсон хойноо л ухаан орсон байна. Тэр хүн хятадын шоронд 20 жил суугаад гарсан ажээ.

Америкийн тагнуулын төв газар тактикаа өөрчлөв. Америкчууд Балбын Мустан ванлигт партизануудыг сурган бэлтгэх болов.[1253] Партизаны отрядууд байгуулж, тэднийг миномёт, карабин, винтов буугаар зэвсэглэхээр төлөвлөсөн байна. Түвдийн дүрвэгчид эдгээр отрядад зуу зуугаараа элсэн орж байв. 1960 онд ЗСБНХУ америкийн тагнуулын нисэх онгоц унагаснаас хойш ерөнхийлөгч Д. Эйзенхауэр нууц ажиллагаануудыг зогсоох шийдвэр гаргажээ. Тагнуулын төв газрын тусламж гэнэт зогсов. 2 мянга гаруй Түвд хүн америкийн лагерьт хоол ундгүй үлдсэнээс болж өлсөж, зарим нь нас баржээ. Жилийн дараа хангалт сэргэв. Босогчид Түвдэд халдлага хийж, ХАЧА-ийн мэдээг замаас нь барьж авч, нилээд хугацаанд шуурхай мэдээллээр өөрийгөө хангаж байв. 1961 онд тэд БНХАУ-д өлсгөлөн болж, хятад-зөвлөлтийн харилцаа муудаж байгаа тухай хятадын нууц баримт бичиг олзлон авчээ.

Партизануудад зориулсан тагнуулын төв газрын ачааг 1958–1962 онд Амдо, Кам мужуудад дөчөөд удаа нисэх онгоцноос хаяжээ. Нийтдээ барагцаалбал 550–800 мянган фунт (250–363 тонн) зэвсэг болон цэргийн хэрэгсэл нисэх онгоцноос хаяж өгсөн байна.[1254] Энэ бол Британийн винтов, америкийн М-1, М-2 маркийн винтов буу, гэдэргээ тийрдэггүй жижгэвтэр сумтай их буу, хөнгөн пулемёт, гар бөмбөг зэрэг байв. Түвдийн партизануудыг тагнуулын төв газраас хэрэгжүүлж байсан хангалтын бүтэц, хэмжээг ХКН-ын армийг ЗСБНХУ-аас хангаж байсан хангамжтай харьцуулан үзвэл Түвдийн тусгаар тогтнол бол АНУ-ын төлөвлөгөөнд ороогүй байсныг ойлгоход тийм ч хүнд бишээ. Түвдчүүд энэ тусламжийг БНХАУ-д шахалт үзүүлэх бусдын төлөвлөгөөний төлөө биш, харин эх орныхоо эрх чөлөөний төлөө хийх амь өрссөн тэмцлийг дэмжиж буй хэрэг хэмээн хүлээн авч байжээ.

Тагнуулын төв газар 1965 оны тавдугаар сард түвдэд сүүлчийнхээ десантыг буулгасан бөгөөд тэр үед партизанууд зэвсэгт халдлагаа зогсоож, үйл ажиллагаагаа тагнуулын мэдээлэл цуглуулах төдийгөөр хязгаарлах зааварчлага авсан байна. Гэвч партизанууд энэ зааварчлагыг үл тоомсорлож, 1960-аад оныг дуустал зэвсэгт тэмцлээ үргэлжлүүлсэн хэвээр байв.[1255] Соёлын хувьсгалаас өмнө Цангпо гол болон балбын хилийн хоорондох нутагт 30–40 мянган партизан үйл ажиллагаа явуулж байжээ.[1256]

Лхас болон бусад хотод нууц байгууллагууд ажиллаж байв.1962–1976 онд хятадууд есөн тийм байгууллагыг илчилж, энэ хугацаанд мөн 44 удаа ил

шууд бослого гарчээ.[1257] Нөгөө талаас зарим Түвд хүн ХАЧА-ийн эгнээнд тулалдаж, хятад шагнал хүртэж байжээ.[1258] Хятадын албан ёсны мэдээгээр бол түвдчүүд "өөрсдийнхөө санаачлагаар ХАЧА-ийн дайчид, цэргийн дарга нарт туслахыг эрмэлзэж, олон газарт өөрийгөө хамгаалах отрядууд, нэгдсэн отрядууд, түүнчилэн мал амьтан хамгаалах отрядууд байгуулж байв. Тэд зам засахад туслаж, ачаа бараа тээвэрлэх, шуудан хүргэх үүрэг хүлээж, газарчийн үүрэг гүйцэтгэж, ХАЧА-ийн дайчдад ус авч ирж, цайгаар дайлж, хамгаалалтын цэгүүдэд жижүүрлэж, шархадсан дайчдыг эмчилж байв. Энэ бүхэн нь бослогчдыг ганцаардуулахад нэрмээс болсон юм."[1259] Эдгээр мэдээ нь сайндаа л гэхэд ялагдагчид нь ялагчдад захирагддагийг л нотлон харуулж байгаа юм. Хятадууд бүр 1954 оноос нэгэнт "өөрчлөгдсөн" өртөө улааны системийг ашиглаж байсан билээ.

Түвд–Энэтхэгийн хил зохицуулагдаагүй, Энэтхэг улс түвдийн дүрвэгчдийг дэмжиж байсан явдал хятад-энэтхэгийн хилийн санал зөрөлдөөн үүсэхийн шалтгаан болжээ. 1959 оноос энэхүү санал зөрөлдөөн зэвсэгт мөргөлдөөн болж хувирав. Энэ бүхэн Энэтхэг улс БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч, НҮБ-ын гишүүн болох, Тайваньтай БНХАУ-ыг сэргээн нэгтгэх тухай тус улсын шаардлагыг дэмжиж, 1954 оны дөрөвдүгээр сарын 29-ны хэлэлцээр, 1954 оны зун Энэтхэгт Жоу Эньлайн хийсэн энхийг эрхэмлэгч мэдэгдлүүдийн дэвсгэр дээр болж өнгөрсөн юм. Гэтэл бүр 1948 онд хятадад сууж байсан Энэтхэгийн элчин сайд С. Паниккар түвдийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхийг засгийн газартаа уриалж байжээ[1260] Хэрэв хятадын коммунистууд засгийн эрхэнд гарч, түвдийг мэдэлдээ оруулбал Хятад, Энэтхэгийн хооронд шууд мөргөлдөөн үүсгэж болохыг тэрээр урьдчилан харжээ.

Үнэхээр ч тийм явдал болов. Хятад улс 1959, 1961, 1962 онд хил дээр зэвсэгт мөргөлдөөн өдөөн тухирав, Макмагоны шугамыг давж, хилийн зүүн хэсэгт 90 мянга гаруй ам дөрвөлжин километр, хилийн төв хэсэгт 2 мянган ам дөрвөлжин километр нутаг дэвсгэр "булаан эзэлсэн" гэж Энэтхэгийг буруушаав.[1261] Хятадууд "сөрөг довтолгоон" хийв. Тэд Энэтхэгийн хилчдийн амь насыг хөнөөж, маргаантай хэд хэдэн нутаг дэвсгэрийг булаан эзэлж, нөхцөл байдлын өрнөлтийг харгалзан үзсэн хэлэлцээ хийхийг санал болгожээ. Эдгээр нутагт газар зүйн Түвд нэр хэрэглэгддэг, урьд өмнө бүх хяналт Хятадын түвдийн. районы орон нутгийн эрх баригчдад байсан юм гэж хятадын эрх баригчид Энэтхэг улсад мэдээлсэн байна. Аксайчин, Али гэдэг хэмээх өөр хоёр район ямагт "Хятадын шинжааны мэдэлд" байжээ.

Зөвлөлтийн удирдагч Н.С. Хрущевийг АНУ-д айлчлахаас хэдхэн

хоногийн өмнө 1959 оны найм-есдүгээр сард хятад, энэтхэгийн хооронд анхны зэвсэгт мөргөлдөөн гарав. Мао Зэдун урьдын адил ЗСБНХУ-ын зүгээс үг дуугүй дэмжинэ гэж тооцоолжээ. Гэтэл зөвлөлтийн удирдлага асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхийг хоёр талд уриалжээ. ХКН-ын төв хороо 1959 оны есдүгээр сарын 13-нд ЗХУКН-ын төв хороонд нууц захидал явуулж, “Неру болон энэтхэгийн засгийн газрын тухайд аялдан дагалдаж, буулт хийх бодлого баримталлаа хэмээн зөвлөлтийн удирдлагыг буруушааж, зөвлөлт-хятадын санал зөрөлдөөнийг ТАСС дэлхий нийтийн өмнө дэлгэн тавьсанаас болж “энэтхэгийн хөрөнгөтнүүд, мөн “америк, английн империалистууд” үнэхээр баярлаж, хөөрч байгаад харамсч буйгаа илэрхийлэв.[1262]

Н.С. Хрущевийг АНУ-д айлчилсны дараа 1959 оны есдүгээр сард хоёр талын харилцаа улам муудав. Хрущев АНУ-ын дараа БНХАУ-д очсон нь дарга Маогийн гомдлыг улам ч их болгов. Аравдугаар сарын 2-нд Мао Зэдун түүнтэй уулзав. Хятадын удирдагчид ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд өөрчлөн байгуулалт хийх гэж дэмий дөрвөн жил өнгөрөөж, Далай ламд Энэтхэг рүү гарах боломж олгож, Шинэ Дели болон хятадын харилцааны асуудлыг зэвсэг хэрэглэн шийдвэрлэсэн юм гэж Хрущев мэдэгджээ. Энэтхэгтэй харилцах асуудал бол “социалист орнуудын нэгдмэл фронтынх” биш, харин БНХАУ-ын хэрэг мөнийг ТАСС-ын мэдэгдэл дэлхий дахинд нотлон харуулсан юм гэж тэр хэлсэн байна. Үүний хариуд Мао: “Далай ламын зэвсгийг шууд хураагаагүйд л бидний алдаа оршиж байгаа юм. Гэхдээ тэр үед бид Түвдийн ард олонтой хэлхээ холбоо тогтоож чадаагүй байсан билээ” гэж мэдэгджээ. Хрущев: “Та нар одоо ч түвдийн хүн амтай хэлхээ холбоо тогтоож чадаагүй л байгаа шүү дээ” гэж хариулав.[1263] Хятад-энэтхэгийн мөргөлдөөний асуудлаар хоёр тал нэгдмэл байр суурьт хүрч чадсангүй. Хрущевийг дагалдаж Бээжинд очсон зөвлөлтийн гол үзэл сурталч М.А. Суслов 1959 оны арванхоёрдугаар сарын 18-нд ЗХУКН-ын төв хорооны улс төрийн товчоонд илтгэл тавьж, бослого хөдөлгөөнд хүргэсэн ХКН-ын бодлогыг шүүмжлэв.[1264]

Ийнхүү ЗСБНХУ төвийг сахисан байр суурь илэрхийлж, БНХАУ-ыг дэмжээгүй бөгөөд харин Их Британи, АНУ энэтхэгт зэвсэг нийлүүлж эхлэв. Хятадын эрх баригчид энэтхэгээс булаан эзэлсэн нутаг дэвсгэрүүдийн олонхийг чөлөөлж өгөхөд хүрчээ. Гэтэл 1965 онд дахиж мөргөлдөөн гарав. Энэ удаад хятадууд Сикким болон Чолын районд цөмөрч орсон боловч энэтхэгчүүдэд цохигдон буцжээ. Өндөр уулын Аксайчин районыг хятадууд өнөөг хүртэл эзэмшиж, тийш нь засмал зам тавьсан нь үнэн билээ.

Хятадын эрх баригчид энэтхэг төдийгүй бусад олон орон, түүний дотор ЗСБНХУ-д нутаг дэвсгэрийн өнгөлзлөг хийж иржээ. 1950-иад оны сүүлчээс хятад-зөвлөлтийн харилцаа тасралтгүй муудав. Мао Зэдун өөрийнх нь бодлогыг үг дуугүй дэмжихээс татгалзсан явдалд, И.В. Сталиныг тахин шүтэж байсныг шүүмжилсэнд, Н.С. Хрущев, Л.И. Брежнев нарын үед зөвлөлт-америкийн харилцаа намжмал болсонд сэтгэл дундуур үлджээ. Гэтэл тэр үед Хятадын коммунист нам ЗСБНХУ-ын ачаар л засгийн эрхийг гартаа бат тууштай барьж, тус улсын аж үйлдвэр давшингуй хөгжжээ. 1960 оны БНХАУ-ын нийт үйлдвэрлэлийн хэмжээнд ЗСБНХУ-ын дэмжлэгээр байгуулагдсан үйлдвэрийн газруудаас гаргасан бүтээгдэхүүн жишээлэхэд гангийн үйлдвэрлэлийн 30 орчим хувийг, цувималын 50 гаруй хувийг, ачааны автомашины тухайд 80 хувь, тракторын 90 хувь, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 25 хувийг тус тус эзэлж байжээ.[1265]

ЗСБНХУ-ын зүгээс үзүүлсэн зөвхөн шинжлэх ухаан-техникийн тусламжийн зах зээлийн өртөгийг барагцаалбал 10824 сая доллараар (БНХАУ үүнээс дөнгөж 125,5 саяыг төлжээ) үнэлжээ.[1266] Энд цэргийн тусламж болон цэргийн биш янз бүрийн нийлүүлэлтүүд ороогүй юм. Одоо төслүүд зогсож, нийлүүлэлт багасчээ.

ХКН Түвдийн бослогыг дарахдаа: “цэргийн халдлага үйлдэх, улс төрийн хүчнийг өөрийн талд татах, олон түмнийг дайчлах” гэсэн салшгүй холбоотой гурван элементийг нэгтгэсэн бодлого хэрэглэжээ. 1959 оны гуравдугаар сарын 29-нөөс Шигазе, Лхас, Ятун, Нетон, Гьянзе, Нагчу, Динчинд “бослогыг зэмлэн буруушаасан” хурал, цуглаан, ярилцлага зохион байгуулав.[1267] Дөрөвдүгээр сарын 15-нд “бослогыг бүрмөсөн дарахыг шаардсан” асар том цуглаан Лхаст болов.[1268] Энэ цуглаанд оролцоогүйг харгис хүчнийг талархан дэмжсэн хэмээн үзэх бөгөөд үүнээс гарах бүх уршиг дагаварыг тэр хүмүүс өөрсдөө хүлээх болно гэж хятадууд зарлав. Тийм арга хэмжээнүүд нь шинэтгэл хийхийг бүх ард түмэн шаардаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх зорилготой ажээ. Жоу Эньлай 1959 оны дөрөвдүгээр сарын 18-нд хоёрдахь удаагийн сонгуулийн БХАТХ-ын анхдугаар чуулган дээр тавьсан илтгэлдээ: “Түвдэд шинэтгэл хийхийг шаардаж буй хөдөлмөрчид, шинэтгэлийг дэмжигч дээд ангийнхны дэвшилт элементүүд, итгүүлэн үнэмшүүлж болох завсрын элементүүдийн тоо 1100 мянган хүнээс давж байна” гэж мэдэгджээ.[1269] Ерөнхий сайд ирээдүйн түвдийн өөртөө засах орны хүн амын тоог барагцаалбал 1200 мянган хүн байна гэж хэлжээ. Ингэхдээ 1953 оны хүн амын тооллогын мэдээг үндэс болгосон нь маргаангүй юм. Тэгвэл хэрэв хүн амын тоог үнэн бус мэдээлэлд үндэслэж

гаргасан юм бол шинэтгэлийг дэмжих ёстой хүмүүсийн тоог ямар аргаар ийм олон болгож гаргасан юм бол? Дам, үндсэндээ ангийн чанартай шалгуур хэрэглэсэн нь тодорхой юм. Тийм дүгнэлт хангалттай биш нь ч мөн тодорхой билээ.

X Банчин лам 1959 оны гуравдугаар сарын 29-нд Мао Зэдун, Жоу Эньлай нарт талархлын цахилгаан утас илгээж, гуравдугаар сарын 30-нд Шигазед болсон цуглаан дээр БНХАУ-ын төрийн зөвлөлийн тушаалыг дэмжсэн үг хэлсэн байна.[1270] Тэрээр дөрөвдүгээр сард БХАТХ-ын чуулганд бусад төлөөлөгчдийн хамт оролцохдоо Түвд бол "БНХАУ-ын салшгүй хэсэг" мөнийг нотлоод 17 зүйлт хэлэлцээрийг албадлагын дор байгуулаагүй бөгөөд түүнийг хятадын тал бүхэлд нь биелүүлж ирсэн, ХКН шашин шүтлэгийг мөрдөн хавчаагүй гэж мэдэгдэв.[1271] Чуулганы төлөөлөгчид ялагдсан түвдчүүдийн байдлыг хөнгөвчлөх гэсэн бололтой юм.

Хятадын тал энэхүү Хэлэлцээрийг тасалдуулсан хэдий ч эхний үед аядуу бөгөөд шудрага хандлагыг зарлан тунхаглаж байв. 1959 оны гуравдугаар сарын 31-нд "Жэньминь жибао" сонины тэргүүн өгүүлэлд: "цэргийн бүх олзлогдогчийн амь насыг хөнөөхгүй, гутаан доромжлохгүй, шургуу эсэргүүцэл үзүүлэх тэр хүмүүсийг л хатуу цээрлүүлэх болно. Түвдэд байгаа ардын чөлөөлөх армийн ангиуд ард олны шашны итгэл үнэмшил, зан заншил, ёс уламжлалыг хүндэтгэх, шашны сүм хийд, эртний соёлын дурсгалуудыг хамгаалах тууштай чиг шугам баримталсан хэвээр байх болно <...> Түвдийн урвагч бүлгийнхний гаргасан бослого түвдэд ардчилсан шинэтгэл хийх шаардлагатай болсныг нотлон харуулав: гэхдээ ардын төв засгийн газар шинэтгэлийг хэрэгжүүлэх цаг хугацаа, арга хэлбэр, энэ талын арга хэмжээний тухай асуудлаар хүн амын дээд болон дунд давхаргын эх оронч сэтгэлгээтэй зүтгэлтнүүд болон түвдийн ард олны янз бүрийн бүлгийн төлөөлөгчидтэй өргөн зөвлөлдөөн хийх болно" гэж бичсэн байна.[1273]

Ирээдүйн түвдийн өөртөө засах оронд ардчилсан шинэтгэл хийж эхлэв. 1959 оны зургадугаар сард Түвдийн өөртөө засах орны бэлтгэл хорооны 2-р чуулганаас гаргасан шийдвэрийн дагуу шинэтгэлийг хоёр шаттай явуулав.[1274] Эхний шат нь "гурван эсрэг": "бослогын эсрэг, өртөө улааны эсрэг, боолчлолын эсрэг" байв. Өртөө улаа гэдэг нь шуудангийн систем, "боол" гэдэг нь гэрийн үйлчлэгч нар гэдгийг сануулья. Эцсийн дүнд коммунистууд жирийн ард иргэдийг шинэтгэлд ашиглахаар шийджээ. Хоёрдахь шат нь "хоёр бууралт" буюу түрээс, зээлийн хүүг бууруулж, дараа нь газрыг дахин хуваарилах явдал байв.

1959 оны зун зэмлэн буруушаах, гэмээ хүлээх, харгис хүчнийг шүүмжлэх, империалистуудад няцаалт өгөх, гашуун дурсамжийг санах зэрэг янз бүрийн сэдэвтэй онцгой олон цуглаан зохион байгуулжээ.[1275] Гашуун дурсамжаа санагалзах цуглаанд оролцсон “хамжлагынхан” газрын эздийн гарт “зовж шаналж” байсан тухайгаа ярьж байв. Эдгээр хурал цуглаан ардчилсан шинэтгэлд “ард олныг дайчлах” зорилго агуулжээ. Хүмүүсийг цуглаануудад хүрэлцэн ирж, тушаасан бүхнийг биелүүлэх үүрэг өгч байсан бөгөөд энэ бол “эрхэндээ оруулах, дайчлах” явдал байлаа. Хятадууд “олон түмнийг дайчлахдаа” хүмүүсийг самуун дэгдээгчдэд хэн тусласан, хэн туслаагүйгээр нь хувааж эхэлсэн байна. Энэ шошгыг эхний бүлэг хүмүүст нааж эхэлсэн байна.[1276] Хожим нь тэдэнд ангийн, улс төрийн гэсэн бусад шошго нэмж наах болсон ажээ. Дээд ангийнхныг бослого хөдөлгөөнд оролцсон, оролцоогүйгээр нь хуваасан явдал хятадын эрх баригчдын сөрөг хүчин бий болгохгүй байх нөхцөл бүрдүүлжээ.

Намын удирдлага санасандаа хүрч: түвдийн нийгмийг хагаралд оруулж, хүн амын хамгийн бүрхэг давхаргаас идэвхтний явцуу давхарга бий болгож чаджээ. Ингээд ч тэдэнд шинэ үүрэг хүлээлгэсэн байна. Мао лүмпэн пролетари нарыг хувьсгалын манлай хүчин хэмээн үзэж, тэдний үүрэг ролийг онцгойлон авч үзсэн юм гэж тухайн үедээ Пэн Дэхуй тэмдэглэж байжээ.[1277] Хятадад сургалтад хамрагдсан хүмүүсээс бусад кадр ажилтанг элсүүлж авав. Тэднийг, тэрч бүү хэл боловсролоо дуусгаагүй хүмүүсийг ч яаравчлан буцаажээ. Эдгээр кадр ажилтан өөртөө засах нэгж бий болгоход биш, харин түвдийн ард олон болон хятадын удирдлагын хооронд зуучлагчид болгоход хэрэгтэй байв.[1278] Тэдний олонхи нь маш муу боловсролтой болсон буюу ямар ч боловсрол эзэмшээгүй ажээ. Энэ хүмүүс бол гол төлөв дунд болон дээд давхаргаас гаралтай ажээ.

Татварыг бууруулж, албадлагын хөдөлмөрийг халах явдал түвдчүүдийн хувьд зөвхөн билэг тэмдгийн шинж чанартай байсан бөгөөд тэртээ тэргүй хуучин системийг үүнээс өмнө халсан байлаа. 1958 оноос өмнө ч өр зээлтэй байсан тийм тариачдад л өр цайруулсан явдал ашиг тус өгчээ.[1279] Тариачдын дунд ч ядуучууд л шинэтгэлийг дэмжсэн байна. Гэсэн ч хятад цэрэг түвдэд байгаа явдал болон хятадуудад урьдын адил итгэл муутай хандах зуршил тэдний сэтгэлийг түгшээх ажээ. Тэд хятадууд удахгүй явах байх хэмээн найдсан байна.

1959 оны зун ирээдүйн Түвдийн Өөртөө Засах Оронд хамтралжуулалтын эхний шат хэрэгжиж, харилцан туслах бригадууд байгуулагдав.[1280] Харгис хүчний шошго зүүсэн хүмүүсийг эдгээр бригадад оруулахгүй байв. Ийм

бригадуудад хамгийн үржил шимтэй газар хуваарьлана. Хувиараа хөдөлмөр эрхлэхээр шийдсэн хүмүүст хамгийн муу газар олгох ажээ. Бригадууд ус зохицуулалт, усжуулалт, ойжуулах ажил эрхэлнэ. Энэ бригадууд илүүдэл ажиллах хүчнийг өөртөө шингээж, барилгын ажилд дайчлах нөөц хүч бий болгох ёстой байсан бөгөөд эцэст нь тэдэнд хяналт тавих явдал хувийн өмчитнүүдийг бодоход хялбар байв.[1281] Гэхдээ хөдөө аж ахуй амины шинж чанартай хэвээр байв. Үнэн чанартаа бол ургацын ихэнх хэсгийг янз бүрийн "сайн дурын" татварын хэлбэрээр буюу заавал хийх нөхөн төлөөс гэлгүйгээр "худалдан авах" хэлбэрээр хураан авдаг байсан юм. Бослогод оролцсон феодалууд болон сүм хийдийн газрыг хураан авч, түүнд оролцоогүй ("эх оронч", "хууль сахидаг") цөөн тооны хүмүүсийнхийг нөхөн төлөөсийн журмаар (барагцаалбал газрынх нь гуравны нэгийг) авах ёстой байв. Ийнхүү нөхөн төлөөсийн журмаар авах эрхийн бичгийг 1300 гэр бүлд тулгаж өгсөн байна.[1282] Газрыг хураан авч, дахин хувиарласны дараа "хамжлагынхан" өрийн дансыг хамтран шатаах ажил зохион байгуулжээ. Үүнээс болж төрсний, нас барсны, гэрлэсний гэрчилгээ болон энгэл жирийн айлуудын ургийн бичгийг шатаажээ.[1283] Ерөнхийдөө бол ийнхүү "тариачид анх удаа газар, билчээрийнхээ эзэн" болжээ.[1284]

Кам, Амдод шинэтгэл нэгэнт хэрэгжсэнийг бид мэдэх билээ. Хятад цэргийнхэн тэнд өөрсдийгөө жинхэнэ эзэд хэмээн бодох ажээ. Тэд хамгийн сайн өвс ургамалтай газарт малаа билчээнэ.[1285] Тэдний араас ядуу хятад тариачид колончлолын шинэ давалгаагаар орж ирэв. Засгийн газар арми болон хятад шилжин суурьшигчдыг хооллож үндлэхын тулд малынхаа сайхан билчээрийг хагалсан газар болгов.Үүнийг газар тариалан эрхлэх явдал хэмээн нэрлэх ажээ. Үүний уршгаар газар нутаг цөлжих болов. 1959 онд Амдо мужийн төвдчүүд тал нутгийнхаа билчээрийг хагалахад хүрч, хөрснийхөө нимгэхэн давхаргыг устгасан юм гэж тэр үеийн үйл явдлыг нүдээр үзсэн хүмүүс ярьжээ. Чулуурхаг хөрсөнд үр суулгасан боловч мэдээжийн хэрэг ургац өгсөнгүй.

1960-аад оны эхээр БНХАУ-д "уй гашуугаа хэлэлцэх" буюу "гунигт дурсамж" хэмээх нэртэй кампанит ажил өрнүүлэв.[1286] Хамтралжуулалтын улмаас үүссэн их өлсгөлөнгийн зовлон гамшигийг ХКН ялахаас өмнөх үеийн гамшиг зовлонтой харьцуулахын аргагүйг хятадуудад үзүүлэх явдал гол зорилго байлаа. Шинэ кампанит ажлыг "үндэсний цөөнхөд" онцгой ач холбогдолтой хэмээн ойлгуулж,тэдэнд"чөлөөлөлтөд"талархах,харгис хүчнийг үзэн ядах сэтгэгдэл төрүүлэх явдал чухал байв.

Улс орон коммунизмын байгуулалтын ээлжит бэрхшээлийг даван туулж

байх үед “их залуурч” өөрөө баян тансаг байдалд умбаж: усан сан бүхий тансаг орд харшид сууж, онцгой үйлдвэр пүүсийн хоол хүнс зооглож, хэд хэдэн татвар эмс хэрэглэж байв.[1287]

Өөр нэг кампанит ажлыг: харх, оготно, ялаа, бор шувуу зэрэг “дөрвөн хортонг устгая” хэмээн нэрлэжээ. Түвдийн хувьд энэ кампанит ажил онцгой учир холбогдолтой, яагаад гэвэл бурханы шашин амьд амьтан хөнөөхийг хориглодог юм. Тэнд золбин ноход болон жижиг биетэй зэрлэг амьтад устгаж эхэлсэн байна. 1960 оны нэгдүгээр сард Лхас хотод золбин нохой устгаж, арсыг нь өвчиж, махы нь сүмийн өмнө шатаахыг гуйланч ядуу хүмүүст тулгажээ.[1288]

1960 онд ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд хурал цуглаан шинэ хүчээр сэргэв. Заримдаа зэргэлдээх байшингуудын дээвэр дээр зэвсэглэсэн хятад цэргүүд суулгаж цуглаан хийлгэнэ.[1289] 1960 оны гуравдугаар сарын 4-нд “Түвдийн өдөр дутмын сонинд” дараах жишээг иш татан бичжээ. Нэгэн тосгоноос феодализмыг эсэргүүцсэн гомдол ирэхгүй байгааг коммунистууд олж мэджээ. Тэд нэн даруй цуглаан хийлгэж, тосгоныхонд “хуучин нийгмийг танин мэдэхэд нь” туслах олон хэв шинжит жишээ татан ярьжээ.

Хятадын суртал нэвтрүүлэгчид эдгээр цуглааныг ард олны дэмжлэгийн нэгэн шинж тэмдэг хэмээн харуулахыг эрмэлзэж байлаа. Үнэн хэрэгтээ бол хүмүүс стандартын асуултад өгөх хариуг цээжилж, дараа нь түүнийг хэлдэг байжээ.

1960 оны зун гэхэд ирээдүйн түвдийн өөртөө засах орны сүм хийдүүдийн барагцаалбал тэн хагаст шинэтгэлийн эхний шат дууссан байлаа гэж Агваан Жигмэд дурсан ярьжээ.[1290] Шинэтгэлийн хоёр дахь шат эхлэв. Бурханы шашны сүм хийдийн эрх мэдэл болон газар эзэмших эрхийг хэдхэн сарын дотор цуцлав. Газар, мал авсан ядуучууд эхний үед баяр хөөртэй байв.Гэсэн ч удалгүй тэдэнд: хятадууд түвдийн газар, ялангуяа сүм хийдийн газрыг хувиарлан олгох ямар эрхтэй юм бэ? гэсэн асуулт гарч ирэв.

1960 оны сүүлч гэхэд хил орчмын нутгуудыг эс оролцуулбал ирээдүйн түвдийн өөртөө засах оронд газар хуваарилах ажил дуусчээ. Хэрэгцээнд тохирох бараг бүх газрыг “хамжлагынханд” хуваарилан өгөв. Гэсэн ч бага газартай буюу газаргүй тариачид, олон “чөлөөлөгдсөн боолуудыг” (феодалуудын үйлчлэгч, зарц байсан хүмүүс буюу хүн амын 5 орчим хувь), хийдээсээ хөөгдсөн олон зуун мянган лам нарыг газартай болгох хэрэгтэй байлаа. Гэтэл сул газар бараг үлдээгүй ажээ.[1291] Мөн “боолууд”ч, лам нар ч газар тариалан эрхлэх дадлага туршлагагүй байв. Зарим хүн

малаа дундчуудад хямд үнээр борлуулна.[1292] Гэсэн ч хүнсний бүтээгдэхүүн урьдынхаас хамаагүй их шаардагдах болсон бөгөөд эзэмшлийн цэргийн хоол хүнсийг хангах хэрэгтэй болов. Урьд өмнө сүм хийдүүд үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлж, рентийн татвар төлөхөд нь тариачдын аж ахуйнуудад тусладаг байв.[1293] Тэгвэл сүм хийдүүд уналтад орсноор тариачдыг энэ түшиг тулгуураас нь салгажээ.

Эдгээр асуудлыг түргэн шийдвэрлэх шаардлагатай болов. Энэ шийдвэрийг хаанаас олох вэ? Мэдээжийн хэрэг хятадынх шиг хамтралжуулалтаас. Тариачдыг зарц үйлчлэгч нар болон хийдээс хөөгдсөн лам нарын хамт маш түргэн хугацаанд хоршоолжуулж эхлэв. Хүмүүс: “ардын коммунуудад хүн бүр: нэг удаагийн иж бүрдэл хувцас, ор дэрний цагаан хэрэгсэл, хоол идэх аяга, хоёр савх” гэсэн гуравхан төрлийн эд хогшилтой байдаг хэмээн ярьдаг байжээ.[1294] Хөдөө аж ахуйг эрчимжүүлэх хэрэгтэй байсан бөгөөд энэ нь Түвдийн нөхцөлд үнэхээр тохирч таарахгүй арга хэмжээ байжээ. Газар тариаланг эрчимжүүлэх ажлыг хагалсан газрын хэмжээг зохих ёсоор нэмэгдүүлэхгүйгээр хийх гэсэн бөгөөд ингэснээр амжилтад хүрэх боломжгүй байв.[1295] Энэ үйл ажиллагааг “бүтээгдэхүүн нэмэгдүүлэх эх оронч санаачлага” хэмээн нэрлэж байв. Ургуулсан үр тариаг феодалуудад биш, харин хятадад өгөх хэрэгтэй болов. Түүнийг “ардын эх оронч үр тариа” хэмээн нэрлэж байлаа. 1961 оны сүүлч гэхэд тариачдын аж ахуйнуудын 90 орчим хувь нь хоршооллын янз бүрийн хэлбэрт хамрагдсан байлаа.[1296] Татварыг аажмаар ургацын 75 хувь хүртэл нэмэгдүүлж, тариачдыг хоногийн хоол төдийхнөөр барьж, дараа нь картын системд шилжүүлэв.

Хамтралжуулалт мэдээжийн хэрэг өлсгөлөн дагуулав. Хятадад 1959–1961 онд ургац алдсан явдал байдлыг улам хүндрүүлэв.Төрөлт буурсныг харгалзан үзэхгүйгээр (33 сая орчим) 1959–1961 онд өлсгөлөнгөөс үүдсэн нас баралтаас шалтгаалсан БНХАУ-ын хүн амын тооны бууралт 20-иос (энэ бол 1988 онд зарласан тоо баримт бөгөөд түүнийг албан ёсны статистик хэмээн үзэж болно) 43 саяд хүрчээ.[1297] Энэ бол хятадын бүх түүхэнд төдийгүй дэлхийн түүхэн дэхь хамгийн аймшигт өлсгөлөн байжээ. 1959 онд Түвдэд сайн ургац авав. Гэвч 1961–1964 онд түвдийг ч мөн өлсгөлөн хамрав.

Мао болон түүний нам энэ бүх дампуурал буруутайгаа хүлээн зөвшөөрөх гэсэнгүй. Энэ бүхэн Зөвлөлт Холбоот Улс тусламж үзүүлэхээ зогсоож, өрөө нэхэх боллоо, үүнээс болж үр тариа зөөж байна, өлсгөлөнгийн шалтгаан ч үүнд байгаа юм гэж түвдчүүдэд итгүүлэхийг эрмэлзэх ажээ. Тэр үед түвдчүүд худал ярьж буйг нь мэддэг байсан ч ийм нотолгоо одоо

ч тааралдаж байна.[1298] Түвдээс ЗСБНХУ-руу биш, харин өлсгөлөнд илүү их нэрвэгдсэн хөрш Ганьсу, Сычуань мужууд руу хүнсний бүтээгдэхүүн зөөж байв.[1299] Үүнийг эдийн засгийг сайжруулж, “чөлөөлж” өгсний төлөө, эрүүлийг хамгаалахыг хөгжүүлж, зам байгуулсны төлөө “эх орондоо төлбөр хийх” шаардлага гэгчээр тайлбарлах ажээ. Ингэхлээр түвдэд хятад руу үр тариа зөөхөд ашиглах зам,бензин шатахуун хүрэлцээ муутай байсан гэх нотолгоо үнэнд үл нийцнэ.[1300]

X Банчин лам өлсгөлөнгийн жинхэнэ шалтгааныг цохон тэмдэглэж хэлэхдээ: “Түвдэд намаас тогтоосон өндөр биш татварын дүнд ардын эх орончи үр тарианы тоо хэмжээ их биш байсан юм. Гэвч бүтээмж дээшлүүлэх уралдаанд байр эзлэхийн төлөө их хөдөлгөөний үед, бие биендээ сайрхаж, өсгөн мэдээлэх чиг хандлага газар авсны уршгаар бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн тухай бодит байдалд үл нийцсэн хуурамч тайлан гаргадаг байв <...> 1959–1960 онд газар тариалан эрхлэгчид болон малчдын хооронд солилцоо зогссоноос хойш засгийн газар мал аж ахуйн нутгуудад үр тариа байрлуулдаг ч энэ нь хангалтгүй байсан юм <...> Үүнээс болж үр тариа хүрэлцэхгүй, хүмүүс малаа олноор нь нядалж идэхээс өөр аргагүй болсон юм. Энэ бүхэн мал аж ахуйн бүтээгдэхүүнд сөрөг нөлөө үзүүлэв <...> Мал аж ахуйд ажилладаг хүмүүст үр тариа үнэхээр хүрэлцэхгүй, тосгоныхонд мах, цөцгийн тос, давс, хужир хүрэлцэхгүй байснаас болж газар тариалан, мал аж ахуйн мужуудын амьдралд хүндрэл үүсгэсэн юм <...> Ардчилсан шинэтгэлийн үед материал болон үр тариа тээвэрлэхийг хориглож, хүмүүс бусад нутаг руу явахыг хатуу хязгаарласан байлаа. Улмаар хөдөө нутгаас нийлүүлсэн бараа таваараар хотуудыг хангах ажил бараг зогссон байв. Хотын хүмүүс ч ихээхэн илүүдэл үр тариа хурааж хадгалсан: жижиг уутанд савласан арвай, замбай хүртэл худалдан авч байсан учир дэндүү их нөөцтэй болсон бизээ. Хэдэн литр арвай болон замбай нуусан айлуудын талаар тэмцэл явуулж байсан нь дэндүү өчүүхэн явдал мэт санагддаг билээ. Олонхи айлын байшинг нэгжиж, үр тариа, мах, шар тосных нь бараг бүх нөөцийг авч явдаг байв. <...>

Үр тарианы хэмжээ хамгийн бага хэрэглээтэй айлд ч хүрэлцэхгүй байсан болохоор өлсөж,зовсноосоо болж уур хилэнгийн гал дүрэлцэх явдал гарч, урьд өмнө түвдэд морь, илжиг, үхэрийн тэжээлд хэрэглэдэг байсан тарианы хаягдал, өвдөл цөвдөл ч олдоход бэрх болсон юм. Одоо эдгээрийг шим тэжээлтэй, амтат хоол хэмээн үзэх болжээ. Түүнчилэн гуанз, зоогийн газрын хариуцлагатай хүмүүс олон төрлийн хоолтой байгаа мэт харагдаж, өдөр дутмын өлсгөлөн, зовлонг тайтгаруулах гэхдээ ямар нэгэн

хэлбэрээр идэж хэрэглэдэг өвс ургамалын хажуугаар бодит амьдралд хоолонд хэрэглэдэггүй модны холтос, навч, өвсний үндэс, үр тэргүүтнийг нөөцөлдөг болжээ. Энэ бүхнийг хольж хутгасны дараа шингэн бантан дээр нэмж хийн гахайн хоол мэт болгож хүмүүст өгнө. Энэ нь гэхэд л ходоод цатгахгүй хязгаарлагдмал хэмжээтэй. Түвдчүүд түүхэндээ хэзээ ч ийм аймшигт өлсгөлөнгийн аюулд нэрвэгдэж үзээгүй, хүмүүс зүүдэндээ ч төсөөлөөгүй тийм өлсгөлөн тулгарсан учраас олон түмэн энэхүү харгис тамлалыг тэсвэрлэж чадахгүй, тэдний байдал өдрөөс өдөрт муудаж байв. Тийнхүү зарим нутагт хүйтэн жавар болон өчүүхэн төдий өвчнөөс болж өдөр бүр хүмүүс олноороо нас барах ажээ. Зарим газарт хоол ундгүйгээс болж хүмүүс олноороо нас барж, нэг айлын бүх хүн насан өөд болох явдал ч гарч байлаа.

Нас баралтын түвшин аймшигтай байв. <...> Жишээ нь, Хөх нуур мужийн Сюньхуа тойргийн Вэнду хийдэд би орон нутгийн кадр ажилтан, түвд, хятад, салар үндэстний төлөөлөгчид зэрэг гурван зуу гаруй хүний чуулга уулзалт зориуд зохион байгуулсан билээ. Тэр уулзалт дээр хүмүүс, гол төлөв орон нутгийн кадр ажилтнууд: “1959-өөс 1961 оныг дуустлах хугацаанд Сюньхуагийн амьдралын нөхцөл санаанд багтахын аргагүй, төсөөлөхөд ч бэрх байсан юм. Тосгон бүрт хүмүүс өлсгөлөнгөөр нас барж байлаа” хэмээн ярьсан юм. Тэд энэ тухай нүдэндээ нулимас цийлэгнүүлэн яриад зогссонгүй: “Урьд өмнө бид сайн ургац авдаг байсан ч амьдрал маань хэзээ ч сайжирч байгаагүй, харин одоо бид яаж амьд үлдэх вэ л гэж бодож байна. Амьдралын тийм гунигтай нөхцөлд бидэнд үйлдвэрлэлээ хөгжүүлэх санаа бодлоо дээшлүүлэх, түүний төлөө шургуу хөдөлмөрлөх боломж байхгүй, тийм учраас бид сайн ургац авна гэдэг худал үг байхаа. Одоо төрөөс бидний гэдсийг цатгасан нөхцөлд л бид сайн ургацын төлөө тэмцэж чадна” хэмээн онцлон тэмдэглэж байсан юм” гэжээ. [1301]

Тийнхүү “чөлөөлөгдсөн” тариачид феодализмыг ардчилсан шинэтгэлээс илүүд үзжээ. Ер нь бол Хөх нуур муж өлсгөлөнгөөрөө БНХАУ-д Гуйчжоу, Аньхойн дараа гуравдугаар байранд зогсож байжээ.[1302] Гурван жилийн дотор (бослогыг дарсан, өлсгөлөн болсон) Хөх нуур мужид 150 мянган хүн буюу 1957 оны хүн амын гуравны нэг гаруй нь нас баржээ. Гэхдээ тосгоныхон төдийгүй хотын оршин суугчид ч өлсгөлөнд нэрвэгдсэн байна. Лхас хотод хүмүүс өлсгөлөнгөөр нас барсан тухай ярихыг хориглож, эс тэгвээс хатуу цээрлүүлнэ хэмээн сүрдүүлснийг тэр үеийн үйл явдлыг нүдээр үзсэн хүн дурсжээ.[1303] Өлсгөлөнгөөр нас барсан нэг хүний гэдсийг хагалж үзэхэд өвс, адууны хомоол гарчээ.

1950 он хүртэл Түвд улс гадаад худалдаа эрхэлж байв. Тэгвэл тус улсын өмнөд хил хаагджээ.[1304] Энэтхэг, Балбатай хийж байсан худалдааны үйл ажиллагаа зохион байгуулалтгүй болж, олон худалдаачин хилийн чанадад дүрвэн гарсан байна. Үүнээс болж дамын наймаа цэцэглэж, үнэ эрс өсөв.[1305]

Чулуу, мод, гангаар эдлэл хэрэглэл хийхээс бусад гар урлал уналтад оржээ. Ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд газрын шинэтгэл эхэлснээс хойш тэндхийн оршин суугчдад түвдийн мөнгийг боослогын өмнөх үеийнхээс тэн хагасаар хямд ханшаар хятад мөнгөн тэмдэгтээр солих 7–10 хоногийн хугацаа санал болгож, энэ хугацаа дуусмагц урьд өмнө хятадуудын авдаг байсан Түвд мөнгөн тэмдэгт буюу цалин цагаан мөнгөн зоосыг хүчингүй хэмээн зарладаг байв.[1306] Лхасын оршин суугчдад шашны эд зүйлсийг оролцуулан үнэт эдлэлээ тушаахыг шаарддаг байв. Олон хүн эд зүйлсээ Кийчу голд хаядаг байв.

1961 оны арванхоёрдугаар сарын 20-нд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас гаргасан 1723-р тогтоолд түвдийн ард түмний эрх зөрчигдөж, "энэ ард түмний соёл, шашны амьдралын гайхамшигт илрэлийг нухчин дарж байгаа явдалд сэтгэл гүнээ түгшиж байгаагаа илэрхийлсэн байна. НҮБ-ын ерөнхий Ассамблей: "1) НҮБ-ын Харти бичиг, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд илэрхийлсэн зарчмуудыг хүндэтгэх нь эрх, хууль ёсны ялалтад үндэслэсэн дэг журмыг дэлхий дахинд тогтооход чухал шаардлагатай зүйл хэмээн үзэж буйгаа нотолж байна; 2) өөртөө засан тохинох эрхийг оролцуулан түвдийн ард түмний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчихөө зогсоохыг дахин уриалж байна; 3) энэхүү тогтоолд илэрхийлсэн зорилтуудыг биелүүлэхийн тулд НҮБ-ын гишүүн улсууд шаардлагатай бүх хүчин чармайлт тавина гэдэгт найдаж байгаагаа илэрхийлж байна" гэж уг тогтоолд өгүүлжээ.

НҮБ-ын ерөнхий Ассаблей 1965 оны арванхоёрдугаар сарын 18-ны өдрийн 2079 (XX)-р тогтоолдоо түвдийн асуудлаар гаргасан өмнөх тогтоолд заасан, "1) түвдийн ард түмний үндсэн эрх, эрх чөлөөг үргэлжлүүлэн зөрчиж байгааг зэмлэн буруушааж; 2) НҮБ-ын Харти бичиг, Хүний эрхнийн түгээмэл тунхаглалд илэрхийлсэн зарчмуудыг хүндэтгэх нь эрх, хууль ёсны ялалтад үндэлэсэн дэг журмыг дэлхий дахинд тогтооход чухал шаардлагатай зүйл хэмээн үзэж буйгаа дахин нотолж; 3) түвдэд хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчиж, түүнчилэн түвдийн ард түмний соёл, шашны хосгүй илрэлүүдийг нухчин дарах нь олон улсын түгшүүртэй байдлыг даамжруулж, бүх дэлхийн ард түмнүүдийн хоорондын харилцааг ээдрээтэй болгоход хүргэнэ гэдэгт итгэж байгаагаа мэдэгдэж; 4) түвдийн ард түмний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчихөө зогсоохыг дахин уриалж; 5) энэхүү

тогтоолд илэрхийлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бүх хүчин чармайлтаа дайчлахыг НҮБ-ын гишүүн улсуудад хандан уриалж байна" гэсэн үндэслэлүүдийг нотолж байгаагаа мэдэгджээ. Гэвч гишүүн улсууд ийм хүчин чармайлт гаргаагүй юм.

1959–1961 оны үеийн Их Түвдийн байдлын тухай үнэтэй баримт бичиг буюу X Банчин ламын 70 мянган дүрс үсэг бүхий нууц илгээлт гэгч хадгалагдан үлджээ. Би энэхүү илгээлтийн зарим заалтыг дээр иш татсан билээ. 1962 оны тавдугаар сарын 18-наар огноолсон энэ баримт бичгийг "Түвд болон түвдийн бусад нутгийн ард олны зовлон гамшгийн тухай Илтгэл, эрхэм хүндэт ерөнхий сайд Жоугаар дамжуулан төвийн эрх баригчдад цаашдын ажлын талаар гаргах санал" хэмээн. нэрлэсэн байна. 1960–1961 онд Түвдээр аялан явахад Банчин ламд төрсөн дүгнэлт, ажиглалтыг энэхүү илтгэлд оруулсан бөгөөд тэрээр энэ үед ардчилсан шинэтгэл хэрхэн өрнөж буйг харжээ. 1961 оны нэгдүгээр сард тэрээр Мао Зэдунтай уулзаж, ажиглалтынхаа тухай түүнд ярьсан байна. Дарга Мао "зүүний алдааг" засах тухай удирдамж гаргажээ.

ХКН-ын төв хороо 1962 оны дөрөвдүгээр сарын сүүлчээр Бээжин хотод "Үндэсний асуудлаархи симпозиум" зохион байгуулав. Тэнд үг хэлсэн Түвд лам нар, ялангуяа лам Шаравжамц олны анхаарлыг татжээ. Хөх нуурт ХКН-ын явуулж буй хүүмүүсийг айлган сүрдүүлэхэд үндэслэсэн үйл ажиллагаа хятадын бүгд найрамдахчуудынхаас ч (гоминьданыхан) дор байна гэж гэвж Шаравжамц мэдэгджээ.[1307] Банчин лам ганцаар биш гэдгээ тэгэхэд ойлгосон байна. Тэрээр эргэж ирснийхээ дараа илгээлтээ бэлтгэж эхлэв. Уг илгээлт тавдугаар сар гэхэд бэлэн болсон байлаа. Гэвж Шаравжамц болон Банчин ламын багш Нгулчу Ринбүүчи нар хэл, найруулгын засвар хийж, харин Агваан Жигмэд "салан тусгаарлагчдын" эсрэг ялалт байгуулсных нь төлөө ХКН-ыг магтан сайшаасан дэлгэрэнгүй оршил бичихийг Банчин ламд ятгажээ.

Нгулку ринбүүчи энэ илгээлтийг явуулахгүй байхыг Банчин ламд ятгасан боловч тэрээр өөрийнхөөрөө зүтгээд үлджээ. Тавдугаар сарын 1-нд хятадууд нас барсан хоригдлуудын шарил дээр бүжиглэхийг тушааж байсан бөөнөөр хорих лагерийн тухай дүрслэлийг илгээлтийн эх бичгээс хасав. Тэр үед феодалууд болон гоминьданыхнаас илүү их гэмт хэрэг үйлдэж байсан тухай өгүүлсэн хэсгийг ч хассан байна. 1962 оны дөрөвдүгээр сараас зургадугаар сар дуустлах хугацаанд Бээжин хотноо орчуулагчдын гурван баг илгээлтийн эх бичгийг түвдээс хятад хэлэнд, бас Банчин ламд шалгуулахын тулд хятадаас Түвд хэл рүү хөрвүүлжээ. Банчин лам тавдугаар сард баримт

бичгийн агуулгыг Жоу Эньлайд илэрхийлж, зургадугаар сард хятад, Түвд хувилбаруудыг удирдлагад албан ёсоор танилцуулсан байна. 1992 онд энэ илгээлт ямар ч байсан хилийн чанадад гарч, англи хэлээр орчуулагдаж нийтлэгдсэн бөгөөд Орост энэ талаар таг чиг өнгөрчээ. 1987 онд Банчин лам нэмэлт баримт гаргаж ирсэн байна.[1308] Энд өөрийнхөө нүдээр харсан, бусдаас олж мэдсэн зүйлүүдээ өгүүлжээ.

У-Цанг, Кам, Амдогийн байдлын тухай баримтуудын хооронд уран цэцэн үг хэллэгүүд хавчуулсан нь илгээлтийн бараг тал хувийг эзэлжээ. Гэхдээ тэнд нөхцөл байдлыг сайн тийш хэрхэн өөрчлөх тухай маш ухаалаг санал хавсаргасан байна. Тийм найруулга зөвхөн БНХАУ-д л боломжтой байх биз ээ. Ингээгүйсэн бол илгээлт бүтэлгүйтэх байсан юм. Хууль бус үйлдэл, олон инйтийг хамруулсан гэсгээн цээрлүүлэлтийг зогсоож, хоршооллох үйл ажиллагаанаас татгалзаж, шашныг хавчин гадуурхахыг зогсоож, феодалууд болон сүм хийдийнхний амьд мэнд үлдсэн төлөөлөгчидтэй хэлхээ холбоо сэргээх боломж олгохыг санал болгожээ.

Банчин ламын хоёр илгээлтэд Түвд дэхь социализмын байгуулалтын өргөн цар хүрээтэй дүр зураг гарч иржээ. Юуны өмнө энэ бол уугуул хүн амыг үй олноор нь устган хөнөөж, бөөнөөр хорин хуаран болон шоронгуудад явуулсан хэрэг мөн. “Намын бодлогыг буруу ойлгосон зарим кадр ажилтан, офицерууд”; “түвдчүүд бол шашны итгэл үнэмшил болон биеэ тоох үзэлд хордсон зөрүүд ард түмэн” гэх маягаар ярьж түвдийн бүх ард түмнийг ноцтой гэмт хэрэг үйлдсэн гэх зэмлэл тулгаж, тэдний талаар ялгаварлан гадуурхсан бодлого баримталж, үндэснийх нь ёс журмыг зөрчсөн юм гэж энэ илгээлтэд өгүүлсэн байна.[1309] Шорон гяндан, хорих лагеруудад ч яс үндсээр ялгаварлан гадуурхах явдал илрэн гарч байсныг нэмж хэлж болох билээ.[1310] Хятадуудад түвдчүүдтэй харьцуулахад илүү хөнгөн ажил өгдөг, тэднийг бага “шүүмжилдэг”, хятад хуягууд болон хоригдлууд түвдчүүдийн “хоцрогдлыг” байнга гоочлон ярьдаг байсан юм.

Орон нутгийн эрх баригчид түвдчүүдэд хийсэн гэмийнх нь хүнд хөнгөнөөр ялгавартай хандаж байгаагүйг Банчин лам дурдатгалдаа өгүүлжээ. Гэм зэмгүй хүмүүст “самуун дэгдээгчийн” шошго зүүдэг байв. Энэ шошгыг бослого гарсан мужуудын хүн ам, тухайн үед зүгээр л тэнд явж байсан жирийн хүмүүст хамаатуулж байв. Дараа нь “самуун дэгдээгчдийн хамсаатан” хэмээх зэмлэл гарч иржээ. Бослогоос өмнө буюу 1957, 1958 онуудад “самуун дэгдээгчидтэй” ямар нэгэн байдлаар хэлхээ холбоотой байсан хүмүүсийг хамсаатан хэмээн зэмлэх ажээ.[1311] Хүмүүсийг шоронд хорьж, хөрөнгө хогшлыг нь хурааж байв.

Жишээ нь, шорон, хорих лагерьт 33 жил суусан Балданжамц гэдэг лам дурсан ярихдаа энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний удирдагчидтай зэрэгцэн зогсож татуулсан гэрэл зурагийг нь надаас олж авсныхаа дараа хятадууд миний номын багшийг баривчилсан юм гэжээ.[1312] Түвдчүүд дэлхийн хоёрдугаар дайнд холбоотнуудын байгуулсан ялалтад зориулсан баяр ёслолын ажиллагаанд оролцохоор энэтхэгт албан ёсоор очсон 1946 онд тэр гэрэл зургийг татжээ. Хятадууд танай багш Энэтхэгийн тагнуул байсныг хүлээн зөвшөөр гэж Балданжамц ламаас шаардах болсон байна. Буддын сургааль ёсоор бол номынхоо багшийг гүжирдэн гүтгэх явдал хамгийн нүгэлт үйлдлийн нэг ажээ. Ингэхээс татгалзсан ламыг хэдэн өдөр занчиж, хөлий нь газар хүрэхгүйгээр дүүжилсэн байна. Дараа нь түүнийг Лхасын бослогод оролцсон тухай асуудал гаргаж иржээ. Бослогыг хэн зохион байгуулсныг онцгой их сонирхох ажээ. Бослогыг түвдийн засгийн газар зохион байгуулсан тухай санаанаас зохиосон үндэслэлээ “нотлох” шаардлага хятад удирдлагад гарсан бололтой юм.

Түвдийн бүх түүхэнд гарч байгаагүй тийм олон хүн хоригдож байлаа. Тэднийг агуулах газрын тухайд хүндрэл үүсэв. Түвдийн шоронгууд хүрэлцээгүй, дээр нь тийм олон хоригдлыг эх орond нь байлгана гэдэг аюултай. Тиймээс хоригдлуудыг хятадын шорон, бөөнөөр хорих лагерууд руу бөөн бөөнөөр нь зөөж эхэлжээ. Хэдэн жилийн дараа хятадууд тэдний заримыг түвдийн шоронгууд руу зөөж эхэлсэн бөгөөд шоронгийн тоо ч богино хугацаанд олон болов. Тэндхийн хуяг, харгалзагчаар хятадууд төдийгүй түвдүүдийг ч авч ажиллуулжээ. Чамдо мужид баривчлагдсан хүмүүсээс 5 мянган хүнийг Маркхамд, 3 мянгыг Чамдогийн хуучин хийдэд, 8 мянган хоригдлыг Ца Помдад тус тус суулгажээ. Хожим энэ хүмүүсийн олонхи нь өлсгөлөн, гачигдлаас болж насан өөд болсон байна. Хөх мөрнөөс зүүн тийшхи Камын түвдчүүдийг, Дарцедогоос зүүн тийш орших тугалганы уурхай руу, Дарцедогоос баруун тийш орших Миньякийн бөөнөөр хорих лагерь руу явуулжээ. Нийтдээ тэнд хэдэн арван мянган түвд, хятад хүмүүс хоригдож байсны олонхи нь нас баржээ. Амдогийн түвдчүүдийг Синин, Ланьжоугийн шоронгууд, Шинжаан, Хөх нуурын бөөнөөр хорих лагеруудад явуулав. Бөөнөөр хорих лагерууд үнэ төлбөргүй ажиллах хүчний чухал эх булаг болж байлаа. Түвдэд босгосон зарим томоохон байгууламжийг хоригдлуудын хөдөлмөргүйгээр төсөөлөхөд бэрх юм.[1313]

Шорон, бөөнөөр хорих лагерийн хоригдлуудын олонхи нь жирийн түвдчүүд байсныг улс төрийн хоригдол байсан хүмүүс надад ярьсан билээ. Жишээ нь, Драпчигийн шорон зургаан хэсгээс бүрддэг, тэдгээрт хоригдох

хүмүүсийн тоо ерөнхийдөө ойролцоо. Язгууртнуудыг зөвхөн тавдугаар хэсэгт хорино. Ядуу гаралтай хоригдлуудад социалист хувьсгалд туслахыг зааварлаж, ангийн дайснуудыг зааж өгөхийг шаардах ажээ.

Банчин лам бичихдээ: "Түвдийн цэргийн тойргийн шоронгуудад хоригдож байсан дээд давхаргынхан, Нам, Төрийн хуулийн дагуу ердийн шоронгуудад байсан засаг захиргааны цөөн тооны хүмүүсийг эс оролцуулбал бусад олонхи шоронгийн хариуцлагатай ажилтнууд хоригдлуудын амь нас,эрүүл мэндийн талаар анхаарал тавьдаггүй байв. Түүнээс гадна шоронгийн хуяг болон кадр ажилтнууд тэндхийн хоригдлуудыг элдэв муу муухай үгээр хараан доромжилж, тэднийг энэ тэр гэж ялгалгүй бүгдий нь хэрцгийлэн зодно. Мөн хоригдлуудыг цаг ямагт нэг газраас нөгөөд, уулнаас нам дор газар руу, хүйтнээс халуун газарт, умраас өмнө зүгт, өндөрлөгөөс тал руу, дээш, доош нь шилжүүлэн зөөж, хоригдлуудад шинэ нөхцөл байдалд дасах боломж үл олгоно.

Хувцаслаад ч, хөнжилдөө ороод ч дулаацахгүй, чийглэг газар учир гудас хатаж амжихгүй, хоригдож буй майхан, байшинцарууд бороо, салхинаас хамгаалж чадахгүй, хоол хүнс үл хүрэлцэнэ. Хоригдлуудын амьдрал үнэхээр тэсвэрлэхийн аргагүй, тэд өглөө эрт босч ажилд гарна, орой болсон хойно буцаж ирнэ. Хоригдлуудаар хамгийн хүнд, хүчир ажил хийлгэх тул хүч чадал нь өдрөөс өдөрт муудна. Хоригдлууд байнга өвчин тусна, түүнээс гадна хангалттай амарч чадахгүй. Эмнэлгийн үйлчилгээ муу учир олон хоригдол зүй бусын шалтгаанаар нас барна. 50–60-аас дээш насны хоригдлууд сул дорой биетэй, үхэхийн даваан дээр байсан ч биеийн хүчний хүнд ажил хийхийг шаардана" гэжээ.[1314]

1960-аад оны эхээр улс орон өлсгөлөнд нэрвэгдсэний дараа нөхцөл байдал онцгой хүнд болсон гэж хоригдол байсан Даваацэрэн дурсчээ.[1315] Өдөрт хоёр удаа хоригдол бүрт арвайн буюу эрдэнэ шишийн гурилаар хийсэн нэг аяга шингэн бантан өгч, зарим үед зүсэм шар манжин хайрлах ажээ. Хүмүүсийн бие сульдаж, юм л бол хэвтэхийг эрмэлзэнэ. Өлссөн сэтгэлээ хуурахын тулд гутлынхаа түрийнээс хэсэг шир тасалж аваад л өдөржин зажлана. Өлсгөлөн улам хүчтэй болоход шоронгийн харгалзагч нар хоригдлуудад хэсэг хэсгээрээ гарч, элдэв төрлийн өт хорхой, жимс тэргүүтэн түүх зөвшөөрөл өгнө. Хоригдлуудаас олон хүн эргэж ирээгүй ажээ. Хэвтээ,суугаа, чулуу түшээд үхсэн хүмүүсийн араг яс олсон тухайгаа хожим нь тэнүүлч хүмүүс ярьсан байдаг. 1962 онд Драпчигийн шоронгийн харгалзагч нар хоригдлуудын нэрийг дуудаж тооллого хийхдээ тэдний тоо цөөрснийг олж мэджээ. "Өлсгөлөнгөөр нас барсан" гэж хариулж болохгүй,

яагаад гэвэл социализмын үед өлсгөлөн байж болохгүй.[1316]

Баривчлагдсан хүмүүсийг эрүүдэн шүүнэ. Энэхүү эрүү шүүлтийн төрөл болон цар хэмжээ феодалуудыг илчлэн бичигчдийн зураглалаас хэд дахин давах ажээ. Мао Зэдун бүр 1943 онд эрүү шүүлтийн тухай: “Эрүү шүүлтийг хэт эрт буюу хэт орой зогсоох хэрэггүй, хор хохирол нь хэтэрхий их байх болно... Ийнхүү гол баримтлах дүрэм бол нягтлан ажиглаж, бүхнийг цаг хугацаанд нь хийх явдал мөн” гэж хэлжээ.[1317] Гэтэл хятадууд баривчлагдсан түвдчүүдэд олон төрлийн эрүү шүүлт тулгах ажээ. Хоригдлыг их цас орж байх үед гадаа нүцгэн суулгах буюу үстэй малгай өмсгөн халуун наранд зогсоож: олон хоног унтуулахгүй байлгана; үйрмэг ясан дээр нүцгэн өвдгөөр нь суулгана; холбож хүлсэн гар болон хөлөөс нь дүүжилж элдвээр тамлана; жагсаалын өмнүүр явуулж хүн бүрээр нударга хүртээлгэнэ; хамрынх нь нүхэнд хуруугаа хийж, шанаанд нь тултал түлхэж унагана; хүйтэн жаварт эмнэг илжгэн дээр нүцгэн суулгаж булгиулна.[1318] Мөн түүнчилэн хоригдлын хоёр гарыг ард нь хүлж, хөлнөөс нь дүүжилнэ; бүсэлхийг нь хүртэл газарт булж, нойтон арьс толгойд нь нөмөргөж, амьсгалах агаар орохгүй болтол нь битүүлнэ; нүдий нь боож, галаар түлнэ; шээх аргагүй болгосны дараа ам руу нь цай цутгана (бөөрний ачаалал хэтэрснээс болж гол төлөв нас барна); эмнэг сарлаг буюу моринд мордуулан хүлээд тавьж явуулна: халуун зүүгээр түлэх, толгой дээр нь халуун ус асгах зэргээр тамлах ажээ.

Нэг удаа ялынхаа хугацааг дуусгасан хоригдлуудыг өвлийн хүйтэнд анжисанд хөллөж, түүн дээр суусан хятад цэрэг газар хагалахыг тушааж ташуурдаж байсан тухай лам Балданжамц дурсаж ярьсан байна.[1319] “Хамжлагынхнаас чөлөөлөгдсөн” энэ хөдөлмөр малын билчээрийг хагалсан газар болгоход хэрэгтэй болсон ажээ. Хүнд жинтэй, бариу төмөр гав өргөн хэрэглэж байжээ: нэг хоригдолд дөрвөн жил хөлийн гавтай байх ял заасан байна. Ажил хийхдээ ч, халуунд ч, хүйтэнд ч түүнийг авдаггүй байна. 1959 онд баривчлагдсаныхаа дараа ямар учрал тохиолдсон тухайгаа улс төрийн хоригдол байсан Т. Чойдрог ийнхүү ярьжээ.[1320] Шоронд ороход хөлийн гав зүүлгэнэ. Ингээд “тэмцэлд” оруулж эхэлсэн. Ингэхийн тулд олсоор битүү ороож хүлээд хоёр гарыг нурууны ард гаргаж холбон хүлж, тохойны дээх нь талаас дүүжилнэ. Хамаг үе мөч мултарах бөгөөд нүүр, толгой руу цохиж, үс, чихнээс зулгааж, нүүр өөд нулимана. Гол зорилго нь Далай ламаас татгалзуулах явдал. Цохиж зодуулснаас төдийгүй үе нь мултарсан гар өвдсөнөөс болж үе үе ухаан алдана. Ухаан ормогц дахиад л тамлалт эхэлнэ. Барагцаалбал нэг сарын завсарлагатай дөрөв дөрвөн цагийн хугацаатай хэд хэдэн удаагийн “шалгалт” авна. Нүд гэмтэх, шүд унах явдал эрүү шүүлтийг

үргэлжлүүлэхэд огт саад болохгүй. Эрүү шүүлтийн хооронд 1 х 2 м-ийн хэмжээтэй өрөөнд ганцаараа хоригдоно. Шоронгийн эмч хэлмэгдэгчийг амь оруулах хариуцлагыг өөрөөсөө зайлуулсан цагт л тэр бүх тамлалт зогссон билээ.

1959 оны аравдугаар сард Чойдрог болон бас 79 хоригдлыг нэг машины тэвшинд 38 хүнээр багцлан ачиж түвдээс хятад руу авч явжээ. Тэд 10 хоногийн турш машин дээрээ зогсоогоороо явах ёстой байв. Тэднийг Хөх нуурын район, тэндээс галт тэргээр шоронд хүргэжээ. Тэнд хоригдлууд шахцалдсан өрөөнд хоригдож, талбайд ажиллах ажээ. Ажил дууссаны дараа оройн 22 цаг хүртэл "дахин хүмүүжүүлэх" ажил эхэлнэ. 1960 оны тавдугаар сард хоригдлуудын хэрэглэх хоолны хэмжээг сард 16,5 фунт үр тариа байсныг 8,5 болгож бууруулав. Тариаг модны холтос, хүнсний биш ургамалын үндэстэй холино. Зургадугаар сар гэхэд бүх хоригдол бараг л араг яс болжээ. Ажил дууссаны дараа хүмүүс үхэтхийн унаж, босч чадахгүй болох ажээ. Зарим хүн өлсгөлөнгөөр нас барав. Үлдсэн хэд нь гутлынхаа түрийнээс огтлон идэж, мэлхий, чийгийн улаан хорхой болон элдэв шавьж барих ажээ. Шоронгийн хаггалзагч нарын хаясан хоолны үлдэгдлийг замын хажуугаас түүж авна. 1962 оны аравдугаар сар гэхэд 79 Түвд хүнээс 21 нь амьд үлдсэн байлаа. Тэднийг эх орон руу нь явуулж, Драпчи шоронд шилжүүлэв. Бүх чөлөөт цагийг "дахин хүмүүжүүлэх", алдааг нь "хүлээн зөвшөөрүүлэх", нөхдийнхөө тухай мэдээлэл өгөхөд зориулна. Баривчлагдсанаас хойш 13 жилийн дараа 17 жил хорих ял оноожээ.Үүний дараа нөхцөл арай сайжирч: Сангьипын шоронд шилжүүлж, зөгийлөөр чулуу бэлтгэх ажилд тавьсан байна. Хэсэг хугацааны дараа эмчийн магадлагаагаар шоронгийн эмнэлэгт ажиллуулах болсон байна. Далай ламын төлөөлөгчдийн айлчлалын дараа буюу 1980 онд суллажээ.

Түвд хоригдлуудыг талбайд үүр гэгээрэхээс од түгэх хүртэл ажиллуулдаг байсан гэж бөөнөөр хорих лагерьт хорин жил болсон Тенпа Сопа гэрчлэн ярьжээ.[1321] Боолын хөдөлмөрийг "алдаагаа ажил хийж засах явдал" хэмээн нэрлэх ажээ. Өвчин туссан хүмүүсийг тэр болгон эмнэлэгт хэвтүүлдэггүй, зарим хүн ажил дээрээ нас бардаг байв. Өдрийнхөө нормыг биелүүлээгүй хоригдлуудыг шоронгийн харгалзагч нар зодож, оройн цагаар өөрсдийн хүмүүс "шүүмжлэх", өөрөөр хэлбэл дахиад л зодно. Ажил дууссаны дараа дахиад л "дахин хүмүүжүүлэх" ажил эхлэх ажээ. Хоригдлуудыг хэд хэдэн бүлэгт хуваана. "Засраагүй" хүмүүст хоригдох хугацааг нь сунгах буюу нэмэлт ажлын цаг өгнө. Сард нэг л өдөр амрах ажээ. Гэхдээ энэ өдрүүдэд суртал нэвтрүүлэг юу шаарднав түүнийг л хийх хэрэгтэй болдог ажээ.

Ийнхүү хаврын баяр, тавдугаар сарын 1, бүгд найрамдах улсын өдөр гэж жилд гуравхан. өдөр амарна.

Хойд зүгийн цөлөрхөг тал газрын районы Жанг Цалакха гэдэг газарт байх таван шоронд 10 мянга гаруй хүн хоригдож, тунсаа (гагнуур хийхэд хэрэглэдэг нунтагласан чулуулаг) олборлож, тээвэрлэх ажил хийнэ.[1322] Тэнд өлсгөлөн, зодуур, сульдаанаас болж өдөр бүр 10–30 хүн, жилд 8 мянга гаруй хүн нас барсан юм гэж тэнд хоригдож байсан хүмүүс ярьж байна. Лхас хотын ойролцоох Начений усан цахилгаан станцийн барилга дээр (ХАЧА барьсан гэгддэг) өдөр бүр 3–4 хүний шарил шатаах буюу гол руу хаядаг байжээ.

1959 онд Дарцедогийн районд өдөрт гурван аяга бантангаас өөр юу ч өгдөггүй, харин усыг бол харамладаггүй байсан гэж хоригдол байсан нэгэн эмэгтэй ярьжээ.[1323] 1960 онд тэр эмэгтэйг Голтокийн тугалганы уурхайд шилжүүлсэн байна. Ажил гэдэг хүнд, хоол унд ч багассан нь өлсгөлөн эхэлсэнтэй холбоотой ажээ. Эрчүүд усан бантандаа өт хорхой хийдэг бол хүүхнүүд ингэхээс айна. Шоронгийн даргын хэлснээр бол 1960-аас 1963 оныг дуустлах хугацаанд тэнд 12019 хоригдол нас баржээ. Ганьсу мужийн Чю-Чоны шоронд хоригдож байсан 76 хүнээс 1959 оноос 1962 оныг дуустлах хугацаанд 53 хүн хорогдсоноос нэг хэсэг нь өлсгөлөн болон хүнд хүчир ажлаас болж нас барж, бусад нь цаазлуулжээ.[1324] Үлдсэн хүмүүсийг Лхас дахь Драпчигийн шоронд шилжүүлжээ. 1979 онд тэндхийн сүүлчийн хоригдол суллагдахад дээр дурдсан 76 хүнээс дөнгөж долоо нь амьд үлдсэн байлаа. Конгпод хоригдлуудын гуравны хоёр нь нас барсан байна.[1325] Зарим хорих газарт нас барсан хүмүүсийн хүүрийг өвлийн хүйтэнд гадаа өрж хадгалах бөгөөд хоригдлууд өлсөж үхэхгүйн тулд заримдаа тэр хүүрнээс иддэг байжээ.

Түвдийн насанд хүрсэн эрчүүдийн бараг тэн хагасыг шорон,бөөнөөр хорих лагерьт хорьсон бөгөөд тэд бараг бүгдээрээ өлсгөлөн болон бусад шалтгаанаар насан эцэслэсэн юм гэж X Банчин лам гэрчлэн бичжээ. Түвдийн хүн амын 5 орчим хувь шоронд орсон гэж тэрээр 1962 онд хэлсэн байна. Гэвч Банчин лам 18 жил шоронд сууж гарч ирээд 1987 онд хэлэхдээ: “Тэр үед миний авсан мэдээллээр бол энэ нь 10–15 хувь байсан юм. Хэрэв би ийм том тоог зориглож хэлсэн бол тамцингаар нас барах байсан бизээ” гэсэн байна.[1326]

“Тамцинг” гэдэг нь түвдээр “тэмцлийн арга” буюу “шүүмжлэл” (доу жэн хуй хэмээх хятад үгнээс гаралтай тэмцлийн цуглаан гэсэн утга) гэсэн санаа илэрхийлнэ. Сонгож авсан хүмүүст хүч хэрэглэх буюу сүрдүүлэх

аргаар “алдааг нь хүлээлгэнэ”. Заавал хэрэгжүүлэх үйл бол доромжлон гутаах, хувьсгалын эсэргүү, харгис этгээд хэмээн зэмлэн буруутгах явдал юм. Энэ “тэмцэл”жанчин тамлах агуулгатай бөгөөд “ард олноор” тусгай цуглаан дээр гүйцэтгүүлж олон дахин давтагдах ба энэ үед хятад түшмэлүүд өөрсдөө оролцолгүй алсаас харан зогсож: “ардын уур хилэнг” харуулах ёстой байжээ. Хятадууд эхэлж тамцингийг яаж явуулах, алахаас наагуур хэрхэн зодож занчихад сургана. Гэмтэн этгээд бүх зүйлийг зөвшөөрч, буруугаа хүлээх ёстой. Толгойгоо гудайлгах буюу мэхийн зогсох ёстой. Шүүгдэж буй хүн нас барах явдал цөөнгүй гарах бөгөөд заримдаа тамцинг цаазаар дуусна гэж Камын нэгэн хоригдол надад ярьсан билээ.

“Тэмцлийн цуглаан” бол Мао Зэдуны үеийн ХКН-ын хосгүй арга мөн. Энэ бол шүүхийн шийдвэргүйгээр залхаах (тулгасан ялыг нотлох хэрэггүй), гутаан доромжлох, эрүү шүүлт тулгах, заримдаа олон хүн оролцуулсан үзэл суртлын цулаан хийх, айлган сүрдүүлэх замаар хүний амь хороох явдлыг хослуулсан арга мөн. Өөр ямар ч дэглэмд энэ бүхнийг хослуулан хэрэглэх санаа төрөхгүй байсан бизээ. Хүмүүс тийм цуглаанаас айдаг байжээ. Ийм цуглаанд оролцохоос татгалзах зориг гаргасан тэрхүү цөөн тооны хүн дайсан хэмээн зарлагдаж, дараа нь өөрсдөө “тэмцлийн” хэлмэгдэгчид болдог байв.[1327] Эхлээд тийм хүнд “та хүйтэн царайтай хүн юм” гэж хэлж болох ажээ.[1328] Энэ нь дараачийн цуглаан дээр тэр хүн хэн нэгний үснээс зулгаах буюу элдвээр доромжлох зэргээр авирлах, өөрөөр хэлбэл “тэмцэх” болжээ гэсэн үг юм. Татгалзвал баривчлагдана.

Мао бүр 1927 онд “тариачдын хувьсгалт тэмцлийг буруутгаж, зэмлэсэн хандлагад” хариулж хэлэхдээ.[1329] “дайснууд”, шашин, уламжлалтай харьцах дараах аргуудыг илэрхийлжээ: “Тосгон бүрт түр хугацааны харгислал явуулахаас өөр аргагүй... Тариачид хэсэг бүлгээрээ газрын эздийн гэр оронд дайран орж, дэндүү чанга биш хэлбэрээр байцаалт явуулна. Ингэсний дүнд тийм хүмүүсийн олонхи нь гэм буруугаа “хүлээснээ” бичнэ <...> Шовгор малгай өмсгөн авч явах. Энэ аргыг газар сайгүй байнга хэрэглэнэ. Газрын эзэд болон нударган баячуудад тэр гэдэг нударган, тэр гэдэг газрын эзэн гэсэн бичигтэй өндөр шовгор цаасан малгай өмсгөж, олон хүн дагалдуулан олсоор хөтлөн гудамжаар авч явна. <...> Гацаа бүрт хамгийн харгис, хамгийн гэмтэй хэд хэдэн ийм хүнийг буудан хороох хэрэгтэй. Ингэх нь харгис хүчнийг нухчин дарах хамгийн үр нөлөөтэй арга байж чадна. <...> Газар сайгүй орон нутгийн тариачдын холбоод сүм хийдийн эд хөрөнгийг хураах шаардлага тавьж байна. <...> Лилин гацаанд мухар сүсгийн зан үйлийг хориглож, янз бүрийн бурханы дүр зурагийг устгахын төлөө хөдөлгөөн

нилээд хүчтэй өрнөж байна. <...> Дунфусы сүмд суралцагч залуус тариачидтай хамтран гуч гаруй модон сийлбэр бурханы дүр шатаажээ. <...> 1927 онд хятадын хөдөө орон нутагт 336 сая хүн аж төрж байсны 45 хувь нь газар эзэмшдэг, тэдний 32 хувь нь нударган баячууд, газрын эзэд байсан юм. Ингэхлээр 48,4 сая хүний тухайд л харгислал явуулсан юм"[1330] гэж онцлон тэмдэглэсэн байна.

1959 оны хоёрдугаар хагаст аливаа хүний гэмт хэргийг түүний гарал үүслээс шалтгаалан тодорхойлдог байлаа.[1331] Жишээ нь, X Банчин ламын эцэг ямар нэгэн муу үйл хийгээгүй боловч "хамжлагын эздийн" ангиас гаралтай байсан. Тэр хүн Шигазед "ард олны өмнө алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрч, гэм буруугаа хүлээжээ". Гэсэн ч орон нутгийн ажлын бригадын гишүүд түүний эсрэг "тэмцэл" явуулж эхэлжээ. Ингээд түүнийг цугларсан олны өмнө суулгаж, уг бригадын идэвхтнүүд хэрцгийгээр зоджээ. Өөр нэг язгууртан хэрэгт холбогдож буй хүнд янжуур асааж өгсний төлөө "тэмцлийн цуглаанаар" шүүгдэж: түүнд ажилчин ангийн сайхан сэтгэлийг худалдаж авахыг эрмэлзсэн хэмээх зэмлэл тулгасан байна.[1332]

Цуглааны өөр нэг хэлбэр бол дукчу буюу "гашуудлын нулимс" хэмээх арга ажээ.[1333] "Хамжлагынхны" бурангуй үйлдлийн шалтгааныг илрүүлэхийн тулд "хуучин шархаа ил тод харуулахыг", өөрөөр хэлбэл "хамжлагат ёсны харгис байгууллын үед бусдын эсэргүүцлийг нухчин дарж байсан" бүх тохиолдлуудаа дүрслэн үзүүлж, уйлан хайлж гэмээ наминчлахыг шаардах ажээ.

Гадаадын, жишээ нь "Правда", "Юманите", "Дейли Уоркер" зэрэг сонины сурвалжлагчид ирэхэд энэ нь онц чухал арга ажээ. Эрх баригчид тийм айлчлаыг урьдаас төлөвлөж, улс төрийн элдэв жүжиг сайтар бэлтгэж, гадаадынхныг хятад кадр ажилтнууд дагалдаж, тэдний хяналт дор төвдчүүд шаардлагатай ярилцлага өгдөг ажээ. Мэдээжийн хэрэг энэ тохиолдолд хэнийг ч эрүүдэн тамладаггүй, алж хороохгүй. Сурвалжлагын үр дүнг ч урьдаас төлөвлөсөн байдаг. Төвдийн байдлыг одоо ч "энэ нотолгоогоор" дүгнэдэг нь харамсалтай билээ.[1334]

1959 онд гадаадын хэсэг сэтгүүлчийн Төвдэд хийсэн аялал тийм хууран мэхлэх ажиллагааны нэг тод жишээ болжээ. Лхас хотод гадаадынхан ирэх гэж байгаа тухай нэг удаа бидэнд мэдээлсэн юм гэж хоригдол байсан хүмүүс дурсаж ярьсан юм.[1335] Хятадууд хийдэд байсан шашны эд зүйлсийг эргүүлэн тавьж, зул асаажээ. Хоригдлуудыг сайн хооллож, гадаадынхан ч тэдэнтэй гэрэл зураг татуулах ажээ. Хийдэд чех, зөвлөлт, британийн зочид ирэх үеэр лам нарт хурал хурахыг зөвшөөрч байсан тухай ялтан байсан

өөр нэг хүнярижээ. Жирийн үед бол лам нараар хурал хураалахын оронд үхэр малын баас арилгуулж, шавар, тоосго зөөлгөж, мод тариулж, талбайд ажиллуулдаг байжээ.

Тэнд мөн зөвлөлтийн сурвалжлагч очжээ. Тэрээр олон Түвд хүнээс ярилцлага авсан байна. Бүгд л ХКН-ын бодлогыг халуунаар дэмжих ажээ. Жоканд "феодализмын аймшигт явдлын" тухай үзэсгэлэн үзүүлсэн байна. Мэдээжийн хэрэг тэнд эрүү шүүлтийн хэрэгслүүд, хүний ясаар хийсэн элдэв зүйлс тавьсан байв. Жишээ нь, мөнгөн хамар, хиймэл нүдтэй гавлын яс байна.[1336] Өнөөдрийн суртал нэвтрүүлэгчид энэ тухай огт дурсахгүй байна. Харин ч иймэрхүү бэлэг дурсгалын зүйлс хийдэг болжээ. Ийм бэлэг дурсгалын зүйлсийг түвдэд төдийгүй бусад оронд ч чөлөөтэй худалдан авч болно. Хэн нэгнийг хүний амь хороосон хэрэгт буруушаах бодол хэний ч толгойд орж ирэхгүй бизээ. Шүүгч нар буруутай этгээдийг дөрвөн бэрх хаях аргаар тодорхойлж байсан мэт яриа ч одоо сонсогдохоо больжээ.

Дрепун хийдийн том толгой гурван ламыг "тэмцлийн цуглаанд" оруулж байсан тухай манай сурвалжлагч дүрслэн бичжээ.[1337] Эхлээд бага зиндааны лам нар "харгис толгойлогчийнхоо" тухай жүжиг тавина. Дараа нь түүнийг өөр хоёр ламын хамт хийдийн хашаанд гаргаж ирээд бэлхүүсээр нь мэхийлгэж зогсооно. Тэдний нэгийг "Бурхны өмнө тавьсан замбай" гэж доромжлоно. Үүнийг гадаадынханд тайлбарлахдаа баяр ёслолын үеэр Бурхны баримал дүрийн өмнө арвайн гурилан замбайг бөөрөнхийлж өнхрүүлээд гадна талыг нь будаж тавих бөгөөд тэр бөөрөнхийлсөн гурил дотор талдаа өмхийрч муудсан байдаг. Ингэхлээр өмхийрсөн өргөл тавьж байсан хэрэг хэмээн тайлбарлана. Дараа нь илчлэгч бага зиндааны лам нар ширээний ард сууж сүм хийдүүдэд, бас тэдгээрийн гадна талд байх самуун дэгдээгчид болон тамлагчид шашны эд хэрэгсэл хийх хүний гавлын яс олж авахын тулд хамжлагын тариачдын амийг хөнөөхийг эндхийн шоронгийнхонд тушааж, бусад хүмүүс өлсөж байхад тэд улам таргалж, худалдаа арилжаа хийж, хүмүүсийг хууран мэхэлж, нүгэл үйлдэж байсан юм гэж зочдод ярьж эхлэнэ. <...> Ингээд тэмцлийн цуглаан дуусч, ирсэн зочид ч үдийн хоол зооглох цаг болох ажээ.Лам нарыг харгалзагчид автобусанд аваачиж суулгана гэж тэр сурвалжлагч бичсэн байна. "Шахцалдсан нарийхан гудамжаар элдвийг сонирхон явах манай сурвалжлагчийн нүдэнд өнөөдрийн бүх үйл явдал:давхарлаж тавьсан алтан гулдмайнууд, өмхий самхай үнэр танар, мөргөлийн өрөөнүүдийн таазнаас унжих тортог, хятад пионеруудын дуу аялсан ламхай нар дахин харагдах ажээ".

Гадаадынханд зориулж амбан захирагч асан Цэвээндорж Лхалутай



Амбан захирагч асан Лхалутай “тэмцэх цуглаан”. Түүний цаана зүүн гар талаас гадаадын сурвалжлагч харагдаж байна (Домогацких, 1962)

“тэмцэх цуглаан” зохион байгуулжээ. Манай сурвалжлагч үүнийг ч дүрслэн бичжээ:[1338] “Хашаан дотор олон зуун хүн сууж, хашгиралдаж, нударга зангидан харуулна. Тэдний зэргэлдээ хуванцар эдээр бүтээсэн ширээ засчээ. Ширээний ард “саньфань” хорооны шүүгчид сууж, “гурвыг эсэргүүцэх” ажиллагаа явуулна. Цэвээндорж бүсэлхийгээрээ мэхийн зогсоно. 1959 оны бослогын удирдагчдын нэг байснаа хүлээн зөвшөөрнө. Гэтэл нэгэн залуу босч түүнийг Чамдод авга ах Геда ламыгаа хордуулсан гэж буруушаах ажээ. Захирагч асан Геда ламыг яаж хордуулсныг нэгбүрчлэн ярина. Тэр залуу уг үйлдлийг хараад зогсож байсан юм болов уу? Нэгэн хамжлагын тариачин босч ирэн Цэвээндоржийн эдлэн газарт байсан шорон руу заах ажээ. Тэхнээ

нь тэр хүн торгууль төлөөгүйн хэргээр тэнд сууж байсан ажээ. Үзэгчдийг шоронд дагуулж оров. Тэндхийн нэгэн хананд олон хадаас зоож орхисныг хүмүүс олж харав. Тэр том хадааснуудаас хоригдлуудыг хүлж өлгөөд үхтэл нь зодож тамалдаг. Хажууханд хилэнцэт хорхой хийдэг хайрцаг байна. Өлсгөлөн харх арзаганасан хонгилд үхсэн хүн аваачиж хаяхад нэг хоногийн дараа хоосон араг яс үлддэг байжээ. Нас барсан хүмүүсийн яс шалаар нэг тарсан харагдах ажээ. Үзэгчид гарч ирэв. Жүжиг үргэлжилсээр. Нэгэн залууг хүмүүс дундаас үсрэн гарч ирэхэд хөгшин эмээ дөхөж очино. Тэд уулзангууд уйлаан майлаан болох ажээ. Хамжлагын эзэн гэр бүлүүдийг төөрөлдүүлж, хүмүүсийг тамлаж байсан болж таарваа. Цугларагсдыг тансаг шилтгээнд дагуулж оров. Тэнд тавьсан зүйлс гэвэл: дарс, мебель тавилга, сав суулга, алт, шүр, сувд, чихэр, цагаан будаа, гурил, шар тос, бас ээ, бурхан минь!, ХБНГУ-ын гар буу байх нь тэр. “Канцлер Аденаурын эх нутгаас герман шар айраг төдийгүй бас герман зэвсэг энд ирдэг байсан болох нь”. Хүмүүсийг дахин гадагш гаргав. Модон хайрцагнаас өрийн данс гаргаж ирэн уншихад хүмүүс орилолдох ажээ. Тэр дансыг хүмүүсийн нүдэн дээр их л бахдалтайгаар шатаана. Хэдэн зуун хүн “заналт боолчлол, хамжлагат ёс сөнөтүгэй” хэмээн дуу нийлүүлэн орилох ажээ. Тэрхүү эдлэн газрыг харилцан туслах бригадуудад өгөв” гэжээ.

Энд төгсгөлийн үг хэлбрээр хэдэн зүйл нэмье: Цэвээндоржийг Драпчигийн шоронд хорьжээ. Тэрээр 1965 онд суллагдаж гарч ирээд тариачин болсон байна. 1983 онд түүнийг цагаатгаж, Хятадын үндэсний улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Түвдийн хорооны орлогч дарга болгожээ. Энэхүү цагаатгал хүн хордуулсан тухай, хананд өлгөөтэй хадаас, хилэнцэт хорхой, өлсгөлөн харх, үхсэн хүний тарж бутарсан ясны тухай асуултад ийнхүү хариу барьсан ажээ.

Бусад сэтгүүлч, жишээлэхэд америкийн сурвалжлагч эмэгтэй А.-Л. Стронг ч өөрт төрсөн сэтгэгдлээ дурсан бичжээ. Хожим нь түүний номууд БНХАУ-д хэвлэгдэж, тэр өөрөө ч улаан хамгаалагчдын эгнээнд орсон байна. Стронг ардчилсан шинэтгэлийг таларханх дэмжиж, олон хүнээс ярилцлага авч, “тэмцлийн цуглаан” болон элдэв төрлийн үзэсгэлэн харж явжээ.[1339] Тэр эмэгтэй болон Домогацкий нар нэг үйл явдлыг хэрхэн дүрсэлж бичсэнийг харьцуулан үзэхэд сонирхолтой байх бизээ. Тэд ХКН-ын бодлогыг янз бүрийн уншигчдад зориулж өөр өөр байдлаар магтан дуулсан байна. Жишээ нь, Стронг лам нарыг хүний амь нас хөнөөсөн, зодож занцдаг байсан, баньдиддаг байсан гэх зэмлэл нотлогдоогүйг тэмдэглэжээ.

1963 онд бодит баримтын олон алдаа бүхий “Хамжлагын тариачин”

хэмээх бараг л үлгэрийн гэхээр хятад кино гарчээ. Тэр киног Лхаст залхтал нь үзүүлсэн байна. Энэ кино ард түмэнд “дарлан мөлжигчдийг” үзэн ядах сэтгэл төрүүлэх ёстой байв. Кино үзэх үед феодалуудад талархан хандагч хэмээх зэмлэлд орохгүйн тулд уйлж суух хэрэгтэй болж байжээ. Зарим хүн нулимс гаргасан болж харагдахын тулд нүднийхээ доод зовхинд гавар түрхдэг байв.[1340]

Х Банчин лам: “1959 оны тавдугаар сард манай аугаа их удирдагч дарга Мао, Ерөнхий сайд Та... Намын Төв Хороо шашныхаа бодлогоор лам, хар бүх олон түмэнд шашны итгэл үнэмшлийн эрх чөлөө олгоод зогсохгүй хууль журам сахигч сүм хийд, сүсэгтэн олныг хамгаалж, урьдын адил “сургааль айлдах, ном хаялцах, ном зохиол туурьвихыг” оролцуулан шашны үйл ажиллагаа явуулахыг бидэнд зөвшөөрнө... хэмээн цохон тэмдэглэсэн билээ” гэж бичжээ.[1341] Гэтэл бодит байдал дараах байдлаар эргэсэн байна.

Шинэтгэлээс өмнө Их Түвдэд санваартнууд хүн амын 10-аас доошгүй хувийг эзэлж байжээ. Агваан Жигмэдийн хэлснээр бол 1959 он гэхэд 2467 хийд, 110 мянга гаруй лам болон гэлэнмаа нар байв.[1342] Хятадын талын мэдээгээр бол 1958 онд Түвдэд үйл ажиллагаа явуулдаг 2711 сүм,хийд байсан бол 1960 онд 370 болтлоо цөөрчээ.[1343] Энэ бол ирээдүйн Түвдийн өөртөө засах орны дүр төрх: Их Түвдэд бол 6259 хийд болон шашны бусад төв байв.[1344] Хятад эх сурвалжаар бол 1958 оноос өмнө Хөх нуурт 722 Түвд хийдэд 57647 лам, 2500 гэлэнмаа шавилан сууж байжээ.[1345] Ардчилсан. шинэтгэлийн дараа тэнд 11 хийд л бүтэн үлдсэн байна. Мөн энэ мэдээгээр 1958 онд Ганьсуд 369 хийд байжээ. Дөнгөж найман хийд хаалгаа барилгүй үлдэж, 16900 ламаас 571 үлдсэн байна. Сычуаньд 922, Юньнаньд 24 хийд байжээ. Хэрэв эдгээр тоог нийт түвдийн бүс нутгаар авч үзвэл 4748 болно. Жижиг сүмүүдийг тусад нь уу эсвэл хийдүүдтэй хамт авч үзэх үү гэдгээс шалтгаалан янз бүрийн тоо гарч байж болзошгүй юм.

У-Цангийн 2136 (бараг бүгд гэсэн үг) хийд бослогыг дэмжсэн гэж А.-Л. Стронг бичсэн байна.[1346] Тийм учраас санваартнуудад л гол гэсгээн цээрлүүлэлт иржээ. Ийнхүү У-Цангд санваартнууд 1958 онд 114100 байсан бол 1960 онд 18104 болж цөөрчээ. Гол гол хийдийн лам нарын тоогч эрс цөөрүүлэв. Жишээ нь Дрепунийн 8–10 мянган ламаас 700, Гүмбүмд 1200-аас 400 үлджээ. Дашлхүмбэд лам нарын тоо хоёр дахин буюу 1980 хүртэл хорогдсон байна. Энэ бол Банчин лам хятадын эрх баригчдыг дэмжиж байсан үе билээ.[1347] Зарим хийдийг шорон, цэргийн хуаран, агуулах, малын хашаа болгожээ.[1348]

Банчин лам хятадын эрх баригчдад бичихдээ: “Ардчилсан шинэтгэлээс

өмнө Түвдэд 2500 гаруй том, дунд,жижиг хийд байсан бол шинэтгэлийн дараа засгийн газар 70 буюу тэр орчим тооны хийд үлдээсэн юм. Энэ бол 97 гаруй хувиар цөөрүүлсэн хэрэг мөн. Олонхи хийдэд хүмүүс суухаа больсон болохоор дацангууд болон шашны бусад байгууламж, лам нарын сууцуудыг хардаг хүн гэж үгүй болжээ. Хүмүүсийн гараар болон бусад хэлбэрээр эвдлэн сүйтгэх ажил өрнөж, үүнээс болж сүм хийдийн хадгалалт буурч, уналтад орох буюу бүрмөсөн эвдэрч сүйдсэн газрууд ч олон байна. Нийт Түвд даяар 110 мянга орчим лам,гэлэнмаа байсан бол барагцаалбал 10 мянга нь хилийн чанадад дүрвэн гарч, 100 орчим мянга үлдсэн байна. Ардчилсан шинэтгэл дууссаны дараа лам хувраг, гэлэнмаа нарын тоо 7 мянга орчим байсан гэж үзэхэд урьдынхаасаа 93 хувиар хорогджээ. Бусдаас арай дээр байгаа Дашлхүмбэ хийд зэргийг оролцуулдаггүй юм гэхэд хийдүүдэд шавилан сууж буй лам, гэлэнмаа нарын мэдлэгийн чанар маш муу болсон байна. <...> Хийдүүд шашны байгууллагынхаа үүрэг, ач холбогдлыг нэгэнт алджээ" гэж онцлон тэмдэглэсэн байна.[1349]

Лам нарыг хар болгох явдлыг сүсэг бишрэлийн эрх чөлөөг хэрэгжүүлж буй явдал гэж үзэж байв. Лам нарын дийлэнхи олонхи хүссэн ч хүсээгүй ч хар болох ёстой гэж үзэж байв.[1350] Гадаадынханд үүнийг дахин дахин хэлж, сүм хийдээс сайн дураараа тариачин болсон хүмүүс "бурханд гэхээсээ нам,төрийн байгууллагуудаас тусламж хүсэх нь улам их болсон, ингэснээрээ тэд алдах биш, харин ч оножбайгаа" хэмээн нэмж хэлэхийг лам нарт шахдаг болсон байна.[1351] Одоогийн зүүний үзэлтнүүд үүнийг давтаж: "хүүхдээрээ шашны бүлэглэлд бүртгэгдсэн гэлэн гэцэлүүд ламын амьдралаас татгалзах эрх чөлөөтэй болж, олон мянган хүн, ялангуяа залуучууд энэ боломжийг ашиглалаа. Үлдсэн хуврагууд засгийн газраас олгодог боломжийн тэтгэлэг, найр хурим, оршуулгын үеийн уншлагаас олдог нэмэлт орлогоор амьдарч ирсэн юм" гэж ярих болсон байна.[1352] Гэтэл бодит байдалд бол олон арван мянган хөөгдсөн лам нар ажил олж чадахгүй гуйланч, ядуучуудын тоог нэмж байна.[1353]

Санваартнуудын тоог дараах аргаар хорогдуулжээ.[1354] "Лам, гэлэнмаа нарыг "аливаа боломжийн аргаар харчуудын давхаргад шилжүүлэхдээ "судлах", "дайчлах" гэгч зорилгоор хийд бүрт тэднийг мөргөлийн том танхим буюу том өрөөнд цуглуулна. Тэднийг нэгбүрчлэн хянаж, эрчимтэй сургаж, хэд хэдэн хоног дараалан бие биеийг нь шүүмжлүүлэхийн тулд хүчээр дайчилж, бөөн хэрүүл маргаан үүсгэнэ. Шашны итгэл үнэмшлээ нийтэд илэрхийлэн гаргасан хүмүүст "мухар сүсэгт этгээд", "хувьсгалыг үзэн ядагч" зэрэг элдвийн нэр хаяг зүүж, тэдний эсрэг тэсвэрлэхийн аргагүй,

тайлбарлаж хэлэхийн аргагүй дайралт, давшилт хийж эхэлнэ. Нөгөө талаас энгийн амьдралд эргэж орохыг хүсч байна уу гэж лам нараас асуухад тэд лам хэвээрээ үлдэх хүсэлтэй байна хэмээн хариулбал тэдэнд: “та заасан бүхнийг сураагүй байна, та мухар сүсгээсээ салаагүй байна” хэмээн хэлж, тэдний эсрэг эрчимтэй тэмцэл эхлүүлэх бөгөөд тэднээс олон хүн хатуу хяналтад орж, зарим нь хоригдол болж хувирах ажээ.

Ийм нөхцөлд та мах цуснаас биш, төмрөөр бүтээгдсэн байлаа ч ламаар минь үлдээж өгөөч гэж хүсэх ямар ч боломжгүй болно. Тийнхүү 60–70 настай лам нар ч хар болж, гэртээ харихыг хүсэхэд хүрдэг байна. Энэ хүмүүс шинээр гэр бүл зохиож, үйлдвэрлэлд оролцох чадваргүй болсон ажээ. Тэд амьдралынхаа тэн хагасыг өнгөрүүлсэн хийдээсээ явахыг хүсээгүй ажээ. Үүнийг бүгд мэдэж байсан. Энэ хүмүүст гэртээ буцаж очихоос өөр сонголт байгаагүй тэрхүү баримт нь асуудал ямар ноцтой байсныг, тэд хийддээ цаашид байх ямар ч боломжгүй болсныг ойлгоход хангалттай юм.

Зарим хийдэд ажилчдын бригадууд лам нарын нэрсийн жагсаалт гаргаж, гэр гэртээ, энгийн амьдралд эргэж очихыг албадан тулгах ажээ. Бүр цагаандаа гарч: нэг талд лам нарыг, эсрэг талд нь гэлэнмаа нар болон энгийн эмэгтэйчүүдийг жагсааж эсрэг хүйстнээсээ хэн нэгнийг сонгож авахыг тулгана. Эр, эм хүмүүс эхнэр, нөхөр болох хүнээ сонгох иргэний эрхтэй гэсэн утгаар үүнийг ойлгож, тайлбарлах ямар ч боломжгүй билээ. Энэ бол хэн ч зөрчиж болохгүй бөгөөд манай хуулиар хамгаалагдсан эрх юм.

Бурханы шашны жижиг хийдүүд болон өндөр ууланд байх даянч нарын сууцанд шашныхаа зан үйлийг хатуу сахиж бүх насаа бясалгалд өнгөрүүлсэн үзэл бодолдоо бүрэн автсан олон хүн байсан юм. Тэд жирийн амьдралын бүх зүйлийг хилэнц нүгэл хэмээн үзэж, хүмүүний ертөнцийг гутрангуй байдлаар хардаг ажээ. Хувьсгалын үйл хэрэг бас л ердийн амьдралын нэг хэсэг биш болохоор тэднээс маш цөөн тооны хүн энэхүү үйл хэрэгт баяр хүргэж, талархан ханджээ. Энэ бол гайхах зүйл биш төдийгүй харин ч байж болох хэвийн үзэгдэл билээ. Гэтэл кадр ажилтнууд үүнийг засаршгүй, зөрүүд, харгис сэтгэлгээний үндэс хэмээн үзжээ. Тэд энэ төрлийн хүмүүсээс олныг хяналтад авч,шоронд хийжээ. Тэд бурхан шашиндаа үнэнч байсан энэ хүмүүсийн эсрэг хүнд дайралт хийсэн юм”.

Хариуцлагатай ажилтнууд “бид мухар сүсгээс ангижирах ёстой” хэмээх лоозонгийн дор устгавал зохих ёс заншлын жагсаалт гаргажээ. “Тэд даянч, бясалгалчдын шашны сургаалийг эсэргүүцсэн лам, гэлэнмаа нарын үйлдлийг байнга хөхүүлэн дэмжиж, мөн ийм үйлдэл хийхийг бясалгалчдаас

шаардах ажээ. Хариуцлагатай ажилтнууд сайныг хойш тавьж, мууг үйлдэх үед тэр хуврагуудыг муу үйлд оролцохыг шаардаж, тэр муу үйлд оролцсон хүмүүс “дэвшилт” үзэлтнүүд, “идэвхтнүүд” хэмээх алдар нэрд хүрч, онцгой анхаарал халамжид орно. Ингэснээр үеэс үед шашны гавьяа хуримтлуулж ирсэн хийдүүдийг хар хорын үйл давамгайлсан газрууд болгон хувиргажээ” [1355].Энэ бүхэн нь ХКН-ын зарлан тунхагладаг улс төрийн бодлого болон хятад улсын хуулиудыг бүдүүлгээр зөрчсөн явдал болж хувирсан билээ гэж Банчин лам тэмдэглэжээ.

1960 оны гуравдугаар сард хятадууд Ничунгри мужийн зам дагуух сүмүүдэд бүдүүлэг халдлага хийжээ. Тэд шавар,чулуугаар хийсэн бүх бурхадын дүрийг гудамжинд гарган хаяж, сүм дуганын дээврийг хуу татан хаяжээ.[1356] Шавар баримлуудыг эвдэж, бие засах газар барихад хэрэглэх тоосго болгожээ. Лхас хотын Гьяпун Тан хэмээх том сүмийг бүрмөсөн нурааж, шавар баримлуудыг эвдлэн нурааж, тэр хавийн зам дагуу асгажээ. 1401–1472 онд Драананийн хөндийн доод биед байгуулсан Майдар бурханы мянган дүрс бүхий түвдийн хамгийн том 37 метр орчим өндөр аугаа их суваргыг 1960 онд устгажээ. Есөн давхар энэ суварганы давхар бүрт сүм байжээ. Нэгдүгээр давхрын сүмд Майдар бурханы асар том хөрөг байжээ. Жампалин хийдийн бүх байшинг эвдлэн нураасан байна.

Гэхдээ ард түмнээр өөрсдөөр нь ариун шүтээн газруудыг нь устгуулах явдал илүү чухал байжээ. Нэг талаас байнгын суртал нэвтрүүлэгт толгой нь эргэж, нөгөө талаас айж хэлмэгдсэн “хамжлагын албат” байсан хүмүүс хийдийн хаалганы дэргэд цуглаанд оролцож, дараа нь дотогш орж эвдлэн сүйтгэх ажилд ордог ажээ. Хэрэглэж болох барилгын материалыг ялган авч байшин барих, зам тавихад ашиглана.[1357] Модон эдлэлүүдийг түлээнд явуулна. Эвдлэн сүйтгэх ажилд оролцоогүй хүмүүсийг “мухар сүсэгтэн”,”шинэчлэгдээгүй этгээдүүд” хэмээн зарлаж, тэдэнтэй “тэмцэх” ажээ. Коммунистууд болон тэдний ухуулгад автсан хүмүүс эвдлэн сүйтгэж, хулгайлан зөөж, түүхий эд болгон ашиглахын хажуугаар ариун шүтээн газруудыг доромжлон гутаана. Хятадууд Буддагийн баримлын толгойг таслан авч, баривчлагдсан түвдчүүдийн нуруунд хөнөг сав болгон үүрүүлэхдээ завсар нь зөөлөвч болгож торгон зургийн аргаар бүтээсэн зурмал бурханы хөрөг хавчуулах ажээ.[1358] Хананд өлгөөтэй байх торгон зургийн урлагт тооцогдох бурханы хөргийг хэдэн хэсэг болгон хуваах ядуучуудад хувааж өгнө.[1359] Судар, номын зузаан цаасыг хятадууд гутал дотроо улавч болгож дэвсэнэ. Судар номын бар сийлсэн хавтгай моднуудыг байшингийн шал, сандал тэргүүтэн хийхэд ашиглана. Шашны ёслолын

хувцас хунарыг “соёл урлагийн бргигадуудад” тарааж өгчээ.

Банчин лам: “Цутгамал болон баримал бурхад, судар ном, суврагуудыг үндсээр нь устгахын тулд манай хятад кадр ажилтнууд улсын хамгаалалтад байсан дөрвөн их хийд зэрэг маш цөөн тооны сүм хийдийг эс тооцсон төлөвлөгөө гаргасан юм. Том биш тосгод, жижиг хотууд, газар тариалан, мал аж ахуйн томоохон мужууд дахь хотуудад байсан түвдийн бусад хийдийн тухайд тэд энэхүү төлөвлөгөөг биелүүлэхийн утга учрыг ойлгоогүй манай Түвд кадр ажилтнууд, идэвхтнүүдээс сонгож авсан зарим хүмүүсийг дайчилсан юм. Тэд олон түмэн хэмээх нэрийг булаан авч, “нүүрэндээ олон түмний баг өмсөж” Буддагийн баримал хөргүүд, шашны ном судар, суврагуудыг устгах аугаа их урсгалыг түрхэрсэн билээ. Тэд тоолж барахын аргагүй олон тооны бурхан, судар ном, сuврага устган шатааж, голын усанд хаяж, эвдлэн сүйтгэсэн юм. Тэд сүм хийд, маанийн зургаан үсэг бичсэн хана хэрэм, суврагыг дэндүү зэрлэг балмад байдлаар устган нурааж, бурханы цутгамал хөрөгт байсан олон гайхамшигт чимэглэлүүд, сувраган дотор хийсэн үнэт эд зүйлсийг хулгайлан авч явсан юм.

Засгийн газрын худалдан авах байгууллагууд үнэт металлаар хийсэн эдлэл худалдаж авахдаа ялгаварлалт хийх гэж эрмэлзээгүй учираас өнгөт металлаар хийсэн Бурханы олон хөрөг, суварга, шашны ёслол үйлдэхэд зориулсан элдэв сав суулга худалдаж авснаараа эдгээр эд зүйлсийг эвдлэн сүйтгэх явдлыг дам хэлбэрээр өөгшүүлэн дэвэргэжээ.Үүний уршгаар зарим тосгон болон хийд хүний бодож боловсруулсан үйл ажиллагааны үр дүн биш, харин дайны үед бөмбөгдүүлсэн мэт болж харахаас л нүд хальтармаар байсан юм. Цаашлаад тэд шашин руу ямар ч ялгаваргүйгээр давшилт хийж, бурханы хөрөг, судар номыг гутал хувцас хийхэд ашиглаж байлаа. Энэ бол үнэхээр утга учиргүй мунхаг үйлдэл байсан юм. Тэд дэндүү олон ийм үйлдэл хийсэн болохоор бүх давхаргын хүмүүс машид эгдүүцэн дургүйцэж, цочролд орж, гунихарсан болохоор хар дарсан зүүдэнд ч бараг давтагдахааргүй зүйл болсон юм. Хүмүүс “Манай газар нутаг харанхуй там болон хувирлаа” хэмээн нулимсаа дуслуулан хашгиралдаж байсан юм. Тийнхүү сүйтгэгдсэн түвдийн бурханы шашны бурхан шүтээн, судар ном, сүм суврагуудыг сэтгэлдээ төсөөлж, дүрслэн бичихэд ч хэцүү байдаг хэдий ч “ажилчин ард түмний өргөн олон нийт ухамсартай болсон учраас дээрх бүтээлүүдийг устгасан юм” гэж зарим хүн одоо ч ярьдаг билээ. Энэ бол түвдийн өнөөгийн байдлыг үнэхээр ойлгоогүйгээс үүдсэн дэндүү утгагүй бодол мөн” гэж бичжээ.[1360].

Шашны байгууламжуудыг дараахь схемээр устгажээ.[1361] Бүх үнэт

чулуун эдлэлийг тодорхойлж, дараа нь авахын тулд хятадын эрдэс чулуулаг судлаачдын тусгай баг тэнд очиж, дараа нь мөн энэ зорилгоор төмөрлөгийн мэрэгжилтнүүд танилцсаны дараа бүх үнэ цэнэтэй эд зүйлсийг цэргийн ачааны машинаар авч явдаг байв. Сүм, дуганын ханыг дэлбэлж, тэдгээрийн багана, банз, дүнз зэргийг зөөж авч явна. Шавраар хийсэн цутгамал бурхад дотор эрдний чулуу байж магадгүй хэмээн бодож хэмх цохин эвдэх ажээ. Үүний дараа үлдсэн мод, чулууг цэвэрлэнэ. Олон зуун тонн шашны үнэт цутгамал бурхад, торгон зургийн урлал, янз бүрийн металлаар хийсэн эдлэл, бусад үнэ цэнэт зүйлсийг түвдээс зөөж авч явжээ. Түвдийн хийдүүдийн металл эдлэлийг хятад руу зөөж яваа ачааны машины цуваануудын тухай олон мэдээлэл байдаг юм.[1362] Эхлээд энэ автомашинуудаар алт, мөнгөөр хийсэн том биш бурхад авч явдаг байсан бол сүүлдээ цаашид хайлуулах зорилгоор хэд хэдэн хэсэг болгож хуваасан том том цутгамал бурхад зөөдөг болсон байна. Энэ дээрэмдлэг 1970-аад оны соёлын хувьсгалын үед ч үргэлжилж, түүнийг “ардчилсан шинэтгэлийн үед баялагийг дахин хуваарилах явдал” хэмээн нэрлэж байв. Мао Зэдуныг “Амьд бурхан”, түүний үзэл санааг шинэ шашин хэмээн үзэх ёстой байлаа. 1960-аад оны эхээр Мао Зэдун, Лю Шаоци, Жоу Эньлай нарын хөргийг бүтэн үлдсэн сүмүүдэд торгон зургийн аргаар бүтээсэн бурхадын хөрөгтэй зэрэгцүүлэн тавьдаг байжээ.[1363]

Шашны амьдрал үндсэндээ үгүй болжээ. Банчин лам: “Ардчилсан шинэтгэлийн дараа цөөн тооны лам нартай үлдсэн хийдүүдэд тодорхой үйл явдлуудад зориулсан шашны хурал ном, элдэв төрлийн ёслол үндсэндээ зогсож, онолын ном хаялцаан зэрэг бусад ажиллагаа үгүй болжээ. Үүнтэй холбогдоод шашны дотоод, гадаад онолын асуудлаар ном хаялцахаа больж, хурал ном хурж, сургааль, тайлбар айлдах, номын буян шингэсэн аршаанаар бие сэтгэлээ ариусгах, бясалгал үйлдэж санаа бодлоо ариусгах,ариун шүтээндээ идээ будаа өргөх, сор залах, ад зэтгэрийг хөөж зайлуулах,цам майдарын бүжиг, дуу тэргүүтнийг тоглож үзүүлэх зэрэг шашны бусад хэвийн үйл ажиллагаа зогсчээ” гэж Банчин лам бичсэн байна. [1364]

Коммунистууд шашныг устгахдаа түвдчүүдийн хувийн амьдралд л анхаарал тавьжээ. “Хүмүүс байшингийнхаа дээвэр дээр хийсгэдэг мөргөлийн дарцагуудаа буулгахад хүрсэн бөгөөд одоо тэдэнд сахиус зүүх явдал тохиромжгүй болж, гэртээ залдаг бурхан тахил, судар ном, жижиг суварган дүрс зэргийг далж хийж нуух болжээ..Тэдэнд маань мэгзэм уншиж, мөргөл үйлдэх хориотой болжээ. Бас бурхан тахилдаа зул өргөх хориотой. Онгон шүтээн газрууд, Бурханы хөшөө, бусад гэгээн суваргыг хүндэтгэн

тахих, хүрд эргүүлэх, том лам нарт мөргөж хишиг буян хүртэх, ядуучуудыг хооллох, буян хураах бусад үйлдэл хийх боломжгүй болжээ. Жишээ нь, хэн нэгэн хүн насан өөд болоход дагсал дуудаж, сүнсий нь сайн төрөлд явуулах шашны ёслол үйлдэхгүй бол талийгаачдыг үл хүндэтгэсэн, хатуу цэвдэг сэтгэл гаргасан явдал гэж үздэг Түвд заншил бий билээ.[1365] Тиймээс хүмүүс: “Бид дэндүү оройтож үхэхнээ, хэрэв арай эрт өнгөрдөгсөн бол ядахдаа маань уншуулж, оршуулгын ёслол үйлдүүлэхсэн, тэгвэл одоогийн насан өөд бололт нохойн үхэлтэй л адил болж: амьсгаа хураамагц л гадаа гаргаж хаях байх даа” хэмээн ярьдаг болжээ.[1366]

Үүний зэрэгцээ коммунистууд боловсон хүчнийг дахин хүмүүжүүлэх, гэгээрүүлэх, шинэ үзэл суртлаар бэлтгэх ажлыг эрчимтэй явуулав. ХКН-ын чиг шугамыг тайлбарласан хурал,цуглаан зохион байгуулна. Ийм хурал,цуглааны дараа хүмүүсээс: “өөр санал байна уу?” гэж асуухад бүгд л нэгэн дуугаар”дэмжиж байна” хэмээн хариулах ажээ. Маргаан өрнүүлэх аюултай, ийм учираас болгоомжилсон хандлага гаргана, яагаад гэвэл нэгэн санаатай байхыг хүн бүрээс шаардана. Тиймээс хэн нэгэн хүн: “хичээлд явж суунаа” гэсэн үг сонсвол түүнд айдас төрөх ажээ.[1367]

“Түвд хэл, хувцас, үндэсий гоёл чимэглэл, сайн сайхан зан заншил, ёс журам болон эрхэмлэн хүндэтгэж ирсэн үндэсний бусад шинж тэмдгүүдийг: “аугаа их сүйтгэл, аугаа их илчлэлт, аугаа их тайлбарлалт” хэмээх хувьсгалт ажлын “гурван аугаа их” обьектод хамруулан оруулжээ. Кадр ажилтнууд хуучин бүхнийг хоцрогдсон, бузар, хэрэггүй зүйл хэмээн үзнэ <...> Тэд Түвд хэлийг үл тоомсорлож, Түвд хувцасыг элдвээр шоолж инээлдэнэ. Тэд эмэгтэйчүүдийн гэзэг самналт болон эрчүүдийн үс засалтад илтэд дургүйцэн ханддаг учир гэзэг үсээ ч янзалж явахад хүнд хэцүү болжээ. Тэд байшингийнхаа гадна талыг шохиодох, дээвэрт нь дарцаг олгох, хурим найр, оршуулах ёслолын үеэр ёс журам баримталсан бэлэг сэлт барих, хурал ном хурах, баяр ёслолын марга хэмжээ зохион байгуулж, үндэсний спортын төрлүүдээр уралдаан тэмцээн явуулахыг үр ашиггүй, огт хэрэггүй зүйл хэмээн үздэнг байсаан учирг эдгээр үйлдэл, ёс заншлын олонхи нь зогсчээ <...> Бид балар эрт цагаас өнөөг хүртэл ажил дээрээ ч, өдөр дутмынхаа амьдралд ч Түвд хувцасаа өмсөж ирсэн билээ. Жишээ нь, өвгөцүүл: “Хэрэв бид хятад хувцас өмсвөл ийм богинохон хувцаснаас болж нуруу маань даарах байх даа, гэвч одоо нэгэнт ийм болсон хойно өөр сонголт байхгүй болж дээ” хэмээн ярьж байжээ. Олон түмэн хятад хувцас өмссөн түвдчүүдийг “хиймэл хятадууд” гэж нэрлэдэг байв”.[1368]

Лам нарынх шиг улаан хүрэн, шаргалдуу өнгийн хувцас өмсөхийг газар



1



2

Нүүдэлчин малчид. 1 – үндэснийхээ хувцастай, 2 – “маогийн малгай, хүрэмтэй” (DIIR Archive, Central Tibetan Administration)

сайгүй хориглоно.[1369] Хүүхэд, эр, эм хүмүүс, янз бүрийн омгийнхон болон янз бүрийн ажил мэрэгжлийн хүмүүст янз янз байдаг өвөрмөц онцлогтой, хурц тод өнгийн Түвд үндэсний хувцас, гэзэг үстэй тэмцэнэ. Тэдгээрийн оронд үсээ нэг янзаар богино болгон тайруулан засуулж, “маозэдуны” нэг хэвийн бүрхэг өнгөтэй стандартын хүрэм, хагас цэргийн, хагас шоронгийн хэлбэртэй эрүү малгай өмсүүлдэг болжээ.

Түвд хэлийг устгах чиг шугам баримтлав.[1370] Түвд хэл бол энэ нутаг дэвсгэрийн сургуулийг Төв хятадынхаас ялгаруулдаг цорын ганц зүйл билээ. Тэгвэл энэ хэлийг хятаджуулах ажлыг эрчимжүүлж: хятад үг, хэллэг оруулж, ахмад хүмүүстэй, тухайлбал язгууртнуудтай ярих үед хэрэглэдэг “эелдэг хэллэг” хэмээн нэрлэгддэг шашны,”феодал-харгис хүчний” үгсийн санг хэрэгсэхгүй болгож эхлэв.[1371] Жишээ нь, хүний нэрийн дараа хэрэглэдэг “ла” хэмээх хүндэтгэлийн дагаварыг хориглов[1372] Түүний оронд: “аугаа их удирдагч”, “аугаа их, яруу алдарт, зөв үйлт ХКН”, хожим нь “маозэдуны үзэл санааны аугаа их улаан туг”, “зөвлөлтийн ревизионистуудын бүлэг”, “цаасан бар”,”урвагч,өдөөн тухирагч, тэмцлээс урвагч буюу штрейкбрехер” гэх мэтийн шинэ боловч харийн хэллэгүүд оруулав.[1373] Эдгээр үг хэллэгийн заримыг өнөөдөр ч суртал нэвтрүүлэгт хэрэглэж байна.

Банчин лам: “Түвд хэл бол хүмүүс өөр хоорондоо харилцах, санаа бодлоо илэрхийлэхэд тохиромжгүй, доод язгуурын хэл хэмээн ярьдаг байлаа. <...> Сүүлийн жилүүдэд доод түвшингийн Түвд хэлтэй, гэхдээ бардам омог нь уулын чинээ, бас зусардаж, бялдуучлахдаа гарамгай болсон

тэр хүмүүс "соёлын хувьсгал" хийж, "бичгийн хэлийг аман ярианыхтай ойртуулах" "ыг эрмэлзэхдээ бидний өвөг дээдсийн зохиосон, Түвд хэлний үндэс болсон Түвд цагаан толгойн гучин үсгийг "буруу", "боловсронгуй биш", "жинхэнэ үсэг биш" гэж балмад өнгө аясаар мэдэгдэж байна. Энэ хүмүүс Түвд үсгүүдийг стандартчилахыг шаардаж, өөрсдийнхөө бий болгосон бичгийн хэлийг алдаа мадаггүй хэмээн үзэхдээ тэрхүү хэлийг өөрчилсөн нь ердийн болон гүн гүнзгий санааг илэрхийлэн гаргах түүий чадварыг алдагдуулахад хүргэжээ.Түүнээс гадна түвдийн төвийн эрх баригчид лхасын аялгыг түвдийн стандарт аялга хэмээн ашиглаж, стандарт биш дуудлагыг бичиж авах болохдоо тэд хүссэн тэр л дуудлагаараа бичиж тэмдэглэж авдаг юм. Тийнхүү лхас аялгыг ойлгодог хүмүүсээс бусад хэн ч эдгээр баримт бичгүүдийг бүрэн ойлгож чадахгүй юм. Үүнтэй адилаар Хөх нуур, Ганьсу, Сычуань, Юньнань болон бусад нутгийн Түвд хэлний багш нар тэр нутгуудын өөрийнх нь аялгыг ердийн бичгийн хэл хэмээн хүлээн авч, өөрсдөө ч энэ хэлээр бичиж байна. Энэ нь тухайн аялгаар ярьж буй нутгийн гадна талд оршин сууж буй хүмүүс тэр хэлний утга агуулгыг бүрэн ойлгох чадваргүй болох тийм байдалд хүргэж байгаа юм. Тийнхүү Түвд хэлний нэгтгэх мөн чанар алдагдаж байна" гэж бичсэн байна".[1374]

Хуучин Түвдэд европ утгаар ойлгогдох сургууль гэж байсангүй. Гэхдээ олон мянган сүм хийд хүн амын боловсролын эрэлт хэрэгцээг хангаж сургууль, их сургуулийн үүрэг гүйцэтгэж иржээ.[1375] Сургуульд сурсан хүүхдүүд сургуулийн насны хүүхдийн 2 хүрэхгүй хувийг эзэлдэг бол залуучууд болон дунд насны хүмүүсийн 95 хувь нь бичиг үсэггүй байсан гэж хятадын албан ёсны мэдээнд өгүүлжээ. [1376] Энэ бол худал мэдээ юм. Гол төлөв залуучууд болон дунд насны хүмүүс болох лам нар бичиг үсэгтэй байв. Их Түвдэд ийм хүмүүсийн тоо бараг 600 мянгад хүрнэ. 1959 оноос өмнө Түвд өрх бүр ядаж нэг хүүхдээ лам болгохыг эрмэлздэг заншилтай байсан. Ингэхлээр түвдийн өрх бүр буюу бараг өрх бүрт бичиг үсэгтэй хүн байжээ. Энэ бол бүх хүн ам биш нь ойлгомжтой.Хэрэв түвдэд 4 сая орчим хүн, ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд 1,2 сая шахам хүн байсан гэж бодвол бичиг үсэгтэй хүмүүсийн эзлэх хувь яасан ч 5-аас дээш гарч байна. Гэхдээ энэ бол бичиг үсэгтэй энгийн олон иргэнийг оруулаагүй тоо бөгөөд төрийн бүх хэрэг хөтлөж, наймаа арилжаа хийхэд янз бүрийн бичилт, тайлан тооцоо гаргадаг байсан нь ойлгомжтой.

Гол төлөв санваартнууд, феодалууд, бусад "дарлан мөлжигчид", өөрөөр хэлбэл хүн амын хамгийн боловсролтой хэсэг гэсгээн цээрлүүлэлтэд өртжээ.

Эвдэрч сүйдсэн сүм хийдүүдийн сургуулийн оронд боловсролын

дэндүү доод түвшинтэй “ардын сургуулиуд” байгуулж, тэдгээрийн олонхийн зардлыг нутгийн оршин суугчдаас гаргаж байв.[1377] Удалгүй эдгээр сургуулийг хаасан юм.

Банчин ламын илгээлтийг тусгай зөвлөлгөөнөөр хэлэлцэн сайшаав. Жоу Эньлай тэр үед Жан Гохуа, Жан Зиньу нарыг Бээжинд дуудан ирүүлж, та нар алдаагаа хүлээн зөвшөөрөх ёстой хэмээн улаан нүүрэн дээр нь хэлсэн байна.[1378] 1962 оны долдугаар сар гэхэд бэлэн болгосон дөрвөн баримт бичгийг ХКН-ын Төв Хороо сайшаав. Тэдгээр баримт бичигт нэгдэн нягтарч, шашны эрх чөлөөг хангаж, 1959 оны “босогчдын” талаар баримтлах дүрэм боловсруулах шаардлагатай болсныг цохон тэмдэглэжээ.

Банчин лам Лхас руу явж, Жан Гохуа, Жан Зиньу нар Бээжинд үлдсэн байна. Тэд намын удирдлагыг өөрсдөд нь хэрэгтээ зүгт эргүүлэх оролдлого хийж эхэлжээ.[1379] Банчин ламыг дэмжигч Ли Вэйханийг нэгдсэн фронтын даргын үүрэгт ажлаас чөлөөлөв. Мао Зэдун түүнийг “ревизионист, зөөлөн” хандлага гаргасан хэмээн зэмлэжээ.

Тэр жилийн зун Бэйдайхэгийн сувилалын газарт Төв Хорооны хурал болов. Ангийн тэмцлийг идэвхжүүлэх явдал намын ажлын чухал хэсэг байх ёстой гэж Мао мэдэгдсэн байна. Яагаад гэвэл түүний хувьд үндэсний асуудал бол ангийн тэмцэл байсан юм. Дарга Мао феодалын удирдагчийн ангийн байр сууриа сэргээхийг эрмэлзэж байна хэмээн Банчин ламыг зэмлээд түүний илгээлтийг “феодалын харгис эздийн зүгээс Нам руу харвасан хортой сум” гэж нэрлэжээ.

Гэтэл Мао коммунист нам шүүмжлэлээс айхгүй гэж мэдэгдэж байжээ.[1380] Түүнээс гадна тэрээр: “Бид шашныг устгахын тулд засаг захниргааны арга хэрэглэж болохгүй, итгэл үнэмшилгүй байхыг хүмүүст тулган хүлээлгэж болохгүй <...> Үзэл суртлын шинж чанартай бүх асуудал, ард түмний доторхи маргаантай бүх асуудлыг ардчилсан аргуудын тусламжтайгаар, хэлэлцэх аргаар, шүүмжлэх аргаар, итгэн үнэмшүүлж, хүмүүжүүлэх аргаар шийдвэрлэх ёстой бөгөөд албадах, шахалт үзүүлэх аргаар шийдвэрлэж болохгүй юм” гэж

мэдэгджээ.[1381] Гэхдээ маогийн үзэлд үл харшлах тэр газарт л шүүмжлэл байж болох ажээ. Эс тэгвээс шүүүмжлэгч этгээдийн амыг зүгээр л хааж орхино: “илэрхий хувьсгалын эсэргүүчүүд, социализмын үйл хэргийг бусниулагч этгээдүүдийн асуудлыг шийдзвэрлэхэд амархан: тэднийг үг хэлэх эрхгүй болгоно Эс тэгвээс ард түмний дотор алдаатай үзэл бодол явсаар байх болно”.

Есдүгээр сард Жан Гохуа дээр дурдсан дөрвөн баримт бичгийг

биелүүлэх ажлыг түр зогсоож, Банчин лам, Шаравжамц нарыг зад шүүмжлэв. Банчин ламыг эрх мэдлийн хөшүүрэггүй болгов. Гэвч түүний илгээлт талаар өнгөрсөнгүй. “Буруу мэдээллээр” баривчлагдсан, бослогод санамсаргүй оролцсон болон “гэмээ хүлээсэн” эгэл жирийн олон хүнийг суллан гаргав. Лхас, Шигазе, Гьянзед 1959 оны бослогыг нухчин дарах үеэр хэлмэгдсэн томоохон сүмүүдийг сэргээн засварлав.[1382] Гэвч Шигазегийн эвдэрч сүйдсэн шилтгээнийг сэргээн засварлаагүй юм. Дрепун, Сэра, Гандан хийдүүдэд хязгаарлагдмал хүрээнд шашны үйлдэл явуулахыг зөвшөөрөв. 1962-оос 1966 оныг дуустлах хугацаанд Хөх нуурт 137 хийд, Ганьсуд 107 хийд шинээр нээж, энэ хоёр мужийн лам нарын тоо 4 мянгад хүрсэн хэмээх мэдээлэл байдаг юм.[1383] Хөдөлмөрийн чадваргүй болсон зарим ламд их биш хэмжээний тэтгэмж олгох болсон байна. Хөдөлмөрийн чадвартай лам нарт тариалан эрхлэх их биш газар олгов. 1960-аад онд эвдрээгүй үлдсэн хийдүүдэд ардчилсан удирдлагын хороод байгуулав. Ийм хороо одоо ч ажиллаж байна. Хийдүүдэд тавих хяналтыг Үндэстний хэрэг эрхлэх Комиссийн төлөөлөгчдөд хариуцуулав. Эдгээр комиссийг хийд түшиглэн байгуулжээ.[1384]

Хамтралжуулалтыг ойрын таван жилд түр зогсоож, “харилцан туслах бригадуудыг” жижиглэн хувааж, хөрөнгийн зарим хэсгийг тариачдад дахин хувиарлав. Харин 1964 онд хоршоолжуулалтыг бүрмөсөн зогсоожээ. Зарим газарт удирдах кадр ажилтнуудыг солив. 1963 оны хавар ирээдүйн түвдийн өөртөө засах орны гацаануудын 50–70 хувьд сонгууль явуулсан боловч удалгүй зогсоожээ.[1385]

Энэ сонгууль явуулсан цэргийн эрх баргигчдын арга хүн амын. дургүйцлийг төрүүлсэн бололтой юм.

Сургалтын шинэ систем нэвтрүүлэх болов. 1964 онд тэнд 60 мянган хүүхэд суралцсан 1682 бага сургууль байсан боловч Лхасаас бусад газарт сургуулийн насны бүх хүүхдийн барагцаалбал тэн хагас нь суралцаж байв.

1964 онд ирээдүйн Түвдиийн Өөртөө Засах оронд улс төрийн кампанит ажил улам идэвхжиж: энд намын байр суурь маш их хүчтэй болсон учир элит байсан хүмүүстэй бага зэрэг буулт хийж харьцах явдал хэрэггүй болжээ. Коммунистууд түвдийн нийгмийг ангийн хувьд нарийвчлан хувааж авч үзэх төлөвлөгөө боловсруулав.[1386] Гэрийн үйлчлэгч нарыг “ядуу тариачид” хэмээн зарлав. Тэд коммунист намд элсэгчдийн гол үндэс болсон байна. Тэднээс бослогод оролцсон хүмүүсийг ч “төөрөлдөгчид” хэмээн зарлаж, өршөөл үзүүлсэн байна. Газартай боловч хөлсний хөдөлмөр ашигладаггүй тариачдыг “дундчууд” хэмээн зарлав. Энд мөн “дарлагдагчид”,

“дарлагчдын” хооронд зааг гаргав. Хожим нь энэ категорийг (дарлагчид) хөлсний ажилчид хэр зэрэг байнга ашиглаж байснаас нь шалтгаалан гурван дэд категорт хуваажээ. Нүүдэлчдийн. тухайд ч иймэрхүү хувиарлалт тогтоосон байна. Тэдний хувьд “мал эзэмшигчид” нь “газар эзэмшигч-тэй нэг зиндаанд тавигджээ.” Цаашдын хуваарилалт эзэмшиж буй малын тоо болон хөлсний хөдлөлмөр ашигласан хэмжээнээс шалтгаалсан байна. Ийнхүү ангилан авч үзэхэд мөн нэмүү бүтээгдэхүүний хэмжээг ашиглажээ.

50 гаруй хувийн нэмүү бүтээгдэхүүнтэй хүн “газар эзэмшигч” болж, 25 хувьтай хүнийг “дундчууд” гэж зарласан байна. Лам нарыг бүгдийг нь “мөлжигчид” гэж зарласан ч тэднийг мөн л анги болгон хуваажээ. Сүм хийдийн ямар зэрэг зиндаатай байснаас нь шалтгаалан тэдний ангийн шинж чанарыг тодорхойлсон байна.

Ангиар ялгаварласан энэ нэр хаягаас хэн ч зайлсхийж чадаагүй ажээ. Энэ нэр хаягаар “ангийн дайснуудыг” тодруулан гаргаж, ядуучууд тэдний эсрэг

“тамцинг” буюу тэмцлийн цуглаан хийх үүрэгтэй байжээ. Суурин газар бүрт чухал албан тушаалтан болж чадсан хятадууд л ийм цуглааныг голлон санаачлах ажээ.

1964 оны эхээр монламын баярыг тохиолдуулан Лхас хотын оршин суугчдын өмнө үг хэлэхийг Банчин ламд санал болгосон байна. Тэрээр зөвшөөрсөн бөгөөд Далай лам бол түвдийн ард түмний жинхэнэ удирдагч мөн гэж хэлсэн нь эрх баригчдыг нилээд гайхшралд оруулсан байна. Тэрээр үгийнхээ төгсгөлд: “Далай лам мандтугай” гэж хашгирсан ажээ.[1387]

Жан Гохуа 1964 оны дөрөвдүгээр сард хамтран зүтгэгчдийнхээ хамт Бээжинд очив. Тэрээр Мао болон түүнийг тойрон хүрээлэгчидтэй уулзахдаа түвдчүүд социализмд бэлэн болсон, гэвч Банчин лам замын саад болж байна гэж мэдэгдэв.[1388] Банчин ламын гэрийг нэгжиж, олон баримт бичиг олж тэдгээрийг хувьсгалын эсэргүү шинж чанартай зүйлс гэж тайлбарлажээ.[1389] Лхас хотод “эд мөрийн баримтын” үзэсгэлэн гаргав. Жишээ нь тэнд байсан жип машиныг ирээдүйд хийх гэж буй хятадын эсрэг бослого нь бүтэлгүйтвэл Энэтхэг рүү зугтахад хэрэглэх гэж хадгалж байсан мэтээр тайлбарлажээ. Банчин ламд “хордуулсан сум” байсныг ч сануулжээ. 1964 оны есдүгээр сарын дунд үеэс арваннэгдүгээр сарыг дуустлах хугацаанд түүнийг олон хүн цугларсан газарт 17 өдөр “тэмцлийн цуглаанд” оруулж: элдвээр доромжилж, зодож, үснээс нь зулгааж, нүүр рүү нь нулимах зэргээр авирлажээ. Гэвч тэрээр “гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрөхөөс” татгалзсан байна. Тэрээр тэсвэр алдаж ширээн дээр байсан баримт бичгүүд

рүү хуруугаараа чичлэн урж хаяжээ. Хожим нь түүнд “муухай авир гаргаж”, “олон түмний шүүмжлэлийг эсэргүүцсэн” гэж анхааруулжээ. Энэхүү шүүх ажилллагаа гэгчийг Жан Гохуа, Жан Зиньу нар зохион байыгуулсанм боловч зохих шийдвэрийг зөвхөн Бээжинд гаргах учиртай байв.

Арван хоёрдугаар сард Банчин лам, Далай лам нарыг Бүх Хятадын ардын Төлөөлөгчдийн Хурлын орлогч даргын албан тушаалаас огцруулж, Банчин ламын ойрын хамтран зүтгэгч гурван хүнийг “Банчингийн бүлэгт” оролцогчид хэмээн зарлаж, түүний хөрөнгийг хураав. Далай ламыг “урвагч” хэмээн зарлаж, Банчин ламыг Бээжинд бусдаас тусгаарлажээ.

1965 оны зун өмнөх сонгуулийг харгалзан үзэлгүйгээр дахин сонгууль явуулж эхлэв.[1390] Ганцхан сарын дотор засаг захиргааны нэгжүүдийн 90 хувьд орон нутгийн ардын төлөөлөгчдийн хурлуудыг эмхлэн байгуулав. Хэдхэн хоногийн дараа гацаа тосгодын хурлын, дараа нь Түвдийн өөртөө засах орны хурлын сонгууль эхлэв. 16 гацаанд ерөөс сонгууль хийлгүй төлөөлөгчдийг “ардын төлөөлөгчдийн бага хурлуудаас” сонгосон байна. Ингээд 1965 оны есдүгээр сард ардын төлөөлөгчдийн хурлын анхдугаар чуулган болж, Агваан Жигмэд тэргүүтэй Түвдийн өөртөө засах орны ардын хороог сонгосон байна. Төлөөлөгчид бараг бүгдээрээ “хамжлагын тариачид”, “боол” байсан хүмүүс байв. Үүнийг бээжингийн албан ёсны эрх баригчид “төрийн хэрэг удирдахад тэгш эрхтэй оролцох түвдийн ард түмний улс төрийн эрхийг” хууль зүйн үүднээс хангасан явдал гэж нотолжээ.[1391] Гэвч Түвдийн өөртөө засах орны ардын төлөөлөгчдийн хурлын анхдугаар чуулганы нэр дээр БНХАУ-ын ардын төлөөлөгчдийн хурлаас явуулсан илгээлт бичигт арай өөр байдлаар,тухайлбал: Түвдийн өөртөө засах орныг зарлан тунхагласан явдал бол “хувьсгал ба түвдийн ард түмний бүтээн байгуулалтын шинэ шатны илрэл бөгөөд хамтлагат ёсыг халж, ардчилсан шинэтгэл хийсний дараах аугаа их ялалт болж байгаа юм” гэж өгүүлжээ.[1392]

1965 онд түвдийн өөртөө засах орныг зарлан тунхагласан нь тэр үед Түвдийн сөрөг хүчнийг үгүй болгосон явдалтай холбоотой юм.[1393] Банчин ламыг залхаан цээрлүүлсэн явдал үүний сүүлчийн ажиллагаа болжээ. “Банчингийн бүлгийн урван тэрслэх үйл ажиллагааг илчилсэн явдал” Түвдийн өөртөө засах орон байгуулах хамгийн шилдэг нөхцөл бүрдүүлсэн юм” гэж Агваан Жигмэд хэлсэн байдаг. Энэ бол өөрөө удирдах ёсны сүүлчийн үлдэгдлийг үндсээр нь устгасан цагт л автономи эрх бий болгох боломж бүрджээ гэсэн үг юм.

Энэхүү ёс төдий өөртөө засах эрх гэгч нь арми, намын байгууллагуудын эрх мэдлийн халхавч болжээ.[1394] 1965 онд Түвдийн өөртөө засах орны

хятадын коммунист намын Ажлын хорооны бүрэлдэхүүнд дан хятадууд байсан бөгөөд тэдний эрх мэдлийг 130–150 мянган хүнтэй арми хангаж байлаа.[1395] Түвдийн өөртөө засах орон байгуулснаар бүр 1959 онд хэрэгсэхгүй шахам болгосон 17 зүйлт Хэлэлцээрийг бүрмөсөн булшлав.[1396] Түвд нь БНХАУ-ын "хосгүй район" байхаа нэгэнт больжээ.

Удалгүй Түвдийн өөртөө засах орны ХКН-ын Хороо байгуулав. Жан Гохуа тус хорооны нарийн бичгийн дарга болж Жан Зиньугийн орыг авчээ. Жан Зиньу үүний өмнөхөн тушаал дэвшиж, Нэгдсэн фронтын ажлын хэлтсийн орлогч захирал болсон байна. Боловсон хүчний ажил үргэлжлэв. Хятадын талын баримт мэдээгээр бол 1965 он гэхэд суурин газруудын түвшинд ажиллах 20 мянган Түвд кадр ажилтан, үүнээс илүү өндөр албан тушаалын 16 мянган ийм ажилтантай болсон байлаа.[1397] "Хувьсгалт тэмцлийн явцад боловсорсон эдгээр хамжлагын тариачид болон боолууд" туршлагагүй, олонхи нь бичиг үсэггүй байв.[1398] Тийм учраас тэдэнд хятадын кадр "зөвлөх", туслах, Түвд орчуулагчид гаргаж өгсөн байна. Тэднийг намын ажлын бригадууд хэмээн нэрлэдэг байжээ. Эдгээр бригадын гол зорилго бол ангийн тэмцлийг тайлбарлан таниулах, "тэмцлийн цуглаан" зохион байгуулах явдал байлаа. "Хамжлагынхаа эздийг" өрөвдсөн хуучин "хамжлагын тариачдад" энэ бол зөвхөн тэдэнтэй хийж буй тэмцэл биш, энэ бол хамжлагын эздийн ангитай "хамжлагын тариачдын" бүх ангийн хийж буй тэмцэл мөн хэмээн тайлбарлах ажээ.

Түвдийн шерпа, монпа, лхопа, тенгрпа, жангпа ястангуудыг "хятадын бие даасан үндэсний цөөнх"хэмээн тодорхойлжээ.[1399] Гэсэн хэдий ч тэд түвдийн ард түмний бүрэлдэхүүнд орж байв. Түвдийн янз бүрийн ястан өөр өөр гаралтайг ул үндэстэй болгож, ингэснээрээ тэд нэгдмэл ард түмэн бүрэлдүүлж чадахгүй байгааг нотлох гэсэн оролдлогыг шинжлэх ухааны үүднээс няцаасан билээ.[1400]

Тийнхүү коммунистууд түвдийн ард түмнийг хятадад нэгтгэж, энэ ард түмнийг зохиомлоор хуваан үзсэнээ мөнхжүүлж чадсан байна. "Түвд эзлэгдсэнээр түвдийн бурханы шашин өлгийнөөсөө, эх орноосоо салж, түвдийн ард түмний чөлөөтэй шүтэж бишрэх эрх зөрчигдөөд зогсоогүй Түвд болон Төв азийн энэхүү оюун ухаан, соёлын баялаг уламжлал хадгалагдан үлдэх явдал аюулын ирмэгт тулж ирсэн юм. Ялангуяа энэ нь түвдийг засаг захиргааны бие даасан олон нэгжид хуваах хятадын бодлоготой холбоотой бөгөөд эдгээр нэгжийн ихэнх хэсэг хөрш зэргэлдээх хятад мужуудын бүрэлдэхүүнд орсон юм. Түүхэн байр сууринаас авч үзвэл Түвдийн оюун санаа, соёлын нийтлэг өв уламжлалд эдгээр мужууд дахь



Түвдийн дүрвэгчид Энэтхэгт. 1960-аад он (DIIR Archive, Central Tibetan Administration).

түвдчүүдийн оруулсан хувь нэмэр асар их билээ. Гэтэл хятад мужуудын бүрэлдэхүүнд орсон өчүүхэн жижиг цөөнх болох эдгээр ястанд ирээдүйд буддын соёлоо, үндэсний өвөрмөц байдлаа хадгалан үлдэхэд маш хүнд байх болно. Түвдийн өөртөө засах орон гэгчийн гадна талд үлдсэн Түвд хүн ам түвдийн бүс нутгийн хүн амын ихээхэн хэсгийг, тухайлбал зургаан сая Түвд хүний барагцаалбал хоёр саяыг бүрдүүлж байна. Түвдийн энэ бүх хэсгийг эргүүлж нэгтгэхгүй бол Түвдийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй, ингэж нэгтгэх нь түвдийн соёлыг авч үлдэхэд зайлшгүй чухал зүйл мөн" гэж XIV Далай лам тэмдэглэн хэлжээ.[1401]

Далай ламын энэ дүгнэлт үнэн болохыг цаг хугацаа нотлон харуулсан билээ. Их Түвдэд нэгэнт ардчилсан шинэтгэл хийсэн болохоор түвдийн ард түмнийг тийнхүү бутаргасан явдлыг мөнхжүүлэх бодит үндэс байхгүй юм.[1402] Ингэсний зорилго бол түвдийн соёлыг устгаж, түүнийг шинэ соёлоор солих явдал байсан хэмээх дүгнэлт хийхээс өөр аргагүй юм.

Далай лам, түүний хамтран зүтгэгчид хилийн чанадад дүрвэж гарсан эх орон нэгтнүүдийнхээ тав тухайг хангах, оюун санааны уламжлал, цагаачлалд байгаа албан ёсны төрийн байгууллагуудыг сэргээх ажил эрхлэн явуулжээ. 1960 оны хоёрдугаар сард өмнөд Энэтхэгийн Карнатак муж улсын Белакуппед түвдийн анхны хөдөөгийн суурин байгуулагдав. Массурид түр байрлаж байсан түвдийн засгийн газар мөн оны дөрөвдүгээр сард өөр хот-

Дарамсалад шилжиж ирэв. Мөн тэр жилийн тавдугаар сард Массури хотод түвдчүүдэд зориулсан анхны сургууль, Дарамсалад хүүхдийн цэцэрлэг нээгдэв. 1970 он гэхэд Энэтхэгт 60 мянган хүн амтай 38 Түвд суурин байсан бол 10 жилийн дараа 45 болжээ.[1403] Эхний үед, ялангуяа биологийн шалтгаанаар нөхцөл байдал онцгой хүнд байв. Энэтхэгийн халуун уур амьсгалд дасаагүй түвдчүүд дүрвэгсдийн хуаранд олноороо нас барж байв.

"Миссамарид амьдрахад тэсвэрлэхийн аргагүй байсан. Уур амьсгал гэж тэсвэрлэхийн аргагүй халуун, бидний цусыг сорсон шумуул цатгалан, олон хүн халуун хумхаа болон гэдэс гүйлгэх өвчнөөр нас барна. Дүрвэгсдийн хуарангуудад бидэнд тусладаг цөөн тооны орчуулагч нар өвчин зовлон, аймшигт байдлыг тэсвэрлэж чадахгүй тэгсхийгээд буцаж явна" гэж дүрвэгчдийн нэг дурсан ярьжээ. [1404] Далай лам дүрвэгчдийг арай сэрүүвтэр уулархаг районд шилжүүлэн суурьшуулахыг энэтхэгийн засгийн газраас хүсчээ. Энэхүү хүсэлтийг ч хангаж, удалгүй хэсэг гэр бүл зам тавихаар Гималайн нурууны нилээд сэрүүвтэр нутаг руу явжээ. Энэ бол түр зуурын ажил байсан бөгөөд дүрвэгсэд шинэ ажил олохоор нэг газраас нөгөөд шилжин очиж байлаа. Гэтэл энд ч хуурай уур амьсгалд түвдчүүдийн хувьд байгаль цаг уурын байдал амаргүй байжээ. Тэдэнд Энэтхэгийн борооны улиралыг тэсвэрлэхэд хүнд байв, учир нь түвдчүүдийн суудаг майхан ус даахгүй, хувцас хунар гээд бүх юм нойтон болох ажээ.

Гэсэн хэдий ч энэ ард түмний хөдөлмөрч чанар, тэдний удирдагчдын авьяас чадвар үр дүнгээ өгөв. Дарамсалад Далай ламын удирдлагаар засгийн газар, мөн ард түмнээс сонгогддог парламент зэрэг түвдийн засаг, төрийн байгууллагууд ажиллаж байв. Засгийн газарт дотоод явдал, гадаад явдал, шашин, соёл, боловсролын, сангийн, аюулаас хамгаалах яамны сайд нарын албан тушаал бий болгов. Парламент буюу ардын депутатуудын комиссиийн анхны ардчилсан сонгуулийг бүр 1960 онд зарлав.[1405] Далай лам 1961 онд ирээдүйн түвдийн үндсэн хууль боловсруулахдаа түвдчүүдийн дэмжлэг авахыг эрмэлзжээ.

1963 онд тэрээр бэрхшээлт байдал болон ирээдүйн хөгжлийн стратегийг хэлэлцэхийн тулд бурханы шашны бүх чиглэл, бон шашны тэргүүн нарын уулзалт зохион байгуулав.[1406] Мөн онд Үндсэн хуулийн дэлгэрэнгүй төслийг ард нийтэд танилцуулжээ. Арван дөрөвдүгээр Далай ламын ивээл дор ажилладаг цагаач засгийн газар хятадын эзэгнэлийн бодлогыг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцэх үр нөлөөтэй хөдөлгөөн зохион байгуулсан байна.

БНХАУ-ын эрх мэдэл тогтохоос өмнөх Түвдийн бүх түүхэнд “дарлагдагч” болон “дарлагч”-дын хооронд ангийн антогнист зөрчлийн нэг ч илрэл байгаагүй, ард түмний зүгээс шинэтгэл хийх гэсэн нэг ч шаардлага гарч байгаагүй юм.[1407] Энэ бол феодалын нийгмийн түүхэн дэхь ховор үзэгдэл мөн. Тийм болохоор хятадын коммунистууд Түвдэд хувьсгалыг экспортлоогүй, өөрсдөө л хөрш орондоо түүнийг зохион байгуулсан юм. “Энхийн чөлөөлөгчдөд” дургүйцсэн ард түмний дургүйцэл 1959 оны бослого болж гарч ирсэн билээ. Энэ бол Түвдийн түүхэнд анх удаа доороос гарсан санаачлага байсан бөгөөд ард олон өөрсдөө зохион байгуулалтад орж, зэвсэглэж, өөрийнхөө хороог байгуулж, өөрсдийнхөө төлөөлөгчид болон шаардлагыг ард нийтээрээ дэвшүүлэн тавьжээ. Коммунист ягшмал номлолд бүрэн нийцэж буй дүгнэлт гэвэл энэ. Энэ ягшмал номлолд үл нийцэх өөр баримт байна: ардын бослого хувьсгалын эсэргүү бослого байсан юм. Энэ бослого ХКН, БНХАУ-ын эсрэг, ардчилал, социализмын эсрэг чиглэсэн юм. Үүнийг зөвшөөрөхгүй байхын аргагүй гэж X Банчин лам тэмдэглэж хэлсэн байна.[1408]

Түвдчүүд эх орныхоо тусгаар тогтнолын төлөө, феодализмыг хамгаалж боссон билээ. АНУ түвдийн партизануудыг дэмжихдээ түвдийн тусгаар тогтнол биш, харин БНХАУ-ыг сулруулахыг хүсч хоёр нүүрт байр суурь баримталжээ. Түвдийн партизанууд гадаадын империалистуудыг дэмжсэндээ биш, өөр хэнээс ч тусламж авч чадахгүй болсондоо л америкийн тагнуулын төв газраас тусламж авчээ. Түвдчүүдийг хилийн чанадаас дэмжсэн явдлыг хууль бус зүйл хэмээн үзэж болохгүй. Түвд нь аливаа бусад улсын нэгэн адил өөрийгөө батлан хамгаалах, түүний дотор партизаны хөдөлгөөний тусламжтайгаар, бусад орны дэмжлэгтэйгээр батлан хамгаалах эрхтэй билээ.

Гэвч өнөөдөр 1950-1960-аад оны хятадын суртал нэвтрүүлгээс эх үүдэлтэй бусад нотолгоог ч өргөн хэрэглэж байгаа юм. “Бослогч олон эрх дархаа алдахаас болгоомжилж, хятадын эсрэг санаа бодолтой болсон түвдийн элит бүлгийн төлөөлөгчдийн араас мунхаглан дагасан билээ.<...> Түвд орон эдийн засаг, ардын боловсрол, эрүүлийг хамгаалахын үзүүлэлтээр, хүн амынхаа амьжиргааны түвшингээр БНХАУ-ын хамгийн хоцрогдсон нэг нутаг байхаар мөнхөд үлдэж болохгүй юм”.[1409] Түвдийн ард түмэн хятадын төв засгийн газар, Түвдийн өөртөө засах орны байнгын хорооны удирдлагаар маш богино хугацаанд үймээн самууныг дарж, ардчилсан

өөрчлөн байгуулалтын ажилд орсон юм”.[1410] Бослогыг гадаадын хүчнүүд, юуны өмнө АНУ-ын империалистууд төлөвлөн чиглүүлжээ.[1411] Бослогыг Түвдийн эрх баригчид болон засгийн газар эхлүүлж, хүн амын 5 гаруй хувь түүнд оролцсоны дотор олонхи нь хууран мэхлэх, сүрдүүлэх аргад автсан бөгөөд харин ард түмэн ХАЧА, хятадын засгийн газарыг дэмжиж жагсаал цуглаан хийх болжээ.[1412] Түвдийн харгис хүчин 1959 оны бослогоор 17 зүйлт хэлэлцээрийг зөрчиж, чанга хатуу ч гэсэн шудрага шинэтгэлийг эрчимжүүлэх давалгааг Бээжингийн зүгээс үүсгэсэн юм [1413], яагаад гэвэл “феодал-шашны байгуулал шашны мухар сүсэг бишрэл төдийгүй айлган сүрдүүлэх, үнэхээр дундад зууны үеийн албадлагын аргад тулгуурлан тогтож байсан” юм[1414] гэх зэрэг нотолгоо гаргасан хэвээр байна.

Энэ бүхэн худал нотолгоо юм. Хэрэв БНХАУ Түвдийг булаан эзлээгүй бол “хятадын хоцрогдсон нутаг” болох ч үгүй, ямар нэгэн ардчилсан өөрчлөлт хийх ч хэрэггүй байсан юм. Төр-шашны байгуулал бол түвдийн ард түмний ухамсартай сонголт мөн. Энэ ард түмэн феодалууны эрх мэдэлд”хоцрогдмол” байдалд, мөн чанартаа бол үв тэгш, тогтвортой нийгэмд амьдрах сайн уу, муу юу гэдгийг өөрсдийн туршлагаар мэдэж байсан юм. Энэ нийгмийг ардчилсан шинэтгэл гэгчээр устгаж эхлэхэд элит бүлгийнхний хойноос “сохроор дагаагүй” харин эх орныхоо тусгаар тогтнголын төлөө тэмцсэн ард түмний үлэмж хэсэг боссон билээ. Түвдийн хөдөлмөрчид босогчдын гол үндсэн хэсгийг бүрдүүлжээ.[1415] Хятадын албан ёсны мэдээнд өгүүлсэн шиг 20 мянган хүн боссон бус, хамаагүй олон хүн байсан бөгөөд хожим нь улаан хамгаалагчдын хэвлэлд түвдийн бүх арми (4 мянган хүн) боссон бөгөөд түүнээс гадна 100 мянга гаруй” зэвсэгт дээрэмчид” байсан юм гэж өгүүлжэээ.[1416] Бидний хамтран зүтгэгчдийн олонхи нь эгэл жирийн хүмүүс байсан юм гэж бослогод оролцож явсан хүмүүс надад ярьсан билээ. Тэд хятадын эрх баригчдын эсрэг хүсэл зоригоороо босчээ.

Түвдэд хэрэгжүүлсэн “ямар нэгэн шудрага шинэтгэлийн” тухай ярьж болохгүй юм. Энэ бол дундад зууны үеийнхээс ч хамаагүй дор албадлага байлаа. 17 зүйлт Хэлэлцээрийг түвдчүүд биш, харин хятадууд биелүүлээгүйг ЗСБНХУ-д сайн мэдэж байсан. “Мао Зэдун болон түүний бүлэг хэрэг дээр 1951 оны хэлэлцээрийн нэг ч заалтыг биелүүлээгүйг олон тооны баримт нотлон харуулж байна”.[1417] Энэ шинэтгэл гэгчийг ойртуулахын тулд л санаатайгаар биелүүлээгүй ажээ. Тиймээс ч Мао бослого эхэлсний дараа: “Энэ бол сайн хэрэг, учир нь бидний асуудлыг энэ байдал л цэргийн хүчээр шийдвэрлэх боломж олгоно. <...> Тэд дайн дэгдээх аян шалтагийг надад

олгосон юм. <...> Самуун хүчтэй болох тусам бидэнд сайн байх болно" гэж мэдэгдсэн байна.[1418] ХКН-ын удирдлага 17 зүйлт хэлэлцээргийг тасалж, түвдийн засгийн газар бослогчдыг дэмжээгүй байтал бослогын хариуцлагыг энэ засгийн газарт тохжээ.

Лхасын бослогыг дарснаас хойш удалгүй Жоу Эньлай 1959 оны дөрөвдүгээр сарын 18-нд хоёр дахь удаагийн сонгуулийн БХАТХ-ын анхдугаар чуулган дээр үг хэлэхдээ: "Ямар ч байсан Түвдийн онцлог байдлыг бүрэн харгалзаж үзэх үндсэн дээр шинэтгэлийг аажим аажмаар үргэлжлүүлэх болно, гэхдээ шинэтгэл хийх явцад түвдийн ард түмний шашин шүтлэг, ёс суртахууныг бүрэн дүүрэн хүндэтгэж, түвдийн ард түмний гайхамшигт соёлыг хүндэтгэн хөгжүүлэх болно" гэж онцлон тэмдэглэжээ.[1419] Гэтэл бодит байдалд эсрэгээр эргэсэн байна. Хятадын албан ёсны эрх баригчдын мэдэгддэг шиг түвдэд эвдлэн сүйтгэх ажиллагааны ихэнхийг 1966–1976 оны соёлын хувьсгалын үед төдийгүй 1955, 1961 онуудад үйлдсэн байна. Тэр үед түвдийн өөртөө засах орны ардын засгийн газрын дэд ерөнхийлөгч байсан Бхучун 1987 оны долдугаар сарын 17-нд болсон хэвлэлийн бага хурал дээр үг хэлэхдээ үүнийг нотолжээ.[1420] Энд тэндгүй эвдлэн сүйтгээд зогсоогүй хүмүүсийг үй олноор гэсгээн цээрлүүлжээ.

Заримдаа Мао Зэдуныг энэ бүх хариуцлагаас чөлөөлөхийг оролдож байна. Дарга Мао аажим өөрчлөлт хийхийг хүссэн боловч орон нутагт цэргийн дарга нар болон түшмэд хэтэрхий яаравчилж дэг журам гажуудаалсан юм гэх мэтээр ярьж байна. Үүнтэй санал нийлэх аргагүй билээ. Эрх баригч нам, түүний удирдлага дотоодынхоо санал зөрөлдөөнөөс үл шалтгаалан буруу чиг шугамынхаа төлөө хариуцлага хүлээх ёстой юм. Мао энэ системийг бий болгосон, түүний шалгарсан удирдагч бөгөөд онолч байлаа. Түвдэд аажим шинэтгэл хийх явдал бол нөхцөл байдалд тохируулсан тактик байсан юм. Кам, Амдод шинэтгэл хэрэгжүүлсэн тэр л замыг ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд бэлджээ. Энэ хоёр нутагт хятадууд эхлээд бас л хэнийг ч гомдоохгүй байх, хүн амыг өөртөө татаж, сайн шан харамж өгөхийг эрмэлзжээ. Үүний зэрэгцээ зам харгуй тавьж, цэрэг болон дэд бүтцийг сайжруулжээ. Тэд байр сууриа бататгаж авсны дараа ардчилсан шинэтгэл буюу уламжлалт нийгмийг бутниргэх ажлаа эхлүүлсэн байна. Энэ нь бослого гарах шалтгаан болж, түүнийг ч шинэтгэлийг эрчимжүүлэхэд ашиглажээ. Ар талдаа буюу Кам, Амдод бослоготой байсан хятадууд ирээдүйн Түвдийн өөртөө засах оронд мөн ийм бослого өдөөн тухирч чадаагүй билээ. Тэр үед түвдэд хангалттай хяналт ч тогтоож чадаагүй байжээ.

Мао Зэдуны биечлэн боловсруулсан, ХКН-ын Төв хорооны намын дотоод удирдамжид тусгасан “түвдийн хувилбар” гэгч байсан тухай мэдээ бий билээ.[1421] Хятадын цэргийн эсрэг түвдчүүдийн тэмцэл өдөөн тухирч, дараа нь түвдийг “бүрэн төгс “илбэн тохинуулахын” тулд өргөн хэмжээний залхаан цээрлүүлэх ажиллагаа явуулах ёстой байжээ. 1977 оны есдүгээр сард “Жэньминь жибао” сонинд: “Бүх зүйл дарга Маогийн урьдчилж хэлснээр болсон юм” гэж бичсэн нь түүний “түвдийн хувилбарыг” хэлсэн хэрэг бизээ. “Бидний гол зорилго бол дайн, дарангуйлал мөн байсан” Мао Зэдун хэлсэн.[1422]

Заримдаа гэм буруутнууд хууль бус үйлдлийнхээ төлөө шийтгэл хүлээж байв. Гэвч чиг хандлага хуучин хэвээр үлджээ. Орон нутгийн түшмэд биелэхийн аргагүй зүйлийг биелүүлэхэд хүрч: хүн амын хүсээгүй зүйлийг тэдний “хүсэлтээр” биелүүлдэг байсан юм. Марксизмын онолоор бол ард түмэн хагаралд орж, дарлан мөлжигчдийг түлхэн унагах ёстой байсан бол ийм зүйл байгаагүй юм. Үүнээс л болж гэсгээн цээрлүүлэлт, ангийн тэмцлийн хуурамч дүр төрх ургаж гардаг ажээ. Маогийн бодлогыг тунхаглалаар нь биш, харин үр дүнгээр нь дүгнэх хэрэгтэй бөгөөд тэрээр хоёр нүүрт шинж чанартай байсныг тэр үеийн хүмүүс тэмдэглэн хэлдэг юм.[1423] “Дэмжих” жагсаал, цуглаан, “гашуун дурсамжийн” цуглаан, тэмцлийн цуглаан, үйлдээгүй гэмт хэргийн төлөө гэмээ хүлээх явдал, ХКН-ыг толгой дараалан магтан сайшаах үйлдэл, шинэтгэл хийх шаардлага – энэ бүхэн бол коммунист намын найруулан тавьсан жүжиг юм. Энэ бүхэн ард түмний санаа зоригтой огтоос холбоогүй, харин тэдний толгой тархийг эргүүлэхэд чиглэжээ. Эндээс л шинэтгэлийг түвдчүүд дэмжсэн тухай албан ёсны тоо баримт гарч иржээ.

1965 он гэхэд Түвдэд юуны өмнө “ангийн дсйнуудын” (лам нар, чинээлэг тариачид) эсрэг гэсгээн цээрлүүлэлтийн шинэ давалгаа, орон нутгийн кадр ажилтан түргэн хурдтай бэлтгэх кампанит ажил, засаг төрийн хурдавчилсан шинэтгэл, хөдөө тосгоныг коммунчлах ажил эхэлжээ. “Боолчууд болон хамжлагын тариачдад тулгуурлах” лоозон дэвшүүлэв. 1965 оны сүүлчээр “социалист хүмүүжлийн” кампанит ажил эхэлж, шашныг үндсээр нь устгах явдал түүний хамгийн чухал чиглэл байв.[1424] Энэ бол соёлын хувьсгалын эхлэл байлаа.[1425]

Бүлэг 9

# Аугаа их пролетарийн соёлын хувьсгал. Маогийн үеийн үр дүн

Аугаа их соёлын хувьсгалыг 1966 онд Мао Зэдун биечлэн санаачилж, тэргүүлжээ. "Соёлын хувьсгалын түймрийг би асаалаа" гэж тэр хэлсэн байна.[1426] Тэрээр насан эцэслэх хүртлээ үүнийг өөрийнхөө нэг гол гавьяа хэмээн үзэж байжээ. Нам-төрийн хуучин кадр ажилтнуудыг устгах замаар хувийнхаа эрх мэдлийг хадгалах, капитализмыг засварлах явдлыг сэрэмжлэн зайлуулж, уламжлалд тулгуурласан үзлийг бүрэн төгс устгаж, үе үеийнхний мөргөлдөөн бий болгох явдал түүний зорилго байв. Мао үе үеэрээ хөгжих диалектик болон эртний хятадын зарчмыг бүдүүлэг байдлаар хэрэглэж: "Эвдрэл сүйрэлгүйгээр бүтээн байгуулалт гэж байхгүй, Эвдлэн сүйтгэх бол шүүмжлэл, энэ бол хувьсгал... Юуны өмнө эвдлэн сүйтгэх хэрэгтэй бөгөөд энэхүү эвдрэлд бүтээн байгуулалт оршиж байгаа юм" гэж сургажээ".[1427] Юуг яаж бүтээн байгуулахыг тэр мэдэхгүй байсан ч ойр ойрхон эвдлэн сүйтгэж байхаар шийджээ. 1966 оны тавдугаар сарын 16-нд ХКН-ын төв хороо одоо соёлын хувьсгалыг анх удаа явуулж байна, цаашид олон дахин явуулах болно хэмээн мэдэгджээ. Дарга Маогийн гэргий Зян Цин тэргүүтэй түүний шадар хүмүүс "мэргэн шийдвэрээ" хэрэгжүүлж байлаа. Хожим нь тэдний заримыг "дөрвөн дээрэмчин" гэж зарлажээ.

Соёлын хувьсгал шинэ, социалист хүн бий болгох ёстой байв. "Хятад үндэстний аугаа их нэгдэл өөр аль ч нутгийнхаас, өөр аль ч үндэстний нэгдлээс түрүүлж амжилттай хэрэгжих болно" гэж Мао Зэдун 1966 онд хэлсэн байна.[1428] Үндэсний асуудал бол ангийн асуудал мөн гэсэн түүний үзэл санаанд тулгуурлах нь үндэсний олон янз уламжлалд дайн зарлана



Соёлын хувьсгалын үеийн зурагт хуудас. 1966 он: ”Мао дарга бидний зүрхэн дахь улаан нар байна” (http://www.oldposters.ru/)

гэсэн үг байв. Үнэн хэрэгтээ энэ бол "үндэсний цөөнхийг" хан үндэстэнд уусгах чиг шугам байсан бөгөөд хан үндэстэн ч өөрчлөгдөх ёстой байжээ.

Энэ нь "тархи шилжүүлэн суулгах" явдал: хуучин үнэт зүйлс, уламжлалыг баримтлагчдад "ногоон тархи", дэвшилт үзэлтэй хүнд хэвийн "цагаан" тархи шилжүүлэн суулгана гэсэн үг байв.[1429] Дэвшилт үзэлтэй хүмүүсийн хэвийн "цагаан" тархийг Маогийн үзэл санаагаар дүүргэх ёстой ажээ. Ийм үзэл санаагаар дүүргэхгүй бол тархи хоосон болох юм байна. Хятадад энэхүү давтан хүмүүжүүлэлт хуучин, шинэ хоёрыг, капитализм, социализм хоёрыг сөргүүлэн тавихтай холбоотой байв. Түвдэд бол "түвдийн", "хятадын" хоорондох зааг ялгаа нэмж орж иржээ. Хятадынхыг олонхи түвдчүүдийн хувьд "шинэ" зүйл болгон харуулж байжээ.

Түвдэд пролетари нар бараг байгаагүй, хувьсгал хийх өөрийн гэсэн боловсон хүчин цөөхөн, засаг захиргааны аппарат үр нөлөөгүй, намын байгууллагууд гол төлөв хятадуудаас бүрдсэн, хүн ам нь хятадуудын эрх мэдэлд дургүйцдэгээ олонтоо илэрхийлэх ажээ. Тиймээс энд үр нөлөөтэй засаглал бий болгох, нийгэм-эдийн засгийн бүтцийг хятад маягаар өөрчлөн байгуулах ажлыг дуусгаж, үндэсний, шашны "атгаг үзлүүдийг" Маогийн үзэл санаагаар шахах явдал соёлын хувьсгалын зорилго болсон байна.[1430] Хятадаас ирсэн "улаан хамгаалагчид" (хунвэйбин), "үймээн дэгдээгчдийн" (заофань) амжилтыг хангах явдал ХАЧА-ийн гол зорилт байв.[1431] "Атгаг үзэл санааг" устгах хөрс суурь ардчилсан шинэтгэлээр нэгэнт бэлтгэгджээ.

Соёлын хувьсгал албан ёсоор 1966 оны тавдугаар сард эхэлсэн ч олонхи түвдчүүдийн хувьд энэ хувьсгал 1409 онд Зонховын санаачлан бий болгосон гол баяр ёслолуудын нэг болох Монламын баярыг Лхас хотод тэмдэглэхийг хятад эрх баригчдын шийдвэрээр хориглосон хоёрдугаар сард эхэлжээ.[1432] Энэ баярын өмнө зориуд янз бүрийн цуглаан зохион байгуулж, түүнийг хөрөнгө мөнгө үрсэн хоосон зүйл гэж нэрлэж байжээ.

1966 оны тавдугаар сард хувьсгал хийх зорилгоор 500 хүнийг, голдуу

ханъ үндэстнүүдийг Бээжингээс Лхаст авч иржээ.[1433] Тэр хүмүүсийн дотор бээжингийн их сургуулиуд, нисэх хүчний болон геологийн дээд сургуулийн оюутнууд байв. Хятадын орон нутгийн есөн байгууллагын улаан хамгаалагчид, “хамжлагын тариачин”, “боол” байсан зарим хүнийг тэдэнтэй нэгтгэсэн байна. Тэд “мао” хувцастай, түүний дүр бүхий тэмдэг зүүсэн, толгойгоо улаан туузаар ороожээ. Хүн бүрийн шахам барьсан жижиг улаан даавуун дээр эрүү малгай тавьсан Маогийн хөрөг нааж, “түвдийн улаан штаб, улаан хамгаалагч” гэсэн үгийг хятад, түвдээр бичсэн байв.[1434] 1966 оны тавдугаар сарын сүүлээр Түвдийн өөртөө засах орны хятадын коммунист нам Лхас хотод Ван Цимэй тэргүүтэй соёлын хувьсгалын хороо байгуулав. Энэ хүн 1951 оноос Түвдэд байсан ажээ. Тухайн үедээ тэрээр Чамдод Агваан Жигмэдтэй хэлэлцээ хийж байжээ.

1966 оны зургадугаар сарын 21-нд БНХАУ-ын гол сонин “Жэньминь жибао” сонинд “Мао Зэдуны үзэл санаа Түвдийг феодалын бурангуй байдлаас чөлөөлөгдөхөд хүргэж байна” гэсэн гарчигтай өгүүлэл нийтлэгдэв.[1435] Феодал-шашны “дарлал мөлжлөгийн үзэл суртал”, “дөрвөн хуучинтай” тэмцэж, Соёлын хувьсгалын үзэл суртлыг газар сайгүй дэлгэрүүлэхийг энэ өгүүлэлд уриалсан байна. “Дөрвөн хуучин” буюу “дөрвөн үлдэгдэл” гэдэг бол хуучин үзэл санаа, соёл, дадал,заншил ажээ. 1966 оны наймдугаар сард Лхаст шинэ үеийн 90 багш “хамжлагын тариачид” байсан хүмүүс буюу тэдний хүүхдүүдийн анхны төгсөлт болов. Тэд ангийнхаа ухамсрыг дээшлүүлж, ертөнцийг үзэх үзлээ өөрчилж, хуучин үзэл санаа, соёл, дадал, заншлыг эвдэх шийдвэрээ улам бэхжүүлсэн юм гэж тэр үед мэдээлж байлаа. Мөн сард 10 мянган гишүүнтэй орон нутгийн залуучуудын байгууллага улаан хамгаалагчдыг дэмжиж байгаагаа мэдэгдэв. Тэр үед мөн “Гунжэнь жибао” сонин Түвдийн нийслэлд “дөрвөн хуучинтай” хийх тэмцэлд зориулсан өгүүлэл нийтлэв

Үйл явдлын ийм дэвсгэр дээр Жоу Эньлай БНХАУ-ын хамгийн их ач холбогдолтой түүхийн зарим дурсгал, тухайлбал Будалын ордныг хамгаалах тухай тушаал гаргав.[1436] Үнэн хэрэгтээ бол бүх түүхэн дурсгалуудыг хамгаалах боломжгүй байсан ч БНХАУ даяар түүний нэрийг соёлын өв уламжлалыг хамгаалах үйл хэргийн билэг тэмдэг болгон ашиглах болсон билээ. “Дөрвөн хуучныг” устгах явдал хувьсгалын нэг гол зорилт байсан боловч чухам юуг устгахыг заагаагүй ажээ.

БНХАУ-д 1966 оны наймдугаар сарын 18-ныг улаан хамгаалагчдын төрсөн өдөр хэмээн үздэг.[1437] Энэ өдөр Мао Зэдун шадар хүмүүсийнхээ хамт Бээжингийн Тяньаньмэний талбайд улаан хамгаалагчдын өргөн цуглаан

хийсэн юм. Дарга Мао энэхүү чухал үйл явдлыг армийн зүгээс дэмжиж байгааг онцлон тэмдэглэхдээ Солонгосын дайнаас хойшхи 16 жилд анх удаа цэргийн дүрэмт хувцастай байжээ. Улаан хамгаалагчдын шинэ байгууллагууд бий болсныг Мао Зэдун биечлэн дэмжиж байгаа юм гэж Чэнь Бода, Линь Бяо, Жоу Эньлай нар хэлсэн үгэндээ онцлон тэмдэглэж байлаа. Маог дээд ерөнхий командлагч, Соёлын хувьсгалын жанжин хэмээн нэрлэж байв. Чэнь Бодагийн анх дэвшүүлсэн "Дөрвөн хуучинтай" тэмцэх лоозонг Линь Бяо дэмжив. Мао наймдугаар сарын 18-наас арваннэгдүгээр сарын 26-ныг дуустлах хугацаанд Бээжин хотод улаан хамгаалагчид, хувьсгалт багш нар, оюутнуудтай найман удаа уулзжээ. Эдгээр уулзалтад 11 сая гаруй хүн оролцсон байна. Мао дарангуйлагчынхаа аргыг залуу байхдаа сонирхож байсан анархи үзэлтэй хослуулж чаджээ.

Мао 1966 оны наймдугаар сарын 23-нд "хэтэрхий соёл иргэншилтэй" байна гэж улаан хамгаалагчдыг зэмлэв.[1438] "Орон нутагт гарч буй эмх замбараагүй явдал гэгчийн талаар ямар чиг шугам баримтлахаа шийдвэрлэхэд асуудлын гол утга учир оршиж байгаа юм. Би дахиад хэдэн сар эмх замбараагүй явдал өдөөж л байг гэсэн саналтай байна" гэж тэр хэлжээ.[1439] Энэ шийдвэр түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд эрх баригч хүн улс орондоо эмх замбараагүй байдал бий болгохыг зөвшөөрчээ. Ингэхлээр улаан хамгаалагчид болон самуун дэгдээгчдийг Гитлерийн германы СА-гийнхантай адилтган "дайралтын отрядууд" гэж нэрлэсэн зөвлөлтийн зохиогчид яг оножхэлээгүй болов уу.[1440]

Сургуулиуд хичээлээ хааж, сурагчид улаан хамгаалагч дээрэмчдийн эгнээг өргөтгөв. "Та нар хэдийчинээн их суралцнав, төдийчинээн их тэнэг болно" гэж Мао хэлсэн болохоор одоо яая гэх билээ.[1441] Гэхдээ есдүгээр сар гэхэд Лхаст олон "соёлын танхим", залуучуудын ордон, Маогийн зохиолыг судлах оройн сургуулиуд нээгдэв.[1442] Хуучин Лхаст оршин суугчдын тэн хагас гаруй нь энэ сургалтад байнга хамрагдах ажээ.

Дарга Маогийн заавар Лхасын улаан хамгаалагчдыг шийдвэртэй үйл ажиллагаанд зоригжуулав. 1966 оны наймдугаар сарын 25-нд Жокан, Рамоче (640 оны үед байгуулагдсан) зэрэг Түвдийн гол сүмүүдийг эвдлэн сүйтгэх ажил эхлэв.[1443] Рибур Тулку энэ тухай дараах зүйлийг ярьсан байна.[1444] Шөнө дундын алдад соёлын үнэт зүйлсийн хэрэг эрхэлсэн хятадын товчооных болов уу гэмээр хэд хэдэн машин дээрх сүмүүдэд дөхөж очсон юм. Тэдгээр машинаас олон цэрэг, бас түшмэд боловуу гэхээр хүмүүс гарч ирсэн. Үүр цаахаас өмнө тэд цутгамал бурхадын бүх алт, мөнгөн чимэглэл, бусад үнэт эд зүйлсийг машиндаа ачиж авч явсан юм. Жоканад Х Банчин

ламын тушаалаар Сэр, Дрепун, Гандан зэрэг томоохон хийдүүдийн шашны үнэт эд зүйлс хадгалагдаж байсан болохоор их олзтой буцсан байх гэжээ. Дараа нь Түвдийн өөртөө засах орны ХКН-ын хороо болон Лхасын бусад байгууллагын удирдагчид өөрсдийн харьяаны хүмүүсийг сүм хийд эвдлэн сүйтгэх ажилд дайчилсан билээ. Хожим нь тийш зөвхөн түвдчүүд орохыг тушааж, хятадууд очихыг хориглосон юм.

Тэр үед сургуулийн сурагч байхдаа Жоканийг эвдлэн сүйтгэхэд оролцож явсан нэгэн эмэгтэй энэ тухай дурсаж ярьсан юм.[1445] Өглөөгүүр дунд сургуулийн сурагчид хоёр улаан хамгаалагчаар удирдуулан хятад багшийн хамт сүм рүү хөдөлсөн. Бид сургуулийнхаа далбааг, бас Маогийн “Самуун бол зөв үйл хэрэг мөн”, “хувьсгалын эсэргүүчүүдийг даран сөнөөе” гэсэн үг бүхий уриа лоозон барьж явлаа. Жагсагчид гудамжаар бөмбөр болон цимбал хөгжмийн аяар алхана. Тэдний замд олон зуун оюутан, залуу улаан хамгаалагч ирж нийлнэ. Үд дунд болоход жагсагчид сүмийн эсрэг талын хашаанд дөхөж ирэн түвдчүүдийн амьдралын уламжлалт хэв маягийг доромжилсон ердийн дуу дуулж, бүжиг үсрэх ажээ. Улаан хамгаалагчид цугларсан олноос зарим хүмүүсийг гаргаж ирээд тэдний үс,гэзэгийг хайчилж, Түвд эмэгтэйчүүдийн хормогчийг хуу татан хаяж, нэг хүнд британийн цэргийн дүрэмт хувцас маягийн юм өмсгөж, империалист болгоно. Шашны ёс жаяг үйлдсэнийх нь төлөө хэд хэдэн хүний хэргийг шүүх ажиллагаа явуулж, шинэ итгэл үнэмшилтэй болохыг тэднээс шаардана. Нэг сурагч хүмүүсийн дунд зогсож байсан эхийгээ сүрдүүлэх бөгөөд тэр эмэгтэй хуучин зуршлаасаа огт татгалздаггүй нэгэн ажээ.

Үд болоход олон хүн цуглав. Улаан хамгаалагчид Жокан сүмээс хэд хэдэн цутгамал бурхан гарган ирж, хэмх цохино. Зарим өвгөд уурласандаа бахардаж буй харагдах ажээ. Улаан хамгаалагчид сүмийн эргэн тойрон дахь Баркорын гудамжны байшингуудын дээвэр дээр гарч, шашны туг,дарцагуудыг хуу татан хаяж, цутгамал бурхадыг байшингийн цонхоор шидэлнэ. Сүм рүү орох дөрвөн хаалгыг улаан хамгаалагчид халхлан зогсчээ. Хажууд нь бас ХАЧА-ийн цэргүүд зогсоно. Орой болсон хойно нэг орох хаалганы дэргэд тэмцэл эхлэв. Цэргүүд юу ч хийж чадахгүй ажээ. Тонуулчид дотогш дайран орох бөгөөд тэдний нилээд нь Лхасын ойролцоох нутгуудаас иржээ. Сургуулийн сурагчид тэдэнтэй нийлж, бурхан шүтээн, өрөө тасалгааг хэрхэн төлөвлөгөөтэй устгахыг харж зогсоно. Тонуулчид алт болон эрдэнийн чулуу эрэх ажээ. Шалан дээр шар тос, элдэв боов боорцог, судар ном, торгон зургийн аргаар бүтээсэн зурмал бурхад, цутгамал бурхадын эвдэрхийнүүд хөглөрөх ажээ. Нэг хэсэг хүн ямар нэгэн



1



2



3



4

Жокан сүмийг эвдлэн нурааж байгаа нь (Woeser, 2006/permission from Woeser):
1 – улаан хамгаалагч оюутнууд, нутгийн оршин суугчид сүмийн ойролцоо бурханы шашны судар ном шатааж байна; 2 – сүм дотор буй улаан хамгаалагчдын эвдлэн сүйтгэсэн бурханы шашны цутгамал бурхад болон шашны ёс үйлдэх эд зүйлс; 3 – сүмийн дээврийн чимэглэлийг эвдэж байна; 4 – сүм эвдэлж нураасан улаан хамгаалагчид. Тэд Мао Зэндуны хөрөг: "Хуучин ертөнцийг бүрмөсөн эвдэлж хая. Бид шинэ ертөнцийн эзэд болох ёстой" гэж бичсэн зурагт хуудас барьжээ

зүйл хулгайлах, нөгөө хэсэг нь аврахыг эрмэлзэнэ. Лам нар Шагжмун, Банданлхам бурхадын цутгамал хөрөг зэрэг ариун шүтээнүүдээ тойрч амьд хэрэм болон зогсох ажээ. Тэднээс нилээд олон хүнийг сүрхий гэмтээсэн дээ.

Эвдлэн сүйтгэгчид Түвдийн хамгийн гол шүтээний нэг болох Шагмун бурханы цутгамал дүрийн хоёр хөлийг салгаж чадсан тухай би дуулсан юм байна. Их хөлгөний болон Лхас хотыг хамгаалагч бурхан болох Банданлхамын сүрлэг том цутгамал дүрийг хадгалж байсан өрөөний дээврийг эвдлэн сүйтгэгчид хуу татан орох тэр агшинд чанга яригчаар "хоцрогдлын эсрэг аугаа их гавьяа байгуулсан тухай" зарлаж, цугласан олны үйлдсэн хэргийг магтан сайшаажээ. Оройн бүрий ороход хүүхдүүдийг сургууль өөд нь явуулж, тэдэнд улаан хамгаалагчдын удирдагчид баяр хүргэнэ.

Тэр өдөр түвдийн ард түмний хүндэлж ирсэн Бурхан Буддагийн эрт дээр үеийн цутгамал дүр, сургааль хамгаалагчид, бурханы шашинт хаадын ийм дүрүүд болон бусад олон мянган шүтээнийг устгав.[1446] Жоканд байсан цутгамал бурхадын дотор VII зуунд амьдарч байсан түвдийн аугаа их Соронзон Гомбо хааны амьдралын сүүлч үед онцгой үүрэг гүйцэтгэсэн хоёр бурхан байжээ. Өөрөө аяндаа бий болсон Буддагийн алдарт модон дүр Балбад байсан гэж домогт гардаг. Энэ бурхныг Соронзон Гомбо хаан авсан ажээ. Жоканд тэр бурхныг бодьсад Арьяабалын хувилгааны шавар баримал дүр дотор хийж хадгалсан байна. Соронзон Гомбо хаан таалал төгсөхдөө Буддагийн жижигхэн модон дүр дотор гэрлийн цацраг болон уусcан байна. Улаан хамгаалагчид бурханы том шавар баримлыг хага цохиход дотроос нь модон дүр гарч иржээ. Нэгэн Түвд хүн түүнийг хадгалж байгаад Энэтхэг рүү XIV Далай ламд явуулж амжсан хэмээх домог байдаг ажээ.[1447]

Жокан сүмийг эвдлэн сүйтгэсэн үндсэн үе шатуудыг мэдээллийн Синьхуа агентлагийн сурвалжлагч гэрэл зургийн хальсанд буулгаж авсан байна.[1448] Ийнхүү гэрэл зураг татах ажлыг эрх баригчид зохион байгуулаагүй байх хэмээн санагддаг, яагаад гэвэл эдгээр гэрэл зурагт үзэл суртлын үнэр шингээгүй ажээ. Хятадууд буюу пролетарийн хүмүүжлийн бригадын гишүүд шөнө болсон хойно ирж үлдсэн бараг бүх бурханыг эвдэж хаясан байна. Жокангийн сүмийн олон зуун гонхон өрөөний дөнгөж хоёр нь бүтэн үлджээ. Дараа өдөр нь эрх баригчдын төлөөлөгчид дунд сургууль дээр очжээ. Тэд болсон явдлыг зэмлэн буруушааж, улаан хамгаалагчид нөхцөл байдлыг хяналтаасаа гаргасныг хэлжээ. Хожим нь улаан хамгаалагчид засгийн эрхийг авмагцаа дээрх хүмүүсийг капиталист санаа бодолтой

хэмээн буруушааж, “цэвэрлэгээнд” оруулжээ. Жоканд улаан хамгаалагчдын “штаб” байгуулжээ.

Жоканийг бутниргэсэн өдөр төрийн үзмэрч нарын сүмд байсан бурхадын хөрөг, зургийг устгасан байна. Рамоче сүмд Түвд дэхь бурхан багшийн хамгийн хүндэтгэлтэй хоёр цутгамал дүрийн хоёрдахийг устгасан байна. Бурхан багш өөрөө түүнийг аравнайлж: VII зуунд түүнийг Соронзон Гомбо хааны Балба эхнэр Бхрикути түвдэд авч ирсэн хэмээх домог бий. Улаан хамгаалагчид алх,хасууртай дархчуудыг авч ирж, дээр дурдсан цутгамал бурханг эвдүүлжээ. Дараа нь түүний эвдэрсэн хэсгүүдийг дахин хайлуулахаар авч явсан байна. Хожим нь энэ бурханыг сэргээсэн бөгөөд 1980 онд түүний доод хэсгийг орон нутгийн хаягдал төмөрийн агуулахаас, цээжин биеийг Бээжингээс олжээ.[1449]

Рамоче сүмд өөр олон мянган ариун шүтээн устгасан байна. Тэндхийн гол танхимын туурганы зургийг арчиж арилгаад уг танхимыг умард Лхасын тойргийн хорооны мэдэлд өгсөн байна. Тэр өдрүүдэд хятадуудын тушаалаар Лхасын гол гол сүмийн бүх судар, номыг (нууж амжсанаас бусад) шатаасан юм гэж Рибур Тулку гашуудан дурсаж бичжээ.[1450] Тус хотын янз бүрийн газарт хэд хоног өтгөн хар утаа суунаглаж байжээ. Жокангийн сүмээс холгүй түвд-хятадын гэрээний бичвэрийг сийлсэн VIII зууны үеийн чулуун багана гэмтжээ. Хятадын суртал нэвтрүүлэгчид Түвд, Хятад хоёр улс эртнээс нааш харилцаа холбоотой явж ирсний нотолгоо хэмээн сүржигнэн магтдаг тэрхүү гэрээ энд яригдаж байгаа юм.

Эвдлэн сүйтгэгчид үйлдлээ хэрхэн дүгнэсэн нь сонирхолтой юм. Дээр бидний дурдсан тухайн үеийн хэрэг явдалд оролцогч эмэгтэй энэ тухай халаглан дурсчээ. Надад одоо зүүд мэт л санагдаж байна. Сүмд хийсэн халдлага дууссаны дараа түвдчүүдийн хэн нь ч юу хийснээ итгэж чадахгүй байсан билээ. Маогийнхны хүчинд автаж эвдрэл сүйтгэлд оролцсон олон Түвд хүн насан эцэслэх хүртлээ хийсэн үйлдлийнхээ төлөө гэмээ наминчилж байсан юм гэж тэр эмэгтэй ярьсан байна.[1451]

Улаан хамгаалагчид “дөрвөн хуучинтай” дайн зарлахдаа энэ дөрөвтэй тэмцэх 20 зүйлт хөтөлбөр зохиожээ. Түвдийн багшийн сургуулийн улаан хамгаалагчид наймдугаар сарын 27-нд энэ программыг оруулсан ухуулах хуудас Лхас хот даяар тараав. Уг хөтөлбөрт:

“1) Хүндэтгэлийн тэмдэг болгож мэхийн ёсолж, хэлээ гаргахыг пролетари нарын эсрэг чиглэсэн феодалын дарлал мөлжлөгийн шинж тэмдэг хэмээн үзэж халах ёстой.

2) шашны баяр аливаа хэлбэрээр тэмдэглэхийг цуцлах ёстой.

3) Гудамж, цэцэрлэгт хүрээлэнгийн феодалын бүх нэрийг өөрчлөх ёстой

4) Том, жижиг бүх суваргыг эвдлэн нураах ёстой.

5) идеализм, феодализмыг магтсан бүх номыг хориглох ёстой.

6) Маанийн зургаан үсэгтэй бүх хана, шашны дарцаг, ангийн бойпоруудыг эвдэлж хаях ёстой.

7) Хэн ч амны уншлага хэлэх, гороо хийх, сунаж мөргөх ёсгүй. Хүмүүс үзмэрч болон зөнч мэргэдтэй зөвлөлдөх ёсгүй.

8) Хүмүүс Далай лам, Банчин ламын бүх гэрэл зургийг устгах ёстой.

9) Засварлах үзэлтнүүд, феодализм, харгис хүчнийг магтсан бүх гэрэл зургийг устгах ёстой.

10) Засгийн газрын хяналтад байгаагаас бусад бүх сүм, хийд нийтийн хэрэглээий газар болон хувирах ёстой.

11) "Түвдийн өдөр дутмын сонин", "Лхасын радио" язгуууртны хэлийг хаяж, пролетари нарын хэл хэрэглэх ёстой. Түвд хэл зүйг зохих ёсоор шинэчлэх ёстой.

12) Бүх ислам сүсэгтэн мөн. Шинэ нийгмийг хүлээн зөвшөөрч, хуучин уламжлалаа эвдэх ёстой.

13) Ардын цэцэрлэгт хүрээлэн болох Норовлин ордон ард түмний амралтын газар болж нээгдэх ёстой.

14) Лам, гэлэнмаа нарыг дахин улс төр, үзэл суртлын талаар улам их хүмүүжүүлэх ёстой. Тэдэнд сүм хийдийн зүгээс даралт үзүүлэхгүйгээр шашны мяндаг, сахил санваараасаа татгалзахыг зөвшөөрөх хэрэгтэй.

15) Лам, гэлэнмаа нарт гэр бүл болохыг зөвшөөрөх хэрэгтэй, тэд үйлдвэрлэлийн хөдөлмөр эрхлэх ёстой.

16) Дарлан мөлжигч ангийнхныг хөдөлмөрөөр хүмүүжүүлж, тэдний зан байдлыг анхааралтай ажиглаж байх хэрэгтэй.

17) Дайллага хийх, бэлэг сэлт, алчуур солилцох зэрэг феодалын заншлыг зогсоох хэрэгтэй.

18) Нэг эр хүн хоёр эхнэртэй, нэг эмэгтэй хоёр нөхөртэй байдаг, эцэг,хүү хоёр эхнэрээ хувааж хэрэглэдэг, эгч, дүү хоёр нэг нөхөр хувааж хэрэглэдэг, ах, дүү хоёр нэг эхнэр хувааж хэрэглэдэг феодалын гэрлэлтийн заншлыг үндсээр нь устгах хэрэгтэй.

19) Шинжлэх ухааны боловсролыг ард түмэнд сурталлчлах хэрэгтэй. Шинжлэх ухаанч хүмүүжилд сургадаг кино үзүүлж байх хэрэгтэй.

20) Лхас хотын бүх золбин нохойг устгах ёстой, хүмүүс гэртээ муур, нохойтой байх ёсгүй".[1452]

Энэ уриалгад капитализм, социализмын тэмцлийн тухай дурдаагүй нь сонирхолтой юм. Коммунист намын орон нутгийн салбарын тухай ч дурдсангүй. Орон нутгийн коммунистууд феодалын уламжлалд өгөх цохилтыг өөрсдөөсөө зайлуулахын тулд мулгуудуухан улаан хамгаалагчдыг энэ уриалгад өдөөн тухирсан юм гэж Ц. Шакья маш зөв тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, эх оронд нь түвдийн гэх зүйлээс үлдээхийн тулд ингэсэн байж болох юм. Энэ уриалга сонирхолтой гэж хэлж болох зөрчил үүсгэжээ.[1453] Жишээ нь, хориглосон цагаан алчуурыг улаан болгож, Маогийн хөрөг зураг болон хэлсэн үгийнх нь номон дээр тохон тавьж, харин олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түүний нэрийг дурдахдаа заавал магтаалын үг хэрэглэх ёстой ажээ.

1966 оны 10 дугаар сарын 15-нд Жоу Эньлай (Лхаст үйлдсэн эвдлэн сүйтгэх ажиллагааны сэтгэгдлээр) түвдийн оюутнуудтай уулзаж хэлэхдээ “дөрвөн хуучныг” эвдлэх явдал мэдээжийн хэрэг сайн зүйл, сүм, хийдэд халдаж, лам нарын засаглалыг устгах хэрэгтэй. Гэхдээ шашин аажмаар мөхөж байна, сүм, хийдүүдийг сургууль, агуулах болговол дээр биз, шашны зарим нэг шүтээн зэрэгхэнийг эвдэн нурааж болох юм, гэхдээ өвгөд хөгшидийг гомдоохгүйн тулд зарим аугаа их сүмүүдийг хадгалан үлдэх талаар бодох хэрэгтэй юм гэж хэлжээ.[1454] Зарим нэг зүйлийг эвдлэхгүй байхыг хүссэн хүсэлт “дөрвөн хуучныг” бутцохин устгах хувьсгалын тов тодорхой заалтаас хамаагүй бүрхэг байгаа биз.

Бичсэн зүйлүүдээс нь үзвэл соёлын өв Маод огт хамаагүй байжээ. Тэрээр өөр зүйлд санаа зовж байсан нь хувийнхаа эрх мэдлийн төлөө, өөрийнхөө бий болгосон эмх замбараагүй байдал хийгээд намын доторхи өрсөлдөөн тэмцэлдээнийг хэрхэн удирдах тухайд, капитализм болон ревизионизмыг илчлэх зэрэг ажээ.

Түйвээн бусниулах ажиллагаа зогсоогүй нь гайхах зүйл бишээ. Тиймээс 1967 оны гуравдугаар сарын 16-нд ХКН-ын Төв хороо, Төрийн зөвлөл, Цэргийн төв комисс улсын өмч хамгаалах тухай захирамж гаргахад хүрсэн байна.[1455] Уг захирамжийн дөрөвдүгээр зүйлд “бодлогогүй хөөрч”, соёлын үнэт зүйлс болон ном зохиол устгахыг шууд хоригложээ. Тавдугаар сарын 14-нд энэхүү улсын өмчийг хамгаалан авч үлдэхийг уриалсан өөр нэг баримт бичиг гаргажээ. Феодалуудын барилга байшин, шашны уран баримлуудыг олон түмнийг хүмүүжүүлэх зорилгоор эрх баригч ангийнхан болон империалистуудын гэмт хэргийг илчлэхийн тулд хэзээ нэгэн цагт ашиглаж болох юм, бас “хор нөлөөтэй номуудыг дайралдсан газар нь шатаагаад байхын хэрэггүй дээр дурдсан зорилгоор тэдгээр номыг хадгалан








1 – Түвд пионерууд Маогийн хэлсэн үгийн ном барьжээ; 2, 3 – коммунист жагсаал, цуглаан (Woeser, 2006/permission from Woeser)




Лхас хот дахь Маогийн хөрөг ба ухуулах хуудсууд (Woeser, 2006/permission from Woeser). Лоозонд: "Шинэ аугаа их зам тавья" гэж бичжээ

авч үлдэж болох юм гэж энэхүү захирамжид тайлбарлажээ.

Мэдээжийн хэрэг тэр үед өөр ойлголт хэрэглэх боломжгүй байв. Гэхдээ өнөөдөр ч тийм томьёолол бүрхэгдүү сонсогдож байгаа бөгөөд хувьсгалт мансуурлын үед бол бүр ч өөр байсан бизээ. Тиймээс ч "дөрвөн хуучныг" эвдлэн нураах зааврыг хэн ч өөрчилж чадаагүй юм. Тийнхүү 1966 оны хоёрдугаар хагасынх шиг тийм хурдацаар биш ч гэлээ эвдлэн сүйтгэх ажил үргэлжилсээр байлаа.

Танхай балмадуудтай тэмцэж болохгүй байсан юм: Мао Зэдун болон түүний төв хороо "ажилчид, тариачид, хотын хүн амыг ямар ч шалтагаар, ямар ч хэлбэрээр суралцагч залуучуудын эсрэг тэмцэлд өдөөн тухирч, зохион байгуулахыг зөвшөөрөхгүй... Суралцагч залуучуудтай шууд ам зөрж, хэрүүл маргаан үүсгэх хэрэггүй, тэдэнтэй мөргөлдөөн үүсгэж болохгүй" гэсэн тов тодорхой заавар өгчээ.[1456] Улаан хамгаалагчдын хувьсгалт үйлдлүүд "ард олны дургүйцлийг илэрхийлж, газрын эзэд, хөрөнгөтөн, империалистууд, ревизионистуудын анги болон тэднийг аялдан дагалдагчдыг хилэгнэн буруушааж байгаа нь..харгис хүчний эсрэг ажиллагаа бол зөв үйл хэрэг мөнийг гэрчлэн харуулж байна. Би та бүхнийг халуунаар дэмжиж байна."[1457] "Залуучууд алдсан ч тэднийг зүгээр өнгөрөөх хэрэгтэй. Тэдний ерөнхий чиг

хандлага зөв учир бага зэргийн алдаа гаргавал ч гаргаг. Энэ залуус практик ажлынхаа явцад засарч чадна гэдэгт итгэлтэй байна".[1458]

Дарга Мао өөрийнхөө үзэл бодлын эсрэг үг хэлэв үү гэлтэй. Яагаад гэвэл тэрээр: "Үзэл суртлын шинж чанартай бүх асуудал, ард түмний доторхи маргаантай бүх асуудлыг зөвхөн ардчилсан замаар, хэлэлцэх, шүүмжлэх, итгүүлэн үнэмшүүлж, хүмүүжүүлэх аргаар шийдвэрлэж болно: эдгээр асуудлыг албадах, шахалт үзүүлэх аргаар шийдвэрлэж болохгүй" гэж хэлж байжээ.[1459] Харин бодит байдалд бол хэрэв Мао "ард түмэн", "дайсан" хоёрыг хэрхэн ялган үзэж байсныг санавал ямар нэгэн зөрчил гараагүй ажээ.

Түвдэд улаан хамгаалагчид гудамжинд яваа эр, эм хүмүүсийн гэзэг, үсийг хайчилж, айлын гэр оронд дайран орж түйвээн бусниулж, түвдийн соёлд хамаатай бүх зүйлийг устгаж байв. Энэ нэгжлэг, түйвээлтийг системтэй явуулж байсан юм. Хэрэв хэн нэгний гэрээс феодалуудын хувцас, тансаг гоёл чимэглэл, түвдийн армийн дүрэмт хувцас зэрэг онцгой эд зүйлс олдвол энэ нь гэрийн эзэнд ёстой гай болж, тэднийг гэрээс нь хөөн гаргаж, элдвээр доромжлон гудамжаар тууж явах ажээ. Мөн түүнчилэн шашны эд зүйлс байгаа эсэхийг дахин эрж нэгжинэ. Ийм эд зүйлсийн заримыг авдранд хийж лацдах бөгөөд харин ном, сударыг шууд шатаах ажээ.[1460] Бүх хүн шашныхаа эд зүйлсийг устгах тухай аймшигт мэдээ өдөр шөнөгүй гарах болов. Бүх алт, мөнгийг Хятадын улсын банканд тушаах ёстой байв. Хүмүүст гоёлынхоо зүйлийг л авч очихгүй юм бол өөр юу ч үлдсэнгүй. Нийт орон даяар түвдчүүд багавтархан овортой цутгамал бурхадыг болох бүх газарт нууж, заримыг нь газар ухан булж, томоохонгуудыг хэмх цохин Кийчу голд хаях ажээ.[1461] Хятадууд шашны болон чимэглэлийн эд зүйлсийн загварыг Тромцикангийн зах дээр тавьж, том том зурагт хуудас хажууд нь байрлуулах ажээ.[1462]. Ийм эд зүйлс эзэмших явдал хууль бус, тэдгээрийг энд авч ирж, эрх баригчдад тушаах хэрэгтэй гэж эдгээр зурагт хуудсанд бичнэ. Айл бүр,байшин бүрт Маогийн хөрөг тавьж, хятад улсын далбаа өргөх болов.[1463] Байшин барилгын ханан дээр дарга Маогийн хэлсэн үгнээс бичсэн хуудас наана. Энэхүү жижиг улаан номууд 1967 оны сүүлч үе гэхэд 350 сая хувиар хэвлэгдэн гарчээ. Дэлхийн бараг бүх хэлээр орчуулагдан гарсан дараа дараачийн хэвлэлүүдийг оруулж тооцвол барагцаагаар нэг тэрбум хувьд хүрсэн байна.

Маогийн зохиолыг анх удаа 1966 онд "Зохиолуудаас авсан ишлэлүүд" нэртэйгээр Орос хэлээр хэвлэн гаргажээ. Гэвч энэ ном одоо олдохоо больсон бөгөөд тэр номонд Н.С. Хрущев болон ЗСБНХУ-ын тухай тааламжгүй



Лам болж төрсөн гэлэнмаа болон түүний эцэг, эхтэй "тэмцэх цуглаан". Лхас хот (Woeser, 2006/permission from Woeser)

үгүүд орсон учир нийтэд худалдахыг хоригложээ. Тэгвэл Лхаст бүх хүн Маогийн номыг судлах үүрэгтэй байсан юм. "Аюулаас хамгаалах бүлгүүд" хэмээн нэрлэгддэг танхай балмад хятад залуус гудамжинд яваа хүмүүсийг зогсоож, маогийн номын тэр тэр хэсгээс цээжээр унш хэмээн шаардана.[1464] Уншвал утгыг нь тайлбарла гэнэ. Чадахгүй бол хатуу шийтгэл оногдох ажээ. Үнэн хэрэгтээ бол дарга Мао юу хэлэх гэж хүссэнийг улаан хамгнаалагчид ч тайлбарлаж чадахгүй байх нь цөөнгүй ажээ.

Уламжлалт баяр ёслол болон эрхлэх аж ахуйг хориглов. Жишээ нь, Жанан гацаа пуру даавуу, сагс, вааран эдлэлээрээ алдартай байв. Гэтэл тэр гацааныхны хөдөлмөрийн бүх багаж хэрэгслийг хурааж авсан учир эндхийнхэн ядуурчээ.[1465] 1980 онд л эргүүлж өгчээ.

Тэр бүү хэл шашны баяруудын үеэр бэлтгэдэг бөгөөд шар тосонд чанасан боов буюу уламжлалт хавсайг феодалын үлдэгдэл хэмээн зарласан байна.[1466] Улаан хамгнаалагчдын тушаалаар ард олон нохой, ялаа устгах



Аравдугаар Банчин ламтай “тэмцэх цуглаан” (Thinley, 1996)

ажил эрхлэх болов. Түвдчүүд нохойг маш их хүндэлдэг учир энэ амьтан маш олон байжээ. Гэтэл нохдыг маогийнхны хяналт дор чулуудаж алах ажээ. Маогийнхан “цэвэрлэх” ба шашинтай тэмцэх гэсэн хоёр зорилтыг биелүүлж чаджээ.

Хүмүүс болон гудамж, байшингийн нэрийг хувьсгалт хятад нэрээр солив. Жишээ нь, Дэнзэн гэдэг нэрийг “Мао Сысян” (“маозэдуны үзэл санаа”); Кечог Вангмо гэдэг нэр “Да Юэзин” (“Урагшлах их үсрэлт”) болгов.[1467] Цуглакан сүмийг “Жайдайсо” (5-р “зочид буудал”), Норовлин ордонг “Жэньминь Гунъюань” (“Ардын цэцэрлэгт хүрээлэн”). Баркхорын гудамжийг “Лисинь” (“Шинийг Тогтоох гудамж”) хэмээн өөрчилж нэрлэв. Түвдийн баяруудад хувьсгалч хятад нэр өгсөн байна.

“Тэмцлийн цуглаанууд” газар сайгүй болно. Цугларсан олон хэн нэгэн хүнийг төрөл төрөгсдийнх нь нүдэн дээр зодож, элдвээр доромжилно. X Банчин лам дурсан бичихдээ хүмүүсийг ам,хамар,нүд, чихнээс нь цус гоожиж эхлэх хүртэл зоддог байв. Олон хүний хөл гарыг хугалж, олон хүн ухаан алдаж, тахир дутуу болох буюу нас барна. Тахир дутуу бололгүй үлдсэн хүмүүс хэдэн жилийн турш сар бүр хөл гарыг нь хүлж, нийтийн



"Үймээн дэгдээгчид" Рибур Тулку гэдэг том зиндааны ламд бузарын шовгор малгай өмсгөж Лхас хотын гудамжаар авч явж байгаа нь (Woeser, 2006/permission from Woeser). "Бузарын шовгор малгай" дээр: "Бурхан, сүнс Наваанжамцыг сөнөөе" гэж бичжээ

өмнө зодож занчих бөгөөд ингэсний дараа хамаг бие хөх няц болсон, толгойн үс туг тугаараа алга болсон байдагсан гэж дурсаж ярьдаг байлаа гэж бичжээ.[1468] Зарим тохиолдолд хөл,гар, толгойд нь гав зүүж, толгой, биеийг нь галаар түлж, хүн,малын өтгөн хүчээр идүүлж, аманд нь морины хазаар зуулгаж татна.[1469]

Хэн ч "тэмцэлд" орж болно. Гэхдээ лам хуврагууд болон хуучин феодал байсан хүмүүс илүү их хэлмэгдэх ажээ. Манай гэрийнхэн бүгд "тэмцлийн



1966 оны наймдугаар сард Лхас хотод болсон “Тэмцлийн цуглаан” (Woeser, 2006/ permission from Woeser). Зүүн гар талаас баруун тийш: сурвалжит хүн Хоркан Соном Балжирын эхнэр, тэр өөрөө, түүний хадам эцэг нар байна. Засгийн газрын дөрөвөөс дээшхи зэрэглэлийн түшмэлийн гоёл буюу торгон хувцасыг Соном Балжирт өмсгөж, зуны халуун өдөр толгой дээр нь үнэгэн лоовууз тавьсан нь доромжлолын шинж чанартай гэнэ. Энэ хувцасыг Хорканийнхны гэрээс олж, “феодал-боол эзэмших” байгуулал сэргээхийг хүсч байна хэмээн буруутгажээ. Соном Балжирын хадам эцэгт британийн цэргийнхний дүрэмт хувцасыг дууриалгасан гэгдэх түвдийн хуучин армийн дүрэмт хувцас болон дуулга малгайг албадан өмсүүлжээ. Тэрээр энэ дүрэмт хувцасыг нууж байсан боловч “хувьсгалч олон түмэн” түүнийг олж, хадам эцэгт өмсүүлжээ

цуглаанд” хэлмэгдсэн гэж X Банчин лам дурсан ярьжээ.[1470] Түүнийг өөрийг нь бүр соёлын хувьсгалаас өмнө “шүүмжилж” байжээ. 1966 онд түүнийг Бээжинд ганцаардмал байдалд оруулсны дараа улаан хамгаалагчид хүрч ирэн хоёр гарыг нь хүлж, үндэстний дээд сургууль дээр аваачиж, дахин “шүүмжилж” зодож, элдвээр доромжилсны дараа гудамжаар авч явахдаа чанга яригчаар энэ бол “Түвдийн хамгийн харгис хамжлагын эзэн, хамгийн том паразитлагч, цус сорогч этгээд” хэмээн зарлаж явжээ.[1471] Жоу Эньлайн тушаалаар Банчин ламыг түвдэд хамгаалан хүргүүлж, гэрийн хорионд суулгав. 1968 оны хавар түүнийг ХАЧА-ийн цэргүүд дахин баривчилсан байна.[1472] Түүнийг нэг хүний давчуу өрөөнд 10 жил суулгажээ. Шоронгийн нөхцөл маш хүнд байсан учир тэрээр амиа хорлох гэж оролдож байжээ.

Зөвхөн нийгэмд эзлэх байр суурь “тэмцэлд” хамрагдах шалтгаан болж



Дөрөв буюу тавдугаар зэрэглэлийн түшмэл байсан удам сайт түвд эр “тэмцлийн цуглаан” дээр (Woeser, 2006/permission from Woeser)

байгаагүй юм. Болгоомжгүй хэлсэн ганц үг, маогийн лоозонг бичих үед баллаж, сохолзон зүйл ч ингэх шалтгаан болдог ажээ. Жишээ нь, Лхасын язгууртан байсан нэгэн эмэгтэйд “Дарга Мао урт наслаг” гэсэн лоозонг хятадаар бичих даалгавар өгчээ. Гэтэл тэр эмэгтэй “Мао” гэсэн үгэн дээр санамсаргүй бэх дусаажээ.[1473] Үүнийг даргыг доромжлох оролдлого хэмээн тайлбарласан байна: хятад ойлголтоор бол хоригдлыг цаазлахын өмнө түүний нэрийг бэхээр дарж зурдаг ажээ. Ингээд л тэр эмэгтэйтэй “тэмцэж” эхэлжээ. Эхлээд бэх дусаасан зурагт хуудасных нь өмнө сөгдүүлэн суулгав. Дараа нь байцаалт явуулж, “хувьсгалын эсэргүү этгээд” гэсэн бичигтэй бузарын шовгор малгай өмсгөж, коллежаас нь хөөлгөж, олон хоног жорлон цэвэрлүүлж, амь зогоох төдий хоолтой суулгаж, хоёр сүлжээ гэзэгнийх нь нэгийг хайчлан тайрч, өөр “шүүмжлэл” рүү чирч явахын тулд нөгөөг нь үлдээжээ. “Тэмцлийн” үеэр тайзан дээр гарган суулгаж элдвээр зодож, доромжилжээ. Энэ байдал долоо хоногт хэд хэдэн удаа давтагдана. Нэгэн

"тэмцэл" дээр цэргүүд ирж, гар буу тулган гэмийг нь "хүлээлгэснээр" энэ бүхэн дуусч, түүнд зургаан жил лагерьт хоригдох ял оноосон байна.

Гэвч энэ бол юу ч биш. Нэгэн Түвд эмэгтэй Мао Зэдуны товхимолыг бие засах газарт унагасан хэргээр цаазаар авахуулахыг би шоронд байхдаа нүдээр харсан билээ гэж Тенпа Сопа надад ярьсан юм.

Хятадууд байцаагдагчдыг эрэмдэг зэрэмдэг болтол нь зоддог байсан гэж улаан хамгаалагч байсан нэгэн бүсгүй ярьсан байна.[1474] Түвдчүүд хятадуудыг бодоход илүү их харгис байдаг ч илүү их нигүүлсэнгүй хандах бөгөөд хэлсэн үгнээс нь гарахгүй буюу цус их гаргасан хүмүүсийг өршөөж явуулна. Тэд байцагдаж буй хүмүүсийн гамшиг зовлонг хөнгөвчлөх гэж эрмэлзэх нь их. Тенпа Сопа өндөр албан тушаалын түшмэл байсан хүнтэй "тэмцсэн" тухай надад ярьж өгсөн юм. Тэр түшмэл бүтэн гурван цаг бөхийж зогсох ёстой байсан, ингэх нь түүнд маш хэцүү байжээ. Жирийн түвдчүүд түүнийг өрөвдөж байсан боловч хятадууд ажиглалт тавьж байсан болохоор яах ч арга алга. Тэгтэл нэг Түвд хүн түүнд: "Чи биднийг байнга зоддог байсан, май энэ саваag ав" гэж түүнд саваа өгөхдөө өөрт нь хэрэг болж магадгүй хэмээн боджээ. Бас нэг хүн: "чи биднээс дандаа замбай нэхдэг байсан, одоо чамд энэ замбайг өгье" гэж хэлээд замбай өгсөн бөгөөд тэр түшмэл шорондоо эргэж очоод түүнийг идсэн бизээ гэж улаан хамгаалагч байсан тэр эмэгтэй дурсан ярьжээ.

Шоронд байнга "тэмцлийн цуглаан" хийх.[1475] Ингэх шалтаг ч мундахгүй. Жишээ нь хэрэв ямар нэгэн хүн сонинд гарсан намын өгүүлэл хэлэлцэх явцад ямар нэгэн доголдол гаргаагүй бол түүнийг шашны ёслол биелүүлж байсан хэмээх зэмлэл тулгана. "Дарлан мөлжигч ангид" хамаатуулсан хүмүүсийг гол төлөв "шүүмжилнэ". Зодуур бол олныг хамарсан байнга хийдэг шийтгэл бөгөөд түүнийг олон арван удаа, жишээ нь, 13 өдөр дараалан орой бүр хийнэ. Зарим хүн зодуур даахгүй нас барах буюу амиа хорлох ажээ. Түвдийн засгийн газрын түшмэл байсан хүмүүс, том зиндааны лам нар, томоохон хийдийн тэргүүн хамбууд, дээд ангийн бусад төлөөлөгч Лхасын ойролцоох Драпчу шоронгийн тавдугаар хэсэгт хоригддог байв.[1476] Тэдний нилээдийг нөхцөл муутай бөөнөөр хорих лагеруудаас энд авч иржээ. 1966 он хүртэл тавдугаар хэсгийн хоригдлууд баривчлагдсан бусад хүнийг бодоход арай гайгүй нөхцөлд байх ажээ. Сүүлдээ бүх зүйл эсрэгээр эргэж:дээр дурдсан хүмүүсийг бусдаас дор хооллож, өглөөний 5-аас оройн 10 цаг хүртэл цөллөгийн ажил хийлгэнэ. Эсэргүүцсэн хүмүүсийг тэмцлийн цуглаанд оруулах ажээ. Энэ хүмүүсийн төрөл төрөгсдөд шоронд хоол оруулахыг зөвшөөрдөг байв. Гэвч ингэсний төлөө тэдэнт "хувьсгалын



Сайд нарын зөвлөлийн гишүүн буюу сайд байсан Санбо Цэвээнрэгзэн 1966 оны наймдугаар сард Лхаст болсон “тэмцлийн цуглаан” дээр (Woeser, 2006/permission from Woeser). Тэрээр командлагчийн орлогч байсны хувьд олон түмэнд хандаж ХКН-аас гаргасан олон уриалгад гарын үсэг зурж байжээ. 1966 оны наймдугаар сард түүнийг болон түүний гэр бүлийн гишүүдийг хөөрсөн олон нэвширтэл нь зодож, гэрийнх нь бүх эд хогшлыг хулгайлан авч явжээ

эсэргүү нарын хамсаатнууд” гэсэн нэр хаяг зүүнэ.

Хоригдлууд “дөрвөн хуучныг” устгах ажиллагаанаас ангид үлдэхгүй. Хэрэв тэдэнд лам хувцас, шашны ном судар буюу төвдийн соёлын бусад эд зүйлс үлдсэн бол энэ бүхнийгээ олны өмнө шатаахыг тулгана.[1477] Жишээлэхэд, “Энэтхэгийн түрэмгийлэн эзлэгчдийн” хийсэн цэвэр арьсан шаахай, жижиг эд зүйлс буюу гурил хийж авч явдаг хүүдий (“феодализмын үлдэгдэл”), модон тагш (мөн энэ шалтгаанаар) зэрэгт дээр дурдсан хувь твилан оногдох ажээ.Улаан хүрэн буюу шар (шашны өнгө) өнгөтэй бүх зүйлийг устгах, эсвэл улаан буюу хар ногоон (ХАЧА-ийн өнгө) өнгөөр будах ёстой ажээ.

Ер нь бол “маогийн үзэл санаа хувьсгалч өргөн олон түмэнд шууд хүртэмжтэй болсон байна. Долоон зуун сая хүн амтай том оронд маогийн



Язгуууртан айлын охинтой гэрлэж олны танил албан тушаалтан болсон хүнтэй "тэмцэх цуглаан" (Woeser, 2006/permission from Woeser). Түүний толгойд угласан "бузарын шовгор малгайн" дээр: "Бурхан, сүнс Цэрэн даран сөнөөе" гэж бичжээ. Энэ хүн 1959 онд ХКН-тай хамтран ажиллаж, засгийн газарт алба хашиж, бослого хөдөлгөөнд оролцоогүй, "эх оронч" хэмээн хүлээн зөвшөөрөгдөж, Лхас хотын даргаар ч томилогдож явжээ. Гэтэл Соёлын хувьсгалын үед түүнийг хувьсгалын эсэргүү бүлгийн гишүүн хэмээн зарласан байна. Тэрээр 1979 онд "түвдийн энх тайван чөлөөлөлтөд" хувь нэмрээ оруулсан "дэвшилт түвд хүн" хэмээн хүлээн зөвшөөрөгдөж байжээ

үзэл санаа ийм өргөн дэлгэрсэн нь одоогийн аугаа их пролетарийн соёлын хувьсгалын хамгийн том ололт мөн. Аугаа их пролетарийн соёлын хувьсгалын явцад олон зуун сая ард олон дарга Мао Зэдуны зохиолын ишлэлүүдээс хэзээ ч салахгүй явж, тэдгээрийг анхааралтай судлаж, практик амьдралд маш нухацтай хэрэглэж байна" гэж Линь Бяо ХКН-ын 9-р их



1



2

“Харгис хүчинтэй тэмцэх цуглаан” (Woeser, 2006/ permission from Woeser):
1 – Уламжлалт түвд хувцастай хүмүүсийн нүүрийг элдвээр буджээ. “Бузарын шовгор малгай” дээр: “Бурхан, сүнсийг даран сөнөөе” хэмээн бичсэн байна. 2- “Бузарын шовгор малгай” болон зурагт хуудсан дээр : “Феодалын харгис ноён Данзанжамцыг [Далай ламын нэр] сөнөөн зайлуулья” гэж бичжээ



Харгислалын үеийн эд зүйлс нууцаар хадгалж байсан, гадаадынханд алтан гоёл чимэглэл худалдсан хэмээн буруутгагдсан эмэгтэйтэй "тэмцэх цуглаан" (Woeser, 2006/permission from Woeser)

хурал дээр үг хэлэхдээ мэдэгдсэн байна.[1478]

Үүнээс болж уламжлалт үзлийг эвдэх үйл явц БНХАУ-ыг бүхэлд нь хамрав. 1966 он гэхэд түвд-монголын соёл иргэншлээс үлдсэн тэрхүү бага зүйлс соёлын хувьсгалын жилүүдэд бүрмөсөн устаж үгүй болжээ. 1970-аад оны эхэн гэхэд үлдэж хоцорсон бараг бүх хийдийг устган нураажээ. Энэ бүхний дүнд Их Түвд дэх 6259 хийд, шашны бусад төвөөс нэг мянга хүрэхтэй үгүйтэй лам нар бүхий дөнгөж найман хийд үлдсэн байна.[1479] Долоо буюу 13 гэсэн мэдээ ч бий.[1480] Олон хийдийг газрын хөрснөөс арчсан бөгөөд өнөөдөр тэдгээрийн суурийг ч үзэх боломжгүй болжээ. Эвдэрч сүйдээгүй үлдсэн сүмүүдийг сургууль, шорон, агуулах, адууны жүчээ, цэргийн хуаран, орон сууц болгож ашигласан байна. Одоо ч зарим хийдийн байшингуудын ханан дээр Маог магтан сайшаасан том улаан дүрс үсгүүд олж харж болно. Нийтдээ 1951-ээс 1979 оныг дуустлах хугацаанд Түвдийн нийт 592558 лам, гэлэнмаа, ринбүүчи (хувилгаанууд) очирт хөлгөний бясалгачдаас 110 мянга шахам нь эрүү шүүлтэд орж, алагдах нь алагдаж, 250 мянга орчим хүн цол хэргэмээ хураалгаж, сүм хийдээс хөөгджээ.[1481]

Эвдэрч сүйдсэн байгууламжуудын тоонд аугаа их шүтээнүүд, дэлхийн соёлын гайхамшигт дургалууд болох түвдийн анхны хийд Самье (775







Лхас хотын гудамжаар зарим хүмүүсийг жигшүүлэх аялал (Woeser, 2006/permission from Woeser)



Маогийн үед сүйтгэгдсэн Цурпу хийдийн туурь. 1993 он. (DIIR Archive, Central Tibetan Administration)

оны хавьд эх суурь нь тавигдсан): Түвдийн шашны чиглэлүүдийн гол үндсэн хийдүүд: Гандан (Гэлуг чиглэлийн гол хийд – 1409 оны хавьд байгуулагдсан), Сажа хийд (Сажа чиглэлийнх – 1073 он), Цурпу (Кагью чиглэлийн – 1115 он), Миндролин (Ньингма чиглэлийн – 1676 он, гуравны нэг орчим нь эвдэрч сүйдсэн), Менри (бон шашны – 1405 он) орсон байна.

Гандан хийдийг 1969 онд бүрмөсөн эвдлэн сүйтгэжээ. Түүнийг цэргүүд болон улаан хамгаалагчид өөрсдийнх нь үзэн яддаг төр-шашны байгууллын сүүлчийн түшиг тулгуурын нэг хэмээн үзэж эвдлэн нурааж, дэлбэлсэн байна.[1482] Түүнээс гадна дөрвөн зуун жилийн туршид энд үнэт металл болон эрдэнийн чулуугаар хийсэн шүтлэгийн, бас бэлэг дурсгалын шинж чанартай олон эд зүйлс цугларсан байжээ. Жишээ нь, Гэлуг чиглэлийн шашныг үндэслэгч Зонховын шарилыг хадгалсан суварга байна. Энэ суваргыг цалин цагаан мөнгөөр үйлдэж, ганжирыг нь давтаж нимгэлсэн шижир алтаар бүржээ. Энэхүү хийдийн 84 хамбын чандар зэс, мөнгө, алтадсан суваргуудад хадгалагдаж байсан ажээ.[1483] Тэдгээр суваргыг эвдлэн буулгаж, үлдсэн хэсгүүдийг устгажээ. Гэлуги чиглэлийн том лам нарын нэг Боми ринбүүчи Зонховын гавлын ясны нэг хэсэг болон чандарынх нь өчүүхэн хэсгийг хадгалан үлдэж чадсан байна. Улаан хамгаалагчид Зонховын суврагыг эвдэлж нураасныхаа дараа түүний шарилыг үүрч авч яваад асч буй гал дээр хаяхыг тэр ринбүүчид тулгажээ[1484] Боми ринбүүчи Зонхов багшийн гавлын яс болон чандарынх нь хэсгийг нууцаар авч үлдээд

дараа нь аюулгүй байдлын үүднээс энэ бүхнийг газар ухаж булжээ. Ингээд Гандан хийдийг сэргээн засварласны дараа нилээд сайтар бодож хийсэн шинэ суврагaнд байрлуулсан бөгөөд одоо ч тэнд байгаа ажээ.

Сажа хотод нийтдээ 108 сүм, хийд байжээ. 1968 он гэхэд зөвхөн гол сүм буюу Сажа Лхакан Ченмо үлдсэн байна.[1485] Бусад сүм, хийдийг юу ч үгүй болтол нь эвдлэн сүйтгэжээ. Үүнийг ингэж хийсэн байна. Улаан хамгаалагчид хотод орж ирмэгцээ хятад засаг захиргааныхан болон орон нутгийн дэвшилт үзэлтнүүдийн хамт цуглажээ. Дараа нь тэд соёлын хувьсгал эхэлсэн тухай зарласан байна. Гэвч дэвшилт үзэлтнүүд гэгчдээс өөр цугларч ирсэн хүн цөөхөн байв. Үүний дараа хөрш зэргэлдээх тосгоноос олон хүн ирж, эвдлэн сүйтгэх ажиллагаанд ханцуй шамлаж орсон байна. Орон нутгийн залуучуудаас зарим нэгэн хүн тэдэнтэй нийлэв. Сажагийн байшингуудыг гол төлөв модоор барьсан бөгөөд Түвдийн уулархаг нутагт бол ийм боломж бараг байхгүй ажээ. Ингээд л галдан шатаах боломж бүрдсэн байна.Энэ удаад ч маогийнхан хүмүүсийн өчүүхэн атгаг санаа бодол дээр тогложээ. Гэхдээ үүний өмнө Соёлын үнэт зүйлсийн хэрэг эрхлэх товчоо аанай л сүмүүдээс үнэт металл болон эрдэнийн чулуугаар хийсэн эдлэлийг дээрэмдэн авчээ.

Лхас хотод 1755 онд байгуулагдаж эхэлсэн Норовлин ордонг эвдлэн сүйтгэжээ. Шигазегийн орчимд байсан эртний түвдийн хаадын бүх хиргэсүүрийг дэлбэлж устгасан байна.[1486] Түвдийн хаадын анхны шилтгээн( манай эриний өмнөх II зуун) Юмбулаганийг мөн сүйтгэсэн байна. 1447 онд үндэс суурь нь тавигдсан Дашлхүмбэ хийдийн байгууламжуудын гуравны нэг, аугаа их шүтээн болох XV зуунд цутгасан бурхан багшийн асар том хөрөгийг эвдлэн сүйтгэсэн байна.[1487] Тэр үед X Банчин лам “шийтгүүлсэн” байв. Үүнийг далимдуулан өмнөх таван Банчин ламын (V–IX хүртэлх) бунхан-субрагуудыг эвдлэн сүйтгэж, тэнд байсан шарилуудыг шатаасан байна. Хэд хэдэн сүсэгтэн хүн амь насаа дүйн байж эвдэрсэн авсны зарим хэсгийг аварч үлдэж чадсан юм гэж X Банчин лам 1989 оны нэгдүгээр сард хэлсэн сүүлчийнхээ үгэнд тэмдэглэжээ.[1488]

Англичуудын их бууны суманд өртөж байсан Гьянзе шилтгээнийг эвдлэн сүйтгэжээ. 1418 онд байгуулагдсан 77 өрөө бүхий есөн давхар сүрлэг том Гьянзе Гүмбүм суврага устгагдаагүй бүтэн үлдсэн байна. Энэ суварга Пелкор Чоде хийдэд байсан бөгөөд харин уг хийд нилээд сүйджээ. Урьд өмнө энэ бол Гьянзе хотын ойролцоох хоёрдахь том хийд хот байжээ. Тэр хийдэд түвдийн бурханы шашны бүх чиглэлийн сүмүүд байсан ажээ. Тэгвэл улаан хамгаалагчид эдгээр сүмийг бүгдийг нь эвдлэн нурааж, гол

сүм, суварга хоёр л үлдсэн байна.

Жоу Эньлайн тушаалаар Будалын ордныг цэргийнхэн хамгаалалтандаа авч аварсан ажээ. Цэргүүд тэндхийн өндөрлөгөөс өөр хоорондоо дайсагнасан "үймээн дэгдээгч" бүлгүүдийн шилжилт хөдөлгөөнийг дурангаар харж, хэрэг гарвал тэднийг хоёр тийш болгоход бэлддэг байжээ. Будалын ордон дээр хятадын төрийн далбаа босгож, дээврийн алтан ганжираас "ХКН мандтугай", "Дарга Мао мандтугай" гэж бичсэн хоёр том улаан дарцаг унжуулжээ.[1489]

Лхас хот дахь Дрепун (1416 онд үндэслэн байгуулагдсан), Сэра (1418 он), Дригун (1179 он), Ретин (Радрен, 1057 он) зэрэг томоохон хийд, төрийн үзмэрч Нэчунийн сүм (XII зуун), Амдогийн Лавран( 1709 он), Гүмбүм (1477 он), Ронво (1300 оны орчим) хийдүүд бага зэрэг эвдэрч сүйджээ. Цанпогийн хөндийд үндэслэн байгуулагдсан бурханы шашны Жонан чиглэлийн гол хийд болж байсан Тактен Пунцоглин хийд (1614 он)-ийн зарим хэсэг эвдэрч сүйдсэн байна.1912 онд хятадууд эвдлэн сүйтгэсний дараа 1917 онд түвдчүүдийн сэргээн босгосон Чамдо Жамбаалин хийдийг дахин сүйтгэжээ. Дэлхийд хамгийн өндөр газарт байрлах (далайн түвшнээс дээш 5100 метрт) Ронбук хийдийг мөн сүйтгэжээ. Бүр 1958 онд сүйтгэж эхэлсэн Амдогийн зүүн хойт нутгийн Чойтен Тан (1360 он), Тонкор (1648 он) хийдүүдийг ч бараг гүйцээж нураажээ. Амдо дахь бон шашны Наншиг (1754 он) хийдийг бүрэн устгасан байна. Лхасын район дахь даянчдын сууц, Драг Йерпын агуйн сүмүүдийг ч хоослон дээрэмдсэн байна. Тэдгээрийн зарим нь Соронзон Гомбо хаан, Бадамжунай, Адиша нартай холбоотой байжээ. Буддын болон индуист шашинтнуудын хувьд ариун дагшин Кайлас уулыг хүндэтгэн гороолдог замд байгуулсан хийдүүдийг ч эвдлэн сүйтгэжээ. "Гадныхан" (түүний дотор энэтхэгчүүд) Кайлас ууланд очихыг 1959–1980 онд зөвшөөрдөггүй байжээ.

Баруун Түвдийн Нгарийн 13 хийдээс 10-ыг нь бүрэн сүйтгэсэн байна. X зуунд Түвдийн Дармаа хааны жич энд 1630 онд Ладакийн хаанд эзлэгдэх хүртэл оршин тогтносон Гугегийн хаант улс байгуулсан түүхтэй юм. Тэр үед булаан эзлэгчид энэ хаант улсад их эвдрэл сүйтгэл учруулсан байна. Гэвч 50 жилийн дараа энэ нутаг дэвсгэр Далай ламын мэдэлд очиж, тэнд хэд хэдэн хийд байгуулсан юм. Тэдгээрийн дотроос хамгийн томоохонд тооцогдох нь Гугегийн хуучин нийслэл Цапарангийн суурин дээр болон Толинд байгуулсан хийдүүд ажээ. Олон зуун жилийн турш тэнд буддын урлагийн олон гайхамшигт бүтээлүүд хуримтлагдсан байна.

Улаан хамгаалагчид эртний энэ ордны туурийг нэг их сонирхолгүй



1



2

Гьянзэ Гүмбүм суваргатай Пелкор Чоде хийд: 1 – 1938 онд; 2 – 2008 онд (С.Л. Кузьмины авсан гэрэл зураг)


1


2


3



4

Маогийн үед эвдлэн сүйтгэсэн Сэра хийдийн даянч тууриуд (permitted by Jose Ignacio Cabezon):
1 – Панлун (Alex Catanese авсан гэрэл зураг); 2 – Сэра Гонпасар (Alex Catanese авсан гэрэл зураг); 3 – Гол Хардо сүмийн цогцолбор (Alex Catanese авсан гэрэл зураг); 4 – Ненан (Jose Ignacio Cabezon авсан гэрэл зураг); 5 – Гарпа (Alex Catanese авсан гэрэл зураг); 6 – Рикья Ритро (Alex Catanese авсан гэрэл зураг)



5



6

орхижээ. Тэд мөхсөн хаант улсыг одоогийн шашныг бодоход тийм ч их хор нөлөөтэй биш хэмээн үзсэн бололтой юм. Тиймээс улаан хамгаалагчид Цапаран, Толинийн сүмүүдэд гол анхаарал тавьжээ. Ийнхүү эртний баримал бурхадын олонхийг зэрэмдэглэсэн буюу устгажээ. Цапарангад гурван том сүм үлдэж, бусад нь эвдэрч сүйдсэн байна. Гэхдээ л тэдгээрт байсан цутгамал бурхадыг эрэмдэг зэрэмдэг болгосон ажээ. Харин эдгээр эвдэрч нурсан сүмүүдийн ханан дээрх зураг харьцангуй хэв янзандаа хадгалагдаж үлдсэн нь энэхүү хээр цөл нутагт бороо хур бага унадагтай холбоотой ажээ.[1490] 1948 онд татсан Цапарангийн сүмүүд дэх цутгамал бурхадын гэрэл зургууд хадгалагдан үлджээ.[1491] Урлагийн ямар гайхамшигт бүтээлүүд устсан нь эдгээр гэрэл зургаас харагдаж байгаа юм.

Тухайн үеийн үйл явдлыг нүдээр харсан хүн надад хятадууд 1960-аад оны эх, 1970-аад оны сүүлчээр Камын өмнөд хэсгийн Чарабамбарт өдөр бүр тэмцлийн цуглаан хийдэг байлаа. Энэ цуглаанд гэр бүл бүрээс дор хаяж нэг хүн оруулах ёстой. Сүүлчийн цуглаан дээр тэнд цугласан олонд тэндхийн хийдийг эвдлэн нураахыг уриалав. Үүнийг ч биелүүлсэн билээ. Хийд доторхи бүх зүйлийг эвдэж, байшин савыг нь агуулах болгосон юмдаг хэмээн ярьсан юм. Хятадууд чандар агуулсан суврагуудыг эвдлэн сүйтгэхдээ доторхийг нь ийш тийш шидлэж, тэдгээрийг устгахыг хүмүүст тушааж байсан. Зарим сүсэгтнүүд шөнө дөлөөр сэм ирж, тэдгээр чандар сэлтийг цуглуулж авсан байх. Тэр хүмүүсийг эрэн сурвалжилж, олдсон нэгийг нь тэмцлийн цуглаанд оруулсан даа. Нэг "гэмтэн" этгээдийн хүзүүнд хуучин шарил өлгөж, түүнийг шүдээрээ зулгаахыг шаардаж байсан. Дараа нь тэнд цугласан хүн бүрээр тэр "гэмтэнг" зодуулсан юм. Хэрэв хажууд хятад идэвхтэн зогсож байвал хүмүүс өөрсдөө "тэмцлийн" хэрэглүүр болохгүйн тулдаяархан цохиж болохгүй. "Тэмцлүүдийн" хооронд хэлмэгдэгчийг хоол ундгүй хоосон өрөөнд хорино.Энэ бүхний эцэст хэлмэгдэгч этгээд өлсгөлөнгөөр нас барсан гэнэлээ гэж тэрхүү нүүдэлчин эр ярьсан билээ.

Соёлын хувьсгалын үед Төвд ном судар болон бусад бичмэл материалуудыг хуу хамж устгажээ. Хуучны ном судараас гадна янз бүрийн бичвэр бүхий модон баруud, хэвлэлийн хэрэгслүүдийг шатаажээ. Хятадууд судар номын цаасыг гутлынхаа уланд дэвсэх буюу бөгс арчих цаас болгон хэрэглэж, шатаахыг нь шатааж, заримы нь малын баастай хольж хаяна. Маш олон тооны судар, номыг шорон руу ачиж аваачин тэнд асгана.[1492] Хоригдлууд тэр номуудыг урж тасдах бөгөөд тусгай бэлдсэн саванд хийж ус, шавартай хольж зуураад байшин, барилгын хана туурга шавах материал гаргадаг байсан гэж тэр үйл явдлыг нүдээр үзсэн хүн ярьжээ.

“Энх тайван чөлөөлөлтөөс соёлын хувьсгал хүртэл Төв Түвдэд гүн ухаан, түүх, намтар судлалын ном, сударын 60 хувь, бичмэл материал, баримт бичгүүдийн 85 орчим хувийг тус тус шатаасан байна.[1493] Устгагдсан зарим номын санд мянган жилийн өмнө энэтхэг эхүүдээс олшруулж авсан олон ном байсан бөгөөд тэдгээр ном манай өнөө үеийг хүртэл тийнхүү хадгалагдан үлдэж чадаагүй билээ. Эртний Бедроя Допан Тана Нгоцар Ригжелин хийдийг түвдийн анагаах ухааны алдарт бүтээлүүд, бүх архивынх нь хамт устган сүйтгэсэн юм. Түүний суурин дээр радиодамжуулагч аппарат хэрэгсэл бүхий цэргийн шорон байгуулжээ. Будалын ордны дэргэд байсан эртний хэвлэлийн газрыг устгасан байна. Цогчин хийдийг хэвлэх үйлдвэр, номын модон баруул, номын сангийнх нь хамт устгажээ. Камын Дугу хийдэд байсан эртний олон бичвэрийн хураангуй, урлагийн хосгүй нандан эд зүйлсийг ч устгасан байна. Эдгээр бүтээлийн заримыг X зуунд бүтээсэн байжээ. Шалу хийдийг устгахдаа “Данжуур”-ын 227 гар бичмэл боть, алдарт түүхч, шашны зүтгэлтэн Бутон Ринчиндубын (1290–1364) бийр, түүний бүтээлийн гар бичмэл эх ноорогийг шатаажээ. Сэра хийдэд суугаа бурхад, 500 жилийн настай бичвэр, ханын зурагийн 95 хувийг устгажээ. Эвдрээгүй бүтэн үлдсэн сүмүүдийг үр тарианы агуулах, шорон болгож ашигласан байна. 1980 онд нэгэн лам сэтгүүлчидтэй уулзахдаа эвдэлж нураасан байшингууд ч яахав хуучирсан эд, харин дал модны навчин дээр алт, мөнгө хольж хийсэн тусгай бэхээр бичсэн эртний гар бичмэлүүд тун харамсалтай. Хятадууд ийм гар бичмэлүүдээр түүдэг гал асаадаг байсан. Лам нар эртний ном зохиолуудыг шатаахгүй үлдээгээч хэмээн цэргүүдээс хүсэхэд “яамай л байна, шашин бол хөрөнгөтний хорт үзэгдэл” гэж хариулдаг байсан юм. Ном, судрууд дээр керосин асгаж шатаадаг байсан юм гэж ярьжээ.

Урьд өмнө даваан дээр чулуугаар овоо босгодог байжээ. Тэгвэл одоо тэдгээр овооны чулууг буулган тарааж хаяжээ. Хадан дээр сийлсэн маанийн үсгүүдийг маогийн лоозонгоор, мөргөлийн дарцагуудыг коммунист улаан тугаар тус тус сольжээ. Замын хажуугийн чулуун дээр сийлсэн маанийн үсгүүдийг арилгуулах буюу тэдгээр чулууг зам тавихад, нийтийн бие засах газар барихад ашиглажээ.[1494]

Бүр 1950 онд эхэлж Амдо, Камд, дараа нь У-Цангд эхэлсэн түвдийн соёлын өвийг тонон дээрэмдэх ажил соёлын хувьсгалын үед үргэлжилжээ. Мао Зэдуныг нас барснаас хойш ингэх өргөн цар хүрээ нээгдсэн байна.

Гитлерчүүд дээрэмдсэн урлагийн бүтээлүүдийг үнэлж чаддаг байсан бол маогийнхан түүний үнэ цэнийг ойлгохгүй устгажээ. Сүмүүдээс дээрэмдсэн уран зураг, цутгамал бурхад, хивс зэрэг эд зүйлсийг өөртөө

авахыг хятадуудад зөвшөөрч байсан тухай мэдээ бий юм.[1495] БНХАУ үнэт металлаар хийсэн шашны олон эд зүйлсийг Зөвлөлт Холбоот Улсад өрөнд өгсөн гэж зарим хүн ярьдаг билээ.[1496] Энэ бол магадлал багатай, яагаад гэвэл тийм эд ЗСБНХУ-д хэрэггүй, харин үнэт металлууд хэрэгтэй байсан байж болох талтай. Хамгийн үнэтэй эд зүйлсийг хятадын музейнүүдэд шилжүүлж, олон улсын дуудлага худалдаанд оруулан арилжиж, заримыг нь хятад түшмэд хулгайлан зөөжээ.Тийм эд зүйлс одоо ч үе үе дуудлага худалдаан дээр гарч ирж байгаа юм. Одоо тэдгээр бүтээлийг гадаадынхан төдийгүй хятад шинэ баячууд худалдан авах болжээ.

Хятадын эрх баригчид ийм эд зүйлс худалдаж авсан гадаадынханд тэдгээрийг авч гарах зөвшөөрөл олгодог болжээ.[1497]

Хятад түшмэд бурханы шашны цутгамал бурхадаар ширээний чийдэн хийдэг гэсэн яриа бий.[1498] Миний бие Москвад тийм ширээний чийдэн худалдаанд байхыг харсан билээ. Энэ чийдэнг барагцаалбал 40 см өндөр цутгамал зэс бурхан ашиглаж хийсэн бөгөөд түүний толгой руу утас оруулан чийдэнгийн шилний суурь суулгаж, оройг нь бүрсэн байна. Бурханы хийц маягаар бол энэ “сувенир” БНХАУ-аас гаралтай нь илэрхий ажээ.

Гэхдээ л хятад руу зөөж аваачсан түвдийн урлагийн бүтээлүүдийн олонхи устжээ. 1982–1983 онд Рибур Тулку тэргүүтэй хэсэг түвдчүүдэд хятадад үлдсэн түвдийн урлагийн бүтээлүүдийг авч явж, сэргээн засварлах зөвшөөрөл олгосон байна.[1499] X Банчин ламын хүчин чармайлтын дүнд л ийм үр дүнд хүрсэн байна. Түвдчүүд Бээжинд ирж эзэн хааны хуучин Гугун ордны нэгэн павильонд хэдэн зуун цутгамал бурхан болон шашны бусад эд зүйлс байгааг олж үзжээ. Цутгамал бурхадыг 1972 онд ган хайлах газруудаас авч ирсэн юм гэж музейн ажилтнууд ярьсан байна. Эдгээр эд зүйлс ингээд гэртээ харьдаг ажээ хэмээн хятадууд ч баяр хөөртэй байжээ. Нийтдээ 26 тонн эд зүйлсийг 463 модон хайрцагт хийж багласан байна. Тэдгээрийн дотор бидний дээр өгүүлсэн Рамоче сүмийн Будда бурхны алдарт цутгамал хөрөгийн дээд биеийн хэсэг байжээ.

Бээжин хот дахь Күнзийн сүмийн доод хонгилоос цутгамал бурхад болон түвдийн шашны бусад металл эдлэлүүд олсон нь зургаан тонн, барагцаалбал 100 хайрцаг болжээ. Хятадад авч ирсэн түвдийн соёлын үнэт зүйлсийн ихэнхийг соёлын хувьсгалын үед устгасан гэж Рибур Тулкуд нэг өвгөн хятад түшмэл ярьжээ. Цэвэр алт, мөнгөөр хийсэн бүтээлүүд алга болсон. Алтадсан зэс, улаан зэс, хонхны хүрэл, гуулиар хийсэн эдлэлүүдийг Түвдийн өөртөө засах орноос Ганьсу мужийн баруун хойд хэсгийн Люйянд авчирдаг байв. Энэ бол тэр үед төмөр замд хамгийн ойрхон газар байсан

юм. Энэ бүх бүтээлийг Люйянаас Шанхай, Сычуань, Тайюань, Бээжингийн фабрикуудад худалдах бөгөөд тэндхийн металл хайлуулах газрууд Түвдийн барагцаалбал адил тооны эв зүйлсийг дахин хайлуулсан байх гэж тэр өвгөн ярьсан байна.[1500]

Бээжингээс 5 километрийн зайтай орших "Үнэт металлын хайлах зуух"(оргинал нэр нь: "Shiyou Ching Rhru Thea") – 600 тонн түвдийн "гар урлалын металл" худалдаж авчээ. Тэр өвгөн цааш нь ярихдаа:[1501] 1973 онд БНХАУ-ын төрийн зөвлөлийн ерөнхий сайдын орлогч Ли Сяньнянь, Бүх хятадын ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хорооны орлогч дарга Улаанхүү (Өвөр Монголын удирдагч) нар хятадын металл хайлах олон газарт түвдийн шашны эд зүйлсийг гулдмай болгон гаргаж байгааг олж мэджээ. Тэд энэ ажлыг нэн даруй зогсоохыг тушаасан байна. Мөн оны долдугаар сард 12 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын хороо байгуулахад түүний нэг гишүүн нь тэр өвгөн байжээ. Хорооны гишүүд дээр дурдсан хайлах газарт очиж үзэхэд 600 тонн эд үйлсээс 50 орчим тонн нь үлдсэн байжээ. Тэдгээр бүтээлийг гадаа овоолж, өргөст торон хашаа барьсан байжээ. Хяналтын хорооны гишүүд дөнгөж 200 тонн эд зүйлсийг л аварч чадсан байна. Бусад нь сэргээхийн аргагүй эвдэрч хэмхэрсэн ажээ. Дараа нь тэнд дахин 30 тонн эд зүйлс ирсэн байна. Тэдгээрийн ихэнх нь эвдэрчээ. Энэ бүхнээс зургаан тонныг аварсан байна. Ингээд Рибур Тулку 1983 оны хавар 13537 цутгамал бурхан бүхий 600 шахам хайрцагийг Чэнду хотоор дамжуулан Түвд рүү ачуулсан юм гэжээ.

Чэндуд Түвдийн өөртөө засах орны шашны хэрэг эрхлэх товчооны Пунцаг Ёндон түвдийн шашны 100 тонн эд зүйлс Шэньси мужийн Тайюаньд хүргэгдсэнээс барагцаалбал нэг тонн нь үлдэж, бусдыг дахин хайлуулжээ хэмээн Рибур Тулкуд мэдээлсэн байна. Энэ хоёр хүн Чэндуд байхдаа Чэндугээс баруун урд зүгт орших Маньшаны районд 2 тонн Түвд цутгамал бурхад болон соёлын дурсгалт бусад эд зүйлс хадгалагдаж үлдсэн тухай цахилгаан утас хүлээж авчээ. Чэндугийн металл хайлах зуухны агуулахаас бас таван тонн эдлэл олдсон байна. Эхний үед хайлах газрынхан засгийн газарт мөнгө төлж авсан гэж шалтаглан эдгээр эд зүйлсийг буцааж өгөхөөс татгалзсан боловч түвдчүүд санасандаа хүрчээ. Тэдгээрийн дотор түүх, шашны ихээхэн үнэ цэнэтэй эд зүйлс байгаагүй ажээ. Эдгээр бүтээлийг Түвдийн хийдүүдэд хуваарилахад хамгийн том цутгамал бурхан Литангийн хийдэд оногдсон байна.

Рибур Тулкуг буцаж ирэхэд Гатар Тулкугаар удирдуулсан түвдчүүдийн өөр нэг хэсэг бас л ямар нэгэн эд зүйлс байсан хэмээх сургаар Хөх нуур

руу явсан байна.[1502] Тэд Сининээс баруун тийш орших Хуанъюань хотод хэд хэдэн агуулах олжээ. Тэдгээрийн заримд дүүрэн цутгамал бурхад байх боловч бусдад нь олон металл эдлэл байсан шинж тэмдэг ажиглагдах ажээ. Нэг агуулах хоосон ч шалан дээр нь Түвд зоос энд тэндгүй хэвтэнэ. Энэ бүхний эцэст бас хэдэн тонн бурханг түвдэд буцааж чадсан байна. Түвдээс ирсэн эд зүйлсийг дахин хайлуулах зорилгоор хадгалж байсан хятад агуулахуудын бүрэн жагсаалт гаргасан тухайгаа Гатар Тулку ярьжээ. Гэвч хятад түшмэд тэрхүү жагсаалтыг булаан авч, хуулбарыг нь буулгаж авах гэхэд зөвшөөрөөгүй ажээ. Чэндуд тэрээр Рибур Тулкутай уулзаж, тэндхийн нэгэн эмэгтэйчүүдийн хийдэд очиход нэг зуу орчим араг (сагс) байсан бөгөөд тэдгээрт бага оворын олон арван үнэтэй Түвд бурхад хадгалагдан үлджээ. Эдгээр эд зүйлсийг баглаж, ямар нэгэн газар руу явуулахаар бэлтгэсэн байжээ. Гэвч энэ бурхадыг аварч чадаагүй, яагаад гэвэл тэдгээрийг хувийн өмчтөн худалдаж аваад өөр хүнд зарсан байжээ.

Ганьсу мужаас бурхан багшийн гурван мянга шахам цутгамал дүр олджээ.[1503] 1986 онд Түвдийн өөртөө засах оронд очсон гадаадын анхны жуулчид Соёлын хувьсгалын үед эвдэлж сүйтгэсэн зэс бурхадыг хадгалах агуулах болгон ашиглаж байсан хуучин сүмүүдийн өрөө тасалгаануудыг үзжээ.[1504]

“Түвдийн урлагийн бүтээлүүд, металл эдлэлүүдийг хураах ажлыг хятадын засгийн газар дэс дараатай, зохион байгуулалттай явуулсан юм” гэж М.М. Смит дүгнэсэн байна.[1505]

Тийнхүү Түвдийн өөртөө засах орны шашин шүтлэгийн эд зүйлсийг Люйян, Хуанъюань руу зөөж байжээ. Амдогийн эд зүйлсийг ч сүүлчийн өртөөнд хүргэж байсан бололтой юм. Камаас Чэнду руу, магадгүй Сычуаны бусад цэгүүдэд ч зөөж байжээ. Дээр дурдсан баримт мэдээгээр бол хятадууд түвдийн хийдүүдээс металл бурхад гэхэд л олон зуун мянгыг дээрэмджээ. Бас цэвэр алт, мөнгөөр цутгасан олон мянган бурхан зүгээр л сураггүй алга болсон байна. Торгон зургийн аргаар бүтээсэн олон мянган бурхан, ном судар, шавар бурхад, урлагийн бусад бүтээл устжээ. Сүсэгтэн олны авч үлдсэн зүйлс тийм ч олон биш бизээ. Жишээ нь, Оросоос очсон жуулчид Зонхов бурханы шавраар хийсэн жижигхэн баримлуудын толгойг наах гэж их л хичээж буй Түвд өвгөнг олж харжээ. Эдгээр баримлыг соёлын хувьсгалын жилүүдэд эвдэж сүйтгэсэн байна.[1506] Шуудайд хийж орхисон эдгээр бурхан 2000 он хүртэл хэнд ч хэрэггүй хэвтжээ. Гэхдээ энэ бол маш ховор тохиолдол. Өнөө үед түвдийн урлагийн хуучин бүтээлүүд тэндээ буюу эх орондоо ч ховор нандин зүйл болжээ.

1969 онд Лхас хотын ислам хорооллыг түйвээх үед нэгэн хүндрэл гарсан нь тэнд эвдлэн сүйтгэж, дахин хайлуулж болох зурмал болон цутгамал бурхад, бусад дүр тэнд байгаагүй ажээ. Тийм болохоор "үймээн дэгдээгчид" эртний шашны судар номуудыг, түүнчилэн Кораныг сүмийн хашаан дотор овоолж байгаад шатаажээ.[1507] Ингэж Түвдэд байсан исламын гол шүтээнийг устгасан байна. Эдгээр судар номуудын дунд Түвдэд XII зууны үед мусальманчууд нүүж ирсэн, тэгээд ямар газар нутгийг Далай ламаас хүртэж, тэдний зан заншил хэрхэн хөгжиж байсан тухай дурьдсан үнэт баримтууд устгагдсан ажээ. "Үймээн дэгдээгчид" исламын сүмийн хамба буюу имамд бузарын шовгор малгай өмсгөн хотын гудамжаар авч явж, түүнийг дарлан мөлжигч хэмээн зарлаж, зодож занчсан бөгөөд ингэсний дараа тэрээр насан өөд болжээ. исламын сүмийг кинотеатр болгосон байна. Лхас дахь исламын нийгэмлэг бараг үгүй болж: одоогийн байдлаар тэнд уугуул ислам сүсэгт иргэд маш цөөхөн үлдсэн бөгөөд гаднаас ирсэн хүмүүс тэдний байдлыг улам муутгадаг ажээ. Түвдэд байсан христосын шашны цорын ганц сүм хаагдсан байна.

Шашныг устгах явдал бол марксистуудын мөнхийн зорилго мөн. Гэвч Соёлын хувьсгалын үеэр хуучин коммунист кадр ажилтнуудын тухай ч мартаж болохгүй байв. 1966 оны аравдугаар сарын 1-нд БНХАУ байгуулагдсаны ойд зориулсан цуглаан дээр Линь Бяо үг хэлэхдээ Соёлын хувьсгал нь нам дахь эрх мэдлээр хангагдсан, капиталист замаар явж буй цөөн тооны этгээдийг бут цохих учиртай юм гэж мэдэгджээ.[1508] Улаан хамгаалагчид Лхас хотод орон нутгийн намын хороог "шүүмжилсэн" том үсгийн хуудас (дацзыбао) нааж эхэлжээ. 1966 оны аравдугаар сард болсон олон нийтийн цуглаанд Агваан Жигмэдийг дуудан ирүүлжээ.[1509] Тэр хүн ч "гэм буруугаа хүлээсэн" байна. Дараа өдөр нь түүнийг дахин дуудахад Агваан Жигмэд Хятад руу явсан байжээ. Арван хоёрдугаар сарын 19-нд болсон цуглаан дээр харин Жан Гохуа "гэмээ наминчлахад" хүрсэн байна.

1966 оны арванхоёрдугаар сарын 22-нд "Лхасын хувьсгалч үймээн дэгдээгчдийн төв штаб" буюу товчилбол Гьенлогийн штаб буюу Гьенлог (хятадаар: цзаофань) хэмээх томоохон бүлэглэл байгуулсан тухай зарлажээ.[1510] Бээжингээс ирсэн улаан хамгаалагчдаар толгойлуулсан 35 хувьсгалт байгууллага энэ штабыг байгуулжээ. Тэд 51 "дайчин отряд" байгуулав. Тэд: "Бид хувьсгал болон үймээн самууныг эрс шийдвэртэй хэрэгжүүлнэ. Пролетари нарын хурц улаан шинэ ертөнц байгуулахын тулд босно, босно, эцсээ хүртэл босно" гэсэн тов тодорхой үзэл суртал баримтлах ажээ.[1511] Тэд арванхоёрдугаар сарын 26-нд уриалга нийтлүүлж,

түвдийн өөртөө засах орны намын хороог хөрөнгөтний харгис чиг шугам баримталсан, Маогийн хувьсгалч чиг шугамыг сөрөн зогссон гэж зэмлэн буруушаав.

Эдгээр штаб үнэн хэрэгтээ: “Эмх замбараагүй байдлаас айхын хэрэггүй. Хөрөнгөтний байр сууринаас барууныхныг ивээн тэтгэж, зүүнийхэнд цохилт өгч, аугаа их соёлын хувьсгалыг боймлож байгаа тэр хүчний эсрэг тэмцэх хэрэгтэй. Янз бүрийн хязгаарлалт бий болгож, олон түмний гар, хөлийг хүлж буй хүчний эсрэг тэмцэх хэрэгтэй” хэмээсэн 1966 оны наймдугаар сарын 12-ны ХКН-ын төв хорооны XI бүгд хурлын шийдвэрийг мөрджээ.[1512] Тийнхүү орон нутгийн эрх баригчид эмх замбараагүй байдлыг нухчин дарах эрхгүй болжээ. Тиймээс тэд өөр замаар явж: штабынхны “шинэ цзаофань” үймээнч бүлгүүд бий болохыг зөвшөөрөх болсон байна.[1513] Эдгээр үймээнчид “Мао Зэдуны үзэл санааг хамгаалах Лхасын дайчин штабын” бүрэлдэхүүнд оров. Энэ штаб 1966 оны арванхоёрдугаар сарын 28-нд байгуулагджээ.

Гьенлогийн “штабууд” эрс үйл ажиллагаа явуулж байв. 1967 оны эхээр энэ “штабууд” радиостанц, мэдээллийн Синьхуа агентлагийн товчоо, төв сонины газрыг эзэлж, “Хунсы заофань бао” хэмээх өөрийн гэсэн сонин гаргаж, Лхасын засаг төрийн хэд хэдэн бүтэц, түүний дотор нийгмийн аюулгүй байдлын товчоог эзлэв.[1514] Үүний зэрэгцээ тэд өрсөлдөгч бүлэглэлийн гишүүдийг илчилж, баривчилж, зодож, байцааж байв. Хоёрдугаар сарын 19-нд гьенлогийн штабынхны сонинд Жан Гохуа болон Түвдийн өөртөө засах орны ХКН-ын ажлын хороог харгис хүчин, ревизионизмыг ивээлдээ авч, хамжлагат ёс, харгис санваартнуудын эрх мэдлийг сэргээн тогтоохыг эрмэлзсэн гэж зэмлэн буруушаасан өгүүлэл гарсан байна. Тэдэнд 1961–1962 оны “зохицуулалтын” үед хэргэлэж байсан арга хэмжээ оногдуулах хэрэгтэй хэмээн үзэж байлаа.

Намын удирдлагууд хариу арга хэмжээ авсан байна.1967 оны хоёрдугаар сард “Мао Зэдуны үзэл санааг хамгаалах Лхасын дайчин штабт” өөр хэд хэдэн бүлэг нэгдэв. Тэдгээр бүлэг “лхасын пролетарийн хувьсгалын үймээнчдийн штабуудын аугаа их холбоо” байгуулав.[1515] Энэ бүлэглэл Нямдрел (түвдээр “холбоо” буюу “хамтдаа” гэсэн үг) хэмээх нэрээр алдаршжээ.

Хоёр бүлэглэлийн хооронд үзэл суртлын зөрөлдөөнгүй: хоёулаа Мао Зэдуны зааврыг мөрдөж, соёлын хувьсгал хийх ажээ. Гэхдээ тэд янз бүрийн давхарга: Нямдрел нь эрх мэдлээ хамгаалж буй орон нутгийн удирдах кадр ажилтнууд, Гьенлог нь энэ эрх мэдлийг булааж авахыг эрмэлзэгч

доод болон дунд шатны кадр ажилтнуудын эрх ашгийг илэрхийлж байв. Гьенлог бүлгийг Бээжингээс ирсэн улаан хамгаалагчид дэмжих ажээ. Хоёр бүлэглэлийн ангийн түшиг тулгуур ерөнхийдөө адил. Эдгээр бүлэглэлд хуучин "дарлан мөлжигчдээс" бусад хэн ч элсэн орж болох бөгөөд дарлан мөлжигчид хоёр талын мөрдлөг хавчилгад өртөнө.

1967 оны нэг–хоёрдугаар сард Түвдийн тосгон бүрт, байгууллага бүрт хоёр бүлэглэлийн аль нэгнийх нь л фракци бий болсон байлаа. Хоёр бүлгийн хоорондын харилцаа улам хурцдаж байлаа. Гьенлогийн гишүүд Нямдрелийн хүмүүс цөөн байдаг газруудыг мэдэлдээ авч, Нямдрелийнхэн ч мөн ийм байдлаар ажиллах ажээ.[1516] Ингээд хоёр бүлэглэл зарим нутаг дэвсгэрийг хуваан авсан байна. Томоохон мөргөлдөөн эхлэв. 1967–1968 онд Будалын ордонд байрласан ХАЧА-ийн цэргүүд 4–5 сарын туршид үе үе хот орохоор явахдаа дайсагнагч бүлгүүдийн хооронд орж, чулуугаар шидүүлж, мод саваагаар зодуулдаг байв. Тэр үед цэргүүдэд зэвсэг тавьж өгөөгүй, өөрийгөө сэнхрүүлэхийн тулд цээжлэх Маогийн товхимолууд л байжээ.1967 оны хоёрдугаар сарын эхээр Гьенлогийн гишүүд ХАЧА-ийн нэг отрядын дэмжлэгтэйгээр Лхас дахь хятад цэргийн штабыг төвийг сахисан бодлого баримтлуулдаг болгохыг оролдов. Хоёрдугаар сарын 21-нд ХКН-ын төв хороо уриалга гаргаж, эрх мэдлийг гартаа авахыг армийнханд уриалсан байна.

Бээжингээс цэргийн төв хорооны зөвшөөрөл авсан штаб дэг журам тогтоож эхлэв. Соёлын хувьсгалыг армид дэлгэрүүлэхийг эрмэлзсэн цэргүүд эхний ээлжинд баривчлагдав. Цэргүүд Лхас хотыг хяналтандаа авч эхлэв. Гуравдугаар сар гэхэд цэргийнхэн төрийн байгууллагуудыг эзэлж, хотод хяналт тогтоов.[1517] Гьенлогийн гишүүдийг хувьсгалын эсэргүүчүүд хэмээн зарлаж, удирдагчдыг нь баривчлав. Лхаст бүх зүйл харьцангуй тайван болж өнгөрсөн. Үүнээс өмнөхөн "Хөх нуурын өдөр дутмын сонины" газарт армийнхан гал нээж, тэр хавьд явж байсан нэг зуу гаруй хүнийг хөнөөсөн тийм хэрэг дахин гаргахыг Жоу Эньлай хоригложээ.

Нийслэлээс очсон улаан хамгаалагчдыг Түвдээс Бээжинд буцаж ирэхийг шаардав. Жан Гохуа бол алдаа гаргасан ч "сайн нөхөр" хэмээн зарласан бөгөөд цзаофанууд цэргийн тойргийн удирдлагатай хамтран ажиллах ёстой болов.[1518] Цэргийнхэн нийт Түвдийн өөртөө засах оронд аажмаар хяналтаа тогтоох болов.

Үүний зэрэгцээ 1966 оны арванхоёрдугаар сараас 1967 оны дөрөвдүгээр сарыг дуустлах хугацаанд Гьенлогийн гишүүдийн тоо 15 мянга гаруй байснаа 3 мянга хүртэл цөөрсөн байна.[1519] Харин Нямдрелийнхны тоо 38

мянга хүртэл өсөв.

Мао Зэдун 1967 оны эхээр олон хуучин кадр ажилтан эрх дархаа сэргээж, армийнхан улс орны байдалд улам хүчтэй нөлөөлөх болсныг олж харжээ.[1520] Тэрээр үлдэж хоцорсон дайснууд руу хувьсгалт олон түмний хоёрдахь давалгааг чиглүүлэхээр шийджээ. 1967 оны дөрөвдүгээр сарын 1-нд ХКН-ын Төв Хороо намын орон нутгийн удирдагчид болон армийнхан олон ниитийн байгууллагуудад хувьсгалын эсэргүүчүүдийн нэр хаяг зүүх ёсгүй:үүнийг төв шийдэх ёстой гэж зарлав. Дөрөвдүгээр сарын 6-нд Цэргийн төв комиссийн гаргасан удирдамжаар бол арми улс төрийн ажлаар хязгаарлагдах ёстой бөгөөд чухал шийдвэрүүдийг Төвийн эрх баригчид, мөн ХАЧА дахь Соёлын хувьсгалын бүлгүүд гаргах ёстой болжээ. Энэ нь өвлийнхөө ялагдлын өшөөг авах гэсэн Гьенлогийнхны урмыг сэргээв. Зун гэхэд Гьенлог буюу хувьсгалч үймээнчдийн төв штаб цэргийнхний дотор хагарал гаргаж, тэдний зарим хэсгийг талдаа татаж чадсан байна.Тавдугаар сарын сүүлчээр бээжингийн улаан хамгаалагчдын зарим гишүүн түвдэд эргэж ирээд Соёлын хувьсгалыг эцэст нь хүргэнэ гэж мэдэгдэв. Тавдугаар сарын 29-нд Нямдрел буюу Лхасын пролетарийн хувьсгалын үймээнчдийн штабуудын аугаа их холбоо Чамдо дахь Гьенлогийн “штаб”-т халдаж, дараа нь Лхас хотод зэвсэгт мөргөлдөөн болов.

1967 оны хоёрдугаар хагасаас хоорондоо дайсагнагч “Үймээн дэгдээгч” дээрэмчдын зэвсэгт мөргөлдөөн тасралтгүй үргэлжлэв. Энэ бол үндсэндээ хоёр бүлэглэлийн үлэмж хэсгийг бүрэлдүүлж, тэднийг удирдаж байсан хятадуудын хийсэн ажил байлаа. 1968 оны эхээр нөхцөл байдал хурцдав. Лхаст 10 өдөр үргэлжилсэн тулалдаан Шигазе болон бусад хотод шилжив.[1521] Мөргөлдөгч талууд пулемёт, гранат хэрэглэсэн байна. Энэ зэвсгийг хоёр бүлэг өөр өөрсдийг нь дэмждэг цэргийнхнээс авсан байх магадлалтай юм. Мөргөлдөөний улмаас олон зуун хүний амь эрсдэв.

Бүр 1967 оны есдүгээр сард Мао түвдийн соёлын хувьсгалыг 1967 оны сүүлч гэхэд дуусгахыг хүсч байна гэж мэдэгджээ.[1522] Гэтэл 1968 оны эхээр ганцхан сарын дотор Лхас хотод нэг мянган хүн амь үрэгдсэн байна. Армийн хяналт хадгалагдан үлдсэн хилийн бүсээс бусад бараг газар сайгүй мөргөлдөөн гарсан байна. Гьенлогийнхан хүчтэй болсон нь цэргүүд үндсэндээ Лхаст байсантай холбоотой бөгөөд энэ нь орон нутагт өөрийнхөө талынхныг элсүүлэн авах боломж бүрдүүлжээ.[1523] Тосгоныхон жилд 140 биш, харин 165 кг үр тариа (гол төлөв арвай) өгөх хэрэгтэй байна гэж Гьенлогийн гишүүд мэдэгдэж байв.[1524]

Бээжингээс зургадугаар сарын 6-нд армийнханд аль нэгэн бүлэглэлийг

дэмжихгүй байхыг тушаасан явдал Гьенлогийнханд завшаан болжээ. Гэвч дараа өдөр нь энэ тушаалыг зөрчжээ. ХАЧА-ийн отрядууд Жокан сүм, санхүүгийн удирдах газар зэрэг Лхас хот дахь Гьенлогийн түшиц газруудад халдав. Энэ хоёр байшингийн орой дээр, түүнчилэн сүмийн дээд давхарт заофаниуд чанга яригч байрлуулж, суртал нэвтрүүлэг хийж байсан явдал ингэхийн шалтгаан болсон байна. Санхүүгийн газарт хийсэн дайралт амжилтгүй болж, харин Жокан сүмийг богино хугацаанд эзэлж авчээ. Энэ бол чухал ялалт байсан бөгөөд сүмийн радиостанц Гьенлогийнхны хувьд маш чухал ач холбогдолтой байв. Армийн цэргүүд 60 гаруй “Босогчид” алж, шархдуулан нэг мянга гаруй сум, есөн гар бөмбөг зарцуулан байж нилээд олон буу болон есөн гар бөмбөг олзолж авсан юм гэж ХАЧА-д алба хааж байсан нэгэн Түвд хүн ярьжээ.[1525] ХАЧА-иас 6 хүн алагдаж, шархаджээ. Гьенлогийн нэг гишүүний дурсамжаар бол 20 хүн алагдаж, хэд хэдэн хүн шархадсан ажээ.

Тийнхүү түвдийн гол сүмд цэргүүд байрлах болов. Цагаачлан гарсан лам нарын ярьснаар бол шинэ эзэд сүмийн хана руу шээж, тэнд гахайн хороо хийж, хашаанд нь мал оруулжээ.

1968 оны наймдугаар сар гэхэд зэвсэгт мөргөлдөөн өргөн цар хүрээтэй болсон учир Жоу Эньлай Түвд дэхь фракц бүлгүүдийн тэмцэл иргэний дайны хэмжээнд хүрснийг арга буюу хүлээн зөвшөөрсөн байна. Мао 1968 оны наймдугаар сарын 11-нд Бээжин хотноо “Түвд дэхь ХАЧА-ийн цэргийн хариуцлагатай нөхөдийг” хүлээн авч уулзав.[1526] Үүний зэрэгцээ ХКН-ын Төв хороо зэвсэгт мөргөлдөөнийг зогсоож, дэг журам тогтоохын тулд Түвд рүү тусгай комисс явуулахаар тогтсон байна. Хятадын засгийн газар 1968 оны наймдугаар сарын сүүлчээр Гьенлог, Нямдрел, хятадын удирдлага, Соёлын хувьсгалын төв бүлэглэлийн төлөөлөгчдийн ээлжит уулзалт зохион байгуулав.

Ингээд Гьенлогийг илбэн тохнинуулахын тулд Түвдийн цэргийн тойргийн штабын намын хорооны байнгын хороо өөрийгөө шүүмжилсэн дэлгэрэнгүй баримт бичиг бэлджээ.[1527] Тухайлбал: “Бид хувьсгалч олон түмний Гьенлог байгууллагын штабыг “хувьсгалын эсэргүү цөөн тооны элементүүдийн” хяналтад байдаг тааруухан байгууллага гэж буруу дүгнэж, бид энэ байгууллагад зэрлэгээр халдан дарж, бид энэ байгууллагын зарим хариуцлагатай хүмүүс, хувьсгалч олон түмний зарим гишүүн, зарим залуу хувьсгалч дайтагчид, хувьсгалч кадр ажилтнуудыг баривчлан эрх чөлөөг нь хасчээ. Тэдгээрийн заримыг “хувьсгалын эсэргүү этгээд” хэмээн нухчин дарсан билээ. Бид энэ хүмүүсийн хувьсгалч урам зоригийг ноцтой байдлаар

сулруулсан байна” гэх зэрэг “алдаануудаа” цохон заасан байна.

Мэдээжийн хэрэг Маогийн үзэл санааг хангалттай бус судласан гэдгээр эдгээр “алдааг” тайлбарлажээ. Бээжинд Гьенлогийн толгойлогчид тэмцлээ зогсоож, Түвдийн өөртөө засах орны хувьсгалт хороо байгуулахад оролцохоор тохиролцжээ.

Ингээд есдүгээр сарын 5-нд энэхүү хувьсгалт хороог байгуулсан тухай зарлав. Хорооны бүрэлдэхүүнд 12 хятад, дөрвөн түвд хүн орсон байна. Үүгээр Түвд дэхь соёлын хувьсгалын үндсэн шат дуусчээ. Засгийн эрх цэргийнхэнд шилжив. Хувьсгалт хорооны дарга Зэн Юнья мөн цэргийн тойргийн командлагч болжээ. Өмнө нь тэрээр Жан Гохуагийн орлогч байсан юм. Жан Гохуаг Гьенлогийнхны өшөө авалтаас зугтаалгаж, Сычуань руу албан тушаал дэвшүүлэх нэрийдлээр явуулсан байна.[1528] Хувьсгалт хорооны гишүүдийн олонхи нь цэргийнхэн, хувьсгалчид, нам, захиргааны кадр ажилтан байсан зарим хүн ажээ. Орон нутагт Гьенлогийнхон төдийгүй эмх замбараагүй байдалд дургүйцсэн нутгийн хүн амын эсэргүүцлээс болж хувьсгалт хороод эмхлэн байгуулах ажил 1969 он хүртэл сунжирсан байна.

1968–1970 онуудад хувьсгалт хороодын дотоодод болон тэдгээрийн эргэн тойронд тэмцэл үргэлжилсэн явдал хотуудад шинэ шинэ мөргөлдөөн гарахад хүргэсэн бөгөөд эдгээр мөргөлдөөнд олон мянган хүн оролцжээ. Тухайлбал, 1968 оны аравдугаар сарын 2-нд Шигазегийн хувьсгалт хороонд халдах үеэр тэндхийн олон ажилтан алагдсан байна.[1529] Гэхдээ хамгийн том мөргөлдөөн 1969 оны наймдугаар сарын 3-нд Лхас хотод гарсан байна. Хувьсгалт хороо хамгийн томоохон бүлгүүдийн 3 мянга орчим цзаофанчуудыг цуглуулж, зэвсгээ хураалгахыг тушаажээ. Тэд татгалзаж, цэргүүдэд баривчлагдсан байна. Энэ дээрэмчдийн 10 мянга гаруй гишүүн энэ тухай олж мэдмэгцээ түвдийн бусад нутгаас Лхас хот руу хөдөлжээ. Тэд хот хавийн засмал зам, гүүрүүдийг эвдлэн сүйтгэж, хотын төв рүү дайран орж, хамтран зүтгэгчдийг нь суллахыг шаардав. Зэвсэгт мөргөлдөөн болов.

Мөн оны арван хоёрдугаар сард лхасын радиостанц Хувьсгалт хороог, мэдээжийн хэрэг, эвлэршгүй ангийн дайснууд, урван тэрслэгчид, тагнуулууд болон зүсэн бүрийн харгис этгээдүүдээс бүх талаар хамгаалахыг уриалав.

Гьенлог, Нямдрелын бие биеэ үзэн ядах хандлага намжсангүй. Эрх мэдэл Гьенлогийнханд шилжсэн нутгуудад Нямдрелагийн хүмүүсийн эсрэг “тэмцлийн цуглаан” эхэлж, тэднийг зодож, амь насыг нь хөнөөх ажээ.[1530] Гьенлогийн хүмүүс Нямдрелагаас эрх мэдэл булааж авахын тулд өрсөлдөгчдөө эдийн засгийн буруу бодлого баримталсан хэмээн буруутгаж, тариачдын айдас хүйдэс, өлсгөлөнг ашиглах ажээ.[1531] Гьенлогийн игишүүд

зарим газарт эрх мэдэл булааж авангуутаа бие даан шашны ёслол үйлдэхийг хүртэл зөвшөөрч байлаа (хийдүүд болон лам хуврагийн амьдралыг сэргээн тогтоох биш). Лхас дахь Гьенлогийн толгойлогчид энэ тухай мэдэж, “олон түмнитйг давшилтад идэвхжүүлэхийн” тулд шашныг ашиглажээ. Хожим нь энэ бүлэглэлийн олон гишүүн “харгис хүчин” хэмээгдэж шийтгэл хүлээсэн байна.

Нөгөө талаас орон нутгийн эрх баригчдын эсрэг ард түмний тэмцэл Соёлын хувьсгалын хэлбэр рүү гулсаж орох боломжтой байлаа. Түвдчүүд хятадуудын эсрэг халдахын тулд хүнд сурталтай тэмцэх тухай Маогийн уриаг ашиглажээ.[1532] 1968 он гэхэд ард олны бослого Түвдийн өөртөө засах орны 51 гацааны 20-д, мөн Амдо, Камын зарим нутагт дэлгэрсэн байв. Үндэсний эрх чөлөөний тэмцэл гол төлөв Нямдрелагийн эсрэг Гьенлогийг дэмжих уриан дор болж байв. Жишээ нь, Баруун Түвдийн Пала гацааны нүүдэлчид 1969 онд коммун байгуулах гэж байгаа тухай олж мэджээ. Тэд өөрсдийгөө Гьенлогийн гишүүн хэмээн зарлаж, бослого хөдөлгөөн гаргаж Нямдрелаг дэмжсэн түшмэлүүдийн заримыг алж хороон, заримыг нь баривчилж, шашны болон аж ахуйн эрх чөлөөг зарласан байна.[1533] Тэд 1959 оны өмнөх байдалд эргэж орно гэж найдсан боловч алдаа болсон байна. Удалгүй Нямдрелагийн гишүүнээр удирдуулсан цэрэг ирж, Соёлын хувьсгалыг жинхэнэ утгаар нь явуулсан байна. Тэнд коммунууд 1981 он хүртэл байжээ. Эрх баригчид зарим нүүдэлчдийг хоосруулав. Тэд хөрөнгө хураам, хүмүүсийг ядууруулж, коммунд орох эрхийг нь хасчээ.

Армийнхан Маог нас барах хүртэл Түвдэд төдийгүй БНХАУ даяар улаан хамгаалагчид болон цзаофанчуудыг устгаж байлаа. Хятадын зарим хотыг дайралт хийн эзлэхэд хүрч байв. Жишээ нь, Гуйлинь хотыг 30 мянган цэргийн хүчээр дайрч,Ужоу хотод напалмын бөмбөг хаяж эзлээд бүх улаан хамгаалагчдын толгойг авчээ.[1534] Дарга Мао өөрийнхөө бий болгосон хүмүүсийг устгаж байжээ. Хэрэв янз бүрийн “дайрагч отрядуудын” хоорондох адил төстэй байдлуудыг дахин санах юм бол гитлерийн отряд СА-гийн удирдлагын эсрэг А. Гитлерийн явуулсан “урт хутганы шөнө” ажиллагаанд хавьгүй бага цус урсгажээ... гэж дүгнэлт хийж болно.

Коммунистууд армийн тусламжтайгаар “үймээн дэгдээгчдийг” нуга дарж авмагцаа хөдөө аж ахуйг хамтралжуулах мөнхийн мөрөөдөлдөө эргэж оржээ. Үнэнийг хэлэхэд Түвдийн өөртөө засах оронд Соёлын хувьсгалаас өмнө буюу 1965 онд коммунууд байгуулагджээ. Харин олон нийтийг хамарсан кампанит ажил 1968–1969 онд л өрнөсөн байна.[1535] Хятадууд коммун байгуулсныхаа дараа Түвд орон хөгжингүй феодализм,

капитализмыг алгасан хамжлагат ёсны феодализмаас социализм руу үсрэлт хийлээ гэж зарлав.[1536] Үлгэрлэвэл БНМАУ-ынх шиг.

Хятадын суртал нэвтрүүлэгчид коммуныг хөдөлмөрчдийн хүсэлтээр байгуулсан бөгөөд тэднийг маогийн үзэл санаа энэ өөд хөтөлсөн юм гэж нотолж байлаа. Гэвч шинэтгэлийн үед газартай болсон Түвд тариачид: “Би социализмын бүх замыг туулахын оронд тэндээ л үлдэх минь” гэж ярьж байжээ. Коммунуудад цай хийх данх хүртэлх бүх зүйлийг хамтын өмч болгож, хүмүүс хоол ундаа хүртэл нийтийн гуанзанд идэх үүрэгтэй байв.[1537] Хуримтлуулсан оноогоор цалин авна. Хүмүүст ямар бүтээгдэхүүнийг хэдий хэмжээгээр өгөхийг заасан татварын хуудас байх ажээ. Мөн түүнчилэн БНХАУ-ын бүх нутгийн нэгэн адил хүнсний болон аж үйлдвэрийн бараа таваарыг нормоор олгоно. Хэрэв хэн нэгэн хүн өвчилсний улмаас ажилдаа гарч чадаагүй бол түүний хүртэх хувь багасна.

Ажилдаа явж чадахгүйд хүрвэл удирдлагаас зөвшөөрөл авах хэрэгтэй.[1538] Гэхдээ л ингэхийн хэрэггүй ажээ. Гэр бүлд өвгөд хөгшид, хүүхэд зэрэг тэжээгдэгчид байдаг бол тэр гэр бүлээс ажиллаж буй хүмүүсийн их биш хувийг бүх хүндээ хуваах хэрэгтэй болно. Өлсөхөө багасгахын тулд эцэг эхчүүд хүүхдээ найман наснаас нь ажил хийлгэнэ. Коммунуудад хятад кадр ажилтнууд гол үүрэг гүйцэтгэнэ. Энэ кадр ажилтнууд коммуны гишүүдэд тооцон гаргасан мөнгөнөөс хувь хүртэж, бас засгийн газраас цалин авч байна гэж тариачид гомдол гаргах ажээ. 1968 оноос коммунуудад Түвд кадр ажилтнууд ирэх болжээ. Намын уриалгаар олон түвд залуучууд алслагдсан нутгууд руу явсан байна. Тэд үүнийг шийтгэл хэмээн үзэж байжээ.

Хамтралжуулалт нь хөдөө нутгууд дахь шинэ өлсгөлөнгийн нэг шалтгаан болсон байна. Өлсгөлөн 1968 оноос 1973 оныг дуустал үргэлжлэв.[1539] Тариачдын бараг бүх бүтээгдэхүүнийг улс хурааж авдагаас болж энэ өлсгөлөн гарсан юм гэж тэрхүү үйл явдлыг мэдэх Камын нэгэн иргэн надад ярьсан билээ. Хүмүүс маш бага цалин хөлс авдаг учир хөдөлмөрийн чадваргүй хүнтэй гэр бүлээ тэжээж чадахгүйд хүрч байлаа. Үүнээс болж зэрлэг ургамалаар гурил хийхэд хүрдэг ажээ. Хүмүүс өлсгөлөнгөөр нас барж байлаа. Лхокийн “Улаан дарцаг” гэдэг үлгэр жишээ коммуныг тэргүүлж байсан хуучин “хамжлагийн тариачин” нэгэн эмэгтэй дурсахдаа бүтээгдэхүүн нэмэгддэг ч хураасан үр тарианыхаа тэн хагасыг Хятад улсад худалдахад хүрдэг байсан гэжээ.[1540] Энэ бүхнээс болоод хүмүүс хоол ундаа залгуулах гэж коммунаасаа мөнгө зээлж өрөнд баригдана. Хүмүүст урам зориг үгүй болж, хөдөлмөрийн бүтээмж ч буурах ажээ.

Бүр 1959 онд Төв Түвдийн агротехникийн туршилтын станцад очсон

гадаадын сурвалжлагчдад олон төрлийн ургамал (улаан буудай, эрдэнэ шиш, шар буурцаг, олс, шар манжин зэрэг) тэгш тал газрыг бодоход 4 км-ийн өндөрт илүү сайн ургаж байгаа тухай ярьжээ.[1541] Түвдийн өндөрлөгт нэг гектараас "Украинка" сортын улаан буудайн 55 центнерийн ургац авсан мэтээр ярьсан нь түүний эх орон болох Украиныхтай адил болжээ. Уламжлалт арвайн оронд улаан буудай тариалахыг газар тариаланчдад шахах болсон байна. Өндөрлөг газарт энэ таримал ургац өгсөнгүй. Малчдыг уламжлалт махан хоолноос нь үр тарианд оруулжээ.

1968 онд Шигазе тойрогт тариачдын аж ахуйнуудын 45 хувь нь ардын коммунд нэгдэж, зарим гацаанд энэ үзүүлэлт 86 хувьд хүрсэн байна.[1542] 1970 оны дунд үе гэхэд Түвдийн өөртөө засах оронд 666 коммун байсан бөгөөд түүнийг бүх гацаанд, мөн хошуудын 34 хувьд зохион байгуулжээ. 1974 оны сүүлч үе гэхэд Түвдийн өөртөө засах орны хошуудын 93 хувьд коммун байгуулжээ. Үүнээс болж хүн амын дургүйцэл төрж, мөн тийш нь "ардын сайн дурын" отрядууд явуулахад хүрсэн байна.[1543] Олон Түвд хүн элсэн чихэр, шар тос, цай, тутрага (цагаан будаа) зэрэг бүтээгдэхүүний бараа харалгүй удсан бөгөөд өлсөж үхэхгүй амьд үлдэхийн тулд олон хүн цусаа мөнгөөр өгөхөд хүрдэг байжээ.[1544]

Бараг бүх сургууль, эмнэлгийн газрууд, орон нутгийн үйлдвэрүүд, их барилга зэрэг газруудын зардлыг коммунуудад хариуцуулна. Шаардлагатай гэж үзвэл хэд хэдэн коммуныг нэгтгэх ажээ. Тэнд намын хороо, залуучуудын эвлэлийн хороо байгуулна. Коммуны гишүүд иргэний болон цэргийн байгуулалтад оролцох, хятад шилжин суурьшигчдыг хүлээн авах нөхцөл бүрдүүлэх, "ардын сайн дурын" отрядууд байгуулах зорилгоор цэргийн бэлтгэл хийх үүрэгтэй байв. Энэхүү "ардын сайн дурын отрядуудад" бараг бүх эрчүүд, эмэгтэйчүүд орох ажээ. ХАЧА-д туслаж, хилийн чанадад гарахыг хүсч буй болон тэндээс ирсэн хүмүүсийг илрүүлэх явдал "сайн дурынхны" нэг гол үүрэг байв.[1545]

Гэхдээ таран байрласан хятад цэргүүдэд үйлчлэх, тэднийг хоол хүнсээр хангах явдал коммунуудын гол зорилго ажээ. Түвдийн ард түмэн ХАЧА-ийг хайрлан хүндэтгэж, дэмжиж байгаа тухай хэвлэлд мэдээлдэг байв.[1546] Энэ хайр гэгч нь тариачид армийн мэдэлд буй талбайг боловсруулах, ургац хураах, цэргүүдийг замбайгаар хангах, мод түлээ бэлтгэж, ус зөөх, цэргүүдэд орон гэрээ "тавьж" өгөх, ачилга, уналганы мал өгөх зэргээр илрэн гарах ажээ. Шаардлагатай гэж үзсэн нөхцөлд "феодалын хамжлагын эздээс чөлөөлөгдсөн" хөдөлмөр өдөр шөнөгүй үргэлжилж болох ажээ.

Ургац хураалтад цэргийнхний үзүүлэх "тусламж" түүнийг хураах

хэлбэрээр илрэн гарах нь элбэг бөгөөд тариачид өндөр уулын тачир байгалийн бүтээгдэхүүн буюу зэрлэг ургамалын үндсээр л хооллоход хүрнэ. Ийнхүү хүн ардын хоол хүнсийг булааж авдгаас болж бослого хөдөлгөөн аяндаа л гарах ажээ.[1547] Жишээ нь, 1969 онд Динри гацааны нэгэн жижиг тосгонд ургац муу гарчээ. Тэнд очсон хятад кадр ажилтнууд тэрхүү бага ургацыг юу ч үлдээлгүй аваад явжээ. Түвдчүүд тэднийг хэмх нүдчихээд ууланд гарсан байна. Эрх баригчид энэ хүмүүсийг мөрдөн хавчихгүй гэж амласан боловч тэднийг, эргэж ирэхэд нь баривчилжээ. Тэнд 60 хүн байжээ.

Феодал-шашны байгууллыг хэрхэн илчилж байсныг харьцуулах жишээ болгож дурдая: “хамжлагын тариачид газар хагалахад хөлс хүчгүй ажиллаж, түшмэд, лам нар, худалдааны отрядууд, түвд цэргүүд, орон нутгийн засгийн газрын эд материалыг тээвэрлэх морь малыг үнэ төлбөргүй тэжээлээр хангаж, адгуулах, түүнчилэн орон нутгийн засгийн газрын ажилд, сүм, хийд байгуулах ажилд хөлс хүчгүй албадлагын хөдөлмөр хийж, арвай, шар тос, тахианы өндөг, цэвэр мөнгөн юань, түвд цалин цагаан мөнгө зэрэг орон нутгийн засгийн газарт шаардлагатай бүх зүйлийг өгөх зэргээр зүтгэнэ. Түүнээс гадна орон нутгийн засгийн газрын янз бүрийн түвшний түшмэд тэндхийн хамжлагын тариачдад албадлагын ажил хийх үүрэг хүлээлгэх ажээ”.[1548]

Гэхдээ тэр үед өлсгөлөн байгаагүй юм. Харин уламжлалт өвөлжих улаан буудай тариалахыг болиулж, ХАЧА-ийн хоол хүнсийг албадан гаргуулах болж, нүүдэлчдийг суурин амьдралд оруулж, хамтралжуулснаар өлсгөлөн үүссэн байна.[1549]

Маогийн үзэл санааг сурталчлах, жишээлэхэд дайн, өлсгөлөн, байгалийн гамшигт бэлтгэлтэй байх хэрэгтэйг сурталчлахын тулд цэрэг илгээжээ. “Зөвлөлтийн урван тэрслэгч ревизионистуудын бүлэг хятадын ард түмэнд ямагт дайсагнан хандаж ирсэн, одоо ч тийм байна. <...> Та нар хичнээн олуулаа, ямар ч хүчинтэй нийлж ирсэн бид эрс шийдэмгий тулалдаж, та нарыг хүйс тэмтрэн устгана.<...> Шинэ хаад сөнөтүгэй, зөвлөлтийн ревизионистуудын социал-империализм сөнөтүгэй” гэх зэргээр сурталчлах ажээ.[1550]

1960-аад онд маогийнхан хятад-зөвлөлтийн хил дээр хэдэн мянган удаа өдөөн хатгалага үйлджээ. 1969 онд Даманы арлын ойролцоо болсон будлиан хамгийн томоохонд орох бөгөөд энэ үед зөвлөлтийн 60 цэрэг, офицер алагдаж, 100 гаруй хүн шархадсан байна.[1551] 1991 оны хэлэлцээрээр энэ арал албан ёсоор хятадын талд шилжсэн билээ. Одоо тэнд ХАЧА-ийн дайчин алдрын Музей байгуулагджээ.

Хятадын удирдлага тун удахгүй дэлхийн гуравдугаар дайн гарна гэдэгт тун их итгэлтэй байжээ. Тэд “ревизионист хаадын” эсрэг батлан хамгаалалт хийхээр шийджээ. Түвдэд өргөн хэрэглээний бараа таваар нийлүүлэх ажил тасалдаж: тээврийн хэрэгслүүдийг дайнд бэлтгэхэд хэрэгтэй бараа бүтээгдэхүүн зөөхөд ашиглах болсон байна.[1552] Энэ бэлтгэл удахгүй дуусна, бараа таваар элбэгшинэ гэж эрх баригчид итгүүлэн үнэмшүүлэхийг эрмэлзэж байлаа. 1970-аад онд Лхас хотын олон зуун иргэн ууланд янз бүрийн хонгил болон бөмбөгдөлтөөс хоргодох байр ухах ажээ.[1553] Коммунууд дайн гарна хэмээн бодож хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх үүрэгтэй байв.[1554]

Коммун байгуулах кампанит ажил 1976 он гэхэд дуусав. Түвдийн өөртөө засах орны ХКН-ын намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Жэнь Жун 1977 онд хэлэхдээ: “Төзо... коммунчлах ажлыг газар сайгүй хэрэгжүүллээ. Үндэсний тэмцлийн шинж чанар бол ангийн тэмцлийн асуудал мөн гэж Мао Зэдуны хэлсэн үг, Мао Зэдуны бусад заалтууд... Түвдийн хувьсгалын ялалтын замыг гийгүүлж, шинэ шинэ ялалтад хүрэх хувьсгалын зөв замаар түвдийн ард түмнийг удирдан жолоодож байна” гэжээ.[1555]

Хамтралжуулах хөдөлгөөн ид өрнөж байсан үе буюу 1971 оны наймдугаар сарын 7–12-нд Түвдийн өөртөө засах орны ХКН-ын анхдугаар их хурал болов.[1556] ТӨЗО-ны ХКН-ын хороог 56 гишүүн, 16 орлогч гишүүнтэйгээр, мөн байнгын товчоог 16 хүний бүрэлдэхүүнтэй тус тус сонгосон байна. Түвдийн цэргийн тойргийн улс төрийн нэгдүгээр комиссар хан үндэстэн Жэнь Жун урьдын адил нэгдүгээр нарийн бичгийн дарга болж, гурван хятад, гурван Түвд хүн нарийн бичгийн даргаар сонгогдсон байна. БНХАУ бүхэлдээ цэргийн тойргуудад хуваагдаж, эдгээр тойргийн намын хороод орон нутагт засгийн эрх барьдаг болохоор Жэнь Жун түвдийн дээд эрхийг илэрхийлэх болсон байна. 1972 оны зургадугаар сард Лхас, Шигазе, Чамдо, Нагчуд намын бага хурал болов.[1557] Түвдчүүдийг ХКН-д элсүүлэх хөдөлгөөн өрнөв. Синьхуа агентлагийн мэдээлснээр бол 1972 оны зургадугаар сараас 1974 оны зургадугаар сарыг дуустлах хугацаанд ТӨЗО-ны 11 мянга гаруй оршин суугч коммунист намын гишүүн болжээ.

1970-аад оны эхээр боловсролын системийг сэргээн босгож эхлэв. 1975 он гэхэд ТӨЗО 4300 бага, 30 дунд сургууль, хоёр дээд сургуультай болсон байлаа. 1971–1975 онд 1200 Түвд хүн төв хятадын их, дээд сургуулиудад суралцахаар явжээ. Боловсролыг дэндүү үзэл сурталжуулсан байв. Хятадууд “хятад-түвдийн найрамдлын хэл” бий болгохын тулд Түвд хэлийг эрс өөрчлөх гэж эрмэлзжээ.[1558] Мөн Түвд хэлээр үйл ажиллагаа явуулдаг театр,

сайн дурын уран сайханчдын хэсгүүд дахин бий болов. Түвд эмнэлэгийн сургуулийг сэргээж эхэлсэн байна.[1559] Аж үйлдвэр дахин хөгжих болов. Үйлдвэр фабрик, нисэх онгоцны буудал зэрэг, ялангуяа засмал зам байгуулах ажил өрнөж, 1975 онд ийм замын урт 16 мянган км-т хүрсэн байлаа. "Чөлөөлөгдсөн" хүн амыг тээврийн, барилгын зэрэг төрөлжсөн отрядуудад албадлагын журмаар хувиарлав.[1560] Жишээ нь, Линьжигийн аж үйлдвэрийн цолболборын барилгын ажилд 10 мянган малчинг дайчилжээ.

Түвдчүүд Лхасыг "ариун газар" буюу "диваажин" хэмээн нэрлэх ажээ. Гэтэл маогийнхны хувьд Лхас нь цус сорогчдын хувьд диваажин, хөдөлмөрчдийн хувьд газар дээрх там" болж байв.[1561] Түвдчүүд хотоо өөрчлөн байгуулах болов.

Одоо тэнд усан цахилгаан станц, ноосны фабрик, цементийн завод, автозасварын газар, цэнгэлдэх хүрээлэн, театр, кино театр ажиллаж, баруун болон хойд дүүрэг хотууд аж үйлдвэрийн бүс болжээ. Лхас хотын эзлэх талбай хоёр дахин нэмэгдэв. Ариун гэгээн хот жирийн социалист дүр төрхтэй болов.

Барилга байгуулалт болон. уурхайн ажилд оролцуулахаар хятад ажилчид олноор нь авчирах болов. 1970-аад оны эхээр ТӨЗО-нд хятад ажилчдын тоо 100 мянгад хүрэв. Засгийн газар хан үндэстнүүд шилжин суурьшихыг идэвхтэй хөхүүлэн сайшааж байлаа. Жишээ нь, армид алба хаасан цэргүүдийг "үндэсний районууд" руу явуулах суртал ухуулга хийж байлаа. Хятадын их, дээд сургууль төгссөн олон хүн "чөлөөлөгдсөн боолуудад хүчин зүтгэхэд бүх амьдралаа зориулж", Түвдэд суурьших хүсэлтээ илэрхийлж байв.[1562] Бусад "үндэсний хязгаар нутгуудад", жишээлэхэд Өвөр Монголд тийм уусгах бодлого баримталжээ. Холимог гэр бүлүүдийг сурталчлан магтана. Хятад эрчүүд Түвд бүсгүйчүүдтэй гэрлэж болдог ч, Түвд эрчүүд хятад эхнэр авах хориотой байсан гэж дүрвэгчид ярьсан байдаг юм. Төрийн албанд ажилладаг түвдчүүд ямар ч түвд эхнэр авч болох, харин албан хаагч түвд бүсгүй төрийн албанд ажилладаггүй түвд эртэй сууж болохгүй ажээ. Түвд бүсгүйчүүдийг хятад хүний эхнэр болгохын тулд хүчээр гэрлүүлэх тохиолдол ч гарч байв.[1563]

Соёлын хувьсгалыг зохион байгуулагчдын нэг бөгөөд Мао Зэдуныг залгамжлагч хэмээн зарлагдсан хүн бол Линь Бяо билээ. Тэрээр 1970 оны эхээр бараг бүх улс төрийн товчоотой хэрэлдэж, 1971 онд БНХАУ-аас нисэх онгоц хөлөглөн гарч, зам зууртаа БНМАУ-д унажээ. 1973 оны наймдугаар сард Бээжинд ХКН-ын X их хурал болов. Линь Бяог хөрөнгөтний албан тушаал хөөцөлдөгч, хутган үймүүлэгч, урвагч, хувьсгалын эсэргүү этгээд

гэж зарласан байна. Соёлын хувьсгалд ёс журам гажуудуулсан явдал гарч байсны хариуцлагыг түүнд тохжээ. "Линь Бяо болон Күнзийг шүүмжлэх" ээлжит кампанит ажил өрнүүлэв. Күнз ард түмэн төрийн үндэс болдогийг, үе үеийнхэн залгамж шинж чанартай байдгийг, залуучууд ахмад настнаа хүндэтгэх явдал чухал болохыг хүлээн зөвшөөрснөөрөө Маогийн сэтгэлд нийцээгүй ажээ. Гэхдээ маогийнхан түүний хятад төвт үзэл баримтлалыг хадгалан үлджээ.[1564] Гэтэл 1973 оноос эзэн хаан Ин Жэнийг (Цинь Шихуан, манай эриний өмнөх 259–210 оны үе) шагшин магтах болов. Энэ хаан. "судар ном шатааж, эрдэмтэн мэргэдийг булж байснаараа" нэрд гарсан нэгэн бөгөөд түрүүчийн эрх баригчдын замаар явахгүй гэсэн ажээ.[1565] Одоо дарга Мао энэ эзэн хаантай төстэй байсныг харуулахын тулд магтан сайшаасан өгүүллүүд олноороо гарах болжээ. Ин Жэний бүхнийг эрх мэдэлдээ байлгаж, Хятадыг нэгтгэж, ард олныг хүчирхийлэх замаар төр удирдаж, хөрш зэргэлдээ орнуудын эсрэг түрэмгийлэл үйлдэж байсан үйлдэл Маогийн сэтгэлд бүрэн нийцжээ. Тэр жилүүдэд хятадын хэвлэл монголчуудын өвөг–хүннү нарын эсрэг дайтаж байсан эртний хятад жанжнуудын "гавьяаг" онцлон тэмдэглэж байв.[1566] Нүүдэлчин хүннү нартай найрамдлын гэрээ байгуулах гэсэн күнзийнхнийг "улс төрийн харгис холбоо байгуулахыг" эрмэлзсэн хэмээн буруутгаж байв. Үүний зэрэгцээ мөн хүннү нарыг түүхэн үүднээс бол Хятадын ард түмнүүдийн нэг байсан гэж нотлохыг эрмэлзэж байв.

Соёлын хувьсгалыг зохиогчид шинэ кампанит ажлыг дайснуудаа залхаан цээрлүүлэхэд ашиглажээ. "Үндэсний цөөнхүүдийн" дунд явуулах суртал ухуулгын ажилд хятад биш ард түмнүүд болон хятадуудын "нэгдэл нягтралыг хүчтэй болгох", "ангийн дайсантай" тэмцэх, Соёлын хувьсгалыг үндэсний хязгаар нутгуудыг цэцэглүүлэн хөгжүүлэх зам хэмээн магтан сайшаах явдал гол зорилго болж байлаа.[1567] Түвдэд энэ кампанийг: "Күнз, Линь Бяо, Далай лам бол нэг л хийдээс гарсан гурван лам мөн" гэсэн уриан дор явуулжээ.[1568] Арван дөрөвдүгээр Далай лам болон түүний "бүлгийг" гадаад талын аюул, X Банчин лам болон түүний талынхныг дотоод аюул гэж дүрслэн харуулж байв. Банчин ламыг таван жил шоронд хоригдож байх үед шүү дээ.

Түвдэд партизанууд ажилагаагаа зогсоогоогүй. Партизаны отрядуудыг бүгдий нь америкийн тагнуулын төв газар зохион байгуулж, шаардлагатай бүх зүйлээр хангаж байсан юм бишээ. ТӨЗО-ны хэд хэдэн районд мянгаад хүнтэй бие

даасан отрядууд үүсэн байгуулагдаж байлаа. Тэд цэргүүд, эрх баригчдын төлөөлөгчдөд халдаж, зам харилцаа, цэргийн обьектуудад

халдах ажээ. Нэг мянга гаруй цэргийн албан хаагч болон кадр ажилтнууд алагдаж шархадсан байна. Жишээ нь, 1966 оны сүүлч, 1967 оны эхээр ТӨЗО-нд орон нутгийн эрх баригчдын эсрэг бослого гарч, түүнд 7 мянган хүн оролцсон байна.[1569] 1968 оны зургадугаар сарын эхээр Софу, Чумай, Зянба болон бусад газарт 3 мянга гаруй Түвд хүн босов. Тэд 200 гаруй кадр ажилтны амь насыг хөнөөсөн байна. Гэзы, Цаламод нэг мянга гаруй Түвд хүн цэргийн ангид халдаж, 300 гаруй цэрэг зоджээ. Наймдугаар сард Өмнөд Түвдийн цэргийн нэгэн анги халдлагад өртсөний улмаас 250 цэрэг алагдаж, цэргийн есөн машин шатсан байна. Аравдугаар сард өлсгөлөн түвдчүүд Шигазейн хүнсний агуулахад халджээ. 100 цэрэг, мөн төдий тооны Түвд хүн алагдсан байна. Арванхоёрдугаар сарын эхээр долоон гацаанд үймээн дэгдэж, коммун байгуулах ажил хийж байсан олон арван ажилтан амь үрэгджээ. 1968 оны сүүлчээр Жагу, Ванрин гацааны 2 мянга гаруй малчин цэргийн анги болон бусад байгууллагад халдсан байна. 100 цэрэг болон кадр ажилтан алагдаж шархаджээ.

1969 онд Ньемо гацааны залуу гэлэнмаа Тинлей Чойдон домогт баатар Гэсэртэй холбоо бүхий бурхан тэнгэр миний сэтгэл зүрхэнд шингэсэн бололтой байна хэмээн ард олонд зар тарааж сэлэм, жадаар зэвсэглэсэн тариачдыг цуглуулж, орон нутгийн засаг захиргааны байгууллагад халдав. Удалгүй энэ бослого өргөжиж 18 тойргийг хамарчээ. Бас ихсийн сүнс орж гараад байх боллоо гэж зарласан хэд хэдэн хүн гарч иржээ. Босогчид хятад түшмэд болон тэдэнтэй холбоо бүхий Түвд кадр ажилтнуудын заримыг цаазалж, заримынх нь гарыг тас цавчжээ. Одоо эдгээр гэрчийн баримтуудыг Ньемогийн музейд тавьжээ. Нямдрелагийн кадр ажилтнуудыг устгаж, эрх мэдлийг гартаа авахыг эрмэлзсэн Гьенлогийн бүлэг дээрх бослогыг ашиглав. Чойдон болон түүний талын 15 хүнийг олон нийтийн өмнө цаазлахаар Лхаст хүргүүлэв. Одоо энэ хэрэг явдлыг сайтар баримтжуулжээ[1570] Энэ бол шашны болон ертөнцийн төгсгөлийн тухай үзэл баримтлалтай холбоо бүхий тариачдын үндэсний эрх чөлөөний тэмцлийн нэг хэсэг байсан бөгөөд түүнийг өөр хоорондоо дайсагнагч бүлгүүд ашигласан юм гэсэн дүгнэлт хийж болох юм. Соёлын хувьсгал үнэт зүйлсийнхээ уламжлалт системд хандах түвдчүүдийн итгэлийг үгүй болгосон юм гэж Ц. Шакья оножтэмдэглэсэн байна.

1970 оны тавдугаар сарын 1-нд 200 морьтой хүний отряд Мазянзуний автостанцийг эвдлэн шатааж, Лхас, Шигазегийн цахилгаан холбооны шугамыг таслав.[1571] Партизанууд Мазянзун, Емозун суурингуудыг хэдэн өдөр мэдэлдээ байлгав. Орон нутгийн тариачид хүнсний агуулахуудыг

эзэлж, хөдөө аж ахуйн багаж хэрэгслийг хувааж авсан байна. 1970 оны тавдугаар сард 800-гаад Түвд хүн Лхас хотоос баруун тийш байрлах Чемогийн гарнизоныг бүслэж, бууджээ. 150 цэрэг алагдав. Түвдийн 12 хүнтэй отряд Энэтхэг, Бутан, Балбатай залгаа хил дээр 1962-оос 1970 оныг дуустлах хугацаанд хятадын цэргийн ангиудад халдаж байжээ. Энэ одряд эзлэгдсэний дараа дөрвөн Түвд хүнийг цаазлаж, бусад нь зургаагаас хорин жил хүртэл шоронд хоригдох ял авсан байна. 1970 оны зун Түвдийн баруун өмнөд нутагт гарсан бослогын үеэр нэг мянга орчим хятад цэрэг алагджээ.[1572] Хятадууд бослогыг дарж, 124 хүн цаазалсан байна. Мөн онд Дорнод Түвдэд коммун байгуулсныг эсэргүүцсэн бослого гарсан байна. “Босогчид” хамгаалалт муутай цэргийн тээвэр болон эргүүлүүдэд халджээ. Лхас, Динри болон бусад хотод нууц бүлгүүд ажиллаж байлаа.

1969 оны сүүлч, 1970 оны эхээр ТӨЗО даяар олон нийтийг хамарсан баривчилгаа явуулж, зарим хүний хэргийг олны өмнө шүүн тасалж, буудахы нь бууджээ.[1573] Гьенлогийн дээрмийн бүлгийнхнийг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон ард түмний эсэргүүцлийн ажиллагаатай хамт даржээ. Жишээ нь, 1970 оны нэгдүгээр сард Лхаст болсон олон нийтийн цуглаан дээр “Түвдийн тусгаар тогтнолын төлөө тэмцлийн байгууллагын” гишүүн 9 охид, хөвгүүдийг, мөн оны зун Шигазед 25 хүн буудан хороожээ.[1574] Өөр олон хүн 20–30 жил шоронд хоригдох ял авчээ. Мөн оны хоёрдугаар сард Лхас хотод болсон цуглаан дээр 123 хүн, өөр хэдэн газарт 20-оос доошгүй хүн буудан хороосон байна. 1970 оны аравдугаар сард Лхаст 20 залуу цаазлуулжээ.[1575] Тэдний гэр бүлийнхэнд цаазлах үед тэнд байж, дараа нь эрх баригчдад баяр хүргэхийг тулган хүлээлгэсэн байна.

Байшингуудын ханан дээр шүүгдэж буй хүмүүсийн дүр, үйлдвэрийн газрын ажил тасалдуулсан, коммун байгуулахыг эсэргүүцсэн, дүрвэгчдэд тусласан зэрэг “гэмт үйлдлүүдийнх” нь жагсаалтыг хавсаргасан ухуулах хуудсууд наах ажээ.[1576] Партизаны хөдөлгөөнийг тамирдуулахын тулд Энэтхэг, Балбатай залгаа хилийн дагуух 100 милийн бүсэд оршин суухыг түвдчүүдэд хоригложээ. Үүний зэрэгцээ хятад цэргүүдийн тоо нэмэгдэж байлаа. 1970-аад оны эхээр тэдний тоо 400 мянгад хүрсэн байна.[1577]

Мао Зэдун өөрөө хилийн чанадаас дэмжсэн дайны тусламжтайгаар засгийн эрхэнд гарсныг дурдах нь зүйтэй бизээ. Үүний дараа маогийн үзлийг Энэтхэг, Бирм, Балба, Бутан, Перу, Филиппин болон бусад олон оронд экспортолжээ. “Хятад улс дэлхийн хувьсгалын улс төрийн төв төдийгүй цэрэг,техникийн хувьд дэлхийн хувьсгалын төв болсон юм. Тэдэнд зэвсэг өгөх хэрэгтэй, одоо бид ил шууд зэвсэг өгч чадна. <...> Хятад

улс дэлхийн хувьсгалын зэвсгийн сан болох ёстой" гэж Мао хэлжээ.[1578] Тэр үеэс хойш нийт дэлхийн хэмжээнд маогийнхны нууц ажиллагааны дүнд хэлмэгдэгчдийн тоо хэдэн зуун мянгад хүрчээ. Хятад улс энэтхэгийн нага, мизо омгийнхны салан тусгаарлах зэвсэгт хөдөлгөөнд тусламж үзүүлжээ. 1970–1980-аад онд тэдгээр омгийн удирдагчид Бээжинд байж, тэндхийн намын сургуульд явж, харин дайтагчид нь хятадад бэлтгэл сургууль хийжээ.[1579] Гэтэл Мао болон түүнийг залгамжлагчид түвдчүүдийн эсэргүүцлийг хилийн чанадаас зохион байгуулсан үйл ажиллагаа хэмээн буруушааж байна.

Гэтэл орчин үеийн олон улсын эрх зүйн зарчмаар бол партизаны дайн нь түрэмгийлэгч этгээд, колонийн хараат байдал, гадаадын эзэгнэлийн эсрэг тэмцлийн зүй ёсны хэлбэр мөн юм. Тухайлбал 1949 оны наймдугаар сарын 12-ны Женевийн конвенцийн нэгдүгээр нэмэлт протоколын 43(1) зүйлд зааснаар "сөргөлдөөнд байгаа талын зэвсэгт хүчин нь мэдэлд нь байгаа хүчнүүдийн зан байдлын төлөө энэхүү Талын өмнө хариуцлага хүлээх этгээдийн командлалд байгаа бүх зохион байгуулалттай зэвсэгт хүчин, бүлэг, салбаруудаас бүрдэнэ, энэхүү тал нь эсрэг талын хүлээн зөвшөөрөөгүй засгийн газар буюу эрх мэдлийг төлөөлдөг байх нь үүнд нөлөөлөхгүй" юм.[1580] Хувьсгалчдад энэ эрх хамаарахгүй, яагаад гэвэл тэд гадаадынхантай биш, харин өөрийнхөө засгийн газартай байлдаж байгаа юм.

БНХАУ-тай эдийн засгийн харилцаа тогтоосноос нь хойш АНУ түвдийн партизануудад туслахаа больжээ. Америктай харилцаагаа сайжруулж, түгшүүртэй байдлыг дэвэргэсэн гэж ЗСБНХУ-ыг шүүмжилж байсан Мао Зэдун өөрөө өрнөдийн империализмын энэхүү түшиг тулгууртай нягт харилцаа тогтоож, Япон, ХБНГУ-тай хамтран ажиллаж эхэлжээ. 1971 оны долдугаар сард АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Г. Киссинжер ерөнхийлөгч Р. Никсоны айлчлалд бэлтгэхийн тулд Пакистанаар дамжин Бээжинд нууцаар айлчилсан юм. Жоу Эньлай 1972 оны долдугаар сарын 8-нд америкийн конгрессийн гишүүн Х.Боггс, Ж.Форд нартай уулзахдаа дэлхийн тавцанд АНУ байх явдал чухал ач холбогдолтой, яагаад гэвэл энх тайван, тогтвортой байдлын эх сурвалж болж байгаа юм гэж мэдэгдсэнийг энэ хоёр хүн хожим дурссан байна.[1581]

АНУ-ын удирдлага БНХАУ-тай харилцаа тогтоомогцоо тухайн үедээ Их Британий эрх баригчид шиг Түвдээс нүүр буруулсан юм. Үүнээс өмнө түвдчүүдэд үзүүлсэн материаллаг дэмжлэг нь түвдийн тусгаар тогтнолыг сэргээн тогтоох биш, БНХАУ-д шахалт үзүүлэх, дипломатын тоглолт хийх

зорилготой байсан нь америкийн нууц байсан баримт бичгүүдээс тодорхой болсон юм.[1582] Ийнхүү АНУ партизануудыг санхүүжүүлэхээ зогсоов. Мустан ванлигт байсан тус улсын бааз үгүй болов. 1974 оны долдугаар сард Далай лам түвдийн партизануудад хандаж 20 минут үг хэлэхдээ зэвсгээ хураалгахыг тэдэнд уриалсан билээ.[1583] Энэ нь олон хүний хувьд драм болж хувирсан юм. Зарим хүн амиа хорлов. Зэвсэгт тэмцэл зогсов.



Найз бүсгүйтэйгээ хамт Энэтхэг рүү оргох гэж яваад баригдсан залуу. “Дээрэмчдийн бүлгийн толгойлогч” – Лхас хотын дунд сургуулийн 66-р бүлгийн сурагч Дэн Зиньмэй. Түүний найз бүсгүйд Энэтхэг рүү оргох гэсний төлөө 20 жил хорих ял оноожээ. Шоронд түүнийг хүчирхийлсний дараа тэрээр амиа хорложээ (Woeser, 2006/permission from Woeser)

1970-аад онд Соёлын хувьсгал эхнэлснээс хойш анх удаа Түвдэд нилээд шилж сонгосон гадаадын сэтгүүлчид оруулав.[1584] Тэр үеэс хойш өрнөдийн хэвлэлд хятадын тухай нийтлэлүүд дахин хөвж эхэлсэн бөгөөд эдгээр нийтлэлд ашиглах мэдээллийг маогийн эх сурвалжуудаас авчээ.[1585] Түвдэд гадаадынхны хийх бүх аялалыг урьдаас боловсруулсан хөтөлбөрөөр зохион байгуулах болсон бөгөөд зочид төлөөлөгчдөд “хөтөч” нар их л элдгээр үйлчилж, зориудаар сонгож авсан түвдчүүд урьдаас бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу ажиллана.[1586] Дахиад л “боолууд”,”хамжлагын эздэд хэлмэгдэгчид”-ийн гэрчүүд, “хүнээр тахил өргөж байсан” тухай,”түвдийн соёлын цэцэглэл хөгжлийн” тухай түүхийн гэрчүүд гарч ирнэ. П. Френчийн тодорхойлсноор “оюун ухааны янхан явдлын” энэхүү урсгал 1980-аад онд бараг дууссан боловч дараа нь дахин сэргэжээ. 1950-аад оноос өнөөг хүртэлх энэ төрөл жанрын “гарамгайчууд”, жишээ нь А.-Л. Стронг, А.Т. Грюнфельд, М. Паренти нар суртал нэвтрүүлэг, аман зохиол, үлгэр домог, санаанаас зохиосон зүйл, зарим бодит гажуудал, ер нь хуучин Түвдийн тухай олж авсан аль муу муухай бүхнээс бүрдсэн бөгөөд маш нарийн бодож боловсруулсан холион бантанг түүх болгон харуулахыг эрмэлзэж иржээ.[1587] Сүүлийн үед хуучин ЗСБНХУ-д ч тийм суртал нэвтрүүлэг бий болжээ.

Сүүлийн хэдэн арван жилд түвдчүүдэд хувь хүмүүс, Нийгэм-нөөцийн

хөгжлийн сан, Түвдийн хүрээлэн зэрэг засгийн газрын бус сангууд хүмүүнлэгийн тусламж үзүүлж байна. Түвдийн цагаач засгийн газар, Энэтхэгийн засгийн газар, олон улсын хандивлагчид 1959-өөс 1992 оныг дуустлах хугацаанд түвдийн дүрвэгчдийн боловсролд 1,5 тэрбум гаруй энэтхэг рупийн хөрөнгө оруулжээ.[1588]

Түвдийн цагаач засгийн газар төсвийнхөө 65 хувийг түвд хүүхдүүдийн боловсролд зориулсан байна. Лам нарыг сургах их зардал үүнд ороогүй юм. Түвдийн цагаач засгийн газрын төсөв үндсэндээ дүрвэгчдээс ирдэг шимтгэлээс бүрддэг бөгөөд дүрвэгчдийн олонхи нилээд амжилттай бизнес эрхлэгчид болсон байна. Бээжингийн суртал нэвтрүүлэгчид, хилийн чанад дахь тэдний туслагч нар түвдийн цагаач засгийн газар хичнээн хэмжээний мөнгө хаанаас, ямар зорилгод авч байна гэдгийг тооцон гаргах гэж махран зүтгэж байгаа ажээ.[1589] Гэвч хэрэв засгийн газар хууль ёсных бол ард түмнээсээ ч, хилийн чанадаас ч хөрөнгө мөнгө авах эрхтэй юм.

Энэтхэг, Балбад олон түвд сургууль бий болжээ. Дарамсалад Түвдийн анагаах ухаан, одон орон судлалын хүрээлэн, Түвдийн зохиол бүтээл болон архивын номын сан, Түвдийн театрын урлагийн дээд сургууль, Түвд урлагийн Хэвлэлийн төв нээжээ. Түвдийн соёлын байгууллагууд энэтхэгийн бусад хотод ч байгуулагдах болов. Залуу цагаач иргэд дээд, түүний дотор их сургуулийн боловсрол эзэмшиж эхэлжээ. Хурал зөвлөлгөөн, бага хурал,бусад арга хэмжээ зохиож байна. 1970-аад онд Түвдийн цагаач засгийн газар “хилийн чанадаас Түвд хэлээр түвдийн дотоодын районууд руу радио нэвтрүүлэг явуулж эхэлсэн бөгөөд маш олон гүжир гүтгэлэгийг санаанаас зохион тарааж, улс төрийн өдөөн хатгалага хийж, салан тусгаарлах үзэл дэвэргэж байна.”[1590]

БНХАУ-ын эрх баригчид Түвд дэхь соёлын хувьсгал, бослого хөдөлгөөний тухай хилийн чанадад бага мэдэж байх нь дээр гэж үзэж байна. Мао Зэдун хүртэл суртал нэвтрүүлэгт бүх зүйл сайн байгаагүй: 70 хувь нь зөв, 30 хувь нь алдаа байсныг хүлээн зөвшөөрч байжээ. Тэрээр бүр 1949 онд намын хороодын ажлын арга барилын тухай ярихдаа: “Жишээ нь, амжилт хэдэн хувийг эзэлж байна, 30 уу, аль эсвэл 70 уу? Багасгах ч, өсгөх ч хэрэггүй” гэсэн дүгнэлт хийжээ”.[1591] Мао 1956, 1957 онд Сталины үйл ажиллагааг 70 хувь сайн, харин 30 хувь муу гэж нэрлэжээ.[1592] Тэрээр 1958 оны долдугаар сарын 31-нд Хрущевтэй өөрийнхөө нээлтийг санал солилцож хэлэхдээ: “Сталины 10 хурууны гурав нь илжирсэн юм билээ гэжээ”.[1593] Мөн1973 оны арванхоёрдугаар сарын 15-нд Дэн Сяопиний ололт, алдааны харьцаа 70, 30 байсныг илрүүлжээ.[1594] Өнөө үед Маогийн өөрийнх

нь үйл ажиллагааг БНХАУ-д 70 хувь сайн, 30 хувь муу гэж зарласан байна. Хаяагүй нэг адилын нууц хувь... Энэ тоог яаж тооцож гаргасан юм бол? Энэ дугаарлалтын эх сурвалж нь хамгийн анхны “мэргэн” дүгнэлт байж болох уу?

Дэлгэрүүлж тайлбарлах учиртай өөр тоо баримтууд ч бий юм. Түвдийн цагаач засгийн газрын мэдээгээр бол 1949-өөс 1979 оныг дуустлах хугацаанд шорон гянданд улс төрийн мөрдлөг хавчлага явуулснаас болж, бас эрүү шүүлт, өлсгөлөнгөөс болж 1,2 сая гаруй Түвд хүн нас барсан бөгөөд Энэтхэгийн хуарангуудад хэт халуун уур амьсгал болон элдэв өвчнөөс болж олноороо нас барсан түвдчүүдийг энэ тоонд оруулаагүй юм. Энэ тоог зарим зохиогчдын зүгээс шүүмжилдэг юм.[1595]

БНХАУ-ын албан ёсны байр суурь бол үнэн хэрэгтээ “энх тайванч чөлөөлөлтийн” үед түвдийн хүн ам 1 сая орчим байсан, харин одоо 2,3 сая гаруй болсон, ингэхлээр 1,2 сая хүн үгүй болсон байх учиргүй гэдэгт оршиж байгаа юм.[1596] Энэ бол тийм биш: хятадуудын нэрлэж буй албан ёсны тоо бол ТӨЗО-нд л хамаарах бөгөөд 1,2 сая гэдэг нь Их Түвдэд оногдох нийт хохирол юм.

Түвдийн тал БНХАУ-ын статистикийн газрын мэдээг иш татахдаа хохиролыг тоолж эхлэхэд баримтлах учиртай түвдчүүдийн нийт тооны тухай дараах мэдээллийг гаргаж тавьдаг юм. 1959 оны арваннэгдүгээр сард ТӨЗО-нд нийтдээ 1273969 хүн байсан, гэхдээ хөрш зэргэлдээх хятад мужуудад хүчээр нэгтгэсэн түвдийн нутгуудад үүнээс хамаагүй олон Түвд хүн амьдарч байсан ажээ. Зарим байдлаар Сикан болж зохион байгуулагдсан Камд 3381064 Түвд хүн байжээ. Хөх нуур муж, мөн Ганьсу мужид нийлүүлсэн Түвд нутгуудад (өөрөөр хэлбэл Амдо) 1675534 түвд хүн оршин сууж байв. Ингээд нийтдээ 6330567 түвд хүн болж байна [1597] 1959 онд хамаарах эдгээр тоо баримтыг 1953 онд явуулсан хятадын хүн амын тооллогын дүнгээс авсан юм (хүн амын дараачийн тооллого 1964 онд болжээ). Түвдийн тал дээр дурдсан тоо баримтыг тайлбарлахдаа дараах алдааг гаргажээ.

1954 онд нийтлэгдсэн хятадын хүн амын 1953 оны тооллогын албан ёсны дүн энэ байна.[1598] БНХАУ-ын янз бүрийн ястны төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтад түвдчүүдийн нийт тоо 2775622 гэжээ. Нийт хүн амыг (зөвхөн түвдчүүд биш) муж мужаар нь хувиарласан хүснэгтэд “Түвд,Чамдод” (ирээдүйн ТӨЗО) 1273969 хүн, Сикан мужид[1599] 3381064, Хөх нуур мужид 1676534 хүн оршин сууж байна гэж заасан байна.[1600] Хэрэв дээрх мужууд болон ирээдүйн ТӨЗО-оор гаргасан эдгээр тоог нийлүүлбэл 6331567 хүн

гэсэн тоо гарч байна.[1601] Гэхдээ дээрхи нутгуудад зөвхөн түвдчүүд сууж байсан, одоо ч сууж буй хэрэг биш бөгөөд мужуудаар бодож гаргасан тоонд бүх ард түмнүүд хамрагдаж байгаа юм. Ингэхлээр Түвд эх сурвалжид түвдчүүдийн тоог өсгөн тавьжээ.

Хэр зэрэг өсгөсөн юм бол? Хятад тоо баримтыг хүлээн зөвшөөрөх нь арай илүү болов уу, ер нь ч ингэдэг билээ. Гэхдээ эдгээр мужийн үндэсний бүрэлдэхүүнийг харгалзан үзэх үндсэн дээр харьцуулалт хийж болох юм. 1953 оны хүн амын тооллогын жинхэнэ яс мэдээлэл би олж чадаагүй ч нилээд хожуу үеийн тоо баримт байна. Мэдээжийн хэрэг энэ нь янз бүрийн үед хийсэн хүн амын тооллогын янз бүрийн арга, 47 жилийн дотор хүн амын бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлт зэргээс үүдсэн алдаа мадагт хүргэж болно. Гэсэн ч энэ алдаа бусад харьцуулалтынхыг бодоход тэгтлээ их байхгүй биззээ.

2000 оны хүн амын тооллогын мэдээгээр ТӨЗО–нд түвдчүүд хүн амын 92,8 гаруй хувийг эзэлсэн байна. 1959 он хүртэл тэнд өөр хүн ам бараг байгаагүй билээ. Тийм болохоор "Түвд ба Чамдогийн" нийт хүн амыг түвдчүүд хэмээн үзвэл -1273969 болохнээ. Хөх нуур (22,5%), урьд өмнө Сиканд орж байсан Сычуаний Түвд тойргууд (65,22%) дахь түвдчүүдийн эзлэх хувийг мөн 2000 оны хүн амын тооллогын дүнгээс авч болно.[1602] Цаашилбал хэрэв эдгээр хувийг Сикан, Хөх нуурын 1953 оны хүн амын нийт тооноос хасвал энэ хоёр нутагт 2205130 ба 377220 Түвд хүн оршин сууж байсан тоо гарч байна.

Гэвч XX зууны эхээр Амдогийн түвдчүүдийн тоог барагцаалбал 500 мянга гэж дүгнэсэн байдаг юм.[1603] 1993 оны "Хөх нуур мужийн долоо хоног дутмын мэдээлэлд" 1957 онд тэнд 513415 Түвд хүн, 1996 оны "Жил дутмын мэдээлэлд" 486269 Түвд хүн байсан гэж бичсэн байна.[1604] Хөх нуурын тухайд миний тооцож гаргасан тоо буурсан байгаа, яагаад гэвэл 2000 он гэхэд тэнд түвдчүүдийн эзлэх хувь хятад шилжин суурьшигчид олноор ирснээс болж буурсан байж болно. Мөн энэ шалтгаанаар Сикантай холбоотой тоог ч буурсан хэмээн үзэх хэрэгтэй. Хэрэв энэ доошилсон тоог 1273969 дээр нэмбэл 3479099 хүн гэсэн дүн гарна. Ингэхлээр 1953 оны хүн амын тооллогын дүнд өгүүлсэн шиг 2775622 Түвд хүн биш, илүү олон байсан болж таарна. Би Ганьсу, Юннань мужуудын Түвд хүн амыг тооцож үзээгүй байхад л ийм тоо гарч байгаа бөгөөд 2000 онд эдгээр нутагт хагас сая гаруй Түвд хүн оршин сууж байлаа. Тийнхүү логик үүднээс харьцуулан авч үзвэл 1953 оны түвдчүүдийн нийт бодит тоо 3479099-өөс их болохнээ.

XX зууны эхний хэдэн арван жилд түвдчүүдийн нийт тоо 4–5 сая байсан

гэж Ч. Белл,[1605] П.К. Козлов[1606] нарын дурдсан тоонууд үнэнд нилээд ойрхон байна. Канадын засгийн газрын үндэсий батлан хамгаалах газрын 1950 оны аравдугаар сарын 6-ны нууц илтгэлд үүнтэй төстэй тоо баримт дурджээ. Тэр илтгэлд ирээдүйн ТӨЗО-ны түвдчүүдийн тоог 1,5–2 сая, Сикан, Хөх нуурынхыг 2 сая хэмээн дүгнэсэн байна.[1607] Нийтдээ 3,5–4 сая болж байна. Энэ тоо миний гаргаж буй тооцоонуудтай нийлж байгаа юм. Түүнээс гадна дээрх тоо XX зууны эхээр түвдчүүдийн тооны харьцаа буурсантай тохирохгүй, харин хүн амын тооллогын дутуу дүгнэлттэй тохирч байгаа юм.[1608] Их Түвдэд 1953 он гэхэд хүн амыг бараг хоёр дахин хорогдуулахаар үйл явдал болоогүй билээ. Харин ч XX зууны эхнээс 1950 он хүртэл хүн амын зүй ёсны өсөлт ажиглагдсан байна.

Тийнхүү бүх зүйлээс харахад түвдчүүдийн нийт тоо 1953 он гэхэд 4 саяас нилээд давсан байжээ.

БНХАУ дахь түвдчүүдийн гурван удаагийн тооллогын (1953, 1964, 1982) дүн яг зөв бишийг тэмдэглэх хэрэгтэй юм. Гэр бүлийн бүртгэл болон анкет бөглүүлсэн дүнд үндэслэн дээр дурдсан тоонуудыг гаргажээ.[1609] Хятадын эх сурвалжаар бол “Түвд болон Чамдогийн районд хүн амын тооллого яс хийгээгүй, тэр үеийн Далай ламаар удирдуулсан түвдийн орон нутгийн засгийн газар л багцаалсан тооллого хийж, төв засгийн газарт хүн амынхаа тооны тухай мэдээлжээ”.[1610] Цааш нь авч үзвэл БНХАУ-ын нэг байгууллага гэхэд л янз бүрийн үед янз бүрийн тоо гаргаж өгсөн байх юм. Би сая Хөх нуурын Түвд хүн амын тооны тухай хятадын өөр хоорондоо зөрчилдсөн тоо баримтуудыг дурдлаа. 1953 оны тооллогоор бол ирээдүйн ТӨЗО-нд 1,274 сая түвдчүүд байсан бол 1959 онд энэ тоог 1,18 сая болтол,[1611] 1991 онд 1,05 сая хүртэл[1612] тус тус бууруулжээ. 1959 оноос хойшхи хүн амын хохиролыг “багасгахын” тулд л эдгээр тоог өөрчлөөд байсан юм биш байгаа?

Хятадын эзэгнэлээс болж 1949–1979 онуудад түвдийн хүн амын хохиролын тухай түвдийн талын мэдээг дараах хүснэгтэд үзүүлэв:[1613]

| Үхлийн шалтгаан | У-Цанг | Кам | Амдо | Нийт |
|---|---|---|---|---|
| Шоронгийн эрүү шүүлт | 93560 | 64877 | 14784 | 173221 |
| Цааз | 28267 | 32266 | 96225 | 156758 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тулалдаанд амь үрэгдэх | 143253 | 240410 | 49042 | 432705 |
| Өлсгөлөн | 131072 | 89916 | 121982 | 342970 |
| Амиа хорлох | 3375 | 3952 | 1675 | 9002 |
| Зодуулах | 27951 | 48840 | 15940 | 92731 |
| Нийтдээ | 427478 | 480261 | 299648 | 1207387 |

Энэхүү хүснэгтэд орсон тоо баримтуудыг Далай ламаас Түвд рүү илгээсэн албан ёсны төлөөлөгчдийн баримт бичиг, мэдээлэл, түвдийн цагаач засгийн газрын тусгай комиссийн зохин байгуулсан дүрвэгчдийн санал асуулгын дүнд үндэслэн тогтоов. Түвдэд байхдаа тухайн үеийн үйл явдлуудад оролцож явсан хүмүүсийн гэрч нотолгоо эдгээр тоо бартимтын үндэс болсон байна.

Хүн ам зүйн олон мэргэжилтэн эдгээр тоог яг зөв хэмээн үздэггүй ажээ. Ямар нэгэн дүгнэлтийг санал асуулгын дүнгээр хийж болохгүй, тэр дундаа түвдийн дүрвэгчид улс төрийн шалтгаанаар өсгөсөн тоо хэлж өгнө гэж хүн ам зүйн судлаачид үзэж байна.[1614] Хэрэв ингэж үзвэл БНХАУ-д оршин суугаа түвдчүүд эрх баригчдаас эмээхдээ бас л бууруулсан тоо хэлдэг болж таарна. Ингэхлээр ерөөсөө түвдчүүдийг сонсох хэрэггүй юу? Энэ хандлагыг баримтлагч зарим хүнд аймаглан устгах үйлдлийг няцаах үзэл тэр хандлагад үндэслэдэг бөгөөд ийнхүү устгасан тухай бүрэн баримтууд нийтлэгдээгүй, гол төлөв гэрчийн мэдүүлэг л байдаг, гэхдээ эдгээр мэдүүлэг ихэнх тохиолдолд өөр хоорондоо зөрчилтэй байдгийг сануулах нь зүйтэй бизээ. Ерөөс томоохон хохиролуудыг яг үнэнээр нь гаргасан түүх үгүй билээ. Тэрч байтугай, дэлхийн хоёрдугаар дайнд ЗСБНХУ, Германы хүлээсэн хохирол ч маргаантай, бусад олон орны хүн амын хохиролыг ч XX зуун хүртэл тооцон гаргаж чадаагүй байна.

Дарамсалагийн архивуудад надад үзүүлсэн материалууд 1,2 сая гэдэг тоог батлаагүй: давхардсан тоонууд байсан, зарим баримтыг олж өгч чадаагүй, янз бүрийн мэдээлэгчдийн өгсөн нэг үйл явдлын тухай мэдээллүүд зарим тохиолдолд янз бүр байсан, эмэгтэйчүүдийн хохиролын тоог дарагдуулсан байсан гэж П. Френч бичжээ.[1615] “Бүх зүйлээс харахад” статистикийн мэдээлэлд тохиолдлын тоонууд оруулж, магадлаагүй баримтуудыг давтаж, хойд болон зүүн түвдийн хүн бага суурьшдаг зарим нутгийн хохиролыг хэтэрхий дээгүүр гаргасан явдал хамгийн гол дутагдал

юм гэж тэр үзжээ.

Хэрэв гол дутагдал үүнд оршиж байгаа юм бол тийм ч их зөрүүтэй дүн гарах учиргүй. Тоо баримтын сонголтыг ямар учраас тохиолдлын гэж үзсэн юм бол, дүрвэгчдээс авсан мэдээллийг шалгах боломжгүй, яагаад гэвэл БНХАУ-д ийм мэдээлэл байх ёсгүй: Түвдийн хүн ам бага суурьшдаг нутгуудын хохирол нь янз бүрийн шалтгаанаар (оршин суугаа нутгаасаа дүрвэсэн, партизаны отрядууд үйл ахжиллагаа явуулсан, баривчлагдсан хүмүүсийг ийш тийш нь явуулж байсан зэрэг) хүмүүс тийшээ шилжин суурьшсантай холбоотой юм. Тэр дундаа 1982 онд Умард болон зүүн умард түвдэд эрэгтэйчүүдтэй харьцуулах эмэгтэйчүүдийн тоо (түвд болон хятадын бусад нутагтай харьцуулахад) өндөр байсан нь тогтоогджээ.[1616] Энэ бол 20 гаруй жилийн дараа гарсан зарим бослого хөдөлгөөнтэй холбоотой юм.Энэ нь үнэнд нийцэхгүй гэж Френчийн үзсэн тоо баримтуудтай нийлж байгаа юм. Бодит байдалд бол 500 мянган Түвд хүн амь үрэгдсэн гэж тэр үзсэн нь статистикийн хувьд мөн л үндэслэл муутай юм. Тэрээр хүн амын нийт тоог гаргахдаа хятадын статистик үзүүлэлт буюу 2,5 сая орчим гэсэн тоог үндэс болгожээ. Ингэхлээр түвдийн ард түмний 20 хувь нь амь үрэгдсэн болж таарч байна.

Бусад эх сурвалжуудад түвдчүүдийн. хохиролыг 102-оос 600 мянган хүн гэж үзсэн тоо баримт бий.[1617] Эдгээр тоог экспертүүдийн дүгнэлт болон янз бүрийн зохиогчдын баримт мэдээллийг харьцуулах үндсэн дээр гаргаж иржээ. ЗСБНХУ-д хятадын хэвлэлийн мэдээнд дүн шинжилгээ хийх үндсэн дээр түвдийн хүн ам 10 гаруй хувиар хорогдсон хэмээх дүгнэлт гаргажээ.[1618]

Загварчлах зарим арга хэрэглэснээр онц сонирхолтой үр дүнд хүрсэн байна.[1619] Энэ талаар дэлгэрүүлж ярьяа. Энэ дүнгээр бол хохирол 1,2 саяас нилээд бага тоогоор тодорхойлогддог юм. Гэхдээ янз бүрийн аргын дүн өөр хоорондоо нилээд ялгаатай, эхлэлийн тоо баримтад олон алдаа гаргасан байдаг. Тийм ч учраас зохиогч өөрөө эдгээр тоо баримтад үндэслэн 1953–1964 оны хохиролыг зөв дүгнэх боломжгүй гэж хүлээн зөвшөөрчээ.

Ян Хаогийн[1620] ашигласан хятад эрдэмтэдийн мэдээллээр бол 1953–1964 онд түвдийн хүн амын тооны өсөлт анх удаа тэр эрдэмтэдийн шинжилгээ судалгаа хийсэн хугацаанд (1953–1990 он) сөрөг үзүүлэлттэй: 9,87 хувиар, өөрөөр хэлбэл 2,775-аас 2,501 сая хүртэл буюу 274 мянгаар буурсан үзүүлэлттэй гарчээ. Харин 1982 он гэхэд хүн амын тоо 3,848 сая хүртэл буюу 53,86 хувиар өссөн байна. Тулалдаанууд болон өлсгөлөнгөөс үүдсэн гол үндсэн хохирол түвдийн цагаач засгийн газрын үздэг шиг тийм

их байгаагүй гэж Ян Хао үзсэн байна. Харамсалтай нь тэрээр өлсгөлөнгөөс, залхаан цээрлүүлэх арга хэмжээнээс болж, мөн түүнчилэн өргөн хэмжээний тулалдаануудаас үүдсэн түвдчүүдийн хохиролыг бүс нутгаар нь гаргасан тоо баримт дурдсангүй.

Хэрэв 1953 онд түвдчүүдийн тоо 4 сая байсан гэж үзэх юм бол энэ ард түмний хохирол янз бүрийн мэдээгээр гуравааc 30 хүртэлх хувь байх болж байна. Нэг зуугаас хэдэн зуун мянган хүний л "их биш" хохирол гарсан хэмээн үздэг зохиогчид 1953 онд түвдчүүдийн нийт тоог бууруулан 2,8 сая гэж үздэг нь сонирхол татаж байгаа юм.

Зарим тоо баримтуудыг энд авч үзье. Хятадын талын мэдээгээр бол Хөх нуурт 1959 онд 477994 Түвд хүн оршин сууж байсан бол 1963 онд 408132 болсон буюу 14,6 хувиар буурчээ.[1621] Ийнхүү хүн амын тоо цөөрсөн нь өлсгөлөнгөөр, тулалдаанд, шорон гянданд нас барахтай төдийгүй шилжин суурьших явдалтай холбоотой юм гэж үзэж байна. Цагаачлан гарсан хүмүүсийн дотор Амдогийн 20 мянган оршин суугч байсан хэмээн үздэг юм байна. Амдод 20 мянга орчим хүн, өөрөөр хэлбэл түвдийн цагаач иргэдийн ярьдагаас тав дахин цөөн хүн өлсгөлөнгөөр нас барсан байж болох юм гэж Б.Заутман дүгнэжээ. Түвд биш хүмүүсийг бодоход түвдчүүдийн дунд өлсгөлөн тийм ч их аймшигтай байдлаар илрэн гараагүй: түвдчүүд гол төлөв тосгонд,тархай бутархай оршин суудаг, гэтэл хурдавчилсан хөгжлийн (Их үсрэлт) эдийн засгийн схемийг хүн ам шигүү суурьшсан мужуудад хэрэгжүүлэхэд илүү хялбар байсан юм гэж Заутман үзсэн байна. Тэгвэл үүнээс л болж бүтээгдэхүүний солилцоо түвдчүүдийн тухайд илүү их зөрчигдсөн байх ёстой юм. Түүнээс гадна, амдочуудын нэг хэсэг нь Ганьсу мужид аж төрж байв. Цааш нь, Амдогийн хүн амын хорогдлыг 1959 оноос биш 1953 оноос тооцож үзэх хэрэгтэй, учир нь 1963 оноос хойш ч өлсгөлөн хэвээр үргэлжилсэн билээ. Төв Түвдэд өлсгөлөн байгаагүй гэх нотолгоо ч буруу бөгөөд үүнийг нотлохын тулд 1958, 1959, 1962 болон 1969 оны хүн амын тооны тухай дүгнэлтийг ашиглаж байна: 1953 оноос хойшхи анхны хүн амын тооллого 1964 онд болжээ.

Нөгөө талаас гэвэл Хөх нуурын (Амдо) хүн амын өлсгөлөнгөөр нас барсан хүний нийт тоог 900 мянга, Сычуаных (Камыг оролцуулаад) 9 сая гэж үздэг бөгөөд энд түвдчүүд хамгийн их хэлмэгдсэн юм.[1622] Нөхцөл байдлыг сайн мэдэх бөгөөд хятадын эрх баригчдад дундыг баримтлан ханддаг X Банчин лам хэлэхдээ Түвдэд хүн амынх нь 10–15 хувийг баривчилснаас[1623] тэн хагас гаруй нь нас барсан гэжээ. Өөрөөр хэлбэл зөвхөн ТӨЗО-нд 1959–1962 онд зөвхөн шорон гянданд 64-96 мянган хүн

нас баржээ. Энэ мэдээлэл түвдийн цагаач иргэдийн гаргаж ирдэг тоонд тун ойролцоо тусдаг юм. Банчин ламын мэдээллийг ХКН-ын нэгдсэн фронтын хэлтсийн түшмэд шалгаж үзсэн байна. 1961 оны нэгдүгээр сард шалгалтын дүнг Төв хороонд явуулсныг албан ёсоор хүлээж авсан байна[1624] Ингэхлээр дээрх тоо баримтад эргэлзэх үндэслэлгүй юм.

Гэвч чухамдаа Түвдэд онцгой хэрцгий гэсгээн цээрлүүлэлт явуулсан тухай нотолгоо үгүй юм гэж үгүйсгэх үзэлтнүүд маргадаг ажээ. Ийм байх боломжгүй, яагаад гэвэл түвдэд хятадын зэвсэгт хүчнийхэн тун цөөн тоотой байсан гэж М. Паренти үзжээ.[1625] Дайсан этгээдийн зарим хэсгийг устгаж, заримыг шоронд явуулж болохыг тэрээр мэдэхгүй байж болох юм. Б. Заутман[1626] шорон, бөөнөөр хорих лагеруудад амь үрэгдсэн 175 мянган түвдчүүдийн тухай тоо баримтыг хүлээж авахгүй байх хэд хэдэн шалтаг гаргаж иржээ. Түүний эдгээр шалтагийг хүлээж авах боломжгүй билээ. Шорон, лагерууд руу гол төлөв түвдчүүдийг явуулж, бусад хоригдлыг бодоход илүү муу нөхцөлд хорьж байсан тухай мэдээлэл байхгүй юм гэж Заутман хэлжээ. (Яагаад ийм байж болохгүй гэж? Яагаад гэвэл бослогыг БНХАУ даяр биш зөвхөн Түвдэд л нухчин дарсан, мөн Түвдэд л лам хуврагуудын эзлэх хувь хамгийн их байсан билээ. Тэндхийн хоригдлуудын эзлэх хувь ч дундаж хэмжээнээс дээгүүр байсан хэмээн үзэж болно. Түвдчүүдийн гэрчлэн ярьдагаар бол хоригдох газруудад ч түвдчүүдтэй бас л муу харьцдаг байсан юм.) Хэрэв баривчлагдсан 10 сая хүнээс жил бүр 5 хувь нь нас бардаг байсан хэмээх том тоог харгалзан үзэх юм бол 174 мянган хүнийг нас баруулахын тулд 1950 оноос 1979 оныг дуустлах хугацаанд жил бүр 116 мянгаас доошгүй Түвд хүнийг буюу тус орны хүн амын 3–4 хувийг шорон руу илгээх хэрэгтэй болох бизээ. Дээр дурдсан хугацаанд цаазлагдсан, эрүү шүүлт даалгүй нас барсан, амиа хорлосон түүвдчүүдийн 50 хувь нь шоронд байхдаа энэ бүхнээс болж хорогдсон гэж үзвэл 450 мянган хүн буюу бүх түвдчүүдийн 10 хувь нь жил бүр шоронд орж байсан болж таарна. (Яагаад болохгүй гэж, түвдийн бараг бүх айл гэсгээн цээрлүүлэлтэд хэлмэгдсэн бишүү?) Баривчилгаанд хүргэсэн ХКН-ын улс төрийн гол гол кампанит ажил БНХАУ-ын бусад хэсгийг бодоход түвдийг бага хөндсөн юм. (энэ бол худал үг, Түвдэд "ангийн тэмцэл" бүрэн далайцтай өрнөсөн билээ) Хэрэв түвдчүүд жинхэнэ Хятадынхтай адил тийм пропорцоор шорон гянданд нас барсан бол ийм түвдчүүдийн нийт тоо 75–100 мянгаас давахгүй байсан билээ. (Хэрэв өөр пропорцоор бол ямар байхсан бол?)

Тийнхүү ардчилсан шинэтгэл түвдийн ард түмний үлэмж хэсгийг

хөнөөсөн нь бүх тоо баримтаар нотлогдож байна. Энэ тухай статистикийн үнэн зөв баримт мэдээлэл зөвхөн БНХАУ-д л байж болох юм: Хэрэв байдаг юм гэхэд бие даасан судлаачдад л лав олдохгүй бизээ. Түвдийн цагаач засгийн газар л орон нутгаас ирсэн мэдээг нэгтгэн дүгнэж, нийтлүүлж байна. Тэнд хэдийгээр зарим нэг хуудуу байлаа ч дээрх тоо бариимтууд бусад бүх дүгнэлтийг бодоход нийтэд тодорхой баримтуудад илүү ойрхон байгаа юм. 1953 буюу 1959 онд Их Түвдийн хүн ам нийтдээ хэд байсан тухайд бол түвдийн тал магадгүй өсгөсөн, харин хятадын тал багасгасан тоо хэлдэг юм.

Соёлын хувьсгал ганц түвдийг биш, БНХАУ-ыг бүхэлд нь хамарсныг тэмдэглэх нь зүйтэй юм. Дэлхийн аугаа их соёлуудын нэг болох хан үндэстний соёлд ч нөхөж баршгүй хохирол учирсан билээ. Аугаа их шүтээнүүд, бичгийн дурсгалууд, урлаг, уран барилгын мөнхийн шилдэг бүтээлүүд устгагдаж, гарамгай сэтгэгчид, зураач,зохиолч, жүжигчид, эрдэмтэн мэргэд, Хятадын эртний уламжлалыг тээгчид, бүх төрлийн шашны төлөөлөгчид эрүү шүүлт, доромжлол, шахалт хавчилтад өртөж, олон хүн амь үрэгджээ.

Бээжин хотод Соёлын хувьсгалын үеэр 6843 түүхийн дурсгалаас 4922 нь эвдэрч сүйджээ.[1627] Энэ хугацаанд түүхийн дурсгалт 2 сая 357 мянган ном судар, 185 мянган зураг, хичээнгүй бичгийн хуйлаас устгаж, эртний бичээс бүхий нэг мянга гаруй чулуун багана эвдлэн нураажээ.[1628] Бээжинд Мин улсын эзэн хаан Жу Изюны (1563–1620) бунханг ухаж гаргасны дараа байгуулагдсан музейг эвдлэн сүйтгэсэн байна. Улаан хамгаалагчид эзэн хаан болон түүний хоёр хатны шарилыг музейгээс гарган ирж, "шүүмжилсний эцэст" бунханы өмнө шатаасан байна. Музейн олон үзмэрийг хулгайлан авч явсан буюу устгажээ. 728 метр урт үргэлжилсэн Чанланы хосгүй гайхамшигт галерейн модон хананд хятадын уламжлалт "гохуа" аргаар зурсан 14 мянган зураг байжээ. Улаан хамгаалагчид тэдгээр зураг дээр будаг асган сүйтгэжээ.[1629] Тэд мөн Аугаа их хятадын цагаан хэрмийн зарим хэсгийг эвджээ.

Хятадын бурханы шашны олон сүмийг бүр 1966 оны наймдугаар сард хаажээ.[1630] Тэдгээр сүмийг нийтийн байр, улаан хамгаалагчдын хурал, суртал нэвтрүүлгийн ажлын байр болгон ашиглах болжээ. Тэр үед Урлагийн төв дээд сургуулийн багш, оюутнууд хуучин уран баримлын дурсгалуудыг устгах "хувьсгалт гал" ноцоожээ. Бурхан багшийн эртний уран баримлуудыг сүх,лоом хэрэглэн эвдэлжээ. Есдүгээр сард улаан хамгаалагчид Ганьсу мужийн "феодалын сүмүүдэд" очиж, Бурхан багшийн

дүүд болон "сүсэг бишрэлийн бусад эд зүйлсийг" шатааж, тэдгээрийн оронд Маогийн хөрөг болон түүний ишлэлийн товхимолуудыг тавьжээ. Цинхуагийн их сургуульд дарга Маогийн бэлэглэсэн амра химсний дэргэд хүмүүс мэхийн ёсолж, тэр жимсийг муудмагц лааны тосоор бүрж, олон хүнд харагдах газарт байрлуулжээ.[1631]

Улаан хамгаалагчид Лоян хотын Баймасын буюу цагаан адууны сүмийг эвдлэн нураажээ. Хятадын хамгийн эртний бурханы шашны сүмүүдийн нэг болох энэ гайхамшигт сүмийг 68 онд үндэслэн байгуулжээ. Нэг мянга гаруй жилийн настай вааран бурхадыг эвдлэн сүйтгэж, хоёр мянган жилийн тэртээ бүтээгдсэн ном, сударуудыг шатаажээ. 1500 жилийн өмнө Шэньси мужийн Дай хэмээх газарт байгуулагдсан Тяньтай сүмд бүх цутгамал бурхад болон сийлбэрүүдийг устгажээ. Юньнань мужид дотоод, гадаадын бурханы шашинтнуудын мөргөлийн газар болох Ханса сүмийг устгасан байна. "Үймээн дэгдээгчид" бурханы шашны алдарт Утайшань цогцолборын лам нарыг хөөн явуулж, тэнд байсан эртний гар бичмэлүүдийг шатааж, тэндхийн жаран сүмийн заримыг эвдлэн нураажээ.[1632] Сианд Тангийн эриний үеийн бурханы шашны дурсгалуудыг эвдэлж нураасан байна.[1633] Сычуаны оршин суугч нэгэн эмэгтэй 1975 онд Хөх мөрнөөр хөлөг онгоцоор аялсан тухайгаа дурсахдаа тэр хавийн сүмүүдийг эвдлэн сүйтгэж, баримал бурхадыг энд тэндгүй шидлэж, этрнээс нааш мөргөлчдийн очдог газруудыг гутаан доромжилсон байж билээ хэмээн халаглажээ.

Күнзийн сүм, гэр, бунханг эвдэлж нураасан байна. 2500 жилийн өмнө Лаозы "Дао дэ Зин" хэмээх гайхамшигт ном бичиж үлдээсэн Лоугуаны сүмийг мөн устгасан байна. Улаан хамгаалагчид даосын бусад олон сүмийг эвдлэн сүйтгэж, лам нарыг нь коммунд элсүүлэхээр хүчээр хөөж явуулсан байна. Түвдийн нэгэн адил хятадад ч түүхийн дурсгалуудыг буулгахад мэргэжилтнүүд ажиглалт тавьж, хамгийн үнэт эд зүйлсийг улсын мэдэлд хураан авч, үлдсэнийг нь дахин хайлуулах буюу хог дээр аваачиж хаяхаар авч явдаг байжээ.[1634]

Шинжаанд эртний уйгурын коран судруудыг устгаж, исламын шашны лам хуврагуудыг хүзүүнд нь гахайн толгой зүүж гудамжаар тууж явах бөгөөд сүмүүдэд нь гахай тэжээж, махыг нь улсад тушаах бөгөөд ислам сүсэгтнүүдэд гахайн мах идэхийг албадах ажээ. Олон сүм эвдлэн сүйтгэж, олон ном, судар хэрэглэхийг хоригложээ.

Христосын сүмүүдийг хааж, эвдлэн сүйтгэж байлаа. Тухайлбал, үнэн алдартны шашны бүх сүмийг хааж, санваартнуудыг гэсгээн цээрлүүлж, олон тийм хүмүүсийн амь насыг хөнөөжээ. Харбинд байсан оросуудын

хоёр оршуулгын газрын (тэндхийн шарилын заримыг бүр 1959 онд өөр газар шилжүүлсэн байжээ) хавтангуудыг голын эргийн дагуу дэвсэхдээ зарим хавтангийн бичээсийг дээш харуулсан байжээ.

БНХАУ даяар улаан хамгаалагчид нэгжлэг хийх үеэр сэжигтэй гэж үзсэн эртний эдлэл, хуйлаасан зураг, гоёл чимэглэлийн болон шашны эдлэлүүдийг “хураах” буюу устгах ажил өрнөжээ.[1635] Бээжин хотод гэхэд л ганцхан сарын дотор 5155 кг алт, 17260 кг цалин цагаан мөнгө, 55,5 сая шахам юуань бэлнээр, 600 нэгж үнэ цэнэт эд материал, үнэт эрдэнэс хурааж авсан байна. 1966-гаас 1976 оныг дуустлах хугацаанд хувь хүмүүсээс 520 мянган орон сууцны байшин, өрөө “хураасан” байна.1966 оны аравдугаар сараас өмнө гэхэд л 397 мянга 400 хүнд “харгис этгээд” хэмээх нэр хаяг зүүж хотуудаас хөөж гаргажээ.

Хятадын янз бүрийн нутагт хүмүүсийн арьсыг хуу татаж, толгойг нь тас цавчиж, давирхайнд чанаж, биенд нь хадаас шааж, хурууг нь нугалж, зүрхий нь суга татан гаргаж, хүүхдүүдийг тасчин хуваадаг байжээ.[1636] Гуанси мужид шөнө дөлийн цагаар модонд хүлсэн хүний арьсыг хуулж, элэгий нь гаргаж ирээд чанаж идэх бөгөөд тэр хүн тэр дороо нас бардаг байжээ.[1637] Алагдсан хүний гавлын ясанд ган хоолой шааж, тархий нь сорж авах, хүний мах шарах зэргээр авирлах ажээ. Ганьсу мужид 50 машин дүүрэн хүн хүлж суулгаж, энд тэндээс нь хутга дүрж цусан далай болгох ажээ. Соёлын хувьсгалын үед нийтдээ 50–100 төрлийн тамалгаа хэрэглэдэг байжээ.

Өвөр монголын өөртөө засах оронд монголчууд бусад ард түмнээс илүү их хэлмэгдсэн байна.[1638] Тэднээс олон арван мянган хүн энэ нутаг дэвсгэрийг БНМАУ-тай сэргээн нэгтгэхийг эрмэлзсэн байгууллага болох өвөр монголын ардын намыг дэмжсэн хэмээх ял сонсон хөнөөгджээ.[1639] Хятадын талын мэдээгээр бол энэ намын хэргээр 346 мянган хүн мөрдлөг хавчилтад орж, 16 мянга гаруй нь амь үрэгджээ.[1640] Нийтдээ энэ өөртөө засах оронд барагцаалбал монгол хүн амын 10 хувь нь амь үрэгджээ.[1641] Гэсгээн цээрлүүлэлт, газрын өөрчлөлт, хан үндэстнүүдийн шилжин суурьшилт зэргээс болж монголчууд төрөлх нутаг орондоо “үндэсний цөөнх” болжээ. Тэд XXI зуунд өвөр монголын хүн амын 18 орчим хувийг эзэлж байна.

Улаан хамгаалагч дээрэмчид түвдийн нэгэн адил монголчуудын газар нутагт уламжлалт үзэл санааг устгаж, хятад хэл тулган хүлээлгэж, хүн амыг харгислажээ. 1966 онд Ордос дахь монголчуудын гол шүтээнүүдийн нэг болох Чингис хаан болон түүний шадар хүмүүсийн хувийн эд зүйлсийг 700 шахам жил хадгалсан гэрүүдийг эвдэн сүйтгэсэн байна.[1642] Улаан

хамгаалагчид эдгээр гэрүүд байсан мавзолейг устган нурааж, тэнд байсан бараг бүх зүйлийг хулгайлж, дараа нь тэнд давсны агуулах хийсэн байна. Нэгэн монгол малчны авч нуусан гурван эмээл л өнөөдрийг хүртэл хадгалагдан үлджээ.

Маог засгийн эрх барьж байсан хугацаанд БНХАУ-д нийтдээ янз бүрийн мэдээгээр гэсгээн цээрлүүлэлт, өлсгөлөнгөөс болж 30-аас 80 сая[1643] хүн амь үрэгдсэнээс 27 хүртэлх сая нь шорон, гяндангуудад ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн байна.[1644] Бөөнөөр хорих лагеруудад 50 хүртэлх сая хүн[1645] хоригдож байжээ. Хятадын талын мэдээгээр бол 100 сая шахам хүн ямар нэгэн хэмжээгээр Соёлын хувьсгалд хэлмэгдэж, тэднээс олон нь өвчин тусч, галзуурсан бөгөөд тэдгээр хүмүүсийн тоо статистикийн ямар нэгэн мэдээнд оролгүй үлджээ.[1646] Энэ хохирол бол Хятад, Түвд, Монголын бүх түүхэнд гарсан хамгийн их хохирол болжээ. Тэр жилүүдийн бараг бүх хятад залуус үзэн ядах хүүмүүжлээр дамжжээ. Маогийнхан үндэснийх нь уламжлалт үзлийг бүрмөсөн устгаж чадаагүй хятадын ард түмнийг гайхан магтаж болох билээ.

❃

1976 оны есдүгээр сарын 9-нд Мао Зэдун нас барж, түүнтэй хамт бас Соёлын хувьсгал булшлагджээ. Түүний удирдлагын уршгаар Түвд орон цөмийн бөмбөгдөлтийн дараах Хиросима шиг харагдаж байв.[1647] Түвдийн бараг бүх айл өрх гэсгээн цээрлүүлэлтэд хэлмэгдсэн байна. Маог нас барсны дараа эх орондоо очсон Далай ламын төлөөлөгчид тэнд аз жаргалтай байсан гэх, тэр жилүүдийн нөхцөл байдлын тухай ямар нэгэн сайн үг хэлэх, гэсгээн цээрлүүлэлт болон тэр үеийн гамшиг зовлонгийн тухай гуниглан ярихгүй нэг ч хүн үгүй болсныг олж мэджээ.

Маогийнхан гитлерчүүдийг дуурайж олон түмнээр хууран мэхлэх арга хэрэглэжээ. "Бидний хувийн зан чанар болон адил төстэй үйлдлүүдийг хувьсгалын галд шатаах ёстой байсан юм, бид амьд бурхан дарга Маод шингэсэн эзэн биегүй эх орон үе үеийнхний цорын ганц эд зүйл болох ёстой нэг хэвийн шинэ зан чанарыг хамт олны ахуйгаас хүмүүжүүлэх ёстой байсан юм".[1648] Энэ дарга эх орных нь өнгөрсөн үеийг өөрийнх нь удирдлагад байгаа хүмүүсийн ухамсараас арчиж хаяхыг мөрөөдөж байсан юм.[1649]

Булаан эзлэгчид түвдийн ард түмэнтэй эв нэгдэлтэй байна хэмээн тунхаглаж хүч хэрэглэх, худал үг хэлэх аргаар "олон түмнийг" эрүү шүүлт, аллага хядлага, шашин, соёлыг устгах хэрэгт дайчилсан юм. Гэхдээ тэд

хятад маягийн аж үйлдвэр, дэд бүтэц, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүлийг хамгаалахын систем бий болгожээ. Суртал нэвтрүүлэгчид үүнийгээ аугаа их ололт хэмээн магтах ажээ. Гэтэл бодит байдалд Түвд орон хосгүй гайхамшигт соёл иргэншлээс хятадын хоцрогдсон зах хязгаар болон хувирчээ.

Түвдэд албан ёсоор дайн болоогүй ч 1951-ээс 1976 оныг дуустлах "энхийн" хугацаа бол оюун ухаан, түвдийн гэх бүх зүйлийг чиглэсэн зорилготой устгах, ард түмнийг хүйс тэмтрэх, "дахин хүмүүжүүлэх", хүчээр хятаджуулах үе байлаа. Энэ бүхнээс болж түвдчүүдийн 3–30 хувь амь үрэгдсэн байна. "Төр өөрөө аллага хядлага зохион байгуулсан юм. Аллага хядлагын их биш хувь улаан хамгаалагчдад оногдох" бөгөөд эвдрэл сүйтгэлийн ихэнх хувийг эрх баригчдын санаачлагаар хэрэгжүүлсэн юм.[1650] Мао үүнийг сайн мэдэж байсан.

1948 оны арван хоёрдугаар сарын 9-нд батлагдаж, 1961 оны нэгдүгээр сарын 12-ноос хүчин төгөлдөр болсон "Аймаглан устгах гэмт хэргийг сэрэмжлэн зайлуулах, түүний төлөө хариуцлага оногдуулах тухай Конвенцид "зааснаар бол" ямар нэгэн үндэсний, угсаатны зүйн, арьстны буюу шашны бүлгийг бүрэн буюу заримдаг байдлаар устгах зорилгоор үйлдэх дараах үйлдлүүдийг аймаглан устгах ажиллагаа хэмээн ойлгоно; a) тийм бүлгийн гишүүдийн амь насыг хөнөөх; b) тийм бүлгийн гишүүдэд биеийн ноцтой гэмтэл буюу ухаан санааны гажуудал учруулах; c) ямар нэгэн бүлэгт түүнийг бүрэн буюу заримдаг байдлаар устгахаар тооцоолсон амьдралын тийм нөхцөл зориуд санаатай бий болгох; d) тийм бүлэгт хүүхэд төрүүлэхгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах; e) хүний нэг бүлгээс нөгөөд хүүхэд хүчээр өгүүлэх" зэрэг болно гэж заасан байна.[1651]

Олон улсын хуульчдын комиссийн хууль ёс сахин мөрдүүлэх хороо: "Түвдэд шашны бүлгийнх нь хувьд түвдчүүдийг устгах зорилготой аймаглан устгах ажиллагаа явуулсан бөгөөд тийм ажиллагаа нь ямар нэгэн гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагаас үл хамааран аймаглан устгах ажиллагаа мөн".[1652] гэсэн дүгнэлт хийжээ. Тус хороо үүнд дараах нотолгоонуудыг гаргасан байна: (а) хятадууд Түвдэд бурханы шашны дүрэм, номын зан үйлийг мөрдөхийг зөвшөөрөхгүй байна; (б) тэд Түвдэд шашны итгэл үнэмшлийг үндсээр нь устгахын төлөө дэс дараатай тэмцэж байна; (в) энэ зорилгоор тэд шашны итгэл үнэмшил, номын зан үйл ажиллагааных нь төлөө шашны зүтгэлтнүүдийг устгаж, бусдыг уриалан дуудаж, үлгэр жишээ үзүүлжээ; (г) тэд шашны хүмүүжил авах боломж олгохгүйн тулд олон тооны Түвд хүүхдийг хүчээр хятад материалист орчин руу шилжүүлэн явуулжээ.

Бусад үндэстий талаар маогийнхны явуулж буй иймэрхүү үйлдэл дээрх дүгнэлтийг өөрчлөхгүй юм. Улмаар Түвдэд явуулж буй хятадуудын үйлдлийг хүн амын хохиролын тухай энд дурдсан дүгнэлтүүдийн чухам алин нь зөв болохоос үл шалтгаалан аймаглан устгах ажиллагаа хэмээн үзэж болно.

ХКН хятадын ард түмний өмнө японы милитаризмын үйлдсэн гэмт хэргийг онцлон тэмдэглэхдээ өөрийнхөө үйлдсэн гэмт хэрэг, тэдгээрийн нэг болох Соёлын хувьсгалын тухай таг дуугүй байна. “Дээрээс” чиглүүлэн найруулсан энэхүү эмх замбараагүй явдал хүний хамгийн доод инстинктийг идэвхжүүлсэн юм. Хэрэг дээр ухаан тархий нь маогийн үзэл санаагаар дүүргэсэн “шинэ социалист хүн төлөвшүүлэн тогтоох явдал” тийм байдлаар эргэсэн байна.

Энэ бол түвд-монголын соёл иргэншлийн бүх түүхийн хамгийн аймшигт хар хуудас болсон билээ. 1966 он гэхэд энэхүү соёл иргэншлийн олон зуун жилийн өв уламжлалаас үлдэж хоцорсон тэрхүү бага зүйлийг бараг бүрэн устгажээ. Үүний хариуцлага Мао Зэдун болон түүний намд оногдоно. А. Гитлер болон үндэсний социал-демократ намын гэмт хэрэгт германы ард түмнийг зэмлэн буруушаадаггүйн нэгэн адил үүнд ямар нэгэн ард түмнийг бүхэлд нь буруушааж болохгүй юм.



Лхас хотын ойролцоох уулс (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Ямдог цо нуур (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



1



2



3

Зонг Шигазе: 1 – 1938 онд (Bundesarchiv, Bild 135-S-17-22-34/фото: Ernst Shaefer/ License CC-BY-SA 3.0); 2 – 2005 онд (А.М. Стрелковын авсан гэрэл зураг); 3 – 2008 онд (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)




Америкийн зураг зүйч А. Финлийн үйлдсэн Ази тивийн 1827 оны газрын зурагт тэмдэглэгдсэн Манж Чин улс болон бусад нутаг дэвсгэр. Түвдийг Чин улсын бүрэлдэхүүнд оруулаагүй байна (Maps of Tibet, 2008)



Будалын ордон (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Түвдийн гол сүм болох Жокан сүм (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Жокан сүмийн ойролцоох Баркорын гудамж (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



1



2



3



4

Гандан хийд: 1 – 1959 оны өмнө (DIIR Archive, Central Tibetan Administration); 2 – 1966 онд эвдлэн сүйтгэсний дараа (Norbulingka Institute Archive, Dharamsala); 3 – 1980-аад оны эхэнд шинээр байгуулж эхлэв (DIIR Archive, Central Tibetan Administration); 4 – 2008 онд (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



1



2



3

Дрепун хийд: 1 – 1900 онд (DIIR Archive, Central Tibetan Administration): 2 – Соёлын хувьсгалын үед эвдлэн сүйтгэсэн сүмүүд (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг); 3 – Хийдийн 2008 оны дүр төрх (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



1



2



3

Сэра хийдийн баруун даянч тууриуд (permitted by Jose Ignacio Cabezon): 1 – Эвдлэн сүйтгэхээс өмнө; 2 – Маогийн үед эвдлэн сүйтгэсний дараа; 3 – Сэргээн босгосны дараа.





Дашлхүмбэ хийд 2008 онд (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)

Дашлхүмбэ хийд дэхь 26 метр өндөр Будда Майтрын цутгамал хөрөг, 2008 он. Түүний өмнө сүүлчийн гурван Банчин ламын хөрөг тавьжээ. Одоо, тухайн үед хулгайлагдсан, Дашлхүмбэ хийдийн эрлийн бүлгийнхний олж тогтоож, XIV Далай ламын баталсан Банчин лам Гэндэн Цогнямын оронд хятадын засаг захиргааны санаачлагаар тодруулж сонгосон Банчин лам буюу Жалцанноровын гэрэл зургийг тавьжээ (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)

Хятадын цэргийнхэн Дашлхүмбэ хийдийг үзэж яваа нь. Тэд сүмүүдээр орохдоо дэг журам сахиж, зарим нь бурхадын өмнө залбирч байлаа





Цапарангийн агуйнууд ба сүмүүд (А.И. Рощин, А.Ю. Горяинов нарын авсан гэрэл зургууд)



Гьяндзе хотын Пелкор Чоде хийдийн Гьянзе Гүмбүм суварган дахь Буддагийн цутгамал дүр
(С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Амдо мужийн Гүмбүм хийд. Зонховын төрсөн газарт байгуулсан сүм ба алдарт мод. Эртний уламжлалаар бол энэ модны навчин дээр Зонховын дүрийг харж болдог ажээ (С.В. Дмитриевийн авсан гэрэл зураг)



Гүмбүм хийдийн найман суварга (С.В. Дмитриевийн авсан гэрэл зураг)



Түвдийн сүлд. Буддын шашинтнуудын хувьд ариун дагшин Кайлас уул, номын хүрд, Түвдийн засгийн газрын үйл ажиллагааг илэрхийлэн харуулж, шашин, төрийн хүчийг нэгтгэсэн цаст уулын хоёр цагаан арслан байна



Түвдийн далбаа. Далбааны төвд байгаа цаст уул нь цас, мөсөн уулсаар хүрээлэгдсэн орон болох Их Түвдийг билэгджээ. Тэнгэрт харагдах зургаан улаан туяа нь түвдийн уугуул зургаан ястныг билэгдэж, улаан туяа болон бүдэг хөх тэнгэр хоёр ээлжлэн харагдах нь эрт дээр үеэс Түвдийг ивээлдээ авч явж ирсэн хоёр бурхан тэнгэрийн шашин, төрийн эрх мэдлийг хамгаалахын тулд явуулах буянт үйлсийг улам боловсронгуй болгоно хэмээх санааг илэрхийлнэ. Цаст уулын оргил дээгүүр мандаж буй нарны туяа түвдийн бүх ард түмний эрх чөлөө, шашин ба төрийн аз жаргал, цэцэглэл хөгжлийг билэгдэнэ. Цаст уулын цагаан арслангууд шашин, төрийн хүч чадлыг нэгтгэж буй засгийн газрын үйл ажиллагааны бүрэн төгс ялалтыг билэгдэн харуулна. Гурван өнгийн эрдэнэ нь Бурхан, Ном, Хувраг хэмээх түвдийн ард түмний гурван их өмөг түшигийг, хишиг буяны хоёр өнгийн эрдэнэ нь юуны өмнө хишиг буяны арван бурхан, хүмүүний ёс суртахууны 16 дүрмээр илэрхийлэгдэн гардаг эрхэм дээд ёс уламжлалын дагуу ёс суртахууны зарчмуудыг сахин мөрдөхийг тус тус билэгдэнэ. Далбааны гадна талын шар хүрээ нь шижир алт лугаа бурхан Буддагийн сургаалийг билэгдэн харуулах ажээ



Уламжлалт хувцастай түвдчүүд (Losell Doll Museum, Norbulingka, Dharamsala.
С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Камын Юндрунлин хийдийн балгас

Түвдийн босогчдын Чуши Гандруг (Дөрвөн гол, уулын зургаан систем) хөдөлгөөний далбаа. Шар дэвсгэр нь буддийн шашны өнгийг, шатаж буй илд буюу мэргэн ухааны бодьсад Манзуширийн билэг тэмдэг нь мунхаг харанхуйг гэтлэн давахыг, хоёрдахь илд нь түвдчүүдийн эрэлхэг зориг, тэдний үе дамжсан эрхийг тус тус илэрхийлсэн бөгөөд энэ бол түвдчүүдийн уламжлалт зэвсэг юм (http://www.phayul.com.)







1 & 2 Гомбодаш Андругцанг. Энэтхэгийн Сарнатх дахь Буддагийн баримал хөрөгийн дор байрлуулсан дурсгалын самбар. 2009 он (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг). Дурсгалын самбар дээр Нямжалцан миний бие Буддагийн энэхүү дүрийг Чуши Гандруг хөдөлгөөнийг үндэслэн байгуулагч, түүний удирдагч талийгаач Андруг Гомбодаш болон Түвдийн төлөө амь насаа зориулсан бүх түвдчүүдийн дурсгалд зориулав, бүх түвдчүүд Арван дөрөвдүгээр Далай ламын удирдлагаар дахин нэгдэгтүн гэж бичжээ



Лхас хотын төв дэхь Будалын ордны өмнөх талбай. Хятадын далбааны цаана Түвдийн “энх тайван чөлөөлөлтийн” хөшөө байна (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Шашны уран баримлуудыг Норлин Ньиво Повранд эвдлэн сүйтгэжээ. 1980 оны гэрэл зураг (DIIR Archive, Central Tibetan Administration)



Норовлин ордны хашаанд хэвтэж буй шашны уран баримал болон сүмийн гуулиар хийсэн эдлэлүүдийн хэсгүүд (DIIR Archive, Central Tibetan Administration)



Лхас хотын нэгэн хуучин (эвдэрч нурсан) хийд дэхь шашны эд зүйлсийн хэсгүүд (Norbulingka Institute Archive, Dharamsala/NgodupTsoknyid)

Лхас хотын район дахь шашны эвдэрч сүйдсэн эд зүйлсийн агуулахаас авсан эвдэрхий баримал барьсан лам банди. 1991 оны гэрэл зураг (Alison Wright авсан гэрэл зураг)





Амдо мужийн Ребкон хийдийн нэгэн сүмд байрласан хятадын агуулах. 1979 оны гэрэл зураг (DIIR Archive, Central Tibetan Administration)



Агуулахад хаягдсан шашны ном, сударууд. Төв Түвд 1980 он (DIIR Archive, Central Tibetan Administration)



Лхасын Жокангийн ойролцоох гол сүмүүдийн нэг болох Шидэ сүмийн балгас. Ретин хийдийн энэ сүмийг 14-р зуунд барьжээ (DIIR Archive, Central Tibetan Administration)




Соёлын хувьсгалын үеийн зурагт хуудас, 1966 он . Түүнд: “Хуучин ертөнцийг эвдлэн нурааж, шинэ ертөнцийг байгуулья” хэмээн бичжээ. Хятад ажилчин христосын загалмай, Буддагын баримал, хятадын сонгодог бичвэрийг лантуудан нурааж байна




Дрепунг хийдийн нэгэн сүмийн ханан дээр байрлуулсан Мао Зэдуны зураг (DIIR Archive, Central Tibetan Administration). Лоозонгийн үгийг орчуулбал: “Их удирдагч бол бүх нийтийн аугаа их багш, чиглүүлэгч их хүч бол аугаа их жолоодогч. Дарга Мао түм наслах болтугай!” гэсэн утга гарна.



Маогийн үед эвдлэн сүйтгэсэн Түвдийн баруун өмнөд нутаг дахь Тинри хийд, 1993 он (DIIR Archive, Central Tibetan Administration)



Маогийн үед эвдлэн сүйтгэсэн Камын Гашу Догон хийдийн балгас, 1979 он (DIIR Archive, Central Tibetan Administration)



Маогийн үед эвдлэн сүйтгэсэн Ретин хийдийн балгас (Norbulingka Institute Archive, Dharamsala/Lobsang Dargyal Album)



37.tif Маогийн үед эвдлэн сүйтгэсэн Түвдийн төв хэсгийн нэгэн хийдийн балгас (Norbulingka Institute Archive, Dharamsala/Linnea Bohm)



1



2

Цангпо голын хөндий дэхь Тактен Пунцоглин хийд: 1 – 17-р зуунд баригдсан бөгөөд Соёлын хувьсгалын үед эвдлэн сүйтгэгдсэн хийдийн балгас; 2 – хийдийн шинэ байшин (Don Croner авсан гэрэл зураг)



1



2

Толинг хийдийн сүмүүдийн эвдэрсэн балгас (Ray Kreisel авсан гэрэл зураг): 1 – сүмүүдийн эд зүйлсийн хэсгүүд, бурхан тахил, ном судар: 2 – баримал бурхадын толгой: 3 – Бурханы баримал байсан газар



3



Цапарангийн сүмүүдийн балгас, нгари: 1 – http://savetibet.ru/uploads/posts/1236625784_monastery.jpg



А.И. Рощин, А.Ю. Горяинов нарын авсан гэрэл зурагууд)



1



2



3



4



5

6





7

8





9

10





11

12



Цапарангийн сүмүүдийн эвдэрч сүйдсэн хэсгүүд: 1 – Том баримал бурхан байсан газар (А.И. Рощин, А.Ю. Горяинов нарын гэрэл зэрэг); 2 – Дөрвөн гартай Махгал бурханы (?) баримал дүр (А.И. Рощин, А.Ю. Горяинов нарын гэрэл зураг); 3 – Лхакан Карпо сүмийн Вайрочана Буддагийн эвдэрч гэмтсэн зургаан баримал дүрийн нэг (Ray Kreisel авсан гэрэл зураг); 4 – хөх Очирваань бурханы баримал дүр (Ray Kreisel авсан гэрэл зураг); 5 – улаан Хаянхирваа бурханы баримал дүр (www.mountainsoftravelphotos.com/ Weyer/ Aschoff авсан гэрэл зураг: Tsaparang, Tibets Grosses Geheimnis/Permitted by Charlotte & Jerome Ryan); 6 – бодьсад Бадмаасан (?) бурханы баримал дүрийн хэсэг (Ray Kreisel авсан гэрэл зураг); 7–8 – Бурхан багшийн баримал дүрийн толгой (Ray Kreisel авсан гэрэл зураг); 9 – Майдар бурханы баримал дүрийн хөлийн тавхай баrималуудын хэлтэрхий болон хар дэвсгэр дээр нунтаг алт, мөнгө хольсон тусгай бэхээр бичсэн хуучны түвд номын хуудсуудтай хамт (Ray Kreisel авсан гэрэл зураг); 10 – соёлын хувьсгалын үед устгагдсан байж болох хуучны модон барын судар номны давхарлаж өрсөн модон хавтаснууд (Ray Kreisel авсан гэрэл зураг); 11 – овоолсон хогон дээр хэвтэж буй нунтаг алт, мөнгө хольсон тусгай бэхээр бичиж, хэвлэсэн түвд номын нэг ширхэг хар хуудас (Ray Kreisel авсан гэрэл зураг); 12 – Жовокан цагаан сүмийн үүдний өрөө (www. mountainsoftravelphotos.com/ Bruno Baumann авсан гэрэл зураг/permitted by Charlotte & Jerome Ryan). Гол бурханы хоёр талын тавиур бүр дээр соёлын хувьсгалаас өмнө жижиг жижиг бурхан байрлуулсан байжээ



Будалын ордноос Лхас хотын харагдах байдал. 2008 он (С.Л.Кузьминий авсан гэрэл зураг)



Мөргөлчид Лхас хотын түвд хороололд. 2008 он (С.Л.Кузьминий авсан гэрэл зураг)



Мөргөлч Лхас хотын шинэ хороололд. 2008 он. (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Самьед Бадмаажунайгын барималыг нурааж байгаа нь. 2007 он (TCHRD)




Шигазе хотын шинэ хороолол 2008 он (С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Лхасын ойролцоох хятадын цэргийн нэг хотхон.



2008 оны гуравдугаар сарын 10-нд Дрепун хийдийн лам нарын хийсэн жагсаал (TCHRD)



2008 оны гуравдугаар сард болсон мөргөлдөөний дараах Жокангийн өмнөх талбай (http://www.portal-credo.ru/site/print.php?act=news&id=69153)



2008 оны гуравдугаар сард Лхас хотод шатаж буй хятад дэлгүүрүүд (http://times.ua/story/15835/)



1 & 2 Лхас дахь хятад цэргүүд, 2008 оны гурав-дөрөвдүгээр сар (TCHRD)



2008 оны гуравдугаар сарын 14-нд Лабрант болсон жагсаал (TCHRD)



2008 оны гуравдугаар сарын 16-нд Нгаба Киртид болсон жагсаалын үеэр алагдсан төвдчүүдийн оршуулга (TCHRD)



2008 оны гуравдугаар сард Нгаба Киртид болсон жагсаалыг тараах үед алагдсан 64 настай Гепан Талхо (TCHRD)



Хятадын засгийн газарт үйлчилдэг түвдчүүдийн гэр оронг Нгаба Киртийн цагдаа нар хамгаалж байна (TCHRD)



Энэтхэгийн нийслэл Дели хот, Мажнука Тила дахь түвд дүрвэгчдийн хороолол
(С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Маклеод-Гандж – Дармасала хотын түвд хэсэг, 2009 оны гуравдугаар сар
(С.Л. Кузьминий авсан гэрэл зураг)



Түвдийн цагаачлалын засгийн газар. Дарамсала, 2009 оны гуравдугаар сар
(С.Л.Кузьминий авсан гэрэл зураг)



Арван дөрөвдүгээр Далай лам Данзанжамц, Арван нэгдүгээр Банчин лам Гэндэн Цогням – түвдийн ард түмний шашны удирдагчид. Орчин үеийн ардын зураг

Бүлэг 10

# Сэргээн босголт ба шинэчлэл

БНХАУ-ын дарга Ху Зиньтао: "Түвдэд сүүлийн 50 жилд олсон гарамгай амжилтууд нь түвдийн хөгжлийн түүхэн үеүдэд нөхөр Мао Зэдун, Дэн Сяопин, Зян Зэминь зэрэг Намын хамтын төв удирдлагын гурван үеийнхэн мэргэн шийдвэр гаргаж, зөв удирдан жолоодсоны үр дүн мөн" гэж хэлсэн байна.[1653] Мао Зэдуны үеийн тухай бид мэднэ. Цаашид юу болсныг одоо харцгаая.

"Их залуурчийг" нас барснаас хойш ХКН-д Дэн Сяопин болон түүний шинэтгэлийн бүлэг тэргүүлэх болов. Баруун өмнөдийн цэргийн тойргийн улс төрийн комиссар байсан, Түвдэд цөмрөн орох ажиллагааг зохион байгуулагчдын нэг, дараа нь Соёлын хувьсгалын бай болж байсан энэ хүн "Хулгана барьж л байвал муур ямар өнгөтэй байх нь хамаагүй" хэмээх хуучин хятад зүйр үгийг удирдлага болгодог нэгэн. Ингэхлээр эдийн засагт улаан биш өнгө байж болохнээ... Тэрээр 1978 оноос БНХАУ-ыг гүнзгий хямралаас гаргах учиртай шинэтгэлийг эхлүүлсэн юм." Хятадын өвөрмөц онцлогтой социализм – энэ бол марксизмын гол гол үндэслэлийг Хятад улсыг шинэчлэх үйл хэрэгтэй холбосон бүтээгдэхүүн мөн, харин шинжлэх ухааны социализм... Хөгжлийн энэ үйл явцад түүхэн хязгаарлагдмал байдлын улмаас үл гүйцэлдэх элементүүдийг өөртөө агуулсан манай өмнөх хүмүүсийн зарим үндэслэлүүдээс татгалзаж, марксизмыг догматик байдлаар хүлээж авах ойлголт, марксизмд хамаатуулах алдаатай үзэл бодлоос гарцаагүй татгалзахаас өөр аргагүй болно".[1654] Ер нь бол Мао Зэдуны урьдчилан анхааруулснаар "их биш хугацааны дараа... нийт оронд хувьсгалын эсэргүү засварлах ажиллагаа гарцаагүй гарч, марксч-ленинч нам бараг л магадлалтайгаар ревизионист нам болон хувирна".[1655] Тэгвэл "ревизионистууд засгийн эрхэнд гарах явдал хөрөнгөтнүүд засгийн эрхэнд гарлаа гэсэн үг мөн".[1656]

Хятадын ард түмэн шинэ чиг шугамыг оргилуун сэтгэлээр дэмжив.

Тэр үеэс хойш бүх дэлхий хувийн үйлдвэр худалдааны үйл ажиллагаанд хятадуудын олж байгаа амжилтаар бахархах болов. БНХАУ-д саятан, тэрбумтнууд бий болов. ХКН-ын олон гишүүн амжилттай бизнес эрхлэгчид болжээ. Насан эцэслэх хүртлээ Мао Зэдуны тунхаглаж ирсэн олон түмний коммунист хүмүүжил хөөс болон хувирав.

Дэн Сяопиний шинэтгэлийн амжилт нь Хятад улс гадаадын (өрнөдийн) хөрөнгө оруулалтыг татаж, дараа нь даяаршилд орсон явдалтай олон талаар холбоотой.[1657] 1979 оны нэгдүгээр сард БНХАУ, АНУ дипломат харилцаа тогтоож, мөн оны долдугаар сард худалдааны харилцааны тухай Хэлэлцээрт гарын үсэг зурж, энэ баримт бичгийн дагуу бие биендээ хамгийн тааламжтай орны статус эрх олгосон байна.Тэр үеэс хойш хоёр орны харилцаа амжилттай хөгжиж байгаа учир XX зууны сүүлч гэхэд АНУ ач холбогдлоороо Хятадын хоёрдахь худалдааны түнш (японы дараа), харин Хятад улс АНУ-ын худалдааны тав дахь түнш болжээ. АНУ хятадын эдийн засагт хөрөнгө оруулагч чухал эх үүсвэр болов. 2005 он гэхэд гадаадын технологиос хамаарах БНХАУ-ын түвшин 50 хувьд хүрчээ.

ХКН-ын эрх мэдэл тогтож, хадгалагдахад гадаад улсууд чухал үүрэг гүйцэтгэв. ЗСБНХУ-гүйгээр БНХАУ оршин тогтож чадахгүй байсан бол өрнөдийн гүрнүүдгүйгээр хятадын эдийн засгийн гайхамшиг гарахгүй байсан юм. АНУ-ын зүгээс БНХАУ-ыг хагаралд оруулахыг эрмэлзэж байна гэсэн бүх үг яриа ямар ч үндэсгүй билээ.

Соёлын хувьсгалын үндэс болж байсан Мао Зэдуны гол гол заалтууд "марксизм-ленинизмд ч, хятадын бодит байдалд ч тохирохгүй болсныг" 1981 онд ХКН-ын төв хороо хүлээн зөвшөөрөв.[1658] Гэхдээ "нөхөр Мао Зэдун бол аугаа их марксч, аугаа их пролетарийн хувьсгалч, стратегч,онолч мөн.<...> Түүний байгуулсан гавьяа гол байр эзэлж, харин алдаа дутагдал нь хоёрдугаар зэрэгт тавигдана. Манай нам, ХАЧА-ийг байгуулж, хөгжүүлэхэд, хятадын бүх ард түмнийг чөлөөлөхөд байгуулсан түүний гавьяа хэзээ ч бөхөшгүй билээ" гэж намын төв хорооны тогтоолд өгүүлсэн байна.

Тийм дүгнэлтэд гайхах зүйлгүй юм. Хувьсгал нь коммунистуудын хувьд зөвхөн сайн үйл, харин хувьсгалын эсэргүү ажиллагаа бол зөвхөн муу үйл байж болох билээ. Тийм учраас тэд соёлын хувьсгалыг хувьсгал биш байсан гэж шийдвэрлэжээ. Харин ч түүнийг Линь Бяо, Зян Цин нар тэргүүтэй "хувьсгалын эсэргүү бүлэг" хийжээ. Тэгвэл Зян Цинь: "Би дарга Маогийн уяаны нохой байсан билээ. Дарга Мао хэнийг хаз гэнэв түүнийг л би хаздаг байсан" гэж шудрагаар хүлээн зөвшөөрчээ.[1659]

БНХАУ-д маогийн үзэл өнгөрсөн үе болж үлдсэн гэж олонхи хүн үздэг.

Энэ бол тийм бишээ. Түүнийг хэн ч өөрчлөөгүй. Өнөөдөр ХКН дүрмийнхээ дагуу “үйл ажиллагаандаа марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санаа, Дэн Сяопиний онол, гурвалсан төлөөллийн чухал чухал үзэл санааг удирдлага болгосон хэвээр байна”.[1660] Гурвалсан төлөөллийн үзэл санаа гэгч нь дараах байдлаар илрэн гарч байна. ХКН бол тэргүүний үйлдвэрлэгч хүчин, тэргүүний хятад соёл, хятадын ард түмний үнэмлэхүй олонхийн төлөөлөл мөн.[1661] “Хятадад марксизм-ленинизмийг хэрэглэн хөгжүүлсний үр дүн болсон Мао Зэдуны үзэл санаа, практикаар нотлогдсон онолын зөв зарчмууд, хятадын хувьсгал болон бүтээн байгуулалтын туршлагыг нэгтгэн дүгнэсэн явдал, Хятадын Коммунимст Намын хамтын оюун ухааны мөн чанарыг илэрхийлж байна.<...> Социалист хөгжлийын зам, ард түмний ардчилсан диктатур, ХКН, марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санааны зүгээс хэрэгжүүлж буй удирдлагыг хатуу тууштай өмгөөлөн хамгаалах явдал манай төрийн үндсийн үндэс мөн.”[1662]

2001 оны нэгдүгээр сарын 10-нд БНХАУ-ын дарга Зян Зэминь: “Манай улс бол социалист улс мөн, хэрэв бидний оюун ухааны гол тулгуур, өөрөөр хэлбэл марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санаа, Дэн Сяопиний онолыг ганхуулбал, хэрэв хятад онцлогтой социализм байгуулах бид бүхний эрхэм дээд зорилгыг ганхуулбал үзэл санааны хямралдаан, нийгмийн эмх замбараагүй байдалд орж болох бөгөөд ингэвэл төр улсын хувьд ч, үндэстний хувьд ч гай гамшиг болон хувирна. Тиймээс марксизмын үндэслэлүүд, хятад онцлогтой социализмын эрхэм дээд үзлийг удирдлага болгох сэдвийг хатуу мөрдөх заалт нь нам, төрийн хувь заяатай холбоотой юм” гэж хэлсэн байна.[1663] Тийнхүү БНХАУ дахь хөрөнгөтний эдийн засаг коммунист үзэл сурталтай хослож байна. Үүгээр ХКН шинэ нөхцөл дэхь эрх мэдлээ хууль ёсны болгож байгаа юм.

Маог нас барснаас хойш түвдчүүдийн байдал сайжирчээ. 1977 оны сүүлчээр шийтгэгдсэн хүмүүсийн заримыг шоронгоос суллаж, заримыг нь өндөр албан тушаалд эргүүлж тавьсан байна. Суллагдсан хүмүүсийн 90 шахам хувь нь түвдийн хуучин засгийн газрын түшмэд, өндөр мэргэжил боловсролтой хүмүүс байв. Эхний үед тэднийг гол төлөв малчид буюу хөдөө аж ахуйн ажилчин болгожээ.[1664] Гэвч одоо хятадын эрх баригчид эрх баригч ангийнханд хамаарагдаж байсан ахмад үеийн түвдчүүдийн төлөөлөгчдийг дэмжихийг эрмэлзэж байна. Ийм хүмүүс эд материалын дэмжлэг, хүндтэй албан тушаал авч байна.[1665]

1979 оноос хятадын засгийн газар болон Арван дөрөвдүгээр Далай ламын төлөөлөгчдийн хооронд хэлэлцээ хийх болсон байна. Чөлөөлөгдсөн

X Банчин лам 1978 онд БНХАУ-ын Ардын Улс төрийн Зөвлөлдөх Хорооны байнгын хорооны гишүүнээр дахин сонгогджээ. Түвдийн ард түмний амьжиргааны түвшин хуучин үеийнхээс бага зэрэг дээшилснийг тэрээр 1979 оны хоёрдугаар сард нотолсон байна.[1666] 1980 онд Бээжин хотод Түвдийн асуудлаар ажлын анхдугаар чуулга уулзалт болов. Энэ чуулга уулзалтад X Банчин ламыг урьсан байна. 70 мянган дүрс үсгээс бүрдсэн илгээлтэд илэрхийлсэн байр сууриа баримталсан хэвээр байгаагаа тэрээр мэдэгджээ. Шоронгийн жилүүд түүний зоригийг мохоогоогүй ажээ. Баруунyхны эсрэг кампанит ажлыг зөвтгөсөн намын байр суурийг Банчин лам ил шууд шүүмжилжээ. Цагаатгагдаагүй Пунцаг Ванжил ч ийм байр суурь баримталж байжээ. ТӨЗО-нд ХКН-ын бодлого дампуурсны гол үндсэн шалтгаан бол зүүний чиг хандлага байсан юм гэж чуулга уулзалтынхан тэмдэглэжээ. ТӨЗО-ны ХКН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргыг өөрчлөв. Намын бүх идэвхтэн “зүүнийхнээс” бүрдэж байсан учир таарч тохирох хүн олоход хүнд байжээ.

1980 оны тавдугаар сарын 22–31-нд ХКН-ын төв хорооны нарийн бичгийн дарга Ху Яобан төлөөлөгчдийн хамт Түвдэд очив. Тэрээр хүн амын ядуу зүдүү байдлыг хараад бараг л балмагдалд орж, олон сая юань үргүй зарж, хятад кадр ажилтнууд муу ажиллаж байгааг тэмдэглэсэн байна. Ху Яобан хаалттай хуралдаан дээр үг хэлэхдээ Түвд дэх хятадын гүйцэтгэж буй үүргийн гаднаас харагдах дүр төрх колончлолыг (эдийн засгийн талыг хэлсэн байх) санагдуулж байна гэж онцлон тэмдэглэжээ.[1667]

Ху Яобан Бээжинд эргэж ирээд ТӨЗО-нд татвар оногдуулах, үнэ хөлсгүй ажил хийхийг шаардах, улсын бэлтгэлд бүтээгдэхүүн нийлүүлэх үүрэг хариуцлагаас гурван жилийн хугацаатай чөлөөлөх, газар тариалан, мал аж ахуйг хамтралжуулсныг болиулах, газар болон өмчийг цаашид хувьчлах, ТӨЗО дахь автономи эрх нь түүний онцгой нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх, түвдийн гацааны түвшингийн засаг захиргааны байгууллагуудад хоёр-гурваас илүү хятад хүн ажиллуулахгүй байх, илүү өндөр түвшинд бол энэ үзүүлэлт 30 хувиас давахгүй байх зэрэг эрс шинэтгэл хийхийг шаарджээ.[1668] ХАЧА-ийг оролцуулахгүйгээр хятад кадр ажилтнуудыг 85 хувиар хорогдуулах, тэнд ажиллахаар үлдэж буй хүмүүсийг Түвд хэлэнд сургах ёстой болжээ. Түүнээс гадна эдийн засгийг либералчлан олон салбартай болгох, хятадын тэтгэлэгийг нэмэгдүүлэх, түвдийн соёл, шашинг сэргээх, соёлын зарим дурсгалууд болон сүм хийдийг сэргээх ажлыг санхүүжүүлж эхлэх ёстой болсон байна. Түвд нутгууд бүхий мужуудын удирдагчид ч намын шинэ удирдамжийг судлах ёстой болсон

байна.

Түвдэд зүүнтний чиг шугамыг гэтлэн давах шаардлагатай байгаа тухай хэд хэдэн нийтлэл гарав. Тухайлбал, үндэсний асуудлыг ангийн тэмцэлд хамаатуулах явдал буруу, энэ асуудлын мөн чанар бол социализмын үед хадгалагдаж үлдсэн үндэстний тэнцвэртэй биш байдалд байгаа юм гэж зарлажээ.[1669] Энэ нь Маогий үзэл баримтлалд харшилжээ. 1970 онд чинээлэг тариачдыг нударган баячууд хэмээх хүн амын бие даасан давхаргад хамаатуулсан хамтралжуулалтын нэг алдааг засах тухай зарлав. Хуучин Түвдэд нударганчууд байгаагүй юм хэмээн зарлажээ. Баян малчид, газар тариалан эрхлэгчид, тэдний төлөөний этгээдүүд, түүнчилэн газар эзэмшигчид, мал эзэмшигчид гэсэн зэрэглэлд багтаж байсан хүмүүсийг цагаатгах тухай зарлав. Олон чинээлэг “хамжлагынхан” энэ зэрэглэлд орсныг хүлээн зөвшөөрчээ. Тэднээс хурааж авсан мал болон хөдөлмөрийн багаж зэвсгийг нөхөж олгохоор болов. Үүний араас 1975 онд капиталистуудын зиндаанд тавигдсан худалдаачдыг цагаатгасан бөгөөд феодалын түвдэд капиталистууд байгаагүй гэж үзэх болсон ажээ.

Хүн амд үндэсний хувцасаа өмсөх, шашны зан үйл хийх, ёс заншлаа сэргээхийг зөвшөөрөв. Орон нутгийн хуулиуд нэг эхнэр хэд хэдэн нөхөртэй буюу нэг нөхөр хэд хэдэн эхнэртэй гэр бүлүүд нь гэрлэлтийн тухай түвдийн хуулийг зарлан тунхаглахаас өмнө бий болсон, мөн тийм гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь энэ байдлаа өөрчлөх шаардлага тавиагүй бол тийм гэр бүлүүдийг хэвээр байлгахыг зөвшөөрөх болсон байна.[1670] Тэнгэрийн (нас барагчдын хүүрээр махчин шувуу хооллох), усны (голд хаях) зэрэг оршуулгын уламжлалт төрлүүдийг зөвшөөрчээ.

Шинэтгэлд мөнгө гаргахаар болжээ. Гэвч дээр дурдсан баталгаа, тэтгэлэгүүдийн үлэмж хэсэг удирдлагын ажилтнуудын авилгалын сүлжээ болон тэдний мэдлэг боловсролын доод түвшингээс болж зориулалтаараа зарцуулагдаж чадаагүй ажээ. Түвдээс буцаж байгаа хятад кадр ажилтнууд аль болох их тансаг эдлэл, ялангуяа алт, урлагийн бүтээл, тэр үед хятадад ховор байсан цэвэр модон тавилга авч явахыг хичээдэг байжээ.[1671] Хөдөө орон нутгийн олонхи хятад кадр ажилтныг буцсаны дараа тэндхийн хүн ам сврага, маань, мэгзэмийн уншлагууд бичсэн ханануудыг сэргээн босгож эхэлсэн байна. Эцэг эхчүүд анх удаа хүүхдүүдээ лам нарт өгч хүмүүжүүлэх боломжоор хангагдав. Залуу үеийнхэн Түвдийн түүх, соёлын тухай үнэнийг мэдэх боломжоор мөн анх удаа хангагдав.

Төрөл төрөгсөдтэйгээ уулзах гэсэн дүрвэгчдийн тухайд тавигдаж байсан хязгаарлалтуудыг зарим байдлаар хүчингүй болгож эхэлсэн байна.

1980-аад онд ХКН Соёлын хувьсгалын жилүүдэд гэмт хэрэг үйлдсэн гурван төрлийн хүмүүсийг цэвэрлэх ажиллагаа явуулав. Гэвч Түвдэд тийм цэвэрлэгээ хийгээгүй, яагаад гэвэл эндхийн коммунистуудын хувьд хэн нь хэнийгээ цэвэрлэх билээ. “Зүүнтнүүд” намын чиг шугамыг аман дээрээ сайшаан дэмжсэн боловч радикал үзэлтнүүд хэвээр үлджээ. Шашны нөлөөг багасгах хэрэгтэй, түвдийн соёл бол хоцрогдсон зүйл мөн гэж тэд үзэж байна. 1983–1984 онуудад БНХАУ-д олон “зүүнтэнг” цагаатгасан байна. Бүх зүйл шинэ бодлогын ачаар шийдэгдэнэ биз хэмээн. найдаж өнгөрсөн “алдаагаа” үл тоомсорлох хандлага бий болжээ. Хуучин хатуужлын Түвд кадр ажилтнуудыг шинэчлэн өөрчилж болно гэж Ху Яобан 1984 онд мэдэгджээ.[1672] Тэрээр ийм кадр ажилтнуудыг дэвшүүлж эхэлжээ. “Зүүнтнүүдийг” ийнхүү аварсан явдал ТӨЗО дахь хятадын шинэ коммунистуудад гутрангуй сэтгэгдэл төрүүлжээ. Хожим нь Банчин лам Түвдийн “зүүнтнүүд” Соёлын хувьсгалын үед гэмт хэрэг үйлдэж байсан хэдий ч зүүний атгаг үзлээсээ татгалзахгүй байна, нам тэдэнд шинэ шинэ албан тушаал өгч байна гэсэн гомдол гаргажээ. Энэ явдал одоог хүртэл ноцтой уршиг дагавартай байгааг бид авч үзнэ.

1985–1988 онд У Зиньхуа ТӨЗО-ны намын хорооны нарийн бичгийн дарга байв. Тэрээр энэ албан тушаалд орсныхоо дараах анхны үгээ Түвд хувцастай хэлжээ.[1673] Түүний захирамжаар Маогийн үеэс үлдсэн лоозон, зурагт хуудсуудыг авч, шашинд хандах хандлагыг сайжруулсан байна.

1987 оны нэгдүгээр сард ХКН дахь хуучинсаг үзэлтнүүд “алдаагаа шүүмжилснийх нь” дараа Ху Яобаныг засгийн эрхнээс зайлуулж чаджээ. ТӨЗО-ны “зүүнтнүүд” энэ үйл явдлыг баярлан тэмдэглэсэн хэмээх яриа байдаг юм.[1674] Гэтэл 1987 оны гуравдугаар сарын 28-нд Банчин лам Бээжин хотноо Ардын Төлөөлөгчдийн Хурлын Байнгын Хорооны хуралдаан дээр үг хэлэхдээ Түвдэд явуулсан Ху Яобаны бодлого, үйл ажиллагааг нааштай байдлаар үнэлсэн байна. Энэ бол Түвдэд ямар нэгэн анхаарал тавьсан цорын ганц дээд тушаалын удирдагч байсан юм гэж тэр хэлсэн байна. Банчин ламын хэлсэн үг БНХАУ-д шүүмжлэлтэй, бас нааштай, төвийг сахисан байдлаар хандах өнгө аястай байжээ.[1675] Тэрээр 1959 оны бослогын үед түвдчүүдийг хүйс тэмтэрч устгасан зарим баримтуудыг дэлгэрүүлж яриад коммунистууд сайны зэрэгцээ бас муу үйл хийсэн юм гэж хэлжээ. “Хэрэв та бүхэн үндэсний цөөнхийг захирч, нухчин дардаг тийм байдалд татагдаж орсон бол ирээдүйд ноцтой асуудал үүсэх болно” гэж тэр хэлсэн байна. Энэ үг хожим биелсэн билээ.

1988 оны сүүлчээр ТӨЗО-ны ХКН-ын хорооны нарийн бичгийн

даргаар Ху Зиньтао томилогдсон бөгөөд тэрээр үүнээс өмнө Ганьсу мужид энэ албан тушаалыг хашиж байжээ. Тэр хүн Түвдэд биш, харин Бээжинд аль болох удаан байхыг эрмэлздэг байсан гэж түүнтэй хамт ажиллаж байсан хүмүүс ярьжээ.[1676] Энэ хандлага ч үр дүнгээ өгч, 1992 онд түүнийг Түвдээс татаж, намын төв байгууллагуудад авч иржээ. Ху Зиньтао түвдийн намын ажилтан Рагдийг дэмждэг байжээ. Энэ хүн тухайн үедээ "үймээн дэгдээгчдийг" тэргүүлж, дараа нь орон нутгийн хувьсгалт хорооны нэрд гарсан гишүүн болсон нэгэн ажээ.[1677] Түүний албан ёсны намтраас үзвэл[1678] Бээжин хотын Улс төрийн шинжлэх ухаан, хууль тогтоомжийн судлалын Төв сургуульд 1959–1961 онд суралцаж, 1961 онд ХКН-д элсэж, 1962-оос 1966 онд Нагчу тосгоны аюулаас хамгаалах байгууллагад ажиллаж, 1968–1979 онд Нагчугийн, дараа нь ТӨЗО-ны хувьсгалт хорооны орлогч даргаар ажиллажээ. 1982 онд ХКН-ын төв хорооны гишүүн болсон байна. Ингээд түвдийн удирдлагад байр сууриа бэхжүүлжээ. 1993 онд ТӨЗО-ны ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хорооны дарга буюу ТӨЗО-ны засгийн газрын орлогч дарга болж, 2008 онд ТӨЗО-ны хөгжлийн хорооны хүндэт дарга болсон байна. Соёлын хувьсгалын дүнд гарч ирсэн бусад хүн ч чухал чухал албанд ажиллажээ.

ТӨЗО-нд баримтлах хятадын бодлого улам харгис шинж чанартай болж, Соёлын хувьсгалын үеийн арга барил, үг хэллэг ч хэрэглэх болсон нь гайхал төрүүлэхгүй бизээ. Ийнхүү хатуурхах болсны шалтгаан зөвхөн кадр ажилтнуудад байсан юм бишээ. Коммунист нам болон шашны хоорондын түгшүүртэй байдал улам их болсон явдал чухал нөлөөтэй байв. Ард түмний аж байдал дээшилж, эдийн засаг либералчлагдсаны улмаас хандивын хэлбэрээр сүм хийдэд орж ирэх мөнгөний урсгал их болсон нь ХКН-ынхны санаанд нийцсэнгүй.[1679] Түүнээс гадна Ху Яобаны бодлогыг олон хүн түвдэд хятадын эзэгнэл гарч ирэх аюул хэмээн үзэж байлаа.

1988 онд ХКН-ын улс төрийн товчоонд болсон зөвлөлгөөн дээр Түвдийг хятадад эдийн засгийн талаар интеграцчилах үйл явцыг түргэтгэж, аюулгүй байдлын механизмыг хүчтэй болгож, намын боловсон хүчний шилэлт сонголтыг сайжруулж, Далай лам буцаж ирэх боломжоос татгалзах шийдвэр гаргав.[1680] Түвдийн асуудлаар1994 оны дөрөвдүгээр сард болсон ажлын гуравдугаар чуулга уулзалтаас үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт, ажиллах хүчин татах замаар ТӨЗО-ны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, түүнчилэн түвдийн бурханы шашныг шинэтгэх гэсэн хоёр чухал стргатеги боловсруулан гаргажээ.[1681] Ху Зиньтао 2002 онд ХКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, 2003 онд БНХАУ-ын дарга болов. Түвдэд баримтлах

хатуу бодлого өөрчлөгдөөгүй нь ойлгомжтой. Ингэхдээ БНХАУ Бага ард түмнүүдийг ялгаварлан гадуурхахаас сэрэмжлэх, тэдний эрхийг хамгаалах асуудлаар НҮБ-ын Дэд Комиссоос 1991 оны наймдугаар сарын 23-ны өдөр гаргасан 1991/10 тоот тогтоолыг үл тоомсорложээ. Энэхүү тогтоолд Төвдийн ард түмний суурь үндсэн эрхийг байнга зөрчиж, энэ ард түмний соёл, шашин, үндэсний нэгдмэл байдлыг устгах аюул учруулж байгаа явдалд сэтгэл ихэд түгшиж байгаагаа илэрхийлээд эдгээр эрхийг хүндэтгэхийг БНХАУ-ын засгийн газарт уриалсан байна.

### *Түвдийн ард түмний тэмцэл, Далай лам ба түвдийн дүрвэгчид*

Арван дөрөвдүгээр Далай лам “хэрэв ард түмэнтэйгээ хамт байхыг хүсвэл” Түвдэд эргэж ирж болох юм гэж 1977 онд Агваан Жигмэд мэдэгдсэн байна.[1682] Далай ламын ах Гьело Дондов 1979 онд БНХАУ-ын засгийн газрын урилгаар Бээжинд иржээ. Түвдийн тусгаар тогтнолоос бусад аль ч асуудлыг хэлэлцэхэд бэлэн байна гэж Дэн Сяопин хэлжээ.[1683] Дэн Сяопин нас барж, хэлэлцээ хийх гэсэн олон удаагийн оролдлого нурсаны дараа ХКН-ын төв хорооны Нэгдсэн Төв Фронтын ажлын хэлтсийн орлогч эрхлэгч Жу Вэйцюнь хэлэхдээ Дэн хэзээ ч ийм үг хэлээгүй, түвдчүүд л бүгдийг санаанаас зохиож байна гэж мэдэгджээ.

Далай ламын маш сайтар сонгож авсан таван хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 1979 оны наймдугаар сарын 2-нд Бээжингээр дамжиж Түвд орохоор Дели хотоос морджээ.[1684] Хятадын эрх баригчид бас гурван хэсэг төлөөлөгчид явуулах тухай Далай ламын саналыг хүлээж авсан байна. Хятадын эрх баригчид сэрэмжлэх арга хэмжээ авсан хэдий ч төлөөлөгчдийг Түвд, Амдод олон мянган түвдчүүд баяр хөөртэй угтан авчээ. Тиймээс төлөөлөгчдийг Шигазе, Сажа, Гъянзед очиход тэндхийн түвдчүүдийг хөдөө орон нутагт ажиллуулахаар явуулжээ.[1685]

Өндөр албан тушаалын нэг кадр ажилтан: “Сүүлийн хорин жилийн бүх хүчин чармайлт ганцхан өдөрт алга болдог байжээ” гэсэн үг амнаасаа унагахыг төлөөлөгчдийн нэг гишүүн сонсжээ.[1686] Төлөөлөгчид Бээжинд буцаж ирээд түвдчүүд даанч ядуу, хаашаа ч гарах газаргүй болсныг хараад үнэхээр балмагдалд орлоо гэж ярьсан байна. 1979–1980 онд Далай ламын гурван хэсэг төлөөлөгчид БНХАУ-д иржээ. Дөрөв дэхийг ч явуулахаар бэлтгэж байжээ.[1687] Гэтэл 1980 оны наймдугаар сарын 6-нд Хятад улс төлөөлөгчдийг хүлээж авч чадахгүй гэж мэдэгдсэн байна. Ингээд хэд хэдэн удаа сануулсны эцэст 1985 онд Түвдийн зүүн хойд нутагт очихыг

зөвшөөрсөн байна. Тэр үеэс хойш нэг ч төлөөлөгчдөд тус бүс нутагт очихыг зөвшөөрөөгүй ажээ. Гьело Дондов 2002 оны долдугаар сард албан ёсны төлөөлөгчийн хувьд биш, зүгээр л хувь хүний журмаар Бээжин, Лхасаар орсон ажээ.

1982 онд Далай ламын элч нар хятадын эрх баригчидтай дахин хэлэлцээ хийж, Их Түвдийг БНХАУ-ын бүрэлдэхүүнд улс төр-засаг захиргааны нэг нэгж болгон нэгтгэж, түвдэд Гонконгийнхтай адил статус эрх олгохыг санал болгов.[1688] Өөрөөр хэлбэл "нэг орон, хоёр байгуулал" зарчмыг хэрэгжүүлэх санал тавьсан юм. Гэвч хятадын эрх баригчид татгалзав. 1984 оны хэлэлцээн дээр тэд Далай ламын статус болон түүний буцаж ирэх болзлыг л авч үзэхийг зөвшөөрчээ. Хятад-түвдийн харилцааг 17 зүйлт Хэлэлцээрээр зохицуулах болсон юм гэж хятадын эрх баригчид иш татан хэлжээ.[1689] Гэтэл энэ хэлэлцээр нэгэнт мөрдөгдөхөө больсон билээ.

Мэдээллийн Синьхуа агентлаг хятадын тал татгалзсаны шалтгааныг нарийвчлан тайлбарлахдаа: "Далай лам түвдэд "нэг орон, хоёр байгуулал" томьёолол нэвтрүүлэхийг эрмэлзэж байгаагаа мэдэгдэж байна. Энэ бол бас л биелэхийн аргагүй худал үг. Хуучин Түвдэд феодал-боол эзэмшлийн дэглэм байсан бөгөөд тэнд төр, шашин хоёр бүхэл бүтэн нэг зүйл байсан юм. Энэ дэглэмийг бүр 1959 онд тэнд эхэлсэн ардчилсан шинэтгэлийн явцад устгасан билээ. Ингэхлээр Түвдэд феодал-хамжлагат ёсны байгуулал сэргээн тогтоох хэрэг байгаа гэжүү? Далай "ардчилал","эрх чөлөөний" талыг баримталдагаа зарлаж, Түвдэд "ардчилал","эрх чөлөө" сэргээн тогтоох хэрэгтэй гэж мэдэгдэж байна. Энэ бол бүр утгагүй зүйл. Хуучин түвдийн гурван томоохон эзний гол төлөөлөгч болох Далай лам феодал-боол эзэмшигчдийн балмад, харанхуй ноёрхол тулган хүлээлгэж байв. Энэ нөхцөлд ардчилал, эрх чөлөө гэж мөрдөгдсөн байж таарах уу? Гэтэл өнөөдөр тэрээр "ардчилал", "эрх чөлөөг" эрхэмлэгчийн дүрд тоглож байгаа нь ардчилал, эрх чөлөөг бүдүүлгээр доромжилж, дайран давшилж буй хэрэг мөн" гэж мэдэгджээ.[1690]

Энэ бол бодит баримтыг мушгин гуйвуулсан хэрэг мөн. Жинхэнэ шалтгаан энгийн бөгөөд Гонконгд Бээжин "тодорхойлолтын дагуу" дуулгавартай байх ёстой хан үндэстэн олонхи нь, харин ТӨЗО-нд бол түвдчүүд байгаа бөгөөд тэдний олонхи нь "салан тусгаарлагчид". Цаашилбал, Арван дөрөвдүгээр Далай лам гадаадад цагаачлан гарахаасаа бүр өмнө "феодал-хамжлагат ёсны"[1691] байгууллыг өөрчилж эхэлсэн, Энэтхэгт очсоныхоо дараа цагаач иргэдийнхээ дотор ардчилсан өөрчлөлт хийж, нийт Түвд орныг ардчилах төлөвлөгөө санал болгосон юм. Түвдэд

хэний ноёрхол илүү “зэрлэг, харанхуй” байсан бэ-феодалуудынх уу, коммунистуудынх уу, чухам юу жинхэнэ шог зохиол шиг сонсогдож байна вэ гэдгийг бид өмнөх бүлгүүдээс олж мэдсэн билээ. “Хятадууд “хоёр байгуулалд” дургүйтэй адил, түвдчүүд ч “нэг оронд” дургүй юм байна гэж хятад эрдэмтэн Л.Сун маш оножхэлжээ.[1692]

1980-аад онд XIV Далай лам болон түүний ард түмэн түвдийн асуудлыг интернационалчилж чадсан билээ. Энэ бол чухал ололт болсон юм. Түвдийн төлөө бүх дэлхийн хөдөлгөөн бий болж, түүнд оролцогчид дэлхийн ард түмэн, тэндхийн эрх баригчид, олон улсын байгууллагуудын анхаарлыг энэ орны нөхцөл байдалд хандуулж, дүрвэгчдэд туслах ажил зохион байгуулж байна. Дэлхийн олон оронд Түвдийг дэмжих засгийн газрын бус бүлгүүд байгуулагдав.[1693] Орост Москва, Петербург, Халимаг, Буриад,Тувад Түвд анд нөхдийн нийгэмлэгүүд бий. Түвдийн цагаач засгийн газар Вашингтон, Нью-Йорк, Лондон, Токио, Цюрих, Москвад төлөөлөгчийн газраа нээжээ. Түвдийн соёлын болон бурханы шашны олон төв нээгдэв. Тийм төвүүд Орос, Монгол, Бутан, Балба, Энэтхэг, БНХАУ(тийм төв Гонконгд бий, бусад газарт байж болох юм) зэрэг бүх хүн ам нь буюу түүний зарим хэсэг түвдийн бурханы шашныг шүтдэг орнуудын хувьд онцгой чухал юм.

Түвдэд “эрэг шураг чангалж байсан хэдий ч “Далай ламын төлөөлөгчид болон хятадын эрх баригчдын хэлхээ холбоо үргэлжилж иржээ. 1987 оны есдүгээр сарын 21-нд АНУ-ын Конгрессийн хүний эрхийн асуудал эрхэлсэн хорооны хуралдаан дээр Далай лам 5 зүйлээс бүрдсэн Энхийн төлөвлөгөөг зарлан мэдэгдсэн юм. Эдгээр зүйлийг жагсаавал: “1. Бүх Түвдийг энх тайвны бүс болгох. 2. Хятад улс түвдчүүд үндэстний хувьд оршин тогтноход заналхийлсэн хүн ам шилжүүлэн суурьшуулах бодлогоосоо татгалзах. 3. Хүний үндсэн эрх, түвдийн ард түмний ардчилсан эрх чөлөөг хүндэтгэх. 4. Хүрээлэн буй байгаль орчныг сэргээн тогтоож, хамгаалах, Хятад улс Түвдийг цөмийн зэвсэг үйлдвэрлэх газар, цөмийн хаягдлын цэг болгон ашиглахаас татгалзах. 5. Түвдийн ирээдүйн статусын тухай, түвд, хятадын ард түмний харилцаа холбооны тухай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэх явуулах” зэрэг болно.[1694]

Таван зүйлт төлөвлөгөөг 1988 оны зургадугаар сарын 15-нд Далай ламын Страсбургийн санаачлагад өргөжүүлсэн байна. Түүний үндсэн заалтууд: “Бүх Түвд нь хууль тогтоомжийн үндсэн дээр, хүн амын саналын дагуу, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангаж, хүмүүс болон хүрээлэн буй орчныг хамгаалах эрх ашгийн дагуу БНХАУ-ын бүтцэд байгуулагдсан ардчилсан өөрөө удирдах ёс бүхий улс төрийн нэгж байх ёстой. БНХАУ-

ын засгийн газар урьдын адил түвдийн гадаад бодлогын төлөө хариуцлага хүлээж болно. Энэ нөхцөлд түвдийн засгийн газар Гадаад хэргийн яамаараа дамжуулан шашин, худалдаа, боловсрол, соёл, аялал жуулчлал, шинжлэх ухаан, спортын салбар болон улс төрийн бус бусад хүрээнд олон улсын харилцааг бие даан хөгжүүлж болно.

Түвдийн засгийн газрыг үндсэн хуулийн үндсэн дээр эмхлэн байгуулдаг байх ёстой. Үндсэн хуулинд ардчилсан. удирдлагын зарчмуудыг суулгаж өгсөн байх ёстой... Энэ бол түвдийн засгийн газар Түвд болон түүний хүн амтай холбогдсон бүх асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байх болно. <....> Түвдийн засгийн газар үг хэлэх эрх чөлөө, хурал цуглаан хийх, шашин шүтэх эрх чөлөөг оролцуулан хүний эрхийн түгээмэл тунхаглалд илэрхийлсэн зарчмуудыг бүрэн баримтлан ажиллаж тийм эрх чөлөөг хангахыг эрмэлзэх болно. Түвдчүүдийн үндэсний өвөрмөц байдал шашинд үндэслэдэг, харин оюун санааны үнэт зүйлс нь Түвдийн баялаг соёлын голт зүрхэнд байдаг болохоор Түвдийн засгийн газар шашны эрх чөлөөг онцгойлон хамгаалж, хөгжүүлэх болно. Засгийн газар нь ард түмнээс сонгогдсон засгийн газрын тэргүүн, хоёр танхимт хууль тогтоох байгууллага, түүнчилэн бие даасан шүүхийн системээс бүрдэх ёстой. Засгийн газрын төв байр Лхас хотод байх ёстой. Түвдийн нийгэм-эдийн засгийн системийг түвдийн ард түмний эрх ашгийн дагуу, улс орны нийт хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх шаардлаггыг харгалзан үзэх үндсэн дээр төлөвшүүлэн тогтоох ёстой.

Түвдийн засгийн газар зэрлэг амьтад болон ургамал хамгаалсан хатуу хуулиуд гаргана. Байгалийн нөөц баялаг боловсруулан эзэмших ажлыг нарийвчлан зохицуулна. Цөмийн болон бусад төрлийн зэвсэг үйлдвэрлэх, турших, хадгалахыг, түүнчилэн атомын эрчим хүч болон аюултай хаягдал бий болгодог бусад технологи ашиглахад хориг тогтоох ёстой. Түвдийг манай гаригийн байгалийн томоохон дархан цаазат газар болгож хувиргах төлөвлөгөө Түвдийн засгийн газрын зорилтуудын нэг байх болно. Цэрэг зэвсэггүй болгох аргаар Түвдийг бодит байдалд жинхэнэ энх тайвны бүс болгохын тулд энх тайвны төлөө бүс нутгийн бага хурал хийлгэх нь чухал байна. Тийм бага хурал хийлгэж, цэрэг зэвсэггүй болох үйл явцыг эхлүүлж, түвдийг төвийг сахисан бүс болгох хүртэл Хятад улс гагцхүү батлан хамгаалах зорилгоор хязгаарлагдмал тооны цэргийн ангийг Түвдэд үлдээх эрх эдэлж болно. ...Хятадын засгийн газар Түвдэд хүний эрх зөрчихөө зогсоож, хятадуудыг түвдэд шилжүүлэн суурьшуулах бодлогоосоо татгалзах ёстой”.[1695]

Тийнхүү Далай лам түвдийн тусгаар тогтнолыг шаардахаасаа татгалзсан

юм. Түүний санал болгосон бүх зүйл ардын засаг, өөрөө удирдах ёс, өөртөө засах эрх, ард түмний санал бодлоо илэрхийлэх эрхийн зарчмуудад, өөрөөр хэлбэл хятадын суртал нэвтрүүлгийнхний зарлан тунхагладаг бүх зүйлд бүрэн нийцэж байгаа юм.

XIV Далай ламын энхийг эрхэмлэгч үйл ажиллагаа түүнийг бүх дэлхийд хүлээн зөвшөөрүүлсэн юм. Янз бүрийн жилүүдэд тэрээр эрдэм шинжилгээний, шашны, олон нийтийн байгууллагуудын олон шагнал, хүндэт цол хэргэм хүртжээ. Түвдийн эрх чөлөөний төлөө, түүний түүх, соёлын өвийг хадгалж үлдэхийн төлөө энх тайванч, хүч үл хэрэглэсэн тэмцэл явуулсныхаа төлөө 1989 оны арванхоёрдугаар сарын 10-нд Далай лам Нобелийн энх тайвны шагнал хүртсэн билээ. Далай лам хэлсэн үгэндээ Энх тайванч төлөвлөгөөгөө нарийвчлан тайлбарлаж, ахимсын буюу хор хохирол үл учруулах бүс байгуулах санал тавьжээ:

“Түвдийн бүх өндөрлөг цэрэггүй бүс болох ёстой; түвдийн өндөрлөгт цөмийн болон бусад зэвсэглэл үйлдвэрлэх, турших, хадгалахыг хориглох ёстой; Түвдийн өндөрлөг дэлхийн томоохон байгалийн буюу биомандлын цэцэрлэгт хүрээлэн болох ёстой; Амьтан, ургамалын аймгийг хамгаалах хатуу хуулиуд гаргах ёстой; экологийн зохих системүүдэд хохирол учруулахгүйн тулд ашигт малтмал боловсруулах ажлыг нягт хяналтын дор хийх ёстой; Түвдийн хүн ам суурьшсан нутгуудыг хөгжүүлэх ирээдүйн программд байгаль хамгаалах заалтууд оруулах ёстой; хорт хаягдал бүхий цөмийн эрчим хүч болон бусад технологи үйлдвэрлэж, ашиглахыг хориглох нь зүйтэй; үндэсний нөөц болон улс төрийн бодлого энх тайвныг жинхэнэ ёсоор дэмжин сахиулах, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн байх ёстой; Түвд орон энх тайвныг бэхжүүлэхийн төлөө, амьдралын бүх хэлбэрийг хамгаалан тэмцэж буй байгууллагуудын хувьд зочломтгой айл гэр болох ёстой юм; Түвдэд хүний эрхийг өргөжүүлж, түүнийг хамгаалахын төлөө тэмцдэг олон улсын болон бүс нутгийн байгууллагууд бий болгохыг хөхүүлэн дэмжвэл зохино”.[1696]

БНХАУ-ын удирдлага Страсбургийн санаачлагыг няцааж, хэлэлцээ хийхээс булзав. Далай лам 1991 оны аравдугаар сард Йелийн их сургуульд хандаж гаргасан уриалгадаа шинэ санал дэвшүүлэв.[1697] Тэрээр нөхцөл байдалтай газар дээр нь танилцахын тулд хятадын удирдагчдаас хэн нэгнийг дагуулан Түвдэд очихыг хүсчээ. 1991 оны арван хоёрдугаар сард БНХАУ-ын ерөнхий сайд Ли Пэнийг Энэтхэгт очиход Далай лам түүнтэй уулзах гэж эрмэлзсэн боловч бүтсэнгүй. Далай лам урьдчилсан болзол тавилгүйгээр хэлэлцээ хийхийг санал болгож, 1993 онд Дэн Сяопин, Зян Зэминь нарт

биечлэн хандсан захидал бүхий төлөөлөгчдийг Бээжин рүү явуулсан байна. Тэрээр буулт хийхэд бэлэн байгаагаа дахин онцлон тэмдэглэжээ. Гэтэл энэ саналыг ч хүлээж аваагүй юм.

Синьхуа агентлагийн баталснаар "1992, 1993 онд Төв засгийн газрын зохих хэлтсүүд Далай ламын бие төлөөлөгчдийг хоёр удаа хүлээн авч уулзжээ. Энэ нөхцөлд дээр дурдсан төлөөлөгчдөд хоёр талын хэлхээ холбооны тухай ч, Төв засгийн газартай хийсэн хэлэлцээний агуулгын тухай ч бусад оронд мэдээлэхгүй байна гэж амалжээ. Гэтэл дээрх уулзалтуудын дараа тэд өгсөн амлалтаа олон удаа зөрчиж, хэлхээ холбооны тухай гадаадынханд яриад зогсоогүй жинхэнэ бодит байдлыг гуйвуулан харуулах имгэж эрмэлзэхдээ хэлэлцээний агуулгыг мушгин гуйвуулж мэдээлсэн байна".[1698] Гэтэл бодит байдалд бүх зүйл эсрэгээр эргэжээ. Түвдийг дэмжих бүлгийнхэн эдгээр хэлэлцээний утга агуулгын тухай ядахдаа ямар нэгэн мэдээлэл авах гэж эрмэлзсэн боловч түвдчүүд дуугүй суугаад өнгөрүүлжээ. Дээрх уулзалтуудын тухай мэдээлэл БНХАУ-ын олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэд хэдэн удаа цацагдсаны дараа буюу 2006 оны сүүлчээр л энэ хэлэлцээнд Далай ламын тусгай төлөөлөгчөөр оролцсон Лоди Гьяри хятадуудаас мэдээллийн хэрэгслүүдэд "шидэж өгсөн" хэлэлцээний агуулгын тухай гуйвуулгад хариу өгөхөөс өөр аргагүй болсон учир анх удаа энэ асуудлаар олон нийтэд ханджээ.

Энэ зуурт дүрвэгчид ирээдүйн түвдийн засаглалын бүтэц болон Үндсэн хуульд хэд хэдэн ардчилсан өөрчлөлт хийж, орчин үеийн Түвд болон цагаачдын засаглалын бүтцээс засгийн эрх шилжүүлэх журам боловсруулжээ. 1992 оны нэгдүгээр сард Далай лам "Түвдийн ирээдүйн нийгмийн байгууллын зөвлөмж болон түүний үндсэн хуулийн гол гол шинж чанаруудыг" танилцуулж хэлэхдээ "Түвдийн ирээдүйн засгийн газар ямар нэгэн үүрэг хариуцлага" хүлээхгүй, улс төрийн уламжлалт байр сууриа өөрөө тодорхойлж байх болно гэдгээ мэдэгджээ.[1699] "Түвдийн ирээдүйн засгийн газрыг сонгох насны хязгаарын үндсэн дээр ард түмэн сонгож байх болно" гэж тэр хэлсэн байна. Хятад цэрэг гаргах, үндсэн хууль хүчин төгөлдөр болох хоёрын хоорондох хэсэг хугацаанд төр улсыг удирдах үүргийг одоо түвдэд ажиллаж буй Түвд түшмэлүүдэд оноох болно. Энэхүү шилжилтийн хугацааны үеэр ерөнхийлөгчийг томилох бөгөөд Далай лам улс төрийн эрх, үүргээ түүнд шилжүүлнэ. Түвдийн цагаач засгийн газар үүгээр үйл ажиллагаагаа зогсооно гэж тэр мөн мэдэгджээ.

2002 онд Далай лам Түвдийн улс төрийн удирдагчийн үүргээсээ татгалзжээ. Самдан ринбүүчи Түвдийн цагаач засгийн газрын тэргүүн

болсон байна. Одоогийн байдлаар Дарамсалад хууль тогтоох (парламент), гүйцэтгэх (засгийн газар), шүүхийн (түвдийн шүүхийн дээд комисс) хэмээх түвдийн төв засаг захиргааны гурван засаглал ажиллаж байна. “Цагаач түвдчүүдийн харти” бичиг хэмээх нэртэй үндсэн хууль үйлчилж байна. Парламентын 46 гишүүний 43-ыг ард түмэн сонгож, гуравынх нь нэрийг Далай лам дэвшүүлнэ. Дараах гол гол газрууд буюу боловсролын, санхүүгийн, шашны,соёлын, дотоод хэргийн, мэдээлэл ба олон улсын харилцааны, аюулгүй байдал ба эрүүлийг хамгаалахын удирдах гэзрууд сайд нарын зөвлөлд захирагдана.

Түвдчүүд цагаачлалд байх үедээ Далай ламын удирдлагаар шашныхаа үйлийг сэргээж, эх орондоо уналтад орсон соёлынхоо уламжлалыг хадгалан үлдэж чаджээ. Энэтхэгт Сэра, Дрепун, Гандан болон бусад хийдийг сэргээж: шашны боловсрол, очирт хөлгөний номын зан үйл, төрийн үзмэрчдээс зөн билэг хүртэх, хойд дүрээр тодорсон лам нарыг эрж олох зэрэг үйлдлүүдийг бүрэн хэмжээгээр шинэчлэн сэргээжээ. Далай лам өөрийнх нь хамаардаг гэлуги чиглэлийн уламжлал төдийгүй түвдийн бусад бүх чиглэлийн шашны уламжлалыг сахин хадгалах явдлыг зорилтоо хэмээн үзэж байна.

Түвдийн цагаач засгийн газрын мэдээлэл ба олон улсын харилцааны удирдах газрын мэдээгээр бол 2007 оны байдлаар Түвд дүрвэгчдийн тоо 145 мянга орчим болжээ. Тэд янз бүрийн оронд аж төрж байгаа боловч гол төлөв Энэтхэг, Балба, Бутанд байна. Эдгээр газарт 58 Түвд суурин байна. Түвд цагаач иргэд лам, гэлэнмаа нарын 200 гаруй хийд үндэслэн байгуулж, тэдгээрт 20 мянга шахам лам сууж байна.[1700] Энэтхэг, Балба, Бутанд бага болон бүрэн ба бүрэн бус дунд сургууль 84 байна. Олон хүн коллежид элсэн суралцаж байна. Цагаач иргэдийн нийт тоонд коллежийн оюутнуудын эзлэх хувь 7,5 байдаг бол БНХАУ-д энэ үзүүлэлт 0,85 хувь байна. Их дээд сургуулиудын хувьд 4,3 ба 0,7 гэсэн үзүүлэлт гарч байна.[1701] Цагаач иргэд 40 гаруй тогтмол хэвлэл, үүнээс 10 гаруй сонин хэвлэн гаргадаг ажээ. Тэд БНХАУ дахь нутаг нэгтнүүдээ бодоход боловсрол эзэмших, мэдээлэл авах илүү их боломжлоор хангагджээ.

Түвдийн цагаач иргэдийн байгууллагуудын тоо өсч байна. Тэд бүгдээрээ Далай ламд буулт хийсэн хандлагатай байдаг гэж хэлэхэд бас хэцүү. 1991 онд улс төрийн хоригдол байсан хүмүүст туслах зорилгоор Гу Чу Суи хөдөлгөөн байгуулагдав. Одоо энэ хөдөлгөөнд цагаачлахаасаа өмнө Түвдийн улс төрийн ажиллагаанд оролцож байсан, баривчлагдан, эрүү шүүлт амсч байсан бүх хүн оролцох болжээ. Тэд Түвдийн тусгаар тогтнолыг сэргээн тогтоох явдлыг гол зорилтоо хэмээн үзэж байна. 1970

онд үндэслэн байгуулагдсан бөгөөд эгнээндээ 30 мянга гаруй хүн нэгтгэж буй Түвдийн залуучуудын Конгрессийн гишүүд амь насаа золиослоод ч болов Түвдийн бүрэн тусгаар тогтнолын төлөө тэмцэх явдлыг нэг гол зорилгоо хэмээн дэвшүүлэн тавьжээ.[1702] Энэ бол Түвдийн хамгийн том улс төрийн намуудын нэг юм. Түвдийн оршин суугчид бүрэн тусгаар тогтнолоо сэргээж, Далай ламыг эх оронд нь ирүүлж, цэрэг гаргах, ерөөс БНХАУ-ыг эх орноосоо гаргахыг шаардаж байна. Ийм лоозонгийн дор өрнөж буй ард олны хөдөлгөөн, бослого, жагсаал цуглаан бол “Далайн бүлгийн хуйвалдаан” биш, харин ард түмний дургүйцлийн үр дагавар мөн билээ.

Энэ нөхцөлд Далай ламын баримталж буй Дунд замын бодлого нь тун аядуу үйлдэл бөгөөд хэлэлцээ хийх үндэс болгож Дэн Сяопиний зөвшөөрсөн тэр саналд харшлахгүй байна. Дунд замын бодлого дараах гол үндсэн элементүүдийг агуулж байна: “1. Түвдийн төв засаг захиргаа түвдийн тусгаар тогтнолын төлөө тэмцлээс татгалзахдаа түвдийн уламжлалт бүх гурван мужийг бүрэлдэхүүндээ багтаасан нутаг дэвсгэр-улс төрийн нэгжийг сэргээхийг эрмэлзэж байна. 2 Тийм нэгж үндэсний болон бүс нутгийн өөртөө засах эрхийн жинхэнэ статустай байх ёстой. 3. Бүх ард түмний санал хураалтын явцад ардчилсан замаар сонгогдсон хууль тогтоох болон гүйцэтгэх засгийн байгууллагууд тийм өөртөө засах байгууллыг тэргүүлэх ёстой. Түүнээс гадна энэхүү автономид бие даасан шүүхийн систем байх ёстой. 4. БНХАУ-ын засгийн газар түвдэд дээр дурдсан статус эрх олгосны дараа Түвд нь салан тусгаарлахыг эрмэлзэхгүй, харин БНХАУ-ын бүрэлдэхүүнд үлдэх болно. 5. Түвд орон энх тайвны бүс, хүч үл хэрэглэх бүс болж хувирах хүртэл БНХАУ-ын засгийн газар батлан хамгаалах зорилгоор хязгаарлагдмал тооны цэргийг Түвдэд хэвээр үлдээх эрх эдлэнэ. 6. БНХАУ-ын засгийн газар Түвдийн олон улсын харилцааны улс төрийн асуудал болон батлан хамгаалалтын төлөө хариуцлага хүлээж, харин түвдийн ард түмэн шашин, соёл, боловсрол, эдийн засаг, эрүүлийг хамгаалах, экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг Түвдийн амьдралын бусад бүх хэргийг удирдах үүрэг хүлээнэ. 7.БНХАУ-ын засгийн газар түвдэд хүний эрх зөрчих, хятад хүн амыг түвдийн нутаг дэвсгэрт шилжүүлэн суурьшуулах бодлогоо зогсоох үүрэгтэй. 8.Түвдийн асуудлыг зохицуулах зорилгоор дээрхийн гэгээн Далай лам шудрага хэлэлцээ хийх, БНХАУ-ын засгийн газартай эвлэрэл тогтоохын төлөө үндсэн хариуцлага хүлээнэ”.[1703]

2007 онд Далай лам АНУ-ын иргэний дээд шагнал болох тус улсын Конгрессийн алтан медалиар шагнуулав. Эрх баригчид эсэргүүцэж байсан

хэдий ч энэ үйл явдлыг Түвдэд тэмдэглэжээ. Хятад улс “дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцлоо” хэмээн улигт эсэргүүцлээ мэдэгджээ.

Маог нас барснаас хойш нөхцөл байдал сайжирсан хэдий ч улс төрийн мөрдлөг, хавчлага зогссонгүй. 1982 оны тавдугаар сард түвдийн улс төрийн 115 идэвхтэнг баривчилж, “гэмт хэрэгтнүүд”, “хар захын завшаанч” гэж зарлав.[1704] Баривчлан цаазлах явдал дахин дахин давтагдав. 1983 оны арваннэгдүгээр сарын сүүлч гэхэд зөвхөн Лхас хотод улс төрийн 750 идэвхтэн баривчилжээ. 1986 оноос эхлэн Их Түвдийн янз бүрийн нутагт бараг жил бүр хятад захиргааг эсэргүүцсэн тэмцэл хөдөлгөөн гарсан байна.

Далай лам таван зүйлт энхийн төлөвлөгөөг нийтэд зарлан тунхагласнаас хойш хятадын суртал нэвтрүүлэгчид түүний эсрэг шүүмжлэлийн мөндөр буулгав. Үүний хариуд 1987 оны есдүгээр сарын 27, аравдугаар сарын 1-нд Лхас хотод Дрепун, Сэра хийдийн лам нар түвдийн тусгаар тогтнолын төлөө уриан дор эсэргүүцлийн жагсаал зохион байгуулжээ.[1705] Цагдаа нар жагсагчид руу буудаж, олон хүн алж, шархдуулан наад зах нь гэхэд 2500 хүн баривчилжээ.[1706] 1988 онд Лхас хот дахь хятад эрх баригчид Монламын баяр тэмдэглэхийг лам нарт тушаав.[1707] Гэвч лам нар олон санваартан баривчлагдсан болохоор баяр ёслол хийх боломжгүй хэмээн үзжээ. Гэсэн ч баярыг хүчээр тэмдэглүүлэв. Энэ нь гуравдугаар сарын 5-д дахиад л сөрөг төвлөрөл үүсэх шалтгаан болжээ. Цагдаа нар Жокан хийд рүү халдаж, лам нар алагдсан тухай мэдээ ч гарав. 1988 оны арван хоёрдугаар сарын 10-нд Жокангийн дэргэд бас нэг жагсаал болов. Ямар ч байсан нэг офицер цэргүүдээ: “түвдчүүдийг алаад өг” хэмээн тушааж байсан гэж өрнөдийн нэг сурвалжлагч гэрчлэн бичжээ. Ингээд 15 хүн алагдаж, 150 хүн хүнд шардаж, 25 шахам хүн баривчлагдсан байна.[1708]

1989 оны гуравдугаар сарын 5-нд Лхаст дахин үймээн самуун эхэлж, гурвөн өдөр үргэлжилжээ. Хэдэн зуун хүн алагдаж, хэдэн мянган хүн шархдаж, 3 мянган хүн баривчлагдсан юм гэж тэнд байсан хятадын сурвалжлагч Тан Дасян бичжээ.[1709] Албан ёсны мэдээгээр бол 100 гаруй хүн алагдаж, шархдаж, 900 гаруй дэлгүүр,засгийн газрын 24 байгууллага, үйлдвэр, сургуулийн газруудыг тонон дээрэмдэж, 20 автомашин шатаасан байна.[1710] Үүнээс өмнөхөн ТӨЗО-ны ХКН-ын хорооны нарийн бичгийн даргаар томилогдсон Ху Зиньтао цэргийн байдал болон хөл хорих цаг тогтоов. Армийнхан бүх сүм, хийдийг хяналтандаа авч, шашны бүх арга хэмжээ, сэтгүүлчдийн орж ирэх хөдөлгөөнийг хоригложээ. Хэрэв энэ хэрэг

явдлаас өмнө Түвдэд XIV Далай ламын хөрөг өлгөөтэй байсан бол тэрхүү жагсаалаас хойш ийнхүү өлгөхийг хоригложээ. Лхас хотод тогтоосон

цэргийн байдал 1989 оны гуравдугаар сарын 7-ноос 1990 оны тавдугаар сарын 1-нийг дуустал үргэлжилжээ

Түвд орон эзлэгдсэний 40 жилийн ойн өмнөхөн буюу 1991 оны дөрөвдүгээр сарын 10-нд 146 “гэмт хэрэгтэн” баривчилж, олон иийтийн эсэргүүцлийн цуглаан хийвэл илүү олон хүн баривчлана хэмээн зарлав.[1711] Ойн өдөр Лхаст хөл хорих цаг тогтоосон тухай зарлав. 1992 оны хоёрдугаар сард баривчилгаа явуулав. Хятадууд арав арван хүний бүрэлдэхүүнтэй бүлгүүд болж түвдчүүдийн гэр оронд дайран орж, Далай ламын гэрэл зураг, ярианы бичлэг, ном, түүний хэлсэн үг,сургаалийн агуулга зэрэг эд мөрийн баримт илэрвэл түүнтэй холбоо бүхий хүн бүрийг баривчилж байлаа. Нийтдээ 200 гаруй хүн баривчилсан байна.

Түвдийн цагаач иргэдийн байгууллагуудын мэдээллээр бол 1987 оны есдүгээр сараас 1995 оны дунд үе хүртэл ТӨЗО-нд 200 гаруй тэмцэл хөдөлгөөн гарчээ. 1987–1992 онтой харьцуулбал 1993–1998 онд тэмцэл хөдөлгөөн бараг тэн хагасаар өсч, түвдийн бусад нутагт 130 хувиар, Лхаст баривчлагдсан хүний тоо 15 хувиар, ТӨЗО-ны бусад нутагт 250 хувиар тус тус өсчээ.[1712] Хүний эрх, ардчилалын төлөө Түвдийн төвийн мэдээгээр бол 1987-гоос 2007 оныг дуустлах хугацаанд 5 мянга гаруй түвд хүн улс төрийн шалтгаанаар баривчлагдсанаас нэг мянга гаруй нь янз бүрийн хугацаагаар шоронд хоргигдох ял заагдаж, шоронгуудад эрүү шүүлт даалгүй 88 хүн нас барсныг баримтжуулжээ.

1990–1991 онд мөн 1998 онд Драпчийн шоронд олон нийтийг хамарсан эсэргүүцлийн хөдөлгөөн болжээ.[1713] 1959 оны бослогын 40 жилийн ойгоор эрх баригчид Лхаст цагдаагийн томоохон хүч оруулж, гудамжуудад өдөр шөнөгүй эргүүл тавьж, хүмүүс цугларч болзошгүй газруудыг хатуу хяналтад авчээ. Түвдийн тухай уриа лоозон хашгирч эхэлсэн хэд хэдэн хүнийг шууд баривчилжээ. Тэмцэл хөдөлгөөн зохион байгуулах гэсэн хүмүүст муу уршиг дагавар тохиолдоно гэдгийг чанга яригчаар анхааруулжээ.[1714] 2000–2007 онуудад хориотой уриа лоозон хашгирсан, мөн хориглосон түвдийн далбаа өлгөсөн, хятадыг эсэргүүцсэн ухуулах болон зурагт хуудас, шог зураг тараасан, тусгаар тогтнолын тухай дуу дуулсан, ялангуяа XIV Далай ламын гэрэл зураг, CD, дүрс бичлэг, ном, эрх чөлөөнд дуудсан уриалга хадгалсны төлөө гэсгээн цээрлүүлэлт явуулжээ.

Түвдийн эх орончид хүнд уршиг дагавартай байна гэдгийг мэдэж байсан ч ил шууд эсэргүүцлийн хөдөлгөөнөө зогсоосонгүй. Жишээ нь, 2007 оны наймдугаар сарын 1-нд Литангийн районд Адрак гэдэг тариачинг баривчилжээ.[1715] Тэр хүн орон нутгийн баярын үеэр индэрт гарч тэнд


Түвдийн эрх чөлөөний төлөө тэмцэгч Ронгьял Адрак (TCHRD)

байсан түшмэд болон түвдчүүдэд хандаж Далай ламыг нутагт нь буцаан ирүүлж, Банчин ламыг суллаж,Түвдийн тусгаар тотгтнолыг ханган тогтоохыг уриалжээ.[1716] Тэрээр газар, уснаас үүдсэн мөргөлдөөнөө зогсоохыг нутаг нэгтнүүддээ уриалаад "эх оронч хүмүүжлийн" ажилд идэвхтэй оролцсон нэгэн ламыг зэмлэн буруушаажээ. Түүнийг дэмжсэн жагсаал цуглаан болсон ч тэр лам 8 жил шоронд суужээ. "Салан тусгаарлагчтай холбоотой байсан", "хагалан бутаргах үйл ажиллагаа явуулсан", "төрийн нууц задалсан" хэргээр тэр ламын нэг нутгийнхан болон зээ дүү нь 5–10 жилийн хорих ял авсан бөгөөд энэ үйл явдлын тухай мэдээлэл хилийн чанадад цацагдсан байна.[1717] Эв санааны нэгдлийн ажиллагаа явуулсан орон нутгийн түвдчүүдийг 3–10 жилийн хугацаагаар шоронд суулгана хэмээн сүрдүүлжээ.

2008 онд гарсан түвдчүүдийн тэмцэл 1959 оноос хойшхи хамгийн цар хүрээтэй тэмцэл хөдөлгөөн байлаа.[1718] Энэ тэмцэл хөдөлгөөнөөс болж ТӨЗО болон түвдийн бусад мужийг хаахад хүрсэн байна. Энэ тэмцэлд олон мянган хүн оролцжээ. Гуравдугаар сард эхэлсэн энэ хөдөлгөөн 1959 оны бослогын 49 жилийн ой болон 2008 оны наймдугаар сард Бээжин хотод хийхээр төлөвлөсөн олимпийн тоглолтод зориулагджээ. Олимпийн тоглолтыг тасалдуулахыг оролдсон гэж Далай ламыг буруутгав. Гэтэл тэрээр энэ тоглолтыг ямагт дэмжиж, хятадын бараа таваар хориг тавих гэсэн саналыг эсэргүүцэж байжээ.

Бүх зүйл гуравдугаар сарын 10-нд эхлэв. Энэ өдрийн орой Дрепун хийдийн 300 орчим лам Лхас хотын Баркорын гудамж руу тайван жагсаал хийж эхэлсэн байна. Тэдний замыг цагдаа нар хааж, хийд рүү орох замыг хамгаалалтад авч, хэд хэдэн хүн саатуулсан байна. Мөн өдөр Сэра хийдийн 15 орчим лам Баркхорын гудамжинд эсэргүүцлийн ажиллагаа зохион байгуулах гэж оролдсон байна. Тэднийг баривчилсан мэдээ бий. Эсэргүүцлийн ажиллагаа дараа өдөр нь үргэлжлэв. Хүчнийхэн дээрх хоёр хийдийг бүслэв. Түвдийн цагаач иргэдийн мэдээллээр бол тэр өдөр Карзед гурван хүн алагдаж, арван хүн шархадсан байна. Гуравдугаар сарын

12-нд Гандан хийд, дараа нь Жокан, Рамоче зэрэг бусад сүм, хийдийг хамгаалалтад авсан байна. Гуравдугаар сарын 13-нд Лхаст, ялангуяа их сургуулийн эргэн тойронд оюутнуудын зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, таван хүн баривчлав.

Гуравдугаар сарын 14-нд Лхаст олон нийтийг хамарсан тэмцэл хөдөлгөөн гарч, хятад иргэдийг түйвээн бусниулсан байна. Энэхүү эмх замбараагүй явдлаас болж мөн зарим ислам сүсэгтэн хэлмэгджээ. Гэвч Түвдийн ислам сүсэгт залуучуудын холбоо меморандум нийтлүүлж, энэ бүхний хариуцлагыг хятадын засгийн газарт тохож, Далай ламын энхийг эрхэмлэгч үйл ажиллагааг дэмжсэн байна.[1719] Хятадын талын мэдээгээр бол эмх замбараагүй явдлын үеэр 19 оршин суугч амь үрэгдэж, 623 хүн шархаджээ.[1720] 120 айлын байшин, 84 автомашин, нэг мянга гаруй улсын болон хятадуудын дэлгүүр хоршоо, үйлдвэр, банк, цагдаагийн хэсэг шатаажээ. Энэ бол түвдийг хятаджуулж байгааг эсэргүүцсэн ард олны дургүйцлийн тэсрэлт байв. Лхас хотод гэхэд л хятад наймаачдын хохирол 200 сая шахам юань болсон юм гэж “Жэньминь жибао” сонинд мэдээлсэн байна. Хятадуудын олонхи хотын Түвд хэсгээс гарч, хятад хэсэгт бөөгнөрсөн байна. Энэхүү үймээн самууныг Түвд хувцас өмссөн хятадын тусгай албадын туршуулаад өдөөн тухирсан бөгөөд тэд олимпийн тоглолтын өмнө сэтгэл дундуур буй хүмүүсийг баривчлах зорилготой байсан хэмээх мэдээ бий боловч тэдгээр мэдээ үнэн зөв эсэхийг хэн ч шалгаагүй ажээ.[1721] Үүний зэрэгцээ мөн өрнөдийн олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд лам хувцас өмссөн хятад цэргүүдийн гэрэл зургийг олшруулан тараажээ.[1722] Хожим нь энэ бол нэгэн уран сайхны киноны хуучин зургийг хэсэг байсныг тодруулжээ.

Их Түвдийн 60 гаруй цэгт, бас Бээжин, Ланьжоуд эсэргүүцлийн жагсаал цуглаан болсон байна. Энэ бүгдийг үймээн самуун уу, эсвэл тайван жагсаал уу гэдгээс үл шалтгаалан хятадын хүчний байгууллагынхан хүч хэрэглэн даржээ. Хятадын талын мэдээгээр бол ТӨЗО, Сычуань, Хөх нуур, Ганьсугийн түвдчүүд бөөнөөр оршин суудаг нутгуудад гуравдугаар сарын 10-наас 25-нд зодоон, дээрэм, галдан шатаах явдал болж хувирсан хүчирхийллийн 150 гаруй ноцтой ажиллагаа гарч, олон хүн хэлмэгдэж, олон мянган байшин шатжээ[1723] Жагсаалд оролцогчдыг хөөн тарааж, баривчилж, заримдаа байлдааны сумаар цугларсан олон руу буудаж байжээ. Насанд хүрээгүй хүүхэд, эмэгтэйчүүд амь үрэгдсэн тухай мэдээ бий. Эрх баригчид түвдийн цагдаа нарт итгээгүй учир тэдний зэвсгийг хураасан гэж Түвд эх сурвалжууд уламжилсан байна.[1724] Хүчнийхэн хийдүүдэд дайран орж,

хүмүүсийг баривчлан зодож, “хорлон сүйтгэх материал” эрэх нэрийдлээр лам нарыг нэгжиж байв.[1725] Лам нараас амиа хорлох явдал ч гарчээ. Лхаст түвдчүүдийн гэр оронг юу ч үгүй болтол нь хоослон дээрэмджээ. Лхасын нэгэн оршин суугч “бидний араас цагдаа нар ирж, өмд өмсөх зав ч өгөхгүй гэдгийг мэдэж байсан учир хувцастайгаа унтдаг байсан” гэж дурсан ярьжээ.[1726] Цагдаа нар орсон айл болгоноо түйвээн бусниулж байсан тухай мэдээ бий юм.[1727]

Хятад хүмүүсийг бодоход түвдчүүд шашин шүтэх, нааш цааш зорчих эрх чөлөөгөөр удаан хугацаагаар хачигдсан билээ. Гуравдугаар сарын 15-нд ТӨЗО-ны дээд шүүх, дээд прокурорын газар, нийгмийг аюулаас хамгаалах товчоо №1 мэдэгдэл гаргаж, гуравдугаар сарын 17-ноос өмнө бууж өгөхийг үймээн самуунд оролцогчдод санал болгожээ.[1728] Ингэсэн хүмүүст хөнгөн буюу хөнгөрүүлсэн шийтгэл онооно хэмээн амласан байна. Нуун дарагдуулсан этгээдийг хатуу цээрлүүлж, мэдээлэл өгсөн хүнийг шагнана гэж амласан байна. Орон нутгийн телевиз тийм шагналыг цаг ямагт сурталчилж байсан боловч бодит байдалд арав дахин бага мөнгө төлсөн гэж тэр үеийн үйл явдлыг нүдээр үзсэн хүн ярьжээ.[1729] Шоронгууд хүнээр дүүрч, саатуулагдсан хүмүүсийг зодож занчина.

Лхасаас бусад газарт ч хүмүүсийг номхотгох мөн л иймэрхүү арга хэрэглэсэн ажээ. Жишээ нь, Кирти хийдэд 572 лам, олон арван энгийн иргэн баривчилжээ.[1730] 8 хүн алагдаж, хоёр лам амиа хорлосон байна. Баривчлагдсан хүмүүсийн заримыг машины тэвшинд суулган тосгон дундуур авч явсан нь тэндхийн оршин суугчдыг айлган сүрдүүлэх зорилготой байжээ. Баривчлагдсан хүмүүстэй жишээлэхэд дараах байдлаар харьцана.Дөрвөн хүүхдийн эх, 38 настай Түвд бүсгүйг жагсаалын үеэр тосгоны захиргааны газрын хаалгыг хамгийн түрүүнд татаж онгойлгосон хэмээх хэргээр баривчилжээ. Тэр эмэгтэйн нөхөр эрх баригчдаас нуугдаж байсан явдал хүндрүүлэх шалтаг болсон байна. Эмэгтэйг найм хоног суулгасны эцэст тавьж явуулжээ. Эмэгтэйн бие хөх няц болсон, ярьж ч, хоол унд идэж ч чадахгүй, байнга бөөлжис нь цутгадаг, дөнгөн данган амьсгалдаг болсон байжээ. Эмнэлэгт түүнд үйлчлэхээс татгалзсан байна. Ингээд хөөрхий бүсгүй 22 хоноод л насан өөд болжээ. Эрх баригчид энэ эмэгтэйг оршуулах үед уншлага, ном айлдахыг лам нарт хориглосон байна.

Лабрангад тайван жагсаалд оролцсоны төлөө саатуулагдсан түвдчүүдийг бороохойдож, хятадаар өгсөн команд ойлгоогүйнх нь төлөө “мал”,”усан тэнэг” гэж доромжилж байжээ.[1731] Хийдэд өрхийн гишүүд хэн хэн бэ, хийдэд яах гэж ирсэн бэ, бурханы шашин ямар байдалтай




2008 оны дөрөв-тавдугаар сард гарсан түвдчүүдийн эсэргүүцлийн хөдөлгөөний газар зүй (by Ts. Shakya)

байна гэж та боддог вэ, гадаадын радио сонсдог уу, хилийн чанадад гарч байсан уу гэсэн асуултын хуудас тараадаг байжээ.[1732] Ганьзы тойргийн ардын засгийн газрын №2 тушаалд үймээн самуунд шууд оролцоогүй ч түүнд хэрхэн хандаж буйгаа тодорхой илэрхийлж хэлээгүй лам нар, эдгээр үймэн хөдөлгөөнд оролцсон лам нарыг сайн удирдаж чадаагүй тэр хүмүүсийг шүүмжлэл өрнүүлж, дахин хүмүүжүүлэх үеэр нарийвчилсан шалгалтад оруулж, тэдний зан байдлыг нийтийн хуралд оролцогчдын өмнө "нэгбүрчлэн судлаж" тогтоох ёстой юм гэж өгүүлсэн байна[1733]

Дөрөвдүгээр сарын 3-нд БНХАУ-ын нийгмийг аюулаас хамгаалах яамныхан ТӨЗО, Сычуань, Хөх нуур, Ганьсу мужуудын хууль сахиулах байгууллагууд лам нарын "нийтийн байрнаас" 185 нэгж галт, 2139 нэгж хүйтэн зэвсэг, 14367 сум, 3862 кг тэсрэх бодис хурааж авсан байна.[1734] Мөн хориглосон олон далбаа, зурагт хуудас, хэвлэмэл бүтээгдэхүүн хураан авчээ. 500 гаруй лам зэрэг 2200 хүн баривчилжээ[1735] гэж өгүүлсэн байна. Ямар учраас энэ зэвсгийг (үнэхээр бослогчдод байсан юм бол) эмх зхмбараагүй явдлын үеэр хэрэглээгүй юм бол? гэдэг нь ойлгомжгүй байгаа юм. Маркхам гацаанд найман удаа сулавтархан дэлбэрэлт болсныг тэмдэглэж авсан бөгөөд тэнд нэг ч хүн хэлмэгдээгүй ажээ.[1736] Эдгээр дэлбэрэлтийн төлөө олон арван лам баривчлагдаж, дөрөв нь 4-өөс 8 жил шоронд хоригдох ял авсан байна. Үнэн хэрэгтээ бол тэд энэхүү тэсрэх бодисыг барилгын ажилд хэрэглэх зорилгоор нууц биш хэлбэрээр олж авсан байна.

Түвдчүүдийн мэдээлснээр бол мөргөлдөөний үеэр 120 Түвд хүн буун суманд оногдож, 6500 хүн баривчлагдаж, нэг мянга орчим хүн сураггүй алга болжээ.[1737] Баривчлагдсан хүүмүүсээс 1157-г сулласан байна.[1738] Лхас хотод олимпийн гал хүлээж авч, цааш буухиалан явуулах ёслолын ажиллагааны хугацааг энэ үйл явдлаас өмнөхөн Сычуаньд болсон газар хөдлөлтөөр шалтаглан 2 цаг болтол хорогдуулжээ. Эрх баригчид амласныхаа дагуу олимпийн тоглолтын дараа баривчлагдсан хүмүүсийн заримыг суллав. 2008 оны намар хэдэн арван лам нарт оноосон ялыг зарлан сонсгожээ.[1739] Тэд нэгээс 20 хүртэлх жилийн ял авсан байна.

Аравдугаар сарын 27-нд мөн таван түвд хүнд найман жилээс бүх насаар нь шоронд хорих ял өгчээ.[1740] Ялын тийм хугацааг хүний амь хөнөөсөн буюу аллага хядлага үйлдсэний төлөө биш, харин "улс орныг хагалан бутаргах үзэл санаа агуулсан" CD, "бослогод уриалсан" ухуулах хуудас тараасан, Лхаст болсон үйл явдлын тухай мэдээллийг "хилийн чанад руу нууцаар дамжуулсны" төлөө оноожээ. Дэлгүүр хоршоо шатаагчдаас хоёр хүнд цаазаар авах ял оноосноос нэгийнх нь ялын гүйцэтгэлийг түр

хойшлуулжээ.[1741] Хятадын талын мэдээллээр бол 2009 оны хоёрдугаар сар гэхэд ТӨЗО-нд хүч хэрэглэсэн ажиллагаанд оролцсон хэмээх сэжгээр 953 хүн баривчилгаанд байжээ. Хүний эрх, ардчилалын төлөө Түвдийн төвийн мэдээллээр бол 2009 оны гуравдугаар сар гэхэд 70 орчим Түвд хүн амь үрэгдсэн тухай тоо баримт батлагдсан бөгөөд баривчлагдсан 6500 хүний 5 мянга орчим нь хоригдсон хэвээр үлджээ.

Бүр Маогийн үед эхлүүлсэн "эх оронч хүүмүүжлийг" сүм хийдүүдэд улам хүчтэй болгожээ. Энэ хүмүүжил гэгчид "тархи угаахын" зэрэгцээ лам нарын цаашид сүм хийдэд байх эсэх нь шалтгаалах шалгалтын асуултууд оруулсан байна. 2008 оны дөрөвдүгээр сард Нгаба гацаанд энэ кампанит ажлыг энгийн хүмүүсийн тухайд хэрэглэх болжээ. Баривчлана хэмээн сүрдүүлж дараах зүйлийг: Би Далай ламыг эсэргүүцэж байна; түүний гэрэл зургийг гэртээ байлгахгүй; Далай лам миний сэтгэлгээнд нөлөөлөхгүй; үндэстнийг хагаралдуулах салан тусгаарлах үзэл болон хуйвалдаанд оролцохгүй; коммунист намд дуртай; бүх үйл хэрэгтээ түүний сургаалийг дагаж мөрдөнө; түүний аугаа их анхаарал халамжийг хүндэтгэн үзэж байна гэж хүлээн зөвшөөрөхийг шаардах ажээ.[1742] ТӨЗО-нд намын байгууллагуудын цэвэрлэгээ хийв. Зарим түвд хүн албан тушаалгүй болж, шашин шүтэж, гэртээ шашны эд зүйлс, судар ном[1743] хадгалахыг коммунистуудад хориглож, Энэтхэгт суралцаж байгаа хүүхдүүдийг гэрт нь буцааж ирүүлэхийг шаардсан байна.[1744]

Эрх баригчид Түвдийг мэдээллийн бүслэлтэд оруулж, Далай ламын эсрэг суртал нэвтрүүлгийн кампани зохион байгуулж, бүх дэлхийд хятадуудын үндсэрхэх үзлийн давалгаа бий болгов. ХКН-д гомдол гаргаж эхэлнэ гэсэн саналаас ч үндсэрхэх үзэл ханхалжээ. 2008 оны есдүгээр сарын 4-нд "Жэньминьван" Интернет-сайтад дарга Ху Зиньтао, ерөнхий сайд Вэнь Зябао нарыг дэмжигчдийн хуудас нээгджээ.[1745] Дөрөвхөн өдөрт энэ хуудсанд 40 мянган хүн орсон байна. Энэ хуудас нээгдсэнээс хойш 5 сарын дараа хятадын ерөнхий сайд иракийг эзлэн түрэмгийлэх ажиллагааг санаачлагч америкийн ерөнхийлөгч Ж. Бага-Бушийг сонгуульд ялагдахад харамссан цахилгаан утас илгээж байжээ. 2009 оны хоёрдугаар сарын 2-нд Вэнь Зябаог Кембрижийн их сургуульд үг хэлж байхад нэгэн аспирант түүн рүү шаахайгаа шиджээ. 2009 оны зургадугаар сарын 2-нд Их Британий шүүх түүний хэргийг хэрэгсэхгүй болгожээ.[1746]

Түвд ямагт хятадын нэг хэсэг байсан тухай нийтлэлүүд гарч ирэв, жишээ нь, энд "Жинхэнэ түвд", "Түвдийг чөлөөлсөн түүх" зэрэг номыг дурдаж болно. "Чөлөөлөлтийн" тухай энэхүү номыг зохиоход "тэр

чөлөөлөлтөд" оролцсон нэг зуу гаруй эрдэмтэн, намын ахмад ажилтан, генералууд оролцжээ.[1747]

Феодализмын үеийн түвдчүүдийн гунигт амьдрал, социализмын үеийн аз жаргалыг харуулах зорилготой "Түвд орон өнөөдөр ба өнгөрсөн үед" гэдэг нэртэй үзэсгэлэн дөрөвдүгээр сарын 30-нд Бээжинд нээгдэв.[1748] Тийм үзэсгэлэн Соёлын хувьсгалын өмнө Түвдэд, 1991 онд Бээжинд ажиллаж байжээ. Урьдын адил энэ үзэсгэлэнд тавьсан олон гэрэл зураг нэг талыг барьсан, эргэлзээ төрүүлэхээр, гэрэл зураг авсан газар болон эх сурвалжууд тодорхой биш ажээ. Энэ суртал нэвтрүүлэгт гэрэл зураг нь байнга тавигддаг сохор хүн бол хятадын тагнуул байсан хүн юм гэнэлээ гэж түвдчүүд надад ярьсан юм. 1959 онд сэтгүүлч М. Домогацких Жоканад нэг иймэрхүү үзэсгэлэнд нэгэн харалган хүний гэрэл зураг үзсэн байдаг, арай энэ биш байгаа даа? Тэр үед сурвалжлагчид руу нэгэн хүн дөхөж очоод энэ хүний нүдийг Түвдийн зүүн нутагт гарсан бослогын үеэр сохолсон юм гэж хэлжээ.[1749] Түвд, хятадын нэрд гарсан зохиолч эмэгтэй Цэрэносор хятад, түвдийн байдлыг дотор нь орсон юм шиг мэддэг байсан бөгөөд тэрээр ХКН-ын засгийн газар хуучин Түвдийн түүхийг зориудаар мушгин гуйвуулж байгааг нотолжээ.[1750] Хятадад өөр бусад материалыг ч зохиомлоор гаргаж ирж байсан тухай мэдээлэл хангалттай байдгийг нэмж хэлж болно. Жишээ нь, дэлхийн хоёрдугаар дайны үед Нанжин хотод японы армийн үйлдсэн зэрлэг балмад ажиллагаа гэгчийг нотлоход ашигладаг олон гэрэл зургийг хуурамчаар үйлдсэн тухай тов тодорхой баримт мэдээллүүд байдаг билээ.[1751]

Интернетэд ХКН-ын байр суурийг янз бүрийн хэл, түүний дотор орос хэлээр сурталчилдаг олон "бие даасан хүмүүс" болон нэгдэл бүлэг бий болжээ. Феодализмын гамшиг зовлонгийн тухай "хамжлагын тариачдын нэг хэвийн дурсамжууд" дахин бий болжээ.[1752] Далай ламын нэр хүндийг гутаах зорилготой санаанаас зохиосон зүйлүүдийг олшруулан тараах болжээ. Жишээ нь, Г. Харрер түүний багш байсан (энэ тухай 4-р бүлгээс үзмүү), түүний "шашны сургааль, "Аум Синрике" шашны үзэл Далай ламаас улбаатай" гэх мэтээр бичжээ.[1753] "Жэньминь жибао он-лайн" Интернет-сайтад байгаа энэ нотолгоо бол худал зүйл юм. 1990-ээд оны эхээр оросын "Маяк" радиостанцийн долгионоор цацагдсан энэ сектийн нэвтрүүлгүүд болон үйл явдлын цаашдын өрнөлтийн тухай дурдах нь зүйтэй юм.

Энэ бүхний зэрэгцээгээр Түвдийн тухай Интернет-сайтын ажлын зохион байгуулалтыг алдагдуулахын зэрэгцээ "дотоодын дайснуудын" хаягийг арилгахын тулд хэрэглэдэг вирустсан программ олноор нь оруулах

болжээ.[1754] 2008 оны тавдугаар сар гэхэд интернет-суртал нэвтрүүлгийн тусгай түр сургуулиудад 127 хятад түшмэд суралцжээ.[1755] Бээжингийн эрх баригчид нэр хүндээ дээшлүүлэхийн тулд Пиар-менеджерүүдийг олноор нь бэлтгэжээ.

Гэвч хятадууд бүгдээрээ суртал нэвтрүүлэгт автсан хэмээн хэлж болохгүй. Мэдээллийг маш нарийвчилсан шүүлтүүрээр оруулдаг БНХАУ-д ч хятадуудын зарим нь түвдчүүдийн тэмцлийг дэмжээд зогсохгүй удирдлагынхаа чиг шугамыг ил шууд шүүмжлэх болсон байна. Зарим ийм зоригтон гэрийн хорионд орж, бас нэг хэсэг нь шоронд сууж, эрүү шүүлт амссан тухай мэдээ ч бий. Гэхдээ бусад оронд өөрсдийгөө ХКН-ын нөлөөний туршуул болохыг илтгэн харуулсан бусад ард түмний олон иргэд олджээ.

Оросын олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд ерөнхийдөө үйл явдлыг харьцангуй байдлаар харуулж иржээ. Гэхдээ нилээд олон мэдээллийн хэрэгсэл тов тодорхой чиг шугам баримталж, жишээлэхэд: БНХАУ америкийн империалистуудээс Далай ламаар дамжуулан зохион байгуулж буй салан тусгаарлах үзэлтэй тэмцэж байна; Түвдэд болж буй үйл явдлуудын зохиолыг (сценари) Косовогийнхоор (мэдээжийн хэрэг Абхаз, өмнөд Осетийнх биш) бичжээ гэх мэтээр. Яг л бээжингийн суртал нэвтрүүлгийнх шиг. Евразийн зүүний болон зарим барууны олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд тиймэрхүү тайлбар хийж байгаа нь сонирхолтой билээ. Түвд орон "бүрхэг дундад зууныхаа" үеэс шинэчлэлийн гэрэлт саруул замдаа орлоо, харин харгис хүчнийхэн түүнийг гэдрэг чангааж байна гэсэн мэдээллүүдийг газар сайгүй тараах ажээ. Большевикууд "дарлагч анги", шашин, бүх хуучин Оросыг устгаснаа яг л ингэж зөвтгөж байсан юм. Тэгвэл одоо үүнийг барууны чиг баримжаа, үнэн алдартны шашин, уламжлалт үзлийг тунхагладаг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд сурталдан дамжуулж байна.

Илүү их мэдээлэлтэй өрнөдийн олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд их баримт мэдээлэл дамжуулжээ. Өрнөдийн мэдээллийн хэрэгслүүд "хүний эрхийн" тухай сэдэв дэвшүүлж тавьсан бөгөөд миний хувийн бодлоор бол асуудлын мөн чанар үүнд биш, харин түвд-монголын соёл иргэншил мөхөх аюул тулгарсанд байгаа ажээ. Тэд урьдынхаа заншлаар энэ бүхнийг ЗСБНХУ-тай зэрэгцүүлэн тавьсан нь буруу юм. Бээжингийн суртал нэвтрүүлэгчид өрнөдийнхний техникийн болон баримт сэлтийн алдааг амжилттай ашиглажээ. "CNN-ийн эсрэг" хэмээх "бие даасан" Интернет-сайт нээжээ. Тэнд дээрх алдаануудыг нарийвчилсан шүүлтүүрээр

оруулахын зэрэгцээ албан ёсныхоо суртал нэвтрүүлгийг давтжээ. Заримдаа БНХАУ-ын байр суурийг өрнөдийн либераль олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, жишээ нь, "Эрх чөлөө" радио сурталчилж байна.[1756]

Өрнөдийнхөн БНХАУ-д аядуу шахалт үзүүлэхийн зэрэгцээ харилцаагаа муутгахгүй байхыг эрмэлзэж байна. Харин ОХУ-ын гадаад явдлын яам хятадуудын арга хэмжээг бүрэн дэмжжээ. Дөрөвдүгээр сарын 10-нд Европын парламент хэрэв БНХАУ-ын эрх баригчид Далай ламтай хийх яриа хэлэлцээг сэргээхгүй бол 2008 оны наймдугаар сарын 8-ны олимпийн тоглолтын нээлтийн ёслолд оролцохгүй байх боломжийг авч үзэхийг Европын холбооны удирдагчдад уриалсан тогтоол гаргажээ. Бээжингийн эрх баригчид үүнийг нухацтай хүлээж авсан боловч тэдний нэр хүндэд сэв суужээ. Түвдийн талаар баримталж буй хятадын бодлогыг эсэргүүцсэн жагсаал олон оронд гарав. Бээжингийн олимпоос сургамж авсан олон улсын олимпийн хороо 2009 оны хавар хойшид олимпийн галыг бүх дэлхийгээр дамжуулж өртөөлөн хүргэдэг журмыг халах шийдвэр гаргажээ.[1757]

2008 оны долдугаар сард БНХАУ-д Далай ламын санаачлагаар түүний төлөөлөгчидтэй хоёр шаттай хэлэлцээ хийв. Харамсалтай нь үр дүнд хүрээгүй юм. Хятад улс үүнийг олимпиадыг сурталчлахад л ашиглажээ. Далай ламын буулт хийсэн саналд ХКН өгсөн хариу урьдынхтай адил[1758] бөгөөд: Далай лам Түвдийн тусгаар тогтнолын бодлогоосоо хэрэг дээр татгалзах ёстой; "эх орноо хагаралд оруулах"-ад чиглэсэн үйл ажиллагааг зогсоох ёстой; Түвдийг Хятадын салшгүй хэсэг, Тайваныг БНХАУ-ын нэг муж, БНХАУ-ын засгийн газрыг нийт Хятадын цорын ганц хууль ёсны засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрөх тухай ил тод мэдэгдэх ёстой гэсэн хариу өгчээ. Таван зүйлт программ ч, шинэ саналууд ч, хятадын талын үзэж буйгаар бол, "Түвдэд тусгаар тогтнол олгох шаардлагыг уг чанараар үгүйсгээгүй" болохоор эдгээр баримт бичиг хэлэлцээ хийх үндэс болж чадахгүй гэж хятадын эрх баригчид үзэж байна.[1759] Түвдийн тал энэ улсын өнөөгийн дотоод байдлыг төдийгүй Түвд урьд өмнө хятадын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрөх тухай түүхийг суртал нэвтрүүлгийн хувьд мушгин гуйвуулж байгаа явдлыг бүрэн хүлээн зөвшөөрөх ёстой ажээ.

"Далай лам болон түүний талынхан эх орноо хагалан бутаргахад чиглэсэн өдөөн хатгах суртал нэвтрүүлгийг Түвдийн өөртөө засах оронд урьдын адил явуулсаар байна. Тэд Лхас хот, бусад нутагт тэмцэл хөдөлгөөн өдөөн тухирч, дэлбэрэлт болон хүч хэрэглэсэн бусад алан хядах ажиллагаа зохион байгуулж байна" гэж Синьхуа агентлаг мэдээлжээ.[1760]. Энэ бол тийм биш. Далай лам байнга хүч хэрэглэхгүй байхын төлөө тэмцэж байна.

“Хэрэв хүч хэрэглэсэн үйлдлээ зогсоохгүй бол” огцруулна гэж түүнийг сүрдүүлсний дараа буюу 2008 оны гуравдугаар сард Далай лам хэсэг дуугүй суухаар шийджээ. Энх тайвны аян, бүх нийтийн санал асуулга, ерөөс олны анхаарлыг түвдийн ард түмний асуудалд хандуулах гэсэн Далай ламын аливаа үйл ажиллагааг бээжингийнхэн “эх орноо хагалан бутаргах гэсэн үйл ахжиллагаа”, жинхэнэ ёсны өөртөө засах эрх тогтоохыг хүссэн түүний шаардлагыг феодализмыг эргүүлж авчирах гэсэн оролдлого хэмээн тайлбарлаж байна. Бодит байдалд бол ХКН-ын удирдлага хэлэлцээр байгуулах хүсэлгүй, харин хэлэлцээ хийх нь БНХАУ-д олон улсын нэр хүндээ дээшлүүлэхэд нь хэрэгтэй ажээ. Хятадын тал түвдийн байдлын оронд Далай ламыг буцаж ирэх нөхцөл дэх түүний статус эрхийн тухай л ярих зэргээр хэлэлцээний сэдвийг өөрчлөхийг байнга эрмэлзэж байна.

Ийм нөхцөлд Түвдийн төлөөлөгчид 2008 оны долдугаар сард дээрх чиглэлээр хэлэлцээг үргэлжлүүлэхээс арга буюу татгалзсан байна. “Хятадын удирдлагын зүгээс түвдийн асуудлыг нухацтай хэлэлцэх улс төрийн зориг хүсэл гаргахгүй байгаа учир бид яриа хэлэлцээг үргэлжлүүлэх нь ямар ч үр дүнгүйг ойлгосон юм” гэж түвдийн элч төлөөлөгч Галсанжалцан мэдэгджээ. Гэсэн хэдий ч 2008 оны аравдугаар сард шинэ хэлэлцээ болсон ч дахиад л үр дүнд хүрсэнгүй. Ингээд арван нэгдүгээр сард Дарамсалад түвдчүүдийн онц их хурал болж, түүнд 500 гаруй төлөөлөгч оролцов. Олонхи төлөөлөгч Далай ламын “дундыг баримталсан замыг”, бас Түвдэд жинхэнэ өөртөө засах эрх олгох тухай шаардлагыг “тууштай” байдлаар дэмжжээ. Их хурлын шийдвэрээр түвдийн цагаач засгийн газар БНХАУ-тай хийх үр дүнгүй хэлэлцээг зогсоох тухай зарлав.[1761]

2009 онд Түвдийн янз бүрийн нутагт аяндаа гарсан эсэргүүцлийн ажиллагаа, тэгэхдээ тийм эрчтэй биш хэлбэрээр өрнөв. Хүмүүс тусгаар тогтнолын төлөө, Далай ламын урт наслахын төлөө уриа лоозон хашгирч, ухуулах хуудас тараажээ. Эсэргүүцлийн ажиллагаанд оролцогчдыг энд тэндгүй зодож, баривчлан хорьжээ.[1762] Хоёрдугаар сарын 25-ны түвдийн шинэ жилийн баяр болон гуравдугаар сарын 10-ны ардын бослогын 50 жилийн ой болох гэж байгаатай холбогдуулан ийнхүү эсэргүүцлийн ажиллагаа эхлүүлжээ. Нэгдүгээр сард Лхас хотын Түвд хорооллуудын байшин барилгын ханан дээр шинэ жилийн баяр тэмдэглэхээс татгалзахыг уриалсан гар бичмэл ухуулах хуудсууд наажээ: “Нэг мянган хүн баривчлагдаж, бас нэг мянган хүн сураггүй алга болжээ. Аюулгүй байдалд үлдсэн өрөвч сэтгэлт түвдчүүдээ хоёр зүйлийг хийцгээе. Дуулж, бүжиглэж, тоглож, ёслолын буудлага хийхийн хэрэггүй. Зөвхөн энэ хоёрыг шүү. Амь

үрэгдэгсдийнхээ тухай дурсаж, амьд буй хүмүүсийнхээ төлөө залбирцгаая" гэж эдгээр ухуулах хуудсанд бичжээ.[1763]

Үүний хариуд эрх баригчид ноцтой тэмцэл хөдөлгөөн гарахаас зайлсхийх боломж олгосон урьд өмнө үзэгдээгүй арга хэмжээ авав. Үнэн хэрэгтээ түвдчүүдийн нутгийг хэдэн сараар тусгаарлан бүслэжээ. Эдгээр нутагт олон мянган цэрэг, зэвсэглэсэн цагдаа нар оруулсан байна.[1764] Лхас хотод нэгжлэг, баривчилгаа явуулав. Жокангийн эргэн тойронд зэвсэглэсэн олон эргүүл, сүмүүдийн орой дээр мэргэн буучид, тэр өдрүүдэд хаалттай байсан Будалын ордны хавьд эргүүл болон өөр хувцас өмссөн туршуулууд тавьжээ: Лхасаас бусад газарт оршин суудаг түвдчүүд нийслэлд очихыг хориглосон байна. Шинэ жилийн баярын үеэр эрх баригчид албан ёсны баяр ёслолын ажиллагаа зохион байгуулав. Зарим газарт гар утсан холбоог салгасан байна. Түвдийн байдлын тухай, зарим газарт гадаадын нэвтрүлэг үзүүлэхгүйн тулд хиймэл дагуулын телевизийг кабелийнхаар сольсон тухай мэдээллийг хилийн чанадад дамжуулсан түвдчүүдийг шийтгэнэ гэж мэдээлжээ.

Бүслэлт хүртэл явж чадсан нэгэн орос иргэн зочид буудлаа сольж (түүнийг хүлээж авахгүй байхыг буудлын эздэд анхааруулжээ), мөрдөлтөөс нуугдаж, хилийн харуулыг тойрч гарахын тулд уулын жимээр явахад хүрсэн байна.[1765] Түүний баримт бичгүүд ямар нэгэн зөрчилгүй, хилийн байцаан өнгөрүүлэхийнхэн ямар нэгэн шаардлага тавиагүй нөхцөлд шүү дээ. Бослогын ойгоор голокууд болон нүүдэлчид ямар ч байсан бослого хөдөлгөөн гаргадаг байсныг тэр хүн мэдэж байсан ажээ. Гэвч хятадын телевиз энэ тухай ч, үнэн хэрэгтээ бол байлдааны цагийн байдал тогтоосон тухай ч мэдээлээгүй юм.

Бослогын 50 жилийн ойгоор эрх баригчид "Хамжлагын боолчлолоос чөлөөлөгдсөн өдөр" хэмээх шинэ "баяр"сэдсэн байна. Энэ өдрийг түвдийн засгийн газрыг тарааж, ардчилсан шинэтгэл хийх тухай аймшигт тушаалд гарын үсэг зурсан өдөр буюу гуравдугаар сарын 28-нд тэмдэглэхээр товложээ. Энэ "баяр" гэгч нь түвдчүүдийн үндэсний санаа бодлыг басамжлан доромжилжээ.[1766] Энэ өдрөөр хувьсгалын сэдэвтэй дуу дуулж, бүжиг үсрэх, намын түвд судлаачдын олон улсын аялал зохиох, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилгаа явуулах зэрэг хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Улсын оргил дээгүүр БНХАУ-ын далбаа мандсан дүрс бүхий улаан өнгийн энгэрийн тэмдэг гаргажээ. Энэ энгэрийн тэмдгийн үзэл санаа бол "Цаст уулан дээгүүр улаан нар мандав" хэмээх маоч дуу ажээ. Нилээд утга төгөлдөр

арга хэмжээнүүдийн нэг бол шинэ хятад сайт- энэ удаад “түвд дэхь хүний эрхийн” тухай сайт нээх явдал байв.[1767] Ийм “баяр” бий болгосныг түвдийн цагаач засгийн газар бүс нутгийн байдлыг тогтворгүй болгоход чиглэсэн өдөөн хатгалага хэмээн үзжээ.[1768]

Далай лам 1959 оны Түвдийн бослогын 50 жилийн ойг тохиолдуулан гаргасан Мэдэгдэлдээ: “Хятадын хэт зүүний үзэлт удирдагчид өнгөрсөн оны гуравдугаар сараас эхлэн түвд, хятадын ард түмний хооронд хагарал гаргаж, тэдний дунд бие биендээ дайсагнах харилцаа бий болгохын тулд суртал нэвтрүүлгийн асар том кампани өрнүүлсэн юм” гэж тэмдэглэжээ.[1769]

“Баярын” өмнөхөн буюу түүний дараа ТӨЗО-ны телевизийн сувгаар Лхаст болсон эцэс төгсгөлгүй намын бага хурлын тухай мэдээ цуварчээ.[1770] Хятад, түвдийн тав-зургаан намын ажилтан, гурван хятад генерал бага хурлын индрээс ээлж дараалан ТӨЗО-ны амжилт ололтын тухай мэдээлэх ажээ. Бага хурлын төлөөлөгчдийн өмнө түвд дуу дуулж, бүжиг бүжихийг үзүүлснээр мэдээний нэвтрүүлэг дуусна. Театрын асар том танхимын үлдсэн суудалд ХАЧА-ын цэргүүд болон үндэсний хувцастай түвд орлон тоглогчид адил тоогоор суужээ. Мэдээнүүдийн хооронд суртал нэвтрүүлгийн баримтат кинонууд, XX зууны дунд үеийн түвдийн амьдралаас харуулсан эцэс төгсгөлгүй “кино хөөс” хөврөх ажээ. 5-7 орчим баримтат кино байх бөгөөд тэдгээрийг байн байн давтаж үзүүлнэ. Эдгээр баримтат киног Хөх нуур мужийн сувгаар, бас өөр 2–3 сувгаар үзүүлнэ. Ямар муу байснаа ямар сайхан болж вэ гэсэн нэг л санааг дахин дахин давтах ажээ. Кино мэдээний кадруудыг нарийвчлан шалгаж сонгосон бөгөөд баярын царай гэрэлтсэн түвдчүүд Лхаст орж ирж буй ХАЧА-ийн цуваag алга ташин угтаж: цэргүүд түвдийн тариачидтай мөр зэрэгцэн үр тариа цайруулж, байшин барьж, ургац хурааж буйг харуулах ажээ. Үзэл суртлын хувьд үнэн бодитой зураг маш цөөн: мэдээний нэг адил зургууд 7–8 минутын завсарлагатай дэлгэцнээ хөврөх ажээ.

Эрх баригчдын зан байдал ойлгомжгүй: нөхцөл байдлыг зөөлрүүлэхийн оронд тэд түүнийг зохиомлоор хурцатгана. Ямар учраас? Төрж, өссөн ТӨЗО-ныхоо байдлыг сайн мэддэг зохиолч эмэгтэй Цэрэносор тийм бодлого бол Соёлын хувьсгалын үед дэвшиж гарч ирсэн түвд түшмэдүүдэд ашигтай юм хэмээн үзэж байна. Тэрээр нэгэн ярилцлагадаа улаан хамгаалагчдын эгнээнээс дэвшиж ТӨЗО-нд өндөр албан тушаалд байгаа хүмүүсийг нэр зааж хэлсэн байна. Эдгээр түшмэд өмнө нь ямар ажил эрхэлж байсан юм бол:[1771]

*Рагди*: Соёлын хувьсгалын үед Нагчу гацааны “Аугаа их нэгдсэн

төвийг"(хувьсгалч үймээн дээгдээгчдийн бүлэглэл) тэргүүлж байсан: 1975–2003 онд ТӨЗО-ны нарийн бичгийн даргын орлогч. *Легчог*: Шигазе гацааны "Аугаа их нэгдсэн төвийг" тэргүүлж байсан: 2008 он гэхэд ТӨЗО-ны ардын төлөөлөгчдийн хурлын дарга. *Баасан*: Лхока (хятадаар бол Шаннань) гацааны "Бага улаан гварди", "Аугаа их нэгдсэн төвийг" тэргүүлж байсан: 1971–2003 онд ТӨЗО-ны нарийн бичгийн даргын орлогч, 2008 он гэхэд Бүх хятадын эмэгтэйчүүдийн холбооны орлогч дарга. *Лувсандондог*–Хятадын түвдийн үндэсний их сургуулийн "Хамжлагынхны дайн" байгууллагын "штабын дарга: 2008 онд ТӨЗО-ны ардын төлөөлөгчдийн хурлын орлогч дарга. *Лхагвапунцаг*: "Аугаа их нэгдсэн төвийн" сонин, "Дайны шуурга" сонины ерөнхий эрхлэгч: 2008 онд Хятадын Түвд судалгааны төвийн хариуцлагатай нарийн бичгийн дарга. *Жамбапунцаг*: "Хамжлагынхны дайн" байгууллагын штабын дарга, 2008 онд ТӨЗО-ны нарийн бичгийн даргын орлогч. *Жанц*: механикийн Таму фабрикийн "Аугаа их нэгдсэн төвийг" тэргүүлж байсан: 2008 онд ТӨЗО-ны орлогч дарга. *Декицомо*: Хятадын түвдийн үндэсний их сургуулийн "хамжлагынхны дайн" байгууллагыг тэргүүлж байсан:2008 онд ТӨЗО-ны ХКН-ын байнгын хорооны гишүүн. *Бхучун*: Лхока гацааны Чонгье тосгоны "Аугаа их нэгдсэн төвийг "тэргүүлж байсан: 2008 онд ТӨЗО-ны нарийн бичгийн даргын орлогч ба ТӨЗО-ны сахилга батын комиссийн нарийн бичгийн дарга. *Баасандондов*: 1969 оны арван нэгдүгээр сараас 1970 оны арван хоёрдугаар сард ХАЧА-д Түвд орчуулагчаар алба хаасан: 2008 онд ТӨЗО-ны ХКН-ын байнгын хорооны гишүүн, ТӨЗО-ны Улс төрийн зөвлөлдөх хурлын орлогч дарга, ТӨЗО-ны нэгдсэн фронтын ажлын хэлтсийн сайд. *Ишданзан*: эхний үед "Үймээний төв"-тэй ("үймээн дэгдээгчдийн" бас нэг бүлэглэл) холбоотой байсан, хожим нь "Аугаа их нэгдсэн төвд" нэгдэж орсон: 2008 онд ТӨЗО-ны улс төрийн зөвлөлдөх хурлын орлогч дарга.

Энэ хүмүүс Далай ламын эсрэг, хятадын үндсэрхэх үзэл тулган хүлээлгэх кампани явуулахтай холбогдсон ажил байнга эрхэлж байсан юм гэж Цэрэносор бичжээ. Эрх баригч энэ давхаргынхан хятадын засгийн газраас Далай ламын төлөөлөгчидтэй хийх хэлэлцээнд байнга саад тавьж ирсэн юм гэж энэ зохиолч эмэгтэй үзэж байна. "Хятадын соёлын хувьсгалын үед Түвдэд засгийн эрхэнд гарч ирсэн хятад-түвдийн энэ түшмэлүүд бүгд нэгэн дуугаар ярих нөхцөл бүрдүүлсэн феодалын хувийн эзэмшил бий болгосон юм хэмээн хэлж болно" гэж тэр эмэгтэй бичжээ. Түвдийн асуудлыг шийдвэрлэхийг хүсч байгаа л юм бол саад болсон энэ бул хар чулууг авч хаяхыг тэрээр хятадын засгийн газарт зөвлөжээ. Гэтэл хятадын

засгийн газар ингэж чадах юм болов уу? Энэ засгийн газар түвдийн ард түмний дотор үүнээс өөр түшиг тулгуур олж чадахгүй байгаа нь тодорхой билээ.

Хэрэв "хувьсгалт үймээн дэгдээгчид" буюу заофаниуд Соёлын хувьсгалын хэв маягийг ашиглаж байгаа бол гайхах зүйлгүй. Бээжингийн суртал нэвтрүүлэгчид тэр хүмүүсийг дэлхий дахинд хэрхэн өргөмжилж байгаа нь бүр ч сонирхолтой. Бээжингийн суртал нэвтрүүлгийн арга зарчмын хувьд өөрчлөгдсөнгүй: ерөнхий мэдээллээс баримтуудыг сугалан авч, засч янзалж, уриа лоозон, гуйвуулга, санаанаас зохиосон зүйлс оруулан баяжуулна. Туршлага муутайхан уншигчид хаана үнэн байна, хаана нь үгүй вэ гэдгийг ойлгоход хүнд бөгөөд эцсийн дүнд бүх зүйлд итгэхэд хүрдэгийг би өмнө тэмдэглэж байсан билээ.[1772] Суртал нэвтрүүлэгчид ийм ч тооцоогоор ажилладаг ажээ. Хэрэв Маогийн үеийн суртал нэвтрүүлгийг одоогийнхтой харьцуулж үзвэл дарга Маог, коммунист намыг, коммунизмыг магтан сайшаахын оронд "дэлхийн хамтын нийгэмлэгт" хүлээн зөвшөөрөгдсөн арга барилаар хийгдсэн ардчилал, элбэг хангалуун байдал, эдийн засгийн өсөлтийн тухай эрэгцүүлэл хүрч иржээ. Гэвч гол үндсэн агуулга түрүүчийнхээрээ үлдэж: Түвд орон дундад зууны үеэс Хятадын нэг хэсэг байсан, коммунист нам ямагт үнэний талд байна, ард түмэн социализмыг сонгосон, Түвдэд гарч буй тэмцэл үймээнийг хилийн чанадаас зохион байгуулж байна гэх ажээ. "Хамжлагат ёсны бүрхэг, хоцрогдсон байгуулал"-аас эхлээд л зүүнтний нэр томьёонууд хэвээр үлдсэн байна. Эдгээр нэр томьёоны нилээд олныг буюу "эх орныхоо ээзд нь", "нэгдмэл фронт","империализмын туршуулууд", "феодалын хоцрогдсон байгуулал", "урван тэрслэх үйл ажиллагааг илчлэх нь", "ардчилсан шинэтгэл" зэргийг большевикуудын үгсийн сангаас авчээ.[1773]

Өнөө үед хятадын интернет суртал нэвтрүүлэгчид, хакеруудын үйл ажиллагаа дэлхий нийтийн шинж чанартай болж байна. Энэ үйл ажиллагааг БНХАУ-аас чиглүүлж, харин хятадын тусгай албад болон арми компьютерийн тагнуулын ажил эрхэлж байна.[1774] Хуучирсан улаан суртал нэвтрүүлгийг хамгийн шинэ үеийн электронон болон пиар-технологийн тусламжтайгаар турааж байна. 2009 он гэхэд хятадын интернэтийн хуудасны нийт тоо 2 саяас давжээ. Тэндээс түвдийн асуудлаар бээжингийн эрх баригчдын баримталж буй байр суурийг илэрхийлсэн олон зуун хуудас, түүний дотор орос хэлээр бичсэн хуудсууд олж болно. Хятадын суртал нэвтрүүлгийн харгис түрэмгий, зэлдэг бус байдал нь түүний нотлох баримтгүйн шинж чанарыг илтгэн харуулж байна. "Мянган удаа давтсан

худал үг үнэн болдог" гэж П.Й. Геббельс хэлжээ.

Хилийн чанад дахь ХКН-ын нөлөө суртал нэвтрүүлгээр хязгаарлагдахгүй гэж германы эрдэмтэн К.А. Хольц нотолсон байдаг. Гадаадын болон хятадын эрдэмтдийн хамтарсан шинжилгээ судалгааг зөвхөн ХКН-ын хувьд хүлээн авч болохуйц хэлбэрээр явуулдаг, дорно дахиныг судлагч өрнөдийн зарим эрдэмтэн хятадад хамаатан садантай, нөгөө хэсэг нь тэнд орон сууцтай, хятадын асуудал судалдаг олон шинжээч хэдэн арван жил хятад хэл зааж, энэ их хөрөнгө оруулалтаараа алба, аминыхаа ажлыг зохицуулдаг юм гэж тэр үзэж байна.[1775] Хятад дахь хэлхээ холбоо багагүй ашиг өгдөг гэж Хольц онцлон тэмдэглэсэн байна. Үүнийг алдахгүй хадгалж байхын тулд ХКН-ыг цухалдуулахгүй байх явдал гэнэ. Үүнээс болоод өөртөө тавих хяналт олон хэлбэртэй болж байна. Коммунист намын нэр томьёо өрнөдийн нийтлэл, багшлах үйл ажиллагаанд нэвтрэн орж, намын суртал ухуулга өрнөдийн сэтгэлгээнд нэвтрэн орж байна. Хятадтай хамтран ажилладаг өрнөдийн зарим эдийн засагч ХКН-ын туслалцааг ил шууд авдаг ажээ. К. Хольц өөрийгөө улам бэрхшээлтэй байдалд оруулж, харин оросын зарим эрдэмтэн, шинжээч, улс төр судлаач болон түшмэлийн хятадын тал баримталсан байр суурь тиймэрхүү шалтгаантай холбоогүй л гэж итгэхээс.

Түвдэд феодализмыг сэргээх гэсэн аюул, энэ байгууллын үед харгис хатуу цээрлэл оноодог байсан явдал өнөөг хүртэл коммунист суртал ухуулгын чухал сэдэв болсон хэвээр байна. Энэхүү номын зургадугаар бүлэгт феодалын түвдэд хэрэглэж байсан бүх эрүү шүүлт, цаазыг тоочиж, тэдгээрийг хэрхэн хэрэглэж байсан тухай өгүүлсэн билээ. Маогийн үед үүнээс л илүү харгис байсан юм. Одоо байдал ямар байгааг авч үзье.

Хуйвалдааныг илрүүлэхийн тулд мөрдөх сүлжээ зохион байгуулжээ. Лхас хотын түвдийн хэсгийн томоохон гудамжуудад, түүний дотор Жоканийг тойрсон Баркхорын гудамжинд дүрс бичлэгийн камерууд зоож, тус хотод мэдээлэгчид болон энгийн хувцас өмссөн тусгай албаны ажилтнууд олноороо байх ажээ. Тэд гадаадынхныг нэг их сонирхохгүй, харин эдгээр гадаадынхан хэнтэй ярилцдагыг л мэдэхийг хүсдэг байна.[1776] Түвдчүүдтэй эрх чөлөөнд нь гай тарьж мэдэх сэдвээр ярилцах гэхийн хэрэггүй.

БНХАУ-ын хууль тогтоомж эрүү шүүлтийг хориглодог бөгөөд хоригдлуудтай хэвийн байдлаар харьцаж, бас тийм нөхцөлд хорих нөхцлийг хангах зорилготой. Хятадын албан ёсны баримт мэдээг авч үзье: "Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хууль ёсны эрхийг хуулиар хамгаална. Гэмт хэрэг үйлдсэн үндэсний цөөнх болон сүсэгтнүүдийг ялгаварлан гадуурхаыг үл зөвшөөрнө. Түүнээс гадна тэдний зан заншлыг хүндэтгэнэ.

Хоол, хувцас, хоригдох өрөө зэрэг гэмт хэрэгтнүүдийг байлгах материаллаг нөхцлийг төрөөс хангана. Түвдийн цагдан хорих газрууд болон шоронд байгаа үндэсний цөөнхийн төлөөлөгчдийн хоол хүнсний талаарх заншил, дадал зуршлыг харгалзан үзэх үндсэн дээр хоригдлуудыг замбай (арвайн гурил, шар тосоор хийдэг Түвд хоол), цөцгийн тостой цай, амтат цайгаар байнга хангадаг тусгай хүнсний газрууд ажиллана. Түвдийн шоронгуудад эмнэлэг-ариун цэврийн үйлчилгээ зохион байгуулагдана. Энд нэг хоригдолд дунджаар нийт улс орны бусад шоронгуудаас илүү олон тооны эмч оногдоно. Хоригдлууд амралтын өдрүүдэд, төрийн болон үндэсний уламжлалт баярын өдрүүдэд амарна. Хоригдлууд шоронд байхдаа хуулийн дагуу сар дутам төрөл төрөгсөдтэйгээ уулзах эрх, шийтгэлээ хөнгөрүүлэх буюу хугацаанаасаа өмнө тэнсэнгээр суллагдах, түүнчилэн шагнуулах хэлбэрээр өршөөл хүртэх эрх эдлэнэ"гэжээ.[1777]

Шүүхийн шийдвэр гарахаас өмнө саатуулах гурван хэлбэр байдаг: албадан дуудах, эрүүгийн баривчилгаа, ердийн баривчилгаа, түүнчилэн шүүхээр хэлэлцэж шоронд хорих ял оноохтой холбоогүй хоёр төрлийн шийтгэл байна: орших суух газрыг нь гурван жил хүртэлх хугацаагаар хяналтад авах, тэнсэн харгалзах ял оноох зэрэг болно. Аливаа хүнийг 7 сар хүртэлх хугацаагаар баривчилгаанд суулгаж болно, хэрэв шинэ нөхцөл байдал үүсвэл баривчилгаанд байх хугацааг сунгаж болно. Баривчлагдсан хүнд хэд хоног, хэдэн сар буюу бүр хэдэн жилийн дараа чи бол тийм хүн гэж зарлан мэдэгдэж болно. Шүүхийн энэ системийн өөр нэг дутагдал бол өмгөөлөгчийн талын гэрчийн этгээдийн мэдүүлгийг бараг ашиглахгүй байгаа явдал мөн.[1778] Урьдчилан хорих үед саатуулагдсан этгээдийн төрөл төрөгсдөд мэдээлэх шаардлагын тухай асуудал гарч ирэхгүй, яагаад гэвэл тэрээр албан ёсоор баривчлагдаагүй. Баривчлах эрхийн бичгийг тэр болгон өгдөггүй байна.[1779]

Гэхдээ эрүү шүүлтийг олонтоо хэрэглэдэг ажээ. Энэ тухай мэдээлэл эрх баригчдаас биш, харин гол төлөв баривчлагдаж байсан хүмүүсээс олддог байна. Зарим талаар дэгэсдүүлж ярих явдал байдаг л биз. Гэхдээ эрүү шүүлтийн тухай мэдээлэл олон нийтийг хамарсан шинж чанартай болж байгаа бөгөөд ийм мэдээлэл өөр хоорондоо холбоотой биш эх сурвалжуудаас, янз бүрийн газраас, цаг хугацааны хувьд ч янз бүрийн үед ирж байна. Энэ бүхэн нь эрүү шүүлтийг байнга хэрэглэж буйг гэрчлэн харуулж, зарим дүгнэлт хийх боломж бүрдүүлж байна. "Ухамсарласанд хөнгөн, эсэргүүцсэнд хатуу ханд" гэсэн хятад зарчим байдаг.[1780] Амдод саатуулагдсан хүмүүсийг бүгдий нь эрүү шүүлтэд оруулдаг гэж цагдаагийн нэг ажилтан хүлээн зөвшөөрсөн

бол саатуулагдсан хүнийг цагдаа нар зодоогүй тийм нэг ч хэрэг шүүхэд орж ирж байгаагүй юм, хэрэв саатуулагдсан этгээд түвдийн улс төрийн хоригдол бол бүр ч их зодно гэж Сининий нэгэн шүүгч ярьсан байна.[1781] Баривчлах, эрүү шүүлт тулгахад түвчүүд оролцдог байжээ.

Дорнод Түвдээс оргож очсон хятадын аюулаас хамгаалах албаны нэгэн ажилтан хоригдлуудад 33 төрлийн эрүү шүүлт тулгадаг тухай ярьжээ.[1782] Гэхдээ ямагт шинэ шинэ эрүү шүүлт сэдэн гаргаж ирдэг ажээ. Биднийг зодох (хөл, гараар, төмөр саваагаар), хоёр гарнаас дүүжлэх, айлган сүрдүүлэх, бусад хүмүүсийг хэрхэн тамлаж байгааг харуулах, цахилгаан гүйдлээр цохиулж, асаасан янжуурын галаар түлэх, нохойгоор уруулж, халуун наранд удаан хугацаагаар суулгах, эмэгтэйчүүдийг мөрдөн байцаагч эрчүүдийн өмнө чармай нүцгэн суулгаж, эмэгтэйчүүд, насанд хүрээгүй охидыг хүчирхийлэх зэргээр тамалдаг байсан гэж улс төрийн хоригдол байсан хүмүүс ярьсан байна. Эмэгтэйчүүдийн чих, үтрээ буюу бөгсрүү цахилгаан бороохой хийж токонд залгах бөгөөд энэ нь хүний эрүүл мэндэд ноцтой хор хүргэдэг ажээ.[1783] Зарим хоригдлын аманд хаймар хоолой шургуулан шээсийг нь шахаж, хумсных нь завсраар хулсан зүү шааж, хадаас хадаж нугалсан саваагаар зодож, хөлийнх нь шагайг алхаар цохиж, тамхины утаа нүд рүү нь үлээж, нүүр рүү нь халуун ус буюу чинжүүтэй халуун хоол цацах зэргээр тамлах ажээ.

Эдгээр эрүү шүүлтээс гол төлөв цахилгаан бороохой (86% хувьд), удаан хугацаагаар зогсоох (86%), халуун наранд суулгах (69%) арга хэрэглэнэ.[1784] Шарх сорви үлдээхгүй ч дотор эрхтэн ноцтой гэмтэх хэлбэрээр зодох явдал ердийн аргад тооцогдоно. Нас барсных нь дараа төрөл төрөгсдөд нь эргүүлж өгсөн зарим хоригдолд задлан хийж үзэхэд олон газар яс хугарсан, дотор эрхтнүүд нь задарч гэмтсэн байжээ. Эрүү шүүлт тулгах үед янз бүрийн жинтэй хөл, гарын гав өргөн хэрэглэнэ. Зарим хоригдлыг гавтай нь ажил хийлгэнэ. Арав гаруй хоног хөлд нь, хорь гаруй хоног гарт нь гавтай байлгах ч энүүхэнд.[1785] Зарим хоригдолд дотор талдаа шүдтэй гав зүүнэ. Баривчлагдсан хүмүүсийг 2х1 м-ийн давчуу өрөөнд удаан хугацаагаар байлгана. Ял заагдсаны дараа шоронд "хүмүүжлийн" ердийн арга хэрэглэдэг нь хүнд ажил хийлгэж, цусы нь хүчээр авч, унд, хоол хасч, хэт их ачаалалтай ажил хийлгэнэ.[1786] Мөргөл үйлдэх, маань унших зэрэг шашны үйл ажиллагааг хориглоно. Арми шиг л хатуу дэглэмд байлгана. Армиас ялгаатай нь гэвэл хоол унд муутай, хэрэв огт хөдлөхгүй дөрвөн цаг зогсож чадахгүй бол, ажлынхаа нормыг биелүүлж чадахгүй бол зодох ажээ.[1787]

Лхас хотын төвд “салан тусгаарлах” үзэлтэй лоозон хашгирсны төлөө би баривчлагдсан юм гэж гэлэнмаа Нямаа ярьсан байна.[1788] Цагдаагийн хэсэгт түүнийг зангидсан нударга, ташуурын сураар, сандлын модоор зодож, өшиглөж, толгой дээр нь халуун ус асгаж, янжуурын галаар түлж, амруу нь гулуузны мод хийн түлхэж тамласан байна. Заримдаа огт хөдөлгөөнгүй удаан хугацаагаар зогсоодог байжээ. Хөдөлгөөнгүй байгааг шалгахын тулд толгой дээр нь ус дүүргэсэн данх тавьж, хоёр өвдөгнийх нь хооронд болон гарынх нь хурууны завсар сонин хавчуулж орхидог байв.[1789] Хэрэв эдгээрийн аль нэг нь хөдөлсөн байвал зодно. Гэлэнмаа Нямаа алдаагаа хүлээж байна, сэтгэлгээгээ шинэчлэхийн тулд ажиллах болно гэх мэтийн улиг болсон үг хэлэхээс татгалзжээ. Тэгтэл ч хуягууд “хөл бөмбөг” тоглохоор шийджээ. Тэд тойрог болон зогсож, гэлэнмааг хүн бүрийн дэргэд очихыг тушааж, ирмэгц нь түүнийг өшиглөн унагах ажээ. Байцаалт хагас жил үргэлжилж, таван жил шоронд хорих ял өгсөн байна. Түүнийг бусад эмэгтэй хоригдлуудтай хамт мөсөн дээр хөл нүцгэн хэдэн цагаар зогсооно. Зогсох хугацаа дуусахын алдад өндөр өсгийтэй шаахай өмссөн хамгаалалтын албаны хятад хүүхэн ирж, хоригдол бүрийн хөлийг гутлынхаа өсгийгөөр гишгэх ажээ. Хоригдол хүүхнүүд мөсөнд наалдсан хөлөө авахад улных нь арьснаас мөсөнд наалдаж үлдэнэ.

Лам Лувсандарь хэргээ шийдүүлэх хүртэл Голокийн шоронд жил суужээ.[1790]

Түүнийг зодож, хөл, гараас нь гав үл салгана. Хүмүүсийг дүүжлээд доор нь гал түлэх явдал өмнөх хоригдлуудын ярьдаг байсан ердийн арга юм билээ гэж лам Жамбалцэрэн ярьжээ. Асч буй галан дээр нунтаг чинжүү асгах ажээ. Байцаалтын үеэр дүүжлэх буюу эрүү шүүлтэд хэрэглэх сонин хэлбэрээр томсон олс байнга хэрэглэнэ.

Эрүү шүүлтийн дараа гарцаагүй үхэх болсон хүмүүсийг гаргах буюу заримыг нь эмнэлэгт шилжүүлнэ.[1791] Хэрэв улс төрийн хоригдол нас барахад хүрвэл гол төлөв түүнийг амиа хорлосон буюу өвчнөөр нас барсанд тооцно.1987–2001 онд ТӨЗО-ны улс төрийн 1900 хоригдлоос дөчин нэгэн хүн (2 орчим хувь нь) нас баржээ. Хүний эрх, ардчилалын төлөө Түвдийн төвийн мэдээгээр бол 1987–2007 онд түвдэд эрүү шүүлтээс болж 88 хүн нас барсныг (2009 оны гуравдугаар сарын тоо баримт) баттай тогтоосон бөгөөд гэхдээ олон тохиолдол мэдэгдээгүй өнгөрсөн гэж тус төвийн ажилтнууд үзэж байна. Эрүү шүүлт тулгахыг хятадын хуулиар хориглосон болохоор Түвдэд түүнийг газар сайгүй хэрэглэсэн нь хууль бус үйлдэл болжээ. Эрх баригчид энэ тухай мэдээгүй байх учиргүй билээ. БНХАУ-д Мао Зэдуны



1



2



3

1 – Лхас хотын нэгэн хийдийн дээвэр дээр байрлуулсан хяналтын камер; 2 – Эсэргүүцлийн жагсаалд оролцож байгаад баривчлагдан Лхас хотын цагдаагийн хэсэгт хүргэгдэж ирсэн түвдчүүд; 3 – Хятад цэргүүд Лхас хотын гудамжинд (AFP авсан гэрэл зураг)



1



2



3

1 – Нийгмийг аюулаас хамгаалах товчооны ажилтнууд Будалын ордны хэрмийн дэргэд марш хийж байгаа нь; 2 – Нийгмийг аюулаас хамгаалах товчооны ажилтнууд 2008 онд Лхас хотын гудамжинд; 3 – хилийн чанадаас мэдээлэл авах замыг нь хаах зорилгоор түвдчүүдээс хурааж авсан хиймэл дагуулын тавган антенууд, Лавран, Амдо, 2009 оны тавдугаар сарын 20 (Никольский В. Новая цензурная инициатива . . . )




1



2



3

Түвдийн шоронгуудад улс төрийн хоригдлуудад тулгадаг эрүү шүүлтүүд: 1 – цахилгаанаар мэдээ алдуулагч хэрэгсэл (TCHRD); 2 – дүүжлэх үед гарыг нь хүлэх схем (TCHRD); 3 – дүүжлэх схем (Kuxing . . ., p. 50)

үеийнх шиг хууль бус арга хэрэглэсээр байна гэсэн дүгнэлт хийж болно.

ТӨЗО-нд байгаа хятад цагдаа нар түвдчүүдийг төдийгүй гадаадынхан, түүний дотор Дарамсалатай холбоотойг нь гэрчлэх “эд мөрийн баримт” олсон гэх оросуудад ч эрүү шүүлт тулгаж байна.[1792] Хятад болон хуэй үндэстний фермер эрхлэгчдийг Түвд нутгуудад шилжүүлэн суурьшуулах ажлыг дэмжих Бүх дэлхийн банкны төслийн тухай олж мэдэхийг эрмэлзсэнийхээ дараа цагдаагийн хэсэгт удаан хугацаагаар байцаагдсан нэгэн америк эр өөрөө цонхоор үсэрсэн үү, эсвэл түүнийг хүч хэрэглэн шидсэн үү бүү мэд ажээ.[1793] Үүнээс болж тэр хүний нугас гэмтэж, хөлийнх нь тавхайн яс хугарч, элэг нь бяцарсан ажээ. 2008 оны олимпийн өдрүүдэд Түвдийг дэмжих ажиллагаанд оролцсоны төлөө Бээжинд баривчлагдсан англи, америкийн иргэд ярихдаа олон цаг үргэлжилсэн байцаалтын үеэр биднийг сандалд суулган хүлж, дуг хийх ч боломж олгоогүй гэж мэдэгдсэн байна.[1794]

Феодалын Түвдэд ердөө л хоёр шорон байжээ. Тэгвэл 2001 онд Түвдэд улс төрийн хоригдлуудыг хаана суулгаж байсныг авч үзье.[1795] Лхасын зүүн хойд захад байх ТӨЗО-ны шорон (Драпчигийн шорон) хамгийн томд орох ажээ. Хамгийн олон жилийн ял авсан хүмүүс энд хоригдоно. Энэ шорон есөн корпустайгийн хоёрт нь улс төрийн хоригдлууд байна. Нийгмийг аюулаас хамгаалах товчооны засан хүмүүжүүлэх төв Лхас хотын хойд захад бий. Лхасын нийгмийг аюулаас хамгаалах товчооны засан хүмүүжүүлэх төв (Гуцагийн шорон) Кийчу голын ойролцоо, Лхасаас зүүн тийш 3 км-ийн зайтай байна. ТӨЗО-ны хөдөлмөрөөр хүмүүжүүлэх төв (Тисамын шорон) Лхасаас баруун тийш 10 километрт Толунийн гүүрний ойролцоо байна. Лхасаас зүүн тийш 500 км-ийн зайтай Трамо хотод Пово Трамогийн шорон байна. Лхасын шорон (өмнө нь Оутриду хэмээн нэрлэгдэж байсан) байна. Түвдийн цэргийн засан хүмүүжүүлэх төв-Лхасаас зүүн тийш барагцаалбал 11 км-ийн зайтай Цалгунтханийн районд байна. Цетангийн ажил хийлгэж засан хүмүүжүүлэх байр Чамдогоос зүүн тийш 10 км-ийн зайтай газарт байна. Маованы шорон Сычуань мужийн Нгаба тойргийн Маованы өөртөө засах нэгжид байна. Түүнээс гадна Түвдийн Сычуань, Юньнань, Ганьсу зэрэг автономиудын гацаа, тойрог бүрт засан хүмүүжүүлэх төвүүд байна. Тэнд ч улс төрийн хоригдлууд байгаа ажээ.

2001 оны мэдээгээр[1796] ТӨЗО-нд 12 шорон, хөдөлмөрөөр хүмүүжүүлэх 13 лагерь, Хөх нуурт–32, Сычуаньд–зургаа байна. Их Түвдийн засан хүмүүжүүлэх байгууллагуудын нийт тооны тухай тодорхой мэдээ байхгүй юм. Түвдийн улс төрийн хоригдлуудын тэн хагас гаруй нь лам нар байна.

Түвдчүүдийн ухамсарт улс төрийн бодлого, шашин хоёр өнөөг хүртэл уялдаатай байгаа бөгөөд шашны эрх чөлөө хязгаарлагдмал байгаа нь улс төрийн тэмцэл гарах хөрс суурь болж байна.

Олон Түвд хүн хилийн чанадад гарахыг хүсч байгаа нь гайхал төрүүлэхгүй. Гэвч Түвдийн өмнөд хил хатуу хяналтад байна. Түүнээс гадна, нилээд олон тохиолдолд түвдчүүд нэг газраас нөгөөд, тэрч байтугай богино хугацаагаар явах хэрэг гарахад албан ёсны зөвшөөрөл авах шаардлага гардаг, тэмцэл хөдөлгөөн гарсан буюу гарах магадлалтай нутгуудад ирж байгаа хүмүүст оршин суугаа тосгод руугаа явахыг албаддаг ажээ.[1797]

Түвдийн хилийн хэсгүүдэд очино гэдэг боломжгүй зүйл. "Хилийн мужуудыг удирдах тухай ТӨЗО-ний Дүрмээр" бол эдгээр мужид аж төрөн суугаа БНХАУ-ын 16-гаас дээш насны иргэд БНХАУ-ын бие хүний үнэмлэх, ТӨЗО-ны хилийн оршин суугчийн үнэмлэхтэй байх ёстой ажээ[1798] Хилийн мужууд руу явж буй ТӨЗО-ны иргэд биеийн байцаалттай байхын зэрэгцээ хилийн мужуудад очих үнэмлэх бичиг авах ёстой. БНХАУ-ын 16 нас хүрээгүй иргэд орон нутгийн байгууллагуудаас хүчин төгөлдөр үйлчлэх батламж бичиг авах ёстой юм байна. "Хилийн чанадад сууж буй эх орон нэгтнүүд" дээр дурдсан нутгуудад очих хэрэг гарвал биеийнхээ байцаалтын зэрэгцээ хилийн мужуудын үнэмлэх авах ёстой. Хил орчмын нутгуудад тусгай зөвшөөрөлгүйгээр газрын зураг зурах, геологийн хайгуул, археологийн судалгаа хийх, гэрэл зураг, кино зураг авах, шинжлэх ухааны судалгаа хийхийг хориглоно. Түвдчүүдийн хувьд хил хавийн Манасаровар нуур, Кайлас уул зэрэг ариун дагшин газруудад мөргөл хийхээр явах зөвшөөрөл авна гэдэг хүнд суртлын тун хэцүү даваа ажээ.

Хилийн чанадад гарна гэдэг бүрч хэцүү, гэвч түвдчүүд шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлж явдаг байна. Хилийн чанадад явах паспортыг Лхас хот дахь нийгмийг аюулаас хамгаалах товчооны байранд олгоно. Энэ бол олон хоног хөөцөлдөх хэцүү ажил[1799] Энэтхэг рүү гарах хэцүү. Харин урилгаар Балба явах арай гайгүй. Тийш явах виз авахын тулд гацаа, тойрог, мужийн түвшний түшмэлүүдийн гарын үсэг авах гэж тус тусад нь өргөдөл гаргана. Авилга өгвөл ажил арай түргэснэ. Гэвч түвдчүүд нууцаар Балба төдийгүй бусад орон, тухайлбал Орос, европын орнууд руу явж байна. Түвдийн цагаач иргэд ТӨЗО-нд ирж, зарим нь тэндээ үлдэж байна. Синьхуа агентлагийн мэдээгээр бол өнгөрсөн хэдэн жилийн дотор (2002 оны хоёрдугаар сарын 1-ний байдлаар) 2 мянга гаруй түвд хүн төрөл төрөгсөдтэйгээ уулзах буюу нутагтаа үлдэхээр хилийн чанадаас ирсэн байна.[1800] 2002 онд ТӨЗО-ны эрх баригчид төрөл төрөгсөд болон танил


1


2


3

Улс төрийн хоригдлуудыг хорьдог түвдийн зарим шорон (TCHRD): 1 – Драпчи; 2 – Сангьип; 3 – Тисам

хүмүүсээ эргэж, Бурхан багшдаа мөргөж, түүхийн дурсгалт газруудаа үзэхийн тулд хилийн чанадаас эргэж ирэхийг эх орон нэгтнүүддээ уриалсан юм. Хэрэв “эх орноо дэмжсэн үйл ажиллагаа явуулах бол” “салан тусгаарлах үйл ажиллагаа” явуулж байсан хүмүүсийг ч урьж байгаа ажээ.

Гэсэн хэдий ч Түвдээс гарч явахыг хүсэгчдийн урсгал буурахгүй, эрх баригчид ч тэднийг гадагш гаргахгүй байхыг эрмэлзэж байна. Жирийн хүн бол хүчилтөрөгчийн дутагдлаас болж өвчлөх аюултай өндөр уулсаар дамжин нууцаар гадагш гарах явдал ч зогсохгүй байна. 1991-ээс 2002 он дуустлах хугацаанд жилд дунджаар 2500 түвд хүн хилийн чанадад гарчээ.[1801] Балбаар дамжих зам хамгийн сайн нь гэнэ. Бусад газраар бол уулс давах бараг боломжгүй. Түүгээр давах хүн гэж ганц нэг л байх бөгөөд тохиромжтой даваа цөөн, тэгээд ч тэнд хятадын хилийнхэн эзэгнэжээ. Дүрвэгчдийн олонхи нь өвлийн дөрвөн сард Балбад очдог байна. Хятадуудын хилийн хяналт бага зэрэг сулардаг явдал үүний нэг шалтгаан ажээ. Өвөл үзэгдэх орчин сайн, цасны гадаргуу мөстөх нь жилийн бусад улиралд зам харгүй нь найдваргүй болдог газруудаар явахад илүү таатай нөхцөл бүрдүүлдэг гэж олон хүн үздэг байна.[1802] Хятадын эргүүлүүдээс гадна тохиолдох өөр аюулууд гэвэл хоол унд бэлтгэх ус, түлш дутагдах, өлсөж, цангах, хэт ядрах зэрэг болно. 40 хэм хүртэлх хүйтэнд цасан шуурга тавих нөхцөлд хүмүүс төөрч, нүүр ам, хөл гараа хөлдөөх, цасанд гялбаж нүд юм харахаа болих зэрэг бэрхшээлтэй тулгарна. Олон дүрвэгч туйлдаа хүртэл ядарсан, хүйтэн жаварт хайруулж, хөлдсөн байдалтай хүрэх газраа очдог байна.

Олон хүн түвдээс гарч чадалгүй баригдаж, зарим нь золгүй тохиолдлоор буюу хятадуудын суманд өртөж амь насаа алдана. Жишээ нь, 2001 оны зургаан сарын хугацаанд хятадын аюулаас хамгаалах албаны ажилтнууд хилийн чанадад гарах гэсэн 2500 түвд хүн баривчилжээ.[1803] 2006 оны есдүгээр сарын 30-нд Нангпа-лагийн даваан дээр хэсэг дүрвэгчийг буудаж хороосныг румыны операторч дүрс бичлэгийн хальсанд буулган авч чаджээ.[1804] Ийнхүү буудан хороохыг харсан гадаадын олон уулчин хүмүүст энэ тухай ярьжээ. Хүүхэд голдуу 70 орчим түвд хүн Балба орохоор явжээ. Тэднийг олж харсан БНХАУ-ын ардын зэвсэгт цагдаагийн 3-5 хүн гал нээсэн байна. 17 настай гэлэнмаа алагдаж, 13 настай жаал хүү шархдаж, удалгүй нас барсан байна. Балба руу 36 хүн явж, бусад нь хятадуудад баривчлагджээ. Хүмүүсийг ийнхүү буудсан тухай дүрс бичлэгийг Интернетэд оруулсан байна. Дараа нь түүнийг монтажилж тэрхүү бичлэгийг хуурамчаар үйлдсэн мэтээр харагдуулж чадсан ажээ.

2003 онд Шигазегийн районд Балба орох замдаа буюу буцаж явахдаа



Өндөр уулс давж Балбад очсон түвд дүрвэгчийн хөлийн хуруунууд хөлджээ (Dangerous crossing, 2005)

баригдсан түвдийн дүрвэгчдэд зориулж тусгай шорон нээжээ. Тэр шоронг "Цас мөсний орны хүлээн авалтын шинэ төв" хэмээн нэрлэсэн байна. Баригдагчдын олонхи нь 3-5 сар суудаг байсан гэж тэр үеийн үйл явдлыг нүдээр үзсэн гэрчүүд ярьжээ.[1805] Бусад газарт бол цагдаагийн хэсэгт шоронд 10 хоногоос 1-3 сар суух шийтгэл оногдуулдаг ажээ.[1806] Хоригдож буй хүмүүсийг гол төлөв зодож, цахилгаан гүйдлээр тамалж, орон нутгийн зам тавих ажилд дайчилна. "Хөдөлмөрөөр хүмүүжүүлэх" хэлбэрийг өргөн хэрэглэнэ. Тэнд хоол унд муу. Олон хүн 1700–5000 юаниар торгуулж, төрөл төрөгсдийнхээ хамт дахиж оргохгүй гэсэн баталгаа гаргаж өгнө. Хэрэв хятадууд зам зааж явсан түвд хүн баривал тэр хүн удаан хугацаагаар хоригдож, хатуухан гараар орно. Эмэгтэйчүүдэд эрчүүдийг бодоход арай гайгүй хандаж: тэднийг зөвхөн суран бүсээр ороолгох бөгөөд харин эрчүүдэд цахилгаан бороохой, бас мал туухад зориулсан цахилгаан үргээгүүр хэрэглэнэ.[1807] 2001 онд хэрэв түвдчүүд хилийн чанад руу гарах гэж оролдвол төрөл төрөгсдийнх нь газрыг хурааж,шоронд хорино гэж түшмэд сүрдүүлжээ.[1808]

Балбад орон нутгийн цагдаагийнхан л Түвд дүрвэгчийг баривчилж болох ажээ. Ингэсэн нөхцөлд дүрвэгчийн бүх алт, мөнгөн эдлэл зэргийг хураaж авна. Гэвч дүрвэгчид хятадын хилийнхэнд шилжүүлж өгөхөөс л илүү их айна. Жишээ нь 2001 онд 15 дүрвэгчийг ийнхүү хятадуудад тушаасан тухай мэдээ гарсан боловч нийт тоо үүнээс ч их байсан гэж хүмүүс үздэг юм.

Балбын эрх баригчид Бээжингийнхний шахалтаар хилийнхээ хяналтыг чангатгаж, Катманду хотод түвдчүүдийн жагсаалыг тараах болж, түвдийн цагаач засгийн газрын төлөөлөгчийн газрыг хаав. БНХАУ түвдийн дүрвэгчдийг "аж ахуйн шилжин суурьшигчид" буюу гэмт хэрэгтнүүд хэмээн үзэхийг Балбын засгийн газарт шахаж байна.[1809] Хэрэв ингэж үзвэл тэд дүрвэгчийн статус эрх авч чадахгүй болж байгаа юм. Бодит байдалд бол дүрвэгчдийн олонхи нь цалин хөлстэй ажил хийх гэж Түвдээс гарч явж байгаа юм бишээ. Жишээ нь, 2006 онд дүрвэгчдийн 45 хувь нь лам,



Түвд, Балбыг заагладаг Нанпа ла даваанд хяналт тавих зорилгоор байгуулсан хятад цэргийн бааз (Dangerous crossing, 2006

гэлэнмаа нар, 30 хувь нь Түвд боловсрол эзэмшихийг хүссэн хүүхэд, оюутнууд, 20 хувь нь тариачид, дөнгөж 5 хувь нь нүүдэлчид болон ажилгүй хүмүүс байжээ.[1810] Эцэг, эхчүүд хятаджуулсан биш, харин зохих ёсны боловсрол эзэмшүүлэхийн тулд л хүүхдүүдээ цагаач Түвд иргэдийн сургууль бараадуулахыг эрмэлзэж байгаа юм.

XX зууны сүүлчээр Балба орон маогийн алан хядагчдын өдөөсөн иргэний дайнд автав. Алан хядагчид: "хотыг тосгодоор хүрээлэх", "хувьсгалт ард түмний эсрэг чиглэсэн феодалын дарангуйлагчдын фашимт дайралт", "дарлал мөлжлөгийн эсрэг бослого", "ардын дайн", "Орос, Герман,Франц зэрэг империалист орнууд", "ялгаварлан гадуурхсан гэрээ хэлэлцээр" зэрэг Маогийн үзэл санааны зэвсгийн санг ашиглаж: хууль бус зэвсэгт бүлгүүдээ "ардын чөлөөлөх арми" хэмээн нэрлэж байв.[1811] Маогийн үзэлтнүүд орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчдийн амь насыг хөнөөж, хөдөө тосгонд дайран орж, эмэгтэйчүүдийг хүчирхийлж, 9–15 насны хүүхдүүдийг дээрмийнхээ бүлгүүдэд хүчээр авч явж,[1812] үлдсэн оршин суугчдад татвар гувчуур оноож байлаа. Дургүйцлээ илэрхийлсэн хүмүүсийг ална. Замуудыг хааж, түүгээр явж байсан машинуудыг шатаах буюу дэлбэлнэ. Тэнд очсон жуулчдад ч татвар онооно. Жуулчдаас аятайхан харагдсан эд зүйлсийг хурааж авна.[1813] Маогийнхан балбын олонхи уулархаг нутаг төвөөс тусгаарлагдсан, засгийн газар сул дорой, вангийн засаг төр хямралд идэгдсэнийг далимдуулан тэнд хяналтаа тогтоожээ. Маогийнхны удирдагч Прачанда ТӨЗО-нд гарч буй эсэргүүцлийн ажиллагааг "салан тусгаарлах гэсэн хүчирхийлэл" гэж нэрлэсэн байна.[1814] Түүнийг мэдээжийн



Ардын зэвсэгт цагдаагийн газрынхан Түвдээс Балба руу гарах гэж яваад Нангпа-ла даваан дээр баригдсан түвд хүүхдүүдийн хамт (Dangerous Crossing, 2006/ Pavle Kozjek авсан гэрэл зураг)

хэрэг АНУ л зохион байгуулж байгаа биз гэж тэр үзэх ажээ.

2008 оны дундуур хувьсгалчид Балбад хаант засгийг түлхэн унагав. Зургадугаар сард БНХАУ, Балбын коммунист намуудын төлөөлөгчдийн уулзалт болов. Манай нам "түвдийн талаар ХКН-ын баримталж буй бодлогыг дэмжиж, Хятад улсыг шилдэг анд нөхрөө хэмээн үзэж байна" гэж балба нөхөр онцлон тэмдэглэжээ.[1815] Балбын хувьсгалын дараа АНУ Балбын маогийн талыг баримтлагч намыг алан хядах байгууллагын нэрсийн жагсаалтаас хасаагүй ч "тогтвортой байдал, ардчилал, энх тайванд дэмжлэг үзүүлэхийн" тулд түүнтэй хамтран ажиллах тухай зарлав.[1816] Сонгуульд маогийн талыг баримтлагчид олонхи болов. Энэ бол гайхах зүйл бишээ. Хүн амд өгсөн саналынх нь төлөө энх амгалан байдал тогтоохыг амласан нь хүүмүүсийг барьцаалсан этгээд хэрэв надад эрх мэдэл өгвөл та нарыг алахгүй гэж амалж байгаатай адил ажээ. Балбад маогийнхны нийгэмд мониторинг, шинээр интеграц хийхэд анхаарал тавьж эхэлжээ. Эдгээр өөрчлөлтийг "дайтагч тал"[1817] хэмээх нэр томьёогоор илэрхийлэх бөгөөд энэ нь алан хядагч хувьсгалч биш харин партизан гэсэн үг ажээ.

Балбад түвдийн дүрвэгчдийн эсрэг гэсгээн цээрлүүлэлт хүчтэй болов. Маогийн коммунист залуучуудын эвлэлийнхэн хүртэл дүрвэгчдийг

баривчлах болсон байна.[1818] 2009 оны наймдугаар сарын 15-нд Лхас хотод зөвлөлгөөн болж балбын нутаг дэвсгэрт болж байгаа хятадын эсрэг тэмцэл хөдөлгөөнийг нухчин дарах тухай хятадын талын саналыг хэлэлцжээ.[1819] Энэ хэлэлцүүлэгт оролцохоор балбын аюулаас хамгаалах албаны бараг бүх удирдлага ирсэн байна. 2009 оны аравдугаар сард Балбын дотоод явдлын яамны сайд хэлэхдээ дүрвэгчид Балбад найрсаг хятадын эсрэг жагсаал хийх эрхгүй; усын хилийг гэмт этгээдүүд орж ирэхээс хамгаалан аюулгүй болгох төрийн төлөвлөгөө бидэнд бий; Балбын сайд нарын танхим 15 мянга гаруй цагдаагийн ажилтан, түүний дотор зэвсэглэсэн цагдаагийн газарт 7 мянган хүн, бусад анги салбаруудад мөн 7 мянган хүн элсүүлж авахыг сайшаасан юм хэмээн мэдэгдсэн юм.[1820] Бээжингийнхний мөрөөдөл бодит үйл хэрэг болсонтой адил болж: Түвдийн бодит байдлын тухай мэдээллийн суваг хаагдах болсон ажээ.

БНХАУ Балбад нөлөөгөө хүчтэй болгохын тулд балбын армид туслахыг эрмэлзэж байлаа. “Хуучин” цэргүүд болон маогийнхны анги нэгтгэлүүдийн “шинэ” хүмүүсийг ч дээрх хэрэгт татан оруулах болов. Түүний зэрэгцээ голчлон уулын ястнуудад түшиглэдэг балбын маогынхан эдгээр үндэстэн ястны уламжлалыг харгалзан үзэж, тэдний бурханы шашны зан үйлүүдэд оролцохоос өөр аргагүйд хүрсэн байв. Гэхдээ БНХАУ-тай тогтоосон хэлхээ холбоо хөгжиж, хятадын тал балбын армид тусламж үзүүлж, балбын хүчний байгууллагынхан БНХАУ-д байн байн очих болсон нь Балбад БНХАУ-ын байр суурь бэхжиж, Энэтхэг улс, түүнчилэн энэ оронд байгаа түвдчүүдийн эрх ашигт хохирол учруулав.[1821]

Гэсгээн цээрлүүлэлт хийж байгаа ч түвдийн ард түмний тэмцэл үргэлжилж байна. Энэ тэмцлийн эрч БНХАУ-ын бусад “үндэсний цөөнхийн” нутаг дэвсгэрийнхээс илүү их байв. Түвд дэх гэсгээн цээрлүүлэлтийн түвшин ч хавьгүй өндөр байсан юм. Социализмын үеийн баривчилгаа, эрүү шүүлт, цаазлалтын цар хүрээ болон харгис чанар феодалын байгууллын үеийнхээс хамаагүй давжээ. Гэвч ард түмэн итгэл найдвараа үл алдах ажээ. Мао Зэдун: “Тэмцэл, ялагдал, дахиад тэмцэл, дахиад ялагдал, дахиад тэмцэл, дахиад ялагдал ийм л байдлаар жинхэнэ ялалт хүртэл –ард түмний логик сэтгэлгээ ийм л байна” гэж зөв хэлжээ.[1822]

## *Шашин*

Маог нас барснаас хойш шашны амьдрал амархан сэргэж эхэллээ. 1979 онд Жокан сүм болон Дрепун хийдийг дахин нээв.[1823] Жокангийн эргэн тойрон

татсан өргөст торон хаалтыг буулгав. Тийнхүү тус сүмд мөргөлчид ирэх болжээ. Үүнд X Банчин лам их үүрэг гүйцэтгэжээ. Түвдчүүд өөрсдийнхөө хүчээр Гандан хийдийг шинээр байгуулж эхлэв. Гэвч 1983 онд сэргээн засварлах ажил саатсан юм. Тэндхийн олон ажилчинг баривчилж, лам нарын тоонд квот, насны хязгаар тогтоож: 18 хүртэлх насны хүүхдүүд социалист хүмүүжил авах ёстой болов. 1982 онд БНХАУ-ын засгийн газар Дашлхүмбэ хийдийг засварлахад 900 мянган юань гаргав.[1824]

1980-аад онд Хятад руу зөөж авч явснаас хойш хадгалагдаж үлдсэн сүм хийдийн тэрхүү цөөн тооны эд зүйлсийг Түвдэд эргүүлж авчирч чадсан байна. VII зуунд Соронзон Гомбо хааны балба эхнэрийн Түвдэд авчирсан Бурхан багшийн цутгамал баримлын цээжин биеийн хэсгийг 1983 онд Бээжингээс Лхаст эргүүлж өгчээ. Рибур Тулку тэргүүтэй түвдийн эрэлийн бүлэг түүнийг нисэх онгоцоор Чэндүд хүргэж ирсэн байна.[1825] Тэнд бурхан багшийн баримал хөрөгийг сүмд байрлуулж, түвд,хятад лам нар аравнайлан ном уншжээ. Харин уг хөрөг баримлыг Лхас хотод авч ирэхэд санасныг бодоход баяр ёслолын байдалтай угтаж авсангүй: учир нь энэ үед түшмэдүүдийн хурал болж байжээ. Гэхдээ Жокан сүмийн дэргэд ариун шүтээнээ буцаж ирсэнд хөөр баяр болсон олон мянган энгийн иргэн цугларсан байжээ.

БНХАУ Будалын ордон, Жокан сүм болон бусад хэд хэдэн обьектыг сэргээн засварлаж, тохижуулахад зориулж 300 сая гаруй юань, их хэмжээний алт, мөнгө болон бусад материал төсөвлөн гаргажээ.[1826] 1989 онд Будалын ордны их засвар эхлэв. 2001 оноос энэхүү их засварын хоёрдугаар ээлжинд, мөн Норовлин шилтгээний цогцолбор, Сажа хийдийн засварт 330 сая юань төсөвлөжээ. 2008 оны дөрөвдүгээр сард 15 нь төрийн онцгой хамгаалалтад байдаг Түвдийн соёлын 22 дурсгалыг сэргээн засварлах төсөл тийнхүү Дашлхүмбэ хийдээс эхэлсэн байна.[1827] Энэхүү төсөлд 570 сая юань гаргахаар төлөвлөсөн байна. Энэ төсөл ТӨЗО-ны түүхэнд хамгийн томоохонд орох болно. Дээр дурдсан обьектуудаас гадна Сэра, Дрепун хийдүүдийг сэргээн босгож, хамгаалалтад авч, Гандан хийдийг шинээр барив. XIV Далай ламын төрсөн нутаг Такцер тосгонд түүнд зориулсан сүм байгуулах ажил 2009 онд дууссан нь тэмдэглүүштэй үйл явдал билээ.[1828] Багш, Хөх нуур мужийн Ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн гишүүн асан 63 настай Гомбодаш энэ ажлыг санаачилсан бөгөөд энэ хүн Далай ламын зээ дүү юм. БНХАУ-ын засгийн газраас санхүүжүүлж буй тэдгээр сэргээн засварлах ажлыг нарийвчилсан сонголтын үндсэн дээр хэрэгжүүлж байгаа юм.

Ер нь бол Түвдийн хийдүүдийг сэргээн засварлах ажлыг шашны хэрэг

эрхлэх товчооны зөвшөөрлөөр л хийж болдог ажээ. Хүнд суртлын олон шат дамжлагын дараа л энэ зөвшөөрлийг олгодог байна.[1829] Энэ шат дамжлагын явцад түвдчүүд хүсэлтээ уламжлан хэд хэдэн удаа хандах, "үндэсний эрх ашигт" шашны үзүүлэх зохисгүй нөлөөний тухай бүхэл бүтэн лекц сонсоход хүрдэг байна. Жишээ нь, 1992 оны аравдугаар сарын 1-ний өдрийн "Орон нутгийн шашны үйл ажиллагааг удирдах Хөх нуур мужийн дүрэмд" заасан журмыг баримтлахгүйгээр шашны байгууламж нээх буюу барьж байгуулах боломжгүй юм.[1830] Эхлээд хүсэлтээ орон нутгийн засгийн газарт явуулна, тэндээс уг хүсэлтийг үндэсний болон шашны хэрэг эрхлэх газарт шилжүүлж, дараа нь арай дээд түвшний байгууллагын мэдэлд очино. Эд бүгдээс зөвшөөрөл авах хэрэгтэй. Тухайн обьект нээгдсэнийхээ дараа орон нутгийн засгийн газар болон шашны хэрэг эрхлэх газрын засаг захиргааны удирдлагад байна. Ардчилсан удирдлага хэрэгжүүлэх ёстой. Ардчилсан удирдлагын хороодын үүрэг хариуцлагад сүм хийдийнхэн болон сүсэгтнүүдийг ХКН-ын удирдлага, социализм, эх оронч үзэл, үндэсний эв нэгдлийг дэмжих үзэл санаагаар хүмүүжүүлэх зорилт орж байна. "Феодалын болон шашны онцгой их эрх дарх, нэгэнт халж хүчингүй болгосон дарлал мөлжлөгийн системийг сэргээж болохгүй" ажээ.

Сүм хийдийг (түүний дотор төрөөс мөнгө гаргаж өгсөн) түвдчүүдийн сайн дурын хөдөлмөр болон мөнгөн хандивын ачаар л сэргээн засварлах боломжтой юм.[1831] Улсаас өгсөн хөрөнгө мөнгө гол төлөв зардлын багахан хэсгийг л бүрдүүлнэ. Хийдүүд засгийн газраас мөнгө авдаггүй: сүсэгтнүүдийн өргөлөөс бүрэн шалтгаална. Харин эрх баригчдаас тогтоосон хэд хэдэн хийдэд орох төлбөр улсын мэдэлд очино. Хятадын хүчний байгууллагынхан зарим үед мөргөлчдийн өргөлийг хурааж авах ажээ. Сүм хийдүүд натурал аж ахуй эрхэлж, өөрөө өөрийгөө хангах ёстой ч ардчилсан удирдлагын байгууллагууд тэдгээрийн санхүүгийн хэргийг хянадаг байна.

Хятадын талын мэдээгээр бол 2000 он хүртэл ТӨЗО-нд шүтлэгийн үйл ажиллагаа явуулах 1700 газар нээгджээ. Хятадын Түвд судалгааны төвийн мэдээгээр бол ТӨЗО-ны бүрэлдэхүүнд ордоггүй түвдийн засаг захиргааны нэгжүүдэд ийм газар 1535 байна.[1832] Энэ бол Соёлын хувьсгалаас хойш долоо буюу арвангурав үлдсэнийг харгалзан үзвэл маш том сэргээн босголт мөн. Гэхдээ хятадын халдлагаас өмнө Их Түвдэд 6259 хийд болон шашны бусад төв байжээ. Ингэхлээр тэдгээрийн тэн хагас орчмыг л сэргээгээд байна. Лам, гэлэнмаа нарын тоо үлэмж өсөв. 2000 он гэхэд тэдний тоо 120 мянгад хүрснээс 46 мянга нь ТӨЗО-нд байна.[1833] Үнэн хэрэгтээ бол албан

ёсоор тооцоогүй хүмүүсийг оролцуулбал лам нарын тоо 180 мянга болсон гэж Ц. Шакья дүгнэжээ.

ТӨЗО-нд буддийнхээс гадна бон шашны 88 хийд, энэ шашны 3 мянга орчим лам нар: Лхас дахь исламын сүм, 2 мянга шахам ислам сүсэгтэн: католик шашны сүм,700 орчим католик шашинтан байна.[1834] Өөр нэг мэдээгээр бол 1990-ээд онд ТӨЗО-нд 3 мянган Түвд ислам сүсэгтэн, 20 мянга орчим хятад ислам сүсэгтэн байжээ.[1835] 2006 онд ТӨЗО-нд исламын дөрвөн сүм, 4-5 мянган ислам сүсэгтэн, католик шашны сүм нэг, тэнд ирдэг 560 сүсэгтэн байсан хэмээх мэдээ бий.[1836] 1967 оноос хойш анх удаа 1986 оны хоёрдугаар сард Лхаст Монламын баярт зориулсан ёслол үйлдэхийг зөвшөөрчээ.

1984 оноос эрх баригчид шашинд тавих хяналтыг нилээд хэмжээгээр сэргээсэн юм. Далай лам 1987 оны гуравдугаар сарын 10-нд хийсэн мэдэгдэлдээ: “Түвд дэхь шашны эрх чөлөө гэгч нь өнөө үед янз бүрийн ёслол үйлдэх сүсэгтнүүдийн боломж төдийгөөр хязгаарлагдаж байна. Энэ нөхцөлд буддын сургааль заах, судлахад ил, далд хязгаарлалтууд тавьж байна. Тийнхүү бурханы шашин мухар сүсэг болж хувирсан бөгөөд хятадын коммунистууд ч бурханы шашныг ийм байдлаар ойлгож байгаа юм” гэж онцлон тэмдэглэжээ.[1837] Хэд хэдэн хууль тогтоомжийн акт гаргаж, ТӨЗО, Хөх нуур, Ганьсу, Юньнаний түвдийн бурханы шашныг удирдах хороо байгуулав. “Засгийн газрын бодлогыг амьдралд хэрэгжүүлэх, лам, гэлэнмаа нарыг эх оронч үзэл санаагаар хүмүүжүүлэх, сүм хийдийн удирдлагад ажиглалт тавих” явдал тус хорооны чухал зорилтууд юм. 1988 оны есдүгээр сарын 28-нд Х Банчин лам шашны хэрэгт хятадын засаг захиргааны хөндлөнгийн оролцоог зогсоож, энэ хэрэгт түвдчүүдийн идэвх оролцоог хүчтэй болгохыг уриалсан байна.

Шашныг сулруулахад засаг захиргааны арга хэмжээ биш, харин хүн ардын боловсролын түвшин, амьдралын сайн сайхан байдлыг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийг хангаж, суртал нэвтрүүлгийг хүчтэй болгох явдал чухал хэрэгтэй юм гэж Зян Зэминь 1990 онд цохон заажээ.[1838] Өөрөөр хэлбэл, оюун санааны хүчин зүйлээс материаллаг байдлыг анхаарах хэрэгтэй гэсэн үг юм. 1991 онд тэрээр коммунист намыг дэмжих, тэр дундаа улс төрийн бодлогод ХКН-тай хамтран ажиллаж, үзэл суртлын тухайд бол бие биенээ харилцан хүндэтгэхийг шашны зүтгэлтнүүдэд уриалсан байна. 1993 онд Зян шашин, социалист нийгэм хоёрыг харилцан нийцүүлэх нь шашинд хандах шинэ хандлагын нэг илрэл болох юм гэж хэлсэн байна. Энэ хандлага нь сүсэг бишрэлээс татгалзахыг биш, харин ХКН,социализмыг дэмжих: социализмд

үл нийцэх шашны байгууллагууд болон үл гүйцэлдэх үзлүүдийг өөрчилж: шашны элементүүдийг социализмд үйлчлэхэд ашиглахыг шаардаж байна. Энэ нь шашингүйн хүмүүжлийг өөрчилж буй хэрэг биш юм гэж тэр хэлсэн байна.

1994 оны дөрөвдүгээр сард Түвдийн асуудлаар хийсэн ажлын гуравдугаар чуулга уулзалтаас түвдийн буддийн шашин болон соёлыг социализмд нийцүүлэх байдлаар өөрчлөх стратегийн зорилт дэвшүүлэн тавьжээ.[1839] Сүм хийд байгуулах, лам хуврагуудын тоог нэмэгдүүлэх явдлыг эцэс болгож, Далай ламын нэр хүндийг унагаж, том ламууд дахин төрөх явдлыг "удирдаж" байхаар шийдвэрлэжээ.

Эдгээр шийдвэрийн хүрээнд 1996 оноос эхлэн гэсгээн цээрлүүлэлтийг хүчтэй болгов.[1840] Хятадад гол төлөв гэмт хэргийн эсрэг чиглэсэн "эх оронч хүмүүжил", "Оюун санааны соёл иргэншил", Хатуу цохилт" зэрэг кампани түвдэд "салан тусгаарлах үзэл" болон "Далай ламын бүлэгт" цохилт болж хувирсан байна. "Эх оронч хүмүүжил" кампанийг хятадын ажилчдын бригадууд хэрэгжүүлэв. Эдгээр бригадыг бараг бүх хийдэд, тэгэхдээ хийдүүдийн зардлаар байгуулжээ. Бригадын гишүүдийн тоо хийдийн том,багаас хамаарна. Эдгээр бригадын гишүүд хичээл, цуглаан зохион байгуулна. Тэдний гол зорилго лам нарын тоог цөөрүүлэх явдал ажээ. "Хүмүүжлийн" дунд зарим лам нар нас барж, нөгөө хэсэг нь амиа хорлоно. "Хүмүүжээгүй" лам нарыг хийдээс хөөж явуулах буюу баривчилна. Ийнхүү 1996–1997 онд 2827 лам хийдээсээ хөөгдөж, 165 лам баривчлагдаж, есөн лам амь үрэгдэж: 1998 онд баривчлагдсан, хөөгдсөн лам нарын тоо 327 ба 7156, 1999 онд 42 ба 1432 болжээ.[1841] Хийдээс хөөгдсөн лам нарт ажлын бригадууд л намайг ийм байдалд орууллаа хэмээн ярьж болохгүй, хэрэв ярьсан байвал баривчилна гэж сүрдүүлжээ.[1842] Лам нарын тоог хатуу хязгаарлана. Зарим сүмд маш цөөн лам байх, зарим нь бүр хоосон ажээ.[1843] Албан ёсны мэдээнээс үзвэл 2000–2008 онд ТӨЗО-нд үйл ажиллагаа явуулж буй сүсэг бишрэлийн газруудын тоо өөрчлөгдөөгүй: "1700 гаруй", лам нарын тоо – 46 мянга гаруй" байжээ.[1844]

Суртал нэвтрүүлэгчид лам нарт түүх болон шашинд хандах мушгин гуйвуулсан үзэл бодол суулгахыг эрмэлзэх ажээ. "Түвдийн бурханы шашны хийдүүдэд эх оронч хүмүүжил дэлгэрүүлэх конспектын "ишлэлийг[1845] танилцуулья. Энэ конспектийг 1997, 1998 онд Хөх нуур мужийн хийдүүдэд хэрэглэж байсан бөгөөд янз бүрийн сэдэвтэй найман хичээл, орон нутгийн хууль тогтоомжийн мэдээллүүдийг багтаажээ. Конспектийн зарим хэсэг Түвд орон ямагт Хятадын нэг хэсэг байсан,түүний тусгаар тогтнолын

тухай асуудал XX зуунд империалистуудын хөндлөнгийн оролцооноос болж үүссэн мэт суртал нэвтрүүлэгтэй давхцах жишээтэй. Бас нилээд хурц хэлбэрийн ишлэлүүд ч байх ажээ: “Түвд албан ёсоор Юань гүрний мэдэлд орсны дараа түвдчүүд зүрх сэтгэлээрээ төр улсынхаа дотоод хэрэгт оролцох гэж эрмэлзээд зогсоогүй тэд эх оронтойгоо эв нэгдэлтэй байдгаа анх удаа ухамсарлан ойлгосон юм.<...> Тэд Түвд орон хятадын нэг хэсэг байсан, түвдчүүд хятадын ард түмний нэг хэсэг байсан, Түвд болон эх орон маань нягт холбоотой бөгөөд хятад болон Түвд үндэстэн сэтгэл, зүрхээрээ нэг, нэг л зүйлд нэгдмэл байсан”.(х.31). “Шашны үйл ажиллагаа, шашны байгууллагууд Нам, засгийн газрын удирдлагыг авах ёстой. Нам, засаг болон шашны байгууллагууд, шашны зүтгэлтнүүдийн харилцаа бол жолоодогч ба харьятууд, удирдагч ба удирдуулагчийн харилцаа мөн.<...> Түвдийн бурханы шашны нийгэмлэгүүд... шашны сөрөг элементүүдийг хязгаарлаж, зохимжгүй үзэгдлүүдийг даван туулж, шашныг социалист нийгэмтэй нийцүүлэхийн төлөө тэмцэх ёстой юм”.(х.36–35). “Түвдийн буддистуудын өргөн олон түмэн эх оронч үзлийн тугийг өндөрт өргөж, Далай ламын нөлөөг ухамсраасаа авч хаях ёстой”.(х.40).

“Сүм хийдүүдэд хийх суртал нэвтрүүлэгт зориулсан № 2 удирдамжид: ТӨЗО-ны сүм хийдүүдийн эх оронч хүмүүжлийн хорооноос гаргасан “салан тусгаарлах үзлийн эсрэг хүмүүжлийн удирдамжийн[1846] 2-р хэсэгт: “Түвдийн тусгаар тогтнол гэдэг бол хуучин, шинэ империалистуудын сэдсэн төлөвлөгөө мөн”, 3-р хэсэгт: “Хятадын эсрэг олон улсын хүчнээс Далай ламын бүлгийг дэмжих бодит зорилго” гэх мэтээр өгүүлсэн байна.

“Эх оронч хүүмүүжлийг жишээ нь, ингэж явуулна.[1847] Хичээлийг ихэвчлэн 9-өөс 13 цаг хүртэл завсарлагатайгаар явуулж, дараа нь 15-аас 18.30 цаг хүртэл үргэлжлэнэ. Хичээл бүрийн дараа 5 минутын завсарлагатай байна. “Салан тусгаарлах үзлийг” эсэргүүцэх нь: Түвд, Хятадын эв нэгдэл: Бээжингээс томилсон XI Банчин ламыг хүлээн зөвшөөрөх нь: өнгөрсөн үеийн Түвдийн тусгаар тогтнол, тусгаар тогтнох гэсэн одоогийн эрмэлзэлийг няцаах нь: Далай лам “эх орны эв нэгдлийг” бусниулж байгаатай санал нэгдэх нь гэсэн таван хичээл байна. Хэрэв ямар нэгэн лам өдрийн хичээлийн асуултад хариулж чадахгүй бол ганцаарчилсан нэмэлт хичээлд суулгана. Энэ тохиолдолд ажилчдын бригад ламын гэрт очиж 1–2 цаг хичээллэнэ.

“Эх оронч хүүмүүжлийн” илүү хатуу аргууд ч бий.[1848] 2000 оны тавдугаар сарын 1-нд Чамдогийн шашны хэрэг эрхлэх газрын 30 түшмэлээс бүрдсэн ажилчдын бригад Зоганг гацааны Тентхок хийдэд очжээ. Далай ламын бүх хөрөнгийг хураахыг лам нарт тушаажээ. Үүнийг лам нар

эсэргүүцэхэд тэдний гуравыг зодож, нэгнийх нь хавиргыг хугалсан байна. Далай ламын зургуудыг хурааж авчээ. Өөр нэг ламыг гуравдугаар давхарт байх өрөөнд хүчээр дагуулан очиж, Далай ламын гэрэл зургийг гаргаж өг хэмээн тушаажээ. Ингэсний дараа тэр лам гуравдугаар давхараас үсэрч нас баржээ. Дараа өдөр нь эсэргүүцлийн ухуулах хуудсууд гарав. Ингэсний дараа нийгмийг аюулаас хамгаалах товчооны хүмүүс ирж, түшмэлүүдтэй хамтарч таван лам баривчилжээ. Хэрэв хэн нэгэн хүн лам “амиа хорлосонд” түшмэлүүдийг буруутгавал олон жилийн хугацаагаар шоронд хорих ял ононо хэмээн сүрдүүлжээ. Санал маргаан шатлан өргөжих хандлагатай болсон учир хяналтын нэмэлт арга хэмжээ авч, 20 шахам энгийн иргэн баривчилсан байна.

Сүм хийдүүдэд хяналт тавих зорилгоор тэнд цагдаа нар болон армийн офицерууд байрлуулж, мэдээлэгч этгээдүүдийг хөлсөлж, гол гол хийдүүдэд цагдаагийн хэсгүүд байгуулав. Хүчний бусад байгууллага ч хяналтын асуудал эрхлэх болсон байна. Жишээ нь, нийгмийг аюулаас хамгаалах газар, “Фалуньгун” хэмээх шашны бүлэгтэй тэмцэх зорилгоор хятадын тусгай албадын байгуулсан бөгөөд дараа нь түвд, уйгур иргэд болон тэрслүү үзэлтнүүд, тайваньчуудтай тэмцэж байсан “610-”ын товчоо” зэрэг болно.[1849] Коммунистуудын дэглэмийг эсэргүүцэгч энэ бүх хүнийг албан ёсны бүтцүүдэд “таван хор” гэж нэрлэдэг байжээ.

Ажлын нэгдсэн фронтын хэлтэс, Шашны хэрэг эрхлэх товчоо, Хятадын бурханы шашинтнуудын холбооны Түвдийн салбар, Ардчилсан удирдлагын хороо, Улс төрийн боловсрол болон улс төрийн судалгааны асуудал эрхэлсэн шалган байцаах газрууд, аюулаас хамгаалах албад зэрэг хүнд суртлын олон байгууллага сүм хийдийн амьдралыг зохицуулах дүрэм журам гаргах ажээ. Түвдийн бурханы шашны хуулиудыг зөрчиж XIV Далай ламын аливаа зураг хөрөг, бичвэрүүдийг хориглож байна.

Жишээ нь, 1997 оны долдугаар сарын 22-нд гаргасан “Лам, гэлэнмаа нарт зориулсан Лхас хотын захиргааны сахилга батын дүрэмд”: “1. Хууль, журам, үндэс ястны эв нэгдэл, эх орны эв нэгдлийг сахин мөрдөж, салан тусгаарлагчдыг сөрөн зогсох хэрэгтэй. 2. Нам, засгийн жолоодогчдыг, социалист системийг, түүнчилэн районы түшмэдийн тогтоосон бодлого, дүрмийг хүндэтгэх хэрэгтэй. 3. улс орны эв нэгдэл, аюулгүй байдалд заналхийлэх буюу хор учруулах харгис суртал нэвтрүүлгийг сонсох буюу тараах: харгис утга агуулгатай ном зохиол, дуу буюу дүрс бичлэг олж авах буюу тараах буюу аливаа төрлийн салан тусгаарлах үйл ажиллагаанд оролцохыг хэнд ч зөвшөөрөхгүй. 4. Хийдийн (сүм буюу даяанчийн газрын)

ардчилсан удирдлагын хорооноос тогтоосон дүрмийг хүлээн авч: нийгэм хийгээд хийдийн сайн сайхны төлөө ажиллаж, үйлдвэрлэл ба хөдөлмөрт идэвхтэй оролцвол зохино. 5. Сүм хийдийн багш нар, түшмэлүүдийн зөвлөмжийг сонсож, ахмадууд болон залуучуудын хоорондын эв санааны нэгдлийг дэмжих хэрэгтэй. 6. Буддад үнэн сэтгэлээсээ итгэн үнэмшиж буйгаа харуулж, бурханы шашны бүх сэдвийг судлаж, түүнийг цэцэглүүлэн хөгжүүлэхийн төлөө тэмцэх хэрэгтэй. 7. Лам, гэлэнмаа нар сахил санваараа, хийдийнхээ сахилга батыг яв цав мөрдөж явах ёстой. Тэд төлөв даруу, ааш зан сайтай байж, онцгой тохиолдлоос бусад нөхцөлд хувраг хувцасаа өмсөж, орхимжоо нөмөрч явах ёстой. 8. Хэн ч шашны нэр барьж засгийн газар болон хууль ёсны түшмэдийг сөрөн зогсох буюу хүмүүжлийн ажлыг эсэргүүцэж болохгүй. 9. Соёлын дурсгалууд, эртний соёлын олдворууд, сүм хийдүүд болон нийгмийн эд хөрөнгийг хамгаалах хэрэгтэй. 10. Хүрээлэн байгаа орчин болон хувийнхаа эрүүл мэндийг сонирхон хамгаалах хэрэгтэй. Лам, гэлэнмаа нар хийдийнхээ нэр хүндийг хамгаалж, шашин, ард түмнээ хайрлаж, хууль дүрэм сахидаг сайн лам, гэлэнмаа болохын тулд эрчимтэй ажиллах хэрэгтэй"[1850] гэж өгүүлсэн байна.

Хийдэд шавилан суух болзлыг чангатгав. Хэрэв урьд өмнө бага насны хүүхдүүдийг хийдэд өгч болдог байсан бол 16 наснаас, дараа нь 18 наснаас өгөх болсон байна. Хийдэд шавилан суух гэж буй хүн эх оронч байж, ХКН-ыг хайрлан хүндэтгэж, материализм болон спиритуализм (сүнсийг бодит зүйл хэмээн үздэг чиглэл) хоёр хоорондоо харшилддагийг ойлгож, эцэг эх болон хийдүүдийн ардчилсан удирдлагын хороо, нийгмийг аюулаас хамгаалах товчоо зэрэг янз бүрийн түвшингийн орон нутгийн эрх барих байгууллагуудын зөвшөөрлийг авсан байх ёстой бөгөөд хүүхдийн эх эцэг улс төрийн хувьд найдвартай байх ёстой: хийдэд орох хүн уг хийд байрлах тэр мужийн оршин суугч байх ёстой болсон байна.[1851] 1983 онд Хятадын бурханы шашинтны холбооны түвдийн салбар түвдийн буддийн дунд сургууль үндэслэн байгуулахын зэрэгцээ янз бүрийн чиглэлийн сүм хийдүүдийн дэргэд сургалтын ангиуд нээсэн бөгөөд 2006 онд тэдгээрт суралцагчдын тоо 3 мянга болжээ.[1852] Бээжинд Түвдийн бурханы шашны Дээд семинар нээгдэв. Гэхдээ тэнд урьд өмнө хийдийн их сургуулиудын гол үндсэн нэгж болж байсан факультет байгуулахыг хориглосон байна.

Хүмүүс эрт дээр үеэс шашны байгууламжууд барьж, хавь орчных нь газрыг тохижуулж иржээ. Хятадын эрх баригчид харин тийм байгууламжуудыг эвдлэн нурааж, тэнд байсан хүмүүсийг хөөж явуулж байна.[1853] Бараг л маогийн үеийнхтэй адил, гэхдээ арай бага цар хүрээтэй

ажээ. 1998 онд “ажилчдын бригад” Жонаг Гүмбүм хийдийг хаав.[1854] Долоон давхар энэ суваргыг XIV зуунд буддын жонанг чиглэлийн шашны гарамгай зүтгэлтэн Шаравжалцан байгуулж, Соёлын хувьсгалын үед дотор талыг нь эвдлэн сүйтгэж, дараа нь сэргээн засварлаж, шашны амьдрал хэвийн болж эхэлсэн ч удалгүй “хүмүүжүүлэх” ажил явуулж, лам нарын заримыг баривчилж, заримыг хөөж явуулсан байна. 1990-ээд оны сүүлчээр Цетан тойргийн Самдуплин, Лхокийн Сунграблингийн хийд, Гонкарын Дрикун Шерта сургуулийг хааж, Шигшазейн Шончэн, Такцерийн Драг Йерпа хийдийг эвдлэн сүйтгэжээ.[1855] 2007 онд Пангса хийдийг хаасан байна.[1856] 2006 онд Карзегийн өөртөө засах тойргийн Интернет-сайтад хийдүүдэд тавих хяналт хүчтэй болж; тус тойрогт хууль бусаар ирж, бас тэндээс гарч явж буй лам, гэлэнмаа нарын тухай; 853 “хууль бус” байшинг эвдлэн нурааж, Ячен хийдээс 1100 лам, гэлэнмаа нарыг хөөж, энэ тойргоос нууцаар гарч, бас эргэж ирсэн хүмүүс эрх баригчдад бүртгүүлэх болсон тухай мэдээлсэн байна.[1857]

2001 онд Сертхарын шашны дээд сургуульд эвдлэн сүйтгэх, суралцагчдыг бөөн бөөнөөр хөөж явуулах ажиллагаа үйлджээ.[1858] 1980 онд Карзе тойрогт Жигмэд Пунцаг энэ сургуулийг үндэслэн байгуулжээ. Тэнд буддын гүн ухаан, сэтгэл судлал, тоо, ламын сахилга бат, тарнын ёсны хичээлийг компьютер, хятад, түвд, англи хэл ашиглан заадаг байжээ. Тус дээд сургуульд хэд хэдэн мянган хүн, түүний дотор нэг мянган хятад хүн, мөн түвд, монголчууд суралцдаг байсан ажээ. Жигмэд Пунцаг 1990-ээд оны эхээр Энэтхэг болон бусад хэд хэдэн орноор орж, Далай ламтай уулзсан байна. 1994 онд хятадын эрх баригчид үүнийх нь төлөө түүнийг буруушааж байжээ. Нэгдсэн ажилчны фронт, шашны хэрэг эрхлэх товчооны түшмэдийн байцаалт, “хүмүүжлийн” болон улаан материал тараах ажил эхэлжээ. Сургуулийн гарах хаалгануудад эргүүл тавьжээ. 1998 онд эрх баригчид Жигмэд Пунцагийн сургуулийн суралцагчдын тоог 8 мянга гаруйгаас 150 хүртэл цөөрүүлэхийг тушааж, дараа нь 1400 хүн авахыг зөвшөөрсөн байна.

1999 оны гурав, дөрөвдүгээр сард шашны дээд сургуульд хяналт тавих, шашны номлол зөв буруу эсэхийг хянах, “салан тусгаарлах” үйл ажиллагааг илрүүлэх, “эх оронч хүмүүжил”олгох, 16 нас хүрээгүй хүмүүсийг,хамгийн хачирхалтай нь хятадууд энэ сургуульд оруулахыг хориглох тухай захирамж гарсан байна. Гэр гэртээ харихыг оюутнуудад шаардаж эхлэв. Энэхүү тушаалыг Зян Зэминь биечлэн өгсөн тухай ч мэдээлэх болсон байна. 2001онд ажилчдын янз бүрийн бригадын гишүүд иржээ. Оюутнуудыг явуулах эцсийн хугацааг тодорхойлж, бусдад нь хэрэв Далай ламыг буруушаавал

үлдээнэ хэмээн амалжээ. Дараа нь нийгмийг аюулаас хамгаалах Товчоо болон ХАЧА-ийн 2 мянга гаруй ажилтан ажилчны бригадуудын гишүүдтэй хамт ирж оюутнуудыг хөөж гаргав. Оюутнуудыг зодох, багш, оюутнууд болон тэдний гэр бүлийнхнийг гэсгээн цээрлүүлнэ хэмээн сүрдүүлэх замаар ийнхүү хөөж явуулжээ. Дөрөвдүгээр сард нэг мянга шахам түвдчүүд, арваннэгдүгээр сар гэхэд бас 3 мянган хүнийг байнга оршин суудаг газар руу явуулжээ. Олон оюутан дахиж тариачид болж, бас олон хүн гуйланч ядуучуудын эгнээнд орсон байна. Ажлын чадваргүй хүмүүсийн хувьд Сертхар нь амь зуулгаа залгуулах цорын ганц эх үүсвэр болж байжээ.

Зургаа-долдугаар сард олон сууц болон аж ахуйн байгууламж эвдэлж нураасан бөгөөд албан ёсны мэдээгээр 1875 байгууламж гэдэг боловч түвдчүүд 2 мянга гаруй хэмээн ярьдаг ажээ. 40–50-иад ачааны машинаар ачиж ирсэн ажилчид ийнхүү эвдлэн сүйтгэх ажлыг гүйцэтгэжээ. Нурааж буулгасан байгууламж бүрийн төлөө ажилчин хүн 130-350 юань авах ажээ. Нилээд хэдэн тохиолдолд ажилчид эд хогшил хулгайлахыг оролдсон байна. Дээд сургуулийн байнгын хорооны гишүүдэд тус сургуулийн өөрийнх нь тушаалаар ийнхүү нурааж байна гэсэн бичиг тараахыг шаардахад тэр гишүүд татгалзжээ. Түшмэл нар болж буй үйл явдлыг нуухын тулд аливаа хэлбэрээр гэрэл зураг авахыг хориглож, замуудыг хааж, цагдаагийн эргүүл харуул тавьжээ. Гэвч түвдчүүд нууцаар гэрэл зураг авч, дүрс бичлэг хийж, тэдгээрийг нийтэд үзүүлжээ. Жигмэд Пунцаг цэргийн эмнэлэгт хүргэгдэж, дараа нь Чэндуд гэрийн хорионд нэг жил сууж, Сертхарт эргэж ирээд 2004 оны нэгдүгээр сарын 6-нд Чэндугийн эмнэлэгт нас баржээ.[1859]

Сайтар шалгагдаагүй мэдээгээр бол Сертхарын есөн гэлэнмаа амиа хорлож, олон хүн эмнэлэгт хэвтжээ. 2002 оны сүүлчээр нилээд хэдэн хүнийг нурсан байгууламжийг сэргээх гэлээ хэмээн саатуулжээ.

Энэ жишээ ХКН-ын түвдийн бодлогын онцлог шинж чанаруудыг илтгэн харуулж байгаа бөгөөд энэ онцлогуудаас дурдвал: шашин бол шашингүйн үзэлт намын хяналт дор хөгжих ёстой; хэрэв суртал нэвтрүүлэг болон сүрдүүлэг тус болохгүй бол нухчин дарах ажил хийж эхлэх хэрэгтэй; гэсгээн цээрлүүлэх бүтэц бол заавал “ажилчны”, “ардын”, “олон нийтийн” байх ёстой; гэсгээн цээрлүүлэлтийг болж өгвөл хууль ёсны шинжтэй болгон харагдуулж, үүнийгээ бүх хэрэгслээр нуун далдлах хэрэгтэй: Түвдчүүд Далай ламтай аливаа хэлбэрээр хэлхээ холбоотой байх нь аюултай уршиг дагавартай байх болно; “өөртөө засах орны өөрсдийнх нь эздийн” оршин суух газрыг журамлан тогтоож, хан үндэстнүүд хяналтгүй шилжин суурьшихыг хөхүүлэн дэмжих хэрэгтэй; хан үндэстнүүдийг ХКН-д тааламжтай биш

үзэл санаанаас тусгаарлах хэрэгтэй зэрэг болно. Түвд уламжлалын дагуу нэг мянган хятад хүн лам болсон явдал бол хятадууд түвдийн бурханы шашныг хүндэтгэж, сонирхох явдал улам өсч буйг гэрчилсэн гайхалтай үзэгдэл мөн.

2007 онд түвдэд очсон оросын жуулчид тэндхийн Самье, Дарченд байсан Гуру римбучи буюу Бадамжунайн хоёр том баримал дүрийг эвдэлж нураасан тухай олж мэджээ.[1860] Энэ тухай мэдээлэл задруулахгүйн тулд хятад эрх баригчид тус хийдэд мөргөлчид, сүсэгтнүүд болон жуулчид оруулахыг хориглож, тэндхийн дэвсгэр нутгийг цагдаа нараар хамгаалуулсан байна. Сүсэгтнүүдийн асуултад хийдийн удирдлага албан ёсны зөвшөөрөл авч чадаагүй байгаа учир тэрхүү бурханг угсарч тавиагүй байна гэж хариулж байжээ.[1861] Мөн Дарчен, өөрөөр хэлбэл Кайлас уул орох замыг гадаадынхны тухайд гурван өдөр хааж: уг барималыг эвдлэн нураахад бэлтгэсэн бөгөөд түвдчүүдийн эсэргүүцэл гарна гэж бодож байжээ.

Шашны байгууламжуудыг эвдлэн нураагаад зогсоогүй түвдийн ард түмний үнэт зүйлсийг хятад руу зөөж авч явсан тохиолдлууд ч гарч байжээ. Будалын ордны үнэт зүйлсийг хятад руу олноор зөөж, тухайлбал, түвдийн засгийн газрын эртний эрдэнэсийн санг хоосолж буйг хараад үнэхээр балмагдсан байдалд орсон шүү гэж 1988 онд Агваан Жигмэд ярьжээ. ЮНЕСКО-гийн хамгаалалтад байсан Будалын ордон дахь VII Далай ламын шарилын хайрцаган дотор байсан Майдар бурханы алтадсан хүрэл барималыг Шанхай руу авч явсан тухай мэдээлэл 2001 онд гарчээ.[1862] 2000 онд Юмбулаган ордноос шашны эд зүйлс алга болжээ. Дараа нь тэдгээрийг олж авахад Хятадад үзэсгэлэнд тавихаар түвдийн хийдүүдээс авч явсан эртний эд зүйлс, ховор нандин цутгамал бурхадыг дуураймал хувилбаруудаар сольсон байжээ. Үүний төлөө харицлага засгийн газрын түшмэдэд оногдох ажээ.[1863]

Түвд ном сударын байдал Соёлын хувьсгалын үеийнхээс үлэмж сайжирчээ. Түүх, шашны хэд хэдэн чухал бичмэл дурсгалуудыг хэвлэн гаргав.[1864] "Будалын ордны үнэт бичвэрүүдийн каталог", "Цас мөсний хязгаар нутгийн ариун нандин бичвэрүүдийн сан"-г системчлэн хэвлэж гаргасан байна. 1990 оноос хойш хэд хэдэн чухал Түвд бичвэрүүдийг хянан тохиолдуулж, хэвлэн гаргажээ. Түүнээс гадна Хийдүүдэд зориулсан бөгөөд умардын бурханы шашны уламжлалт ёс жаягийг дүрслэн харуулсан номууд, гарамгай зүтгэлтнүүдийн намтар цадиг, тэдгээрийн бүтээлүүдийг бие даасан товхимолын хэлбэрээр хэвлэж гаргасан байна. Хятадын буддийн шашинтнуудын холбооны түвдийн салбар "Түвдийн бурханы шашин"

хэмээх тогтмол сэтгүүл хэвлэн гаргаж байна. Энэ салбарын дэргэд түвдийн бурханы шашны академи, Түвд судар ном хэвлэн гаргах Хүрээлэн бий. 1970 онд үндэслэн байгуулагдсан түвдийн ардын хэвлэлийн газар гол төлөв Түвд ном судар олон хувиар хэвлэн гаргаж байна. Энэ бол шинжлэх ухааны хялбаршуулсан материалууд, хуучны ном, түвдийн сонгодог бүтээлүүд, судар, Түвд эмнэлэг, цаг тооны бичиг, түүх, намтар цадиг, ардын аман зохиол, ардын урлагийн бүтээлүүд юм.[1865] Түүх, соёлын дурсгалын олон боть бүтээл гарч байна.

Түвдийн дэлгүүрүүдээс түвд, хятад хэлээр бичсэн шашны олон ном судар, шүтлэгийн эд зүйлс, шашны сэдэвтэй бэлэг дурсгалын зүйлс чөлөөтэй худалдан авч болно.

Сүм дуганууд, ариун дагшин уул ус, нууранд очиж мөргөл үйлдэх, шашны элдэв ёслол үйлдэхийг түвдчүүдэд зөвшөөрдөг болжээ. Өнгө бүрийн дарцаг, бурханы шашны судар номын ишлэлээс бичсэн том том маанийн чулуу, сунаж мөргөж, залбирч яваа, мөн эргэл мөргөл хийж яваа сүсэгтнүүдийг хаа л бол хаа харж болно.[1866] Энэ зорилгоор жил бүр Лхас хотод нэг сая гаруй Түвд хүн ирдэг байна. Бараг Түвд айл бүрт мөргөл үйлдэх газар байдаг юм.

Гэхдээ бас шашны хязгаарлалтууд ч бий. Тухайлбал, Ньемод 1999 оны эхээр хятадын эрх баригчид Түвд айл бүрт зул, мөргөлийн гонхонтой байхыг хориглож, суврага тойрох, гонхондоо зул барих зэрэг шашны ёслол үйлдэхийг түвдийн бүх тариачин, нүүдэлч малчдад хоригложээ.[1867] Улсын эмнэлэг, сургуулийн эмч, багш нар, өндөр насны тэтгэвэрт гарсан төрийн албан хаагчдын гэрт шашны ёслол үйлдэх гонхонтой байхыг хориглосон байна. Айлуудаар шалгалт хийж, оршин суугчдад Далай ламын зураг өлгөхийг хоригложээ. Маогийн үеийн уламжлалыг үргэлжлүүлэн орон сууцны байшингууд болон бусад газарт хятад улсын далбаа өлгөж байхыг үүрэг болгожээ.

Түвдийн бурханы шашны хоёр том мяндагтан – XVI Кармапа, X Банчин лам таалал төгссөн явдал нилээд ноцтой асуудал болжээ. Кармапа гэдэг бол түвдийн бурханы шашны дөрвөн үндсэн чиглэлийн нэг болох хамгийн нөлөө бүхий Гарма Кагьюгийн тэргүүний цол юм. Кармапаг (1924–1981) цагаачлалд байхдаа насан өөд болсны дараа Түвдийн зүүн нутгаас түүний хойд дүрийг олжээ. Энэ бол 1985 оны долдугаар сарын 17-нд төрсөн Пэрэнлэйдорж юм. Эхлээд түүнийг ямар нэгэн том ламын хойд дүр гэж тодорхойлсон байна. Хожим нь үе залгамжлан засаг баригчдын нэг Тай Ситу римбучи өмнөх Кармапагийн захидлыг олж авсан бөгөөд түүнийхээ

үндсэн дээр тэр жаал хүүг XVII Кармапа мөн гэж тодорхойлжээ.

Түүний тодорхойлолтыг Далай лам нотолсон байна. 1992 оны есдүгээр сард Цурпху хийдэд XVII Кармапаг сэнтийд залах ёслол болов. ТӨЗО-нд Кармапагийн эрх чөлөө тун их хязгаарлагдмал байсан: түүнийг XIV Далай ламаас хөндийрч, Хятад улс бол “шашны эрх чөлөөний түшиг тулгуур” хэмээн мэдэгд гэж байнга шахалт үзүүлдэг байжээ.[1868] Шашны сургалтын боломж хязгаарлагдмал байв. Кармапа 1999 оны арванхоёрдугаар сарын сүүлчээр Түвдээс Балбаар дамжин Энэтхэгт оргож очсон байна. Үүний өмнө тэрээр удаан хугацаагаар гэрээс гарахгүй бясалгал хийж сууна гэж хятадын хамгаалалтын албаныханд мэдэгдсэн байна. Энэ явдал хятадуудын сонор сэрэмжийг тодорхой хэмжээгээр сулруулсан бизээ. Гэтэл залуу Кармапа Энэтхэгт очингуутаа тэндхийн тусгай албадын сэжиглэлд орж, Кармапа хятадуудын дэмжлэг ивээлгүйгээр ийм зоригтой алхам хийж чадах байсан гэдэгт энэтхэгийн тусгай албаныхан итгэж чадахгүй байжээ. Оргож очсоноосоо хойш анх удаа 2008 онд л тэрээр хилийн чанадад гарч болно гэсэн Энэтхэгийн эрх баригчдын зөвшөөрөл авсан байна. XVII Кармапа Пэрэнлэйдорж бол БНХАУ-ын эрх баригчдаар ч, Далай ламаар ч хүлээн зөвшөөрөгдсөн түвдийн бурханы шашны нэг чиглэлийн цорын ганц тэргүүн юм.[1869]

X Банчин лам (1938–1989) “энх тайван чөлөөлөлтөөс” хойшхи бүх хугацаанд Түвд, Хятадаас гараагүй ажээ. Энэ хүн эрх баригчидтай үр бүтээлтэй яриа хэлэлцээ хийхийг ямагт дэмжигч байсан юм. Хятадын албан ёсны байр суурь дараах байдлаар тодорхойлогджээ: “Банчин Эрдэнэ Чойжижалцан түвдийн шашны нийгэмлэгийн гарамгай удирдагч, Хятадын аугаа их эх оронч, төрийн нэрт зүтгэлтэн болохоо харуулж... салан тусгаарлах аливаа үйлдлийг гуйвалтгүй, эрс тууштай эсэргүүцэгч байсан бөгөөд тэрээр Эх орныхоо эв нэгдлийг хамгаалж, үндэсний нэгдэл нягтралаа бэхжүүлэхэд мөхөшгүй хувь нэмэр оруулсан билээ. Эх орныхоо эв нэгдэл, үндэсний нягтрал, ард түмний сайн сайхан байдад, Түвдийн хөгжил, бурханы шашны итгэл үнэмшлийн цэцэглэлт, даян дэлхийн энх тайвны дэвшил хөгжлийг хангах явдал миний жинхэнэ хүсэл эрмэлзэл мөн гэж тэрээр амьд ахуйдаа удаа дараа хэлж байсан билээ”.[1870] Түүний зэрэгцээ өмнөх хүмүүсээс X Банчин ламд шилжиж ирсэн цол хэргэмүүдийн дотор энэ төрөлдөө олж авсан “Самуун цагийн аврагч” хэмээх цол байна. Энд “самуун цаг” гэдэг нь Түвд дэхь БНХАУ-ын эзэгнэлээс эхэлсэн үеийг хэлжээ.

1989 оны нэгдүгээр сарын 13-нд X Банчин лам V–IX Банчин ламуудын суврагыг байрлуулсан дурсгалын павильоныг аравнайлах ёслолд ороцохоор


X Банчин лам

Лхасаас Шигазед очжээ. Тэрээр нэгдүгээр сарын 22-нд павильон нээх ёслолын ажиллагааг тэргүүлж, ном айлджээ.[1871] Дараа нь хэд хэдэн мөргөлд оролцсон байна. Банчин лам нэгдүгээр сарын 24-нд ТӨЗО, Хөх нуур, Ганьсу, Сычуань, Юньнаны санваартнуудын төлөөлөгчид оролцсон ярилцлагыг даргалахдаа бурханы шашны дээд удирдагчид шинэ төрөл олох асуудлыг авч үзэж ярихдаа: "юуны өмнө нэр дэвших гурван жаал хүү олох хэрэгтэй, дараа нь хүүхэд бүрийг судлах нь зүйтэй.<...> Би Шагмуни бурхны дүрийн өмнө байрлуулсан Алтан бумбанаас шодож эцсийн сонголтыг хийх хэрэгтэй гэж би үзэж байна."[1872] гэж хэлжээ. БНХАУ-ын эрх баригчид энэ үгийг түүний гэрээс хэмээн үздэг юм. Гэхдээ эрх баричид тэр өдөр Банчин лам Түвд дэхь хятад захиргааг эрс шүүмжилсэн явдал сонссон хүмүүсийн сэтгэлийг ихэд хөдөлгөсөн тэрхүү баримтыг дурсахгүй байна. Банчин лам Түвдийн бодлогыг боловсруулахад Далай ламтай хамтран ажиллах боломж олгохыг уриалаад чөлөөлөлтөөс хойш хөгжиж байгаа ч түүний үнэ ашиг тус гаргахаас ч илүү их байсан юм гэж мэдэгджээ.

1989 оны нэгдүгээр сарын 28-нд X Банчин лам таалал төгсчээ. Албан ёсны мэдээгээр бол зүрхний шигдээс өвчнөөр таалал төгссөн байна.[1873] Банчин лам гэнэт өвчилсөн тухай мэдээ авмагцаа БНХАУ-ын засгийн газар Шигазе руу бүрэн эрхт төлөөлөгч болон эмч яаралтай явуулахдаа Банчин ламыг дагалдах эмчид туслахыг тэр төлөөлөгчид үүрэнг болгосон боловч үр дүнд хүрч чадаагүй юм гэж хятадын эрх баригчид мэдээлж байжээ.

Түүний таалал төгсөний дараах гуравдахь өдөр БНХАУ-ын төрийн зөвлөл ерөнхий сайд Ли Пэний гарын үсэгтэй "X Банчин ламыг оршуулах, түүний хойд дүрийг тодруулах тухай тогтоол" гаргажээ. Энэ тогтоолд: "Дашилумпо хийдийн ардчилсан удирдлагын зөвлөл, лам нарын хүсэлтийг хүлээн авч, түүнчилэн түүхэн уламжлалыг харгалзан үзэж БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс тогтоох нь: 1. Шигазе хотын Дашилумпо хийдэд Банчин эрдэнэ Чойжижалцаны чандар бүхий Ариун суварга, Эх орныхоо болон

итгэл үнэмшлийнхээ төлөө түүний явуулсан үйл ажиллагааг мөнхжүүлэх зорилгоор дурсгалын павильон босгосугай. Ариун суварга, дурсгалын павильон байгуулах ажлыг Түвдийн өөртөө засах орны ардын засгийн газар, Дашилумпо хийдийн ардчилсан удирдлагын зөвлөлд даалгасугай. Барилга байгуулалтын ажлын зардлыг улсаас гаргасугай. 2 X Банчин ламыг хүндэтгэн дурсах, түүний биеийг занданшуулахтай холбогдсон арга хэмжээг түвдийн бурханы шашны ёс заншлын дагуу гүйцэтгэхийг Дашилумпо хийдийн ардчилсан удирдлагын зөвлөлд даалгасугай. Шаардлагатай хөрөнгө мөнгийг улсаас гаргана. 3. Банчин Эрдэнийн хойд дүрээр тодрох жаал хүүг эрж олох, тодруулахтай холбогдсон ажлыг Дашилумпо хийдийн ардчилсан удирдлагын зөвлөлд хариуцуулж байгаа бөгөөд тус зөвлөл шаардлагатай гэж үзвэл Хятадын бурханы шашинтнуудын нийгэмлэг, түүний түвдийн салбарын тусламжийг авах ёстой. X Банчин ламын хойд дүрээр тодорсон хүүхдийг БНХАУ-ын Төрийн зөвлөлд танилцуулж батлуулах ёстой" гэж өгүүлсэн байна.

БНХАУ-ын засгийн газар дараачийн Банчин ламыг тодруулах ажиллагаанд зориулж төсвийн тусгай зүйл ангиар 77 сая 410 мянган юань төсөвлөн гаргажээ. Энэ бол их мөнгө гэдгийг тэмдэглэх хэрэгтэй юм.[1874] X Банчин ламын биеийг зохих ёс журмын дагуу занданшуулж тусгайлан байгуулсан павильоны суварган дотор байрлуулжээ.

Бээжингийн албан ёсны эрх баригчид ёс жаягийн талыг хэлбэрэлтгүй баримталснаа онцгойлон тэмдэглэдэг юм. Гэхдээ энд нилээд их шинэлэг зүйл орсон нь хойд дүрийг эрж олох, тодруулахтай холбогдсон ажлыг Дашлхүмбэ хийдийн ардчилсан удирдлагын хороонд даалгаж, нэр дэвшсэн хүүхдүүдээс шодож тодруулах асуудлыг БНХАУ-ын Төрийн зөвлөлд шилжүүлж, хятадын бурханы шашинтнуудын холбооны дарга Жао Пучу, энэ нийгэмлэгийн түвдийн салбарын хүндэт дарга Пагва Гэлэг Намжил тэргүүтэй шинжээчдийн хэсэг байгуулсан байна.[1875] Хойд дүрийг эрж олох ажиллагаа ёс жаягийн дагуу: мөргөл үйлдэх, ном судар унших, нуурын ус ажиглаж таах, тохирох насны онцгой ухаантай жаал хүүтэй айлуудад нууцаар очих, олон эд зүйлс дотор байгаа А Банчин ламын эдэлж байсан тэр зүйлийг нэр дэвшсэн жаал хүүхдүүдээр таниулах зэргээр явагджээ.

Далай лам бол Банчин ламтай оюун санааны үл тасрах холбоотой байдаг юм. Өмнөх төрлүүдэд энэ хоёр хүний насаар ахмад нь багш, дүүмэд нь шавь гэгддэг байжээ. Тийм учир XIV Далай лам хойд дүр эрж тодруулах үйл хэрэгт дэмжлэг үзүүлэх санал тавьсан боловч БНХАУ-ын эрх баригчид татгалзсан хариу өгчээ. Энэтхэгт зохих ёс жаяг үйлдэж, Далай ламын

төлөөлөгчид Түвдийн лам нар, түүний дотор Дашлхүмбэ хийдийнхэнтэй холбоо тогтоожээ.

Тийнхүү Түвдийн Лхарийн районоос XI Банчин лам болох жаал хүүг тодруулсан байна.[1876] Энэ бол 1989 оны дөрөвдүгээр сарын 25-нд төрсөн Гэндэн Цогням гэдэг жаал хүү ажээ. Тэр хүү хэлд ормогцоо л: "Би бол Банчин, миний хийд бол Дашлхүмбэ, би өндөр сэнтийд сууж байна" гэж хэлжээ.

БНХАУ-ын засгийн газрын байгуулсан Банчин ламын хойд дүр эрж тодруулах асуудал эрхэлсэн хорооны тэргүүн Чадрал ринбүүчи (Дашлхүмбэ хийдийн тэргүүн хамба, тус хийдийн ардчилсан удирдлагын хорооны тэргүүн, ТӨЗО-ны ардын улс төргийн зөвлөлдөх зөвлөлийн гишүүн) олж тодруулсан хүүгийн нэрийг хятадуудад өгөхөөсөө өмнө Далай ламаар батлуулахаар нууцаар явуулжээ. Далай лам түүнийг шалгах шаардлагатай бясалгалууд хийсний дараа тавдугаар сарын 14-нд тодруулсан дүр зөв болохыг зарлажээ. Далай лам түүнд Дэнзэн Цэдэн Иш Тинлей Пунцаг хэмээх сахилын нэр өгсөн байна. Тавдугаар сарын 17-нд тэр хүү эцэг, эхийнхээ хамт үл мэдэгдэх чиглэлд алга болжээ. Хоёр жилийн дараа 1996 оны тавдугаар сарын 28-нд эрх баригчид түүнийг эцэг эхийнх нь хүсэлтээр БНХАУ-ын засгийн газрын хамгаалалт авсан, яагаад гэвэл түүнийг салан тусгаарлагчид хулгайлах аюултай байгаа юм гэж мэдээлжээ. Тэр үеэс хойш жаал хүү болон түүний эцэг, эх гадаад ертөнцтэй чөлөөтэй харилцах боломжгүй болсон байна. Жаал хүү хорионд биш, бие нь маш сайн, сургуульд сурч байгаа, түүний эцэг, эхийн сэтгэл хангалуун, маш аз жаргалтай аж төрж суугаа гэсэн Рагдигийн 2002 оны арван нэгдүгээр сарын 12-ны мэдэгдлээс өөр түүний тухай ямар ч мэдээлэл үгүй ажээ.[1877] Гэндэн Цог Нямын хүүхэд байхдаа татуулсан гэрэл зургууд л байдаг, гэхдээ эдгээр гэрэл зургийг Түвдэд хориглосон бөгөөд түвдчүүдийн олонхи тэдгээр гэрэл зургийг хэзээ ч олж үзээгүй ажээ.

1997 оны тавдугаар сарын 17 буюу 18-нд Чадрал римбүүчийг шинэ Банчин ламын хойд дүрийг эрж, тодруулах зорилгоор Далай ламтай хэлхээ холбоо тогтоосон байж болзошгүй гэсэн сэжигээр гэрийн хориондсуулгажээ.[1878] Дөрөвдүгээр сарын 21-нд түүнд зургаан жил шоронд хорих ял оноож, гарч ирснийх нь дараа "эх орноо хагаралд оруулах зорилготой" хуйвалдаанд оролцсон, "төрийн нууц задруулсан" хэргээр гурван жил улс төрийнх нь эрхийг хасахаар болжээ. Сычуаны зүүн хэсгийн шоронгийн онцгой нууц салбарт түүнийг хорисон хэмээх мэдээ байдаг юм. Тавдугаар сарын 17-нд эрэлтийн хорооны нарийн бичгийн даргыг баривчилж "төрийн

нууц задруулсан хэргээр” дөрвөн жил шоронд хорих, бизнес эрхлэгч нэг хүнд хоёр жил шоронд хорих ял оноосон байна.

Бээжингийн албан ёсны эрх баригчид XI Банчин ламын хойд дүрийг Далай лам батлах нь хууль бус зүйл гэж үзсэн хэвээр байна. Үүнийг нотлох хэд хэдэн баримт гаргаж ирж байгаа юм.[1879] Эдгээрийн нэг бол нэр дэвшигчдийн жагсаалтыг төв засгийн газарт оруулж танилцуулах ёстой, Алтан бумбанаас шодолт хийх ёслолын ажиллагааг засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч даргалах ёстой, сонгогдсон нэр дэвшигчийг засгийн газар эцсийн хувилбараар баталсны дараа залгамжлагчийг сэнтийд залах ёслол болох ёстой бөгөөд түүнийг засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч тэргүүлж явуулна хэмээсэн байна.

Гэхдээ Банчин лам бүрийг алтан бумбанаас шодож сонгож байгаагүй ажээ. Жишээ нь, XIX зууны эхээр XIV Кармапаг Алтан бумбанаас шодолгүйгээр, XX зуунд XVII Кармапаг БНХАУ-д мөн тэгж шодолгүйгээр тодруулж байжээ.[1880] Цаашилбал БНХАУ-ын засгийн газрын шийдвэрлэгч үүрэг гэгч нь манжийн эзэн хааны уламжлалыг хууль бусаар шилжүүлэн хэрэглэсэн явдал юм байна. Манжийн эзэн хаад зөвхөн Хятад биш Чин гүрнийг толгойлж, марксизм биш, харин буддийн шашин мөрддөг байсан бөгөөд тэдний зүгээс Банчин ламуудыг тодруулах ёслолыг удирдах ямар нэгэн удирдлагын тухай огт яригддаггүй байжээ.

Цааш нь коммунистуудын бүрдүүлсэн бүлэг Далай ламын бүрдүүлэх бүлгээс илүү хууль ёсны байх ямар ч боломжгүй билээ. Ингэхлээр Дашлхүмбэ хийдийн нэг төлөөлөгч оролцсон Далай ламын төлөөлөгчид “сайн дураараа” нуурын мандал дээгүүр ажиглалт хийх нь коммунистуудын хяналтан дор хийх тийм ажиглалтаас хамаагүй илүү ёс журамаа сахисан үйлдэл болох юм. Санал хураалтад оруулах нэрсийн жагсаалтад “шинэ” нэр дэвшигчийг оруулахад нэмэлт шалгалт хийх хэрэгтэй байсан боловч Далай лам “зам хөндлөн хэвтсэн юм” гэж бээжингийнхэн мэдэгджээ. Магадгүй коммунистууд энэ шалгалтыг Далай ламаас илүү хийх байсан юм болов уу? Хэрэв тэд шудрага шодолт хийхээр төлөвлөж байсан юм бол шинэ нэр дэвшигчийг жагсаалтад оруулахад нь юу саад болсон юм бол? Далай лам шинэ дүрийг баталсан болохоор л бээжингийн эрх баригчид зориуд санаатай будлиан тарьж байна хэмээх дүгнэлт хийхэд хүрч байна. Далай ламын төлөөлөгч гурилан үрлээр таасан үйлдлийг хууль бус гэж зарласан нь тэрхүү таах ажиллагаанд эрх баригч бүлгийнхний төлөөлөгч оролцоогүйгээс болсон хэрэг бизээ.

IX Банчин ламаас эхлээд энэ хүн болон Далай ламын хоорондох багш,

шавийн харилцаа хэрэг дээр зогссон, учир нь Банчин лам болон түүний хүрээллийнхэн Далай лам болон түүний хүмүүс "хавчлагад өртсөн юм" хэмээх бээжингийнхний албан ёсны байр суурь байдаг юм. XIII Далай лам, IX Банчин лам нарын хооронд санал зөрөлдөөн гарсны улмаас Банчин лам удаан хугацаагаар Хятадад суусныг энд харгалзан үзсэн хэрэг бизээ. Гэтэл энэ хоёр их хүн аль эрт ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн бөгөөд тэдний хоорондын харилцааны тухай асуудлыг дахин авч үзэх нь утгагүй хэрэг юм. X Банчин лам, XIV Далай ламын тухайд бол тэд хэвийн харилцаатай байсан юм. X Банчин лам XIV Далай ламыг дэмжсэнийхээ төлөө хятадуудад баривчлагдсан нь үүний нэг гэрч нотолгоо мөн бизээ. Банчин лам 1955 онд Вс.Овчинниковтой ярилцахдаа Далай лам бид хоёрын дотоод сэтгэлийн харилхуу байдал үгүй болсон гэж тэмдэглэсэн байдаг.[1881] Хожим нь Банчин лам Лхас хотод 1985 онд Монламын баярын үеэр үг хэлэхдээ, би Далай ламтай сахил санваарын нөхөрлөлөөр холбогдсон, бидний хооронд хөндийрхөх зүйл байхгүй гэж мэдэгджээ.[1882] Үүнийг ч Далай лам Банчингаас захидал авч байсан тухайгаа ярихдаа хэд хэдэн удаа батлаж хэлсэн байдаг.

Цааш нь хятадууд X Банчин ламыг нас барахаас өмнө жаал хүү төрснийг нотолдог юм.[1883] Гэтэл түвдчүүдийн мэдээлснээр бол тэрээр өмнөх төрлийнхөө хүнийг таалал төгссөнөөс гурван сарын дараа төржээ. Энэ ч эрүүл ухааны үүднээс бол зөрчилтэй зүйл хэмээн хэлж болох юм. Яагаад гэвэл буддын төсөөллөөр бол дараах төрлийн хүн үрийн шингэн ялгарах үед олдох учиртай бөгөөд ингэхлээр Банчин ламын хойд дүр түүнийг таалал төгсөнөөс хойш гурван сарын дараа биш, харин ч наад зах нь гэхэд есөн сарын дараа эхээс төрөх учиртай юм. Гэтэл X Банчин лам таалал төгсөхөөсөө 2–3 хоногийн өмнө дээрх болзлыг заавал баримтлах албагүйг мэдэгдээд VI Далай ламыг насан өөд болохоос нэг жилийн өмнө мэндэлсэн VII Далай багшийг жишээ татаж хэлсэн нь тохиолдлын хэрэг биш байсан болов уу: *чөлөөлөгдөж* гарч ирсэн биет нэгэн зэрэг олон дүр төрхөөр илрэн гарах чадвартай байдаг ажээ.

Хятад улс XIV Далай ламын хүлээн зөвшөөрсөн хойд дүрийг няцаасан байна. Шинэ Дели хотод сууж байсан хятадын элчин сайдын яам энэ талаар Далай ламын хийсэн мэдэгдлийг засгийнхаа газарт мэдээлэхээс татгалзжээ. 1995 оны тавдугаар сарын 16-нд БНХАУ-ын гадаад явдлын яамны төлөөлөгч "хойд дүр тодруулж сонгох шашны ёслолыг улс төрийн зорилгод ашигласан" хэмээн буруушааж, дараа өдөр нь БНХАУ-ын шашны хэрэг эрхлэх зөвлөлийн албан ёсны төлөөлөгч Далай ламын хийсэн сонголт хууль бус болсныг мэдэгджээ. БНХАУ-ын эрх баригчид ийнхүү дургүйцэх

болсны шалтгаан Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Бүх хятадын хорооны дарга Ли Жуйхуаны хэлсэн үгнээс тод харагдаж байна: “Ямар нэгэн бие хүн буюу шашныхыг оролцуулан нийгмийн бүлэг аливаа хэлбэрээр төрийн хууль зөрчиж, ард түмний эрх ашигт хохирол учруулж, үндэсний нягтрал, төр улсын эв нэгдлийг бусниулах ёсгүй. Аливаа үйлдэл, үйл ажиллагааны хамгийн суурь үндсэн шалгуур ийм л байх ёстой”.[1884] Энд заасан шалгуур шашинд огт хамаагүй юм.

1995 оны арваннэгдүгээр сарын 8–11-нд эрлийн бүлгийн шийдвэрлэх гуравдугаар хуралдаан болжээ. Ли Жуйхуань хуралдаан дээр үг хэлэхдээ, шинэ дүрийг эрж олох ажил “ХКН-ын шашны ажлын улс төрийн зааврын дагуу”, мөн шашны ёс жаягаар хийгдлээ.Харин Далай лам энэ ажлын нэр хүндийг гутаах гэж эрмэлзэж байна хэмээн мэдэгдэв. Ли хэлсэн үгэндээ сонголтын дараах шалгууруудыг онцлон тэмдэглэсэн байна: 1. Эрлийн бүлгийг гол төлөв Дашлхүмбэ хийдийн түрүүчийн томоохон зүтгэлтнүүдийн хойд дүрүүд болон цол хэргэмтэй лам нараас бүрдүүлэв. 2. Эрлийн ажлыг шашны ёс, журамын дагуу явуулж байна. 3. Алтан бумбанаас шодох ёслолд оруулах нэр дэвшигчдийн жалсаалтыг БНХАУ-ын засгийн газарт батлуулахаар оруулж байна. 4. Алтан бумбанаас шодох ёслолыг БНХАУ-ын засгийн газрын тусгай бүрэн эрхт төлөөлөгч тэргүүлж байна. 5. Шодолтоор тодорсон хүнийг БНХАУ-ын засгийн газар эцэслэн батлах ёстой. 6. X Банчин ламыг залгамжлах жаал хүүг ариун сэнтийд залах ёслолын ажиллагааг БНХАУ-ын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн удирдлагын дор зохион явуулна. Шагжмун бурхны санаа бодол, нэр дэвшигчийг батлахад энэ засгийн газар голлох үүрэг гүйцэтгэж буйг илэрхийсэн Алтан бумбаны шодолт бол хамгийн чухал үйлдэл мөн. Тиймээс “хойд дүр тодруулах үйлийг аль болох түргэн дуусгахын тулд ажлаа шамдуулах хэрэгтэй байна”.[1885]

Ийм шахалтан дор сонгож авсан лам нарт Далай ламын санал болгосон нэр дэвшигчийг няцааж, Алтан бумбанаас шодох өөр гурван хүүгийн нэр дэвшүүлэхийг албадан тулгажээ. Үүний хариуд Түвдийн Лхас, Шигазе, Чамдо зэрэг томоохон хотод хөл хорих цаг тогтоосон хэдий ч түвдийн ард түмний сүсэг бишрэлийг дахин бүдүүлгээр доромжилсныг эсэргүүцсэн жагсаал аяндаа гарсан байна.

1995 оны арваннэгдүгээр сарын 29-нд XI Банчин ламыг Алтан бумбанаас шодож сонгох, түүнийг хятадын эрх баригчид батлах ёслолын ажиллагаа болов.[1886] Намын найдвартай гэр бүлээс гаралтай Жалцанноров хэмээх хүү сонгогджээ.[1887] БНХАУ-ын төрийн зөвлөлийн гишүүн Ли Теин

төрийн эрх барих энэ байгууллагаас Жалцанноровыг XI Банчин ламаар батлах тухай Алтан батламж бичгийг уншиж сонсгов. Ли Теин хятад, Түвд хэлээр бичсэн бичээс бүхий алтан тамгыг түүнд гардуулсан байна.[1888] Ёслолын ажиллагаанд хэд хэдэн том ламыг албадан оролцуулжээ. Соёлын хувьсгалын үед Зонховын чандарын зарим хэсгийг авч үлдэж чадсан тэр хүн болох Боми ринбүүчи тэдний нэг байв. Түүнд өөр сонголт байгаагүй: ингэснээр Түвдэд буддийн шашныг хадгалж үлдэх боломж олдоно хэмээн тэрээр найдсан юм гэж түвдчүүд ярьдаг ажээ.[1889] Тэрээр Далай ламыг хэзээ ч "салан тусгаарлах үзэл" энээ тэрээгээр буруутгаж байгаагүй юм.

Энэ зуурт гэсгээн цээрлүүлэх байгууллагууд бээжингийн албан ёсны эрх баригчдын яриагүй зүйлийг хийжээ. Энэ бол бээжингийнхний эмхлэн байгуулсан бөгөөд эрх баригчдын заавраар явахыг хүсээгүй эрлийн бүлгийн гишүүдийн эсрэг үйлдсэн гэсгээн цээрлүүлэлт байлаа. Энэ бүлгийн найман гишүүний дөрөвт хөөх буюу баривчлах шийтгэл оноож, 1999 он гэхэд XI Банчин ламын тухай асуудалтай холбогдуулан 80 гаруй хүн баривчилжээ.[1890] Ингэхлээр энэ бүлгийн дарга төдийгүй түүний гишүүдийн тэн хагасаас доошгүй хувь нь л Далай ламын зүгээс нэр дэвшигчийг дэмжиж байжээ. X Банчин ламын гарын зарц нөхцөл байдлыг тэсч чадалгүй зүрхний дутагдал өвчнөөр нас барав. X Банчин ламын хүүхэд ахуй цагаа өнгөрүүлсэн Гүмбүн хийдийн хамба лам Агья римбүүчи хятадын талаас санал болгосон нэр дэвшигчийг дэмжихгүй гэсэндээ АНУ-руу оргожээ.[1891] Чадрел римбүүчийн хоригдох хугацаа дууссан ч түүний байгаа газар одоо болтол тодорхой бус байна.

Шашны уламжлалыг зөрчиж ёслол үйлдсэн нэр хэмээх нь шашныг гутаан долромжилсон хэрэг мөн. Ёс уламжлалыг эрх баригчдад ашигтай байх тийм л хэлбэрээр баримталсан төдий болоод өнгөрчээ. Ингэхлээр XI Банчин лам гэж эрх баригчдын гаргаж ирсэн тэр залуу хүү тийм хүн биш болж таарч байгаа юм. Тэрээр одоо Бээжинд боловсрол эзэмшиж байгаа бөгөөд Түвдэд хааяа ирэхдээ БНХАУ-ын удирдлагыг дэмждэгээ мэдэгддэг ажээ. Шигазед Жалцанноровын хөргийг X Банчин ламынхтай зэрэгцүүлэн тавьж, хятадын эрх баригчид түүнд түвдчүүд хүндэтгэн ханддаг тухай мэдэгдэж байгаа ч гол төлөв Бээжинд суудаг энэ хүн Түвдэд түүнд тун янз бүрээр ханддагийг олж мэджээ. Хэрэв Шигазед мөргөлчдийн зан байдлыг ажиглавал тэд шинэ дүрийг хүндэтгэхгүй байгаа нь харагддаг юм.[1892] Эрх баригчид түүний хөрөгийг худалдаж авахыг хүн амд тулган хүлээлгэж байна.[1893] Түүнээс гадна 1996 оны нэгдүгээр сард Жалцанноровын гэрэл зурагийг шатаасан хэргээр есөн лам баривчилж, зургадугаар сард Гэндэн

Цогнямын урт наслахын төлөө залбиралын үгийг олшруулан тараасан гэж Гьянзегийн бага сургуулийн багшийг баривчилсан байна.[1894]

Тийнхүү XIV Далай ламын хүлээн зөвшөөрсөн Гэндэн Цогням жинхэнэ XI Банчин лам болж байгаа юм. Дарамсалад болсон бага хурал дээр түвдийн шашны бүх дөрвөн чиглэлийн дээд лам нар түүнийг хүлээн зөвшөөрчээ.[1895] Гэвч түүнийг хятадын эрх баригчид тусгаарлажээ.

Саяхан коммунистууд том лам нарын хойд дүр тодруулах ажлыг будлиантай болгох журамыг хууль ёсны болгосон байна. БНХАУ-ын шашны хэрэг эрхлэх газраас гаргасан түвдийн буддийн шашин дахь том лам нарын хойд дүр тодруулах ажиллагааг удирдах тухай 5 тоот тушаал 2007 оны есдүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болжээ.[1896] Энэ тушаал буддийн шашны ёс жаяг төдийгүй шүтэж бишрэх эрх чөлөөг зөрчжээ. Жишээ нь, уг тушаалын 2-р зүйлд: “Амьд бурхадыг тодруулах ажиллагаа дараах буюу: үндэстний эв нэгдэл, угсаатны бүлгүүдийн эв санааны нэгдлийг хадгалахад тус дөхөм болох, шашин ба нийгэм үв тэгш оршин тогтох нөхцлийг хамгаалах зарчмуудад нийцсэн байх ёстой. Гэхдээ нэгэнт үгүй болсон феодалын эрх дархыг сэргээх хэрэггүй юм. Амьд бурхадын хойд дүр тодруулах хэрэгт гадаадын байгууллагууд болон хувь хүн хөндлөнгөөс оролцож, удирдах гэх ёсгүй” гэж өгүүлжээ. Цааш нь төр засгийн байгууллагууд том лам нарын хойд дүрийг тодруулж батлах журмыг заасан байна. Тухайлбал, зүйл 4 (2)-т “Тухайн районы хамааргддаг тэр хотын ардын засгийн газар, түүнээс нилээд өндөр түвшинд хойд дүр тодруулах ажиллагааг зөвшөөрөхгүй гэж нийтэд зарласан бол “дүр тодруулах мэдэгдэл өгөхийг” зөвшөөрөхгүй”. Зүйл 5: “Амьд бурхадын хойд дүр тодруулах ажиллагааг мэдүүлэг гаргаж, түүнийг сайшаасан нөхцөлд явуулна”. Мэдүүлгийг гацааны орон нутгийн ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэст, дараа нь муж буюу өөртөө засах орны зэрэг илүү өндөр түвшинд, харин нилээд том дээд лам нарын тухайд бол БНХАУ-ын Төрийн зөвлөлийн түвшинд гаргана.

Намын түшмэд сайшаасны дараа л тухайн хийд хойд дүрийг эрэх бүлэг байгуулах эрх эдлэнэ (зүйл 7). Дараа нь Алтан бумбанаас шодолт хийх буюу нэр дэвшигчийг тухайн шатны шашны хэрэг эрхлэх хэлтэст батлуулна (зүйл 8).

Батлуулсны дараа тэрхүү хэлтсээс зөвшөөрөл авч, үүний дараа шашны хэрэг эрхлэх Улсын комисст бүртгүүлнэ (зүйл 9). Эдгээр дүрмийг зөрчвөл засаг захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ (зүйл 11). Хойд дүрийг тодруулсны дараа хүмүүжлийн төлөвлөгөө болон сонгож авсан залгамжлагчийн тухай баримт мэдээллийг мэдүүлгийн хэлбэрээр орон

нутгийн ардын засгийн газарт батлуулахаар оруулна (зүйл 12). Орон нутгийн түвшинд илүү нарийвчилсан дүрэм боловсруулж болно (зүйл 13).

Шашны ёс жаягийг бүдүүлгээр зөрчсөн эдгээр хүнд сурталт ажиллагааны зорилго бол Далай ламыг таалал төгссөний дараа буюу бусад бүх том лам нарын хойд дүрийг эрж олж тодруулах ажиллагаанд коммунист намын хяналт тавих явдал мөн. Түвд буюу БНХАУ-д нэгтгэсэн бусад мужид шашин шүтлэгийн эрх чөлөө тогтохгүй бол би эдгээр нутагт дахин төрөхгүй гэж Далай лам өөрөө хэд хэдэн удаа мэдэгджээ.

Буддын гол чиглэлүүдийн тэргүүнүүд ба Түвдийн цагаач засгийн газрын шашин ба соёлыг хариуцсан департамент албан ёсоор энэ дүрмийг няцаасан байна.[1896а.]

Гэвч Түвдэд шашныг нухчин дарж байгаа явдал санамсаргүй үр дүнд хүргэжээ. Түвдийн бараг бүх дээд санваартнууд оролцсон түвдийн дүрвэгчдийн ачаар буддийн болон бон шашин дэлхийн олон оронд дэлгэрч эхэлсэн байна. Хязгаарлагдмал нийгэмд аж төрж ирсэн түвдчүүд харин ч шинэ нөхцөл байдалд сайн дасч чаджээ. Магадгүй энэ нь түвдчүүдийн үндэсний онцлог байдалтай холбоотой бөгөөд цагаач түвдчүүдийн хувьд орчин үеийн эрээнтэй бараантай орчинд нүүдэлчин лам буюу нүүдэлчин малчнаас дэлхий нийтэд танигдсан нүүдэлчин лам, худалдаачин, сэргээн засварлагч, зураач болж хувирах нь тийм ч их хэцүү биш байсан бололтой юм.[1897]

Хэрэв өрнөдөд буддийн шашны тухай гол төлөв дорно дахиныг судлаачид л мэддэг байсан бол 1960-аад оноос хойш олон лам Европ, Америк, Азийн орнуудад гарчээ. Энэ явдал буддийн шашныг улам их сонирхох болсонтой давхацжээ. Үүний дүнд урьд өмнө огт мэдэхгүй байсан үзэл баримтлал, эх сурвалжуудыг судлаж эхэлсэн төдийгүй түвдийн олон төв, нийгэмлэг, сүм хийд бий болж байна. Европ, америкийн болон оросын олон хүн буддийн шашинд орж, зарим нь лам болж байна. Түвд багш нарын олонхи нь Өрнөдөд цэвэр сургааль дэлгэрүүлж, зарим тохиолдолд түүнийг европын нөхцөл, нийгэм-эдийн засгийн бодит байдалд дасгахыг эрмэлзэж, заримдаа бас хүмүүсийн хүсэл, сонирхолд “нийцүүлэх” явдал ч гарч байна.[1898] Одоогийн байдлаар Түвдийн гадна талд нэг мянга гаруй түвдийн буддийн шашны нийгэмлэг, мөн бон шашны нийгэмлэгүүд байна. Жишээ нь, АНУ-д буддийн шашин шүтэгчдийн нийт тоо нийт хүн амын 4 хувиас давж, Европын орнуудад – 1–2 хувь (азийн орнуудаас очсон цагаачдыг оролцуулан) -ийг эзэлж байна. Хуучин ЗСБНХУ-ын нутаг дэвсгэрт Балт орчмын бүгд найрамдах улсууд, Украин, Москва, Санкт Петербург,

Екатеринбург зэрэг оросын “буддийн биш” бүс нутгуудад, Гүрж, Армени, Белорусс, Казахстанд түвдийн буддийн шашны нийгэмлэг, төвүүд байна.

Энд XIV Далай лам онцгой гавьяатай. Тэрээр 60 гаруй ном бичсэний нилээд олон нь гадаад хэл, түүний дотор орос хэлээр орчуулагдан гарчээ. Эдгээр номоос уншигчид түвдчүүдийн шашин, уламжлал, түүхийн тухай мэдэж, амьдралын тухай сургааль авч байна. “Шинэ мянган жилийн ёс зүй” хэмээн номыг онцгойлон тэмдэглэх хэрэгтэй юм. Тэнд Далай лам “шашны гэхээсээ илүү нийтлэг зарчимд” үндэслэсэн дэлхий нийтийг хамарсан ёс суртахууны хандлагын тухай өгүүлсэн байна.[1899] Энэ хандлага оюун санааны биш харин материалын үнэ цэнэт зүйлсийг илүү их сонирхох хандлага дэлхий дахинд давамгайлах болсон өнөө үед онцгой чухал ач холбогдолтой юм. Далай лам болон түүний эргэн тойрны ертөнцтэй ямар нэгэн байдлаар холбоотой олон ном гарчээ. Жишээ нь, Г. Харрерын “Түвдэд долоон жил” хэмээх олны хүртээл болсон ном байна. Энэ номоор кино хийжээ. Өөр кино ч бий билээ. Оросын баримтат “Мандах/шингэх” кино (2007 онд гарсан) байна.

XIV Далай лам дэлхийн бүх шашин, түүнчилэн иудаизмын удирдагчидтэй нэг бус удаа уулзжээ. Тэрээр 1973 онд ромын пап VI Павелтай, 1980, 1982, 1990, 1996, 1999 онд II Иоанн Павелтай, 1981 Кентерберийн тэргүүн хамба Р.Ранси болон английн сүм хийдийн бусад удирдагчтай уулзжээ. Далай лам дэлхийн шашнуудын их хурал дээр үг хэлжээ. Үнэн алдартны шашны төлөөлөгчидтэй ч хэлхээ холбоо тогтоожээ. Далай лам оросын тэргүүн хамба Пиментэй ч уулзаж байжээ. Далай лам 2008 онд энэтхэгт исламын шашны томоохон төлөөлөгчидтэй уулзахдаа энэ шашныг алан хядах ажиллагаатай адилтган үздэг явдал “туйлаас буруу” гэж мэдэгджээ.

Бүх шашин ач буянтай, шашин бүр үнэнийг баримталж, өөрийн гэсэн гайхамшигт үзэл санаа, аргатай байдаг гэж тэр үзсэн байна. Хүмүүсийн үзэл бодол янз бүр байдгийн нэгэн адил шашин ч ийм олон янз байх нь чухал юм гэж тэр хэлсэн байна. Далай лам шашин,түүний дотор буддийн шашин номлохыг эсэргүүцдэг бөгөөд өөрийнхөө уламжлалт шашныг л шүтэж бишрэх нь илүү сайн гэж үздэг ажээ. Сүүлийн арван жилд монголын бараг бүх залуучуудыг хэрэг дээр худалдан авч буй протестант, католик болон сектант шашин номлогчдын тэнд үйлдэж буй түрэмгийллийг тэрээр эсэргүүцдэг юм. Итгэл үнэмшлээ солихгүй байх нь дээр, аливаа хүн заавал ч үгүй шүтэх шаардлагатай хэмээн ухамсарласан тохиолдолд л ингэж болох юм гэж Далай лам үздэг юм.

Тэрээр дэлхийн хамгийн их “хөдөлгөөнтэй” шашны удирдагчдын нэг болжээ. Одоогийн байдлаар Далай лам дэлхийн 50 шахам оронд очиж, Ж. Буш, Б. Клинтон, А. Меркель, Ф. Миттеран, Ж. Неру, Ж. Ширак зэрэг дэлхийн олон удирдагчтай уулзжээ.1979, 1982, 1986, 1991, 1992, 1994, 1996,2004 онд орост иржээ. Далай лам 1994 онд Төрийн Думд үг хэлсэн байна. Түүний олон улсын айлчлал бүрийг бээжингийн албан ёсны эрх баригчид эсэргүүцдэг юм. Далай ламыг ганцаардуулах явдал л бээжингийнхний гол зорилт ажээ. Гэтэл эсрэгээр эргэж: хятад түшмэд ундууцаж багтарсан үйлдэл бүрээрээ даян дэлхийн хүн ардын анхаарлыг Далай лам болон түвдийн асуудал руу улам их татаж байна.

Далай ламыг Орост очиж эхэлсэн тэр үед орос-хятадын харилцаа дахин өөрчлөгджээ. БНХАУ-тай сөргөлдөхийн оронд орос улс хятадыг аядуухан байдлаар дэмжих болжээ. ОХУ хятадын нутаг дэвсгэрийн зарим өнгөлзлөгийг хүлээн авч “алдсан” хэд хэдэн нутаг дэвсгэрийг нь хятадад эргүүлж өгсөн байна. Харин эдийн засгийн хамтын ажиллагаа хэвийн болж иржээ. Хятад бараа таваар орос руу урсав. Орос улс хятадын армийн хувьд зэвсэглэлийн гол үндсэн нийлүүлэгч болж, эрчим хүчний хамтын ажиллагаа хөгжих болов. Дараа нь ОХУ, БНХАУ-ын эрх баригчид АНУ-ын өдөөн тухирсан “хилэн хувьсгал”-ыг хүлээж авахгүй байх талаар хэл амаа ололцсон юм.[1900].

ОХУ, БНХАУ-ын хооронд байгуулсан 2001 оны гэрээний 4-р зүйлд зааснаар хоёр орон төрийн эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалтай холбогдсон асуудлаар бие биенээ дэмжих үүрэг хүлээжээ.[1901] Дараа дараачийн хамтарсан тунхаглалуудад ОХУ Түвдийг БНХАУ-ын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрч байгаагаа удаа дараа нотолж байна. Ямар учраас жишээлэхэд Ляонин ч юмуу өөр ямар нэгэн муж буюу өөртөө засах орон байгаагүй юм бол? ОХУ жишээлэхэд, Смоленск муж буюу Чукоткийн хойг тус улсын харьяанд байдгийг нотлуулах гэж хятадуудтай уулзах тоолондоо шаардаагүй бизээ.

БНХАУ-ын удирдлага Түвдийн талаар тавьж буй өнгөлзлөг нь маргаантайг ойлгодог учраас л түүнийг байнга нотлуулахыг шаарддаг нь тодорхой. Дараа нь эдгээр баримт бичгийг иш татан Орос улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож, оросын буддийн шашинтнуудын хүсэл эрмэлзэлийг үл харгалзан Далай ламыг хүлээж авахгүй байхыг уриална. Үүний хариуд яаж байна? “Хятадын тал төрийнхөө эв нэгдлийг хамгаалах, Чечений алан хядагч, салан тусгаарлагчдын хүчинтэй тэмцэх талаар Оросын талын тавьж буй бүх хүчин чармайлтыг дэмжиж байна”.[1902] Гэтэл чечений

салан тусгаарлагчид хэзээ ч БНХАУ-ыг ашиглаж байгаагүй, ашиглалаа гэхэд хятад улсад өөрт нь ашигтай биш байх байсан биззэ. Түүнээс гадна Чечень, түвдтэй холбоотой нөхцөл байдлууд огт өөр өөр юм.

Тийм нөхцөл байдалд санаанаас зохиосон элдэв шалтагаар Далай ламд оросын виз олгохоос татгалздаг болжээ. Тэрч бүү хэл 2001 онд ОХУ-ын гадаад явдлын яам түүнд дамжин өнгөрөх виз олгоогүй юм. Үүнээс болж Монголд хийх айлчлалыг дараа жил нь нисэхийн өөр рейсээр хийсэн билээ. ОХУ-д хийсэн сүүлчийн санваартны айлчлал (2004 онд Халимагт) сүсэгтэн олонтой Далай ламын уулзаж ярилцах хугацааг дээд зэргээр хязгаарласан тийм нөхцөл бүрдүүлжээ. Хожим нь дахиад л виз олгоогүй. 2009 оны эхээр оросын гадаад явдлын яамны сайд С.В. Лавров ОХУ-ын Холбооны зөвлөлд үг хэлэхдээ Далай лам айлчлах боломжийн тухай дурдаад: “Бид ирээдүйд түүний шашны чиглэлийн айлчлалыг зохион байгуулах асуудлыг авч хэлэлцэхэд бэлэн байна. Түүнийг орост айлчлах тухайд ямар ч саад тотгор байхгүй” гэж мэдэгдсэн тухай мэдээлэл тарсан юм.[1903] Мөн оны дөрөв-тавдугаар сард гадаад явдлын яам ОХУ-ын Төрийн Думын депутатуудын асуулгад өгсөн хариундаа Лавровын хэлснийг дараах байдлаар тодруулжээ:Далай ламын айлчлал бол ОХУ-ын дотоод хэрэг төдийгүй, энэ айлчлал ОХУ болон БНХАУ-ын харилцаанд цочроогч болж мэдэх юм, Далай лам болон Бээжингийн харилцаа хэвийн болсны дараа л энэ айлчлалийг хийнэ биз. Тийнхүү саад байгаа л биз. Бээжингийнхний энэ санал ОХУ-д орос иргэдийн санал бодлоос илүү чухал болжээ.

“Далай ламын статус эрхийн тухай “шүүхийн” шийдвэр монополи эрхтэй гаргах албан ёсны Бээжингийн өнгөлзлөг бол хятадын төр дэлхийн буддийн шашинтнуудын нийгэмлэгийн амьдралд хөндлөнгөөс оролцож, шүтэж бишрэх эрх чөлөөг зөрчиж буй хэрэг мөн” хэмээх дүгнэлтийг зөвшөөрөхгүй байхын аргагүй юм.[1904] Гэтэл шүтэж бишрэх эрх чөлөө БНХАУ-ын 1982 оны Үндсэн хуулийн 36-р зүйлийн заалтад нийцэж байгаа юм. Тэнд: “Шашны үйл ажиллагаа чөлөөтэй явуулах эрхийг төр хамгаална. Хэн ч шашныг олон нийтийн хэв журам зөрчих, иргэдийн эрүүл мэндэд хор хохирол учруулахад болон улсын боловсролын системд хохирол учруулах байдлаар ашиглаж болохгүй. Шашны байгууллагууд, шашны үйл хэрэг, гадаадын хяналтаас ангид чөлөөтэй байна” гэж өгүүлсэн байна. Тийм томьёолол хийсэн нь тохиолдлын хэрэг бишээ. Энэ томьёолол коммунист нам аливаа шашны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох боломж бүрдүүлж байна. Нөгөө талаас БНХАУ-д зөвшөөрөгдсөн аливаа шашны удирдагчид, түүний дотор түвдийн буддийн шашны удирдагчид хилийн чанадад

байж болохгүй болж байгаа юм.Далай лам болон түвдийн шашны бусад удирдагчийг хүлээж авахгүй байхыг бусад оронд хориглох нь хятадын хууль тогтоомж БНХАУ-ын хилээр дамжин үйлчилж буй хэрэг болно. Тэгвэл ОХУ өөр хууль тогтоомжтой. ОХУ-ын Үндсэн хуулийн 19-р зүйлийн 2-т зааснаар "Нийгмийн, арьс өнгөний, үндэсний, хэлний буюу шашны шинж байдлаар иргэдийн эрхийг хязгаарлах аливаа хэлбэрийг хоригложээ". Ингэхлээр шашныхаа тэргүүнийг урих буддийн шашинтнуудын эрх хэн нэгний улс төрийн ашиг сонирхлоос болж хязгаарлагдах ёсгүй ажээ.

Гэтэл БНХАУ-ын улс төрийн нэг гол зорилт бол стратегийнхаа хилийг үндэсний нутаг дэвсгэрийнхээ хязгаараас гадагш, түүний дотор Приморийн хязгаар, Амар мөрний хавь нутаг, Монгол улс, Дундад ази руу тэлэх явдал ажээ.[1905] Дэн Сяопин "түүхэн шудрага ёсоор "эргүүлж авахыг залгамжлагч нартаа гэрээслэхдээ БНХАУ-ыг япон тэнгэс рүү гаргах хэрэгтэйг иш үндэс болгожээ. Зян Зэминий үед Алс дорнодын хүн ам цөөрч буй нөхцөлд дамжин өнгөрүүлэх чадварын маш их нөөц боломжтой хятадын дэд бүтцийг оросын хил рүү татах ажил эхэлжээ. Хятадын эрх баригчдын ил биш өөгшүүлгээр Орост хятад шилжин суурьшигчид улам олон болж, газрын зурагт тэмдэглэгдээгүй суурин газрууд бий болж байна.[1906] Одоохондоо хүн ам сийрэг Сибирьт шилжин суурьшигчид ирж байгаа нь хүн ам зүйн аюул учруулахгүй байна. Бүс нутгийн байгаль орчин, нийгмийн ухамсар, эдийн засгийн хүрээнд аюул тулгарч: хил давуулсан дамын наймаа хийх, татварын болон валютын зөрчил гаргах, хууль бус үйлдвэр худалдааны үй ажиллагаа явуулах, байгалийн нөөц баялгыг дээрэмдэх, үнэтэй тоног төхөөрөмж хулгайлах, хулгайн ан хийх, соёлын үнэт зүйс авч гарах, хууль бус аж ахуйн үйл ажиллагаа явуулах,[1907] тагнуул хийх[1908] зэрэг үйлдэл газар авч байна.

Одоо БНХАУ Оросын Алс дорнод руу шилжин суурьшигчдаа үй олноор нь явуулах гэж хүчлэхгүй байгаа бололтой. Тус улсад илүүдэл хэрүүл маргаан ямар хэрэгтэй юм бэ? Алс дорнодын оршин суугчид хилийн худалдаанд улам өргөн татагдан орж, визгүй орж гарч, БНХАУ-д хямд төсөр үл хөдлөх хөрөнгө худалдан авч, амарч, эмчлүүлэхээр тийшээ явж байна. Хилийн дагуу олон сая хүн амтай хятад хотууд улам олширч, дэд бүтэц хөгжиж байна. Алс дорнодын хүн ам хөршөөсөө хараат байх явдалд дасч байх шигээ.

БНХАУ одоохондоо ОХУ-д албан ёсоор нутаг дэвсгэрийн өнгөлзлөг тавиагүй байна. Гэвч хэрэв европчуудын ойлгох ухамсарт энэ нь шудрага бус байдлын тухай асуудлыг хэрэгсэхгүй болгодог бол хятадын билэг тэмдгийн

ухамсарт бол энэ нь “шудрага шаардлагын” асуудлыг хүчингүй болгож байгаа хэрэг бишээ. Хятадуудын хувьд “албан ёсны өнгөлзлөг”,”шудрага шаардлага” хэмээх ойлголтууд өөр өөр зүйл ажээ.

Хятадын нийтлэлүүдэд А.Д. Воскресенскийн хийсэн нарийвчилсан дүн шинжилгээ дараах байдлыг илтгэн харуулжээ.[1909] БНХАУ-д оросууд Алс дорнод, Төв азийг эзэмшсэн явдлыг “хаант засгийн үзлийн түрэмгийлэл”, “хятадын уугуул нутгуудыг хавсарган нэгтгэсэн явдал” хэмээн үздэг байна. 1970-аад онд хятад судлаачид “нэгдмэл олон үндэстний хятадын” үзэл баримтлалыг гүйцээн боловсруулж, түүнийг 1980-аад онд улам нарийвчлан гаргажээ. Тэр үзэл баримтлал дотор хоёр чиг хандлага байгаа юм: (1) төр улс гэдэг бол урт удаан үйл явцын үр дүн мөн, (2) Хятад ямагт нэгдмэл,олон үндэстний улс байсан, хан үндэстнүүдтэй холбоо бүхий аливаа ард түмний нутаг дэвсгэр бол Хятадын нутаг дэвсгэр байна. 1980-аад оноос БНХАУ-д “хятадын хилийн хувьсгалын тухай” асуудлыг эрчимтэй судлаж, Сибирь, Алс Дорнодыг Орост “шудрага бусаар” нэгтгэснийг авч хэлэлцэж байна. 1978–1980 онд “Хятад дахь хаант оросын түрэмгийллийн түүх” гэдэг номыг дөрвөн ботиор хэвлэн гаргав.[1910]

Тийнхүү “алдагдсан нутаг дэвсгэрийн” үзэл баримтлал Хятадын “дотоодын хэрэглээнд” үйлчилсэн хэвээр байна. БНХАУ одоохондоо ОХУ-д нутаг дэвсгэрийн өнгөлзлөг тавихгүй байгаа нь тактик бөгөөд стратегийн хувьд бээжингийн эрх баригчид энэ боломжийг сайн цаг ирэх хүртэл хадгалж байгаа юм.[1911]

Орос улс өрнөдийн империалистуудын өөдөөс гэж БНХАУ-ыг зэвсэглэхдээ 60 жилийн өмнөх шиг тармууран дээр гишгэхгүй гэж үү? Яагаад гэвэл ХАЧА “стратегийн хил, амьдрах орон зайн” үзэл баримтлалын дагуу зохион байгуулагдаж, энэ үзэл баримтлал байлдааны давшилтын ажиллагаа явуулах нь зүйтэйг хүлээн зөвшөөрч байна.[1912] Хятадын цэргийн бодлогын зарим талыг оросын эсрэг чиглэлтэй хэмээн тайлбарладаг болжээ. Одоохондоо БНХАУ цэрэг зэвсгийнхээ хүчээр ОХУ, АНУ, тэрч байтугай Энэтхэгийн (хэрэв цөмийн нөөц хүчийг харгалзан үзвэл) дараа орж байгаа бөгөөд Орост халдах тодорхой төлөвлөгөө боловсрогдоогүй байгаа болов уу.[1913] Гэвч хятадын цэрэг-аж үйлдвэрийн чадавхи түргэн хөгжиж байна. БНХАУ оростой цэрэг-техникийнхээ хамтын ажиллагааг сүүлийн үед хумиж, бусдын хамгийн шинэ загварын зэвсэглэл хуулж авахыг эрмэлзэж байна: өөрийнхөө үйлдвэрийн газруудад зэвсэглэл үйлдвэрлэх, энэ талаар Өрнөдтэй хамтран ажиллах чиг баримжаанд шилжих магадлалтай: БНХАУ-ын удирдлага болон ХАЧА-ийн командлал ойрын ирээдүйд ОХУ болон Төв

Азийн орнууд руу давшилтын байлдааны ажиллагаа явуулах боломжийг нухацтай авч үзэж буй шинжтэй байна.[1914]

Хятад улс хуучин ЗСБНХУ-ын орон зайд байр сууриа хүчтэй болгож, ингэхийн тулд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад ( ШХАБ ) эдийн засгийнхаа байр суурийг бэхжүүлж байна.[1915] Тус улс ШХАБ-ыг өөрийнх нь эрх ашгийг далдлагч "халхавч" байгууллага болгон ашиглаж Дундад Азид чиглэсэн зорилготой, тууштай нэвтрэн орж байна.[1916] БНХАУ өөрт нь ашиг өгөхгүй тэр газарт Орос улсыг дэмждэггүй юм. Жишээ нь, 2008 оны наймдугаар сард оросын цэрэг гүржийн цэргийн халдлагыг няцааж, Абхаз болон Өмнөд Осетийн тусгаар тогтнолыг хангажээ. Гэвч ШХАБ-ын уулзалт дээр хятад улс "гүржийн зүгээс үйлдсэн аймаглан устгах ажиллагаа болон түрэмгийлэл "хэмээх Орос улсын санал болгосон нэр томьёог хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан байна.[1917] БНХАУ-ын шахалтаар ШХАБ-ын нэг ч орон дээрх хоёр бүгд найрамдах улсыг хүлээн зөвшөөрөх тухайд Орос улсыг дэмжээгүй юм.

Гэтэл Орос улс хятадын улс төрийн бодлогод оросынход Хятадын гүйцэтгэдэгээс хамаагүй бага үүрэг гүйцэтгэж байна. БНХАУ-ын тухайд бол Өрнөдийн улсууд илүү чухал ач холбогдолтой ажээ. БНХАУ-ын бараа гүйлгээнд ОХУ-ын эзлэх хувь 2-т хүрдэггүй, харин ч буурч байгаа бол ОХУ-ын бараа эргэлтэд БНХАУ-ын эзлэх хувь 6,5-д хүрч, цаашид өсөх хандлагатай байна[1918] Хятадын бараа эргэлтэд эзлэх хувь хэмжээгээрээ ОХУ АНУ-ынхаас 10 дахин бага, Японыхоос 9 дахин, Европын холбооныхоос 8 дахин, Өмнөд Солонгосынхоос 6 дахин тус тус бага байна.[1919] БНХАУ санхүү-банкны хүрээнд ОХУ-тай биш, харин АНУ, Япон, Европын холбоотой хамтран ажиллахад ихээхэн найдвар тавьж байна. БНХАУ-руу гаргаж буй Оросын экспортын бүтээгдэхүүнд түүхий эд голлох байр эзэлж байна. Хятадын удирдлага эдийн засгийнхаа хамтын ажиллагаанд БНХАУ дахь оросын нөлөөний "тунг" хатуу барьж, ОХУ дахь нөлөөгөө хүчтэй болгохыг эрмэлзэж байна.[1920] Тэгэхдээ эдийн засгийн нөлөөгөөр хязгаарлагдахгүй байна. Оросын олон нийтийн мэдээллийн зарим хэрэгсэл, улс төр судлаачид, шинжээчид, эрдэмтэд, тэрч бүү хэл хятад оюутнууд хятадын суртал нэвтрүүлгийг нийгмийн ухамсарт улам идэвхтэй суулгаж байна.

Тийнхүү Орос улс хятадтай харилцахдаа: "байгалийн нөөц баялгийг хамтран ашиглах", "дэд бүтцийг боловсронгуй болгох", "Дэлхийн худалдааны байгууллагад Орос улсыг элсүүлэхийн тулд буулт хийх", "БНХАУ-ын стратегийн хил хязгаарыг үндэсний нутаг дэвсгэрийн

хүрээнээс тайван замаар гаргах" зэрэг эрх ашигт нь харшилсан "хятад залийг" ойлгож буйгаа илтгэн харуулах ёстой юм.[1921] Далай лам болон Түвд улсын талаархи хятадын гадаад улс төрийн өнгөлзлөг, түүх, шашинд хандах бээжингийнхний намын үзэл бодлыг Орос улсад тулган хүлээлгэх гэсэн оролдлого бол дээрхи байр сууринаас л гаралтай зүйл билээ.

БНХАУ бол хүн амынх нь сүсэг бишрэлийн өсөлт эрх баригч намын болгоомжлолыг төрүүлж буй дэлхийн цөөхөн орны нэг мөн. Арга ч үгүй биз: улам олон хятад хүн буддийн шашин шүтэж; хятадын буддийн сүм хийдүүдэд шашны ёслол үйлдэж буй залуучууд улам олон харагдах болжээ. Олон сая хятад жуулчин түвдэд очсон нь хятадын зах зээлд Түвд бараа таваар хахахад хүргэж; түвдэд очсон хятадуудын бичсэн ном олны сонирхол татаж; хятадын оюунлаг хүмүүс, бизнес эрхлэгчид, зураачид түвдийн соёл, түвдийн буддийн шашныг улам их сонирхох болов.[1922] Энэ шашин улам олон хятад хүний сонирхол татах болжээ. Далай ламын сургааль судалдаг нууц бүлгэм дугуйлан хятадын төв нутгуудад ч байгаа ажээ.[1923] Хятадууд тухайлбал тус улсын хотуудаар аялаж яваа лам нараар дамжуулан шашинд улам их дэмжлэг (түүний дотор материаллаг) үзүүлж байна.[1924] Хятадын зарим бизнес эрхлэгч түвдийн шашны байгууламжуудыг засварлах, шинээр байгуулахад хэдэн арав, хэдэн зуун мянган доллар хандивлах болсон байна.[1925] Хятадууд бизнес эрхлэхийн тулд биш, харин түвдийн соёлын хүрээлэлд амьдрахын тулд түвдэд суурьшихаар ирэх явдал ч гардаг болжээ. Ийм сонирхлын давалгаа ХКН-ын дээд бүлгийнхэнд ч хүрчээ.

Түүний зэрэгцээ шашныг "халз тулан" устгах гэсэн Мао Зэдуны бүтэлгүй оролдлого намын удирдлагыг илүү ухаалаг ажиллахад сургажээ. Шашин нэгэнт "устаагүй" учир түүнийг дотоод улс төрийн зорилгод ашиглахаар шийджээ. Ингэхийн тулд шашнаар гадна талынх нь ёс жаягийг хэвээр үлдээж, харин шашны амьдрал, тэрч байтугай номлолын чанартай үндэслэлүүдийг аажмаар өөрчлөх жүжиг тавихыг эрмэлзэж байна. Эндээс л том лам нарын хойд дүр тодруулах ажлыг удирдах гэсэн оролдлого, "гадаадын нөлөөг" хориглох, сүм хийдүүдийн амьдралд хөндлөнгөөс оролцох гэсэн оролдлого, "эх оронч хүмүүжил", лам нар, сүм хийдүүдийн тоог хязгаарлах эрмэлзэл үүдэн гарч байна БНХАУ-ын удирдлага хяналтандаа байдаг буддийн шашны байгууллагуудын хэлхээ холбоог олон улсынхаа нөлөөг улам хүчтэй болгоход ч ашиглаж байна.[1926]

Хятадын эрх баригчид Түвдэд Маогийн өмнөх үеийнх шиг тийм хэмжээгээр шашны үйл ажиллагаа сэргээхийг зөвшөөрөхгүй байгаа юм. Энэ нь ард түмний хүсэл эрмэлзэлд харшилж байгаа боловч коммунистуудын

зорилготой нийцэх ажээ. Сүүлийн жилүүдэд Түвдэд баримтлах хятадын бодлого улам их харгис шинж чанартай болсон учир түвдчүүд түүнийг “хоёрдахь соёлын хувьсгал” хэмээн нэрлэх болсон байна.[1927]

Энэ нөхцөлд 2006 онд Монгол улсад айлчлах үеэрээ Далай ламын дэвшүүлсэн санал онцгой чухал ач холбогдолтой юм. Өнөөдөр Монгол улс, Оросын буддийн шашинт бүгд найрамдах улсууд, Энэтхэгийн гималайн бүс нутгийн буддийн хамтын нийгэмлэгүүд буддийн шашныг цаашид хадгалан хөгжүүлэхийн төлөө хариуцлага хүлээх ёстой юм; өнөө үед энэ бүс нутгуудад түвдийн уугуул хүн амыг бодоход хавьгүй их боломж байгаа юм гэж тэр онцлон тэмдэглэжээ.[1928]

### *Өөртөө засах эрх ба хүн ам зүй*

“Үндэсний орон нутгийн өөртөө засах эрх эдэлж буй аливаа үндэстэн ястан удирдлагын зохих байгууллагууд бий болгож орон нутгийн удирдлагын асуудал, үндэстнийхээ хэргийг бие даан шийдвэрлэж нутаг дэвсгэртээ эзэн нь болж байна.<...> Түвдэд 1965 онд орон нутгийн үндэсний өөртөө засах эрхийн систем тогтоосноор түвдчүүд Хятадын төв засгийн газрын удирдлагаар нутаг орныхоо эзэн нь болж БНХАУ-ын Үндсэн хууль болон бусад хуулинд заасан өөрөө удирдах эрхийг бүрэн дүүрэн эдэлж төрийн болон орон нутгийн хэргийг удирдан жолоодох үйл хэрэгт идэвхтэй татагдаж орсон билээ.<...> Түвд орон өөртөө засах эрхийг хэрэгжүүлэх болсон нь Хятадын коммунист намын удирдлагаар хятад онцлогтой социализм байгуулах замыг түвдчүүд сонгож авсаны зайлшгүй үр дүн мөн.<...> Далай тэргүүтэй түвдийн орон нутгийн шашин төрийн феодал-хамжлагат ёсны засгийн оронд түвдийн ард түмний өөрсдийнх нь байгуулсан ардчилсан засаг иржээ.<...> Түвдийн ард түмэн... хуулийн дагуу нутаг орныхоо, үндэстнийхээ хэргийг удирдах эрх эдэлж, түүнчилэн төрийн онцгой хамгаалалт, дэмжлэг хүлээж байна. Түвд дэхь орон нутгийн өөртөө засах эрхийн систем НҮБ-ын тунхаг болон олон улсын бусад баримт бичигт заасан бөгөөд яс үндэсний буюу арьсны өнгийн хамаарал, шашин, хэлний салбарт цөөн хүн амтай бүлгийн эрхтэй холбоо бүхий жижиг угсаатны тэгш эрх, тэднийг ялгаварлан гадуурхахгүй байх, онцгой хамгаалалтад авах эрхийн зарчмуудыг бүх талаар тусган илэрхийлээд зогсоогүй мөн хятад онцлогтой социализмын давуу талыг бүрэн дүүрэн шингээсэн билээ. ХКН-ын удирдлагаар хятад онцлогтой социализмын замаар замнаж, орон нутгийн өөртөө засах эрхийн системийг мөрдөх нөхцөлд л хувь заяаныхаа эзэн нь

болсон төвдийн ард түмний статус эрхийг бодит байдалд хэрэгжүүлж, баталгаатай хангаж болох билээ”.[1929]

Бодит байдалд 1970-аад оноос ТӨЗО-ны засаг төрийн байгууллагуудад төвдчүүд тооны хувьд давамгайлж байна. ТӨЗО оршин тогтож ирсэн жилүүдэд Ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хорооны даргын албан тушаалд зөвхөн төвдчүүд ажиллаж иржээ. Гэхдээ зөвлөлт төрийн байгууллагууд засал чимэглэлийн үүрэг гүйцэтгэдэг, бүх гол үндсэн шийдвэрийг коммунист намын байгууллагууд гаргадаг байсныг бид Зөвлөлт Холбоот Улсын амьдралын жишээнээс мэдэх билээ. БНХАУ-д ч мөн адил юм. ТӨЗО-ны коммунист намын орон нутгийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргын албан тушаалд зөвхөн хятадууд ажиллажээ. Төвдийн дээд тушаалын түшмэд өөрсдийнх нь “удирдлагад байдаг” хятадуудын зөвшөөрөлгүйгээр шийдвэр гаргаж чадахгүй.[1930] 2000-аад онд төвдчүүд болон бусад “үндэсний цөөнхийн” төлөөлөгчид Ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хорооны дарга, орлогч дарга нарын 87,5 хувь, Ардын төлөөлөгчдийн хурлын байнгын хорооны гишүүдийн. 69,2 хувь, Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн байнгын хорооны гишүүд, эгэл жирийн гишүүдийн 90,4 ба 89,4 хувь, районы, тойргийн, гацааны зэрэг гурван түвшингийн кадр ажилтны 78 хувь, мөн эдгээр түвшингийн ардын шүүх, ардын прокурорын ажилтнуудын 70 ба 82,3 хувийг тус тус эзэлж байна.[1931] Төвдээс Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлын депутатаар 19 хүн сонгогдсоны 12 нь Төвд хүн байна. БХАТХ-ын орлогч даргын албан тушаалыг XIV Далай лам, X Банчин лам, Агваан Жигмэд, Гэлэг Намжил, Рагди нар эзэлсэн байв. Одоо Хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн бүх хятадын хороонд төвдийн төлөөлөгчид байна. Гэвч дунд болон дээд шатны албан тушаалтнуудын үйл ажиллагааг намын ажилтан хятадууд хянана. ТӨЗО-ны гадна орших төвдийн өөртөө засах нэгжүүдийн оршин суугчид Лхасын удирдах байгууллагуудын сонгуульд оролцохгүй.

1965-аас 1990 оныг дуустлах хугацаанд Төвдийн өөртөө засах орны Ардын төлөөлөгчдийн хурал болон түүний байнгын хороо Төвдийн улс төрийн бодлого, эдийн засаг, соёл, гэгээрэл болон амьдралын бусад салбарт хамаарах агуулга бүхий нийтдээ 220 хууль тогтоомжийн багц болон бие даасан хуулийн заалт боловсруулсны дотор: “ТӨЗО-ны соёлын дурсгалыг хамгаалах тухай дүрэм”,”ТӨЗО-ны хүрээлэн байгаа орчныг хамгаалах тухай Дүрэм“, ”ТӨЗО-ны уулсын оргилд гадаадынхан гарах ажлыг удирдах арга хэмжээний тухай Дүрэм”, “ТӨЗО-ны хүн амын өргөдөл, гомдлыг барагдуулах ажлын тухай Дүрэм”, “Төвд хэл, бичгийг судлах,

ашиглах, хөгжүүлэх тухай тогтоол”,”эх орны эв нэгдлийг дэмжин сахиулах, үндэсний нягтралыг хүчтэй болгох тухай, хагалан бутаргах ажиллагааны эсрэг чиглэсэн арга хэмжээний тухай Тогтоол”, “Хүний амь нас хөнөөсний төлөө мөнгөн нөхөн төлөөс оноох хууль бус, гэмт үйлдлийг тууштай таслан зогсоох тухай Тогтоол” зэргийг дурдаж болно.[1932]

Албан ёсны үүднээс бол хэрэв ТӨЗО-ны засаг захиргаа дээд байгууллагын удирдамжууд “бодит нөхцөл байдалд” харшилж байна хэмээн үзвэл эдгээр байгууллагад санал бодлоо мэдэгдэж болох бөгөөд дээрээс зөвшөөрөл ирсний дараа эдгээр удирдамжийн хэрэгжилтэд өөрчлөлт оруулах буюу ерөөс зогсоож болно. Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд энэ эрхийг нэг бус удаа эдэлжээ. Үүний дунд орчин үеийн түвдийн хууль тогтоомж хятадынхаас ялгаатай, гэхдээ л ХКН-ын жанжин шугамд үл харшлах тохиолдлуудад ийм болжээ. Жишээ нь, бүс нутгийн ирээдүйн тухай асуудлаар Түвдэд бүх ард түмний санал асуулга явуулах гэсэн Арван дөрөвдүгээр Далай ламын саналыг Бээжин няцаажээ. “Өөрөө удирдах” эрх эдэлж буй, социализмыг “өөрсдөө сонгож авсан” өөртөө засах орныхоо “эздийн” дунд явуулахаар төлөвлөсөн санал асуулга шүү дээ.

1990-ээд онд ХКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Зян Зэминь үндэсний асуудалд онцгой анхаарал тавьж, энэ асуудалд зориулж ном бичжээ.[1933] Үндэстэн хоорондын болон шашны харилцаа онцгой үүрэгтэйг төдийгүй нас хүйс, хүн амын тоо, нийгэм-эдийн засагийн хөгжлийн түвшингээс үл шалтгаалан бүх үндэстэн ястан хятадын төрт ёсны хөгжилд хувь нэмэр оруулсныг заан тэмдэглэсэн явдал шинэ зүйл болжээ. Энэ бол 1990-ээд онд хятадын үндсэрхэх үзэл газар авч эхэлсэнд өгсөн хариу болсон болов уу. Холбооны байгууллыг дахин эрс эсэргүүцэж, үнэнч марксистууд гол гол албан тушаалыг эзлэн суух өөртөө засах эрхийг хамгийн шилдэг хувилбар хэмээн. зарлав. Зян Зэминь Их Түвдийн өргөн өөртөө засах эрхийн тухай Далай ламын үзэл санааг эсэргүүцжээ. “Төрөөс үндэсний өөртөө засах орнуудад өөрөө удирдах эрхийг нь ханган олгож байгаа бөгөөд үндэсний өөртөө засах орнууд нам, төрийн чиг шугам, бодлогыг бүх талаар хэрэгжүүлэх ёстой билээ”.[1934] Чухам үүнээс л болж бүх түвшний засаг төрийн байгууллагуудад муугүй төлөөлөлтэй болсон Үндэсний кадр ажилтнууд уламжлалт соёл мөхөх, хятадууд олноор орж ирэх, ард олны тэмцэл хөдөлгөөн гарах, хятадчилах чиг шугам хэрэгжих аюулыг хэзээ ч сэрэмжлэн зайлуулж чадаагүй юм.

Хятадууд шилжин суурьших үйл явцыг хөхүүлэн дэмжих бодлого үүний нэг гол шалтгаан мөн. Бүр Мао Зэдун, Жоу Энь Лай, Дэн Сяопин нар

Түвдийн эдийн засгийг хөгжүүлэхийн тулд тийш нь мэрэгжилтэй ажилчид болон удирдлагын боловсон хүчнийг олноор нь илгээх шаардлагатай байна хэмээн ярьж байжээ. Зян Зэминь энэ бодлогын тухай ярихдаа: "Өнгөрсөн 40 гаруй жилд мянга мянган, хэдэн арван мянган кадр ажилтан, ажилчин, сэхээтэн, ХАЧА-ийн цэрэг,дарга нар зэрэг хятад үндэсний хүмүүс намын уриалгыг дэмжин сайшааж, үндэсний цөөнх оршин суудаг нутгуудад ажиллаж, амьдрахаар явж, үндэсний цөөнхийн бүх хүнтэй хамт нэг бүхэл бүтэн цогц болж, тэдний хамгийн ойр дотны хүмүүс болсон билээ. Тэд ах дүү үндэстнүүдийн хөгжилд, үндэсний нутгуудын дэвшил, цэцэглэлтэд залуу нас, хүч чадлаа зориулж, энэ үйл хэрэгт асар их хувь нэмэр оруулсан юм" гэжээ.[1935] Сүүлийн үед эдгээр хүмүүс дээр бизнес эрхлэгчид нэмэгджээ.

1983 оноос хойш хятадаас Төв Түвдэд шилжин суурьшигчдын тоо түргэн өсч байна. 1984 оны тавдугаар сарын 14-нд Бээжингийн радио: "60 мянга шахам хүнтэй барилгын ажилчдын тэргүүн бүлгүүд ТӨЗО-нд ирж эхлэв" гэж мэдээлжээ. 1985 оны зун Сычуаниас бас 60 мянган хятад хүн ТӨЗО-нд очжээ.[1936] 1987 онд Дэн Сяопин: " Түвд бие даан хөгжиж чадахгүй.<...> Бид Түвд рүү олон хятад хүн явуулахад хүрсэн бөгөөд тэд шинжлэх ухааны болон техникийн шинэ ололтуудыг (ноу-хау) түвдчүүдэд шилжүүлэн өгч, шинжлэх ухаанч удирдлагын мэдлэгээ хуваалцаж, эдийн засгийн хөгжлөө түргэтгэхийн тулд шинжлэх ухаан, техникийн болон удирдлагын боловсон хүчин бэлтгэхэд нь түвдэд туслах болно"[1937] гэж давтан хэлжээ. Хятадын бүх нутгийн мэрэгжилтнүүзд янз бүрийн байгууламжууд барих ажилд оролцохоор ирлээ, бас 300 мянга орчим ажилчин тэдэнтэй нэгдэхэд бэлэн байна гэж 1991 онд зарлажээ.. 1993 оны тавдугаар сард ямар нэгэн нууц хурал болж, хятадуудыг шилжүүлэн суурьшуулах бодлогыг зөвшөөрсөн тухай мэдээлж байжээ.[1938]

2000 оны хүн амын тооллогоос БНХАУ-ын түвдчүүдийн тооны тухай дараахь мэдээ гарчээ.[1939] Нийт 5416021 хүн,үүнээс ТӨЗО-нд 2427168, Сычуаньд 1269120, Хөх нуурт 1086592,Ганьсуд 443228, Юньнаньд 128432 хүн, бусад нутагт 61481 хүн байна. Сычуаньд түвдчүүд 1,5 хувь, хятадууд 95 хувь, Хөх нуурт (Хөх нуур, Амдо) 22,5 ба 54 хувь, Ганьсуд (Амдо) 1,8 ба 91,2 хувь, Юньнаньд (Кам) 0,3 ба 66,6 хувь, ТӨЗО-нд 92,8 ба 6,1 хувь гэсэн тоо гарчээ. Сычуань, Ганьсу, Юньнань мужуудын бүрэлдэхүүнд оруулсан Түвд нутгуудад хятадууд хамгийн их төвлөрсөн бөгөөд Хөх нуурт ч хятадууд шилжин суурьших хөдөлгөөнийг хөхүүлэн дэмжиж байна. 2003 оны хүн амын тооллогоос үзвэл ТӨЗО-ны хүн ам 1951 оноос хойш 1,1409 саяас 2,7017 сая хүртэл өссөний дотор 1964 онд түвдчүүд 1,2087

сая байсан бол 2003 онд 2,5072 сая болсон бөгөөд энд түвдчүүд хүн амын 92 гаруй хувийг эзэлжээ.[1940] Түвдийн хүн амын төрөлт, өсөлт олон жилийн турш БНХАУ-ын дундаж үзүүлэлтээс дээгүүр байна. Энэ өсөлт гол төлөв түвдчүүдээс бүрдэж байна гэж эрх баригчид нотолжээ.

Гэхдээ хятадуудын үлэмж хэсэг нь улиралын чанартай шилжин суурьшигчид, жуулчид, цэргийнхэн бөгөөд хятадын статистик мэдээлэлд үүнийг харгалзан үздэггүй ажээ.[1941] Орж,гарч буй бизнес эрхлэгчдийн тооны тухай үнэн зөв мэдээлэл ч байхгүй юм. Өдөр бүр Лхаст дүүрэн зорчигчтой хоёр галт тэрэг, хэд хэдэн нисэх онгоц ирж байна. Лхас хотын ойролцоох ганцхан “Гонкар”-ын нисэх онгноцны буудлаар жилд 400 гаруй мянган хүн тээвэрлэж байна. Хятадын талын мэдээгээр бол ТӨЗО-нд ирж буй зорчигчдын тоо жил бүр 20 хувиар нэмэгдэж байна.[1942] 2006 онд Лхас хүртэлх төмөр зам нээгдсэнээр хятадуудын урсгал эрс өсчээ. 1981 оноос 1987 оныг duustlah хугацаанд түвдэд ирэх жуулчдын тоо жилд 1,5 мянгаас 43 мянга хүртэл,[1943] 1948-аас 2000 оныг дустлах хугацаанд 95,6 мянгаас 500 мянга хүртэл[1944] өссөн бол 2007 онд 4,03 сая хүн иржээ.[1945] Энэ хүмүүсийн олонхи нь хятадууд.

Хятад “тэнүүлч ажилчдын” урсгал, ялангуяа Хөх нуур-түвдийн төмөр зам нээгдсэнээс хойшхи энэ урсгалыг зохицуулан удирдах талаар бэрхшээл үүсч байгааг ТӨЗО-ны ХКН-ын хорооны нарийн бичгийн даргын орлогч Жан Изюн 2008 оны есдүгээр сарын 2-нд хүлээн зөвшөөрчээ.[1946] Төмөр замаар орж ирж буй хятадуудын урсгалын тухай нарийн тодорхой мэдээ байхгүй юм. Түвдийн. төлөө олон улсын кампанийн мэдээгээр бол шинэ төмөр замаар эхний жилд тээвэрлэсэн 1,5 сая орчим хүний барагцаалбал 900 мянга нь Түвд биш хүмүүс: түвдэд ямар нэгэн хугацаагаар үлдэх хүсэл бүхий бизнес эрхлэгчид, ажилчид, худалдаачид байжээ.[1947] Хятадын статистик мэдээлэлд өөр тоо байдаг бөгөөд 2006 оны долдугаар сарын 1-нээс 2007 оны тавдугаар сарын 31-нийг дуустлах хугацаанд 659 мянган хүн түвдэд ирж, 642 мянган хүн явжээ.[1948] Ингэхлээр энэ замын ачаар 10 сарын дотор түвдийн хүн ам дөнгөж 19 мянгаар өссөн болж байна. Энэ бол түвдийн хүн амын жилийн өсөлтөөс хамаагүй бага тоо ажээ. Гэвч төмөр замаар тээвэрлэсэн жуулчдын тоо тасралтгүй өсч байна. Энэхүү төмөр зам ашиглалтад орсон эхний хоёр жилд Лхасын төмөр замын буудлаар дамжсан зорчигчдын урсгал 2,8 сая хүнээс давсан нь ТӨЗО-ны хүн амын нийт тоотой тэнцэж байна.[1949]

ТӨЗО-нд ирж буй хятадууд орон сууцны бодлого, хангамж, боловсрол, цалин хөлс, нийгмийн хангамжийн тухайд давуу эрх эдэлж байна. Тэд

хөдөлмөрийн хүнд нөхцөл гэгчтэй холбогдуулан их хэмжээний мөнгө нэмж авч байна. Хятадын талын баримт мэдээгээр бол шилжин суурьшигчдын барагцаалбал 10 хувь нь уулын архаг өвчнөөс болж зовж байна. Эрх баригчид хятадууд ийнхүү шилжин суурьшихийг хөхүүлэн дэмжиж байгаа хэрнээ түвдчүүдийн дотоодын шилжилт хөдөлгөөнийг хатуу хянаж байна. Хотууд аж үйлдвэрийн хөгжлийг хангах, хөдөө нутаг нь шилжин суурьшигчдыг үр тариагаар хангах үүрэг тус тус гүйцэтгэх ёстой ажээ. Тийм учраас 1960-аад оны эхээр түвдийн тариачдыг хөдөө нутагт нь баттай суурьшуулахад чиглэсэн оршин суугаа газраар нь бүртгэх систем нэвтрүүлжээ.

Түвдийн цагаач иргэдийн мэдээллээр бол[1950] энэ систем үндэс угсаагаар ялгаварлан гадуурхсан шинжтэй ажээ. Түвдэд очсон хятад ажилчид нэн даруй түр буюу байнга оршин суух эрх олж авдаг нь хотуудад орон сууц, ажилтай болох, тэтгэвэр тэтгэмж авах боломж бүрдүүлж өгч байгаа юм. Түвдчүүд хотод ажил олсон нөхцөлд л түр оршин суух эрх олж авдаг байна. Гэтэл ажил олно гэдэг хэцүү, яагаад гэвэл хөдөөнөөс орж ирж буй хүмүүсийн олонхи нь бичиг үсэггүй, орчин үеийн шаардлагатай хэмжээний дадал чадваргүй байдаг ажээ. Баруун хязгаарыг хөгжүүлэх арга хэмжээний тухай 2001 оны захирамжийн дагуу бол “авьяаслаг хүмүүсийг” тийш нь чөлөөтэй шилжүүлэн суурьшуулахыг хөхүүлэн дэмжэж, тэд ч хэд хэдэн хөнгөлөлт эдэлж байна. Жишээ нь, хятад ажилчид буцаж явахад тэдний оршин суугаа газрын хуучин бүртгэлийг хэвээр үлдээдэг байна. Дээрх эх сурвалжаар бол 1991–1992 онд ТӨЗО-ны бизнесийн 20 хүрэхгүй хувь түвдчүүдэд оногдож, Лхас хотын дэлгүүрүүдийн 75 хувь хятадуудын мэдэлд байжээ. Засгийн газар түвдчүүдийг сургаж, тэдэнд зориулсан ажлын байр бий болгох хөтөлбөрийн тухай, жишээлэхэд 2003 онд хотуудад 10 мянган ажлын байр бий болгох тухай зарлав. Гэвч эдгээр ажлын байрны үлэмж хэсэг нь хятад ажилчдад очих ажээ.

Түвдийн цагаач иргэдийн мэдээллээр бол түвдэд жуулчдын хятад хөтөч нарын тоо өсч байгаа бол түвдчүүд эрх баригчдын шахалтад өртөж байна. Жишээ нь, Энэтхэгийн Түвд сургуулиудад боловсрол эзэмшсэн 60 хөтөчийн лицензийг шууд хураажээ.[1951] 2003 онд ТӨЗО жил бүр хятадаас 100 хөтөч ажилд авч байх үүрэг хүлээжээ.[1952] 1980-аад онд ТӨЗО-ны оршин суугчдаас ганц нэгхэн хүн англиар ярьдаг байсан бол одоо байдал өөр болжээ. Түвд хөтөч нар англиар сайн ярьж байна. Бусад олон хэлээр ярьдаг хүн олоход ч хүнд биш ажээ. Жишээлэхэд нэмэлт хөлс төлж орос хэлтэй хятад хөтөч олж болно. Гэхдээ түвдийн түүх, соёлыг мэддэг хүн цөөрөх хандлагатай байна. Хятадууд зөвхөн хөтөчөөр ажиллаад зогсохгүй түвдийн нилээд газарт Түвд

биш хүмүүсээс бүрдсэн Түвд дуу дуулж, бүжиг үсэрдэг (дашрамд дурдахад Өвөр Монголд ч иймэрхүү бүлгүүзд бий боловч тэнд монголчууд заавал байх ажээ) "ардын дуу, бүжгийн" бүлгүүд ажиллаж байна. Хотууд дахь хятад наймаачид Түвд хувцас өмс ч, Түвд бэлэг дурсгалын зүйлс худалддаг бөгөөд тэднээс олон хүн Хятадад ч ийм байдлаар ажиллана.

Түвдэд хүмүүсийг байнгын суурин газруудад төвлөрүүлэн амьдруулах уламжлал байхгүй юм. Томоохон хийдүүд л хот гэгддэг байж. Тэгвэл хятадууд шинэ шинэ хот бий болгож байна. Хөх нуур мужид (Амдо) нэг ам дөрвөлжин километр газарт 3 хүрэхгүй хүн оногдох бөгөөд эргэн тойронд үржил шимтэй газар, өтгөн өвч ургасан билчээр, байгалийн ашигт малтмалын баялаг байх ажээ.[1953] "Ажил амьдрал буцалсан, баяр баясгалантай шинэ амьдралын гал асаах хөдөлмөрч хүмүүс ийм нутгуудад ирэх ёстой. Тийнхүү Хунань, Жэзян, Гуандун, Зянсугаас охид, хөвүүд энэ нутаг руу явж байна. Одоохондоо тэд мянгаар тоологдож байгаа боловч ирээдүйд олон сая хүн болно. Энэ хүмүүс Хөх нуур мужийг өөрчлөн байгуулах учиртай, хүн ам суурьшаагүй,зэлүүд цөл энэ хязгаар энд тэндгүй цахилгаан гэрэл ассан, үйлдвэр, заводын яндангийн утаа суунагласан, алтан шаргал тариан тэнгэс долгилсон нутаг болон хувирна".[1954]

Коммунистуудын мөрөөдөл биелж: одоо Амдод Түвд хүн амын тоо хятадуудынхаас хоёр дахин цөөн болжээ. Жишээ нь, Амдогийн зүүн хэсэгт орших цөөн тооны нүүдэлчид бүхий Карму (Голмуд) гэдэг цөлөрхөг газар 200 мянган хүн амтай хот болон хувирч, түвдчүүд тэндхийн хүн амын 2 хүрэхгүй хувийг эзэлж байна. Лхас орох төмөр замын дагуу олон суурин газар байгуулахаар төлөвлөжээ.[1955] 1996-гаас 2000 оныг дуустлах хугацаанд л ТӨЗО-ны хотуудын тоо 112-оос 140 болж өссөн байна. 2000 онд Лхасыг Амдо, Кам,Балбатай холбодог засмал замын дагуу 100 жижиг хот байгуулахаар төлөвлөж, 2010 он гэхэд эдгээр хотын хүн ам 440 мянгаас 780 мянгад хүрэх ёстой байжээ.

Хятадын талын 1988 оны мэдээгээр бол ТӨЗО-нд байгаа 72 мянган хятад иргэний 52,5 хувь нь Лхас болон түүний хавьд сууж байжээ.[1956] Мөн Шигазе, Цетан, Чамдо болон бусад томоохон хотод олон хятад иргэн суурьшжээ. Гьелтан, Цетангийн Түвд хүн ам оршин суудаг нутгуудад хятадууд маш эрчимтэй суурьшиж, тэндхийн соёл мөхөж, авилгал, арьсны үзэл цэцэглэн хөгжиж байна гэж энэ үйл явдлыг нүдээр үзсэн хүмүүс гэрчлэн ярьжээ.[1957] Одоо Лхаст гаднаас ирж буй хүмүүсийн тоо түвдчүүдээс хоёр дахин олон болжээ.[1958] Өнөөдөр Түвдийн нийслэлийг хятад, түвд хоёр хотоос бүрдэж байна хэмээн хэлж болох бөгөөд хятадууд хотын Түвд

хэсгийг улам эрчимтэй эзэгнэн суурьшиж байна.[1959] Лхасыг Түвдийн ариун дагшин төв байх үед түүний эзлэх талбай 3 ам дөрвөлжин километр, хүн ам нь 30 мянга байжээ. 2000 он гэхэд хотын эзлэх талбай 53 ам дөрвөлжин км, 2005 онд 70 ам дөрвөлжин км, хүн ам нь 257400 болтлоо өргөжиж, харин 2015 он гэхэд эрх баригчид хотын эзлэх талбайг 272 ам дөрвөлжин км-т хүргэхээр төлөвлөж байгаа бөгөөд хүн ам нь 300 мянгаас давах ажээ.[1960] Хотод хөрөнгө оруулалт орж ирж, дэд бүтэц түргэн хурдацтай хөгжиж байна.

Хятадууд түвдчүүдээс ангид суух ажээ.[1961] Энэ нь байнгын оршин суугчдад ч, түр хугацаагаар ирж буй хүмүүст ч хамаарах ажээ. Хятадууд гол төлөв шинэ хорооллуудад суурьшина. Хот түргэн хөгжиж, түүний дүр төрх ч улам бүр хятаджиж байна. Шинэ байшин барихад Түвд уран барилгын уламжлалыг харгалзан үзэхээ больжээ. 1993–1998 онд Лхас хотод жилд дунджаар 35 хуучин байшин буулгажээ.[1962] 3-р чуулга уулзалтын шийдвэрийг биелүүлэх хүрээнд нийслэлийн хуучин хэсэгт 1996 оны сүүлч гэхэд эртний 600 дурсгалын 350-ыг буулгажээ.[1963] Түвд уран барилгын хуучин байшингуудыг олон давхар бетонон барилгаар сольж, тэдгээрт хятадуудыг суулгав. 1998 онд Лхас хотын төвд хуучин байшин буулгахад түр хориг тогтоосон тухай зарлаж, тэдгээр байшингийн 76-г сэргээн засварлахаар шийдсэн байна. Гэвч 2002 онд түвдийн ислам сүсэгтнүүдийн хуучин сүмийг буулгаж, оронд нь шинэ, бетонон сүм байгуулав.[1964] Энэ барилгад түвд, хятад, дундад азийн хэв загвар хутгалдан шингэжээ. Будалын ордны өмнөх талбайд хачирхалтай өндөр сүрлэг хөшөө олж үзэж болно. Энэ хөшөө Түвдийн “энх тайван чөлөөлөлтийг” билэгдэж байгаа ажээ. Түүнийг Далай ламын хуучин өргөөний эсрэг талд байрлуулсан нь тохиолдлын зүйл биш, улс төрийн далд утга агуулж байгаа гэнэ.[1965] Лхас хотын төвд Жокан сүмийн цаах нь 13 давхар байшин хот дээгүүр сүндэрлэн харагдана. Энэ байшинг 2002 онд босгожээ. Энэ бол нийгмийг аюулаас хамгаалах товчооны төв байр.[1966] Лхас хот дахь “Алтан сарлагууд” гэдэг том хөшөө “Шинэ түвдийг” бэлэгдэж байгаа юм. Гэвч түвдчүүд энэ хөшөөг өөр утгаар тайлбарлаж: хоёр сарлагийн нэг нь Будалын ордныг, нөгөө нь Норовлин шилтгээнийг, өөрөөр хэлбэл Далай ламын өвөл, зуны өргөөг харж буй ажээ.

Саявтархан найдвар төрүүлсэн мэдээ гарсан нь: 2009–2020 онд 6,47 ам дөрвөлжин км талбай бүхий Лхасын түүхэн төвийн уламжлалт дүр төрхийг сэргээхээр болсон байна.[1967] Энд босох шинэ байшингуудын өндөр 15 метрээс давахгүй байх бөгөөд уламжлалт дүр төрхөд үл нийцэх




Лхас хотын шинэ хороолол, 2008 он (С.Л. Кузьмины авсан гэрэл зураг)




Лхас хотын хойд, төв, зүүн гудамжууд, 2008 он (С.Л. Кузьмины авсан гэрэл зураг)

байшингуудыг буулгах юм байна.

БНХАУ-д гэр бүлийн төлөвлөлт гэж байдгийг нийтээр мэдэх билээ. Хүн амын тоо болон нягтрал маш их, тэдгээрийн дийлэнхи олонхийг хятадууд эзэлдгийг харгалзан үзвэл үүнийг зөвтгөж болно. Гэтэл төлөвлөгөөтай хүүхэд төрөлтийг "үндэсний цөөнхөд" хамаатуулжээ. Дан хятадуудаас бүрдсэн гэр бүл зөвхөн нэг хүүхэд төрүүлж, өсгөж болох бөгөөд ТӨЗО-ны кадр ажилтнууд, хот,тосгодын оршин суугчид тодорхой хугацааны завсарлагатайгаар хоёр хүүхэд төрүүлэхийг 1984 оноос хөхүүлэн дэмжих болсон байна.[1968] Гэр бүл төлөвлөлтөд сайн дурын зарчмыг тунхаглаж, албадан үр хөндөхийг хоригложээ. Малчид, тариачдын дунд (хүн амын 80 орчим хувь) хүүхэд төрөлтийг хязгаарлах шинжлэх ухааны аргын тухай тайлбарлан таниулах ажил, хүүхэд төрөлтийг оновчтой болгох суртал нэвтрүүлэг явуулж, харин хил орчмын бүсэд тийм суртал нэвтрүүлэг ерөөс явуулаагүй байна. "Өөрсдөө төлөвлөгөөтэй хүүхэд төрүүлэхийг хүсч буй Түвд үндэсний малчид, тариачдад ТӨЗО-ны засгийн газрын эрүүлийг хамгаалах албанаас аюулгүй, найдвартай үйлчилгээ үзүүлж байна". Хятадын талын мэдээгээр бол ТӨЗО-ны хөдөө орон нутгийн нэг айл дунджаар 4–5, цөөнгүй тохиолдолд 7–8 хүүхэдтэй байна. Сычуань, Хөх нуурт орон нутгийн дүрэм өөр ч төрөлтийг хязгаарлах бодлого илүү хатуу байна.[1969]

Орон нутгаас түвдчүүдийн мэдээлснийг авч үзье. 1980-аад онд ТӨЗО-нд олон мянган Түвд бүсгүйчүүдийн үрийн сувгийг боож, олон зуун хүнд үр хөндөлт хийсэн бөгөөд энэ зорилгоор төрөлтөд хяналт тавих хөдөлгөөнт бригадуудыг хөдөө нутгуудаар явуулав.[1970] Албадлагын түвшин газар орон, цаг хугацаа, түшмэлүүдийн харгис чанараас хамааран янз бүр байв. Кам, Амдод хатуу арга хэрэглэжээ. Жишээ нь, 1983 онд Пари гацаанд 2415 эмэгтэйн үрийн сувагийг боосны 82 хувь нь Түвд бүсгүйчүүд байжээ.1987 онд Карзе тойрогт 764 хүнд ийм мэс ажилбар хийсний 660 нь түвдчүүд ажээ. 1996 онд Хөх нуур мужид эмэгтэйчүүдийг үй олноор нь хамруулан ерөндөг тавьсан байна. 2958 Түвд бүсгүйд спираль тавьснаас болж төрөлт 86,13-аас 85,73 хувь хүртэл буурчээ.[1971]

Түвд эх сурвалжаас үзвэл[1972] 1996 онд Лхас хотын нэгэн районд гурван хүүхэд төрүүлсэн 308 Түвд бүсгүйн үрийн сувагийг 22-хон өдөрт багтаан хүчээр боожээ. Тэднээс нэг хүн мэс ажилбараас хойш гурав хоногийн дараа эмнэлэгт нас барсан байна. 1997 онд ТӨЗО-ны Түвд бүсгүйчүүдэд албан хүчээр үр хөндсөн, үрийн суваг боосон 883 тохиолдол бүртгэгдсэн байна. ТӨЗО-ны хүн амын 12 хувь л (хотуудын оршин суугчид ) төлөвлөгөөтэй

хүүхэд төрөлтөд хамрагдана гэж 1984 онд хятад засаг захиргаа зарласан ч бодит байдалд айлын гуравдахь хүүхдэд 1,5- 3 мянган юаний торгууль тогтоожээ.[1973] "Илүүдэл" хүүхдэд хүнсний карт олгохгүй, ажиллаж буй хүмүүсээс цалингийнх нь 50 хувийг суутгах буюу цалинг нь 3-6 сар тавьж олгохгүй авч үлддэг байжээ.

Түвд бүсгүйчүүдийн үрийн сувагийг боож байгаа тухай мэдээ нилээд хожуу үед ч ирж байлаа.[1974] Зарим газарт нөхөртэй эмэгтэйчүүдийн 90 хүртэлх хувьд үрийн суваг боох мэс ажилбар хийжээ.[1975] Хэрэв аль нэгэн айлд тогтоосон тооноос илүү хүүхэд төрвөл торгууль болон бусад хориг арга хэмжээнээс эмээхдээ хүүхэд төрүүлснээ нуух явдал ч гарч байжээ. Тийм хүүхэд төрийн нийгмийн баталгаанаас хасагдсан учир сургуульд ч өгч болохгүй байжээ. Торгууль тухайн айлын жилийн орлогоос ч давж, 5 мянган юань (588 ам.доллар) хүрч болдог байв. Нагчу гацаанд жирэмслэлтийн 7-8 сартай эмэгтэйчүүдэд үр хөндүүлэхийг тулган шаардаж байсан тухай 2001 оны аравдугаар сард дүрвэгчид мэдээлжээ.[1976] Чамдо тойргийн Драяб хошуунд 700 хүнээр бодож төлөвлөөд өдөрт 50-60 эмэгтэйд үрийн суваг боох мэс ажилбар хийж байжээ. Үүнээс татгалзсан хүмүүст 1600 (188 ам.доллар) юаний торгууль тавьжээ. Хөх нуур мужаас ч мөн иймэрхүү мэдээ ирсэн байна. Жишээ нь, Голок тойргийн нэгэн хошуунд жил бүр таван эмэгтэйд үрийн суваг боох мэс ажилбар хийхийг шаардаж, ингэхийн тулд хүүхэд төрүүлээгүй байгаа (20-иос дээш насны) эмэгтэйчүүдийн дунд сугалаа сугалуулдаг байжээ. Зарим тохиолдолд үрийнхээ сувагийг боолгосон, дараа нь эмнэлгийн үйлчилгээ авсан гэж эмэгтэйчүүдээс бас төлбөр нэхэж авдаг байжээ.[1977]

Энд дахиад л хэтрүүлэгийн тухай асуудал гарч ирж болох юм. Гэхдээ дээрхийн адил мэдээллүүд удаан хугацааны туршид, янз бүрийн газар нутгаас, янз бүрийн хүмүүсээс ирж байсан юм. Энэ нь наад зах нь гэхэд төрөлтөд хяналт тавихын тулд эмэгтэйчүүдийг олноор нь хамруулан үргүйтүүлэх ажил явуулж байсныг гэрчлэн харуулна. Үүний үр дүн ч гарсан нь тодорхой. ТӨЗО-нд хүн амын төрөлт болон өсөлт хэдэн арван жилд барагцаалбал хоёр дахин буурсан байна.[1978] Энэ бол хятадуудын тоо түргэн өссөн нөхцөлд шүү.

Тийнхүү Түвд нутгууд дахь Түвд биш хүн амын өсөлт, хорогдлын тухай нарийн статистик мэдээлэл байхгүй ч эрх баригчдын үйлдэл Түвдэд хятадуудын тоо нэмэгдэхэд тус дөхөм болж байгаа нь эргэлзээгүй юм. Энэхүү шилжин суурьшилт нь мөн түвдчүүд талбайн гадна үлдэж, эдийн засгийн түргэн хөгжиж буй салбарууд хятадуудын мэдэлд шилжихэд

хүргэдгээрээ ч аюултай юм.

| Он | Төрөлтийн тоо | Төрөлтийн тоо, % | Хүн амын зүй ёсны өсөлт | Зүй ёсны өсөлтийн хурдац |
|---|---|---|---|---|
| 1991 | 51700 | 2,35 | 35400 | 1,61 |
| 1993 | 48800 | 2,13 | 32000 | 1,4 |
| 1995 | 48200 | 2,06 | 30500 | 1,3 |
| 1997 | 44300 | 1,84 | 26200 | 1,09 |
| 1999 | 36000 | 1,45 | 19900 | 0,8 |

***Хэл, боловсрол, соёл***

"Түвдийг тайван замаар чөлөөлж, ардчилсан шинэтгэл хийснээс хойш өнгөрсөн хэдэн арван жилд Хятад улс хууль зүй, эдийн засаг, засаг захиргааны арга хэрэглэн түвдийн соёл, уламжлал, үндэсний өвөрмөц байдлыг хамгаалж, аварч, дэлгэрүүлэхэд хүн хүчний, санхүүгийн болон эд материалын асар их тусламж үзүүлсэн нь хэн бүхэнд тодорхой билээ".[1979] Соёлын хувьсгалын үед түвд хэл,соёлыг устгах чиг шугам баримталсныг энд дурдахыг би хүсч байна. Түвд хэл заахыг хориглосон байлаа. ТӨЗО-нд албан хэрэгцээнд зориулан ашиглах "түвдийн үндэстэн ястнуудын асуудлаар 1965–1985 онд гаргасан баримт бичгийн эмхэтгэлд" ийм дүгнэлт хийжээ: "Түвд хэлний багш нар болон Түвд хэл рүү орчуулга хийх чадвартай хүмүүс маш цөөхөн үлджээ. Үүнээс болж энэ хэлд сургах, түүнчилэн хоёр хэлээр албан ёсны баримт бичгүүд зохиоход маш хүнд болсон байна.Олон тооны Түвд түшмэд төрөлх хэлээрээ зөв бичиж, уншиж чадахгүй байна. Тэд энэ шалтгаанаар намын бодлогыг олон түмний дунд баримтлан явуулж чадахгүй байна".[1980]

Маог нас барснаас хойш Лхас хотод Түвд хэлээр зарлал ч гаргахаа больсон байлаа. 1960 оноос хойш тэнд байсан хятад түшмэл гадаадынханд Түвд хэлээр "ажаамуу", "Танд талархая" гэж хэлж чадахгүй хэрнээ "зайлцгаа" "хөдлөөч", "түргэл түргэл" гэхийг мэддэг байжээ.[1981]

Х Банчин лам 1988 онд хятадын Түвд судлалын хүрээлэнгийн анхдугаар хурал дээр үг хэлэхдээ: "Долдугаар зуунаас эхлэн 1300 жилийн турш хувь заяагаа өөрсдөө шийдвэрлэж ирсэн орон чөлөөлөлтөөс хойш төрөлх хэлээ алджээ. Бид хоцрогдмол бас алдаа хийж байсан ч төрөлх хэлээ ашиглан дэлхийн хамгийн өндөрлөг газарт өөрсдөө л амьдрал ахуйгаа зохицуулан тодорхойлж ирсэн юм. Манай хэл буддийн сургааль, ардын урлал, одон

орон судлал, зурхай судлал, яруу найраг, сэтгэл судлал, хуулийн болон улс төрийн бүтээлүүд зэрэг манай соёлд бидний олсон бүх зүйлийг хадгалж чадсан юм. <...> Түвд хэл амьд үлдэх үү,эсвэл мөхөх үү гэдгийг би мэдэхийг хүсч байна" гэжээ.[1982] ТӨЗО-ны гадна талд Түвд хэлний хувь заяа бүр ч дор байлаа. Жишээлбэл, Карзе тойргийн ХКН-ын Түвд гишүүд болон түшмэл 6044 хүний дөнгөж 991 нь уншиж, бичдэг байжээ.[1983]

Нөхцөл байдлыг засч эхлэв. 1987, 1988 онд "Түвд хэл, бичиг судлах, ашиглах, хөгжүүлэх тухай зарим үндэслэл", "ТӨЗО-нд Түвд хэл, бичиг судлах, ашиглах, хөгжүүлэх тухай зарим үндэслэлийг хэрэгжүүлэх нарийвчилсан дүрэм" нийтэлжээ.[1984] Эдгээр баримт бичиг Түвд хэл,бичгийг хадгалж үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. ТӨЗО-ны ардын төлөөлөгчдийн хурлын бүгд хурлаас ийм "дүрэм" батлан гаргахыг гол санаачлаөгч нь X Банчин лам мөн. Эдгээр "дүрэмд" ТӨЗО-нд түвд, хятад хэлийг адилхан хэрэглэх тухай заасан боловч Түвд хэлийг гол үндсэн хэл хэмээн тунхаглажээ. ТӨЗО-ны бүх түвшний ардын төлөөлөгчдийн хурлын бүх тогтоол, хууль эрхийн актууд, түүнчилэн ТӨЗО-ны орон нутгийн засгийн газрууд, тэдгээрийн хэлтэс байгууллагуудаас доод шатны байгууллагуудад явуулах бүх албан бичгүүд, төрөл бүрийн зар мэдээллүүдийг одоо түвд, хятад хэлээр нийтэлж байна. Түвдчүүдийн хэргийг шүүх ажиллагаа, мөн тэднийг байцаасан бүх баримт бичгийг Түвд хэлээр хийж, үйлдэж байна. Албан байгууллагын тамгын бичээс, биеийн байцаалт /анкет/, лавлагаа, шуудангийн дугтуйн хаяг, бүх төрлийн албан бичиг баримт, албан байгууллага, үйлдвэрийн газар, сургуулиуд, галт тэрэгний болон нисэх онгоцны буудал, дэлгүүр хоршоо, зочид буудал, зоогийн газар, театр, жуулчдын газрууд, спортын цогцолбор, номын сангийн гудамж-замын тэмдэглэгээний заалтуудыг хятад орчуулгатай Түвд хэлээр бичиж байна. Хэд хэдэн сонин сэтгүүл, ном Түвд хэлээр гарч байна.

Мэдээллийн Синьхуа агентлагийн уламжилснаар бол[1985] Түвд бичлэг бүхий гар утас, компьютер, албан өрөөний программ хангамж, Түвд хэл ашигласан браузер улам их болж: түвд-хятад-англи хэлний онлайн (интернэт) толь бичиг бий болгожээ. Түвд хэлээр программ хангамж зохиох ажил БНХАУ-ын Мэдээллийн яамны дэмжлэгтэйгээр үргэлжилж, түүний төсөл бараг дуусч байна.

Гэвч ТӨЗО-нд очиход өөр дүр зураг нүдэнд тусна. Армийн анги нэгтгэлүүд, олон үйлдвэрийн газар зөвхөн хятад хэлээр бичсэн хаягтай, хэд хэдэн байгууллагын элдэв зар мэдээлэл мөн л Түвд орчуулгагүй, телевийн болон радио нэвтрүүлгийн ихэнх нь дан ганц хятад хэлээр явж байна.[1986]

Түвд хэлээр явдаг телевизийн нэвтрүүлэг шинэ хятад сувгуудыг бодоход илүү их хяналтад байдаг бололтой юм билээ.[1987] Сонин, сэтгүүлийн тухайд ч мөн адил.

Лхас хотын шар айрагны орчин үеийн заводын ажилчдын олонхи нь түвдчүүд боловч тэндхийн бүх зарлал, заавар, бичээсийг мөн л хятадаар бичиж, энд Түвд хэл хэрэггүй гэж заводын удирдлага үзсэн байна.[1988] Интернет-кафед программ хангамж ч хятад, англи хэлээр ажээ. Түвдчүүдээс гол үндсэн баримт бичгүүдийг зөвхөн хятад хэлээр авдаг тухай мэдээ бий юм. Гадаад хэлнээс үг хэллэг орж ирэх үзэгдэл ч хятад хэлтэй холбоотой байгаа нь хэл адилсахад нэрмээс болж байна.[1989] Оксфордын нэг эрдэмтэн тухайн бичвэрээс шалтгаалан хятад, Түвд үгүүд ижилсэх үзэгдлийг судалжээ.[1990] Лхас хотын оршин суугчдын үгийн сангийн 30-40 хувь нь хятад хэлнээс орж ирсэн байжээ. Цөөхөн тооны Түвд хүн Түвд хэлийг өндөр түвшинд заах чадвартай байгаа учираас хэлний стандарт ийнхүү унаж байгаа ажээ.

Түвдийн сургуулиудад түвд, хятад хоёр хэлийг заавал үзнэ. 1985 оноос эхлэн БНХАУ-ын засгийн газрын хөрөнгөөр 21 муж, хотод түвд анги ба сургууль байгуулжээ. Дээд, тусгай мэрэгжлийн дунд сургуулийн дипломтой 10 мянга шахам түвд мэргэжилтэн бэлтгэж гаргасан байна.[1991] 2003 оны сүүлч үе гэхэд ТӨЗО-нд янз бүрийн шатны 1011 сургууль, 2020 сургалтын төвтэй болсон байлаа. Сургуулиудад 4563,4 мянган хүн суралцаж, хүүхдүүдийн 91,8 хувь нь сургуульд явж, бичиг үсэггүй хүмүүсийн эзлэх хувь 30 хүртэл буурсан байв. Гэвч НҮБ-ын мэдээгээр бол 2005 онд түвдчүүдийн 55 хувь нь бичиг үсэггүй байсан бол БНХАУ-ын 31 мужийн алиных нь ч тухайд бичиг үсэггүй хүмүүсийн эзлэх хувь 20-иос доош байжээ.[1992]

2008 оны мэдээгээр ТӨЗО-нд хоёр хэлээр хичээл заадаг 15523 багш байсны 10927 багш Түвд хэл дагнаж заадаг байв. Багаас дунд сургууль хүртэлх 16 хичээлд үзэх 181 сурах бичиг, 122 сургалтын гарын авлага, 16 сургалтын программ түвд хэлээр зохиосон буюу энэ хэл рүү орчуулан гаргажээ.[1993] Хэрэв түвдэд боловсролын асуудал тийм сайн байгаа юм бол эцэг эх нь Энэтхэг дэхь Түвд сургуулиуд руу нууцаар явуулж буй хүүхдүүдийн урсгал яагаад зогсохгүй байна вэ? Асуудлыг илүү сайн ойлгохын тулд албан ёсны мэдээллийн нөгөө талыг авч үзэх нь зүйтэй бизээ.

Түвдэд сургууль бүрийн хашаанд өндөр суурин дээр босгосон хятад улсын далбаа нүднээ тусна. Ямар ч сургуульд хятад хүүхэд цөөнх байсан ч бүх хичээлийг хятад хэлээр заадагийг оросын сэтгүүлчид ажиглаж мэджээ.[1994] Сурагчид суудаг сандал ширээ, хэрэглэдэг сурах бичиг, түүнчилэн сургуулийн ямар нэгэн эд хэрэглэл эвдэрч гэмтсэний төлөөх бүх



Түвд сургуульд, 1980 оны үе

төлбөрийг төлдөг ажээ. Буддийн шашны номын зан үйл бол “хоцрогдсон явдал”, түвдийн түүх бол хятад түүхийн өчүүхэн хэсэг гэж сурагчдад хэлдэг ажээ. 2008 оны арванхоёрдугаар сард сургуулиудад “угсаатны нэгдмэл байдал” хэмээх хичээл орох болсон тухай зарлажээ.[1995] Одоо сурагчид “хятадын засгийн газар болон коммунист намын угсаатны зүйн бодлогын давуу талыг ухааран ойлгож”, “угсаатны зүйн асуудалд хандах марксист хандлагын” үндсэн дээр “салан тусгаарлах үзлийг” сөрөн зогсож чаддаг болжээ. Бүр XX зууны эхээр оросын нэрд гарсан жуулчин В.К. Арсеньев Приморийн хязгаарт шилжин суурьшсан хятад иргэдээс “өөр язгуурын хүмүүсийн” талаар явуулж буй үйл ажиллагааны хамгийн аюултай зүйл бол тэд энэ хүмүүст зориулан хятад дүрс бичиг, хятад ёс зүй, түүх заадаг сургуулиуд байгуулж, өөрөөр хэлбэл хятаджуулж буй явдал мөн гэж тэмдэглэсэн байдаг.[1996]

Түвдээс дүрвэж очсон хүүхдүүд хятад захиргааныхны хэрэглэдэг шийтгэлийн тухай мэдээлснээс үзвэл тэр хүүхдүүдээр услалтын суваг цэвэрлүүлж, багш нарын хувцас угаалгаж, аж үйлдвэрийн районуудад цэвэрлэгээ хийлгэдэг ажээ.[1997] Бага ангийн сурагчдыг (6–12 настай) хаймар бороохой, ташуур, сур, цахилгаан гүйдэл, сандлын хөл, хулсан саваа хэрэглэн зодох ажээ.

Сургуулиудад ийм харгислал үйлдэж, хятадчилах ажиллагаа явуулдаг

нь олон хүүхдийн дургүйг хүргэдэг байна.

Гэхдээ боловсролыг хятаджуулах явдал заавал хэрэгжүүлэх төрийн бодлого биш байж болно. Олон эцэг эх хүүхдүүддээ хятад боловсрол эзэмшүүлэхийг хүсдэг, яагаад гэвэл ингэх нь ирээдүйд илүү их боломж нээж өгдөг юм байна.[1998] Жишээлбэл, жил бүр 3 мянга шахам төгсөгч хятадын их, дээд сургуулиудад элсэн орж байна. “Дотоодын сургуулиуд” гэгчид бий болж: эдгээр сургуульд түвд хүүхдүүдийг сонгон авч, тэднийг хятад руу, жишээлэхэд Ляонин, Фузянь руу явуулдаг ажээ. Түүний зэрэгцээ 2008 онд Лхасын их сургуульд 2,5 мянган хүн элсэн орж, 1,5 мянган хүн төгссөн байна.[1999] ТӨЗО-нд гадаадынхан ирж, түвд хэл болон соёл судлаж, зарим нь энэ сэдвээр эрдмийн зэрэг горилсон зохиол бүтээл бичиж байна. Ингэхлээр түвд хэл одоохондоо мөхөөгүй байна.

Эрх баригчид ардын урлал, туульс, театрыг хадгалан авч үлдэх арга хэмжээ авч байна. 2000 онд Түвдийн номын сан нээгдэж, сайн дурын уран сайхны болон түвдийн театрын 160 гаруй хэсэг, урлагийн төвүүд ажиллаж байна.[2000] Баатарлаг туульсын гайхамшигт бүтээл болох “Гэсэр” судлалд онцгой анхаарал тавьж байна. ТӨЗО-ны засгийн газар баатарлаг туульсыг хадгалж, судлахын тулд 1979 онд тусгай байгууллага бий болгожээ.[2001] Ардын аман зохиолын хэд хэдэн тайлбар эмхэтгэл хэвлэн гаргав. 1980-аад оноос шашны 40 гаруй баяр тэмдэглэдэг уламжлалыг сэргээв.[2002] Уламжлалт баяруудын зэрэгцээ БНХАУ болон дэлхий дахинд тэмдэглэдэг бусад баяр бий болгожээ.

Уламжлалт болон орчин үеийн спорт хөгжиж байна. Лхас, Шигазе хотод хэд хэдэн музей, үзэсгэлэн ажиллаж байна. Тэнд тавьсан үзмэрүүд түвдийн түүхийн тухай, бас “феодал-хамжлагат ёсны харгис” байгууллын тухай өгүүлэх ажээ. Шинээр байгуулсан Гьянзегийн сүмд английн түрэмгийлэгчидтэй хийсэн тэмцэл, мэдээжийн хэрэг феодалын байгуулалд зориулсан музей бий юм. 1999 онд энэ музейг үзсэн нэгэн хүн түүх гуйвуулсан олон тооны үзмэр болон дуурайлгаж үйлдсэн эд өлөгийн зүйлсийг хараад өөрийн эрхгүй инээд алдсан тухайгаа хожим ярьсан байдаг.[2003]

Гэхдээ олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд түвдчүүдэд илүү хүчтэй нөлөө үзүүлж байна. Эдгээр хэрэгсэл өрнөдийн олон нийтийн соёлыг хятад хувилбараар нэвтрүүлж байна. Зар сурталчилгаа, өнгө өнгийн зуурагтай элдэв сэтгүүл, кино, телевизийн болон радио нэвтрүүлэг, дүрс болон дуу бичлэг, элдэв шоу, дискотек, баар цэнгээний газрууд болон бусад шинэ үзэгдэл томоохон хотуудад хүч түрэн орж ирж, хөдөө орон нутагт ч дэлгэрч байна. Хүмүүс хятад шоу улам их үзэх болжээ. Уламжлалт соёл хэрхэн



Шигазе хотын дэлгүүрт тавьсан марксизм-ленинизмын сонгодог онолчдын хөрөгүүд (С.Л. Кузьмины авсан гэрэл зураг)

мөхөж буйг хотуудад харж болно. Энд архидан согтуурах явдал, гэмт хэрэг, гэр бүл салалт, гэрийн хүчирхийлэл, биеэ үнэлэх явдал дэлгэрч байна. Албан ёсны мэдээгээр бол 2000 онд Лхас хотод гэр бүл салалтын түвшин 20 хувьд хүрсэн нь хятадын аль ч нутгийнхаас их байна.[2004] Үүний үндсэн шалтгаан бол эрчүүд архинд донтож, бас гадуур зугаалдаг явдал мөн. Түвдэд эдийн засгийн шинэтгэлийн явцад үр хөврөл нь бүрдсэн караоке-бар, дискотек болон бусад иймэрхүү байгууллагуудад л биеэ үнэлэх явдал газар авч байна. 1990 онд Лхас хотын 18 төв гудамжинд 658 янхны газар, Цетангад 60, 1990-ээд оны дунд үед Чамдолд 15, Дромод 4 ийм газар байжээ.[2005] Үүний гол үндсэн шалтгаан бол хятад эрчүүд олноор орж ирсэн, цэргүүд ч хаа сайгүй байсан явдал мөн бөгөөд эд нарын хэрэгцээг хангахаар хятадаас олон янхан хүүхэн иржээ. Тэд гол төлөв засгийн газрын байгууллагууд, эмнэлэг, сургууль, түүнчилэн дэлгүүр хоршооных нь олонхи хятадуудын мэдэлд байдаг худалдаа арилжааны бүсүүдэд цугларах, бас зарим хятад янхан хүүхэн ариун дагшин газрууд, жишээ нь, Лхас хотын Баркорын гудамжинд уулзалддаг байжээ.[2006] Түвд бүсгүйчүүдийн дунд, сүүлийн үед бүр хөдөө орон нутагт ч биеэ үнэлэх явдал дэлгэрчээ. Тэр хүмүүсийн олонхи нь гэр бүлээ ядуурлаас аврахыг хүсчээ. Биеэ үнэлэх явдалтай хийх эрх баригчдын тэмцэл зарим янхны газрыг хаах төдийгөөр хязгаарлагдах ажээ.




Лхас хот дахь орчин үеийн дэлгүүрүүд (С.Л. Кузьмины авсан гэрэл зурагууд)

"Хятадад төвдийн үндэсний онцлог байдал, уламжлалт соёлд ихэд хүндэтгэн хандаж, тэдгээрийг хамгаалах, сурталчлах, хөгжүүлэх талаар арга хэмжээ авч байна. Шинэтгэлийн хэрээр уламжлалт соёл, урлагт шинэ бөгөөд эрин үеийн үзэл санаа нэвт шингэсэн илүү баялаг зүйлс нэвтрэн орж байна".[2007] Гэтэл эрин үеийн ямар үзэл санаа юм бол? Энэ үзэл санаа амьдралын хэвшлийн уламжлалыг энд тэндхийн жуулчдын сонирхлыг татах, төр улсын нэр хүндийг дээшлүүлэх хэрэглүүр болон хувирахгүй биз? Материаллаг өсөлтийг голлон үздэг бөгөөд үүний тулд боловсон хүчин, түүний дотор орон нутгийн кадр ажилтан хэрэгтэй гэдэг билээ. Үүний тулд л Төвдэд сүүлийн жилүүдэд боловсролыг сайжруулаад байгаа юм биш биз? Энэ салбарт өнөөг хүртэл шийдэгдээгүй зөрчил бий: хятадын үндэсний эв нэгдэл, тогтвортой, аюулгүй байдал нь уусгалт болон нэг хэлтэй байхыг шаардаж байгаа бөгөөд харин улс орон нь олон үндэстнийх гэдгийг хүлээн зөвшөөрөхийн тулд хятад биш ард ттүмий соёлыг хуурамчаар ч гэсэн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болох билээ.[2008]

***Байгаль орчны байдал***

ТӨЗО-ны засгийн газар удаан хугацааны үв тэгш хөгжлийн стратеги зарлан тунхаглаж, хүрээлэн байгаа орчныг хамгаалах арга хэмжээнүүд төлөвлөж

байна.[2009] Орчныг хамгаалах, бохирдолтод хяналт тавих механизм бий болгож, экологийн байгуулалтад их анхаарал тавьж байна. ТӨЗО-нд бүх хятадын болон орон нутгийн чанартай байгаль хамгаалах 18 нутаг дэвсгэр байна. Өндөр уулын байгаль орчны хэврэг тэнцвэртэй байдал, хот, тосгодын амьдрах орчин үндсэндээ хадгалагдан үлджээ. Байгаль орчны бүтцийн хадгалагдан үлдсэн түвшин БНХАУ-д хамгийн өндөрт, дэлхийд хамгийн өндрийн нэгэнт тооцогдоно. Сүүлийн жилүүдэд бүс нутгийн түвшинд ой, зэрлэг амьтан, ургамал хамгаалах, хөдөө аж ахуйг оновчтой хөтлөн эрхлэх тухай, түүхийн болон аялал жуулчлалын хувьд онцгой чухал ач холбогдолтой дурсгалт газрууд, геологийн обьект, байгалийн тогтоцыг хамгаалах тухай хэд хэдэн хууль тогтоомжийн акт болон дүрэм гарч, зохих бүтцүүд байгуулагджээ.[2010] Өөртөө засах орны засгийн газар долоон дархан цаазат газар, 1993 онд нийт 325 мянган ам дөрвөлжин км талбай бүхий бас зургаан дархан цаазат газар байгуулах тогтоол гаргажээ.

Бусад нутагт маш ховорт тооцогдох амьтаны тоо ТӨЗО-нд өнөөдөр олон хэвээр байна. Гэхдээ л асар олон зэрлэг сарлагын сүрэг зэрэг бусад том биетэй сүүн тэжээлтэн амьтан урьдынх шигээ үзэгдэх нь ховор болжээ. Энэ амьтад дархан цаазтай газруудад л үлджээ. Түвдчүүд байгалаа хамгаалахад засгийн газартаа байдаг л чадлаараа тусладаг ажээ. Жишээ нь, чиру гөрөөстэй дархан цаазтай газуудад нутгийн оршин суугчид хулгайн анчдын эсрэг хятадын хуулийг хэрэгжүүлэхийн тулд амь насаа золиослон байж сайн дураар эргүүл зохион байгуулжээ.[2011] Гаднаас ирсэн хулгайн анчдын суманд өртөж нас барсан хүн ч бий юм. Нэгэн ийм эрэлхэг байгаль хамгаалагчийн дурсгалыг хүндэтгэж хөшөөг нь босгожээ.

Гэсэн хэдий ч хятад захиргааны жилүүдэд Түвдийн байгаль орчинд их хохирол учирсан байна. 1949 онд түвдийн эртний ой мод 221800 ам дөрвөлжин км талбайг бүрхэн оршдог байсан бол 1985 он гэхэд 134 мянган ам дөрвөлжин километр болтлоо буурчээ.[2012] Модыг уулнаас ачааны машин болон ердийн булхайгаар цагаалан буулгаж, дараа нь сал тавин хятадад хүргэх замд их алдагдалтай байдаг бөгөөд ой нөхөн сэргээх ажил огт хийгээгүй юм.[2013] Ой мод үгүй болж, хөрсний эвдрэл үүсч, гол горхи хатжээ. X Банчин лам 1987 онд Камд ийм байдал үүссэнийг харжээ: “Өнгөрсөн онд би Камд айлчлахдаа ой модыг их хэмжээгээр ямар ч сонголтгүй хяргасны улмаас тэнд үлэмж хэмжээний газар нутаг цөлжсөнийг олж харсан билээ” гэж онцлон тэмдэглэсэн байна.[2014] Ой модыг хамаагүй хяргасны харгайгаар 1981 онд Сычуаньд их үер болжээ. Тэр үед эрх баригчдын толгойд ой хамгаалах санаа төрсөн ажээ. Мод бэлтгэх ажлыг хатуу дэг журамд оруулж,



Түвдээс хятад руу мод зөөж байна

ой сэргээх ажлыг эрчимжүүлжээ. Одоо жил бүр уулын орой хавийн 140 мянган га газарт модны үр суулгаж, модны өсөлт нь хяргаж унагасныхаас давах болжээ.[2015] Маргаангүй ашигтай энэ үйл ажиллагаанд бас сөрөг тал байгаа нь тариачид болон нүүдэлч малчид өөрсдийнх нь амьдралд удаан хугацааны нөлөө үзүүлэх,эсэхээс үл шалтгаалан түргэн ургадаг тийм төрлийн мод тарих ёстой болж байна.[2016]

Мод бэлтгэлийн ажилд квот тогтоож, жилд 150 мянган шоо дөрвөлжин метрээр хязгаарлаж байна.[2017] Галын түлээг эрчим хүчний бусад эх үүсвэр, жишээлэхэд нарны эрчим хүчээр ажилладаг халаагуур зэргээр орлуулахыг төрөөс хөхүүлэн дэмжиж байна. Одоо ТӨЗО-ны хүн ам тийм төрлийн үнэ өртөг багатай халаагчуудыг өргөн хэрэглэж байна. Хөрсний эвдрэл болон цөлжилттэй тэмцэхэд үлэмж их хөрөнгө мөнгө төсөвлөн гаргаж байна. Үйлдвэрийн газруудад байгаль орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авч байна.

Ариун дагшин Кайлас уул одоо аялал жуулчлалын хэн бүхний мэдэх төв болон хувирчээ. Тэр уулын хормойд зочид буудал, зоогийн газар, зам харгуй байгуулжээ.[2018] Хэрэв урьд өмнө мөргөлчид энэ ууланд байгаа элдэв хог тэргүүтнийг цэвэрлэдэг байсан бол одоо Кайлас уул улам их бохирдож, хогонд дарагдаж байна. 2008 онд эрх баригчид түвдийн талаас Жомолунгма оргилд авирах хүсэлтэй жуулчдын тоог хязгаарлахаар шийдвэрлэжээ. 2007

онд тийм авирагчид 120 тонн хог саг орхиод явжээ.[2019] Жирийн үед бол хамгаалахгүй орхиж болох байсан газруудын хамгаалалтыг эдийн засгийн үндэстэй болгож байгаад л аялал жуулчлалын бизнесийн томоохон ашиг тус оршино.

Түвдийн нутаг дэвсгэрийн үлэмж хэсэг буюу 68,1 хувийг малын билчээр болгон ашиглаж болох, бас тариан талбай болгон хагалж ч болох нугархаг нутаг эзэлж байна. Түвдэд улам олноороо ирж буй хятад хүн амыг тэжээхийн тулд эрх баригчид малын сайхан билчээрийг тариан талбай болгон хувиргаж байна.[2020] Үүнээс болж газар хатаж, малын билчээрт ч, тариан талбайд ч хэрэггүй болж, Амдод асар өргөн уудам ийм нугархаг нутаг цөл болон хувирчээ. Энд жил бүр 60 мянган га газар цөлжиж байна.[2021] Бээжингийн их сургуулийн нэгэн эрдэмтэний мэдээгээр бол 1996 онд түвдэд 20,47 сая га газар цөлжиж, бас 1,36 сая га газар ийм аюулд нэрвэгдэхэд бэлэн байна. Байгаль орчны систем эвдэрч муудахад хүний хүчин зүйлээс гадна уур амьсгалын өөрчлөлт, тухайлбал дэлхий нийтийг хамарсан дулаарал “хувь нэмэрээ” оруулж байна.

Эрх баригчид усжуулалтын систем байгуулж, усны эх үүсвэрүүдийг хамгаалж, билчээрийг зохистой ашиглах, олон наст ургамал тариалан малын билчээр бий болгож, элдэв төрлийн хортонтой тэмцэж, малчдын сайн сайхан байдлыг дээшлүүлж, тэднийг суурин амьдралд шилжүүлж байна.[2022] Гэхдээ билчээрийг зөв зохистой ашиглах явдал малчдын уламжлалт арга, харин усжуулах, хортон шавьжтай тэмцэх, нүүдэлчдийг суурин амьдралд шилжүүлэх нь түр зуурын сайжрал өгч байгаа юм. Уламжлалт хэвшил үгүй болж, мал аж ахуй эрхлэх явдал эрчимжсэний дараа байгаль орчны систем улам түргэн эвдэрч эхэлсэн байна. Сүүлийн жилүүдэд нугархаг нутгийг сэргээх хөтөлбөр хэрэгжүүлж: газрын зарим хэсгийг эргэлтээс гаргаж, тариачид болон нүүдэлч малчдыг өөр газарт шилжүүлэн суулгаж, тэдний алдагдлыг нөхөн олгож байна. Гэвч экологийн байр сууринаас авч үзвэл “байгаль орчны шилжих хөдөлгөөн” зохион байгуулснаас байгаль ашиглах уламжлалт хэлбэр болон амьдралын хэвшлийг хадгалан үргэлжлүүлэх нь илүү оновчтой зүйл болж байна. Аж үйлдвэрийн хөгжил болон цэрэгжилт байгальд онцгой хохирол учруулж байна. Хөх нуур мужид уул уурхайн олборлох болон нефтхийн аж үйлдвэр, эрчимжсэн хөдөө аж ахуй байгаль орчинд маш хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна.[2023] Хөх нуурын ус тариалангийн талбайн усжуулалтаас болж багасч: түүнд цутгадаг голуудын 85 хувь орчим нь хатжээ.[2024] Хатсан нуурын ёроолын тунсаа, давсыг ил аргаар олборлож, муу зохион байгуулалттай алт олборлох ажил үргэлжилж

байна.

Бүх дэлхийн зэрлэг байгалийн сангийн мэдээгээр бол хамгийн муу байдалд орсон дэлхийн арван голын дөрөв нь түвдийн Дричу, Гьелмо Нгнулчу, Цачу ба Сенгье Хабаб голууд байна.[2025] Далан байгуулах ажил, бохирдол, загас хэт олноор барих явдал болон уур амьсгалын өөрчлөлт гол аюул болж байна. Хятадад голын урсгал, хур тундасны түвшин, усны нөөц багасч байна. Хятадууд түвдийн ой модыг устгасан явдал энэ хямралд гол нөлөө үзүүлжээ. Тэгвэл одоо хятад улс усныхаа асуудлыг түвдийн нөөцөөр шийдвэрлэж байна.

Хөдөөгийн оршин суугчдыг ундны цэвэр усаар хангах явдал чухал зорилт болж байна. Түвдийн голууд урсгалынхаа доод биеэр Инд, Брахмапутра, Меконг, Хөх мөрөн, Шар мөрөн зэрэг азийн томоохон голууд болдог ажээ. Эдгээр гол мөрд зөвхөн хятадууд биш янз бүрийн орны ард түмэнд ашиглагдах ёстой билээ. Түвдийн өөртөө засах орон болон Хөх нуур мужид усан цахилгаан станц байгуулснаас болж их хэмжээний талбай усанд автаж, станцуудаас цааш урсах голуудын ус татарч ширгэхэд хүрч байна. Ийм нөхцөлд улс орны зүүн хойт зүгт ус урсгах “Аугаа их баруун зам” хэмээх төлөвлөгөө боловсруулжээ.[2026] Хэрэв энэ төлөвлөгөө хэрэгжвэл байгаль орчны тэнцвэр их хэмжээгээр алдагдаж, түвдчүүд олноороо шилжин суурьшиж, хэд хэдэн ариун дагшин газрууд усанд автах аюул нүүрлэж байгаа юм. Энэ төслийг хилийн чанадад болон БНХАУ-д эсэргүүцэж байна.

Түвдэд олон цөмийн цэнэгт хошуу байрлуулж, түвдийн өндөрлөг хэмжиж тогтоохын аргагүй цацраг идэвхт хаягдлаар бохирдож байна. [2027]

Хөх нуураас холгүй орших Нэйбэйд ийм хаягдал бүхий том “хэрэгсүүр” бий. Хэд хэдэн газраас уран олборлож байна. Канхо тойргийн Тхево гэдэг газарт томоохон уурхайнууд бий юм. Тэр хавийн газар бохирдсоноос болж түвдчүүд болон тэдний мал адгуус үл мэдэгдэх өвчнөөр үхэж, элдэв гажигтай хүүхэд олон төржээ. Цайдамын сав газарт, Ямдог цо нуур болон Дамшунгд ураны уурхай байна. Эдгээр газрыг цэргийнхэн хамгаалдаг учир тодорхой мэдээлэл тун ховор ажээ.

Газрын ховор элементийн хэд хэдэн орд газар илрүүлсэн боловч тэдгээрийг олборлох төлөвлөгөө хэлэлцэхэд орон нутгийн Түвд хүн амыг оролцуулдаггүй байна.

Дүрвэгчид байгаль орчин сүйдэж байгаа тухай баримт мэдээлэл дурдахад БНХАУ-ын эрх баригчид тэднийг “түвдийн хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах талаар анхаарал тавьж буй мэт дүр эсгэсэн энэ

хүмүүс үнэн хэрэгтээ бол Түвдийн нийгмийн дэвшил, шинэчлэлийн үйл явцыг саатуулж, олон нийтийн санаа бодлыг түвдийн хоцрогдсон феодал хамжлагат ёсны байгууллыг сэргээн засварлаж, хятадын ард түмнийг хагаралдуулах гэсэн улс төрийнхөө зорилгод хандуулахыг л хүсч байгаа юм" гэж буруушааж байна.[2028] Гэтэл Түвдийн байгаль харьцангуй муу биш байгаагийн шалтгаан бол түвдчүүдэд олон зууны туршид байгальтайгаа зохицон амьдрах нөхцөл бүрдүүлсэн байгалиа түшч амьдрах уламжлалт систем мөн. Тийм уламжлал феодал-шашны байгууллын салшгүй хэсэг юм. Энэ байгуулал байгаль хамгаалах тухайд социализмаас ч, капитализмаас ч илүү байсан нь маргаангүй билээ.

Түвдийн байгаль газрыг эрчимтэй биш аргаар ашиглах, хүн амын тоо цөөн байх, байгаль орчны системд аль болох бага ачаалал өгөхийг шаардаж байна. Байгаль хамгаалах талаар авч хэрэгжүүлж буй төрийн арга хэмжээнүүд эрчимтэй аж ахуй, байгаль орчны хямралын нөхцөлд Өрнөдөд боловсруулсан аргачлалд нийцэж байх ёстой юм. Тэгвэл түвдэд тийм хямрал болоогүй, эрхэлж буй аж ахуй нь эрчимжиж чадаагүй юм. Хятадын хүрээнд ч, түүний гадна талд ч түвдийн тогтвортой хөгжлийн цорын ганц зөв зам бол эрэлт хэрэгцээ, уламжлалтай нь илүү сайн зохицсон хөгжлийн тэр л загварыг нэвтрүүлэх боломжийг энэ орны оршин суугчдад олгох явдал мөн. Тухайлбал нүүдэлчдийг суурин амьдралд шилжүүлж, "экологийн шилжилт" зохион байгуулахын оронд тэдэнд амьдралынх нь ердийн хэвшил, байгаль ашиглах уламжлалыг нь хэвээр үлдээх явдал илүү оновчтой юм. Түвд орон газар ашиглах уламжлалт аргадаа эргэж очих ёстой бөгөөд энэ нөхцөлд хүн ам нь өндөрлөг нутагтаа тархай суурьшиж, газар ашиглах арга ч эртнээс заяагдсан хил хязгаартаа мөн тархай,үв тэгш зохицсон байх ёстой юм.[2029] Бүс нутгаа ахимсын нутаг дэвсгэр хэмээн зарлах гэсэн Далай ламын санал оновчтой сонсогдож байгаа юм.

***Эдийн засаг***

Түвдчүүдийн 80 шахам хувь нь хөдөө нутагт сууж байна. Түвдчүүдийн эдийн засагт хөдөө аж ахуй чухал үүрэг гүйцэтгэж байна. Соёлын хувьсгал түвдийн хөдөө нутагт хүнд өв үлдээжээ. 1977 онд нэг Түвд хүнд 90–120 кг арвай оногдож байв. Түвд жил бүр 30 мянган тонн орчим үр тариа гаднаас авахад хүрч байв.[2030] Ажиллах хүчин болон малыг үнэ хөлсгүй хэрэглүүлж байсан юм гэж хятадын хэвлэлд тэмдэглэжээ. Хэд хэдэн газарт ардын гар урлалыг хориглож, амины аж ахуйг зохицуулж байв. Энэ бүх байдлыг

засахын тулд төв засгийн газар тогтоол гаргаж, шалган байцаах ажил явуулжээ. Гэхдээ эдгээр арга хэмжээ зарим нэг үр дүн өгснөөс хэтэрсэнгүй. Үр тариа хүрэлцэхгүй байсан явдлыг хаа сайгүй газар хагалах явдлаар нөхөх гэж шийдсэн байна. Түвдэд хэрэгжүүлсэн арга хэмжээ бол нийт хятадын кампанит ажлын нэг хэсэг бөгөөд түүнийг төвөөс өгсөн зааврын дагуу хэрэгжүүлэв. ТӨЗО-ны нийт ажиллах хүчний тэн хагас гаруйг худаг ухах, суваг шуудуу татах, услалтын систем байгуулахад дайчилжээ. Энэ бүх ажлыг: “Ус багатай газарт усжуулалт хэрэгтэй, газар багатай нутагт атар хагалах хэрэгтэй” гэсэн зарчмын дагуу явуулсан байна.[2031]

1979 онд эрх баригчид “үр тарианы үйлдвэрлэлийг гол болгон авч үзэх” чиг шугамаас татгалзав. Ядуу коммунуудад туслах ажил газар сайгүй өрнөв. ХКН-ын төв хорооны 3-р бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор зарлан хийлгэсэн ТӨЗО-ны ХКН-ын хорооны бүгд хурал 1979 оны гуравдугаар сард болов. “Дөрвөн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд Түвдийн бодит байдлыг бүх талаар харгалзан үзэх” гэсэн лоозон гол зүйл болов.[2032] Олон салбарт хөдөө аж ахуйд, мөн мал аж ахуйг үл тоомсолрлох явдал дахин гаргахгүй байхад гол анхаарал тавих болов. Хувиарлалтыг хориглов. Коммунуудын 30 хувьд хүмүүс 1960-аад оны дунд үеийнхээс дор аж төрж байгааг, бас 30 хувьд нь орлого өөрчлөгдөөгүйг 1980 онд ТӨЗО-ны засгийн газрын орлогч дарга хүлээн зөвшөөрчээ. ТӨЗО-нд 150 мянган хүн ядуу аж төрж байгааг тэрээр мөн хүлээн зөвшөөрсөн байна. Гэхдээ тэр жилүүдэд гаргасан хятадын өөр нэг дүгнэлтээр бол 300-350 мянган хүн ядуу амьдарч байжээ. Өөрөөр хэлбэл феодализмыг түлхэн унагаснаас хойш 20 жилийн дараа түвдчүүдийн гуравны нэг гаруй нь ядуу амьдарч байв. Төрөөс үзүүлэх тусламжгүйгээр амьдарч чадахгүй байгаа тэр хүмүүсийг л дээрх бүлэгт оруулжээ. Ингэхлээр бодит байдалд ядуучууд илүү олон байжээ.

Хөдөө аж ахуйн талаар баримтлах чиг шугам байнга өөрчлөгдөж: 1979 он хүртэл “газар тариаланг гол зүйл болгож”: нөхцөл байдлаас шалтгаалан (1979–1987) газар тариалан буюу мал аж ахуй эрхлэх, аль алиныг нь хослуулах, гэхдээ мал аж ахуйг голлох (1984 он) чиг шугам дэвшүүлжээ. ТӨЗО-ны засгийн газар 1984 оны тавдугаар сарын 1-нд хөдөө аж ахуйг либеральчлах талаар авах есөн арга хэмжээний тухай: тариачдыг газрын болон малын татвараас чөлөөлснийг 1990 он хүртэл сунгах,тэдгээрийн аж ахуйн бие даасан байдлын эрхийг баталгаажуулах, газар эзэмших гэрээг сунгах (30-50 жил), хөдөө аж ахуйн аль нэгэн үйл ажиллагаанд албадах, дээрээс төлөвлөгөө өгдөгийг зогсоох тухай зарлав.[2033] Энд амины аж ахуйнуудын тухай биш, харин үйлдвэрлэлийн хэрэгслийн зарим хэсгийг

л бүрэн өмчилдөг аж ахуйнуудын тухай яригдсан бөгөөд газар болон билчээрийг зүгээр л ашигладаг, тэдгээр нь “нийгмийн”, өөрөөр хэлбэл төрийн өмч байсан юм.

Өвс ургамал сайтай нугархаг газруудын жижиг, жижиг хэсгийг гэр бүлүүдийн дунд хувиарлаж өгсөн нь мал сүргийн билчих газрыг эрс багасгаж, билчээрийн ашиглалт зөрчигдөх аюул бий болгов.[2034] Нүүдэлчдийг суурин амьдралд шилжүүлж эхлэв. Энэ нь нүүдэлчдийн билчээр сэлгэн нүүх боломжийг хязгаарлаж, мал сүрэг хязгаарлагдмал орон зайд төвлөрч, билчээр амархан талхлагдахад хүргэжээ.

1984 оны наймдугаар сард ХКН-ын төв хорооны нарийн бичгийн дарга, Төрийн зөвлөлийн орлогч дарга нар амины аж ахуй, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд гол анхаарал төвлөрүүлэх хэрэгтэйг хүлээн зөвшөөрөв. Энэ зорилго өөд урагшлахын хэрээр түвдийн уламжлалт мал аж ахуй улам бүр арилжааны шинж чанартай болов.[2035] Нэг хэсэг нүүдэлчид устай билчээр, нөгөө хэсэг нь усгүй билчээр авч байлаа. Өмч хувьчлах үед билчээр хувиарлаж, түүнийг зааглах нь хэрүүл маргаан, мөргөлдөөн үүсгэдэг байна. 1977–1999 онд Ганьсу, Хөх нуур мужид ийм мөргөлдөөний улмаас 27 Түвд хүн амь эрсэджээ. Сүүлийн үед газрыг хувиараа болон хамт олноор ашиглах хүрээнд янз бүрийн стратеги баримтлах боломж боловсруулж байна. Сүүлийн жилүүдэд билчээрийн зарим хэсгийг сэргээх зорилгоор эргэлтээс гаргаж байна. Тариачид болон нүүдэлчдэд хэдэн жилээр мөнгө болон үр тариагаар нөхөн төлөөс олгож байгаа бөгөөд энэ хугацаанд тэд өөр ажил олох ёстой боловч тэр болгон бүтдэггүй ажээ.[2036] Олон гэр бүлийг өөр нутгууд руу шилжүүлэн суулгажээ. Дүүрэг хотуудад жижиг суурингууд байгуулж, тэнд нүүдэлчид хэдэн жил тэтгэлэгээр амьдарч болох аж. Билчээрийг сэргээсний дараа малчид хуучин газартаа эргэж очиж болно.[2037] “Экологийн шилжилт” Хөх нуур, Сычуань мужид өргөн дэлгэрчээ.

Бас нэг бэрхшээл бол феодалын засаг аль хэдийнэ коммунист засгаар солигдсон ч зарим газарт өшөө хонзон авах явдал болон өөр хоорондын тэмцэл хадгалагдаж үлдсэн явдал юм. Нүүдэлчид хэрүүл маргаан таслах үед том тушаалын лам нарыг зуучлагч болгож ашигласан хэвээр байна.[2038] Жишээ нь, нүүдэлчин голокуудын нутагт хятадууд маш цөөн (9 мянга, харин түвдчүүд 126 мянга).[2039] Тэдний нийгэм-улс төрийн бүтцийн үндэс нь өнөөг хүртэл рукор буюу 35 айлаас бүрдсэн нүүдлийн лагерь ажээ. Хэрэв нэг айл малд явах хүн хүрэлцээ муутай, нөгөөд нь дэндүү олон хүнтэй, мал бага байвал тэд харилцан туслах зорилгоор нэгддэг байна. Голокуудын хүч

ба сул тал нь отог омгийнхондоо зүй ёсоор ханддаг, харин өөр омгийнхныг үзэн яддаг явдал мөн. Тэгвэл одоо тэдний нийгмийн байгуулалт аюулд ороод байна. 1970–1980-аад онд хуурай уур амьсгалтай Голок тойрогт бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдүүлэхийг хөхүүлэн дэмжиж байлаа. Малын тоо толгой эрс өсөв. Сүргийн тоо олон болсноос шалтгаалан билчээр талхлагдах аюул тулгарсан нь нэг ноцтой асуудал болсон нь ойлгомжтой.[2040] Тиймээс малын тоо толгой нэмэгдүүлэхийг урьтал болгохгүй, билчээрийг хамгаалах болсон байна. Одоо Голок (Амдо), Нгабад (Сычуань) байгалиа хамгаалахын тулд малынхаа билчээрээс салсан хүмүүс эгнээ эгнээгээр жирийлгэн барьсан нэг хэвийн байшингуудад аж төрөн амьдарч байна.[2041] Голок, Юйшу тойрогт нүүдэлчид билчээрийнхээ 40 хувийг ашиглаж чадахгүй байна. Үлдсэн 38 хувьд сүргийн хэмжээг хоёр дахин багасгах тушаал өгсчээ. Нуга,билчээрийг оновчтой ашиглах талаар зуун зуун жилээр шалган боловсруулсан системийг үр нөлөөгүй аргаар ийнхүү сольжээ. БНХАУ-ын шинэ хууль тогтоомжууд голокуудыг хоосолж байна, яагаад гэвэл эрх баригчид мал аж ахуйн асуудлаар шийдвэр гаргахад оролцох голокуудын эрхийг булааж авчээ.

1990-ээд онд Цанпо, Нагчу голуудын сав газрын төв хэсгийг эзэмших ажил эхэлжээ. Тэнд ТӨЗО-ны хүн амын үндсэн хэсэг аж төрдөг, хөдөө аж ахуйн үндсэн талбайнууд байдаг юм.[2042] 593 мянган га-д усжуулах ажил хийхээр болж, ТӨЗО-нд 1959 онд 182,9 мянган тонн үр тариа хурааж байсан бол 2007 онд 938,6 мянган тонныг хурааж авчээ: нэг му-гаас (15 му нь 1 га-тай тэнцэнэ) хураах үр тарианы хэмжээ дунджаар 355 кг-аар нэмэгджээ.[2043] Тийнхүү ТӨЗО үндсэндээ өөрийгөө хүнсээр хангах болсон байна.

Янз бүрийн бэрхшээл байсан хэдий ч хамт олныхоос амины хөдөө аж ахуйд шилжсэн явдал нааштай үр ашгаа өгсөн байна. Түвдэд өлсгөлөн гэж үгүй болж, амьжиргааны түвшин байнга дээшилж байна. 2006 онд ТӨЗО-ны татварын орлогод хөдөө аж ахуйн хувийн сектороос орсон хөрөнгийн хэмжээ анх удаа хамт олны болон нийгмийн өмчийн үйлдвэрийн газруудынхаа давжээ.[2044] Мал сүрэг өрхийн өмч болов. Түүний зэрэгцээ улам олон Түвд тариачин газраа хятад шилжин суурьшигчдад хөлсөлж, тэд ч хотуудад улам олноор ирэх хятад хүн амын хүнсний ногооны хэрэгцээг хангах болжээ. Эрх баригчид олон тариачинг өөр газарт нүүлгэн суурьшуулж, тэдний удам дамжин эзэмшиж ирсэн газрыг хятадуудад шилжүүлэн өгч байлаа.

Сүүлийн жилүүдэд ТӨЗО-нд БНХАУ-ын засгийн газраас олгох тэтгэлэг жил бүр 1,2 тэрбум юаниас давах болов.[2045] 2000-аад оны дунд үед тэнд 260 гаруй улсын үйлдвэрийн газарт 51 мянган хүн ажиллаж байв.[2046]

Хятад голдуу хувийн бизнес эрхлэгчид улам олон болов. Олборлох, мод боловсруулах, хөнгөн ба хүнсний аж үйлдвэр, барилгын салбар хөгжиж байна. Улам олон уурхай ашиглалтад орж байна. ТӨЗО-ны статистикийн газрын мэдээгээр бол 2007 онд эндхийн дотоодын нийт бүтээгдэхүүн 34,22 тэрбум юаньд хүрсэн бол 1959 онд энэ үзүүлэлт дөнгөж 174 саяд хүрч байжээ.[2047] ТӨЗО-ныг шинэчлэх ажлыг үндсэнд нь дуусгаж, түүнийг аялал жуулчлалын томоохон район, байгалийн дархан цаазат газар, Түвд эмнэлэгийн эмийн ургамал үйлдвэрлэх газар, БНХАУ-ын баруун өмнөд нутгийн ховор болон үнэт металл олборлож, дахин боловсруулах томоохон бааз газар болгохоор төлөвлөж байна.

Эрчим хүчний үйлдвэрлэл, холбоо, тээврийн дэд бүтэц эрчимтэй хөгжиж байна. 2008 он гэхэд 500 гаруй цахилгаан станц баригдаж, цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын тоо 1,85 саяд хүрсэн нь ТӨЗО-ны хүн амын 66 хувь болжээ.[2048] Ард түмний саналыг авалгүйгээр Усан цахилгаан станцууд барьж байна. Жишээлэхэд, Ямдог цо нууран дээр усан цахилгаан станц байгуулах нь түвдчүүдэд илүү их тааламжтай байдал бий болгоно гэж хятадууд мэдэгджээ. Түвдчүүд тэдний тэдний удирдагч X Банчин лам, Агваан Жигмэд нар эсэргүүцэл илэрхийлж станц барих ажлыг хэдэн жилээр саатуулсан нь энэ төсөл байгаль орчинд хортой нөлөө үзүүлэх, бас хүн амын шашны үзэл бодолд харшилж байсантай холбоотой юм. Гэвч станц барих ажлыг эхлүүлжээ. 1990-ээд онд ХАЧА-ийн 1500 цэрэг станцийн барилгын ажлыг хамгаалж, энгийн иргэдийг түүний ойр орчимд ч оруулахгүй байв. Олон Түвд айлыг нүүлгэн шилжүүлэв.

2007 онд Карзе тойргийн ариун дагшин уулыг аж үйлдвэрийн аргаар ашиглахыг эсэргүүцсэн түвдчүүдийг шийтгэсэн тухай мэдээлж байв.[2049]

1995 оны наймдугаар сараас 1996 оны арванхооёрдугаар сард Лхас хотын ойролцоо Гонкарын нисэх онгоцны буудал, 1994 оны есдүгээр сард Чамдод Помдагийн нисэх онгоцны буудал, 2006 оны долдугаар сард Энэтхэг, Бирмтэй залгаа хил дээр Ньингтрийн нисэх онгоцны буудал байгаалав.[2050] Бас хэд хэдэн ийм буудал байгуулахаар төлөвлөж байна. Түвд, хятадын хооронд үйлдэх 10 нислэг, Катманду хот руу үйлдэх олон улсын нэг нислэг нээв.

Түвдийг "чөлөөлсөн" өдрөөс эхлэн засмал зам тавих ажил эрчимжив. Төлбөртэй ажил хөлсгүй болов. Бүр 1980-аад оны дунд үед бид гэр бүлээрээ зам тавих ажилд оролцдог байсан гэж У-Цанг, Камын Түвд дүрвэгчид ярьжээ. Ингэсний төлөө цалин хөлс авдаггүй, хоол ундаа ч өөрсдөө авч ирдэг байжээ. "Чөлөөлөгдсөн" хөдөлмөрөөс татгалзсан хүмүүсийг баривчлах ажээ. 1997

оноос Драяб хошуунд “Ядуу, хоцрогдсон түвдчүүдийг цэцэглэл хөгжил өөд татах нь” хэмээх уриан дор эрх баригчид хүмүүсийн хөдөлмөрийг үнэ хөлсгүй ашиглав. [2051] Энэ ажилд орон нутгийн 18–60 насны бүх Түвд хүн оролцсон байна. 12-16 насны хүүхдүүд эцэг, эхдээ тусална. Нийгмийг аюулаас хамгаалах товчооны офицерууд хүмүүс хэрхэн ажиллаж байгаад хяналт тавина. Зам тавих, байшин барих, мод унагах гээд хүнд ажлыг үдийн цай уух 15-хан минутын амралттайгаар өглөөний 8-аас оройн 18 цаг хүртэл, заримдаа түүнээс ч орой болтол хийнэ. Эхний хагас жилд ажилчид нэр төрийн төдий цалин хөлс авч байсан ч удалгүй тэр бага мөнгөө ч өгөхөө больжээ. Тариачдыг дунджаар хагас жилийн хугацаагаар аж ахуйгаас нь хөндийрүүлнэ. Ажиллах цагийн хуваарь гэж байхгүй, жилийн улирлаас үл шалтгаалан ямар ч үед хүмүүсийг дуудаж ажиллуулах ажээ. Дуудахад нь очиж ажиллаагүй хүмүүс сард 300 юаны торгууль төлнө. Орон нутгийнхны хувьд энэ бол дэндүү их мөнгө. Ийм болохоор нэг бол ажиллах, үгүй бол гоёл чимэглэлийнхээ зүйлсээс эхлээд идэх хоолоо хүртэлх бүх эд хөрөнгөө худалдах ийм л хоёр зам байх ажээ. Зарим хүн гуйлга гуйхаар Лхаст очих боловч нийгмийг аюулаас хамгаалах товчооныхон тэднийг буцааж ажилд нь оруулна. Энэ бүх бүтээн байгуулалтын ажил бидэнд биш, хятадуудад л хэрэгтэй юм гэж түвдчүүд ярьдаг байв.

2000 он гэхэд ТӨЗО-ны засмал замын урт 22 мянган км, 2008 он гэхэд 48,6 мянган км-т хүрчээ. Асфальтан хучилт маш сайн. Авто зам одоо өөртөө засах орны олонхи тосгоноор дайран өнгөрч байгаа боловч тэнд нийтийн тээврийн систем бараг үгүй юм. Түүний оронд морь, илжиг, сарлаг, луус ашиглана. Ачааны машин болон бага оворын трактор ердийн тээврийн хэрэгсэл болсон байна.

БНХАУ-ын засгийн газрын эртнээс төлөвлөсөн нэг төсөл бол төвийн районуудаас Лхас хүрэх төмөр зам тавих явдал байлаа. 2006 оны долдугаар сард энэ төмөр зам түвдийн нийслэл хүрэв. Мөсөн гол, мөнх цэвдгийн бүсэд тавьсан энэ төмөр зам бол хятадын инженерийн урлагийн томоохон ололт мөн. Энэ бол дэлхийн хамгийн өндөрлөг газарт байгуулсан төмөр зам бөгөөд далайн түвшнээс 4 мянган метрээс дээш өндөрт 960 км үргэлжилж, замын хамгийн өндөр цэг 5072 метрт, 550 гаруй км урт хэсэг мөнх цэвдэгийн бүсээр дайран гарч байна. Америкийн “Женерал Электрик” пүүсийн дизель хөдөлгүүрт зүтгүүргүйгээр энэ замаар явах боломжгүй юм.[2052] Суудлын вагонууд хүчилтөрөгчийн маскаар тоноглогдсон,цонхны давхар шил хэт ягаан туяанаас хамгаална. Одоо Бээжингээс галт тэргээр гарч өөр галт тэргэнд шилжиж суухгүйгээр Лхас хот орж болно. Өдөр бүр Синин-



Карзегийн цэргийн тусгай шинэ бааз (2009 TibetInfoNet/permission of the photographer)

Лхасын хэсэгт хоёр чиглэлээр суудлын найм, ачааны есөн галт тэрэг явж байна. 2007 оны есдүгээр сарын 28-нд Нагчу хотын районд тээврийн төв байгуулах ажил эхэлсэн бөгөөд энэ бол дамжин өнгөрөх чухал төв болох учиртай юм.[2053]

2002 онд ТӨЗО-ны хүн амын 81,7 хувь нь радио сонсдог, 80,1 хувь нь телевиз үздэг болсон тухай Синьхуа агентлаг мэдээлсэн байна. Одоо энэ үзүүлэлт 100-д ойртсон байх ёстой. 2002 онд хятад улс Түвдийн тухай мэдээлэл тараах өрнөдийнхний монополь байдлыг таслахын тулд “Түвдийн тухай тоо баримт” нэртэй Интернет-сүлжээ бий болгохоор шийдвэрлэжээ.[2054] Хятад интернет-сайтын тоо өсөв. Лхасаас Шигазе, Ньингчи, Чамдо болон бусад нутаг руу шилэн хоолойн кабель тавьсан байна. 2002 онд Түвд рүү явуулах хятадын телевиз, радио нэвтрүүлгийг өргөжүүлэв. Түвд хэлээр явуулах радио нэвтрүүлэг хоногт 9-17 цаг хүртэл нэмэгдэв.

Ийнхүү Түвд орон алслагдсан, тусгаарлагдсан байдал одоо хятад улс түүнийг эзэмшихэд саадтай биш болжээ. Сүүлийн жилүүдэд түвдийн эдийн засагт хувийн сектор цэцэглэж, хөрөнгө оруулалт өсч байна. Энэ нь үндсэндээ хятад бизнес эрхлэгчдэд хамаарч байгаа юм. Хятад бизнес эрхлэгчид илүү туршлагатай, бас хятадын зах зээлд орох боломжтой учир эдийн засгийн гол гол салбарт хяналтаа тогтоожээ. Сүүлийн хорин жилийн эдийн засгийн бодлого Түвдийг Хятадын бүрэлдэхүүнд интеграцчилахад чиглэжээ.

### *Цэрэгжилт*

"Энх тайван чөлөөлөлт" дуусмагц л ХАЧА-ийн томоохон хүч түвдэд оржээ. Зарим газарт орон нутгийн хүн амыг хөөж, оронд нь хятад цэргийн анги, нэгтгэлүүд оруулав.[2055] 1986 он хүртэл БНХАУ цэргийн 11 тойрогтой байснаас

Түвд гуравынх нь хяналтад байв.[2056] 1986 онд тойргийн тоог долоо хүртэл цөөрүүлж, Түвд Чэндуд төв байртай зүүн өмнөдийн цэргийн тойрог, Ланьжоуд төв байртай Ланжоугийн цэргийн тойргийн хяналтад орсон байна. Эхний тойрогт ТӨЗО, Карзе, Нгаба, Дэчин, Мили, хоёрдугаар тойрогт Хөх нуур, Канлхо, Пари оржээ. Түвдийн цагаач засгийн газрын гаргасан тооцоогоор бол 1990-ээд онд Их Түвдэд 500 мянга орчим хятад цэрэг, офицер байжээ. ТӨЗО-нд ХАЧА-ийн 40394 цэргийн албан хаагч байсан гэж хятадын албаны хүмүүс нотолдог юм. 1990-ээд онд ТӨЗО-нд цэргийн зургаан дэд тойрог байв. Эдгээрт явган цэргийн хоёр дивиз, хилийн зургаан хороо, хилийн таван батальон (суман), их бууны гурван хороо, барилгын гурван хороо, холбооны гол төв, холбооны хоёр хороо, тээврийн гурван батальон, нисэхийн дөрвөн бааз, агаараас эмсэргүүцэн хамгаалах хоёр хороо, туслах цэргийн хоёр дивиз, нэг хороо, ардын цэргийн цагдаагийн нэг дивизион, зургаан хороо, пуужингийн арванхоёр дивизион, радарын арвандолоон станц, байлдааны арвандөрвөн нисэх онгоц, пуужингийн таван бааз байсан бөгөөд эдгээр баазад бусад зэвсгийн зэрэгцээ тив хоорондын найман баллистик пуужин байжээ.

Амдогийн цэргийн томоохон баазууд Синин, Чахе, Кармуд байна. Энэ гурван газарт мөн нисэхийн баазууд бий.[2057] Камд цэргийн байгуулалт Литан, Карзе, Таву, Дарцедод төвлөрчээ. Түүнээс гадна агаараас эсэргүүцэн хамгаалах постууд, нисэх-буух нууц талбайнууд байгуулжээ.

Хятад улс Дхашуд (хятадаар Хайянь) цөмийн зэвсэг үйлдзвэрлэх төвүүдтэй, тэдгээр нь Цочангийн Түвд тойрог, мөн Амдогийн Тонгхор буюу хятадаар Хуанньюаньд байрласан гэж үздэг юм байна. Цөмийн зэвсэг боловсруулж, үйлдвэрлэх хятадын анхны үйлдвэрийн газрыг 1960-аад оны эхээр Дхашуд зохион байгуулжээ.[2058] Вашингтонд төвтэй "Түвдийн төлөө олон улсын кампани" байгуулллагаас бэлтгэсэн "Цөмийн түвд" хэмээх илтгэлд дурдсанаар энэ үйлдвэр Хөх нуурын эргээс холгүй газарт байгаа ажээ. Энэ төвийг цөмийн зэвсэглэл боловсруулж, бий болгох асуудал эрхэлсэн баруун умард академи буюу "9-р академи" хэмээн нэрлэдэг ажээ. 1970-аад онд чухам энд л хятадын атомын бүх бөмбөгийг бүтээжээ.

Пуужингийн баазууд Хөх нуураас өмнө зүгт, Нагчукаас баруун хойш байна. 1971 онд түвдийн өндөрлөгт анхны цөмийн зэвсэг хүргэж, Цайдамын сав газарт байрлуулжээ. Өнөөдөр хятадын цөмийн цэнэгт хошууны нэг хэсэг түвдэд байна.

Хятадын анхны атомын бөмбөг үйлдвэрлэсэн Цочангд жуулчдын бааз нээх болсон тухай 2007 онд зарлажээ.[2059] "Энэ бааз аялал жуулчлалын нэг гол газар болж, Хятадын ард түмнийг хүмүүжүүлж, тэдний эх оронч санаа бодлыг дэмжих талбай болон хувирна" гэж хошууны засгийн газрын дарга Зо Сюйминь мэдэгджээ.

Хятадууд энэтхэгийн зүүн хойт зүгийн Аруначал-Прадеш муж улсад нисдэг тэрэг бууж, нисэх талбай байгуулсан нь энэ муж улсын нутаг дэвсгэрийг БНХАУ-ын нэг хэсэг хэмээн үздэгтэй холбоотой юм. Энэтхэг улс цэрэг явуулав. Нэг долоо хоног хэртэй маргалдсаны эцэст хоёр тал цэргээ албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хил хязгаартаа татжээ. Маргаантай нутаг дэвсгэрт хүмүүс байлгахгүйгээр талууд тохирсон байна. 2006 оны нэгдүгээр сард БНХАУ-ын гадаад явдлын яамны төлөөлөгчид энэ муж улсад Энэтхэгийн ерөнхий сайд очсон явдалд дургүйцэл илэрхийлжээ.[2060] Хятадын цэргийн албан хаагчид "энэтхэгчүүд оршин суугаагүй газар болгон энэтхэгийнх биш, бидэнд оногдох ёстой" хэмээх шалтаг заан энэ муж улсын зарим хэсэгт урьд өмнө ч нэвтрэн ордог байжээ.[2061] Бүр 1956 онд өөрсдийнх нь газар нутагт өнгөлзсөн хятадуудын тухай сонссон орон нутгийн оршин суугчид хятадын биш, харин Энэтхэгийн мэдэл дор аж төрөхийг хүсч буйгаа мэдэгдэж байжээ. Өдөөн хатгалага Аруначал-Прадеш муж улсаар хязгаарлагдсангүй. Хятадын жижгэвтэр нэгтгэлүүд баруун (Ладак), дунд (Уттарканд, Химачал), зүүн (Сикким) зэрэг бүх сектороор Энэтхэгийн умард хилийг үе үе зөрчдөг байв.[2062] Бээжингийн эрх баригчид тийм замаар бусдын нутаг дэвсгэрийг "буцааж" авахыг эрмэлзээд зогсохгүй түвдийн талаар баримтлах энэтхэгийн бодлогод нөлөөлөхийн тулд Нью-Делид шахалт үзүүлж байгаа юм.

Тийнхүү бээжингийн эрх баригчид Хятад, Балба, Бутан, Энэтхэгийн хоорондоршиж ирсэн энх тайванч улсыг цэрэгжсэн бүс, цэргийн буудлагын талбай болгон хувиргажээ. Энэ бол "энхийн чөлөөлөлтийн" нэг зорилго байсан юм. Өнөөгийн ТӨЗО-нд очсон хүмүүс хаана ч цэрэг,зэвсэглэл тийм ихээр төвлөрснийг олж хараагүй гэж тэмдэглэдэг юм. Үүнийг тайлбарлаж болох бөгөөд Түвд бол хятадын "алдагдсан нутаг дэвсгэрүүд" байдаг Төв болон Өмнөд азийн хил дээр стратегийн чухал байрлал эзэлж байгаа билээ.

***Амьжиргааны түвшин ба эрүүлийг хамгаалах***

Маогийн үеийнхтэй харьцуулахад түвдчүүдийн амьжиргааны түвшин дээшилжээ. БНХАУ-ын засгийн газар ганц бие өвгөд, эмгэд, ядуучууд болон ажилгүйчүүдэд эд материалын дэмжлэг үзүүлж, үр тариа, хувцас, майхан, үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл хувиарлан олгож байна. 2300 гаруй хүн хилс хэргээр шийтгэгдсэн гэж мөнгөн хэлбэрээр нөхөн төлөөс авчээ.[2063] Хоол унд, хувцастай холбогдсон асуудлыг үндсэнд нь шийдвэрлэжээ. 1978 онд хот, тосгодын нэг хүн амд оногдох орлого 565 юань, 1986 онд 1 мянган юаниас давж, 2007 онд 1131 юань болсон байна. Сүүлийн таван жилд ТӨЗО-ны тариачид, малчдын нэг хүнд оногдох жилийн дундаж орлогын өсөлт 19,25 хувийн түвшинд эргэлдэж байна.[2064] Хүн амын хуримтлалын хэмжээ өсч, хадгаламжийн мөнгө 16,01 тэрбум юаньд хүрчээ.

Эдгээр тоог үнэ, инфляцийн (мөнгөний ханшны уналт) түвшин, орлого, зарлагын бүтэц зэрэг бусад хүчин зүйлийг харгалзахгүйгээр авч үзэх боломжгүй юм. Жишээ нь, Түвдийн статистикийн товчооны мэдээгээр бол ТӨЗО-ны хөдөө нутагт амьжиргааны өртөг 1992 оноос 2001 оныг дуустлах хугацаанд 97 хувиар, харин хүн амын орлого дөнгөж 69 хувиар тус тус өссөн байна.[2065] Ингэхлээр худалдан авах бодит чадвар буурчээ. Өлсгөлөнд нэрвэгдсэн үед ч БНХАУ-ын засгийн газар амьдрал сайжирч байгаа тухай мэдэгдэл хийдэг байсан. 1980-аад онд ТӨЗО-нд зориулж гаргасан тэтгэлэгийг хятад иргэдийн хэрэгцээнд үлэмж хэмжээгээр ашиглаж, гол төлөв хотуудад суудаг хятадуудад олгох тэтгэмжид зориулжээ.[2066] 1970-аад оны сүүлч, 1980-аад оны эхээр хотын нэг оршин суугчид оногдох татаас 128 доллар, харин хөдөөгийн оршин суугчийнх дөнгөж 4,5 доллар болжээ. Хятадуудын хэрэглэдэг тэдгээр бүтээгдэхүүнд л татаас оноох ажээ 2007 онд ТӨЗО-нд амьжиргааны доод түвшингийн дэглэм тогтоов. 800 юаниас доогуур жилийн орлоготой бүх тариачин, малчин энэ дэглэмд хамрагдана гэж зарлаж, 230 мянган хүн тусламж авч, түвдийн хот, хөдөөгийн бүх оршин суугч эмнэлэгийн даатгалын системд хамрагдав.[2067] Гэвч ядуурал арилсангүй. Түвдийн хотуудад үгээгүй ядуу, гуйлгачин хүмүүс, түүний дотор хүүхдүүд олшров. Тэдгээрийн зарим хэсэг ажил хийж болох боловч аль ч байгууллалд байдагийн нэгэн адил гуйлга гуйж амьдрахыг урьтал болгож байна. Гэвч бусад хүмүүс, ялангуяа өвгөд,хөгшид, тахир дутуу хүмүүс үүнээс өөр гарцгүй болжээ.

2006 оноос ТӨЗО-нд “Боломжийн сууц” хөтөлбөр хэрэгжиж эхлэв. Тэр үеэс хойш 570 гаруй мянган тариачид, малчид шинэ байшинд оров.

Энэ төслийн дагуу 2010 он гэхэд ТӨЗО-ны тариачид, малчдын 80 хувь нь шинэ сууцанд орох ёстой.[2068] Энэ төслийг хэрэгжүүлснээр түвдийн бараг бүх нүүдэлчдийг суурин амьдралд шилжүүлнэ. Сычуань болон Хөх нуур мужийн Түвд районуудад ч дээрх үйл явц өрнөж байна. "Хьюмен Райтс Уотч" байгууллагын 2007 оны илтгэлд малчид мал сүргээ худалдаж, олон жилийн зээлд дарагдах тоосгон байшингуудад шилжиж ороход хүрч байгаа бөгөөд энэ зээлийг төлөхийн тулд шинэ ажил олж хийх хэрэгтэй болж байна гэж тэмдэглэжээ.[2069] Засгийн газар таваарын хүнсний ногооны аж ахуй эрхлэх ажилд суралцах хэрэгтэй гэж санал болгож байгаа боловч илүү их туршлагатай хятад шилжин суурьшигчидтай өрсөлдөх нөхцөлд нилээд их бэрхшээлтэй тулгарах болж байгаа юм. Өөр ажилд мэрэгшинэ гэдэг бас л хүнд. Хятадууд хятад хэл илүү сайн мэддэг учир ажилд орох үед олонхи түвдчүүдээс давуу байдалтай юм гэж X Банчин лам бүр 1987 онд тэмдэглэжээ.[2070] Нүүдэлчдийг суурин амьдралд шилжүүлэх явдал тэдний үндэсний өвөрмөц байдлыг алдагдуулж, магадгүй ядуурлыг ч ихэсгэж болох юм. Засгийн газрын тушаалын талаар маргаж, түүнийг эсэргүүцсэн нүүдэлчдийг баривчлан хорих, зодох, торгох зэргээр шийтгэх ажээ.[2071]

Түвдийн ардын анагаах ухаан соёлын хувьсгалын жилүүдэд маш ихээр хэлмэгдэж, дараа нь сэргэж эхэлсэн билээ. 2006 онд Түвд эмнэлэгийн эм, тан үйлдвэрлэдэг ТӨЗО-ны эмийн үйлдвэрүүдийн нийт бүтээгдэхүүн 623 сая юань болж, энэ баазад түшиглэсэн эмийн бизнес өөртөө засах орны эдийн засгийн нэг гол тулгуур болжээ.[2072] 2008 оны байдлаар ТӨЗО-нд нийт 1400 хүнийг ажлаар хангасан хошууны түвшингийн 10 эмнэлэг, түвдийн анагаах ухааны эм, тан хийж гаргадаг 18 үйлдвэр байв.[2073] Нийтдээ 360 нэр төрлийн эм үйлдвэрлэн гаргаж байна. Гэхдээ л европ эмнэлэг эрүүлийг хамгаалахын үндэс болж байна. Эдүгээ ТӨЗО-нд 1300 эмнэлэгийн байгууллага байгаагийн зэрэгцээ эмнэлэгийн орны нийт тоо 6700-гаас давж, мэрэгжлийн эмнэлгийн ажилтан 10 мянга ажиллаж байна.[2074]

Хэрэв хуучин түвдэд хүн амын дундаж наслалт 35,5 байсан бол 2000 онд 67 болсон байна.[2075] 1959 оноос өмнө шинэ төрсөн болон бага насны хүүхдийн нас баралт 43 хувьтай байсан бол 3,1 хувь хүртэл буурчээ.[2076] Хувьсгалын өмнөх түвдийн хувьд энэ статистик мэдээ үнэн эсэх нь эргэлзээ төрүүлж болно. Хятадын халдлагагүйгээр ч түвдийн хүн амын дундаж наслалт нэмэгдэж болох байсан гэж үзэх мэргэжилтнүүд байдаг юм.[2077] Гэсэн хэдий ч зарим чиг хандлагын тухай ярьж болох билээ. Энэ бол феодалын байгуулалтай харьцуулахад коммунистуудын ололт мөн нь гарцаагүй үнэн юм.

Мөн ТӨЗО-ны эмнэлэгийн системд дутагдал бас бий.[2078] Түвдийн цагаач засгийн газрын мэдээгээр бол мэрэгшлийн шалгалт өгч чадаагүй буюу маш муу дүнтэй өгсөн, тийм ч учраас хятадад ажил олох хэтийн төлөвгүй болсон эмч нар л гол төлөв түвдэд ирж байгаа ажээ. Хожим нь тэдний мэрэгшлийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна. Эмнэлгийн тусламжийн чанар маш муу, ялангуяа хятадын эсрэг жагсаал цуглаанд оролцож байгаад баривчлагдсан хүмүүст ийм тусламж үзүүлэхээс татгалздаг тухай мэдээлэл одоо ч ирсээр байна[2079].

Эмчилгээ төлбөртэй. Хэрэв урьдчилгаа төлөхгүй бол эмнэлгийн тусламж үзүүлэхгүй.[2080] Нөгөө талаас түвдийн анагаах ухааны хэд хэдэн эмнэлэгт, ялангуяа сүм хийдийн эмнэлэгт төлбөр сайн дурынх, эмчлүүлэгч төлбөр хийхгүй байж ч болно. Нийт Түвд даяар лам нар сургууль, эмнэлэг болон хүмүүсийн сайн сайхны хэрэгт чухал ач холбогдолтой бусад алба бий болгохын тулд л нэр хүндээ ашиглан мөнгө хуримтлуулна.[2081] Сайн сайхны үйлсийн энэ төрөл эрт дээр үеэс уламжлалтай ажээ.

Анагаах ухааны талаар тодорхой хэмжээний амжилтад хүрсэн ч түвдэд уушигны сүрьеэ, Кашин-бекийн өвчин, нойтон хамуу болон элэгний шар өвчин одоо болтол арилаагүй байна. Зарим нутагт уушигны сүрьеэгээр өвчлөх тохиоллдол 20 хувьд хүрч байна. Тарваган тахлаар өвчилсөн зарим тохиолдол бүртгэгджээ.[2082] 2006 он гэхэд ТӨЗО-нд дархлалын олдмол хомсдолтой таван хүнийг оролцуулан AIDS өвчтөний тоо 40 болсноос хоёр нь нас баржээ.[2083]

Гэхдээ сүүлийн үед Түвдэд эрүүлийг хамгаалахын чанар дээшилснийг тэмдэглэх хэрэгтэй билээ.

Бээжингийн албан ёсны эрх баригчид ТӨЗО-ны хөгжлийн дүнг дараах байдлаар илэрхийлж байна: “Түвд орон өөртөө засах эрхтэй болсон 40 жилийн дотор эрин үеийн шаардлагаас дэндүү их хоцорсон феодал-хамжлагат ёсны нийгмээс ардын ардчилалын социалист нийгэмд орж, эдийн засгийн хөгжлийн өндөр хурдац болон бүх талын нийгмийн дэвшлийг хэрэгжүүлсэн юм. <...> Дундад зууны дангаар ноёрхох феодалын дэглэмээс орчин үеийн ардчилалын нийгэмд шилжсэн явдал бол хоцрогдол болон харанхуй бүдүүлэг байдлаас соёл, дэвшилд шилжсэн нийгмийн хөгжлийн зүй тогтол мөн”.[2084] Ийм логик сэтгэлгээгээр бол колончлол тааламжтай зүйл болж таарч байна: яагаад гэвэл Их Британийн колони байсан Гонконг хятадын хамгийн тэргүүний район болжээ.

Хэрэв түвдчүүд бүгд сэтгэл хангалуун байгаа бол хаанаас ийм их эсэргүүцэл гарах билээ? Бодит байдалд бол сүүлийн 40 жилд түвдэд гарсан дэвшлийн зэрэгцээ аймаглан устгах ажиллагаа, Соёлын хувьсгал, шашин, соёлыг устган хөнөөсөн үйл явдлууд гарчээ. Сүүлийн хорин таван жилд Маогийн үеэс үлдсэн гэсгээн цээрлүүлэлт, суртал нэвтрүүлгийн зарим арга хэрэглэж байгаа ч байдал сайжирч,эд материалын хангамж өсч байна.

Гэсэн хэдий ч марксизм-ленинизм, маогийн үзэл, хятадчилах үйлдэл болон шинэтгэлийн аль алиныг түвдчүүд сонгож авсангүй. Тэд эрх чөлөөг илүү үнэтэйд тооцож байна. Энэхүү эрх чөлөө шашин, үндэсний уламжлал зэрэг оюун санааны үнэт зүйлстэй холбоотой юм. Олонхи Түвд хүн эрх чөлөөг тусгаар тогтнол хэмээн үздэг. Буддийн шашинд шүүмжлэлтэй ханддаг түвдийн орчин үеийн нийтлэлүүдийг сонирхдог залуучуудын тэр хэсэг ч хятадууд олноор орж ирж байгаа явдалд сөрөг байдлаар хандаж байна.[2085]

Эхлээд “хоцрогдсон, бүдүүлэг харанхуй” түвдийг хятад улс колони маягаар ашиглаж: хөрөнгө оруулалт хийх буюу эрх тэгш худалдаа эрхлэхийн оронд түвдийг цэргийн түшиц газар, түүхий эд, ажиллах хүчний эх үүсвэр болгосон бөгөөд ардын ардчилалын дэглэм энэхүү ажиллах хүчнийг боолын хөдөлмөр, гэсгээн цээрлүүлэлтээр дамжуулан “соёл хийгээд дэвшилд” хүргэжээ. Сүүлийн хорин жилийн нөхцөл байдлаас үзвэл Түвдийг хятадын колони гэж үзэхээргүй байна. Түвдийн бүс нутагт хөрөнгө оруулалт ирж, энэ нутгийг хөгжүүлэх арга хэмжээ авч, үндэснийх нь соёлыг хоцрогдмол хэмээн зарлахаа больжээ. Эзэн гүрнүүд колониуддаа аль болох бага хөрөнгө оруулж сорон мөлжихийг эрмэлздэг бол БНХАУ сүүлийн жилүүдэд Түвдэд маш их хөрөнгө оруулалт хийж байна гэж хятадын тоймчид шудрагаар заан тэмдэглэжээ Гэхдээ энэ хөрөнгө оруулалт хятад шилжин суурьшигчид болон орон нутгийн хүн амыг угсаатны зүйн хувьд биш гэлээ ч соёлын талаар уусгах бодлоготой “нэг багц” болон орж ирж байна. Энэ нь “гартаам чулуу олж авахын тулд гартаа буй тоосгыг хая” гэсэн эртний хятад зүйр үгийг санагдуулна.[2086] Одоо түвдийг хуучин эзэн гүрэн нь нөөц баялгийн эх булаг төдийгүй амьдрах орон зай болгон эзэмшиж буй нутаг дэвсгэр хэмээн үзэх хэрэгтэй юм.

Бүлэг 11

# Түвд орон хятадын салшгүй хэсэг мөн үү?

Энэ асуултад түүхэн баримтууд болон эрх зүйн хүрээнд л хариу өгч болно.Эхлээд олон улсын эрх зүйн нийтлэг ойлголтыг (хэдийгээр уйтгартай юм шиг санагдах боловч), дараа нь түвдийн байдлыг авч үзье.

### *Олон улсын эрх зүй болон хятадын уламжлал дахь төрт ёс*

Олон улсын эрх зүйн томоохон мэрэгжилтэн М.К. ван Вальт ван Прааг энэхүү төрт ёсны ойлголтод түвдийн асуудалтай холбогдуулан нарийвчилсан дүн шинжилгээ хийжээ. Цаг, цаас хэмнэх зорилгоор би олон тооны эх сурвалжуудын ишлэлийг орхиод түүний гол гол үндэслэлийг энд авч үзье. Дээрх ишлэлүүдийг эх зохиолоос нь олж үзэж болно.[2087]

Олон улсын эрх зүйд төрт ёс гэдэг нь олон улсын субьект мөн бөгөөд төрийг зохион байгуулалттай хамтын нийгэмлэг төдийгүй олон улсын харилцааг дэмжин сахиулах чухал хүчин зүйл хэмээн үздэг зарим шинж тэмдгүүдийг агуулсан тийм хамтын нийгэмлэг хэмээн үздэг байна. Бүрэн тусгаар тогтнолоос эхлээд олон улсын субьектийн шинж чанар бүрэн алдагдсан улс төрийн төрт ёс байх буюу алдагдах явдал энд гол асуудал болдог юм. Олон улсын эрх зүйн үүднээс бол төр байхын тулд тэр нь тодорхой хэмжээний нутаг дэвсгэр, хүн амтай, бас олон улсын бусад субьектээс үл шалтгаалан энэхүү нутаг дэвсгэрийг захирсан, олон улсын эрх зүйн бусад субьекттэй харилцаанд орох чадвар бүхий засгийн газартай байх ёстой юм. Нутаг дэвсгэрийн хэмжээ төр оршин тоггтноход нөлөө үзүүлдэггүй болохоор түүний хил хязгаарыг нарийвчлан тогтоох (хилийн шугамыг гэрээгээр тогтоох) шаардлагагүй юм. Үр нөлөө бүхий засгийн

газартай байх явдал хамгийн чухал болзол мөн. Нийтээр хүлээн зөвшөөрсөн журмын дагуу бол засгийн газрын гүйцэтгэх үүрэгт ард түмэн, нутаг дэвсгэрийг хуулийн дагуу шүүн захирах, татвар хураах, хууль тогтоомжийг ард нийтэд хүргэх, дэг журам сахиулах, шүүхийн үйл ажиллагаа явуулах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах зэргийг оруулдаг байна.

Төрийн бүрэн эрхт байдал гэдэгт аливаа төрд байх ёстой нутаг дэвсгэртээ дээд эрх эдлэх, олон улсын харилцаанд бие даан оролцох явдлыг хамруулан ойлгоно. Олон улсын эрх зүйн ойлголтоор бол бие даасан эрх мэдэл нь тухайн улсын гадна талд биш, улс дотроо байх явдал төрийн бүрэн эрхт байдалд чухал учир холбогдолтой юм. Гэхдээ нэг ч улс үнэмлэхүй бие даасан байдаггүй: олон улсын эрхийн үүднээс үүнд тодорхой хязгаарлалт тавьдаг байна. Жишээ нь, бие даасан байдал нь олон улсын байгууллага, холбоод, эдийн засгийн хамтын нийгэмлэгүүдэд оролцох; олон улсын шүүхүүд болон гэрээ хэлэлцээрийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх явдлаар хязгаарлагдана. Тухайн тогтож бий болсон бүрдлийг төр хэмээн тооцож болохгүйд хүрвэл бие даасан байдал нь нилээд хүчтэй хязгаарлагдаж болно. Нөгөө талаас аливаа төр өөр төрийн үлэмж их хяналтад байсан ч түүнийг бие даасан хэмээн үзэж болно. Зарим тохиолдолд ийм төр бие даасан байдалдаа хохирол учруулахгүйгээр батлан хамгаалалт буюу олон улсынхаа харилцааг өөр төрөөр төлөөлүүлж болно.

Гэрээгээр үүрэг хүлээх явдал албан ёсны бие даасан байдлыг бууруулахгүй. Жишээ нь, Манж чин улс болон Бүгд найрамдлах хятад улсаас “боолчлолын гэрээгээр” гадаадынханд олгосон нутаг дэвсгэрийн өргөн эрх мэдлээс үл хамааран нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон улс төрийн бие даасан байдал албан ёсоор хадгалагдан үлджээ. Бодитой бие даасан байдал албан ёсныхоос ялгаатай нь гэвэл тухайн засгийн газар гадаад талын эрх мэдлээс хараат биш байх тийм нөхцөл байдал мөн.

Хэрэв хувьсгал хийсэн буюу олон улсын эрх зүйн суурь үндэслэлүүдийг зөрчсөн бол бодит бие даасан байдлын түвшин төрт ёс олж авахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Улс орныг гадаадын хүчин эзэгнэсэн нөхцөлд түүний ил буюу албан ёсны бие даасан байдал хөндөгдөхгүй. Мөргөлдөөнийг бүрэн төгс зохицуулах боломж харагдаж байвал тухайн улсын засгийн газар нийт нутаг дэвсгэрийнхээ хүрээнд үнэхээр үр нөлөөгүй болсон буюу цагаачилж гарсан байлаа ч цэргийн эзэгнэл тэр улсын бүрэн бүтэн байдалд нөлөөлж чадахгүй. Хэрэв дайны дүнд буюу өмнөх төр хяналтаа алдсан, тухайн орны оршин суугчид засгийн эрх авсны дүнд улс бий болсон бол засгийн газрын үр нөлөөтэй эрх мэдэл төрт ёсоо тогтоох хамгийн чухал нөхцөл болно.

Жишээ гэвэл 1917–1918 онд Финландын бие даасан байдлыг тогтоосон явдал. Нөгөө талаас 1941–1946 онд холбоотнууд Ираныг эзэгнэсэн явдал төрт ёс нь бие даасан засгийн газрын маш сул эрх мэдэлтэй хосолдгийг илтгэн харуулж байна.

Нэг талаас аливаа улс тун богино хугацаанд оршин тогтож болно, нөгөө талаас удаан хугацаанд оршин тогтох явдал төрт ёсны болон түүнийг практикт хүлээн зөвшөөрч буйн чухал нотолгоо болдог байна. Энэ тохиолдолд бусад улс орон хүлээн зөвшөөрөх явдал чухал хүчин зүйл болно. Гэхдээ энэ нь цорын ганц хүчин зүйл болж чадахгүй,тийм биш бол төр нэгэн зэрэг оршиж байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг тийм сонин байдал үүснэ. Хүлээн зөвшөөрөх үйлдэл зарлан илэрхийлэх буюу дуугүй хэлбэртэй байж болно. Зарлан илэрхийлж хүлээн зөвшөөрөх гэдэг нь ийнхүү хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр албан ёсны акт үйлдэхийг хэлнэ. Дуугүй буюу ойлгуулах хүлээн зөвшөөрөлт гэдэг нь тухайн улс орныг хүлээн зөвшөөрөх эрмэлзэлийг илэрхийлсэн аливаа үйлдлээс үүдэн гарна. Эдгээрийн дотроос хамгийн найдвартай нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид оролцсон хоёр этгээдийн гэрээ байгуулах явдал мөн. Тийм гэрээ бол гадаад талын бүрэн эрхт байдлын дээд илэрхийлэл мөн. Хүлээн зөвшөөрөхийн эхний шат бол худалдааны төлөөлөгчид буюу консулын алба солилцох явдал юм. Олон улсын эрх зүйд бодит ба хууль ёсны төрт ёс буюу бие даасан байдлыг ялган авч үзэхийг зөвшөөрдөг бөгөөд эдгээр ойлголтыг шийдвэрлэгдээгүй маргааны нөхцөлд хэрэглэнэ.

Хүлээн зөвшөөрөхөөс гадна нотлох хүч агуулсан төр улсын зан байдлын бусад хэлбэр гэж байна. Жишээ нь, аль нэг улсын засгийн газартай шууд болон салангид харилцаа тогтоох явдал мөн. Мөн хоёр этгээдийн албан ёсны хэлхээ холбоо, ялангуяа засгийн газрын албан ёсны элч илгээх болон хүлээж авах, гэрээ хэлэлцээр байгуулах, зуучийн үүрэг гүйцэтгэх, цэргийн болон засгийн газрын тусламж үзүүлэх, худалдаа хийх зэргийг энд дурдаж болно. Мөн ард түмний итгэл үнэмшил, хүсэл зоригийг онцгойлон авч үзэх хэрэгтэй юм.

Нөгөө талаас бие даасан байдал алдагдсаныг хүлээн зөвшөөрөх ул суурьтай үндэслэл байх хэрэгтэй,- хэрэв ийм үндэслэлгүй бол бие даасан байдал хүлээн зөвшөөрөгдөх ёстой. Хэрэв ямар нэгэн улс нөгөөгийн бүрэн эрхийг авах гэж хүсвэл хоёр талын санал нэгдсэн байх буюу эхний улс нөгөөг удаан хугацаагаар үр ашигтай удирдсан байх явдал үүний үндэслэл болох ёстой. Цэргийн хүчээр эзэлсэн тохиолдолд удаан хугацаагаар үргэлжлэх зарчим, үр ашигтай байх зарчмаас илүү чухалд тавигдана.

Гэхдээ нэг улс олон улсын эрх зүйн зарчмыг зөрчиж нөгөө улсад хяналт тавьсан бол төрт ёс алдагдахгүй. Ингэхлээр хууль бус интервенц, түрэмгийлэл, эзэгнэл нь төр улс үгүй болохын шалтгаан болж чадахгүй. Хэрэв XX зууны эхэн хүртэл цэргийн хүчээр эзлэх явдал болон хууль бус интервенцийг тухайн нутаг дэвсгэрийг чөлөөлөх буюу хавсарган нэгтгэх замаар шийдвэрлэж болно гэж үзэж байсан бол орчин үеийн эрх зүйд ийм үндэслэл байхгүй юм.

XIX зуун хүртэл европт хэрэглэгдэж байсан сонгодог үзэл баримтлалаар бол бүрэн эрхт улсууд бүх харилцаанд заавал адил тэгш байх албагүй байв. “Эрх тэгш биш холбоог” сул дорой улсууд хүчтэйгээс хараат байна гэж ойлгодог байв. Азид ч иймэрхүү систем байсан бөгөөд хил залгаа улсууд эрх тэгш байх явдал тун ховор гэж энэ системээр үзэж байжээ. Улс орнууд эрх тэгш байх үзэл баримтлалыг европт XVIII зууны хоёрдугаар хагасаас л баримталж эхэлсэн бол Азид нэг зуу гаруй жилийн дараа хэрэглэх болжээ.

Түвдийн статус эрхийн тухайд “протекторат” буюу ивээн эзэрхэх журам, “сюзеренитет” буюу эзэн, хараатын харилцаа, “данник” буюу албатын харилцаа хэмээх хуучин нэр томьёонд дүн шинжилгээ хийж болох юм. Эдгээр нэр томьёог яв цав тодорхойлж болохгүй, тэр дундаа энэ гурван нэр томьёо улс төрийн шалтгаанаар өөрчлөгдөж иржээ. “Протекторат” буюу ивээн эзэрхэх журам гэгч нэр томьёог авч үзье. Протекторатыг байгуулахад хичнээн хэрэглүүр ашигласан байна тэр л хэмжээгээр эдгээр претекторатууд өөр хоорондоо ялгаатай байна. Олон улсын шүүхийн баримталж ирсэн ивээн эзэрхэх журмын харилцааны нийтлэг шинж чанарууд дараах байдлаар илрэн гарна: энэ бол нэг улс хууль ёсны замаар нөгөөг гадаад талын аюулаас хамгаалах үүрэг хүлээж, хамгаалуулж буй улсын гадаад харилцааг өөртөө авч буй олон улсын эрх зүйн хоёр субьектын хооронд зохицсон харилцаа мөн. Протекторатын тухай хэлэлцээр байгуулах явдал нь өөрөө бүрэн эрхт байдлын акт мөн болохоор харилцан тохирсон талуудын бүрэн эрхт статусыг онцлон авч үздэг байна. Хоёр талын засгийн газрын байгууллагууд янз бүр байна. Хамгаалуулж буй улс засгийн газрынхаа зарим үүргийг төлөөлүүлдэг боловч засгийн газрынх нь эрх мэдэл хэвээр үлддэг байна. Ивээн эзэрхэх журмын харилцаа хоёр тохиолдолд хүчингүй болно: хамгаалуулж байсан орон хамгаалагч оронд бүрэн даган орох (хамгаалуулагч орон тусгаар тогтнолоо алдах) эсвэл хамгаалуулж байсан орон бие даасан байдлыг бүрэн сэргээн тогтоох зэрэг болно. Түүнээс гадна хэрэв хоёр орны хооронд дайн гарвал дээр дурдсан харилцаа үгүй болно. Ийм төрлийн харилцаа Европт төдийгүй Төв Азид ч байжээ.

“Сюзеренитет” нь эзэн, хараатын харилцааг тодорхойлсон феодалын эрх зүйн ёс журам болно. Энэхүү нэр томьёо Их Британий хөндлөнгийн оролцооны дараа л Түвдийн тухайд хэрэглэгдэх болсон хэдий ч тийм төрлийн харилцаа Түвд, Монгол, Манжийн болон Азийн бусад эзэнт гүрнүүдэд эртнээс нааш оршин тогтож ирсэн байна. Улс төрийн бодит бүрэн эрхийг ард түмэн бус, эрх баригчид эзэмшсэн тэр улсуудын тухайд л “сюзеренитет” хэмээх ойлголтыг хэрэглэдэг. Ийм болохоор эрх баригчид л бие биенээс ямар хамааралтай байхаа тодорхойлдог ажээ. Жишээ нь, 1648 оны Вестфалийн найрамдлын гэрээгээр Ромын Ариун Эзэнт гүрэн германы бие даасан ванлигуудын дээр сюзеренитет эрх тогтоожээ.

Эрх баригч нь нэгэн зэрэг эзэн ба хараат байж болно. Европт улсуудын хоорондын сюзеренитетийн харилцаа өөр хоорондоо маш төстэй, ивээн эзэрхэх журмыг ч санагдуулахаар байжээ. Улс хоорондын харилцаанд феодалын хувийн харилцааны үндсэн шинэ чанарууд хадгалагдан үлджээ. Хараат улсын эрх баригч өөрийнхөө хүмүүст цол хэргэм олгох бие даасан эрхийг эзэн улсын эрх баригчаас авах бөгөөд түүнд үнэнч байх тангараг өргөнө. Эзэн улс хараатаа хамгаалах үүрэгтэй, хараат улс нь дайн гарсан тохиолдолд эзэн улсад цэргийн тусламж үзүүлэх үүрэг хүлээнэ. Түүнээс гадна хараат улс жил бүр алба гувчуур төлөх үүрэгтэй байв. Гэхдээ олон тохиолдолд энэ харилцаа дан ганц ёс төдий шинж чанартай бөгөөд зүгээр л эзэн улсыг хүлээн зөвшөөрч, түүнд талархал илэрхийлэх төдийгөөр хязгаарлах явдал ч байжээ. Энэ нь хятадын нутаг дэвсгэрийг өөртөө нэгтгэсэн эзэнт гүрнүүдийн тухайд маш түгээмэл шиж чанартай байжээ.

Эзэн, хараатын харилцаа буюу сюзеренитет эрх заавал олон улсын гэрээ хэлэлцээрт үндэслэдэггүй, эзэн улсын эрх мэдэлд хараат улсын засгийн газрын бүрэн эрхийг заавал оруулах албагүй байв. Ийм тохиолдолд хараат улс бүрэн тусгаар тогтнож чадаагүй ч олон улсын эрх зүйн нэг субьект болох ажээ. XIX зуунд энэ нэр томьёог бутран унаж буй эзэнт гүрнүүд, жишээ нь, Османы эзэнт гүрнээс “ховхорч унасан” улсуудын тухай хэрэглэх болсон байна. Сюзеренитетийн янз бүрийн хэлбэрүүдийн нийтлэг шинж чанар ивээн эзэрхэх харилцааныхаас цөөн байжээ. Нөгөө талаар Европт сюзеренитет нь хараат улсын бүрэн эрхт байдлыг илэрхийлэх бөгөөд энэ нөхцөлд түүнийг эзэн улс олон улсын тавцанд төлөөлдөг байна. Тэр цагаас хойш сюзеренитет нь мөн чанарын хувьд билэг тэмдгийн буюу нэр төдий, түүнчилэн колонийн харилцааг илэрхийлэх болов.

Тийнхүү, уг “сюзеренитет эрх” улс хоорондын харилцаан дахь олон улсын эрх зүйн субьект мөн эсвэл үгүй гэдгийн учиргүй болжээ. Мөн тийм

чанар үгүй нь жинхэнэ сюзернитет буйг тухайлна, харин нэр төдий нь – тухайлахгүй.

Ази, Африк, Төв Америкийн зарим хэсэг империалистуудын хяналтад орсныг илэрхийлэхийн тулд “нөлөөний хүрээ” хэмээх нэр томьёог зориуд гаргаж ирсэн байна. Энэхүү хяналтын түвшин янз бүр байжээ. Энэ түвшинг олон улсын гэрээ, нэг талын тунхаглал буюу шууд оролцоогоор тодорхойлно. Захиргаанд нь буй орны нутаг дэвсгэрийн нэг хэсгийг салгаж авах явдлыг гуравдахь этгээдэд олгохгүй байх явдал, түүнчилэн олон улсын харилцаан дахь энэ орны удирдах үүрэг хэв шинжит хэрэглүүр болж байв. Нөлөөний хүрээг гэрээ, хэлэлцээрээр зохицуулж байжээ. Энэ тохиолдолд ч нөлөөний хүрээнд байгаа улсууд тусгаар тоогтнол буюу бүрэн эрхт байдлаа алдаж байгаагүй ажээ.

Одоо Хятад болон түүнтэй холбоотой улсуудын тухай авч үзье.

Мин болон Чин гүрнүүдийн олон улсын харилцааг эртний хятадын албатын харилцааны системийн үүднээс ойлгох хэрэгтэй юм. Тийм систем күнзийн ертөнцөд XIX зууны бүр эцэс хүртэл оршин тогтжээ. Бодит амьдралд энэ систем 1842 оны англи-чин улсын дайны дараа л өрнөдийн орнуудтай байгуулах гэрээ хэлэлцээрээр аажим аажимдаа солигдох болсон байна. Албатын систем (тогтолцоо) Жоугийн үед (манай эриний өмнөх 1122 оноос манай эриний өмнөх 249 он хүртэл) харьяат ванлигуудын зүгээс Тэнгэрийн Хөвүүн Жоу хаантай харилцах “дотоод” тогтолцоо хэлбэрээр үүссэн байна.[2088] Энэ систем Тэнгэрийн хөвүүний ёс суртахууны их хүч, ач буяныг нотлох үүрэгтэй байжээ. Тэнгэрийн Хөвүүн хятадууд төдийгүй “зэрлэгүүд” гээд нийт хүн төрөлхтнийг төлөөлөх ажээ. “Зэрлэгүүд” бол бүгдээрээ хятад биш хүмүүс юм байна. Зэрлэгүүдээс хятадууд “давуутай” болох нь угсаатны зүйн буюу улс төрийн үндэс гэхээсээ илүү соёлын үндэстэй юм байна. Энэхүү давуутай байдал хүч хэрэглэхэд биш, харин хятад аж төрөх ёс буюу хятад маягийн амьдрал, күнзийн зарчим болон хятад бичгийн хэлэнд илүү их үндэслэжээ. “Зэрлэг балмад байдлын” шинж тэмдэг бол яс,үндэсний ялгаа биш, харин хятад маягийн амьдралд тааламжгүй хандах явдал ажээ. Хятадын соёл иргэншлээс өөртөө ашиг гаргахын тулд “хүрч ирж, өөрчлөгдөхийг” хүсч буй тэр “зэрлэгүүд” Хятад, өөрөөр хэлбэл Дундад Иргэн улсын эзэн хааны дээд эрхийг хүлээн зөвшөөрөх ёстой нь дээрхээс үүдэн гарч байгаа юм.

Хятадыг эзэн хаанаараа дамжуулан тэнгэр бурхантай шууд холбогддог дундад улс хэмээн сэтгэдэг байжээ. Харин “зэрлэгүүдэд” тийм холбоо байгаагүй ажээ. Хятадын эзэнт гүрний тууштай баримталдаг үзэл суртлаар

бол түүний төр баригч – Тэнгэрийн хөвүүн бол тэнгэр хийгээд хүмүүсийн хоорондын цорын ганц зуучлагч ажээ.[2089] Түүгээр дамжин дэлхийд их хишиг буян буюу дэ-хэмээх өөрчлөн байгуулагч аугаа их хүч дэлхийд дэлгэрч байдаг юм байна.Эзэн хааны Дэ бол дээд эрх мэдлийн билэг тэмдэг, бас хэрэглүүр ажээ. Энэ хүч зөвхөн улс төрийн бодлоготой холбоотой биш ажээ. Түүний нөлөөгөөр хүмүүс “дотоод сэтгэлээ өөрчилж”, хятадын эзэн хааныг сүсэглэн дагаж, гол мөрд гольдролоо даган урсдаг ажээ. Эндээс л “Тэнгэрт сүсэглэсний хүчинд талхаа идэж сууна” хэмээх хуучны хятад бурхан (жаазанд хийсэн зурмал бурхан), эзэн хаан хавар газар хагалах анхны шан татах заншил үүдэн гарчээ. Тэнгэрийн хөвүүний “догшин, бас буян хишгийн хүч газар сайгүй хүрч буй” болохоор “зэрлэгүүд” орчлонт ертөнцийг хамарсан эзэн хааны соёл иргэншилт өөрчлөн байгуулалтаас зайлж чадаагүй бөгөөд “дэлхийн хуулийн” дагуу захирагдах ёстой, өөрөөр хэлбэл тэнгэрийн хөвүүнд сүслэн захирагдах ёстой гэнэ.[2090]

Е.Л. Беспрозванныхын номонд энэ тогтолцооны товч дүн шинжилгээ оржээ.[2091] “Дэлхийг төвхнүүлэх хятадын хаант улсын үзэл баримтлалын гол үндэслэл гэвэл: 1) хятадын эзэн хааны эрх мэдэл бол цорын ганц эрх мэдэл мөн; 2) энэ засаг – түгээмэл; 3 ) эзэн хааны хувьд “дотоодын” ба “гадаадын” гэж байхгүй. Эзэн хааны хишиг буяны “дэ” нөлөө усны мандалд үүссэн дугуй долгион мэт дэлгэрнэ (хятад төвтэй дэлхийн зураглал лугаа) – эхлээд “ойрынхон” буюу хятадуудад, дараа нь “холынхон” буюу “зэрлэгүүд” хүртэл усны тэр долгион тархах ажээ. Энэхүү хишиг буяны нөлөө тархан дэлгэрсэн нь “зэрлэгүүд”-ийн дотоодод гүн гүнзгий хувирал гаргасан юм. <...> Хятадын эрх баригчдын хувьд “зэрлэгүүд” хааны ордонд ирэх нь сүсэглэхүйн чухал утга агуулж байгаа бөгөөд дэлхийд дэг журам тогтоох үйл явц дууссаныг илтгэн харуулж байгаа ажээ. <...> Энд гадаад улс төрийн тодорхой агуулга нь эргэн тойрныхоо бүх ард түмэнд Хятад улсын үр нөлөөтэй хяналт тогтсоныг илтгэн харуулж байна. <...> Гадаадын төлөөлөгчдийг хятадын хааны ордонд ирүүлж, ёслол үйлдүүлэхийн гол зорилго бол “дэлхийн улс төрийн үйл явцыг гагцхүү эзэн хааны ордноос чиглүүлж буй үйл явц” хэмээн тайлбарлах гэсэн эрмэлзэл мөн юм. Практик үзэл бодлын үүднээс авч үзвэл “зэрлэгүүд” хааны ордонд ирэх нь тун чухал ач холбогдолтой, яагаад гэвэл “чин сэтгэлээс хандах байдал яваандаа захирагдах байдалд хүргэх” ажээ. “Зэрлэгүүд” хааны ордонд заавал ирж уулзаж байх явдлыг тайлбарлахдаа: хэрэв ингэж ирэхгүй байвал “зэрлэгүүд” захирагдах дургүй буйн шинж, эсвэл тухайн удирдлага Тэнгэрийн санаа бодолд нийцэхгүй байгаагийн шинж тэмдэг ажээ. Хэрэв ид шидийн “дэ”

хүч ямар нэг байдлаар “зэрлэгүүдэд” зохих ёсны нөлөө үзүүлж чадахгүй бол өөр арга хэмжээ авах хэрэгтэй болох ажээ: “ордонд ирэхийг уриалсан” дипломатын арга хэрэглэх буюу “сүрдүүлэг” ба зэвсэг хэрэглэх ёстой ажээ.

“Зэрлэгүүд” хятадад захирагдахгүй байх, тэрч бүү хэл “алба гувчуур” авчирч өгөхгүй байх явдлыг шазруун зан төдийгүй сансрын тэнцвэртэй байдлыг зөрчиж, Тэнгэрийн санаа бодлыг эсэргүүцсэн хэрэг хэмээн үздэг байв.[2092]

Хөрш орнуудтай харьцах хятадын харилцааны хоёр загварыг онцгойлон авч үздэг байна: энэ бол хятад төвт болон гэрээт харилцааны загвар юм. Эхнийхийг арай сул хөршүүдийн тухайд, харин хоёрдахийг илүү хүчирхэг хөршүүд болон ердийн биш тохиолдлуудад хэрэглэнэ.[2093] Энэхүү хоёрдахь загварт нөхцөл байдлаас шалтгаалсан хувилбарууд байна. Энэ загвар наад зах нь гэхэд манай эриний өмнөх 206 оноос манай эриний 220 он хүртэл оршин тогтсон Хань улсын үетэй холбоотой юм. Үр нөлөөтэй хяналтад орж өгөхгүйн зэрэгцээ гадаад талын аюул агуулж буй улс орон, омог аймгуудын талаар “харилцаагаа таслахгүй байж сулхан уяагаар тогтоож байх” зарчим хэрэглэж байжээ.[2094] Энэхүү зарчмын мөн чанар бол ноёрхол буюу хяналт тавихыг эрмэлзэхгүйгээр тэдний элч нарыг хүлээж авах, гэхдээ Хятадад хийж буй тэдний айлчлалыг “алба гувчуур” өгсөн хэрэг хэмээн тайлбарлахад оршиж байв. Хүчтэй бөгөөд аюул учруулж болох дайснуудын эсрэг “зэрлэгүүдийн тусламжтайгаар зэрлэгүүдийг номхотгох” зарчим хэрэглэж байв.

Хэрэв эзэн хааны цэрэг ялагдал хүлээвэл “зэрлэгүүдтэй” эзэнт гүрний гэр бүлийн холбоо тогтоох ажээ. “Зэрлэгүүдийн” захирагч эзэн хааны хүргэн, түүний хүүхдүүд эзэн хааны ач нар болох ажээ. Тэд гэр бүлийн шатлалд нилээд доогуур суух учир илүү дуулгавартай болох ёстой гэнэ. Гэхдээ энэ аргыг тун цөөн тохиолдолд хэрэглэжээ. Төрсөн охидоо зэрлэг омгийнхны бэр болгох нь харамсалтай учир “хуурамч гүнж” нар илгээхийг эзэн хаад эрмэлздэг байв.

Гэвч хятад төвтэй загвар хятадын гадаад улс төрийн номлолын үндэс болжээ. Зарим зохиогч энэ загварыг XIX зуун хүртэлх цорын ганц загвар хэмээн үздэг бөгөөд “алба гувчуур төлөгчид” хятадын эзэнт гүрний зүгээс хориг тавьж мэднэ хэмээн айсандаа л “дэлхийн хятад дэг журмын” хэм хэмжээг сахин мөрдөж байсан юм биш гэж үздэг байна. Тэд “ноён – боол” буюу “багш – шавийн” харилцааны дүрмийг хүлээн зөвшөөрснөөрөө тун үнэтэй зүйл буюу “дуулгавартай байсны төлөө энх амгалан байдалтай болж” өөрөөр хэлбэл протоколын шинжтэй гадаад талын заалтуудыг сахин

мөрдөх замаар, үг хэлээрээ боол мэт байж, доромжлолын гэхээр ёс дэглэм сахих үнээр дотоод, гадаадын өнгөлзлөгөөс суудлаа аюулгүй байлгаж чаджээ. Хятадын “соронзон оронд” орсон улсуудын хувьд гадаад талын хэлхээ холбоо тогтоох өөр зарчим, олон улсын харилцааны өөр систем XIX зуун хүртэл үнэхээр байсангүй.[2095]

Тиймээс хятадын эрх баригчидтай хэлхээ холбоонд орсон хэн ч “алба гувчуур” төлөгчийн хувьд л үүнийг хийж болох байв. Жишээ нь, 166 онд гүйлгээ ухаантай хэсэг худалдаачин алс холоос Хань гүрэнд ирж, өөрсдийгөө ромын эзэн хаан Марк Аврелийн элч нар хэмээн танилцуулжээ. Хууран мэхлэлт ч үр “дүнгээ” өгч: “Сүүлч үеийн Хань гүрний түүхэнд” ромын эзэн хаан элч төлөөлөгчдөө илгээн алба гувчуур хүргүүлсэн юм гэсэн бичиглэл хадгалагдан үлджээ.[2096] Ромын эзэнт гүрэн тийнхүү Хань гүрний “алба гувчуур өгөгч”, Марк Аврелий хятадын эзэн хааны “харьяат” болжээ.

Хуучин хятадын гадаад улс төрийн номлолд төв (Жун-го буюу дундад улс) ба хязгаар нутгийг (вайфань) өөр хооронд нь сөргүүлэн тавьжээ.[2097] Жун-го нь дэлхийн төвд байх бөгөөд Тэнгэртэй холбоотой, зах хязгаар гэдэг нь бусад бүх улс орон ажээ. Жун-го хэмээх нэр томьёо хоёр мянга таван зуун жилийнхээ түүхэнд утгын хувьд хэд хэдэн удаа өөрчлөгдөж, янз бүрийн нутаг дэвсгэрийн тухайд байнга буюу цөөн удаа хэрэглэгдэж байсан ч хятад угсааны засаг төрийн байх уламжлалт газар буюу Хятад улс хэмээх угсаатны утгаа алдалгүй явж иржээ.

Бүр Цинь, Хань гүрний үеэс аугаа их эв нэгдлийн тухай төсөөлөл улс орны төвийн эрч хүчтэй давуу хөгжлийн үндэс болж иржээ.[2098] Харин зах хязгаар нутгуудад хараат эзэмшлийн оршин суугчид, Бээжинд нэр төдий захирагддаг ард түмнүүд, эдгээр ард түмэнтэй холбоо тогтоосон бие даасан харь улсуудын оршин суугчдыг (гадаадынхан) оруулдаг байжээ. Харьцангуй хожуу үед Монгол, Түвд, Амдо (Хөх нуур), Дорнод Туркестаныг зах хязгаар нутаг хэмээн үзэж байв.

“Хэрэв алс хязгаар нутгийн оршин суугчид эрхшээлд орохгүй бол тэднийг татахын тулд соёл хийгээд буян хишгийн үйлсээ боловсронгуй болгох хэрэгтэй. Тэд ийнхүү татагдан ороод ирэхийн цагт номхотгоод авагтун”[2099] гэж Күнз бичжээ. Түүний үед зэрлэгүүдийг хятаджуулах тухай яриа байгаагүй билээ. Хятад угсаатны тухай төсөөлөл тодорхой биш: хэрэг дээр хятадын хант улс бүр өөрсдийгөө хамгийн “зөв” хятадууд, бусдыг гол төлөв зэрлэг хятадууд хэмээн үзэж байлаа. “Зэрлэгүүдийг” хятад соёлд татан оруулах явдал тэднийг дуулгавартай болгож, хятадын нөлөөний

хүрээнд оруулах ёстой байжээ. "Зэрлэгүүдийн" удам "уугуул" хятадуудтай зэрэгцэхгүй байж болно, гэхдээ хятадууд тэр үед л хятад биш омгуудыг нилээд идэвхтэй уусгасан хэмээн үздэг ажээ. Тэр үед хятад биш ард түмнийг уусгах бодлого тун бага баримталж байсан нь эдгээр ард түмнийг яг байгаагаар уусгахад саад болоогүй байна.

Хятад маягийн аж төрөх ёсыг хүлээж авах явдал нийт хүн төрөлхтнийг удирдах "Тэнгэрийн мандат"-ыг автоматаар хүлээн зөвшөөрч буй хэрэг юм гэж Ван Вальт тэмдэглэжээ. "Тэнгэр хоёр нартай байдаггүйн адил, улс-хоёр эзэн хаантай байж болохгүй" гэж "Ёс заншлын тухай бичээс" хэмээх номонд бичсэн байна. Хэрэв хэд хэдэн эзэн захирагч байгаа бол нэг нь л Жун-го улсад хууль ёсны эрх мэдэлтэй байна.

Эзэнт гүрэн нутаг дэвсгэрийн тодорхой хил хязгааргүй, нутаг дэвсгэрийнхээ дотор дотоод харилцаа, харин түүний гадна улс хоорондын харилцаатай байна.[2100] Эзэн хааны дээд эрхийг ёслолын үүднээс хүлээн зөвшөөрөх явдал бол хүндэтгэлийн ёслол үйлдэх явдал мөн ажээ: "Алба гувчуур төлөгчид" хамгаалуулах, захирагдах, бэлэг барих, найрсаг буюу худалдааны харилцаа тогтоох зэрэг янз бүрийн шалтгаанаар ирж бараалхана. Гэхдээ аливаа элчингийн үйлдлийг алба гувчуур хэмээн үзнэ. "Алба гувчуурыг" орон нутгийн бүтээгдэхүүнээр өгч болох бөгөөд үүнийг гэрээгээр баталгаажуулна. Үүнийг дундад зууны европын ноён, хараатын харилцаатай харьцуулан үзэж болно гэж Ван Вальт тэмдэглэсэн байна. Алба гувчуурын системийн тусламжтайгаар хилийн, гадаад улс төрийн, засаг захиргааны зэрэг янз бүрийн зорилтыг шийдвэрлэж байсан юм гэж А.С. Мартынов үзсэн нь үнэнд нийцнэ. Энэ систем уян хатан байсан бөгөөд нутаг дэвсгэрийг булаан эзлэхэд хүргээгүй ажээ. Зарим "гувчуур" төлөгчид бусадтай эзэн, хараатын харилцаа тогтоох ажээ. Чин гүрэн XIX зуунаас л 1899, 1907 оны Гаагын энхийн бага хуралд оролцож, олон этгээдийн хэд хэдэн конвенцид гарын үсэг зурж, олон улсын хууль тогтоомж боловсруулах ажилд оролцох болжээ.

"Нэр төдий хараат байх харилцаа хэрэг дээр хараат улсын дотоод, гадаад бодлогод хамаардаггүй, яагаад гэвэл эзэн хааны илгээлтийг ч, "ван" цол шийтгэн олгох явдлыг ч орон нутгийн эрх баригчид Хятадаас хараат буйн шинж тэмдэг хэмээн хүлээж авдаггүй байжээ. Гадаад орнуудын элч нараас хятадад авчирч байсан "бэлгийг" нэг ёсны солих наймаа хэмээн үздэг байсан, учир нь түүний хариуд адилхан өртөг бүхий бэлэг өгөхөд хүрдэг байв. Тийнхүү нэр төдий хараатын харилцаа бол юуны түрүүнд өөрийнхөө буюу хятад хүн амд зориулагдсан суртал нэвтрүүлгийн арга

төдийгөөс үл хэтрэх зүйл ажээ. Бодит эзэн, хараатын харилцаа нь нэр төдий ийм харилцааны дээр дурдсан бүх шинж чанаруудыг өөртөө багтаахаас гадна хараат улсын гадаад бодлогод хятад эрх баригчид байнгын хяналт тавих, түүнчилэн дотоод улс төрийнх нь амьдралд тодорхой хязгаарлалттай оролцох явдалтай холбоотой байв. Энэ тохиолдолд орон нутгийн засаг захиргааны бат, тогтвортой байдал Хятадын эзэнт гүрний зүйг баримтлах явдлаас шууд шалтгаалж байсан юм" гэж Е.Л. Беспрозванных бичжээ: "Хараат" хэмээх үг хятад хэлэнд "хашаа","бургасан гөрмөл хашаа" хэмээх санаа илэрхийлдэг, өөрөөр хэлбэл, хараатууд, тэдний хилийн чанадад аж төрж буй гадаадынхны халдлагад саад хаалт болох ёстой ажээ. Хэрэв тэд хүчтэй болбол эхлээд энэ хашааг давах гэж оролддог:ингэхлээр хараатуудын сууж буй газар нутаг хэдийчинээн өргөн уудам байнав жинхэнэ хятад нутаг төдийчинээн тайван байх болж байна" гэж В.П. Васильев бичсэн байна. Эдгээр "гадаад эзэмшлүүдийг" В.С. Мясников, Н.В. Шепелева нар "ивээлд байгаа жанжин сайдын газар" хэмээх нэр томьёогоор илэрхийлсэн нь тэдгээрийн Бээжингээс хамаарах түвшинг нилээд бодитой тусган харуулжээ. [2101]

Үүнтэй зарим талаар санал нийлж болох юм: хараат улсын харилцаа энэ тохиолдолд заавал биш ч гэсэн ивээн тэтгүүлэгчийн шинжтэй байх бөгөөд харин"гадаад талын эзэмшлүүд" ("завсрын нутаг дэвсгэрүүд" гэж Беспрозванныхын нэрлэсэн) нь өөр улсын нэг хэсэг биш, харин хязгаарлагдмал эрхтэй хараат улсын хувьд олон улсын харилцааны субьект хэвээр үлдэж байна. Зарчмын хувьд энэ бүхнийг Османы эзэнт гүрэн болон Византийн улстай (дэлхийн цорын ганц эзэнт гүрэн хэмээх үзэл баримтлалын утгаар бол бусад бүх эрх баригчид энэ гүрний тухайд номхон ба номхон бус хараат болох ажээ) харьцуулан үзэж болох юм.

Сунь Ятсен 1912 оны нэгдүгээр сарын 1-нд Бүгд найрамдах Хятад улсыг зарлан тунхаглахдаа манай бүгд найрамдах улсын зорилго бол: "[Хятадын хувьд] соёл иргэншилт орны бүх эрхийг авч", "Хятад улсыг олон улсын хамтын нийгэмлэгийн хүндтэй байранд аваачиж тавих явдал мөн" гэж мэдэгдсэн байна[2102] Энэ зорилгод хүрэх зарчимч хэрэглүүр бол олон улсын эрх зүйг хүлээн зөвшөөрөх явдал мөн. Төрийн шүүх, хууль цаазны байгууллагууд, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа зэргийг олон улсын эрх зүйн зарчимтай холбож иш татвал хятад улсыг энэхүү эрх зүйг баримталдаг гэдэгт эргэлзэх зүйлгүй шахам болгож байгаа юм. 1945 онд Хятад улс НҮБ-ыг үндэслэн байгуулагчдын нэг болсон. БНХАУ колони орнуудын бие даах эрхийг дэмжиж, олон улсын байгууллагуудын ажилд оролцож байна.

БНХАУ 1971 онд НҮБ-ын гишүүн болж, түүний Дүрмийг хүлээн авч, 1984 онд БНХАУ-ын хуульч хүн олон улсын шүүхийн гишүүн болсон юм. Коммунистууд зарим онол болон эрхийн хэм хэмжээг хөрөнгөтний хэмээн шүүмжилдэг боловч олон улсын эрхийг хэзээ ч няцааж байгаагүй юм.

БНХАУ бүрэн эрх, өөртөө засан тохинох, жинхэнэ тэгш эрх, энх тайвнаар зэрэгцэн орших явдлыг олон улсын эрхийн гол үндсэн зарчим хэмээн үздэг юм. Хятадын тогтолцоот үзлээр бол аливаа улс үүсэн байгуулагдаж, олон улсын эрхийн субьект болохыг тэр улсын ард түмэн шийдэх ёстой ажээ. Өөрийнх нь улс хууль ёсных уу, аль эсвэл үгүй юу гэдгийг ч ард түмэн шийдвэрлэнэ. Эдгээр асуудлыг бусад улс орон шийдвэрлэж чадахгүй. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх явдал бол шинэ улс оршиж буй баримтыг л нотолж буй хэрэг мөн ажээ. Жишээ нь, энэ бол 1933 оны Монтевидеогийн америк дундын Конвенцид бүрэн нийцэж байгаа бөгөөд энэ баримт бичгийн дагуу бол аливаа улс улс төрийн талаар оршин тогтнох явдал түүнийг бусад улсууд хүлээн зөвшөөрөхөөс шалтгаалахгүй, тийнхүү хүлээн зөвшөөрөх явдал нь нэг улс нөгөөг бүх эрх,үүргийнх нь хамт л тэрүүхэндээ хүлээн зөвшөөрч буй хэрэг мөн.

Нутаг дэвсгэрээ удирдах аливаа улсын эрх бол бүрэн эрхт байдлын тодорхой илрэл мөн гэж Ван Вальт тэмдэглэжээ. Улмаар энэ нь улс орнуудын тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, эрх тэгш бус гэрээ хэлэлцээрээс татгалзаж буй хэрэг мөн юм. БНХАУ-д улс орнуудын тэгш эрхийг хүлээн зөвшөөрөх явдал хуулийн өмнө тэгш эрхтэй байх нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл баримтлалын хүрээ хязгаараас хальж гарч байна: улс хоорондын харилцаа хуулийн өмнө тэгш эрхтэй байх төдийгүй “жинхэнэ ёсны тэгш эрхтэй байдалд” үндэслэж болох билээ. Өөрөөр хэлбэл, арай сул дорой улсуудын бүрэн эрхт байдал илүү хүчтэй улсуудын зүгээс шахалт үзүүлэх гэсэн оролдлогоос хамгаалагдана. Марксизм-ленинизмийн онолоор бол эрх тэгш ба эрх тэгш бус гэрээ хэлэлцээр гэж бий. Эрх тэгш бус гэрээ олон улсын эрх зүйг зөрчиж буй явдал мөн. Энэ үүднээс бол 1840–1940 он хүртэлх Хятадын статус өрнөдийн гүрнүүдтэй харьцуулахад эрх “тэгш биш” байжээ. Гоминьданы удирдагчид ч эрх тэгш бус гэрээий тухай ярьж байв. Гэвч тэд эдгээр гэрээ хэлэлцээрийг засварлах хэрэгтэй гэж үзэж байсан бол БНХАУ-д эдгээр гэрээ ерөөс олон улсын эрх зүйд харшилж байна гэж ярьж байна. Орчин үеийн хятадын номлолд ивээн эзэрхэх журам (протекторат) буюу нөлөөний хүрээ хэмээх харилцааны тухай огт өгүүлээгүй байна. Гэвч хятадын хуульчид сюзеренитет бол феодализмын үед хамаатай, харин нилээд шинэ үед ийм харилцаа нь империалист түрэмгийллийн л хэрэглүүр

болж байгаа юм, тиймээс одоогийн нөхцөлд “сюзеренитет” гэсэн нэр томьёог хэрэглэж болохгүй юм гэдэгтэй санал нэг байна.

“Нутаг дэвсгэрээ тавьж өгсөн орнууд албадлагын дор байсан бөгөөд нэг бол сул дорой, үгүй бол ялагдал хүлээсэн орнууд байсан юм. Тавьж өгсөн нутаг дэвсгэрийг авсан орнууд бол нутаг дэвсгэрийг түрэмгийлэн эзлэх үйл ажиллагаанд оролцсон империалист орнууд юм. <...> Тийнхүү нутаг дэвсгэрээ тавьж өгнө гэдэг бол дайн хийх буюу хүчээр сүрдүүлэх замаар империалист орнуудын ашиглаж буй сул дорой болон ялагдал хүлээсэн орнуудын нутаг дэвсгэрийг дээрэмдэх арга юм” гэж хятадын хуульчид бичжээ.[2103] Илүү хүчтэй улс бусад орны бүрэн эрхт байдлыг булааж авахын тулд хүч хэрэглэх, шахалт үзүүлэх, албадлагын бусад хэлбэрийг заавал ч үгүй ашигладаг ажээ. Ингэхлээр булаах буюу удаан хугацаагаар эзэгнэх замаар бусдын нутаг дэвсгэр хавсарган нэгтгэх нөхцөлд хавсарган нэгтгэсэн улсад уг нутаг дэвсгэрийг эзэмших эрх зүйн давуу тал олдохгүй. Түүнээс гадна нэг орны бүрэн эрхт байдлыг нөгөө орон төлөөлөх эрх ч үүсэхгүй.

“Аль нэгэн улсын засгийн газрын хууль ёсны эрхийг нөгөө орны засгийн газарт ямар нэгэн маргаангүйгээр шилжүүлэх хүртэл эхний улсын ёс төдий тусгаар тогтнол хэвээр үргэлжилнэ. Бие даасан улсын засгийн газрын үр нөлөөтэй эрх мэдэл бүрмөсөн алга болох буюу энэ улсын нутаг дэвсгэрийг хяналтандаа авсан улсын үр нөлөөтэй эрх мэдлээр солигдох хүртэл бодит бие даасан байдал алдагдахгүй.”[2104]

Байлдан эзлэх замаар бусдын нутаг дэвсгэрийг аль нэгэн орон өөртөө нэгтгэсэн явдлыг хууль ёсны хэмээн үзэх эсрэг тэсрэг шинж чанартай хоёр хандлага байна. Гэхдээ түрэмгийлэх буюу хүчээр сүрдүүлэхийг[2105] олон улсын эрх зүйд зэмлэн буруушаах нь байлдан эзлэх үйлдлийг хэрэг дээр ядаж л дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойш гаргуулахгүй байж чаджээ. Олон улсын хуучин эрх зүйгээр бол байлдан эзэлсэн нутаг дэвсгэрийг хавсарган нэгтгэх явдал эзлэгдсэн улс нутаг дэвсгэрээ хянаж, бүрэн эрхтэй эзэмших боломжийг үгүй болгож, ялагчийн эрх мэдлийг хуульчлан тогтоодог байсан бол 1945 оноос хойш олон улсын эрх зүйгээр дээр дурдсан замаар булаан эзлэх явдлыг хууль ёсны болгох эрх зүйн ёс суртахууны болон логик хүч үйлчлэхээ больсон байна.

Жишээ нь, шинэхэн түүхэнд Балт орчмын гурван бүгд найрамдах улсыг Зөвлөлт холбоот улс, Иерусалимыг Израиль улс “хавсарган нэгтгэснийг” зарим орон хүлээн зөвшөөрөөгүй юм.

Тийнхүү “аливаа нутаг дэвсгэрт хандсан бөгөөд үр нөлөөтэй, гэхдээ хууль бусаар ашиглахад үндэслэсэн өнгөлзлөгийг дэлхийн олонхи улс

орчин үеийн олон улсын эрх зүйд харшилсан үйлдэл хэмээн няцааж байна. Булаан эзэлсэн нутаг дэвсгэрийг удаан хугацаагаар хяналтандаа байлгасан гэх шалтгаар эзэмших гэсэн аливаа оролдлого бүтэлгүй зүйл болохыг НҮБ-ын Дүрэм баталснаас хойш өнгөрсөн цаг хугацаа нотлон харуулжээ.”[2106] Хятад улс Макаогийн тухайд үүнийг нотлон харуулсан.

БНХАУ-ын эрх баригчид булаан эзлэх, хавсарган нэгтгэх буюу удаан хугацаагаар эзэгнэсэн явдал зэргийг аливаа нутаг дэвсгэрийг өөртөө нэгтгэх хууль ёсны зам мөнийг хүлээн зөвшөөрөөгүй ч Түвдийг тийм аргаар өөртөө нэгтгэсэн тухайгаа хэзээ ч мэдэгдэж байгаагүй юм. Түвдийг эзэмших хятадын бүрэн эрх олон зуун жилийн уламжлалтай тухай л мэдэгдэж иржээ. Тийм ч учраас БНХАУ-д өнгөрсөн түүх рүүгээ экскурс хийх явдлыг ихээхэн ач холбогдолтойд тооцдогийн учир үүнд л байгаа бөгөөд өмнөх бүлгүүдэд бид энэ тухай олон жишээ дурдсан билээ.

***Хятад ба “хятадын эзэнт улсуудын” тухай***

Энэ талаар хэлэлцэхийн хэрэггүй мэт, Хятад гэж юу болох нь тэртээ тэргүй тодорхой юм чинь хэмээн санагдаж болох юм. Гэвч хятадууд өөрсдөө энэ үгийг огт хэрэглэдэггүй юм. Тэд улс орноо Жун-го – Дундад иргэн улс буюу Тянься – Тэнгэрийн доорхи улс хэмээн нэрлэдэг. “Хятад гэдэг бол хятад биш үг юм. Энэ үг эрт дээр үеэс Ар монгол, Манжуурын нутаг дэвсгэрт аж төрж байсан монгол бүлгийн нэгэн ард түмний нэр буюу “кидань” гэсэн үгнээс үүсчээ. Киданчуудыг олон судлаачид монгол хэлтэн ард түмэн байсан гэж үздэг. Киданууд X зуунд Номхон дөлгөөн далайгаас Дорнод Туркестан, Монгол, Манжуураас Төв хятад хүртэл үргэлжилсэн Ляо гүрнийг байгуулжээ. Энэ эзэнт гүрнийг жүрчидүүд (тунгус-манжуур бүлгийн ард түмэн) устгасны дараа киданчуудын зарим хэсэг (хар кидань буюу хар хятад) дундад азийн Талас, Чу голын район руу явсан байна. Тэд энэ нутагт Баруун Ляо улс байгуулжээ. Монголчууд төдийгүй ислам сүсэгтнүүд ч хятадыг киданууд бөгөөд Туркестаны нэг хэсэг гэж үзэж байжээ. Баруун түрэгийн хаант улсын эрх баригчид “Тагач хан” буюу хятад хан гэсэн цолтой байжээ. Түрэг ард түмнүүд хятадуудыг тагачууд гэж нэрлэж байжээ. Энэ уламжлал тоба аймгийнханд хамаарах Умард Вэй улсаас (386–564 он) үүдэлтэй байх магадлалтай юм. Караханидын эрх баригчдад Малик аль-Машрик (аль-шарк) ва’ль-Син (Дорно дахин болон Хятадын захирагч) гэсэн цол байжээ.[2107] “Китай” хэмээх үг Орост хятад хэмээх монгол үгнээс, Өрнөд Европт Хубилай хааны харьяат нутгийн умард хэсгийг “Катай” хэмээн

нэрлэсэн (энэхүү харьяат нутгийн өмнөд хэсэг "Манзи") Марко Пологоос тус тус дамжиж очжээ.

Японд "Манзи"-гийн зүүн хэсгийг "Чин" хэмээн нэрлэж байсан гэж Марко Поло бичжээ.[2108] Энэ бол хятадын энэтхэг, япон, малайз нэр бөгөөд аугаа их эзэн хаан Ин Жэн буюу Цинь Шихуаны үндэслэн байгуулсан манай эриний өмнөх 221–206 оны үеийн хятадын Цинь гүрэн юм. Гэхдээ үгийн гарал зүйн өөр хувилбар ч бий бөгөөд жишээлэхэд, "дорнод" гэхийг нэрлэдэг санскрит үгнээс, Хань гүрний (одоогийн Вьетнам) цэргийн нэгэн районы нэрнээс, лоло ард түмэн Елан хэмээх хятад нэртэй ванлигийг (өнөөгийн Гуйжоу муж )нэрлэж байсан энэ ард түмний үгнээс гаралтай гэж үздэг байна.[2109] Sina хэмээх латин үг болон түүнээс үүссэн нэрүүд Цинь улсаас гаралтай гэж үздэг. Хятад улс Европтой эрт дээр үеэс хэлхээ холбоотой байсныг бид мэднэ.[2110] Эртний зохиогчдын (Страбон, Эцэг Плиний, Клавдий Птолемей зэрэг) бүтээлүүдэд гардаг "Хятад"-ыг Seres гэж үздэг бөгөөд эндхийн оршин суугчдыг Seres ("торгон", "торго байдаг орноос ирсэн" хэмээх грек үг) гэж нэрлэж байжээ. Гэвч энэ зохиогчдын бичсэнээр бол Seresa нь Хятадад биш, түүнээс нилээд зүүн тийш байжээ.

Sina хэмээх нэртэй холбогдуулан хятадыг нэрлэдэг Син гэдэг араб үгийг дурдахгүй байж болохгүй. Үгийн гарал үүсэл яг тодорхой биш ч энэ үг Цинь буюу Sina-гаас гаралтай байх магадлалтай юм. Дундад зууны үед иранчууд болон түрэгүүд зэрэг зарим ислам шашинт ард түмэн Манжуурыг умард хятадын хамт, Өмнөд хятадыг Энэтхэг-хятадын хойгтой хамт Чин ба Мачин гэсэн үгээр нэрлэж байв. Эртний орос хэлний "Хин", "хинове" гэсэн үгүүд дуудлагаараа дээрх үгүүдтэй төстэй юм. Монголын өмнөх Орост энэ хоёр үгээр дорно зүгийн нүүдэлчдийг илэрхийлж байжээ. Энэ хоёр үг орчин үеийн монголын нутагт аж төрөн амьдарч байсан ард түмэн болох хүннү нарын нэрээс, эсвэл Зинь гүрний нэрнээс гаралтай гэж зарим судлаач үзэж байна.[2111] Зүрчидүүдийн байгуулсан энэ гүрэн Хятадын нэг хэсгийг өөртөө нэгтгэж байжээ. Зинь гүрнийг монголчууд мөхөөжээ.

Эцэст нь орчин үеийн европын "China" гэсэн нэр томьёо янз бүрийн хувилбараар "Чин ба Мачин"-аар дамжин "Цинь" гэсэн үгнээс, мөн манжуурын "Цин" хэмээх үгнээс гарвалтай байж болох юм. Гэтэл Жун-го-гийн ард түмэн болох хан үндэстэн, өөрөөр хэлбэл хятадуудын хувьд Энэтхэг-хятадын хойгийн оршин суугчид, лоло нар, киданууд, зүрчид аймаг, манж нар болон монголчууд "зэрлэгүүд" ажээ. Зэрлэгүүд алба гувчуур төлж, хятад эзэн хаанд захирагдах ёстой байв.

Тийнхүү "Хятад", "China" зэрэг үгүүд янз бүрийн үед янз бүрийн

утгатай байжээ. Азийн төдийгүй европ, оросын жуулчид XIX зуун хүртэл Хятадыг эзэн хаанаас хараат бусад орнуудаас ялгаж чаддаг байжээ.[2112] Тэд “хятадыг” Бээжин нийслэлтэй улсын утгаар ойлгож, энэ ойлголтоо бээжингээс удирдуулдаг буюу түүнээс хараат байдаг бусад оронд дэлгэрүүлжээ. Тийм ойлголт күнзийнхэд ойртож очсон байна. Учир юу гэвэл Дундад улс ямагт бие даасан шинжтэй байсан бөгөөд энэ улсыг янз бүрийн хаад л удирдаж байжээ. Гэвч хуучин эзэнт гүрнүүдийн бичиг баримтуудаас үзэхэд “Жун-го” хэмээх нэр томьёог хэзээ ч Түвд болон хятад биш бусад нутгийн тухайд хэрэглэж байсангүй.[2113] “Хэрэв бид эртний хятадын нутаг дэвсгэрийн хэмжээг ойлгохыг хүсвэл тодорхой үед тодорхой эзэнт гүрнүүдийн хяналтад байсан бодит нутаг дэвсгэр ямар их хэмжээтэй байсан тухай л ярьж чадах билээ” гэж Шанхайн хятад түүхч Гэ Зяньсюн маш шударга тэмдэглэн хэлжээ.[2114]

Энэ эзэнт гүрнүүд гэж юу вэ? Дахиад л хачин асуулт тавьсан юм ишиг санагдаж болох юм. “Зөвлөлтийн их нэвтэрхий толь бичиг”-ээс авсан тодорхойлолтыг үзье: “Эзэнт гүрэн (династи – dynasteia хэмээх грек үгнээс гаралтай, засаглал, ноёрхол гэсэн үг) гэдэг бол хаант засагт улсуудад угсаа залгамжлах эрхийн дагуу хаан ширээнд бие биенээ орлон суух нэг урагийн (гэр бүлийн) хэд хэдэн хаад (жишээ нь, Орост Романовынхан, Австри-Унгарт Габсбургийнхэн, Францад Валуа ба Бурбоныхон зэрэг) гэжээ. Ингэхлээр эзэнт гүрэн (династи) гэсэн үг гагцхүү эрх баригч овогийнхон ажээ. Европчууд энэ зарчмыг Төв Ази, Алс Дорнодод уламжлуулжээ. Хэрэв Орост Романовынхан эрх барьж байсан бол Хятадад чин, Сун овгийнхон байжээ. Нөгөө талаас “чин улс”,”юань гүрэн” гэж бичдэг. Тэгвэл ямар учраас “Романовын эзэнт гүрэн” гэж хэлж болоогүй юм бол?

Энэ тухай эрэгцүүлсэн зүйл бага байдаг юм. Интернетийн “дорнодын хуудсанд” явуулдаг хэл шинжлэлчид болон түүхчдийн санал маргаан маш их сонирхол татдаг юм.[2115] Эндээс дараахь дүгнэлт хийж болно. “Эзэнт гүрэн” (династи) утгаар хэрэглэгдэж буй “чао” хэмээх хятад дүрс үсэг европын ийм нэгдмэл ойлголтоос ялгаатай хэд хэдэн өөр утга илэрхийлж байна. Хятад-хятадын тайлбар толь бичгүүдэд: “Улсын нэрийг тогтоогч (нэг буюу хэд хэдэн үеийн) төр баригчийн засаглалын бүх үе”, “нэг төр баригчийн засаглалын үе”, “эрин ба үеийн нэр”,”хаант төрийн эриний нэр”, түүнчилэн арван хоёр жилийн мөчлөгийн (хааны засаглалын) эхний жилийн нэр”, “эзэнт гүрэн нь (буюу засаглалын үе) эрх баригчдын бүхэл бүтэн үеийнхэн, түүнчилэн ямар нэгэн эзэн хааны засаглалын үеийг илэрхийлнэ” хэмээн тайлбарлажээ. Ийнхүү хоёр үндсэн утга: нэг буюу хэд хэдэн эзэн хааны

засаглалын хугацаа (үе, эрин) ба эдгээр эзэн хаадын ургийн үе залгамжлах ёс" зэрэг болно. Тийм учраас жишээ нь, "Мин чао", өөрөөр хэлбэл Мин улсыг үндэслэгч болон түүнийг залгамжлагчдын засаглалын үе" төдийгүй мөн "Кан-си чао", өөрөөр хэлбэл "Кан-си уриатай эзэн хааны засаглалын үе" хэмээн ярьж болно.

Энд эзэнт гүрний нэр нь овог ч биш, нэр ч биш ажээ. Энэ бол хаант засгийн эрх авсан овогийн төлөөлөгчийн өгсөн билэг тэмдгийн нэр (буюу эзэн хаан ганцаараа байх тохиолдолд түүний сонгож авсан засаглалын уриа) юм. Гэхдээ энэ нэрийг заавал ч үгүй эзэнт гүрнийг үндэслэн байгуулагч өгөх ёстой бишээ. Жишээ нь, Юань, Чин гүрний нэрийг Чингис хаан, Нурхаци нар өгөөгүй юм. Эдгээр нэр энэ хоёр хүнийг нас барснаас хойш бий болж, хоёр эзэн хааныг эдгээр гүрнийг үндэслэгч хэмээн нэхэн зарлажээ. Нөгөө талаас эзэнт гүрнүүдийн нэр ч мөн байнгын биш байлаа: заримдаа ээлжилж төр баригчдын нэг улсынхаа нэрийг өөрчлөх явдал ч гардаг байв (жишээ нь, Хоу Зинийг Цин болгожээ). Үе буюу өв залгамжилсан хаадыг илэрхийлсэн "чао" гэдэг хятад үгэнд улс (го) гэсэн утга байхгүй. Күнзийн үзэл баримтлалаар бол улс бол ямагт нэг – Дундад (Жун-го, өөрөөр хэлбэл хятад) улс ажээ. Энэ улс өөр ямар нэгэн улсын нэг хэсэг байж болохгүй. Тийм учраас хэрэв энэ улс бодит байдалд харийнханд булаан эзлэгдвэл (өөрөөр хэлбэл байлдан дагуулалтын дүнд харийнхны оронд нэгтгэгдвэл) хятад тогтолцоогоор бол урвуугаар: Жун-гогийн эрх баригч одоо бас нэг өөр нэг газар нутгаар жолоодох болж байгаа ажээ. Хятад тархай бутархай байсан үед буюу хил залгаа орнуудын тухайд хаадын угсааны нэг хүн Жун-гог, бусад нь бусад орны засгийн эрх барьж болох ажээ. Хэрэв күнзийн номлолыг баримтлах юм бол бусад орон гэгчийг Жун-гогийн нэг хэсэг хэмээн үзэж болох ажээ. Европ утгаар бол энэ нь нэг улс нөгөөд орж байгаа биш, харин соёл иргэншилтийн нэгдэл болж байгаа юм. Тэгвэл хятадын төрт ёсны үзэл баримтлал соёл иргэншилт үзэл баримтлалтай таарч байна.

Энэ бүх улс болон эзэмшил газар хаадын урагаар, тухайлбал хаадын өөрсдийнх нь нэр болон засаглалын үеэр нэрлэгджээ. Жишээ нь, Манж гүрний албан ёсны нэр Жун-го биш харин Да-Цин Ди-го (Да Цин-го) ажээ. Сүүлчийн нэрийг олон улсын баримт бичгүүдэд хэрэглэж байсан боловч хятадууд, ялангуяа эрдэмтэд бүгдээрээ үүнийг байж болох зүйл хэмээн хүлээн зөвшөөрөөгүй юм.[2116] Хэзээ ч Турк гэж нэрлэгдэж байгаагүй (ер нь угсаатны нэрийг заасан утга бүхий үг цээртэй байжээ) Османы их улсыг энд дурдаж болох бөгөөд энэ бол Осман урагийн султануудын захирсан олон үндэстний эзэнт гүрэн байжээ.

Тийнхүү “Хятадын эзэнт улсууд” (династи) бол эрх баригч гэр бүлийнхний овгоор л тодорхойлогддог Европын эзэнт гүрнүүд огт биш билээ. “Хятадууд (хан үндэстэн) “эзэнт гүрэн” (династи) хэмээх ойлголтод улсын нэрийг оруулснаараа бусад ард түмний бие даасан улсуудыг эзэнт гүрнийхээ он дараалллын түүхэнд хүчээр хамруулж, Жун-гогийн түүх судлаачдыг ч үүнд сургаж байгаа юм. Энэ түүх судлаачид “эзэнт гүрний” ойлголтод хятад маягийн тайлбарыг шууд хуулан хэрэглэдэг байна.[2117] Хэрэв Европт хаадын үеийнхний ойлголт төрийн тухай ойлголт, илэрхийллээс ангид байдаг бол Хятадад нэг байдаг, хэрэв тухайн нэг эрх баригчийн тухай яригдаж байгаа бол тусгайлан авч үзэж болох ажээ.

Хятад биш ард түмнүүд хятад нэр, нэр томьёо, төр улс болон эзэн хаадын үечлэлийн систем, күнзийн үзэл суртлыг хэрэглэх нь тэр ард түмнүүдийн улс орон хятадын нэг хэсэг болж буйн шинж тэмдэг гэж заримдаа үздэг ажээ. Энэ бол буруу зүйл: эдгээр шинж тэмдэг бол төрт ёсонд нөлөөлөхгүй ажээ. Жишээлэхэд, I Петр хааны шинэчлэл Орос улсыг европжуулжээ. Орос улс өрнөд европоос шинэ хуанли (ертөнц бий болсон цагаас биш Христийн төрсөн өдрөөс эхлэн тоолдог), удирдлага, албан тушаал, цол хэргэм, хувцас, зан заншлын системийг албан ёсоор зээлдэн авч, герман, франц хэл хэрэглэх болж, засаг зкахиргааны байгууллагуудад өрнөдөөс ирсэн олон гадаад хүн ажиллах болж, зарим германчуудын нутаг Орост шилжиж ирсэн байна. Гэхдээ үүнээс болоод оросууд өрнөд европынхон, Орос улс германы буюу ерөөс өрнөд европын нэг хэсэг болоогүй билээ. Нэгдүгээр Петр хаан бол Романовынхны удамд хамаарна. “Романовынхан” гэдэг үг бол орос биш, харин латин гаралтай үг. Гэсэн ч энэ бол италийн биш орос удмынхан, Орос улс бол Италийн нэг хэсэг биш билээ.

“Улс” ба “гүрэн” гэж томъолсон монгол үгийн утга нь – орон юм. Хожим хятадын нөлөөллийн дор монголчууд эдгээр үгээр хятадын “чао” гэдэг ойлголтыг илэрхийлэх болжээ. Гэвч анхандаа монгол ч ба хятад ч хэлэнд Европын “династи” гэсэн үгийн ойлголтыг илэрхийлэх нэг утгатай үг байхгүй байсан бололтой. Монголын “хааны ураг” гэсэн гол ойлголтыг илэрхийлсэн “угсаа” гэдэг үг утгын хувьд ойр юм.

Бүх “хятад овогийн хаадынханд” дүн шинжилгээ хийх гэх нь утгагүй зүйл юм. Түвдийн асуудалтай холбоотойгоор л сонирхол татах зарим нэгийг нь энд дурдъя. Тан гүрэн (Ли овогийн эзэн хаад төр барьж байсан) 618–907 оршин тогтож байжээ. Хятадуудын хувьд Тан улсын эзэн хаан “хятад төдийгүй дэлхийн цорын ганц, хууль ёсны эрх баригч байсан юм” гэж түүхч Дань Ихун тэмдэглэжээ.[2118] Үнэн хэрэгтээ бол тэр үед Түвд бие даасан улс

байсан бөгөөд одоо БНХАУ-ын бүрэлдэхүүнд орохгүй байгаа нутаг дэвсгэр буюу Тайландын эзэн хаан түвдийн хараат байжээ. Тан, Юань улсуудын хооронд Түвд нь хятадтай маш сул харилцаатай байсан тухай бүлэг 2-т өгүүлсэн билээ.

“Хятадын Юань гүрний” тухай дэлгэрэнгүй байдлаар авч үзье. БНХАУ-ын гадаад явдлын яамны Интернет-сайтад: “Монголын эрх баригчид 1271 онд улс байгуулж, түүнийгээ Юань гэж нэрлэсэн бөгөөд энэ улс 1279 онд бүх хятадыг нэгдмэл төвлөрсөн удирдлага дор нэгтгэсэн юм. <...> Хятадын эзэнт гүрнүүдийн төв засгийн газрууд түвдийг удирдаж байсан юм. 13-р зууны дунд үеэс Түвдийн район Юань гүрний нутаг дэвсгэрийн эзэмшилд албан ёсоор орсон юм” гэж бичжээ.[2119] Гэтэл бодит байдалд огт эсрэгээр эргэжээ. Хятад нь монголыг биш, харин Монгол улс хятадыг байлдан дагуулсан билээ. Хятад улс өөрийнхөө (хятад биш) хаант засгаар удирдуулсан өөр орны нэг хэсэг болсон юм. Энэ орон бол Номхон далайгаас Төв Европ хүртэл үргэлжилсэн аугаа их монгол улс байлаа. Энэ улс харьяат нутгуудад хуваагдаж, тэр бүрийг Чингис хааны удмынхан эзлэн захирч байв. Чингис гэдэг бол нэр биш цол билээ. Энэ цолны нэр “тэнгис” хэмээх үгнээс гарчээ. Нилээд хожуу үеийн сурвалж бичгүүдэд аугаа их хааны цолыг Далай хаан (монголоор “далай” буюу “океан”, “аугаа их” гэсэн үг) гэж бичжээ. “Далай” хэмээх үгнээс Далай лам хэмээх цол үүсчээ. Чингис хааны эцэг эхээс өгсөн нэр бол Тэмүүжин. Тэрээр монголчуудын алтан ураг хэмээн нэрлэдэг Боржигин овогийн хүн юм. Монголчууд нилээд хожуу үеийн (буддийн үеийн) түүх судлалаар бол Алтан урагийг Энэтхэгээс – үлгэрийн Махасамади хаан, Энэтхэг дэхь түүний удмынхнаас, дараа нь Түвдийн анхны долоон хааны үеэс гаралтай гэж үздэг боловч Хятадаас гэсэн нэг ч үг байдаггүй юм.[2120]

Харьяат нутгуудын монгол хаад нэг ураг төрлийнхөн байв. Тэд бас л нэг овогийн аугаа их хааныг “эзнээ” хэмээн үздэг байсан юм. Монгол хаадын харьяат нутгуудад (Цагаадайн улс, Алтан ордны улс гэх мэт) Дундад Азийн орнууд, Орос, Иран, Ирак, бүх Кавказ, Сибирийн ихэнх хэсэг орж байв. Харийн нутгуудыг захирах их хааны эрх мэдэл удалгүй нэр төдий зүйл болж, харьяат нутгуудын удирдлага бие даасан шинжтэй болжээ. Гэхдээ харьяат нутгуудын бүх эрх баригч их хааны дээд эрхийг хүлээн зөвшөөрч, түүнд боломжийн хэрээр бэлэг–алба гувчуурын хэлбэрээр явуулах ажээ. Энд нийслэлээ алдсан Тогоон төмөр хааныг ч дурдаж болох юм.[2121]

Монголын харьяат газруудын нэг бол Юань улс байв. Хятадууд түүнийг Да Юань, монголчууд Их Юань улс хэмээн нэрлэж байв.[2122] Энэ бол их

хаан Хувилай болон түүний удмынхны харьяат нутгийн нэр юм. Тэднээс хэн нь ч хятад хүн байгаагүй. Юань улсын бүрэлдэхүүнд хятад, солонгос, түүнчилэн Бирм, Камбожийн зарим хэсэг, Тангад улс болон бусад хятад биш нутгуудыг өөртөө нэгтгэсэн Монгол улс орж байв. Ингэхлээр чухамдаа хятад л Монголын нэг хэсэг байжээ. Эхний үед их хаад Монголынхоо нутаг дэвсгэрт, Хархорин хотод ("Каракорум" буюу "Хар хад" хэмээх түрэг гаралтай үг), 1264 оноос Ханбалык (Дайду, Бээжин) хотод төр барин сууж байлаа.[2123] Хувилайн ачаар энэ хот өөрийнх нь харьяат нутгийн төдийгүй нийт Их Монгол улсын нийслэл болж хувирсан байна. Үүний дараа Юань гүрэн ба бие даасан хятад улс (Өмнөд Сун) зэрэгцэн оршиж байсан боловч 1279 онд монголчууд өмнөд сун улсыг бүрмөсөн байлдаж эзэлсэн байна.

Хувилайн эрх мэдэл шууд тогтоогүй юм. 1236 онд тэрээр Синьжоуг (одоогийн Хубэй муж) эрхэндээ оруулж, 1251 онд Мөнх хаан түүнийг умард хятад руу явуулав. 1258 онд тэрээр өмнөд хятадын эсрэг цэргийн ажиллагаанд туслуулахаар Хувилайг дууджээ. Гэвч Хувилай зам зуурт Мөнх хаан нас барсан тухай олж дуулжээ. Дараа нь Хар хоринд их хуралдай болж Ариг Бухыг их хаанаар зарлан тунхаглав. Тэр үед Ариг Бухын ах Хувилай одоогийн өвөр монголын шандугийн талын Кайпин хот дахь өргөөндөө өөр их хуралдай хийлгэж, 1260 онд түүнийг их хаанаар тунхагласан байна. Хятадын түүх судлалаар бол Хувилай эзэн хаан (хятадаар хуанди) хэмээн цоллогдох болжээ. Энэ үед түүнээс хараат биш хятадын эзэнт улс гэж байсан юм. Ариг Бух монголын уламжлалт үнэт зүйлсийн талыг баримтлагч байсан бөгөөд Чингис хааны заавры хэлбэрэлтгүй сахин мөрдөхийг эрмэлзэж байжээ. Тэгвэл Хувилай шинэтгэлийн талыг баримтлагч, хятад улсуудынх шиг тийм системээр эзэнт гүрнээ зохион байгуулахыг эрмэлзжээ.

Монголын хаан ширээ залгамжлан суух уламжлалын байр сууринаас бол Хувилайн зарлан хийлгэсэн их хурал хууль ёсны биш, яагаад гэвэл эзэнт гүрэнд нийслэл хотдоо хууль ёсоор сууж буй эзэн хаан Ариг Бух байсан юм.[2124] Түүнээс гадна Хувилай ноёд, вангуудыг талдаа татах аргыг өргөн хэрэглэжээ. Ариг Бух ахдаа элч илгээж бичсэн захидалдаа: "Төрийн эрх мэдлийн хуулиар бол их хуралдайгаас хааныг тавьдаг атал та Хятадад сууж, хятад хууль мөрдөж, зоргоороо авирлаж, дээдсийн үзэл баримтлалыг үл тоомсорлов" хэмээжээ.[2125] Хувилай дүү Ариг Бухыгаа засгийн эрх булаан эзлэгч хэмээн зарлаж, өөрөө хятад уламжлалаар удирдлагын Жун-тун хэмээх анхныхаа уриаг хүлээж авсан байна. 1261–1264 онд тэрээр дүүгийнхээ эсрэг байлдаж, Ариг Бух бут цохигдон Хувилайд бууж өгчээ. Ийнхүү Монголд нэг их хаан үлдэв. Эзэнт гүрний бүх нутгийн эрх баригчид

түүнд захирагдах ёстой болов.

Хувилай 1264 онд өөрийнхөө өргөөг зүрчидийн хуучин нийслэл Жундугийн ойролцоо нүүлгэн аваачиж, түүнийг Ханбалык (“хааны хот”) буюу Дайду (гол нийслэл) гэж нэрлэв. Ханбалык нийт Их Монгол гүрний нийслэл болов. Хожим нь Юань гүрэн мөхсөний дараа энэ хот Бээжин хэмээн нэрлэгдэх болсон байна. Хувилай удирдлагынхаа уриаг Жун-тун байсныг Жи-юань болгож өөрчлөв. Хаан энэ талаар гаргасан зарлигтаа үүнийг сүүлт од үзэгдсэн, болоогүй цагт бороо орсон зэрэг муу ёрын шинж тэмдгүүдээр тайлбарлаж, засаг төрийн бодлого Хуулинд харшилж буйг энэ бүхэн харуулж байгаа юм гэж хэлсэн байна.

1271 онд Хувилай улс орныхоо нэрийг өөрчлөхөөр шийдвэрлэв. Хятадын “Өөрчлөлтийн номонд” заасныг баримтлан тэрээр “цянь юань”: “цянь” – тэнгэр ба “юань” – анхны хэмээх дүрс (ханз үсэг) үсгийг улсынхаа нэрээр сонгож авчээ гэсэн мэдээ бий.[2126] Энд “цянь” гэдэг нь тэнгэрийн ч, эзэн хааны ч билэг тэмдэг ажээ.

Хувилайг энэ бүх үйлдэлд хятад зөвлөхүүд хатгажээ. Бүр багаас нь түүний дэргэд хэд хэдэн хятад багш ажиллаж байжээ. Тэд Хувилайд улс орныхоо түүхийг хэлж өгөөд зогсоогүй удирдлагын асуудлаар байнга зөвлөгөө өгдөг байв.[2127] Хятадад нэрд гарсан олон эрдэмтэн, сайд нар Хувилайд үйлчилж байжээ. Тэдний нэг Хао Зин их хааны суудал болон эрх мэдлийг булааж авах аргыг санал болгожээ. Хувилай залуудаа энэ хүмүүст итгэж, хятадаар ярьж сурсан боловч хятад бичиг үзэхээс татгалзжээ. Юань гүрний дээд дархаргынхан хятадын төрт ёсны үзэл баримтлал, удирдлагын систем, түүх судлалыг хүлээж авсан нь гайхалтай биш юм. Хувилайн үед хятадууд Чингис хааныг Тай-зу( Аугаа их өвөг-эзэнт гүрнийг үндэслэн байгуулагчад өгдөг сүмийн стандарт нэр), Фа-тянь ци-юнь, Шэн-у хуанди ( Тэнгэрт нийцэмтгий ба хувь заяаг нээгч, дайнч гэгээн эзэн хаан) гэж янз янзаар нэрлэж байжээ.[2128] Түүний жинхэнэ монгол нэр Тэмүүжин амьд байх үед нь хориглосон нэр байв. Хувилайгаас өмнө төр барьж байсан бусад их хаад бас л сүмийн хятад нэртэй байв. Гэсэн хэдий ч юань гүрний бүх эзэн хаадад өөрийн ч, хаан суудлын ч монгол нэр байсан юм.

1279 онд Хувилай хаан хятадыг байлдан эзэлж дуусав. Тийнхүү бүх хятад монголчуудын эзэнт гүрний салшгүй хэсэг болсон байна. Энэ эзэнт гүрнийг бүрдүүлэгч хэсгүүд адил тэгш биш: төвд захирагдах түвшин ч янз бүр байсан юм гэж Марко Поло зэрэг тэр үеийн үйл явдлыг нүдээр үзсэн хүмүүс тэмдэглэсэн байна. Тиймээс монголчууд тэдгээрийн заримыг жишээлэхэд Солонгос, Ганьсуг орон буюу вант улс хэмээн нэрлэж

байлаа. Эдгээр орны зарим нь одоо бол тусгаар тогтносон улсууд жишээ нь, Солонгосыг монголчууд шууд удирддаг байжээ. Юань улсын засаг захиргааны байгууллагуудын бүх системд нийт улсыг хамарсан нэг ч нэгж байгаагүй ажээ.[2129]

Юань улсын төрийн удирдлага монгол, хятадын хоорондын эрлийз шинж чанартай боловч эзэнт гүрэн нь монгол хэвээрээ үлджээ. Энэ гүрэн бүхлээрээ Чингис хааны бүгд хууль болох Их Засаг хуулийг мөрдөх ажээ. Төрийн аппаратад гагцхүү шаардлагатай гэсэн тохиолдолд л хятадуудыг авч ажиллуулна.[2130] Монголчууд засаг захиргааны хувьд ч, нийгмийн байдлын үүднээс ч ямагт хятадуудаас хөндий байна.[2131] Монголчууд төрөлх хэлээ хатуу баримтална. Бичиг үсгийг ч тэдэнд эхлээд уйгурууд, дараа нь төвдчүүд боловсруулж өгсөн болохоос биш хятадуудыг энэ хэрэгт оролцуулаагүй ажээ. Ли Танын бослогоос хойш хятадуудыг өндөр албан тушаалд ажиллуулахыг ерөөс хоригложээ. Бараг бүх албан тушаалыг “өнгөт нүдтэй хүмүүс” буюу исламынхан, христос шашинтан, түрэгүүд, кидан, тангадуудад өгөх ажээ. Татвар хураах болон санхүүгийн бусад хэргийг гол төлөв ислам сүсэгтнүүд гүйцэтгэнэ.[2132]

Юань улсын оршин тогтносон сүүлч үед түүнийг нэгтгэхийн тулд хятадын дээд давхаргын төлөөлөгчдийг ашиглах шаардлага гарч ирэхэд л монголчууд хятад соёлыг сонирхож эхэлсэн байна. 1343–1345 онд монголчуудын тушаалаар Ляо, Зинь, Сун улсуудын дэлгэрэнгүй түүх зохиожээ.[2133] Хэдийгээр Сун бол хятад, Ляо бол кидан, Зинь бол зүрчидийн зэрэг өөр өөр улс байсан ч хятадын түүх бичлэгийн ёсоор бол хятадын эзэнт улсуудынх шиг л нэг янзаар бичжээ. Монголын эзэнт гүрэнд түүх бичиж байгаа боловч нэгэнт тогтсон күнзийн аргаар бичсэн байна. Тиймээс Ляо, Сун зэрэг огт өөр орнуудын түүхийг ч хятадын эзэнт гүрний нэгэн адил аргаар бичсэн байна. Энэ ажлын үеэр “хятадын эзэнт гүрнүүдийн албан ёсны түүхэнд” монгол хаадын нэрийг оруулах хууль ёсны, эсэхтэй холбогдсон зөрчил гарчээ. Энэ зөрчил түүх бичих ажлын төгсгөлийн шатанд буюу Тогоон төмөр хааны үед шийдэгдэх шатандаа оржээ. Энэ гурван улсын чухам алин нь монголчуудыг “хятадын хаант улсуудын” хууль ёсны залгамжлагчид болгосон юм бэ? гэсэн асуудал маргаан гарах гол үндэс болжээ. Ингээд энэ гурван улс өөр өөрийн гэсэн түүхтэй байсан, харин монголчууд гурвууланг нь эрхэндээ оруулсан гэдэг дээр санал нийлж үлдсэн байна. Монголчуудыг бээжингээс хөөж гаргасан учир дээрх асуудал дан ганц академийн шинж чанартай зүйл болон үлджээ.

Монголчууд эзэнт гүрнээ унах хүртэл хятадыг түүний нэг хэсэг, их

хаанаа хятадууд зэрэг ард түмнүүдийг "илбэн тохинуулагч" гэж үзэж байв. [2134] Тэгвэл Хувилай хаан Юань гүрний үеийг зарлан тунхаглахдаа яах гэж хятад системийг зээлдэж авсан юм бол?

Тэрээр өөрийгөө хойч удмынхныхаа ой дурдатгалд мөнхжүүлж, эзэнт гүрний хамгийн олон тоотой ард түмэн болох хятадуудын нүдэнд монголын эзэнт гүрнийг "хятад гүрнүүдийн" нэрсийн жагсаалтад хууль ёсоор оруулахыг хүсчээ. Түүнээс гадна монгол хаад бүх дэлхийг эзэгнэх эрмэлзэлтэй байв. Тэд хятадыг эзэлснээрээ тийм эрх мэдлийн бэлэн бөгөөд сайтар боловсруулсан, бас тохиромжтой үзэл баримтлалтай болсон байна. Яагаад гэвэл монголчуудын байгуулсан улс- дэлхийн хамгийн гол улс, тэгэхлээр Дундад (Төв) улс, тиймээс бусад улс орон эрхшээлд орох ёстой ажээ. Хятадуудаас ялгаатай нь гэвэл монголчуудын хувьд энэ ойлголт угсаатны зүйн хувьд хятад гэсэн утгагүй байжээ. Дундад улс иймхүү Монголчуудын аугаа их улс болон ойлгогдох болжээ. Угсаатны зүйн асуудлыг дутуу үнэлсэн явдал монголчуудын хувьд ихээхэн уршиг дагавартай болсон байна. Хятадад хан үндэстнийхэн засгийн эрхийг булааж авахад күнзийн сургааль ёсоор бол хятадууд энэхүү аугаа их дундад улсад хууль ёсных болж, монгол нутгууд "зэрлэгүүдийн хязгаар" болон хувирав. Монголчууд өөрөөр үзэж байсан ч хятадуудын хувьд энэ нь огт чухал зүйл биш байв.

Иймхүү 1368 онд Хятад улс Юань гүрнээс өрх тусгаарлав. Энэ нь монголчуудын хувьд сүйрэл болж: их хааны харьяат нутгийн "бүх монголын ард түмэн" тавь гаруй түмэн хүн байсанаас дөчин түмэн нь (өөрөөр хэлбэл гэр бүлийнх нь гишүүдийг эс тооцвол 400 мянган цэрэг) хятадын цагаан хэрмээс урагш орших нутгуудад үлджээ.[2135] Тогоон төмөр хаантай хамт дөнгөж зургаан түмэн хүн монгол руу буцсан байна. Үлдсэн бусад хүн хятадын янз бүрийн нутагт баривчлагдсаны ихэнхийг нь устгажээ. Аль хэдийнэ хаягдсан монгол нутаг өмнө зүгээс буцаж ирсэн олон зуун мянган хүнийг арай ядан хооллох төдий чадвартай байв. Тэгвэл хятадад мин улсын эрх баригчид монголын нөлөөг устгах, түүний дотор монголчуудыг уусгах замаар ингэхийн тулд бололцоотой бүхнийг хийв. Мин гүрний хууль тогтоомжид сонирхолтой заалт орсон нь: тэнд үлдсэн монголчуудад өөр хоорондоо биш, зөвхөн хятадуудтай гэр бүл болохыг зөвшөөрчээ.[2136] Энэ заалтыг зөрчвөл банз шаахай хэрэглэн зодох шийтгэл оноох буюу боол болгох ажээ.

Эртний уламжлалаар бол ямар нэгэн эзэнт улсыг жинхэнэ ёсоор хүлээн зөвшөөрөх явдал албан ёсны күнзийн түүх бичлэгээс ихээхэн хэмжээгээр

шалтгаалах бөгөөд энэ ажиллагааны төгсгөлийн шат бол албан ёсны түүх зохиох явдал байлаа. Үе залгамжлах эзэнт улсын хааны томилсон тусгай комисс энэ түүхийг бэлтгэж, бэлэн болсон бичвэрийг хаан өөрөө батлах ажээ.[2137] Күнзийн хэвээр хэвлэгдсэн хятад түүхчид хятад хэлээр гарсан 1368–1370 оны үйл явдлуудын хураангуйг “Юань ши”-гийн албан ёсны он дарааллын бичиг болгон хуулбарлаж тавина. Тэд монголчуудын түүхэнд болсон үйл явдлууд болон олон бие хүмүүсийн тухай мэдлэг муутай. Юань улсыг тэд өвөрмөц хятад шинж чанартай болгож дүрсэлсэнд гайхах зүйлгүй юм.

Гэхдээ энэ улс үүнээс хойш ч, өөрөөр хэлбэл хятадын Мин гүрэнтэй нэгэн зэрэг оршин тогтсон хэвээр байжээ. Хятадууд түүнийг Буй Юань буюу Умард Юань гэж нэрлэх бөгөөд 1370–1377 онд засаглалынх нь уриа Сюань-гуан, 1378–1387 онд – Тянь-юань байв.[2138] Түүний зэрэгцээ эзэн хаад нь урьдын адил хувийн гэсэн монгол нэртэй байжээ. 1388 онд их хаан Тогос Төмөр хятадуудад бутцохигдож, төрлийнхөө хүмүүст алагджээ. Түүний хүү буюу залгамжлагч Энх-Зоригт (1388–1392 ) эзэн хааны титмийн төлөө өрсөлдөхөөс зүрхшээж, мин улсын эзэн хаадаас айж хятадын хаан ширээний нэр аваагүй болохоор Тогос Төмөр юань улсын сүүлчийн хаан болжээ.[2139]

Гэвч монголын язгууртнуудын зарим хэсгийн дунд мин улсын гуравдагч эзэн хаан Жу Ди бол Тогоонтөмөр хаанаас гаралтай гэсэн домог бий болжээ.[2140] Мин улсын анхны эзэн хаан Жу Юаньжан Дайду хотыг авсныхаа дараа Тогоонтөмөр хааны бие давхар татвар эмийг ордондоо авч ирсэн бөгөөд түүнээс Жу ди төрсөн гэж монголын зарим язгууртнууд үздэг болжээ. Энэ домгоор бол Юаны удмынхан Монголд төдийгүй Хятадад ч хадгалагдан үлджээ.

Монголын хамгийн гайхамшигт он дараалын бичиг зохиолын нэг болох “Болор эрх”-д бичсэнээр бол Чингис хаанаас Лигдэн хаан хүртэлх (1592–1634) хамаг монголын хаад нэгдмэл ураг бүрдүүлж, Чингисээс Тогоонтөмөр хүртэлх хаад Өмнөд Юань улсыг, харин түүний хүү Биликт хаанаас Лигдэн хүртэлх эзэн хаад Умард Юань улсыг тус тус захирч байжээ. Ингэхлээр монголчууд хятад монголын эзэнт гүрнээс салж явсны дараа ч Хятадыг эзэгнэн захирах гэж эрмэлзсэн хэвээр байжээ.

Тийнхүү Аугаа их Монгол улс задарч, харьяат газрууд ч, түүний дотор монголын Юань гүрэн ч нэгэн адил задарчээ. Тийм болохоор БНХАУ-д Юань гүрнийг залгамжлагч болох гэж өрсөлдөх ямар ч үндэс байхгүй юм. Тэгэхдээ тулбал хятад сэтгэл зүйгээр бол Орос ч Хятадын нэг хэсэг

гэж тооцогдох ёстой болохнээ.[2141] Тэгвэл Унгараас Номхон дөлгөөн далай хүртэлх бүх нутгийг (мэдээжийн хэрэг БНХАУ-ыг оролцуулан) өнөөгийн Монгол улсын нэг хэсэг хэмээн үзэж яагаад болохгүй гэж? Мөн хэрэв эртний оросын хөлсний дайчид болж байсан номонууд буюу варягуудыг дурсах юм бол бүх скандиновын хойгийг ОХУ-ын нэг хэсэг гэж яагаад хэлж болохгүй гэж?

Юань гүрнээс тасарч гарсан хятад дахин улс болов. 1421 онд хятадын эзэн хаан нийслэлээ өмнө зүгээс Бээжинд шилжүүлжээ. Тэрээр монголчуудаас айж байсан учир батлан хамгаалалтынхаа умард хилд ойр байх гэж эрмэлзжээ. Тэнд Мин гүрнийг захирсан хятадын Жу овогийнхон байв. Энэ улсын хил монголын байлдан дагуулалт хүртэл оршин тогтносон хятадын умард Сун улсын хилтэй бараг давхацжээ.[2142] Гэхдээ сун улсын үзэл суртал хятад төвт загварыг хангалттай хэмжээний тууштай байдлаар хэрэгжүүлжээ. Тиймээс Мин улсын үзэл сурталчид хятадад монголчуудын учруулсан гутамшигт ялагдлын төлөө өшөө хонзон авахыг онцлон тэмдэглэхдээ хятадын уламжлалт үнэт зүйлсийг нэлэнхүйд нь сэргээн тогтоох гэж эрмэлзжээ.[2143]

Хятадууд монголчуудыг засгийн эрхийг хууль бусаар булааж авсан харийнхан гэж үзэж байжээ. Мин улсын анхны эзэн хаан Жу Юаньжан хаан ширээнд заларсныхаа дараа жил Түвд рүү элч явуулж тунхаг бичиг хүргүүлжээ. Энэ тунхагт: “Зэрлэг ху (монголчууд) Хуасяг (хятад) булаан эзлэж 100 гаруй жил эзэгнэжээ. Малгай, гутал хоёрын байр солигдоход уур нь хүрэхгүй эрүүл ухаантай хүн гэж байх уу? <...> Миний бие Тэнгэрийн дор голлох гүрэн улсыг үндэслэн байгуулав. Тэр улсаа Да Мин (Аугаа их Гэрэл) хэмээн нэрлэлээ” гэж бичжээ.[2144]

Монголын талын байр сууринаас бол мин улсын өнгөлзлөг бодит байдлын үүднээс ч, албан ёсны байр сууринаас ч ул үндэсгүй юм: монголын эзэнт улсуудын статус хятадыг эзэгнэх мин улсын эрх мэдлээр биш, харин монголын хаант улсуудаар тодорхойлогдож байлаа.[2145] Хятадууд Түвдэд эрх мэдлээ тогтоох гэж оролдсон боловч ямар ч үр дүнд хүрээгүй юм. Мин улс бол монголын “өв уламжлалд” санаархах эрхгүй гадаадын улс болохыг түвдчүүд, монголчууд ч, тэр үеийн хятадууд ч ойлгож байсан юм. Энэ бүхэн нь Мин улс Юань гүрэнтэй ямар нэгэн залгамж халааны шинж чанаргүйг батлан харуулж байна.

Түвд аймгууд болон сүм хийдүүдээс гадна Мин улстай хил залгаа ч оршиж байгаагүй Борнео, Цейлон, Филиппин, Аден, Герат, Самарканд, Медина, Исфахан зэрэг 121 газар алба гувчуур төлдөг байв.[2146] Элч нар,

худалдаачид нь Хятадад ирж байсан бүх хот, улс орныг алба гувчуур төлөгчөөр бүртгэж авсан бололтой юм. Японы далайн дээрэмчид хятадын эрэгт халдсантай холбогдуулан 1408 онд мин улсын эзэн хаан зарлиг гаргажээ. Тэрээр японы эзэн хаанд Мин улсын тушаалыг нэн даруй, үр нөлөөтэй биелүүлэхийг шаардсан байна.[2147] Энэ бүхэн "нэрлэсэн засаглал" гэгчийн тухай хятадын уламжлалд нийцжээ. Түүний зэрэгцээ Мин улсын эзэн хаад бодитой сэтгэгчид байсан учир бүх дэлхийг эрхэндээ оруулах гэж эрмэлзсэнгүй. Хятад улс дэлхийд хосгүй хэмээх үзэл санааг дэвэргэсэн нь ард олныг барьж байх гэсэн дотоодын шинж чанартай үйл ажиллагаа байв.[2148] Хятадуудын гадаад бодлогын үндсэн томьёолол бол: "Эрх баригчийн хувьд гадаад гэх зүйл байхгүй" гэх явдал ажээ.

Дараачийнх нь Манж чин улс юм. Мин улсаас хойд зүгт Амар мөрөн хавийн нутагт эрт дээр цагаас аж төрөн суусан тунгусын янз бүрийн үндэстэн ястны нутаг оршиж байв. Тэд хятадын эзэнт улсын бүрэлдэхүүнд орж байгаагүй юм. Тэдний удирдагчид хятадаас цол хэргэм, тусламж, эдийн засаг, улс төрийн давуу эрх авч байсан нь өөр хоорондын байнгын хэрүүл тэмцлийн үед үнэхээр чухал ач холбогдолтой байв.[2149] Түвдийн нэгэн адил энэ ард түмнүүд хятадтай бэлэг солилцож байсан бөгөөд үүнийг хятадууд алба гувчуур хэмээн үздэг байжээ. Хятад улс эдгээр ард түмний удирдагчдыг "нэг хэсэг зэрлэгүүдийг нөгөө зэрлэгүүдээр дамжуулан хазаарлаж тогтоох"-од амжилттай ашиглажээ.

Зүрчид аймгийн удам болох Тун омогийнхон Пэктусан уулын районоос (Солонгостой залгаа Манжуурын хил) манжуурын өмнөд хэсэг рүү шилжин суурьших болов. Маньжу хэмээх эзэмшил энэ овогийнхонд хамаарагдаж байв. Энэ омогийн удирдагч Нурхаци (1559–1626) хөрш зэргэлдээх аймгуудыг эрхэндээ оруулж, олзлогдсон олон хүнийг эзэмшилдээ аваачиж, хүчирхэг улсын эхлэлийг тавьжээ. Нурхаци 1589 онд өөрийгөө ван, 1596 онд Зянжоу улсын ван хэмээн зарлав.[2150] Түүний армийн үндэс нь кидан, тунгус аймгууд, монголчууд болон хятадуудаас улбаатай энгийн болон армийнхныг нэгтгэсэн тугийн систем байлаа. Эхлээд тус армид цэвэр цусны манж нар болон тэдэнтэй төрөл аймгуудаас бүрдсэн дөрвөн корпус буюу "тугууд" байв. Хожим нь бусад ард түмний "тугууд" байгуулагдав.

Эхний үед манж улс хятадуудаас хараат хэмээгдэж, Нурхаци мин улсын эзэн хаанаас цол хэргэм авч байжээ.[2151] Нурхаци янз бүрийн аймгуудыг нэгтгэж, хятадуудын эсрэг дайн хийж эхлэв. 1616 онд Нурхаци өөртөө хаан цол олгож, сүүлд Тянь-мин гэх(хятадаас орчуулбал: Тэнгэрийн заяат) засаглалын уриаг нэмжээ. Тэрээр зүрчидийн Зинь буюу Алтан улсын хаадтай

ураг төрөл хэмээн өрсөлдөх болсон байна. Тиймээс тэрээр өөрийнхөө овогийг алтан овог гэж зарлаж, тийнхүү сэргээн байгуулсан улсыг хятадын түүхчид Хоу Зинь буюу хожуу үеийн Зинь улс хэмээн нэрлэжээ. Манжийн эзэн хаад Монголын Лигдэн хааны эсрэг ялалт байгуулснаасаа хойш бид бол Юань улсыг залгамжлагчид, Чингис хааны тамга бидний мэдэлд байх ёстой гэж улам их тэмдэглэн хэлэх болсон байна. 1644 он гэхэд Зинь улсыг залгамжлагчид хэмээх үе бараг мартагдсан байв.

1618 онд Нурхаци Жун-го улсыг үзэн ядах болсон долоон шалтгаан гэгчийг илэрхийлэн хэлсэн байна. Мин улс “үнэн болон шудрага ёсны эсрэг” явж, нэгэнт тогтсон хил хязгаарыг зөрчсөн явдлыг бүх гомдол, үзэн ядалтын үндэс гэж тэр хэлсэн байна.[2152] 1622 он гэхэд манж нар хятадуудын эсрэг хэд хэдэн ялалт байгуулж, Ляодун хотыг булаан эзлэв. Тэнгэр бурхан миний тал руу эргэж, Мин улсаас нүүр буруулав гэж тэр хэлсэн байна.

Нурхаци 1623 оны хавьд хятадын эзэн хаанд явуулсан илгээлтдээ Тэнгэрийн дэмжлэг буюу цээрлэлийг илтгэн харуулахын тулд хятад болон бусад орны түүхээс авсан 19 үйлдлийг тоочин бичжээ. Тэрээр илгээлтээ дараах үгээр дуусгасан байна: “Хятад хүн чамайг тэнгэр бурхан цээрлүүлэн буруушааж, янз бүрийн муу ёр шүглүүлжээ. Чиний цэрэг бутцохигдож, чиний газар нутаг булаагдаж байхад чи “би юунд алдсанаа мэдэхгүй байна, миний улсын цэрэг аугаа сүр хүчтэй” хэмээх том том үг хэлсэн хэвээр байна. Муу хятад чи Тэнгэр бурхантай тэрсэлдээд хаа хүрнээ” гэжээ.[2153] Харваас, манж нарын гаргаж ирж буй учрын тодорхойлолт күнзийн сургаальтай яг таарч байгаа биз.

Манж нар 1625 онд нийслэлээ Сунгари голоос Мүгдэн рүү шилжүүлэв. Нурхаци 1626 онд насан өөд болжээ. Түүний хүү Абахай хятадаас бие даасан эрх баригч хэмээн тооцогдсон хэвээр байв.[2154] Эхний үед тэрээр Мин улсын эзэн хаанд явуулсан илгээлтдээ Манж бол хараат улс болохыг хүлээн зөвшөөрсөн боловч булаан эзлэх бодлого багримталсан хэвээр байлаа. Эзэнт гүрнээ өргөтгөх биш, харин цэргээ амьд хүчээр сэлбэхийн тулд хөрш зэргэлдээх аймгуудыг эрхэндээ оруулах явдал гол зорилго байв.[2155] 1636 оны тавдугаар сарын 5-нд манжийн хаан өөрийнхөө овог болон улсын хувьд Чин хэмээх нэр авсан нь хөрш зэргэлдээ орших хятадын Мин буюу (Гэрэлт) улсын эсрэг Чин буюу (Цэвэр) улс болсон байна.[2156]

1643 онд хятадад бослого гарав. Босогчид Бээжин хотыг эзлэн авч, Мин улсын эзэн хаан Жу Юзянь (засаглалын уриа – Чжун-чжэнь) амиа хорлов. Босогчдын удирдагч Ли Зычен хятадын Шунь хэмээх шинэ улсыг зарлан тунхаглав. Мөн онд чин улсын эзэн хаан Абахай насан өөд болсон байна.

Фулинийг эзэн хаанаар (засаглалын уриа-Шунь-чжи) зарлан тунхаглав. Бослогыг дарах хүчгүй болсон Мин улсын генералууд манж нарыг урьсан байна. Ингээд 1644 онд бага настай эзэн хааны авга ах Дорнониор удирдуулсан манжийн цэрэг Бээжин хотыг эзлэн авчээ. Хятадын хаан ширээг зүгээр л устгажээ.[2157] Фулинь хаан ширээнд суулгүй хятадыг Чин гүрний бүрэлдэхүүн хэсэг болгож, өөрөө энэ гүрний эзэн болсон байна.

Үүний дараа манжийн эзэнт гүрэн Да Цин-готой (Их Цэвэр улс) нэгэн зэрэг хятадын улсууд оршин тогтож байснаас: 1662 он хүртэл Мин улсын үлдэгдлүүд; 1673-1678 онд Ханжоу нийслэлтэй У Саньгуй улс; Тайвань бие даасан нутаг дэвсгэр байсан бөгөөд 1683 онд л тэнд манж нарын эрх мэдэл тогтсон байна.

Хятадын үндэстнүүд манж нарыг “гуань вайды жэнь” буюу “боомтын гадна байгаа хүмүүс”, өөрөөр хэлбэл Их хятадын цагаан хэрмийн гадна талд байгаа хүмүүс хэмээн нэрлэж байв.[2158] Чухамдаа тэнд манж нарын овог удамын нутаг,тэдний хуучин иийслэл Мүгдэн хот байсан бөгөөд манж нар 1668 онд энэ хотод хятадууд ирж суурьшихыг хоригложээ. Тэдний улсыг тариачдын хөнөөн устгах дайны дараа Чин гүрэнтэй нэгтгэсэн нь Хятадын хүн ам эрс цөөрөхөд хүргэжээ. Хятадад 1623-аас 1660 онд 10 сая гаруй хүн алагдаж, мөн олон сая хүн халдварт өвчин, өлсгөлөн, гуйланчлалаас[2159] болж нас барж, олон хүн боол болов. Хятадууд Чин гүрнээс салан тусгаарлах оролдлогоо зогсоосонгүй Эзлэгдсэнээс хойшхи эхний 18 жилд манжийн эсрэг бослого хөдөлгөөн нэг зуу гаруй удаа гарсан байна.[2160]

1850 онд л Дорнод Хятадад гарсан бослого амжилтад хүрч, Юньнань, дараа нь Нанжинд нийслэлтэй бие даасан улс байгуулагдав. Босогчид шинэ улсаа Тайпин Тяньго буюу Аугаа их Буян хишиг, Тэгш эрхийн Тэнгэрийн улс хэмээн нэрлсэн байна. Нанжин хотыг Юань улсаас салан тусгаарлах бааз болгон ашиглаж байсан Мин гүрний удирдагчдын жишээг тайпиний эрх баригчид дагасан байна. Тайпинчууд христосын шашин мөрдөхөө мэдэгдэж, буддийн болон даосын шашны бүх ном, сударыг устгаж, күнзийн сургаалийг хяналтад авч, түүнийг тусгай тайлбар зүүлттэйгээр хэвлэн гаргах болсон байна.[2161] Тэд удирдлагын тогтолцоо болон арми байгуулав. Эрх баригч нь тэнгэрийн ван хэмээх цол авав. Түүний зэрэгцээ үйлдвэрлэлийн хүрээнд бүх нийтийн тэгшитгэлийн систем нэвтрүүлэх гэж оролджээ.. Гэвч яваандаа Тайпин хуучин маягийн хан (хятад) улс болон хувирсан байна. Тус улсын удирдагчид 1852 онд: “Хятад бол толгой нь, харин манж нар хөл нь юм. Хятад бол ариун орон, харин манж нар бол бузар шуламууд. Гэхдээ энэ шуламуудын хөл нь толгой дээрээ гарчээ” гэж бичжээ.[2162] Тайпин тэр

үед цорын ганц хятад улс байсан бөгөөд Чин гүрэнтэй хил залган оршиж байжээ. 1864 онд Чин улсынхан Өрнөдийн улсуудын дэмжлэгтэйгээр Тайпинийг эзлэн авчээ.

Манж нар өөрсдийгөө хятад хэмээн үзэж байгаагүй юм. Манжийн эзэн хаад,тэдний ойрын төрөлүүд, өөрөөр хэлбэл язгууртнуудынх нь эхний зургаан үе зөвхөн манж нар болон монголчууд байв.[2163] Манжийн язгууртнууд гол төлөв монгол гүнж авдаг байв. Гол хэл нь манж хэл (хятад хэлэнд огт хамаагүй алтайн язгуурын хэлнүүдийн тунгус-манж бүлгийн хэл). Манж гүрэнд манж хэлний дараа монгол, хятад хэлүүд хэрэглэгдэх ажээ. Хятадыг байлдан эзлэхээс өмнө 1599 онд Нурхацийн үед ажиллаж байсан хоёр монгол орчуулагч Эрдэнэ багш, Гагай заргач нар манж бичиг үсэг зохиосон байна. Уйгур бичигт үндэслэсэн монгол цагаан толгой манж бичиг үсэгийн үндэс болжээ.

Манжийн эзэн хаад эрх мэдлээ бататгахын тулд хятад уламжлалыг баримтлан санаандаа үл нийцсэн түүхэн зохиолуудыг хяналтад оруулж, заримыг нь устгах болжээ. Тиймээс чин улсын түүхийн олон эх сурвалж, ялангуяа Чин болон Мин улсын сурвалж бичгүүд туйлын ховор болжээ.[2164] Чин улсын эрхтнүүд Хятадад өргөн уудам эзэмшил газартай болж бусдын гэр байшинг булаан авч, эздийг нь хөөж гаргадаг байв. Үүний улмаас, түүнчилэн өмнөх байлдааны ажиллагаануудын улмаас Манжийн умард болон төв нутгийн хүн ам эрс хорогдсон байна. Манж нар тоогоор дэндүү олон хятадуудын дунд үндэстнээ хадгалж үлдэхийг эрмэлзэхдээ ялгаварлан гадуурхсан хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Тэдгээрийн заримаас дурдъя.[2165] 1662 оноос 1792 оныг дуустлах хугацаанд Чин гүрний тамгын газарт манж, хятад, монголчуудын эзлэх харьцаа ямагт 5:2:1 байлаа. Эхний үед төрийн болон цэргийн бүх чухал хэргийг эзэн хаан зөвхөн манж нар ажилладаг дээд язгууртны зөвлөлтэй хамтран шийддэг байжээ. 1720-иод онд тэр зөвлөлд хэд хэдэн хятад хүн оруулсан боловч шийдвэрлэх санал манж нарт хэвээр үлдсэн байна.

1911 оны Синьхайн хувьсгал хүртэл манж нар эзэнт гүрний гол албан тушаалд бат суурьтай сууж байв.[2166] Хятадуудад эрх мэдэл гартаа төвлөрүүлэхэд хязгаар тогтоосон байна. Хятад түшмэд төрсөн муж, нутагтаа алба хаах эрхгүй байв. Манж нар хятад хуульд захирагдахгүй, харин хятадууд манжийн хуулийг дагаж мөрдөх ёстой ажээ. Адил гэмт хэрэг үйлдсэн хятад, манж хоёр хүн байлаа гэхэд манжид нь хөнгөн ял оноох жишээтэй. Манж, хятад хүмүүс гэр бүл болохыг хоригложээ. Манж нар цорын ганц язгуур угсааныхан болон цэргийнхнийг бүрдүүлэх ажээ. Тэдэнд худалдаа-аж

үйлдвэрийн үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Бүр XIX зууны дундуур эзэн хаан Миньнин (засаглалын уриа – Дао-гуан) манж нар морь унаж явах, нум сум харвах, манж хэлээр бичиж, ярихаас гадна ямар нэгэн төрийн боловсрол эзэмшихийг эсэргүүцэж байжээ. Үнэнийг хэлэхэд бодит байдалд үүнийг сахиж мөрдөх нь ховор, тэр дундаа түшмэлүүдийн тухайд бүр ч боломжгүй байжээ. Хятадын уламжлалт эрдэм боловсролыг эхний үед зөвхөн хятадуудын дунд л сайшаан дэмждэг байв. Хятадууд манжийн эзэн хаанд захирагдаж буйн тэмдэг болгож үсээ хусуулж, гэзэг унжуулж явах ёстой байв.Эхний үед хятадууд үүнийг эсэргүүцсэн боловч тийм хүмүүсийг цаазлан хороож байв. Манж, монгол бүсгүйчүүд хятад хүүхнүүдийн нэгэн адил хөлөө жижиг болгох албагүй болжээ. Манжийн засгийн газар засгийн эрхийг хэвээр барьж байхын тулд л өөрийн мөхөлтийн өмнөхөн ялгаварлан гадуурхсан арга хэмжээнүүдийг хүчингүй болгосон байна.

Манж нар юуны өмнө Дундад улсын үзэл баримтлал,”Тэнгэрийн заяат” эзэн хааны эрх мэдлийг хятадуудаас өвлөж авчээ. Энэ үзэл баримтлал нутаг дэвсгэрийн өнгөлзлөг, тухайлбал хятадын эсрэг ийм өнгөлзлөг хийх явдлыг зөвтгөжээ. Энд Юань гүрний түүх ямар нэгэн хэмжээгээр давтагдсан байна. Манж нарт дэлхийг ноёлох өөр загвар байгаагүй бизээ.

Манж нар эзэн хааны эрх мэдлийн үзэл баримтлалын хамт алба гувчуурын системийг уламжлан авчээ. Албатын системд үнэнч байх явдлын үндсэн шалтгаан бол үндэсний аюулгүй байдал мөн гэж чин улсын эрх баригчид нотлох бөгөөд чин гүрэнтэй харилцахыг хүсч буй хэн бүхэн үүнийг эзэн хааны “албатын” журмаар л гүйцэтгэх ёстой ажээ. Аугаа их чин гүрний жинхэнэ бөгөөд тууштай тэмдэглэлүүд (“Да Цин ли-чао ши-лу”) хэмээх бичигт заасан хараатуудын нэрсийн жагсаалтаас үзэхэд энэ систем утга учиргүй зүйл болох нь харагддаг юм. Түвд, Турфан, Солонгос, Аннам, Сиам, монголын улсууд зэрэг,хятадын хөрш орнуудын зэрэгцээ “албатуудын” бүрэлдэхүүнд Лаос, Португали, Ромын папын улс, Орос, Ява, Англи, Голландыг оруулжээ.[2167] XVII зуунд Солонгос улс Бээжингээс хараат болохоо хүлээн зөвшөөрч, XVIII зуунд Бирм, Вьетнам, Балба улсууд мөн ийм алхам хийжээ. Хожим нь Бээжингийн эрх баригчид Бутаныг мөн албатаа хэмээн зарлажээ. 1662-оос 1875 оныг дуусталхи хугацаанд 18 орныг Чин улсын “албатуудын” нэрсийн жагсаалтад оруулсан байна.[2168] Дээрх нэрсийн жагсаалтад мөн Рюкю, Сулу, Киргиз, Кокандыг оруулжээ. Ямар учраас ингэсэн юм бол? Эд бүгдээрээ хятадын бүрэлдэхүүнд орж байсан гэж үү?

Голландыг оруулсан явдал үнэхээр гайхал төрүүлэхээр ажээ. Голланд

улс 1653 онд эзэн хаанд алба гувчуур илгээж байх онцгой эрх олгохыг хүссэн юм гэж дээр дурдсан баримт бичигт өгүүлжээ. Эзэн хаан Сюаньегийн (засаглалын уриа – Кан-си) зарлигт: "Хо-лань улсын элч алба гувчуур өгөхөөр ирэхдээ өөрийнх нь улс оросуудтай холимог хэмээн мэдээллээ" гэж өгүүлсэн байна.[2169] Энэ орон Тайваны эргээс босогчид болон далайн дээрэмчдийг хөөж явуулахад эзэн хааны отрядуудад тусласан юм гэж энэхүү зарлигт мөн өгүүлсэн байна. Бодит байдалд бол голландчууд худалдааныхаа бэхлэлтийг далайн дээрэмчдээс хамгаалсан ажээ.

Орос, Их Британий талаар ч иймэрхүү худал мэдээлэл хийж байжээ. Түвд, монголын ванлигуудын түшмэд болон вангуудын хэрэг эрхлэх асуудал эрхэлсэн гадаад харилцааны (Лифаньюань) танхимын 4-р экспедицийн мэдэлд оросуудтай бичиг захидлаар харилцаж байсан тухай мэдээлэл бий юм. Тэнд хятадуудыг оролцуулдаггүй зөвхөн манж, монгол хүмүүс ажилладаг байжээ.[2170] Ёслолын яамны гадаад зочдын хэрэг эрхлэх газар бусад оронтой харилцах асуудал эрхэлдэг байв. Оросуудыг гадаад харилцааны танхимд хариуцуулсан нь тохиолдлын хэрэг биш байжээ. Юань гүрний эзэн хаадын тамгыг бид эзэмшиж байгаа бөгөөд Орос улс урьд өмнө Монголын их эзэнт гүрний бүрэлдэхүүнд орж байсан юм гэж чин улсын эзэн хаад баталдаг байжээ. Монголын "уламжлалд" санаархдаг чин улсын эзэн хаад "Хятадын албат" болсноо ч мэдээгүй байсан оросуудыг эзэнт улсынхаа бүрэлдэхүүнд оруулсан байж болох юм.

Оросын элч нар манжийн түшмэлүүдтэй хэлэлцээ хийж байсан тухай баримт бичгүүд хадгалагдан үлджээ. Манж түшмэд эдгээр элч нарыг "зэрлэгүүд алба гувчуур төлж байсан" үйл явдал мэтээр харагдуулахыг эрмэлзжээ. Эзэн хаан Сюанье: "Тэнгэрийн доорхи их улсын аугаа их эзэн хаан миний бие Хятадад болон өөр газарт байхаас үл хамааран дэлхийн бүх оронд аж төрөн суугаа бүх хүмүүсийн төлөө бага жаахан хүүхдүүдийн нэгэн адил анхаарал халамж тавьж, хүн бүр өөр өөрийнхөөрөө жаргаж, оршин суугаа нутаг орондоо энх амгалан байхыг хүсч байна" гэж бичжээ.[2171] Сюанье мөн Далай лам болон монголын ноёдод явуулсан илгээлтдээ өөрийгөө "дэлхийн захирагч" хэмээн нэрлэсэн байна.[2172] Оросын хаан Алексей Михайловичаас чин улсын эзэн хаанд явуулсан жуух бичгийг чин улсын түшмэд орчуулсан бололтой юм. Оросын хааны цол хэргэмүүдийг тоочсоны дараа чин улсын эзэн хааны цолыг "бүх улсын ерөнхий эзэн, Дундад иргэн улсын аугаа их хаан" гэж орчуулсан байна.[2173]

1793 онд чин улсын эзэн хаантай уулзахаар ирсэн английн элчийн хөлөг онгоцон дээр "английн талаас алба гувчуур авч ирэгч" гэсэн үгтэй

далбаа мандуулахыг шаардаж байжээ. Эзэн хаан Хунли (засаглалын уриа – Цянь-лун) энэ элчийг буцахын өмнө английн хаан III Георгт хаягласан лүндэн гардуулжээ. Уг лүндэнд:

“Далай тэнгэсийн чанадад алс хол оршин суугаа ч манай соёл иргэншлийн буян хишгийг хүртэх ариун хүсэл эрмэлзэлтэй эрхэм дээд эзэн таны зарж явуулсан элч нар Таны илгээлтийг бидэнд хүндэтгэн хүргэж иржээ. Таны илгээлтийн нухацтай үг хэллэгүүд Таны зүгээс машид хүндэтгэлтай хандаж буйг илэрхийлэн харуулсныг тэмдэглэхэд тааламжтай байна. <...> Танай орны зүгээс хятадтай хийх худалдаанд ажиглалт тавих Танай төлөөлөгчийн газрыг миний тэнгэрийн ордны дэргэд нээх тухай Таны илгээлтийн тухайд бол тийм хүсэлт миний эзэнт гүрний бүх заншилд харшлах бөгөөд энэ хүсэлтийг хүлээж авах ямар ч боломжгүй. <...> Миний бие тэр холоос бэлэг явуулсан таны сэтгэлийг л бодож энэ бэлгийг хүлээж авах шийдвэр гаргасныг болгоон соёрхоно уу. <...> Манай эзэнт гүрний аугаа их ялалтууд Тэнгэрийн доорхи бүх оронд нэвт шингэж орсон учираас хуурай газар, тэнгэс далайн бүх үндэстний эзэн хаад бидэнд үнэтэй бэлэг явуулдаг билээ. Бидэнд дутагдах гачигдах зүйлгүйг Таны элч нүдээр харж итгэсэн гэдэгт найдаж байна. Би заль ухаан гаргаж хийсэн хачирхалтай эд зүйлсийг тань үнэлж тоохгүй, ер нь ч Танай орны эд зүйлс бидэнд хэрэггүй. <...> Чичрэн дагагтүн, цалгар байдал бүү үзүүлэгтүн” гэж өгүүлжээ.[2174]

Энд Тэнгэрийн доорхи улс гэдгийг ерөөс дэлхийн бүх орон, манжийн эзэн хаан гэдэгт энэхүү тэнгэрийн доорхи улсын захирагч хэмээх утгаар хэрэглэсэн нь тодорхой байна.

Чин улсын түшмэд европын элчин сайд нарыг хүлээж авахдаа тэдний итгэмжлэх жуух бичигт эрх тэгш орны элчин сайдаас мөн тийм орны эрх баригчид барих жуух бичиг хэмээх утгатай “шу” гэдэг үгийн оронд хараат орны баяр хүргэсэн илтгэл хэмээх утга илэрхийлсэн “бяо” гэдэг үг хэрэглэсэн эсэхийг шалгадаг байжээ.[2175] Элчин сайдыг оролцуулан тус яамны ажилтнууд нэг командаар эзэн хааны өмнө өвдөг сөхрөн сууж, дараа нь гурван удаа толгойгоо газарт хүргэн мөргөх ёстой байв. Хүндэтгэл үзүүлэх ёслолын төгсгөлд дээрх үйлдлийг хийх ажээ. Элчин сайд нар нь доромжлолын шинжтэй энэ ёслолыг үйлдэхээс татгалздаг учир зарим орны элчин сайдын яам нээх ажил амжилтгүй байв. Ингэхлээр зарим “зэрлэгүүд” “гэгээрсэн биш” байдлаараа үлддэг ажээ... Энэ нь бусад ертөнцийн (“зэрлэгүүд”) “гэгээрэл” цаг хугацааны л асуудал хэмээх үзэл санаанд үл харшилна. Жишээ нь, 1795 онд эзэн хаан Хунли Түвдийг Жун-гогийн гадна талд байгаа зах хязгаар (вайфань) хэмээн нэрлэжээ.[2176] Гэхдээ Түвдийг

Оростой харьцуулах ёсгүй юм. Одоогоор зэрлэг хэвээр байгаа бөгөөд соёлд сургах ёстой Оросыг “зэрлэг улс” хэмээн нэрлэх нь зөв юм гэж хэлсэн байна.[2177]

Цаашид манжийн засгийн газар Өрнөдийн улам өсөн нэмэгдэж буй шахалт болон түрэмгийллийг албатын уламжлалт харилцаа гэж харуулахыг эрмэлзэж байв. Эзэн хаан Сюаньзуны үед (1821–1850 онд төр барьсан) гарсан “хар тамхины” дайны үеэр хааны зөвлөхүүд түүнд: “Зэрлэг англичууд манай хаант улсын үед алба гувчуур төлөхөөр хааны ордонд хэд хэдэн удаа иржээ. Тэд зэрэг дэвийн хуваарилалтыг манай улсаас зээлдэж авсан байна, тэдний албаны бүх хүн хятадаар ярьж байна” гэж мэдээлжээ.[2178]

19-р зууны хоёрдугаар хагаст өрнөдийн гүрнүүдээс хятадад тулган хүлээлгэсэн эрх тэгш бус гэрээ хэлэлцээрүүдийг чин улсын удирдлага дээрх байдлаар тайлбарлахыг эрмэлзэж байжээ.[2179] Өрнөдийн гүрэнтэй эрх тэгш бус гэрээ байгуулсныг тэр зүгээс дуулгавартай хандсан явдал, түүнийг хяналтандаа барьж байх боломж, “зэрлэгүүдийн талархлыг хүлээх” боломж хэмээн тайлбарлаж байв. Тийм харилцаа өрнөдийнхний булаан эзлэх бодлогыг тогтоон барьж байсан юм гэж Бээжингийн эрх баригчид тайлбарлах ажээ. Англи, Францийн түрэмгийллийг “номхотгох” хэрэгтэй “зэрлэгүүдийн бослого” хэмээн тайлбарлажээ. 1860 оноос хойш Бээжин дэх гадаад гүрнүүдийн элчин сайд нар эрх тэгш орнуудын төлөөлөгчдийн нэгэн адил төрийн тэргүүнд бараалхаж итгэмжлэх жуух бичгээ барьдаггүй, харин “албат” орнуудын төлөөлөгчдийн адил үзэгддэг болсон байна.

Энэ бүхнийг европын орнууд хятадад захирагдаж буйн “баримтжуулсан нотолгоо” гэж тайлбарлаж ч болох ажээ.

Тийнхүү Чин гүрэн бол хан үндэстний эзэнт улсын үзэл суртлыг хүлээн зөвшөөрсөн манж улс мөн. Манж нар болон хятадууд бол өөр өөр гарал үүсэлтэй, өөр өөр түүхтэй өөр ард түмнүүд мөн. Чин гүрэн бол хятад биш, харин хятадыг байлдан эзлэхээс бүр өмнө түүний гадна талд манж нарын байгуулсан улс юм. Манж нар хятадыг өөртөө нэгтгэхдээ түүний төрийн системийг, Монголыг нэгтгэхдээ Монголын эзэнт гүрэнтэй залгамж халааны холбоотойгоо онцлон тэмдэглэж байжээ. Хятад төвт гадаад улс төрийн загварыг яс мөрдсөн нь улс орныг удирдах манж нарын хууль ёсны шинж чанарыг бэхжүүлсэн юм гэж манжийн язгууртнууд үзэж байжээ.[2180] Энэ нь хан үндэстэн феодалуудын хэд хэдэн хуучин эрх, дархыг хангасан хятад засаг захиргааны загварыг хятад нутагт ашиглахад тус дөхөм болжээ. Манжийн эзэнт гүрэнд эзлэгдсэн Мин улсын юуны өмнө дотоодын хэрэгцээнд ашиглах үзэл суртлын үзэл бодол бүрэн хэмжээгээр илрэн

гарчээ.[2181]

Тийнхүү Европ дахь “династия” хэмээх нэр томьёо болон түүний хятад орчуулга өөр өөр утга санаа илэрхийлж байна. Европт бол “династия” гэсэн үг бие биенээ халж гарч ирсэн гэр бүлүүдийн нэг төлөөлөгчдийн овог юм. “Хятад династия” (“хятадын эзэнт улс”) нь хаант засгийн хятад үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрсөн нэг овгийн хүний засаглалын хугацаагаар хэмжигдэх улсын нэр, тэгэхдээ энэ бол хятадыг нэг хэсгээ хэмээн нэгтгэсэн тийм улс буюу нэг хятад улс буюу улс хэмээн зарласан түүний нэг хэсэг буюу хятадтай хил залгаа улс юм. Хэрэв Европт “династия” хэмээх ойлголт (нэг овогтой хэд хэдэн эрх баригч) улс гэсэн ойлголтоос тусдаа байдаг бол Хятадад энэ хоёр ойлголтыг нэгтгэжээ. Европт янз бүрийн овгийн хаад байж болно, улсууд үүсч, үгүй болж, бусдад нэгдэж, задран унаж болно. Гэтэл Хятад (Жун-го) үүрд байна, яагаад гэвэл бусад аль нэгэн орноос давуу, эзэн хаан нь бүх дэлхийг захирах үүрэгтэй. Хятад хуваагдаж болно, харин дараа нь заавал эргэж нэгдэнэ. Гэхдээ хятад өөр улсын нэг хэсэг байж болохгүй, түүнийг булаан эзлэсэн нөхцөлд ийм байж болохгүй: яагаад гэвэл аливаа улс түүнд захирагдах тавилантай гэнэ. Ингэхлээр Хятадын дотоодод засаг солигдож байсан, тодруулж хэлбэл тухайн үед улсыг нэрлэж байсан засаглалын үеийн нэр л солигдож байсан болж байна.

Хятадад хэн төр барьж байсан, хятад нь ямар нэгэн улсын бүрэлдэхүүнд бүрэн буюу хагас байдлааар орж байсан зэргээс үл хамааран энэ бүхэн бол “Хятадын янз бүрийн эзэнт улсууд” ажээ. Хуучирсан энэ систем устаж алга бололгүй оршсоор л байна. Харин ч БНХАУ-ын “үндэстэн байгуулалтын” үндэс болжээ.

### *Хятадад үндэсний асуудлыг шийдвэрлэсэн нь*

Хятадад “үндэсний цөөнхийнхөн” засгийн эрх барьж байсан гэж ярьдаг. Энэ нь ямагт хятадуудын эрх мэдлийг сэргээн тогтоох явдлаар, тэд шинэ шинэ нутаг дэвсгэртэй болох явдлаар дуусч байжээ. Бүр хорьдугаар зууны эхээр өрнөдийг судлагч, ардчилал ба хятад даяаршлыг өмгөөлөн хамгаалагч Лян Цичао үүнийг тов тодорхой томьёолжээ:

“Манай өвөг дээдэс 5 мянган жил хөдөлмөрөө зориулсан нэг аугаа их үйл хэрэг бий билээ. Энэ нь ямар үйл хэрэг вэ? Би түүнийг “хятад үндэстнийг өргөтгөх явдал” хэмээн нэрлэе. Эхлээд манай хятад үндэстэн Шаньдун, Хэнаньд аж төрөн амьдарч байсан хэдхэн жижиг аймаг байв. Олон мянган жилийн турш тэд өссөөр, өссөөр, өссөөр, асар том, сүр хүчит

улсыг байгуулсан аугаа их үндэстэн болтлоо бойжжээ. Манай үндэстэн хоёр замаар өссөн байна: нэгдүгээр зам- энэ бол манай хилийн дотор болон гадна талд байсан тоо томшгүй олон ястанг уусгах явдал, хоёрдугаар зам- энэ бол манай үндэстний хүмүүсийг жилээс жилд хил рүү шилжүүлэн суулгаж, нутаг дэвсгэрээ өргөтгөх явдал мөн. <...> Түүх таван мянган жилийн турш энэ л замаар явж иржээ" гэж тэрээр бичсэн байна.[2182]

Хан үндэстэнд эрт дээр цагаас өөрийгөө бат бэх барилдлагаар нэгдсэн эх орон нэгт ах дүү нарын нэг бүрэлдэхүүн хэсэг гэсэн ухамсар тогтжээ[2183] гэж Лян Цичао тэмдэглэжээ. Хятадууд гол төлөв холимог хүн ам бүхий нутгуудад оршин суудаг хятад биш хүмүүсийн зан заншилд хүндэтгэн ханддаг юм гэж тэр бичсэн байна.[2184] Энэ нь эсэргүүцлийн хөдөлгөөн зохион байгуулах гэсэн оролдлогуудыг саармагжуулж, ингэснээр уусгалт амжилттай хэрэгжиж байжээ. Тэрээр хятад үндэстний хүмүүсийн гол дутагдлуудын тоонд эх оронч үзэл сул хөгжсөн, төр улсын тухай хийсвэр төсөөлөлтэй, тусгаар тогтнолын тухай асуудалд хөнгөн байдлаар ханддаг зэргийг нэрлэж оруулсан байна.

Сүүлийн 900 жилд хятадыг байлдан эзэлсэн хэн бүхэн эцсийн дүнд өөртөө хор хүргэдэг, яагаад гэвэл тэд эзэнт гүрнийхээ бүрэлдэхүүнд ялагчдаасаа хэдэн зуу дахин олон хүн амтай орныг оруулах нь эрт орой хэзээ нэгэн цагт өөрсдийг нь залгихад хүргэхийг ойлгоогүйгээс л дээр дурдсан байдалд ордог.

XX зууны эхээр хятадууд энэ "дутагдлаа" амжилттай даван туулжээ. Синьхайн хувьсгал хятадын үндсэрхэх үзлийн уриан дор болсон тухай бид өмнө авч үзсэн билээ. Хятадын үндсэрхэх үзэлтэн бол "бүгд найрамдах улсын эцэг" Сунь Ятсен байлаа. Хилийн чанадад хувьсгалын ажлаа эхлүүлэхэд энэ үзэл саад болоогүй ажээ. Манж нар бол "араатан авиртай, хүмүүсийн харилцаа яаж тогтох ёстой тухай ямар ч төсөөлөл тэдэнд байгаагүй юм. <...> Зэрлэгүүд соёл иргэншилтэй ард түмнийг удирдаж чадахгүй, зэрлэг аймгууд Хятадыг эзэгнэн ноёлож чадахгүй. <...> Хуанди хааны удам хятадууд бид дээрэмчин манж нартай нэг тэнгэр дор амьдарч болохгүй, нэг бол бид тэднийг, үгүй бол тэд биднийг устгана" гэж тэр хэлсэн байна.[2185]

1905 онд Сунь Ятсен хятадын хувьсгалт байгууллагуудын холбоо – Тунмэн-хуэйг Токиод тэргүүлжээ. 1905 оны наймдугаар сард гарсан энэ холбооны тунхаглалд хувьсгал болон улс орны ирээдүйн удирдлагын зорилтуудыг илэрхийлэхдээ: "Хятад улс байгуулагдсан цагаас эхлэн түүнийг ямагт хятадууд удирдаж ирсэн, засгийн эрхийг өөр аймгийнхан булаан эзэлж байсан ч бидний өвөг дээдэс ямагт тэднийг хөөн зайлуулж, Эх

орныхоо яруу алдрыг сэргээн тогтоож, түүнийг хойч үеийнхэндээ хадгалан үлдээх хүчтэй байсан юм. Эдүгээ ханьчууд шудрага ёсны төлөө, умардын зэрлэгүүдийг хөөн гаргахын төлөө тэмцлийг зарлан тунхаглаж байгаа нь өвөг дээдсийнхээ яруу алдарт гавьяаг үргэлжлүүлж буй явдал мөн. <...> Одоо бидний манж нар хэмээн нэрлэж буй тэр хүмүүс бол манай хилийн цамхагуудын цаана амьдарч ирсэн дорно зүгийн зэрлэг аймгийнханд хамаарна. Мин улсын үед тэд манай улсын хилийг байнга түгшээж ирсэн юм. Хожим нь Хятад дахь үймээн самууныг ашиглан тэд манай хил хязгаарт цөмрөн орж, манай хятад улсыг устгаж, засгийн эрхийг булаан авч, хятадууд биднийг аргагүйн эрхэнд өөрсдийн боол болгосон юм. Тэд тэмцэж боссон олон сая хүнийг устгаж хөнөөсөн. <...> Хятад орон хятадуудын улс болох ёстой, энэ улсыг хятадууд удирдах ёстой билээ. Манж нарыг хөөж гаргасны дараа манай үндэсний улс алдар суугаа сэргээн тогтоох болно" гэжээ.[2186] Сунь Ятсен 1906 онд Токиод хэлсэн "Ардын гурван зарчим" хэмээх үгэндээ хятадууд засгийн эрхийг гартаа авсан цагт л төр улсаа байгуулна, эс тэгвээс төр улс манай хятадын биш хэвээр байх болно. <...> Бид дэлхийн хамгийн том үндэстэн, хамгийн эртний, хамгийн соёлтой үндэстэн билээ гэж онцлон тэмдэглэжээ.[2187]

"Хятад хүн" гэсэн ойлголт "хан үндэстэн" хэмээх ойлголттой адил юм. Гадны аймгийнхны эзэнт улсыг устгах замаар хятад үндэсний улсаа сэргээн байгуулах явдал гол зорилго болж байна. Хилийн чанадаас зээлдэж авсан бүгд найрамдах улсын үзэл санаа л мөн чанартаа шинэ зүйл болж байна. XX зуун хүртэл хятадад манж нарыг цэргийн явцуу бүлгээс тогтсон гадаадын булаан эзлэгчид хэмээн үзэж ирсэн юм. Зарим талаар хятаджисан ч тэд хятадууд болоогүй юм. Хэрэг дээр Цысийг нас барах хүртэл манж нар болон хятадуудын хооронд гүнзгий зааг хэвээр байсан юм гэж онцлон тэмдэглэжээ.[2188]

Тийнхүү манж нарын эсрэг чиглэсэн хувьсгалчдын зэмлэл суртал нэвтрүүлэг төдий байсан юм бишээ. Энэ зэмлэл манжийн эзэнт улс бол хятад биш байсан хэмээх тэр үеийн бодит байдалд үндэслэжээ. Цаашлаад энэ нь хувьсгалын дараа хятадад манж нарыг ялгаварлан гадуурхахын үндэс болжээ. Манж нар өөртөө засах эрхгүй цорын ганц "үндэсний цөөнх" болжээ. Маогийн үед манж хэл судлах дугуйлан буюу сонгон суралцах хичээл зохион байгуулах гэсэн аливаа оролдлогыг хувьсгалын эсэргүү ажиллагаа болон хаант засгийн эсрэг тэмцлийн хүрээнд таслан зогсоодог байсныг хэдий чинээ надад мэдэгдэнэ.

Синьхайн хувьсгал 1911 онд эхлэв. Энэ хувьсгал Манж Чин улс задран

унаж, Бүгд найрамдах Хятад улс зарлан тунхаглахад хүргэжээ. Зарим хувьсгалчид түүнийг нийгмийн асуудлыг үл тоон “арьсны өнгийн хувьсгал” гэж нэрлэж байлаа. Бүх мужийн засгийн газар хаант засгийг түлхэн унагаж, хятад үндэстний бүгд найрамдах улс байгуулах гол зорилго дэвшүүлэн тавьжээ.[2189] Сунь Ятсен францад байхдаа 1911 оны аравдугаар сарын 26-нд Бүгд найрамдах хятад улсыг зарлан тунхаглав. Хятадын Нанжин хотод 1912 оны нэгдүгээр сарын 1-нд энэ улсыг зарлан тунхаглах ёслолын ажиллагаа болсон байна.

Дээр дурдсан Сунь Ятсений ишлэлт түүний анхан үеийн үзэл бодлыг тусган харуулж байна. Хувьсгалын дараа хятадын нутаг дэвсгэрийн тухай асуудал гарч ирэв. Нутаг дэвсгэрийн өнгөлзлөг түүхэн хязгаар буюу хятадын цагаан хэрмээр хязгаарлагдсангүй, “зэрлэг” манж нарт эзлэгдсэн бусдын нутаг дэвсгэрийг хамрах болов. Эдгээр нутаг дэвсгэрийг эзэмшигч ард түмнүүдийн асуудлыг шийдэх хэрэгтэй байлаа. Бүх ястан хан үндэстний дотор уусч, төмөр хайлах зууханд орсон мэт “хайлж урсах” ёстой юм гэж аугаа их хувьсгалч үзсэн бөгөөд түүнд америк үндэстний тухай хуучин үзэл баримтлал нөлөөлсөн байж болох юм.[2190] Түвд, монгол, түрэг ард түмнүүд хувьсгал хийж, бүгд найрамдах улсаа байгуулахын оронд тусгаар тогтнохыг л хүсч байгаа хэмээх санаа бодол түүнд нөлөөлсөн байж болох, тийм болохоор асуудлыг шийдвэрлэх хамгийн шилдэг арга бол хөршүүдийгээ уусгах эртний хятад онол байсан бизээ.

Сунь Ятсен хилийн чанадад хийсэн аялалаасаа зөвхөн америк үндэстний үзэл баримтлалтай танилцсан хэрэг бишээ. Тэрээр мөн XX зууны эхэн үеийн сонгодог үндсэрхэх үзэлтэй танилцсан бололтой юм. Энэ үзэл баримтлалынхан үндэсний цөөнхөөс нэгдмэл үндэстэн бий болгох хэрэгтэй, жишээлэхэд бретончууд, лангедууд болон парисынхнаас франц үндэстэн, османыхан, армянууд, грекүүдээс турк үндэстэн үүсэх ёстой хэмээн үзэж байв. Энэ нөхцөлд үндэсний цөөнхийн эрх ашгийг харгалзан үзэхгүй байж ч болох ажээ.

Сунь Ятсен 1912 оны нэгдүгээр сарын 1-нд хятадын түр ерөнхийлөгчийн албан тушаалд орохдоо хийсэн тунхаглалдаа хятадын “үндэсний эв нэгдэл чухал болохыг, турхайлбал бүх ард түмний газар нутгийг нэг улсад, ард түмнүүдийг нь “нэг гэр бүлд” нэгтгэхийг уриалсан байна.[2191] 1912 оны хоёрдугаар сард батлан гаргасан Дүрмийн гуравдугаар зүйлийн 2-т: “ястнуудыг уусгахыг” тунхаглажээ.[2192] Гуравдугаар сарын 10-нд хятадын 17 мужийн төлөөлөгчид Бүгд Найрамдах Хятад Улсын түр үндсэн хуулийг баталсан бөгөөд тэнд хятадын нутаг дэвсгэрт тус улсын 22 муж төдийгүй

Өвөр, Ар Монгол, Түвд, Хөх нуурыг оруулсан байна. Үндсэн хуулийн зүйл 1-д "Бүгд найрамдах хятад улсыг Хятадын ард түмэн байгуулж байгаа юм" гэж тунхагласан хэдий ч монгол, түвдчүүдийг энэ улсын бүрэлдэхүүнд хүчээр нэгтгэн оруулжээ. Сунь Ятсен 1912 оны есдүгээр сарын 1-нд Бээжин хотноо үг хэлэхдээ хятадын хятад биш үндэстэн ястнууд Бүгд Найрамдах хятад улсын бүрэлдэхүүнд байх нь илүү ашигтай, хаант засгийг бодоход бүгд найрамдах байгуулал тэдэнд иргэнийх нь хувьд улс төрийн эрх олгоно хэмээн мэдэгдсэн байна.[2193]

Бүгд Найрамдах улсынхныг бут ниргэх хангалттай хүч нөөцтэй байсан ерөнхий командлагч Юань Шикай ингэхийг эрмэлзсэнгүй. Харин ч тэрээр ордны янз бүрийн бүлгийнхэнд шахалт үзүүлж, бага настай эзэн хааныг огцруулах шаардлага тавьжээ. 1912 оны хоёрдугаар сарын 12-нд төр баригч Лунъюй гэдэг эмэгтэй, хүү Пуигийнхээ нэрийн өмнөөс бүгд найрамдах улсын түр засгийн газар эмхлэн байгуулахыг Юань Шикайд даалгасан зарлигт гарын үсэг зурсан байна.

Уламжлалт үзэлт хятадуудын олонхи нь үүнийг юуны өмнө манж нарын эсрэг хятадын ард түмний байгуулж буй ялалт хэмээн үзжээ. Хаан суудалд хятад овгийн хүн суух ёстой гэж тэр хүмүүс үзсэн байна. Гэтэл Мин гүрнийг захирч байсан Жу овогийн бүх гишүүнийг манж нар хүйс тэмтрэн устгасан бөгөөд шинэ овогийнхон гаргаж ирэх явдал боломжгүй зүйл байлаа.[2194] Ингээд л бүгд найрамдах улсыг сонгохоос өөр аргагүй болсон байна. Одтой гялалзаж яваа цэргийн жанжин Юань Шикай шинэ эзэн хаан болж чадна гэж уламжлалт үзэлт хятадууд найджээ. Айсинь Гиорогийн овогийнхны "улс орноо захирах мандатыг" Тэнгэр бурхан тасалсан болохоор хааны удмын ээлжит солигдол эхэлж байна гэж тэр хүмүүс ойлгож байлаа. Гэтэл бүх зүйл өөрөөр эргэв. Хаант засгийн оронд бүгд найрамдах улс ирсэн бөгөөд энэ байгуулал 37 жилийн дараа бүрэн төгс ялжээ.

Сунь Ятсен шинэ албан тушаалд орсноосоо хойш зургаан долоо хоногийн дараа суудлаа Юань Шикайд өгчээ. Тэрээр албан тушаал өгөх ёслолоо Мин гүрнийг үндэслэн байгуулагч Жу Юаньжаны булшны дэргэд хийсэн байна.[2195] Тэнд Сунь Ятсений илгээлтийг уншиж сонсгосон бөгөөд хятадад эрх чөлөөтэй бүгд найрамдах засаг тогтсон тухай, үндэстний хамгийн хүчтэй дайсан манж нарыг устгасан тухай тэр илгээлтэд өгүүлжээ. Тэнд мөн "Мин улсын эзэн хаан Тайзу монголчуудыг хөөж явуулаад хятад улсыг сэргээн байгуулсан юм" гэж өгүүлжээ.[2196]

Энэ бүх мэдэгдлийг Бүгд найрамдах хятад улс бол Юань болон Чин улсуудыг залгамжлагч биш, энэ хоёр эзэнт гүрэн бол хятад биш байсныг

албан ёсоор хүлээн зөвшөөрсөн хэрэг байсан юм хэмээн үзэж болох юм. Харин хятадын үе залгамжлалыг хан үндэстний Мин гүрнээс эх авч сэргээн тогтоосон бөгөөд энэ гүрний бүрэлдэхүүнд Түвд ч, Монгол ч, Шинжаан ч орж байгаагүй билээ. Зөрөлдөөн үүслээ: харь газрын “зэрлэгүүд” болох монголчууд болон манж нарын эзэмшилд байсан газар нутагт Бүгд Найрамдах Хятад улс өнгөлзөх боломжгүй болсон билээ.

Бүгд найрамдах хятад улсын эхний саруудад хан үндэстнүүдийн дунд “таван ястны” тухай санал маргаан өрнөв. Аугаа их Хятад (Да Жун-го жу-и) ба Уугуул хятад (Бэнь-бу Жун-го) –ын зарчмын тухайд санал зөрөлдөөн үүсэв.[2197] 1912 оны эхээр эдгээр санал зөрөлдөөнийг нэгтгэн дүгнэсэн өгүүлэл нийтлэгдсэн байна. Нэгдүгээр зарчмын талынхан хятадуудыг (хан үндэстэн) үндэстэн байгуулалтыг хийх чадвартай цорын ганц ард түмэн хэмээн хүлээн зөвшөөрч, үлдсэн дөрвөн ард түмнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзжээ. Хоёрдахь зарчмын талынхан улсынхаа гадаад хилийг аюулгүй болгохын тулд “хил орчмын” ард түмнүүдийг тусгаар тогтнуулахыг дэмжив. Гэвч тэд цөөнх болжээ. Монгол, түвд, түрэгүүдээр хятадын дотоот нутгуудыг хамгаалуулах, гадаадын хүчнүүд ашиглаж болох өөрийн гэсэн улс орон байгуулахыг хориглох замаар бүгд найрамдах улсын бүрэлдэхүүнд оруулах нь зүйтэй гэсэн үзэл бодол давамгайлжээ. Тийнхүү “нэгдмэл хятад үндэстний” үзэл баримтлал төлөвшин бий болжээ.

Энэ үзэл баримтлал өрнөдийн үндсэрхэх үзэл болон өөрийнхөө тухай, аж төрөн амьдрах нутаг орныхоо тухай хятадууд болон тэдний өвөг дээдэс болох хуасянуудын төсөөллийн нөлөөн дор XX зууны эхээр л үүсч бий болжээ.

1920-оод онд Сунь Ятсен “нэгдмэл үндэстний” үзэл санаанаас хятадуудын “төрийн үндэстний” үзэл санаанд шилжиж, хүн амынх нь тоо цөөн “гаднынхныг” зүгээр л үл тоомсорлон орхижээ. Түвдчүүд Английн, монголчууд Оросын, манж нар Японы нөлөөнд орсон юм гэж тэр мэдэгдсэн байна. Ингэхлээр “тэд өөрийгөө хамгаалах чадваргүй” болсон, зөвхөн хятадууд л түрэмгийллийг сөрөн зогсож чадах ажээ.[2198]

Гэвч тэрээр хятадууд “зэрлэг” орнуудыг булаан эзлэж, колончлохыг түрэмгийлэл хэмээн үзээгүй юм. Ингэхлээр тэр хүн Өрнөдөөс эзэнт гүрэн задран унах үзэл санаа биш, харин хувьсгал болон ардчилалын үзэл санаа авч иржээ. 1920-иод оны эхээр Лян Цичао бүгд найрамдах хятад улс хэмээх төрийн эхлэлийг иш үндэс болгож хятад үндэстэнг тодорхойлох гэж оролджээ.[2199] Энэ үндэстэн төлөвшин тогтоход 4-5 мянган жилийн асар их хүчин чармайлт шаардагдсан, харин одоо энэ үндэстэн ирээдүйн “аугаа

их эв нэгдлийн" үндсийг бий болгож буй "хүн төрөлхтний хамгийн чухал хүчийн" үүрэг гүйцэтгэх ёстой юм гэж тэр үзсэн байна.

1924 онд Сунь Ятсен тусгаар тогтнолоо зарлан тунхагласан орнуудыг хятадын нэг хэсэг хэмээн үзэж, өөртөө засан тохиножь, өөрөө удирдах чадварыг нь хөгжүүлэхэд туслахыг хятадын засгийн газарт санал болгосон байна.[2200] Түвд, Монгол улсууд төрт ёсны олон зуун жилийн туршлагатай байсан биш мэтээр үзжээ... Сунь Ятсенийг нас барснаас хойш л түүний байгуулсан Гоминьдан нам "төрийн үндэстэн" хэмээх ойлголтод угсаатны зүйн өргөн утга оруулав.

Коммунистууд өөртөө засан тохинох үндэстний эрхийг хүлээн зөвшөөрөхөөс эхлэн бодит байдалд түүнийг няцаах зам туулжээ. 1922 онд хуралдсан ХКН-ын 2-р их хурлын тунхаглалд Монгол, Түвд, Шинжаанд "өөртөө засах гурван улс" байгуулах үзэл санааг дэмжжээ.[2201] Ингэхдээ хятадын холбооны улс чөлөөт шинж чанартай байх ёстойг, өөрөөр хэлбэл хятадын бүрэлдэхүүнээс гарах эдгээр нутаг дэвсгэрийн эрхийг хүлээн зөвшөөрчээ. 1923 онд хуралдсан ХКН-ын 3-р их хурлаас батлан гаргасан намын программд Түвд, Монгол, Хөх нуур, Шинжааны өөртөө засан тохинох эрхийн тухай өгүүлсэн байна. Энэ үед ХКН Коминтерн болон Бүх Оросын коммунист намын зөвлөмжийг дагасан хэвээр байсан юм.

1931 онд зөвлөлийн бүгд найрамдах Зянси улсын үндсэн хууль бүгд найрамдах улсуудын өрх тусгаарлаж, бие даасан улсаа байгуулах эрхийг зарлан тунхаглав.[2202] 1938 онд болсон ХКН-ын төв хорооны 6-р бүгд хурал дээр Мао Зэдун үг хэлэхдээ тэгш эрхтэй байх, өөртөө засан тохинох, эвлэлдэн нэгдэх гэсэн үндэсний бодлогын гурван гол зарчим дэвшүүлэн тавьжээ. Өөртөө засан тохинох тухайд ямар нэгэн яриа гараагүй юм. Шинэ байр суурь Гоминьдан намтай тогтоосон түр зуурын хамтын ажилллагааны үр дүн байв. 1940 онд ХКН Гоминьдан намын эрх мэдлийг муутгаж, хятад биш ард түмнүүдийг талдаа татахын тулд өөртөө засан тохинох зарчмын асуудлаар заль мэх гаргав.[2203] Мао Зэдун 1938 онд "Хятадын хувьсгал ба ХКН" хэмээх бүтээлдээ бүрэлдэхүүнд нь янз бүрийн ястан ордог хятад үндэстний тухай бичжээ. Гоминьдан нам үндэстний өөртөө засан тохинох эрхийг хүлээн зөвшөөрсөн ХКН-ын анхдугаар их хурлын тунхаглалын заалтыг дэмжихээс 1930-аад оноос эхлэн татгалзсан байна.

Тийнхүү үндэсний асуудалд хандах хоёр намын хандлага 1930-аад онд хоёр тийшээ болжээ. Үүнээс өмнөхөн Хятадад түүхэнд анх удаа "үндэсний цөөнх" гэсэн нэр томьёо гарч ирж: 1924 онд түүнийг Гоминьдан намын бага хурал дээр, 1926 онд ХКН ашиглажээ.[2204] Тийнхүү "олон үндэстний

хятад” хэмээн зарласан хятадуудын улсад Түвд, Өвөр монгол, Шинжааны ард түмэн “үндэсний цөөнх” болов. Тэр цагаас хойш энэ үндсэн дээр эдгээр оронд үндэсний бодлого хэрэгжих болсон байна. ХКН их хятадын болон орон нутгийн үндсэрхэх үзэл байж болохгүй зүйл хэмээн зарлан тунхаглаж байна. Хан болон хан биш зэрэг янз бүрийн үндэстэн ястнаас бүрэлдсэн “нэгдмэл хятад үндэстэн” гэж байна хэмээн нотлох болов. Тийм учраас хятад, монгол, түвдчүүд бол бүгдээрээ хятадууд ажээ.

Тийнхүү түүхийн үүднээс хан угсаатантай холбоотой Дундад иргэн улс хэмээх ойлголтыг хятад биш ард түмэн, нутаг дэвсгэрүүдэд тулган хүлээлгэжээ. “Хятадууд” гэж байнга илэрхийлэх нь зарлан тунхаглаагүй ч хятаджуулах үйл явцад хувь нэмэр болдог байна. Угсаатны зүйн нэгдмэл байдлыг зарлан тунхаглах явдал юуны өмнө хятад олонхид ашигтайг Мао Зэдун ойлгож байлаа: “манай оронд үндэсний цөөнхийн хүн амын тоо 30 саяас давжээ. Тэд улс орны нийт хүн амын дөнгөж 6 хувийг эзэлж байгаа ч оршин сууж буй нутаг нь өргөн уудам, улс орны нийт нутаг дэвсгэрийн барагцаалбал 50-61 хувийг эзэлж байна. Тийм учраас хятадууд болон үндэсний цөөнхийн харилцааг улам ойртуулах нь зүйтэй юм. Их хятад үндэстний дээрэнгүй үзлийг даван туулах явдал дээрх асуудлын гол учир утга юм. Зарим үндэсний цөөнхийн дотор ч байгаа орон нутгийн үндсэрхэх үзлийг даван туулах явдал ч чухал байна” гэж Мао бичжээ.[2205]

Тийм болохоор “үндэсний цөөнх” өөрсдөө төдийгүй тэдний газар нутаг, нөөц баялаг хэрэгтэй ажээ. Тиймээс холбооны байгууллыг ч хойш тавьж байна. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн үндэстнүүдийн хэрэг эрхлэх комиссийн орлогч дарга Ван Фэн 1958 онд үүнийг томьёолж хэлэхдээ: хятадууд 94, “үндэсний цөөнх” 6 хувийг эзэлж байна.[2206] Ингэхлээр тэд бие даасан холбооны бүгд найрамдах улс яаж байгуулж чадах юм бэ? Тэдгээрийн хооронд ямар байдлаар хил хязгаар тогтоох юм бэ? Хамгийн гол нь бүх “үндэсний цөөнх” хоцрогдмол, тэд бие даан социализм байгуулж, улс төр, эдийн засаг, соёлын талаар түргэн хөгжиж чадахгүй. “Янз бүрийн ястныг тэгш эрхийн үндсэн дээр аажим аажмаар нэгтгэх явдал нийгмийн хөгжлийн зүй ёсны хууль мөн” гэж онцлон тэмдэглэжээ. Мөн онд Жоу Эньлай хэлэхдээ нэг ястан нөгөөг уусгаж устгана гэдэг харгис үйлдэл, хэрэв үндэстнүүдийн зүй ёсны нэгдэл сайн сайхан байдалд хүргэж байвал дэвшилт үзэгдэл мөн гэж хэлсэн байна.

Эдгээр үндэслэлийн дагуу 1960-аад онд хятадын эрдэмтэн Цянь Бозянь уусгалтын угсаатны зүйн онол дэвшүүлэн тавьжээ.[2207] Энэ онолоор бол “өндөр хөгжсөн” ард түмэн “бага хөгжилтэйг” байлдан эзлэхдээ түүний

дэвшил хөгжилд төдийгүй аажмаар уусах үйл явцад тус дөхөм үзүүлдэг ажээ. Хэрэв байлдан эзлэгч ард түмэн соёл иргэншлийн хувьд ч, оюун санааны тухайд ч эзлэгдсэн ард түмнээс сул дорой байвал эзлэгдсэн ард түмэнд гарцаагүй уусч алга болох ажээ. Энэ онол Лян Цичаогийн үзэл бодолтой нийлж байгаа бөгөөд түүний уг үндэс эртний хятадаас гаралтай юм. Тэнд үндэсний болон хятад соёлын үзэл баримтлал, өөрөөр хэлбэл нэг бол хятад соёл байж болно, үгүй бол ямар ч соёл байх ёсгүй гэсэн үзэл баримтлал байгаагүй юм.[2208] Жишээ нь, нүүдэллэн амьдрана гэдэг бол "зэрлэгшлийн" нэг төрөл ажээ. Зэрлэгүүдийг соёлжуулахын тулд суурин амьдралд шилжүүлж, хятадуудаас шалтгаалах хамаарлыг нь нэмэгдүүлэх хэрэгтэй бөгөөд коммунистууд чухамдаа ингэж л байгаа билээ.

Өнөө үед уусгах тухай биш, харин эв нэгдлийн тухай ярьж байна: "манай орны бүх үндэстэн ястанг нэгдмэл гэр бүлд нэгтгэж, энэ харилцааг үеэс үед дамжуулж буй гурван гол зүйл байна; нэгдүгээрт, энэ бол төр улс удаан хугацаагаар эв нэгдэлд байх; хоёрдугаарт, энэ бол үндэстэн ястнууд хамтран оршин тогтож, бие биеэ түшч ирсний үр дүн болсон эдийн засаг, соёлын харилцаа; гуравдугаарт, энэ бол шинэ үеийн зааг дээр бүх үндэстэн ястан гадаадын түрэмгийллийг хамтран няцаах, урт удаан хугацааны хувьсгалт тэмцэл явуулах үйлст хамтарч орсон цагаас хойш бүрэлдэн тогтсон нийтлэг төрөл эрх ашгийн харилцаа мөн юм".[2209] Эдгээр гурван зарчмын тухай дээр тодорхой авч үзсэн билээ.

ХКН холбооны улсын тухай онолыг няцаахдаа "үндэсний цөөнхийн" өвөрмөц шинж чанар болон өөртөө засах эрхийг ямагт тунхаглаж иржээ. Гэтэл бодит хэрэг дээр ямар байна вэ? БНХАУ бол нэгдмэл улс мөн. "Энэ нь Хятадын тухайд тус улсын амьдрал, үйл ажиллагааны бүх хүрээнд үндэсний цөөнхийн соёл биш, харин хан үндэстний соёлын үнэт зүйлс тусгалаа олж байгаа юм"[2210] Үндэсний цөөнхийн өөрөө удирдах ёс гэгч нь хоосон зүйл болон хувирч: хамгийн чухал асуудлуудыг Бээжингийн эрх баригчид шийдвэрлэж ирсэн, одоо ч тийм байна. Мао Зэдуны үед үндэсний соёлыг чиглэсэн зорилготой устгаж, шилжин суурьших явдал болон уусгах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжээд зогсоогүй үндэсний нутаг дэвсгэрүүдийг ч хяналтандаа авчээ. БНХАУ-д "үндэсний цөөнх" газар нутагтаа хятадуудаас давуутай эрх эдэлж чадахгүй байна. Цөөнх үндэстнийг хөгжүүлэх тухай ярихдаа "үндэсний цөөнхийг хадгалан үлдэх" хэмээх нэр томьёоноос ч зайлсхийж, хэл, уламжлалыг хадгалан үлдэх талаар авч буй арга хэмжээнүүд үзүүлэнгийн шинж чанартай болжээ.[2211] Хэрэв бусад мужаас улам их хараат байдалд орж, хятадууд ямар ч хязгаарлалтгүй шилжин суурьшиж байгааг

харгалзан үзэх юм бол үндэсний цөөнх уусах аюулын өмнө тулж ирээд байна.

Эртний хятадын эзэнт гүрний үзэл баримтлалыг дахин санад: Жунго өөр улсын нэг хэсэг байж болохгүй. Тэгвэл энэ үзэл баримтлалыг 1969 оны аравдугаар сарын 8-ны өдрийн баримт бичигт хэрхэн томьёолсныг авч үзье: "Хятад бүр хоёр мянга гаруй жилийн өмнө нэгдмэл олон үндэстний феодалын улс болсон байв. Хятад нь феодалын хаадын овогууд солигдож байсан, улс оронд ямар үндэстэн эрх баригч байсан гэдгээс үл шалтгаалан ямагт дэлхийн олон үндэстний улс хэвээр явж ирсэн билээ".[2212] Өнөө үед: "Хятадын хил хязгаар түүхийнхээ явцад олон удаа өөрчлөгдсөн боловч энэ хил хэзээ ч хятадууд оршин суудаг нутгийн хэмжээнд хязгаарлагдаж байгаагүй юм: XIX зууны дунд үед өрнөдийн империалист гүрнүүд хятадад цөмөрч орох хүртэл хятадын хил тов тодорхой зааглагдсан байсан юм"[2213]

Ингэхлээр бусад улсын эрх баригчид (Чингис, Хувилай, Абахай зэрэг) бол "хятадын умардад" гүрэн улсаа байгуулсан "үндэсний цөөнхийн гарамгай төлөөлөгчид байсан болж таарч байна". Жишээ нь, "монголын ард түмнийг хятадын үндэсний цөөнх, Чингис хааныг хятадын үндэсний цөөнхийн эрх баригч хэмээн үзэж болох ажээ".[2214]

Тиймийн учир өөртөө засан тохинох эрхийн тухай ярих хэрэггүй болж байна. Монголчууд өөрсдийгөө хятад биш монгол л гэж, түвдчүүд мөн адил бодож сэтгэсэн хэвээр байгаа нь чухал биш болж байна. Тэд БНХАУ-д аж төрөн суухыг хүсч байна уу, үгүй гэдэгийн хооронд ямар ялгаа байгаа юм бэ? Тэд гадаадынхны бодож олсон тодорхойлолтоор л хятадын бүрэлдэхүүнд орж байгаа ажээ. Бүгд найрамдах хятад улсын үед буюу хорьдугаар зууны эхээр түүхч Кэ Шаоминь шинэ эх сурвалжуудын үндсэн дээр Юань гүрний дундад зууны үеийн он дарааллын бичиг –"Юань ши"-г нэмэн баяжуулж засварласан нь сонирхол татна. "Синь Юань ши" буюу "Юаны шинэ түүх" хэмээх номыг Хятадын ерөнхийлөгчийн тусгай хуулиар баталсан нь "хаадын албан ёсны он дарааллын бичигийн" сүүлчийнх болжээ.[2215]

Бүгд найрамдах хятад улсыг зарлан тунхагласнаас хойш удалгүй – 1916 ба 1932 онуудад Камчаткаас Сингапур хүртэлх Алс Дорнод, Бутан, түүнчилэн Афганистан, Энэтхэгийн зарим хэсэг зэрэг "алдагдсан нутаг дэвсгэрүүдийг буцааж авах" гол үндсэн үзэл санаа бүхий номууд гарсан байна.[2216] 1939 онд Мао Зэдун: " Империалист гүрнүүд хятадад цэргийн түрэмгийллэл үйлдэж, хятадын мэдэлд байсан үлэмж олон орныг хүчээр булаан авч, тус улсын уугуул нутаг дэвсгэрийн зарим хэсгийг булаан эзэлсэн юм. Япон улс Тайвань, Солонгос, Порт-Артур, Рюкю ба Пэнху

арлыг өөртөө нэгтгэж: Англи улс Бирм, Бутан, Балба, Гонконгыг булаан авч: Франц улс Аннамыг булааж, өчүүхэн жижиг Португал улс биднээс Макаог булааж авсан юм" гэж мэдэгджээ.[2217] 1965 онд Мао эдгээр өнгөлзлөгөө: "Бид Өмнөд Вьетнам, Тайланд, Бирм, Малайз, Сингапурыг оролцуулан зүүн-өмнөд азийг заавал буцааж авах ёстой. <...> Зүүн өмнөд азийн район бол маш баян, тэнд ашигт малтмалын их нөөцтэй, энэ районыг авахын тулд гаргах зардал амархан нөхөгдөх учиртай билээ. Ирээдүйд энэ нутаг хятадын аж үйлдвэрийг хөгжүүлэхэд маш үр дүнтэй байх болно. Тийнхүү энэ районы төлөө хүлээх алдагдал бүрэн нөхөгдөх болно. Бид зүүн өмнөд азийг авсныхаа дараа энэ районд цэргийнхээ хүчийг нэмэгдүүлж болох бөгөөд ингэснээр бид зөвлөлт-дорнод европын эвслийг сөрөн зогсох хүчтэй болох юм" гэж үндэслэсэн байна.[2218]

Тэр жилүүдэд Мао дэлхий нийтийг хамарсан зорилго дэвшүүлэн тавьжээ: "Бид дэлхийн бөмбөрцгийг эрхэндээ оруулах ёстой... Бид хүчирхэг гүрэн улсаа байгуулахад манай дэлхийн бөмбөрцөг бүхнээс чухал хэмээн би бодож байна" гэж тэр хэлсэн байна.[2219] Хятадын алдагдсан нутаг дэвсгэр гэгчдийн жагсаалт энэ байна: Бирм, Лаос, Вьетнам, Балба, Бутан, Энэтхэгийн умард нутаг, Тайланд, Малайз, Сингапур, Солонгос, Рюкю арлууд, Өмнөд хятадын, дорнод хятадын, Шар тэнгэсүүдийн 300 арал, Киргиз, Өмнөд Казахстан, афганистаны Бадахшан муж, Монгол, Өвөр байгал, Агнуурын тэнгэс хүртэлх Алс донодын өмнөд хэсэг ажээ.[2220] "Алдагдсан нутаг дэвсгэр" 10 сая гаруй ам дөрвөлжин километр талбай эзэлж байна. Энэ нь БНХАУ-ын нутаг дэвсгэрийн хэмжээнээс (9,6 сая ам дөрвөлжин км) давж байна. Дэлхийн өөр ямар ч улс нутаг дэвсгэрийн ийм өнгөлзлөг тавьж байгаагүй билээ.[2221] Тийнхүү дэлхийн хувьсгалын марксч-ленинч үзэл санаа түгээмэл эрх мэдэлтэй байх "Тэнгэр бурхны мандаттай" хосолжээ.

Өнөө үед БНХАУ дэлхийн хувьсгалыг зарлан тунхаглахаа больж, дээр дурдсан бүх орон, нутаг дэвсгэрт албан ёсны өнгөлзлөг тавихгүй байна. Гэхдээ түүхэнд тиймэрхүү хандлага хадгалагдан үлджээ. Жишээ нь, Хятадын түүхийн олон боть академийн атласын тавдугаар ботид.[2222] 618–907 онд оршин тогтож байсан Тан гүрний дараах хил хязгаарыг заажээ:баруун талд-Арал тэнгис болон Балхаш нуурын хойд эрэг хүртэл (32–33-р зураг), Дорнод Сибирьт-Ангар мөрөн, орчин үеийн агнуурын тэнгэс хүртэл (50–51-р зураг ). Энд Алс Дорнодын умард хилийг цаасны зай хүрэлцээгүй гэх шалтгаар бүтэн заагаагүй байна. Дундад Ази дахь Тан улсын нутаг дэвсгэрт цаасан дээр л тэмдэглэгдэж байсан цэрэг-засаг

захиргааны нэгжүүд гэгчийг оруулжээ.

Асар өргөн уудам эдгээр нутаг дэвсгэрийн олонхи хэзээ ч хятадын удирдлагад байгаагүй, “Атлас”-ыг зохиогчид ямар нэгэн үед эзэн хааны ордонд “бэлэгтэй” ирж байсан аймгуудыг нэг их итгэлтэй биш байдлаар тухайн нутагт хүчээр суурьшуулах үндсэн дээр л Тан гүрний хил хязгаарт оруулсан нь тодорхой байна. Олонхи нь тан улсын нийслэл Чанъаниас нэр төдий л хараат байсан аймгуудыг жинхэнэ хятад нутгуудтай нэгэн зиндаанд төвөөс удирдаж байсан хятадын нэг хэсэг хэмээн үзэх нь хачирхалтай байгаа бөгөөд “Атласт” эдгээр нутаг дэвсгэрийг хятадын төв мужуудаас огт үл ялгарах өнгөөр буджээ.

Гэтэл “Таван хант улс, 10 улс” хэмээх 82–83-р зурагт эдгээр хаант улс болон улсын бүрэлдэхүүнд тэр үед Хятадад огт хамаарч байгаагүй нутаг дэвсгэрүүдийг оруулсан байна. Жишээ нь, Түвдийг хойд талаараа Байгаль нуур хүртэл, Амар мөрнөөс цааш Сахалин хүрсэн дэндүү том нутаг дэвсгэр болгон харуулжээ. “Атласын” Чин гүрэнд зориулсан 8-р ботид 1820 оны 3–4-р ерөнхий зурагт энэ орны хил хязгаарт өнөөгийн Хабаровын хязгаарыг Еврейн Автономит тойргийн хамт, Амар муж, Сахалин, Урианхай, Семиречийг Балхаш нуурын хамт оруулсан байна. Ладакыг Түвдэд оруулж, Түвдийг жинхэнэ хятад мужуудаас огт үл ялгарах нэг муж болгож оруулсан байна. Өмнөд тэнгэсийн арлуудыг хятадын нутаг хэмээн зурсан бөгөөд хятад улс одоо ч түүнийг өөрийн нутаг хэмээн маргалддаг юм.

Академийн хэвлэлд байгаа иймэрхүү будлиантай зүйлийг хятадын удирдлагын улс төрийн захиалга гэдгээр л тайлбарлахаас өөр аргагүй. “Хятад дахь хаант Оросын түрэмгийллийн түүх” хэмээх олон боть бүтээлийг энд дахин дурдъя. Хятад улс Хань болон Тан гүрнүүдийн үед цэрэг армиа хилээсээ хол явуулж байсан уу, үгүй юу, янз бүрийн ард түмэн Ляо, Цинь, Юань, Чин гүрнүүдийг байгуулж байсан уу, үгүй юу, манж нар оросын Амар орчмын нутагт цөмрөн орж, монгол нутгуудыг булаан эзлэж байсан уу, үгүй юу гэдэг энэ бүхэн бол хятадын дотоодын үйл явдлууд бөгөөд хараат ард түмнүүдийн гаргаж байсан бослогууд бол урван тэрсэлсэн үйлдэл буюу эх орноо хагаралд оруулах гэсэн эрмэлзэл байсан юм гэж энэ бүтээлд баталжээ.[2223]

БНХАУ-д гарсан марксист бослогыг 1990-ээд оноос “эх оронч” бослого болгон өөрөөр нэрлэх болжээ. Бусад орноос хятадыг ялгаруулдаг “үндэсний хосгүй гайхамшигт нөхцлүүдийг” дээрх олон боть бүтээлд онцлон тэмдэглэжээ.[2224] Одоо коммунист намыг биш, харин БНХАУ-ыг олон үндэстний улс хэмээн алдаршуулан магтаж, ХКН-ыг энэхүү улсын манаа

хэмээн ярих болжээ. Коммунист нам өөрийгөө “эх оронч үзэл”,”үндэсний хосгүй нөхцөл байдлаар” магтан сайшааж байна.

Эдийн засгийн амжилтууд БНХАУ-ыг дэлхийн хүчний төвүүдийн нэг болгож байна. Эрх баригчид хятадын соёлд улам их анхаарал тавих болсон явдал тус улсыг өрнөджүүлэхэд нөлөөлж байна. Хятадын үндэсний үзэл, дан ганц хятад сургааль болох күнзийн онол, “зөөлөн хүчирхийлэлийг” онцлох болов. Түүнээс гадна күнзийн сургааль бол шашны гэхээсээ иш зүйн үндэстэй юм. Тийм ч учраас энэ сургааль бусад шашныг бодоход марксизмын материалист ягшмал номлолд тэгтлээ их харшилдаггүй юм. Күнзийн сургааль болон хятадын үндсэрхэх үзэл БНХАУ-ын дотоодод дэмжлэг хүлээгээд зогсохгүй байна. 1980-аад оны сүүлчээр хятадын эрх баригчид дэлхийн янз бүрийн оронд күнзийн сургаалийн 100 институт байгуулахаар шийдсэнээс 40 орчим нь ажиллаж байна. Тийм замаар хятад улс дотооддоо интеграцчилагдаж, өөрийнхөө эргэн тойронд күнзийн соёлын орнуудын бүс нутаг бий болгож байна.[2225] Марксизм-ленинизм ХКН-ын үзэл суртлын үндэс суурь хэвээр байгаа болохоор тийм өөрчлөн байгуулалт одоо коммунист үзэл сурталтай нэгджээ.

Тийнхүү бүгд найрамдахчууд (хөрөнгөтний, дараа нь коммунист бүгд найрамдахчууд) БНХАУ-ын үндэстэн ястны эрх тэгш байдлыг тунхаглахдаа хамгийн олон тооны үндэстэн ястанд бодит давуу тал олгох бодлого баримталсан, одоо ч баримталж байна. Бүрэлдэхүүнд нь БНХАУ-ын янз бүрийн ястнууд ордог “нэгдмэл хятад үндэстэн” гэдэг бол бодит байдалд үндэсний цөөнхийг уусгах үйл явц дахь хан үндэстэн мөн билээ. Тийнхүү бид энэ бүлгийн эхэнд иш татсан Лян Цичаогийн дүгнэлтийг эргэн давтаж байна.

### *Түвдийн статус: түүхэн өнгөрсөн үе*

Түвд бол “хятадын салшгүй хэсэг” мөн гэсэн тогтолцоот үзэл XX зуунд үүсчээ. Гэхдээ Бүгд найрамдах хятад улсад эхний үед Түвд янз бүрийн эзэнт гүрэнд захирагдаж байсан тухай л ярьж байсан юм.[2226] Хятадын олон тооны эх сурвалжуудад нарийвчилсан дүн шинжилгээ хийж үзэхэд орчин үеийн хятадын түүх судлалын тухайд ( БНХАУ-д ч, Тайваньд ч) манж чин улсын эрх баригчдын улс төрийн бодлогыг сайшаан дэмжих явдал хэв шинжит дүр төрхтэй болсон бөгөөд Тайваньд хийж буй орчин үеийн шинжилгээ судалгааны ажил олон талаар “нэгдмэл хятад үндэстний тухай” Гоминьдан намын программын шинжтэй үндэслэлүүдээр тайлбарлагдаж байна.[2227]

Гэхдээ БНХАУ-д шинжилгээ судалгааны ажилд ХКН-ын марксч-ленинч үзэл суртал хүчтэй нөлөө үзүүлдэг бол Тайваньд гоминьданы үзэл суртал (жишээ нь, Тайваньд хэвлэгдэн гарсан орчин үеийн нэг газрын зурагт Монгол, Тува улсуудыг ч бүгд найрамдах улсын Хятадын хил хязгаарт оруулан зуржээ) нөлөөлж байна. Сүүлийн үед Тайваньд ч, БНХАУ-д ч тийм үзэл бодлоос хөндийрөх чиг хандлага ажиглагдаж байна.

Гэхдээ л Түвдийг хятадад хамааруулан зурсан хуучин газрын зургууд чухал учир шалтгаан болсон хэвээр байна. Бусад иймэрхүү газрын зураг ч цөөнгүй байдгийг тэр бүр бүх хүн мэддэггүй юм. Жишээ нь, Түвдийг ерөөс зааж тэмдэглээгүй Мин улсын эртний газрын зураг бий. Түвдийг бие даасан улс болгож тэмдэглэсэн европ газрын зургууд ч бий. Жишээ нь, энд П.ван дер Аа (1680 он ), Ж. Де Иль (1700 он), В. Гатри (1785 он), А. Финли (1827 он), С.А. Митчелл (1860 он) нарын газрын зургууд байна. 1908 онд лондон хотод “хятадын өөийнх нь 18 муж, дөрвөн хараат нутаг дэвсгэр”, түүний дотор Түвдийг харуулсан атлас хэвлэгджээ. 1942 онд АНУ-д нийтлэгдсэн газрын зурагт Хятад, Манж-го, БНМАУ, Түвдийг бие даасан улс гэж харуулжээ. 2008 онд тийм газрын зургийг хуанлийн хэлбэрээр хэвлэн гаргасан байна.[2228] “Түвд орон эрт дээр цагаас Хятадын салшгүй хэсэг байсан юм. Бүр манай эринээс өмнө түвдэд аж төрөн сууж байсан хүмүүс Төв хятадын хан үндэсний хүмүүстэй харилцаатай байжээ. <...> Хятад орон урт удаан хугацааны туршид олон эзэнт гүрний уналт, босолтыг үзэж, тус улсын төв засаг нэг бус удаа солигдож байсан ч Түвд цаг ямагт Хятадын төв засгийн газрын удирдлагад байсан билээ”.[2229]

Бодит байдалд бол түвдчүүд хятадуудаас үл шалтгаалан түвдийнхээ өндөрлөгт ард түмэн болж төлөвшин тогтжээ. Түвдийн төрт ёс ч бие даан төлөвшжээ. Хятадын Тан гүрний хөрш Түвд улс сүр хүчнийхээ оргилд хүрч байжээ. Түвдчүүд хятадын нийслэл Чанъань хотыг эзлэн авч байсан байна. Түвдчүүд “алба гувчуур төлж байсан” тухайд бол VII–IX зууны үеийн түвд-хятадын харилцааны түүхээс үзвэл түвдчүүд биш, харин хятадууд түвдэд алба гувчуур төлдөг байжээ.[2230] Тэгэхлээр Түвд улс “хятадын ямар ч төв засгийн газрын удирдлагад” байгаагүй ажээ. Хятадын бодит түүхчид Түвд орон Тан гүрнээс хараат биш байсныг хүлээн зөвшөөрч байгаа нь тэмдэглэлтэй зүйл юм.[2231]

Түвдийн Соронзон Гомбо хаан 646 онд хятад гүнж Вэньчэнтэй гэрлэснийг түвдийг хятадад интеграцчилах үйл явцын эхлэлийг тавьсан чухал үйл явдал гэж зарим зохиогч үздэг юм. Хятадын Тан улсын эзэн хааныг “авга ах”, түвдийн хааныг “зээ дүү” хэмээн нэрлэсэн 821/822 оны

гэрээг ч тэр багцааны ач холбогдолтойд тооцдог юм байна. Энэ бол буруу тайлбар мөн. Вэньчэн бол Соронзон Гомбо хааны хоёрдахь эхнэр, харин эхнийх нь балбын гүнж Бхрикути байжээ. Тэгвэл Түвдийг Балбад нэгтгэх тухай ярих хэрэгтэй болох уу?[2232] Цааш нь гэвэл, Азид ч, Европт ч эртнээс нааш тийм маягийн гэрээ, хэлэлцээр байгуулагдаж л байжээ.[2233] Хэрэв гэрээ байгуулагчдын статус янз бүр байвал тэдгээрийн нэгийг "авга" буюу "ах", нөгөөг "зээ" буюу "дүү" хэмээн нэрлэдэг байжээ. Энэ нь нэг хаан нөгөөд буюу нэг улсын сюзеренитет эрх нөгөөгийнхөд захирагдана гэсэн үг биш билээ.[2234] Азид ч, Европт ч эзэн хаад нь янз бүрийн түвшингийн цол, жишээлэхэд ван, хаан, эзэн хаан цолтой тусгаар тогтносон улсууд олон байжээ. Түүнээс гадна нэг зэрэглэлийн цолтой эрхмүүд ч тухайн улсын нөлөөний хүрээнээс шалтгаалан ах, дүүгийн журмаар харилцах явдал ч байжээ. Гэвч дэлхийн тэргүүлэх эрх мэдлийн төлөө санаархагч хятадын эзэн хаад тийм ялгааг нэг нь нөгөөдөө захирагдах шалтгаан хэмээн тайлбарлаж иржээ. Тухайн толхиолдолд Түвд улс Тан гүрний эрх баригчдад захирагдах ямар ч шинж тэмдэг байгаагүй ажээ.

Түүнээс гадна хятадын биш, харин түвдийн тал хүчээр түрээ барих байр сууринаас хандсан байна. Энэ нөхцөл байдал эртний оросын Владимир ванд тохиолдсон үйл явдалтай ямар нэг байдлаар төстэй юм. 988 онд византын Херсонес хотыг булаан эзлэнгүүтээ эзэн хаан Василий, Константин нараас дүү хүүхэн Анмаг нь эхнэр болгон авахыг шаарджээ.[2235] Владимир түүнтэй гэрлэснийхээ дараа византийн хааны ордны ноён цол хүртэж, византын эзэнт гүрэнд гарсан бослогыг дарахад туслажээ. Өөрөөр хэлбэл Константинополийн талаас үзэх юм бол Византийн албат болжээ. Гэтэл бодит байдалд Киевийн Орос тусгаар тогтносон улс хэвээр үлдэж, одоогийн ОХУ болон Украин улс Грекийн "салшгүй хэсэг" болоогүй ажээ.

821 оны Түвд, Тан улсын гэрээ бол тэгш эрхт улсуудын хооронд байгуулсан гэрээ мөн бөгөөд энэ талаар олонхи судлаач санал нийлдэг билээ. Түвдийн хаан хятад гүнжтэй гэрлэсэн явдал балба гүнжтэй гэрлэсэнтэй утга нэг юм. Түүнд бас өөр дөрвөн эхнэр байжээ. Ингэхлээр энэ үйл явдал бол Түвд давамгайлах эрхтэй байсны гэрч нотолгоо мөн.

Дармаа хаанаас хойш түвдийн интеграц задрах үед гол үндсэн харилцаа хятадаас Балба, Энэтхэг рүү шилжжээ.[2236] 300 жил үргэлжилсэн интеграцийн задралын дараа Түвд орон "монголын дээд эрх мэдлийн нөлөөн дор" шашны удирдагчдын эрх мэдэлд нэгджээ. XIII зуунд Түвдийн шашин төрийн эрх баригчид монголын, дараа нь манжийн эзэн хаадтай "номын багш-төрийн ивээн тэтгэгчийн" зарчимд тулгуурласан харилцааны үндэс

тавигдсан байна. Энэ бол “хараат-эзэн” буюу “иргэн-төрийн” хэмээх нийтэд тодорхой болсон харилцаанаас огт өөр зүйл билээ. Энэ үзэл баримтлалтай төстэй зүйл бол Дундад зууны европын “хоёр илдний” онол: оюун ухааны илд эзэмшсэн пап лам эзэн хаан буюу ванд төрийн илд өгдөг онол байж болох юм.

Түвд, Монголын хооронд биш, харин хан хүү Годан, Сахьяа бандид нарын хооронд гэрээ байгуулжээ. Хувилай хааны үед монголын хаад болон Сажаагийн дээд эрх баригчдын “багш-ивээн тэтгэгчийн” зарчимд үндэслэсэн харилцааг бүрэн төгс албан ёсны болгожээ. Албан ёсны үзэл бодлын үүднээс бол Сахьяа бандидын түвдийг захирах төрийн эрх мэдлийн эх үүсвэр улс орны нутаг дэвсгэрийн гадна талд буюу монгол хаанд оногджээ. Гэтэл монгол хаан ч “дэлхийг” захирах эрх мэдлээ лам багшийн хүлээн зөвшөөрсөн шашны мандатаар албан ёсны болгон тогтоожээ. Олон улсын эрх зүйн үүднээс авч үзвэл Юань улс дахь монголчуудын талаархи Түвдийн байр суурийг илэрхийлэн тодорхойлох стандарт категори үгүй юм.[2237]

Эзэнт гүрнүүдийн албан ёсны хятад түүх судлалд улсын хил хязгаарыг нарийн тодорхой зурж гаргахыг эрмэлзэж иржээ. Гэхдээ Юань улсын мужуудын жагсаалтад түвдийг оруулаагүй байна.[2238] Үүнийг тайлбарлаж болох бөгөөд Түвд энэ эзэнт улсын нэг хэсэг байгаагүй ажээ. Монголчууд түвдэд алба татвар оногдуулаагүй, тус орны оршин суугчид юань гүрний цэргийн алба хаагаагүй, заавал гүйцэтгэх албан үүрэг ч хүлээгээгүй: түвдийн тухай асуудлаар гаргасан бүх баримт бичиг хятадууд биш, харин монголчуудтай харилцах түвдийн харилцаатай л холбоотой байжээ.[2239] Түүнээс гадна Пагва лам Хувилай хаантай “багш-ивээн тэтгэгчийн” харилцаа тогтоож, 1254 онд, өөрөөр хэлбэл хятадыг Монголд нэгтгэхээс бүр өмнө (1279) Түвдийг захирах эрх мэдэл олж авсан байна.

Монголчууд болон Түвдчүүдийн хоорондын харилцаа жишээлэхэд монгол, хятадуудын буюу Юань гүрний бусад улсуудын харилцаанаас хамаагүй нягт байжээ. Энэ хэлхээ холбоо Хятад дахь монголын эзэгнэлээс хараат биш байжээ. Ингэхлээр монгол-түвдийн болон монгол-хятадын хэлхээ холбоо өөр өөр шинж чанартай байсан ажээ. Түвд болон Юань гүрний түрүүчийн харилцаа Хятадыг тусгаарлахаас өмнө зогссон байна. Үүний дараа засгийн эрх Түвдэд эргэж ирсэн байна гэж М.К. ван Вальт шудрагаар тэмдэглэн бичжээ. Олон улсын харилцааг ч бие даан явуулж байв. Тийнхүү Түвд, Хятад хоёр монголын мэдэлд байсныхаа хувьд л харилцаж байсан хэрэг бишээ.

Үүний дараа Мин гүрний үед тан улсын үеэс хойш анх удаа Түвд,хятадын хоёр этгээдийн харилцаа сэргэжээ. Энэ бол түвдийн лам нараас монголын эрх баригчидтай тогтоосон харилцааны зэрэгцээ хятадуудтай тогтоосон “багш-ивээн тэтгэгчийн” зарчимд үндэслэсэн хувийн харилцаа байсан юм. Энэ хэлхээ холбоо түвдийг удирдах явдалд нөлөөлөөгүй ажээ. Энэ үед Түвд бүрэн бие даасан улс байжээ. Яваандаа энэ харилцаа зогссон байна. Тиймээс “Мин улсын төв засгийн газар Түвдийг удирдахдаа Юань гүрний аргыг залгамжилж авсан″ хэмээх нотолгоо хачирхалтай сонсогдож байгаа юм.[2240]

Гэсэн хэдий ч бэлэг сэлт солилцох, түвдийн язгууртнууд болон лам нарт цол, тамга шагнах, өргөл барьц өгөх явдал үргэлжилсэн хэвээр байжээ. Энэ бол нэг нь нөгөөдөө захирагдаж байсны нотолгоо биш билээ.[2241] Гэвч энд хятадын хааны үзэл бодол хамаарахгүй юм. Хэрэв хэн нэгэн этгээд тамга гардан авч, бэлэг сэлт авчирч өгсөн л бол тэр хүн хятадын түшмэл болсон хэрэг мөн гэж хятадууд үзэж байв. Нөгөө талын санал бодол, хэргийн бодит нөхцөл байдлыг харгалзан үздэггүй байв. Түвдчүүд “төвийн эрх баригчдын бүрэн эрхт түшмэд байсан” хэмээх өнөөгийн хятадын суртал нэвтрүүлгийн нотолгоо үүнд л үндэслэжээ. Мин гүрэн болон түвдийн харилцаа бусад бие даасан орнуудынхтай адил байв. 1594 онд шүүхийн газрын албан хаагч Ван Фэний зохиосон Мин гүрний нарийвчилсан газрын зураг үүнийг нотлон харуулж байна.[2242] Энэхүү газрын зургийн тайлбарт уг зурагт хятадын бүх нутаг дэвсгэрийг оруулав хэмээн бичжээ. Гэвч тэнд түвдийн бүс нутгууд, тэрчбайтугай Амдогийн зүүн хэсэг ороогүй ажээ.

V Далай ламын үед түвдийг Далай лам захиран удирдах болов. Тэр үеэс түвдийн эрх мэдлийн төв нь Далай лам буюу түүний тамгын газар болжээ. Өөрөөр хэлбэл энэ төв улс орны гадна талд биш, дотоодод нь байсан юм.[2243] Тэр үед манжийн Аисинь Гиорогийн овогийнхон Чин гүрнийг захирч байсан бөгөөд хятад манжийн бүрэлдэхүүн хэсэг байжээ. Энэхүү эзэнт гүрэнд манж нар хятадуудын хувьд монгол, түвдчүүд шиг л гадаадынхан болж байсан юм. Түвд, хятадын засгийн газрын хоёр этгээдийн харилцаа дахин тасалдаж: хятадын тал дахиад л өөр орны нэг хэсэг болжээ.

Монголчууд, магадгүй түвдчүүд ч Манжийн эзэнт гүрнийг Монголын эзэнт улсын залгамжлагч хэмээн үзэж байв. Чин улсын эзэн хаад энэ санаа бодлыг дэмжихийг эрмэлзэж байсан юм. Чингисийн алтан урагийн хамгийн ахмад нь болох монголын Лигдэн хааныг таалал төгссөний дараа манжийн Абахай хаан монголын их хаадын тамгыг гардаж авсан гэж мэдэгджээ.

Ингэснээрээ тэрээр монголчуудын хаан болсноо албан ёсоор онцлон

тэмдэглэжээ. 1636 онд өмнөд болон зүүн монголчуудын ноёдын их хуралаас Абахай хаанд элч явуулж, бүх монголын богд хаан, өөрөөр хэлбэл эзэн хааны цол хүргүүлжээ. Тийнхүү монголчуудын нэг хэсэг( хожим нь мөн Өвөр Монголд) Чин гүрэн Их Юань улсын залгамжлагч болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Гэхдээ түвдчүүд, монголчуудын хоорондын тэрхүү ойр дөт байдал түвд, манж нарын хооронд үүсээгүй, яагаад гэвэл манж нар угсаатан соёлын хувьд монголчуудыг бодоход түвдчүүдэс илүү хол байсан юм. Гэхдээ энэ харилцаа түвдчүүд болон хятадуудынхыг бодоход яваандаа хавьгүй хүчтэй болжээ.

Далай ламын цолыг түүнд чин улсын эзэн хаан шагнаж олгоогүй билээ. Энэ цолыг монголын Алтан хаан олгожээ. Дараа нь л чин улсын эзэн хаан бие биенээ хүлээн зөвшөөрч, хүндэтгэж буйн шинж тэмдэг болгож Далай ламтай цол солилцжээ. Гүш хаан. хятадуудад захирагдаж байсан, тэрээр V Далай ламыг засгийн эрхэнд гаргасан, тийм учраас Далай лам ч хятадуудад захирагдаж байсан гэж хятадын зарим баримт бичигт нотолдог юм.[2244] Энэ бол худлаа: Гүш хаан тэр үед хятадын биш, харин монголын бие даасан эрх баригч байсан юм. Тэрээр Далай ламтай "багш-ивээн тэтгэгчийн" зарчимд үндэслэсэн харилцаатай байв. Гүш хаан Түвдэд байхдаа энэ харилцааг хэвээр үргэлжлүүлж байсан боловч түвдийн хаан байгаагүй юм.

Түвдийн эрх баригчид болон чин улсын эзэн хаад өөр хоорондынхоо харилцааг янз бүрээр тайлбарлаж байсан: түвдчүүд-"багш-ивээн тэтгэгч" хэмээх нэр томьёогоор, чин улсын эзэн хаад "хараат -эзэн" хэмээх нэр томьёогоор: эхний үед энэхүү үл авцалдааг "ажиглахгүй" байхыг эрмэлзэж байсан ч хожим нь энэ харилцаа эзэн хаанаас хараатын хараат байдалд байх хэв шинжит хэлбэрт шилжсэн бөгөөд түвдийн эрх баригчид "нэр нүүрээ хадгалж үлдэхийн" тулд өөрийгөө хуурсан хэвээр байсан юм хэмээх дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөд бэрхшээлтэй юм.[2245] Бидний энд иш татсан бүтээлд дурдсан хараат байдлын шинж тэмдгүүд дараах шалтгаанаар "багш-ивээн тэтгэгчийн" харилцаанд үл харшилна.

1653 онд болон түүнээс хойш ч эзэн хаан Фулинь болон V Далай ламын хооронд цол харилцан олгож байсныг хятадын түүх судлал Түвдийн тал Бээжингийн эрх баригчдад захирагдаж байсан явдал хэмээн тайлбарлажээ. Далай ламд олгосон нэгэн цолыг "Нийт Дундад иргэн улсын буддын хэргийг удирдагч" хэмээн орчуулж: түүнд диплом болон тамга өгч: эзэн хаанд бэлэг сэлт хүргүүлэх элч зарж явуулсныг алба гувчуур хэмээн нэрлэсэн байна. Оросын түүхчид тийм дүгнэлтийг бодит нөхцөл байдлыг тусган харуулаагүй өрөөсгөл үйлдэл гэж шудрагаар дүгнэж:

тухайн үедээ улс төрийн засгийн албан ёсны тэргүүн байгаагүй этгээдийн статусаар дамжуулан улс орны (Түвдийн) статусыг тодорхойлжээ гэж онцлон тэмдэглэсэн байна.[2246] Түүнээс гадна дээд зиндааныхны элэгсэг үг хэллэгүүдийг нөгөөдөө захирагдаж буйн шинж тэмдэг хэмээн тайлбарлах нь зүйд нийцэхгүй юм. Жишээ нь, XIII Далай лам Хоёрдугаар Николай хаанд бичсэн захидлаа: "Аугаа их эзэнтээн, номхон хүлцэнгүй түвдийг хойшид ч ивээн тэтгэж, өрөвч сэтгэлдээ тээж явахыг хичээнгүйлэн хүсье" хэмээх үгээр дуусгажээ.[2247] Хятад сэтгэлгээгээр бол энэ хэллэгийг Түвд орон Орост захирагдаж буйн шинж тэмдэг хэмээн ойлгох хэрэгтэй болж байна.

Түвдчүүд манж нартай холбоотой байсан тэр л аргаар хятадуудтай холбогдоогүй юм гэж XIV Далай лам хэлсэн байна.[2248] Манж нар хятадыг булаан эзлэхээс бүр өмнө манжийн эзэн хаан V Далай ламыг урьж байжээ. Манж нар Бээжинг эзэлсний дараа Далай ламыг тус хотод хүлээн авч уулзжээ. Манж нар Далай ламыг боолын хувьд биш, харин түүний эрх мэдэл болон монголчуудын дунд дэлгэрсэн нэр хүндийг нь харгалзан үзэж урьжээ. Түүнийг гадаадын удирдагчийн хувьд хүлээж авсан байна. Эзэн хааны хүлээн авалт дээр Далай ламыг арай доод түвшингийн сэнтийд суулгасан гэж түүний намтарт бичжээ. Гэхдээ энэ бол тэрээр боол байсныг гэрчлэхгүй бөгөөд манжийн эзэн хаан илүү хүчирхэг улсын тэргүүн байсантай л холбоотой билээ.

Эзэн хаан Сюанье VII Далай лам болон II Банчин ламтай огт уулзаж байгаагүй, тэднээс сургааль хүртэж байгаагүйг иш үндэс болгож тэрээр ёс төдий ч ивээн тэтгэгч хэмээн тооцогдож чадаагүй юм гэсэн дүгнэлт хийж байна.[2249] Гэтэл "багш-ивээн тэтгэгчийн" харилцаа нь шашны бүх дээд тушаалтнууд бүх эзэн хаадтай заавал биечлэн уулзаж байхыг шаардаагүй билээ. Цааш нь гэвэл Будалын ордны өмнөх чулуун баганан дээр сийлсэн бичээсэнд эзэн хаан Зүүнгарынхныг хөөн гаргасны төлөө өөрийгөө болон цэрэг дайчдаа магтан дуулж: "Далай лам болон бусад хүн манай төрийн гурван хаанд чин сэтгэлээс үнэнч байсан тухай, амбан сайд нарг шарын хуулийг эртнээс сүсэглэн дагаж ирсэн тухай хойч үейинхэн мэдтүгэй" хэмээн бичжээ.[2250] Хэлбэрийн хувьд энэ бол эзэн хааны дээд эрх мэдлийг тунхагласан күнзийн маягийн баримт бичиг мөн. Гэхдээ түүнд "багш-ивээн тэтгэгчийн" харилцаанд харшилсан утга үгүй бөгөөд "үнэнч байна" гэдэг бол боол байхын нэр биш, амбан сайд нар Шарын шашныг сүсэглэн дагана гэдэг бол Далай ламын Гэлуги чиглэлийн шашинг сүслэнэ хэмээх санаа мөн юм.

Манжийн эзэн хаад янз бүрийн хүмүүсийн тухайд харилцааны янз бүрийн арга барил хэрэглэж байсан бөгөөд тэдний хувьд күнзийн болон буддийн үзэл баримтлал бие биендээ үл харшлах ажээ. 1718 оны сүүлч, 1719 оны эхээр чин улсын төлөөлөгчид түвдэд очсон байна. Төлөөлөгчдийн аялалын дүнгээр эзэн хаан Сюанье амбан сайд нартаа дараах лүндэн буулгахдаа: “Ажил хэргийн байдал иймэрхүү байгааг хараад дараах дүгнэлт хийж болох байна. Шинэ хойд дүрийн тухайд бол түүнд Далай лам цол бэлэглэж, диплом, тамга гардуулан өгөх хэрэгтэй бизээ. Эсэргэн жилийн ногоо гарах цагаар шинээр тодорсон хойд дүрийг Түвдэд дагалдан хүргэж, Далай ламын сэнтийд залж суулгах хэрэгтэй”[2251] гэжээ. Гүмбэн хийд рүү Далай ламд явуулсан эзэн хааны зарлигт “Ирэх жилийн дөрөвдэхь сард дээд тушаалын дөрвөн түшмэл аугаа их армийн командлагчийн хамт гайхамшигт Ламыг Түвдийн У-цангад ихэд хүндэтгэн хүргэж, юутай ч зүйрлэшгүй аугаа их Будалын ордны гайхамшигт алтан сэнтийд түүнийг залж суулгана” гэжээ. Хоёр баримт бичигт өөр өөр нэр томьёо:хятад, манж нарт “зэрлэгүүдтэй” харьцдаг хэллэг, түвдчүүдэд буддийн шашны үг хэллэг хэрэглэсэн байна. Өөрөр хэлбэл эзэн хаан хятадууд, манж нарын хувьд Тэнгэрийн хүү, Дундад иргэн улсын захирагч, түвдчүүдийн хувьд буддийн шашныг ивээн тэтгэгч болжээ.

Энэ бол гайхах зүйл биш, хятадын эзэн хааны систем аливаа орнуудтай тэгш эрхтэй харилцахыг зөвшөөрдөггүй юм. Ингэхлээр Түвдтэй харилцах харилцаа “хараат -сюзерений” зарчимд л тулгуурлаж болох байжээ.[2252] Орос, англи, голландчуудад тохиолдсон явдлыг санацгаая.Түвдийн шашин төрийн удирдагчид орос, англи, голландын “бүх үүрэг хариуцлагаа хүлээсэн” боол болоогүй ажээ. Түвдчүүд боолын үүрэг хариуцлага биелүүлэх бэрхшээлтэй тулгараагүй, “багш-ивээн тэтгэгчийн” зарчмаар л хамтран ажиллаж ирсэн бөгөөд эзэн хаад ч түүнийг эсэргүүцээгүй ажээ. Тэр эзэн хаад Түвдийг гадаад, дотоодын аюулаас хамгаалахыг эрмэлзэж иржээ. Чухам тэр үед л чин улсын цэрэг Түвдэд орж, нөлөөгөө хүчтэй болгожээ.

Эзэн хаан ивээн тэтгэгчийнхээ үүргийг биелүүлж, Түвдийн улс төрийн ажиллагаанд оролцож, тус улсын хууль тогтоомжийн актуудыг гаргаж өгч байв. Гэхдээ түвдчүүд тэдгээрийг биелүүлэх, эсэхээ өөрсдөө шийдэж байжээ. Түвдэд мужийн засаг захиргаа гэж байгаагүй, Хятадын “босоо удирдлагын” систем түвдэд үйлчлээгүй, түвдийн Далай лам нар шашны нэр хүндээс гадна бодит эрх мэдэлтэй байсан юм.[2253] Далай лам нарын нэр хүнд хятадын мужуудад хүчээр нэгтгэсэн Түвд нутаг дэвсгэрүүдэд ч хадгалагдсан хэвээр байв. Еэзэн хаан Инь Жэнь VII Далай ламд явуулсан

илгээлтдээ: “Өнөө үед Өрнөдийн орнууд болон манай Сычуань, Юньнань мужууд нийтлэг хил хязгаартай байна. Үүний улмаас хоёр талын хооронд жил бүр элчин солилцож байна” гэж бичжээ. Хятадын тал энэ баримт бичгийг түвдийг хятад захирч байсны нотолгоо хэмээн буруу тайлбарлаж байгаа бөгөөд харин ч бүрXVIII зууны дунд үед хятад улс түвдээс хил хязгаараар тусгаарлагдаж байсан тухай энд яригдаж байгаа юм.[2254]

Лхас хотод амбан нар томилон суулгах болсон явдал эзэнт гүрний нөлөөг хүчтэй болгосон ч энэ нь Түвдийг Чин гүрний бүрэлдэхүүнд оруулсан хэрэг биш юм. Түвд бие даасан улс болсон билээ. Хоёр талын харилцааны тухайд гэвэл ивээн тэтгэх шинж тэмдэгтэй байсан нь үнээн. Амбан сайд нар түвдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцдоггүй, түвдчүүд болон эзэн хааны хооронд ажиглагч, зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байв. 1793 оноос хойш нөлөө хүчтэй болсон ч чин улсын бүрэн эрх тогтоход хүргээгүй юм. Тэр үеэс хойш олон улсын харилцааг нэг бол Түвд өөрөө, үгүй бол түвдийн нэрийн өмнөөс амбан сайд нар хэрэгжүүлж байжээ. Тэдний нөлөө тодорхой нөхцөл байдал болон амбан сайд нарын зан чанараас шалтгаалан нилээд мэдэгдэхүйцээс бараг тэг хэмжээний хооронд хэлбэлзэж байжээ. Сайд нарыг томилохдоо амбантай зөвлөлдөж болдог байсан ч түвдчүүд өөрсдөө эрх баригч бүлгийнхэн болон ард түмний санал бодлыг харгалзан үздэг байсан юм.

1793 онд түвдэд Лхас, Бээжингийн бүрэн эрхийг хязгаарласан “Түвдийн хэргийг журамд оруулах Дүрмийг хүндэтгэн баталснаар” Түвд орон хятадын бүрэлдэхүүнд орсон юм гэж А.С. Клинов бичжээ[2255] Энэ үйл явдал “багш-ивээн тэтгэгчийн” зарчмыг тодруулж өгсөн бөгөөд тухайн орны оршин суугч болох багш нь эзэн хаанаас нилээд доогуур байр суурь эзлэх болсон юм.Тийм учраас Түвд боол орон болсон юм гэж тэр үзжээ. Эзэн хаан ямар нэгэн баримт бичгийг хүлээж авах буюу няцаахыг санал болгоход Далай лам хүлээж авбал Хятадын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болно. Тиймээс дээр дурдсан дүрэм хятадын боол (хараат) болох түвдийн байдлыг баталгаажуулсан юм. Энэ дүрэм илүү тодорхой эрх зүйн акт болж байгаа учраас “багш – ивээн тэтгэгчийн” зарчмаас давуу эрхтэй байна, хууль эрх зүйн маргаан гарахад ерөнхий биш тодорхой норм үйлчилж байгаа юм. Энэ дүрмээр түвдийн засгийн газар хятадын эрх зүй өөрийнхөөс нь илүү хүчтэйг хүлээн зөвшөөрсөн юм. “Багш – ивээн тэтгэгчийн” зарчмын үйлчилгээний хүрээ газар зүйн хувьд Дорнод, мөн түүнчилэн Төв Азийн үлэмж хэсгийг хамарсан хятадын эрх зүйн хүрээг бодоход хязгаарлагдмал юм.

Үүнийг хүлээн зөвшөөрөхөд бэрх юм. Хятад бол Чин гүрэн бишээ.

Дээр дурдсан дүрэм “багш-ивээн тэтгэгчийн” зарчмаас илүү хүчтэй байж чадахгүй. Эдгээр хэм хэмжээг орчин үеийн олон улсын эрх зүйн ойлголтын системд ерөөс харьцуулан үзэж болохгүй юм. Түүнээс гадна Дүрэмд Түвд чин улсын мэдэлд орсон тухай ч, дотоодын хараат байдалтай болсон тухай ч заагаагүй юм. Түвдчүүд Дүрмийн зарим зүйл ангийг л хүлээж авчээ. Ингэснээр тэд удирдлагын тусламж авч, харин бусад орны мэдэлд ороогүй, энэхүү Дүрэмд үл харшилсан “багш-ивээн тэтгэгчийн” зарчмаас татгалзалгүй үлдсэн билээ.

Дээд тушаалын лам нарын хойд дүрийг Алтан бумбанаас шодож тодруулдаг явдал Түвдийг чин улсын хараат гэж үзэх нэг гол шалтгаан болжээ. Гэхдээ тэрхүү шодолтыг тэр болгон хэрэглээд байдаггүй, энэ үйлдлийг амбан сайд нар “удирддаггүй”, зүгээр л оролцох буюу ажиглагчийн үүрэг гүйцэтгэдэг ажээ. Олон тооны эх сурвалжуудад дүн шинжилгээ хийх үндсэн дээр хийсэн дүгнэлттэй санал нийлэх боломжгүй бөгөөд тэр дүгнэлтэд: “шодолтыг сугалах замаар хойд дүр тодруулах үйлдэлд төлөөний сайд нар шүүгчийн үүрэг гүйцэтгэдэг” гэж өгүүлсэн байна.[2256] Тэр сугалж гаргасан нэрэн дээр Далай ламын дардаг эзэн хааны тамга түвдчүүдийн хувьд заавал байх зүйл биш ажээ.[2257]

Хятадын эх сурвалжуудад түвдийн хэргийг бодит байдалд удирддаг хэмээх тодорхойлолт бол үнэн хэрэгтээ засаг төрийн үүргийг хэрэгжүүлэх биш, харин зарим талын туслалцаа үзүүлэх төдийгөөр л хязгаарлагдаж байжээ.[2258] Зарим оронд суугаа элчин сайд нарын өндөр статус эрх дээрхтэй төстэй зүйл байж болох юм. Тухайлбал, социалист эвслийн орнууд ЗСБНХУ-аас хараат байсан бөгөөд тус улс тэдгээрийн улс төрийн бодлого, төр, засгийн томилгоо, хууль тогтоомжийн боловсруулалт, дотоод, гадаад бодлогод их нөлөө үзүүлдэг байсан юм. Зөвлөлтийн элчин сайд нар дээрх орнуудын хэрэгт чин улсын амбан сайд нар түвдийн хэрэгт үзүүлдэгээс илүү хүчтэй нөлөө үзүүлж байв. 1980-аад оны эхээр ЗСБНХУ-аас Монгол руу бараг л өдөр бүр цэрэг, байлдааны техник ачсан галт тэрэгий цуваа явдаг байсныг миний бие санаж байна. Гэтэл хэн ч Монгол улсыг Оросын нэг хэсэг гэж үзээгүй билээ.

Аливаа төлөөлөгчийн газрыг “хараат орнуудын” төлөөлөгч хэмээн үздэг хятадын түүх судлалд нэг их ач холбогдол өгөөд байхын хэрэггүйг дээр дурдсан жишээнүүд харуулж байна. Хэрэв Түвд, Монголыг Чин улсын салшгүй хэсэг (хятад буюу манжуурын нэгэн адил) хэмээн үзэх юм бол сюзеренитеттэй төстэй “харьяатын” харилцаатай байхгүй байхсан билээ. Бээжинд гадаад харилцааны хэрэг эрхлэх танхим Түвдийн хэргийг эрхэлдэг,

тэр танхимын мэдэлд манж нар, хятадууд биш, монгол, түвд, орос, түрэг зэрэг "гадаад" ард түмнүүд байсан юм. 1906 онд энэ танхимыг Зунли-ямыны хэлтэс буюу гадаад улс төрийн хэрэг эрхлэх газар болгон өөрчилжээ. Ерөнхийдөө бол өөрийн мэдлийн нутаг дэвсгэрт явуулах гадаад харилцааны хэрэг эрхлэх танхимын үйл ажиллагаа гүйцэтгэн захирах, хууль тогтоох болон хяналтын үүргийг хослуулсан эзэнт гүрний төв байгууллагуудын үүрэг гүйцэтгэж байжээ.[2259]

Тийнхүү манжийн эзэн хаад болон. Далай лам нарын харилцаа Түвдэд цэргийн тусламж үзүүлж байх үед ивээн тэтгэгчийн шинж чанар бүхий "багш-ивээгчийн" харилцаа байсан юм.[2260]

Их Британи улс манжуурынхантай хамт түвдийн хэрэгт хөндлөнгөөс оролцсон нь тэнцвэртэй байдлыг алдагдуулсан юм. Хоёр тал хэдийгээр түвдийг чин гүрнээс ялгаатай улс төрийн субьект хэмээн үзэж байсан ч чухамдаа Их Британи улс олон улсын эрх зүйн баримт бичигт Түвдийн тухайд сюзеренитет эрхтэйгээ тусгажээ.[2261] Ингэхдээ тус улс юуны өмнө өөрийн колони болох энэтхэгийг тогтоон барьж байх тухай бодол санаа агуулжээ.

Их Британи улс энэтхэгээс хойш Чин болон оросын эзэнт гүрнүүдийн нөлөө тогтоолгохгүй байх завсрын бүс бий боллгохыг эрмэлзсэн байна.[2262] Гэвч Их Британийн эрх баригчид энэ зорилгоо тусгаар тогтнолоо олж авахад нь Түвдэд барьцтай тусламж үзүүлэх явдлаар ч, түүнийг Сикким буюу Бутаны нэгэн адил хараатын нутаг дэвсгэрийн хувьд нэгтгэх замаар ч хамгаалаагүй юм. Британчууд олон улсын асуудлаас зайлсхийж үүний оронд Бээжинд билэг тэмдгийн чанартай захируулах маягаар өөртөө засах эрх олгох тухай үзэл санаа дэвшүүлжээ.

Энд улс төрийн сонирхлоос гадна европын төвт үзэл үүрэг гүйцэтгэсэн байж болох бөгөөд ийм үзлийн хүрээнд бол "багш-ивээн тэтгэгчийн" харилцаа авцалдах боломжгүй юм. XIII Далай лам Түвд болон чин улсын харилцааг ивээн тэтгэгч болох эзэн хаантай зөвхөн өөрөө багш болохын хувьд тогтоосон хувийн харилцаа хэмээн үзэж байсан юм гэж дипломатч Ч. Белл дурсан бичжээ. Белл[2263] бол дээр дурдсан харилцаа европын ойлголтод нийцэхгүйг ойлгож мэдсэн цөөн тооны европчуудын нэг юм. Далай лам бол бодит байдалд ч, эрх зүйн үүднээс ч эх орныхоо бүрэн эрхт эзэн байсан юм гэж 1903 онд Энэтхэгийн дэд ван лорд Ж.Н. Керзон онцлон тэмдэглэжээ. Тэрээр 1903 оны нэгдүгээр сарын 8-нд Лондон руу: "Түвдийг захирах Хятадын бүрэн эрх гэгч нь үндсэн хуулийн зохиомол зүйл: хоёр талд нэр алдахгүй байх үүднээс л хийгдэж буй улс төрийн марзагнал мөн"

гэж бичжээ.[2264] Түвдэд суугаа амбан сайд "дэд вангийн" статусгүй, ердийн л элчин сайд байсан юм гэж Керзон тэмдэглэжээ.

"Түвдийн тусгаар тогтнол гэгч нь Хятадын эсрэг колончлогч, империалист түрэмгийлэл эхэлсэн XIX зууны хоёрдугаар хагасын л бүтээгдэхүүн "мэтээр үзэж болохгүй юм.[2265] Харин ч энэ бол: Их Британи улс түвдийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөхөд саад болсон Түвдийг захирах "хятадын бүрэн эрх" гэгчийг бий болгосон явдал бол дээр дурдсан түрэмгийллийн бүтээгдэхүүн болсон юм.

1904 оны Лхасын хэлэлцээр Түвдийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах манжийн засгийн газрын давуу эрхийг няцаасан билээ. Түүнээс гадна, нутаг дэвсгэрээ ямар ч нөхцөлд "гадаадын эрх мэдэлд" өгөхгүй байх үүрэг, хариуцлага Их Британиас бусад аливаа улс орон, түүний дотор Чин гүрэнд хамаарч байгаа юм.[2266] Түвдийн засгийн газар манжийн эзэн хаанаас үл шалтгаалан гэрээ хэлэлцээрт нэгдэн орох бүрэн чадвартайг британийн засгийн газар хүлээн зөвшөөрсөн явдалд Лхасын конвенцийн чухал ач холбогдол оршино. Гэвч Их Британи улс шүүмжлэлийн шахалтад орж 1906 онд чин гүрэнтэй нэмэлт хэлэлцээр (лхасын конвенцийн нэмэлт) байгуулав. Энэ хэлэлцээр Чин гүрнийг "гадаадын эрх мэдэл" хэмээх ойлголтоос хасч, Түвдийн өмнөөс гадаад хэрэг эрхлэн явуулах давуу эрхийг манж нарт олгожээ. Ингэхлээр Их Британийг бодоход Чин гүрэн түвдийн бүрэн бүтэн байдлын төлөө илүү их хариуцлага хүлээх болжээ. Хожим нь хятадын эрх баригчид үүнийг өөртөө засах эрхийг хүчингүй болгосон явдал хэмээн буруу тайлбарлажээ.

XIX зуунаас XX зууны эхэн хүртэлх хугацаанд байгуулсан нэг ч гэрээ хэлэлцээрт Түвдийг ямар нэгэн улсын салшгүй хэсэг гэж үзээгүй байна. Эзэн хаан Түвдийн нэрийн өмнөөс олон улсын асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулах эрхтэйг л хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ үүнийг ч салшгүй эрх гэж авч үзээгүй ажээ. Зориуд түвдийн асуудлаар л байгуулаагүй юм бол эзэнт гүрний аливаа олон улсын гэрээ, хэлэлцээрүүд түвдийн хувьд хүчин төгөлдөр үйлчлэх зүйл биш хэмээн үзэж байлаа.[2267] Перс, Афганистан, Түвдийн асуудлаар Орос, Их Британий хооронд 1907 онд байгуулсан конвенц хууль ёсны бус байсан, яагаад гэвэл түүнд хятадын ар хударгаар гарын үсэг зурсан гэж Ч. Ран бичжээ.[2268] Үнэн хэрэгтээ бол энэ хэлэлцээр хууль ёсны биш, яагаад гэвэл түүнд түвдийн ар хударгаар гарын үсэг зурсан юм. "Энэ бол Түвдийг захирах хятадын "бүрэн эрхийг" "сюзеренитет эрхээр" сольсон олон улсын анхны албан ёсны баримт бичиг болсон юм" гэж БНХАУ-д үзэж байна.[2269] Дараах өгүүлбэр ойлголтыг солих утга агуулж

байгаа ажээ. Суверенитет буюу бүрэн эрх гэдэг нь европ ойлголт, Чин гүрэнд бол эрх мэдлийн тухай үзэл баримтлал өөр байсан, энэ эзэнт гүрэн бол Хятад биш юм.

Түвдчүүдийн тухайд бол тэд өрийнх нь нэрийн өмнөөс гэрээ, хэлэлцээр байгуулах Чин улсын сюзеренитетийг ч, ингэх эрхийг ч хэзээ ч хүлээн зөвшөөрч байгаагүй юм. Энэхүү сюзеренитетийг бусад орон хүлээн зөвшөөрнө гэдэг бол дан ганц нэр төдий зүйл билээ. Ийнхүү хүлээн зөвшөөрөх явдал түвдийн олон улсын бие даасан байдлыг хязгаарлаагүй бөгөөд Их Британий нөлөөний хүрээнд Түвдийг оруулахад саад болжээ.[2270] Энэ нь түвдийг эзэнт гүрнийхээ мэдэлд оруулах гэсэн манж нарын оролдлогын эхлэлийг тавьжээ.

Хожим БНХАУ-д батлан гаргасан "эрх тэгш биш гэрээний" онолооор бол Түвд 1856, 1904 оны гэрээнүүдээс татгалзсан нөхцөлд л дээр дурдсан онолыг хүчингүй хэмээн үзэж болох юм.

XX зууны эхээр манж нар "багш-ивээн тэтгэгчийн" харилцааг зөрчиж: түвдэд гадаадын халдлага орохыг сэрэмжилж чадаагүй, дараа нь өөрсдөө түвдэд халджээ. Далай ламыг "түлхэн унагасан", гэвч бээжингийн эрх баригчдад ийм эрх байгаагүй ажээ. Тиймээс Далай лам хоёр талын харилцааг зогсоох тухай албан ёсоор зарлажээ. Эзэн хаад бодит эрх мэдэлгүй болж, улс орныг бэлбэсэрсэн хатан Цыси болон төр баригч Лунъюй нар захирч байсан үед манж нар ийм үйлдэл хийж, "багш-ивээн тэтгэгчийн "харилцааг цуцалжээ.

1911 онд эхэлсэн Синьхайн хувьсгалын дүнд хаант засгийг халж, Чин гүрэн задран унажээ. "1911 онд мандсан Сиьхайн хувьсгалын дүнд хятад, манж, монгол, хуй, Түвд үндэсний ард түмнийг нэгтгэсэн Бүгд найрамдах хятад улс байгуулагдсан юм. Юань, Мин, Чин улсуудын үеийнх шиг түвдийг удирдаж байсан юм".[2271] Энэ бол худал нотолгоо. Түвд, Монголчуудын эрх баригчид Бүгд найрамдах хятад улстай биш, манжийн Айсинь Гиорогийн улстай харилцаатай байсан юм. Одоо энэ харилцаа зогсчээ.

Хувьсгал гарч, эзэн хаан суудлаасаа унасан явдал засаглалын залгамж чанар тасалджээ гэсэн үг билээ. Засгийн эрхийг бүгд найрамдах улсын засгийн газарт шилжүүлэх тухай актад манжийн төр баригч гарын үсэг зурсан нь төрийн шинэ загварт шилжсэнийг илтгэн харуулсан юм. Үүнийг хараат орнууд хятадад "шилжиж" ирсэн явдал хэмээн үзэж болохгүй юм. Шинэ засгийг хараат орнуудын ард түмэн төдийгүй хятадуудын үлэмж хэсэг дэмжээгүй юм. Хятад улс тархай бутархай байдалд орж, нутаг дэвсгэрийн бүлгүүдийн тэмцэл өрнөж, Пуиг өөрийнх нь санаачлагаар байгуулсан

Манж-го улсын эзэн хаанаар сэргээн тогтоосон явдал үүний нотолгоо мөн. Тийнхүү Чин гүрний залгамжлагч бол хятад биш, харин манж-го улс бөгөөд 1934 онд зүүн талын гурван мужийн өөртөө засах эрх тийшээ шилжиж очжээ.[2272] Япон улс манж-гогийн бүрэн эрхийг хязгаарласан хэдий ч энэ бол олон улсын харилцаа бүхий улс байв. Тухайлбал, ЗСБНХУ-тай харилцаатай байсан бөгөөд зөвлөлтийн удирдлага 1945 онд манж-гог хятадад нэгтгэж, эзэн хааныг нь шоронд суулгажээ. Бүгд найрамдах хятад улс өөрийгөө Чин гүрний залгамжлагч хэмээн зарлаагүй. БНХАУ мөн өөрийгөө энэ эзэнт гүрний ч, энэ бүгд найрамдах улсын ч залгамжлагч гэж зарласангүй. Түүнээс гадна Бүгд найрамдах хятад улс, БНХАУ бол үндэсний улсууд юм. Энэ бол хаанаар удирдуулсан эзэнт гүрнийг бодоход төрт ёсны өөр төрөл мөн.

Тэгтэл ч хуучин османы эзэнт гүрний залуу туркуудын үзэл баримтлалтай төстэй “нэгдмэл олон үндэстний хятад улсын” үзэл баримтлал гэгчийг санаанаас зохиох шаардлага гарч иржээ. Үүнийг ашиглан хятадын үндсэрхэх үзэлтнүүд бусдын газар нутгийг “эргүүлж авах” ажил эрхлэв. 1912 оны дөрөвдүгээр сарын 8-нд хятадын ерөнхийлөгч Юань Шикай монгол, түвд, дорнод туркестаны хараат нутаг дэвсгэрийн статусыг халах тухай хууль гаргаж: тэдгээрийг хятад мужуудтай адил болгожээ. Энэ үйл ажиллагаа хятад улс сул дорой хөршүүдээсээ цэргийн хүчээр давуу, европынхон тус улсыг Чин гүрэнтэй адилтган авч үзэж байсны улмаас цаашид үргэлжилжээ.

Хувьсгалын дүнд үүсч бий болсон улс хууль ёсных мөн бишийг бодитой бие даасан байдлын түвгшингээр тодорхойлдогийг дээр авч үзсэн билээ. Бүх эзэнт гүрэн тийм нөхцөлд мөхөж, хуучин боол буюу хараат байсан субьектүүд тусгаар тогтнох эрхтэй болдог нь маргаангүй юм. Үүнийг ойлгосон большевикууд хуучин оросын эзэнт гүрний газар нутгийг эзэлж аваагүй бөгөөд харин тийш хувьсгал экспортолсны дараа шинэ эрх баригчид өөрсдөө холбоо тогтоохыг хүсчээ. ЗСБНХУ зарим талаар сэргэсэн эзэнт гүрний хувьд дан ганц нэгдмэл улс байгаагүй юм.

Чин гүрэнтэй харьцуулах хамгийн тохиромжтой жишээ тбол Османы эзэнт улс мөн. Эзэнт гүрний системийн нийтлэг зүй тогтол гэж байдаг болохоор энд бүх талаар адил байх тухай биш, төстэй талуудын тухай авч үзье. Чин гүрэн (манж нар) Мин улсыг (хятад) булаан эзэлсэн бол Османы (турк) эзэнт улс Византийн (грек) улсыг булаан эзэлжээ. Манж нар болон османы туркууд булаан эзэлсэн улсуудынхаа нийслэлийг (Бээжин ба Константинополь) нийслэл хотоо болгожээ. Манж нар эрх мэдлээ Монгол,

Зүүнгар, Дорнод Туркестанд, нөлөөгөө Түвд болон бусад нутаг дэвсгэрт дэлгэрүүлсэн бол Туркууд балканы хойгийн орнууд, египет, иракийг эзэлж, Алжир, Арави, Молдав болон бусад оронд нөлөөгөө тогтоожээ. Чин гүрэнд ч, Османы эзэнт улсад ч боол болон хараат улсууд байлаа. Хоёр гүрэн мөхөж, хоёуланд нь хувьсгал гарчээ. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн болон дайны ялагдлаас болж энэ хоёр гүрнээс нийслэлээ эзэнт гүрний нийслэл болгуулсан орнууд буюу Грек, Хятад улсууд бие даан салжээ. Грек улс уугуул газар нутгийнхаа зарим хэсгийг эргүүлэн авч, Османы эзэнт гүрний бусад "өвийн" төлөө өрсөлдөхгүй байна. Жишээ нь, Йемен буюу Молдав бол Грекийн салшгүй хэсэг мөн гэж мэдэгдэхгүй байна. Гэтэл хятадын эрх баригчид тийм нөхцөлд Монгол, түвдийг салшгүй хэсгээ хэмээн зарлаж байна.

Өөр нэг жишээ бол АНУ юм. 1776 оны долдугаар сарын 4-нд их Британийн зөвшөөрөлгүйгээр "тусгаар тогтнолын тухай Тунхаглал" гаргасныг эрх зүйн үндэсгүй гэж хэн ч няцаахгүй байна. Үүний тайлбар түвдийнхтэй харьцуулахад илүү энгийн бөгөөд: "Нэг ард түмэн түүнийг өөр ард түмэнтэй холбож байсан улс төрийн шижмийг аргагүйн эрхэнд тасалж, дэлхийн гүрнүүдийн дотор бие даасан, тэгш эрхтэй байр сууриа эзэлжээ".[2273]

Түвд, хятадын улс дотоодын харилцаа хувьсгалын дараа үүссэн байж болохгүй юу? Тэр үед Хятад, түвдийн хооронд, хятадын ерөнхийлөгч болон Далай ламын хооронд нэг нь нөгөөгөө захирах ямар ч харилцаа байгаагүй юм. Хятадын нутаг дэвсгэрийн өнгөлзлөгийг Түвд ямагт няцааж иржээ. Үүнийг тэр үед хятадын засгийн газраас гаргаж байсан:түвд Бүгд найрамдах хятад улсыг"сайшаав", "хүлээн зөвшөөрөв", "нэгдэж оров" мэтийн мэдэгдлүүдээс тодорхой харж болно.[2274]

XIII Далай лам энэтхэгээс буцаж ирснийхээ дараа түвдийн засгийн газрын эрхийг сэргээн тогтоох болсон тухайгаа албан ёсоор мэдэгджээ. 1913 онд тусгаар тогтнолын тухай баримт бичиг нийтлэгдэж, дараа нь 40 шахам жил Түвдийн засгийн газар засгийн бүх эрхийг хэрэгжүүлж иржээ. Тиймээс хятадын засгийн газрын гишүүдийн нэрсийн жагсаалтад 1913 оны тавдугаар сард "түвдийн төлөөлөгчдлийг" оруулсан нь хууль бус үйлдэл байв. Кам муж хятадын нэг хэсэг байгаагүй учир тус мужийн захирагч 1913 онд XIII Далай ламаар хууль ёсоор сонгогдсон байна. Түвд төвийн болон орон нутгийн үр нөлөөтэй засаглалаас гадна арми, хууль эрх зүйн систем, татвар оногдуулалт, цахилгаан холбоо, шуудан, валют, өөрийгөө хангах толтолцоо гээд бие даасан улсын бүх шаардлагатай албатай байв. Тус улс

зоосон мөнгөө цутгаж, цаасан мөнгө болон шуудангийн марк хэвлэн гаргаж байлаа. 1947 онд өрнөд рүү гарсан В.Д. Шакабпа тэргүүтэй түвдийн анхны төлөөлөгчид очсон улс бүрийн засгийн газрууд хүлээн зөвшөөрсөн өөрийн гэсэн Түвд паспорттой байжээ. Түвдэд цагаач засгийн газар болон эрх чөлөөний төлөө тэмцэгчдийн одоо ч хэрэглэж буй сүлд, далбаатай байжээ.

Хятадын суртал нэвтрүүлэгчид энэ далбааны тухай мэдээлэхдээ: “1947 онд түвдийн эрх баригчид Их британи, АНУ болон өрнөдийн бусад орны дэмжлэгтэйгээр Дели хотноо болсон Ази дундын бага хуралд төлөөлөгчдөө явуулсан юм. Тэрхүү бага хуралд оролцохын тулд түвдийн эрх баригчид цаст уулын цагаан арслангийн дүртэй түвдийн армийн далбааг яаравчлан бэлтгэж, түүнийгээ “түвдийн үндэсний далбаа” болгон хэрэглэсэн юм” гэсэн нь үнэхээр инээдтэй явдал билээ.[2275] Түвдчүүд өөрийн гэсэн далбаа хийсэн, харин БНХАУ-ын далбааны үндсэнд үндэсний биш, харин дэлхийн хувьсгал болон коммунизмаас зээлдэж авсан билэг тэмдэг байдаг юм.

Эдийн засгийнхаа шалгуураар ч Түвд бие даасан улсын шинж чанарт бүрнээ нийцэж байгаа юм. Хөгжингүй аж ахуй бүхий орчин үеийн улсуудын хил эдийн засгийн нэгдмэл механизм үйл ажиллагаа явуулж нутаг дэвсгэрийн хил хязгаартай давхцах ёстой билээ.[2276] Түвд өөртөө хүрэлцээ бүхий эдийн засагтай, шаардлагатай бүх хэрэгцээгээ хангаж байв.

1947 онд хятадын үндэсний хуралаас батлан гаргасан үндсэн хуульд Түвдэд өөртөө засах эрх баталгаатай олгоно гэж өгүүлсэн байна. Түүний хуралдаануудад түвдчүүд оролцжээ. Үүнийг Түвд орон хятадын бүрэлдэхүүнд орсон хэрэг хэмээн тайлбарладаг юм. Гэтэл тэр түвдчүүд оролцогчид биш, зөвхөн ажиглагчид байжээ. Тэд үндсэн хуулийг хүлээн зеөвшөөрч, гарын үсэг зураагүй, тэгэх ч бүрэн эрхгүй байсан юм. Ингэхлээр тэнд орсон Түвдийн тухай зүйл анги жишээлэхэд ОХУ-ын үндсэн хуульд Финланд буюу Польшийн өөртөө засах эрхийн тухай зүйл анги орсонтой адил хууль бус зүйл юм. Хятадын бүгд найрамдахчууд дахиад л хаант засгийн үеийн арга хэрэглэж: гадаад улсуудын элч төлөөлөгчид сүслэн дагахаа илэрхийлэхээр ирсэн бөгөөд албан ёсны хүлээн авалт бол тэр төлөөлөгчдийн харьяалах улсууд хятадад захирагдах болсны ёслол байсан юм гэж мэдэгджээ.

Судлаачид гол төлөв хамгийн “сул талуудыг” олж заадаг бөгөөд энэ нь Түвдийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тодорхой баримт байхгүй юм гэж иш татдаг юм. Нэг иймэрхүү баримт гаргаж ирж байгаа юм. Иргэд, төрийн байгууллагын харилцааг зохицуулах олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн үндэслэлээр бол тусгаар тогтносон улс эрх зүйн

субьектын гурван үндсэн элемент буюу улс төрийн шинж чанартай олон улсын гэрээ хэлэлцээрт бие дааж оролцох, олон улсын байгууллагуудад бие даан оролцох, дипломатын үндсэн дээр олон улсын эрхийн субьектуудтай олон улсын хэлхээ холбоо хэрэгжүүлэх эрх эдлэх ёстой. Түвдэд 1911–1951 онд энэ бүхэн байгаагүй юм.[2277] Гадаад Монгол 1913 онд түвдийн тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн ч олон улсын эрх зүйн үүднээс авч үзвэл Монгол улс албан ёсоор хятадын нэг хэсэг байсан учир ийнхүү хүлээн зөвшөөрөх боломжгүй байсан: Түвдтэй харилцаатай байсан гэх Бутан, Балба улсууд Их Британиас хараат орнууд байсан билээ гэж хятад судлаачид үздэг ажээ.

Олон улсын хуульчдын комиссийн дүгнэлт бол экспертийн дагнасан дүгнэлт бөгөөд олон улсын шүүхийн Дүрмийн 38-р зүйлийн 1-д зааснаар бол олон улсын конвенцуудтай харьцуулахад туслах чанарын хэрэгсэл болдог байна. Энэ тохиолдолд 1914 оны Симлагийн конвенц болон 1954 онд Энэтхэгтэй БНХАУ-ын быайгуулсан хэлэлцээрийг авч үзэх гэж байна.[2278] Симлагийн конвенц түвдийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн акт болж чадахгүй, хожим нь түүнийг өөр баримт бичгүүдээр сольжээ. НҮБ-ын тогтоолууд зөвлөмжийн, заавал биелүүлэх биш шинж чанартай байна. Ингэхлээр Түвдийн статус эрхийн тухай асуудлаар гаргасан олон улсын баримт бичгүүдийн дотроос НҮБ-ын тогтоолууд болон олон улсын хуульчдын комиссийн дүнэлтүүдээс БНХАУ, Бүгд Найрамдах Энэтхэг улсын хооронд байгуулсан Хятадын Түвдийн район, Бүгд найрамдах энэтхэг улсын хооронд 1954 оны дөарөвдүгээр сарын 29-нд байгуулсан худалдаа, харилцааны тухай хэлэлцээрийг илүүд авч үзэх хэрэгтэй юм. Энэ хэлэлцээр Түвдийг захирах хятадын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч байгаа юм. Ингэхлээр олон улсын баримт бичгүүдийн зэрэглэлээр бол Түвд нь хятадын нэг хэсэг болж байна.

Энэ учир шалтгааныг хүлээн зөвшөөрөхөд хэцүү юм. Энэ толхиолдолд Монгол улстай түвдийн байгуулсан гэрээ шийдвэрлэх ач холбогдолтой байх ёстой бөгөөд яагаад тэр вэ.Түвд-монголын гэрээнд 1913 оны нэгдүгээр сарын 11- нд монголын нийслэл Өргөө хотод гарын үсэг зуржээ. Энэ гэрээнд “монгол, түвдийн тал манжийн дарлалаас чөлөөлөгдөж, хятадаас тусгаарлагдмагцаа бие даасан улсаа байгуулсан юм” гэж өгүүлсэн байна. Энэ гэрээ олон улсын өргөн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөөгүй ч дараах шалтгаанаар улс хооорондын харилцаа тогтоосныг баталсан хууль ёсны акт болж байгаа юм.[2279] Түүнээс нилээд өмнө 1912 оны арван нэгдүгээр сарын 3-нд Орос-Монголын хэлэлцээрт гарын үсэг зурж, Монгол улсын “өвөрмөц”

буюу өөртөө засах байгууллыг" тунхаглаж, монгол улс "хятад болон өөр гадаад улстай" гэрээ хэлэлцээр байгуулах эрхтэй болсон билээ. Баримт бичгийн агуулгаар, түүнийг боловсруулж байгуулсан (Бээжинг алгасан бие дааж) аргаас нь авч үзвэл тэр үед олон улсын хэд хэдэн шинжээчийн үзэж байсны адил бие даасан улс үүсч бий болсныг дээрх хэлэлцээрээр хүлээн зөвшөөрсөн байна. Тэр гэрээнд "Гадаад монгол" хэмээх үгийн оронд Монгол улс хэмээх илүү өргөн агуулгатай нэр томьёо хэрэглэжээ. Монгол улсын байгууллыг гэрээний орос хувилбарт "автономит", "бие даасан", монгол хувилбарт "бие даасан", "тусгаар тогтносон" хэмээх нэр томьёогоор илэрхийлжээ. Хоёр хувилбар хоёулаа нэгэн адил хуулийн хүчинтэй байв. Орос улс Монголыг гэрээ байгуулсан улс хэмээн үзэж Бүгд найрамдах хятад улсаас түрүүлж хүлээн зөвшөөрсөн байна. Энэхүү баримт бичигт гарын үсэг зурсан тухай дэлхий дахинд зарлан мэдээлсэн нь "Монгол" хэмээх нэртэй шинэ улсыг хэрэг дээр хүлээн зөвшөөрсөн явдал болсон билээ. Монгол улс тэр өдрөөс эхлэн олон улсын эрх зүйн хуулийн субьект болжээ. Тэр үед түвд-монголын гэрээг бусад орноор хүлээн зөвшөөрүүлэх шаардлагагүй байв. Монгол улс түвдийг хүлээн зөвшөөрсөн нь түвдийг олон улсын эрх зүйн субьект болгожээ. Харин 1915 оны Орос, Хятад, Монголын Хиагтын гурван этгээдийн хэлэлцээрээр монгол улсыг хятадын автономи хэмээн нэр төдий хүлээн зөвшөөрч, хожим нь тус улс тусгаар тогтносон улс болсон юм.

1949 онд Балба улс НҮБ-д элсэх өргөдөл гаргахдаа Түвдийг хүлээн зөвшөөрсөн байна.[2280] Тухайлбал, Балба улс дипломат харилцаатай зургаан улсын бүрэлдэхүүнд Түвдийг оруулжээ. Балба улс өөр улсын нэг хэсэг буюу колони биш, бие даасан улсын хувьд Түвдтэй ийм харилцаатай байжээ. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх буюу хүлээн зөвшөөрөхгүй байх нь шинэ улс оршин тогтноход нөлөөлдөггүй болохоор дээр дурдсан бүх акт бичгүүд Түвдийн төр ёсны нэмэлт гэрч нотолгоо л болж байгаа юм.

Тийнхүү 1950 онд БНХАУ халдаж орох хүртэл Түвд бодит баримтаар ч, эрх зүйн хувьд ч бие даасан орон байжээ. Түүхийн тухай тухайн үед гадаадын хөндлөнгийн оролцоо үлэмж хэмжээтэй байсан ч Түвд орон дээр дурдсан хугацаанд бодит болон албан ёсны бие даасан байдал, төрт ёсны шинж чанаруудтай байсан юм.[2281] Олон улсын эрх зүйн хувьд бол энд тухайн улсын ззлгамж шинж чанар хэзээ ч зөрчигдөж байгаагүй ажээ. Тийм бишсэн бол жишээ нь, Бутан, Чехословак, БНАГУ, БНМАУ-ыг бие даасан улсууд гэж үзэж болохгүй байхсан билээ. 1950 онд Түвд, хятадын харилцааг авч үзвэл өнгөрсөн зуунд эрх баригчид нь нидерландыг эзэмших эрхтэй хэмээн зарлаж байсан Испани болон Францтай нидерландчуудын

хэрэгжүүлж ирсэн харилцаанаас үлэмж доод түвшинд байжээ.

Хятад улсын нэгдэж орсон 1928 оны Парисын гэрээгээр дайныг олон улсын маргаан шийдвэрлэх хэрэгсэл, үндэсний бодлогын хэрэглүүр болгож ашиглахыг хориглосон байна[2282] Тийм дайныг олон улсын эрх зүйн хэмжүүрээр бол цэргийн гэмт хэрэг хэмээн үзнэ. БНХАУ-ын эрх баригчид түрэмгий дайн болон хүч хэрэглэхээр сүрдүүлэх явдлыг тууштай зэмлэн буруушааж иржээ. НҮБ-ын Дүрмийн 1-р бүлгийн 2-р зүйлийн 4-т "НҮБ-ын бүх гишүүн орон олон улсынхаа харилцаанд аливаа улсын нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг, түүнчилэн Нэгдсэн Үндэстний зорилгод үл нийцэх бусад ямарваа хэлбэрээр хүчээр сүрдүүлэх буюу түүнийг хэрэглэхээс түдгэлзэнэ" гэж заасан байна.[2283] Энэхүү дүрэм 1945 оны аравдугаар сарын 24-нд буюу Түвдэд БНХАУ халдаж орохоос өмнө хүчин төгөлдөр болжээ.

Энэ халдлага төрийн бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын зарчим, интервенц хийх болон хүчээр сүрдүүлэхийг хориглох зарчмыг зөрчиж, олон улсын эрх зүйд харшилж байна. Энэ халдлага БНХАУ-ын оролцсон Үндэстний холбоо байгуулах тухай Версалийн гэрээ, Парисын энхийн гэрээ, НҮБ-ын дүрэм, бусад гэрээ хэлэлцээрийн заалтын үг үсэг,үзэл санаанд харшилж байгаа юм.[2284] Түүнээс гадна Түвдэд халдаж орсон явдал түрэмгийллийг тодорхойлох тухай 1933 оны Конвенцийн зүйл 2(2)-т зааснаар бол түрэмгийллийн ажиллагаа, Нюрнбергийн болон Токиогийн олон улсын цэргийн шүүхийн дүрмийн 6 а болон 5-р зүйл ангиар бол энх тайвны эсрэг гэмт хэрэг болж байгаа юм.[2285] Хятад бол токиогийн шүүхийг бүрэлдүүлэгч 11 холбоотны нэг юм.

1951 оны тавдугаар сарын 23-нд "Түвдийг энх тайвнаар чөлөөлөх талаар авах зарим арга хэмжээний тухай Хятадын ардын төв засгийн газар, түвдийн орон нутгийн засгийн газрын хэлэлцээрт" гарын үсэг зурав. 1954 оны есдүгээр сард БНХАУ-ын үндсэн хууль баталсан БХАТХ-ын анхдугаар чуулганы ажилд Далай лам, Банчин лам, бусад Түвд хүн оролцож, Далай лам БХАТХ-ын байнгын хорооны орлогч дарга, Банчин лам тус хорооны гишүүнээр сонгогдов. Энэ хоёр тохиолдолд түвдчүүд гадна талын илэрхий шахалтан дор ажилласан байна.

Түүнээс гадна 1951 онд төлөөлөгчид тийм хэлэлцээрт гарын үсэг зурах эрхгүй, тамгыг Бээжинд хуурамчаар үйлдсэн байв.

Хэрэв зэвсэгт хүчин нь "хэлмэгдэгч-улсыг" эзлэж авсан улс ямар нэгэн хэлэлцээрийг тулган хүлээлгэсэн буюу хэлмэгдэгч улс эзэгнэлд буюу олон улсын эрх зүйг зөрчсөн тийм эзэгнэлийн аюулын өмнө байгаа бол тийм

хэлэлцээр хуулийн хүчинтэй байж чадахгүй.[2286] Олон улсын гэрээний эрхийн тухай Венийн конвенцийн 52-р зүйлд зааснаар хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр сүрдүүлсэн нөхцөлд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд бүр эхнээс хүчин төгөлдөр биш байна.[2287] НҮБ-ын олон улсын эрх зүйн комиссийн дүгнэлтээр бол хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн үүднээс хууль бус сүрдүүлгэн дор буюу хүч хэрэглэх замаар байгуулсан гэрээ хүчин төгөлдөр биш байна.[2288]

17 зүйлт хэлэлцээрт түрэмгийллийн нөхцөлд, Түвдийг эзэгнэж эхэлсэн үед, шахалтан дор гарын үсэг зуржээ. Далай лам болон түүний засгийн газар энэ хэлэлцээрийг батлахаас татгалзжээ.

Энд гурван чухал нөхцөл байгаа юм. Нэгдүгээрт, БНХАУ-д энэ хэлэлцээрийг олон улсын биш, харин дотоодын гэрээ хэмээн үзэж байгаа бөгөөд 1969 оны Венийн конвенц бусад улсын тухайд л түрэмгийлэл үйлдэх буюу үйлдэхээр сүрдүүлэхийг хоригложээ. Гэсэн ч дээр дурдсан баримтууд Түвдийг бусад улсын нэг хэмээн үзэх боломж олгохгүй байна. Чин улсын үеэс ялгаатай нь гэвэл Түвд 1951 онд гадаадын цэрэг ирүүлэхийг хүсээгүй юм. Тиймээс манжийн эзэн хаад болон хятадын коммунистууд Түвд рүү цэрэг илгээсэн явдлын хооронд тэнцүүгийн дэмдэг тавьж болохгүй юм. Хоёрдугаарт, Далай лам болон түүний түшмэд шинэ нөхцөл байдлыг зөвшөөрч, хятадуудын байгуулсан засаг төрийн шинэ байгууллагуудад оролцсон явдал юм. Гуравдугаарт, Түвд дэхь хятадын оролцоо, 17 зүйлт хэлэлцээрийг өргөн хэмжээгээр эсэргүүцсэн явдал юм. Сүүлчийн хоёр зүйлд түвдчүүд сөрөг байр сууринаас ханддаггүй юм, яагаад гэвэл албадлагын арга хэмжээнд өгсөн өөр хоорондоо уялдаа холбоотой хариу үйлдлүүд юм.[2289] Тийм нөхцөлд Далай лам хэнд ч хэрэггүй хүчирхийллээс зайлсхийж, түвдийн хувьд өөртөө засах эрхийг ч болов хадгалж үлдэхийг эрмэлзжээ. Хэрэв эсэргүүцэл үзүүлсэн бол энэ эрх ч үгүй болох байжээ.

Хэрэв хүчээр сүрдүүлж гэрээ байгуулсан бол “хэлмэгдэгч улс” хэзээ ч энэхүү гэрээ хүчингүй гэж мэдэгдэх эрх эдэлсэн хэвээр байна. Далай лам болон түвдийн албаны бусад хүн цагаачлан гарч, байр сууриа ил шууд илэрхийлэх боломжтой болсныхоо дараа ийнхүү мэдэгдсэн билээ. Далай лам цагаачлахаар гарсныхаа дараа энэхүү Хэлэлцээр хууль ёсны хүчгүй хэмээн зарласан юм.[2290] Далай лам бүр 1952 оны эхээр Такцер ринбүүчийгээр дамжуулан АНУ-руу явуулсан илгээлтдээ хятадууд хүч хэрэглэн түвдчүүдэд болзлоо тулган хүлээлгэсэн юм гэж бичжээ.[2291]

Ингэхлээр 17 зүйлт хэлэлцээр бол олон улсын эрх зүйн үүднээс авч үзвэл түүнд гарын үсэг зурсан цагаас эхлэн хууль бус байсан, хожим ч

хууль ёсных болоогүй билээ. 1950-аад онд Бээжинд түвдийн төлөөлөгчдийн явуулсан бусад үйл ажиллагааны тухай мөн л иймэрхүү зүйл хэлж болно, яагаад гэвэл тэд эрх чөлөөтэй байдалд биш, эх орныг нь булаан эзлэх ажиллагаа эхэлж байх нөхцөлд шийдвэр гаргаж байсан юм. Зарим хуульч үүнд эргэлздэг юм.[2292] Тэгэхдээ хүрвэл дайны дүнд1856 онд Балбатай байгуулсан Түвдийн хэлэлцээрийг ч, 1904 онд Их Британтай байгуулсан гэрээг ч хууль бус хэмээн үзэх хэрэгтэй гэж тэд үзэж байна. Энэ эргэлзээ ул үндэс муутай юм. Энэхүү зарчим 1945 оноос үйлчилж эхэлсэн бөгөөд XIX зуун болон XX зууны эхэн үеийн гэрээ, хэлэлцээрүүдэд хамаарахгүй юм. Түүнээс гадна, 17 зүйлт хэлэлцээрийг хятадын тал байнга зөрчиж иржээ.

XX зууны эхний хагаст янз бүрийн орныг булаан эзэлж, тэдгээр орны засгийн газарт иймхүү булаан эзлэх явдлыг зөвшөөрүүлэх гэж албадаж байсан аймшигт жишээнүүдийг харьцуулах үүднээс дурдан хэлж болох юм. Жишээ нь, Австрийг фашист герман өөртөө хүчээр хавсарган нэгтгэх гэсэн бодлого байна. 1938 оны хоёрдугаар сарын 12-нд Австрийн канцлер Гитлерийн өргөөнд дуудагдан очиж, улс орноо германы хяналтад оруулах тулган шаардах бичигт гарын үсэг зуржээ. 1938 оны хоёрдугаар сарын 22-нд Их Британий ерөнхий сайд Н.Чемберлен хэлэхдээ Австри улс үндэстний лигийн хамгаалалтад найдаж чадаагүй юм гэж мэдэгдсэн байдаг. Гуравдугаар сарын 11-нд австрийн канцлер огцорч, тус улсын хил дээр бөөгнөрсөн германы цэрэг Австрид орсон юм. Австрийн арми бууж өгөв. Гуравдугаар сарын 13-нд "Австри улсыг Германы эзэнт гүрэнтэй сэргээн нэгтгэх" тухай хууль гарав. Дараа нь Герман, Австрид олон нийтийн санал асуулга (түвдэд хэзээ ч тийм санал асуулга болоогүй) болов. Австричуудын дийлэнхи олонхи нь дэмжсэн санал өгсөн байна.

1940 онд Данийг булаан эзэлсэн өөр жишээ байна. А. Гитлер булаан эзлэх ажиллагаанд бэлтгэх тухай удирдамжид: "Зарчмын хувьд Скандинавын хойгийн орнуудын төвийг сахисан байр суурийг зэвсгийн хүчээр хамгаалах зорилготой энхийн шинж чанартай ажиллагаа явуулах гэж буй дүр харагдуулахыг эрмэлзэх хэрэгтэй ажиллагаа эхлэхтэй нэгэн зэрэг эдгээр орны засгийн газарт зохих ёсны шаардлага тавих болно. Шаардлагатай гэж үзвэл зохих шахалт үзүүлэхийн тулд нисэх хүчин,флотын үзүүлэх ажиллагаа явуулна. Хэрэв энэ бүхнийг үл харгалзан эсэргүүцэл үзүүлбэл өөрт байгаа цэргийн бүх хэрэгслийн тусламжтайгаар энэхүү эсэргүүцлийг нуга дарах болно" гэж бичжээ.[2293] 1940 оны дөрөвдүгээр сарын 9-нд Копенгаген хотод суугаа германы элчин сайд Данийн засгийн газарт тулган шаардах бичиг гардуулж, "рейхийн хамгаалалтад" нэн даруй, аливаа эсэргүүцэлгүйгээр

босохыг шаарджээ. Их Британиас тусламж ирнэ гэж хүлээх үр дүнгүй болсон байв. Би болон манай засгийн газар улс орондоо энх амгалан байдал, дэг журам сахин хадгалж, даничууд болон германы цэргийн хооронд гарах аливаа эвдрэлцээнийг зайлуулахын тулд бололцоотой бүхнийг хийнэ гэж Данийн хаан мэдэгджээ. Тэрээр улс орноо золгүй явдлаас хамгаалахыг хүсчээ.

Даничууд ч, австрийнхан ч боссонгүй. Тэд угсаатан болон соёлын хувьд түвд,хятадуудыг бодоход германчуудад илүү ойр байжээ. Мөн Австри,Герман хоёр улс нэгэн цагт нэгдмэл улс буюу Ариун Ромын эзэнт гүрний бүрэлдэхүүнд орж байжээ. Гэсэн хэдий ч Авсри болон Дани улсад тохиолдсон явдлыг олон улсын эрх зүйн үүднээс хүчээр булаан эзэлсэн хэрэг хэмээн тайлбарладаг юм.

Түвдийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөхөд сааад хийж байсан орнууд болох Их Британи, АНУ Авсрийг хүч хэрэглэн нэгтгэхийг хүлээн зөвшөөрч байжээ. Гэтэл өнөө үед тэд Австрийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байна.

Сүүлийн үед БНХАУ-аас янз бүрийн оронтой байгуулж буй хоёр этгээдийн тунхаглалуудад Түвд хятадын мэдэлд байгаа тухай үг өгүүлбэрүүд байнга орох болжээ. Тиймэрхүү тунхаглалууд бусдын нутаг дэвсгэрийг мөнхөд эзэмших баталгаа болж чаддаггүйг түүх нотолно.

Гэвч 17 зүйлт хэлэлцээрийг хууль ёсны хэмээн үзэж буй хүмүүсийн байр суурин дээр очих гээд үзье. 1959 оны түвдийн бослогын улмаас энэ хэлэлцээр хэрэгжихээ зогсож, хэрэг дээр 1959 оны гуравдугаар сарын 28-ны өдрийн төрийн зөвлөлийн тушаал болон БНХАУ-ын дараа дараачийн үйлдлүүдээр хүчингүй болсон юм. Дээр дурдсан бослого түвдийн засгийн газрын оролцоогүйгээр гарчээ. Ингэхлээр түвдийн тал бослогын төлөө, түүнчилэн хэлэлцээр тасалдсаны төлөө хариуцлага хүлээхгүй. Үүний төлөөх хариуцлага хятадын талд оногдоно. Яагаад гэвэл хятадын тал онолын хувьд бослогыг дарснаас хойш ч хэлэлцээрийг биелүүлж болох байсан боловч түүнтэй холбогдохгүй байх нь зүйтэй гэж үзжээ. Ингэснээр хятадын тал одоо болтол иш татан улиглаж буй хууль эрхийн тэрхүү үндсийг устгасан юм. Тийнхүү хэрэв Түвд дэх хятадын засаглал 17 зүйлт хэлэлцээрээр хууль ёсны болсон гэж үзэх юм бол 1959 оноос энэхүү хууль ёсны байдлыг хятадын тал зогсоосон болж таарч байгаа юм.

Түвдийн тусгаар тогтнолын түүх, түүнийг XX зуунд хятадын бүрэлдэхүүнд оруулсан түүхэнд Монголтой тохиолдсон үйл явдалтай төстэй зүйлүүд бий юм. Гадаад монгол манжийн эзэнт гүрнээс Түвдээс ч

илүү их хараат байсан: манжийн эзэн хаан эзэн орны эрх эдлэн монголын ноёд, вангуудад газар, албан тушаал шагнаж, өв залгамжлах асуудлыг шийдвэрлэж байлаа. Чин гүрний бууралтын үед Түвд, Монгол улсууд хамтдаа Чин гүрнээс өрх тусгаарлахаар шийдэж, хожим нь улс хоорондын гэрээ байгуулжээ. Оросын хаант улс Гадаад монголын автономи эрхийг хятадаар хүлээн зөвшөөрүүлж, Их Британи улс чин гүрний сюзеренитет эрх болон түвдийн бие даасан байдлыг хүлээн зөвшөөрсөн байна. Монголд ч, түвдэд ч үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөв. Монгол улс ЗСБНХУ-ын дагуул улс болж хятадад эзлэгдэх аюулаас ангижирсан боловч үүний төлөө өндөр үнэ төлж: улаантнуудад шашин,соёлоо устгуулав. Тэр үед Түвд бие даасан хэвээр байсан юм.

Дэлхийн хоёрдугаөар дайны дараа дэлхийн байгуулалтыг И.В. Сталин, Ф. Рузвельт, У. Черчилл нарын Ялтын хэлэлцээр тодорхойлсон юм. Их Британи улс Түшдийн тусгаар тогтнолыг хадгалж үлдэхийн тулд юу ч хийгээгүй. Харин ЗСБНХУ-ын удирдагчид БНМАУ-ын талаар өөр бодлого баримталсан юм. Сталин Ялтын хэлэлцээрт БНМАУ-ын статус-квог тусган оруулж, дараа нь тусгаар тоогтнолын тухай асуудлаар бүх ард түмний санал асуулга явуулахыг зөвшөөрөв. Энэ бүхний дүнд хятад улс БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн юм. Өөр холбоотон түшиглэхээс өөр аргагүй болсон Түвд хятадад эзлэгдэв.

Ард түмнүүдийн өөртөө засан тохинох эрхийг НҮБ-ын дүрэм болон олон улсын бусад хэд хэдэн баримт бичигт тунхаглажээ. Энэ эрх колонийн биш нөхцөл байдлуудтай бүрэн дүүрэн нийцэхгүй байна.[2294] Гэхдээ зөвхөн түвдийн ард түмэнд зориулж энэ эрхийг 1961 оны арван хоёрдугаар сарын 20-ны өдрийн НҮБ-ын ерөнхий ассамблейн 1723 тоот тогтоолоор нотолсон билээ. Гэвч Түвдийн асуудлаар гаргасан энэ болон бусад тогтоол биелээгүй, яагаад гэвэл эдгээр тогтоол зөвлөлмжийн шинж чанартай байдаг, их гүрнүүдэд тэдгээрийг биелүүлэхийн төлөө тэмцэх ашигтай биш байдаг ажээ.

1990-ээд онд хүний эрх, олон улсын хууль тогтоомжийн асуудал эрхэлсэн шинжээчид түвдийн ард түмний өөртөө засан тохинох тухай асуудлыг хэд хэдэн удаа авч хэлэлцжээ.[2295] 1992 оны арван нэгдүгээр сард Страсбург хотод хуралдсан олон улсын байнгын шүүхийн хурлаас түвдчүүд өөртөө засан тохинох эрх бүхий ард түмний нийтээр хүлээн зөвшөөрсөн шалгуурт нийцэж байгаа учир тэдэнд энэ эрхийг хэрэгжүүлэх боломж олгох ёстой юм гэсэн дүгнэлт хийжээ. “Түвдийн нутаг дэвсгэрт хятадын засаг захиргаа үйл ажиллагаа явуулж байгаа нь түвдийн ард түмнийг гадаадынхан ноёрхож

байгаа" хэрэг хэмээн үзэх хэрэгтэй бөгөөд "1950 оноос түвдийн ард түмэн өөртөө засан тохинох эрхээ хэрэгжүүлэх боломжоо алдсан байна" гэж тус шүүх тогтоожээ.[2296]

Ард түмнүүдийн өөртөө засах эрхийн асуудлаарх томоохон мэрэгжилтнүүд оролцсон Европ, Африк, Ази, Умард болон өмнөд америкийн олон улсын эрхийн нэрд гарсан 30 мэрэгжилтэн хэдэн долоо хоногийн дараа Лондонд болсон өөр нэг бага хурал хийлгэж, хятадынхыг оролцуулан бүх материалыг нарийвчлан авч хэлэлцээд бичгээр мэдэгдэл гаргасан байна.[2297] 1) Олон улсын эрхийн дагуу Түвдийн ард түмэн тусгаар тогтнолоо олох ёстой: өөртөө засан тохинох эрх "түвдийн ард түмэнд олгогдоно", "хятадын засгийн газар ч, өөр ямар нэгэн үндэстэн буюу улс ч түвдийн ард түмний тусгаар тогтнолыг булааж авах эрхгүй". 2) 1949-50 оны цэргийн ажиллагааны үеэс хойш Түвд орон БНХАУ-ын эзэгнэлд байгаа бөгөөд тус орныг колонийн засаг захиргаа уцдирдаж байна. 3) Бид Түвд орон тусгаар тогтносон улс байж ирсэн урт удаан хугацааны түүхийг харгалзан үзээд тусгаар тогтнолыг оролцуулан түвдийн ард түмний өөртөө засан тохинох гэсэн шаардлага улс орны үндэсний эв нэгдэл, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдлын зарчимд нийцэж байна хэмээн үзлээ гэж энэхүү мэдэгдэлд өгүүлжээ.

Тийнхүү "БНХАУ цэргийн халдлага буюу үр нөлөөтэй хяналтын дараа дараачийн арга хэмжээний үндсэн дээр Түвдийг эзэгнэх албан ёсны эрх авч чадаагүй юм. Ард түмний олонхи Далай ламыг дэмжсэн хэвээр байгаа явдал, Түвд дэхь хятадын эрх мэдлийг ард олон идэвхтэй эсэргүүцэж, хилийн чанад дахь түвдийн нийгэм амжилттай хөгжиж, цагаач засгийн газар үйл ажиллагаа явуулж байгаа энэ бүх хүчин зүйл бол түвдийн төр улс залгамж шинж чанартайг нотлон харуулж байна. Нөгөө талаас түвдэд хятадын тал цөмрөн орсон явдал хууль бус ажиллагаа болсон, 17 зүйлт хэлэлцээр хүчин төгөлдөр бус нь тогтоогдсон зэргээс авч үзвэл Түвдэд цэргийн их хүч оруулах замаар хятад улсын тавьж буй хяналтын түвшин ч, халдаж орсноос хойш бага биш хугацаа өнгөрсөн явдал ч хятад улс түвдийн бүх нутаг дэвсгэрийг хууль ёсны замаар мэдэлдээ оруулсан хэмээх дүгнэлт хийх боломж бүрдүүлж чадахгүй байна. Өнөө үед олон улсын эрхийн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээний дагуу Түвдийн төр улс бүрмөсөн мөхөж, салшгүй хэсгийнх нь хувьд БНХАУ-д хууль ёсоор нэгдсэн хэмээх дүгнэлт хийх боломж олгосон нэг ч үйл явдал болоогүй юм. ...Түвд улс Дарамсалад өөрийгөө төлөөлсөн хууль ёсны цагаач засгийн газартай бие даасан хуулийн этгээдийн хувьд оршин тогтносоор байна. Ингэхлээр

энэ засгийн газар болон түвдийн ард түмэн нутаг дэвсгэртээ бүрэн эрхт байдлаа бусад улсын хөндлөнгийн оролцоогүйгээр дахин олж авах эрхтэй юм".[2298]

Хувьсгалын өмнөх, дараа нь түвдийн цагаач засгийн газрыг бусад оронтой хэлхээ холбоо тогтоож, гэрээ хэлэлцээр байгуулж, тэдгээр орноос тусламж авч байна хэмээн зэмлэн буруушааж, энэ бүхнийг "эх орноосоо урвасан хэрэг" хэмээн тайлбарлаж байна. Эдгээр зэмлэл бол ул үндэсгүй зүйл: аливаа улсын хууль ёсны засгийн газар бусад оронтой харилцах эрхтэй. БНХАУ-ыг ч мөн гадаадын тусламжтайгаар л байгуулсан юм гэсэн дүгнэлт хийхээс өөр аргагүйд хүрч байна.(4, 7, 10-р бүлгүүдийг үзмүү).

❀

Эрт болон дундад зууны үеийн улсуудын харилцаа орчин үеийнхээс өөр юм. Өнөө үед батлан гаргаж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээг тэдэнд шилжүүлэн хэрэглэж болохгүй. Гэхдээ бас үүний эсрэг байдлаар хандаж: аль хэдийнэ хуучирсан эрх зүйн ойлголтыг орчин үеийн нөхцөлд, төрт ёсны нэг загварыг нөгөөд, нэг соёл иргэншлийн төсөөллийн системийг нөгөөд шилжүүлэн хэрэглэж болохгүй.Тухай тухайн үедээ ассир-вавилоны, византийн, хятадын, монголын, манжийн болон бусад эзэн хаад дэлхийд ноёрхох гэж санархаж байлаа. Гэтэл манай өнөө үед хятадын улс төрийн бодлогод л төрт ёсны эртний болон орчин үеийн төсөөллүүд холилдож байна. Хятадыг байлдан эзэлж байсан ард түмнүүд өөрийн эзэнт улс биш "хятадын гадаад эзэнт гүрэн" байгуулж байсан болж байна. Тийм логик сэтгэлгээ өөр хаана ч байхгүй. Тийм логик сэтгэлгээгээр бол хэрэв А орон Б орныг булаан эзэлсэн бол Б орон А орны нэг хэсэг болсон биш, харин эсрэгээр А орон өөрөө Б орон болж хувирсан хэрэг болж байна. Хэрэв нэг улс өөрийгөө бусад улсын нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрвөл үүнд хоёр тал санал нэгдсэн байх ёстой. Нэг орон нөгөөг өөрийнхөө нэг хэсэг хэмээн үзэж, гэтэл тэр орон өөрийгөө тусгаар тогтносон хэмээн үзэх байдлаар олон зуун жил зэрэгцэн оршиж болохгүй билээ.

Тан, Сун, Юань, Мин, Чин улсууд бол нэг орны өөр өөр эзэн хаад биш, янз бүрийн эзэнт гүрнүүд билээ. Эдгээрийн аль нэгэнд Түвд нэгдэн орсныг тэмдэглэн үлдээсэн нэг ч баримт бичиг үгүй юм. Түвд орон хятадын мэдэлд байсныг гэрчлэх нотолгоо болгож БНХАУ-д нийтлэгдсэн олон тооны хуучин баримт бичгүүд харин ч эсрэг нотолгоо болж байна.[2299] Түвд Монголын Юань эзэнт гүрэн, Манж Чин улсаас л хараат байсан болохоос биш хэзээ ч төрт ёсоо алдалгүй явж иржээ.

Күнзийн үеийн эзэнт гүрнүүдийн албан ёсны түүх судлал зохион байгуулалттай нэгдмэл систем байсан юм. Түүний алба ёсны шинж чанар нь түүх судлалд эрх баригчид хяналт тавиад зогсохгүй тэд түүх судлалын үйл явцад идэвхтэй оролцох явдлаар илрэн гардаг байв.[2300] Түүх нь эрх баригчдын системд үйлчилнэ. Тийм учраас энэ түүх судлалыг Хятад хэмээн нэрлэгдэх эзэнт гүрнүүдэд аль нэгэн орныг оруулах учир шалтгаан болгон авч үзэж болохгүй юм. “Алба гувчуур өгөх”, цол хэргэм тараах, зарлиг лүндэн буулгах, “удирдлагын байгууллагууд” дангаар бий болгох зэрэг нь нэг улс нөгөөд захирагдаж байсныг гэрчлэх шинж чанарууд биш, гагцхүү эртний хятад төвт уламжлалын л шинж тэмдгүүд юм.

Түвдийн эрх баригчид өөрсдийгөө хэн нэгэн улсын харaатууд гэж үзээгүй, төр улсынхаа хяналтыг хэрэгжүүлж иржээ. Дээд тушаалын лам нар эзэн хаадтай хоёр этгээдийн үндсэн дээр тогтоосон “багш-ивээн тэтгэгчийн” зарчимд үндэслэсэн хувийн харилцаатай байжээ. Энэ үзэл баримтлалыг төрийн эрх мэдлийн орчин үеийн нэр томьёогоор тодорхойлоход бэрхшээлтэй юм. Дээрх харилцааг янз бүрийн үед янз бүрээр хүлээн авч байлаа. Түвдийг эзэмших гэсэн бээжингийнхний өнгөлзлөг бүх дэлхийн эзэн хааны тухай күнзийн үзэл баримтлалд үндэслэжээ. БНХАУ түвдийг эзэгнэсэн явдлаа ул үндэстэй болгохын тулд дундад.зууны үеийн харилцааг орчин үеийн үндэсний улсын нэр томьёогоор тайлбарлахыг эрмэлзэж байна.[2301] Энэ бол буруу хандлага.

“Нэгдмэл хятад үндэстний” үзэл санаа хэдийгээр эртний хятад төвт үзэл суртлаас гаралтай ч үндсэндээ бол XX зууны эхний хагасын бүтээгдэхүүн мөн. Энэ бол олон үндэстний эзэнт гүрнүүд бутарч, үндэсний улсууд бий болсон үе билээ. Энэ үзэл санаа хятадад өрнөдөөс шилжин орж иржээ.

Аливаа улсын нэг хэсэг нөгөөдөө өнгөлзөж болохгүй. Тийм учраас Монголын болон Манж гүрнийг “залгамжлах” гэсэн хятадын өнгөлзлөг ул үндэсгүй юм. Тэр дундаа дээрх эзэнт гүрнүүдэд орж байгаа оронд бол бүр ч үндэсгүй. Ингэх нь түүхэн баримт, олон улсын эрх зүйд төдийгүй марксизм-ленинизмд харшилна. Марксизм-ленинизм үндэстний өөртөө засах эрхийг хүлээн зөвшөөрдөг юм. Маргаантай мужуудын хүн ам хувь заяагаа өөрсдөө шийдвэрлэх ёстой гэж Ф. Энгельс хэлжээ.[2302]

“Үндэстний өөртөө засах эрх гэдэгт өөр үндэстний хамт олноос төр улсаа тусгаарлах эрх, бие даасан үндэсний улсаа байгуулах эрхийг хамруулан ойлгох ёстой юм” гэж В.И. Ленин бичжээ.[2303] Тэрээр цааш нь: “түүх-эдийн засгийн үзэл бодлын үүднээс бол марксистуудын программ дахь “үндэстний өөртөө засах” эрх гэдэгт улс төрийн талаар өөртөө засан

тохинох, төрийн тусгаар байдлаа хамгаалах, үндэсний улсаа байгуулах гэдгээс өөр утга байхгүй юм". "Өөртөө засан тохинох эрх чөлөө, өөрөөр хэлбэл тусгаар тогтнох эрх чөлөөний талынхныг салан тусгаарлах үзлийг өөгшүүлсэн хэмээн зэмлэн буруушаах нь гэр бүл салалтын эрх чөлөөг дэмжигчдийг гэр бүлийн холбоог эвдлэн сүйтгэгчид гэж буруушаахын нэгэн адил мунхаг бөгөөд бялангач зан мөн". "Өөртөө засан тохинох буюу бие даах эрхийг няцаах нь бодит байдалд ноёлох ангийн эрх дарх, удирдлагын ардчилсан аргуудыг хохируулж цагдаагийн харгис аргыг дэмжиж буй явдал гарцаагүй мөн билээ" гэж бичжээ. "Социализмын үед үндэстний өөртөө засан тохинох эрхийг хэрэгжүүлэхээс татгалзах явдал социализмаас урван тэрсэлсэн хэрэг болохсон билээ" гэж Ленин онцлон тэмдэглэжээ.[2304] Гэтэл ХКН дүрмийнхээ дагуу бол марксизм-ленинизмийг удирдлага болгодог, түүнийг хатуу тууштай мөрддөг, энэ сургаалийг судлан мэдэхийг гишүүдээсээ шаарддаг билээ л.[2305]

1959 онд Лхаст байгуулагдаж, дараа нь цагаачлан гарсан түвдийн засгийн газар ч, түвдийн ард түмэн ч хятадын эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөггүй юм. Тэд урьдын адил удирдагч Далай ламыгаа л хүндэтгэдэг. *Олонхи Түвд хүний нүдэн дээр Далай лам шашин, төрийн эрх мэдлийг нэгтгэсэн хэвээр байна. Түвдийн цагаач засгийн газар бол хилийн чанадад байгуулагдсан шинэ бүтэц бишээ. Энэ засгийн газар Лхасын хууль ёсны засгийн газрын залгамж шинж чанарыг хадгалж байгаа юм. Түвд өөрөө эзлэгдсэн улс мөн. Ингэхлээр түвдийн асуудал бол БНХАУ-ын дотоод хэрэг төдий зүйл бишээ. Эх орныхоо тусгаар тогтнолын тухай түвдчүүдийн шаардлагыг салан тусгаарлах үзэл хэмээн үзэж болохгүй. Энэ бол шинэ улс байгуулахын тулд нэг улсын хэсгийг тасалж авах гэсэн шаардлага биш юм.*

Гэхдээ хил хязгаарыг ийм байдлаар тайлбарлах нь ариун үйл хэрэг бишээ. Өнөөг хүртэл олон улсын практикт ард түмнүүдийн өөртөө засах эрх, улс орнуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал хэмээх бие биенээ үгүйсгэсэн хоёр зарчим үйлчилж иржээ. Энэ хоёр зарчмыг улс төрийн үзэл бодлын үүднээс хэрэглэж ирсэн байна. НҮБ 25 гаруй жилийн өмнө түвдчүүдийн өөртөө засан тохинох эрхийг нотолсон билээ.[2306] Гэвч энэ шийдвэрийг үл тоомсорлосон хэвээр байна. ЗСБНХУ хууль ёсных, түүний хил хязгаарыг нийтээр хүлээн зөвшөөрсөн юм бол ямар учраас зарим орон тус улсын бүрэлдэхүүнд балт орчмын гурван бүгд найрамдах улс орсныг хүлээн зөвшөөрөхгүй байсан юм болоо? Дашрамд дурдахад XX зуун хүртэл энэ гурван улсын хоёр нь төрт ёсгүй байсан юм. Гэтэл дээр дурдсан зарим орон олон зуун жилийн төрт ёстой Түвд улс Хятадын бүрэлдэхүүнд

орсныг ямар учраас хүлээн зөвшөөрч байгаа юм болоо? Өрнө, Дорнын эзэнт гүрнүүдээс (Испанийн, Британийн, Португалийн, Францийн, Османы зэрэг) бие даасан улсууд салж гарах явдал хууль ёсных, харин Чин улсаас бол хууль ёсны биш байдагийн учир юунд байна вэ? Ямар учраас Австри-Унгар буюу ЗСБНХУ-ын хувьсгалт задрал хууль ёсных байдаг, Чин гүрний хил хязгаар дахь хятадын бүрэн бүтэн байдал маргаангүй байдаг юм болоо? Ямар учраас Косово буюу Өмнөд Осетийг хүлээн зөвшөөрч болдог, харин Түвдийг болдоггүй юм болоо?

Иймэрхүү асуултыг үргэлжлүүлж болно. Яагаад гэвэл олон зуун жилийн туршид олон улсын харилцаан дахь гол эрх бол хүчтэйгийнх байсан хэмээх нэг л хариулт байх болно. Олон улсын хэм хэмжээг их гүрнүүдийн ашиг сонирхлыг зохицуулахад ашиглаж байна. Хэрэв эх газрын сул дорой орон хүчирхэг ивээн тэтгэгчгүй бол эрт орой хэзээ нэгэн цагт хөршүүддээ тусгаар тогтнолоо алдана. Өнгөрсөн үед тун их ашигтай байсан байгалийн саад тотгор өнөө үед хамгаалалт болж чадахаа больжээ. Түвдийн хувь заяа үүний нэг жишээ мөн.

Бүлэг 12

## Түвд-монголын соёл иргэншил бөхөж байгаа юу?

Нийт хүн төрөлхтний сонирхлыг гарцаагүй татах бүх дэлхийн түүхэн үйл явц бий хэмээх үзэл бодол байдаг билээ. Хамгийн өндөр технологи өрнөдөд байдаг болохоор өрнөд маягийн соёл иргэншил хамгийн өргөн дэлгэрч байна. Түүний хувилбарууд: социализм, коммунизм, фашизм, хөрөнгөтний ардчилал гээд олон янз. Гэхдээ эдгээр хувилбар бусад соёл иргэншилд хамаарах нийгмүүдэд харилхуу шинжтэй байна. XX зуунд хувьсгал экспортлох явдал, колончлол, даяаршил гээд л “хоцрогдсон” орнуудыг “дэвшилт” (хөрөнгөтний буюу коммунист) жороор ардчилах аргууд гарч иржээ. Үр дүн нь- нийгмийн байгууллыг хүчээр өөрчлөх, уламжлалт үзлийг эвдэж, “соёл иргэншилтнүүдийн” маягт оруулах явдал мөн. Хэрэв аль нэгэн ард түмэн өөрийнхөөрөө амьдрахыг хүсвэл үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, хувьсгалын эсэргүү ажиллагаа,иргэний дайн буюу эсэргүүцлийн хөдөлгөөн аяндаа гарч ирнэ. Гадаадын “соёл иргэншилтнүүдийн” түрэмгийлэн эзлэх бодлогыг эсэргүүцэн тэмцэж буй хүчнийг харгис хүчин хэмээн (жишээ нь, “түвдийн харгис хүчний самуун) нэрлэдэг нь тохиолдлын хэрэг бишээ. “Бүх дэвшилт дайн шудрага байдаг, харин дэвшил хөгжилд саад хийж буй бүх дайн шудрага бус байдаг” гэж Мао Зэдун худал хэлжээ.[2307]

Үнэндээ бол дэлхийн ёс жаяг тийм ч бүдүүлэг байдлаар зохион байгуулагдаагүй билээ. Үнэт зүйлсийн янз бүрийн систем бий. Тэдгээрийг “хоцрогдсоноос” “дэвшилтэд” хүртэл нэгэн эгнээнд зэрэгцүүлэн тавьж болохгүй Дээр дурдсан системүүд бүх талаар харьцуулан үзэх боломжгүй тийм л янз бүрийн шинж чанартай юм. Нэг хүний нүдэнд хоцрогдсон мэт

харагдаж буй систем өөр хүнд, тэр дундаа нэг соёл иргэншлийн хүрээнд тэргүүний харагдаж болно. Үүний нэг сайхан жишээ бол коммунизм бөгөөд марксистууд түүнийг капитализмаас илүү тэргүүний байгуулал гэж үздэг бол марксизмыг эсэргүүцэгчид эсрэг бодолтой байна. Бүгд биш гэлээ гэхэд XX–XXI зууны олонхи хувьсгал орон нутгийн боловсон хүчин бэлтгэх дэвшилт үзэл суртлын янз бүрийн хувилбар экспортлох буюу шууд интервенц хийх замаар ямар нэгэн байдлаар гаднаас зохион байгуулжээ. Энэ байдал янз бүрийн түвшингээр Хятадын хөрөнгөтний ардчилсан Синьхайн хувьсгал, шинэ ардчилсан хувьсгал, Оросын хоёрдугаар сарын болон октябрын хувьсгал, Монголын ардын хувьсгал (1921), Түвдийн ардчилсан шинэтгэл, Балбын маогийн талыг баримталсан хувьсгал, хуучин ЗСБНХУ, дорнод европын орнууд, Гүржид гарсан “хилэн хувьсгалуудад” илрэн гарчээ.

Түвд ямагт уламжлалт нийгэм байсан бөгөөд тэнд хувьсгал гарах угтвар нөхцөл хэзээ ч байгаагүй юм. Түвдчүүд дэвшил хөгжлийн хишиг буянаас татгалзаагүй боловч тэдэнд уламжлалт ёс заншил илүү үнэтэй байсныг түүх нотлон харуулсан билээ. 1951 оноос хойш түвдэд гарч байгаа үйл явдал бол үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн мөн. Хэргийн учир нийгмийн байгууллыг өөрчлөхөд биш, харин гадаадын эзэгнэлийг зогсооход оршиж байгаа юм. Түвдчүүд гадаадын үзэл суртлыг албаар хүлээж авах биш, харин түүнээс ангижирахыг хүсч байна. Тийм учраас түвдчүүдийн хөдөлгөөн бол “хилэн хувьсгал” бишээ.

Түвдчүүд олон зуун жил тусгаар улсад аж төрсөн бөгөөд өөрсдийгөө хэзээ ч хятадын оршин суугч гэж үзээгүй юм. “Хятадууд ирээд бидэнд Түвд ямагт хятадын нэг хэсэг байсан гэж хэлэхэд бид огт ойлгоогүй. Бидэнд түүхийн тухай өөр ойлголт бий. Мэдээжийн хэрэг коммунистууд бидний яриаг хүүхдийн үлгэр мэт үзэж няцаах гэж эрмэлзсэн боловч бидний хувьд энэ нь итгэл үнэмшилтэй хүүрнэл, түвдчүүд гэж хэн бэ гэдгийн нэг хэсэг юм”.[2308] Түвд орон хэзээ ч хятадын нэг хэсэг байгаагүйг ард түмний өөрийн ухамсар төдийгүй түүхийн эрх болон бодит баримтууд нотлон харуулж байна. Түүнээс гадна Түвд орон хэзээ ч хятадын соёл иргэншилд ороогүй билээ.

Хэд хэдэн жирийн боловч хурц тод жишээ дурдаж болно.[2309] Түвдчүүд Боловсронгуй Биетээс, хятадууд Шар эзэн хаанаас гаралтай: хятадуудын эх орон бол Дундад иргэн улс, Түвдчүүдийнх цас мөсний орон:хятадуудын шашин бол күнзийн сургааль, даогийн үзэл, хятадын буддийн шашин, түвдчүүдийнх бол түвдийн буддийн шашин болон бон шашин: хятадуудын

бичиг үсэг бол үзэл сурталжсан, хоёр үет, нэг үед бичиг, түвдчүүдийнх бол цагаан толгойн, хоёр үед бичиг үсэг: хятадуудын захирагч бол эзэн хаан, түвдчүүдийнх бол Далай лам: хятадын улсуудын улс төрийн байгуулал бол хүнд сурталт, төвт байгуулал, түвдчүүдийнх бол шашин төрийн байгуулал: хятадуудын уламжлалт хоол бол тутрага, түвдчүүдийнх бол замбай: хятадуудын урлаг, утга зохиолд жирийн амьдралын сэдэв давамгайлдаг бол түвдийнхэд шашны сэдэв илүүтэй байна.

Түвдчүүд монголчуудтай хамтран бусдаас ялгарах өөрийн гэсэн соёл иргэншил бий болгожээ. Энэ соёл иргэншил төлөвшин тогтсон явдал энэ хоёр ард түмний соёл ялангуяа Чингис хаан болон түүнийг залгамжлагчдын аян дайнаас хойш өөр хоорондоо улам гүнзгий шингэсэн явдалтай холбоотой юм. Түвд орон хятадын бүрэлдэхүүнд ороогүй ч түвдчүүд оршин суудаг зарим нутаг дэвсгэр дундад зууны хятад, монголын улсуудын бүрэлдэхүүнд оржээ. Монголчууд эх орноо нэгдмэл засаг дор нэгтгэхэд нь түвдчүүдэд нэг бус удаа тусалж байжээ. Монголчуудын үйлдэл түвдийг төвлөрүүлэх, буддийн шашны Сажаа чиглэл, дараа нь гэлуги чиглэлийг хөгжүүлэхэд төдийгүй түвд-монголын соёл иргэншлийг цаашидд хөгжүүлэхэд тус дөхөм болжээ.

Энэрэнгүй сэтгэлт бодьсад-удирдагч буюу Далай ламын үзэл баримтлал түвдийг нэгтгэх цорын ганц зөв үзэл байлаа.[2310] Шашны эрх мэдэл төрийнхөөс дээгүүр байсан нь түвдийн хувьд зарим судлаачдын баталдагаар үйлийн үр дагуулсан биш, харин ч авралын од болжээ. Төрийн эрх баригчид засгийн эрхэнд гарсан тэр үеүдэд өөр хоорондын тэмцэл хөдөлгөөн эхэлж, улс орон задарчээ (Монголд ч мөн тиймэрхүү явдал болжээ). Улс орныг дээд тушаалын лам нар нэгтгэсэн бөгөөд монголын, дараа нь манжийн эзэн хаадтай тэдний тогтоосон “багш-ивээн тэтгэгчийн” харилцаа түвдийг хятадын жирийн муж болгон хувиргах үйл явцыг саатуулж чаджээ. Энэ харилцааны үзэл баримтлалыг төрийн эрх мэдлийн орчин үеийн нэр томьёогоор илэрхийлэхэд бэрх юм.

Европ болон Чин гүрнээс ялаатай нь гэвэл түвдэд хятадын ардчилсан шинэтгэл хүртэл ангийн хүчтэй антогнист зөрчил гэж байсангүй. Феодал-шашны байгуулал үндсэндээ ард түмний сэтгэл санаанд нийцэж байжээ. Тэндхийн “хамжлагууд” үнэн хэрэгтээ фермер эрхлэгчид, “боолууд” гэгч нь гэрийн үйлчлэгч нар байлаа. Феодал-шашны байгууллын үед түвдийн ард түмний талаар БНХАУ-ынх шиг харгис үйлдэл хийж байгаагүй билээ.

XVII–XIX зуунд Зүүнгар, Байгал нуураас Гималайн нурууны өмнөд бэл хүртэл үргэлжлэн тогтсон түвд-монголын соёл инргэншлийн нутаг

дэвсгэр бараг бүхлээрээ Чин болон Оросын эзэнт гүрний бүрэлдэхүүн, нөлөөний хүрээнд оржээ. Гэсэн хэдий ч түвд, монголчууд өөрийнхөөрөө амьдарч, өөрөөр хэлбэл шашин, нийгмийн бүтэц, уламжлалт эдийн засаг, зан заншлаа үндсэнд нь хадгалж үлджээ. Энэ хоёр их гүрэнд түвд, монголчуудын өвөрмөц байдлыг хамгаалсан хууль тогтоомжийн актууд гарч байжээ. Түүнээс гадна: тэр үед түвд-монголын соёл иргэншил нэгдмэл бүхэл бүтэн зүйл болон хөгжихөд гималайн нуруунаас хөх нуураар дамжин Монгол хүртэлх умард,өрнөдийн зам харилцаа, олон зуун жилээр боловсрогдсон хэлхээ холбоо тус дөхөм үзүүлжээ. БНХАУ, ЗСБНХУ-аас ялгаатай нь гэвэл Чин болон оросын эзэнт гүрнүүдийн төр анги хоорондын үзэн ядалт дэвэргэх, шашныг устгах, уламжлалт үзлийг үндсээр нь устгах, бүх нийтээр тэгшитгэх зорилтыг хэзээ ч дэвшүүлэн тавьж байгаагүй ажээ.

Орос болон Манж чин улсад гарсан хувьсгал түвд-монголын соёл иргэншилд нөхөж баршгүй хохирол учруулжээ. Хаант засгийн оронд үзэл суртлынх нь үндэс хүн ардын амьдралыг нэг хэвийн болгох, хил хязгаарыг хаах, феодалын нийгмийг устгах явдал болсон хөрөнгөтний бүгд найрамдах улс Хятадад, социалист бүгд найрамдах улс ЗСБНХОУ-д тус тус байгуулагдав. Энэ нь угсаатан соёлын нийтлэг байдлыг зориудаар салгах, ЗСБНХУ болон Монголд уламжлалт соёлыг бутниргэхэд хүргэжээ. Монгол улс тийм л үнээр ЗСБНХУ-ын тусламжиайгаар тусгаар тогтносон улс болж чадсан юм.

Тэгвэл Түвд бие даасан байдлаа удаан биш хугацаанд хадгалж чадсан байна. Их Британи улс Ази дахь колониудаа, хятадад үзүүлэх хуучин нөлөөгөө алдав. Дэлхийн хоёрдугаар дайнд японыг бутниргэсний дараа И.В.Сталины тусламжтайгаар Манж-го улс болон Өвөр монголын нутаг дэвсгэрийг хятадад нэгтгэв. Мөн энэ тусламжийн ачаар Хятадын засгийн эрхийг Мао Зэдун тэргүүтэй ХКН авав. Их Британи ч, АНУ ч Түвдэд бэхжих буюу тус улсыг тусгаар тогтнуулах гээгүй юм. Энэ хоёр улсын хувьд Түвд улс төрийн тоглоомын бутархай мөнгө болж байв. Аугаа их хятадтай харилцаатай байх явдал түүхэн шудрага ёс болон олон улсын эрх зүйгээс илүү чухал байжээ. Түвдчүүд ч, монголчууд ч тусгаар тогтнолоо хамгаалах хангалттай хүчгүй байв. Ямар ч шинэтгэл түвд, монгол хоёр орныг хэдхэн арван жилийн дотор гадаадын тусламжийн дүнд бүс нутгийн хамгийн хүчирхэг гүрэн болсон БНХАУ-ын интервенцийг ганцаараа няцаах тийм хүчтэй болгож чадаагүй юм. Түвдийн хувь заяаг тус орны ард түмний ар хударгаар шийджээ.

И.В. Сталиныг нас барснаас хойш удалгүй Хятадын эрх баригчид

саяханыхаа ивээн тэтгэгчийг чиг баримжаа болгохоосоо татгалзав. Мао Зэдун Зөвлөлт холбоот улсыг ревизионист (засварлах үзэлт) улс хэмээн зарлаж, нилээд холын санаатай өнгөлзлөг тавьжээ. 1967 оны нэгдүгээр сарын 27-нд "Жэньминь жибао" сонинд: "Марксизм-ленинизмын гэрэлтүүлэгч улаан туг, Мао Зэдуны үзэл санаа улаан талбайд, Октябрын хувьсгалын эх оронд мандан бадрах өдөр ирнэ гэдэгт бид итгэлтэй байна" гэж бичжээ.[2311] Тийнхүү Сталин өөрөө хүсээгүй хэрнээ эх орондоо урт хугацааны стратегийн аюул бий болгожээ.

Тэрч бүү хэл маогийнхан түвдэд хувьсгал экспортолж, өөрсдөө түүнийг харь оронд хийжээ. Хятадууд өөрсдийнхөө хувьсгалаас тодорхой хэмжээний ашиг хонжоо гаргаж: харийн ( манжийн) засгийг түлхэн унагаж, эх орныхоо эв нэгдлийг хангаж: түүний бүрэлдэхүүнд Чин гүрний хараат нутаг дэвсгэрүүд болон боолын эзэмшил нутгуудыг нэгтгэв. Харин "үндэсний цөөнх" соёл, шашнаа сүйтгүүлж, хятадчилагдаж, хятадуудад колончлогдож, коммунист хятадын засаг захиргаа өөрсдийг нь улс орондоо хэрхэн нэгтгэж, өөрсдийнхөө үзэмжээр шинэчилж байгааг хөндлөнгөөс ажиглагчийн байр суурьтай л болжээ. Түвд-монголын соёл иргэншлийн олон зуун жилийн өвийг коммунистууд бараг бүрэн устгажээ. Түвдийн хууль ёсны удирдлага цагаачлалд байх зууртаа ЗСБНХУ-д биш, харин түүний өрнөөдийн өрсөлдөгчдөд найдлага тавих болсон байна.

Түвдийг хятадад нэгтгэсний гол үр дүн юу вэ? Энэ үр дүнг хүмүүнлэгийн болон соёл иргэншлийн хэмээх хоёр хэлбэрээр авч үзэж болно. Хүмүүнлэгийн салбарт хамгийн гол нь ард түмний сайн сайхан байдлын дундаж түвшинг дээшлүүлэв. Түүний гол үзүүлэлт бол хүн амын дундаж наслалт дээшилсэн явдал мөн. Шинээр төрж байгаа болон бага насны хүүхдийн үхэл буурч, эрүүлийг хамгаалахын ажил сайжирч, ядууралтай тэмцэж байна. Энэ бол ХКН-ын маргаангүй гавьяа мөн ч ийм амжилтад хүрэхийн өмнө маогийн үед түвдийн хүн амын үлэмж хэсэг амь үрэгдсэн юм. Тэмцэл хөдөлгөөн өнөөдөр ч үргэлжилж байгаа нь хариу гэсгээн цээрлүүлэлт үүсгэж байна. Материаллаг хангамж дээшилсэн ч ийм явдал болсон хэвээр байна. "Аливаа хүн зөвхөн хооллохын тулд л амьд явдаггүйг" энэ бүхэн харуулна. Үүний шалтгаан юунд байна вэ? Энд бид соёл иргэншлийн асуудлыг авч үзэх хэрэгтэй юм.

Түвдчүүд хятад биш Түвд хүн хэвээр байхыг хүсч байна. Тэд олон зуун жилийн соёл иргэншлээ хадгалан авч үлдэхийг хүсч байна. Гэтэл түвдийг хятадад нэгтгэснээс хойш тэнд харийн соёл иргэншлийн загвар тулган хүлээлгэжээ.

Үзэл суртлын салбарт бол энэ нь хятад онцлогтой коммунизм юм. Сүүлийн хэдэн арван жилд түвд,монголчуудын соёл иргэншлийг шууд устгасан бол одоо "хөнгөн маягаар" хятадчилах, уусгах үйл ажиллагаа үргэлжилж байна. БНХАУ-ын бүх ард түмэн нэгдмэл соёл иргэншил бүрдүүлдэг болгохыг Коммунист нам хүсч байна, гэтэл бодит байдалд тэд янз бүрийн соёл иргэншилд, тухайлбал хятад, түвд-монгол, исламын соёл иргэншилд хамаарч байгаа билээ. Түвдчүүд баян хятад болж хувирахын оронд ядуу ч гэсэн өвөрмөц байдлаа хадгалж үлдэхийг хүсч байна.

"Хэл, хувцас, зан заншил, үндэстний бусад чухал шинж чанар үгүй болоход үндэстэн өөрөө үгүй болох бөгөөд... энэ үндэстэн өөрөө өөр үндэстэн болон хувирна хэмээн хэлж болно. <...> Хүмүүсийн сэтгэлийнхээ гүнээс итгэж, хайрлаж байсан шашин дэндүү суларч, тэр хүмүүст сүслэн бишрэхийг зөвшөөрөхгүй байх тусам олон хүний сэтгэлгээн дэхь шашны санаа бодол улам хүчтэй болж, итгэл үнэмшил нь өнгөрсөн үеийнхээс ч улам гүнзгий болдог ажээ".[2312] Бүр соёлын хувьсгалаас өмнө X Банчин ламын хэлсэн энэ үг бодит үйл хэрэг болох тавилантай байжээ. Чухам ийм учраас л түвдчүүдийн уламжлалт үзлийг устгаж чадаагүй ажээ. Гэхдээ орчин үеийн шинэчлэлийн "зөөлөн" арга хүч хэрэглэсэн үйлдлүүдээс ч аюултай:энэ нь хүний үнэт зүйлсийн учир шалтгаан, системийг өөрчилдөг байна.

БНХАУ-д шашныг нухчин дарсан шалтгаан бол коммунистуудын прагматик үзэлд огт үл харшлах тэдний материалист үзэл суртал мөн. Тийнхүү материалист болон парагматик үзлийг хослуулах нь ХКН-ыг хууль ёсны шинжтэй болгож, улс орноо даяаршлын гольдролоор хөтөлж, хэрэглээний нийгэм байгуулах боломж бүрдүүлж байна.

ХКН-ын удирдагчид шашныг тодорхой шатанд улс төрийн зорилгод ашиглаж болох боловч ер нь бол устгах хэрэгтэй гэж үзсэн хэвээр байна. Шашныг устгах гэсэн ХКН-ын стратегийн чиг шугам Зян Зэминий хэлсэн үгнээс илэрхий харагдаж байна.[2313] "Коммунист намын гишүүд бол шашингүйн үзэлтнүүд, цаашид ч ямагт шашингүйн үзлээ хатуу тууштай баримталж, түүнийг сурталчлах хэрэгтэй. <...> Манай оронд дарлан мөлжигч байгуулал, дарлан мөлжигч ангийг устгасантай хамт шашин оршин байх ангийн үндэс устсан юм.Гэвч хуучин нийгмээс үлдсэн хуучин үзэл санаа, хуучин зуршлыг богино хугацаанд бүрэн төгс устгах боломжгүй юм. Бид материаллаг болон оюун санааны соёлыг хөгжүүлж, шашин оршин тогтох эх булгуудыг аажмаар устгах замаар л шашны асуудлыг уг үндсээр нь шийдвэрлэж болох билээ. Өөрөөр хэлбэл эдийн засгийн байгуулалтыг

зохих ёсоор хэвийн байдалд оруулж, ертөнцийг үзэх шинжлэх ухааных нь үзлийн үүднээс, соёлынх нь түвшингийн үүднээс хүмүүсийн чанарыг дээшлүүлэх хэрэгтэй байна. <...> Коммунист намын гишүүн шашинд хандах марксист үзлийг баталж явах үүрэгтэй, өөрөө сүсэг бишрэлтэй байх ёсгүйгээр барахгүй шашингүйн үзлийг сурталчилж, олон түмэнд ухамсараа дээшлүүлэхэд нь туслах ёстой билээ". "Материаллаг болон оюун санааны соёл иргэншлийг нэгэн зэрэг байгуулах явдал бидний гол үндсэн чиг, шугам мөн. Оюун ухааны соёл иргэншил бий болгох зорилт товчоор хэлэхэд бүх үндэстний чанарыг дээшлүүлэх, эрхэм дээд зорилготой, ёс суртахуунтай, соёлтой, сахилга баттай шинэ социалист хүн хүмүүжүүлэхэд чиглэх ёстой юм. <...> Эдийн засаг хэдийчинээн хөгжиж, материаллаг хангамжийн түвшин хэдийчинээн өндөр байнав үзэл суртал-улс төрийн ажил, оюун санааны соёл иргэншил бий болгох үйл хэргийг төдийчинээн хүчтэй явуулах хэрэгтэй юм".

Коммунистууд шашныг хориглодоггүй ч түүнийг материализмтай тэгш биш байдалд тавьдаг бөгөөд шашны гол гол үндэслэлийг социализмын эрх ашгийн дагуу өөрчлөх хэрэгтэй хэмээн үздэг юм. Тийм хандлага шашныг дотроос нь "устгах"-ад чиглэх ёстой. Энэ хандлага идеалист үзэлтэй сөрөг төвлөрөлд орж ялагдал хүлээсэн марксизм-ленинизмд харшилж байгаа юм.

Түвдийн уламжлалт эдийн засаг хэрхэн хөгжиж байсныг БНХАУ-ын эрх баригчид ойлгохгүй байна, энэ бол соёл иргэншлийн өөр систем учраас л иймхүү ойлгож чадахгүй байгаа юм. Тэд энэ системийг хоцрогдсон бөгөөд нэг бол устгах (ардчилсан шинэтгэлээр, соёлын хувьсгалаар), үгүй бол хятад онцлогтой хөрөнгөтний шинэчлэлд (өнөө үед) оруулах хэрэгтэй хэмээн үзэж байна. Хэрэглээ болон үр ашгийг дээшлүүлэх явдал Түвдийн гэрэлт ирээдүйд хүрэх түлхүүр гэж коммунистууд үзэж байна. Үл гүйцэлдэх марксист тэнцвэртэй байдал одоо гагцхүү материаллаг тансаг байдлаар хэмжигдэх чинээлэг нийгмээр солигджээ. Уламжлалт аж ахуйг нь устгаснаас болж түвдийн бүс нутаг өөрийгөө хангаж чадахгүйд хүрч, эдийн засгийн хувьд Хятадаас хамааралтай болоход хүргэжээ. Энэ нь түвдийн хосгүй гайхамшигт соёл иргэншлийн мөхлийг түргэтгэж байна. Ингэхлээр манжийн эзэнт гүрний авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг эргэж харвал "үндэсний цөөнхийг" олонхид уусах аюулаас хамгаалсан хамгаалалт байжээ.

Түвд орон хятадад интеграцчилагдаж байна, хятадын эрх баригчид ингэх хүсэлтэй юу, ардчилал, шинэчлэл, нийгмийн байгуулал, соёлоо өөрчлөхийг хүсч байна уу, үгүй юу гэж түвдийн ард түмнээс хэзээ ч асуугаагүй юм.

Түвдийн ард түмэн үүнийг огт хүсээгүйг түүхийн явц нотлон харуулсан билээ. Тийм ч учраас ХКН-ын бодлогод түвдийн ард түмний санаа бодлыг сонсохыг ямагт эсэргүүцэж иржээ. ХКН-ын удирдлага түвдийн асуудлаар ямар ч буулт хийхийг хүсэхгүй байна. Ямар учраас? Энэ удирдлага Түвдэд дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэж байгаа юм чинь. БНХАУ-ын “бүрэн бүтэн байдалд” хэн ч заналхийлээгүй, “олон улсын хамтын нийгэмлэг” нэгэнт бий болсон байдалтай аль хэдийнэ эвлэрч, эдийн засгийн ашиг хонжооны эрх ашгаас шалтгаалан хятадын үйлдэл хууль ёсны эсэхийг хэлэлцэхийг ч хүсэхгүй байна.

Манай өнөө үед түвд-монголын соёл иргэншлийн арал улам улам тэлж, энэ хоёр улсын багтаж буй орнуудын таяг тойргоор явж байна. Хятад, орос, тусгаар тогтносон Монгол улс аж үйлдвэржсэний дараах хөгжил, даяаршлын замаар явж байна. Тийм нөхцөлд тухайн улсын соёл гол төлөв аялал жуулчлалын обьектын хувьд хадгалагдан үлддэг байна.

Түвд-монголын хүрээнд үүнээс зайлсхийх цорын ганц боломж бол уламжлалт үзэл сурталд түшиглэж, буддийн шашныг хөгжүүлэх явдал мөн. ОХУ, БНХАУ, Монголд ингэх магадлал бага, харин уламжлалт үзэл энэтхэг (Сикким, Ладак, Аруначал-Прадеш мужийг оролцуулан), Бутан, Балба зэрэг Гималайн түвдчүүдийн дунд хадгалан үлдэж болно. Үүний тулд дээрхи хамтын нийгэмлэгүүдийг өөр хоорондоо нь соёлын хувьд интеграцчилах хэрэгтэй. Тэгсэн цагт энэ нийгэмлэгүүд түвд-монголын ертөнц ирээдүйд оюун санааны хувьд сэргэн мандах эх булаг болж чадна.

# Тайлбар

### Өмнөтгөл

1 Гуревич, 1958.
2 Богословский и др., 1975; Богословский, 1978.
3 Современная политика Китая в Тибете, 2000.
4 Parenti M. Friendly feudalism . . . ; Ely M. The true story . . .

### Бүлэг 1. Түвдчүүдийн газар зүй ба гарал үүсэл

5 Tibetan Plateau, 2009, p.7.
6 The Sino-Tibetan etymological dictionary . . .
7 Шакабпа, 2003.
8 Шакабпа, 2003.
9 Кычанов, Мельниченко, 2005.
10 Намкай Норбу, 2008, с. 16–20.
11 Кычанов, Мельниченко, 2005.
12 Намкай Норбу, 2008, с. 16–27, 104, 109–111.
13 Намкай Норбу, 2008, с. 187–189.
14 Кычанов, Мельниченко, 2005.
15 ldenderfer, 2003, p. 542–549.
16 Кычанов, Мельниченко, 2005.
17 Шакабпа, 2003.
18 Gelek. A Brief Description . . .
19 Jong L. DNA profiles . . .
20 Beall, 2006, p.18–24.
21 Biello, 2007.
22 Beall et al., 2001, p. 411–412.
23 Halperin et al., 1998, p.237–437.
24 Wu et al., 2005, p.598–604.
25 Wiermeyer et al., 1995, p.1248–1252; Wiley, 2004.
26 Gantenbein, 1993; Curran et al., 1997, p.2098–2104.
27 Кычанов, Мельниченко, 2005.
28 Smith, 1996.
29 Wu K., Wu C., 2004.
30 Бичурин, 1833, с. 74–123.

### Бүлэг 2. Эртний ба дундад зууны үе

31 Smith, 1996.
32 Кычанов, Мельниченко, 2005.
33 Шакабпа, 2003.
34 Кычанов, Мельниченко, 2005.
35 Кычанов, Мельниченко, 2005.
36 Шакабпа, 2003.
37 Кычанов, Мельниченко, 2005.
38 Шакабпа, 2003.
39 Кычанов, Мельниченко, 2005.
40 Рерих, 1958, с. 109.
41 Шакабпа, 2003.
42 Намкай Норбу, 2008, с. 170–171.
43 Кычанов, Мельниченко, 2005.

44 Эртний олон овог, хот, улсын нэр, хүний нэр зэрэг нь хятад хувилбараар үлджээ. Хятад биш хэлээр тэмдэглэсэн нэрүүд хадгалагдаж үлдсэнгүй, учир нь зарим хэл бичиг үсэггүй байжээ.
45 Кычанов, Мельниченко, 2005.
46 Коротко о Тибете . . .
47 Царь Сонгцен Гампо . . .
48 Tiang J. The Administrative System . . .
49 Кычанов, Мельниченко, 2005.
50 Шакабпа, 2003.
51 Шакабпа, 2003.
52 Кычанов, Мельниченко, 2005.
53 Кычанов, Мельниченко, 2005.
54 Шакабпа, 2003.
55 Кычанов, Мельниченко, 2005, с. 52.
56 Шакабпа, 2003.
57 Кычанов, Мельниченко, 2005.
58 Ngapo, 1988.
59 Сицзан цзяньши, 1993 — номонд: Кычанов, Мельниченко, 2005, с.56.
60 Кычанов, Мельниченко, 2005.
61 Шакабпа, 2003.
62 Van Walt, 1987, p.2.
63 Шакабпа, 2003.
64 Шакабпа, 2003.
65 өөрөөр хэлбэл, цэргийн ангийн хөдөөлгөөний шинж тэмдэг.
66 Van Walt, 1987, p. 1–2.
67 Коротко о Тибете: исторический очерк . . .
68 Кычанов, Мельниченко, 2005.
69 Ssanang Ssetsen, 1829.
70 Шакабпа, 2003.
71 Шакабпа, 2003.
72 Bira, 1999 — Кычанов, Мельниченко, 2005.
73 Шакабпа, 2003, с. 75–76.
74 Шакабпа, 2003.
75 Беспрозванных, 2001, с. 57.
76 Кычанов, Мельниченко, 2005.
77 Шакабпа, 2003.
78 The Mongols, 2009, p.17.
79 Шакабпа, 2003, с. 79–80
80 Parenti M. Friendly feudalism . . .
81 Овчинников, 2007, 2009.
82 Далай Ч., 1977, с. 324.
83 Шакабпа, 2003, с. 82–83
84 Шакабпа, 2003.
85 Успенский, 1996, с. 40–51.
86 The Mongols, 2009, p.31.
87 Шакабпа, 2003.
88 Юань ши, 1935 — номонд: Кычанов, Мельниченко, 2005, с.88.
89 Franke, 1981, p.186–328.
90 Farquhar, 1981, p.25–55.
91 Franke, 1981.

92 Кычанов, Мельниченко, 2005.
93 Farquhar, 1981.
94 The Mongols, 2009, p.21–22.
95 Petech, 1989 — номонд: Кычанов, Мельниченко, 2005, с. 92.
96 Smith, 1996, p.91–92.
97 Кычанов, Мельниченко, 2005.
98 Шакабпа, 2003.
99 Franke, 1981.
100 Далай Ч., 1977, с. 330–331.
101 Горохова, Цендина, 2005, с. 39.
102 Van Walt, 1987.
103 Sperling, 2004.
104 Китаев С. Независимость Тибета . . .
105 mith, 1996, p.101.
106 Успенский, 1996.
107 Шакабпа, 2003.
108 Шакабпа, 2003, с. 97.
109 Van Walt, 1987.
110 Установления о соли и чае, 1975.
111 О тибетском вопросе, 1959.
112 Шакабпа, 2003.
113 Kolmas, 1967.
114 Шакабпа, 2003.
115 История Эрдэни-цзу, 1999 — Кычанов, Мельниченко, 2005, с. 107.
116 Шакабпа, 2003.
117 Шакабпа, 2003, с. 106–107.
118 Шакабпа, 2003, с. 108.
119 Parenti M. Friendly feudalism . . .
120 China, Tibet . . .
121 Мартынов, 1978.
122 Шакабпа, 2003, с. 109.
123 Шакабпа, 2003, с. 112.
124 Шакабпа, с. 112–114.
125 Кычанов, Мельниченко, 2005.
126 Шакабпа, 2003, с. 118.
127 Шакабпа, 2003, с. 123.
128 Беспрозванных, 2001.
129 энэ чиглэлийн сургууль өнөөг хүртэл хадгалагдан үлдэж, Түвдийн алслагдсан нутгуудад түүний сүм хийдүүд байгааг олж илрүүлсэн бөгөөд XIV Далай лам энэ сургуулийг сэргээх лүндэн буулгасан байна.
130 Рубрук, 1957, с.174.
131 Андросов, 2006а, с.594.
132 Овчинников, 2006, с.41–42.
133 Parenti M. Friendly feudalism . . .
134 Елихина, 2006.

**Бүлэг 3. Чин гүрний үе**

135 Кычанов, Мельниченко, 2005.
136 Мартынов, 1978.

137 Манжийн эзэн хаад хятад системийг авч хэд хэдэн нэртэй байв: төрөхөд нь өгсөн нууц нэр, нас барсных нь дараа өгдөг сүмийн нэр зэрэг болно.
138 Кычанов, Мельниченко, 2005.
139 Шакабпа, 2003, с. 126.
140 Шакабпа, 2003, с. 127; Кычанов, Мельниченко, 2005.
141 Dukula'i Gozang — номонд: Tibet and Manchu, 2008, p.8.
142 Успенский, 1996.
143 Tibet and Manchu, 2008, p.9.
144 Шакабпа, 2003. с. 129.
145 Berzin, 2000.
146 Кычанов, Мельниченко, 2005.
147 Беспрозванных, 2001, с. 148.
148 Шакабпа, 2003, с. 129.
149 Мартынов, 1978.
150 Беспрозванных, 2001, с. 147.
151 Шакабпа, 2003, с. 130–131
152 Духовная культура Китая, 2009.
153 Кычанов, Мельниченко, 2005.
154 Богословский, 1978.
155 Левкин Г.Г. Китай или Маньчжурия . . .
156 Кычанов, Мельниченко, 2005.
157 Smith, 1996, p.117.
158 Ya Hanzhang, 1994, p. 73 — Кычанов, Мельниченко, 2005.
159 Шакабпа, 2003.
160 Успенский, 1996.
161 Кычанов, Мельниченко, 2005.
162 Kolmas, 1967.
163 Шакабпа, 2003
164 Кычанов, Мельниченко, 2005.
165 Шакабпа, 2003, с. 146.
166 The Rebel Dalai Lama . . .
167 Кычанов, Мельниченко, 2005.
168 Коротко о Тибете: исторический очерк . . . .
169 Tibet and Manchu, 2008, p.19–20.
170 Кычанов, Мельниченко, 2005.
171 Шакабпа, 2003, с. 149.
172 Беспрозванных, 2001, с. 168.
173 Шакабпа, 2003, с. 150.
174 Smith, 1996, p.126.
175 Кычанов, Мельниченко, 2005.
176 Беспрозванных, 2001.
177 Намсараева, 2003.
178 Беспрозванных, 2001, с. 176.
179 Smith, 1996, p.126.
180 Түвдээс гадна манжуурчууд ийм цаазыг XX зууныг хүртэл хэрэглэж байсан.
181 Кычанов, Мельниченко, 2005
182 Намсараева, 2003.
183 Намсараева, 2003.
184 Лу, 1828, с.114.
185 Шакабпа, 2003, с.158

186 Шакабпа, 2003, с.160.
187 Цыбиков, 1981, с.13.
188 Сицзян цзянши, 1993 — номонд: Кычанов, Мельниченко, 2005.
189 Намсараева, 2003.
190 Намсараева, 2003.
191 Шакабпа, 2003, с.163.
192 Материалы, 1994.
193 Новая история Китая, 1972 — номонд: Кычанов, Мельниченко, 2005.
194 Беспрозванных, 2001, с. 40.
195 Tibet and Manchu, 2008, p.45.
196 A 60-point commentary . . .
197 Tibet and Manchu, 2009, p.59.
198 Ran, 1991.
199 Кычанов, Мельниченко, 2005.
200 Шакабпа, 2003.
201 Шакабпа, 2003.
202 Шакабпа, 2003.
203 Намсараева, 2003.
204 Шакабпа, 2003.
205 Шакабпа, 2003.
206 Мартынов, 1978.
207 Ya Han Chang, 1991 — номонд: Тибет: правда, 1993.
208 Намсараева, 2003.
209 Намсараева, 2003.
210 Ya Han Chang, 1991 — номонд: Тибет: правда, 1993.
211 Намсараева, 2003.
212 Намсараева, 2003, с.119.
213 Намсараева, 2003, с.121–122
214 Шакабпа, 2003.
215 Шакабпа, 2003.
216 Шакабпа, 2003.
217 Yeh, 2003, p.499–523.
218 Шакабпа, 2003; Smith, 1995, p.137–138.
219 Кычанов, Мельниченко, 2005.
220 Van Walt, 1987.
221 Шакабпа, 2003.
222 Туччи, 2004.
223 Кычанов, Мельниченко, 2005.
224 Tibet and Manchu, 2008, p.65.
225 Кычанов, Мельниченко, 2005.
226 Сидихменов, 1985.
227 Выяснена причина смерти Гуансюя . . .
228 Van Walt, 1987.
229 Smith, 1996, p.141.
230 Рокхиль, 1901; Уоддель, 1906.
231 Шакабпа, 2003.
232 Леонтьев, 1956.
233 Шакабпа, 2003.
234 Van Walt, 1987.
235 Кулешов, 1992; Шакабпа, 2003.

236 Уоддель, 1906.
243 Англо-русский вопрос, 1891, с.151.
244 Намтар: Доржиев, 2003.
245 Bell, 1992, p.62.
246 Shaumian, 2000.
247 Shaumian, 2000.
248 Shaumian, 2000.
249 Shaumian, 2000.
250 Shaumian, 2000.
251 Уоддель, 1906, с.37–49.
252 Шакабпа, 2003, с.225.
253 Уоддель, 1906, с.203.
254 Ran, 1991, p.1–2.
255 Уоддель, 1906, с.195.
256 Уоддель, 1906, с.248–249.
257 Шакабпа, 2003, с.227.
258 Козлов, 2004.
259 Laird, 2006, p.225.
260 Кузьмин, Оюунчимэг, 2009, с.59–64.
261 Бадарчи, Дугарсурэн, 2000, с.37.
262 Белов, 1996, с.138.
263 Shaumian, 2000.
264 Уоддель, 1906, с.342.
265 Уоддель, 1906; Кычанов, Мельниченко, 2005.
266 Van Walt, 1987, p.35.
267 Шакабпа, 2003.
268 Shaumian, 2000.
269 Андреев, 2006а.
270 Lamb, 1966, p.301 — номонд: Van Walt, 1987, p.38.
271 Political & Secret files of the India Office, London/10/147, Bell to Government of India, 16 May 1910, Inclosure Tsongdu to Bell — номонд: Van Walt, 1987, p.38.
272 Кычанов, Савицкий, 1975.
274 Sperling, 2003, p.70.
275 Козлов, 1947.
276 Sperling, 2003, p.70.
277 Sperling, 2003, p.73–75.
278 Шакабпа, 2003, с.237.
279 Леонтьев, 1956.
280 Шакабпа, 2003, с.238–239.
281 Kolmas, 1967.
282 Kolmas, 1967; Sperling, 2003.
283 Кычанов, Мельниченко, 2005.
284 Shaumian, 2000.
285 Белов, 2005.
286 Shaumian, 2000.
287 Шакабпа, 2003, с.238.
288 Van Walt, 1987.
289 Андреев, 2006а, с.420.
290 Шакабпа, 2003.
291 Smith, 1996, p.166; Андреев, 2006а.

292 Сидихменов, 1985, с.256.
293 Андреев, 2006а.
294 Шакабпа, 2003.
295 Сидихменов, 1985.
296 Выяснена причина смерти Гуансюя . . .
297 Smith, 1996, p.167.
298 Шакабпа, 2003.
299 Shaumian, 2000.
300 Van Walt, 1987.
301 Шакабпа, 2003.
302 Белов, 2005, с.135–137.
303 Белов, 2005, с.143.
304 Bell, 1992, p.114.
305 Van Walt, 1987.
306 Шакабпа, 2003, с. 249–250.
307 Шакабпа, 2003.
308 Белов, 2005, с.166–167.
309 Van Walt, 1987, p.39.
310 Андреев, 2006а.

**Бүлэг 4. Тусгаар тогтнолын сүүлчийн жилүүд**

311 Macdonald, 1932.
312 Шакабпа, 2003, с.251.
313 Кычанов, Мельниченко, 2005.
314 Кулешов, 1992.
315 Van Walt, 1987.
316 Белов, 2005, с.178–179.
317 China can not have Tibet, 1912.
318 Шакабпа, 2003, с.259.
319 Белов, 1999, с.103.
320 Van Walt, 1987, p.320–321.
321 Кычанов, Мельниченко, 2005.
322 Шакабпа, 2003, с. 260–262.
323 Shakya, 1999.
324 Ya Hanzhang, 1993 — номонд: Кычанов, Мельниченко, 2005.
325 Кычанов, Мельниченко, 2005.
326 Шакабпа, 2003, с.267.
327 Van Walt, 1987.
328 Шакабпа, 2003, с.268.
329 Кулешов, 1992, с.265–267.
330 Ran, 1991.
331 Van Walt, 1987, p.58.
332 Андреев, 2006а.
33 Кычанов, Мельниченко, 2005.
334 Bell, 1992, p.193.
335 Van Walt, 1987.
336 Духовная культура Китая, 2009, с.294.
337 Van Walt, 1987, p.88.
338 Усов, 2007, с.90–109.
339 Френч, 2004.

340 Цендина, 2006.
341 Шакабпа, 2003.
342 Андреев, 2006б, 2008.
343 Van Walt, 1987.
344 Андреев, 2006а.
345 Клинов, 2000, с.34–35.
346 Кычанов, Мельниченко, 2005.
347 Богословский, 1978
348 Van Walt, 1987.
349 Гуревич, 1958, с. 51.
350 Шакабпа, 2003, с.285.
351 Кычанов, Мельниченко, 2005.
352 Френч, 2004, с.361.
353 Bell, 1992, p.190.
354 Богословский, 2002, с.60.
355 Гуревич, 1958.
356 Shakya, 1999, p.6.
357 Богословский, 2002.
358 A 60-point commentary, 2008.
359 Кычанов, Мельниченко, 2005.
360 Кычанов, Мельниченко, 2005.
361 Богословский, 2002.
362 Smith, 1996; Кычанов, Мельниченко, 2005; A 60-point commentary, 2008; http://reting.org/retingtulku5.html.
363 A 60-point commentary, 2008.
364 A 60-point commentary, 2008.
365 Түвдийг захирах эрхтэйг нотлох зорилготой боловч бодит баримтын болон хууль эрхийн ямар ч хүчгүй гоминьданы баримтуудад хийсэн нарийвчилсан дүн шинжилгээ. A 60-point commentary, 2008.
366 Parenti M. Friendly feudalism . . .
367 Браун, 1974.
368 Усов, 2007, с.108.
369 О чем умалчивают в Пекине, 1972, с.24.
370 Кычанов, Мельниченко, 2005.
371 Norbu, 2003, p.613.
372 Van Walt, 1987, p.89.
373 Ling, 1964, p.447–448.
374 Ling, 1964, c.447–448; Kolas, Thowsen, 2005, p.45.
375 Браун, 1974.
376 Shakya, 1999, p.33
377 Браун, 1974.
378 Френч, 2004.
379 Ледовский, 2005, с.14.
380 Кычанов, Мельниченко, 2005; McCarthy, 1997.
381 Андреев, 2006а.
382 Андреев, 2006б, с.127–132.
383 Вермахтын талд тулалдаж явсан Халимагуудын тухай Гучиновын 2004 оны номноос үз.
384 Харрер, 2002.
385 Laird, 2006, p.290.

386 Богословский, Москалев, 1984.
387 Кычанов, Мельниченко, 2005.
388 Ran, 1991.
389 Van Walt, 1987.
390 Van Walt, 1987.
391 Цендина, 2006.
392 В Тибете обнаружены останки . . .
393 Qin Yongzhang. A secret history . . .
394 Гуревич, 1958, с. 80.
395 Van Walt, 1987.
396 Кычанов, Мельниченко, 2005.
397 Клинов, 2000, с. 381.
398 Шакабпа, 2003; Van Walt, 1987.
399 Van Walt, 1987.
400 Кычанов, Мельниченко, 2005.
401 Van Walt, 1987, p.83.
402 Smith, 1996, p.253–254.
403 Кычанов, Мельниченко, 2005.
404 Богословский, Москалев, 2002.
405 Shakya, 1999, p.3.
406 Кычанов, Мельниченко, 2005.
407 Van Walt, 1987.
408 Shakya, 1999, p.8.

### Бүлэг 5. Шашин ба соёл

409 Намкай Норбу, 2008, с.114.
410 Кычанов, Мельниченко, 2005.
411 Кузнецов, 2001.
412 Гумилев, 1968.
413 Кычанов, Мельниченко, 2005.
414 Намкай Норбу, 2008, с. 32.
415 Шакабпа, 2003; Намкай Норбу, 2008, с.52–56.
416 Намкай Норбу, 2008, с. 120–126.
417 Овчинников, 2006.
418 Николаев, 2005.
419 Бичурин, 1833, с.130.
420 Намкай Норбу, 2008, с.37.
421 Харрер, 2002.
422 Кычанов, Мельниченко, 2005
423 Кычанов, Мельниченко, 2005.
424 Шакабпа, 2003.
425 Шакабпа, 2003.
426 Будон, 1999.
427 Орос хэлээр: Чже Цонкапа, 2007.
428 Орос хэлээр гарсан Зонховын намтар 2007, т. 1, с.XXXV–LIII.
428 -1. Далай лам, 2004.
429 Далай-лама, 1991, 2008.
429 -1. Далай лам, 2004.
430 Намкай Норбу, 2004, с.5–34.
431 Буддиийн шашинд Бурхан – бүтээгч эсвэл Бурхан – бие хүн гэсэн тогтолцоот үзэл

байхгүйгээс ч барахгүй “олон бурханы” ойлголт Түүний оронд байхгүй. Эндээс буддийн шашин бол шүтлэггүй үзэл гэсэн дүгнэлт хийдэг. Энэ нарийн зөв биш: буддийн шашин өөр ойлголтын систем дээр тулгуурладаг тул шүтлэггүй үзэлд аваачин үзэх нь буруу юм.

432 Далай-лама, 2008, с. 38.

433 Дхарма санскритээр “тэр барьж байгаа юм”, Бүх юм – дхарма, тэд өөрийн мөн чанарыг эсвэл авирыг барих буюу даах утга учрын үзэгдэл. Мөн сургаал эсвэл шашин – энэ дхарма.

434 Туччи, 2004.

435 Далай-лама, 1992

436 Тело великого ламы . . .

437 Тибетский лама . . .

438 Подробнее см.: Mind and Life Institute . . .

439 Далай-лама, 2008.

440 Торчинов Е.А. Буддийская традиция . . .

441 Коротко о Тибете: Население и народности . . .

442 Переговоры . . .

443 Protection and development . . .

444 Шакабпа, 2003.

445 Butt, 1994; Харрер, 2002.

446 Китай: Тибет цифры и факты 2006 . . .

447 Пандаев, 1999.

448 Smith, 2008, p.68, 72, 133–135.

449 Smith, 1996, p.553–554; Kalovski I. The true face . . .

450 Овчинников, 2006, с.95–96; 2009.

451 Балакирев Е.В. Миф . . .

452 Дхаммапада, X, 129, 131; XII, 165.

453 China’s Tibet exhibit . . .

454 Grunfeld, 1996.

455 Wright, 1904, p.333–334; Forney M. China . . .

456 Олон зураг: La magie . . .

457 Гедин, 1899, с.417.

458 Туччи, 2004.

459 Рингардт, 1903, с.83.

460 Байков, 1997, с.30–123.

461 Белов, 1999.

462 КПК продолжает препятствовать . . .

463 Bell, 1991, p.289.

464 Френч, 2004, с.263.

465 Kauffner P. Was human . . .

466 Smith, 2008, p.133–134.

467 Powers, 2004, p.141.

468 Grunfeld, 1996, p.29–30; Kauffner P. Was human . . .

469 Стонтон, 1804, с.23–24.

470 Мулдашев, 2008, с.139.

471 Мулдашев, 2008, с.244–247.

472 Мулдашев, 2008, с.347.

473 Жиронкина Ю. “Ясная картина мира” . . .

474 Далай-лама, 2007, с.377.

**Бүлэг 6 Төр, нийгмийн байгуулалт, эдийн засаг**

475 Кычанов, Мельниченко, 2005.
476 Кычанов, Мельниченко, 2005.
477 Валиахметов, 1958, с.40.
478 Петербургт олон жил амьдран суусан лам Жамьян Хенце XX зууны дунд үед өөрийнхөө хийдэд нэгэн тийм сорилтыг үзсэн бөгөөд гэм буруугүй хүн буцалж буй тосонд гараа дүрэхэд огт түлэгдээгүйг нүдээр харснааярижээ.
479 Кычанов, Мельниченко, 2005.
480 Тибет: правда, 1993.
481 Шакабпа, 2003.
482 Кычанов, Мельниченко, 2005.
483 Childs, 2003, p.423–444.
484 Childs, 2003, p.424.
485 Тибет: правда, 1993.
486 Ecological Improvement . . .
487 Тибет: правда, 1993.
488 Chhodak, 2003, p.36–42.
486 Ecological Improvement . . .
487 Тибет: правда, 1993.
488 Chhodak, 2003, p.36–42.
489 Козлов, 1947; Овчинников, 2006; Bell, 1991, p.159.
490 Шакабпа, 2003.
491 Шакабпа, 2003.
492 Богословский, 1978.
493 Van Walt, 1987.
494 Grunfeld, 1996.
495 Кычанов, Мельниченко, 2005.
496 Далай-лама, 2000.
497 Macdonald, 1932, p.209–210.
498 Кычанов, Мельниченко, 2005.
499 Далай-лама, 2000.
500 Кычанов, Мельниченко, 2005.
501 Van Walt, 1987.
502 Поборник мира . . .
503 Счастье Тибета . . .
504 Grunfeld, 1996.
505 Laird, 2006, p.318.
506 Tibet: a Human Development, 2007.
507 Smith, 2008, p.15–16.
508 Шакабпа, 2003.
509 Тариачдын эдэлбэр газрыг үр хүүхэддээ хувааж өгөх явдал Оросын эзэнт гүрний европын хэсэгт хэдэн үеийнхний туршид тариачид газаргүй болохын нэг гол шалтгаан болжээ. Хожим энэ нь нийгэм-эдийн засгийн хямралын нэг шалтгаан болсон байна (Брюханов 2007).
510 Далай-лама, 2000.
511 Тибет: правда, 1993.
512 Parenti M. Friendly feudalism . . .
513 Parenti M. Friendly feudalism . . .

514 Goldstein, 2007, p.12.
515 Tibet: a Human Development, 2007.
516 Parenti M. Friendly feudalism . . .
517 Гуревич, 1958.
518 Andrugtsang, 1973, p.28.
519 Goldstein, 2007, p.13.
520 Norbu, 1999, p.174–175.
521 Andrugtsang, 1973, p. 30.
522 Bell, 1991.
523 Шакабпа, 2003.
524 Tibet: a Human Development, 2007, p.70.
525 За полвека население . . .
526 Шакабпа, 2003.
527 Валиахметов, 1958, с.12.
528 Кычанов, Мельниченко, 2005.
529 Norbu, 1999.
530 Кычанов, Мельниченко, 2005.
531 Гуревич, 1958.
532 Кычанов, Мельниченко, 2005.
533 Шакабпа, 2003.
534 Parenti M. Friendly feudalism . . .
535 Гуревич, 1958.
536 Далай-лама, 2000.
537 Bell, 1991; Govinda, 2002, p.100.
538 Шакабпа, 2003.
539 Кычанов, Мельниченко, 2005.
540 Шакабпа, 2003, с.261–262.
541 Гуревич, 1958.
542 Далай-лама, 2000.
543 Богословский, 1976, с. 262.
544 Тибет: правда, 1993.
545 Шакабпа, 2003, с. 261.
546 Тариачдын хүүхдүүд сүм хийдэд сексийн элэг доогт нэрвэгдэж байсан мэтийн баталгаа (Goldstein et.al., 1997- иш таталт: Parenti M. Friendly feudalism…), хэдийгээр ганц нэг тиймэрхүү үйлдэл байдаг гэх боловч дайсагнагч атеистуудын “бүтээлд” христийн шашинтныг буруутгасан гүтгэлийн адил ямар ч үндэсгүй зүйл юм.
547 Palden Gyatso, 1997, p.27.
548 Parenti M. Friendly feudalism . . .
549 Andrugtsang, 1973, p.20.
550 Стонор, 1958, с.140.
551 Tibet: a Human Development, 2007.
552 Tibet: a Human Development, 2007.
553 Рингардт, 1903.
554 Шакабпа, 2003.
555 Кычанов, Мельниченко, 2005.
556 Шакабпа, 2003.
557 Van Walt, 1987.
558 Шакабпа, 2003.
559 Гуревич, 1958.
560 Parenti M. Friendly feudalism . . .

561 Шакабпа, 2003.
562 Van Walt, 1987.
563 Кычанов, Мельниченко, 2005.
564 Macdonald, 1932, p.231.
565 Шакабпа, 2003.
566 Гуревич, 1958.
567 Shakya, 1999, p.12.
568 Шакабпа, 2003.
569 Tibet: a Human Development, 2007.
570 Кычанов, Мельниченко, 2005.
571 Клинов, 2000.
572 Кычанов, Мельниченко, 2005.
573 Гуревич, 1958.
574 Smith, 2008.
575 Козлов, 1947.
576 Пржевальский, 1883.
577 Козлов, 1923.
578 Пржевальский, 1875.
579 Пржевальский, 1875.
580 Козлов, 1947.
581 См., Козлов, 1947.
582 Пржевальский, 1883, с. 237.
583 Левкин Г.Г. Китай или Маньчжурия . . .
584 Шакабпа, 2003.
585 Гуревич, 1958.
586 Bell, 1991.
587 Харрер, 2002.
588 Харрер, 2002.
589 Валиахметов, 1958, с. 43.
590 Kalovsky I. The true face . . .
591 Национальная районная автономия . . .
592 Grunfeld, 1996; Sautman, 2008.
593 Козлов, 2004, с.35.

## Бүлэг 7. "Энх тайван чөлөөлөлт" ба түүний уршиг дагавар

594 Александров, 1995.
595 Bache. 50 years of turmoil . . .
596 Петров, 2003, с.499–501.
597 Ледовский, 2005, с.25–28.
598 Ледовский, 2005, с.25–28.
599 Борисов, Колосков, 1972.
600 Сапожников, 1984.
601 Ледовский, 2005, с.31.
602 Ледовский, 2005, с.67.
603 Малиновский Г. Тринадцать лет . . .
604 Ледовский, 2005, с.31.
605 Борисов, Колосков, 1972.
606 Борисов, Колосков, 1972.
607 Ледовский, 2005, с.109–110.
608 Ледовский, 2005, с.32–48.

609 Ледовский, 2005, с.112–113.
610 Ледовский, 2005, с.116.
611 Ледовский, 2005, с.117.
612 Мао Цзэдун, 2008, с.166.
613 Ледовский, 2005, с.112.
614 Андреев, 2006а.
615 Рахманин, 2005, с.116–117.
616 Мао, 1967.
617 Shakya, 1999, p.7–9.
618 Шакабпа, 2003.
619 Ледовский, 2005, с.118–119.
620 Ледовский, 2005, с.110–111.
621 Гуревич, 1958, с.93.
622 Shakya, 1999.
623 Жэньминь Жибао, 22 11.1952.
624 Тибет: правда, 1993.
625 Кычанов, Мельниченко, 2005, с. 259.
626 Promises and lies, 2001, p.24–30.
627 Шакабпа, 2003
628 Goldstein, 2003, p.535.
630 Goldstein, 2007.
631 Тибет: правда, 1993; Кычанов, Мельниченко, 2005.
632 Далай-лама, 1992.
633 Goldstein, 2007.
634 Goldstein, 2007
635 Кычанов, Мельниченко, 2005.
636 Ледовский, 2005, с.149–150.
637 Ледовский, 2005, с.155–156.
638 Ледовский, 2005, с.156.
639 Цөмийн зэвсгийн тухай асуудал нилээд хожуу буюу 1958 онд Н.С. Хрущев, Мао Зэдун нарын хооронд болсон хэлэлцээний үеэр яригджээ (Федоренко, 1992, с.101).
640 Ледовский, 2005, с.165–166.
641 Советская военная помощь . . .
642 Борисов, Колосков, 1972.
643 Борисов, Колосков, 1972.
644 Филатов, 1980, с.13–32.
645 Филатов, 1980, с.55.
646 Глазунов, 2008, с.54–55.
647 1953 оны 9-р сарын 15-нд Жэньмин Жибао сонинд гарсан “Аугаа их тусламж үзүүлсэн ЗХУ-д талархая” өгүүлэл — Борисов, Колосков, 1972, с.64.
648 Великая пролетарская культурная революция, 1970, с.8.
649 Van Walt, 1987.
650 Goldstein, 2003, p.537.
651 К вопросу о китайско-индийской границе, 1962, с.123.
652 Shakya, 1999, p.12.
653 Van Walt, 1987.
654 Шакабпа, 2003, с.316–317.
655 Promises and lies, 2001.
656 Гуревич, 1958, с. 115.
657 Goldstein, 2007.

658 Smith, 1996, p.272–273.
659 Goldstein, 2007.
660 Гуревич, 1958.
661 Norbu, 1986 — номонд: Smith, 1996, p.273.
662 Shakya, 1999, p.38; Smith, 1996, p.274; Herold K. An annotated . . .
663 Гуревич, 1958.
664 Smith, 1996.
665 Smith, 1996, p.273.
666 Харрер, 2002.
667 Гуревич, 1958.
668 Далай-лама, 2000.
669 Кычанов, Мельниченко, 2005, p.260.
670 Van Walt, 1987.
671 Palden Gyatso, 1997, p.30.
672 Herold K. An annotated chronology . . .
673 McCarthy, 1997, p.52–54.
674 Shakya, 1999.
675 McCarthy, 1997, p.54.
676 Herold K. An annotated chronology . . .
677 Shakya, 1999.
678 Smith, 1996, p.279.
679 Wang Jiawei, Nyima Gyaincain, 1997, p.210.
680 Кычанов, Мельниченко, 2005, с.260.
681 Ling, 1964, p.13.
682 A Survey of Tibet Autonomous Region, 1984 — номонд: Тибет: правда, 1993.
683 Шакабпа, 2003, с.318
684 Promises and lies, 2001.
685 Van Walt, 1987, p.144.
686 Ling, 1964, p.8–9.
687 Гуревич, 1958, с.139.
688 Шакабпа, 2003, с.319.
689 Van Walt, 1987.
690 Goldstein, 2003, p.536.
691 Van Walt, 1987.
692 Secret: CTC releases documents . . .
693 Van Walt, 1987, p.145.
694 Кычанов, Мельниченко, 2005.
695 Гуревич, 1958.
696 Далай-лама, 1992.
697 Стонор, 1958, с.139.
698 Horlemann B. Modernization efforts . . .
699 Далай-лама, 2000.
700 Shakya, p.50–51.
701 Goldstein, 2007, p.85.
702 Shakya, 1999, p.50.
703 Shakya, 1999, p.62.
704 Shakya, 2003, p.589–606.
705 Shakya, 1999, p.64–65.
706 Promises and lies, 2001.
707 Shakya, 2005.

708 Norbu J. March winds . . .
709 Shakya, 2005.
710 Promises and lies, 2001.
711 Promises and lies, 2001.
712 Shakya, 1999, p.70–71.
713 Promises and lies, 2001.
714 Promises and lies, 2001.
715 Китай: Тибет; факты и цифры, 2005 . . .
716 Ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлт.
717 Далай-лама, 1992, с.66.
718 Promises and lies, 2001; Cao, 2007, p.111–114; Китаев С. Как Тибет стал . . .
719 Van Walt, 1987.
720 A 60-point commentary, 2008.
721 Promises and lies, 2001.
722 Сталин, 1948, с.357–374.
723 Goldstein, 2007, p.101.
724 Богословский, 1978.
725 Shakya, 1999, p.90.
726 Тридцать шесть стратагем, 2000, с.71.
727 Promises and lies, 2001
728 О тибетском вопросе, 1959, с.233.
729 Shakya, 1999, p.70–71.
730 Promises and lies, 2001
731 Shakya, 1999, p.70–71.
732 Promises and lies, 2001
733 Shakya, 1999, p.70–71.
734 Secret: CTC releases documents . . .
735 Arpi, 2007, p.78–81; Ngapoi, 1991, p.5, 10–12.
736 Promises and lies, 2001
737 Далай-лама, 1992.
738 Promises and lies, 2001.
739 Promises and lies, 2001.
740 Promises and lies, 2001.
741 Promises and lies, 2001.
742 Le, 1985 — номонд: Goldstein, 2007, p.225–226.
743 Origin of the title . . .
744 Blondeau, Buffetrille, 2008, p.68.
745 Тибет: правда, 1993.
746 Шакабпа, 2003; Promises and lies, 2001
747 Далай-лама, 1992, 2000.
748 Goldstein, 2007, p.244.
749 Shakya, 1999, p.95.
750 Goldstein, 2007, p.252.
751 Palden Gyatso, 1997, p.43.
752 Goldstein, 2007, p.253.
753 Goldstein, 2007, p.302–303.
754 Кычанов, Мельниченко, 2005.
755 Рахимов, 1968.
756 Кычанов, Мельниченко, 2005.
757 Кычанов, Мельниченко, 2005.

758 Рахимов, 1968, с.73.
759 Цзян Цзэминь, 2004, с.204.
760 Shakya, 1999; Promises and lies, 2001.
761 Mao Tse-tung, 1977, p.73–76.
762 Shakya, 1999, p.106–107.
763 Promises and lies, 2001
764 Goldstein, 2007, p.352.
765 Богословский, 1978.
766 Norbu, 1999, p. 126.
767 Goldstein, 2007, p. 309–310.
768 Shakya, 1999, p.118.
769 Andrugzang, 1973, p.33–35.
770 Norbu, 1999, p.126.
771 Кычанов, Мельниченко, 2005.
772 Ginsburgs, Mathos, 1964, p.95.
773 Norbu, 1999, p.130–140; Smith, 1996, p.371–372.
774 Shakya, 1999, p.164.
775 Ling, 1964, p.44.
776 Богословский, 1978.
777 Кычанов, Мельниченко, 2005.
778 Laird, 2006, p.321.
779 Shakya, 1999, p.123.
780 Шакабпа, 2003.
781 Кычанов, Мельниченко, 2005.
782 Далай-лама, 2000, с.113.
783 Далай-лама, 1992, с.101.
784 Goldstein, 2007.
785 Andrugzang, 1973, p.37.
786 Ling, 1964, p.107–108.
787 Валиахметов, 1958, с. 36.
788 Валиахметов, 1958, с. 35–36.
789 Далай-лама, 1992, с.107.
790 Goldstein et al., 2004, p.206 — номонд: Fifth International Conference, 2008, p.102.
791 Andrugtsang, 1973, p.39–40.
792 Подробнее см.: Богословский, 1978, с.65–68.
793 Шакабпа, 2003.
794 Кычанов, Мельниченко, 2005
795 Богословский, 1978.
796 Кычанов, Мельниченко, 2005.
797 Валиахметов, 1958, с. 17.
798 Palden Gyatso, 1997, p.37.
799 Shakya, 1999, p.116.
800 Tibet: 1950–1967. 1968, p.491.
801 Goldstein, 2007, p.181–184.
802 Palden Gyatso, 1997, p.36–37.
803 Shakya, 1999, p.134.
804 Norbu, 1999, p.112–121.
805 Goldstein, 2007, p.430–438.
806 Ling, 1964, p.206–207.
807 Тибет под властью коммунистического Китая, 2001.

808 Домогацких, 1962, с.19–20.
809 Ling, 1964, p.60.
810 Шакабпа, 2003.
811 Goldstein, 2007, p.417–418.
812 Tibet: a Human Development, 2001.
813 Кычанов, Мельниченко, 2005.
814 Ling, 1964, p.118.
815 Кычанов, Мельниченко, 2005.
816 Khetsun, 2008.
817 Тибет глазами тибетцев, 1995, с.19.
818 Далай-лама, 2000.
819 Goldstein, 2007, p.439.
820 Тридцать шесть стратагем, 2000, с.35, 68.

**Бүлэг 8. Ардын бослогоос соёлын хувьсгал хүртэл**

1048 Norbu, 2003, p.613.
1049 Andrugzang, 1973, p.11.
1050 Клинов, 2000, с.318.
1051 Tibet Under Chinese, 1976, p.14; Norbu, 2006.
1052 Tibet and the Chinese People's Republic, 1960.
1053 Tibet Under Chinese, 1976, p.14–21.
1054 Tibet and the Chinese People's Republic, 1960.
1055 Клинов, 2000, с.318.
1056 Smith, 1996, p.387.
1057 Клинов, 2000, с.318.
1058 Shakya, 1999, p.143.
1059 Secret: CTC releases documents . . .
1060 Andrugtsang, 1973, p.31.
1061 Wang Jiawei, Nyima Gyaincain, p.232.
1062 Клинов, 2000, с. 318.
1063 Ling, 1964, p.224.
1064 Shakya, 1997.
1065 Ling, 1964, p.86.
1066 Parenti M. Friendly feudalism . . .
1067 Далай-лама, 2000.
1068 Богословский, 1978.
1069 Butterfield, 1979.
1070 The Question of Tibet, 1959, p.206; Tibet and the Chinese People's Republic, 1960, p.42–253.
1071 Shakya, 1999, p.140.
1072 Гарри, в печати.
1073 Norbu J. March winds . . .
1074 Smith, 1996, p.410.
1075 Tibet and the Chinese People's Republic, 1960, p.42, 235.
1076 Tibet and the Chinese People's Republic, 1960; Message of American Embassy in Karachi to the State Department, 06.09.1956, National Archives 793B.00/9–656 — номонд: Smith, 1996, p.410.
1077 Norbu, 2006.
1078 The Question of Tibet, 1959, p.37.
1079 Norbu, 1999, p.145–146.

1080 Shakya, 1999, p.144–147.
1081 Andrugtsang, 1973, p.40–41.
1082 Andrugtsang, 1973.
1083 Smith, 1996, p.407.
1084 Далай-лама, 1992.
1085 Далай-лама, 1992.
1086 Andrugtsang, 1973, p.37–38.
1087 The Question of Tibet, 1959, p.38.
1088 Клинов, 2000, с.319.
1089 Богословский, 1978.
1090 The Question of Tibet, 1959, p.53; Tibet and the Chinese People's Republic, 1960; Secret: CTC releases documents . . .
1091 Клинов, 2000, с. 319.
1092 Tibet and the Chinese People's Republic, 1960.
1093 Френч, 2004.
1094 Tibet and the Chinese People's Republic, 1960, p.38, 43–44.
1095 Tibet and the Chinese People's Republic, 1960, p.43–44.
1096 Smith, 1996, p.404.
1097 Trikamdas, 4 June 1959.
1098 Secret: CTC releases documents . . .
1099 Secret: CTC releases documents . . .
1100 The Question of Tibet, 1959, p.38.
1101 Tibet and the Chinese People's Republic, 1960, p.196
1102 Samsara: personal testimony . . .
1103 Френч, 2004, с. 187–188.
1104 Tibet and the Chinese People's Republic, 1960, p. 87; Далай-лама, 2000.
1105 Tibet and the Chinese People's Republic, 1960; Далай-лама, 1992, 2000; Куртуэ С. и др. Черная книга коммунизма.
1106 Далай-лама, 1992, 2000.
1107 His Holiness the Panchen Lama . . .
1108 Panchen Lama, 1997, p.67.
1109 Ardley, 2002, p.31.
1110 China Spring, 1986, June, номонд: Тибет: правда, 1993.
1111 His Holiness the Panchen Lama . . .
1112 Norbu J. March winds . . .
1113 Andrugtsang, 1973, p.88–91.
1114 номонд: Tibet: 1950–1967. 1968, p.326.
1115 Клинов, 2000, с.319.
1116 Parenti M. Friendly feudalism . . .
1117 Ling, 1964, p.192–194.
1118 Mao, 1966, c.47–48, 51.
1119 Dangdai zhongguo de xizang, p.225 — номонд: Jian Ch. The Tibetan rebellion . . .
1120 номонд: Кычанов, Мельниченко, 2005, с.268–269.
1121 Andrugtsang, 1973, p.42–43.
1122 Andrugtsang, 1973, p.48–49.
1123 Шакабпа, 2003.
1124 Ильин, 1978.
1125 Кычанов, Мельниченко, 2005.
1126 Мао Цзэдун. К вопросу . . .
1127 Богословский, 1978.

1128 Далай-лама, 1992.
1129 Brief introduction of Chushi Gangdruk . . .
1130Andrugtsang, 1973, p.55.
1131 Ardley, 2002, p.31.
1132 Andrugtsang, 1973, p.60.
1133 Andrugtsang, 1973, p.62–66; National uprising . . .
1134 Brief introduction of Chushi Gangdruk . . .
1135 Wang Jiawei, Nyima Gyaincain, 1997, p.244.
1136 Andrugtsang, 1973, p.91.
1137 Goldstein, 1994, p.93.
1138 Andrugtsang, 1973, p.69–70.
1139 Andrugtsang, 1973, p.72–73
1140 Brief introduction of Chushi Gangdruk . . .
1141 Далай-лама, 1992, с. 127.
1142 Andrugtsang, 1973, p.70–91.
1143 Brief introduction of Chushi Gangdruk . . .
1144 Andrugtsang, 1973, p.92.
1145 Dunham, 2004, p.256.
1146 Сюй, 1958, с.24.
1147 Щербаков, 1958, с.9–15.
1148 Jiang D. Popular history . . .
1149 Тибет: правда, 1993.
1150 Ling, 1964, p.248–251.
1151 Ling, 1964, p.322, 332.
1152 Tibet: 1950–1967. 1968, p.322–323.
1153 Smith, 1996, p. 442–443.
1154 Tibet and the Chinese People's Republic, 1960, p.43–44.
1155 Kolas, Thowsen, 2005, p.47.
1156 Шакабпа, 2003.
1157 The Question of Tibet, 1959, p.41–43.
1158 Trikamdas, 5 June 1959; The Question of Tibet, 1959, p.43; in English: Tibet and the Chinese People's Republic, 1960, p.21, 59–63.
1159 Norbu J. March winds . . .
1160 Shakya, 1999, p.185.
1161 Богословский, 1976, с.263.
1162 Shakya, 1999, p.488.
1163 Клинов, 2000.
1164 Богословский, 1978.
1165 Andrugtsang, 1973, p.95.
1166 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1167 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1168 Patterson, 1965 — номонд: Богословский, 1978.
1169 Shakya, 1999, p.489.
1170 Далай-лама, 2000.
1171 Шакабпа, 2003
1172 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1173 The Question of Tibet, 1959, p.13.
1174 Кычанов, Мельниченко, 2004.
1175 Шакабпа, 2003.
1176 Andrugtsang, 1973, p.96.

1177 Jiang Ch. The Tibetan rebellion . . .
1178 О тибетском вопросе, 1959, с.187–190.
1179 Кычанов, Мельниченко, 2005.
1180 Shakya, 1999, p.194.
1181 Богословский, 1978.
1182 О тибетском вопросе, 1959, с.30–35.
1183 Wang Jiawei, Nyima Gyaincain, 1997.
1184 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1185 Богословский, 1978.
1186 Norbu J. March winds . . .
1187 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1188 Tenpa Soepa, 2008, p.21.
1189 Palden Gyatso, 1997, p.52.
1190 Шакабпа, 2003.
1191 Panchen Lama, 1997, p.5.
1192 Өөрөөр хэлбэл бүх түвдчүүд. “Мани” – “ум ма ни бад ме хум”-ыг товчилсан үг, монголоор бол маань, мэгзэмийн маанийг хэлж байна.
1193 Panchen Lama, 1997, p.4–5.
1194 Liu M. When heaven shed blood . . .
1195 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1196 Norbu J. March winds . . .
1197 Norbu J. March winds . . .
1198 Кычанов, Мельниченко, 2005.
1199 Далай-лама, 1992, 2000.
1200 Tenpa Soepa, 2008, p.29–31.
1201 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1202 Shakya, 1999, p.203–204.
1203 Palden Gyatso, 1997, p.53.
1204 Phuntsok, 1992.
1205 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1206 Tibet Under Chinese, 1976, p.31.
1207 Одели, 2005, с. 178.
1208 Smith, 1996, p.451.
1209 Khetsun, 2008.
1210 Smith, 1996, p.452.
1211 О тибетском вопросе, 1959.
1212 Shakya, 1999, p.204.
1213 Wang Jiawei, Nyima Gyaincain, 1997, p.246–247.
1214 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1215 His Holiness the Panchen Lama . . .
1216 Shakya, 1999, p.201–202.
1217 Andrugtsang, 1973, p.102–103.
1218 Ji Youcuan, 1993, p.87 — номонд: Jian Ch. The Tibetan rebellion, p.91.
1219 Smith, 1996, p.480–482.
1220 О тибетском вопросе, 1959, с.1–3.
1221 О тибетском вопросе, 1959, с.1
1222 О тибетском вопросе, 1959, с. 4–17.
1223 Сан, 2004, с. 83; В Тибете учрежден День . . .
1224 Богословский, 1978, с.75–83.
1225 О тибетском вопросе, 1959, с.60.

1226 О тибетском вопросе, 1959, с.195–197.
1227 Клинов, 2000, с.323.
1228 Шакабпа, 2003.
1229 Van Walt, 1987, p.163.
1230 О тибетском вопросе, 1959.
1231 Түвд коммунист хятадын эрх мэдэлд, 2001.
1232 Далай-лама, 1992.
1233 О тибетском вопросе, 1959, с.10.
1234 Norbu J. March winds . . .
1235 Ji Youquan, 1993; Knaus, 1999 — номонд: Blondeau, Buffetrille, 2008, p.89.
1236 Богословский, 1978.
1237 О тибетском вопросе, 1959, с.80–84.
1238 His Holiness's Middle Way Approach . . .
1239 Шакабпа, 2003.
1240 Клиновын номонд түвдийн асуудлыг янз бүрийн жилүүдэд НҮБ-д хэлэлцэж байсан тухай нарийвчилсан дүн шинжилгээ хийжээ.
.1241 Современная ситуация в Тибете . . .
1242 Norbu, 1999, p.156–157.
1243 Butt, 1994, p.8–9.
1244 Andrugtsang, 1973, p.110.
1245 Ling, 1964, p.449–450.
1246 Wang Jiawei, Nyima Gyaincain, 1997, p.249.
1247 Panchen Lama, 1997, p.100.
1248 Френч, 2004.
1249 Norbu, 2006.
1250 Sonam, 2007.
1251 Sonam, 2007.
1252 Sonam, 2007.
1253 Френч, 1984.
1254 Brief introduction of Chushi Gangdruk . . .
1255 Sonam, 2007.
1256 Богословский и др., 1975.
1257 Van Walt, 1987.
1258 Wang Jiawei, Nyima Gyaincain, 1997.
1259 Кому принадлежит суверенитет . . .
1260 Shakya, 1999, p.23–24.
1261 Хятад-энэтхэгийн хилийн тухай асуудалд., 1962.
1262 Зубок, 2001 (1), с.106–107.
1263 Зубок, 2001 (2), с.99.
1264 Jian Ch. The Tibetan rebellion . . .
1265 Филатов, 1980, с.48.
1266 Филатов, 1980, с.121.
1267 О тибетском вопросе, 1959.
1268 Shakya, 1999, p.244–245.
1269 О тибетском вопросе, 1959, с.67.
1270 О тибетском вопросе, 1959.
1271 Кычанов, Мельниченко, 2005.
1272 О тибетском вопросе, 1959, с.24–25.
1273 Panchen Lama, 1997, p.37.
1274 Tibet: 1950–1967. 1968, p.388–389.

1275 Palden Gyatso, 1997, p.63–64.
1276 Shakya, 1999, p.245.
1277 Шевелев В.Н. Мао Цзэдун . . .
1278 Shakya, 1999, p.256.
1279 Shakya, 1999, p.250–253.
1280 Smith, 1996, p.472–473.
1281 Богословский, 1978.
1282 Богословский, 1978.
1283 Knuth, 2003, p.220.
1284 Овчинников, 2006, с.97.
1285 Tibet: a Human Development, 2007.
1286 Smith, 1996, p.477–478.
1287 Юн Чжан, Холлидей, 2007.
1288 Tibet and the Chinese People's Republic, 1960, p.33.
1289 Shakya, 1999, p.248, 257.
1290 Tibet: 1950–1967. 1968, p.396.
1291 Богословский, 1978.
1292 Goldstein et al., 2009, p.74.
1293 Клинов, 2000, с. 327.
1294 Panchen Lama, 1997, p.110.
1295 Богословский, 1978.
1296 Богословский и др., 1975.
1297 Куртуэ С. и др. Черная книга . . .
1298 Palden Gyatso, 1997, p.84, 94.
1299 Smith, 1996, p.488.
1300 Sautman, 2008, p.239.
1301 Panchen Lama, 1997, p.26–27, 30, 112–113.
1302 Yang, 1996 — Blondeau, Buffetrille, 2008, p.143.
1303 Tibet Under Chinese, 1976, p.56.
1304 Tibet, 2007.
1305 Panchen Lama, 1997.
1306 Smith, 1996, p.472–473.
1307 Barnett, 1997, p.xvii.
1308 His Holiness the Panchen Lama . . .
1309 Panchen Lama, 1997, p.64.
1310 Tenpa Soepa, 2008, p.90–92; Khetsun, 2008.
1311 Panchen Lama, 1997, p.13.
1312 Palden Gyatso, 1997, p.66–71.
1313 Shakya, 1999.
1314 Panchen Lama, 1997, p.37.
1315 Френч, 2004.
1316 Palden Gyatso, 1997, p.84.
1317 Юн Чжан, Холлидей, 2007, с.255.
1318 Samsara, a Tibetan human rights archive . . .
1319 Palden Gyatso, 1997, p.78–79.
1320 Victim of Chinese torture . . .
1321 Tenpa Soepa, 2008, p.68–80.
1322 Тибет: правда, 1993.
1323 Behind bars . . .
1324 Tenpa Soepa, 2008, p.93–96.

1325 Khetsun, 2008.
1326 His Holiness the Panchen Lama . . .
1327 Shakya, 2002.
1328 Palden Gyatso, 1997, p.96.
1329 Mao, 1952, c.44–59, 70, 72.
1330 Идейно-политическая сущность маоизма, 1977.
1331 Panchen Lama, 1997.
1332Palden Gyatso, 1997, p.121.
1333 Norbu, 1999, p. 186–187.
1334 Parenti M. Friendly feudalism . . .
1335 Tibet Under Chinese . . . , 1976, p.56, 88.
1336 Домогацких, 1962, с. 41–43.
1337 Домогацких, 1962, с. 50–53.
1338 Домогацких, 1962, с.55–64.
1339 Strong, 1959.
1340 Shakya Ts. Tibet and China . . .
1341 Panchen Lama, 1997, p.40.
1342 Ling, 1964.
1343 Цзин Цзюнь — Smith, 1996, p.474.
1344 Briefing paper . . .
1345 Harris — Kolas, Thowsen, 2005, p.46.
1346 Strong, 1959.
1347 2001 онд тэнд нийтдээ 800 лам байжээ (Кычанов, Мельниченко, 2005).
1348 Palden Gyatso, 1997, p.72–75; Puntshok, 1998, p.24.
1349 Panchen Lama, 1997, p.52.
1350 Богословский, 1976, с.272.
1351 Домогацких, 1962, с.14.
1352 Parenti M. Friendly feudalism . . .
1353 Богословский и др., 1975.
1354 Panchen Lama, 1997, p.49–50.
1355 Panchen Lama, 1997, p.54–55.
1356 Tibet Under Chinese, 1976, p.56.
1357 Ely M. The true story . . .
1358 Puntshok, 1998, p.22–26.
1359 Smith, 2008.
1360 Panchen Lama, 1997, p.50–51.
1361 Тибет: правда, 1993.
1362 Tibet Under Chinese, 1976, p.80; Smith, 2008, p.116; Smith W. Congressional panel . . .
1363 Богословский, 1978.
1364 Panchen Lama, 1997, p.56–57.
1365 Энд ч, доор ч: “chaodu ёслол” – “bar do thos sgrol” бичвэрийн Түвд нэрийг хятад галиг (“Бардо Тодол” – “Сүнс зайлах үед бие чөлөөлөгдөхөд зориулсан уншлага”). Орост үүнийг “түвдийн үхэгсдийн хойноос унших уншлага” хэмээн нэрлэдэг юм.
1366 Panchen Lama, 1997, p.57–58.
1367 Panchen Lama, 1997.
1368 Panchen Lama, 1997, p.65–66.
1369 Puntshok, 1998.
1370 Тибет: правда, 1993.
1371 Үүнээс хорин таван жилийн өмнө иймэрхүү үг,хэллэгийг БНМАУ-д огт хэрэглэхээ больсныг тэмдэглэх хэрэгтэй.

1372 Puntshok, 1998, p.24.
1373 Тэр үеийн бээжинд орос хэлээр гардаг ном,хэвлэлд “маозэдунүзэл” хэмээх үг газар сайгүй тааралддаг байсан юм (жишээ нь Великая пролетарская культурная революция, 1970 он, 40, 41 ,47, 70, 96-р хуудас). Маш сайн орчуулга болсон учир энэ үгийг “Маозэдуны үзэл” хэмээх нэр томьёонй оронд хэрэглэж болно.
1374 Panchen Lama, 1997, p.69–70.
1375 Тибет: правда, 1993.
1376 Национальная районная автономия . . .
1377 Богословский, 1978.
1378 Barnett, 1997, p.xix–xx.
1379 Shakya, 1999, p.290.
1380 Мао, 1966, с. 269.
1381 Мао Цзэдун. К вопросу о правильном разрешении . . .
1382 Богословский, 1978.
1383 Kolas, Thowsen, 2005, p.47.
1384 Богословский, 1996, с. 275.
1385 Богословский, 1978.
1386 Shakya, 1999, p.294–296.
1387 Далай-лама, 1992, с.234.
1388 Norbu, 1999.
1389 Shakya, 1999, p.298–299.
1390 Богословский, 1978.
1391 Тибетский вопрос . . .
1392 Tibet: 1950–1967. 1968, p.512.
1393 Shakya, 1999, p.300.
1394 Богословский, 1978.
1395 Кычанов, Мельниченко, 2005.
1396 Shakya, 1999, p.306.
1397 Tibet: 1950–1967. 1968, p.493, 518.
1398 Shakya, 1999, p.304.
1399 Тибет: правда, 1993.
1400 Намкай Норбу, 2008, с.200–208.
1401 Далай-лама, 1995, с.24.
1402 Богословский, 1978.
1403 Van Walt, 1987.
1404 Taklha, 2001, p.92.
1405 Van Walt, 1987.
1406 Далай-лама, 1992, с. 182.
1407 Богословский, 1976, 1978.
1408 Panchen Lama, 1997, p.98.
1409 Кычанов, Мельниченко, 2005, с. 278.
1410 Национальная районная автономия . . .
1411 Ran, 1991.
1412 О тибетском вопросе, 1959.
1413 Овчинников, 2004, 2007.
1414 Овчинников, 2006, с.95.
1415 Клинов, 2000, с.323.
1416 Богословский, 1978, с.82.
1417 Рахимов, 1968, с.72.
1418 Юн Чжан, Холлидей, 2007, с.481.

1419 О тибетском вопросе, 1959, с.67.
1420 Тибет: правда, 1993.
1421 Ильин, 1978.
1422 1957 оны гуравдугаар сарын10-нд сэтгүүлчид болон хэвлэлийн газрынхантай уулзахдаа Мао Зэдуны хэлсэн үгнээс.
1423 Браун, 1974.

**Бүлэг 9. Аугаа их пролетарийн соёлын хувьсгал. Маогийн үеийн үр дүн**

1424 Горбунова, 2008, с.144.
1425 Богословский, 1978.
1426 ХКН-ын Төв хорооны ажлын зөвлөлгөөн дээр аравдугаар сарын 25-нд хэлсэн үгнээс. номонд: О чем умалчивают в Пекине, 1972, с.55.
1427 Великая пролетарская культурная революция, 1970, с.108.
1428 номонд: Идейно-политическая сущность маоизма, 1977.
1429 Shakya, 1999, p.316.
1430 Богословский, 1978.
1431 Кычанов, Мельниченко, 2005.
1432 Shakya, 1999, p.317.
1433 Богословский, 1978.
1434 зураг: Woeser, 2006, p.196.
1435 Горбунова, 2008, с. 145.
1436 Ho, 2006, p.67.
1437 Усов, 2006, с. 50–52.
1438 Юн Чжан, Холлидэй, 2007.
1439 Маоизм без прикрас, 1980, с.202.
1440 Идейно-политическая сущность маоизма, 1977.
1441 Маоистская библиотека . . .
1442 Tibet: 1950–1967. 1968, p.606.
1443 Smith, 2008, p.123–125.
1444 Smith, 2008, p.125–131.
1445 Френч, 2004, с. 273–285.
1446 Smith, 2008, p.131.
1447 Laird, 2006, p.40–41.
1448 Френч, 2004, с. 283.
1449 Wren, 1983.
1450 Smith, 2008, p.129–132.
1451 Laird, 2006, p.346.
1452 номонд: Shakya, 1999, p.320–321.
1453 Shakya, 1999, p.512.
1454 Ho, 2006, p.68.
1455 Ho, 2006, p.69–71.
1456 Маоизм без прикрас, 1980, с.203–204.
1457 Великая пролетарская культурная революция, 1970, с.30–31.
1458 Маоистская библиотека . . .
1459 Мао, 1966, с.54.
1460 Smith, 2008, p.129–130.
1461 Френч, 2004.
1462 Tibet Under Chinese, 1976, p.178.
1463 Kalovski I. The true face . . .
1464 Tibet Under Chinese, 1976, p.162.

1465 Богословский, 1996.
1466 Френч, 2004.
1467 Norbu, 1999, p. 275; Tibet: 1950–1967. 1968, p.607.
1468 Френч, 2004.
1469 Shakya, 1999, p.322.
1470 His Holiness the Panchen Lama . . . .
1471 Hilton, 1999, p.162 — номонд: Гарри (в печати).
1472 Thinley, 1996, p.21–24.
1473 Френч, 2004.
1474 Френч, 2004.
1475 Palden Gyatso, 1997, p.135–137; Tenpa Soepa, 2008, p.117–120.
1476 Tenpa Soepa, 2008, p.112–116.
1477 Palden Gyatso, 1997, p.127–128.
1478 Великая пролетарская культурная революция, 1970, с.40.
1479 Smith, 1996, p.561.
1480 Tsering, 1985, p.14–15.
1481 Тибет: правда, 1993.
1482 Butterfield, 1979.
1483 Цыбиков, 1981, с. 166.
1484 Tibet 2002.
1485 Norbu, 1999.
1486 Левин Г.Г. Рунические надписи . . .
1487 Тибет глазами тибетцев, 1995, p.14.
1488 Panchen Lama X. The Panchen Lama's Last Speech . . .
1489 Tibet: 1950–1967. 1968, p.609.
1490 The lost kingdom of Guge . . .
1491 Govinda, 2002, p.153–183.
1492 Patt, 1992 — номонд: Knuth, 2003, p.219.
1493 Knuth, 2003, p.220, incl. in Kewley, 1990, Aldridge, 1999, Harrer, 1985 etc.; Лотосовая роща великих таинств . . .
1494 Smith, 2008, p.126.
1495 Smith, 2008.
1496 Smith, 2008.
1497 Конгресс США . . .
1498 Smith, 2008, p.114, 545.
1499 Ribhur Tulku, 1988, p.1–12.
1500 Smith, 2008, p.116–117.
1501 Ribhur Tulku, 1988.
1502 Smith, 2008, p.116–117.
1503 Wren, 1983.
1504 Laird, 2006.
1505 Smith, 2008, p.117.
1506 Тибет глазами русских . . .
1507 Френч, 2004.
1508 Великая пролетарская культурная революция, 1970, с.245.
1509 Goldstein et al., 2009.
1510 Goldstein et al., 2009.
1511 Founding of Tibet's "Revolutionary Rebels" Red Guards, December 1966 — Kalovski I. The true face . . .
1512 Великая пролетарская культурная революция, 1970, с. 149–150.

1513 Богословский, 1978.
1514 Богословский, 1978; Goldstein et al., 2009.
1515 Shakya, 1999, p.328.
1516 Goldstein et al., 2009.
1517 Богословский, 1978.
1518 Богословский, 1978.
1519 Goldstein et al., 2009.
1520 Shakya, 1999, p.336–337.
1521 Богословский, 1978.
1522 Shakya, 1999, p.341.
1523 Goldstein et al., 2009.
1524 Tibet Under Chinese, 1976, p.123.
1525 Goldstein et al., 2009.
1526 Богословский, 1978.
1527 Goldstein et al., 2009, p. 52–57.
1528 Van Walt, 1987.
1529 Богословский, 1978.
1530 Goldstein et al., 2009, p.90–91.
1531 Goldstein et al., 2009, p.64, 172–181.
1532 Smith, 1994, p.68.
1533 Goldstein, 1994, p.94–95.
1534 Куртуэ и др. Черная книга коммунизма . . .
1535 Богословский, 1978.
1536 Shakya, 1999, p.308–310.
1537 Tibet: a Human Development, 2007.
1538 Tenpa Soepa, 2008, p.132–133.
1539 Тибет: правда, 1993.
1540 Shakya, 1999, p.311.
1541 Домогацких, 1962, с. 168–170.
1542 Богословский, 1978.
1543 Китайская Народная Республика в 1974 г., 1977.
1544 Богословский, 1996; Tenpa Soepa, 2008, p.133–134.
1545 Tibet Under Chinese, 1976.
1546 Богословский, 1978.
1547 Богословский, 1978.
1548 Феодал-хамжлагын баыгуу”ллын мөн чанар.
1549 Түвд коммунист хятадын мэдэлд, 2001.
1550 “Долой новых царей!” . . .
1551 1969 оны гуравдугаар сар. Зөвлөлтийн цэргийн албан хаагчдын хохирол. http://www.damanski-zhenbao.ru/.
1552 Tibet Under Chinese, 1976, p.124.
1553 Shakya, 1999, p.376.
1554 Богословский и др., 1975.
1555 Жэньминь жибао, 16.11.1977 — номонд: Богословский, 1996, с.8.
1556 Кычанов, Мельниченко, 2005.
1557 Кычанов, Мельниченко, 2005.
1558 Smith, 2008.
1559 Blondeau, Buffetrille, 2008, p.227–228.
1560 Богословский и др., 1975; Богословский, 1978.
1561 Hsin, 1972, p.22.

1562 Китайская Народная Республика в 1975 г., 1978.
1563 Рахимов, Богословский, 1971, с.142–148.
1564 Юрков, 1981, с. 4.
1565 Ван Мин, 1975.
1566 Тихвинский, 1979, с. 196–198.
1567 Китайская Народная Республика в 1974 г., 1977.
1568 Shakya, 1999.
1569 Богословский, 1978.
1570 Goldstein et al., 2009; Shakya, 1999; Shakya Ts. Blood in the snows . . .
1571 Кычанов, Мельниченко, 2005.
1572 Богословский, 1978.
1573 Богословский, 1978.
1574 Богословский и др. 1975.
1575 Khetsun, 2008.
1576 Богословский и др., 1975.
1577 Кычанов, Мельниченко, 2005.
1578 Маоизм без прикрас, 1980, с.218.
1579 Shakya, 1999, p.516.
1580 Дополнительный протокол . . .
1581 Колосков, 1977, с.210.
1582 Questions pertaining to Tibet . . .
1583 Строкань С. “Самый живой Будда” . . .
1584 Smith, 1996.
1585 Great Changes, 1972, etc.; Френч, 2004, с.373.
1586 Ильин, 1978.
1587 Schrei J.M. A lie repeated . . .
1588 Тибет: правда, 1993.
1589 Baker M. 2007.
1590 Поборник мира . . .
1591 Мао, 1966, с.121.
1592 Рахманин, 2005, с.118–119.
1593 Зубок, 2001 (1), с.118.
1594 Мао Цзэдун. О Дэн Сяопине . . .
1595 Sautman B. How repressive . . . ; The myth of Tibet . . .
1596 “Түвдийн ард түмний эрх ашгийг илэрхийлэгч”.
1597 Жэньмин Жибоа, 10, 11. 1959—цит. по; Тибет; правда, 1993
1598 People’s Republic of China State . . .
1599 1955 онд түвдийн өөртөө засах хэд хэдэн нэгжийн хэлбэрээр Сычуань мужид нэгтгэв.
1600 Ишлэл авч буй эх сурвалжид 1675534 биш харин 1676534 гэж бичжээ, гэхдээ энд Ганьсу мужийг оруулаагүй байна.
1601 6330567 биш.
1602 Department of Population
1603 Козлов, 1923, с.413.
1604 Sautman, 2008, p.240.
1605 Bell, 1992.
1606 Козлов, 2004, с.35.
1607 Secret: CTC releases documents . . .
1608 Yan Hao, 2000, p.14.
1609 Yan Hao, 2000.
1610 Китай: Тибет — факты и цифры 2005 . . .

1611 Shakya, 1999, p.504.
1612 Sautman, 2008, p.240.
1613 Тибет: правда, 1993.
1614 Review: Sautman, 2008, p.238.
1615 Френч, 2004, c.408–414; French, 2008.
1616 The population atlas of China, 1987 — номонд: Norbu, 2003, p.612.
1617 См. обзор: Source list . . .
1618 Ильин, 1978.
1619 Yan Hao, 2000.
1620 Чжан Тяньлу, Чжан Мэй, 1993 — номонд: Yan Hao, 2000.
1621 Sautman, 2008, p.241–242.
1622 Becker, 1996, Blondeau, Buffetrille, 2008, p.89.
1623 His Holiness the Panchen Lama . . .
1624 Panchen Lama, 1997, p.xv-xvi.
1625 Parenti M. Friendly feudalism . . .
1626 Sautman, 2008, p.245–246.
1627 Юн Чжан, Холлидей, 2007.
1628 Усов, 2006, c.65.
1629 Усов, 2006, c.57.
1630 Кузнецов, 2006.
1631 Усов, 2006, c.150.
1632 Куртуэ С. и др. Черная книга коммунизма . . .
1633 Горбунова, 2008, c.148.
1634 Юн Чжан, Холлидей, 2007.
1635 Усов, 2006.
1636 Усов, 2006, c.60–64; Девять комментариев, 2005, c.32.
1637 Френч, 2004.
1638 Blondeau, Buffetrille, 2008, p.73.
1639 Bache. 50 years of turmoil . . .
1640 Усов, 2006, c.147.
1641 The Eight White Ordon . . .
1642 The Eight White Ordon . . .
1643 Пирман К. Невежество . . .
1644 Юн Чжан, Холлидей, 2007.
1645 Куртуэ С. ба бусад. Коммунизмын хар ном.
1646 Усов, 2003.
1647 Лукин А. Картина мира . . .
1648 Norbu, 1999, p.189.
1649 Юн Чжан, Холлидей, 2007.
1650 Юн Чжан, Холлидей, 2007, c.576 etc.
1651 Организация Объединенных Наций . . .
1652 Tibet and the Chinese People's Republic, 1960, p.3, 13–14.

### Бүлэг 10. Сэргээн босголт ба шинэчлэл

1653 Hu Jintao Full Text of Speech . . .
1654 XIII всекитайский съезд, 1988, c.63.
1655 Великая пролетарская культурная революция, 1970, c.20.
1656 Мао Цзэдун. Выступления и статьи . . .
1657 О торговом балансе…; О торгово-экономических отношениях . . . ; Степень зависимости…

1658 Решение по некоторым вопросам, 1981, с.34, 58–59.
1659 Юн Чжан, Холлидей, 2007, с.631.
1660 Устав Коммунистической партии . . .
1661 Современный Китай . . .
1662 Устав Коммунистической партии . . .
1663 Цзян Цзэминь, 2004, с.567.
1664 Tenpa Soepa, 2008, p.127.
1665 Гарри (в печати).
1666 Далай-лама, 2000; Shakya, 1999, p.382.
1667 Smith, 1996, p.568.
1668 Smith, 1996, p.569.
1669 Богословский, 1996.
1670 Национальная районная автономия . . .
1671 Smith, 1996, p.582–583.
1672 Shakya, 2002.
1673 Karmel S.M. Ethnic tension . . .
1674 Shakya, 1999.
1675 His Holiness the Panchen Lama's Warning to China . . .
1676 Tibet 2002.
1677 Tibet 2002.
1678 ChinaVitae: Raidi . . .
1679 Цас мөсний орон дахь луу . . . .
1680 Тибет под властью коммунистического Китая, 2001.
1681 Андреев, 2006а, с. 398.
1682 Кычанов, Мельниченко, 2005.
1683 Gyalo Thondup reconfirms Deng Xiaoping's offer . . .
1684 Далай-лама, 1992, с. 230–231.
1685 Smith, 1996, p.567.
1686 Далай-лама, 1992, с. 230–231.
1687 Тибет: правда, 1993; Tibet 2002.
1688 Кычанов, Мельниченко, 2005.
1689 Song, 2007, p.41.
1690Хэлэлцээ ба хагалан бутаргах үйл ажиллагаа.
1691 Буюу "феодал-боол эзэмших систем" үү? Зарим тушмэд феодалын болон боол эзэмших байгууллыг андуурдаг юм, түүхэн материализмыг мэдэх ёстой билээ.
1692 Song, 2007, p.42.
1693 Worldwide Tibet Movement . . .
1690Хэлэлцээ ба хагалан бутаргах үйл ажиллагаа.
1691 Буюу "феодал-боол эзэмших систем" үү? Зарим тушмэд феодалын болон боол эзэмших байгууллыг андуурдаг юм, түүхэн материализмыг мэдэх ёстой билээ.
1692 Song, 2007, p.42.
1693 Worldwide Tibet Movement . . .
1694 Далай-лама, 1992, с.248.
1695 Далай-лама. Страсбургское предложение . . .
1696 Далай-лама, 1991.
1697 Биография Его Святейшества Далай-ламы . . .
1698 Переговоры или раскольническая деятельность . . .
1699 Тибет: правда, 1993.
1700 Tibetan exile monasteries . . .
1701 Decision of History, 2008, p.3.

1702 Tibetan Youth Congress . . .
1703 Политика Срединного пути, 2007.
1704 Тибет: правда, 1993.
1705 Кычанов, Мельниченко, 2005.
1706 Тибет: правда, 1993.
1707 The New Times, 2008.
1708 Тибет: правда, 1993; Smith, 1996, p.617.
1709 Events in Lhasa March 2nd-10th 1989, Tang Daxian, London: TIN, 1990, June 15 — номонд: Тибет: правда, 1993.
1710 Поборник мира или вдохновитель беспорядков . . .
1711 Тибет: правда, 1993.
1712 Marshall, 1999, p.6 — номонд: Тибет под властью коммунистического Китая, 2001.
1713 Behind bars: prison conditions in Tibet . . .
1714 Atmosphere of "martial law" . . .
1715 A Tibetan arrested in Lithang . . .
1716 Об этой проблеме см. ниже.
1717 Human Rights Situation in Tibet: Annual Report 2007; Никольский В. В провинции Сычуань . . .
1718 Uprising in Tibet 2008 . . .
1719 Memorandum from the Tibetan Muslim . . .
1720 Сканави А. Крутой поворот . . .
1721 Chinese regime . . .
1722 Tibet riots orchestrated . . .
1723 Закулисная сторона . . .
1724 Путешествие француза в Тибет . . .
1725 Woeser Ts. A record . . .
1726 Путешествие француза в Тибет . . .
1727 Uprising in Tibet 2008, p.103.
1728 China's midnight deadline . . .
1729 Письмо из Лхасы . . .
1730 China arrest over 572 monks . . . ; Никольский В. Китайские власти . . .
1731 Human Rights Situation in Tibet: Annual Report 2008, p.21–30.
1732 Human Rights Situation in Tibet: Annual Report 2008, p.102–104.
1733 Полный Human Rights Situation in Tibet: Annual Report 2008, p.117–118.
1734 Правоохранительные органы Китая . . . Өөр эх сурвалжид орсон мэдээллүүд (www.phayul.com) зөрөөтэй байна: 176 буу, 130143 сум, 19000 тэсрэх бөмбөг, 7725 фунт [1 фунт нь 409,5 граммтай тэнцэнэ] тэсрэх бодис, хоёр гранат, 350 чинжаал хутга.
1735 В ряде монастырей . . .
1736 Никольский В. Трое тибетских монахов арестованы . . .
1737 Human Rights Situation in Tibet: Annual Report 2008.
1738 Освобождены более тысячи участников беспорядков . . .
1739 Никольский В. Трое тибетских монахов . . .
1740 Никольский В. TCHRD . . .
1741 Обвиняемый в поджогах . . .
1742 Human Rights Situation in Tibet: Annual Report, 2008, p.92.
1743 Габуев, 2008; Тибетские коммунисты . . .
1744 Никольский В. Служащим госучреждений . . .
1745 Фан-портал . . .
1746Никольский В. Суд оправдал немецкого аспиранта . . .
1747 В Китае издана книга . . .

1748 В Пекине открылась гала-выставка . . .
1749 Домогацких, 1962, с.44.
1750 Түвд зохиолч эмэгтэй.
1751 China: 20th Century . . .
1752 См., напр.: Тибетка — бывшая крепостная . . .
1753 В свете истины: дружеские отношения . . .
1754 Nichols S. Malware writers target . . . ; Cyber attacks target . . .
1755 Китайские агенты . . .
1756 Эх, "Свобода" . . .
1757 МОК отменил . . .
1758 Тибетский вопрос . . .
1759 Переговоры или раскольническая деятельность . . .
1760 Переговоры или раскольническая деятельность . . .
1761 Никольский В. Тибетское правительство . . .
1762 Никольский В. В Кардзе . . .
1763 Никольский В. В Лхасе . . .
1764 Никольский В. Пекинское руководство . . . ; Никольский В. SCMP . . .
1765 А.С. Путешествие в мятежный Тибет . . .
1766 Китаев С. Гуравдугаар сарын 28- Түвдийн шинэ баяр.
1767 Интернетэд хятадын анхны сайт нээгдэв.
1768 Никольский В. За фасадом . . .
1769 Заявление Его Святейшества Далай-ламы по случаю 50-й годовщины . . .
1770 А.С. Путешествие в мятежный Тибет . . .
1771 Woeser, 2008.
1772 Китаев С. Конфликт в Тибете . . .

1773 Монгольская Народная Республика, 1952; О тибетском вопросе, 1959, с.205–246.
1774 Гетц, Розенбах, 2009.
1775 Хольц К.А. Все эксперты . . .
1776 Френч, 2004.
1777 Новый прогресс в защите прав человека . . . , 1998.
1778 Prisoners of Tibet, 2006.
1779 Torture in Tibet, 2000.
1780 Behind bars . . . энэ бол: "гэм буруугаа хүлээсэн хүмүүст хүлцэнгүй зөөлөн, харин эсэргүүцсэн этгээдүүдэд хатуу чанга ханд" хэмээх Мао Зэдуны хэлэх дуртай үг.— номонд: Великая пролетарская культурная революция, 1970, с.51.
1781 Torture in Tibet, 2000.
1782 Тибет: правда, 1993.
1783 Kuxing: Torture in Tibet . . .
1784 Kuxing: Torture in Tibet . . .
1785 Behind bars: prison conditions in Tibet . . .
1786 Тибет: правда, 1993.
1787 Behind bars: prison conditions in Tibet . . .
1788 Kuxing: Torture in Tibet . . .
1789 Дүүрэн устай данх толгой дээр нь тавьж "цалгиулахгүй" зогсоох эрүү шүүлтийг янз бүрийн хэлбэрээр хэрэглэдэг, бас нүүрээр нь халуун нар руу харуулж суулгаад олон цаг байлгах арга хэрэглэж болох ажээ (Tibetan Envoy, 2003, no. 7, p.5).
1790 Tales on terror, 1999.
1791 Torture in Tibet, 2000; Tibet 2002.
1792 Комментарий от 25.03.2008 . . .

1793 Френч, 2004.
1794 Никольский В. Активисты из Британии и США . . .
1795 Annual Report 2001.
1796 Tibet: a human development . . . ; Behind bars . . .
1797 Тибет: правда, 1993.
1798 Tibet 2002.
1799 Annual Report 2001.
1800 Tibet 2002.
1801 Dangerous Crossing, 2003.
1802 Annual Report 2001
1803 Annual Report 2001.
1804 Dangerous Crossing, 2006; Chinas massacre in Tibet . . . ; Западные альпинисты . . .
1805 Dangerous Crossing, 2004.
1806 Annual Report 2001.
1807 Dangerous Crossing, 2006.
1808 Annual Report 2001.
1809 Dangerous Crossing, 2005.
1810 Dangerous Crossing, 2006.
1811 Roy, 2008; http://www.cpnm.org.
1812 Подробнее см.: Маоисты в Непале . . .
1813 Туристы и маоисты . . .
1814 Prachanda defends Chinese crackdown . . .
1815 Китай и Непал . . .
1816 США объявили о внесении корректировок . . .
1817 "The Himalayan" IV 2009.
1818 Никольский В. Комсомольцы-маоисты . . .
1819 Никольский В. В Катманду непальские полицейские . . .
1820 Никольский В. Министр внутренних дел Непала . . .
1821 Struggling for influence in Nepal . . .
1822 Мао, 1966, с. 72.
1823 Butterfield, 1979.
1824 Тибет глазами тибетцев, 1995, с. 14.
1825 Ribhur Tulku, 1988.
1826 Тибетский вопрос . . .
1827 В Тибете в 2008 г . . .
1828 Никольский В XIV Далай ламын эх оронд . . .
1829 Тибет: правда, 1993.
1830 A Sea of Bitterness, 1999, p.41–45.
1831 Тибет: правда, 1993.
1832 China-Tibet . . .
1833 Shakya Ts. Tibetan questions . . .
1834 Түвдийн тухай товчхон: шашин ба сүсэг бишрэл . . . ; Китай: Тибет — цифры и факты 2006 . . .
1835 Butt, 1994.
1836 Fifth International Conference, 2008, p.195.
1837 Религия и национальная самобытность . . .
1838 Москалев, 2004, с. 274–283.
1839 Современная политика, 2000, с. 12; Андреев, 2006а, с.398
1840 Тибет: правда, 1993; Тибет под властью коммунистического Китая, 2001; China launches education . . .

1841 Тибет: правда, 1993.
1842 Religious persecution . . .
1843 Annual Report 2001.
1844 China's Tibet, 2000 — номонд: Кычанов, Мельниченко, 2005, с. 301; Белая книга: в Тибете охраняются . . .
1845 A Sea of Bitterness, 1999.
1846 Human Rights Situation in Tibet: Annual Report 2008, p.95.
1847 Religious persecution . . .
1848 "Patriotic Re-education" . . .
1849 Троянский конь из Поднебесной . . .
1850 Nationalities and Religious Bureau . . .
1851 Тибет: правда, 1993.
1852 Китай: Тибет — цифры и факты 2006 . . .
1853 Human Rights Situation in Tibet: Annual report 2001.
1854 Kumbum's Song, 1998, p.1.
1855 Современная политика, 2000.
1856 Chinese authorities closes down Pangsa . . .
1857 Fifth International Conference, 2008, p.195.
1858 Destruction of Serthar Institute . . .
1859 Khenpo Jigme Phuntsok . . .
1860 О религиозной свободе в Тибете . . .
1861 В Тибете разрушена статуя . . .
1862 Potala palace desecrated, p.6.
1863 Mass transportation, 2003, p. 24.
1864 Национальная районная автономия . . .
1865 Fifty years in Tibet . . .
1866 Китай: Тибет — цифры и факты 2006 . . . ; "Тибетский вопрос" не является религиозным вопросом . . .
1867 Severe religious restrictions . . .
1868 Кармапа XVII бежал из Тибета, 2000, с.50–57.
1869 Гарма кагью чиглэлийг баримтлагчдын зарим хэсэг Шамар ринбүүчийн тодруулсан өөр хүнийг Кармапа хэмээн үздэг юм.
1870 Кончина Панчена X . . .
1871 Английский перевод: Panchen Lama X. The Panchen Lama's Last Speech . . .
1872 Кончина Панчена X . . .
1873 Кончина Панчена X . . .
1874 Шесть лет поисков . . .
1875 Шесть лет поисков . . .
1876 XI Панчен-лама, 1999.
1877 Tibet 2002 . . .
1878 XI Панчен-лама, 1999.
1879 Далайн санал болгосон нэр дэвшигч . . . .
1880 Sperling, 2004.
1881 Овчинников, 2006, с.80.
1882 XI Панчен-лама . . .
1883 Кандидатура со стороны Далая . . .
1884 Речь Ли Жуйхуаня . . .
1885 Шесть лет поисков . . .
1886 Жеребьевка из золотой вазы . . .
1887 Буддизм России № 24–25, 1995–1996.

1888 Интронизация Панчена XI . . .
1889 Tibet 2002 . . .
1890 XI Панчен-лама . . .
1891 Френч, 2004.
1892 Заезжий. Почему взбунтовались тибетцы . . .
1893 Re-education in Kan Lho, 1996, p.2.
1894 1996: The year in Tibet . . .
1895 Tibetan religious leaders, 1995, p.10.
1896 Приказ № 5 . . .
1896a Joint Statement to repudiate . . . ; Statement of the department of Religion and Culture . . .
1897 Tibet: a Human Development, 2007.
1898 Аюшеева, 1986.
1899 Далай-лама, 2001.
1900 Качинс, 2007, с.61–71.
1901 Договор о добрососедстве . . .
1902 Совместная Декларация . . .
1903 Препятствий для визита Далай-ламы в Россию нет . . .
1904 Кузнецов, 2006, с.303.
1905 Интерес Китайской Народной Республики, 2007.
1906 Китай — Россия, 2005.
1907 Ларин, 2005.
1908 Глазунов, 2008; Китайский военный шпионаж . . . ; Китай наладил . . .
1909 Воскресенский, 1994.
1910 Воскресенский, 1994
1911 Глазунов, 2008, с. 207; Ивашов Л.Г. Война . . .
1912 Храмчихин А.А. Угроза . . . ; Шаравин А. Россия и Америка . . .
1913 Цянь, 2003.
1914 Храмчихин А.А. Миллионы солдат . . .
1915 Интерес Китайской Народной Республики, 2007.
1916 Саммит ШОС . . .
1917 ШОС, 2008.
1918 2006 он: Лукин, 2007, с.72–92.
1919 Китайские группы влияния, 2006.
1920 Интерес Китайской Народной Республики, 2007.
1921 Китай — Россия, 2005.
1922 Мы ездили в Бурятию . . .
1923 Одели, 2005, с.264–265.
1924 Fan, 2009.
1925 Мы ездили в Бурятию . . .
1926 Кузнецов, 2006.
1927 Human Rights Situation in Tibet: Annual Report 2008, p.84.
1928 Жиронкина Ю. Далай-лама возлагает надежды . . .
1929 Национальная районная автономия . . .
1930 Тибет: правда, 1993.
1931 Автономия в политическом аспекте . . .
1932 Автономия в политическом аспекте . . .
1933 Москалев, 2004.
1934 Москалев, 2004, с.278.
1935 Цзян Цзэминь, 2004, с.212.
1936 China’s Population, 1988.

1937 Тибет под властью коммунистического Китая, 2001, с.27.
1938 Strangers, 1997.
1939 Tibet 2002.
1940 Национальная районная автономия . . .
1941 Strangers, 1997.
1942 Tibet 2002.
1943 Далай-лама, 1992.
1944 Тибет под властью коммунистического Китая, 2001.
1945 В прошлом году . . .
1946 Chinese migrants . . .
1947 China's Train, 2009, p.60–61.
1948 Пассажирооборот . . .
1949 За 2 года . . .
1950 Tibet: a Human Development, 2007.
1951 Tibet: a Human Development, 2007.
1952 Запрещенный Тибет: путеводитель . . .
1953 Tibet: a Human Development, 2007.
1954 Домогацких, 1962, с.11.
1955 Tibet: a Human Development, 2007.
1956 Ma Rong, 1993, p.268–277.
1957 Jarrah, 2002, p.13–17.
1958 Tibetan blasts . . .
1959 Заезжий. Почему взбунтовались тибетцы . . .
1960 Tibet: a Human Development, 2007.
1961 Ma Rong, 1993, p.268–277.
1962 Blondeau, Buffetrille, 2008, p.222.
1963 Современная политика, 2000, с.16.
1964 Tibet 2002.
1965 Запрещенный Тибет . . .
1966 Tibet 2002.
1967 Администрация Лхасы . . .
1968 Коротко о Тибете: население и народности . . .
1969 Yan Hao, 2000.
1970 Тибет под властью коммунистического Китая, 2001.
1971 Birth control, 1996, p.2.
1972 Strangers, 1997
1973 Тибет под властью коммунистического Китая, 2001.
1974 Human Rights Situation in Tibet: Annual Report 2001; Chinese birth control, 2001, p.5.
1975 The status of Tibetan women . . .
1976 Human Rights Situation in Tibet: Annual Report 2001.
1977 Chinese birth control . . .
1978 Tibet Statistical Yearbook 2002 — Tibet: the gap . . .
1979 Комментарий: Высказывание клики . . .
1980 Тибет: правда, 1993.
1981 Ильин, 1978.
1982 Тибет: правда, 1993.
1983 Современная политика, 2000, с.20.
1984 Китай: Тибет — цифры и факты 2006 . . .
1985 Развитие тибетского языка . . .
1986 Заезжий. Почему взбунтовались тибетцы . . .

1987 Shakya Ts. Tibetan questions . . .
1988 Меринов, 2003.
1989 Ломанов А. Будда из золотой вазы . . .
1990 Shakya Ts. Tibetan questions . . .
1991 Национальная районная автономия . . .
1992 Tibet: a Human Development, 2007.
1993 Белая книга: в системе образования Тибета . . .
1994 Ломанов А. Будда из золотой вазы . . .
1995 Китайских детей обучат . . .
1996 Арсеньев, 2004.
1997 Human Rights Situation in Tibet: Annual Rreport 2001.
1998 Shakya Ts. Tibetan questions . . .
1999 2,5 тыс. студентов . . .
2000 Кычанов, Мельниченко, 2005.
2001 Национальная районная автономия . . .
2002 Белая книга: в Китае на правовой основе . . .
2003 Powers, 2004, p.93.
2004 Tibet: a Human Development, 2007.
2005 Political veteran, 1998, p.2.
2006 Prostitution, 1995, p.19, 21.
2007 Национальная районная автономия . . .
2008 Tibet: a Human Development, 2007.
2009 Национальная районная автономия . . .
2010 Экологическое строительство . . .
2011 Tibet: a Human Development, 2007.
2012 Тибет: правда, 1993.
2013 International Commission of Jurists Report on Tibet 1997.
2014 His Holiness the Panchen Lama . . .
2015 Кому принадлежит суверенитет . . .
2016 Tibet: a Human Development, 2007.
2017 Ecological improvement . . .
2018 Tibet: a Human Development, 2007.
2019 Радио России, 23.06.2008.
2020 Тибет: правда, 1993.
2021 Tibet: a Human Development, 2007.
2022 Ecological improvement . . .
2023 International Commission . . .
2024 Tibet 2002.
2025 Tibet: a Human Development, 2007.
2026 Tibet: a Human Development, 2007.
2027 Тибет: правда, 1993.
2028 Ecological improvement . . .
2029 Tibet: a hHuman Development, 2007.
2030 Богословский, 1996.
2031 Жэньминь жибао, 25.01.1977 — номонд: Богословский, 1996, с.8.
2032 Богословский, 1996.
2033 Богословский, 1996.
2034 Tibet: a Human Development, 2007.
2035 Tibet: a Human Development, 2007.
2036 Tibet: a Human Development, 2007.

2037 Никольский В. Тибетское плато . . .
2038 Pirie F. Segmentation . . .
2039 Tibet: a Human Development, 2007.
2040 Horlemann B. Modernization efforts . . .
2041 Tibet: a Human Development, 2007.
2042 Кычанов, Мельниченко, 2005.
2043 Перемены в благосостоянии . . .
2044 Темпы роста ВВП . . .
2045 Тибетский вопрос . . .
2046 Сведение о Тибете . . .
2047 Тибет: за годы после начала . . .
2048 Перемены в благосостоянии . . .
2049 Fifth International Conference, 2008, p.184.
2050 Tibet: a Human Development, 2007.
2051 Compulsory unpaid labour . . .
2052 China’s Train, 2009, p.12.
2053 Начато строительство . . .
2054 Tibet 2002.
2055 Рахимов, 1968.
2056 Тибет: правда, 1993.
2057 Тибет: правда, 1993.
2058 Тибет: правда, 1993.
2059 Китай откроет для туристов . . .
2060 В Индии отвергают все притязания . . .
2061 Krishnatry, 2005, p.155.
2062 Another Chinese ‘incursion’ . . .
2063 Shakya, 1999.
2064 Перемены в благосостоянии . . .
2065 Tibet 2002.
2066 Тибет: правда, 1993.
2067 Китайский тибетолог . . .
2068 Tibet to provide housing . . .
2069 26-янв-08 Китайское руководство объявило . . .
2070 His Holiness the Panchen Lama . . .
2071 Путешествие француза в Тибет . . .
2072 “Цзинцзи жибао”: бурное развитие . . .
2073 Быстрое развитие тибетской медицины . . .
2074 Тибетский вопрос . . .
2075 Водораздел между старым . . .
2076 Национальная районная автономия . . .
2077 Blondeau, Buffetrille, 2008, p.106.
2078 Тибет: правда, 1993.
2079 Display of Tibetan flag . . .
2080 Human Rights Situation in Tibet: Annual Report 2001.
2081 Tibet: a Human Development, 2007.
2082 В Тибете выявлены случаи . . .
2083 В Тибете усиливается контроль . . .
2084 Национальная районная автономия . . .
2085 Далай-лама: “Товарищ — это было лицемерие” . . .
2086 Тридцать шесть стратагем. 2000, с.94.

**Бүлэг 11. Түвд орон хятадын салшгүй хэсэг мөн үү?**

2087 Van Walt, 1987, p.93–110.
2088 Духовная культура Китая, 2009, c.163.
2089 Гончаров, 2006, c.100–110.
2090 Духовная культура Китая, 2009, c.162.
2091 Беспрозванных, 2001, c.38–40.
2092 Духовная культура Китая, 2009, c.163.
2093 Намсараева, 2003.
2094 Гончаров, 2006, c.120–121.
2095 "Китайский мировой порядок" . . .
2096 Хенниг, 1961, т. 1, c.434–435.
2097 Намсараева, 2003.
2098 Духовная культура Китая, 2009, c.119.
2099 Конфуций. Беседы и суждения (16, 1) — номонд: Лукьянов, 2005.
2100 номонд: Мартынов, 1978.
2101 Беспрозванных, 2001, c.41.
2102 Van Walt, 1987, p.113.
2103 Van Walt, 1987, p.117.
2104 Van Walt, 1987, p.177.
2105 Тэдний нэрийн өмнөөс баримт бичигт гарын үсэг зурсан орнууд болон хүмүүст учрах аюулын тухай ярьж байна.
2106 Van Walt, 1987, p.183.
2107 Пиков, 2007, c.111–123.
2108 Марко Поло, 1955, c.173.
2109 Pelliot, 1912; Wade, 1999.
2110 Хенниг, 1961–1963.
2111 Гузев В.Г., Творогов О.В. Хин(ова) . . .
2112 Стонтон, 1805; Тимковский, 1824.
2113 A 60-point commentary . . .
2114 Vembu, 2007.
2115 Хронология Китая 3 . . .
2115 Хронология Китая 3 . . .
2116 Gang Zhao, 2006 — номонд: Esherick, 2006, p.232, 254.
2117 Левкин Г.Г. Нийтлэг алдаа.
2118 Laird, 2006, p.45.
2119 Түвдийн тухай товчхон: түүхэн тэмдэглэл.
2120 Лубсан Данзан, 1973, c.49–53.
2121 Удел Могултая . . .
2122 "Юан" гэдэг үг хятад гаралтай, гэхдээ үүнээс болж монгол улс хятад болохгүй. Оросын эзэнт гүрний нийслэлийн нэр "Санкт-Петербург"-бас л орос биш үг бол яахав. Улс хэмээх монгол үг байдаг ч хятадыг оролцуулаад дэлхийн томоохон улсуудыг "эзэнт гүрэн" хэмээн нэрлэж байжээ.
2123 Дмитриев, 2009.
2124 Далай, 1977, c.325.
2125 Ганболд и др., 2006.
2126 Ганболд и др., 2006, c.20–21.
2127 Далай, 1977, c.324.
2128 Храпачевский, 2004.
2129 Farquhar, 1981.
2130 Langlois J.D., Jr., 1981, p.137–185.

2131 Вернадский, 2000.
2132 Духовная культура Китая, 2009, с.684–685.
2133 Chan, 1981, p.56–106.
2134 Лубсан Данзан, 1973, с.243–246.
2135 Удел Могултая . . .
2136 Законы великой династии Мин, 2002, ст. 122.
2137 Ланьков А. “Мандат Неба” . . .
2138 Левкин Г.Г. Типичные ошибки . . .
2139 Удел Могултая . . .
2140 Пучковский, 1963.
2141 Терентьев А. “Позвольте возразить” . . .
2142 Kolmas, 1967.
2143 Гончаров, 2006, с.136–137.
2144 Мартынов, 1978, с.48
2145 Удел Могултая . . .
2146 List of tributaries . . .
2147 Сладковский, 1979, с.166.
2148 Гончаров, 2006, с.136–137.
2149 Тихвинский, 1979, с.206.
2150 Непомнин, 2005, с.32.
2151 Мартынов, 1978.
2152 Левкин Г.Г. Исторические измышления . . .
2153 Пан, 2007, с.20.
2154 Мартынов, 1978.
2155 Непомнин, 2005, с.35.
2156 Левкин Г.Г. Исторические измышления . . .
2157 Левкин Г.Г. Китай или Маньчжурия . . .
2158 Левкин Г.Г. Китай или Маньчжурия
2159 Непомнин, 2005, с.77–78.
2160 Патрушева, 1981.
2161 Левкин Г.Г. Китай или Маньчжурия . . .
2162 Тихвинский, 1966, с.29.
2163 Непомнин, 2005.
2164 Тихвинский, 1966, с.5–75.
2165 Тихвинский, 1966.
2166 Непомнин, 2005, с. 58–59, 102–104.
2167 Van Walt, 1987.
2168 List of tributaries of Imperial China . . .
2169 Некоторые маньчжурские документы, 1912.
2170 Esherick, 2006, p.232.
2171 Некоторые маньчжурские документы, 1912.
2172 Мартынов, 1978, с.146.
2173 Ивановский, 1888.
2174 История Китая, 1974, с.188–189.
2175 Лу Хуачжу, 1828.
2176 Blondeau, Buffetrille, 2008, p.29.
2177 Беспрозванных, 2001, с. 277.
2178 Малявин, 2000, с. 604.
2179 Духовная культура Китая, 2009, с.166–167.
2180 Намсараева, 2003.

2181 Гончаров, 2006, с.137.
2182 Цзуй цзинь чжи уши нянь (Последние пятьдесят лет), Шанхай, 1923, 1–2. — номонд: Идейно-политическая сущность маоизма, 1977.
2183 Духовная культура Китая, 2009, с.19.
2184 Москалев, 2005.
2185 Синьхайская революция, 1968, с.38, 53.
2186 Сунь Ятсен, 1961, с.113–117.
2187 Сунь Ятсен, 1985, с.110.
2188 Rhoads, 2001, p.68–119.
2189 Непомнин, 2005.
2190 Москалев, 2005.
2191 Сунь Ятсен, 1985, с.121–122.
2192 Духовная культура Китая, 2009, с.22.
2193 Москалев, 2005.
2194 Непомнин, 2005
2195 Сидихменов, 1985, с.288–289.
2196 Сунь Ятсен, 1985, с.112.
2197 Esherick, 2006, p.244.
2198 Москалев, 2005, с.81.
2199 Духовная культура Китая, 2009, с.21.
2200 Сунь Ятсен, 1985, с.637.
2201 Москалев, 2005, с.94.
2202 Shakya, 1999, p.123.
2203 Москалев, 2005.
2204 Jin, 1987
2205 Мао Цзэдун. К вопросу о правильном разрешении . . .
2206 Smith, 1996, p.433–434.
2207 Булдакова В.Г. Национальная политика КНР . . .
2208 Smith, 1996, p.22–23, 438, 439.
2209 Цзян Цзэминь, 2004, с.205.
2210 Клинов, 2000, с.31.
2211 Булдакова В.Г. Национальная политика КНР . . .
2212 Мясников, 1979, с.238.
2213 Пограничная политика КНР . . .
2214 Гуанмин жибао, 10.09.1979 — номонд: Юрков, 1981, с.13.
2215 Храпачевский, 2004.
2216 Мясников, 1979, с.234–235.
2217 Мао, 1948.
2218 Сладковский, 1979, с.165–166.
2219 Мао Цзэдун сысян ваньсуй, 1967 — номонд: Юрков, 1981, с.3.
2220 Рожинцев А. Четыре стороны мира . . .
2221 Юрков, 1981, с.10.
2222 Чжунго лиши диту цзи, 1996.
2223 Юрков, 1981, с.12.
2224 Zhao Suisheng, 2004, p.215–240.
2225 Лукьянов, 2005.
2226 Sperling, 2004.
2227 Намсараева, 2003.
2228 Maps of Tibet, 2008.
2229 Коротко о Тибете: исторический очерк . . .

2230 Беспрозванных, 2001, с.47.
2231 Vembu, 2007.
2232 Ngapo, 1988.
2233 Хятадууд иймгэрээг манай эриний өмнөх 2-р зуунаас байгуулж эхэлжээ.
2234 Юзефович, 2007.
2235 Карамзин, 1989.
2236 Van Walt, 1987.
2237 Van Walt, 1987.
2238 Sperling, 2004; The Mongols and Tibet, 2009.
2239 A 60-point commentary . . .
2240 Коротко о Тибете: исторический очерк . . .
2241 A 60-point commentary . . .
2242 The Mongols and Tibet, 2009, p.34 and map.
2243 Van Walt, 1987.
2244 Шакабпа, 2003
2245 Беспрозванных, 2001, с.116, 299 etc.
2246 Кычанов, Мельниченко, 2005.
2247 Белов, 2005, с. 82.
2248 См.: Laird, 2006, p.170.
2249 Беспрозванных, 2001, с.171.
2250 Беспрозванных, 2001, с.171.
2251 Беспрозванных, 2001, с.167.
2252 Беспрозванных, 2005, с.114–116.
2253 Кычанов, Мельниченко, 2005.
2254 A 60-point commentary . . .
2255 Клинов, 2008, с.41–46.
2256 Намсараева, 2003, с.125.
2257 A 60 point commentary . . .
2258 A 60-point commentary . . .
2259 Намсараева, 2003.
2260 Van Walt, 1987.
2261 Van Walt, 1987.
2262 Goldstein, 2003, p.536.
2263 Bell, 1992, p.215.
2264 Van Walt, 1987, p.32.
2265 “Выразитель интересов тибетского народа” . . .
2266 Van Walt, 1987.
2267 Van Walt, 1987.
2268 Ran, 1991.
2269 Кому принадлежит суверенитет . . .
2270 Van Walt, 1987.
2271 Коротко о Тибете . . .
2272 Левкин Г.Г. Ответы посетителям гостевой книги . . .
2273 Декларация независимости . . .
2274 Van Walt, 1987.
2275 Поддержка спецслужбами США . . .
2276 Клинов, 2000, с.31.
2277 Клинов, 2008, с.41–46.
2278 Клинов, 2000, с.450.
2279 Батсайхан, Кузьмин, 2008, с.68–86; Kuzmin, in press.

2280 Van Walt, 1987.
2281 Van Walt, 1987.
2282 Van Walt, 1987.
2283 Устав Организации Объединенных Наций . . .
2284 Van Walt, 1987, p.154.
2285 Van Walt, 1987, p.153–155.
2286 Van Walt, 1987.
2287 U.N. Doc. A/CONF. 39/27 (1969), 8.I.L.M. 679 (1969). Done at Vienna on 23 May 1969, entered into force on 27 January 1980 — номонд: Van Walt, 2007, p.98.
2288 Van Walt, 1987, p.153.
2289 Van Walt, 1987.
2290 His Holiness's Middle Way Approach . . .
2291 Smith, 1996, p.320.
2292 Song, 2007, p.39–40.
2293 Ширер У. Крах нацистской империи . . .
2294 Van Walt, 1987.
2295 Тибет: правда, 1993.
2296 Session on Tibet: Verdict. — Permanent Tribunal of Peoples. Strasbourg. 1992. 20 Nov., p.15, 23 — номонд: Тибет: правда, 1993.
2297 International Lawyers' Statement on Tibet. London, 1993, 10 Jan., p. 6–8 — номонд: Тибет: правда, 1993.
2298 Van Walt, 1987, p.188.
2299 A 60-point commentary . . .
2300 Духовная культура Китая, 2009, с. 36.
2301 Van Walt, 1987.
2302 Энгельс, 1965, с.317.
2303 Ленин, 1961, с.255–320.
2304 Ленин, 1962, с.18–22.
2305 Устав Коммунистической партии Китая . . .
2306 Албан ёсны шалгуураар Түвдийг бие даасан улс гэж НҮБ хүлээн зөвшөөрөх баттай үндэслэлүүд бий — номонд: Van Walt, 1987; Johnston C. Tibet: the international mistake . . .

**Бүлэг 12. Түвд-монголын соёл иргэншил бөхөж байгаа юу?**

2307 Mao, 1966, с. 62.
2308 Palden Gyatso, 1997, p.13.
2309 Norbu, 1998, p.24–26.
2310 Елихина, 2006.
2311 Галенович, 2005, с.110.
2312 Panchen Lama, 1997, p.69–70, 52.

# Ашигласан ном зохиол


XI Панчен-лама Гедун Чеки Ньима: самый юный политзаключенный в мире. 1999. М.

XIII Всекитайский съезд Коммунистической партии Китая. 1988. М.: Политиздат.

1996: The year in Tibet. — http://www.tchrd.org/publications/hr_updates/1996/hr19961230.html#year_in_tibet. 14.12.2008.

2,5 тыс. студентов примет тибетский вуз. — http://www.km.ru/news/view.asp?id=7A7F038CB0CE4FD4AF6AD1EFE1EC996B. 06.10.2008.

26-янв-08 Китайское руководство объявило о готовящемся в 2008 году переселении 52 тысяч тибетцев. — http://www.tibet.spb.ru/tibet-news/41/. 28.07.2008.

А.С. Путешествие в мятежный Тибет. — http://pressa.irk.ru/number1/2009/16 /029001.html. 26.04.2009.

Автономия в политическом аспекте. — http://russian.china.org.cn/china/archive/Tibet-06/2007–05/16/content_8263222_2.htm. 28.07.2008.

Администрация Лхасы готовится применить комплекс мер для охраны центральной части города. — http://russian.people.com.cn/31516/6639590.html. 17.04.2009.

Александров М.В. 1995. Внешнеполитическая доктрина Сталина. Canberra: Austral. National Univ. — http://grachev62.narod.ru/alexandrov/chapt02.htm. 21.07.2009.

Англо-русский вопрос в Азии и оборона Индии. 1891. — Сб. географических, топографических и статистических материалов по Азии, в. 47.

Андреев А.И. 2006а. Тибет в политике царской, советской и постсоветской России. СПб.: Изд. СПб ун-та–Нартанг.

Андреев А.И. 2006б. Тибет и современное мифотворчество (миф о нацистском оккультизме). — Буддизм России, № 40.

Андреев А.И. 2008. Гималайское братство: теософский миф и его творцы. СПб.: Изд. СПб ун-та.

Андросов В.П. 2006. Учение Нагарджуны о Срединности. М.: Вост. лит.

Арсеньев В.К. 2004. Китайцы в Уссурийском крае. Нансен Ф. В страну будущего. М.: Крафт+.

Аюшеева Д.В. Адаптация тибетского буддизма к современному западному миру. — http://www.sunhome.ru/journal/1986.

Байков Н.А. 1997. Записки заамурца. — Россия в Азии, № 4.

Балакирев Е.В. Миф о человеческих жертвоприношениях. — http://board.buddhist.ru/showpost.php?p=151404&postcount=130. 31.03.2007.

Бадарчи О.С., Дугарсүрэн Ш.Н. 2000. Богд хааны амьдралын он дараалын товчоон. Улаанбаатар: Хаадын сан.

Батсайхан О. 2008. Монголын сүүлчийн Эзэн Хаан VIII Богд Жавзандамба 1911 оны үндэсний хувьсгал. Улаанбаатар: Адмон.

Батсайхан О., Кузьмин С.Л. 2008. Основания современной монгольской государственности. — Олон улс судлал, № 2.

Белая книга: в Китае на правовой основе защищены нормальное отправление религиозного культа и свобода вероисповедания в Тибете. — http://russian.people.com.cn/31521/6506503.html. 09.11.2008.

Белая книга: в системе образования Тибета всесторонне практикуется двуязычное обучение. — http://russian.people.com.cn/31521/6506193.html. 25.09.2008.

Белая книга: в Тибете охраняются культурно-исторические памятники. — http://russian.northeast.cn/system/2008/09/26/000081640.shtml. 15.12.2008.

Белов Е.А. (ред.) 2005. Россия и Тибет. М.: Вост. лит.

Белов Е.А. 1996. Записка подполковника Генерального штаба Хитрово о Далай-ламе и его

деятельности 1906 года. — Восток, № 4.
Белов Е.А. 1999. Россия и Монголия (1911–1919 гг.). М.: Наука.
Беспрозванных Е.Л. 2001. Лидеры Тибета и их роль в тибето-китайских отношениях XVII–XVIII в. Волгоград: Изд-во Волгогр. гос. ун-та. — http://window.edu.ru/window_catalog/files/r25629/volsu196.pdf. 13.06.2009.
Беспрозванных Е.Л. 2005. Тибето-китайские отношения в XVII–XVIII веках. Волгоград: Изд-во Волгогр. гос. ун-та. — http://window.edu.ru/window_catalog/files/r25904/volsu488.pdf. 13.06.2009.
Биография Его Святейшества Далай-ламы. — http://savetibet.ru/dalaj-lama/2005/dalaj-lama-bio.php. 07.06.2009.
Бичурин И. 1833. История Тибета и Хухунора с 2282 г. до Р.Х. до 1227 г. по Р.Х., ч. 1. СПб.: Имп. АН.
Богословский В.А. 1962. Очерк истории тибетского народа (становление классового общества). М.
Богословский В.А. 1976. Ламаистская церковь в Тибете и ее современное положение. — В кн.: Китай: традиции и современность. М.
Богословский В.А. 1978. Тибетский район КНР (1949–1976). М.: Наука.
Богословский В.А. 1996. Тибет после Мао Цзэдуна. М.
Богословский В.А. 2002. Политика XIII Далай-ламы в Тибете. М.: Ин-т востоковед. РАН.
Богословский В.А. и др. 1975. Великодержавная политика маоистов в национальных районах КНР. М.: Политиздат.
Богословский В.А., Москалев А.А. 1984. Национальный вопрос в Китае (1911–1949). М.: Наука.
Борисов О.Б., Колосков Б.Т. 1972. Советско-китайские отношения 1945–1970. Краткий очерк. М.: Мысль.
Браун О. 1974. Китайские записки (1932–1939). М.: Политиздат.
Брюханов В. 2007. Трагедия России. Цареубийство 1 марта 1881 г. М.: КМК.
Будон Ринчендуб. 1999. История буддизма. СПб.: Евразия.
Булдакова В.Г. Национальная политика КНР в отношении малочисленных народов. — http://www.analitika.org/article.php?story=20080702064346733. 02.07.2008.
Быстрое развитие тибетской медицины и фармацевтики за годы проведения политики реформ и открытости в Китае. — http://russian.people.com.cn/31516/6518243.html. 09.11.2008.
В Индии отвергают все притязания Китая на штат Аруначал-Прадеш. — http://news.mail.ru/politics/1600483/. 25.10.2008.
В Интернете открыт первый китайский сайт на тему прав человека в Тибете. — http://russian.people.com.cn/31521/6610161.html. 10.03.2009.
В Китае издана книга по истории освобождения Тибета. — http://newsonchina.ru/china/134. 08.10.2008.
В Пекине открылась гала-выставка “Тибет сегодня и в прошлом”. — http://russian.people.com.cn/31521/6402468.html. 27.07.2008.
В прошлом году Тибет посетили более 4 млн. туристов. — http://www.businessrest.ru/NewsAMShow.asp?ID=428609. 28.07.2008.
В ряде монастырей Ганьнань-Тибетского автономного округа в пров. Ганьсу изъято оружие и боеприпасы. — http://russian.people.com.cn/31516/6393877.html. 01.11.2008.
В свете истины: дружеские отношения между Далай-ламой, нацистами и “Аум Синрике”. — http://russian.people.com.cn/95181/6568166.html. 06.01.2009.
В Тибете в 2008 г. отреставрируют 22 памятника культуры. — http://www.vsesmi.ru/news/1358048/. 27.07.2008
В Тибете выявлены случаи бубонной чумы. — http://www.ntv.ru/text/news/index.

jsp?nid=68425. 07.12.2008.
В Тибете обнаружены останки американских военных летчиков времен 2-й мировой войны. — http://russian.people.com.cn/200209/28/rus20020928_66248.html. 04.11.2008.
В Тибете разрушена статуя Гуру Падмасамбхавы. — http://savetibet.ru/2007/06/05/guru_rinpoche_statue.html. 09.06.2009.
В Тибете усиливается контроль за распространением вируса СПИДа. — http://russian.people.com.cn/31516/5108054.html. 07.10.2008.
В Тибете учрежден День освобождения тибетцев от крепостного рабства. — http://russian.people.com.cn/31521/6576914.html. 11.03.2009.
Валиахметов Г.М. 1958. Органы власти и управления Тибета. М.: Гос. издат. юридич. лит.
Ван Мин. 1975. Полвека КПК и предательство Мао Цзэдуна. М.: Политиздат.
Великая пролетарская культурная революция (важнейшие документы). 1970. Пекин: Изд. лит. на иностр. яз.
Вернадский Г.В. 2000. История России: монголы и Русь. М.: Аграф.
Водораздел между старым и новым Тибетом. — http://russian.people.com.cn/31521/6577728.html. 11.03.2009.
Воскресенский А.Д. 1994. Современные концепции русско-китайских отношений и погранично-территориальных проблем в России и Китае (80–90 гг. XX в.). М.: Росс. науч. фонд.
“Выразитель интересов тибетского народа” или преданное орудие антикитайских сил Запада. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/dllm/t69968.htm, 27.07.2008.
Выяснена причина смерти Гуансюя — китайского императора династии Цин. — http://russian.people.com.cn/31516/6527467.html. 05.11.2008.
Габуев А. 2008. Тибет ждет тяжелое воспитание. — Коммерсантъ, № 59(3876).
Габуев А. Патриотизм с китайским лицом. — http://www.kommersant.ua/doc.html?docId=885571. 22.04.2008.
Галенович Ю.М. 2005. Смерть Мао Цзэдуна. М.: Изографъ.
Ганболд Ж., Мөнхцэцэг Т., Наран Д., Пунсаг А. 2006. Монголын Юан Улс. Улаанбаатар.
Гарри И.Р. (в печати) Буддизм и политика в Тибетском районе КНР (II половина XX — начало XXI в.).
Гедин С. 1899. В сердце Азии. СПб.: Изд. А.Ф. Девриена.
Гетц Й., Розенбах М. Под цифровым обстрелом. — Der Spiegel, № 14 (617), 20.04.2009. http://www.profile.ru/items/?item=28363. 26.04.2009.
Глазунов О.И. 2008. Китайская разведка. М.: Алгоритм.
Гончаров С.Н. 2006. О Китае средневековом и современном. Записки разных лет. Новосибирск: Наука.
Горбунова С.А. 2008. Китай: религия и власть. История китайского буддизма в контексте общества и государства. М.: Форум.
Горестное существование тибетцев при феодально-крепостническом режиме. — http://russian.people.com.cn/31513/6406041.html; http://russian.people.com.cn/31513/6405150.html. 30.10.2008.
Горохова Г.С., Цендина А.Д. (перев.) 2005. Золотое сказание. — В кн.: История в трудах ученых лам. М.
Гузев В.Г., Творогов О.В. Хин(ова). — Фундаментальная электронная библиотека “Русская литература и фольклор”. — http://feb-web.ru/feb/slovenc/es/es5/es5–1791.htm. 04.01.2008.
Гумилев Л.Н. 1968. Древнемонгольская религия. — Доклады ВГО, вып. 5. Л.
Гуревич Б.П. 1958. Освобождение Тибета. М.: Вост. лит.
Гучинова Э. 2004. Улица “Kalmuk Road”. СПб.: Алатейя.
Далай Ч. 1977. Борьба за великоханский престол при Хубилае и его преемниках. — В кн.: Татаро-монголы в Азии и Европе. М.

Далай-лама XIV. 1991. Буддизм Тибета. М.–Рига: Нартанг–Угунс.
Далай-лама XIV. 1992. Свобода в изгнании. Дхарамсала — СПб.: Нартанг.
[Далай-лама XIV.] 1995.Обращение Его Святейшества Далай-ламы по случаю годовщины Тибетского народного восстания 10 марта 1959 г. — Буддизм России, № 23.
Далай-лама XIV. 2000. Моя земля и мой народ. СПб.: Нартанг — Corvus.
[Далай-лама XIV.] Его Святейшество Далай-лама XIV. 2001. Этика для нового тысячелетия. СПб.: Центр тиб. культуры и информ.
Далай лам XIV. 2004. Түвдийн буддизмын ертөнц.Улаанбаатар.
Далай-лама XIV. 2007. 365 медитаций на каждый день. М.: Эксмо.
Далай-лама XIV Тензин Гьяцо. 2008. Сутра сердца: учения о Праджняпарамите. Элиста: Океан Мудрости.
Далай-лама XIV. Страсбургское предложение. — http://savetibet.ru/2007/08/11/psp3.html. 07.06.2009.
Далай-лама XIV: “Товарищ — это было лицемерие”. — http://savetibet.ru/2009/01/13/dalajjlama_tovarishh__jeto_bylo_licemerie.html. 13.01.2009.
Девять комментариев о коммунистической партии. Комментарий 7. — Великая эпоха, эксклюзивный выпуск 2005.
Декларация независимости. — http://www.hist.msu.ru/ER/Etext/indpndnc.htm. 04.05. 2009.
Дмитриев С.В. 2009. К вопросу о Каракоруме. — В кн.: Общество и государство в Китае, вып. 39, с. 76–100.
Договор о добрососедстве, дружбе и сотрудничестве между Российской Федерацией и Китайской Народной Республикой. — http://2002.kremlin.ru/events/260.html. 10.11.2008.
“Долой новых царей!” Передовая статья китайских газет “Жэньминь жибао” и “Цзефаньцзюнь бао” (4 марта 1969 г.), посвященная событиям на острове Даманский. — http://www.coldwar.ru/conflicts/china/statya.php. 16.03.2009.
Домогацких М. 1962. Утро Тибета. М.: Молодая гвардия.
Дополнительный протокол I к Женевским конвенциям от 12 августа 1949 года, касающийся защиты жертв международных вооруженных конфликтов 8 июня 1977 года. — http://www.icrc.org/Web/rus/siterus0.nsf/iwpList133/4A1B0FBA8B5AE3CEC3257107002A11CC. 03.01.2008.
Доржиев А. 2003. Занимательные заметки. М.: Вост. лит.
Дракон в Стране снегов. Интервью с современным историком Тибета Церингом Шакья. — http://savetibet.ru/2008/07/18/tibet.html.
Духовная культура Китая. Историческая мысль, политическая и правовая культура. 2009. М.: Вост. лит.
Дхаммапада (Топоров В.И. перев.). 1998. Самара: Агни.
Елихина Ю.И. 2006. Культ бодхисаттвы Авалокитешвары и его земных воплощений в истории тибетской государственности VII–XIX вв. Автореф. канд. дисс. СПб.
Жеребьевка из Золотой вазы. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/bczs/t69963.htm. 28.07.2008.
Жиронкина Ю. Далай-лама возлагает надежды на Монголию и буддийскую Россию. — http://savetibet.ru/2006/08/30/mongolia_dalai_lama.html. 28.07.2008.
Жиронкина Ю. “Ясная картина мира”: беседа Его Святейшества Далай-ламы XIV с российскими журналистами. — http://www.savetibet.ru/1128697243.html. 16.11.2008.
За 2 года с начала эксплуатации ж/д Цинхай-Тибет пассажирооборот вокзала Лхасы превысил 2,8 млн. чел/раз. — http://russian.people.com.cn/31516/6440620.html. 07.05.2009.
За полвека население Тибета выросло в 2,8 раза. — http://russian.china.org.cn/china/txt/2008–05/05/content_15063519.htm. 03.01.2009.
Заезжий. Почему взбунтовались тибетцы? Впечатления очевидца. — http://savetibet.ru/2008/03/24/tibet_today.html. 07.06.2009.

Законы великой династии Мин со сводным комментарием и приложением постановлений, ч. 2. 2002. М.: Вост. лит.

Закулисная сторона организованного кликой Далай-ламы движения “Восстание тибетского народа”. — http://russian.people.com.cn/31521/6387771.html. 07.04.2008.

Западные альпинисты видели расстрел тибетских беженцев. — http://savetibet.ru/1160660940.html. 04.11.2008.

Запрещенный Тибет: Путеводитель. — http://savetibet.ru/img/2008/tibet-travel-guide-en.pdf. 04.11.2008.

Заявление Его Святейшества Далай-ламы по случаю 50-й годовщины Тибетского народного восстания. — http://savetibet.ru/2009/03/10/dalai_lama_address.html. 10.03.2009.

Зубок В.М. (сост.) 2001. Переговоры Н.С. Хрущева с Мао Цзэдуном 31 июля — 3 августа 1958 г. и 2 октября 1959 г. — Новая и новейшая история, № 1 и № 2.

Иванов Н.Б. 1999. Организация наиболее влиятельных иностранных лобби в США. — Мировая экономика и международные отношения, № 3.

Ивановский А.О. 1888. Посольство Спафари. — Записки восточного отделения Российского Археологического общества, т. 3, вып. 1–2. СПб. — http://www.vostlit.info/Texts/Dokumenty/China/XVII/1660–1680/Posolstvo_Spafari/text.htm. 04.01.2009.

Ивашов Л.Г. “Война между США и Китаем вызревает в России”. — http://www.beregrus.ru/artmon/txt/?news_id=666. 04.11.2008.

Идейно-политическая сущность маоизма. 1977. М.: Наука. — http://socialistica.lenin.ru/txt/m/maoism.htm. 03.05.2009.

Ильин С. 1978. “Тибетский вариант”. — Литературная газета (Москва), № 29 (4679), 19.07.1978.

Интерес Китайской Народной Республики к России и ее продукции. 2007. — Центр политической информации: Информ.-аналитич. бюлл., № 3. М.

Интронизация Панчена XI. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/bczs/t69962.htm. 06.10.2008.

История Китая с древнейших времен до наших дней. 1974. М.: Вост. лит.

История Тибета: всестороннее укрепление административной юрисдикции над Тибетом в период правления Цинской династии (17) — http://russian.people.com.cn/31513/6406191.html; http://russian.people.com.cn/31513/6406186.html. 05.06.2009.

К вопросу о китайско-индийской границе. 1962. Пекин: Изд. лит. на иностр. яз.

Кандидатура со стороны Далая. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/bczs/t69959.htm. 28.07.2008.

Карамзин Н.М. 1989. История государства Российского, т. 1. М.: Наука.

Кармапа XVII бежал из Тибета. 2000. — Буддизм России, № 33.

Качинс Э. 2007. Россия и Китай: двойственный союз. — Pro et contra, ноябрь–декабрь.

Китаев С. 28 марта — новый праздник в Тибете. День освобождения от логики. — http://savetibet.ru/2009/03/27/tibet.html. 27.03.2009.

Китаев С. Как Тибет стал частью КНР. О чем молчит китайская пропаганда. — http://savetibet.ru/2009/03/09/tibet.html. 07.06.2009.

Китаев С. Конфликт в Тибете: факты и пропаганда. — http://savetibet.ru/2008/04/12/tibet_facts_and_propaganda.html. 07.06.2009.

Китаев С. Независимость Тибета в исторической ретроспективе. — http://savetibet.ru/2009/02/16/independence_of_tibet_in_historical_retrospective.html. 07.06.2009.

Китай — Россия: подводные камни отношений. 2005. — Центр политической информации: Информ.-аналитич. бюлл., № 13. М.

Китай и Непал готовы к укреплению межпартийных связей. — http://russian.people.com.cn/31521/6430414.html. 16.06.2008.

Китай наладил серийное производство нелегальных копий российских вооружений. —

http://www.newsland.ru/News/Detail/id/255933/cat/42/. 06.11.2008.
Китай: Тибет — факты и цифры 2005. — http://russian.china.org.cn/russian/233808.htm. 07.05.2009.
Китай: Тибет — цифры и факты 2006. Свобода вероисповедания. — http://russian.china.org.cn/china/archive/Tibet-06/2007–05/15/content_8254856.htm. 30.10.2008.
Китай: Тибет цифры и факты 2006. — http://russian.china.org.cn/china/archive/Tibet-06/2007–05/16/content_8263181.htm.
Китай: факты и цифры 2005. Приложение 6. Соглашение между Центральным Народным Правительством и местным Тибетским Правительством о мероприятиях по мирному освобождению Тибета. — http://russian.china.org.cn/russian/248118.htm. 18.10.2008.
Китай откроет для туристов базу, на которой создавались атомные бомбы. — http://www.rian.ru/world/20070503/64838400.html. 03.05.2007.
Китайская Народная Республика в 1974 г. 1977. М.: Наука.
Китайская Народная Республика в 1975 г. 1978. М.: Наука.
Китайские агенты внедряются в чаты и форумы. — http://www.gorodfm.ru/dn_archive/date.20050531/news.67928/
Китайские группы влияния в России. 2006. — Центр политической информации: Информ.-аналитич. бюлл., № 13. М.
Китайский военный шпионаж против России. — http://www.gazetanv.ru/archive/ 2008/88/5326/.
“Китайский мировой порядок”: альтернативная интерпретация. Историческая трансформация внешнеполитической парадигмы. — http://www.chinastar.ru/rus/1/5/6/. 31.01.2009.
Китайский тибетолог: тибетцы — самые большие бенефициары быстрого развития Тибета. — http://russian.people.com.cn/31516/6382675.html. 28.03.2008.
Китайских детей обучат “этнической целостности”. — http://savetibet.ru/2008/12/17/china_to_teach_children_ethnic_unity.html. 17.12.2008.
Клинов А.С. 2000. Политический статус Тибета и позиция держав (1914 г. — конец XX в.). Майкоп: Ин-т экономики, права и естеств. специальностей.
Клинов А.С. 2008. К вопросу о международно-правовом статусе Тибета. — Мир Евразии, т. 2, № 2, с. 41–46. — http://e-lib.gasu.ru/Evrazia/arhiv/2008/mire_2.pdf. 05.08.2009.
Козлов П.К. 1923. Монголия и Амдо и мертвый город Хара-хото. М.-Петроград: Госиздат.
Козлов П.К. 1947. Монголия и Кам. М.: Географгиз.
Козлов П.К. 2004. Тибет и Далай-лама. М.: КМК.
Колосков Б. 1977. Внешняя политика Китая 1969–1976гг. Основные факторы и ведущие тенденции. М.: Политиздат.
Комментарий: Высказывание клики Далай-ламы об “уничтожении тибетской культуры” — сплошная неправда. — http://russian.people.com.cn/31521/6377482.html. 20.03.2008.
[Комментарий от 25.03.2008] http://savetibet.ru/2008/03/19/petition_to_support_dalai_lama.html.
Кому принадлежит суверенитет над Тибетом и как в Тибете обстоит дело с правами человека (Белая книга). 25.09.1992 г. — http://chinaconsulate.khb.ru/rus/ziliao/zt/zfbps/t25315.htm. 28.07.2008.
Конгресс США проведет расследование китайского мародерства в Тибете. — http://savetibet.ru/1131096480.html. 11.12.2008.
Кончина Панчена X и его предсмертное волеизъявление. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/bczs/t69965.htm.
Коротко о Тибете: исторический очерк. — http://www.fmprc.gov.cn/rus/about/zgxz/xajk/t1997.htm. 01.11.2008.
Коротко о Тибете: население и народности. — http://www.fmprc.gov.cn/rus/about/zgxz/xajk/

t1998.htm. 28.07.2008.
Коротко о Тибете: религии и вероисповедания. — http://www.fmprc.gov.cn/rus/about/zgxz/xajk/t1999.htm, 01.11.2008.
КПК продолжает препятствовать проведению мероприятий памяти 40-й годовщины Культурной революции. — http://www.epochtimes.com.ua/ru/articles/view/4/856.html. 28.05.2006.
Кузнецов Б.И. 2001. Бон и маздаизм. СПб.
Кузнецов В.С. 2006. Буддийский фактор во внешней политике КНР. М.: Ин-т Дальнего Востока РАН.
Кузьмин С.Л., Оюунчимэг Ж. 2009. Последний великий хан Монголии. — Азия и Африка сегодня, № 1.
Кулешов Н.С. 1992. Россия и Тибет в начале XX в. М.: Наука.
Куртуэ С., Верт Н., Панне Ж.-Л., Пачкоски А., Бартошек К., Марголен Ж.-Л. Черная книга коммунизма. — http://blackrotbook.narod.ru/. 07.06.2009.
Кучера С. 1977. Завоевание монголами Тибета. — В кн.: Татаро-монголы в Азии и Европе. М.
Кычанов Е.И., Мельниченко Б.Н. 2005. История Тибета с древнейших времен до наших дней. М.: Вост. лит.
Кычанов Е.И., Савицкий Л.С. 1975. Люди и боги Страны снегов: очерк истории Тибета и его культуры. М.: Вост. лит.
Ланьков А. “Мандат Неба” или легитимность по-китайски. — http://lankov.oriental.ru/d27.shtml. 01.07.2002.
Ларин В.Л. 2005. Российско-китайские отношения в региональных измерениях (80-е годы XX — начало XXI века). М.: Восток-Запад.
Левин Г.Г. Рунические надписи Тибета. — http://www.kyrgyz.ru/?page=38. 24.12.2008.
Левкин Г.Г. Исторические измышления кандидата исторических наук Владимира Попова. — http://www.levking.ru/izms.htm. 30.10.2008.
Левкин Г.Г. Китай или Маньчжурия — сосед России? — http://www.levking.ru/man2.htm. 30.10.2008.
Левкин Г.Г. Ответы посетителям гостевой книги. — http://www.levking.ru/gb1.htm. 14.10.2009.
Левкин Г.Г. Типичные ошибки и заблуждения в вопросах, связанных и историей Чжунго (Китая). — http://www.levking.ru/mists.htm. 30.10.2008.
Ледовский А.М. 2005. СССР, США и китайская революция глазами очевидца 1946–1949. М.: Ин-т Дальнего Востока РАН.
Ленин В.И. О праве наций на самоопределение. — В кн.: Ленин В.И. 1961. Полное собрание сочинений, издание 5, т. 25. М.
Ленин В.И. Итоги дискуссии о самоопределении. — В кн.: Ленин В.И. 1962. Полное собрание сочинений, издание 5, т. 30. М.
Леонтьев В.П. 1956. Иностранная военная экспансия в Тибете в 1888–1919 гг. М.: Изд-во АН СССР.
Ломанов А. Будда из Золотой вазы. — http://www.vremya.ru/2003/192/13/82362.html. 14.10.2009.
Лотосовая роща великих таинств: тибетский художник Дугу Чеджел Ринпоче. — http://oldtradition.org/teachers/tibetskii-khudozhnik-dugu-chedzhel-rinpoche-master-traditsii-drukpa-kagyu. 24.12.2008.
Лу Хуачжу. 1828. Описание Тибета в нынешнем его состоянии. СПб.: Тип. Имп. воспит. дома.
Лубсан Данзан. 1973. Алтан тобчи (“Золотое сказание”). М.: Наука.
Лукин А. 2007. Китай: опасный сосед или выгодный партнер? — Pro et contra, ноябрь–

декабрь.
Лукин А. Картина мира: Буддизм и коммунизм. — Ведомости, 28.03.2008, № 56 (2078). — http://www.vedomosti.ru/newspaper/index.shtml?2008/03/28.
Лукьянов А.Е. 2005. Китайская цивилизация как новый мировой порядок. — Психол. газета: Мы и Мир, №11(111). — http://www.gazetamim.ru/culture/dialog/lukjanov.htm. 04.01.2009.
Малиновский Г. Тринадцать лет китайской войны. — http://www.bbratstvo.org/index.php3?path=_jornal/2002/02&source=neizvoin. 10.12.2008.
Малявин В. 2000. Китайская цивилизация. М.: Астрель — Дизайн, Информация, Картография.
Мао Цзэдун. 1948. Сюаньцзи (Избранные произведения). Харбин: 211. — http://mx.esc.ru/~assur/ocr/maoism/ref.html#ref_215. 30.04.2009.
Мао Цзэдун. 1952. Избранные произведения, т. 1. М.: Изд-во иностр. лит.
Мао Цзэдун. 1966. Выдержки из произведений. Пекин: Изд-во лит. на иностр. яз.
Мао Цзэдун. 1967. Довести революцию до конца. Пекин: Изд-во лит. на иностр. яз.
Мао Цзэдун. 2008. Автобиография. Стихи. М.: Рубежи XXI века.
Мао Цзэдун. К вопросу о правильном разрешении противоречий внутри народа, 27 февраля 1957 г. — http://www.maoism.ru/library/on_the_correct_handling.htm. 22.05.2009.
Мао Цзэдун. Выступления и статьи Мао Цзэ-дуна разных лет, ранее не публиковавшиеся в печати, вып. 6. 1976. М. — http://www.maoism.ru/library/Mao_set.htm. 06.11.2008.
Мао Цзэдун. О Дэн Сяопине (реплика в беседе с членами политбюро и командующими большими военными округами 15 декабря 1973 г.). — http://www.maoism.ru/library/remark-15–12–1973.htm. 22.05.2009.
Маоизм без прикрас. 1980. М.: Прогресс.
Маоистская библиотека. — http://www.maoism.ru/library/index.htm. 06.11.2008.
Маоисты в Непале используют детей как живой щит. — http://www.kommentator.ru/accent/2005/a0629–12.html. 01.05.2009.
Мар Н.И. 1969. Остров Даманский. М.: Знание.
[Марко Поло]. Книга Марко Поло. 1955. М.: Географгиз.
Мартынов А.С. 1978. Статус Тибета в XVII–XVIII веках. М.: Наука.
Материалы из “Ниндин Чжуньгээр Фанлюэ” (Описания усмирения джунгаров) по истории Джунгарии и Восточного Туркестана. 1994. — В кн.: Китайские документы и материалы по истории Восточного Туркестана, Средней Азии и Казахстана XIV-XIX вв. Алматы. — http://www.vostlit.info/Texts/Dokumenty/China/XVII/1680–1700/Kit_ist_Sr_az/21–40/frametext21.htm. 12.06.2009.
Меринов С. Очищение у золотого озера. — Российская газета. Неделя № 3339, 06.11.2003 — http://www.rg.ru/2003/11/06/tibet.html. 03.12.2008.
МОК отменил всемирную эстафету олимпийского огня. — http://www.lenta.ru/news/2009/03/27/torch/. 27.03.2009.
Монгольская Народная Республика. М., 1952.
Москалев А.А. 2004. Цзян Цзэминь о национальной политике КПК. — В кн.: Китай в диалоге цивилизаций. М.
Москалев А.А. 2005. Нация и национализм в Китае. М.: Памятники исторической мысли.
Мулдашев Э.Р. 2008. От кого мы произошли? М.: ОЛМА Медиа групп.
“Мы ездили в Бурятию, китайцы теперь едут в Тибет!” — Буддизм России, № 39.
Мясников В.С. 1979. Идейное банкротство пекинских лжеисториков. — В кн.: Территориальные притязания Пекина: история и современность. М.
[Намкай Норбу] Чогьял Намкай Норбу. 2004. Введение. — В кн.: Тибетская книга мертвых. СПб.: Уддияна — Шангшунг.
[Намкай Норбу] Чогьял Намкай Норбу. 2008. Драгоценное Зеркало древней истории Шанг-Шунга и Тибета. М.: Шечен — Ганга.

Намсараева С.Б. 2003. Институт наместников цинского Китая в Монголии и Тибете в XVIII веке. Кандидатская диссертация. М.: Ин-т востоковед. РАН.

Национальная районная автономия в Тибете. — http://russian.china.org.cn/russian/115293.htm. 27.07.2008.

Начато строительство крупнейшего в Тибете логистического центра в Нагчу. — http://www.russian.xinhuanet.com/russian/2007–09/29/content_497801.htm. 28.07.2008.

Некоторые маньчжурские документы из истории русско-китайских сношений в XVII-м веке. — Записки Вост. отделения Имп. Русск. Археол. общества. 1912, т. XXI, вып. 2–3. СПб. — http://www.vostlit.info/Texts/Dokumenty/China/XVII/1680–1700/Manc_rus_kit/text.htm. 26.10.2008.

Непомнин О.Е. 2005. История Китая: эпоха Цин. XVII — начало XX в. М.: Вост. лит..

Николаев Р. 2005. Как на советские деньги попала свастика. — http://www.vodyanoyznak.ru/magazine/21–22/432.htm. 06.02.2009.

Никольский В. SCMP: В условиях суровых мер безопасности тибетцы отмечают ‘черный’ Новый год дома. — http://savetibet.ru/2009/02/28/tibet.html. 16.03.2009.

Никольский В. TCHRD: Семь тибетцев приговорены к тюремному заключению вплоть до пожизненного в связи с “беспорядками 14 марта” в Лхасе. — http://savetibet.ru/2008/12/19/tchrd_sem_tibetcev_prigovoreny_k_tjuremnomu_zakljucheniju_vplot_do_pozhiznennogo_v_svjazi_s_besporjadkami_14_marta_v_lkhase.html. 19.12.2008.

Никольский В. Активисты из Британии и США на допросах были прикованы к стульям. — http://savetibet.ru/2008/08/30/activist.html. 30.08.2008.

Никольский В. В Кардзе провинции Сычуань продолжаются стихийные протесты тибетцев. — http://savetibet.ru/2009/01/12/tibetans_in_new_kardze_protests.html. 12.01.2009.

Никольский В. В Лхасе распространяется кампания по бойкоту новогодних торжеств. — http://savetibet.ru/2009/02/05/tibet_new_year.html. 05.02.2009.

Никольский В. В Катманду непальские полицейские арестовали 25 участников тибетского протеста. — http://savetibet.ru/2009/08/18/nepal_tibet.html. 06.10.2009.

Никольский В. В провинции Сычуань осужден на пять лет тюрьмы племянник Ронгье Адрака. — http://savetibet.ru/2008/07/19/tibetans.html. 04.11.2008.

Никольский В. За фасадом “Дня освобождения крепостных” скрываются репрессии. — http://savetibet.ru/2009/03/28/tibet_today.html. 28.03.2009.

Никольский В. Китайские власти потребовали от тибетских монахов не проводить молебен по умершей участнице протестов. — http://savetibet.ru/2008/05/09/tibetan_dead.html. 09.05.2008.

Никольский В. Комсомольцы-маоисты передали полиции Непала 5 тибетских беженцев. — http://savetibet.ru/2009/02/24/nepal.html. 16.03.2009.

Никольский В. Министр внутренних дел Непала: “Тибетские беженцы не имеют права” на мирный протест. — http://savetibet.ru/2009/10/06/tibet_nepal.html. 06.10.2009.

Никольский В. На родине Далай-ламы XIV завершено строительство посвященной ему пагоды. — http://savetibet.ru/2009/03/03/dalai_lama.html. 03.03.2009.

Никольский В. Новая цензурная инициатива в тибетских регионах Китая: демонтаж спутниковых тарелок. — http://savetibet.ru/2009/06/25/tibet.html. 25.06.2009.

Никольский В. Пекинское руководство проводит в тибетских регионах демонстрацию военной силы. — http://savetibet.ru/2009/02/22/lhasa.html. 16.03.2009.

Никольский В. Служащим госучреждений из числа тибетцев дан двухмесячный срок на возвращение детей из школ и монастырей Индии. — http://savetibet.ru/2008/07/18/tibetan_children.html. 28.07.2008.

Никольский В. Суд оправдал немецкого аспиранта, бросившего кроссовку в премьера Госсовета КНР. — http://savetibet.ru/2009/06/03/humanrights.html. 03.06.2009.

Никольский В. Тибетское плато: трудности жизни экологических переселенцев. — http://savetibet.ru/2008/10/21/tibetan_nomads.html. 21.10.2008.
Никольский В. Тибетское правительство в изгнании прерывает переговоры с Китаем. — http://savetibet.ru/2008/11/23/tibet.html. 23.11.2008.
Никольский В. Трое тибетских монахов арестованы по подозрению в причастности к взрыву в Чамдо. — http://savetibet.ru/2008/11/02/tibetans.html. 03.11.2008.
Новый прогресс в защите прав человека в Тибете (Белая книга). 1998. — http://chinaconsulate.khb.ru/rus/ziliao/zt/zfbps/t25323.htm. 13.07.2008.
О религиозной свободе в Тибете. — http://community.livejournal.com/ru_free_tibet/6258.html. 01.11.2008.
О тибетском вопросе. 1959. Пекин: Изд. лит. на иностр. яз.
О торговом балансе между КНР и США (Белая книга). — http://russian.china.org.cn/russian/32943.htm. 03.05.2009.
О торгово-экономических отношениях между Китаем и США. — http://www.chinaconsulate.khb.ru/rus/xwdt/2002x/t117755.htm. 03.05.2009.
О чем умалчивают в Пекине. 1972. М.: АПН.
Обвиняемый в поджогах в ходе беспорядков в Тибете приговорен к смерти. — http://www.interfax.ru/society/news.asp?id=75953. 23.04.2009.
Овчинников В. 2004. Далай-лама в России. Осложнит ли его визит отношения между Пекином и Москвой? — Российская газета, № 3643, 01.12.2004.
Овчинников Вс. 2006. Вознесение в Шамбалу: своими глазами. М.: АСТ.
Овчинников В. 2007. Вашингтон, Пекин и Далай-лама: Тибет стал частью Китая еще в средние века. — Российская газета: Неделя №4502 от 25 октября 2007 г. — http://www.rg.ru/2007/10/25/tibet.html. 30.10.2008.
Овчинников В. 2009. Явь Тибета опровергает мифы. — Российская газета: Неделя № 5061(237) от 10 декабря 2009 г. — http://www.rg.ru/2009/12/10/tibet.html.12.12.2009.
Одели Б. 2005. Дхарамсала. Тибетские хроники. Нижний Новгород: Деком.
Организация Объединенных Наций. А. Генеральная Ассамблея. A/RES/260 A (III). Третья сессия. Резолюция, принятая Генеральной Ассамблеей. 260 A (III). Утверждение Конвенции о предупреждении преступления геноцида и наказании за него и текст этой Конвенции. — http://www.un.org/russian/documen/convents/genocide.htm. 07.10.2008.
Освобождены более тысячи участников беспорядков в Тибете. — http://www.lenta.ru/news/2008/06/21/release/. 21.06.2008.
Пан Т.А. 2007. Обращение Поздней Цзинь к династии Мин. — Письменные памятники Востока, т. 2, вып. 7.
Пандаев П.К. 1999. Мракобесие для простаков. — http://bookz.ru/authors/pandaev-p/antikura/1-antikura.html. 14.11.2008.
Пассажирооборот на Цинхай-тибетской железной дороге превысил 1,3 млн. чел/раз. — http://russian.people.com.cn/31518/6201208.html. 07.05.2009.
Патрушева М.А. 1981. Китайская колонизация Маньчжурии и политика Цинского правительства (вторая половина XIX — начало XX в.). Кандидатская диссертация. М.: Ин-т востоковед. АН СССР.
Переговоры или раскольническая деятельность под маской переговоров. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/dllm/t69969.htm. 08.02.2009.
Перемены в благосостоянии тибетского общества. — http://www.chinafactory.ru/xinwen_content.asp?newsid=1822. 28.07.2008.
Петров В.И. 2003. Мятежное “сердце” Азии. Синьцзян: краткая история народных движений и воспоминания. М.: Крафт+.
Пиков Г.Г. 2007. Из истории названия “Китай”. — В кн.: Чингисхан и судьбы народов Евразии, т. 2. Улан-Удэ.

Пирман К. Невежество красной звезды. — http://www.epochtimes.ru/content/view/12032/17/. 03.08.2007.
Письмо из Лхасы, Тибет. — http://savetibet.ru/2008/05/08/lhasa_tibet.html. 08.05.2008.
Поборник мира или вдохновитель беспорядков. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/dllm/t69970.htm. 01.11.2008.
Пограничная политика КНР. — http://www.chinastar.ru/rus/1/5/5/. 14.10.2009.
Поддержка спецслужбами США т.н. “независимости Тибета”. — http://russian.people.com.cn/31521/6393021.html.
Политика Срединного пути. Подход Его Святейшества Далай-ламы к урегулированию тибетского вопроса. 2007. Дхарамсала: Департамент информации и международных отношений Центральной тибетской администрации.
Политическое измерение Богдо-гегена. 2004. — Буддизм России, № 38.
Последний визит Чжоу Эньлая в СССР. — http://russian.cpc.people.com.cn/84091/6649135.html. 01.05.2009.
Потери советских военнослужащих, принимавших участие в оказании военной и военно-технической помощи другим странам, а также в ликвидации пограничных военных конфликтов (1946–1991 гг.). — http://www.soldat.ru/doc/casualties/book/chapter6.html#6_11. 06.06.2009.
Правоохранительные органы Китая в ходе расследования дела о беспорядках в Лхасе конфисковали крупную партию оружия. — http://russian.people.com.cn/31516/6386904.html. 05.04.2008.
Препятствий для визита Далай-ламы в Россию нет — Лавров. — http://www.rian.ru/politics/20090128/160322940.html. 28.01.2009.
Пржевальский Н.М. 1875. Монголия и страна тангутов, т. 1. СПб.: Тип. В.С. Балашева.
Пржевальский Н.М. 1883. Из Зайсана через Хами в Тибет и на верховья Желтой реки. СПб.: Тип. В.С. Балашева.
Приказ № 5 по управлению реинкарнациями живых будд в тибетском буддизме. — http://www.sara.gov.cn/GB//zcfg/89522ff7–409d-11dc-bafe-93180af1bb1a.html; русский перевод: http://radiowarhait.livejournal.com/15390.html. 27.07.2008.
Путешествие француза в Тибет. — http://savetibet.ru/2009/01/30/r233cit_du_p233riple_dun_fran231ais_224_travers_le_tibet.html. 16.03.2009.
Пучковский Л.С. 1963. Идея преемственности происхождения ханов в монгольских летописях XVII — XIX вв. — В кн.: Тр. 25-го Междунар. конгр. востоковедов, т. 5. М.
Развитие тибетского языка в эпоху информатики. — http://russian.people.com.cn/31515/6394888.html. 06.10.2008.
Рахимов Т. 1968. Национализм и шовинизм — основа политики группы Мао Цзэ-дуна. М.: Мысль.
Рахимов Т., Богословский В. 1971. Великодержавный шовинизм Мао Цзэ-дуна. — В кн.: Опасный курс, вып. 2.
Рахманин О.Б. 2005. Страницы пережитого. М.: Памятники исторической мысли.
Религия и национальная самобытность тибетцев. — http://savetibet.ru/2008/04/11/religion_and_national_identity.html. 04.10.2009.
Рерих Ю.Н. 1958. Основные проблемы тибетского языкознания. — Советское востоковедение, № 4.
Речь Ли Жуйхуаня на 3-м заседании Руководящей группы по организации поисков мальчика-перевоплощения Панчена X. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/bczs/t69961.htm. 28.07.2008.
Решение по некоторым вопросам истории КПК со времени образования КНР. 1981. Пекин: Изд. лит. на иностр. яз.
Рингардт С. 1903. В горах Тибета. СПб.: Труд.

Рожинцев А. Четыре стороны мира под одной крышей, или где воевал Китай. — http://www.otechestvo.org.ua/hronika/2004_08/h_9_01.htm. 07.07.2008.
Рокхиль В.В. 1901. В страну лам. Путешествие по Китаю и Тибету. СПб.: Тип. И.Н. Скороходова.
Рубрук Г. де. 1957. Путешествие в восточные страны. — В кн.: Дж. дель Плано Карпини. История монгалов. Г. де Рубрук. Путешествие в восточные страны. М.
Саммит ШОС в Екатеринбурге узаконил доминирование Китая в экономике региона. — http://www.newsru.com/finance/16jun2009/shos2.html. 16.06.2009.
Сапожников Б.Г. 1984. Народно-освободительная война в Китае. М.: Воениздат.
Сведение о Тибете. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/xzjj/default.htm.
Сидихменов В.Я. 1985. Маньчжурские правители Китая. М.: Наука.
Синьхайская революция 1911–1913 гг. Сборник документов и материалов. 1968. М.: Наука.
Сканави А. Крутой поворот. — http://savetibet.ru/2008/11/06/tibet.html. 06.11.2008.
Сладковский М.И. 1979. Безрассудность территориальных притязаний руководителей КНР, их экспансионистские замыслы в отношении соседних стран. — В кн.: Территориальные притязания Пекина: история и современность. М.
Советская военная помощь Китаю (1946–1950 гг.). — http://www.rustrana.ru/article.php?nid=20588. 26.11.2008.
Совместная Декларация РФ и КНР. — http://www.kremlin.ru/events/articles/ 2004/ 10/77866/161384.shtml. 01.11.2008.
Современная политика Китая в Тибете. 2000. Б.м.
Современная ситуация в Тибете. — http://www.tibet.spb.ru/tibet-situation/13/. 26.10.2008
Современный Китай: кто есть кто? Момент истины еще не скоро. — Альманах “Восток”, вып. 9 (21), 2004. — http://www.situation.ru/app/j_art_534.htm. 03.01.2009.
Сталин И.В. 1948. Сочинения. М.: Политиздат, т. 8, с. 357–374. — http://grachev62.narod.ru/stalin/t8/t8_23.html. 04.05.2009.
Степень зависимости Китая от зарубежных технологий достигает 50 процентов. — http://russian.people.com.cn/31517/3931103.html. 04.05.2009.
Стонор Ч. 1958. Шерпы и снежный человек. М.: Изд-во иностранной литературы.
Стонтон Г. 1804–1805. Путешествие во внутренность Китая и в Тартарию, ч. 3. М.: Тип. Х. Клаудия.
Строкань С. “Самый живой Будда”. — http://www.religare.ru/article14152.htm. 02.02.2005.
Сунь Ятсен. 1985. Избранные произведения. М.: Наука.
Сунь Ятсен. 1961. Избранные произведения. М. — http://www.vostlit.info/Texts/Dokumenty/China/XX/1900–1920/Sinhaj_rev/1–20/1.htm. 28.04.2009.
Суть феодально-крепостнического строя старого Тибета II. — http://russian.people.com.cn/31521/6397759.html. 01.11.2008.
Счастье Тибета — счастье простых людей (народный форум). — http://paper.people.com.cn/rmrb/html/2009–03/10/content_208316.htm. 06.06.2009.
США объявили о внесении корректировок в политику в отношении Компартии Непала /маоистской/. — http://russian.people.com.cn/31520/6421912.html. 01.11.2008.
Сюй Дисинь. 1958. Классовая борьба в Китае в переходный период. — Советское китаеведение, № 3.
Тело великого ламы осталось нетленным. — http://www.glubinnaya.info/science/lama/lama.htm. 14.06.2009.
Темпы роста ВВП Тибета в 2006 году превысили 13,2 проц. — http://russian.people.com.cn/31518/5443541.html. 28.07.2008.
Терентьев А. “Позвольте возразить”. О ложных воззрениях журналиста Овчинникова (по публикациям “Российской газеты” 9 апреля 2008 г.). — http://www.buddhisminkalmykia.ru/?page=shownews&newsid=478&PHPSESSID=32d7a15b...04.11.2008.

Тибет глазами русских: хорошо ли быть монахом в Лхасе? — http://savetibet.ru/1129838880.html. 21.10.2005.
Тибет глазами тибетцев (серия “Краткие сведения о Китае”). 1995. Пекин: Изд-во Синьсин.
Тибет под властью коммунистического Китая: 50 лет. 2001. Дхарамсала: Деп. информ. и междунар. отношений.
Тибет: за годы после начала осуществления демократической реформы ВВП увеличился в 60 раз. — http://russian.people.com.cn/31518/6389274.html. 28.07.2008.
Тибет: правда, основанная на фактах. 1993. Дхарамсала: Деп. информ. и международных отношений Центральной тибетской администрации. М., 1994. — изд. 2-е: Tibet: Proving Truth from Facts. — http://www.tibet.net/en/index.php?id=142&rmenuid=11. 07.06.2009.
Тибетка — бывшая крепостная — сравнивает нынешнюю жизнь с прошлой. — http://russian.people.com.cn/31521/6392315.html. 01.11.2008.
Тибетская писательница сомневается в правдивости истории Тибета, представленной КПК. — http://www.epochtimes.ru/content/view/23312/4/. 28.03.2009.
Тибетские коммунисты теперь не могут хранить дома религиозные сочинения на тибетском языке. — http://www.religare.ru/article52772.htm. 28.07.2008 09.04.2008.
Тибетский вопрос. — http://www.fmprc.gov.cn/rus/about/zgxz/xajk/t2000.htm. 27.07.2008
“Тибетский вопрос” не является религиозным вопросом. — http://russian.people.com.cn/31521/6401152.html. 28.07.2008.
Тибетский лама сохранял состояние медитации в течение 18 дней после смерти. — http://savetibet.ru/2008/10/07/tibetan_lama.html. 07.10.2008.
Тимковский Е. 1824. Путешествие в Китай через Монголию в 1820 и 1821 гг. СПб.: Тип. Мед. деп. Мин. внутр. дел.
Тихвинский С.Л. 1966. Маньчжурское владычество в Китае. — В кн.: Маньчжурское владычество в Китае. М.
Тихвинский С.Л. 1979. Великоханьский гегемонизм и историческая наука в КНР. — В кн.: Территориальные притязания Пекина: история и современность. М.
Торчинов Е.А. Буддийская традиция Тибета. — http://buddhism.org.ru/buddhism_08.html. 05.12.2008.
Тридцать шесть стратагем (перев. В.В. Малявин). 2000. М.: Белые Альвы.
Троянский конь из Поднебесной. — http://www.chas-daily.com/win/2008/04/04/v_014.html?r=31.
Туристы и маоисты. — http://www.indostan.ru/forum/24_162_2.html. 04.05.2009.
Туччи Дж. 2004. Святые и разбойники неизведанного Тибета. СПб.: Алетейя.
Удел Могултая — Монгольская империя в 1248–1388. — http://www.wirade.ru/history. 21.12.2008.
Уоддель А. 1906. Лхаса и ее тайны. Очерк тибетской экспедиции 1903–1904 гг. СПб.: Тип. П.Ф. Пантелеева.
Усов В.Н. 2003. Последний император Китая Пуи (1906–1967). М.: Олма-Пресс.
Усов В.Н. 2006. История КНР, т. 2. М.: АСТ — Восток-Запад.
Усов В.Н. 2007. Советская разведка в Китае. 30-е годы XX века. М.: КМК.
Успенский В.Л. 1996. Ламаистский Пекин: от Шунь-Чжи до Дао-Гуана. — Восток, № 4.
Устав Коммунистической партии Китая, 21 октября 2007 г. — http://russian.china.org.cn/china/archive/shiqida/2007–10/26/content_9128399.htm. 06.11.2008.
Устав Организации Объединенных Наций. — http://www.un.org/russian/documen/basicdoc/charter. 20.02.2009.
Установления о соли и чае. 1975. М.: Наука.
[Фан-портал] http://russian.people.com.cn/95460/6495971.html. 06.10.2008.
Федоренко Н.Т. 1992. Сталин И.В. и Мао Цзедун. — Новая и новейшая история. №5–6.
Филатов Л.В. 1980. Экономическая оценка научно-технической помощи Советского Союза

Китаю 1949–1966. М.: Наука.
Френч П. 2004. Тибет, Тибет. М.: АСТ.
Харрер Г. 2002. Семь лет в Тибете. М.: Центрполиграф. — http://www.lhasa.ru/sevenyearsintibet/tibet6.html. 30.10.2008.
Хенниг Р. 1961–1963. Неведомые земли, тт. 1–4. М.: Изд-во иностранной литературы.
Хольц К.А. Все эксперты по Китаю подкуплены? — http://www.epochtimes.com.ua/ru/articles/view/5/10120.html. 28.11.2008.
Храмчихин А.А. Угроза, которая сама по себе “не рассосется”. Китай неизбежно сломает нынешний мировой порядок. — http://nvo.ng.ru/concepts/2008–02–22/2_ugroza.html. 06.11.2008.
Храмчихин А.А. Миллионы солдат плюс современное вооружение. Китайская армия меняет ориентиры. — http://nvo.ng.ru/forces/2009–10–09/1_china.html. 09.10.2009.
Храпачевский Р.П. 2004. Военная держава Чингисхана. М.: АСТ–ВЗОИ.
Хронология Китая 3. — http://oriental.ru/cgi-bin/forum/YaBB.pl?board=china;action=display;num=1024834869. 30.10.2008.
Царь Сонгцен Гампо. — http://dazan.spb.ru/teachers/kings-tibet/561/. 25.11.2008.
Цендина А.Д. 2006. И страна зовется Тибетом. М.: Вост. лит.
“Цзинцзи жибао”: бурное развитие национальной экономики ТАР. — http://www.anctc.ru/inform/textnews/2008–04–22/113756/?site=3. 28.07.2008.
Цзян Цзэминь. 2004. О социализме с китайской спецификой, тт. 2–3. М.: Памятники исторической мысли.
Цултэм Н. 1986. Монгольская национальная живопись “Монгол зураг”. Улан-Батор: Госиздат.
Цыбиков Г.Ц. 1981. Избранные труды, т. 1: Буддист-паломник у святынь Тибета. Новосибирск: Наука.
Цянь Сяоюнь. 2003. Опасный миф о “китайской военной угрозе”. — Азия и Африка сегодня, №№ 2–3.
Чже Цонкапа. 2007. Большое руководство к этапам пути Пробуждения, тт. 1 — 2. СПб.: Изд-во А. Терентьева.
Чжунго лиши диту цзи (Атлас истории Китая — ред. Тань Цисян), тт. 5, 8. 1996. Пекин.
Шакабпа В.Д. 2003. Тибет: политическая история. СПб.: Нартанг.
Шаравин А. Россия и Америка против Китая. — http://www.rusk.ru/st.php?idar=112247. 07.11.2008.
Шевелев В.Н. Мао Цзэдун — великий кормчий. — http://eastlib.narod.ru/modern/mao.htm. 22.06.2009.
Шесть лет поисков мальчика-перевоплощения Панчена X. — http://ru.china-embassy.org/rus/ztbd/xzzt/bczs/t69964.htm.
Ширер У. Крах нацистской империи. — http://navycollection.narod.ru/library/Krah_nacist_imper/part_1/15.html. 12.03.2009.
ШОС поставит кавказский диагноз России. — Независимая газета, 27.08.2008.
Щербаков И.С. 1958. Китайская Народная Республика на подъеме. — Советское китаеведение, № 3.
Экологическое строительство и охрана окружающей среды в Тибете (Белая книга). — http://russian.china.org.cn/russian/65188.htm. 28.07.2008.
Энгельс Ф. Письмо В.И. Засулич, 3 апреля 1890 г. — В кн.: Маркс К., Энгельс Ф. 1965. Соч., т. 37. М.
Эх, “Свобода”... (23.03.2008). — http://www.buddhismofrussia.ru/news/164/. 06.02.2009.
Юзефович Л. 2007. Путь посла. Русский посольский обычай. Обиход. Этикет. Церемониал. СПб.: Изд. И. Лимбаха.
Юн Чжан, Холлидей Дж. 2007. Неизвестный Мао. М.: Центрполиграф.
Юрков С.Г. 1981. Азия в планах Пекина. М.: Политиздат.

[Янгхасбенд Ф.Э.] 1893. Нашествие русских в Индию, Юнгхезбанда. — Сб. геогр., топогр. и статистич. матер. по Азии, вып. 53.
A 60-point commentary on the Chinese Government Publication: A Collection of Historical Archives of Tibet. 2008. Diir Publications. — http://www.tibet.net/en/index.php?id=346&rmenuid=11. 27.01.2009.
A Sea of Bitterness. Patriotic Education in Qinhai Monasteries. 1999. London: Tibet Information Network.
A Tibetan arrested in Lithang for political demonstration. — http://tchrd.org/press/2007/pr20070802.html. 04.11.2008.
Aldenderfer M.S. 2003. Moving up in the world. — American Scientist, v. 91.
Andrugtsang G.T. 1973. Four Rivers, Six Ranges. Reminiscences of the Resistance Movement in Tibet. Dharamsala: Information and Publicity Office of H.H. the Dalai Lama.
Another Chinese 'incursion' at Sikkim border. — www.phayul.com. 19.06.2008.
Ardley J. 2002. The Tibetan Independence Movement. NY: Routledge.
Arpi C. 2007. The "17-point Agreement": context and consequences. — В кн.: Facts About the 17-point "Agreement" Between Tibet and China. Dharamsala.
Atmosphere of "martial law" in Lhasa on 5 and 10 March 1999. — http://www.tchrd.org/publications/hr_updates/1999/hr19990315.html#atmosphere. 14.12.2008.
Bache. 50 years of turmoil in Inner Mongolia. — http://www.hunmagyar.org/turan/mongol/50yrs.html. 03.01.2009.
Baker M. 2007. "Democratic imperialism": Tibet, China, and the national endowment for democracy. — Global Research, August 13. — http://www.globalresearch.ca/index.php?context=va&aid=6530. 25.01.2009.
Barnett R. 1997. Preface. — В кн.: [Panchen Lama X] 1997. A Poisoned Arrow. The Secret Report of the 10th Panchen Lama. The Full Text of the Panchen Lama's 70,000 Character Petition of 1962, Together with a Selection of Supporting Historical Documents. London: Tibetan Information Network.
Beall C.M. 2006. Andean, Tibetan and Ethiopean patterns of adaptation to high-altitude hypoxia. — Integr. and Comp. Biol., v. 46, no. 1
Beall C.M., Laskowski D., Strohl K.P., Soria R., Villena M., Vargas E., Alarcon A.M., Gonzales C., Erzurum S.C. 2001. Pulmonary nitric oxide in mountain dwellers. — Nature, v. 414.
Behind bars: prison conditions in Tibet. 1998. — http://www.tchrd.org/publications/topical_reports/behind_bars-prison_conditions-1998/. 07.11.2008.
Bell Ch. [1924] 1992. Tibet: Past and Present. New Delhi — Madras: Asian Education Services.
Bell Ch. [1928] 1991. The People of Tibet. New Delhi — Madras: Asian Educational Services.
Berzin A. 2000. Relating to a Spiritual Teacher: Building a Healthy Relationships. Ithaca: Snow Lion. — http://www.berzinarchives.com/web/en/archives/e-books/published_books/spiritual_teacher/pt1/spiritual_teacher_02.html?query=Manchu+Manjushri. 06.02.2009.
Biello D. 2007. How Tibetans enjoy the high life. — Scientific American, 29.10.2007.
Birth control policy in Amdo. 1996. — Human Rights Update: TCHRD, v. 2, no. 23.
Blondeau A.-M., Buffetrille K. (eds.) 2008. Authenticating Tibet: Answers to China's 100 Questions. Berkeley — Los Angeles — London: Univ. of California Press.
Brief introduction of Chushi Gangdruk Defend Tibet Volunteer Force. — http://www.chushigangdruk.org/history/index.html. 25.01.2009.
Briefing paper for travellers to Tibet 1999. — http://www.tchrd.org/publications/topical_reports/travellers_to_tibet-1999. 28.01.2009.
Butt M. 1994. Muslims of Tibet. — Tibetan Bull., January–February.
Butterfield F. 1979. Buddhism's influence stays strong in Tibet. — New York Times, 19.06.1979.
Cao Ch. 2007. Tibetan tragedy began with a farce. — В кн.: Facts About the 17-point "Agreement" between Tibet and China. Dharamsala.

Chan H. 1981. Chinese official historiography at the Yuan court: the composition of the Liao, Chin, and Sung histories. — In: China under Mongol Rule. Princeton.
Chandra L. 1999. Buddhist Iconography. New Delhi: Intern. Acad. of Indian Culture — Aditya Prakashan.
Chhodak T. 2003. The 1901 Proclamation of the H.H. Dalai Lama XIII. — В кн.: The History of Tibet (McKay A. ed.), v. 3. London — New York.
Childs G. 2003. Polyandry and population growth in a historical Tibet society. — History of Family, v. 8. — http://www.case.edu/affil/tibet/booksAndPapers/childs.polyandry.and.population.growth.pdf. 27.01.2009.
China: 20th Century China incident and Nanking incident, 1938. — http://www.jiyuu-shikan.org/e/archives.html. 14.08.2009.
China arrest over 572 monks from Kirti Monastery in two-day raid. — http://www.phayul.com/news/article.aspx?article=China+arrest+over+572+monks+from+Kirti+Monastery+in+two-day+raid&id=20227. 01.04.2008.
China can not have Tibet, says Britain. — New York Times, 30.08.1912.
China launches education drive in Lhasa. — www.phayul.com. 21.04.2008.
China, Tibet and Chinese nation. Facts and figures on Tibet in 1999. — http://www.index-china.com/index-english/Tibet-s.html. 08.11.2008.
China's midnight deadline for Tibetans to "surrender". — http://beijingwideopen.org/. 17.03.2008.
Chinas massacre in Tibet. Shooting at Tibetan pilgrims. — http://www.youtube.com/watch?v=BkMcj4vQtRU, 27.07.2008.
China's Population. 1988. Beijing.
China's Tibet exhibit toes the party line. — http://alkimija.newsvine.com/_news/2008/07/10/1653485-chinas-tibet-exhibit-toes-the-party-line. 05.11.2008.
China's Train, Tibet's Tragedy. 2009. Dharamsala: DIIR.
China-Tibet: religious demography. — http://www.thearda.com/internationalData/countries/Country_51_2.asp. 18.01.2009.
ChinaVitae: Raidi. — http://chinavitae.com/biography/Raidi_/full. 03.11.2008.
Chinese authorities closes down Pangsa Monastery in Tibet. — http://www.tchrd.org/publications/hr_updates/2007/hr200711.html#Pangsa. 14.12.2008.
Chinese birth control policy affects Tibetan women. 2001. — Human Rights: TCHRD, December.
Chinese migrants, a cause for Tibet protest: China. — www.phayul.com/news/tools/print.aspx?id=22816&t=0. 18.09.2008.
Chinese regime implicated in staging violence in Lhasa. — www.phayul.com. 25.03.2008.
Compulsory unpaid labour in Drayab County. — http://www.tchrd.org/publications/hr_updates/2001/hr200108.html#unpaid. 13.12.2008.
Curran L.S., Zhuang J., Shin F., Moore L.G. 1997. Ventilation and hypoxic ventilatory responsiveness in Chinese-Tibetan residents at 3,658 m. — Journal of Appl. Physiol., v. 83, no. 6.
Dangerous Crossing: Conditions impacting the flight of Tibetan refugees 2002 update. 2003. International Campaign for Tibet — www.savetibet.org.
Dangerous Crossing: Conditions impacting the flight of Tibetan refugees 2003 update. 2004. International Campaign for Tibet. — www.savetibet.org.
Dangerous Crossing: Conditions impacting the flight of Tibetan refugees 2004 update. 2005. International Campaign for Tibet — www.savetibet.org.
Dangerous Crossing: Conditions impacting the flight of Tibetan refugees report 2006. International Campaign for Tibet — www.savetibet.org.
Decision of history and choice of people. 2008. — Tibetan Envoy, no. 12.
Department of Population, Social, Science and Technology Statistics of the National Bureau of Statistics of China and Department of Economic Development of the State Ethnic Affairs

Commission of China, eds. Tabulation on Nationalities of 2000 Population Census of China. 2 vols. Beijing: Nationalities Publishing House, 2003 [на кит. яз.]. — Цит. по: Tibet. http://articles.industrialsoft.org/wp/t/Tibet.htm. 26.01.2009.
Destruction of Serthar Institute: A special report. — http://www.tchrd.org/publications/topical_reports/destruction_of_serthar-2002/. 07.10.2008.
Display of Tibetan flag leads to death of detainee: an account of imprisonment after rare 1990s rural protest. — http://www.phayul.com/news/article.aspx?id=17012&t=1&c=1. 28.07.2008.
Dunham M. 2004. Buddha's Warriors: the Story of the CIA-backed Tibetan Freedom Fighters, the Chinese Invasion, and the Ultimate Fall of Tibet. New York: J.P. Tarcher — Penguin.
Ecological improvement and environmental protection in Tibet. Official publication. 2003 — www.gov.cn.
Ely M. The true story of Maoist revolution in Tibet. — http://rwor.org/a/firstvol/tibet/tib-in.htm. 08.11.2008.
Esherick J.W. 2006. How the Qing became China. — В кн.: Empire to Nation. Historical Perspectives on the Making of the Modern World (eds. J.W. Esherick, H. Kayali, E. van Young). Lanham, Maryland.
Ethnic repression in Tibet masterminded by faceless Chinese trio. — www_phayul_com.htm. 23.03.2008.
Fan M. In China, a different brand of Buddhism. Ethnic Han turning to Tibetan doctrine for guidance. — Washington Post, Friday, February 20, 2009.
Farquhar D.M. 1981. Structure and function in the Yuan Imperial Government. — В кн.: China under Mongol Rule. Princeton.
Fifth International Conference of Tibet Support Groups Brussels, 11–14 May, 2007. Dharamsala, 2008.
Fifty years in Tibet: media. — http://www.tibet.cn/tibetzt/tibet50-en/figure/doc/023.htm. 01.11.2008.
Forney M. China falls for Tibet chic. — http://www.time.com/time/world/article/0,8599,96835,00.html. 05.11.2008.
Franke H. 1981. Tibetans in Yuan China. — В кн: China Under Mongol Rule. Princeton.
French P. He may be a God, but he's no politician. — New York Times, 22.03.2008. — http://www.nytimes.com/2008/03/22/opinion/22french.html?ex=1363924800&en=17894010eb93d018&ei=5124&partner=permalink&exprod=permalink. 26.01.2009.
Gantenbein D. 1993. The high life. — http://discovermagazine.com/1993/oct/thehighlife286/. 17.03.2009.
Gelek. A Brief Description of the historical relations between ancient Tibetan culture and the Chinese Culture. — China Tibetology, no. 2. — http://www.tibet.cn/english/zt/TibetologyMagazine/200312004421152145.htm. 03.11.2008.
Ginsburgs G., Mathos M. 1964. Communist China and Tibet. The First Dozen Years. Hague.
Goldstein M. 1994. Change, conflict and continuity among a community of momadic pastoralists: a case study from Western Tibet, 1950–1990. — В кн.: Resistance and Reform in Tibet (ed. R. Barnett, Sh. Akiner). Bloomington.
Goldstein M.C. 2003. The demise of the Lamaist state. — В кн.: The History of Tibet (ed.A. McKay), v. 3. London — New York.
Goldstein M.C. 2007. A History of Modern Tibet, v. 2. The Calm Before the Storm: 1951–1955. Berkeley — Los Angeles: Univ. of California Press.
Goldstein M.C., Jiao B., Lhundrup T. 2009. On the Cultural Revolution in Tibet: the Nyemo Incident of 1969. Berkeley — Los Angeles — London: Univ. of Los Angeles Press.
Govinda L.G. 2002. Tibet in Pictures. A Journey into the Past. Berkeley (CA): Dharma Publ.
Graham-Harrison E. Chinese migrants may flee Tibet as tourism stalls. — Reuters, Thursday, Feb. 12, 2009.

Great Changes in Tibet. 1972. Peking: Foreign Language Press.
Grunfeld A.T. 1996. The Making of Modern Tibet. Armonk (NY): M.E. Sharpe.
Gyalo Thondup reconfirms Deng Xiaoping's offer on Tibet talks. — http://www.phayul.com/news/article.aspx?id=23254&article=Gyalo+Thondup+reconfirms+Deng+Xiaoping%e2%80%99s+offer+on+Tibet+talks&t=1&c=1. 21.11.2008.
Halperin B. D., Sun S. et al. 1998. ECG observations in Tibetan and Han residents of Lhasa. — J. Electrocardiol., v. 31, no. 3.
Herold K. Tibet Justice Center, an annotated chronology of relations in the 20th Century, 2nd ed., 1994. — http://www.tibetjustice.org/reports/chron.html. 21.07.2009.
His Holiness the Panchen Lama. The Panchen Lama's warning to China. — http://www.friends-of-tibet.org.nz/panchen-lama.html. 08.10.2008.
His Holiness's Middle Way Approach for resolving the issue of Tibet. — http://www.dalailama.com/page.225.htm. 11.03.2009.
Ho D.D. 2006. To protect and preserve: resisting the Destroy of Four Olds campaign, 1966–1967. — В кн.: The Chinese Cultural Revolution as History (J.W. Esherick, P.G. Pickowicz, A.G. Walder eds.). Stanford.
Horlemann B. Modernization efforts in Mgo log: a chronicle, 1970–2000. — http://www.cwru.edu/affil/tibet/booksAndPapers/horlemann.pdf/ 08.11.2008.
Hsin M. 1972. Lhasa's new look. — В кн.: Great Changes in Tibet. Peking.
[Hu Jintao] Full Text of Speech by Hu Jintao at Tibet's Peaceful Liberation. — http://english.peopledaily.com.cn/english/200107/19/eng20010719_75376.html, 27.07.2001.
Human Rights Situation in Tibet: Annual Report 2001. Dharamsala: TCHRD.
Human Rights Situation in Tibet: Annual Report 2007. — http://www.tchrd.org/publications/annual_reports/2007/ar_2007.pdf. 14.12.2008.
Human Rights Situation in Tibet: Annual Report 2008. Dharamsala: TCHRD.
International Commission of Jurists Report on Tibet 1997.
Jarrah W. 2002. Gyelthang and Tsethang — a traveller's impression. — Tibetan Bull., July–September.
Jian Ch. The Tibetan rebellion of 1959 and China's changing relations with India and the Soviet Union. — В кн.: Cold War Studies at Harvard University. — http://www.fas.harvard.edu/~hpcws/jcws.2006.8.3.pdf. 25.01.2009.
Jiang D. Popular history: the suppression of rebellion in Tibet (posted by Zh. Li). — http://chinadigitaltimes.net/2008/03/popular-history-the-suppression-of-a-rebellion-in-tibet. 21.12.2008.
Jin B. 1987. When does the word "minority nationality" [shaoshu minzu] [first] appear in our country? — Nationality Solidarity (Minzu Tuanjie), v. 6. — http://www.columbia.edu/itc/ealac/barnett/pdfs/link21-jinbanggao.pdf. 16.05.2009.
Johnston C. Tibet: the international mistake of the Century. — http://www.friends-of-tibet.org.nz/mistake-of-the-century.html/ 03.11.2008.
Joint Statement to Repudiate the so-called Order no. 5 of China's State Administration of Religious Affairs on Management Measures for the Reincarnation of 'Living Buddhas' in Tibetan Buddhism. – http://www.tibet.net/en/prelease/2007/020907.html. 13.06.2011.
Jong L. DNA profiles of "Han" Taiwanese. — http://www.taiwandna.com/ProfileJong.html. 17.02.2009.
Kalovski I. The true face of the Dalai Lama. — http://kalovski.blog.com/763351/. 15.05.2009.
Karmel S.M. Ethnic tension and the struggle for order: China's policies in Tibet. — http://www.thefreelibrary.com/Ethnic+tension+and+the+struggle+for+order%3a+China's+policies+in+Tibet.-a018280032. 03.11.2008.
Kauffner P. Was human sacrifice practiced in old Tibet? — http://stason.org/TULARC/travel/tibet/

B4-Was-human-sacrifice-practiced-in-old-Tibet.html/ 21.11.2008.
Khenpo Jigme Phuntsok. Abbot of Serthar Buddhist Institute dies. — http://www.phayul.com/news/article.aspx?id=5791&t=1. 07.10.2008.
Khetsun T. 2008. Memoirs on Life in Lhasa Under Chinese Rule. Univ. of Columbia Press.
Knuth R. 2003. Libricide: The Regime-sponsored Destruction of Books and Libraries in the Twentieth Century. Westport, Conn.: Praeger.
Kolas A., Thowsen M.P. 2005. On the Margins of Tibet: Cultural Survival on the Sino-Tibetan Frontier. Washington: Univ. of Washington Press.
Kolmas J. 1967. Tibet and Imperial China. Canberra: Austral. National Univ.
Krishnatry S.M. 2005. Border Tagins of Arunachal Pradesh. Unarmed Expedition 1956. New Delhi: National Book Trust.
Kumbum's song of sadness. 1998. — Human Rights Update: TCHRD, v. 3, no. 17.
Kuxing: Torture in Tibet. A Special Report. TCHRD. — http://www.tchrd.org/publications/topical_reports/torture/torture.pdf. 07.06.2009.
Kuzmin S.L. (in press). The Treaty of 1913 between Mongolia and Tibet and Its Validity.
La magie du Bouddha. — http://magiedubouddha.com/p_tib-os1.php. 08.11.2008.
Laird Th. 2006. The Story of Tibet. Conversations with the Dalai Lama. New York: Grove Press.
Langlois J.D., Jr. 1981. Political thought in Chin-hua under Mongol rule. — В кн.: China Under Mongol Rule. Princeton.
Ling N. 1964. Tibetan Sourcebook. Hong Kong: Union Research Inst.
List of tributaries of Imperial China. — http://en.wikipedia.org/wiki/List_of_tributaries_of_Imperial_China. 21.12.2008.
Liu M. When heaven shed blood. Details of the CIA's secret war in Tibet are only now leaking out, a tale of daring espionage, violence and finally betrayal. — http://www.buddhistview.com/site/epage/31552_225.htm. 17.02.2009.
Ma Rong. 1993. Residential patterns and their impact on Han-Tibetan relations in Lhasa City, the Tibet Autionomous Region. — В кн.: Urban Anthropology in China (Gulden G., Southall A. eds.). Boston.
Macdonald D. 1932. Twenty Years in Tibet. London: Seely, Service & Co.
Mao Tse-tung. 1977. On the policies for our work in Tibet. Directive of the Central Committee of the Communist party of China. — В кн.: Selected Works of Mao Tse-tung. Peking: Foreign Languages Press. — http://www.marx2mao.com/Mao/WT52.html. 08.11.2008.
Maps of Tibet. Historic Images of the High Plateau. 2008 Calendar. International Campaign for Tibet.
Mass transportation of objects of Tibetan historical and cultural value to China. 2003. — Tibetan Envoy, no. 7.
McCarthy R.E. 1997. Tears on Lotus: Accounts of Tibetan Resistance to the Chinese invasion 1950 — 1962. Jefferson (N Carolina) — London: McFarland & Co.
Memorandum from the Tibetan Muslim Youth Federation. — www_phayul_com.htm. 21.03.2008.
Mind and Life Institute. — http://www.mindandlife.org. 06.06.2009.
Movement westward. 1985. — Reference Material (2). Embassy of the PRC, New Delhi, 4 February.
National uprising. — http://www.tibet.com/WhitePaper/white3.html. 14.03.2009.
Nationalities and Religious Bureau of Lhasa Municipality, 20.7.1997 — цит. по: New temple and monastic rules. — http://www.tchrd.org/publications/hr_updates/1997/hr19971215.html#reeducation. 14.12.2008.
Ngapo Ngawang Jigme. 1988. When did Tibet come within the sovereignty of China? — Bull. Hist. Tibet Communist Party, v. 3 (General Series, no. 21, translation by Tibet Information Network, London (TIN Ref: Doc 22(ZY)): Background Papers on Tibet, September 1992, pt. 2. London: Tibet Information Network.

Ngapoi Ngawang Jigme. 1991. On Tibetan Issues. Beijing: New Star.

Nichols S. Malware writers target pro-Tibet groups. — http://www.vnunet.com/vnunet/news/2212635/malware-writers-aim-pro-tibet. 27.07.2008; Cyber attacks target pro-Tibet groups. — www.phayul.com. 23.03.2008.

Niermeyer S., Yang Ping, Sganmina, Drolkar, Janguo Zhuang, Moore L.G. 1995. Arterial oxygen saturation in Tibetan and Han infants born in Lhasa, Tibet. — New England J. Medicine, v. 333, no. 19.

Norbu D. 1998. Self-determination: the satisfactory solution. — Tibetan Bull., May–June.

Norbu D. 1999. Tibet: the Road Ahead. New Delhi: HarperCollins.

Norbu D. 2001. China's Tibet Policy. Surrey: Routledge–Curzon Press.

Norbu J. 2003. The Tibetan resistance movement and the role of the CIA. — В кн.: The History of Tibet (McKay A. ed.), v. 3. London — New York.

Norbu J. 2006. The forgotten anniversary — remembering the great Khampa uprising of 1956. — http://www.phayul.com/news/article.aspx?c=4&t=1&id=14993&article=The+Forgotten+Anniversary+-+Remembering+the+Great+Khampa+Uprising+of+1956. 25.01.2009.

Norbu J. March winds. — http://www.phayul.com/news/article.aspx?article= MARCH+ WINDS+-+Jamyang+Norbu&id=24032. 07.03.2009.

Origin of the title of "Dalai Lama" and its related backgrounder. — http://news.xinhuanet.com/english/2009–03/01/content_10921943_3.htm. 09.03.2009.

Palden Gyatso. 1997. Fire Under Snow. Testimony of a Tibetan Prisoner. London: The Harvill Press.

[Panchen Lama X] 1997. A Poisoned Arrow. The Secret Report of the 10th Panchen Lama. The Full Text of the Panchen Lama's 70,000 Character Petition of 1962, Together with a Selection of Supporting Historical Documents. London: Tibetan Information Network, китайский текст и английский перевод. Английский перевод есть в Интернете — http://www.asiafinest.com/forum/index.php?showtopic=22841. 10.10.2008.

[Panchen Lama X] The Panchen Lama's Last Speech: Full Text. — http://www.columbia.edu/itc/ealac/barnett/pdfs/link5-Panchenspeech.pdf. 16.05.2009.

Parenti M. Friendly feudalism: the Tibetan myth. — http://www.swans.com/library/art9/mparen01.html; сокращенный и неточный русский перевод: Паренти М. Дружественный феодализм: миф о Тибете. — http://left.ru/2008/6/parenti175.phtml.

"Patriotic Re-education" campaign results in one death and 25 arrests. — http://www.tchrd.org/publications/hr_updates/2000/hr200006.html#reeducation. 14.12.2008.

Pelliot P. 1912. L'origine du nom de "Chine". — T'uong Pao, v. 18.

[People's Republic of China State Statistical Bureau. Registers the result about the first national census the bulletin on November 1, 1954 (на кит. яз.)]. — http://www.stats.gov.cn/tjgb/rkpcgb/qgrkpcgb/t20020404_16767.htm. 26.01.2009.

Phuntsok Tashi Taklha. 1992. Historical Sino-Tibetan relations, 1949–1951 and the Seventeen-point Agreement. — http://www.columbia.edu/cu/lweb/indiv/area/tibet-potomac/historical/taklha.html. 27.01.2009.

Pirie F. Segmentation within the state: the reconfiguration of Tibetan tribes in Chinese reform period. — Nomads 9_1_11_04_05. — www.case.edu/affil/tibet/tibetanNomads/documents/NPpaper.pdf. 27.09.2008.

Political veteran speaks... 1998. — Human rights update: TCHRD, v. 3, no. 11.

Potala palace desecrated. 2001. — Tibetan Bull., March–June.

Powers J. 2004. History as Propaganda: Tibetan Exiles Versus the People's Republic of China. New York: Oxford Univ. Press.

Prachanda defends Chinese crackdown on Tibetans. — http://www.hindu.com/thehindu/holnus/003200803232124.htm. 15.05.2009.

Prisoners of Tibet: Special Report. 2006. TCHRD.

Promises and lies: “The 17-point Agreement”. The full story as revealed by the Tibetans and Chinese who were involved. 2001. — Tibetan Bull., March–June.

Prostitution abounds in Lhasa. 1995. — Tibetan Bull., May–June.

Protection and development of Tibetan culture (2008). Information Office of the State Council of the People’s Republic of China September 2008, Beijing. — http://english.gov.cn/official/2008–10/16/content_1123105.htm. 16.10.2008.

Puntshok J. 1998. Testimony of political prisoner. — Tibetan Envoy, v. 3.

Qin Yongzhang. A secret history of Japan coveting Tibet during the anti-Japanese aggression war. — China Tibetology, no. 6. — http://www.tibet.cn/english/zt/TibetologyMagazine/200312006911 61216.htm. 03.11.2008

Questions pertaining to Tibet, 1969–1972. — http://www.state.gov/documents/organization/70146.pdf. 03.01.2008.

Ran Ch. 1991. The origin and truth of the “Independence of Tibet”. Beijing: New Star.

Re-education in Kan Lho. 1996. — Human Rights Update: TCHRD, v. 2, no. 23.

Religious persecution through “patriotic re-education”. — http://www.tibet.com/Humanrights/HumanRights97/hr97–1.html. 03.11.2008.

Rhoads E.J.M. 2001. Manchu and Han. Ethnic Relations and Political Power in Late Qing and Early Republican China 1861–1928. Seattle — London: Univ. of Washington Press.

Ribhur Tulku. 1988. Search for Jowo Mikyoe Dorjee. Dharamsala: Office for Inform. & Intern. Relations, Central Tibetan Secretariat.

Roy A. 2008. Prachanda, the Unknown Revolutionary. Katmandu: Mandala Book Point.

Samsara, a Tibetan human rights archive. — personal testimony. — http://www.subliminal.org/tibet/testimony. 27.07.2008.

Samsara: personal testimony: Statement No. 11. — http://www.subliminal.org/tibet/testimony/icj60-stmt11.html. 03.11.2008.

Sautman B. 2008. “Demographic annihilation” and Tibet. — В кн.: Contemporary Tibet: Politics, Development and Society in a Disputed Region (eds. B. Sautman, J.T. Dreyer). New Delhi.

Sautman B. How repressive is the Chinese Government in Tibet? — http://www.international.ucla.edu/article.asp?parentid=2732. 26.01.2009.

Sautman B., Dreyer J.T. 2005. The Tibet question in contemporary perspective. — В кн.: Contemporary Tibet: Politics, Development, and Society in a Disputed Region. New York.

Schrei J.M. A lie repeated — the far left’s flawed history of Tibet. — http://www.studentsforafreetibet.org/article.php?id=425. 15.03.2009.

[Secret: CTC releases documents from Canada’s Tibet file]. — http://tibet.ca/_media/PDF/secret_canada_tibet_file.pdf. 30.01.2009.

Seres. — http://en.wikipedia.org/wiki/Seres. 04.01.2009.

Severe religious restrictions in Nyemo County. — http://www.tchrd.org/publications/hr_updates/2000/hr200005.html#restrictions. 14.12.2008.

Shakya Ts. 1997. Historical introduction. — In: Leaders of Tibet: a Directory. London, Tibet Information Network. — http://www.columbia.edu/itc/ealac/barnett/pdfs/link6-shakyaintro.pdf. 25.01.2009.

Shakya Ts. 1999. The Dragon in the Land of Snows. A History of Modern Tibet Since 1947. London: Pimlico.

Shakya Ts. 2002. Blood in the snows. Reply to Wang Lixiong. — New Left Review, v. 15, May–June. — http://www.newleftreview.org/?view=2388; http://www.tibetwrites.org/?Blood-in-the-Snows. 04.03.2009.

Shakya Ts. 2003. The genesis of the Sino-Tibetan Agreement of 1951. — В кн.: The History of Tibet (ed. A. McKay), v. 3. London — New York.

Shakya Ts. 2005. The prisoner. — New Left Review 34. — http://newleftreview.org/A2576. 25.01.2009.

Shakya Ts. Tibet and China: the past in the present. — http://www.phayul.com/news/article.aspx?c=4&t=1&id=24245&article=Tibet+and+China%3a+the+past+in+the+present+-+By+Tsering+Shakya. 21.03.2009.

Shakya Ts. Tibetan questions. — http://www.newleftreview.org/?page= article&view= 2720; http://newleftreview.org/?getpdf=NLR28501&pdflang=en. 04.11.2008)

Shaumian T. 2000. Tibet: the Great Game and Tsarist Russia. New Delhi: Oxford Univ. Press.

Smith W. Congressional panel to probe Chinese theft of Tibetan treasures. — http://www.rfa.org/english/commentaries/cambodia_cullumoped-04042008160706.html/tibet_smith-04042008160846.html. 20.09.2005.

Smith W.W.1994. The nationalities policy of the Chinese Communist Party and the Socialist transformation of Tibet. — В кн.: Resistance and Reform in Tibet (eds. R. Barnett, Sh. Akiner). Bloomington.

Smith W.W. 1996. Tibetan Nation. A History of Tibetan Nationalism and Sino-Tibetan Relations. Boulder: Westview.

Smith W.W. 2008. China's Tibet? Autonomy or Assimilation. Lahman etc.: Rowman & Littlefield.

Sonam T. 2007. A Cold War in Shangri La — the CIA in Tibet. — http://www.tibetwrites.org/?A-Cold-War-in-Shangri-La-The-CIA. 17.02.2009.

Song L. 2007. Reflections on the 17-point Agreement of 1951. — В кн.: Facts About the 17-point "Agreement" Between Tibet and China. Dharamsala.

Source list and detailed death tolls for the twentieth century hemoclysm. — http://users.erols.com/mwhite28/warstat1.htm. 26.01.2009.

Sperling E. 2003. The Chinese venture in K'am, 1904–11, and the role of Chao Erh-Feng. — В кн.: The History of Tibet (ed. A. McKay), v. 3. London — New York.

Sperling E. 2004. The Tibet–China conflict: history and polemics. — Policy Studies, v. 7 (Washington, East–West Center). — http://www.eastwestcenterwashington.org/publications/publications.htm. 15.12.2008.

Ssanang Ssetsen. 1829. Geschichte der Ost-Mongolen und Ihres Fuerstenhauses. St. Petersburg.

Statement of the department of Religion and Culture. – http://www.tibet.net/en/index.php?txtSearch=reincarnations. 13.06.2011.

Strangers in their own country: Chinese population transfer in Tibet and its impacts (a report by Tibetan Youth Congress). 1997. Dharamsala.

Strong A.-L. 1959. When Serfs Stood Up in Tibet. Peiking: New World Press. — http://www.marx.org/reference/archive/strong-anna-louise/1959/tibet/index.htm. 21.07.2009.

Struggling for influence in Nepal. — TibetInfoNet, 31.10.2008.

Taklha N.L. 2001. Born in Lhasa. Ithaca, NY: Snow Lions Publ.

Tales on terror: torture in Tibet (1999). — http://www.tchrd.org/publications/topical_reports/tales_of_terror-torture-1999// 08.11.2008.

Tenpa Soepa. 2008. 20 Years of My Life in China's Death Camp. Bloomington (India): Author House.

The Eight White Ordon, the offering ceremonies of Genghis Khan and the Mausoleum of Genghis Khan. — http://members.tripod.com/Mongolian_Page/white.txt. 08.10.2008.

The lost kingdom of Guge. — http://www.himmies.com/h1/tales_guge.html. 09.06.2009.

The Mongols and Tibet. A Historical Assessment of Relations Between the Mongol Empire and Tibet. 2009. Dharamsala: DIIR.

The myth of Tibet genocide. — http://thenewvoice.wordpress.com/2008/04/17/the-myth-of-tibet-genocide/. 26.01.2009.

The New Times представляет три точки зрения на ситуацию в Тибете: глазами правозащитника, журналиста и ученого-китаиста. №58 — от 24 Марта 2008. — http://lightbreeze.beon.ru/2181–230-the-new-times-tri-tochki-zrenija-na-situaciju-v-tibete.zhtml. 07.06.2009.

The Question of Tibet and the Rule of Law. 1959. Geneva: International Commission of Jurists.

The rebel Dalai Lama. — http://www.friendsoftibet.org/main/songs.html. 17.02.2009.
The Sino-Tibetan etymological dictionary and thesaurus. — http://stedt.berkeley.edu/html/STfamily.html#TBlg. 17.02.2009.
The status of Tibetan women in Tibet (1995–2000). — http://www.tibetanwomen.org/publications/books/status_of_women_in_tibet-un-2000.html. 28.04.2009.
Thinley P. 1996. The tragedy and courage of the late Panchen Lama. — Tibetan Bull., Jan.–Feb.
Tiang J. The Administrative System in Tibet during the Tang and Yuan Dynasties. — China Tibetology, no. 1. — http://www.tibet.cn/english/zt/TibetologyMagazine/200312003121614 2213.htm. 03.11.2008.
Tibet 2002 — a Yearbook: Reports from Tibet. London: Tibet Inform. Network.
Tibet and Manchu. An Assessment of Tibet-Manchu Relations in Five Phases of Historical Development. 2008. Dharamsala: DIIR.
Tibet and the Chinese People's Republic. A Report of the International Commission of Jurists by Its Legal Inquiry Committee on Tibet. 1960. Geneva: International Commission of Jurists.
Tibet riots orchestrated? — http://www.watbowon.org/Joomla1011/index.php?option=com_content&task=view&id=229&Itemid=85. 29.03.2008.
Tibet: the gap between fact and fabrication: III. Developments: The economic and social development. — http://www.tibetanyouthcongress.org/development_part3.htm. 14.12. 2008.
Tibet to provide housing for 52,000 farmers, herders in 2008. — http://english.peopledaily.com.cn/90001/90776/6340343.html. 28.07.2008.
Tibet Under Chinese Communist Rule. A Compilation of Refuge Statements, 1958–1975. 1976. Dharamsala: Information and Publicity Office of H.H. the Dalai Lama.
Tibet: 1950–1967. 1968. Hong Kong: Union Research Inst.
Tibet: a Human Development and Environment Report. 2007. Dharamsala: Central Tibetan Administration.
Tibetan blasts 'demographic aggression'. — www.phayul.com.
Tibetan exile monasteries. — http://www.khawakarpo.org/tibet_monasteries.htm. 20.09.2008.
Tibetan Plateau under the mercy of climate change and modernization. 2009. — Tibetan Bull., v. 13, no. 1.
Tibetan religious leaders not to accept Chinese imposed Panchen Lama. 1995. — Tibetan Bull., September–December.
Tibetan Youth Congress. — http://www.tibetanyouthcongress.org. 27.07.2008.
Torture in Tibet. A Report Submitted to the United Nation Committee Against Torture. 2000. Dharamsala.
Trikamdas P. 4 June 1959; 5 June 1959. Tibet — Summary of a Report on Tibet: Submitted to the International Commission of Jurists by Shri Purshottam Trikamdas, Senior Advocate, Supreme Court of India. — http://www.icj.org/news.php3?id_article=3415&lang=en&print=true. 04.05.2009.
Tsering B.K. 1985. Religion in Tibet today. — Tibetan Bull., v. 16, no. 1.
Uprising in Tibet 2008. Documentation of Protests in Tibet. Dharamsala: TCHRD.
Van Walt van Praag M.C. 1987. The Status of Tibet: History, Rights, and Prospects in International Law. Boulder, Colorado: Westview Press.
Van Walt van Praag M. 2007. The relevance of 17-point Agreement today. — Facts About the 17-point "Agreement" Between Tibet and China. Dharamsala.
Vembu V. 2007. Tibet wasn't ours, says Chinese scholar. — http://www.dnaindia.com/report.asp?newsid=1081523&pageid=0. 22.12.2008.
Victim of Chinese torture in Tibet. — http://www.subliminal.org/tibet/testimony/Choedrak-Congress.html. 03.11.2008.
Wade G. 1999. The polity of Yelang and the origins of the name "China". — Sino-Platonic Papers, no. 118, May. — http://www.sino-platonic.org/complete/spp188_yelang_china.pdf.

Wang Jiawei, Nimajianzan, Nyima Gyaincain. 1997. The Historical Status of China's Tibet. China Intercontinental Press.
Wiley A.S. 2004. An Ecology of High-Altitude Infancy. Cambridge: Cambridge Univ. Press.
Woeser Ts. A record of the Tibetan unrest: March 10 — March 25. — http://www.phayul.com/news/article.aspx?id=20170&article=A+Record+of+the+Tibetan+Unrest%3a+March+10%e2%80%94March+25#. 01.11.2008.
[Woeser] Diagnosing the Current Situation in Tibet. Interview with the Tibetan author Woeser. 1 May 2008. — http://www.tibetwrites.org/?Diagnosing-the-Current-Situation. 21.02.2009.
Woeser (Wei Se). 2006. Sha jie. Sishi nian de jiyi jinqu. Jingtou xia de Xizang wenhua. Di yi ci gongkai (Forbidden memory. Tibet during the Cultural Revolution), Taipei: Dakuai Wenhua, 296 с.
Worldwide Tibet Movement. — http://www.tibet.net/en/diir/wwtm/index.html. 07.06.2009.
Wren C.S. 1983. Life and death in Tibet: the past clings fiercely. — New York Times, 24.05.1983.
Wright A.R. 1904. Tibetan drum and trumpet. — Folklore, v. 15, no. 3 (Sep.: 29, 1904).
Wu T., Wang X., Wei C., Cheng H., Wang X., Li Y., Dong G., Zhao H., Young P., Li G., Wang Z. Hemoglobin levels in Qinghai-Tibet: different effects of gender for Tibetans vs. Hans.. — J. Appl. Physiol., v. 98.
Wu Keliang, Wu Changxin. Documentation and mining of yak culture to promote a sustainable yak husbandry. — В кн.: Proceedings of the International Congress on Yak, Chengdu, Sichuan, P.R. China 2004. — http://www.ivis.org/proceedings/yaks/2004/session7/Keliang.pdf.
Yan Hao. 2000. Tibetan population in China: myths and facts re-examined. — Asian Ethnicity, v. 1, no. 1. — http://www.case.edu/affil/tibet/booksAndPapers/tibetan.population.in. china.pdf. 25.01.2009.
Yeh E.T. 2003. Tibetan range wars: spatial politics and authority of the grasslands of Amdo. — Development and Change, v. 34, no. 3.
Zhao Suisheng. 2004. Nation-state by Construction: Dynamics of Modern Chinese Nationalism. Stanford: Stanford Univ. Press